

СУДАЛГААНЫ ЭМХЭТГЭЛ



ТОЙМ АГУУЛГА

- Эдийн засаг
- Нийгэм
- Эрх зүй, төрийн байгуулал

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

“Судалгааны эмхэтгэл” (ХХҮIII боть)- ийг
Улсын Их Хурлын Тамгын газраас эрхлэн гаргав.

Хянасан: Б.Эрдэнэбилэгт (Ph.D)
Ц.Норовдондог (Ph.D)

Эмхэтгэсэн: Д.Жигваагүнсэл

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Т.Цэнд-Аюуш



ГАРЧИГ

I БҮЛЭГ. ЭДИЙН ЗАСАГ

- 1.1 Газрын тосны орлогыг олборлолт явагдаж буй бүс нутагт хэрхэн хуваарилдаг талаарх бусад орнуудын туршлага 5
Г.Билгээ, Р.Нургүл
- 1.2 Далайд гарцтай болон гарцгүй орнуудын усан замын тээврийн аюулгүй байдлын эрх зүйн орчин 25
Д.Халиун, О.Нарантуяа, Ц.Элбэгзаяа
- 1.3 Төрийн орон сууцны санхүүжилтийн тогтолцоо ба бодлогын арга хэрэгслүүд, тэдгээрийн давуу болон сул тал, бусад орнуудын туршлага 69
Ц.Норовдондог (Ph.D), Г.Билгээ, Д.Жигваагүнсэл, Р.Нургүл, Д.Халиун, Ц.Элбэгзаяа

II БҮЛЭГ. НИЙГЭМ

- 2.1 Хүүхдийн эрх хамгааллын эрх зүйн орчин, тогтолцоо ба хэрэгжүүлэх механизмын талаарх гадаадын зарим орны туршлага 130
Г.Билгээ, О.Нарантуяа, Р.Нургүл
- 2.2 Монгол Улс дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах хууль, эрх зүйн орчин, боловсронгуй болгох арга замууд 180
Ц.Норовдондог (Ph.D), О.Нарантуяа, Д.Жигваагүнсэл, Р.Нургүл, Ц.Элбэгзаяа
- 2.3 Монгол Улс дахь хүүхэд хөгжил, хүүхдийн эрх хамгааллын эрх зүйн орчин, бодлогын хэрэгжилтийн өнөөгийн байдал 255
И.Жаргалзаяабямба, О.Нарантуяа
- 2.4 Бүгд Найрамдах Улс тунхагласны баярын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбоотой лавлагаа мэдээлэл 302
Р.Нургүл, Ц.Элбэгзаяа

III БҮЛЭГ. ЭРХ ЗҮЙ, ТӨРИЙН БАЙГУУЛАЛ

- 3.1 Парламентын Хүний эрхийн хороод, тэдгээрийн үйл ажиллагааны талаарх гадаадын зарим орны туршлага 307
Г.Алтан-Оч (Ph.D), Д.Жигваагүнсэл, Р.Оргилмаа, Ц.Элбэгзаяа
- 3.2 Гадаадын зарим орны Парламентын Судалгааны албаны үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт 334
Ц.Норовдондог (Ph.D), Г.Алтан-Оч (Ph.D), Д.Жигваагүнсэл, И.Жаргалзаяабямба, Р.Нургүл
- 3.3 Парламентын спикер намын гишүүнчлэлээс түдгэлздэг эсэх, спикерийн бүрэн эрхийн хугацаа ба бүрэн эрхтэй холбоотой зарим зохицуулалт 374
Г.Алтан-Оч (Ph.D), Г.Билгээ, И.Жаргалзаяабямба, Д.Жигваагүнсэл, О.Нарантуяа, Р.Нургүл, Р.Оргилмаа, Ц.Элбэгзаяа
- 3.4 Парламентын ээлжит бус чуулганыг гадаадын зарим орны үндсэн хууль болон холбогдох бусад хууль, дүрмээр зохицуулсан байдал 392
Д.Халиун
- 3.5 Зөрчил шалган тогтоох, шийдвэрлэх ажиллагааг зохицуулж буй гадаадын зарим орны эрх зүйн орчин 445
Д.Халиун, Г.Алтан-Оч (Ph.D), Г.Билгээ, И.Жаргалзаяабямба, Д.Жигваагүнсэл, О.Нарантуяа, Р.Нургүл, Ц.Элбэгзаяа

1 БҮЛЭГ

ЭДИЙН ЗАСАГ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ГАЗРЫН ТОСНЫ ОРЛОГЫГ ОЛБОРЛОЛТ ЯВАГДАЖ БУЙ БҮС НУТАГТ ХЭРХЭН ХУВААРИЛДАГ ТАЛААРХ БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА

(Харьцуулсан судалгаа)

Г.Билгээ, Р.Нургүл

АГУУЛГА

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Газрын тосны орлогыг олборлолт явагдаж буй бүс нутагт хэрхэн хуваарилдаг талаарх бусад орнуудын туршлага:

- Оросын Холбооны Улс
- Америкийн Нэгдсэн Улс
- Холбооны Бүгд Найрамдах Нигер Улс
- Бүгд Найрамдах Хятад Ард Улс
- Бүгд Найрамдах Индонез Улс

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Өнөө үед байгалийн баялгийн орлогыг хуваарилах асуудал дэлхий нийтийн хувьд чухал асуудлын нэг болсон бөгөөд түүнийг хэрхэн хуваарилах арга зам улам боловсронгуй болж байна.

Улс орон бүр байгалийн баялгийг хуваарилах тогтолцоог нэвтрүүлэхдээ тухайн улс орны онцлог байдлыг харгалзан, улс болон орон нутагт тулгамдсан нийгэм, эдийн засаг, байгаль орчны асуудлыг шийдвэрлэх боломжтой тэрхүү хувилбарыг хэрэгжүүлдэг.

Дэлхийн улс орнууд байгалийн баялгаас олох орлогыг орон нутагт хуваарилах өөрийн гэсэн тогтолцоотой. Тухайн тогтолцоог сонгох болсон үндэслэл шалтгаан нь улс бүрт өөр өөр байдаг. Зарим улсын орлого хуваарилах тогтолцоо нь байгалийн баялгийг эзэмшдэг орон нутагт илүү үр ашиг хүртээх шаардлагыг хангасан байхад зарим нь олборлолтоос үүдэлтэй байгаль орчны доройтол болон бусад сөрөг үр дагаврыг нөхөн сэргээхэд анхаарсан. Зарим улсын хувьд байгалийн баялгаас үүдэлтэй зөрчил, мөргөлдөөнийг намжаахыг зорьдог байна¹.

Байгалийн баялгаас орох орлогыг орон нутагт хуваарилах үндсэн 2 арга байдаг². Үүнд:

1. **Орон нутгийн төсөвт шууд хуваарилах.** Зарим улсад орон нутагт татвар хурааж, хуримтлуулах эрх олгосон байдаг. Ихэнх нэгдмэл улсад хөрөнгийн татвар, зарим төрлийн хураамж зэрэг байгалийн баялагтай холбоотой татвар, төлбөрүүд орон нутгийн төсөвт шууд ордог. Орлогын илүү чухал эх үүсвэр болох аж ахуйн нэгжийн орлогын татвар, роялти, ашиг орлогын татвар, нэмэгдсэн өртгийн татвар, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн татвар зэрэг ашгийн татварууд голдуу Засгийн газрын төсөвт төвлөрдөг байна.
2. **Орон нутагт шилжүүлэх замаар хуваарилах** (Засгийн газрын нэгдсэн төсөвт төвлөрүүлж, орон нутгийн төсөвт хуваарилна). Ихэнх улс орнууд байгалийн баялгаас олох орлогыг хуваарилахдаа төсвийн бусад орлогын нэгэн адил Засгийн газрын төсвөөс орон нутгийн төсөвт шилжүүлэн хуваарилдаг. Зарим орны хувьд төсвийн бусад орлогоос тусад нь авч үзээд өөр зарчмаар хуваарилдаг онцлогтой (*based on derivation* - орлогын эх үүсвэрт, эсхүл *indicator based* - орлогын төрөлд үндэслэж хуваарилах).

Практикт байгалийн баялгаас олох орлогыг хуваарилахад дээрх 2 аргыг хосолсон хэлбэрээр ашиглах нь түгээмэл байна.

Байгалийн баялгаас олох орлогыг хуваарилах байдлаар (Засгийн газар болон орон нутаг хооронд) нь улс орнуудыг дараах 3 бүлэгт хувааж болно³.

Нэгдүгээр бүлэгт байгалийн баялгаас олох орлогыг төсвийн бусад төрлийн орлоготой адил зарчмаар хуваарилдаг улс орнууд багтана. Энэ тохиолдолд Засгийн газар нь байгалийн баялгаас олох орлогыг төсвийн бусад орлогын адил

¹Natural Resource Revenue Sharing. National Resource Governance Institute, UNDP. September 2016. P.5.
<https://resourcegovernance.org>

²Natural Resource Revenue Sharing. National Resource Governance Institute, UNDP. September 2016. P.18-19.
<https://resourcegovernance.org>

³Natural Resource Revenue Sharing. National Resource Governance Institute, UNDP. September 2016. P.29-31.
<https://resourcegovernance.org>

нэгдсэн байдлаар төвлөрүүлж, дараа нь орон нутгийн төсөвт хуваарилдаг.

Хоёрдугаар бүлэгт байгалийн баялгаас олох орлогыг тусад нь авч үздэг бөгөөд орлогын эх үүсвэрийн төрөлд үндэслэж хуваарилдаг (based on derivation) улс орнууд орно. Энэ бүлэгт 30 гаруй улс хамрагдаж байна. Байгалийн баялгаас орох орлогыг тусад нь авч үзэх ба эх үүсвэрийн төрлөөс (татвар, хураамж, төлбөр болон бусад төрлийн орлого) хамааруулан зарим хэсгийг олборлолт явагдаж буй орон нутагт хуваарилдаг. Зарим тохиолдолд олборлолтын үйл ажиллагааны сөрөг нөлөө (байгаль орчин, нийгмийн гэх мэт) учирч буй бусад орон нутагт ч хуваарилж болно.

Гуравдугаар бүлэгт дээрхтэй адил байгалийн баялгаас олох орлогыг тусад нь авч үздэг улс орнууд багтана. Гэхдээ хуваарилалт хийх зарчим нь өвөрмөц онцлогтой бөгөөд тодорхой нэг үзүүлэлтэд үндэслэж хуваарилдаг (indicator based). Хоёр дахь бүлэгтэй харьцуулахад цөөн тооны улсууд үүнд хамрагдаж байна. Энэ бүлэгт ордог улсууд орон нутагт орлого хуваарилахдаа янз бүрийн шалгуур үзүүлэлтийг авч үздэг. Жишээлбэл, хүн амын тоо, орлогын түвшин, ядуурлын түвшин, газарзүйн онцлог гэх мэт. Өөрөөр хэлбэл, байгалийн баялгаас орох орлогыг тусгайлсан үзүүлэлтээс хамааруулан төсвөөс хуваарилалт хийнэ. Орлогыг олборлолт явуулсан орон нутагт төдийгүй бусад орон нутагт мөн адил хуваарилдаг. Хуваарилалт хийх үзүүлэлт нь маш тодорхой, хэмжигдэхүйц байх шаардлагатай. Онолын хувьд ингэж хуваарилах нь хэрэгцээт орон нутагт орлогыг оновчтой хуваарилах магадлалтай. Мөн орон нутгийн хөгжлийн тэнцвэргүй байдлыг бууруулах боломжтой гэж үздэг байна.

Байгалийн баялаг нь улс орнуудад эерэг болон сөрөг үр дагаврыг авчирдаг. Газрын тос, байгалийн хий, ашигт малтмалын олборлолт нь нийгмийн үйлчилгээ, дэд бүтцийн салбарт байгалийн баялгийн орлогоор хөрөнгө оруулалт хийх зэрэг ихээхэн үр ашгийг авчирдаг. Гэвч олборлолт явагдаж буй ойр орчмын орон нутгийн иргэд түүний сөрөг үр дагаврын нөлөөнд ихээр өртөж болзошгүй. Жишээ нь орон нутгийн иргэдийг нүүлгэн шилжүүлэх, амьжиргаагаа алдах, уул уурхай болон газрын тос, байгалийн хийн орд газрын нөлөөнөөс байгаль орчин сүйрэх, эдийн засгийн идэвхжилт болон гадны хөдөлмөр эрхлэлт ихээхэн нэмэгдсэнээр амьжиргааны өртөг өсөх зэрэг сөрөг талуудыг дурдаж болно. Олборлолтын үйл ажиллагаа ихэвчлэн хөгжлийн хувьд хоцронгүй хөдөө орон нутагт явагддаг тул сөрөг нөлөөний улмаас хөдөөгийн ядуурал улам даамжрах магадлалтай юм.

Тиймээс цөөнгүй улс орон, ялангуяа байгалийн баялгаар баян улсууд түүнээс олох орлогыг төсвийн бусад орлогоос тусад нь авч үздэг бөгөөд тусгай хууль гарган хуваарилж байна. Байгалийн баялгаас олох орлогыг ийнхүү хуваарилах нь тухайн олборлолт хийж буй орон нутгийн нийгэм, эдийн засаг, байгаль орчныг нөхөн сэргээх асуудлыг шийдвэрлэхээс гадна санхүүжилт дутагдалтай, хөгжил буурай бусад бүс нутгуудад нэмэлт санхүүжилт олгох давуу талтай.

Энэхүү судалгаанд газрын тосны олборлолтоор тэргүүлдэг, төрийн байгууламжийн хувьд холбооны улсууд болох ОХУ, АНУ, Нигер болон нэгдмэл улс орнууд болох БНХАУ, Индонез зэрэг улсын туршлагыг судалсан болно. Судалгаанаас гарсан үр дүнг хураангуйлан тоймолбол дараах байдалтай байна. Үүнд:

Оросын Холбооны Улсын хувьд: ОХУ-ын Төсвийн тухай хуулийн дагуу

газрын тосны салбараас орох татварын орлогын ихэнх хувь нь холбооны төсөвт, цөөхөн хувь нь тус улсын субъектүүд буюу бүс нутагт болон орон нутагт тус тус хуваарилагдаж байна.

Одоогийн байдлаар газрын тос үйлдвэрлэгч компаниудын төлсөн нийт татварын 10-15 хувь нь олборлолт явагдаж буй бүс нутгийн төсөвт орж байгаа бөгөөд үүнд ААН-ийн өмчийн татвар, хувь хүний орлогын албан татвар, бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилтийн ААН-ийн орлогын татвар, газрын хэвлий ашигласны төлбөр голлож байна.

Ашигт малтмал (газрын тос)-ын татварын орлогыг авч үзвэл, энэ орлогоос олборлолт явагдаж буй бүс нутгийн төсөвт үлдэх хэмжээ 2002 онд байсан 20 хувиас буурсаар 2014 онд холбооны төсөвт бүрэн төвлөрөх болжээ.

Төсвийн тухай хуулиар хүрээлэн буй орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх нэхэмжлэлийг хохирол учруулсан орон нутаг, хот болон холбооны чанартай хотын төсөвт 100 хувь шилжүүлэхээр заасан боловч одоогийн байдлаар шүүх (арбитр)-ийн шийдвэрээр нэхэмжлэлийн дүнг холбооны төсөв, эсхүл ОХУ-ын субъектүүдийн төсөвт шилжүүлж байна.

Америкийн Нэгдсэн Улсын хувьд: Энэхүү судалгаанд АНУ-ын газрын тос болон байгалийн хийн олборлолтоор тэргүүлдэг 16 муж хамрагдсан. Муж болон орон нутгийн захиргаа нь газрын тос болон байгалийн хийгээс олох орлогыг янз бүрийн хэлбэрээр (эх үүсвэрээс) бүрдүүлдэг.

Орон нутагт орлогыг татвар ногдуулах замаар **шууд**, эсхүл мужийн төсвөөс хуваарилалт хийх замаар **шууд бусаар** бүрдүүлнэ. Газрын тос болон байгалийн хийн орлогыг хэрхэх талаарх бодлого нь нийт зарцуулалт болон сургуулийн дүүрэг (school district), муниципалитет (municipalities), тойрог (counties), бусад орон нутгийн нэгжүүдэд хэрхэн хуваарилах хүрээнд харилцан адилгүй байна. Мөн түүнчлэн зарим мужууд нэлээд хэмжээний хөрөнгийг төсөл шалгаруулан санхүүжилт хийх замаар хуваарилдаг.

Жич: municipalities – орон нутаг засаг захиргааны нэгж бөгөөд АНУ-ын хувьд хот, тосгоныг хэлнэ⁴. Counties буюу тойрог нь мөн орон нутаг засаг захиргааны нэгж бөгөөд АНУ-ын 50 мужаас 48 муж нь нийт 3007 тойргоос бүрддэг.⁵

Ерөнхийдөө хамгийн их орлогын эх үүсвэрийг ашигт малтмал олборлосны татвар ба түүнтэй адилтгах орлого, дараа нь мужаас ногдуулсан газар ашигласны төлбөр, гуравдугаарт орон нутгаас газрын тос болон байгалийн хийн олборлолтод ашиглагдаж буй хөрөнгөд ногдуулсан татвар, дөрөвдүгээрт холбооны засгийн газраас ногдуулсан газар ашигласны төлбөр бүрдүүлдэг. Мужуудын олсон орлогын дийлэнх хэсэг нь мужийн төсвийн урсгал зардал ба боловсролын зардлыг санхүүжүүлэхэд зарцуулагдаж, үлдсэн хэсэг нь орон нутагт хуваарилагдаж байна. Зарим мужууд газрын тос болон байгалийн хийн олборлолтоос олох орлогын тодорхой хэсгийг Баялгийн санд хуваарилдаг.

Ер нь орлого бүрдүүлэх механизм болон түүнийг хуваарилах бодлого нь муж

⁴ <https://en.wikipedia.org/wiki/Municipality>

⁵ https://en.wikipedia.org/wiki/List_of_United_States_counties_and_county_equivalents

бүрийн хувьд харилцан адилгүй төдийгүй орлогын бүтэц, хуваарилалтын хувь хэмжээ хүртэл ялгаатай байна.

Холбооны Бүгд Найрамдах Нигер Улсын хувьд: Нигерийн төв Засгийн газар нь газрын тосны олборлолтоос хамаарч сар бүр орлогын 13 хувиас багагүй хувийг муж улсуудад хуваарилдаг. 1999 онд ХБННУ-ын Үндэсний Ассамблейгаас баталсан байгалийн баялгийн орлогын хуваарилалтын дагуу холбооны данснаас Холбооны Засгийн газарт 52.68 хувийг, үлдсэн хувийг нь муж улсын болон орон нутгийн засгийн газруудад тэдгээрийн эдийн засаг, хүн ам зүйн үзүүлэлтүүдэд тулгуурлан хуваарилдаг байна.

Байгалийн баялгаас орж ирэх татварын орлого тодорхой данс руу хуваарилагдана. Тэдгээрийн нэг болох нэмэгдсэн өртгийн албан татварын орлогын 96 хувийг Нэмэгдсэн өртгийн албан татварын санд орох бөгөөд тус сангаас холбооны нэгдсэн төсөв (15 хувь), муж улсын засгийн газруудад (50 хувь), орон нутгийн засгийн газруудад (35 хувь) тус тус дахин хуваарилагдана.

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хувьд: Газрын тос, байгалийн хийн олборлолтоос орох орлогын гол эх үүсвэрүүд нь роялти буюу ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, байгалийн баялгийн нөхөн төлбөр, байгаль орчинтой холбоотой газрын тосны тусгай орлого болон заавал төлөх төлбөр, бусад татварууд байна. Түүнчлэн төрийн өмчит аж ахуйн нэгжүүд Засгийн газарт ногдол ашиг төлдөг.

БНХАУ нь 1994 оноос орон нутгийн татварын тогтолцоонд суурилсан. Энэ нь:

(1) төв болон орон нутгийн засгийн газрууд өөрсдөө төсвөө боловсруулж, захиргааны асуудлуудаа бие даан удирдана;

(2) төв болон орон нутгийн засгийн газар хооронд татвар хуваарилах болсон ба татварыг Засгийн газрын, орон нутгийн, хуваалцах татвар гэж ангилна;

(3) татвар бүрдүүлэлтийг удирдан зохион байгуулах татварын төв алба болон орон нутгийн татварын удирдлага бий болсон;

(4) төв Засгийн газар нь жил бүр татварын орлогын тодорхой хувийг мужийн засаг захиргаанд шилжүүлнэ;

(5) жил бүр төв болон бүс нутгийн засгийн газар хооронд шилжүүлэг хийгдэнэ.

НӨАТ нь төв Засгийн газрын төсвийн орлогын хамгийн том эх үүсвэр болдог. Харин бизнесийн татварууд (business taxes) нь аймгийн засгийн газруудын төсвийн орлогын чухал эх үүсвэр байдаг. Олборлох үйлдвэрлэлийн орлогын өөр нэг урсгал бол роялтитай адил байгалийн баялгийн татвар юм. Газрын тос, байгалийн хийд ногдуулах байгалийн баялгийн татварыг орлогын үндсэн дээр тооцдог бол бусад ашигт малтмалд ногдуулах байгалийн баялгийн татварыг үйлдвэрлэлийн хэмжээгээр тооцдог байна. 2016 оны 10 дугаар сарын байдлаар газрын тос, байгалийн хийд ногдуулах байгалийн баялгийн татварын хувь хэмжээ 6 хувьтай байсан.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар нь БНХАУ-д НӨАТ-ын дараа төсвийн орлогын хоёр дахь гол эх үүсвэр юм. Газрын тос, байгалийн хийн гол 2 компаний аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогыг төв Засгийн газар авна. Харин бусад компаний (уул уурхайн компанийг оролцуулаад) аж ахуйн нэгжийн орлогын албан

татварын орлогын 60 хувийг төв Засгийн газарт, 40 хувийг орон нутгийн засгийн газарт тус тус хуваарилна.

Байгалийн баялгийн нөөцийн нөхөн төлбөрийн удирдлагын тухай журмын дагуу 1997 оноос төв Засгийн газар нь байгалийн баялгийн нөөцийн нөхөн төлбөрийг ногдуулж эхэлсэн. Журмын дагуу энэ нөхөн төлбөрийн орлогыг төв болон орон нутгийн засгийн газруудад тэнцүү хуваарилна, харин Төвд болон Өвөр Монгол зэрэг 5 өөртөө засах орны засгийн газарт орлогын 60 хувь, төв Засгийн газарт 40 хувийг тус тус хуваарилна.

2006 оноос эхлэн газрын тосны орлогын тусгай хураамжууд (*Special Petroleum Proceeds*)-ыг ногдуулах болсон. Эдгээр хураамж нь дэлхийн газрын тосны үнийн өсөлтийн ашгаас авах бөгөөд энэ нь гэнэтийн ашгийн татвартай төстэй. Энэ орлого нь олон улсын түүхий нефтийн үнээс шалтгаалж байгаа учраас байнга хэлбэлзэж байдаг.

Төв Засгийн газарт хуваарилсан байгалийн баялгийн орлогын дийлэнх хэсгийг улсын төсөвт төвлөрүүлж, төсвийн бусад орлогын хамт дахин хуваарилна. Гэсэн ч төв Засгийн газарт роялти болон бусад татвар, хураамжаас төвлөрсөн орлогын тодорхой хувийг олборлолт явагдаж байгаа бүс нутагт голдуу геологийн хайгуулын ажилд зарцуулдаг.

Бүгд Найрамдах Индонез Улсын хувьд: Индонез Улсын Засгийн газраас газрын тосны орлогын 3.1 хувийг олборлолт явагдаж буй мужид нь, 6.2 хувийг тус мужийн бүх орон нутгуудад нь тус тус хуваарилдаг байна.

Тус улсын Засгийн газар зарим мужтай тусгай гэрээ байгуулсан байна. Тухайлбал, 2002-2011 онд Ачех мужид газрын тос, байгалийн хийн орлогын 70 хувийг олгож байсан бөгөөд тогтоосон хугацаа дуусахад 50 хувь болгож буулгажээ. Мөн ийм гэрээг Папуа болон Баруун Папуа мужуудтай 2002 оноос 2027 оныг хүртэл байгуулжээ.

Байгалийн баялгийн орлого хуваарилах энэ тогтолцоо дараах асуудлыг дагуулсан байна. Нэгд, газрын тос, байгалийн хийн нөөцтэй зарим бүс нутгууд гэнэтийн их хэмжээний орлоготой болсон ч гэсэн янз бүрийн нөхцөл байдлаас хамаарч мөн гэнэтийн санхүүгийн уналтад орсон. Хоёрт, олборлолт явагддаггүй орон нутагт байгалийн баялгийн орлогоос хуваарилдаггүй сул талтай.

СУДАЛГААНЫ САН

ГАЗРЫН ТОСНЫ ОРЛОГЫГ ОЛБОРЛОЛТ ЯВАГДАЖ БУЙ БҮС НУТАГТ ХЭРХЭН ХУВААРИЛДАГ ТАЛААРХ БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА

1. ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС

Газрын тосны нөөц ба олборлолт

2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар ОХУ-ын газрын тосны нийт нөөц 28.9 тэрбум тонн хэмээн тус улсын Эрчим хүчний яамнаас мэдээлсэн бөгөөд газрын тосны нөөцийг газар зүйн байршлаар дараах 6 бүс нутагт хуваадаг.⁶ Үүнд:

- 1) Баруун Сибирийн бүс нутаг (62.5 хувь);
- 2) Ижил мөрөн, Уралын бүс нутаг (15.1 хувь);
- 3) Зүүн Сибирийн бүс нутаг (11.8 хувь);
- 4) Алс Дорнодын бүс нутаг (2.1 хувь);
- 5) ОХУ-ын далайн усны сан (8.0 хувь);
- 6) Бусад бүс нутаг (0.5 хувь).

ОПЕК⁷-ийн 2017 оны статистикийн мэдээгээр газрын тосны үйлдвэрлэлийн хэмжээгээрээ ОХУ нь дэлхийд 2 дугаарт орж байна.⁸

ОХУ-ын засаг захиргаа нийт 85 субъектэд хуваагдах ба зарим субъектүүд нь “матрёшка” бүтэцтэй. Тухайлбал, Тюмень муж нь нүүрсустөрөгчийн олборлолтоор тэргүүлэгч Ханты-Мансийск, Ямало-Ненецк гэсэн хоёр субъектийг өөртөө багтаасан. 2010 онд Ханты-Мансийск автономит муж нь хойд хөршийн газрын тосны нийт олборлолтын 53 хувийг, Ямало-Ненецк автономит муж нь байгалийн хийн нийт олборлолтын 85 хувийг тус тус олборложээ.⁹

2012 оны мэдээгээр тус улсын 36 субъектэд газрын тос олборлож байсан.¹⁰ Доорх зурагт 2008, 2010 онд газрын тос олборлогч субъектүүдийг үзүүлэв. (Зураг 1.)

2011 оны 01 дүгээр сарын 01-ний байдлаар тус улсын нутаг дэвсгэр дээр 325 газрын тос олборлогч ААН үйл ажиллагаагаа явуулж байсан бөгөөд тэдгээрийн 145 нь “Роснефть”, “Газпром”, ЛУКОЙЛ, ТНК-ВР, “Сургутнефтегаз”, “Татнефть”, “Башнефть”, “Русснефть” зэрэг 8 томоохон компанийн охин компаниуд ажээ.¹¹

⁶ Налогообложение нефтяной отрасли: введение НФР. Министерство Энергетики РФ. Москва. 2015. Эх сурвалж: www.komitet-bn.km.duma.gov.ru/upload/site7/document_news/MU0aEDlBzA.pdf

⁷ ОПЕК - Газрын тос экспортлогч орнуудын байгууллага (Organization of Petroleum Exporting Countries, OPEC) нь газрын тос олборлон боловсруулагч 12 улсын Засгийн газар хоорондын олон улсын байгууллага.


⁸ Дэлхийн газрын тосны үйлдвэрлэлээр Саудын Араб (өдөрт 10.46 сая баррель), ОХУ (өдөрт 10.29 сая баррель), АНУ (өдөрт 8.88 сая баррель) тэргүүлж байна. Эх сурвалж: OPEC Annual Statistical Bulletin – 2017. 52nd edition. 6 дахь тал. www.opec.org

⁹ Герасимчук И.В. Государственная поддержка добычи нефти и газа в России: какой ценой? Исследование Всемирного фонда дикой природы (WWF) и Глобальной инициативы по субсидиям Международного института устойчивого развития (IISD). Москва-Женева: WWF России и IISD, 2012. 39 дэх тал. www.iisd.org

¹⁰ Мөн тэнд. 39 дэх тал.

¹¹ Мөн тэнд. 29 дэх тал.

Зураг 1. ОХУ-ын газрын тосны олборлолт
(тэрбум тонн, бүс нутгаар, 2008, 2010 оноор)¹²



¹² Мөн тэнд. 29 дэх тал.

Газрын тосны салбарын татвар, төлбөрийн орлогын хуваарилалт

ОХУ-ын хуулийн дагуу газрын тос олборлогч компаниуд орлогын албан татвар, НӨАТ, ашигт малтмал (газрын тос)-ын олборлолтын татвар, гааль (экспорт)-ийн татвар, газрын хэвлий ашигласны төлбөр болон хуулийн этгээдэд хамааралтай бусад татваруудыг төлдөг.

ОХУ-ын Төсвийн тухай хуулийн¹³ 10 дугаар зүйлд зааснаар тус улсын төсвийн тогтолцоог холбооны, ОХУ-ын субъектүүдийн, орон нутгийн болон хот, тосгоны, хотын дүүргийн төсөв хэмээн үндсэн дөрвөн бүлэгт хуваагдана.

Төсвийн тухай хуулийн дагуу газрын тосны салбараас орох татварын орлогын ихэнх хувь нь холбооны төсөвт, цөөхөн хувь нь тус улсын субъектүүд буюу бүс нутагт, орон нутагт тус тус хуваарилагдаж байна. (Хүснэгт 1)

Хүснэгт 1. ОХУ-ын газрын тосны салбарын татвар, төлбөрийн орлогын хуваарилалт

Татвар, төлбөрийн төрөл	Төсвийн хуваарилалт	Татварын хувь хэмжээ¹⁴
Ашигт малтмал (газрын тос)-ын олборлолтын татвар	Холбооны төсөв - 100% ¹	493 руб./тонн
Роялти	Холбооны төсөв - 100% ¹	10%-аас багагүй
ААН-ийн ашгийн татвар	Холбооны төсөв - 100% ¹	20%
НӨАТ	Холбооны төсөв - 100% ¹	18%
Гааль (экспорт)-ийн татвар	Холбооны төсөв - 100% ²	35-40%
ААН-ийн өмчийн татвар	Бүс нутгийн төсөв - 100%³	2%
Хувь хүний орлогын албан татвар	Бүс нутгийн төсөв - 85%³ Орон нутгийн төсөв - 15%⁵	
Бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилтийн ААН-ийн орлогын татвар	Холбооны төсөв - 25% ¹ Бүс нутгийн төсөв - 75%³	Гэрээний дагуу
Газрын хэвлий ашигласны төлбөр	Холбооны төсөв - 40% ³ Бүс нутгийн төсөв - 60%⁴	120-540 руб./км ² 5-20 мян.руб./км ²

Эх сурвалж: ¹ Төсвийн тухай хуулийн 50 дугаар зүйл.

² Төсвийн тухай хуулийн 51 дүгээр зүйл.

³ Төсвийн тухай хуулийн 56 дугаар зүйл.

⁴ Төсвийн тухай хуулийн 57 дугаар зүйл.

⁵ Төсвийн тухай хуулийн 61, 61.1 дүгээр зүйл.

2002 оноос өмнө ашигт малтмал (газрын тос)-ын олборлолтын татварын орлогын 60 хувь нь газрын тосны олборлолт явагдаж буй бүс нутгийн төсөвт үлдэж, 40 хувь нь холбооны төсөвт ордог байжээ. Дэлхийн газрын тосны үнэ нэмэгдэхийн хэрээр олборлолт явагдаж буй бүс нутгийн төсвийн орлого нэмэгдэж байсан учир 2002 оноос хойш ОХУ-ын Засгийн газар нь энэ татварын орлогын холбооны болон орон нутагт хуваарилах хэмжээг хэд хэдэн удаа өөрчилжээ. Ашигт малтмал (газрын тос)-ын

¹³ "Бюджетный кодекс Российской Федерации" от 31.07.1998 N 145-ФЗ (ред. от 03.08.2018).

¹⁴ Учет интересов сырьевых регионов при налогообложении нефтяной промышленности. А.Н.Токарев (доктор экономических наук). ФГНУ «Институт экономики и организации промышленного производства» СО РАН (Новосибирск). Финансы и Банки. 2016. <https://elibrary.ru>

олборлолтын татварын орлогоос тухайн бүс нутгийн төсөвт үлдэх хэмжээ 2002 онд 20 хувь, 2003 онд 15 хувь, 2005 онд 5 хувь хүртэл буурсаар¹⁵ 2014 оноос холбооны төсөвт бүрэн төвлөрөх болжээ.

2014 он хүртэл ААН-ийн ашгийн татварын орлогын 14.5 хувийг нь бүс нутгийн төсөвт, 2 хувийг нь орон нутгийн төсөвт тус тус төвлөрүүлж байсан бол одоо бүхэлд нь холбооны төсөвт төвлөрүүлж байна.¹⁶

Одоогийн байдлаар газрын тос үйлдвэрлэгч компаниудын төлсөн нийт татварын 10-15 хувь нь олборлолт явагдаж буй бүс нутгийн төсөвт орж байгаа¹⁷ бөгөөд үүнд ААН-ийн өмчийн татвар, хувь хүний орлогын албан татвар, бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилтийн ААН-ийн орлогын татвар, газрын хэвлий ашигласны төлбөр (Хүснэгт 1.) голлож байна.

Газрын тосны алдагдалын улмаас байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлөх

ОХУ-ын Хүрээлэн буй орчныг хамгаалах тухай хуулийн¹⁸ 77 дугаар зүйлд заасны дагуу аж ахуйн болон бусад үйл ажиллагааны улмаас хүрээлэн буй орчинд учруулсан хохирлын хэмжээг хуулийн дагуу нөхөн төлөх ба хохирлыг сайн дураараа, эсхүл шүүх (арбитр)-ийн шийдвэрээр хэрэгжүүлнэ.

Хүрээлэн буй орчинд учруулсан хохирлыг сайн дураараа төлөх: Хүрээлэн буй орчинд учруулсан хохирлын хэмжээг нөхөн сэргээх бодит зардлаар тооцох ба үүнд алдагдсан ашгийн алдагдлыг багтааж тооцно. Түүнчлэн нөхөн сэргээсэн ижил төслийн нөхөн төлбөрийн хэмжээтэй адил хэмжээгээр төлж болно. Харин ижил төсөл байхгүй бол нөхөн төлбөрийг Байгалийн нөөц, экологийн яамнаас баталсан “Хүрээлэн буй орчныг хамгаалах объект болох хөрсөнд учирсан хохирлын хэмжээг тооцох аргачлал”¹⁹ болон “Усны тухай хууль тогтоомж зөрчсөний улмаас усан санд учирсан хохирлын хэмжээг тооцох аргачлал”²⁰-ын дагуу тооцно.

Шүүх (арбитр)-ийн шийдвэрээр хүрээлэн буй орчинд учруулсан хохирлыг төлөх: Шүүх (арбитр)-ийн шийдвэрийг үндэслэн хариуцагч нь хүрээлэн буй орчныг хамгаалах тухай хууль тогтоомж зөрчсөний улмаас хүрээлэн буй орчинд учруулсан хохирлыг өөрийн хөрөнгөөр барагдуулна.

Төсвийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт зааснаар хүрээлэн буй орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх нэхэмжлэлийг хохирол учруулсан орон нутаг, хот болон холбооны чанартай хот (Москва, Санкт-Петербург, Севастополь)-ын төсөвт бүрэн шилжүүлэхээр заасан байна. Гэсэн ч одоогийн байдлаар шүүх (арбитр)-ийн шийдвэрээр нэхэмжлэлийн дүнг холбооны төсөв, эсхүл ОХУ-ын субъектүүдийн төсөвт шилжүүлж байна. Үүний нэг жишээ бол 2016 онд Ханты-Мансийск автономит

¹⁵ Москва и регионы делят налоговые доходы от нефти и газа. Галина Курляндская (Директор Центра фискальной политики). 29.10.2016. <http://pressmia.ru/authors/kurlyandskaya/>

¹⁶ Учет интересов сырьевых регионов при налогообложении нефтяной промышленности. А.Н.Токарев (доктор экономических наук). ФГНУ «Институт экономики и организации промышленного производства» СО РАН (Новосибирск). Финансы и Банки. 2016. <https://elibrary.ru>

¹⁷ Как учесть интересы нефтяных регионов? А.Н.Токарев (доктор экономических наук), Институт экономики и организации промышленного производства СО РАН, Новосибирск. 2015. <https://elibrary.ru>

¹⁸ Федеральный закон от 10.01.2002 №7-ФЗ “Об охране окружающей среды”.

¹⁹ Приказ Минприроды от 8 июля 2010 года № 238 “Об утверждении Методики исчисления размера вреда, причиненного почвам как объекту охраны окружающей среды (с изменениями на 25 апреля 2014 года). www.garant.ru

²⁰ Приказ Минприроды России от 13 апреля 2009 г. № 87 “Об утверждении Методики исчисления размера вреда, причиненного водным объектам вследствие нарушения водного законодательства” (с изменениями и дополнениями). <http://base.garant.ru>

мужийн хүрээлэн буй орчны хяналтын байгууллага “РН-Юганскнефтегаз” ХХК-д гаргасан газрын тосны алдагдлын улмаас байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх нэхэмжлэлийг давж заалдах шатны арбитрын шүүхийн шийдвэрээр 3144960 рублийг холбооны төсвийн орлого болгосон байна.²¹

2. АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС²²

Сүүлийн жилүүдэд АНУ-д газрын тос болон байгалийн хийн олборлолт нэлээд өссөн бөгөөд энэ нь олборлолтын үйл ажиллагаа явуулж буй муж болон орон нутагт ихээхэн нөлөө үзүүлж байна.

Энэхүү судалгаанд АНУ-ын газрын тос болон байгалийн хийн олборлолтоор тэргүүлдэг 16 мужийг авч үзсэн. Үүнд: Аляск, Арканзас, Калифорни, Колорадо, Канзас, Луйзиана, Монтана, Умард Дакота, Нью Мексико, Окойя, Оклахома, Пенсильвани, Техас, Юта, Баруун Виржини, Вайоминг орно. Эдгээр мужууд 2013 оны санхүүгийн жилд АНУ-ын газрын тос болон байгалийн хийн олборлолтын дийлэнхийг бүрдүүлсэн байна.

АНУ-ын муж болон орон нутгийн захиргаа нь газрын тос болон байгалийн хийгээс олох орлогыг янз бүрийн хэлбэрээр бүрдүүлдэг. Энд голлох 4 эх үүсвэрийн хувьд авч үзье²³. Үүнд:

1. Газрын тос болон байгалийн хийн олборлолтоос бий болсон бүтээгдэхүүний өртөг, эсхүл хэмжээнд ногдуулсан **мужийн татварын орлого (олборлолтын татвар)**;
2. Тухайн орон нутгийн газрын тос болон байгалийн хийн олборлолтын үйл ажиллагаанд хамааралтай **хөрөнгийн татварын орлого**;
3. Мужийн өмчит нутаг дэвсгэрт хамаарах газрын тос болон байгалийн хийн орд газраас авах **газар ашигласны төлбөрийн орлого**;
4. Холбооны өмчит нутаг дэвсгэрт хамаарах газрын тос болон байгалийн хийн орд газраас авах **газар ашигласны төлбөрийн орлого** зэрэг орно.

АНУ-д орон нутагт ногдох газрын тос болон байгалийн хийн олборлолтоос олох орлогыг хэрхэн хуваарилах талаар авч үзье.


Орон нутагт орлогыг татвар ногдуулах замаар **шууд**, эсхүл мужийн төсвөөс хуваарилалт хийх замаар **шууд бусаар** бүрдүүлнэ. Газрын тос болон байгалийн хийн орлогыг хэрхэх талаарх бодлого нь нийт зарцуулалт болон сургуулийн дүүрэг (school district), муниципалитет (municipalities), тойрог (counties), бусад орон нутгийн нэгжүүдэд хэрхэн хуваарилах хүрээнд харилцан адилгүй байна. Мөн түүнчлэн зарим мужууд нэлээд хэмжээний хөрөнгийг төсөл шалгаруулан санхүүжилт хийх замаар хуваарилдаг. Доорх зураг нь орон нутагт хуваарилагдах орлогын бүтцийг харуулж байна.

²¹ Постановление Восьмого арбитражного апелляционного суда от 11.02.2016 по делу No А75-4973/2015. Эх сурвалж: О практике деятельности органов прокуратуры по обращению в суд с исками о компенсации вреда, причиненного окружающей среде. Исламова Эльнара Рафисовна (Кандидат юридических наук), Дицевич Ярослава Борисовна (Кандидат юридических наук). Matters of Russian and International Law. 2017, Vol. 7, Is. 2B. <http://publishing-vak.ru/file/archive-law-2017-2b/2-ditsevich.pdf>

²² US State and Local Oil and Gas Revenues. Daniel Raimi and Richard G. Newel. Resource for the future. November 2016. P.13-16. <http://www.rff.org/files/document/file/RFF-DP-16-50.pdf>

²³ US State and Local Oil and Gas Revenues. Daniel Raimi and Richard G. Newel. Resource for the future. November 2016. P.3. <http://www.rff.org/files/document/file/RFF-DP-16-50.pdf>

Зураг 2.



Орлогын бүтцийн дундаж үзүүлэлтийг авч үзвэл орон нутгийн сургуулиудын (Local schools) санхүүжилт хамгийн өндөр буюу газрын тос болон байгалийн хийн олборлолтоос олох орлогын ойролцоогоор 2.5 хувийг эзэлж байна. Энэ нь мужийн газар ашигласны төлбөрийн орлогоос боловсролын санд хуваарилсан орлого болон орон нутгийн хөрөнгийн татварын орлогоос бүрдэнэ. Ихэнх баруун бүсийн мужууд нь Нэгдсэн улсын баруун зүгт хийсэн өргөжилтийн эрин үед Холбооны Засгийн газраас газар эзэмшүүлэх хэлбэрээр байгуулсан боловсролын санд газар ашигласны төлбөрийн орлогыг хуваарилдаг. Колорадо, Оклахома, Нью-Мексико, Техас, Ваойминг мужийн сургуулиуд хамгийн их хувь хэмжээгээр (4-7 хувь) санхүүжилт хүртдэг бол Луйзиана, Окойя, Пенсильвани мужийн сургуулиуд багахан хэмжээний шууд санхүүжилтийг хүртдэг. Гэхдээ энэ нь эдгээр мужийн сургуулиудийн санхүүжилт хангалтгүй гэсэн үг биш юм. Муж бүр сургуулиудын үйл ажиллагааг төрөл бүрийн эх үүсвэрээс санхүүжүүлдэг тул эдгээр мужууд газрын тос болон байгалийн хийгээс хамааралгүй бусад эх үүсвэрийг сургуулиудын санхүүжилтэд ашигладаг.

Тойргийн (county) захиргаануудаас Аляск, Колорода, Канзас, Монтана, Юта мужийн тойргууд (county) хамгийн их хэмжээний орлогын хувийг (1.5–2 хувь) хүртдэг бол Арканзас, Калифорни, Нью-Мексико, Окойя, Пенсильвани, Техас мужийн тойргууд (county) багахан хувийг (0.6 хувиас бага) хүртэж байна. Ихэнх мужийн тойргууд (county) нь орлогынхоо дийлэнх хувийг газрын тос, байгалийн хийн орд газрын өртөг, олборлолтын хэмжээний өртөг, олборлолтын үйл ажиллагаанд хамаарах тоног төхөөрөмжийн өртөгт ногдуулсан татвараар бүрдүүлдэг. Монтана, Умард Дакота, Пенсильванид орон нутаг нь ийм төрлийн татвар ногдуулах боломжгүй тул Монтана, Умард Дакотад ихэнх орлого нь мужийн татвараас бүрдэж, харин Пенсильванид орчны нөлөөний хураамжаас (*impact fee*) орлогоо бүрдүүлдэг.


Сургууль болон тойрогт (county) оногдох орлогын эх үүсвэр харилцан адилгүй байдаг нь дараах 3 хүчин зүйлтэй холбоотой.

1. Муж тус бүрийн орон нутгийн захиргаа нь хөрөнгийн татварыг төрөл бүрийн татварын суурьд ногдуулдаг. Зарим тохиолдолд газрын тос болон байгалийн хийд холбогдолтой хөрөнгөд татвар ногдуулдаггүй тохиолдол ч бий.
2. Орон нутгийн захиргаа нь газрын тос болон байгалийн хийд хамаарах хөрөнгөд татвар ногдуулахдаа төрөл бүрийн татварын хувь хэмжээг хэрэглэдэг.
3. Мужаас сургууль, тойрог (county) зориулж олгодог санхүүжилтийн хуваарилалт харилцан адилгүй байдаг.


Муниципалитет (municipalities) болон тусгай дүүргүүдийн газрын тос болон байгалийн хийн олборлолтоос хүртэх ашгийн хувь нь тойрог (county) болон боловсролын дүүргийн хүртэх хувиас бага байх (ихэнхдээ 0.5 хувиас бага) хандлагатай байна. Муниципалитетуудын (municipalities) газрын тос болон байгалийн хийгээс олох орлого нь голдуу борлуулалтын татварт тулгуурладаг (энэ судалгааны хувьд борлуултын татварыг хамруулаагүй). Мөн муниципалитетын (municipality) хувьд тойрог (county) болон боловсролын дүүргээс ялгаа нь газар нутгийн хувьд жижиг, хүн амын нягтрал өндөр тул газрын тос болон байгалийн хийн олборлолтын үйл ажиллагаа тухайн орон нутгийн хамрах хүрээнд явагдах нь ховор байдаг. Үүнээс шалтгаалж газрын тос болон байгалийн хийн олборлолтын үйл ажиллагаанд ногдуулах татварын болон бусад төлбөр, хураамжийн орлого олох боломж нь бага байна. Муниципалитетад (Municipality) орох ихэнх орлого нь мужийн төсвөөр дамжин ордог бөгөөд ихэнх тохиолдолд тухайн орон нутагт хамрагдах олборлолтын хэмжээнээс хамаарч байдаг (зарим тохиолдолд өөр байж болно). Муниципалитетад (municipality) оногдох орлогын хувь хэмжээ хамгийн өндөр мужууд нь Канзас, Умард Дакота, Пенсильвани, Вайоминг байна (0.5-0.8 хувь).

Колорадо, Умард Дакота, Пенсильвани, Юта мужууд нь төсөл шалгаруулах хэлбэрээр орон нутгуудад мужийн санхүүжилт хуваарилах бодлогыг өргөн ашигладаг. Ингэхдээ зөвхөн сайн төсөл боловсруулж хэрэгжүүлэх бололцоотой орон нутагт төдийгүй бас зайлшгүй шаардлагатай орон нутагт санхүүжилт олгоход анхаарах нь чухал юм.

Зураг 2-т газрын тос болон байгалийн хийн олборлолтоос орон нутагт орох орлогын эх үүсвэр болон түүний зарцуулалтын задаргааг харуулав.



Зураг 3



Дээрх задаргаанд газрын тос болон байгалийн хийн олборлолттой холбогдолгүй мужийн төсвөөс орох санхүүжилтийг тусгаагүй болно. Жишээ нь зарим муж ашигт малтмал олборлосны татвар, газар ашигласны төлбөр болон аж ахуйн нэгжийн ашгийн албан татвар авах замаар газрын тос, байгалийн хийн олборлолтын үйл ажиллагаанаас их хэмжээний орлогыг төсөвт төвлөрүүлж, түүнийг төсвийн хүрээний санхүүжилтээр орон нутагт хуваарилдаг. Ингэж орон нутагт хуваарилсан санхүүжилтийг дээр дурдсан графикт оруулаагүй болно.

Орон нутаг нь өөрийн мэдэл дэх нийтийн эзэмшлийн газрууд болох цэцэрлэгт хүрээлэн, нисэх буудал болон бусад газарт явагдах газрын тос болон байгалийн хийн олборлолтын үйл ажиллагаанаас газар ашигласны төлбөрийг мөн авч болно. Гэхдээ энэ судалгаанд ийм төрлийн газар ашигласны төлбөрийн талаарх мужийн хэмжээний тоо баримтыг тусгаагүй. Түүнээс гадна газрын тос болон байгалийн хийн олборлолтын үйл ажиллагаанаас шууд бусаар орох орлого болох борлуулалтын татварын өөрчлөлт, мөн цөөн тохиолдолд орон нутгаас ногдуулдаг орлогын албан татварыг оруулаагүй болно.

АНУ-д дунджаар газрын тос болон байгалийн хийн олборлолтоос олох орлогын 10 орчим хувь нь орон нутагт оногдож байгаа бөгөөд хамгийн багадаа 1 хувь, хамгийн ихдээ 40 хүртэл хувь байна. Гэхдээ газрын тос болон байгалийн хийн олборлолтоос олох орлогын хувь нь бага байлаа гээд мужууд газрын тос болон байгалийн хийн салбараас авах татвараа нэмэх ёстой, эсхүл орлогын хувь нь өндөр гээд тухайн салбарын зохицуулалт үр дүнтэй гэж ойлгож болохгүй. Энэ нь муж болгон төсвийн бодлогоо тухайн мужийн эдийн засаг, нийгмийн байдал, төсвийн нөхцөлтэй уялдуулан боловсруулдагтай холбоотой.

Ерөнхийдөө хамгийн их орлогын эх үүсвэрийг ашигт малтмал олборлосны татвар ба түүнтэй адилтгах орлого, дараа нь мужаас ногдуулсан газар ашигласны төлбөр, гуравдугаарт орон нутгаас газрын тос болон байгалийн хийн олборлолтод ашиглагдаж буй хөрөнгөд ногдуулсан татвар, дөрөвдүгээрт Холбооны Засгийн газраас ногдуулсан газар ашигласны төлбөр бүрдүүлдэг. Мужуудын олсон орлогын дийлэнх хэсэг нь мужийн төсвийн урсгал зардал ба боловсролын зардлыг санхүүжүүлэхэд зарцуулагдаж, үлдсэн хэсэг нь орон нутагт хуваарилагдаж байна. Зарим мужууд газрын тос болон байгалийн хийн олборлолтоос олох орлогын тодорхой хэсгийг

ирээдүйд гарах төсвийн зардал болон боловсролын зардлыг санхүүжүүлэхэд зориулж Баялгийн санд хуваарилдаг. Гэхдээ орлого бүрдүүлэх механизм болон түүнийг хуваарилах бодлого нь муж бүрийн хувьд харилцан адилгүй төдийгүй орлогын бүтэц, хуваарилалтын хувь хэмжээ хүртэл ялгаатай.

Зарим мужууд, ялангуяа Аляск мужийн бодлого нь газрын тос болон байгалийн хийн олборлолтоос орох орлогыг савалгаа ихтэй болгож байна. Ийм бодлого нь газрын тос болон байгалийн хийн үнэ өндөр байх үед их хэмжээний гэнэтийн ашгийн орлого оруулах боловч үнэ унах үед төсвийн хүндрэл үүсгэх магадлалтай. Баялгийн сан нь төсөвт орох орлогыг илүү тогтвортой болгодог боловч урт хугацаанд үргэлжилсэн үнийн уналт, эсхүл олборлолтын хэмжээ буурахад хангалттай төсвийн хамгаалалт болж чадахгүй байж болох юм.

3. ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ НИГЕР УЛС²⁴

Нигер бол Африкийн хамгийн том газрын тос экспортлогч орон бөгөөд өдөрт 2.2 сая баррелийг олборлодог байна. 2011 онд газрын тосны орлого 50.3 тэрбум ам.доллар байсан нь тус улсын нийт орлогын 70 орчим хувийг эзэлж байна. Хэдийгээр хагас зуун жилийн туршид газрын тос олборлож байгаа ч Нигер Улсын ядуурлын түвшин өндөр хэвээр байна.

Нигер нь холбооны улс бөгөөд засаг захиргааны хувьд 36 муж, холбооны нийслэл, 774 орон нутгийн нэгжээс бүрдэнэ. Холбооны Засгийн газар нь муж улсын болон орон нутгийн засгийн газруудад сар бүр холбооны данснаас орлого шилжүүлэх ба шилжүүлгийн 80 орчим хувь газрын тос, байгалийн хийн орлогоос бүрдэж байна.


1970-аад оноос тус улсын өмнөд хэсгийн 10 муж нь газрын тосноос олох орлогын хамгийн том эх үүсвэр болсон бөгөөд тэдгээрийг Дельта Нигер хэмээн нэрлэдэг. Эдгээрээс Аква Ибом, Байелса, Дельта, Риверс, Имо болон Одо зэрэг муж улсууд нь байгалийн баялгийн орлогоос ихээхэн хамааралтай байдаг. Ялангуяа Аква Ибом, Байелса нь газрын тосны орлогоос хамгийн их хамааралтай бөгөөд 2007-2011 онуудад энэ хоёр муж улсын газрын тосны орлого нь жилийн нийт орлогын 80-аас дээш хувийг бүрдүүлж байсан.

Ихэвчлэн үндэстний цөөнх амьдардаг Дельта Нигер болон төв Засгийн газар хороонд олон жилийн турш газрын тосны орлогын хуваарилалтын талаар ширүүн маргаан өрнөсөн. Тус бүс нутгийнхан газрын тосны орлогын хуваарилалтыг нэмэгдүүлэх талаар төв Засгийн газраас шаардаж байсан. Үүний үр дүнд газрын тосны олборлолтоос хамаарч сар бүр орлогын 13 хувиас багагүй хувийг муж улсуудад хуваарилах болсон.

1999 онд Орлогын зохицуулалт, хуваарилалт, санхүүгийн хороо (*RMAFC - Revenue Mobilization, Allocation and Fiscal Commission*)-ны саналаар Үндэсний Ассамблей байгалийн баялгийн орлогын хуваарилалтын томъёолол баталсан. Уг томъёоллын дагуу холбооны данснаас Холбооны Засгийн газарт 52.68 хувийг, үлдсэн хувийг нь батлагдсан томъёоллын дагуу муж улсын болон орон нутгийн засгийн газруудад тус тус хуваарилна.

²⁴ Natural Resource Revenue Sharing. National Resource Governance Institute, UNDP. September 2016. P.95-98.
<https://resourcegovernance.org>

Зураг 4. Нигер Улсын байгалийн баялгийн орлогын хуваарилалт



Тайлбар:

- (1) Гаалийн болон онцгой албан татварын орлогын 93 хувийг холбооны дансанд, үлдсэн 7 хувийг Нигерийн Гаалийн алба руу тус тус шилжүүлнэ.
- (2) Аж ахуйн нэгжийн орлогын татварын орлогын 96 хувийг Холбооны дансанд, үлдсэн 4 хувийг Холбооны дотоод орлогын алба (Federal Inland Revenue Service, FIRS) руу тус тус шилжүүлнэ.
- (3) Нэмэгдсэн өртгийн албан татварын орлогын 96 хувийг Нэмэгдсэн өртгийн албан татварын санд, үлдсэн 4 хувийг Холбооны дотоод орлогын алба руу тус тус шилжүүлнэ.

Орлогыг муж улс, орон нутгийн засгийн газруудад хуваарилахдаа эдийн засаг, хүн ам зүйн дараах 10 үзүүлэлтэд тулгуурлана. Үүнд:

- 1) 45.2 хувийг нь бүх муж улсуудад тэнцүү хэмжээгээр хуваарилна; мөн

- 2) 25.6 хувийг нь хүн ам (population);
- 3) 8.3 хувийг нь дотоод орлого (internal revenue);
- 4) 5.3 хувийг нь газрын масс (land mass);
- 5) 5.4 хувийг нь газар нутаг (terrain);
- 6) 1.5 хувийг нь хүн амын нягтрал (population density);
- 7) 1.2 хувийг нь хөдөө орон нутгийн зам, дотоодын усан зам (rural roads and inland waterways);
- 8) 1.5 хувийг нь ундны ус (potable water);
- 9) 3 хувийг нь эрүүл мэндийн үзүүлэлтүүд (health indicators);
- 10) 3 хувийг нь боловсролын үзүүлэлтүүд (education indicators) зэрэгт үндэслэж хуваарилна.

Байгалийн баялгаас орж ирэх татваруудын орлого тодорхой данс руу хуваарилагдана. (Зураг 4-ийн “Тайлбар” хэсгээс дэлгэрүүлж үзнэ үү.) Тэдгээрийн нэг болох нэмэгдсэн өртгийн албан татварын орлогын 96 хувь нь Нэмэгдсэн өртгийн албан татварын санд орно. Цаашлаад тус сангаас дахин хуваарилагдах бөгөөд ингэхдээ 35 хувийг орон нутгийн засгийн газруудад, 50 хувийг муж улсын засгийн газруудад, 15 хувийг Холбооны нэгдсэн төсвийн орлогод тус тус шилжүүлнэ.

4. БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛС²⁵

БНХАУ-ын эрчим хүчний салбар нь тус улсын эдийн засгийн өсөлтөд чухал үүрэг гүйцэтгэдэг. 2014 онд БНХАУ нь дэлхийн эрчим хүчний 19.1 хувийг үйлдвэрлэсэн. Тодруулбал, тус улс нь дэлхийн хамгийн том нүүрсний үйлдвэрлэгч орон, мөн газрын тосны 4 дэх, байгалийн хийн 6 дахь том үйлдвэрлэгч юм.

Газрын тос, байгалийн хийн томоохон талбайнууд Хятад орны гүнд орших бөгөөд тэдгээрийн ихэнх хэсэг нь тус улсын баруун болон хойд төв хэсэгт байрлах найман голын сав газарт багтдаг.

БНХАУ нь хүн амын тоогоороо дэлхийд нэгт, газар нутгийн хэмжээгээрээ гуравт ордог бөгөөд төрийн байгууламжийн хувьд нэгдмэл тогтолцоотой улс юм. Засаг захиргаа нутаг дэвсгэрийн удирдлагын хувьд аймаг (болон өөртөө засаг орон), тойрог, муж, хошуу, тосгон зэрэг таван түвшинд хуваагдана.

Одоогийн байдлаар тус улсад (*China National Petroleum Corporation, CNPC*), Хятадын газрын тос, химийн корпорац (*China Petroleum and Chemical Corporation, Sinopec*), Хятадын үндэсний хилийн чанад дахь газрын тосны корпорац (*China National Offshore Oil Corporation, CNOOC*) зэрэг үндэсний 3 том компани газрын тос олборлох, мөн аймгийн өмчит Шаньси янчан газрын тосны корпорац (*Shanxi Yanchang Petroleum Corporation*) нь газрын тос, байгалийн хий олборлох тусгай зөвшөөрөлтэй.

Хятадын үндэсний газрын тосны компани (*CNPC*) нь Хятадын хойд бүс нутагт, Хятадын газрын тос, химийн корпорац (*Sinopec*) нь өмнөд бүс нутагт үйл ажиллагаагаа явуулдаг бол Хятадын үндэсний хилийн чанад дахь газрын тосны корпорац (*CNOOC*) нь далайн нефтийн нөөцийг судалдаг байна.

²⁵ Natural Resource Revenue Sharing. National Resource Governance Institute, UNDP. September 2016. P.81-84. <https://resourcegovernance.org>

Газрын тос, байгалийн хийн олборлолтоос орох орлогын гол эх үүсвэрүүд нь роялти буюу ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, байгалийн баялгийн нөхөн төлбөр, байгаль орчинтой холбоотой газрын тосны тусгай орлого болон заавал төлөх төлбөр, бусад татварууд байна. Түүнчлэн төрийн өмчит аж ахуйн нэгжүүд Засгийн газарт ногдол ашгаа төлдөг.

1994 оноос БНХАУ нь орон нутгийн татварын тогтолцоонд суурилсан. Энэ нь:

(1) төв болон орон нутгийн засгийн газрууд өөрсдөө төсвөө боловсруулж, захиргааны асуудлуудаа бие даан удирдана;

(2) төв болон орон нутгийн засгийн газар хооронд татвар хуваарилах ба татваруудыг төв Засгийн газрын, орон нутгийн, хуваалцах татвар гэж ангилна;

(3) татвар бүрдүүлэлтийг удирдан зохион байгуулах татварын төв алба болон орон нутгийн татварын удирдлага бий болсон;

(4) төв Засгийн газар нь жил бүр татварын орлогын тодорхой хувийг мужийн засаг захиргаанд шилжүүлнэ;

(5) жил бүр төв болон бүс нутгийн засгийн газар хооронд шилжүүлэг хийгдэнэ.

НӨАТ нь төв Засгийн газрын төсвийн орлогын хамгийн том эх үүсвэр болдог. Харин бизнесийн татварууд (*business taxes*) нь аймгийн засгийн газруудын төсвийн орлогын чухал эх үүсвэр байдаг. Олборлох үйлдвэрлэлийн орлогын өөр нэг урсгал бол роялтитай адил байгалийн баялгийн татвар юм. Газрын тос, байгалийн хийд ногдуулах байгалийн баялгийн татварыг орлогын үндсэн дээр тооцдог бол бусад ашигт малтмалд ногдуулах байгалийн баялгийн татварыг үйлдвэрлэлийн хэмжээгээр тооцдог байна. 2016 оны 10 дугаар сарын байдлаар газрын тос, байгалийн хийд ногдуулах байгалийн баялгийн татварын хувь хэмжээ 6 хувьтай байсан.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар нь БНХАУ-д НӨАТ-ын дараа төсвийн орлогын хоёр дахь гол эх үүсвэр юм. Дээр дурдсан газрын тос, байгалийн хийн 2 компанийн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогыг төв Засгийн газар авна. Харин бусад компанийн (уул уурхайн компанийг оролцуулаад) аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогын 60 хувийг төв Засгийн газарт, 40 хувийг орон нутгийн засгийн газарт тус тус хуваарилна.

Байгалийн баялгийн нөөцийн нөхөн төлбөрийн удирдлагын тухай журмын дагуу 1997 оноос төв Засгийн газар нь байгалийн баялгийн нөөцийн нөхөн төлбөрийг ногдуулж эхэлсэн. Журмын дагуу энэ нөхөн төлбөрийн орлогыг төв болон орон нутгийн засгийн газруудад тэнцүү хуваарилна, харин Төвдийн болон Өвөр Монгол зэрэг 5 өөртөө засах орны засгийн газарт орлогын 60 хувь, төв Засгийн газарт 40 хувийг тус тус хуваарилна.

2006 оноос эхлэн газрын тосны орлогын тусгай хураамжууд (*Special Petroleum Proceeds*)-ыг ногдуулах болсон. Эдгээр хураамж нь дэлхийн газрын тосны үнийн өсөлтийн ашгаас авах бөгөөд энэ нь гэнэтийн ашгийн татвартай төстэй. Үүний орлого нь олон улсын түүхийн нефтийн үнээс шалтгаалж байгаа учраас байнга хэлбэлзэж байдаг.

Төв Засгийн газарт хуваарилсан байгалийн баялгийн орлогын дийлэнх хэсгийг улсын төсөвт төвлөрүүлж, төсвийн бусад орлогын хамт дахин хуваарилна. Гэсэн ч төв Засгийн газарт роялти болон бусад татвар, хураамжаас төвлөрсөн орлогын тодорхой

хувийг олборлолт явагдаж байгаа бүс нутагт голдуу геологийн хайгуулын ажилд зарцуулдаг.

5. БҮГД НАЙРАМДАХ ИНДОНЕЗ УЛС²⁶

Индонез Улс нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн удирдлагын хувьд үндэсний, мужийн, орон нутгийн гэсэн гурван түвшинтэй. Тус улсын Засгийн газраас газрын тосны орлогын 3.1 хувийг олборлолт явагдаж буй мужид нь, 6.2 хувийг тус мужийн бүх орон нутгуудад нь тус тус хуваарилдаг байна.

Харин байгалийн хийн орлогоос олборлолт явагдаж буй мужид нь 6.1 хувийг, орон нутгуудад нь 12.2 хувийг тус тус хуваарилна.

Индонез Улсын Засгийн газар нь Ачех мужтай тусгай гэрээтэй. 2002-2011 онд Ачех мужид газрын тос, байгалийн хийн орлогын 70 хувийг олгож байсан бөгөөд тогтоосон хугацаа дуусахад 50 хувь болгож буулгажээ. Засгийн газар нь ийм гэрээг Папуа болон Баруун Папуа мужуудтай 2002 оноос 2027 оныг хүртэл байгуулжээ.

Байгалийн баялгийн орлого хуваарилах энэ тогтолцоо дараах асуудлыг дагуулсан байна.

Нэгт, газрын тос, байгалийн хийн нөөцтэй зарим бүс нутгууд гэнэтийн их хэмжээний орлоготой болсон, тухайлбал, 2014 онд Риану 1.2 тэрбум ам.долларын (хүн ам 6.4 сая), Хойд Калимантан 280 сая ам.долларын (хүн ам 628 мянга) орлого хуримтлуулжээ.

Гэтэл эдгээр бүс нутгууд нь их хэмжээний орлоготой байж байгаад дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ буурах, эсхүл түүхий эдийн нөөц шавхагдаж дуусах үед гэнэтийн санхүүгийн уналтад ордог. Түүнчлэн эдгээр бүс нутгийн эрх баригчид гэнэтийн их хэмжээний орлогыг удирдах чадвар байдаггүй, мөн тухайн бүс нутгийн орон байрны түрээс, барилга угсралт, үйлчилгээ, засгийн газрын ажиллагсдын урамшуулал, эсхүл тэдний мөрөөдлийн төсөл зэргээс хамаарч төсвийн зардал өсөх нь заримдаа бүс нутгийг инфляцын уналтад хүргэдэг байна.

Хоёрт, Индонез Улсад орлогын хуваарилалтын тогтолцоо нь 2004 оноос хойш тогтвортой байгаа боловч олборлолт явагддаггүй орон нутагт байгалийн баялгийн орлогоос хуваарилдаггүй сул талтай.

УИИМН
СУДАЛГААНЫ САН

²⁶ Natural Resource Revenue Sharing. National Resource Governance Institute, UNDP. September 2016. P.41. <https://resourcegovernance.org>

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Natural Resource Revenue Sharing. National Resource Governance Institute, UNDP. September 2016. <https://resourcegovernance.org>
- US State and Local Oil and Gas Revenues. Daniel Raimi and Richard G. Newel. Resource for the future. November 2016. www.rff.org/files/document/file/RFF-DP-16-50.pdf
- “Бюджетный кодекс Российской Федерации” от 31.07.1998 N 145-ФЗ (ред. от 03.08.2018).
- Федеральный закон от 10.01.2002 No7-ФЗ “Об охране окружающей среды”.
- Налогообложение нефтяной отрасли: введение НФР. Министерство Энергетики РФ. Москва. 2015. www.komitet-bn.km.duma.gov.ru
- OPEC Annual Statistical Bulletin – 2017. 52nd edition. 6 дахь тал. www.opec.org
- Государственная поддержка добычи нефти и газа в России: какой ценой? Исследование Всемирного фонда дикой природы (WWF) и Глобальной инициативы по субсидиям Международного института устойчивого развития (IISD). Герасимчук И.В. Москва-Женева: WWF России и IISD, 2012. www.iisd.org
- Учет интересов сырьевых регионов при налогообложении нефтяной промышленности. А.Н.Токарев (доктор экономических наук). ФГНУ «Институт экономики и организации промышленного производства» СО РАН (Новосибирск). Финансы и Банки. 2016. <https://elibrary.ru>
- Как учесть интересы нефтяных регионов? А.Н.Токарев (доктор экономических наук), Институт экономики и организации промышленного производства СО РАН, Новосибирск. 2015. <https://elibrary.ru>
- Москва и регионы делят налоговые доходы от нефти и газа. Галина Курляндская (Директор Центра фискальной политики). 29.10.2016. <http://pressmia.ru>
- Постановление Восьмого арбитражного апелляционного суда от 11.02.2016 по делу No А75-4973/2015. Эх сурвалж: О практике деятельности органов прокуратуры по обращению в суд с исками о компенсации вреда, причиненного окружающей среде. Исламова Эльнара Рафисовна (Кандидат юридических наук), Дицевич Ярослава Борисовна (Кандидат юридических наук). Matters of Russian and International Law. 2017, Vol. 7, Is. 2B. <http://publishing-vak.ru>

ДАЛАЙД ГАРЦТАЙ БОЛОН ГАРЦГҮЙ ОРНУУДЫН УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН

(Харьцуулсан судалгаа)

*Д.Халиун, О.Нарантуяа,
Ц.Элбэгзаяа*

АГУУЛГА

УДИРТГАЛ

1. Далайд гарцгүй, томоохон нууруудтай орнуудын усан замын тээврийн аюулгүй байдлыг зохицуулж буй эрх зүйн орчин
 - Бүгд Найрамдах Казахстан Улс
 - Швейцарын Холбооны Улс
2. Далайд гарцтай, томоохон нууруудтай орнуудын усан замын тээврийн аюулгүй байдлыг зохицуулж буй эрх зүйн орчин
 - Оросын Холбооны Улс
 - Бүгд Найрамдах Финланд Улс
3. Виктория нуурын тээврийн аюулгүй байдлыг зохицуулж буй хууль эрх зүйн орчин

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

УДИРТГАЛ

Судалгааны хамрах хүрээ: Энэхүү судалгаанд далайд гарцтай болон гарцгүй, томоохон нууруудтай орнуудын усан замын тээврийн аюулгүй байдлыг зохицуулж буй эрх зүйн орчныг судалсан болно. Судалгаанд хамрагдах улс орнуудын сонголтыг хийхдээ захиалагчаас ирүүлсэн хүсэлтийн дагуу Ром-Германы (эх газрын) эрх зүйн тогтолцоотой, томоохон нууруудтай, нуурын тээвэр сайн хөгжсөн, газарзүйн хувьд далайд гарцтай болон гарцгүй зэрэг нөхцөлүүдийг шалгуур болгон авч үзсэн бөгөөд эдгээр орнуудын усан замын тээврийн аюулгүй байдлын эрх зүйн орчныг судалсан болно.

Судалгааны нэгдүгээр хэсэгт, далайд гарцгүй, томоохон нууруудтай улсууд болох БНКаз.У болон Швейцарын дотоодын усан замын тээврийн аюулгүй байдлыг зохицуулж буй эрх зүйн орчин, хоёрдугаар хэсэгт, далайд гарцтай, томоохон нууруудтай улсууд болох ОХУ болон Финланд улсын усан замын тээврийн аюулгүй байдлыг зохицуулж буй эрх зүйн орчин, гуравдугаар хэсэгт, Африк тивийн хамгийн том, дэлхийд хоёрдугаарт ордог цэнгэг уст нуур болох Кени, Танзани, Уганда Улсын дунд оршдог Виктория нуурын тээврийн аюулгүй байдлыг зохицуулж буй хууль эрх зүйн орчныг тус тус судалсан болно.

Судалгааны үр дүнгийн тойм: Судалгаанд хамрагдсан орнуудаас БНКаз.У, ОХУ, Швейцарт усан замын тээврийн аюулгүй байдлыг “Дотоодын усан замын тээврийн тухай” хууль тогтоомжийн хүрээнд зохицуулж байна. БНКаз.У, ОХУ-ын хуульд тээврийн аюулгүй байдалтай холбоотой асуудлыг зохицуулсан тусгайлсан бүлэг байхаас гадна ОХУ-д “Тээврийн аюулгүй байдлын тухай” хуулиар тээврийн аюулгүй байдлын ерөнхий хүрээг тогтоож, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн үйл ажиллагаа, арга хэмжээтэй холбоотой асуудлыг зохицуулсан байна. Харин Финланд улсын хувьд усан замын тээврийн аюулгүй байдлыг 2009 онд батлагдсан “Хөлөг онгоцны аюулгүй ажиллагаа, техникийн аюулгүй байдлын тухай хууль” гэсэнбие даасан хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд зохицуулж байна.

Бүгд Найрамдах Казахстан Улсын хувьд далайд гарцгүй хамгийн том улс төдийгүй дэлхийн хамгийн том нуур болох Каспийн тэнгистэй хиллэдгээс гадна Балхаш, Алаколь зэрэг томоохон нууруудтай. Усан тээвэр, үүний дотор дотоодын усан замын болон далайн тээвэр нь тус улсын эдийн засагт стратегийн чухал ач холбогдолтой бөгөөд Казахстанар дамжих ачаа тээврийн 90 гаруй хувийг далайгаар тээвэрлэдэг байна.

Казахстан Улсын Хөрөнгө оруулалт, хөгжлийн яамны Тээврийн хорооны Усан замын тээврийн хэлтэс болон Усан замын тээврийн хяналтын хэлтэс нь усан замын тээвэртэй холбоотой асуудлыг хариуцан ажилладаг. 2014 онд Тээврийн хорооны дэргэд Каспийн тэнгист хөлөг онгоцны аюулгүй ажиллагааг хангах үүрэг бүхий Актау ба Баутино боомтын далайн захиргааг байгуулсан.

Дотоодын усан замын тээврийн аюулгүй байдлыг 2004 онд батлагдсан “Дотоодын усан тээврийн тухай хууль”-иар зохицуулах ба хөлөг онгоцны үйлдвэрлэл (барих, завсар үйлчилгээ) болон дотоодын усан замын хөлөг онгоцны аюулгүй ажиллагааны шаардлагууд, тээврийн аюулгүй байдлыг хангах субъект, усан зам болон боомтод аюулгүй байдлыг хангахтай холбоотой хяналт, шалгалтын хэлбэр, журам

зэргийг энэ хуулиар нарийвчлан зохицуулсан байна.

Швейцарын Холбооны Улсын хувьд далайд гарцгүй улс хэдий ч усан замын тээвэр сайн хөгжсөн, далайн тээврийн эртний уламжлалтайгаас гадна далайд гарцгүй орнуудаас хамгийн том худалдааны флоттой юм. Тус улсад 1484 нуур байдгаас Боденс, Лаго Маджоре, Женевын нуурууд нь усан тээврийн ачааллаар дэлхийд тэргүүлдэг байна. Эдгээр нууруудад гол төлөв амралт зугаалга, аялал жуулчлал зонхилдог бол Базель дахь Рейн мөрний боомт нь дэлхийн хамгийн том боомт болох Нидерландын Роттердамтай холбогдон, Швейцарын экспорт, импортын бараа бүтээгдэхүүний дийлэнхийг тээвэрлэдэг байна.

1975 онд батлагдсан “Дотоодын усан замын тээврийн тухай хууль” нь дотоодын усан замын тээврийг зохицуулж буй гол хууль юм. Тус хуульд заасны дагуу усан замын тээврийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой дүрэм, журам батлах, ерөнхий хяналт тавих эрх бүхий субъект нь Холбооны Зөвлөл буюу Засгийн газар байх ба усан замын тээврийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой зарим эрх үүргээ холбогдох байгууллага, кантон (муж улс)-д шилжүүлж болно гэж заасан байна.

Оросын Холбооны Улсын хувьд Тээврийн аюулгүй байдлыг зохицуулж буй эрх зүйн үндсэн акт нь 2007 онд батлагдсан “Тээврийн аюулгүй байдлын тухай холбооны хууль” бөгөөд тус хуулиар тээврийн аюулгүй байдлын ерөнхий хүрээг тогтоож, тээврийн аюулгүй байдлын үндсэн зарчим, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн үйл ажиллагаа, арга хэмжээг тодорхойлсон байна.

Харин дотоодын усан замын тээврийн асуудлыг “ОХУ-ын дотоодын усан замын тээврийн тухай хууль”-аар зохицуулж буй бөгөөд дотоодын усан замд тээврийн үйл ажиллагаа явуулахтай холбоотойгоор ОХУ-ын дотоодын усан тээврийн байгууллага, ачаа илгээгч, ачаа хүлээн авагч, зорчигч болон бусад хувь хүн болон хуулийн этгээдийн хоорондын харилцаа, эрх, үүрэг, хариуцлагыг тогтоосон байна.

Сүүлийн жилүүдэд бага оврын завь, хөлөг онгоцтой холбоотой осол нэмэгдэх болсонтой холбогдуулан 2018 оны 9 дүгээр сард тус хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан байна. Уг нэмэлт, өөрчлөлт мөрдөгдсөнөөр бага оврын завийг улсын бүртгэлд заавал бүртгүүлдэг болох юм.

Эрхүү мужид 2018 оны зун 200 хүртэл кг жинтэй, 8 кВт/цагийн хүчин чадалтай моторт завь, хөлөг онгоц оролцсон нийт 12 осол гарч, 8 хүн амь насаа алдсан байна. Дээрх ослууд нь гол төлөв тухайн төрлийн завь, хөлөг онгоцны жолооч нар нь завь, хөлөг онгоц байрлуулах дүрэм, хөвөлтийн болон бусад дохио, тэмдэглэгээг мэддэггүйгээс үүдэлтэй байна гэж холбогдох албаныхан дүгнэсэн байна. Нэмэлт, өөрчлөлтөд дээрх төрлийн завь, хөлөг онгоц жолоодоход бага оврын хөлөг онгоц жолоодох эрхийн гэрчилгээ авах, холбогдох бүртгэл, хяналт шалгалтад хамрагдах шаардлагуудыг тусгасан байна.²⁷

Финландын Бүгд Найрамдах Улсын хувьд Финландын усан замын тээврийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн гол хууль бол 2009 онд батлагдсан “Хөлөг онгоцны аюулгүй ажиллагаа, техникийн аюулгүй байдлын тухай хууль” юм. Тус хуулиар хөлөг онгоцны техникийн аюулгүй байдал, даацын тэмдэглэгээ, хөлөг онгоцны

²⁷ <http://snews.ru/news/obyazatelnyu-registraciyu-malomernyh-sudov-v-kodeks-vodnogo-transporta-predlozhila-vvesti-gims>

үзлэг, шалгалт, хөлөг онгоцны багтаамжийн хэмжилт ба хөлөг онгоцны аюулгүй ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулж байна.

ОХУ-ын адилаар Финланд Улс нь мөн завьтай холбоотой хууль дүрмээ чангатгахаар төлөвлөж байгаа ба одоо мөрдөгдөж буй завь, түүний аюулгүй ажиллагаатай холбоотой 18 хууль тогтоомжийг нэгтгэн, шинэ хуулийн төсөл боловсруулах ажил хийгдэж байна. Шинэ хуулиар завины аюулгүй ажиллагаатай холбоотой шаардлагуудыг нэмэгдүүлэхээр төлөвлөж байгаа ба үүнд тээврийн хэрэгсэл (завь) дээр байгаа хүүхдэд аврах хантааз өмсүүлэх шаардлагыг тавих юм. Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжоор хөлөг онгоцон дээр байгаа хүн бүрийн тоогоор аврах хантааз байх ёстой ба заавал өмсөх шаардлага тавигддаггүй байна. Мөн усан дээрх тээврийн хэрэгслийн хурдны хязгаарыг тодорхой болгохоор зорьж байгаа ба холбогдох хуулийн төслийг 2018 онд багтаан Парламентад өргөн мэдүүлэхээр төлөвлөсөн байна.

Дээрхээс гадна завь, хөлөг онгоцонд тавигдах шаардлага, завь хөлөг онгоцны хурд, мөн жолоочийн цусан дахь спиртийн зөвшөөрөгдсөн хэмжээ зэргийг өөрчлөхөөр хэлэлцэж байна.

Хөрш Швед Улсад амралт зугаалгын завь дээрх 15 нас хүрээгүй хүүхдэд аврах хантааз өмсүүлэх шаардлагыг хуульд тусгахаар хэлэлцэж байгаа бол Норвегид 8 метрээс богино завь, хөлөг онгоц дээрх хүн бүр аврах хантааз өмсөх ёстой журам үйлчилдэг байна.²⁸

Виктория нуурын хувьд 2007 онд нуурын усан замын тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангах, сайжруулах зорилгоор Зүүн Африкийн хамтын нийгэмлэгээс Виктория нуурын тээврийн тухай хуулийг баталж, Кени, Танзани, Уганда улсуудын төрийн тэргүүнүүд гарын үсэг зурж баталсан байна.

Тус хууль нь 2009 оны 11 дүгээр сарын 4-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн бөгөөд тус хуулиар нууран дахь зорчигчид, ачаа тээвэрлэлт, судалгаа шинжилгээ, хөлөг онгоцны бүртгэл, зөвшөөрөл, ажилчдад тавигдах шаардлага, зорчигчдын болон ачаа тээвэрлэлтийн аюулгүй байдал зэрэг өргөн хүрээний асуудлыг зохицуулж өгсөн байна.

Тус хуулийн зорилго нь нууран дахь усан замын тээврийн аюулгүй байдал, эрэн хайх, аврах ажиллагаа, гидрографик, цаг агаар, зураг зүй, харилцаа холбоотой холбогдон үүсэх харилцааг зохицуулах, журамлах, хянах болон тээвэрлэлтээс үүдэлтэй нуурын бохирдлоос урьдчилан сэргийлэхэд чиглэгдэж байна. Хуулийн үйлчлэх хүрээнд нуурын дотор, эсхүл боомт, зогсоолд байгаа хөлөг онгоц, нууранд судалгаа шинжилгээ, эсхүл нефтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулахад зориулагдсан барилга байгууламж, түүнийг эзэмшигч этгээд, оролцогч улсуудын загас агнуурын хөлөг онгоцнууд багтаж байгаа бол оролцогч улс орнуудын цагдаа, тэнгисийн цэрэг болон батлан хамгаалах зориулалтын хөлөг онгоцнууд тус хуулийн зохицуулалтад хамаарахгүй.

²⁸ https://yle.fi/uutiset/osasto/news/tougher_boating_rules_planned_for_2018/9702306

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Тээврийн аюулгүй байдал нь нэлээд нарийн төвөгтэй ойлголт бөгөөд тээврийн цогцолборын хэвийн үйл ажиллагаанд учруулах аюулын төрөл зүйлээс хамааран янз бүрээр тодорхойлогдож болдог. Уламжлал ёсоор, байгалийн гаралтай гамшиг, техникийн холбогдолтой аюул болон нийгмийн шинж чанар бүхий аюулын хамгийн түгээмэл гурван төрөл байх ба энэ нь тээврийн аюулгүй байдалд мөн адил хамаарах бөгөөд дээрхээс гадна гаднын болон дотоод, мөн тухайлсан тээврийн хэрэгслийн төрөлд хамаарах гэж тус тус ангилж болох юм.

2007 онд Тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийн гишүүн орнуудын Парламентын Ассамблейн чуулганаар “Тээврийн аюулгүй байдлын тухай”²⁹ загвар хуулийг баталсан ба тус хуулийн 8 дугаар зүйлд *техникийн гаралтай аюулд* тээврийн хэрэгсэл, дэд бүтцийн их хэмжээний элэгдэл, хорогдол, тээврийн хэрэгслийн техник хэрэгслийн хоцрогдол, тээврийн хэрэгсэл, дэд бүтцийн хангалтгүй байдал, үйлдвэрлэлийн дутагдлыг оруулсан бол *байгалийн гаралтай гамшигийн* төрөлд цаг уурын болон цаг агаарын таагүй нөхцөл, тооцоолох боломжгүй гадаад хүчин зүйлсийн нөлөөлөл, байгалийн бусад хүчин зүйл, гамшиг зэргийг оруулсан байна. Харин тээврийн аюулгүй байдлын *нийгмийн шинж чанар бүхий аюулын* төрөлд боловсон хүчний бэлтгэл сургалтын хангалтгүй байдал, тээврийн цогцолборын хэвийн үйл ажиллагаанд харшлах аливаа хууль бус халдлагууд, “хүний хүчин зүйл”³⁰ зэргийг хамруулсан байна. Тээврийн аюулгүй байдалд учирч болзошгүй аюул заналын жагсаалтыг ТУХН-ны гишүүн орнуудын эрх бүхий байгууллагууд тээврийн цогцолборт бүхэлд нь болон тээврийн хэрэгслийн төрөл тус бүрийн хувьд тогтооно.

Тээврийн хэрэгслийн төрлөөс хамааран аюулын төрлийн эзлэх хувь харилцан адилгүй байх ч хамгийн түгээмэл нь техникийн шалтгаантай аюул юм. Техникийн хангалтгүй байдал, эвдрэл гэмтлээс үүдсэн осол нийт осол, гамшигийн 64%-ийг, байгалийн гаралтай гамшигийн осол 32% -ийг, террорист халдлага буюу хүнийн үйл ажиллагаанаас үүдэлтэй осол нь 4%-ийг эзэлдэг байна. Тээврийн хэрэгслийн төрөл тус бүрийн хувьд аюул, гамшигийн төрөл, шинж чанар нь ялгаатай, хэмжээний хувьд харилцан адилгүй байна. Тухайлбал, авто тээврийн ослын 85% нь хүнийн үйл ажиллагаанаас үүдэлтэй байх бол бусад тээврийн хэрэгслийн төрлүүдэд дээрх хувь нь харьцангуй бага байдаг.

“Тээврийн аюулгүй байдал”-ыг тээврийн хэрэгсэл, тээврийн дэд бүтэц, тээврийн үйлчилгээний хэрэглэгч (зорчигч)-ийг аюулын янз бүрийн төрөл (байгалийн гамшиг, техникийн гаралтай аюул), хууль бус халдлага зэргээс хамгаалж, тээврийн тасралтгүй, үр дүнтэй ажиллагааг хангах явдал гэж хэлж болох юм.

Зарим судлаачид тээврийн аюулгүй байдлыг хууль бус халдлагаас хамгаалах болон тээврийн ажиллагааны аюулгүй байдлыг хангах гэж хоёр бүлэгт хувааж үздэг. Тээврийн хэрэгсэл, тээврийн дэд бүтцийн байгууламжийг хууль бус халдлагаас хамгаалах гэдэгт хүний амь нас, эрүүл мэнд болон тээврийн хэрэгсэл, байгууламж, тээврийн тоног төхөөрөмж, зам тээврийн хэрэгсэл эзэмшигчдийн хөрөнгийг аюулаас

²⁹ МОДЕЛЬНЫЙ ЗАКОН О безопасности на транспорте, МЕЖПАРЛАМЕНТСКАЯ АССАМБЛЕЯ ГОСУДАРСТВ – УЧАСТНИКОВ СОДРУЖЕСТВА НЕЗАВИСИМЫХ ГОСУДАРСТВ, 2007 <http://www.cisatc.org/1289/135/154/248>

³⁰ Судлаачид тус хэлбэрт илэрхий хэлбэрүүдээс гадна эд хөрөнгийг завших, гэмтээх мөн (эсхүл) үрэгдүүлэх зэрэг “далд буюу нуугдмал” аюулыг хамруулж болно гэж үздэг.

хамгаалахад чиглэсэн хашаа, барилга байгууламж, хамгаалалтын тусгай алба, хамгаалалтын нэгж, зохион байгуулалт, хууль эрх зүйн арга хэмжээ, техникийн болон бусад тогтолцоог ойлгоно гэж тодорхойлсон байдаг. Харин тээврийн аюулгүй ажиллагаа гэдэгт хүний амь нас, эрүүл мэнд, тээврийн хэрэгсэл, байгууламж, байгаль орчин, тээврийн тоног төхөөрөмж, зам тээвэр эзэмшигчдийн хөрөнгийг аюулаас хамгаалахад чиглэсэн зураг төсөл, зохион бүтээх, үйлдвэрлэл (барих), туршилт ба ашиглалтад оруулах, тээврийн хэрэгсэл, зам тээвэр, тээврийн тоног төхөөрөмжийн ашиглалт ба засвар үйлчилгээ, тээврийн хэрэгслийн үйлчилгээний багийн сургалт, бэлтгэл, эрүүл мэндийн болон цаг уурын хяналт, замын тээвэр, тээврийн тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл болон түүний хөдөлгөөний хяналт, зохион байгуулалт, хууль эрх зүйн арга хэмжээ, тээврийн ослын шалтгааныг мөрдөн шалгах ба түүний бүртгэл бүхий тогтолцоог хэлнэ гэж тодорхойлсон байна.³¹

НЭГ. ДАЛАЙД ГАРЦГҮЙ, ТОМООХОН НУУРУУДАЙ ОРНУУДЫН УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛЖ БУЙ ТУРШЛАГА, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

1.1. БҮГД НАЙРАМДАХ КАЗАХСТАН УЛС

Дэлхийд далайд гарцгүй, зөвхөн газраар хиллэдэг 44 улс байдаг бөгөөд үүний нэг нь Казахстан Улс юм. Гэсэн хэдий ч тус улс нь далай, тэнгист гарцгүй боловч эх газрын хамгийн том нуур болох Каспийн тэнгисээр дамжин далайд гардаг онцлогтой.

Усан замын тээвэр нь тус улсын тээврийн салбарын төмөр болон авто замын дараа гуравдугаарт ордог. Сүүлийн жилүүдэд усан замын тээврийн салбарыг хөгжүүлэхэд Казахстаны Засгийн газраас ихээхэн анхаарч байгаа бөгөөд Ази, Европыг холбосон орчин үеийн торгоны замыг хөгжүүлэх зорилт тавин ажиллаж байгаа. Тус улс нь Актау, Атырау гэсэн 2 боомт хотоор Каспийн тэнгистэй холбогддог бөгөөд Каспийн сав газрын ачаа тээврийн ихэнхийг бүрдүүлдэг улс бөгөөд экспортын гол бараа бүтээгдэхүүн³² нь газрын тос, төмөрлөгийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн болон улаан буудай юм.

Актау, Атырау боомтууд

Актау буюу Цагаан уул хэмээх хот нь Каспийн тэнгисийн зүүн хэсэгт оршдог Казахстаны хот юм. Тус боомт нь TRASEKA /Европ-Кавказ-Ази тивийн тээврийн коридор/ болон Өмнөд Ази, Энэтхэгийг Хойд Европтой холбосон Хойд-Өмнөдийн олон улсын тээврийн коридор боомт хот юм. Актау олон улсын далайн худалдааны боомтоор жилд 8 сая тонн газрын тос, 1.5 сая тонн ачаа тээвэрлэлт, 24 мянган чингэлгийн ачаа эргэлт явагддаг. 2014 онд Гүрж, Туркийг холбосон төмөр зам нээгдсэнээр тус боомтоор дамжин өнгөрөх бараа эргэлтийн хэмжээ нэмэгдэж тус боомтын ач холбогдол нэмэгдсэн.

Атырау хот нь Каспийн тэнгисийн Урал гол /Ural river/-ын аманд байрладаг. Газрын тос болон загасны аж ахуйгаараа алдартай. Атырау боомт нь Каспийн тэнгис

³¹ http://law-vestnik.ksu.kz/ru/content/srch/2015_Law_4_80_2015.pdf

³² Тус улсын голлох салбар нь өнгөт болон хар төмөрлөгийн үйлдвэрлэл. Ашигт малтмалын нөөцөөр баялаг бөгөөд цайр, бари, вольфрамын нөөцөөр дэлхийд 1, мөнгө, хар тугалга, хромоор 2, зэс, флюоритоор 3, молибденоор 4, алтны нөөцөөр 6 дугаар байранд тус тус ордог. (Дэлхийн улс орнуудын парламент, 2010), 140 дэх тал

дэх Казахстаны гол боомт хот бөгөөд Урал голоор хуваагдаж Ази, Европ хоёр тивд байрладаг хот юм.

Усан замын тээврийн аюулгүй байдал³³

Казахстан Улсын Хөрөнгө оруулалт, хөгжлийн яамны Тээврийн хорооны Усан замын тээврийн хэлтэс болон Усан замын тээврийн хяналтын хэлтэс нь усан замын тээвэртэй холбоотой асуудлыг хариуцан ажилладаг. *Дотоодын усан тээврийн тухай хууль* /Law on Inland Water Transport/-ийн 4 дүгээр бүлэгт тээвэрлэлтийн аюулгүй байдалтай холбоотой харилцааг дараах байдлаар зохицуулсан байна. Тухайлбал,

15 дугаар зүйл. Ерөнхий зүйл

Усан онгоцыг³⁴ далайд гаргах бэлтгэл ажил, тээвэрлэлтийн аюулгүй ажиллагааны шаардлагуудыг хангах нь усан онгоцны эзэмшигч болон өмчлөгчийн үүрэг юм.

1. Усан онгоцыг дараах тохиолдолд далайд гарахыг зөвшөөрнө:

1) Дотоодын усан замын тээврийн хэрэгслийн хүрээнд аюулгүй ажиллагааны шаардлага болон Казахстан Улсын хуулиар тогтоосон байгаль орчин, галын аюулгүй байдал, эрүүл ахуй болон өвчний тархалт хяналтын дүрэм журмыг дагаж мөрдсөн байх ёстой.

2) Усан онгоцны тавцан дээрх багийн бүрэлдэхүүний тоо нь хамгийн бага бүтэц бүхий багийн гишүүдийн тогтоосон шаардлагаас багагүй байна.

2. Усан онгоцны эзэмшигч, эсхүл өмчлөгч нь дараах үүрэгтэй:

1) усан онгоцны аюулгүй ажиллагааг хангах;
2) усан онгоцны аюулгүй ажиллагааг хариуцах хүнийг томилох;
3) багийн гишүүдийн ур чадварыг тогтмол сайжруулах, бусад ажилчдын тээвэрлэлтийн аюулгүй ажиллагааг сайжруулах;

4) Энэхүү хуулиар тогтоосон тээвэрлэлтийн аюулгүй байдлын шаардлагын дагуу хөлөг онгоцыг техникийн хувьд баталгаатай байлгах, мөн багийн гишүүдээр хангах.

Дотоодын усанд байрлах гидротехникийн болон бусад байгууламжийн эзэмшигчид тээвэрлэлтийн аюулгүй байдалд тулгарсан аливаа нөхцөл байдлыг цаг алдалгүй тухайн бүс нутгийн салбар ангиудад мэдээллэх үүрэгтэй.

5) Усан замын гидротехникийн байгууламжийн эзэмшигчид усан замын гидротехникийн байгууламжийн засвар үйлчилгээ, хяналт болон техникийн үйл ажиллагааны дүрэм журмыг мөрдөх үүрэгтэй. Усан замын гидротехникийн байгууламжийн аюулгүй ажиллагааны шалгуурыг усан замын гидротехникийн байгууламжийн засвар үйлчилгээ, хяналт болон техникийн үйл ажиллагааны дүрэмд заасны дагуу тодорхойлно.

6) Тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор бүс нутгийн салбар ангиуд нь Казахстан Улсын далбаан дор явж байгаа усан онгоц болон өөр орны далбаатай

³³ Закон Республики Казахстан «О транспорте в Республике Казахстан» от 21 сентября 1994 г. № 156, Гражданский кодекс РК, Закон РК «О торговом мореплаваннии» от 17 января 2002 г. № 284, Кодекс об административных правонарушениях РК, Закон РК «О чрезвычайных ситуациях природного и техногенного характера» от 5 июля 1996 г. №19 «Правила технической эксплуатации судов внутреннего водного плавания» от 21 июня 2011 г. № 680; «Правила плавания по внутренним водным путям», утвержденными Постановлением Правительства Республики Казахстан, от 22 июля 2011 г. № 845

³⁴ Хөлөг онгоц- тээвэрлэлтийн бүртгэлийн техникийн хяналтанд байгаа өөрөө хөдөлдөг эсхүл хөвдөг бүтэц бүхий тээвэрлэлтэнд зориулагдсан дотоодын усан тээврийн онгоц мөн далайгаар аялах зориулалттай хөлөг онгоц, гатлага онгоц, үйлдвэрлэлийн хөлөг онгоц (уснаас шавар гаргаж авах, ачаа өргөгч кран хөвүүлэх зэрэг техникийн тоног төхөөрөмж)

явж байгаа усан онгоцыг шалгах эрхтэй.

7. Усан онгоц барих болон түүнийг засварлах үйл ажиллагаа явуулж байгаа хувь хүн болон аж ахуйн нэгж нь тээвэрлэлтийн бүртгэлийн газраас олгосон тохирох баримт бичигтэй байна.

15-1 дүгээр зүйл. Дотоодын усан тээврийн техникийн шаардлага:

1. Дотоодын усан тээврийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байгаа хувь хүн болон аж ахуйн нэгжүүд нь хүний амь нас, эрүүл мэнд, зорчигчдийн аюулгүй байдал болон тээвэрлэлтийн аюулгүй ажиллагааг дагаж мөрдөх ёстой.

2.Тээвэрлэлтийн аюулгүй байдлыг байгаль орчин болон хүний амь, эрүүл мэндийг хамгаалахад зориулагдсан зохион байгуулалтын болон техникийн цогц гүйцэтгэл, дотоодын усан тээврийн хүрээн дэх осол авааргүй нөхцөлийг бий болгох, дотоодын усан тээврийн засвар үйлчилгээ, техникийн хувьд тохиромжтой нөхцөл байдалд байгаа усан онгоц, боомт, эрэг хавийн объект болон байгууламжууд мөн усан онгоцны ослоос урьдчилан сэргийлэх зэргээр хангагдана.

Техникийн шаардлага тавигдах объектууд нь:

1) Дотоодын усан зам дахь усан онгоц, боомт, эрэг хавийн объект болон байгууламжууд;

2) Дотоодын усан зам дахь усан тээврийн хөлөг онгоц, боомт, эрэг хавийн объект болон байгууламжуудын үйлдвэрлэл /угсралт, засвар, шинэчлэл/;

3) Дотоодын усан зам дахь усан тээврийн хөлөг онгоц, боомт, эрэг хавийн объект болон байгууламжуудын үйл ажиллагаа;

4) Дотоодын усан зам дахь усан тээврийн хөлөг онгоцны агуулах;

5) Дотоодын усан зам дахь усан тээврийн хөлөг онгоцны ачилт, тээвэрлэлт;

6) Дотоодын усан зам дахь усан тээврийн хөлөг онгоцны эвдрэл гэмтэл, ашиглалт.

15-2 дугаар зүйл. Дотоодын усан тээврийн хөлөг онгоц, боомт³⁵, эрэг хавийн объект болон байгууламжуудын аюулгүй байдлын шаардлага:

1. Ачааны усан онгоц /ачаа илгээгч/, илгээгч, хүлээн авагч /ачаа хүлээн авагч/, аюултай ачаа хүлээн авагч мөн аюултай ачааг тээвэрлэж байгаа тээвэрлэгч нь ачааны аюулгүй байдлыг хангах үүрэгтэй ба онцгой нөхцөл байдлын болон түүний үр дагаврын үед тэдгээрийг татан буулгах хөдөлгөөнт салбар ангитай байх;

2. Аюултай ачаа тээвэрлэлтийн үед аюултай нөхцөл байдал тохиолдсон үед ачааны усан онгоц /ачаа илгээгч/, илгээгч, хүлээн авагч /ачаа хүлээн авагч/, аюултай ачаа хүлээн авагч мөн аюултай ачааг тээвэрлэж байгаа тээвэрлэгч нь цаг алдалгүй үүссэн нөхцөл байдлыг салбар ангиудад мэдээллэх үүрэгтэй байх.

15-3 дугаар зүйл. Дотоодын усан зам дахь усан тээврийн хөлөг онгоц, боомт, эрэг хавийн объект болон байгууламжуудын үйлдвэрлэл /угсралт, засвар, шинэчлэл/-ийн аюулгүй байдлын шаардлага:

³⁵ Боомт-Зорчигчид, ачаа ачилт, ачаа болон зорчигчдыг буулгах, агуулахыг хүлээн авах, карго олголт болон бусад төрлийн тээврийн хэрэгсэлтэй харилцан хамаарал бүхий үйлчилгээний зорилгоор тохижуулж бэлтгэсэн дотоодын усан замын усны хэсэг болон хэсэг газар дээр байрласан цогц байгууламж.

1. Дотоодын усан зам дахь усан тээврийн хөлөг онгоц, боомт, эрэг хавийн объект болон байгууламжуудын үйлдвэрлэл /угсралт, засвар, шинэчлэл/-ийн дизайны бичиг баримтыг Казахстаны газар дундын усан тээврийн хууль дүрэм, шаардлагад нийцүүлэх ёстой.

2. Дотоодын усан зам дахь усан тээврийн хөлөг онгоц, боомт, эрэг хавийн объект болон байгууламжуудын үйлдвэрлэл /угсралт, засвар, шинэчлэл/-ийн үйлдвэрлэгч нь аюулгүй байдлыг хангахаар дизайны бичиг баримтад заагдсан бүх арга хэмжээг авах мөн бүхий л техникийн үйл ажиллагааг хянах боломжоор хангах үүрэгтэй.

3. Дотоодын усан тээврийн хөлөг онгоц, эрэг хавийн объект болон байгууламжуудын аюулгүй байдлыг явцад нь шалгаж үзэх /тест хийж үзэх шаардлагатай, эсхүл бүр үйлдвэрлэлийн дараа нь дизайны бичиг баримтын бүх шаардлагын дагуу бүрэн хэмжээний шалгалт хийж гүйцэтгэнэ.

4. Хөлөг онгоц бүр их бие дээрээ харагдахуйц, уншиж болохоор арилдаггүй бүртгэлийн дугаартай байх ёстой.

5. Усан онгоц нь хүмүүсийг усан онгоцноос унах эрсдэлийг багасгах болон усанд унасан хүмүүсийг аврахад чиглэсэн зориулалттай байна.

6. Гол залуурын хяналтын хэсэг нь бүх талыг хамарсан харах орчинтой байна.

7. Хөлөг онгоц усаар дүүрэх болон гал гарах эрсдэлд онцгой анхаарал хандуулж хөлөг онгоцыг үйл ажиллагааны зааварчилгаагаар хангасан байна.

15-4 дүгээр зүйл. Дотоодын усан зам дахь усан тээврийн хөлөг онгоц, боомт, эрэг хавийн объект болон байгууламжуудын үйл ажиллагааны аюулгүй байдлын шаардлага:

1. Дотоодын усан зам дахь хөлөг онгоц, боомт, эрэг хавийн объект болон байгууламжууд нь аюултай бүсүүдийн тээвэрлэлтийн үйл ажиллагаатай холбогдсон бол Казахстаны газар дундын усан тээврийн хууль дүрмийг дагана.

2. Дотоодын усан зам дахь хөлөг онгоц, боомт, эрэг хавийн объект болон байгууламжуудын үйл ажиллагаа эрхэлж байгаа хувь хүн болон аж ахуйн нэгжүүд Казахстаны газар дундын усан тээврийн хууль, дүрэм, журмыг дагаж мөрдөнө.

3. Хөлөг онгоцны номон дахь улсын бүртгэлтэй онгоцнууд нь бага оврын онгоцны техникийн хяналтад тавигдах шаардлагыг дагаж мөрдөнө.

4. Хөлөг онгоцны номон дахь улсын бүртгэлтэй онгоцнуудын техникийн хяналтыг эрх бүхий байгууллагаар хийлгэж анхан шатны, жил бүрийн болон тусгай техникийн гэрчилгээ авна. Түүнчлэн тусгай үзлэг, шалгалт хийнэ.

5. Хөлөг онгоцны номон дахь улсын бүртгэлтэй онгоцнуудын ашиглалт болон тэдгээрийн зогсоолын баазыг /байгууламж/ бага оврын хөлөг онгоцны ашиглалт болон зогсоолын дүрэм журмын дагуу явагдана.

6. Хөлөг онгоцны номонд өөрөө явагч улсын бүртгэлтэй онгоцнуудын хөтөч /жолоодогч/ нь хөтчийн сургалтад хамрагдан тэнцсэн мөн бага оврын онгоц удирдах эрхийг эзэмших гэрчилгээтэй байна.

Бага оврын онгоц удирдах эрхийг эзэмших гэрчилгээ олголт болон хөтчийн /жолоодогч/ сургалтын зохицуулалт, хөтчийн /жолоодогч/ бүртгэл зэргийг бага оврын онгоц удирдах эрхийг хөтөч /жолоодогч/-д олгох дүрэм журмын дагуу олгоно.

Бага оврын онгоцны жолооч нарт зориулсан сургалт зохион байгуулж буй байгууллагууд нь бүс нутгийн анги салбаруудад эхний 3 үйл ажиллагааны талаар дараах зүйлсийг хавсарган мэдээлнэ:

- 1) усан тээврийн багшлах эрхийн дунд болон дээд боловсролын гэрчилгээний хуулбарууд;
- 2) бага оврын онгоц удирдах эрхийг хөтөч /жолоодогч/-д олгох дүрэм журамд үндэслэн сургалтын хөтөлбөрийг боловсруулна.
- 3) өмчлөх, эсхүл түрээслэх эрхтэй холбоотой үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг гэрчлэх бичиг баримтын хуулбар.

16 дугаар зүйл. Хөлөг онгоцны техникийн аюулгүй байдал

2. Дотоодын усан онгоц болон гол мөрний усан онгоц нь усан замд явуулах үйл ажиллагаанаас хамааралгүйгээр ангилал, техникийн хяналт болон гэрчилгээнд хамрагдах ёстой:

- 1) Зорчигч;
- 2) Зорчигчгүй өөрөө явагч хөдөлгүүртэй газар дундын хөлөг онгоц нь 55 киловатт /75 морины хүчин чадал/ буюу түүнээс дээш чадал бүхий хөдөлгүүртэй байна;
- 3) Өөрөө явагч хөдөлгүүртэй болон хөдөлгүүргүй хөлөг онгоцны ачааны зай нь 80 тонн болон түүнээс дээш байна.

3. Хөлөг онгоцны техникийн аюулгүй байдлыг хангах тээврийн бүртгэлийн баталгаажуулалтыг үнэ төлбөргүйгээр хийнэ. Хөлөг онгоцны эзний буруугаас болж дахин баталгаажуулалт хийгдсэн тохиолдолд зардлыг онгоцны эзэн хариуцна.

17 дугаар зүйл. Орон нутаг дахь салбарууд дотоодын усан замын тээврийн хэрэгслийн хяналт, шалгалтыг дараах байдлаар хэрэгжүүлнэ.

- Казахстан Улсын засгийн газраас баталсан дүрмийн дагуу осолд орсон усан замын тээврийн хэрэгслийн шинжилгээ судалгаа, бүртгэл ангилал зэргийг хийх бөгөөд түүнчлэн энэ нь бага оврын хөлөг онгоцонд ч хамаарна;
- Усан замын болон усны тоног төхөөрөмжийн шаардлагатай засвар үйлчилгээний хяналт, шалгалт;
- Хөлөг онгоц, хүний амь нас, эрүүл мэнд, ачааг хамгаалахын тулд онгоцны хөдөлгөөнийг зогсоох, хориглох;
- Хөлөг онгоц эзэмшигчид, багийн гишүүд, хувь хүн, хуулийн этгээд хууль тогтоомжид заасан усан онгоцыг тээвэрлэх аюулгүй байдлыг хангах шаардлагыг биелүүлж буй эсэхэд хяналт тавих;
- Хууль тогтоомжид заасны дагуу усан онгоцны холбогдох баримт бичгийг бүртгүүлэх;
- Хууль тогтоомжийн дагуу илрүүлсэн зөрчлийг арилгах тухай зөвлөмжийг хэрэгжүүлэх;
- Тээвэрлэгч зорчигчтой тээвэрлэгчийн иргэний хариуцлагын даатгалын гэрээг заавал байгуулах бөгөөд түүнд хяналт тавих;
- Бага оврын усан онгоцны техникийн хяналтыг хийх;
- Казахстан Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний шаардлагыг дагаж мөрдөж буй эсэхэд хяналт тавих;

- Усан онгоцны техникийн үзүүлэлт болон өмчлөгчийн байнгын оршин суугаа газар солигдсон тухай мэдээллийг дахин бүртгэх;
- Бага оврын усан онгоцны жолооч нарт зориулсан сургалтын бүртгэл;
- Бага оврын усан онгоцны үзлэг, хяналтын асуудлаар мэргэжлийн эскпертүүдийн оролцуулах;
- Бага оврын усан онгоцны жолооч согтууруулах ундаа, мансуурлах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэсэн тохиолдолд усан онгоц удирдахаас чөлөөлж, шинжилгээний байгууллагад хүргүүлнэ;
- Захиргааны зөрчлийг Казахстаны хууль тогтоомжийн дагуу мөрдөн байцаах ажиллагаа явуулах.

21 дүгээр зүйл. Хөлөг онгоцны хөдөлгөөнийг хязгаарлах, хориглох

1. Байгалийн гамшиг, цэрэг дайны үйл ажиллагаа, түүнчлэн боомтод ачаа, хөлөг онгоцны хэт ачааллын улмаас тухайн орон нутгийн салбар нь тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангах, хүний амь нас, эрүүл мэнд, ачааны хадгалалтыг хамгаалах зорилгоор хөлөг онгоцны хөдөлгөөнийг хязгаарлах буюу хориглох шийдвэр гаргах эрхтэй бөгөөд энэ тухай эрх бүхий байгууллагад яаралтай мэдэгдэнэ.

Таван сараас дээш хугацаагаар хөлөг онгоцны хөдөлгөөнийг хязгаарлах, хориглох тохиолдолд эрх бүхий байгууллага нь энэ тухай нэн даруй Засгийн газарт мэдэгдэнэ.

2. Орон нутгийн салбар тээвэрлэгч, ачаа илгээгч, хүлээн авагчид хөлөг онгоцны хөдөлгөөнийг хязгаарлах, хориглох болсон шалтгааныг ачаа тээвэрлэх дүрэмд заасан журмын дагуу мэдэгдэнэ.

1.2. ШВЕЙЦАРЫН ХОЛБООНЫ УЛС

Швейцарын төрийн далбааг мандуулан хөвөх хөлөг онгоцны бүртгэлийг Швейцарын далайн навигацийн газар (ШДНГ) /Swiss Maritime Navigation Office/³⁶ хариуцдаг. Далайн тээвэр нь олон улсын эрх зүйн салбарт хамаардаг учир тус газар нь Гадаад харилцааны департаментад харьяалагддаг байна. ШДНГ нь далайн навигацийн хяналт болон хууль сахиулах үүргийг хэрэгжүүлэх ба далайн дарвуулт онгоцыг бүртгэж, гадаадын гол мөрөн болон эрэг дагуу усанд ашиглах жижиг хөлөг онгоцон дээр Швейцарын төрийн далбааг мандуулан хөвөх эрхийн гэрчилгээ олгоно. Одоогийн байдлаар 1500 гаруй далайн дарвуулт онгоц Швейцарын далбаа дор хөвдөг ба эдгээр нь гагцхүү спорт, амралтын зориулалттай байх бөгөөд ашиг олох зорилгоор зорчигч, ачаа бараа тээвэрлэхийг хориглосон байна.

Холбооны байгаль орчин, тээвэр, эрчим хүч ба харилцаа холбооны департаментын харьяа Холбооны тээврийн алба /Federal Office of Transport/³⁷ нь Швейцарын нийтийн тээвэр болон ачаа тээврийн (үүнд төмөр зам, канатан зам, усан онгоц, трамвай болон автобус зэрэг) аюулгүй байдал, төсөв санхүү болон дэд бүтэц зэргийг хариуцан ажиллана. Швейцарын гол мөрөн, нуураар холбооны бүртгэлд бүртгэлтэй 170 гаруй зорчигч тээврийн хөлөг онгоц жил бүр 13 сая зорчигчдыг тээвэрлэж, 260 гаруй ачаа тээврийн хөлөг онгоц жил бүр 4 сая тонн ачаа бараа

³⁶ Swiss Maritime Navigation Office (SMNO) <https://www.eda.admin.ch/smno/en/home.html>

³⁷ Federal Office of Transport (FOT) <https://www.bav.admin.ch/bav/en/home.html>

тээвэрлэдэг байна.

Дотоодын усан замын тээврийн хувьд Холбооны тээврийн алба нь хөлөг онгоц барихтай холбоотой асуудал, тээврийн үйлчилгээ, усан замын тээврийн хэрэгсэл дээр ажиллах мэргэжлийн багт гэрчилгээ олгох зэргийг хариуцахаас гадна холбооны бүртгэлд бүртгэлтэй хөлөг онгоцны аж ахуйн нэгжүүдийн холбогдох журам, стандартын мөрдөлтөд хяналт тавина. Хуульд заасан холбогдох бусад хяналтыг кантон (муж улс)-ууд хэрэгжүүлнэ. Дээрхээс гадна Холбооны тээврийн алба нь Женев (Францтай хиллэдэг), Боденс (Австри, Германтай хиллэдэг), Лугано (Италитай хиллэдэг) зэрэг нуурын Олон улсын усан тээврийн хороодтой олон улсын гэрээ байгуулах, нэмэлт, өөрчлөлт оруулах зэрэг эрх, үүргийг хэрэгжүүлдэг байна.

Усан замын тээврийн аюулгүй байдал

Швейцарын далайн тээврийг зохицуулж буй гол эрх зүйн акт нь *“Швейцарын далбаа мандуулан хөвөх холбооны хууль”* (буюу Навигацийн тухай хууль)³⁸–ба тус хуулийг хэрэгжүүлэх журмууд юм. Дээрхээс гадна Швейцарын зарим нуурууд болон Рейн мөрөн дээр олон улсын хоёр болон олон талт гэрээнүүд үйлчилдэг.

1975 онд батлагдсан *“Дотоодын усан замын тээврийн тухай хууль”* (Bundesgesetz über die Binnenschifffahrt)³⁹ нь 10 бүлэг 64 зүйлээс бүрдэх ба дотоодын усан замын тээврийг зохицуулж буй гол хууль юм. Тус хуульд заасны дагуу усан замын тээврийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой дүрэм, журам батлах, ерөнхий хяналт тавих эрх бүхий субъект нь Холбооны Зөвлөл буюу Засгийн газар байх ба усан замын тээврийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой зарим эрх үүргээ холбогдох байгууллага, кантон (муж улс)-д шилжүүлж болно. Дотоодын усан замын тээврийн тухай хууль нь дараах бүтэцтэй байна.

“Дотоодын усан замын тээврийн тухай хууль” 1975 он

(Албан бус орчуулга)

Бүлэг I. Ерөнхий зүйл

Бүлэг II. Боомтын байгууламжууд

Бүлэг III. Хөлөг онгоц болон хөлөг онгоцны ахмад, хөлөг онгоцны баг

Бүлэг IV. Хөвөлтийн дүрэм

Бүлэг V. Рейн мөрөн дэх олон улсын тээврийн тусгай зохицуулалт

Бүлэг VI. Хариуцлагын даатгал

Бүлэг VII. Хүчингүй болсон

Бүлэг VIII. Эрүүгийн хариуцлага

Бүлэг IX. Холбогдох байгууллагуудын эрх, үүрэг

Бүлэг X. Төгсгөлийн заалт

БҮЛЭГ III. ХӨЛӨГ ОНГОЦ БОЛОН ХӨЛӨГ ОНГОЦНЫ АХМАД, ХӨЛӨГ ОНГОЦНЫ БАГ

I Хэсэг. Хөлөг онгоц

³⁸ https://www.eda.admin.ch/dam/smno/en/documents/Seeschiffahrtsgesetz_en.pdf

³⁹ <https://www.admin.ch/opc/de/classified-compilation/19750266/index.html#fn1>

10 дугаар зүйл. Үйл ажиллагааны аюулгүй байдал

1. Хөлөг онгоцыг хөвөлтийн дүрмийг дагаж мөрдөн, хөлөг онгоцны тавцан дээрх этгээд, усан замын бусад хэрэглэгчдийг аюулд өртүүлэхгүй байдлаар барьж, тоноглож, ашиглана.

2. Хөлөг онгоцыг гагцхүү аюулгүй байдлыг хангаж, холбогдох дүрэм, журмыг мөрдсөн нөхцөлд ашиглахыг зөвшөөрнө.

11 дүгээр зүйл. Хөлөг онгоцыг барих, тоноглох

1. Холбооны Зөвлөл нь хөлөг онгоц барих, тоноглох, шалган тохируулах журмыг боловсруулна. Тус журмыг боловсруулахад ус болон байгаль орчныг хамгаалах шаардлагыг харгалзан үзнэ.

2. Холбооны Зөвлөл нь хөлөг онгоцны хэмжээг тогтоож, хөдөлгүүрийн үзүүлэлтийг тогтоож, зарим төрлийн хөдөлгүүр ашиглахыг хязгаарлаж болно.

[...]

13 дугаар зүйл. Хөлөг онгоцны гэрчилгээ

1. Хөлөг онгоц нь гагцхүү гэрчилгээтэй хөвөлтөд гарна.

2. Хөлөг онгоцны гэрчилгээг холбогдох шаардлагуудыг хангасан, даатгалд даатгуулсан нөхцөлд олгоно.

3. Усан зам дахь хөлөг онгоцны тоог хязгаарласан нөхцөлд, кантоноос олгох нэмэлт зөвшөөрлөөр тээвэрлэлт хийж болно.

4. Хөлөг онгоцны шилжилт хөдөлгөөн, эсхүл эзэмшигч, өмчлөгч солигдсон бол хөлөг онгоцны шинэ гэрчилгээ олгоно.

5. Холбооны Зөвлөл нь хөлөг онгоцны гэрчилгээ шаардлагагүй, эсхүл тусгай гэрчилгээ олгох шаардлагатай хөлөг онгоцыг тогтооно. Гадаадад бүртгэлтэй хөлөг онгоц Швейцарын усан замд түр хугацаагаар хөвөх бол гадаадын гэрчилгээг хүлээн зөвшөөрч болно.

14 дүгээр зүйл. Үзлэг болон шалгалт

1. Хөлөг онгоцонд гэрчилгээ олгохоос өмнө хөлөг онгоц нь албан ёсны үзлэг, шалгалтаар орсон байна.

2. Холбооны Зөвлөл нь нэг төрлийн хөлөг онгоцыг (нэгдсэн байдлаар шалгалтад орсон) бие даасан шалгалтаас чөлөөлж болно.

3. Шалгалтыг дараах байдлаар явуулна:

а. Тогтмол давтамжтайгаар;

б. Хөлөг онгоцны аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал эргэлзээтэй бол;

с. Хөлөг онгоц их хэмжээгээр өөрчлөгдсөн бол;

4. Хөлөг онгоц эзэмшигч, өмчлөгч нь хөлөг онгоцонд орсон томоохон өөрчлөлтийг холбогдох байгууллагад мэдэгдэнэ.

5. Холбооны Зөвлөл нь хөлөг онгоцны үзлэг, шалгалттай холбоотой журмыг батална.

15 дугаар зүйл. Хөлөг онгоцны бүртгэл

1. Хөлөг онгоц бүрийг холбооны хөлөг онгоцны бүртгэлд бүртгэж, холбогдох тэмдэглэгээ хийнэ.

2. Холбооны хөлөг онгоцны бүртгэлд бүртгүүлээгүй хөлөг онгоцыг тэдгээрийн харьяа кантон бүртгэнэ.

3. Холбооны Зөвлөл нь хөлөг онгоцны бүртгэл, хөлөг онгоцны тэмдэглэгээтэй холбоотой журмыг батална.

II Хэсэг. Хөлөг онгоцны ахмад, хөлөг онгоцны баг

16 дугаар зүйл. Хөлөг онгоцны удирдлага

1. Хөлөг онгоц бүр хариуцлагатай удирдлагатай байна.

2. Ахмад (шкипер) нь хөлөг онгоцыг удирдана.

3. Холбооны Зөвлөл нь хөлөг онгоцны төрөлд тохирох хөлөг онгоцны бүрэлдэхүүний доод хэмжээг тогтооно.

4. Хөлөг онгоцны баг болон хөлөг онгоц дээрх бусад этгээдүүд нь хөлөг онгоцны навигаци болон хөлөг онгоц дээр хэв журмыг хангуулахтай холбоотой гаргасан заавар, тушаалыг сахин биелүүлнэ.

17 дугаар зүйл. Усан замын тээврийн хэрэгсэл жолоодох үнэмлэх

1. Холбооны Зөвлөл нь жолооны үнэмлэхтэй жолоодох хөлөг онгоцыг тогтооно.

2. Усан замын тээврийн хэрэгсэл жолоодох үнэмлэхийг тухайн төрлийн хөлөг онгоцны хөдөлгөөний дүрэм, аюулгүй ажиллагааны шалгалт өгч, тэнцсэн этгээдэд олгоно.

3. Холбооны Зөвлөл нь хөлөг онгоц дээрх бусад үйл ажиллагааг журамлаж болно.

4. Усан замын тээврийн хэрэгсэл жолоодох үнэмлэхийг дараах этгээдэд олгохгүй.

а. Насанд хүрээгүй;

б. Хөлөг онгоцны аюулгүй ажиллагаа хангах чадваргүй, эсхүл биеийн эрүүл мэнд, сэтгэцийн хувьд мэргэжлээрээ ажиллах боломжгүй бол;

с. Усан замын тээврийн хэрэгсэл жолоодох, мэргэжлээрээ ажиллахад нь хүндрэл учруулахуйц нөхцөл байдалтай бол (согтууруулах ундаа, бусад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисонд донтсон);

5. Хөлөг онгоцны ахмад, багийн тохиромжтой байдалд эргэлзээ үүссэн бол дахин шалгалтад оруулна.

III Хэсэг. Баримт бичиг

18 дугаар зүйл. Хамрах хүрээ

1. Хөлөг онгоц, ахмад болон хөлөг онгоцны бүрэлдэхүүний гэрчилгээ нь Швейцарын бүх нутаг дэвсгэр дээр хүчинтэй байна.

2. Дээр дурдсан гэрчилгээ нь хязгаарлалттай байж болно.

3. Олон улсын гэрээний дагуу олгосон гэрчилгээ нь Швейцарын нутаг дэвсгэр дээр үйлчилнэ.

4. Холбооны Зөвлөл нь гадаадад олгосон гэрчилгээг хүлээн зөвшөөрөхтэй холбоотой асуудлыг шийдвэрлэнэ.

19 дугаар зүйл. Хүчингүй болгох

1. Гэрчилгээ болон зөвшөөрлийг тухайн гэрчилгээ, зөвшөөрлийг олгосон нөхцөл байхгүй болсон тохиолдолд хурааж авах/хүчингүй болгоно.

2. Гэрчилгээ болон зөвшөөрөл олгох нөхцөл, журмыг дагаж мөрдөөгүй, эсхүл хөлөг онгоцны холбогдох татвар, хураамжийг төлөөгүй бол хурааж авах/хүчингүй болгоно.

20 дугаар зүйл. Жижиг зөрчил гаргасан хөлөг онгоцны жолоочийн усан замын тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасах

1. Дараах жижиг зөрчил гаргасан жолоочийн эрхийг хасна;
 - a. Хөвөлтийн аюулгүй байдлын дүрмийг зөрчиж, хөлөг онгоцны хөдөлгөөнд бага хэмжээний эрсдэл, эсхүл усан замын тээвэрт сөрөг нөлөө үзүүлсэн бол;
 - b. Усан замын, байгаль орчны дүрэм, журмыг зөрчсөн;
 - c. Баримт бичгийн зөрчил гаргасан;
 - d. Согтуугаар хөлөг онгоц жолоодсон, гэхдээ цусан дахь спиртийн хэмжээ тогтоосон хэмжээнээс хэтрээгүй, хөвөлтийн аюулгүй байдлын дүрмийг зөрчөөгүй.

2. Жижиг зөрчил гаргасан этгээд нь өмнөх хоёр жилийн хугацаанд жолоодох эрхээ хасуулж байсан, эсхүл захиргааны зөрчил гаргаж байсан бол жолоодох эрхийг нэг сараар хасна.

3. Жижиг зөрчил гаргасан этгээд нь өмнөх хоёр жилийн хугацаанд эрхээ хасуулж байгаагүй, эсхүл захиргааны зөрчил гаргаж байгаагүй бол сануулах арга хэмжээ авна.

4. Тодорхой хөнгөн зөрчилд ямарваа нэгэн арга хэмжээ авахгүй.

20а дугаар зүйл. Дунд зэргийн зөрчил гаргасан хөлөг онгоцны жолоочийн усан замын тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасах

1. Дараах дунд зэргийн зөрчил гаргасан хөлөг онгоцны жолоочийн эрхийг хасна:
 - a. Хөвөлтийн аюулгүй байдлын дүрмийг зөрчиж, бусдын аюулгүй байдалд эрсдэл учруулсан бол;
 - b. Согтуугаар хөлөг онгоц жолоодсон, гэхдээ цусан дахь спиртийн хэмжээ тогтоосон хэмжээнээс хэтрээгүй, хөвөлтийн аюулгүй байдлын дүрмийг зөрчин, жижиг зөрчил гаргасан бол;
 - c. Хулгайлагдсан хөлөг онгоцыг жолоодсон бол;
 - d. Зохих баримт бичиггүй хөлөг онгоцыг удирдсан, эсхүл хөлөг онгоц дээр усан тээвэртэй холбоотой ажил гүйцэтгэсэн бол;
 - e. Бусдад аюул, хохирол учруулахгүй байдлаар усан замын тээврийн хэрэгслийг аюулгүй жолоодох чадвар, чадамжгүй бол.
2. Дунд зэргийн зөрчил гаргасан хөлөг онгоцны жолоочийн эрхийг:
 - a. Нэг сараас доошгүй хугацаагаар хасна;
 - b. Өмнөх хоёр жилийн хугацаанд дунд зэргийн, эсхүл ноцтой зөрчил гаргаж эрхээ хасуулж байсан бол дөрвөн сараас доошгүй хугацаагаар хасна;
 - c. Өмнөх хоёр жилийн хугацаанд дунд зэргийн зөрчил гаргаж эрхээ 2 удаа хасуулж байсан бол есөн сараас доошгүй хугацаагаар хасна;
 - d. Өмнөх хоёр жилийн хугацаанд ноцтой зөрчил гаргаж эрхээ 2 удаа хасуулж байсан бол арван таван сараас доошгүй хугацаагаар хасна;
 - e. Өмнөх хоёр жилд доод тал нь дунд зэргийн зөрчил гарган 3 удаа эрхээ хасуулж байсан бол тодорхойгүй хугацаагаар, эсхүл хоёроос доошгүй

жилээр эрхийг хасна. Усан замын тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хассанаас хойш таван жилийн хугацаанд дахин захиргааны зөрчил гаргаагүй бол зөрчилгүйд тооцно.

- f. Өмнөх 5 жилийн хугацаанд е хэсэгт заасан, эсхүл 20б-ийн 2-р хэсэгт заасан үндэслэлээр жолоодох эрхийг бүрмөсөн хасна.

20б дугаар зүйл. Ноцтой зөрчил гаргасан хөлөг онгоцны жолоочийн усан замын тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасах

1. Дараах ноцтой зөрчил гаргасан хөлөг онгоцны жолоочийн эрхийг хасна:
 - a. Хөвөлтийн аюулгүй байдалд ноцтой хохирол учруулсан бол;
 - b. Согтуугаар хөлөг онгоц жолоодсон, (цусан дахь спиртийн хэмжээ тогтоосон хэмжээнээс хэтэрсэн) хөлөг онгоцыг удирдсан, удирдахад оролцсон, хөлөг онгоц дээр усан тээвэртэй холбоотой ажил гүйцэтгэсэн бол;
 - c. Мансуурсан, эсхүл бусад шалтгаанаар (мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэсэн) усан замын тээврийн хэрэгслийг аюулгүй жолоодох чадамжгүй бол;
 - d. Холбооны Зөвлөлөөс явуулж буй мөрдөн шалгах ажиллагаанд санаатайгаар саад учруулсан, холбогдох (цусны, амьсгалаас архины сорил авах гм) эрүүл мэндийн бусад шинжилгээ өгөхөөс татгалзсан бол;
 - e. Бусдыг аврах, тусламж үзүүлэх үүргээ биелүүлэхээс зайлсхийсэн, эсхүл зөрчсөн бол;
 - f. Холбогдох эрхээ хасуулсан боловч хөлөг онгоц жолоодсон, хөлөг онгоц дээр усан тээвэртэй холбоотой ажил гүйцэтгэсэн бол.
2. Ноцтой зөрчил гаргасан хөлөг онгоцны жолоочийн эрхийг:
 - a. Гурван сараас доошгүй хугацаагаар хасна;
 - b. Өмнөх таван жилийн хугацаанд дунд зэргийн зөрчил гаргаж эрхээ хасуулж байсан бол зургаан сараас доошгүй хугацаагаар хасна;
 - c. Өмнөх таван жилийн хугацаанд ноцтой зөрчил гаргаж эрхээ 2 доош удаа хасуулж байсан бол арван хоёр сараас доошгүй хугацаагаар хасна;
 - d. Өмнөх арван жилд ноцтой зөрчил гарган 2 удаа хасуулсан, эсхүл дунд зэргийн зөрчил гарган 3 удаа эрхээ хасуулж байсан бол тодорхойгүй хугацаагаар, эсхүл хоёроос доошгүй жилээр эрхийг хасна. Усан замын тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хассанаас хойш таван жилийн хугацаанд дахин захиргааны зөрчил гаргаагүй бол зөрчилгүйд тооцно.
 - e. Өмнөх 5 жилийн хугацаанд d хэсэгт заасан, эсхүл 20а -ийн 2-р хэсэгт заасан үндэслэлээр жолоодох эрхийг бүрмөсөн хасна. [...]

БҮЛЭГ IV. ХӨВӨЛТИЙН ДҮРЭМ

I Хэсэг. Ерөнхий эрх, үүрэг

22 дугаар зүйл. Туслах үүрэг

1. Ахмад нь хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулах, эд хөрөнгөнд хохирол учруулах, усан замын тээвэрт саад учруулах, мөн байгаль орчинд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг явуулж, хөлөг онгоцны багийн сургалтыг хариуцаж, шаардлагатай бүх арга хэмжээ авна.

2. Зайлшгүй ослын үед, ахмад нь хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх дүрэм, журмыг үл харгалзан шаардлагатай бүх арга хэмжээ авах ёстой.

23 дугаар зүйл. Аврах үүрэг

1. Хөлөг онгоц дээр зорчигч, хүн байхад осол гарсан тохиолдолд хөлөг онгоцны ахмад болон баг нь шаардлагатай тусламж үзүүлэх, аврах ажиллагаа явуулах үүрэгтэй.

2. Усанд хүний амь насанд эрсдэл учирсан тохиолдолд ахмад нь өөрийн хөлөг онгоцонд аюул учруулахгүйгээр, тусламж үзүүлэхэд боломжит арга хэмжээ авах үүрэгтэй.

24 дүгээр зүйл. Осол, гэмтлийн талаар мэдээллэхтэй холбоотой зохицуулалтыг тусгасан байна.

1а хэсэг. Жолоодох чадваргүй байдлыг тогтоох

25 дугаар зүйл. Жолоодох, амрах журам

1. Холбооны Зөвлөл нь хөлөг онгоцны тээврийн журмыг батлах бөгөөд дохио, тэмдэг, гэрэлтүүлэг болон аюултай ачаа тээвэрлэх болон тээврийн аюулгүй байдлын журмыг батална.

2. Мөн тэрээр усан цана болон ижил төстэй үйл ажиллагаа болон усан зам ашиглагч бусад этгээдийн аюулгүй байдалтай холбоотой журмыг баталж болно.

3. Кантон нь тээврийн болон байгаль орчны аюулгүй байдалтай холбоотойгоор орон нутгийн тусгай журам гаргаж болно.

26 дугаар зүйл. Сэрэмжлүүлэх, аврах алба

1. Кантон нь салхи шуурга, аадар бороо, манантай үед тээвэрт гарахыг хориглох, усан тээвэрт гарсан хөлөг онгоцыг зогсоолд зогсохыг шаардах эрх бүхий олон нийтийг сэрэмжлүүлэх болон аврах албыг байгуулж болно.

2. Кантон нь өөрийн газар нутагт байрлах хөлөг онгоц эзэмшигч, өмчлөгчдийг дээрх үйлчилгээний санхүүжилтэд хувь нэмэр оруулах, хөлөг онгоц түрээсийн компаниудыг аврах ажиллагаа үзүүлэхийг үүрэг болгож болно.

3. Аврах ажиллагааны зардлыг аврагдсан хөлөг онгоцны жолооч, эзэмшигч, өмчлөгчөөр төлүүлж болно.

4. [Улсын усан замын тээврийн компани дээрх журмыг өөрөө тогтооно.]

27 дугаар зүйл. Туршилт, цэргийн сургуулилттай мэдээллэхтэй холбоотой зохицуулалтыг тусгасан байна.

28 дугаар зүйл. Рейн мөрөн дэх олон улсын усан тээврийн тусгай зохицуулалт

1. Холбооны байгаль орчин, тээвэр, эрчим хүч ба харилцаа холбооны департамент нь Рейн мөрөн дэх тээврийн Төв Комиссын тогтоолыг үндэслэн Рейн мөрөн дэх олон улсын усан тээврийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн журмыг батална. [...]

БҮЛЭГ VIII. ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА

40 дүгээр зүйл. Хөвөлтийн дүрмийн зөрчигсдөд хүлээлгэх хариуцлага

1. Хөвөлтийн дүрэм, олон улсын гэрээ, эсхүл холбооны буюу кантоноос гаргасан захирамжлалын баримт бичгийг зөрчсөн этгээдэд шийтгэл ногдуулна.

2. Хөвөлтийн дүрмийг ноцтой зөрчин бусдын аюулгүй байдлыг ноцтой эрсдэлд оруулсан, ноцтой хохирол учруулсан бол 3 хүртэл жилээр хорих ял оногдуулах, эсхүл торгууль ногдуулна. [...]

43 дугаар зүйл. Аюулгүйн шаардлагыг хангаагүй хөлөг онгоц

1. Хөлөг онгоцны ажиллагааны аюулгүй байдлыг санаатайгаар зөрчин, осол гарах эрсдэлийг бий болгосон этгээдэд 3 хүртэл жилээр хорих ял оногдуулах, эсхүл торгууль ногдуулна.

2. Аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаагүй гэдгийг мэдэж буй, эсхүл мэдэх боломжтой боловч хөлөг онгоцыг удирдсан, эсхүл болгоомжгүйгээр дээрх хөлөг онгоцыг ашигласан бол торгууль ногдуулна. [...]

ХОЁР. ДАЛАЙД ГАРЦТАЙ, ТОМООХОН НУУРУУДТАЙ ОРНУУДЫН УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛЖ БУЙ ТУРШЛАГА, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

2.1.ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС

ОХУ нь дотоодын усан замын сүлжээний хэмжээгээр (усан замын урт 101,7 мянга гаруй км) дэлхийд Хятадын дараа хоёрдугаар байранд ордог ч ачаа тээврийн дийлэнхийг авто зам, төмөр замаар тээвэрлэдэг байна. ОХУ-ын Европын хэсгийн 6,5 мянган км усан замаар нефтийн бүтээгдэхүүн, мод, металл болон бордоо зэрэг тарифын хэмжээ өндөр бүтээгдэхүүнийг голлон тээвэрлэдэг.

ОХУ-ын гол мөрөнд 130 гаруй боомт үйл ажиллагаа явуулдаг ба дийлэнх нь авто зам, төмөр замтай шууд холбогдож, холимог тээвэрлэлт хийх боломжтой. ОХУ-ын дотоодын усан замын тээвэр нийт тээврийн эзлэх хувийн 1,5%-ийг эзлэх ба энэ нь Европын дундаж хэмжээтэй ойролцоо (харин ХНБГУ-11%, Франц-10%, Нидерланд-34%) байгаа юм.⁴⁰

Төрөөс дотоодын усан замын тээвэр бүхий тээврийн салбарт баримтлах бодлого, норматив эрх зүйн зохицуулалтыг боловсруулах эрхийг ОХУ-ын Тээврийн яам, гол мөрний боомт дахь холбооны өмчийг удирдах, тус өмчийг хувь хүн ба хуулийн этгээдэд шилжүүлэх эрхийг Төрийн өмчийн удирдлагын холбооны агентлаг, бүс нутгийн хэмжээнд дотоодын усан замын тээврийн удирдлага, үйлчилгээ, хөгжүүлэх асуудлыг 15 дотоодын усан замын сав газрын захиргаа, “Москвагийн сав газрын гол мөрний захиргаа” болон “Москвагийн нэрэмжит суваг” тус тус хэрэгжүүлдэг байна. Дотоодын усан замын тээврийн төрийн үйлчилгээ үзүүлэх, төрийн өмчийг удирдах үүрэг бүхий гүйцэтгэх эрх мэдлийг холбооны байгууллага нь Далай, мөрний тээврийн Холбооны агентлаг (Росморречфлот) байна.

2004 оноос усан замын тээврийн аюулгүй байдал, байгаль орчин, галын аюулгүй байдал, холбооны өмчит усан замын тээврийн гидротехникийн байгууламжийн аюулгүй байдлыг хангах, хяналт, шалгалтыг явуулах, холбогдох зөвшөөрөл олгох эрх, үүргийг Тээврийн хяналтын асуудал эрхэлсэн холбооны алба (Ространснадзор)

⁴⁰ <http://static.government.ru/media/files/YxvWxYkzMqwAsfBmAX6anAVViKnFgYwA.pdf>

хэрэгжүүлж байна. Дотоодын усан замын сав газрын захиргааны салбарын хувьд усан замын бүс нутаг дахь салбар, гидротехникийн байгууламж, технологийн харилцаа холбооны нэгж, хөлөг онгоц болон усан замын тээврийн бусад техникийн байгууламжийн засвар үйлчилгээний 89 нэгж үйл ажиллагаа явуулдаг ба дотоодын усан замын байгууллагад 28 мянга гаруй ажилтан ажилладаг байна.

ОХУ нь 2009 онд “2020 он хүртэл баримтлах Үндэсний аюулгүй байдлын стратеги” төлөвлөлтийн баримт бичгийг баталсан ба 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Нэмэлт, өөрчлөлтөөр тээврийн аюулгүй байдалд илүү анхаарал хандуулсан байх ба энэ талаар өмнө нь зөвхөн үндэсний батлан хамгаалах болон эдийн засгийн өсөлтийг хангах, иргэдийн амьдралын чанарыг сайжруулахад тээврийн дэд бүтцийг сайжруулахаар тусгасан байсан бол шинэ стратегид тээврийн аюулгүй байдалд учирч болзошгүй аюулыг шинэчлэн тодорхойлсон байна.

Орчин үеийн нийгэмд тээвэр нь зөвхөн эдийн засгийн салбарт хамаараад зогсохгүй өөр олон салбарт хамаарагддаг. Энэ утгаараа, тээврийн дэд бүтцийг террорист үйл ажиллагаанаас хамгаалах, аюулгүй ажиллагааг бэхжүүлэх, түүнчлэн сайжруулах болон хөгжүүлэх арга хэмжээг төрийн болон олон нийтийн аюулгүй байдлыг хангах, ОХУ-ын иргэний амьдралын чанарыг сайжруулах, эдийн засгийн өсөлт зэрэг стратегийн тэргүүлэх чиглэл, асуудалд хамруулсан байна. Түүнчлэн тээврийн дэд бүтцийн байгууламжийг устгах, үйл ажиллагааг тасалдуулахад чиглэсэн үйл ажиллагааг төрийн болон олон нийтийн аюулгүй байдалд заналхийлэх гол аюулын нэг гэж тодорхойлсон байна.

2030 он хүртэл ОХУ-ын тээврийг хөгжүүлэх стратегийн баримт бичгийн зорилгын нэг нь тээврийн тогтолцооны аюулгүй байдлыг сайжруулах явдал байна. Энэхүү зорилгод хүрэхэд хөдөлгөөн, нислэг, хөвөлтийн аюулгүй байдлын олон улсын болон үндэсний шаардлагад нийцсэн түвшинд хүрэх явдал байна.

Тээврийн стратегийн зохих түвшинд хүрэх зорилгын хүрээнд “Тээврийн аюулгүй ажиллагааны шаардлагад нийцсэн тээврийн дэд бүтцийн байгууламж хувь” гэх шалгуур үзүүлэлтийг боловсруулсан байна. Энэ хүрээнд агаарын тээврийн объектыг 2018 онд 100 хувь холбогдох тээврийн аюулгүй шаардлагад нийцүүлэх бол дотоодын усан замын тээврийн хувьд 2024 онд 100 хувь, харин төмөр замын тээврийн объектыг 2030 он гэхэд 11,5 хувийг (12,6 хувь (хурдацтай хувилбараар) тээврийн аюулгүй байдлын шаардлагад нийцүүлэхээр төлөвлөсөн байна.⁴¹

Хууль эрх зүйн орчин

ОХУ-ын тээврийн аюулгүй байдлыг зохицуулж буй эрх зүйн үндсэн акт нь 2007 онд батлагдсан “Тээврийн аюулгүй байдлын тухай холбооны хууль” (Федеральный закон о Транспортной безопасности) юм. Тус хуульд тээврийн аюулгүй байдал, аюулгүй байдлыг хангах зорилго, зорилт, үзэл баримтлал, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн үйл ажиллагаа, арга хэмжээг тодорхойлсон байна. Тус холбооны хууль нь ерөнхий хүрээг тогтоосон шинжтэй ба тус хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарсан

⁴¹ Стратегия развития внутреннего водного транспорта Российской Федерации на период до 2030 года, <http://static.government.ru/media/files/YxvWxYkzMQwAsfBmAX6anAVViKnFgYwA.pdf>

норматив эрх зүйн актуудаас бүрдэнэ.⁴²

“Тээврийн аюулгүй байдлын тухай холбооны хууль” нь 2007 онд батлагдсан ба дараах 13 зүйлээс бүрдэж байна.

- 1 дүгээр зүйл. Хуулийн нэр томьёо
- 2 дугаар зүйл. Тээврийн аюулгүй байдлыг хангах зорилго, зорилт
- 3 дугаар зүйл. Тээврийн аюулгүй байдлыг хангах зарчим
- 4 дүгээр зүйл. Тээврийн аюулгүй байдлыг хангах
- 5 дугаар зүйл. Тээврийн дэд бүтцийн объект ба тээврийн хэрэгслийн хууль бус халдлага болон эмзэг байдлыг үнэлгээ
- 6 дугаар зүйл. Тээврийн дэд бүтцийн байгууламж болон тээврийн хэрэгслийн ангилал
- 7 дугаар зүйл. Тээврийн дэд бүтцийн байгууламж, тээврийн хэрэгслийн аюулгүй байдлын түвшин
- 8 дугаар зүйл. Тээврийн аюулгүй байдлыг хангахад тавигдах шаардлага
- 9 дүгээр зүйл. Тээврийн дэд бүтцийн байгууламж, тээврийн хэрэгслийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт
- 10 дугаар зүйл. Тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангахтай шууд холбоотой ажлын гүйцэтгэлд тавих хязгаарлалт
- 11 дүгээр зүйл. Тээврийн аюулгүй байдлын талаарх мэдээллийн хангамж
- 11.1-зүйл. Тээврийн аюулгүй байдлын салбар дахь төрийн хяналт (шалгалт)
- 12 дугаар зүйл. Тээврийн аюулгүй байдлын салбар дахь тээврийн дэд бүтцийн субъект, тээвэрлэгчдийн эрх, үүрэг
- 12.1-р зүйл. Тээврийн аюулгүй байдлын хангах хүний нөөц бэлтгэх, баталгаажуулах, тээврийн аюулгүй байдлын албадын магадлан итгэмжлэл
- 12.2-р зүйл. Тээврийн аюулгүй байдлыг хангах үзлэг шалгалт, нэмэлт үзлэг, дахин хяналт шалгалт
- 12.3-р зүйл. Тээврийн дэд бүтцийн байгууламж, тээврийн хэрэгслийн хууль бус халдлагаас хамгаалалтын онцлог
- 13 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох.

“Тээврийн аюулгүй байдлын тухай холбооны хууль”-ийн зарим зохицуулалтууд.

2 дугаар зүйл. Тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангах зорилго, зорилт

1. Тээврийн аюулгүй байдлыг хангах зорилго нь тээврийн цогцолборын тогтвортой, найдвартай үйл ажиллагааг хангах, тээврийн цогцолбор дахь хууль бус халдлагаас хувь хүн, нийгэм, төрийн эрх ашгийг хамгаалахад оршино.

⁴² Конституция РФ;

Кодекс внутреннего водного транспорта РФ от 07.03.2001 № 24-ФЗ;

Положение о лицензировании перевозок внутренним водным транспортом пассажиров, утвержденное Постановлением Правительства РФ от 13 августа 2006 г. № 490;

Правила плавания по внутренним водным путям РФ, утвержденные приказом Минтранса РФ от 14.10.2002 № 129;

Правила пожарной безопасности на судах внутреннего водного транспорта РФ, утвержденные приказом Минтранса РФ от 24.12.2002 № 158;

Положение о минимальном составе экипажей самоходных транспортных судов, утвержденное приказом Минтранса России от 01.11.2002 № 138;

7. Положение о дипломировании членов экипажей судов внутреннего плавания, утвержденное Постановлением Правительства РФ от 31.05. 2005 № 349;

Положение об особенностях режима рабочего времени и времени отдыха работников плавающего состава судов внутреннего водного транспорта, утвержденное приказом Минтранса России от 1605.2003 № 133;

Положение о классификации судов внутреннего и смешанного (река - море) плавания, утвержденное приказом Минтранса РФ от 01.11.2002 № 136,

иные законодательные и ведомственные правовые акты.

2. Тээврийн аюулгүй байдлыг хангах гол зорилтууд нь:

- 1) тээврийн аюулгүй байдлыг хангах хууль эрх зүйн зохицуулалт;
- 2) хууль бус халдлага үйлдэх аюул заналыг тодорхойлох;
- 3) тээврийн дэд бүтэц, тээврийн хэрэгслийн эмзэг байдлын үнэлгээ;
- 4) тээврийн дэд бүтэц, тээврийн хэрэгслийн объектын ангилал;
- 5) тээврийн аюулгүй байдлыг хангах шаардлагыг боловсруулах, хэрэгжүүлэх;
- 6) тээврийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ боловсруулах, хэрэгжүүлэх;
- 7) тээврийн аюулгүй байдлын боловсон хүчний сургалт, баталгаажуулалт;
- 8) тээврийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр төрийн хяналтыг (шалгалтыг) хэрэгжүүлэх;
- 9) тээврийн аюулгүй байдлын мэдээлэл, материал-техникийн, шинжлэх ухаан-техникийн дэмжлэг;
- 10) тээврийн аюулгүй байдлын техникийн аргын баталгаажуулалт.

3 дугаар зүйл. Тээврийн аюулгүй байдлыг хангах зарчим

Тээврийн аюулгүй байдлыг хангах үндсэн зарчмууд нь:

- 1) хуульд нийцсэн байх;
- 2) хувь хүн, нийгэм, төр засгийн эрх ашгийн тэнцвэртэй байдлыг хангах;
- 3) тээврийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр хувь хүн, нийгэм, төрийн хамтын хариуцлага;
- 4) тасралтгүй байдлыг хангах;
- 5) Олон улсын аюулгүй байдлын тогтолцоонд нэгдэх;
- 6) тээврийн дэд бүтцийн субъектүүд, төрийн байгууллагууд, орон нутгийн өөрөө удирдах байгууллагуудын ажлын уялдаа холбоог хангах.

4 дүгээр зүйл. Тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангах

1. Энэхүү Холбооны хууль болон бусад холбооны хуулиар өөрөөр заагаагүй бол тээврийн дэд бүтцийн объект, тээврийн хэрэгслийн тээврийн аюулгүй байдлыг хангах үүргийн тээврийн дэд бүтцийн субъект, тээвэрлэгчдэд хүлээнэ.

2. Гүйцэтгэх эрх мэдлийн холбооны байгууллага нь энэхүү Холбооны хууль, бусад холбооны хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан ОХУ-ын бусад норматив хууль тогтоомжоор олгосон эрх мэдлийн хүрээнд тээврийн аюулгүй байдлыг хангана. ОХУ-ын субъектийн гүйцэтгэх мэдлийн байгууллага, орон нутгийн өөрөө удирдах байгууллага нь энэхүү Холбооны хууль, холбооны бусад хууль тогтоомж, болон тэдгээрт нийцүүлэн гаргасан ОХУ-ын бусад норматив хууль тогтоомжоор олгосон эрх мэдлийн хүрээнд тээврийн аюулгүй байдлыг хангахад оролцоно.

4. Тээврийн дэд бүтцийн объект, тээвэрлэгч нь тээврийн аюулгүй байдлыг хангах үүргийг тээврийн хэрэгслийн ажилтнуудад тэдгээрийн ажил үүргийн гүйцэтгэлийг саад болохгүй хэмжээнд тээврийн аюулгүй байдлыг хангах хариуцлагыг хүлээлгэх эрхтэй.

5. Тээврийн дэд бүтцийн объект, тээврийн хэрэгслийн тээврийн аюулгүй байдлыг гагцхүү гүйцэтгэх эрх мэдлийн холбооны байгууллага хангахыг холбооны хууль тогтоомж, ОХУ-ын Засгийн газрын норматив эрх зүйн актаар тогтооно.

6. Энэхүү хуулиар тээврийн дэд бүтцийн байгууллагад хамруулаагүй барилга, байгууламж, мөн тээврийн дэд бүтцийн байгууламжийн бүс (талбай)-д баригдаж буй

барилга байгууламжийг хууль бус халдлага, үүнд террорист үйл ажиллагаанаас хамгаалах асуудлыг энэхүү хуульд заасны дагуу тухайн дэд бүтцийн байгууламжийн ангиллыг харгалзан аюулгүй байдлыг хангана. Дээрх байгууламжийг хууль бус халдлагаа, үүнд террорист ажиллагаанаас хамгаалахад холбогдох дэд бүтцийн байгууламжийн тээврийн аюулгүй байдлыг хангах төлөвлөгөөгөөр тодорхойлно.

7. Тээврийн дэд бүтцийн байгууламж ба (эсхүл) тээврийн хэрэгсэлд хууль бус халдлагын аюул, заналхийллийн талаарх мэдээллийг шалгахад гүйцэтгэх эрх мэдлийн холбооны байгууллага байгууллага, ОХУ-ын субъектийн гүйцэтгэх мэдлийн байгууллага, орон нутгийн өөрөө удирдах байгууллага болон тээврийн дэд бүтцийн субъект, тээвэрлэгч нарын хамтын ажиллагааг тээврийн асуудал эрхэлсэн гүйцэтгэх эрх мэдлийн холбооны байгууллага, ОХУ-ын аюулгүй байдлыг хангах асуудал эрхэлсэн гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагатай зөвшилцөн ОХУ-ын Засгийн газар тогтооно.

“ОХУ-ын дотоодын усан замын тээврийн тухай хууль”⁴³

Тээврийн аюулгүй байдал гэх нэр томъёоноос “ОХУ-ын дотоодын усан замын тээврийн тухай хууль” 2001 он (Кодекс внутреннего водного транспорта Российской Федерации) болон “ОХУ-ын худалдааны далайн тээврийн үйл ажиллагааны тухай хууль” 1999 он (Кодекс торгового мореплавания Российской Федерации)-д - "усан замын тээврийн аюулгүй байдал" (безопасность судоходства), “хөлөг онгоцны хөвөлтийн аюулгүй байдал”, “далайн тээврийн аюулгүй байдал” зэрэг нэр томъёог хэрэглэж байна.

“ОХУ-ын дотоодын усан замын тээврийн тухай хууль” нь 19 бүлэг 167 зүйлээс бүрдэх ба дотоодын усан замын тээврийг зохицуулж буй гол хууль юм. Тус хууль нь дараах бүтэцтэй бөгөөд дотоодын усан замын аюулгүй байдлыг 6 бүлэгт зохицуулсан байна.

Бүлэг I. Ерөнхий зүйл

1 дүгээр зүйл. ОХУ-ын Дотоодын усан замын тээврийн тухай хуулиар зохицуулсан харилцаа

2 дугаар зүйл. ОХУ-ын Дотоодын усан тээврийн тухай хууль тогтоомж

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4 дүгээр зүйл. Дотоодын усан тээврийн төрийн зохицуулалт

4.1-р зүйл. Дотоодын усан тээврийн улсын хяналт

5 дугаар зүйл. Дотоодын усан тээврийн зарим төрлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл

6 дугаар зүйл. Тээвэрлэлтийн хөлс, төлбөр (хураамж)

Бүлэг II. Дотоодын усан зам

Бүлэг III. Хөлөг онгоц

Бүлэг IV. Хөлөг онгоцны эзэмшил, хөлөг онгоцны болон тэдгээрийн эрх улсын бүртгэл, хөвөх байгууламжийн бүртгэл

Бүлэг V. Хөлөг онгоцны баг

⁴³ Кодекс внутреннего водного транспорта Российской Федерации, 2001 <http://kvvt.ru>

Бүлэг VI. Усан замын тээврийн аюулгүй байдал

34 дүгээр зүйл. Ерөнхий зүйл

34.1. Ачааны аюулгүй байдлын удирдлагын систем

35 дугаар зүйл. Хөлөг онгоц болон хөвөх төхөөрөмжийг ангилах, шалгах

36 дугаар зүйл. Хүчингүй болсон

37 дугаар зүйл, 38 дугаар зүйл. Хүчингүй болсон

38.1. Боомтын улсын хяналт

39 дүгээр зүйл. Хөлөг онгоц эзэмшигчдийн байгаль орчныг хамгаалах үүрэг

40 дүгээр зүйл. Байгаль орчны аюулгүй байдлын хяналт

41 дүгээр зүйл. Хөлөг онгоцны жолоодлого (Лоцманская проводка судов)

Бүлэг VII. Хөлөг онгоц мөргөлдсөнөөс үүссэн хохирлын нөхөн олговор

Бүлэг VIII. Живсэн эд хөрөнгө

Бүлэг IX. Боомтууд

Бүлэг X. Хөлөг онгоц түрээслэх

Бүлэг XI. Ачаа тээвэрлэлт

Бүлэг XII. Хөлөг онгоц болон хөвөгч объектуудыг чирэх

Бүлэг XIII. Зорчигч, тэдгээрийн ачаа тээш, шуудангийн тээвэрлэлт

Бүлэг XV. Хөлөг онгоц эзэмшигч, тээвэрлэгч, чирэгч, ачаа илгээгч, ачаа хүлээн авагч, чирүүлж буй объектын илгээгч, хүлээн авагчийн хариуцлага

Бүлэг XVI. Хөлөг онгоц болон бусад эд зүйлсийг аврах ажиллагаа

Бүлэг XVII. Нийтлэг осол

Бүлэг XVIII. Нэхэмжлэл, акт, өргөдөл

Бүлэг XIX. Төгсгөлийн заалтууд

БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1 дүгээр зүйл. ОХУ-ын дотоод усан замын тээврийн тухай хуулиар зохицуулсан харилцаа

1. Энэ хууль нь дотоодын усан замд тээврийн үйл ажиллагаа явуулахтай холбоотойгоор ОХУ-ын дотоодын усан тээврийн байгууллага, ачаа илгээгч, ачаа хүлээн авагч, зорчигч болон бусад хувь хүн болон хуулийн этгээдийн хоорондын харилцааг зохицуулах ба тэдгээрийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлно.

2. Энэ хуулийн зохицуулалтууд нь дараахад үйлчилнэ:

- ОХУ-ын дотоодын усан зам ба түүн дээр байрлах усан замын гидротехникийн байгууламж, хөлөг онгоцны зогсоол;
- ОХУ-ын дотоодын усан замд байрлалтай боомтууд;
- ОХУ-ын дотоодын усан замд ашиглах зориулалт бүхий хөлөг онгоц болон хөвөх байгууламж.

3. Хуульд тусгайлан зааснаас бусад зохицуулалтууд нь байлдааны хөлөг онгоц, хилийн (хил хамгаалах) хөлөг онгоц, байлдааны туслах хөлөг онгоц, мөн төрийн тусгай хамгаалалтын объектын аюулгүй байдлыг хангах мөн (эсхүл) тээврийн үйлчилгээ

үзүүлэх зорилгоор ашиглаж буй хөлөг онгоцонд хамаарахгүй. Эдгээр (дурдсан) хөлөг онгоцны ОХУ-ын дотоодын усан замын тээврийн нөхцөлийг ОХУ-ын Засгийн газрын тогтоолоор тогтооно.

4. ОХУ-ын дотоодын усан замын аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлыг хангах, (үүнд аврах ажиллагаа орно) нөхцөл бүхий, навигаци-гидро газар зүйн хэсэгт, худалдааны далайн тээврийн шаардлага үйлчлэх ба худалдааны далайн тээврийн нөхцөлөөс үүсэж буй аюулгүй байдалтай холбоотой харилцааг ОХУ-ын худалдааны далайн тээврийн үйл ажиллагааны тухай хуулиар зохицуулах бол тээврийн гэрээнээс үүссэн харилцааг энэхүү хуулиар зохицуулна.

2 дугаар зүйл. ОХУ-ын дотоодын усан замын тээврийн тухай хууль тогтоомж

ОХУ-ын дотоодын усан замын тээврийн тухай хууль тогтоомж нь ОХУ-ын Үндсэн хууль, ОХУ-ын Иргэний хууль, энэ хууль, бусад холбооны хуулиудаас бүрдэнэ. ОХУ-ын дотоодын усан замын тээврийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг мөн ОХУ-ын Ерөнхийлөгчийн холбогдох норматив эрх зүйн акт, ОХУ-ын Засгийн газрын норматив эрх зүйн акт болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан гүйцэтгэх эрх мэдлийн холбооны байгууллагын энэ хууль болон холбооны бусад хуульд харшлаагүй норматив эрх зүйн актаар зохицуулна.

БҮЛЭГ VI. УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

34 дүгээр зүйл. Ерөнхий зүйл

2. Хөлөг онгоцны хөвөлтийн бэлтгэлийг хөлөг онгоцны эзэмшигч нь хангана.

Хөлөг онгоцны багийг зохих хэмжээнд бүрдүүлсэн мөн ОХУ-ын дотоодын усан замын тээврийн салбарын хууль тогтоомжоор тогтоосон усан замын тээврийн аюулгүйн, экологийн, эрүүл ахуйн болон галын аюулгүй байдлын шаардлагыг хангасан хөлөг онгоцыг хөвөлтөд тохирсонд тооцно. Хөлөг онгоцны баг нь тухайн хөлөг онгоцыг хөвөлтөд гарах өдөр тогтоосон доод хэмжээнээс цөөн бол хөвөлтөд тохирохгүйд тооцно.

3. Усан замын тээврийн аюулгүй байдлыг энэ хуульд заасан зохицуулалт болон Тээврийн асуудал эрхэлсэн гүйцэтгэх эрх мэдлийн холбооны байгууллагаас баталсан дотоодын усан замын тээврийн дүрэм, дотоодын усан замын сав газар дахь хөдөлгөөн болон зогсоолын дүрэм, дотоодын усан замын усан хаалт (шлюз)-аар нэвтрүүлэх, хөлөг онгоцны хөдөлгөөний диспетчерийн зохицуулалт ба дотоодын усан зам дахь хөлөг онгоцны удирдлагын дүрэм, Тээврийн асуудал эрхэлсэн гүйцэтгэх эрх мэдлийн холбооны байгууллагын Холбооны асуудал эрхэлсэн гүйцэтгэх эрх мэдлийн холбооны байгууллагатай хамтран баталсан дотоодын усан зам дахь хөдөлгөөнт радио холбоо болон хөдөлгөөнт хиймэл дагуулын үйлчилгээний дүрмээр тус тус зохицуулна.

4. Дотоодын усан замын сав газарт тээврийн аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий дотоодын усан замын сав газрын захиргаа нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

- 1) Дотоодын усан замын засвар үйлчилгээ;
- 4) Хөлөг онгоц, хөвөгч объектыг усан замын гидротехник байгууламжаар нэвтрүүлэх;
- 5) Хөвөлтийн тодорхой хязгаарлалт бүхий хөлөг онгоцны хөдөлгөөний диспетчерийн зохицуулалт ба дотоодын усан зам дахь хөлөг онгоцны

удирдлага;

6) Дотоодын усан замд технологийн холбооны зохион байгуулалт;

7) Боомтын улсын хяналт;

8) Хөлөг онгоцны улсын бүртгэлд хөлөг онгоц бүртгэх, гадаадын түрээсийн хөлөг онгоц бүртгэх, зогсож буй хөлөг онгоц бүртгэх;

9) Хөлөг онгоцны ахмадын баг болон спортын дарвуулт (далбаат) онгоцны багийг гэрчилгээжүүлэх;

10) Тогтоосон нөхцөлд далайчны баримт бичиг олгох;

11) Дотоодын усан замын сав газарт усан замын тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг гэрчилсэн жолоодлогын гэрчилгээ олгох (цаашид “жолоодох гэрчилгээ” /лоцманское удостоверение/);

12) энэ хуульд заасны дагуу бусад чиг үүрэг.

5. Дотоодын усан замд байрлах байгууламжийн өмчлөгч нь усан замын тээврийн аюулгүй ажиллагаанд аюул учруулж болзошгүй нөхцөл байдал үүссэнийг холбогдох арга хэмжээ авахуулахаар цаг тухайд нь дотоодын усан замын сав газрын захиргаанд мэдэгдэнэ.

8. ОХУ-ын Төрийн далбааг мандуулсан далайд тээвэр хийдэг хөлөг онгоц, эсхүл гадаад улсын далбаан дор тээвэр хийж буй хөлөг онгоц нь дотоодын усан замаар явах тохиолдолд дотоодын усан замын хөлөг онгоцны адилаар боомтын улсын хяналтад хамрагдана.

34.1 дүгээр зүйл. Хөлөг онгоцны аюулгүйн удирдлагын тогтолцоо

1. Бага оврын завь (20 метрээс богино, 12-оос дээшгүй суудалтай), аяллын завь (25 метрээс богино, 12-оос дээшгүй суудалтай), спортын дарвуулт завинаас бусад улсын бүртгэлд бүртгүүлэх хөлөг онгоц эзэмшигчид нь усан замын тээврийн аюулгүйн болон хүрээлэн буй орчныг бохирдуулахаас урьдчилан сэргийлэх шаардлагыг үр дүнтэй хангуулах чиглэсэн болон хөлөг онгоцтой холбоотой аюул, ослын нөхцөл байдалд хөлөг онгоц эзэмшигчийн ажилтнуудын (үүнд хөлөг онгоцны баг орно) авах арга хэмжээний баримтжуулсан цогц арга хэмжээ бүхий хөлөг онгоцны аюулгүйн удирдлагын тогтолцоог боловсруулж, хэрэгжүүлнэ (цаашид “аюулгүйн удирдлагын тогтолцоо” гэх).

1) энэ хуульд заасан хөлөг онгоцны аюулгүй ажиллагаа болон байгаль орчны бохирдлоос сэргийлэх хөлөг онгоц эзэмшигчийн ажилтнуудын заавар;

2) хөлөг онгоцны аюулгүй ажиллагаа, байгаль орчны бохирдлоос сэргийлэхэд хөлөг онгоцны ашиглалтыг удирдаж буй хөлөг онгоц эзэмшигчийн ажилтнуудын эрх үүрэг болон хоорондын харьцааг тогтоосон баримт бичиг;

3) хөлөг онгоцны аюулгүй ажиллагаа, байгаль орчны бохирдлоос сэргийлэхэд хөлөг онгоц эзэмшигчийн хөлөг онгоцны багийн гишүүдийн эрх үүрэг, хоорондын харьцааг тогтоосон баримт бичиг;

4) хөлөг онгоцны эзэмшигчийн ажилчид болон хөлөг онгоцны багийн гишүүдийн хоорондын харилцааны журам;

5) хууль тогтоомж, мөн (эсхүл) хөлөг онгоц эзэмшигчийн шаардлагыг үл биелүүлсэн талаарх мэдээлэл, хөлөг онгоцны баг ослын талаарх мэдээллийг дамжуулах журам;

6) ослын нөхцөл байдал үүсэхэд хөлөг онгоцны багийн гишүүд болон хөлөг

- онгоц эзэмшигчийн бусад ажилтнуудын авах арга хэмжээний журам;
- 7) Хөлөг онгоц эзэмшигчийн дараах үүргийг тогтоосон баримт бичиг:
Хөлөг онгоцны багийн гишүүд хөлөг онгоцны аюулгүй ажиллагааг хангах;
Хөлөг онгоцны аюулгүй ажиллагаанд шаардлагатай тушаал, заавар гаргах;
Хөлөг онгоцыг аюулгүй ажиллуулахад тавигдах шаардлагын биелэлтийг шалгах;
Аюулгүйн удирдлагын тогтолцооны дутагдлын талаар хөлөг онгоц эзэмшигчид цаг тухайд нь мэдээллэх;
 - 8) Амь нас, эрүүл мэндийг хамгаалах үүрэг хариуцлагыг багтаасан хөлөг онгоцны ахмадын онцгой эрх мэдлийг багтаасан хөлөг онгоцны ахмадын байгаль орчны бохирдлоос сэргийлэх, хөлөг онгоцны аюулгүй ажиллагааг хангах эрх мэдлийг тогтоосон баримт бичиг;
 - 9) Ослын нөхцөл байдлын үед авах арга хэмжээний хөлөг онгоцны багийн сургалтын хөтөлбөр;
 - 10) Шинээр ажилд орсон, эсхүл хөлөг онгоцонд томилогдсон хөлөг онгоцны багийн гишүүнийг хөлөг онгоцыг хөдлөхөөс өмнө түүний эрхлэх ажил, үүргийг танилцуулах журам;
 - 11) Хөлөг онгоц эзэмшигчийн ажилтныг ажилд авах, байгаль орчны бохирдлоос сэргийлэх, хөлөг онгоцны аюулгүй ажиллагаа хариуцсан үүрэг бүхий өөр ажилд томилоход түүний ажил, үүргийг танилцуулах журам;
 - 12) Хөлөг онгоцны аяллыг төлөвлөх, түүний аяллын аюулгүй байдлыг хангах журам;
 - 13) Хөлөг онгоцны механизм, багаж, тоног төхөөрөмжийн найдвартай байдлыг хангах арга хэмжээ, үүнд байнга хэрэглэгддэггүй механизм, багаж, тоног төхөөрөмжийн тогтмол хяналт;
 - 14) Хөлөг онгоцны аюулгүйн удирдлагын тогтолцооны үр нөлөөний хяналт, шаардлагатай бол шинэчлэл хийх журам.

2. Аюулгүйн удирдлагын тогтолцоог боловсруулах, хэрэгжүүлэх журмыг тээврийн асуудал эрхэлсэн гүйцэтгэх эрх мэдлийн холбооны байгууллага батална.

3. Хөлөг онгоц эзэмшигч нь хөлөг онгоцны аюулгүй ажиллагааг хангах, эзэмшигч болон хөлөг онгоц дээр байрлах иргэдийг холбох үүрэг бүхий (хөлөг онгоцны багийн гишүүн бус) ажилтан, эсхүл ажилтнуудыг томилно. Хөлөг онгоцны аюулгүй ажиллагаа хариуцсан ажилтанд гэрчилгээ олгох, мэргэжлийн ур чадварын, мэргэшлийн шаардлага, мэргэжлийн боловсролын, мэргэшлийн нэмэлт сургалтын шаардлагыг энэ хуулийн 2 дугаар зүйлд заасны дагуу тогтооно. Эдгээр ажилтны үүрэгт хөлөг онгоц эзэмшигчийн ажилтнуудын хөлөг онгоцыг аюулгүй ажиллуулах, байгаль орчны бохирдлоос сэргийлэхэд авч буй арга хэмжээний биелэлтэд хяналт тавих, хөлөг онгоцны аюулгүйн шаардлагыг хангуулах зэрэг орно.

4. Хөлөг онгоц эзэмшигч нь дараахийг хангана:

- 1) Хөлөг онгоцыг ашиглах бүс болон түүний төрөлд таарсан хөлөг онгоцны ахмадын зохих мэргэжлийн ур чадварын шаардлага, мэргэшлийн шаардлагыг хангуулах;
- 2) Хөлөг онгоцны ахмадыг хөлөг онгоцны аюулгүй удирдлагын тогтолцоотой танилцуулах;
- 3) Хөлөг онгоцны ахмадын үүргийг хангуулах.

5. Хөлөг онгоц эзэмшигч нь хөлөг онгоцны үйл ажиллагааг энэ заалтад заасан шаардлагын дагуу боловсруулан, хэрэгжүүлж буй аюулгүй удирдлагын тогтолцоонд нийцэж буйг баталсан баримт бичигтэйгээр явуулна. Техникийн хяналтын баримт бичгийг хөлөг онгоц эзэмшигчид, тээврийн асуудал эрхэлсэн гүйцэтгэх эрх мэдлийн холбооны байгууллагаас эрх олгосон хөлөг онгоц ангилах, техникийн хяналт тавих эрх бүхий байгууллагаас, эсхүл тээврийн асуудал эрхэлсэн гүйцэтгэх эрх мэдлийн холбооны байгууллагаас эрх олгосон олон улсын хөлөг онгоцны техникийн хяналтын байгууллага (Ангиллын нийгэмлэг) нь энэ хуулийн 2 дугаар заалтад заасан журмын дагуу энэ заалтад заасан шаардлагыг хянасны дараагаар олгоно. Техникийн хяналтын баримтыг 5 жилийн хугацаагаар олгоно.

6. Хөлөг онгоцны аюулгүй ажиллагааны техникийн хяналтын баримт бичгийг тээврийн асуудал эрхэлсэн гүйцэтгэх эрх мэдлийн холбооны байгууллагаас эрх олгосон хөлөг онгоц ангилах, техникийн хяналт тавих эрх бүхий байгууллагаас, эсхүл тээврийн асуудал эрхэлсэн гүйцэтгэх эрх мэдлийн холбооны байгууллагаас эрх олгосон олон улсын хөлөг онгоцны техникийн хяналтын байгууллага (Ангиллын нийгэмлэг) нь (хөлөг онгоцны баггүй ажилладаг хөлөг онгоцноос бусад) хөлөг онгоцны аюулгүйн удирдлагын тогтолцоог хөлөг онгоц эзэмшигч, өмчлөгч заалтад заасан шаардлагын дагуу боловсруулж, хөлөг онгоцонд зохих байдлаар хэрэгжүүлж буйг нотлон хөлөг онгоцонд олгоно.

Хөлөг онгоц эзэмшигч, өмчлөгч нь аюулгүйн удирдлагын гэрчилгээ хүсэхэд хөлөг онгоцонд аюулгүйн удирдлагын тогтолцооны хэрэгжилтийн хяналтыг явуулах өргөдлийг тээврийн асуудал эрхэлсэн гүйцэтгэх эрх мэдлийн холбооны байгууллагаас эрх олгосон хөлөг онгоц ангилах, техникийн хяналт тавих эрх бүхий байгууллагаас, эсхүл тээврийн асуудал эрхэлсэн гүйцэтгэх эрх мэдлийн холбооны байгууллагаас эрх олгосон олон улсын хөлөг онгоцны техникийн хяналтын байгууллага (Ангиллын нийгэмлэг)-д нь энэ хуулийн 2 дугаар заалтад заасан журмын дагуу гаргаж, хяналтаар орно. Хөлөг онгоц эзэмшигч, өмчлөгч нь аюулгүйн удирдлагыг хэрэгжүүлж буй гэрчилгээг 5 жилийн хугацаагаар олгох ба түүний хүчинтэй байх хугацааны 2 ба 3 дахь жилийн хооронд тээврийн асуудал эрхэлсэн гүйцэтгэх эрх мэдлийн холбооны байгууллагаас эрх олгосон хөлөг онгоц ангилах, техникийн хяналт тавих эрх бүхий байгууллагаас, эсхүл тээврийн асуудал эрхэлсэн гүйцэтгэх эрх мэдлийн холбооны байгууллагаас эрх олгосон олон улсын хөлөг онгоцны техникийн хяналтын байгууллага (Ангиллын нийгэмлэг) нь энэ хуулийн 2 дугаар заалтад заасан журмын дагуу хөлөг онгоц дээр аюулгүй удирдлагын тогтолцооны хэрэгжилтийг хянасны дараа баталгаажуулна.

7. Хөлөг онгоцны баггүй ажилладаг хөлөг онгоцны хувьд энэ 34.1-р зүйлийн 3-10-р заалт, энэ зүйлийн 6-р заалт хамаарахгүй. Өөрөө явагч бус хөлөг онгоц (несамоходные суда)-ы хувьд 34.1 дүгээр зүйлийн 1-3, 7-11, 13-р заалт, 34.4-р заалт хамаарахгүй.

8. Хөлөг онгоц нь аюулгүйн удирдлагын гэрчилгээ болон хөлөг онгоц эзэмшигч, өмчлөгч нь тухайн хөлөг онгоцны техникийн хяналтын баримт бичгийг ОХУ-ын олон улсын гэрээнд заасан нөхцөлийн дагуу олгосон бол энэ зүйлд заасан хөлөг онгоц эзэмшигчид тавигдах шаардлагыг бүрэн хангасанд тооцно.

35 дугаар зүйл. Хөлөг онгоц болон хөвөх төхөөрөмжийг ангилах, техникийн

хяналт тавих

1. Арилжааны бус зорилгоор ашиглаж буй бага оврын завинаас бусад улсын бүртгэлд бүртгүүлэх шаардлагатай хөлөг онгоцыг хөлөг онгоц эзэмшигч, өмчлөгчийн зардлаар тээврийн асуудал эрхэлсэн гүйцэтгэх эрх мэдлийн холбооны байгууллагаас эрх олгосон хөлөг онгоц ангилал, техникийн хяналт тавих эрх бүхий байгууллагаас, эсхүл тээврийн асуудал эрхэлсэн гүйцэтгэх эрх мэдлийн холбооны байгууллагаас эрх олгосон олон улсын хөлөг онгоцны техникийн хяналтын байгууллага (Ангиллын нийгэмлэг) ангилж, техникийн хяналт тавина.

Байгууллага, үүнд гадаадын ангиллын нийгэмлэгт ангилах, техникийн хяналт тавих эрхийг олгох журам, мөн тэдгээрт тавигдах шаардлагыг тээврийн асуудал эрхэлсэн гүйцэтгэх эрх мэдлийн холбооны байгууллага тогтооно.

2. 1-р хэсэгт заасан хөлөг онгоцны ангилал, техникийн хяналтыг хөлөг онгоцны ангилал, техникийн хяналт тавих тухай зохицуулалт, хөлөг онгоцны ашиглалтын явцад техникийн хяналт тавих журам, хөлөг онгоцыг барилгын явцад тавих техникийн хяналтын дүрэм, барихад хэрэглэх материал, эдлэл үйлдвэрлэлийн техникийн хяналтын дүрэм, Хөлөг онгоцноос үүдэлтэй бохирдлоос сэргийлэх дүрэм ба хөлөг онгоцны ангилал болон энэ хуулийн 14 дүгээр зүйлийн 1 заалтын 3, 4, 6 дугаар хэсэгт заасан бусад баримт бичиг олгох хөлөг онгоцны ангилал болон техникийн хяналтын дүрэмд заасны дагуу явуулна.

Хөлөг онгоц ангилах болон техникийн хяналт тавих зохицуулалтад хөлөг онгоц ангилах, техникийн хяналт тавих журам, гэрчилгээ олгохоос татгалзах үндэслэл, ангиллын гэрчилгээ болон энэ хуулийн 14 дүгээр зүйлийн 1 заалтын 3, 4, 6 дугаар хэсэгт заасан бусад баримт бичгийн үйлчлэх хугацааг түдгэлзүүлэх, хүчингүй болгох үндэслэлийг тус тус заана.

Хөлөг онгоцны ангилал болон техникийн хяналтын зохицуулалтыг тээврийн асуудал эрхэлсэн гүйцэтгэх эрх мэдлийн холбооны байгууллага батална.

Хөлөг онгоцны ашиглалтын явцад техникийн хяналт тавих журам, хөлөг онгоцыг барилгын явцад тавих техникийн хяналтын дүрэм, барихад хэрэглэх материал, эдлэл үйлдвэрлэлийн техникийн хяналтын дүрэм, хөлөг онгоц ангилах болон барих дүрэм, хөвөгч байгууламж ангилах, техникийн хяналт тавих дүрмийг тээврийн асуудал эрхэлсэн гүйцэтгэх эрх мэдлийн холбооны байгууллагаас ангилах, техникийн хяналт тавих эрх олгосон байгууллага боловсруулж, батална. Хөлөг онгоцноос үүдэлтэй бохирдлоос сэргийлэх журмыг тээврийн асуудал эрхэлсэн гүйцэтгэх эрх мэдлийн холбооны байгууллага болон байгаль орныг хамгаалах асуудал эрхэлсэн гүйцэтгэх эрх мэдлийн холбооны байгууллагатай зөвшилцөн боловсруулж, батална.

3. Арилжааны бус зорилгоор ашиглаж буй бага оврын завинаас бусад улсын бүртгэлд бүртгүүлэх шаардлагатай хөлөг онгоцыг ОХУ-ын Засгийн газраас эрх олгосон гүйцэтгэх эрх мэдлийг холбооны байгууллага ангилж, техникийн хяналтыг тавина.

4. Хөвөгч байгууламжийг түүний эзэмшигч, өмчлөгчийн зардлаар тээврийн асуудал эрхэлсэн гүйцэтгэх эрх мэдлийн холбооны байгууллагаас ангилах, техникийн хяналт тавих эрх олгосон байгууллага, эсхүл тээврийн асуудал эрхэлсэн гүйцэтгэх эрх мэдлийн холбооны байгууллагаас ангилах, техникийн хяналт тавих эрх олгосон байгууллагаас эрх олгосон гадаадын ангиллын нийгэмлэг хөлөг онгоц ангилах,

техникийн хяналт тавих журмын дагуу ангилж, техникийн хяналт тавина.

Тээврийн асуудал эрхэлсэн гүйцэтгэх эрх мэдлийн холбооны байгууллагаас ангилах, техникийн хяналт тавих эрх олгосон байгууллага, эсхүл тээврийн асуудал эрхэлсэн гүйцэтгэх эрх мэдлийн холбооны байгууллагаас ангилах, техникийн хяналт тавих эрх олгосон байгууллагаас эрх олгосон гадаадын ангиллын нийгэмлэг нь дээрх дүрмүүдийг мөрдөөгүй тохиолдолд хөвөгч байгууламжид хөвөгч байгууламжийн нийцлийн гэрчилгээ олгохгүй, өмнө олгосон нийцлийн гэрчилгээг түдгэлзүүлэх, хүчингүй болгоно.

38.1-р зүйл. Боомтын улсын хяналт

1. Дотоодын усан зам дахь хөлөг онгоц болон хөвөгч байгууламжийн боомтын улсын хяналтыг (цаашид “боомтын улсын хяналт”) улсын хяналтын дотоодын усан замын сав газрын захиргааны бүтцэд багтах боомтын хяналт шалгалтын албан хаагч хэрэгжүүлнэ.

2. Дотоодын усан замын сав газрын ахмад нь улсын хяналтын дотоодын усан замын сав газрын захиргааны бүтцэд багтах боомтын улсын хяналт шалгалтыг тэргүүлж, дотоодын усан замын тээврийн төрийн өмчийг удирдах, төрийн үйлчилгээ үзүүлэх гүйцэтгэх эрх мэдлийг холбооны байгууллагад шууд захирагдаж, ОХУ-ын Засгийн газраас тогтоосон журмын дагуу тээврийн асуудал эрхэлсэн гүйцэтгэх эрх мэдлийн холбооны байгууллагын баталсан дотоодын усан замын сав газрын ахмадын тухай зохицуулалтыг үндэслэн үйл ажиллагаа явуулна.

Дотоодын усан замын сав газрын ахмад ба боомтын улсын хяналтыг хэрэгжүүлэх этгээд нь ОХУ-ын харьяат байх ба гадаадын улсын харьяат байж болохгүй, эсхүл ОХУ-ын харьяат гадаад улсад удаан хугацаагаар оршин суух эрх, буюу түүнийг гэрчлэх бусад баримт бичгийг эзэмшиж болохгүй. Дотоодын усан замын сав газрын ахмадад тавигдах мэргэжлийн болон бусад шаардлагыг дотоодын усан замын сав газрын ахмадын тухай зохицуулалтаар тогтооно.

3. Боомтын улсын хяналт нь дотоодын усан замд байрлах хөлөг онгоц, хөвөгч байгууламжийн багаж, тоног төхөөрөмж, хөлөг онгоцны машин, механизм, аврах болон бусад хэрэгсэлд тавих шаардлага, тэдгээр хөлөг онгоц, хөвөгч байгууламжийн аюулгүй ашиглалтын шаардлага, хөлөг онгоцны багт тавигдах мэргэжлийн ба ур чадварын шаардлага зэргийг хангаж буй эсэхийг хянан, шалгахгаас бүрдэнэ.

4. Дотоодын усан замд байрлах хөлөг онгоц болон хөвөгч байгууламжийн шалгалтын боомтыг улсын хяналт хэрэгжүүлэх албан хаагч, дотоодын усан замын сав газрын ахмадын тушаал (захирамж)-д нийцсэн төлөвлөгөөт даалгаврын үндсэн дээр хэрэгжүүлнэ.

5. Төлөвлөгөөт даалгаврын агуулга ба түүнийг боловсруулах журам, хөлөг онгоц, хөвөгч байгууламжид заавал тавигдах шаардлагын дүнд үндэслэн шалгалтыг явуулах журам, боомтын улсын хяналтын мэдээллийн системд боомтын улсын хяналтын дүнгийн төвлөрсөн бүртгэлийн журам, боомтын улсын хяналт хэрэгжүүлэх этгээдэд тавигдах мэргэжлийн, мэргэшлийн шаардлагыг тээврийн асуудал эрхэлсэн гүйцэтгэх эрх мэдлийн холбооны байгууллага батална.

6. Дотоодын усан замын сав газрын ахмад болон боомтын улсын хяналт

хэрэгжүүлж буй этгээд нь усан замын тээврийн хяналтын байцаагч байх ба дараах эрхтэй:

- 1) Гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага, орон нутгийн өөрийн удирдах байгууллага, хуулийн этгээд, иргэд (үүнд хувиараа хөдөлмөр эрхлэгч)-ээс хяналт шалгалт явуулах явцад шаардагдах баримт бичгийг үндэслэл бүхий хүсэлтийн үндсэн дээр албан бичгээр хүсэх;
- 2) Ажлын үнэмлэх болон дотоодын усан замын сав газрын ахмадын шалгалт явуулах тушаал (захирамжийн) хуулбарыг үндэслэн дотоодын усан замын сав газарт байрлах хөлөг онгоц, хөвөгч байгууламжид чөлөөтэй нэвтрэх, хөлөг онгоцны ашиглалтын шинж чанар, багаж, тоног төхөөрөмж, машин механизмыг ажиллагааг хянан шалгах;
- 3) Хөлөг онгоц эзэмшигч, өмчлөгч нарт заавал тавигдах шаардлагын зөрчлийг арилгуулах үүрэг өгөх, хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчин, хувь хүн болон хуулийн этгээдийн өмч, улсын болон орон нутгийн өмчид аюул хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ, байгалийн гаралтай гамшиг, техникийн холбогдолтой ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахуулах;
- 4) Заавал тавигдах шаардлагын зөрчилтэй холбоотой захиргааны зөрчлийн тухай протокол хөтлөх, тодорхой захиргааны зөрчлийг шалган шийдвэрлэж, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;
- 5) Заавал тавигдах шаардлагын зөрчилтэй холбоотойгоор, гэмт хэргийн шинжийг үндэслэн эрүүгийн хэрэг үүсгэх эсэх асуудлаар эрх бүхий байгууллагад баримт бичиг хүргүүлэх;
- 6) Шалгалтын явцад заавал тавигдах шаардлагын зөрчлийг илрүүлсэн мөн хөлөг онгоц, хөвөгч байгууламжийн ашиглалт, эсхүл тээврийн аюулгүй ажиллагаанд аюул учруулахуйц зөрчлийг арилгуултал хөлөг онгоц, хөвөгч байгууламжийг түр саатуулах шийдвэр гаргах. Хөлөг онгоц, хөвөгч байгууламжийг түр саатуулах үндэслэлүүд (заавал тавигдах шаардлагын зөрчлүүдийн жагсаалт) болон түр саатуулах дээд хугацааг тээврийн асуудал эрхэлсэн гүйцэтгэх эрх мэдлийн холбооны байгууллага тогтооно;

7. Энэ хуулийн 6-р заалтын 6-р хэсэгт заасан зөрчлийг хөлөг онгоц, хөвөгч байгууламжийг түр саатуулсан газарт арилгах боломжгүй бол боомтын улсын хяналтыг хэрэгжүүлж буй этгээд нь хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчинд аюул учруулахгүй, мөн усан замын тээврийн хөдөлгөөнд саад учруулахгүй нөхцөлд илрүүлсэн зөрчлийг арилгах газарт шилжүүлэх /нүүлгэх/-ийг зөвшөөрч болно. Хөлөг онгоц, хөвөгч байгууламжийн зөрчлийг арилгуулах газарт шилжүүлэх эрхийг олгох нөхцөл, журмыг тээврийн асуудал эрхэлсэн гүйцэтгэх эрх мэдлийн холбооны байгууллага тогтооно.

39 дүгээр зүйл. Хөлөг онгоц эзэмшигчдийн байгаль орчныг хамгаалах үүрэг

1. Байгаль орчныг бохирдуулахаас урьдчилан сэргийлэх үүргийг хөлөг онгоц эзэмшигч хүлээнэ. Хөлөг онгоц эзэмшигч нь хөлөг онгоцноос газрын тосоор бохирдуулахаас урьдчилан сэргийлэх, энэ төрлийн бохирдлын үр дагаврыг арилгах онцгой арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, тээврийн асуудал эрхэлсэн гүйцэтгэх эрх мэдлийн холбооны байгууллагаас баталсан журмын дагуу төлөвлөгөөний хэрэгжилтийг хангана.

Энэ хуульд заасан газрын тосонд (үүнд түүхий тос, мазут, хүнд дизель түлш, тосолгооны тос) түүнийг хөлөг онгоцонд ачаа хэлбэрээр тээвэрлэж буй, эсхүл бункерийн түлш хэлбэрээр ашиглах буйгаас үл хамааран аливаа тогтвортой нүүрс-устөрөгчийн шингэнийг ойлгоно. Хөлөг онгоцны бункерийн түлш (бункерное топливо) нь хөлөг онгоцыг ашиглах, эсхүл хөлөг онгоцны багийн үйл ажиллагаанд шаардагдах газрын тосны бүтээгдэхүүн (үүнд тосолгооны тос), түүний хаягдлыг хэлнэ.

2. Хөлөг онгоцноос үүдэлтэй бохирдлоос сэргийлэх шаардлагыг энэ хуулийн 35-р зүйлийн 2-т заасан Хөлөг онгоцноос үүдэлтэй бохирдлоос сэргийлэх дүрмээр тогтооно.

40 дүгээр зүйл. Байгаль орчны аюулгүй байдлын хяналт

Дотоодын усан замын сав газрын захиргаа нь дотоодын усан замын тээврийн холбогдох сав газрын захиргааны үйл ажиллагааны бүсэд байгаль орчныг хамгаалах байгууламжийн ажиллагаа, байршуулалтад хяналт тавьж, мөн экологийн аюулгүй байдлын асуудлаар хөлөг онгоц эзэмшигч, өмчлөгч, хөлөг онгоцны ахмадуудад мэдээллийн үйлчилгээ үзүүлнэ.

2.2. БҮГД НАЙРАМДАХ ФИНЛАНД УЛС

Бүгд Найрамдах Финланд Улс нь “Мянган нуурын орон” гэж алдаршсан ба Финландын Далайн захиргаа нь нийт 16 мянга гаруй км усан зам хариуцдаг бол үүнээс 8,2 мянган км далайн эрэг орчмын, 7,8 мянган км нь дотоодын усан зам байдгаас 4 мянга гаруй км нь арилжааны тээврийн зориулалтаар ашиглагддаг байна.⁴⁴ Тус улсын хамгийн том нуур болох Сайма нь 4400 мянган км² талбайтай, Европын томоохон нууруудын тоонд багтдаг. Тус нуур болон дотоодын усан замаар мод, химийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн болон барилгын материал, түүхий эд тээвэрлэгдэг байна. 2012 онд дотоодын усан замаар нийт 316,000 зорчигч тээвэрлэсэн байна.

Финландын усан зам нь нарийн, мушгираа ихтэй, гүехэн эрэгтэй, өвлийн улиралд эрэг орчмын ус хөлддөг зэрэг нь усан замын тээвэрт хүндрэл учруулдаг байна.

Хууль эрх зүйн орчин⁴⁵

⁴⁴ <https://www.liikennevirasto.fi/web/en/waterways#.W6i9xC2B3Sw>

[http://www.europarl.europa.eu/RegData/etudes/BRIE/2016/563423/IPOL_BRI\(2016\)563423_EN.pdf](http://www.europarl.europa.eu/RegData/etudes/BRIE/2016/563423/IPOL_BRI(2016)563423_EN.pdf)

⁴⁵ Act on Security Measures on certain Ships and in Ports serving them and on monitoring the Security Measures

<https://www.finlex.fi/en/laki/kaannokset/2004/en20040485.pdf>

1. Act on Ships' Crews and the Safety Management of Ships https://www.finlex.fi/fi/laki/kaannokset/2009/en20091687_20140878.pdf
2. Act on the Finnish Transport Safety Agency (863/2009)
3. Government Decree on the Finnish Transport Safety Agency (865/2009)
4. Interoperability of information systems Act on Transport Services (320/2017)
5. Ship safety Act on the Technical Safety and Safe Operation of Ships (1686/2009)
6. Certification of seafarers Act on Ships' Crews and the Safety Management of Ships (1687/2009)
7. Government Decree on the Manning of Ships and Certification of Seafarers(166/2013)
8. Medical fitness examinations Act on Medical Fitness Examinations of Seafarers (1171/2010)
9. Act on the Register of Medical Fitness Examinations of Seafarers (25/1999)
10. Act on Certifying Medical Practitioners Authorised to Conduct Medical Fitness Examinations of Seafarers (47/2009)
11. Decree of the Ministry of Social Affairs and Health on the Standards of Eyesight and Hearing required of Seafarers (224/2013)
12. Working and living conditions of seafarers Act on the Working and Living Environment and Catering for Seafarers on Board Ships (395/2012)
13. Government Decree on Catering for Seafarers on Board Ships (820/2012)
14. Ships' medical stores Act on Ships' Medical Stores (584/2015)
15. Decree of the Ministry of Social Affairs and Health on Ships' Medical Stores(589/2015)
16. Inspections and port state control Ship Safety Control Act (370/1995)
17. Government Decree on Inspecting Foreign Ships in Finland (1241/2010)
18. Ice classes of ships Act on the Ice Classes of Ships and Icebreaker Assistance (1121/2005)
19. Register of ships Register of Ships Act (512/1993)
20. Register of Ships Decree (874/1993)

Финландын далайн ба дотоодын усан замын тээврийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн гол хууль болох 2009 онд батлагдсан “**Хөлөг онгоцны аюулгүй ажиллагаа, техникийн аюулгүй байдлын тухай хууль**”⁴⁶ нь 13 бүлэг 97 зүйлээс бүрдэнэ.

Бүлэг I. Ерөнхий зүйл

Бүлэг II. Далайд хүний аюулгүй байдлыг хангах тухай олон улсын конвенц (SOLAS)-д хамаарах хөлөг онгоцны аюулгүй ажиллагааны шаардлага

Бүлэг III. SOLAS-бус Удирдамжид хамаарах дотоодын аялал үйлдэгч зорчигч тээврийн хөлөг онгоцны аюулгүй байдлыг хангах шаардлага

Бүлэг IV. Загас агнуурын хөлөг онгоц, тусгай зориулалтын хөлөг онгоц, бусад хөлөг онгоц болон дугуйт техник тээвэрлэх тавцант усан онгоц (ro-ro ships)-ны нуман хаалга (bow doors)-тай холбоотой тусгай шаардлагууд

Бүлэг V. Даацын тэмдэглэгээ

Бүлэг VI. Хөлөг онгоцны хяналт, шалгалт

Бүлэг VII. Хөлөг онгоцны багтаамжийн хэмжилт

Бүлэг VIII. Хөлөг онгоцны ажиллагаа

Бүлэг IX. Хөлөг онгоц дахь нисдэг тэрэгний ажиллагаа

Бүлэг X. Бусад зохицуулалтууд

Бүлэг XI. Торгууль

Бүлэг XII. Давж заалдах

Бүлэг XIII. Хүчин төгөлдөр болох

Бүлэг I. Ерөнхий зүйл

1 дүгээр зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

Энэхүү хуульд техникийн аюулгүй байдал, даацын тэмдэглэгээ, хөлөг онгоцны хяналт шалгалт, хөлөг онгоцны багтаамжийн хэмжилт ба хөлөг онгоцны аюулгүй ажиллагаатай холбоотой зохицуулалтыг тусгасан болно.

2 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

1. SOLAS Convention – 1974 оны Далайд хүний аюулгүй байдлын хангах тухай олон улсын конвенцыг хэлнэ;

2. Non-SOLAS Directive – Европын Парламент, Зөвлөлөөс баталсан зорчигч тээврийн хөлөг онгоцны аюулгүй байдлыг хангах дүрэм, стандарт (2009/45/EC Удирдамж)-ыг хэлнэ.⁴⁷

21. Act on Enhancing the Competitiveness of Ships engaged in Sea Transport(1277/2007)

22. Pollution prevention Act on Environmental Protection in Maritime Transport (1672/2009)

23. Act on Oil Pollution Response (1673/2009)

24. Ship and port security Act on Security Measures on certain Ships and in Ports serving them and on monitoring the Security Measures (485/2004)

25. VTS Vessel Traffic Service Act (623/2005)

26. Government Decree on Vessel Traffic Service (763/2005)

27. Pilotage Pilotage Act (940/2003)

28. Fairway dues Act on Fairway Dues (1122/2005)

⁴⁶ https://www.finlex.fi/en/laki/kaannokset/2009/en20091686_20160474.pdf

https://www.trafi.fi/filebank/a/1332425400/a3068aad82335cf237e9bbdea3cafefd/9462-Alusturvallisuuslaki_EN.pdf

⁴⁷ Non-SOLAS Directive means Directive 2009/45/EC of the European Parliament and of the Council on safety rules and standards for passenger ships

<https://eur-lex.europa.eu/LexUriServ/LexUriServ.do?uri=OJ:L:2009:163:0001:0140:EN:PDF>

Бүлэг III. SOLAS-бус Удирдамжид хамаарах дотоодын аялал үйлдэгч зорчигч тээврийн хөлөг онгоцны аюулгүй байдлыг хангах шаардлага

14 дүгээр зүйл. Зорчигч тээврийн хөлөг онгоцны ангилал

1. SOLAS-бус Удирдамжид хамаарах дотоодын аялал үйлдэгч зорчигч тээврийн хөлөг онгоцыг тэдгээрийн байрлаж байгаа газраас хамааран А, В, С, D гэж ангилна.

2. 1 дэх хэсэгт заасан далайн бүс нутгийн заагийг Финландын Тээврийн аюулгүй байдлын агентлаг (Finnish Transport Safety Agency) тогтооно.

3. Радио холбоотой зохицуулалтыг хэрэглэхдээ далайн бүс нутгийн заагийг IV бүлэгт заасан SOLAS Конвенцод заасныг дагаж мөрдөнө.

15 дугаар зүйл. Техникийн аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлагууд

1. SOLAS-бус Удирдамжид хамаарах зорчигч тээврийн хөлөг онгоцнууд нь SOLAS-бус Удирдамжид холбогдох ангиллын хөлөг онгоцонд тогтоосон техникийн аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлагуудыг дагаж мөрдөнө.

2. SOLAS-бус Удирдамжид хамаарах хөлөг онгоцнууд нь хөлөг онгоцны их бие, машин механизм, цахилгаан угсралт болон хөлөг онгоцны автоматжуулалттай холбоотойгоор ангиллын нийгэмлэгээс гаргасан дүрмийг, эсхүл Финландын Тээврийн аюулгүй байдлын агентлагаас баталсан адил тэнцүү дүрэм, журмыг дагаж мөрдөнө.

3. SOLAS-бус Удирдамжийг мөрдөхөд Финландын Тээврийн аюулгүй байдлын агентлаг нь хөлөг онгоцны техникийн аюулгүй байдлын нарийвчилсан дүрэм, журмыг боловсруулж, мөрдүүлнэ.

16 дугаар зүйл. Аюулгүй ажиллагааны нэмэлт шаардлагууд

1. Хөлөг онгоцны аюулгүй ажиллагааны зохих түвшинг хангахын тулд Финландын Тээврийн аюулгүй байдлын агентлаг нь SOLAS-бус Удирдамжид хамаарах зорчигч тээврийн хөлөг онгоцны техникийн аюулгүйн шаардлагыг цаг уур, цаг агаарын нөхцөл байдал, эсхүл орон нутгийн бусад тодорхой нөхцөл байдалтай уялдуулан илүү нарийвчилсан техникийн шаардлагыг боловсруулан, мөрдүүлж болно.

17 дугаар зүйл. Хөнгөлөлтүүд

1. Финландын Тээврийн аюулгүй байдлын агентлаг нь SOLAS-бус Удирдамжид хамаарах зорчигч тээврийн хөлөг онгоцонд тавигдах Удирдамжид заасан зарим тусгай шаардлагуудыг дотоодын аялал үйлдэж буй нөхцөлд үйлчлэхгүй байхаар нарийвчилсан зохицуулалтаар зохицуулж болно.

2. Финландын Тээврийн аюулгүй байдлын агентлаг нь SOLAS-бус Удирдамжийн үйл ажиллагааны шаардлагаас аюулгүй байдлын түвшинг бууруулахгүйгээр чөлөөлж болно. [...]

Бүлэг IV. Загас агнуурын хөлөг онгоц, тусгай зориулалтын хөлөг онгоц, бусад хөлөг онгоц болон дугуйт техник тээвэрлэх тавцант усан онгоц (ro-ro ships)-ны хаалга (bow doors)-тай холбоотой тусгай шаардлагууд

21 дүгээр зүйл. Загас агнуурын хөлөг онгоцны тухай удирдамжид хамаарах загас агнуурын хөлөг онгоц

1. Загас агнуурын хөлөг онгоцны тухай удирдамжид хамаарах загас агнуурын хөлөг онгоцнууд нь Загас агнуурын хөлөг онгоцны тухай удирдамж болон холбогдох

бусад удирдамжид заасан техникийн аюулгүй байдлын шаардлагыг хангасан байна. Мөн хөлөг онгоцнууд нь Загас агнуурын хөлөг онгоцны тухай удирдамжид тусгасан Торремолинос Протоколд заасан шаардлагуудыг хангасан байна.

2. Загас агнуурын хөлөг онгоцны тухай удирдамжид зааснаас гадна зураг төсөл гаргах, хөлөг онгоц барих, хөлөг онгоцны их биед засвар үйлчилгээ хийх, гол болох туслах машин механизм, цахилгаан угсралт болон загас агнуурын хөлөг онгоцны автоматжуулалттай холбоотойгоор хүлээн зөвшөөрөгдсөн ангиллын нийгэмлэгээс, эсхүл Финландын Тээврийн аюулгүй байдлын агентлагаас гаргасан ижил төстэй шаардлагыг хангасан байна.

3. Загас агнуурын хөлөг онгоцны тухай удирдамж болон бусад удирдамжийг дагаж мөрдүүлэхэд Финландын Тээврийн аюулгүй байдлын агентлаг нь загас агнуурын хөлөг онгоцны техникийн аюулгүй байдлын нарийвчилсан дүрэм, журмыг боловсруулж, мөрдүүлнэ.

4. Тодорхой шалтгаанаар, Финландын Тээврийн аюулгүй байдлын агентлаг нь Загас агнуурын хөлөг онгоцны тухай удирдамжид заасан шаардлагаас аюулгүй байдлын түвшинг бууруулахгүйгээ тухай бүр чөлөөлж болно.

5. Загас агнуурын хөлөг онгоцны тухай удирдамжид заасан нөхцөлийн дагуу Финландын Тээврийн аюулгүй байдлын агентлаг нь аливаа угсралт, материал, тоног төхөөрөмж, аппарат хэрэгсэл, эсхүл бусад зохицуулалтыг Загас агнуурын хөлөг онгоцны удирдамжид заасан шаардлагад нийцэж буй эсэхийг тохиолдол тус бүрээр тогтоож болно.

22 дугаар зүйл. Тусгай зориулалтын хөлөг онгоц

1. Тусгай зориулалтын хөлөг онгоцны тухай хуульд (Special Purpose Ship Code) заасан хөлөг онгоцнууд тус хуульд заасан техникийн аюулгүй байдлын шаардлагыг хангасан байна.

2. Хөлөг онгоцны аюулгүй ажиллагааны зохих түвшинг хангахын тулд Финландын Тээврийн аюулгүй байдлын агентлаг нь тусгай зориулалтын хөлөг онгоцны техникийн аюулгүй байдлын нарийвчилсан дүрэм, журмыг Олон улсын далайн байгууллага (ОУДБ)-ын удирдамж, зөвлөмжид нийцүүлэн боловсруулж, мөрдүүлнэ.

3. Финландын Тээврийн аюулгүй байдлын агентлаг нь хөлөг онгоцны урт, үйлдэх аяллын маршрут зэргээс хамааран тавигдах аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан нөхцөлд эрэг орчмын усанд аялал үйлдэх хөлөг онгоцыг Тусгай зориулалтын хөлөг онгоцны тухай хуульд заасан шаардлагаас тохиолдол тус бүрээр чөлөөлж болно.

4. Финландын Тээврийн аюулгүй байдлын агентлаг нь хөлөг онгоцны урт, үйлдэх аяллын маршрут зэргээс хамааран тавигдах аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан нөхцөлд тусгай зориулалтаар байнга ашиглагддаггүй, онцгой нөхцөлд тусгай зориулалтаар аялал үйлддэг хөлөг онгоцыг Тусгай зориулалтын хөлөг онгоцны тухай хуульд заасан шаардлагаас тухай бүр чөлөөлж болно.

5. Тусгай зориулалтын хөлөг онгоцны тухай хуульд заасан нөхцөлийн дагуу Финландын Тээврийн аюулгүй байдлын агентлаг нь аливаа угсралт, материал, тоног төхөөрөмж, аппарат хэрэгсэл, эсхүл бусад зохицуулалтыг Тусгай зориулалтын хөлөг онгоцны тухай хуульд заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг тохиолдол тус бүрээр тогтоож болно.

6. Финландын Тээврийн аюулгүй байдлын агентлаг нь 500 тонноос бага даацын тусгай зориулалтын хөлөг онгоцонд Тусгай зориулалтын хөлөг онгоцны тухай хуулийг хэрэглэхтэй холбоотой журам гаргаж болно.

Бүлэг VIII. Хөлөг онгоцны ажиллагаа

Бүлэг IX. Хөлөг онгоц дахь нисдэг тэрэгний ажиллагаа [...]

78 дугаар зүйл. Аюулгүй ажиллагааны заавар

Зорчигч тээврийн хөлөг онгоцны зорчигчдод өгөх ажиллагааны заавар нь хөлөг онгоцны ажлын хэл дээр болон хөлөг онгоцны зорчигчдын гол бүлгүүдийн хэл дээр олгоно, эсхүл зааврыг олон улсын тэмдгийн хэлбэрээр илэрхийлнэ.

Бүлэг XI. Торгууль

87 дугаар зүйл. Хөдөлгөөнд аюул учруулах

Хөдөлгөөнд аюул учруулах (*торгууль, эсхүл 6 сар хүртэл хугацаагаар хорих*) болон хөдөлгөөнд ноцтой аюул учруулахад (*30-аас түүнээс дээш хоногийн торгууль, эсхүл 2 жил хүртэл хугацаагаар хорих*) хүлээлгэх хариуцлагыг Эрүүгийн хуулийн 23 бүлгийн 1,2⁴⁸ дахь зүйлээр тус тус зохицуулсан.

88 дугаар зүйл. Усан замын тээврийн хөдөлгөөнд согтуугаар оролцох, тээврийн хэрэгслийн согтуу этгээдэд шилжүүлэх ба тээврийн хэрэгслийг жолоодох эрхийн үнэмлэхгүй жолоодох

Усан замын тээврийн хөдөлгөөнд согтуугаар оролцсон (*торгууль, эсхүл 2 жил хүртэл хугацаагаар хорих*), тээврийн хэрэгслийн согтуу этгээдэд шилжүүлсэн (*торгууль, эсхүл 1 жил хүртэл хугацаагаар хорих*) ба тээврийн хэрэгслийг жолоодох эрхийн үнэмлэхгүй жолоодсон (*торгууль, эсхүл 6 сар хүртэл хугацаагаар хорих*) тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг Эрүүгийн хуулийн 23 бүлгийн 5,8, 10⁴⁹ дахь

⁴⁸The Criminal Code of Finland (39/1889)

Section 1 - Causing a traffic hazard (545/1999)

(1) A road user who intentionally or negligently breaches the Road Traffic Act (267/1981) or the Vehicle Act (1090/2002) or the regulations or orders issued on the basis thereof, in a manner conducive to causing a hazard to others, shall be sentenced for *causing a traffic hazard* to a fine or to imprisonment for at most six months. (1094/2002)

2) A sentence for causing a traffic hazard shall be passed also on a person who in the manner referred to in subsection 1

1. (1) while in charge of steering a vessel or performing a duty essentially affecting the safety of navigation, breaches the Waterway Traffic Act (463/1996) or the regulations or orders issued on the basis thereof or pertaining to the prevention of collisions at sea, on an inland waterway or in a canal,
2. (2) while piloting an aircraft or performing a duty as a member of the crew or affecting the safety of air traffic, or otherwise, breaches the Air Traffic Act (281/1995) or the regulations or orders issued on the basis thereof, or
3. (3) while driving a train or performing a duty essentially affecting railway traffic safety breaches the rules governing railway safety.

⁴⁹**Section 5 - Waterway traffic intoxication** (296/2012)

(1) A person who operates a vessel or performs a duty on a vessel essentially affecting the safety of its navigation,

1. (1) after having consumed alcohol so that during or after said operation his or her blood alcohol level is at least 1.0 per mille or his or her exhalation contains at least 0.44 milligrams of alcohol per litre of air or his or her capacity to perform as required in said operation is impaired, or
2. (2) after having used intoxicants other than alcohol or such substances and alcohol together, so that so that his or her ability to perform as required in the operation is impaired,

and the circumstances are such that the offence is conducive to endangering the safety of others, shall be sentenced for *waterway traffic intoxication* to a fine or to imprisonment for at most two years.

(2) Also a person who in professional waterway traffic operates a vessel or under orders performs a duty on such a vessel that essentially affects its safety or the prevention of pollution of the environment after having consumed alcohol so that during or after said operation his or her blood alcohol level is at least 0.5 per mille or his or her exhalation contains at least 0.22 milligrams of alcohol per litre of air shall be sentenced for waterway traffic intoxication.

(3) However, no sentence shall be passed for waterway traffic intoxication when the person has operated a rowing boat or a vessel comparable thereto in size, speed or otherwise or when the duty referred to in subsection (1) has been performed aboard such a vessel.

Section 8 - Relinquishing a vehicle to an intoxicated person (545/1999)

A person who relinquishes a motor-driven vehicle, tram, train, vessel or aircraft as referred to in section 5, to the operation, steering or

зүйлээр тус тус зохицуулсан.

90 дүгээр зүйл. Хөлөг онгоцны баримт бичигтэй холбоотой зөрчил

Хөлөг онгоцны баримт бичигтэй холбоотой зөрчилд Далайн тухай хуулийн 20 дугаар бүлгийн 3 дугаар зүйлд заасан хариуцлагыг ногдуулна.

91 дүгээр зүйл. Хөлөг онгоцны аюулгүй байдлын зөрчил

Санаатайгаар, эсхүл хайхрамжгүй хандсаны улмаас дараахыг хангаагүй этгээд нь:

- 1) 5-р хэсэгт заасан аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлагыг биелүүлээгүй;
- 2) 6 (1-3) хэсэгт заасан ерөнхий техникийн аюулгүй байдлын шаардлагууд, эсхүл 6 (4) хэсэгт дурдсан журмыг мөрдөөгүй;
- 3) 15 (1), (2) хэсэгт заасан техникийн ерөнхий аюулгүй байдлын шаардлагууд, v 15 (3) хэсэгт дурдсан журмыг мөрдөөгүй;
- 4) 21 (1), (2) хэсэгт заасан 21 дүгээр зүйлийн (3) хэсэгт заасан журмын дагуу техникийн аюулгүй байдлын шаардлагыг биелүүлээгүй;
- 5) 22 (1) хэсэгт заасан техникийн аюулгүй байдлын шаардлагууд, эсхүл 22 (2) хэсэгт хэсэгт дурдсан журмыг мөрдөөгүй;
- 6) 23-р бүлэгт заасан бусад хөлөг онгоцнуудтай холбоотой техникийн дүрэм журмыг дагаж мөрдөөгүй;
- 7) 24 (1) хэсэгт заасан 24-р зүйлийн (2) хэсэгт заасан журмын дагуу тавьсан хөлөг онгоцны нуман хаалгатай холбоотой шаардлагыг биелүүлээгүй;
- 9) 28-р хэсгийн (1) хэсэгт дурдсан SOLAS бус удирдамжид тусгасан хөлөг онгоцны багтаамжийн хэмжилттэй холбоотой шаардлагыг биелүүлээгүй, эсхүл 28 (2) хэсэгт заасан бусад хөлөг онгоцны талаар ачааны шугамын тэмдэг, 28 (3) -р хэсэг;
- 10) 12, эсхүл 19 дүгээр хэсэгт дурдсан зөвшөөрөлгүйгээр хөлөг онгоцыг ажиллуулсан;
- 11) 33 (2), (4) хэсэгт заасан хөлөг онгоцны багтаамжийн гэрчилгээ аваагүй;
- 12) 34 дүгээр хэсэгт заасан хоригийг зөрчсөн;
- 13) 38 (5) эсхүл 65 (5) хэсэгт заасан томилолтын бичиг буцааж өгөх үүргийг биелүүлээгүй;
- 14) 44 (1), (2) хэсэгт заасан тусламж үзүүлэх үүргийг биелүүлээгүй;
- 15) 46 (1), хэсэг 47 (1), 48 (1), (2), 49 (1), (2), 50 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан үзлэгтэй холбоотой үүргийг биелүүлээгүй; эсхүл (3), 51 (1), 52 (1), 53 (1), 54 (1), эсхүл (3) хэсгүүд;
- 16) 56 дугаар хэсэгт заасан хоригийг зөрчсөн;
- 17) 58-р зүйлд заасан гэрчилгээ авахгүй;
- 18) 59 (1) хэсэгт заасан гэрчилгээ авах үүргээ биелүүлээгүй;
- 19) 60 (1) хэсэгт заасан гэмтэл, дутагдлыг арилгах талаар мэдэгдэх үүргийг биелүүлээгүй;

control of a person who is apparently in such a state that he or she is guilty of an offence mentioned in sections 3 through 7, shall be sentenced for *relinquishing a vehicle to an intoxicated person* to a fine or to imprisonment for at most one year.

Section 10 - Operation of a vehicle without a license (545/1999)

(1) A person who operates, steers or controls a motor vehicle, tram, train, vessel or aircraft without the right to do so or without a license proving the required competence, shall be sentenced for *operation of a vehicle without a license* to a fine or to imprisonment for at most six months.

(2) Also a person who without the required competence performs a duty essentially affecting railway traffic safety, waterway traffic safety, or air traffic safety, shall be sentenced for *operation of a vehicle without a permit*.

20) 67 (1) хэсэгт заасан багтаамжийн хэмжилттэй холбоотой үүргийг биелүүлээгүй;

21) 69-р хэсэгт заасан гадаад хөлөг онгоцны багтаамжийн хэмжилт үүргийг биелүүлээгүй;

22) 70-р хэсэгт заасан буцаан өгөх үүргийг биелүүлээгүй;

23) 72-р хэсэгт заасан ачааны заагийг тэмдэглэх үүргийг биелүүлээгүй;

24) 73 (1), (2) хэсэгт заасан мэдэгдэл өгөх үүргийг биелүүлээгүй, эсхүл 73 (4) хэсэгт заасан багтаамжийн гэрчилгээ авах үүргийг биелүүлээгүй;

25) 74 (1) хэсэгт заасан мэдэгдэх үүргээ биелүүлээгүй, эсхүл 74 (2) хэсэгт заасан буцаах үүргийг биелүүлэхгүй байх;

26) 75 дугаар зүйлд заасан ачих, чирэх болон ачааны тээвэрлэх заалтыг зөрчсөн;

27) 76-р хэсэгт заасан үр тариаг бөөнөөр ачихтай холбоотой заалтыг зөрчсөн;

28) 77-р бүлэгт заасан хөлөг онгоцонд тэмдэглэгээ хийх үүргийг биелүүлээгүй;

29) 78-р хэсэг заасан аюулгүй ажиллагааны зааварт хамаарах үүргийг зөрчсөн;

30) 78-р хэсэг заасан нисдэг тэрэгний үйл ажиллагааны талаарх заалтуудыг зөрчсөн.

Энэхүү хуульд илүү хүнд хариуцлага ногдуулахаар тусгагдсанаас бусад хөлөг онгоцны барилга угсралт, тоног төхөөрөмжтэй холбоотой зөрчил буюу хөлөг онгоцонд аюулгүй ажиллагааны зөрчилд торгох шийтгэл ногдуулна.

92 дугаар зүйл. Хариуцлагаас чөлөөлөх

1. Хөлөг онгоцны аюулгүй байдлын зөрчлийг бага, эсхүл зөрчсөн этгээдэд хүлээлгэх захиргааны хариуцлага нь зөрчлийн хэлбэрээс хамааран хангалттай гэж үзвэл, хариуцлагаас чөлөөлж болно.

2. Зөрчил нь 1-р дэд хэсэгт заасан зөрчлийн хэлбэртэй бол, Финландын тээврийн аюулгүй байдлын агентлаг нь бусад хариуцлагаас чөлөөлж, зөрчигчдөд сануулга өгч болно.

ГУРАВ. ВИКТОРИЯ НУУРЫН ТЭЭВРИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ЗОХИЦУУЛЖ БУЙ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Виктория нуурын тээврийн тухай хууль⁵⁰ 2007 он

Виктория нуур нь 68800 км² талбай бүхий Африк тивийн хамгийн том, дэлхийд хоёрдугаарт ордог цэнгэг уст нуур юм. Газар зүйн байрлалын хувьд Кени, Танзани, Уганда Улсын дунд оршдог байна. Виктория нууранд жилд 5000 орчим хүн амиа алдаж байна гэсэн судалгаа гарсан байна. 2007 онд нуурын усан замын тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангах, сайжруулах зорилгоор Зүүн Африкийн хамтын нийгэмлэгээс уг хуулийг батлан гаргаж, Кени, Танзани, Уганда улсуудын төрийн тэргүүнүүд гарын үсэг зурж баталсан байна.

Тус хууль нь 2009 оны 11 дүгээр сарын 4-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн бөгөөд тус нууран дахь зорчигчид, ачаа тээвэрлэлт, судалгаа шинжилгээ, хөлөг онгоцны бүртгэл, зөвшөөрөл, ажилчдад тавигдах шаардлага, зорчигчдын болон ачаа тээвэрлэлтийн аюулгүй байдал зэрэг өргөн хүрээний асуудлыг

⁵⁰The Lake Victoria Transport Act, 2007

зохицуулж өгсөн байна. Тус хууль нь 16 бүлэг 247 зүйлтэй.

Хуулийн нэгдүгээр бүлэгт уг хуулийн зорилгыг нууран дахь усан замын тээврийн аюулгүй байдал, эрэн хайх, аврах ажиллагаа, гидрографик, цаг агаар, зураг зүй, харилцаа холбоотой холбогдон үүсэх харилцааг зохицуулах, журамлах, хянах болон тээвэрлэлтээс үүдэлтэй нуурын бохирдлоос урьдчилан сэргийлэхэд чиглэгдэнэ гэж тодорхойлоод хуулийн үйлчлэх хүрээг нуурын дотор, эсхүл боомт, зогсоолд байгаа хөлөг онгоц, нууранд судалгаа шинжилгээ, эсхүл нефтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулахад зориулагдсан барилга байгууламж, түүнийг эзэмшигч этгээд, оролцогч улсуудын загас агнуурын хөлөг онгоцнууд байна гэж тодорхойлсон байна.

Харин оролцогч улсуудын цагдаа, тэнгисийн цэрэг болон батлан хамгаалах зориулалтын хөлөг онгоцнууд тус хуулийн зохицуулалтад хамаарахгүй байна. Түүнчлэн Зүүн Африкийн хамтын нийгэмлэгийн зөвлөлөөс нууранд байрлах боомттой ойролцоо газар, орон нутгийн аялал жуулчлал, байгалийн өвөрмөц тогтоц зэрэг тус хуулийн зорилго, үйлчлэлд хамааралгүй гэж үзсэн газар орчин, түүнд зорчих хөлөг онгоцыг тус хуулийн үйлчлэлээс чөлөөлж болох зохицуулалтыг тусгаж өгсөн байна.

Мөн хуулийн нэр томъёоны тайлбарыг тус бүлэгт оруулсан байна.

2 дугаар бүлэг. Зүүн Африкийн хамтын нийгэмлэгийн зөвлөл⁵¹ нь тус хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэгтэй байна. Зөвлөл нь дараах чиг үүрэгтэй байхаар зааж өгчээ.

- Тус хуулийн хэрэгжилтийг уялдуулан зохицуулах;
- Усан тээврийн сургалт эрхлэгч байгууллагуудын магадлан итгэмжлэл, аудит хийх стандартыг батлах;
- Усан тээврийн аюулгүй байдлын бодлого, хөтөлбөрүүдийг боловсруулах;
- Оролцогч улсуудын усан тээврийн асуудал эрхэлсэн байгууллага хоорондын мэдээлэл солилцох асуудлыг хялбарчлах;
- Нуурын аюулгүй байдалтай холбогдох олон улсын гэрээ хэлэлцээрүүд, тэдгээрийн хэрэгжилт болон нууран дахь усан тээврийн үйл ажиллагаатай холбогдох дотоодын хууль тогтоомж батлан гаргах асуудлаар Зүүн Африкийн хамтын нийгэмлэгт зөвлөх;
- Үндэсний болон олон улсын наад захын хэм хэмжээ жишигт нийцүүлэн усан тээврийн үйл ажиллагааны сургалтын стандартыг батлан гаргах;
- Нууран дахь усан замын хөдөлгөөний удирдлага, тусламжийг үзүүлэх;
- Нууран дахь усан замын ослын шалгалтыг удирдан чиглүүлэх;
- Өөрийн үзүүлж буй үйлчилгээтэй холбогдох төлбөр хураамжийн хэмжээг тогтоох;
- Нуурын бохирдлоос урьдчилан сэргийлэх, хяналт тавих бодлогыг боловсруулах;
- Тус хуулиар олгосон чиг үүрэгтэй холбоотой бусад асуудлыг эрхлэн гүйцэтгэх.

Тус бүлэгт зааснаар оролцогч улсууд нь нууран дахь усан тээврийн үйл ажиллагаатай холбогдох асуудлыг эрхлэх төрийн зохих байгууллагатай байх ба Зөвлөл болон тус газруудын хоорондын харилцааны журмыг Зөвлөлөөс батлан гаргахаар зохицуулжээ.

⁵¹

3 дугаар бүлэг. Хөлөг онгоцны бүртгэл

Канозэ завь болон 12 хүний суудлаас хэтрэхгүй завинаас бусад хөлөг онгоц нь хуульд зааснаар бүртгэлд хамрагдана. Бүртгэлд хамрагдах хүсэлтийг өмчлөгч болон түүний эрх олгосон этгээд гаргана. Бүртгүүлэх тухай хүсэлтэд тухайн хөлөг онгоцны өмчлөгч нь тухайн улсын иргэн, аж ахуйн нэгж болох тодорхойлолт, хөлөг онгоц нь усан тээвэрт ашиглаж болох техникийн нөхцөлд байгаа талаарх тодорхойлолт, онгоцны багийн ахмад болон гишүүд холбогдох мэргэжлийн шаардлага хангасан болохыг тодорхойлсон баримтууд, онгоц үйлдвэрлэгдсэн газар болон өөрийн жин, даацын талаарх үйлдвэрлэгчийн баримт бичгүүдийг хавсарган ирүүлэхээр заажээ.

Мөн тус бүлэгт хөлөг онгоцны нэр болон харьяа боомтын нэр зэргийг цагаан суурин дээр латин хар үсгээр хөлөг онгоцны нум хэсэгт бичих зэргээр хөлөг онгоцны таних тэмдэгтэй холбогдох зохицуулалтуудыг нарийвчлан тусгасан байна.

Хөлөг онгоцыг бүртгэхэд түүнд хяналтын үзлэг шалгалтыг хийж гүйцэтгэдэг байна. Үзлэгийг тухайн хөлөг онгоцны харьяалагдах боомтод түүний хөдөлгөөнд оролцох бүрэн бүтэн байдал, тус хуульд заасан арга хэлбэрээр тоноглогдсон эсэх, онгоцны жин хэмжээс, хөдөлгүүрийн зохион байгуулалт, зориулалт, зорчигч болон ачаа тээврийн даац, газар зүйн болон ямар нэгэн байдлаар хөдөлгөөнд оролцоход аюултай нөхцөл байдал үүсч болох нөхцөл байдлын талаар Зөвлөлөөс баталсан журмын дагуу үзлэг шалгалтыг хийж гүйцэтгэдэг байна. Үзлэгийн дагуу хөлөг онгоцонд аюулгүй байдлын гэрчилгээ олгоно.

Гэрчилгээний хугацаа 1 жил байх бөгөөд онцгой нөхцөлд 3 сараар сунгаж болохоор зохицуулсан байна. Хугацаа дуусмагц дээрх журмын дагуу дахин шинэчлэн сунгуулах үүрэгтэй.

Гэрчилгээ нь:

- А ангилал буюу нээлттэй усанд тохиромжтой;
- Б ангилал буюу хязгаарлагдмал хүрээнд хаалттай хамгаалагдсан усан зайд тохиромжтой;
- В ангилал буюу үзлэг явуулсан мэргэжилтнээс тодорхойлон заасан орчны хүрээнд ашиглах боломжтой гэсэн 3 ангилалтай байна.

Хөлөг онгоц аюулгүй ажиллагааны үзлэгт тэнцээгүй бол шалтгааныг өмчлөгчид нь тодорхой тайлбарлан зааж өгч, зөрчлийг арилгасны дараа дахин хандах боломжтой байдаг байна.

Мөн гэрчилгээг олгохоос татгалзах үндэслэлийг зааж өгсөн байна. Үүнд:

- Хөлөг онгоц нь аюулгүй ажиллагааны шаардлага хангахгүй, эсхүл нуурын буюу усанд бохирдол үүсгэж болзошгүй;
- Хөлөг онгоцны багийн аюулгүй байдал, эрүүл мэндийн байдал, шаардлага хангахгүй;
- Хөлөг онгоцыг гэмт хэргийн зорилгоор ашиглаж болзошгүй.

Түүнчлэн тус бүлэгт гэрчилгээг үрэгдүүлсэн, хаясан, гэмтээсэн тохиолдолд гэрчилгээний төлбөртэй холбогдох асуудлыг зохицуулсан байна. Хөлөг онгоц гэмтсэн, шатсан, булаагдсан, дээрэмдүүлсэн тохиолдолд 7 хоногийн дотор бүртгэлийн асуудал хариуцсан газарт өмчлөгч нь мэдэгдэх үүрэгтэй ба дахин хяналтын үзлэгт оруулах

журамтай байдаг байна.

Бүртгэлийн асуудал эрхэлсэн байгууллага нь хөлөг онгоцны нэр, дугаар, үйлдвэрлэсэн он, өмчлөгчийн мэдээлэл, анх буюу өөр ямар улсад бүртгэлтэй байсан, холбогдох зээлтэй эсэх, тухайн улсын бүртгэлээс чөлөөлөгдсөн эсэх зэрэг мэдээллийг бүртгэж авдаг байна. Бүртгэлийн гэрчилгээг 5 жилийн хугацаагаар олгоно. Мөн бүлэгт бүртгэлийн гэрчилгээ хүчингүй болгох, бүртгэлд өөрчлөлт оруулах зэрэг бүртгэлтэй холбогдох бусад асуудлыг зохицуулж өгчээ.

Дөрөвдүгээр бүлэгт тус хуулийн дагуу бүртгэлд хамрагдсан хөлөг онгоцыг шилжүүлэх худалдахтай холбогдсон асуудлыг зохицуулсан байна. Гуравдугаар бүлэгт заасан бүртгэлийн процесстой адил зарчмаар явагддаг байна. Шилжүүлэхдээ шинэ өмчлөгч нь тухайн улсын иргэн байх, мөн аюулгүй ажиллагааны нөхцөлд байгаа болон, шинэ багийн гишүүдийн мэдээлэл зэрэг асуудлаар бичгээр мэдэгдэл гаргах ёстой байна.

Тавдугаар бүлэгт тус хуулийн 3 дугаар бүлэгт зааснаас бусад хэлбэрээр буюу хөлөг онгоц лицензээр эзэмшихтэй холбоотой харилцааг зохицуулжээ. Лиценз эзэмшихийг хүссэн этгээд нь дээрх бүлгүүдэд дурдсан холбогдох мэдээллийг бүртгэлийн байгууллагад гаргаж өгнө. Лицензийн зөвшөөрлийг 1 жилийн хугацаагаар олгоно. Улирлын шинжтэй бизнес, тодорхой төрлийн ажил гүйцэтгэх, эсхүл хязгаарлагдмал хугацааны шинжтэй тохиолдлуудад 3 сараас хэтрэхгүй хугацаагаар лиценз олгож болохоор зохицуулжээ. Лицензийг бүртгэлийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр бусдад шилжүүлэхийг хориглодог байна. Олгох, шалгах процесс нь дээрх бүлгүүдэд заасан журмын дагуу явагддаг байна.

6 дугаар бүлэг. Үзлэг болон шалгалт

Хуулийн 67 дугаар зүйлд зааснаар хөлөг онгоцны үзлэг, шалгалтыг эрх бүхий албан хаагч нь дараах нөхцөлөөр явуулна.

- Зүтгүүр, бойлер;
- Хөлөг онгоцны тоног төхөөрөмжүүд, тоноглол;
- Амь нас аврах, гал түймэртэй тэмцэх болон аюулгүй ажиллагааны бусад байгууламжууд;
- Навигацийн ба холбооны тоног төхөөрөмж;
- Ачаа хадгалах, аюултай бараа агуулах нөхцөл, байр сав;
- Хөлөг онгоцны зорчигч болон багийн гишүүний амрах орон байр, орчин, тоног төхөөрөмж;
- Бусад холбогдох асуудлууд.

Үзлэг, шалгалтыг хийх албан хаагч нь хөлөг онгоц энэ хуульд заасан аюулгүй ажиллагааны болон бусад нөхцөлийг хангаж байгаа эсэхийг магадлан шалгах үүрэгтэй бөгөөд хөлөг онгоцны бүртгэлтэй холбоотой болон ямар ч үед аюулгүй ажиллагааны шалгалтыг хийж гүйцэтгэх эрхтэй байна. Албан хаагч нь хөлөг онгоцыг усан замд ажиллуулах, холбогдох эд ангийг тусгайлан шалгах, холбогдох шаардлагатай мэдээллийг гаргуулж авах, гаргаж өгөхийг шаардах эрхтэй байна. Бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь саад учруулсан, холбогдох мэдээллийг гаргаж өгөөгүй, санаатайгаар худал мэдээлэл өгсөн этгээдийг 2000 ам.доллараар торгох буюу 1 жилээс дээшгүй хугацаагаар хорих ял оногдуулах санцгийг суулгаж өгсөн байна.

Тус албан хаагч нь шалгалтыг хийж гүйцэтгэсний дараа бичгээр мэдэгдэл өгөх ба тус мэдэгдлийн дагуу холбогдох засвар үйлчилгээг хийж гүйцэтгэх ёстой. Энэ мэдэгдлийг Бүртгэлийн байгууллага болон холбогдох боомтуудад хүргүүлнэ. Боомтын захиргаанаас мэдэгдлийн дагуу онгоцыг хөдөлгөөнд оролцуулахгүй байх үүрэг хүлээдэг.

Хөлөг онгоцны өмчлөгч болон багийн ахмад нь хөлөг онгоцны бүрэн бүтэн, аюулгүй байдлыг энэ хуульд заасны дагуу хангасан байх үүрэгтэй. Хөлөг онгоцны бүтэц, тоног төхөөрөмж, машин механизм зэрэг аюулгүй ажиллагаатай холбогдох эвдрэл гэмтэл, осол гарсан тохиолдолд нэн даруй үзлэг, шалгалтыг гүйцэтгэх, холбогдох албан тушаалтан, боомтын захиргаанд мэдэгдэх үүрэгтэй ба тус мэдэгдлийг үндэслэн үзлэг, шалгалтыг гүйцэтгэх эсэх шийдвэрийг гаргахаар заасан байна.

125 тонн ба түүнээс дээш жинтэй хөлөг онгоцонд ISM Code буюу Олон улсын усан тээврийн байгууллагаас баталсан “Далайн бохирдлоос урьдчилан сэргийлэх ба хөлөг онгоцны аюулгүй ажиллагааны удирдлага менежментийн заавар”-ыг мөрдөхөөр хуульд тусгасан байна.

Эрх бүхий албан хаагчийн мэдэгдэлд заасан арга хэмжээг заасан хугацаанд биелүүлээгүй тохиолдолд Бүртгэлийн байгууллагад гэрчилгээг түдгэлзүүлэх талаарх хүсэлтийг албан тушаалтан гаргана.

Үзлэг, шалгалт гүйцэтгэх эрх бүхий албан тушаалтны нэрсийг Зөвлөлөөс гаргаж, төрийн албан ёсны хэвлэлээр олон нийтэд танилцуулна.

Хөлөг онгоцны үзлэгийг хуульд зааснаар:

- Хөлөг онгоц үйлчилгээнд буюу ашиглаж эхлэхийн өмнөх анхан;
- Ашиглагдаж байгаа хөлөг онгоцны тухайд 12 сараас доошгүй хугацаанд давтан;
- Бүртгэлийн байгууллагын хүсэлт, шаардлагын дагуу буюу нэмэлт шалгалтыг хийж гүйцэтгэж байхаар заасан байна.

Анхан шатны үзлэг шалгалтыг хөлөг онгоцыг ашиглагдаж эхлэхийн өмнө:

- Их биеийн;
- Бойлер болон бусад даралтын систем;
- Үндсэн болон туслах машин;
- Цахилгааны холболт;
- Радио суурилуулалт;
- Моторт завины усан онгоцны радио холбооны хэрэгсэл;
- Зөөврийн радио аппарат;
- Амь нас аврах хэрэгсэл;
- Гал унтраах төхөөрөмжийг илрүүлэх ба унтраах;
- Шат;
- Бусад тоног төхөөрөмж, үүнд навигацийн аппарат гэсэн чиглэлээр хийж гүйцэтгэхээр заасан байна.

Давтан үзлэг, шалгалтыг дээрх чиглэлээр болон хөлөг онгоцны гэрэл, дуу, ослын дохиог шалгах замаар гүйцэтгэнэ.

Нэмэлт үзлэг, шалгалтыг Бүртгэлийн байгууллагын хүсэлтээр онгоцонд осол

гарсан, бүрэн буюу аюулгүй ажиллагаанд нөлөөлж болохуйц эвдрэл, гэмтэл гарсан, их хэмжээний засвар, шинэчлэл өөрчлөлт хийгдсэн нөхцөлд хийж гүйцэтгэнэ.

Шалгалтаар шаардлагатай засвар үйлчилгээг бүрэн гүйцэт, үр дүнтэй хийж гүйцэтгэсэн эсэх, засвар үйлчилгээнд ашигласан сэлбэг хэрэгсэл шаардлага хангаж байгаа эсэх, онгоц холбогдох олон улсын гэрээ, конвенц энэ хуульд заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг магадлан тогтооно.

7 дугаар бүлэг. Хөлгийн багийн бүрэлдэхүүн тэдгээрт тавигдах шаардлага.

25 тонн ба түүнээс дээш жинтэй хөлөг онгоцонд тус бүлгийн зохицуулалт хамаарахаар заасан байна. Хуульд заасан зохих бүрэлдэхүүнгүйгээр хөлөг онгоц хөдөлгөөнд оролцсон бол хөлөг онгоцны өмчлөгчийг 3000 хүртэлх ам.доллараар торгох буюу 1 жил хүртэлх хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан байна. Мөн бүртгэлийн байгууллагаас хөлөг онгоцны зөвшөөрлийг хүчингүй болгох буюу хуульд заасан шаардлагыг хангах хүртэл хөдөлгөөнд оролцуулахыг хориглож болно.

Хуулийн 87 дугаар зүйлд зааснаар Зөвлөл нь дор дурдсан асуудлыг хариуцан, холбогдох журам батлан мөрдүүлнэ.

- Хөлөг онгоцны багийн гишүүдэд тавигдах шаардлага, стандарт, бүрэлдэхүүн тэдгээрийн тоо;
- Холбогдох зөвшөөрөл бүхий багийн гишүүдтэй байвал зохих хөлөг онгоцнуудын ангилал;
- Багийн гишүүдэд эрх олгосон гэрчилгээ олгох;
- Нууранд холбогдох багийн ахмад гишүүдийн хамтаар удирдвал зохих хөлөг онгоцны жин хэмжээсийн ангилал, хөлөг онгоцны зориулалтууд;
- Багийн гишүүдийн мэргэжил, ур чадвартай холбогдох бусад асуудлууд.

Гадаад улсад энэ хуулиар тогтоосон шаардлагыг хангасан мэргэжил ур чадвар эзэмшсэн этгээдэд хөлөг онгоцонд ажиллах зөвшөөрлийг шууд олгож болно гэж мөн заасан. Бүртгэлийн байгууллага энэ бүлэгт заасан журмаар олгогдсон хөлөг онгоцны багийн гишүүдэд олгох гэрчилгээтэй холбогдох мэдээллийг мөн хариуцан ажиллахаар заасан байна.

Хуулийн **8 дугаар бүлэгт** хөдөлгөөний удирдлага навигацийн асуудлыг, 9 дүгээр бүлэгт хөлөг онгоцны багийн гишүүдийг авч ажиллуулах буюу хөдөлмөрийн гэрээний харилцааг нарийвчилсан байдлаар зохицуулж өгсөн байна.

10 дугаар бүлэгт их хэмжээний болон аюултай ачаа тээвэрлэхтэй холбогдох харилцааг зохицуулсан. Их хэмжээний болон аюултай ачааг тээвэрлэхэд тус хууль болон 1974 оны Далайд хүний аюулгүй байдлыг хангах конвенц, Хөлөг онгоцноос үүдэлтэй бохирдлоос урьдчилан сэргийлэх тухай конвенцын 3-р хавсралт, олон улсын усан тээврийн байгууллагаас баталсан аюултай ачааны жагсаалтыг дагаж, мөрдөж ажиллахаар заасан байна.

11 дүгээр бүлэг. Аюулгүй ажиллагаа

Хүрээлэн буй орчин, бусдын амь нас, эд хөрөнгөнд аюул, эрсдэл учруулж болзошгүй тохиолдолд хөлөг онгоцыг хөдөлгөөнд оролцуулахыг хориглох бөгөөд зөрчсөн тохиолдолд өмчлөгч буюу хөлгийн ахмадыг 5000 хүртэлх ам.доллараар торгох, эсхүл 2 жил хүртэлх хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан байна. Үзлэг,

шалгалт хийх эрх бүхий албан хаагч хөлөг онгоцны аюулгүй ажиллагаанд байгаа эсэхийг тогтоох ба дараах тохиолдолд аюулгүй ажиллагааны бус гэж үзнэ.

- Хөлөг онгоц эвдэрсэн нөхцөл байдалд байгаа;
- Хөлгийн тоног төхөөрөмж эвдрэлтэй байгаа;
- Хөлгийн тоног төхөөрөмж дутуу байгаа;
- Багийн бүрэлдэхүүн, эсхүл тэдний мэргэжил, ур чадвар хангалтгүй бол;
- Даац хэтрүүлсэн, эсхүл буруу тохиромжгүй байдлаар ачаалсан.

12 дугаар бүлэг. Хөлөг онгоцны сэг, хаягдал

Зөвлөлөөс хөлөг онгоц нууранд осолдсон, эвдэрсэн, хаягдсан тохиолдолд хариуцан ажиллах эрх бүхий албан хаагчдыг томилон төрийн албан ёсны хэвлэлд нийтэлнэ. Тус албан хаагч нь дээрх тохиолдолд тус ажиллагааг удирдан зохион байгуулах болон тухайн үйл ажиллагаанд бусдыг татан оролцуулах, түүний үйл ажиллагаанд тусламж үзүүлээгүй этгээдэд хүлээлгэх хариуцлага, эвдэрсэн буюу олдсон хөлөг онгоцны талаар олон нийтэд мэдээллэх, хадгалах, худалдан борлуулах, бусдад учруулсан хохирлыг арилгах зэрэг харилцааг тус бүлэгт зохицуулсан байна.

13 дугаар бүлэгт нуурын бохирдлоос сэргийлэх зохицуулалтыг оруулж, аливаа тосон бүтээгдэхүүн, бодис, бохир ус, хуванцар эдлэл, хөлгийн хог хаягдлыг нууранд хаяхыг хориглож, хариуцлагыг зааж өгсөн байна.

14 дүгээр бүлэгт Зөвлөлөөс нууранд хөдөлгөөнд оролцож буй хөлөг онгоц, багийн гишүүд, зорчигчдод зориулан албан журмын даатгалын хэмжээ, тохиолдол зэргийг зохицуулах журмыг гаргах эрхийг тусгаж өгсөн ба харин хуульд зааснаар дээрх даатгалд төрийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулж байгаа хөлөг онгоцнууд хамаарахгүй байхаар заасан байна.

15 дугаар бүлэгт хөлөг онгоцны ослыг шалган тогтоох журмыг заасан бол 16 дугаар бүлэгт хууль хүчин төгөлдөр болох зэрэг бусад нөхцөлийг тусгаж өгчээ.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Закон Республики Казахстан «О транспорте в Республике Казахстан» от 21 сентября 1994 г. № 156,
Swiss Maritime Navigation Office, <https://www.eda.admin.ch/smno/en/home.html>
- Federal Office of Transport, Switzerland <https://www.bav.admin.ch/bav/en/home.html>
- Bundesgesetz über die Binnenschifffahrt, 1975,
<https://www.admin.ch/opc/de/classified-compilation/19750266/index.html#fn1>
- Стратегия развития внутреннего водного транспорта Российской Федерации на период до 2030 года,
<http://static.government.ru/media/files/YxvWxYkzMqwAsfBmAX6anAVViKnFgYwA.pdf>
- Кодекс внутреннего водного транспорта РФ от 07.03.2001 № 24-ФЗ,
<http://pravo.gov.ru/proxy/ips/?docbody=&nd=102069974>
- Act on the Technical Safety and Safe Operation of Ships, Finland (1686/2009)
https://www.trafi.fi/filebank/a/1332425400/a3068aad82335cf237e9bbdea3cafefd/9462-Alusturvallisuuslaki_EN.pdf
- The Criminal Code of Finland (39/1889)
<https://www.finlex.fi/en/laki/kaannokset/1889/en18890039.pdf>
- Maritime Safety on Lake Victoria,
<https://www.duo.uio.no/bitstream/handle/10852/22806/AishaxNakyonyixThesisxFinal.pdf?sequence=1/>
- The Lake Victoria Transport Act, 2007
<http://www.businesslicences.go.ug/kcfinder/upload/files/Lake%20Victoria%20Transport%20Act%2C%202007.pdf>

ТӨРИЙН ОРОН СУУЦНЫ САНХҮҮЖИЛТИЙН ТОГТОЛЦОО БА БОДЛОГО, ТҮҮНИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭРЭГСЛҮҮД, ТЭДГЭЭРИЙН ДАВУУ БОЛОН СУЛ ТАЛ, БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА

(Харьцуулсан судалгаа)

Ц.Норовдондог (Ph.D), Г.Билгээ, Д.Жигваагүнсэл,
Р.Нургүл, Д.Халиун, Ц.Элбэгзаяа

АГУУЛГА

УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Төрийн орон сууцны санхүүжилтийн тогтолцоо ба бодлого, түүнийг хэрэгжүүлэх арга хэрэгслүүд, тэдгээрийн давуу болон сул тал, бусад орнуудын туршлага:

- АНУ
 - Орон сууцны санхүүжилтийн тогтолцоон дахь төрийн оролцооны талаарх тойм;
 - Зорилтот бүлгийн иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх, нөхцөлийг сайжруулахад төрийн болон орон нутгийн байгууллагуудын оролцоо, эрх үүрэг, санхүүжилтийн тогтолцоо:
 - АНУ-ын орон сууцны хөтөлбөрүүд;
 - Орон сууцны хөтөлбөрийн төлөвлөлт;
 - Орон сууцны хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд төр, орон нутгийн байгууллагуудын оролцоо.
- БНСУ
 - Зорилтот бүлгийн иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх, нөхцөлийг сайжруулахад төрийн болон орон нутгийн байгууллагын оролцоо, эрх үүрэг, санхүүжилтийн тогтолцоо;
 - Төрийн орон сууцны корпорацын бүтэц, үйл ажиллагааны чиглэл, эрх үүрэг, санхүүжилтийн тогтолцоо;
 - Төрийн болон орон нутгийн өмчийн түрээсийн орон сууцны сан бүрдүүлэх, уг санг ашиглахтай холбогдсон харилцаа.
- СИНГАПУР
 - Орон сууц ба Хөгжлийн Зөвлөл;
 - Зорилтот бүлгийн иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх, сайжруулахад ОСХЗ-ийн оролцоо;
 - Орон сууц ба Хөгжлийн Зөвлөлийн бүтэц;
 - Орон сууц ба Хөгжлийн Зөвлөлийн санхүүжилт;
 - Түрээсийн орон сууц;
 - Хуримтлалын төв сан.

- ОХУ
 - ОХУ-ын орон сууцны хангамжийн асуудал;
 - Зорилтот бүлгийн иргэдийн орон сууцны хангамж:
 - Эрх зүйн орчин;
 - Төрийн байгууллагуудын бүрэн эрх;
 - Зорилтот бүлгийн иргэдэд чиглэсэн төсөл, хөтөлбөр;
 - Нийтийн түрээсийн орон сууц.
 - Орон сууцны хөгжлийн нэгдсэн институт буюу “Орон сууц” ХК:
 - “Орон сууц” ХК-ийн зорилго, үйл ажиллагааны чиглэл;
 - “Орон сууц” ХК-ийн удирдлагын бүтэц, зохион байгуулалт, эрх, үүрэг;
 - “Орон сууц” ХК-ийн санхүүжилтийн эх үүсвэр;
- ЯПОН
 - Япон улсын орон сууцны хангамжийн асуудал;
 - Зорилтот бүлгийн иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх, нөхцөлийг сайжруулахад төрийн болон орон нутгийн байгууллагуудын оролцоо, эрх үүрэг, санхүүжилтийн тогтолцоо;
 - Төрийн болон орон нутгийн өмчийн түрээсийн орон сууцны сан бүрдүүлэх, сангийн үйл ажиллагаа, харилцаа.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

ХАВСРАЛТ

- Ц.Норовдондог, “Ипотекийн үнэт цаасны зах зээлийн хөгжлийн асуудал” Бодлогын дүн шинжилгээ, зах зээлийн харьцуулалт, 2011 он, УБ

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Төрийн орон сууцны санхүүжилтийн бодлогыг хэрэгжүүлэх арга хэрэгслүүд, тэдгээрийн давуу болон сул тал, бусад орнуудын туршлага

Орон сууцны санхүүжилтэд төсвийн болон төсвийн гадуурх эх үүсвэрийг үр ашигтай ашиглах нь орон сууцны санхүүжилтийн бодлогыг зөв төлөвлөлттэй, оновчтой явуулах чухал механизм болдог.

Олон улсын туршлагаас үзэхэд, орон сууцны санхүүжилтийн бодлогыг дараах үндсэн 3 хүрээг хамран хэрэгжүүлдэг байна. Үүнд:

- орон сууц худалдан авалтыг санхүүжүүлэх;
- орон сууц үйлдвэрлэлийг санхүүжүүлэх;
- орлого багатай айл өрхийг орон сууцаар хангахад төрөөс дэмжлэг үзүүлэх (зах зээлийн нөхцөлөөр банкнаас ипотекийн зээл авах боломжгүй айл өрхөд дэмжлэг үзүүлэх).

Эдгээр 3 үндсэн чиглэлийн хүрээнд төрийн орон сууцны санхүүжилтийн бодлогыг хэрхэн явуулах, орлогын янз бүрийн түвшинд байгаа айл өрхүүдийг орон сууцтай болгох асуудлыг ямар арга механизмаар, үр ашигтай, оновчтой шийдвэрлэх вэ гэдэг асуудал аль ч орны орон сууцны төрийн бодлогын стратегийн үндсэн зорилт юм.

Орон сууцны талаар төрөөс баримтлах бодлого нь хөгжиж байгаа орнууд төдийгүй хөгжингүй орнуудын төрийн бодлогын чухал бүрэлдэхүүн хэсэг байсан, байсаар ч байна. Дэлхийн ихэнх улс орнуудад төрөөс иргэдийнхээ орон сууцны асуудлыг шийдэхэд идэвхтэй оролцож, дэмжлэг үзүүлдэг бөгөөд төсвийн хөрөнгөнөөс орон сууцны нөхцөл сайжруулах зорилгоор иргэддээ үзүүлж буй дэмжлэг, татаас нь ДНБ-ний тодорхой хувиар хэмжигдэж байна. Тухайлбал, АНУ-д 2005 онд иргэдийнхээ орон сууцны нөхцөлийг сайжруулахад олгосон төсвийн дэмжлэг, татаас ДНБ-ны 0,3%-тай тэнцэж байна.

Төрөөс иргэдэд үзүүлэх орон сууцны санхүүжилтийн дэмжлэг болон төрийн оролцоо, түүнийг хэрэгжүүлэх арга механизм, боломж бололцоо нь дараах хүчин зүйлүүдээс хамааралтай байна. Үүнд:

- Улс орны эдийн засгийн хөгжлийн түвшин;
- Хүн амын амьжиргааны түвшин, орон сууцны нийт эрэлт хэрэгцээ;
- Улсын орон сууцны фондын хэмжээ;
- Орон сууцны ипотекийн зээлийн зах зээл, түүний хөгжил, түүний цар хүрээ;
- Орон сууцны ипотекийн зээлийн шаардлага, олгох нөхцөл;
- Орон сууцны барилга үйлдвэрлэл, түүний хүчин чадал;
- Орон сууцны салбарыг зохицуулж буй эрх зүйн орчин.

Олон улсын туршлагаас үзэхэд, орон сууцны хангамжийн талаар төрөөс баримтлах бодлого боловсруулахад хэд хэдэн зарчмыг баримталж байгаа нь харагдаж байна.

Орон сууцны хангамжийн бодлого, стратегийг боловсруулахад юуны өмнө бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлох нь чухал. Өөрөөр хэлбэл, төрөөс зайлшгүй оролцож дэмжлэг үзүүлэх шаардлагатай хүн амын хэсгийг тодорхойлох, суурьшил өндөртэй бүс нутгуудад иргэдийн амьжиргааны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх, орон

сууцны хүртээмжийг сайжруулж, худалдан авалтын нөхцөлийг хөнгөрүүлэх, орон сууцны зах зээлээр дамжуулан эдийн засгийн өсөлтийг дэмжих гэх мэт.

Төрөөс иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх асуудалд яагаад санаа тавих ёстой вэ?

- *Иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх нь нийгмийн тогтвортой байдлын хүчин зүйл болно.*

Нийгмийн тогтвортой байдлыг хадгалахын тулд орон сууцны түрээсийн зах зээлийг хөгжүүлэхээс илүүтэйгээр орон сууц өмчлөгч нийгмийн бүлгийг нэмэгдүүлэх нь чухал байдаг. Энэ зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд төрөөс орон сууцны татаас олгох хөтөлбөрийн шаардлагыг хангасан, хөтөлбөрт хамрагдах айл өрх, иргэд, тэдгээрт тавигдах шаардлага, сонгон шалгаруулах журмыг тодорхойлохоос гадна уг хөтөлбөрийн хүрээнд баригдах орон сууц, түүнд тавигдах шаардлага, стандартыг тодорхойлох хэрэгтэй болно.

- *Тогтмол суурьшлын бүсэд амьжиргааны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх шаардлага*

Ихэнх хөгжиж байгаа орнуудад (тухайлбал, Энэтхэг, Филиппин, Мексик гэх мэт) орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх бодлогын үндсэн арга хэрэгслийн нэг нь улсаас татаас олгох арга юм. Ялангуяа хүн амын ихэнх хэсэг нь амьжиргааны стандарт түвшингээс доогуур амьдралтай бүс нутагт хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэх зорилтын хүрээнд энэхүү арга хэмжээг түлхүү авч хэрэгжүүлсэн.

Өндөр хөгжилтэй орнуудад (АНУ, Нидерланд, Франц гэх мэт) амьжиргааны түвшин доогуур бүс нутагт татаасын аргыг хэрэглэж иргэдийн амьжиргааны хэвийн нөхцөлийг хангахад анхаарсан бол ОХУ-д хүн амьдрахад тааламжгүй бүс нутаг (Алс дорнод, түүнтэй адилтгах бүс нутаг) буюу байгаль экологи, гамшигт нэрвэгдсэн бүс нутагт энэхүү аргыг түлхүү хэрэглэсэн.

Орон сууцны хүртээмж, орон сууц худалдан авах боломжийг нэмэгдүүлэх хүрээнд орон сууцны зах зээлийн нөхцөл байдалд гүнзгий дүн шинжилгээ хийж, иргэд орон сууцтай болж чадахгүй байгаа шалтгааныг илрүүлэхэд анхаардаг. Энэ хүрээнд зах зээл дээрх орон сууцны нийлүүлэлт яагаад бага байгаа, эдийн засгийн болон эрх зүйн зохицуулалтын хүрээнд ямар арга хэмжээ авах, инженерийн дэд бүтцэд холбогдох боломжтой орон сууцны барилга барих газар дутагдалтай байгаа эсэх, барилга үйлдвэрлэлийн салбар дахь монополь, орон сууцны үйлдвэрлэлийн санхүүжилтийн эх үүсвэр, зээлийн зах зээлийн хөгжил зэрэг олон хүчин зүйлийг судалж дүгнэлт гаргах шаардлагатай болдог. Мөн иргэдийн орон сууц худалдан авах төлбөрийн чадвар муу байгаа шалтгаан: иргэдийн цалин, орлогын түвшин, орон сууцны зээлийн системийн хөгжил, орлогын эх үүсвэр багатай иргэдэд тавигддаг зээлийн хатуу нөхцөл, арилжааны банкууд эдийн засгийн өндөр орлоготой хэсэгтэй харьцаж ажиллах эрмэлзэлтэй байдаг шалтгаан, орон сууцны зах зээлийн хөгжил сул зэрэг олон хүчин зүйлийг дурдаж болно. Эдгээр хүчин зүйл болон шалтаг, шалтгааныг олж тодруулсны үндсэн дээр төрөөс орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх бодлого, хөтөлбөрийг боловсруулдаг.

- *Орон сууцны сектороор дамжуулан эдийн засгийн өсөлтийг идэвхижүүлэх шаардлага*

Эдийн засгийн хямрал, уналтын дараа орон сууцны секторын хөгжилд онцгой анхаарал хандуулах замаар нийт эдийн засгийн хөгжлийг идэвхжүүлж ирсэн туршлага олон оронд бий. Тухайлбал, АНУ-ын орон сууцны институтууд буюу Холбооны орон сууцны удирдах газар (Federal Housing Administration, FHA), 1934 болон Холбооны үндэсний ипотекийн нийгэмлэг (Federal National Mortgage Association, “Фэнни Мэй”)-ийг Засгийн газраас их хямралын дараа байгуулсан. Тэгвэл хөгжиж байгаа ихэнх орнуудын хувьд төсвийн хөрөнгө хүрэлцээгүй байдаг учраас орон сууцны зах зээлээр дамжуулан эдийн засгийн өсөлтийг хангах боломж хязгаарлагдмал.

Сүүлийн жилүүдэд гадаадын бусад орнуудын орон сууцны зах зээлд харилцан уялдаа бүхий 2 хандлага ажиглагдах болсон.

- 1) Орон сууцны эрэлтийг дэмжих бодлогын хүрээнд төсвийн татаасыг чухал арга хэрэгсэл болгон ашиглах болсон;
- 2) Орон сууцны зах зээлийг дэмжих, идэвхжүүлэх үйл ажиллагаан дахь төрийн оролцооны арга хэлбэр өөрчлөгдөж байгаа.

Орон сууцны бодлогыг хэрэгжүүлэх чухал арга хэрэгслүүдийн нэг нь орон сууцны санхүүжилтийн системтэй холбоотой төрөл бүрийн татаасууд байдаг.

Гадаадын бусад орнуудын туршлагыг харьцуулан судалсны үндсэн дээр төрөөс орон сууцны санхүүжилтийг дэмжих, иргэд орон сууц худалдан авах болон ипотекийн зээлд хамрагдах нөхцөлийг хөнгөвчлөх үүднээс дараах хэд хэдэн төрлийн татаас болон дэмжлэгүүдийг ашигладаг байна. Үүнд:

- Зах зээлийн нөхцөлөөр олгосон ипотекийн зээлийн хүүний зөрүүд татаас олгох;
- Тусгай сангийн эх үүсвэрээс татаас олгох замаар зах зээлийн хүүнээс доогуур хувиар орон сууцны зээл олгох;
- Ипотекийн зээлийн хүүний төлбөрийг орлогын албан татвараас чөлөөлөх замаар орон сууцны зээлийн хөнгөлөлт үзүүлэх;
- Орон сууцны хадгаламжийг төрөөс дэмжих хөтөлбөрүүд хэрэгжүүлэх;
- Орон сууцны ипотекийн зээлийн эрсдэлийг төрийн даатгалд хамруулах;
- Орон сууцны зээлийг төрийн банкаар дамжуулан санхүүжүүлэх;
- Орон сууцны ипотекийн зээлэнд хамрагдаж буй иргэнд төрөөс 1 удаагийн татаас хэлбэрээр зээлийн урьдчилгаа төлбөр олгох.

Дээрх татаас болон дэмжлэгүүдийн давуу болон сул талуудыг харьцуулан авч үзвэл:

1. Зах зээлийн нөхцөлөөр олгосон ипотекийн зээлийн хүүний зөрүүд татаас олгох

Энэ тохиолдолд төрөөс зээлдэгчийн төлөх орон сууцны ипотекийн зээлийн хүүг зах зээлийн хүүнээс доогуур хувиар тогтоох ба хүүний зөрүүг банк санхүүгийн байгууллагад татаас хэлбэрээр олгоно. Өөрөөр хэлбэл, зээлдүүлэгч байгууллагад зээлийн хүүний хөнгөлсөн/ бууруулсан хэсэгт нь татаас хэлбэрээр нөхөн олговор олгож, зээлдэгч иргэнд хөнгөлөлттэй хүүгээр зээл олгоно.

Зээлийн хүүний хөнгөлөлт нь хэлбэр, хугацааны хувьд өөр байж болно. Тухайлбал, зээлийг бүрэн төлж дуусах хүртэлх хугацаанд, эсхүл зээл олгох үед

тогтоосон хугацаанд, эсхүл зээлдэгчийн орлогоос хамааран аажим буурах, эсхүл зээлийн хугацаа хэтрэлтээс хамааруулан бууруулах гэх мэт.

Тодорхой нөхцөл байдал үүссэн тохиолдолд зээлийн хүүний зөрүүд олгох татаасыг зогсоож болно. Жишээлбэл, АНУ-д хэрэв зээлдэгч хөнгөлөлттэй нөхцөлөөр худалдан авсан зээлийн байшиндаа тодорхой хугацаанд (5-6 жил) оршин сууж амьдраагүй бол тэрээр зээлийн хүүний зөрүүд олгосон татаасыг эргүүлэн төлөх үүрэгтэй. Ийм төрлийн татаасыг тодорхой төрлийн орон сууцнууд (үнэ өртгийн хувьд тодорхой хязгаар тогтоосон шинэ байшин) болон тодорхой зорилтот бүлэгт хамаарах гэр бүлийн (анх удаа байр худалдан авсан) орон сууцны зээлд олгогдоно.

Энэ төрлийн татаасаас үүдэлтэй гол асуудал нь ирээдүйд санхүүгийн зах зээл дээр үүсч болзошгүй нөхцөл байдал болон инфляцын түвшингийн өөрчлөлтийг урьдчилан тооцож, үүнтэй уялдуулан төсвийн зардлыг төлөвлөхөд хүндрэлтэй байдаг.

Зээлийн хүүний зөрүүд татаас олгох төрийн бодлогын арга хэрэгслийн сул талыг дараах байдлаар тайлбарласан байна. Үүнд:

Зээлийн хүү бол зах зээлийн хэрэгсэл юм. Зээлийн хүүний хэмжээг тухайн банкны зээлийн эх үүсвэр хэлбэрээр татан төвлөрүүлсэн хөрөнгийн өртөг, банкны үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэл, үүний дотроос ипотекийн зээл олголттой холбоотойгоор үүсч болзошгүй эрсдэлийн үнэлгээ зэрэг зах зээлийн хүчин зүйлсийн нөлөөллөөс хамааруулан тогтоодог. Түүнээс гадна ипотекийн зээлийн хугацаа урт байдаг тул хэрэв эдийн засагт тогтворгүй байдал үүсвэл зээл-санхүүгийн зах зээл дээр ч мөн болзошгүй өөрчлөлт, эрсдэл үүсч болох юм. Үүнээс үүдэн зээлийн хүү өсөх, улмаар зээлийн хүүд олгож байгаа татаасын хэмжээ нэмэгдэх нөхцөл үүсч төсөвт ачаалал үүсгэх талтай. Өөрөөр хэлбэл, төсөвт нэмэлт эрсдэл үүсгэхээс гадна банк санхүүгийн байгууллагад төсвөөс олгох татааст хөрөнгө хүрэлцэхгүйн улмаас тэд ч мөн эрсдэл хүлээх, энэ хэмжээгээр банкны ашигт ажиллагаанд нөлөөлөх байдал үүсч болзошгүй. Зээлийн хүүд төрөөс олгох татаасын хэмжээг тооцоолоход төвөгтэй байдаг бөгөөд учир нь энэхүү хөрөнгийн хэмжээ зээл-санхүүгийн зах зээл дээр үүсч болзошгүй нөхцөл байдал, санхүүгийн зах зээлийн хандлагаас ихээхэн хамааралтай байдаг учраас урьдчилан төлөвлөх, тооцоолоход хүндрэлтэй.

Төрөөс зээлийн хүүд татаас олгох хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа үед харгалзан үзэх бас нэг чухал хүчин зүйл бол ипотекийн зээлийн зах зээл дэх өрсөлдөөн юм. Хэрэв зах зээл дээр өрсөлдөөн хязгаарлагдмал байгаа бол цөөн тооны банк монополь эрхтэйгээр ипотекийн зээлийн хүүний татаасыг авах болно. Энэ тохиолдолд төрөөс олгож байгаа татаас нь ипотекийн зээлийн эрэлтийг даган нэмэгдэж, улмаар зах зээл дээрх ипотекийн нийт зээлийн хүүний түвшинг нэмэгдүүлэхэд нөлөөлнө.

Зээлийн хүүний зөрүүд татаас олгох хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэх эхний үед зарцуулах хөрөнгийн хэмжээ харьцангуй бага байж болох ч явцын дунд санхүүгийн зах зээл дээрх нөхцөл байдлаас үүдэн төсвөөс зарцуулагдах хөрөнгийн хэмжээ өөрчлөгдөж ч болох юм. Иймд төсвөөс татааст олгох хөрөнгийн хэмжээг бүх параметраар, хөтөлбөрийн хэрэгжих бүх хугацаагаар тооцох шаардлагатай. Жишээлбэл, Чех улсад 2005 оноос эхлэн шинээр худалдан авч байгаа орон сууцны зээлийн хүүг бууруулах арга хэмжээ авч эхэлсэн бөгөөд явцын дунд зах зээл дээрх зээлийн хүүний түвшин 3-4%-иар буурсан тул татаасын хэмжээ буурсан. Унгар Улсад

ипотекийн бондын хүүний зөрүү болон шинээр орон сууц худалдан авч байгаа иргэдэд зээлийн хүүний зөрүүд улсаас татаас олгодог. Йордан улс жил бүр орон сууцны зээлийн хүүний хөнгөлөлтийн зөрүүд улсын төсвөөс хөрөнгө төсөвлөдөг бөгөөд ирээдүйд гарах энэ төрлийн зардлыг ч мөн төсөвт суулгахаар төлөвлөдөг.

2. Тусгай сангийн эх үүсвэрээр зах зээлийн хүүгээс доогуур хувиар орон сууцны зээл олгох

Төрөөс орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх хүрээнд тусгай зориулалтын сан байгуулж энэхүү сангаас хөнгөлөлттэй нөхцөлөөр орон сууц худалдан авах болон орон сууцны барилга үйлдвэрлэлийг санхүүжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Жишээ нь, Бразил улсад ажилтнуудын нийгмийн баталгааны сан байгуулах, Индонезид банк санхүүгийн байгууллагад төрөөс хямд өртөгтэй (бага хүүтэй) зээл олгох, Мексикт Орон сууцны тусгай зориулалтын сан байгуулах, Филиппин улсад Тэтгэврийн сангаас орон сууцны зээлийн санхүүжилтэнд зориулан бага хүүтэй зээл олгодог гэх мэтийн туршлагауд гадаадын зарим оронд байна.

Тусгай зориулалтын сангаас хямд өртөгтэй зээлийн эх үүсвэр гаргах замаар орон сууцны санхүүжилтийг дэмжих бодлогын энэхүү арга хэрэгслийн сул тал нь гэвэл магадгүй санхүүгийн зах зээл дээр гажуудал үүсгэж болзошгүй. Учир нь төрийн дэмжлэгтэйгээр орон сууцны зээл олгож байгаа банкууд санхүүгийн зах зээлд давамгайл байдал үүсгэх ба ингэснээр хувийн хөрөнгө оруулалттай банк санхүүгийн байгууллагууд зах зээлээс шахагдаж бага орлоготой айл өрхөд орон сууцны зээл олгох боломжгүй болох, санхүүгийн зах зээлийн хөгжил удаашрах, шинэ төрлийн банк санхүүгийн институт гарч ирэхэд саад учруулах, улмаар өрсөлдөөнийг хумих нөхцөл үүсгэх талтай.

Давуу тал нь орон сууцны зээлийн хүүний зөрүүд төсвөөс татаас олгох шаардлагагүй, банк санхүүгийн байгууллага болон тусгай зориулалтын сангууд зээлийн эргэн төлөлттэй холбоотой эрсдэлийг хүлээх учраас төрөөс үүнд зориулан мөнгө төсөвлөх, алдагдал хүлээх шаардлагагүй болно.

3. Ипотекийн зээлийн хүүний төлбөрийг орлогын албан татвараас чөлөөлөх замаар орон сууцны зээлийн хөнгөлөлт үзүүлэх

Орон сууцны зээлийн хөнгөлөлт үзүүлэх энэхүү арга нь орон сууц худалдан авах болон орон сууцны нөхцөл сайжруулах зорилгоор авсан зээлийн хүүг тухайн этгээдийн татвар ногдох орлогоос хасч тооцоход чиглэгдэнэ. Энэхүү бодлогын арга хэрэгслийг практикт хэрэгжүүлэх хэд хэдэн арга, онцлог нөхцөлүүд байдаг. Үүнд:

- Татвар ногдох орлогоос зөвхөн зээлийн хүү төдийгүй үндсэн зээлийн төлбөр болон үл хөдлөх хөрөнгийн татварыг хасч тооцох (Португали, Норвеги)
- Татвар ногдох орлогоос хасч тооцох зээлийн хүүний хэмжээг тогтоох, эсхүл хөнгөлөлтөнд хамаарах зээлийн нийт хэмжээнд хязгаар тогтоох (Их британи, Финланд, Дани)
- Татварын зээл (зээлийн хүүний тодорхой хувийг татварын дансанд бүртгэж татвар төлсөнд тооцох) (Финланд, Герман)
- АНУ-д орон сууцны зээлийн хүүний зөрүүд олгох татварын хөнгөлөлтөнд хязгаар тогтоодоггүй.

Энэхүү бодлогын арга хэрэгслийн сул тал нь гэвэл, хамгийн их орлого өндөртэй гэр бүлүүд хамгийн их хөнгөлөлт эдлэх, хамгийн бага орлоготой гэр бүлүүд хамгийн бага хөнгөлөлт эдлэх нөхцөл үүсдэг. Учир нь бага орлоготой айл өрхүүд нэг бол орлогын албан татвараас чөлөөлөгддөг, эсхүл орон сууц худалдан авахад хүрэлцэхүйц хангалттай хэмжээний орлогогүй байдаг учраас татварын хөнгөлөлтөнд тэр бүр хамрагдаж чаддаггүй.

4. Орон сууцны хадгаламжийг төрөөс дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх

Орон сууцны хадгаламжийг төрөөс дэмжих хөтөлбөрийн схем нь үндсэндээ ХБНГУ-ын барилгын хадгаламжийн хоршооны загвараар хэрэгжинэ. Өөрөөр хэлбэл, хөтөлбөрт хамрагдсан иргэн жил бүр хуримтлуулсан мөнгөндөө хүү авах ба хүүний хуримтлуулсан орлогыг зөвхөн гэрээгээр тогтсон хугацаа өнгөрсний дараа л данснаас хасч болдог. Энэхүү үйл ажиллагааг тусгай эрх бүхий санхүүгийн байгууллага буюу Барилгын хадгаламжийн касс (Bausparkassen) эрхлэн явуулна.

Үйл ажиллагааны зарчим: Барилгын хадгаламжийн касс (БХК) нь иргэнтэй хадгаламжийн гэрээ байгуулах ба гэрээгээр хадгаламжийн дансанд хөрөнгө хуримтлуулах болон үл хөдлөх хөрөнгө барьцаалан зээл олгох нөхцөлийг тохирно. Энэ төрлийн хадгаламжид олгож буй хүүний хэмжээ зах зээлийн хүүнээс доогуур байдаг тул зээлийн хүү ч мөн зах зээлийн хүүнээс доогуур хувьтай байна.

Энэ аргыг хэрэглэж буй нэг жишээ нь Франц улс юм. Францад иргэн хүн өөрийн хөрөнгөө санхүүгийн компани болон арилжааны банкуудад ирээдүйд орон сууцны зээл авах зорилгоор хадгаламж хэлбэртэй байршуулна. Барилгын хадгаламжийн энэхүү системийн зарчим нь, банк санхүүгийн байгууллага иргэдийн хадгаламжийг орон сууцны зээлийн зориулалтаар хуримтлуулснаар зээлийн эх үүсвэрт шаардагдах хөрөнгийн хэмжээгээ нэмэгдүүлэх, зээлдэгчийн төлбөрийн чадварыг үнэлэх боломжтой болох, улмаар энэхүү хуримтлуулсан хямд өртөгтэй зээлийн эх үүсвэрийг орон сууцны санхүүжилтэнд нэмэлт эх үүсвэр болгон зах зээлийн хүүгээр олгох боломж бүрдүүлэхэд оршино.

Барилгын хадгаламжийн системийн хүрээнд иргэдийг орлогын түвшингээр нь ялгаварлан ангилдаггүй учраас орлогын янз бүрийн түвшингийн айл өрхүүд энэхүү зээлийн хөтөлбөрт хамрагдах боломжтой. Төрөөс олгож буй татаасын ихэнх хувь нь дундаж орлоготой айл өрхөд ногддог бөгөөд эдгээр айл өрхүүд нь барилгын хадгаламжийн хөтөлбөрт хамрагдахгүйгээр ипотекийн зээл авах, орон сууц худалдан авах хэмжээний хадгаламжийн хуримтлал үүсгэх чадвартай байдаг. Германд орон сууцны зээлийн хүүний зөрүүд олгох татаасын хэмжээнд хязгаарлалт тогтоож өгсөн байх ба ийм төрлийн зээлийг зөвхөн ипотекийн ердийн зээл дээр нэмэлт болгон авч ашиглана. Орон сууцны хадгаламжийн схемийг Герман, Франц, Чех, Унгар, Словак, Чили, Өмнөд Африк зэрэг орнуудад амжилттай ашиглаж байна.

Орон сууцны хадгаламжийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой шийдвэрлэх хамгийн гол асуудал бол энэ төрлийн хадгаламжийг татан төвлөрүүлэх хөшүүргийг бий болгох явдал юм. Орон сууцны хадгаламжийн хүү нь зах зээлийн хүүнээс доогуур хувьтай байдаг учраас орон сууцны зээлд хамрагдах шаардлагагүй иргэд төдийлөн сонирхдоггүй. Ийм учраас бусад орнуудад төрөөс орон сууцны санхүүжилтийн эх үүсвэрт иргэдийн хадгаламжийг татах механизм буюу хадгаламжийн хүүний зөрүүд

татаас олгох аргыг хэрэгжүүлж байна. Энэхүү арга нь төрөөс орон сууцны хадгаламжийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд үзүүлж буй чухал дэмжлэг юм.

Дээр нэрлэсэн орнуудад орон сууцны хадгаламжийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ тодорхой болзол, нөхцөл хангасан хадгаламжийн хуримтлалд төрөөс татаас өгөх замаар хэрэгжүүлсэн. Хамгийн гол асуудал нь татааст олгох хөрөнгийг тооцож улсын төсөвт суулгах асуудал юм. Ялангуяа эдийн засгийн байдал тогтворгүй, инфляцыг тодорхой түвшинд барьж чадахгүй үед хэдий хэмжээний хөрөнгийг төсвөөс гаргахыг тооцоолоход хүндрэлтэй байдаг. Жишээ нь, ипотекийн зээлийн хүү 5-6% байгаа үед ипотекийн хадгаламжийн хүүг 3-4% байлгана, энэ тохиолдолд төрөөс орон сууцны санхүүжилтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд хадгаламжийн хүүг инфляцын 10%-ийн түвшинд ойролцоогоор 11-12%-тай байлгах шаардлагатай болдог. Энэ түвшинд барьж байж иргэдийн хадгаламжийг ханшийн уналтаас хамгаалж, тодорхой хэмжээнд ашиг авчрах нөхцөлийг бүрдүүлнэ. Орон сууцны санхүүжилтийн эх үүсвэрийг хадгаламж татан төвлөрүүлэх аргаар шийдвэрлэж байгаа үед төрөөс хүүний зөрүүд татаас өгөх хэлбэрээр оролцох бөгөөд хамгийн чухал шаардлага нь төсвийн хөрөнгийг зөв тооцоолох, зориулалтын дагуу зарцуулах, мэдээллийн ил тод байдлыг хангах явдал юм.

5. Ипотекийн зээлийн эрсдэлийг төрөөс даатгах (ипотекийн даатгал)

Бусад орнуудын туршлагаас үзэхэд, төрөөс ипотекийн зээлийг бүхэлд нь буюу хэсэгчлэн даатгах хариуцлагыг өөр дээрээ авдаг. Өөрөөр хэлбэл банк санхүүгийн байгууллагуудаас зээлдэгчид олгосон ипотекийн зээлийг бүхэлд нь, эсхүл тодорхой хэсгийг эргэн төлөхтэй холбоотой эрсдэл үүссэн тохиолдолд төр хариуцахаар баталгаа гарах (батлан даах) буюу зээлийн төрийн (улсын) даатгалд хамруулдаг.

Ипотекийн зээлийн даатгалд төлбөрийн чадварын стандарт шаардлага хангасан гэр бүлийг хамруулна. Тухайлбал, тодорхой хэмжээний орлоготой боловч орон сууцны зээлийн урьдчилгаа төлбөрийг төлөх хэмжээний хуримтлал үүсгэж чадаагүй айл өрхүүдийг ихэвчлэн хамруулна, ингэснээр орон сууцны зээлийн хүртээмжийг нэмэгдүүлж, төрөөс орон сууцны хангамжийг нэмэгдүүлэхэд тодорхой хэмжээний дэмжлэг үзүүлэх нөхцөл бүрдэнэ.

Ипотекийн даатгалын системийн зорилго нь иргэд (эсхүл тодорхой зорилтот бүлгийн иргэд) барьцаа хөрөнгийн үнэлгээтэй харьцуулахад илүү хэмжээтэй зээл (LTV) авах боломжийг бүрдүүлэхэд чиглэгдэнэ. Ипотекийн зээлийн энэхүү схем нь ялангуяа тодорхой зорилтот бүлгийн иргэдийг орон сууцаар хангахад илүү тохиромжтой. Учир нь орон сууцны үнэ болон олгох зээлийн хэмжээнд тодорхой хязгаарлалт тогтоох замаар энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. Ийм маягаар төрөөс ипотекийн даатгалын системийг хөгжүүлснээр мэргэшсэн үйлчилгээний тогтолцоог хөгжүүлж, зээлдэгчдийн хүрээг өргөтгөх, урт хугацаатай орон сууцны зээлийн зах зээлийг хөгжүүлэх боломж нэмэгдэнэ.

Нөгөө талаас, орон сууцны зээлийн урьдчилгаа төлбөрийн хэмжээг бууруулснаар барьцаа хөрөнгийн үнэлгээнээс үл хамааран зээлдүүлэгчийн зүгээс өндөр дүнтэй зээл олгох байдал үүсэх бөгөөд магадгүй энэ нь тодорхой хэмжээнд зээлийн нэмэлт эрсдэл үүсгэж, зээлдэгч бүрэн төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд санхүүгийн хохирол үүсгэж болзошгүй. Ипотекийн эрсдэлийн даатгалын

гэрээгээр зээлдэгч- банкны энэхүү зээлийн нэмэлт эрсдэлийг бүрэн болон хэсэгчлэн төрөөс хариуцахаар зохицуулдаг.

Энэ тохиолдолд ипотекийн даатгалын гэрээ нь хэрэв зээлдэгч төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд, эсхүл зээлийн барьцаа хөрөнгийг худалдан борлуулснаас олсон орлого нь зээл, зээлийн хүүний төлбөрт хүрэлцэхгүй байгаа тохиолдолд хохирлыг барагдуулах нэмэлт баталгаа болж өгдөг. Даатгалын тохиолдол үүссэн үед даатгалын компани нь гэрээнд заасны дагуу даатгалын нөхөн төлбөр олгох хязгаарт багтаан хохирлыг барагдуулах ба нөхөн төлбөрийн хэмжээг гэрээгээр тохирно.

Ипотекийн даатгалын системийг орон сууцны хангамжийг дэмжих бодлогын хэрэгсэл болгон ашиглаж байгаа, энэ төрлийн даатгалын систем өндөр хөгжсөн орнуудыг нэрлэвэл АНУ (хямд өртөг бүхий орон сууцны эргэн төлөлтийн эрсдэлийг төрөөс бүрэн хариуцдаг, мөн ахмад дайчдад зориулсан тусгай хөтөлбөр хэрэгжүүлдэг), Канад, Филиппин, ӨАБНУ-ыг нэрлэж болно.

Тухайлбал, 1934 онд АНУ-ын Засгийн газраас Холбооны Улсын Төрийн Орон сууцны удирдах газар болон түүний харьяанд АНУ-ын орон сууц, хотын хөгжлийн газрыг байгуулсан. Эдгээр байгууллагууд нь зээлийн эрсдэлийн даатгалыг хариуцан хэрэгжүүлдэг бөгөөд зээлдэгчдийн төлбөрийн чадвар муудсанаас үүдэлтэй банк санхүүгийн удаа дараагийн хямралыг амжилттай даван туулах, ипотекийн зээлийн анхдагч болон хоёрдогч зах зээлийг сонгодог утгар нь хөгжүүлэхэд ихээхэн түлхэц болсон юм. Банк санхүүгийн байгууллагууд төрийн орон сууцны удирдах газрын даатгалд хамрагдсан зээлдэгчид барьцаа хөрөнгийн үнэлгээний 95-97%-д зээл олгож байсан бөгөөд зээлдэгч дампуурсан, төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд төрөөс хохирлыг бүрэн хариуцна гэсэн баталгаагаар хангагдаж байсан юм. Ингэснээр ипотекийн зээлд хамрагдах иргэд, тэрэн дундаа орлогын түвшин доогуур иргэдийн ипотекийн зээлд хамрагдах боломж нэмэгдэж, ипотекийн зээлийн хэмжээ эрс өссөн юм.

Хуучин социалист орнуудаас одоогийн байдлаар ОХУ, Казахстан, Литва улсад ипотекийн даатгалын энэхүү системийг төлөвшүүлэн хөгжүүлэхэд ихээхэн анхаарч байна. Тухайлбал, Казахстан улсад “Ипотекийн зээлийн баталгааны сан” байгуулагдсан ба 2002 оноос эхлэн хувийн даатгалын компаниуд энэ төрлийн зээлийн эрсдэлийн даатгалын үйлчилгээг үзүүлж эхэлсэн. Литва улсад 2000 онд ипотекийн зээлийн эрсдэлийн төрийн даатгалын систем үүссэн.

6. Төрөөс ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрт зориулан нэг удаагийн татаас олгох

Дээр дурдсан ипотекийн зээлийн зах зээлийг дэмжих бодлогын арга хэрэгслүүд нь ихэвчлэн шууд бус замаар иргэдийг орон сууцтай болоход нь дэмжлэг үзүүлэх аргууд юм. Тэгвэл төрөөс иргэдэд орон сууны зээлд хамрагдах урьдчилгаа төлбөрийг хэлбэрээр нэг удаагийн татаас хэлбэрээр олгох аргыг шууд дэмжлэгт тооцно. Тухайлбал, ХБНГУ-д орон сууцны ипотекийн зээлд хамрагдаж байгаа бүх иргэдэд зээлийн урьдчилгаа төлбөрийг улсаас нэг удаа олгоно. Тэгвэл Чили, Коста-Рика, Эквадор зэрэг орнуудад урьдчилгаа төлбөрийн дэмжлэгт бага болон дунд орлоготой, анх удаа орон сууц худалдан авч байгаа айл өрхүүдийг хамруулна.

Шууд татаас авах төрийн дэмжлэгийг орон сууцны зээлд хамрагдах хүсэлтэй боловч зээлийн урьдчилгаа төлбөрт шаардагдах хөрөнгийг хуримтлуулж чадахгүй байгаа иргэдийг түлхүү хамруулна. Нэг удаагийн татааст хамрууллаа ч гэсэн үүний үр ашгийг гаргаж чадахгүй иргэдэд банк төдийлөн зээл олгохгүй учраас үр ашиггүй. Татаасыг зээлийн урьдчилгаа төлбөр төлөх, хэлцлийн төлбөр гүйцэтгэх болон шаардагдах зээлийн хэмжээг бууруулах замаар олгоно.

Хэрвээ бага орлоготой айл өрхийг татааст хамруулж байгаа бол худалдан авах орон сууцны байршил, төрөл, үнэ зэргийг төрөөс тусгайлан зааж өгнө. Энэхүү арга нь захиргааны зохицуулалтын шинжтэй тул хөтөлбөрийг боловсруулахдаа хэнд зориулж байгаа, ямар бүлгийн хүмүүс энэхүү дэмжлэгт хамрагдахыг тодорхойлох хэрэгтэй. Ингэснээр олгох татаасын хэмжээ, түүнийг хэрэгжүүлэх механизм ил тод, тодорхой болох бөгөөд дэмжлэгт хамрагдах зорилтот бүлгийн зээлдэгчдийн төлбөрийн чадвар нэмэгдэхийн хэрээр татааст олгох хөрөнгийн хэмжээг бууруулан тооцох боломжтой болно.

Урьдчилгаа төлбөрт татаас олгох аргыг ихэвчлэн хуримтлалын хөтөлбөртэй хамтатган хэрэгжүүлэх буюу хөтөлбөрт хамрагдсан иргэний зүгээс төлбөрийн чадвар, үүсгэсэн хуримтлалын талаарх мэдээллийг өгсөнөөр үүнтэй учлдуулан олгох зээлийн хэмжээг бууруулах, аль болохоор бусад зээлдэгчдэд хүртээмжтэй байлгах бодлого баримтална. Тухайлбал, Чили улсад энэ төрлийн хөтөлбөрт эхний ээлжинд бага орлоготой айл өрхүүдийг хамруулсан. Ингэхдээ хөтөлбөрийн нөхцөлийн дагуу зөвхөн шинэ байшин худалдан авах айл өрхүүдэд нэг удаагийн зээлийн урьдчилгаа төлбөр олгосон бөгөөд эдгээр айл өрхүүд нь хувийн банкны зээлийн шаардлагыг хангаж чадахгүй ч гэсэн төрийн банкнаас нэмэлт санхүүжилт авч чадах хэмжээнд байх ёстой гэсэн шаардлагыг тавьсан. Хамгийн гол нь хөтөлбөрийн хүрээнд эдгээр айл өрхүүд тодорхой хэмжээний хуримтлал үүсгэх шаардлагыг хэрэгжүүлж ажилласан.

7. Төрийн орон сууцны банкаар дамжуулан санхүүжүүлэх

Орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх энэхүү аргыг Африкийн ихэнх орнууд, Бразил, Индонез, Йордан, Тайланд зэрэг орнуудад ихэвчлэн хэрэглэсэн. Одоогоор эдгээр төрийн орон сууцны банкууд хувьчлагдах буюу татан буугдсан байдалтай байна. Тухайлбал, Тайландад Төрийн орон сууцны банк нь орон сууцны зээлийн тогтолцоо үүсэн бий болж төлөвших үндсэн нөхцөлийг бий болгосон бөгөөд одоо ч гэсэн хувийн банк санхүүгийн байгууллагуудыг бага орлоготой иргэдэд орон сууцны зээл олгох ажиллагаанд татан оролцуулахад тодорхой үүрэг гүйцэтгэсээр байна. Йорданий төрийн орон сууцны банк нь арилжааны банкны статустай.

Бусад орнуудын туршлагаас үзэхэд, төрийн орон сууцны банкаар дамжуулан орон сууцны санхүүжилт олгох энэхүү арга нь хувийн хэвшлийн банкууд урт хугацаатай, хүү багатай орон сууцны санхүүжилтийн зээл олгох нөхцөл бүрдээгүйн улмаас төрийн орон сууцны бодлогыг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байгаа, шинэ тутам ипотекийн зээлийн систем үүсэн бий болж байгаа улс орнуудад тохиромжтой бөгөөд орон сууцны санхүүжилтийн зах зээлийн хөгжлийг хурдасгахад чухал үүрэг гүйцэтгэсэн байдаг.

Энэ аргыг хэрэглэж байгаа үед тулгарч болзошгүй асуудал нь төрийн банкны үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх тухай асуудал юм. Учир нь төрийн статустай

банкны үйл ажиллагааны болон захиргааны зардал өндөр байх, мөн зээлийн эргэн төлөлт, найдваргүй зээлийн улмаас үүсэх алдагдал их байх магадлалтай.

Давуу тал нь гэвэл, төрийн орон сууцны бодлогыг хэрэгжүүлэхэд хялбар, энгийн, шууд зохицуулалтын арга юм.

Дүгнэж хэлэхэд, дээрх орнуудын туршлага, төрийн орон сууцны бодлогыг хэрэгжүүлэх арга механизмууд нь дэлхий нийтэд хэрэглэгдэж байгаа түгээмэл арга хэрэгслүүд бөгөөд улс орон бүр өөр өөрийн үндэсний эдийн засгийн онцлог, төсвийн боломжид нийцүүлэн аль тохиромжтой арга хэрэгслүүдийг ашиглан иргэдээ орон сууцаар хангах бодлого, стратеги боловсруулан ажиллаж байна.

Орон сууцны санхүүжилтийн зах зээлийг төрөөс яагаад дэмжих ёстой вэ гэдэг асуултын хариулт энгийн юм. Учир нь зах зээлийн эдийн засгийн харилцаатай аль ч оронд орон сууц, газар, түүний дээр байгаа барилга байгууламжууд бүхэлдээ үндэсний баялагт тооцогдох ба үл хөдлөх хөрөнгөд оруулсан иргэдийн хөрөнгө оруулалт нь тухайн айл өрхийн материаллаг актив хөрөнгө байдаг. Улс орон бүрийн хэрэгжүүлж байгаа ядуурал болон утааг бууруулах, иргэдийнхээ амьдралын чанарыг сайжруулах, эрүүл, тохь тухтай орчинд иргэдээ амьдруулах стратегийн зорилтууд нь тухайн орны эдийн засгийн хөгжлийн бодлогын хамгийн гол үндсэн чиглэлүүдийн нэг байдаг.

1.АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС

Орон сууцны санхүүжилтийн тогтолцоон дахь төрийн оролцооны талаарх тойм⁵²

Холбооны засгийн газар нь 1930-аад оны эдийн засгийн хямралаас үүдэлтэйгээр санхүүгийн тогтолцооны тогтвортой байдлыг хангах, барилгын салбарт ажлын байр бий болгох зорилгоор орон сууцны салбарт төрөөс дэмжлэг, туслалцаа үзүүлж эхэлсэн байна. Ийнхүү санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор 1932 онд Холбооны орон сууцны ипотекийн банкны тогтолцоо (Federal Home Loan Bank System)-г, бусад зээлдэгчдийн хугацаа хэтэрсэн ипотекийн зээлийг дахин санхүүжүүлж, урт хугацаат, тогтмол хүүтэй зээл олгох үүрэг бүхий Орон сууц эзэмшигчдийн ипотекийн корпорац (Homeowners Mortgage Enterprises, Inc)-ыг 1933 онд, ипотекийн даатгалын үйл ажиллагаа

эрхлэх Холбооны орон сууцны удирдах газар (Federal Housing Administration)-ыг 1934 онд тус тус байгуулсан байдаг. Тухайн үед Холбооны орон сууцны ипотекийн банк болон Холбооны орон сууцны удирдах газар нь бага орлоготой иргэдэд дэмжлэг үзүүлэхээс илүүтэйгээр зээлийн байгууллагуудад дэмжлэг үзүүлж, АНУ-ын эдийг засгийг хямралаас гаргахад голлон анхаарч байсан.

1937 онд батлагдсан АНУ-ын орон сууцны тухай хуулиар бага орлоготой иргэдэд зориулсан орон сууц барьж байгуулахыг урт хугацаат бондоор санхүүжүүлэх эрхийг орон нутгийн орон сууцны асуудал эрхэлсэн удирдлагуудад олгож, Төрийн орон сууцны хөтөлбөрийг эхлүүлсэн байдаг. 1938 онд анхны засгийн газрын санхүүжилттэй байгууллага (government sponsored enterprise) болох орон сууцны ипотекийн зээлүүдийг банкууд болон бусад анхдагч зээлдэгч нараас худалдан авч, үнэт цаасжуулж, хөрөнгө оруулагчдад худалдан борлуулах үүрэг бүхий АНУ-ын Холбооны үндэсний ипотекийн нийгэмлэг (Federal National Mortgage Association, “Фэнни Мэй”)-ийг байгуулан, ипотекийн хоёрдогч зах зээлийн хөгжлийн эхлэлийг тавьсан байна.

Дэлхийн II дайны дараагаар цэргүүд эх орондоо эргэн ирж орон сууцны зах зээл дээр хомсдол үүссэнийг Ахмад дайчдын орон сууцны ипотекийн баталгааны удирдах газар байгуулах замаар шийдвэрлэж, Холбооны орон сууцны удирдах газрын орон

1930

- 1934 оны Үндэсний орон сууцны тухай хууль
- 1937 оны АНУ-ын орон сууцны тухай хууль

1940

- 1949 оны АНУ-ын орон сууцны тухай хууль

1950

- 1954 оны АНУ-ын орон сууцны тухай хууль
- 1956 оны Орон сууцны тухай хууль

1960

- 1961 оны Орон сууцны тухай хууль
- 1965 оны Орон сууц, хотын хөгжлийн яамны тухай хууль
- 1968 оны ОСХХЯ-ны тухай хууль

1970

- 1974 оны ОСХХЯ-ны тухай хууль

1980

- 1983 оны Орон сууц ба хотыг сэргээн босгох тухай хууль

1990

- 1990 оны Үндсэнхий хүртээмжтэй орон сууцны тухай хууль
- 1992 оны орон сууцны орон нутгийн хөгжлийн тухай хууль

2000

- 2008 оны Орон сууц ба эдийн засгийг сэргээх тухай хууль

⁵² The Federal Role in Housing, <https://webcache.googleusercontent.com/search?q=cache:RIIB1-MDrDAJ:https://govinfo.library.unt.edu/mhc/FRH.doc+&cd=3&hl=en&ct=clnk&gl=mn&client=safari>

сууцны ипотекийн даатгалын үйл ажиллагааг өргөжүүлсэн байна. 1949 оны Орон сууцны тухай хуульд “Америк гэр бүл бүрийг тохиромжтой орон сууц, амьдралын таатай орчноор хангах” зорилгыг дэвшүүлсэн байна. Мөн хуулийн хүрээнд ядуусын хорооллыг арилгах, газар худалдан авах өртгийг бууруулахад орон нутагт буцалтгүй зээл олгон Хотын шинэчлэл ((Urban Renewal (хуучнаар Urban Redevelopment))-ийн хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна. Мөн хуулиар төрийн 810,000 орон сууцны санхүүжилтийг шийдвэрлэж, алслагдмал бүсэд амьдарч буй Америк иргэдийн орон сууцны асуудлыг шийдвэрлэхэд Хөдөө аж ахуйн яаманд бага орлоготой фермерүүдэд зээл олгож, холбогдох дэмжлэг үзүүлэх чиг үүргийг харьяалуулсан байна.

1950-иад онд орон нутгууд Хотын шинэчлэл хөтөлбөрөөр дахин төлөвлөлтийг санхүүжүүлж, 1954 оны Орон сууцны тухай хуулиар “хэрэгжихүйц төлөвлөгөө”-ний дагуу орон нутгуудад дахин төлөвлөлтийн төлөвлөгөө боловсруулах шаардлага тавьсан ба энэ нь холбооны санхүүжилт авахад дэлгэрэнгүй төлөвлөгөө боловсруулах жишгийг тогтоож, өнөөг хүртэл хэрэгжиж байна. Түүнчлэн 1950-иад онд ашгийн бус өмчлөгчид ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй түрээслэгчдийг орон сууцаар хангахад чиглэсэн тусгай хөтөлбөрийг хэрэгжүүлснээс гадна Холбооны орон сууцны удирдах газар нийтийн зориулалттай орон сууцны ипотекийн зээлийг даатгалд хамруулахыг эрчимжүүлж, орон сууцны санхүүжилтэд холбооны засгийн газрын оролцоо нэмэгдсэн байна.

1960-аад онд Холбооны орон сууцны удирдах газар нь бага, дунд орлоготой гэр бүлүүдэд зориулсан нийтийн зориулалт бүхий орон сууцны үйлдвэрлэлийг дэмжих татаас, дэмжлэг олгох орон сууцны санхүүжилтийн шинэ хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлж, хувийн секторын оролцоог дэмжих зорилгоор зах зээлийн хүүнээс доогуур хүүтэй ипотекийн зээл, олон янзын шууд татаас, татварын чөлөөлөлт, хөнгөлөлт зэргийг нэвтрүүлж эхэлсэн байна. Хөтөлбөр хэрэгжих хугацаанд өмчлөгчдийн өгөөжийг хязгаарлаж, 20 жилийн дараа зах зээлийн ханшаар түрээслэх боломжоор хангасан байна. Тус хөтөлбөрийн үр дүнд засгийн газар нь хамгийн ашигтай, байрлал сайтай хөрөнгөө алдаж, байрлал муу, хөрөнгө хадгалах зардлыг нөхөх хангалттай өндөр түрээс бүрдүүлэх чадваргүй хөрөнгөтэй үлдсэн байна.

1965 онд холбооны хэмжээнд орон сууц болон орон нутгийн хөгжлийн хөтөлбөрүүдийг хянах, зохицуулах үүрэг бүхий АНУ-ын Орон сууц, хотын хөгжлийн яам (цаашид “ОСХХЯ” гэх)-ыг байгуулсан. 1960-аад онд төрийн орон сууцны байгууллагууд зорилтот бүлгийн түрээслэгчдэд хувийн өмчит орон сууцыг түрээслүүлэх шинэ чиг хандлага дэлгэрсэн байна. Энэ нь улмаар орон сууцны сертификат, ваучерийн (housing certificates and vouchers) эхийг тавьж, бага орлоготой иргэдэд хувийн өмчит орон сууц түрээслэх боломжоор хангасан байна.

1969 он гэхэд төрийн орон сууцны хамгийн ядуу түрээслэгчид түрээсийн зардалд орлогынхоо $\frac{3}{4}$ -тэй тэнцэх төлбөр төлж байсан ба нийт орлогын талаас дээш хувийн түрээс зардалд төлөх нь түгээмэл байжээ. Хэд хэдэн нэмэлт, өөрчлөлтөөр Төрийн орон сууцны агентлаг (цаашид “ТОСА” гэх)-ийн түрээсийн дээд хэмжээг тогтоох эрхийг хасаж, оронд нь түрээсийн төлбөрийн дээд хэмжээг түрээслэгчийн орлогын 25 хувьтай тэнцүүлэн тогтоосон байна. 1970 онд Конгрессоос ТОСА-ийн үйл ажиллагааны орлогын алдагдлыг нөхөхөд түрээсийн орлого болон үйл ажиллагааны зардлын зөрүүнд татаас олгож эхэлсэн байна. Хожим нь 1981 онд батлагдсан “*Omnibus Budget*

Reconciliation Act” хуулиар Конгресс ТОСА-ийн орлогыг нэмэгдүүлэхийг оролдон, түрээсийн доод хэмжээг 25 хувиас 30 хувь болгож нэмэгдүүлсэн байна. Түүнчлэн Орон сууц, хотын хөгжлийн яам нь өмнө баталсан хуулиудын хүрээнд орон сууц нэн шаардлагатай өрхүүдэд давуу эрх олгох журмыг боловсруулсан байна.

1974 оны Орон сууц, орон нутгийн хөгжлийн тухай хуулиар орон сууцны хөтөлбөрт 2 том өөрчлөлт оруулсан нь орон нутагт олгох 7 ангилал бүхий буцалтгүй зээлийн хөтөлбөрийг нэгтгэн Орон нутгийн хөгжлийн буцалтгүй зээлийн багц (Community Development Block Grant) хөтөлбөр болгож, орон нутгийн хөгжлийн санаачилгуудыг үргэлжлүүлэн санхүүжүүлсэн боловч Орон сууц, хотын хөгжлийн яамаа албан ёсны төлөвлөлтийн хэрэгсэл болох “Орон сууцны дэмжлэгийн төлөвлөгөө”-г боловсруулж, батлуулах шаардлагыг тусгасан бол нөгөө нь 1974 оны хуулиар 1937 оны Орон сууцны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан “8-р зүйл” (Section 8 program) хөтөлбөрийг бий болгосон явдал юм. “8-р зүйл” хөтөлбөрөөр түрээслэгчийн орлоготой уясан түрээсийн тогтмол зардал болон Орон сууц, хотын хөгжлийн яамнаас тогтоосон “зах зээлийн бодит үнэ” хоёрын хоорондын зөрүүнд татаас олгох юм. “8-р зүйл”-ийг орон нутгуудад хөрөнгө, санг шинэ барилга барих, сэргээх, түрээслэгчид суурилсан, түрээсийн орон сууц түрээслэхэд дэмжлэг үзүүлэх зэрэгт уян хатан зарцуулах боломжоор хангасан байна. “8-р зүйл”-ийн хүрээнд баригдах шинэ орон сууцны урт хугацаат (20-40 жил) татаасын гэрээ, дунд зэргийн нөхөн сэргээлт зэрэг нь тухайн хөтөлбөрийн хувийн секторын санхүүжилтийг нэмэгдүүлсэн байна.

1980-аад оны татварын нэмэлт хөшүүргүүд нь хүртээмжтэй түрээсийн орон сууцны хөтөлбөрүүдийг улам ашигтай болгосон байна. 1986 оны Татварын шинэчлэлийн тухай хуулиар хурдавчилсан хорогдуулалтыг болиулж, бусад энгийн орлогыг элэгдэл хорогдлыг шимтгэлээр нөхөж байсан нь нийтийн зориулалттай орон сууцны үйлдвэрлэл буурахад нөлөөлсөн байна. Мөн хуулиар муж улсууд нийтийн зориулалттай орон сууцыг санхүүжүүлэхэд татвараас чөлөөлөгдөх бонд гаргахад хязгаар тогтоож эхэлсэн ба хөтөлбөрт хамрагдах айл өрхийн орлогод тавигдах хязгаарыг тогтоосон байна. Мөн хуулийн хүрээнд Бага орлоготой өрхийн орон сууцны татварын зээл (Low Income Housing Tax Credit)-ийн хөтөлбөрийг боловсруулж, бага орлоготой өрхөд зориулсан түрээсийн орон сууцны үйлдвэрлэлд хувийн секторыг дэмжих хөшүүргийг нэмэгдүүлсэн байна. 1987 онд батлагдсан МакКинни-Вентогийн орон гэргүй иргэдэд дэмжлэг үзүүлэх тухай хууль (McKinney-Vento Homeless Assistance Act) нь орон гэргүй иргэдийг орон байраар хангахад санхүүжилт олгоход чиглэсэн анхны холбооны хэмжээний хууль тогтоомж юм.

1990-ээд оноос HOME хөрөнгө оруулалтын түншлэлийн (HOME Investment Partnerships) хөтөлбөрийг нэвтрүүлж, муж, орон нутгийн засгийн газраас хүртээмжтэй орон сууцны эрэлт, хэрэгцээг хангахад буцалтгүй зээлийн багцийг олгож эхэлсэн байна. Хэд хэдэн зорилтот стандарт, орон сууцны хэрэгцээний талаарх тоо мэдээ, Хүртээмжтэй орон сууцны хангах цогц стратеги (Нэгдсэн төлөвлөгөө болон өөрчлөгдсөн)-д тодорхойлсон үйл ажиллагааг үндэслэн дэмжлэг хүлээн авагч орон нутгууд нь өөрсдийн түрээсийн орон сууц, эсхүл орон сууц худалдаж авах хэрэгцээг хангах хөтөлбөр, арга хэмжээг боловсруулах эрхтэй болсон байна. 1990-ээд онд ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тусгай дэмжлэг, туслалцаа олгож,

хуучирч, муудсан төрийн орон сууцыг сэргээн засварлахад санхүүжилт (HOPE VI), Уугуул америк иргэдийн орон сууцжуулалтад буцалтгүй зээлийн багцыг тус тус олгож эхэлсэн байна.

АНУ-ын хувьд орон сууцны талаар бодлого нь төвлөрсөн бус загвартай, холбооны, муж улсын, орон нутгуудын хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдээс багтана. АНУ-ын орон сууцны бодлого, хууль эрх зүйн орчин нь маш их шүүмжлэл дагуулдаг.

1.1.ЗОРИЛТОТ БҮЛГИЙН ИРГЭДИЙН ОРОН СУУЦНЫ ХАНГАМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ, НӨХЦӨЛИЙГ САЙЖРУУЛАХАД ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ОРОЛЦОО, ЭРХ ҮҮРЭГ, САНХҮҮЖИЛТИЙН ТОГТОЛЦОО^{53, 54}

АНУ-ын орон сууцны хөтөлбөрүүд⁵⁵

АНУ-д хэрэгжиж буй орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх, нөхцөлийн сайжруулах хөтөлбөрүүд нь бага, дунд орлоготой иргэд, орон гэргүй иргэд, уугуул америк иргэд, ахмад дайчид, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хөгжлийн бэрхшээлтэй ахмад дайчид, алслагдмал бүсэд амьдарч буй иргэд зэрэг олон бүлэг, өргөн хүрээг хамарсан байх ба орон нутгууд нь холбооны хөтөлбөрүүдийг өөрсдийн хэрэгцээ, шаардлагад тааруулан, тохиромжтой хувилбаруудыг боловсруулж хэрэгжүүлдэг.

АНУ-ын хэрэгжиж буй хөтөлбөрүүдийг зориулалтаар нь дараах байдлаар багцалж болох юм. Үүнд:

- түрээсийн орон сууцны дэмжлэг;
- орон сууц худалдан авахад үзүүлэх дэмжлэг;
- газар ашиглалт болон зохицуулалтын хөшүүргүүд.

Түрээсийн орон сууцны дэмжлэг олгодог төсөл, хөтөлбөрүүдийн тоонд **Бага орлоготой өрхийн орон сууцны татварын зээлийн хөтөлбөр** (Low Income Housing Tax Credit) болон **Холбооны орон сууцны ваучерийн хөтөлбөр** (Federal Housing Choice Voucher Program)-ийг дурдаж болох юм.

Нэгдүгээрт, Түрээсийн орон сууцны дэмжлэгийн хөтөлбөрүүд нь бага, дунд орлоготой өрхүүдэд зориулсан хямд түрээсийн орон сууцны үйлдвэрлэл, үйлчилгээнд дэмжлэг олгох юм. Түрээсийн орон сууцны дэмжлэгийн бусад хөтөлбөрүүд нь бага орлоготой түрээслэгчдийг чанартай түрээсийн орон сууц түрээслэхэд нь дэмжлэг үзүүлэхэд чиглэж байна.

Хоёрдугаарт, орон сууц худалдан авахад дэмжлэг үзүүлэх хөтөлбөрүүд орох ба орон сууц худалдан авах боломжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн байна. Энэ төрлийн хөтөлбөрүүд нь борлуулахад зориулсан орон сууцны үйлдвэрлэл, сэргээн засварлалтад татаас олгох юм. Эдгээр хөтөлбөрүүд нь орон сууц худалдан авахад бага хүүтэй зээл олгох, орон сууц худалдаж авах, өмчлөхтэй холбоотой зөвлөх

⁵³ Зарубежный опыт применения инструментов градостроительного регулирования для увеличения предложения доступного жилья, Институт экономики города, 2015

<http://www.urbanecomomics.ru/research/analytics/zarubezhnyy-opyt-novyie-napravleniya-v-gradostroitelnom-regulirovanii-y-celyah>


⁵⁴ Зарубежный опыт предоставления субсидий на приобретение жилья гражданам с невысоким уровнем доходов http://www.urbanecomomics.ru/sites/default/files/3518_import.pdf

⁵⁵ Anastasia Kalugina, Affordable Housing Policies: An Overview, 6-2016, Cornell University

үйлчилгээ үзүүлэх болон урьдчилгаа төлбөр төлөхөд дэмжлэг үзүүлэх зэрэгт чиглэгддэг байна.

Гуравдугаарт, газар ашиглалт болон зохицуулалтын хөшүүрэг, санаачилгуудаар хувийн хэвшлийг үйлдвэрлэгч нарт хүртээмжтэй орон сууцны үйлдвэрлэхэд байршил, шинж чанар болон зардалтай холбоотой удирдамжаар хангана. Үүний зарим жишээ орон нутгийн газар ашиглалтын журам, барилгын хууль тогтоомж, бүсчилсэн зохицуулалтын журам, ухаалаг өсөлтийн санаачилгууд багтана.

HOME:⁵⁶ 2018 оны federal omnibus package багц нь HOME хөтөлбөрт 1.36 тэрбум ам.доллар, 2017 оныхоос 412 сая ам.доллараар санхүүжилтийг нэмэгдүүлжээ. 1990-ээд оны эхээр хэрэгжиж эхэлсэн тус хөтөлбөр нь муж улс болон орон засаг захиргаанд бага орлоготой өрхүүдийг хүртээмжтэй орон сууцаар хангахад дэмжлэг үзүүлдэг.




<https://prrac.org/pdf/HOME-AFFH.pdf>

CDBG: Community Development Block Grant буюу Орон нутгийн хөгжлийн буцалтгүй зээлийн багц 2018 онд 3.3 тэрбум ам.долларын санхүүжилтийг хүлээн авсан ба энэ 2017 онтой харьцуулахад 300 сая ам.доллараар нэмэгдсэн байна. Орон нутгийн хамгийн түгээмэл нэгж болон гүнлэг/тойргууд нь уян хатан нөхцөлтэй тус хөтөлбөрийг орон сууц, усан хангамж, дэд бүтэц болон нийтийн үйлчилгээ зэрэг орон нутгийн болон эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлд багтах төслүүдийг дэмжихэд ашигладаг.

Орон гэргүйчүүдэд олгох тэтгэлэг: Homelessness Assistance Grants нь өрхийг хүртээмжтэй орон сууцны хэрэгцээг хангах зорилго бүхий тус хөтөлбөрийг Орон сууц, хотын хөгжлийн яамнаас хэрэгжүүлдэг. 2018 онд тус хөтөлбөрт 2.5 тэрбум ам.доллар

⁵⁶ <https://www.naco.org/articles/affordable-housing-federal-programs-and-legislation>

төсөвлөсөн байна. Omnibus-аас дээрх 2.5 тэрбум долларын 80 сая долларыг орон гэргүй залуучуудад зориулж олгодог.




Эх сурвалж: <https://www.everycrsreport.com/reports/RL33764.html>

Орон сууцны ваучер: (Housing Choice Vouchers) Omnibus-аас 2018 онд Орон сууцны ваучерын “8-р зүйл” (Section 8 program) хөтөлбөрт 22 тэрбум ам.доллар төсөвлөсөн байна. Тус хөтөлбөр нь бага орлоготой өрхүүдийг хувийн өмчийн түрээсийн орон сууц түрээслэхэд түрээслэгчийн орлоготой уясан түрээсийн тогтмол зардал болон Орон сууц, хотын хөгжлийн яамнаас тогтоосон “зах зээлийн бодит үнэ” хоёрын хоорондын зөрүүнд татаас олгох юм.

HCV Administration and Relationships

The administration of the HCV program involves participation of different parties, that is, The Department of Housing and Urban Development (HUD), Seattle Housing, the landlord/owner and HCV participant, as illustrated below.



https://www.seattlehousing.org/sites/default/files/SHA_AP_V2_2018.pdf

Төрийн орон сууц: 2018 онд Omnibus-аас Төрийн орон сууцны үйлдвэрлэлийн санд 2.7 тэрбум доллар ба Үйл ажиллагааны санд 4.55 тэрбум ам.доллар тус тус олгосон байна. Төрийн орон сууцны хөтөлбөр нь бага орлоготой өрх, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан хөнгөлөлттэй, найдвартай түрээсийн байраар хангахад чиглэсэн. Төрийн орон сууц нь нийтийн зориулалттай орон сууцны байшин болон амины орон сууц байж болно.

Түрээсийн Тусламж (RAD): Rental Assistance Demonstration хөтөлбөр нь төрийн орон сууцны удирдах байгууллага (ТОСУБ) төрийн орон сууцыг нөхөн сэргээх, засвар үйлчилгээгээр хангахад санхүүжилт олгодог. Энэ нь ТОСУБ-ыг төрийн орон сууцанд хөрөнгө оруулалтад улсын болон хувийн санхүүжилтийг нэмэгдүүлэх боломжийг олгодог. Энэ нь өртгийн хувьд ОСХХЯ-ны төсвийг нэмэгдүүлдэггүй, төрийн орон сууцны хөтөлбөрөөс “8-р зүйл” ваучерын хөтөлбөрт шилжүүлэх замаар үйлчилгээ үзүүлэгчид хувийн хөрөнгө оруулалтыг татах боломж олгодог. RAD хөтөлбөр нь 2017-2018 онд Холбооны санхүүжилтийг хүлээн аваагүй болно.

Үндэсний Орон сууцны Сан - National Housing Trust Fund (HTF): 2008 онд Орон сууц, эдийн засгийг сэргээх тухай хуулиар байгуулагдсан HTF нь нэн бага болон бага орлоготой өрхүүдэд зориулсан хүртээмжтэй орон сууцны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд муж улсуудаас буцалтгүй зээл олгох хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. Тус хөтөлбөрийг Засгийн газрын санхүүжилттэй байгууллага болох Фэнни Мэй, Фредди Мак-ийн үнэлгээгээр санхүүждэг ба 2017 онд 222 сая ам.доллар олгосон байна.

Орон нутаг буюу засаг захиргааны нэгж болох Тойргуудын Үндэсний нийгэмлэг (NACo) нь ОСХХЯ-наас хэрэгжүүлж буй бага дунд орлоготой өрхийн орон сууцаар хангахад чиглэсэн HOME, CDBG, 8-р зүйл “орон сууцны ваучер” хөтөлбөр, төрийн орон сууцны хөтөлбөрүүдийг дэмжиж ажилладаг.

Хүртээмжтэй орон сууцны өөр нэг гол хөтөлбөр бол Орлого багатай орон сууцны

татварын хөнгөлөлт юм.

Орлого багатай орон сууцны татварын хөнгөлөлт (LIHTC): NACo нь 1986 онд байгуулагдсан Бага орлоготой орон сууцны татварын хөнгөлөлтийг (LIHTC) дэмждэг бөгөөд АНУ-д хямд түрээсийн шинэ орон сууцны холбооны хамгийн том эх үүсвэр нь юм. Орон нутгийн орлогын алба (IRS). Хөтөлбөр нь хөгжүүлэгчдэд боломжийн орон байр бий болгоход татварын хөшүүргийг олгодог. Татварын кредитийг хүн амд суурилан төрд олгож, улсын татварын кредит хуваарилах агентлагт хуваарилдаг. Дараа нь муж улсын томилогдсон агентлаг нь төрийн байгууллагуудын хүсэлтийг үндэслэн орон сууцны зориулалттай байршлуудыг үндэслэн хөгжүүлэгчдэд тараана. Хөгжүүлэгчдэд олгосон татварын хөнгөлөлтийг 10 жилийн хугацаанд олгодог.

Figure 1: Typical Legal Structure for Direct Investment in LIHTC-Financed Project



Source: OCC

Орон сууцны хөтөлбөрийн төлөвлөлт

АНУ-д хүртээмжтэй орон сууцны төлөвлөлтийг дараах 2 үндсэн чиг хандлага дээр суурилан гүйцэтгэдэг байна.

Нэгдүгээрт, хүртээмжтэй орон сууц барьж байгуулахад тавигдах захиргааны хязгаарлалтуудыг багасгахад чиглэсэн арга хэмжээнүүд багтах ба гол төлөв ОСХХЯ хэрэгжүүлдэг байна. Ихэнх хотууд хүртээмжтэй орон сууцны хангамжийг нэмэгдүүлж, орон сууцны үнийг бууруулахад хотын төсвийн дийлэнхийг бүрдүүлдэг үл хөдлөх эд хөрөнгийн татварын бааз суурь даган өөрчлөгдөж, сургууль, цэцэрлэг болон хотоос үзүүлэх бусад үйлчилгээний санхүүжилт буурдаг учир таатай бус хүлээн авч, эсэргүйцэх нь түгээмэл байдаг байна. Иймд хотын удирдлагууд нягтрал ихтэй, эсхүл хямд өртөг бүхий орон сууц барьж байгуулах, нэмэгдүүлэхэд нэмэлт хязгаарлалтууд тогтоодог байна. Харин холбооны засгийн газар нь эдгээр хязгаарлалтуудыг бууруулах, арилгахад анхаарч ажилладаг байна.

Хоёрдугаарт, шинэ барилгажуулалтад хүртээмжтэй орон сууц барих шаардлага тавих явдал юм. Энэ төрлийн шаардлагыг хот төлөвлөлтийн процесст суулгаж өгсөн байдаг ба "inclusive zoning" гэж нэрлэж байна. Дээрхээс гадна хот төлөвлөлттэй холбоогүй зохицуулалтын арга хэрэгслийг ашиглах ба үүнд орон сууцны түрээсийн

зохицуулалт (rent control) орж байна.

АНУ-д муж улсын хууль тогтоох байгууллагууд нь газар ашиглалт болон барилгажуулалтын үндсэн зарчмуудаа тогтоож, гол зохицуулалтууд хотын түвшинд хийгддэг ч муж улсаас хамааран хот төлөвлөлтийн асуудалд оролцох оролцоо нь ялгаатай байна. Муж улсуудын талаас доошгүй хувь нь хотуудад хот төлөвлөлтийн төлөвлөгөө нь орон сууцны бодлоготой хэрхэн уялдаж байгааг тодорхойлсон Comprehensive Plans буюу дэлгэрэнгүй төлөвлөгөө боловсруулахыг шаардлага болгодог байна.

Орон сууцны хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд төр, орон нутгийн байгууллагуудын оролцоо

Холбооны хэмжээнд Орон сууц, хотын хөгжлийн яам нь буцалтгүй тусламж, орон сууцны хямд ипотекийн зээлээр дамжуулан бага, дунд орлоготой иргэд, орон нутгийн түншлэлийн байгууллагуудад орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлдэг. 2018 онд ОСХХЯ нь HOME хөтөлбөрийн хүрээнд муж улсуудын төрийн болон хувийн хэвшлийн секторт хүртээмжтэй орон сууцны санхүүжилтэд 1,36 тэрбум ам.доллар хуваарилсан нь сүүлийн 7 жилийн хугацаанд төсөвлөсөн хамгийн өндөр дүнтэй төсөв юм. Энэ төрлийн татаасыг буцалтгүй зээлийн багц (block grant) гэж нэрлэх ба хот суурин газрын шинэчлэл, хөдөө орон нутагт орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх, барилгажсан газрыг хөгжүүлэхэд олгох ба санхүүжилтийг муж улсын засгийн газар, эсхүл орон нутгийн удирдлагаас хэрэгжүүлж буй тодорхой хөтөлбөрүүд болон хувийн хэвшлийн секторт олгодог байна. Муж улс, эсхүл хот татаас авахад хот байгуулалт, орон сууцны бодлогын зорилтыг хэрэгжүүлэх Нэгдсэн төлөвлөгөөг (Consolidated Plan) боловсруулж, батлуулсан байх урьдчилсан нөхцөл тавигддаг байна.

Холбооны засгийн газар нь хүртээмжтэй орон сууцны санхүүжилтийг шууд бусаар дэмжих хоёр хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. Үүний нэг нь бага орлоготой иргэдэд хувийн хэвшлийн орон сууц түрээслэх боломжийг олгодог **Холбооны орон сууцны ваучерийн хөтөлбөр** (Federal Housing Choice Voucher Program) юм. Тус хөтөлбөрийн хүрээнд төрөөс хөтөлбөрийн зорилтод нийцэж буй өрхөд орон сууц түрээслүүлж буй түрээслүүлэгчдэд түрээсийн төлбөрийн хэсэгт татаасыг тогтмол олгодог байна. Хөтөлбөрийг орон нутгийн захиргаа ОСХХЯ-ны нэрийн өмнөөс удирддаг байна.

Хоёр дахь хөтөлбөр нь Бага орлоготой өрхийн орон сууцны татварын зээл (Low Income Housing Tax Credit)-ийн хөтөлбөр байна. Тус хөтөлбөр нь хүртээмжтэй орон сууцны үйлдвэрлэлд хөрөнгө оруулж буй хувийн секторт татварын хөнгөлөлт үзүүлдэг байна.

2. БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС

2.1.Зорилтот бүлгийн иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх, нөхцөлийг сайжруулахад төрийн болон орон нутгийн байгууллагын оролцоо, эрх үүрэг, санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх талаар.

БНСУ нь Орон байрны суурь хууль (Framework act on residence⁵⁷)-ийг баталсан бөгөөд тус хуулийн зорилго нь орон байрны тогтвортой байдал, орон сууцны стандарт

⁵⁷ https://elaw.klri.re.kr/kor_service/lawView.do?hseq=46253&lang=ENG

нөхцөлийг сайжруулах, иргэдийн орон байранд амьдрах боломжтой байх эрхийг хангах, баталгаажуулах үүднээс орон сууцаар хангах бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд хамаарал бүхий асуудлуудыг тодорхойлж өгөхөд оршино гэж заажээ. Хуульд зааснаар төр болон орон нутгийн засаг захиргаа нь орон сууцны бодлого боловсруулж, хэрэгжүүлэх дараах үндсэн зарчмыг тусгасан байна.

- Орон сууцны зардал нь хүний орлогын түвшин, амьдралын мөчлөг, орон сууцны хангамж, дэд бүтэцтэй уялдан тохиромжтой түвшинд байх;
- Доогуур орлоготой болон шаардлага хангаагүй орон сууцны нөхцөлд амьдарч байгаа өрхийг түрээсийн орон сууцанд хамруулах, орон сууцны зардлыг бууруулах замаар орон сууцны стандартыг сайжруулах;
- Сайн чанарын орон сууц ашиглалтад оруулахыг дэмжих, түрээсийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх;
- Орон сууцны хангамжийг системтэй үр өгөөжтэйгээр нэмэгдүүлэх;
- Тахир дутуу, өндөр настан болон орон сууцны тааламжгүй нөхцөлд амьдардаг иргэдийг аюулгүй, тааламжтай орчин нөхцөлд амьдрах боломжоор хангах.

Газар, дэд бүтэц, тээврийн яам (Ministry of Land, Infrastructure and Transport)-наас иргэдийн тогтвортой оршин суух орчин, нөхцөлийг сайжруулах үүднээс орон сууцны цогц хөтөлбөрийг батлан хэрэгжүүлнэ.

Орон сууцны цогц хөтөлбөрт орон сууцны бодлогын үндсэн чиглэл, зорилт, орон сууцны хэрэгцээ шаардлага, хангамж, түрээс зэрэг нийтийн орон сууцны хангамжийн асуудал, орон сууцны бодлого дэмжих сангууд, тэдгээрийн үйл ажиллагааг тодорхойлох, орон байрны орчин нөхцөлийг сайжруулах, доогуур орлоготой, тахир датуу, өндөр настай зэрэг бүлгийн орон сууцны хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, тохирсон орон сууцны дэд бүтэц, зардал, түрээсийн орон сууцны хангамж зэрэг асуудлуудыг зайлшгүй тусгасан байхыг шаарддаг.

Дээр дурдсан хөтөлбөр нь 10 жилийн болон жил тутмын гэсэн төрөлтэй бөгөөд хөтөлбөрийг улсын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан батална. Төр, орон нутгийн засаг захиргаа, Газар, орон сууцны корпорац нь тус хөтөлбөрийн дагуу орон сууцны төслүүдийг хэрэгжүүлнэ.

Дээрх зохицуулалттай холбоотойгоор *Нийтийн орон сууцны тухай тусгай хууль* (Special act on public housing)-д зааснаар Газар, дэд бүтэц тээврийн яам болон нийслэлийн захирагч нь тус хөтөлбөрт нийцүүлэн нийтийн орон сууцтай холбогдох төлөвлөгөөг 5 жил тутам боловсруулж хэрэгжүүлнэ. Хуулийн 3 дугаар зүйлд Төр болон орон нутгийн засаг захиргаа нь жил бүр төсөвтөө нийтийн орон сууцны түрээслэх, худалдан авах болон барихтай холбогдох асуудлыг тусгахыг эрмэлзэх шаардлагатай бөгөөд доогуур орлого бүхий өрхийн орон сууцны хангамжийн асуудлыг сайжруулах үүднээс орон сууц барих, худалдан авах, ашиглалттай холбоотой татварын хууль тогтоомжид заасан улсын болон орон нутгийн татвараас чөлөөлөх, хувь хэмжээг бууруулах зэрэг арга хэмжээг авч болно гэж заасан байна.

Мөн *Удаан хугацаагаар түрээсийн байранд оршин суугчдын амьжиргааны түвшинг дэмжих тухай хууль* (Act on the support for improving the quality of lives of tenants in long-term public rental housing)-д зааснаар төр болон орон нутгаас орон сууцны болон хотын оршин суугчдын сангийн санхүүжилтийн тусламжтайгаар

баригдсан 30 буюу түүнээс дээш жилийн хугацаагаар түрээслүүлэх зорилго бүхий орон сууцыг удаан хугацааны түрээсийн орон сууц гэж ойлгох ба төрөөс 5 жил тутам тус оршин суугчдад зориулсан хөтөлбөр батлан холбогдох санхүүжилтийг шийдвэрлэж байх үүрэгтэй. Тус хуульд зааснаар түрээслүүлэгч нь түрээслэгчийн амьдралын түвшинг харгалзан түрээсийн хэмжээг өөрөөр тогтоосон бол төрийн зүгээс холбогдох татаас өгч болохоор заасан байна. Мөн тухайн төрлийн оршин суугчдын амралт, хэрэгцээнд зориулсан нийтийн байгууламжийг төр, орон нутгаас барьж байгуулах, эсхүл холбогдох үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлж болохоор тусгасан байна.

1989 онд батлагдсан *Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн халамжийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд* Засгийн газар болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өдөр тутмын амьдралд тохиромжтой орон сууцны болон холбогдох хэрэгслээр хангах талаар бодлого боловсруулж, түүнийг хөгжүүлэх үүрэгтэй гэж заасан байна. Тус хуулийн 16 дугаар зүйлд мөн засгийн газар нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эдийн засгийн бие даасан байдлыг дэмжих, эдийн засгийн дарамтыг багасгах үүднээс холбогдох татварын хөнгөлөлт, олон нийтийн үйлчилгээний газруудад хөнгөлөлт үзүүлэх зэрэг бодлогын арга хэмжээг хэрэгжүүлнэ. Мөн 17 дугаар зүйлд дээрх байгууллагууд нь тус хуулийн зорилтыг хангах үүднээс хууль зүйн болон санхүүгийн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Тус байгууллагууд нь Ерөнхийлөгчөөс баталсан тусгай нөхцөлийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсрол, ажил эрхлэлт, бизнес эрхлэх, сургалтанд хамрагдах зэрэг үйл ажиллагааг дэмжих чиглэлээр зээлийн сан байгуулж болохоор заажээ.

2.2.Төрийн орон сууцны корпорацийн бүтэц, үйл ажиллагааны чиглэл, эрх үүрэг, санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх талаар.

БНСУ-ын 2003 онд батлагдсан *Орон сууцны санхүүжилтийн корпорацийн тухай хууль* (Korea housing finance corporation act №7030 Dec.31, 2003)-ийн зорилго нь урт хугацаанд тогтвортойгоор орон сууцны санхүүжилтийн хангамжийг дээшлүүлэх үүднээс ипотекээр баталгаажсан нэхэмжлэл хангах, зээлийн баталгаа гаргах чиг үүрэгтэй корпорацийг байгуулах замаар үндэсний эдийн засаг, нийгмийн халамжийг сайжруулахад дэмжлэг үзүүлэхэд оршино гэжээ.

Корпорац нь тус хууль болон нийтийн захиргааны байгууллагуудын удирдлагын тухай хуульд зааснаар корпорацийн хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулна. Корпорац нь үйл ажиллагаагаа явуулахад шаардлагатай бол салбар, төлөөлөгчийн газраа байгуулж болно.

Корпорацийн өөрийн хөрөнгө нь 5 их наяд вон байх бөгөөд үүнийг Засгийн газар болон Солонгосын банк бүрдүүлнэ.

Корпорацад түүний үйл ажиллагаа, бизнес төлөвлөгөө зэрэг үндсэн чиглэлийг тодорхойлох, хянан шалгах Орон сууцны санхүүжилтийн удирдлагын хороо ажиллана. Хороо нь дараах асуудлуудаар хянан шалгах, шийдвэр гаргах эрхтэй.

- 1) Корпорацийн үндсэн үйл ажиллагааны бодлого, бизнес төлөвлөгөөг боловсруулах, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах;
- 2) Төсвийн нэмэлт, өөрчлөлт;
- 3) Төсөвт хийх нэмэлт өөрчлөлт, дансны тооцоо;

- 4) Ипотекийн нэхэмжлэлийг буцаах шалгуурын асуудал;
- 5) Ипотекийн баталгаа гаргах шалгуурын асуудлууд;
- 6) Сангийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах, түүнд өөрчлөлт оруулах;
- 7) Нөхөн төлбөрийн нэхэмжлэлийг хорогдуулах асуудлууд;
- 8) Дүрэмд заасан Корпорац, Сан, Бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой бусад асуудлууд.

4-р асуудалд зээлээр худалдан авах орон сууцны үнэ, зээлийн хэмжээ, зээлдэгчийн орлогын түвшинтэй харьцуулсан сар тутмын төлөх зээлийн буцаан төлөлт, зээлээр худалдан авч болох орон сууцны тоо, урьдчилгаа төлбөр зэрэг багтана.

Хороо нь хорооны даргыг оролцуулан 6 гишүүний бүрэлдэхүүнтэй байна. Хорооны гишүүнд дараах этгээд хамаарна.

- 1) Корпорацын Ерөнхийлөгч;
- 2) Газар, дэд бүтэц, тээврийн яамнаас өөрийн албан хаагчдын дундаас томилсон 1 гишүүн;
- 3) Санхүүгийн үйлчилгээний комиссоос өөрийн албан хаагчдаас томилсон 1 гишүүн;
- 4) Санхүүгийн үйлчилгээний комиссоос санхүүгийн байгууллагуудын дундаас сонгосон, орон сууцны санхүүжилтийн талаар туршлага бүхий 1 этгээд;
- 5) Дээр дурдсан яам болон Солонгосын банкны захирлаас санал болгосны дагуу санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд дундаас сонгосон 2 этгээд.

Дээрх 4 болон 5 дугаарт заасан гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 2 жил байх ба гишүүний орон гарсан нөхцөлд шинээр томилогдсон гишүүний бүрэн эрхийн хугацаа өмнөх гишүүний үлдсэн бүрэн эрхийн хугацаатай адил байна.

Корпорацын ерөнхийлөгч нь хорооны даргаар ажиллана. Ерөнхийлөгч нь хороог төлөөлөх ба бүх л асуудлаар хяналт шалгалт явуулах бүрэн эрхтэй. Хорооны дарга бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй нөхцөлд хорооноос томилсон гишүүн орлон гүйцэтгэнэ. Хорооны хуралдаан гишүүдийн олонх оролцсоноор хүчинтэй байх ба оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэр гаргана.

Хорооны гүйцэтгэх удирдлага нь дарга, дэд дарга, орон тооны 4 хүртэлх захирал, орон тооны бус 1 ба түүнээс дээш захирал, 1 аудитор байна. Гүйцэтгэх удирдлагад Солонгос үндэстэн бус этгээдийг томилохыг хориглоно. Гүйцэтгэх удирдлагыг сэтгэцийн өвчний улмаас албан үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон, энэ хууль болон корпорацын дүрмийг зөрчсөнөөс бусад тохиолдолд албан үүргээс нь чөлөөлөхийг хориглодог байна.

Хорооны дарга корпорацын хууль зүйн асуудал хариуцсан төлөөлөгчийг гүйцэтгэх удирдлага болон албан хаагчдын дундаас томилж болно. Корпорацын бусад албан хаагчдыг Ерөнхийлөгч томилж, чөлөөлнө.

Корпорац дараах үйлчилгээг хариуцан үзүүлнэ.

- 1) Ипотекийн зээлийн барьцаа хөрөнгө;
- 2) Ипотекийн зээл;

- 3) Дараах зүйлс тус бүрээр төлбөрийн баталгааны үйлчилгээ;
 - a. Ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаас;
 - b. Оюутны зээлээр баталгаажсан үнэт цаас;
 - c. Тусгай зориулалтын компаниас гаргасан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас.
- 4) Санхүүгийн байгууллагуудын зээлийн өргөжилт;
- 5) Ипотекийн болон оюутны зээлийн нэхэмжлэлийг үнэлэх, бодит судалгаа хийх;
- 6) Сан болон бүртгэлийн удирдлага, үйл ажиллагаа;
- 7) Зээлийн батлан даалт;
- 8) 7 дугаар зүйлд хамаарах зээлийн баталгааны үүргийг биелүүлэх, нөхөн төлбөр шаардах эрхийг хэрэгжүүлэх;
- 9) Зээлийн судалгаа, зээлийн мэдээллийн нэгдсэн менежмент;
- 10) Моргейжийн зээлийн баталгааны үүргийг биелүүлэх, нөхөн олговор олгохыг шаардах;
- 11) Орон сууцны санхүүжилтийн судалгаа, статистикийн мэдээлэл цуглуулах, бэлтгэх, дотоод, гадаадын холбогдох байгууллагуудтай солилцоо, хамтран ажиллах;
- 12) Санхүүгийн үйлчилгээний хорооноос баталсан дээрх үйлчилгээнүүдтэй холбоотой нэмэлт үйлчилгээ.

Корпорацын санхүүгийн жил төрийн албатай адил байх ба санхүүгийн тайлангаа Санхүүгийн үйлчилгээний комисст санхүүгийн жил дууссанаас хойш 3 сарын дотор хүргүүлнэ. Корпорац нь үйл ажиллагаанаас олсон ашгийн 1/5 (тавны нэгийг) хуульд заасан өөрийн хөрөнгийн хэмжээг бүрдүүлэх хүртэл нөөц болгон хадгална. Сангийн яамнаас зөвшөөрөл авсан нөхцөлд үйл ажиллагааны ашгийг хөрөнгө оруулагчдад хуваарилна. Корпорац нь Засгийн газар, санхүүгийн байгууллагууд болон олон улсын санхүүгийн байгууллагаас зээлэх замаар өөрийн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай санг үүсгэж болно.

Корпорацын дор орон сууцны санхүүжилтийн зээлийн баталгааны санг байгуулна.

Сан нь дараах санхүүгийн эх үүсвэрээс бүрдэнэ.

1. Засгийн газраас оруулсан хандив;
2. Санхүүгийн байгууллагуудын оруулсан хандив;
3. Засгийн газар, санхүүгийн байгууллагаас бусад хүмүүсээс оруулсан хандив;
4. Баталгааны шимтгэлийн орлого;
5. Нөхөн төлбөр шаардах эрхийн дагуу олсон орлого;
6. Сангийн үйл ажиллагаанаас олсон орлого;
7. Санхүүгийн байгууллага буюу Засгийн газрын удирдан ажиллуулж буй сангийн зээл;
8. Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоосон бусад санхүүгийн эх үүсвэр.

Засгийн газар төсвийн жилд төсвийн хязгаарт багтаан санд тодорхой хэмжээний хөрөнгө өгч болно. Сан нь дараах зорилгоор ашиглагдана.

1. Зээлийн баталгааны үүргээ гүйцэтгэх;
2. Зээл болон хүүний төлбөрийг эргэн төлөх;
3. Сангийн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны зардал;

4. Сан хөгжүүлэх судалгаа, хөгжил;
5. Сан байгуулах зорилгод хүрэхэд шаардлагатай бусад үйл ажиллагаа.

2.3.Төрийн болон орон нутгийн өмчийн түрээсийн орон сууцны сан бүрдүүлэх, уг санг ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулах талаар.

БНСУ-ын орон сууцны сангийн асуудлыг “**Орон сууц болон хотын оршин суугчдын сан**⁵⁸”-гийн тухай 5 бүлэг, 36 зүйл бүхий хуулиар зохицуулж байна.

Энэхүү хуулийн зорилго нь Орон сууц, хот байгуулалтын сан байгуулах, орон сууц, хот байгуулалтын корпорацыг бий болгох, иргэдийн амьдралын түвшинг дээшлүүлэхэд хувь нэмрээ оруулах замаар орон сууцны хангамжийг дээшлүүлэх, хот байгуулалтын нөхөн сэргээлтийг сайжруулахад оршино. Нөгөөтэйгүүр Орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх, хотжуулах, хотын нөхөн сэргээлтийг дэмжих зорилгоор Орон сууцны болон хотын оршин суугчдын сан гэсэн нэртэй компанийн эрх зүйн үндсийг тус хуулиар тогтоосон. Тус компанийг төрөөс үүсгэн байгуулах ба орон сууцны болон хотын гэсэн 2 сантай байна. Сангийн эх үүсвэрийг үндэсний орон сууцны бонд, орон сууцны зориулалттай хэрэглэхээр гадаад улсаас авсан зээл, тус сангаас санхүүжүүлсэн байгууллагуудын хүүний орлого, ногдол ашгийн орлого, бусад холбогдох сангуудаас оруулбал зохих хөрөнгө, хандив, тусламж зэргээр зааж өгсөн байна.

Сангийн зориулалтыг дараах байдлаар тодорхойлжээ:

- Үндэсний орон сууцны бүтээн байгуулалт, үндэсний орон сууцнаас томгүй хэмжээний орон сууцны худалдаа, түрээс, орон сууцны бус оршин суугчдын хэрэгцээнд зориулан баригдаж буй барилга, түүний худалдаа, түрээс, үндэсний орон сууцнаас томгүй хэмжээний орон сууцны дахин төлөвлөлт, орон сууцны газар чөлөөлөх, бэлтгэх үйл ажиллагааг санхүүжүүлэх, дээрх үйл ажиллагаанд зээл олгох;
- Орон сууц болон хотын сангийн корпорац, Солонгосын газар ба орон сууцны корпорац зэрэг хуульд нэрлэн заасан байгууллагуудын үйл ажиллагааг, санхүүжүүлэх, тусламж үзүүлэх, зээл олгох;
- Түрээсийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх үүднээс үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалтын компаниас гаргасан үнэт цаасыг худалдан авах;
- Үндэсний орон сууцны бондын төлбөр, хүү, тус сангийн үйл ажиллагааны зардлыг төлөх;
- Орон сууцны асуудалтай холбогдох гадаад улсад хийгдэх судалгаа шинжилгээ, боловсон хүчин бэлтгэх зардлыг хариуцах;
- Засгийн газрын бодлогоор хэрэгжүүлж буй орон сууцны хөтөлбөрийг санхүүжүүлэх.

Сангийн үйл ажиллагааг Газар, дэд бүтэц, тээврийн асуудал эрхэлсэн сайд удирдах ба сантай холбогдох бүх болон зарим асуудлыг Орон сууц хотын оршин суугчдын баталгааны корпорацад хариуцуулан шилжүүлж болно. Корпорац зарим асуудлыг сайдын зөвшөөрлөөр зохих санхүүгийн байгууллагад шилжүүлэн гүйцэтгүүлж

⁵⁸ Housing and urban fund act-https://elaw.klri.re.kr/kor_service/lawView.do?lang=ENG&hseq=44538

болно. Корпорац сайдын өмнө үйл ажиллагаагаа хариуцан тайлагнана. Сайдын зүгээс сангийн үйл ажиллагаатай холбогдох үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулахдаа Санхүү, стратегийн асуудал эрхэлсэн сайдтай зөвшилцөнө.

Орон сууц ба хотын оршин суугчдын баталгааны корпорац нь тус сангийн үйл ажиллагааг эрхлэн явуулах болон тус хуулийн зорилгыг хангах бодлогын төслүүд, олон тооны бизнесийн баталгааны үйл ажиллагааг эрхлэхэд хамтран ажиллана. Корпорац нь хуулийн этгээдийн хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулна. Корпорацын өөрийн хөрөнгийн хэмжээ 5 их наяд вон байх ба 50-иас доошгүй хувийг Засгийн газраас бүрдүүлж, төрийн эзэмших хувьцааг Газар, дэд бүтэц тээврийн асуудал эрхэлсэн сайд төлөөлөн эзэмшинэ. Корпорац нь Ерөнхийлөгч, Гүйцэтгэх захирал, 4-өөс илүүгүй төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн мөн аудитортой байна. Корпорацын албан хаагчдыг Ерөнхийлөгч томилж, чөлөөлнө.

Корпорац дор дурдсан асуудлыг эрхлэн гүйцэтгэнэ.

- Сангийн удирдлага, үйл ажиллагаатай холбогдох асуудлууд;
- Орон сууц худалдах, түрээсийн барьцаа, доголдол засахтай холбоотой баталгаа гаргах;
- Орон сууц барих, баталгаат засвар гаргах зэрэг хуульд баталгаа гаргахаар заасан асуудал болон нөхөн төлбөртэй холбогдох асуудлууд;
- Тусгай хэрэгцээний компаниас гаргасан үнэт цаасанд баталгаа гаргах;
- Үл хөдлөх хөрөнгийг борлуулах, өмчлөх, шинэчлэн засварлах хүсэлт хүлээн авах;
- Төр болон орон нутгаас шилжүүлэн өгсөн асуудлууд;
- Дээр дурдсан асуудлуудтай холбогдох судалгаа шинжилгээний ажил.

Сан болон корпорацын санхүү бүртгэл тусдаа байхаар уг хуулиар зохицуулсан байна.

3.БҮГД НАЙРАМДАХ СИНГАПУР УЛС

Сингапурын орон сууцны хөтөлбөр хэрэгжүүлсэн туршлага нь алсын хараатай, холч бодлоготой, дэлхийд гайхагдсан өвөрмөц тогтолцоо юм.

Ихэнх улс орны хувьд хямд төсөр орон сууцны зориулалтаар ашиглах газрын хүртээмж хязгаарлагдмал байдаг. Сингапур Улс 1967 онд Газар чөлөөлөх тухай хууль баталсан нь нийтийн хэрэгцээнд зориулан газрыг бага өртөг зардлаар чөлөөлж авах боломжийг олгосон юм. 1965 онд нийт газрын 49 хувийг төр эзэмшиж байсан бол одоо 90 хувийг эзэмшиж байна.

Хот суурин газрын нийтийн орон сууцны загварыг муу боловсруулснаар нийгмийн тэгш бус байдлыг нэмэгдүүлэх, улмаар тогтворгүй байдалд хүргэж ядуусын хорооллыг бий болгодог. Сингапур энэхүү суурь зарчмыг эртнээс ойлгосноор орон сууцны хорооллыг янз бүрийн түвшний орлоготой иргэдэд зориулан холимог байдлаар шийдэх, орон сууцны хорооллын иргэдэд боловсрол ба нийтийн тээврийн чанартай үйлчилгээг хүртээмжтэй хүргэх, алдартай худалдааны төвүүдийг барих загварыг няхуур бодож боловсруулжээ.

3.1. Орон сууц ба Хөгжлийн Зөвлөл (Housing & Development Board - HDB)

Орон сууц ба Хөгжлийн Зөвлөл (ОСХЗ) нь Сингапур улсыг орон сууцаар хангах гол тулгуур багана юм. Зөвлөл нь Орон сууц ба Хөгжлийн тухай хуулиар (*HOUSING AND DEVELOPMENT ACT*) байгуулагдсан төрийн агентлаг бөгөөд Үндэсний хөгжлийн яамд харьяалагдана.

ОСХЗ нь 1960 онд орон сууцны хямралын үеэр байгуулагдсан ба Сингапурт иргэдийг орон байраар хангах асуудал хурцаар тавигдаж хямралд орсон үед амжилттай ажиллан, хурдан хугацаанд асуудлыг оновчтой шийдэж чадсан байна.

Сингапурын орон сууцны бодлого цаг хугацааны явцад өөрчлөгдсөөр ирсэн. 1960-аад оны үед Малайзтай нэгдсэн, Английн колончлолоос чөлөөлөгдөж, тусгаар тогтносон зэрэг тус улсын хувьд түүхэн өөрчлөлтүүд болсон. Тухайн үед таатай орчин бүрдээгүйн улмаас орон сууцны салбарт урт хугацааны хөрөнгө оруулалт татах боломжгүй байлаа. Английн колончлолоос чөлөөлөгдсөний дараа шинэ Засгийн газар нь иргэдийг орон сууцаар хангахад цагаачлал болон хүн амын их хэмжээний өсөлт, урт хугацаанд үргэлжилсэн орон сууцны хомсдол зэрэг бэрхшээлтэй тулгарсан. 1959 онд Сингапур тусгаар тогтносон улс болоход нийт хүн амын дөнгөж 9 хувь орон байраар хангагдсан бөгөөд байранд голдуу хэт олуулаа, орчин үеийнх шиг усны болон ариун цэврийн байгууламжгүй, шаардлага хангаагүй нөхцөлд амьдарч байсан. Бусад төрлийн орон байр нь бүр хүнд нөхцөлд байв. Засгийн газар энэхүү асуудлыг шийдвэрлэхийн тулд дараах 3 алхмыг оновчтой хийж, амжилтад хүрчээ⁵⁹. Үүнд:

- 1960 онд ОСХЗ-ийг байгуулсан.
- 1966 онд Газар эзэмших тухай хуулийг баталсан.
- 1968 онд Хуримтлалын төв сан (Central Provident Fund – CPF) хэмээх нийгмийн даатгалын сангийн үүргийг өргөтгөн, ОСХЗ-ийн орон сууцжуулах хөтөлбөрийг дэмжих болсон.

1960 онд батлагдсан Орон сууцны хөгжлийн тухай хуулиар ОСХЗ-д тус улсын орон сууцны асуудлыг цогцоор нь шийдэх эрх олгожээ.

Мөн 1966 онд баталсан Газар эзэмших тухай хуулиар нийтийн хэрэгцээнд зориулж газар чөлөөлөх боломж бүрдсэнээр ОСХЗ нь энэ хууль болон иргэдийг дахин байршуулах бодлогынхоо хүрээнд хуучин хорооллын газрыг хүндрэлгүй чөлөөлсөн бөгөөд иргэд нь хуучин орон байрнаасаа орчин үеийн орон сууцны хороололд шилжин амьдрах болсон байна.

ОСХЗ 1964 онд иргэдээ орон сууцжуулах ажлыг дэмжих үүднээс Орон сууц эзэмших схемийг баталсан нь орон сууцжуулах хөтөлбөрийн үйл ажиллагааг шинэ шатанд гаргажээ. Эхэн үед схемийн хэрэгжилт удаан байсан бол 1968 онд ОСХЗ нь Хуримтлалын төв сантай хамтран ажиллах болсноор орон сууцжуулах ажил эрчимжсэн байна. Иргэд Хуримтлалын төв сан дахь хуримтлалаараа орон сууцны урьдчилгаа төлбөр, сар тутмын зээлээ төлөх бололцоотой болсон.

Ийнхүү оновчтой бодлого явуулж ОСХЗ-ийг Хуримтлалын төв сантай (HDB-CPF) холбосон тогтолцоог бий болгосноор сайн үр дүнд хүрсэн. Уг сангаас санхүүгийн

⁵⁹ Housing Policies in Singapore. Sock-Yong Phang and Matthias Helble. No. 559 March 2016 Asian Development Bank Institute. P5 https://ink.library.smu.edu.sg/cgi/viewcontent.cgi?article=2801&context=soe_research

дэмжлэг үзүүлэх болсноор 1980-аад онд орон сууцны хомсдолыг шийдвэрлэсэн байна.

1990-ээд онд хуучирсан барилга байгууламжийг сэргээх, ОСХЗ-ийн мэдлийн орон сууцны зах зээлийг бий болгох, хуучны байруудыг орчин үеийн саруулхан орон сууц болон амины орон сууц болгон сайжруулахыг зорьсон. Мөн орон сууцны тэтгэлэг олгох хэлбэрээр иргэдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх хөтөлбөрүүдийг нэвтрүүлсэн.

2000 оноос хойш орон сууцны бодлого боловсруулахад орон сууцны эрэлт хэрэгцээ, орлогын түвшний ялгаа, хүн амын насны ялгаа зэрэг асуудлыг тусгах болсон. Энэ хүрээнд бага, дунд орлоготой иргэдийг дэмжих зорилготой орон сууцны тэтгэлэг болон ахмад настай хүмүүст зориулсан хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж эхэлсэн.

Дэлхийн банкны тайланд 1970, 1980-аад оны турш Сингапурын эдийн засаг жил бүр дунджаар 8 хувиар өссөн нь дэд бүтэц, хямд төсөр орон сууц, нийгмийн үйлчилгээг нийтэд үр дүнтэй хүргэх хот төлөвлөлтийн стратеги хэрэгжүүлсний үр дүн юм гэж дүгнэжээ⁶⁰.

1959 онд орон сууцны хүртээмж дөнгөж 9% байсан бол өнөөдөр Сингапурын нийт хүн амын 80 гаруй хувь нь төрөөс бариулсан орон сууцанд амьдарч байна. ОСХЗ-өөс Сингапурын далайн эргийн эргэн тойронд байрлах 23 хот, 3 орон сууцны хороололд 1 сая орчим байрыг барьж байгуулжээ.

3.2.Зорилтот бүлгийн иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх, сайжруулахад ОСХЗ-ийн оролцоо

ОСХЗ нь нийтийн орон сууцны бодлого, орон сууцаар хангах төлөвлөгөөг хүн амын байнгын хэрэгцээ, хүсэл эрмэлзэлд сайтар уялдуулан боловсруулдаг. Энэ хүрээнд үндэстэн угсаатны эв нэгдлийг хангах, гэр бүлийн хэлхээ холбоог бэхжүүлэх, өндөр настан, бага орлоготой өрхийн хэрэгцээг анхаарч үзэх зэрэг үндэсний зорилтуудыг дэмжин ажиллаж байна.

ОСХЗ нь зорилтот бүлгийнхэнд зориулж тэдгээрийн онцлогт тохирсон орон сууцны хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг. Энд дараах төрлийн зорилтот бүлгүүд хамрагдана⁶¹. Үүнд:

- анх удаа байр авч буй өрх;
- хоёр дахь удаа байр авч буй өрх;
- ам бүл олуулаа өрх (эцэг, эхээс өрх тусгаарлаагүй гэр бүл);
- ганц бие хүмүүс;
- ахмад настан зэрэг болно.

Түүнээс гадна эхнэр, нөхрөөс салсан, эсхүл бэлэвсэн гэр бүлд зориулсан тусгай хөтөлбөрүүд ч бий. Эдгээр зорилтот бүлгүүд байраа сонгохдоо ОСХЗ-ийн бариулсан шинэ болон хуучин орон сууцнаас сонголт хийх боломжтой.

ОСХЗ нь иргэдийг орон сууцаар хангахдаа тухайн цаг хугацаа болон нөхцөл байдалд маш сайн уялдуулж шударга, оновчтой хуваарилалтыг боловсруулан хэрэгжүүлдэг.

Ийнхүү хуваарилалт хийхэд нийтийн орон сууцанд зэрэгцэн амьдрах төрөл бүрийн үндэстэн угсаатны нийгмийн уялдаа холбоо, хоорондоо эв найртай, тав тухтай

⁶⁰ <http://www.worldbank.org/mn/news/press-release/2017/10/03/better-infrastructure-jobs-services-in-cities-urgently-needed-in-east-asia-pacific-world-bank-report>

⁶¹ <https://www.hdb.gov.sg/cs/infoweb/about-us/our-role/public-housing--a-singapore-icon>

амьдрах нөхцөл бүрдүүлэхийг чухалчлан авч үздэг. Үүнтэй холбоотой 1989 оноос Үндэстний интеграцийн бодлого хэрэгжиж эхэлсэн байна.

ОСХЗ байрны үнийг тогтоохдоо хүмүүс худалдан авсан байрандаа үргэлжлүүлэн амьдрах бололцоотой байхыг (төлбөрийн чадварыг) бодолцож тогтоодог. Тиймээс иргэдийн орлогын түвшин, насны ялгаа, хэрэгцээ шаардлага, хүсэл сонирхол, гэр бүлийн байдал болон бусад хүчин зүйлтэй уялдуулан олон тооны хөтөлбөр хэрэгжүүлдэг. Тухайлбал, *Additional CPF Housing Grant Scheme* хөтөлбөрийг нэвтрүүлснээр бага орлоготой өрхүүд анхны байраа авахад томоохон дэмжлэг болсон байна. Хөнгөлөлт бүхий бусад төрлийн хөтөлбөрүүд ч байр худалдаж авахад төлбөрийн таатай нөхцөл бүрдүүлдэг. Ингэснээр анх удаа байр авч байгаа иргэдийн хувьд өрхийн сарын нийт орлогын $\frac{3}{4}$ -ийг л байрны зээлийн төлбөрт зарцуулах болсон.

Одоо Сингапурын хүн амд эзлэх ахмадуудын хувь хурдацтай өсч байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд ахмадуудыг ая тухтай орон сууцаар хангах асуудлыг чухалчилж байна.

Ахмадууд үр хүүхэддээ ойр мөртлөө өөрийн эрх дураар тусдаа амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, орон сууцны хийц, тавилга, шат, хонгил, гэрэлтүүлэг, чөлөөт цагаа өнгөрүүлэх орчин зэргийг тэдний онцлог, хэрэгцээ, шаардлагад тулгуурлан барьж байгуулдаг. Мөн ахмадуудад зориулсан төрөл бүрийн үйлчилгээг нэвтрүүлж байна.

ОСХЗ-ийн орчин үеийн орон сууцжуулах бодлого нь технологийн дэвшлийг ашиглан ухаалаг (smart) орон сууц барихад чиглэх болсон.

3.3. Орон сууц ба Хөгжлийн Зөвлөлийн бүтэц

Зөвлөл нь Тэргүүн, дэд тэргүүн, 3-аас багагүй 10-аас ихгүй тооны гишүүдтэй байх ба тэдгээрийг Сайд томилно. Мөн Гүйцэтгэх захирлыг томилно⁶².

ОСХЗ нь барилга, үл хөдлөх хөрөнгө, корпорацын асуудал хариуцсан 3 газартай бөгөөд газар тус бүр нь дотроо хэлтсүүдэд хуваагддаг. Хэлтсүүд нь тодорхой асуудал эрхэлсэн албадаас бүрдэнэ⁶³. Зураг 1, Зураг⁶⁴ 2, Зураг⁶⁵ 3, Зураг⁶⁶ 4-т ОСХЗ-ийн бүтцийг харуулав.



⁶² HOUSING AND DEVELOPMENT ACT.PART II.6 (1) <https://sso.agc.gov.sg/Act/HDA1959#pr6->


⁶³ <https://www.gov.sg/sgdi/ministries/mnd/statutory-boards/hdb>

⁶⁴ <https://www.gov.sg/sgdi/ministries/mnd/statutory-boards/hdb/departments/building>

⁶⁵ <https://www.gov.sg/sgdi/ministries/mnd/statutory-boards/hdb/departments/estate>


⁶⁶ <https://www.gov.sg/sgdi/ministries/mnd/statutory-boards/hdb/departments/corporate>

Зураг⁶⁷ 1.




UIN.MN
СУДАЛГААНЫ САН

⁶⁷ <https://www.hdb.gov.sg/cs/infoweb/about-us/organisation-structure>




⁶⁸ <https://www.gov.sg/sgdi/ministries/mnd/statutory-boards/hdb/departments/building>



УИХ-ЫН
СҮДАЛГААНЫ САН

⁶⁹ <https://www.gov.sg/sgdi/ministries/mnd/statutory-boards/hdb/departments/estate>



UIH.MN
СУДАЛГААНЫ САН

⁷⁰ <https://www.gov.sg/sgdi/ministries/mnd/statutory-boards/hdb/departments/corporate>

3.4. Орон сууц ба Хөгжлийн Зөвлөлийн эрх, үүрэг, үйл ажиллагааны чиглэл

ОСХЗ нь орон сууц барьж байгуулах, түүнтэй холбоотойгоор газар чөлөөлөх, чөлөөлөх газарт амьдарч байсан иргэдийг байршуулах, орон сууц худалдан авах зориулалтаар зээл олгох, түрээсийн болон худалдсан орон сууцны ашиглалтыг хариуцан ажилладаг.

Сингапурын Засгийн газраас ОСХЗ-ийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор санхүүгийн болон хууль эрх зүйн багц арга хэмжээ авч хэрэгжүүлсэн.

Засгийн газраас санхүүгийн баталгаа гаргах, орон сууц барихад зээл олгох замаар орон сууцжуулах хөтөлбөрийг санхүүгийн хувьд дэмжсэн бол 1960 онд батлагдсан Орон сууц ба хөгжлийн тухай хуулиар ОСХЗ-д тус улсын орон сууцны асуудлыг цогцоор нь шийдэх эрх олгожээ.

ОСХЗ нь орон сууцны барилга байгууламжийг төлөвлөх, барих, хот төлөвлөлтийг өөрчлөн шинэчлэх замаар чанартай, тав тухтай амьдрах орчин бүрдүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Зөвхөн нийтийн орон сууцаар зогсохгүй худалдаа, амралт, зугаа цэнгэл, нийтийн үйлчилгээний зориулалттай барилга байгууламжаар бас хангана.

Орон сууц ба хөгжлийн тухай хуульд тодорхойлсноор ОСХЗ нь доорх төрлийн үйл ажиллагааны чиг үүрэгтэй байна.⁷¹ Үүнд:

1. Дараах ажил үүргийн хүрээнд төсөл, төлөвлөгөө, санал боловсруулна. Үүнд:
 - барилга байгууламжийг худалдах, түрээслэх болон бусад зорилгоор барих, сэргээн засварлах, сайжруулах, өргөтгөл хийх;
 - хуучирсан хороолол болон хот суурин газруудыг нурааж дахин төлөвлөх;
 - Сайдын шийдвэрээр тухайн газрыг төлөвлөн хөгжүүлэх, эсхүл дахин төлөвлөн хөгжүүлэх;
 - ОСХЗ-ийн үйл ажиллагааны хэрэгцээнд хөдөө орон нутаг болон газар тариалангийн бүс нутгийг төлөвлөн хөгжүүлэх зорилгоор, эсхүл Сайдын шийдвэрээр иргэдийг нүүлгэн шилжүүлэх.
2. ОСХЗ-д хамааралтай газар, амины орон сууц, байшин барилга болон бусад үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой үйл ажиллагааг зохион байгуулна.
3. ОСХЗ-ийн үйл ажиллагаа болон үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай бүх төрлийн судалгаа шинжилгээ, хяналт шалгалтыг хэрэгжүүлнэ.
4. Сайдын зөвшөөрлөөр болзол хангасан хүмүүст зээл олгоно.
5. ОСХЗ нь хуульд тодорхойлсон эрх, үүргийг хэрэгжүүлнэ.
6. ОСХЗ нь чиг үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай бусад үйл ажиллагааг явуулна.

3.5. Орон сууц ба Хөгжлийн Зөвлөлийн санхүүжилт

Сингапур улсын хувьд орон сууцны хөтөлбөр хэрэгжүүлэхэд төрийн оролцоо давамгайлсан байдаг. Хэдий тийм боловч энэ нь дэлхийд гайхагдсан, дахин давтагдашгүй сайн туршлага болжээ. Орон сууцны хөтөлбөр амжилттай хэрэгжиж буй нэг шалтгаан нь төрөөс үзүүлж буй томоохон дэмжлэг юм⁷².

⁷¹HOUSING AND DEVELOPMENT ACT, PART III

<https://sso.agc.gov.sg/Act/HDA1959#P11III->

⁷² <https://www.hdb.gov.sg/cs/infoweb/about-us/history>

ОСХЗ-ийн үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлдэг⁷³. Үүнд:

- Засгийн газрын татаас;
- Засгийн газрын зээл;
- хөрөнгийн зах зээлээс босгосон хөрөнгө;
- орон сууцны борлуулалтаас орох орлого;
- зээлээр орон сууц авсан иргэдийн зээлийн хүүгийн орлого;
- орон сууцны түрээс, түүнээс олох ашиг орлого;
- машины зогсоол зэрэг болно.

Эдгээр санхүүжилтийг доорх үйл ажиллагаанд зарцуулна. Үүнд:

- ОСХЗ-ийн байрыг худалдан авч буй иргэдэд зориулсан моргейжийн зээл олгох;
- орон сууцны завсар болон шинэчлэл;
- ОСХЗ-ийн орон сууцны хороолол барих хөтөлбөр болон үйл ажиллагааг санхүүжүүлэхэд ашигладаг.

3.6. Түрээсийн орон сууц

Сингапурт байр худалдан авах санхүүгийн бололцоогүй иргэдэд зориулж Түрээсийн орон сууцны хөтөлбөрийг (*Public Rental Scheme*) хэрэгжүүлдэг. Гэхдээ түрээсийн байрны тоо хязгаартай бөгөөд үүнд хамрагдахын тулд тодорхой шалгуурыг хангах ёстой⁷⁴.

Түрээсийн орон сууцны хөтөлбөр нь гэр бүл болон ганц бие хүмүүст тусгайлан зориулсан хөтөлбөртэй байна⁷⁵.

Гэр бүлд зориулсан хөтөлбөрт (*Family Scheme*) хамрагдахын тулд дараах болзлыг хангах ёстой. Үүнд:

1. Сингапурын иргэн байх;
2. гэр бүлийн гишүүдийн ядаж нэг нь сингапурын иргэн байх, эсхүл тус улсад байнга оршин суух эрхтэй байх;
3. гэр бүл дараах бүрэлдэхүүнтэй байх ба үүнд:
 - иргэн болон түүний эхнэр/нөхөр;
 - гэрлээгүй тохиолдолд, иргэн болон түүний эцэг, эх;
 - салсан, эсхүл бэлэвсэн тохиолдолд иргэн болон түүний албан ёсны асрамжид байдаг хүүхэд (салсан тохиолдолд, хэрэв хүүхэд асрамжлан хамгаалах эрхийг салсан эцэг, эх хоёулаа хуваалцан хэрэгжүүлдэг бол аль нэг нь түрээсийн байранд хүсэлт өгөхөд нөгөө нь заавал бичгээр зөвшөөрөл өгсөн байх);
 - сүй тавьсан хосууд;
 - хэрэв өнчин бол түүний төрсөн ах, эгч (эцэг, эхийн аль нэг сингапурын иргэн, эсхүл байнгын оршин суух эрхтэй байсан) хамаарна.

Ганц бие хүний хувьд тусгайлсан хөтөлбөрийг (*Joint Singles Scheme*) хэрэгжүүлэх ба дараах болзлыг хангах шаардлагатай. Үүнд:

1. Түрээслэгч болон хамтран түрээслэгч нь Сингапурын иргэн байх;
2. Түрээслэгч болон хамтран түрээслэгч хоёулаа ганц бие байх;

⁷³ <http://tosk.gov.mn/78.html>

⁷⁴ <https://www.hdb.gov.sg/cs/infoweb/residential/renting-a-flat/renting-from-hdb/public-rental-scheme>

⁷⁵ <https://www.hdb.gov.sg/cs/infoweb/residential/renting-a-flat/renting-from-hdb/public-rental-scheme/eligibility>

3. Дараах тохиолдлыг ганц бие гэж тооцно. Үүнд:
- 35 хүртлэх насны гэрлээгүй хүн;
 - 35 хүртлэх насны салсан, эсхүл хуулийн дагуу тусдаа амьдарч буй иргэн;
 - бэлэвсэн, эсхүл өнчирсөн хүн хамрагдана.

Эдгээрээс гадна дараах нэмэлт болзлууд тавигдана. Үүнд:

- өргөдөл гаргах үед ядаж 21 нас хүрсэн байх;
- сарын орлого 1500 доллараас хэтрэхгүй байх;
- иргэн болон хамтран түрээслэгч ОСХЗ-ийн орон сууцыг эзэмшигч, эсхүл түрээслэгч байж болохгүй.
- Иргэн болон хамтран түрээслэгч орон сууцны бусад (HDB flat болон Design, Build & Sell Scheme flat) хөтөлбөрүүдэд хамрагдсан, эсхүл бүртгүүлсэн байж болохгүй.
- Сингапурт болон гадаад улсад хувийн үл хөдлөх хөрөнгө (амины орон сууц, газар, барилга байгууламж), орон сууц, бусад үл хөдлөх хөрөнгөгүй байх;
- Executive Condominium-д хамрагдаагүй байх (Энэ нь төрийн мэдлийн биш бөгөөд хувийн хэвшил барьж, худалдан борлуулдаг ч иргэд худалдан авахдаа Хуримтлалын төв сангаас тэтгэлэг авах боломжтой, хямд үнэтэй нийтийн орон сууц юм)

Дараах тохиолдолд “Түрээсийн орон сууц хөтөлбөрт” хамрагдахгүй. Үүнд:

- Түрээсийн орон сууц хөтөлбөрийн болзолыг өмнө нь хангаагүй иргэн болон хамтран түрээслэгч нь уг хөтөлбөрт дахин хүсэлт гаргах, хамтран түрээслэгчээр бүртгүүлэх боломжгүй.
- Хэрэв тухайн иргэний үр хүүхэд түүнийг гэртээ байлгах боломжтой бол, эсхүл орон сууцны бусад хөтөлбөрт хамрагдах хэмжээний санхүүгийн бололцоотой бол хамрагдахгүй.

3.7.Хуримтлалын төв сан (Central Provident Fund - CPF)⁷⁶

Энэ нь Сингапурын нийгмийн даатгалын сан бөгөөд тус улсын харьяат иргэн болон байнгын оршин суух эрхтэй хүмүүст зориулсан нийгэм хамгааллын цогц систем юм. Хуримтлалын төв сангаас тэтгэвэр, эрүүл мэндийн үйлчилгээ, орон сууцжуулах хөтөлбөр, гэр бүл хамгааллын үйлчилгээ, үл хөдлөх хөрөнгийн ашиглалт болон засвар үйлчилгээг санхүүжүүлдэг. Хуримтлалын төв сантай холбоотой харилцааг Хуримтлалын төв сангийн тухай хуулиар (CENTRAL PROVIDENT FUND ACT) зохицуулна.

1964 онд Орон сууц эзэмших хөтөлбөрийг нэвтрүүлж, 1968 онд Хуримтлалын төв сангийн үйл ажиллагааг өргөжүүлэн байгуулснаар иргэдийг орон сууцжуулахад дэвшилтэт алхам болжээ.

Орон сууцны зээлийн тогтвортой тогтолцооны нэг хэлбэр нь хуримтлалын сан юм. Түүнийг хөдөлмөр эрхлэгчдийн цалин, тэтгэврээс орон сууцны хэрэгцээг хангах зорилгоор дийлэнхдээ төрөөс албадан зохион байгуулдаг. Хуримтлалын сангийн хөрөнгийг ажилчдын цалингийн тодорхой хувийг тусгай санд байршуулж бүрдүүлнэ. Үүнийг амжилттай хэрэгжүүлсэн улсын нэг Сингапур юм.

Зураг 5-д Хуримтлалын төв сангийн санхүүжилтийн схемийг харуулав. Сингапурт

⁷⁶ <https://www.cpf.gov.sg/Members/AboutUs/about-us-info/cpf-overview>

орон сууцны зээлийг ОСХЗ болон Хөдөлмөрийн яамнаас удирддаг Хуримтлалын төв сангаас олгоно. Тус сан нь хөдөлмөр эрхлэгчдийн цалингийн тодорхой хувийг хүүтэй хуримтлуулж эх үүсвэр татдаг. Зээл авах сонирхолтой иргэд санд буй хуримтлалаа ашиглан орон сууцны зээлийн урьдчилгаа болон зээлийн төлбөрийг төлөх боломжтой. Түүнчлэн орлогын түвшин багатай иргэд орон сууцны үнийн 90 хүртэлх хувийн зээлийг зах зээлээс бага хүүтэй (2.6%), урьдчилгаа төлбөр төлөхгүйгээр авч болно. Харин орон сууцны зээл авах шаардлага хангаагүй, эсхүл хувийн орон сууц худалдан авах сонирхолтой өрхүүд банкнаас 5-10 хувийн урьдчилгаа төлбөртэй, зах зээлийн хүүгээр (5.3%) зээл авах боломж бас бий.⁷⁷

Зураг 5



Хуримтлалын төв сангийн хөрөнгийг сар бүр ажилтан болон ажил олгогчоос цалингийн тодорхой хувийг шимтгэлд авч, хүүтэй хуримтлуулах замаар бүрдүүлдэг. Сангийн хуримтлалыг доорх дансуудад хуваарилна⁷⁸.

Данс	хүүгийн хэмжээ	Зарцуулалт
Энгийн данс (Ordinary Account - OA)	3.5 хувь	Орон сууцжуулах хөтөлбөр, даатгал, хөрөнгө оруулалт болон боловсролыг санхүүжүүлнэ.
Тусгай данс (Special Account - SA)	5 хувь	Өндөр нас болон тэтгэвэрт хамааралтай бүтээгдэхүүн үйлчилгээнд зарцуулна.
(MediSave Account MA) Эрүүл мэндийн үйлчилгээний данс		Эмнэлгийн үйлчилгээ болон баталгаажсан эрүүл мэндийн даатгалыг санхүүжүүлнэ.
(Retirement Account-RA) Тэтгэврийн данс	5 хувь	55 нас хүрэнгүүт автоматаар үүсдэг.

⁷⁷ Орон сууцны зээлийн тогтолцоо: Олон улсын харьцуулалт. С.Мөнхчимэг, С.Билгүүнзул. МОНГОЛБАНК. 2017 оны 4 дүгээр сар. Хуу.89 <https://www.mongolbank.mn/documents/tovhimol/group12/12-05.pdf>

⁷⁸ <https://www.cpf.gov.sg/Members/AboutUs/about-us-info/cpf-overview>

Хуримтлалын төв сангаас орон сууцжуулах ажлыг дэмжих зорилгоор дараах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ. Үүнд:⁷⁹

- *Нийтийн орон сууцны хөтөлбөр (Public Housing Scheme - PHS)* нь Энгийн дансны хуримтлалаа ашиглан төрийн мэдлийн шинэ, хуучин орон сууц худалдан авах боломжийг олгодог. Байр худалдаж авах санхүүгийн бололцоогүй иргэд түрээсийн орон сууцны хөтөлбөрт хамрагдах боломжтой.
- *Хувийн орон сууцны хөтөлбөр (Private Properties Scheme)* нь хувийн орон сууцны зориулалттай үл хөдлөх хөрөнгө худалдан авах буюу барих тохиолдолд Энгийн дансны хуримтлалаа ашиглах боломжийг олгоно.
- *Байраа хадгалж үлдэх хөтөлбөр (Home Protection Scheme)* нь орон сууцны хөтөлбөрт хамрагдсан (байрны зээлтэй) иргэн ба түүний эхнэр/нөхөр нас барах, эсхүл хөдөлмөрийн чадвараа түр болон бүр алдах тохиолдолд зээлээ эргэн төлж чадахгүй байраа алдах эрсдлээс хамгаалах арга хэмжээ юм.

Эдгээр хөтөлбөрт Хуримтлалын төв санд шимтгэл төлөгч иргэн хамрагдана.

4.ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС

4.1.ОХУ-ын орон сууцны хангамжийн асуудал⁸⁰

ОХУ-ын Үндсэн хуулийн⁸¹ 40 дүгээр зүйлд хүн бүр орон байртай байх эрхтэй гэж хүний суурь хэрэглээ болох орон сууцны талаар заасан байна. Засгийн газрын үйл ажиллагааны зорилтын нэг бол иргэдийг хүртээмжтэй, тохилог орон сууцаар хангах хэмээн “ОХУ-ын орон сууцны салбарыг 2025 он хүртэлх хөгжүүлэх стратеги”⁸² (цаашид “Стратеги” гэх)-д дурдсан байна.

Стратегиас үзэхэд, 2016 онд шинэ орон сууцны барилгын хэмжээ 2004 оныхтой харьцуулахад 2 дахин нэмэгдсэн, орон сууцны нөхцөлөө сайжруулах шаардлагатай иргэдийн тоо 61 хувиас 45 хувь болж буурсан нь орон сууцны ипотекийн зээл 29 дахин нэмэгдсэнтэй шууд холбоотой гэсэн байна.

Гэсэн ч шийдэх олон асуудлууд байна. Тухайлбал, тус улсын нийт гэр бүлийн 35 хувь нь орон сууцны хангамжаа шийдээгүй байна, тус улсын орон сууцны сангийн 3.6 тэрбум метр талбайн 33 хувь нь 1970 оноос өмнө баригдсан, чанар муутай орон сууц эзэлж байна.

Мөн орчин үед орон сууцны хангамжаас гадна түүнд тавигдах шаардлага өндөр болсон. Наад зах нь орон сууц дотроо жижиг ч зохион байгуулалтын хувьд зөв шийдэлтэй, тохитой, гаднаа өнгө үзэмжтэй байхыг шаардах болсон. Цаашлаад иргэд орон сууцны тав тухтай хороолол, хотын таатай орчныг хүсэх болсон. Гэтэл шинэ орон сууцны орчим тээврийн дэд бүтцийг тооцоогүй, олон нийтийн газрыг төлөвлөхгүй барьсаар байгааг Стратегид дурджээ.

Хүн амын нягтаршил нь хотын тулгамдсан асуудлын нэг болоод байна. Орон сууцны барилгын болон ипотекийн зээлийн 50 хувь нь тус улсын томоохон 15 агломерац буюу хүн амын бөөгнөрөлд хамаарч байна.

⁷⁹ <https://www.cpf.gov.sg/Members/Schemes>

⁸⁰ “Стратегия развития жилищной сферы Российской Федерации на период до 2025 года”. Минстрой России, Дом РФ.

⁸¹ “Конституция РФ” (принята всенародным голосованием 12.12.1993).


⁸² “Стратегия развития жилищной сферы Российской Федерации на период до 2025 года”. Минстрой России, Дом РФ.

Тийм учраас дараах зорилгуудыг Стратегид дэвшүүлсэн байна. Үүнд:


- орон сууцны чанарыг болон хотын орчныг сайжруулах;
- хот, суурин газрын тогтвортой, тэнцвэртэй хөгжлийг хангах;
- орон сууцны ипотекийн зээлийн зах зээлийг хөгжүүлэх замаар орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх;
- түрээсийн орон сууцны зах зээлийг хөгжүүлэх.

Эдгээр зорилгуудыг үндсэн чиглэлд дараах байдлаар тусгасан байна:

1. Тав тухтай хот, суурин газарт чанартай, хямд орон сууцаар хангах талаар



2. Хотын тав тухтай орчны талаар



4.2. Зорилтот бүлгийн иргэдийн орон сууцны хангамж

4.2.1. Эрх зүйн орчин

Хуучин тогтолцооны үед тус улсын төр нь иргэдийг орон сууцаар хангах үүргийг өөртөө авч байсныг 1993 оны Үндсэн хуулиар өөрчилсөн нь төрөөс орон сууц шаардлагатай байгаа бага орлоготой иргэдийг орон сууцаар үнэ төлбөргүй, эсхүл хямд өртгөөр хангах болсон. Харин бусад иргэд орон сууцны асуудлаа өөрсдөө шийдвэрлэх ба төрөөс орон сууц барилгажилтыг дэмжих, орон сууцтай байх эрхээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхийг Үндсэн хуульд заасан байна.

Орон сууцтай холбоотой бүхий л асуудлыг, тэр дундаа орон сууцны хангамжтай холбоотой харилцааг Орон сууцны тухай хууль⁸³ болон холбогдох бусад хууль тогтоомж (ОХУ-ын Ерөнхийлөгчийн зарлиг, ОХУ-ын Засгийн газрын тогтоол, холбооны төрийн захиргааны байгууллагуудын шийдвэр, ОХУ-ын субъектүүдийн хууль тогтоомж,

⁸³ "Жилищный кодекс Российской Федерации" от 29.12.2004 N 188-ФЗ (ред. от 03.08.2018)

нутгийн өөрөө удирдах байгууллагуудын шийдвэр)-оор зохицуулна. Үүнд Үндсэн хуулийн 72 дугаар зүйл, Орон сууцны тухай хуулийн 5 дугаар зүйлд заасны дагуу холбооны болон ОХУ-ын субъектүүдийн хамтран гаргасан хууль тогтоомжууд багтана.

ОХУ-ын Засгийн газрын тогтоолоор батлагдсан “ОХУ-ын нийгэм, эдийн засгийн 2020 он хүртэлх урт хугацааны хөгжлийн үзэл баримтлал”-аар⁸⁴ тус улсын төрийн бодлогын тэргүүлэх чиглэлийн нэг нь орон сууцны бодлого аж. Энэ стратегид дурдсанаар “2020 он гэхэд иргэдийн орлогын түвшин, амьдралын чанар нь хөгжингүй эдийн засгийн шинж чанарын үзүүлэлтүүдэд хүргэнэ”, үүний нэг шалгуур үзүүлэлт болох “орон сууцны хангамжийг шаардлагатай түвшинд хүргэх”-ийн тулд иргэдийг хямд үнэтэй, чанартай орон сууцаар хангах, бүс нутгууд болон үндэстнүүдийн амьдралын олон хэв маягийг харгалзан төлбөрийн уян хатан тогтолцоог бий болгохоор зорьсон байна.

4.2.2.Төрийн байгууллагуудын бүрэн эрх

ОХУ-ын Орон сууцны тухай хуулийн 12, 13, 14 дүгээр зүйлд холбооны болон ОХУ-ын субъектүүдийн төрийн захиргааны байгууллагууд, орон нутгийн өөрөө удирдах байгууллагууд гэсэн гурван түвшний бүрэн эрхийг тусгасан байна.

ОХУ-ын төрийн эрх бүхий байгууллагуудын бүрэн эрх:

- орон сууц шаардлагатай байгаа бага орлоготой иргэдийг тогтоох шалгуур үзүүлэлтүүдийг батлах;
- ОХУ-ын орон сууцны сангаас орон сууц олгох бусад зорилтот бүлгийн иргэдийг тодорхойлно;
- орон сууцны сангийн улсын бүртгэл хөтлөх журам батлах;
- ОХУ-ын орон сууцны сангаас орон сууц шаардлагатай байгаа болон холбооны хууль тогтоомжоор тогтоосон зорилтот бүлгийн иргэдэд орон сууц олгох журам батлах;
- нийтийн түрээсийн гэрээгээр орон сууцанд хамрагдах иргэдийг тогтоох шалгуур үзүүлэлтүүд, тэдэнд нийтийн түрээсийн орон сууц олгох журам батлах;
- амьдрах шаардлага хангахгүй орон сууцны шалгуур үзүүлэлтүүдийг болон ийм орон сууцыг хүлээн зөвшөөрөх журам батлах.

ОХУ-ын субъектүүдийн төрийн эрх бүхий байгууллагуудын бүрэн эрх:

- ОХУ-ын субъектийн орон сууцны бүртгэлийг хөтлөх;
- орон сууц шаардлагатай байгаа болон бага орлоготой иргэдийг тогтоох зорилгоор өрхийн гишүүн бүрт ногдох орлогын хэмжээг тогтоох, тэдний өмчийг үнэлэх журмыг, орон нутгийн орон сууцны сангаас нийтийн түрээсийн гэрээгээр орон сууц олгох журмыг тус тус батлах;
- нутгийн өөрөө удирдах байгууллагын орон сууц шаардлагатай байгаа иргэдэд нийтийн түрээсийн гэрээгээр орон сууц олгосон тухай бүртгэлийг хөтлөх журам батлах;
- ОХУ-ын субъектийн орон сууцны сангаас орон сууц олгох бусад зорилтот бүлгийн иргэдийг тодорхойлох;

⁸⁴ Распоряжение Правительства РФ от 17.11.2008 N 1662-р (ред. от 28.09.2018) “О Концепции долгосрочного социально-экономического развития Российской Федерации на период до 2020 года”.

- ОХУ-ын субъектийн хууль тогтоомжоор тодорхойлсон зорилтот бүлгийн иргэдэд нийтийн түрээсийн гэрээгээр орон сууц олгох журам батлах;
- ОХУ-ын субъектийн орон сууцны сангийн орон сууцыг амьдрах шаардлага хангахгүй болсныг хүлээн зөвшөөрөх.

Нутгийн өөрөө удирдах байгууллагуудын бүрэн эрх:

- орон нутгийн орон сууцны бүртгэлийг хөтлөх;
- бага орлоготой иргэдийг тогтоох зорилгоор өрхийн гишүүн бүрт ногдох орлогын хэмжээг тогтоох, тэдний өмчийг үнэлэх, орон сууцны нийтийн түрээсийн гэрээгээр орон сууц олгох;
- нийтийн түрээсийн гэрээгээр орон сууц шаардлагатай байгаа иргэдийн тогтоох зорилгоор өрхийн гишүүдийн орлогын дээд хэмжээ, өрхийн гишүүдийн өмчийн үнэлгээний дээд хэмжээг тогтоох;
- нийтийн түрээсийн гэрээгээр орон сууц шаардлагатай байгаа иргэдийн бүртгэлийг хөтлөх;
- орон нутгийн орон сууцны тусгай сангаас орон сууц олгох журмыг батлах;
- орон нутгийн орон сууцны сангаас бага орлоготой иргэдэд нийтийн түрээсийн гэрээгээр орон сууц олгох.

4.2.3.Зорилтот бүлгийн иргэдэд чиглэсэн төсөл, хөтөлбөр

Зорилтот бүлэгт хамаарах иргэд: Зорилтот бүлгийн дараах иргэдэд орон сууцны хангамжийн талаар зарим хөнгөлөлтүүдийг үзүүлнэ:

- асран хамгаалагчгүй үлдсэн хүүхдүүд;
- аугаа эх орны дайны ахмад дайчид;
- Чернобылийн атомын цахилгаан станцад гарсан ослын үр дагаварт өртсөн иргэд;
- хуучин, эсхүл ослын аюултай нь тогтоогдсон орон сууцанд амьдарч байгаа иргэд;
- хөдөлмөрийн бэрхшээлтэй иргэд;
- нээлттэй хэлбэрийн сүрьеэ өвчтэй иргэд;
- бусад хүмүүстэй хамт амьдарч байгаа архаг өвчтэй иргэд;
- удаан хугацаанд эмнэлэгт хэвтэж эмчлүүлсний дараа эмчийн тусламжаас татгалзсан, эмнэлэгт хэвтэхээсээ өмнө амьдарч байсан орон сууцандаа буцаж очих боломжгүй болсон иргэд;
- Социалист хөдөлмөрийн баатар, ОХУ-ын Хөдөлмөрийн баатар, ЗХУ-ын болон ОХУ-ын баатар, Хөдөлмөрийн гавьяаны 3 дугаар зэргийн одонтой иргэд;
- ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн шүүгчид, холбооны шүүгчид, прокурорууд;
- ОХУ-ын Мөрдөн байцаах хорооны ажилчид;
- цагдаа болон цэргийн генерал, хурандаа цолтой албан хаагчид;
- эрдмийн зэрэг цолтой эрдэмтэд;
- бага орлоготой гэр бүлүүд;
- залуу гэр бүлүүд;
- 3 ба түүнээс олон хүүхэдтэй гэр бүлүүд;

- албан үүргээ гүйцэтгэж байхдаа амиа алдсан цэргийн албан хаагчдын гэр бүлүүд;
- хөдөлмөрийн бэрхшээлтэй хүүхэдтэй гэр бүлүүд;
- ганц бие ээжүүд г.м.

“Орон сууц – 2011-2015” холбооны зорилтот зорилтот хөтөлбөр⁸⁵: Орон сууцны хангамжид чиглэсэн энэхүү хөтөлбөрийг ОХУ-ын Засгийн газрын 2010 оны 1050 дугаар тогтоолоор батлан хэрэгжүүлсэн. Засгийн газраас зорилтот хөтөлбөрийн хүрээнд дараах 4 дэд хөтөлбөрийг хамт баталсан. Үүнд:

- “Залуу гэр бүлийг орон сууцаар хангах” дэд хөтөлбөр;
- “Холбооны хууль тогтоомжоор тогтоосон зорилтот бүлгийн иргэдийг орон сууцаар хангах” дэд хөтөлбөр;
- “ОХУ-ын субъектүүдийн орон сууцны барилгажилтыг хөгжүүлэх хөтөлбөрийг дэмжих” дэд хөтөлбөр;
- “Нийтийн дэд бүтцийн объектуудыг шинэчлэх” дэд хөтөлбөр.

Энэ тогтоолд Засгийн газрын 2015 оны 889 дугаар тогтоолоор⁸⁶ өөрчлөлт оруулж хөтөлбөрийг 2020 он хүртэл сунгажээ. Ингэхдээ холбогдох хууль тогтоомж, ОХУ-ын Ерөнхийлөгч, Засгийн газраас өгсөн чиглэлийн дагуу хөтөлбөрт өөрчлөлт оруулсан байна. Энэхүү өөрчлөлтөөр эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй байх шаардлагыг хангасан хямд үнэтэй ангиллын орон сууцны зах зээлийг бий болгох, зорилтот бүлгийн иргэдийг орон сууцаар хангах үндсэн зорилгыг дэвшүүлсэн байна.

Ипотекийн хөнгөлөлттэй зээл: ОХУ-ын Барилгын яам, “Орон сууц” ХК нь орон сууцны ашиглалтыг нэмэгдүүлэх замаар иргэдийн амьдрах нөхцөлийг сайжруулах зорилгоор “Ипотекийн болон түрээсийн орон сууц” төслийг хэрэгжүүлж байна.

Иргэд янз бүрийн нөхцөлөөр орон сууц худалдан авдаг тул ипотекийн хөнгөлөлттэй зээлийг олон төрлийн нөхцөлөөр олгохоор төслийг хэрэгжүүлж байна. Мөн баригдаж байгаа шинэ орон сууцны ипотекийн зээлийн хүү 9,25 хувь, харин хоёрдогч зах зээлийн баригдсан орон сууцны ипотекийн зээлийн хүү 10,0 хувь байна. Зорилтот бүлгийн иргэдэд олгох орон сууцны ипотекийн зээлийн хүү, урьдчилгаат төлбөрийн хэмжээг ялгаатай нөхцөлөөр тогтоосон байна. (Хүснэгт 1.)

ОИХ.МН
СУДАЛГААНЫ САН

⁸⁵ Постановление Правительства РФ от 17 декабря 2010 г. N 1050 "О реализации отдельных мероприятий государственной программы Российской Федерации. Федеральная целевая программа "Жилище" на 2011-2015 годы

⁸⁶ Постановление Правительства РФ от 25 августа 2015 г. N 889 "О внесении изменений в постановление Правительства РФ от 17 декабря 2010 г. N 1050".

**Хүснэгт 1. Зорилтот бүлгийн иргэдэд олгож байгаа
орон сууцны ипотекийн зээлийн нөхцөл**

Орон сууцны ипотекийн зээл олгох зорилтот бүлэг	Хүүгийн хувь хэмжээ	Урьдчилгаа төлбөр	Зээлийн хугацаа
Олон хүүхэдтэй гэр бүл (2018.01.01-2022.12.31-ний хугацаанд 2 болон түүнээс олон хүүхэдтэй болсон гэр бүлд олгох ипотекийн хөнгөлөлттэй зээл)	6,00%	20%	3-8 жил
Цэргийн албан хаагчид (Цэргийн албан хаагчдад зориулсан орон сууцны ипотекийн хуримтлалын систем)	9,25%	20%	3 жилээс дээш
Эмч, багш, эрдэмтэд (Москвагийн бүс нутгийн эмч, багш, эрдэмтдэд зориулсан ипотекийн хөнгөлөлттэй зээл)	8,50%		10 жил

4.2.4. Нийтийн түрээсийн орон сууц

ОХУ-ын хууль тогтоомжоор төрөөс орон сууц худалдан авах, эсхүл ипотекийн хөнгөлөлттэй зээлд хамрагдаж чадахгүй байгаа зорилтот бүлгийн иргэдийн тодорхой ангилалд зориулан нийтийн буюу арилжааны бус түрээсийн орон сууц олгох хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Нийтийн түрээсийн орон сууц нь улсын эзэмшилд байгаа орон сууц, үл хөдлөх хөрөнгө байна.

Орон сууцны тухай хуулийн 3 дугаар хэсэгт түрээсийн орон сууцанд хамрагдах зорилтот бүлгийн иргэдийн ангилал, түрээсийн орон сууц олгох нөхцөл, гэрээ байгуулах журам зэргийг зохицуулахаар тусгасан байна.

Нийтийн түрээсийн орон сууцыг иргэдэд гэрээгээр олгох бөгөөд гэрээний хугацааг сунгах, гэрээг цуцлах нөхцөлийг ОХУ-ын Иргэний хуулийн 35 дугаар бүлгийн дагуу зохицуулна.

Нийтийн түрээсийн орон сууцанд хамрагдах зорилтот бүлгийн иргэд: Орон сууцны тухай хуулийн 93.3-т зааснаар нийтийн түрээсийн орон сууцанд орон сууц худалдаан авч чадахгүй иргэд хамаарах ба ингэхдээ гэр бүлийн нийт орлого болон эзэмшиж байгаа үл хөдлөх хөрөнгийг, мөн тухайн бүс нутгийн орон сууцны үнэ ханш зэргийг харгалзан авч үзнэ.

Орон сууцны тухай хуулийн 51-д зааснаар дараах иргэд нийтийн түрээсийн орон сууцанд хамрагдах боломжтой:

- орон сууцгүй иргэд (ингэхдээ тэдний ойрын хамаатан садан⁸⁷ нь орон сууц эзэмшдэггүй байх);
- нийтийн түрээсийн өөр орон сууцгүй иргэд (ингэхдээ түүний ойрын хамаатан садан нь орон сууцны сангаас орон сууц аваагүй байх);
- өөрийн, эсхүл нийтийн орон сууцанд амьдардаг боловч стандартад зааснаас бага хэмжээний талбайд⁸⁸ амьдардаг иргэд.

⁸⁷ Ойрын хамаатан садан - эхнэр / нөхөр, эсхүл гэрлэлтээ цуцлуулснаас хойш нэг жилийн хугацаанд болон шүүхийн шийдвэрээр нэг байранд хамт амьдарч байгаа салсан эхнэр / нөхөр; хүүхдүүд; өвөө, эмээ; ах, эгч. (ОХУ-ын Орон сууцны тухай хуулийн 51 дүгээр зүйл)

⁸⁸ Амьдрах орон сууцны талбайн хэмжээний стандартыг орон нутгийн захиргаа тогтоох ба Орон сууцны тухай хуулийн 50-д зааснаар нэг хүний амьдрах талбайн хамгийн бага хэмжээ нь орон сууцанд 18 м², нийтийн байранд 6м² байна.

Нийтийн түрээсийн орон сууцны хөтөлбөр: Тус улсын Засгийн газраас бага орлоготой иргэдийн орон сууцны хангамжийг тэдэнд орон сууц хувьчлах замаар хэрэгжүүлж байсныг арилжааны бус (нийтийн) түрээсийн орон сууцанд хамруулахад анхаарч байна.

Одоогийн байдлаар нийт байрны 10 хувийг түрээслүүлж байна. Эдгээрийн 97 хувь нь хувь түрээслэгчид байна. (Хүснэгт 2)⁸⁹

Хүснэгт 2. Түрээсийн байрны статистик үзүүлэлт

	Түрээсийн хэлбэр	Түрээслүүлэгч	Байрны тоо
Нийт байрны тоо			64,9
Түрээсийн байр	Арилжааны (зах зээлийн) нөхцөлөөр	Хувь хүн	3,7
		Байгууллага	0,1
	Арилжааны бус нөхцөлөөр	Хамаатан садан ба найз нөхөд ("саарал түрээс") Улсын (нийтийн түрээс), ажил олгогч	1,9
			2,8
Өөрийн байранд амьдарч байгаа			56,4

“Орон сууц” ХК-ийн 2017 оны жилийн тайланд ОХУ-ын Барилгын яам, “Орон сууц” ХК-ийн хамтарсан судалгааны үр дүнг тайлагнасан байна. Тайланд тус улсын 25 субъектэд 446 мянган м² талбай бүхий 132 түрээсийн орон сууц, үүнд, тус улсын 11 субъектэд 126 мянган м² талбай бүхий 66 арилжааны бус түрээсийн орон сууцыг барьсан байна.⁹⁰

Арилжааны бус түрээсийн орон сууцны асуудлыг орон нутгийн засаг захиргаагаар дамжуулан хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй байгаа боловч энэ төрлийн орон сууцыг бий болгох, ашиглах төсөв, урамшууллын хөшүүрэг дутагдалтай байна.

Өмнө нь дурдсанчлан “ОХУ-ын орон сууцны салбарыг 2025 он хүртэлх хөгжүүлэх стратеги”-йн гол зорилгын нэг бол бага орлого багатай иргэдийг орон сууцаар хангах төрийн бодлогыг хэрэгжүүлэхийн тулд “түрээсийн орон сууцны зах зээлийг бий болгох” бөгөөд үүний тулд арилжааны бус түрээсийн орон сууцыг хөгжүүлэхийн тулд дараах ажлыг төлөвлөж байгаа аж. Үүнд:

- бага орлоготой иргэдийн орон сууцны хангамжийг тэдэнд шинэ орон сууц үнэгүй хувьчлахаас татгалзаж, арилжааны бус түрээсийн байраар хангах;
- тусгайлан хариуцах байгууллага буюу арилжааны бус түрээсийн орон сууцны институтыг байгуулах;
- арилжааны бус түрээсийн байр барих туршилтын хөтөлбөрийг орон нутгийн засаг захиргааны дэмжлэгтэйгээр боловсруулж, хэрэгжүүлэх;
- арилжааны бус түрээсийн орон сууц барихад төсвөөс дэмжлэг үзүүлэх механизмыг боловсруулж, хэрэгжүүлэх;
- арилжааны бус түрээсийн орон сууц барихад хувийн хөрөнгө оруулагчдыг татахад чиглэсэн хөнгөлөлтийн бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх;

⁸⁹ “Стратегия развития жилищной сферы Российской Федерации на период до 2025 года”. Минстрой России, Дом РФ.

⁹⁰ Годовой отчет АО «ДОМ.РФ» - 2017.

- төр, хувийн хэвшлийн хамтарсан төслүүдийг хэрэгжүүлэх;
- арилжааны бус түрээсийн орон сууцаар хангах зорилтот бүлгийн иргэдийн тогтоох шалгуур үзүүлэлтүүдийг батлах.

4.3.Орон сууцны хөгжлийн нэгдсэн институт буюу “Орон сууц” ХК

Орон сууцны хангамжийн асуудал хариуцсан төрийн байгууллага болох “Орон сууц” ХК нь анх 1997 онд холбооны Засгийн газрын 1996 оны 1010 дугаар тогтоолоор⁹¹ Орон сууцны ипотекийн зээлийн асуудал эрхэлсэн агентлаг⁹² нэртэйгээр анх байгуулагдсан. Тус агентлаг нь 2003 онд стратегийн ач холбогдолтой төрийн оролцоот 18 компанийн жагсаалтад оржээ.⁹³

2015 онд *Орон сууцны удирдлагыг хөгжүүлэх, түүний үр ашгийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх болон ОХУ-ын орон сууцны хууль тогтоомжид өөрчлөлт оруулах тухай* (цаашид “Орон сууцны удирдлагыг хөгжүүлэх тухай”) хуулийн⁹⁴ 2.1-д заасны дагуу тус агентлаг нь Орон сууцны хөгжлийн нэгдсэн институт болж өөрчлөгдсөн. Мөн оны 8 дугаар сард хувьцаат компани болсон. Харин 2018 оны 3 дугаар сарын 2-ны өдрөөс Төрийн өмчийн удирдлагын холбооны агентлаг (ТӨУХА)⁹⁵-ийн шийдвэрээр агентлагийн нэр “Орон сууц” ХК болжээ.

Орон сууцны хөгжлийн нэгдсэн институт болох “Орон сууц” ХК нь орон сууцны барилга болон зээлийн салбарыг хөгжүүлэхэд нэгдсэн бодлогоор хандах бөгөөд тав тухтай, хямд орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх замаар нийт иргэдэд хүртээмжтэй болгох бодлогоор байгуулагдсан.

Орон сууцны удирдлагыг хөгжүүлэх тухай хуулийн 2.1.1-д заасны дагуу “Орон сууц” ХК-ийн нийт хувьцаа нь Засгийн газрын мэдэлд байх ба хувьцааг барьцаалах, шилжүүлэх болон захиран зарцуулах бусад хэлбэрийг холбооны хуулиар тогтооно. Тус компани нь ашгийн бус байгууллага байна. (Хуулийн 3.1)

4.3.1. “Орон сууц” ХК-ийн зорилго, үйл ажиллагааны чиглэл

Орон сууцны удирдлагыг хөгжүүлэх тухай хуулийн 2-т Орон сууцны хөгжлийн нэгдсэн институт буюу “Орон сууц” ХК-ийн үндсэн зорилго, зорилт, тэдгээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлийг тусгасан байна.

“Орон сууц” ХК-ийн үйл ажиллагааны үндсэн зорилго бол орон сууцны бодлогыг хэрэгжүүлэх, энэ салбарын хөгжлийг дэмжих, хөрөнгө оруулалт татах, орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх, иргэдийн амьдралын тав тухтай орчныг бүрдүүлэх, орон сууцны салбарын удирдлагын үр ашгийг дээшлүүлэх явдал аж.

Тус компани нь орон сууцны салбарыг хөгжүүлэхэд дараах үндсэн зорилтыг хэрэгжүүлнэ (Хуулийн 2.3):

- 2015 онд батлагдсан Орон сууцны барилгын хөгжлийг дэмжих тухай хуульд⁹⁶ тусгасан механизмуудыг ашиглан орон сууцны (үүнд стандарт болон түрээсийн орон сууц хамаарна) барилгажилтыг хөгжүүлэх;

⁹¹ Постановление Правительства РФ от 26 августа 1996 г. N 1010 "Об Агентстве по ипотечному жилищному кредитованию".

⁹² Агентство по ипотечному жилищному кредитованию (АИЖК).

⁹³ Универсальный стимулятор. 22.10.2012 Эх сурвалж: <https://www.kommersant.ru/doc/2049598>

⁹⁴ Федеральный закон "О содействии развитию и повышению эффективности управления в жилищной сфере и о внесении изменений в отдельные законодательные акты Российской Федерации" от 13.07.2015 N 225-ФЗ.

⁹⁵ Федеральное агентство по управлению государственным имуществом (Росимущество)

⁹⁶ Федеральный закон от 24 июля 2008 года N 161-ФЗ "О содействии развитию жилищного строительства".

- орон сууцны ипотекийн зээл, ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаасны зах зээл болон бусад санхүүгийн хэрэгслийг хөгжүүлэх, төлбөрийн чадварыг нэмэгдүүлэх;
- орон сууцны салбар дахь төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагуудад орон сууцны хөтөлбөрүүд хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх;
- газрыг зохистой ашиглах, тэр дундаа цэцэрлэгт хүрээлэн, үйлдвэрийн болон технологийн парк, бизнес-инкубатор байгуулах арга хэмжээг сайжруулахад дэмжлэг үзүүлэх;
- орон сууц, бусад барилга байгууламжид олгосон газарт инженерийн, нийгмийн болон тээврийн дэд бүтцийн хангамжид дэмжлэг үзүүлэх;
- дэвшилтэт болон эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй технологи, бараа материалыг хөгжүүлэн хэрэглээнд нэвтрүүлэх, орон сууцны барилгад ашиглах нөхцөлийг бүрдүүлэх, тэр дундаа орон сууцны дундын өмчлөлийн эд хөрөнгийн их засварт, мөн нийгмийн болон тээврийн дэд бүтэц, нийтийн аж ахуйн дэд бүтцийн системийг шинэчлэхэд ийм технологи, бараа материалыг ашиглах;
- орон сууцны ипотекийн зах зээл болон ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаасны эрсдэлийг бууруулах;
- орон сууцны барилгад хяналт шинжилгээ, үнэлгээг хийх.

“Орон сууц” ХК нь дээрх зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд дараах үйл ажиллагааны чиглэлээр ажиллана:

- орон сууцны барилга болон ипотекийн зээлийг дэмжих арга хэмжээг сайжруулах саналыг бэлтгэх, тэр дундаа орон сууцны салбарын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;
- харьяа байгууллагуудыг удирдлагаар хангах;
- зах зээл дээр орон сууцны ипотекийн зээл болон ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаасны баталгаа гаргах замаар эрсдэлийг бууруулах арга хэмжээ боловсруулан хэрэгжүүлэх (тухайлбал, “Орон сууц” ХК нь ипотекийн агентлагийн бондыг батлан даах);
- орон сууцны барилгын нэгдсэн мэдээллийн санг байгуулах.

2016 оны 2 дугаар сард ОСХНИ-ын Хяналтын зөвлөлөөс “Орон сууцны хөгжлийн нэгдсэн институтын 2016-2020 оны хөгжлийн стратеги”⁹⁷ (цаашид “2016-2020 оны стратеги”)-ийг баталсан бөгөөд 2017 оны 11 дүгээр сард Стратегид өөрчлөлт оруулсан⁹⁸ байна. Энэ Стратегид “Орон сууц” ХК-ийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлсон байсан бөгөөд өөрчлөлтөөр үүнийг илүү тодорхой болгосон байна.

⁹⁷ Стратегией развития единого института развития в жилищной сфере на период 2016–2020 гг., утвержденной Наблюдательным советом 26 февраля 2016 года.

⁹⁸ Стратегией развития единого института развития в жилищной сфере на период 2016–2020 гг., утвержденной Наблюдательным советом 30 ноября 2017 года.

Зураг 1. “Орон сууц” ХК-ийн үйл ажиллагааны үндсэн чиглэлд орсон өөрчлөлт

Анх батлагдсан Стратеги 2016 оны 2 дугаар сар	Өөрчлөлт орсон Стратеги 2017 оны 11 дүгээр сар
<ul style="list-style-type: none"> • ипотекийн зээл, ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаасны зах зээл болон бусад санхүүгийн хэрэгслүүдийг хөгжүүлэх; • орон сууцны барилгыг хөгжүүлэх; • газрыг зохистой ашиглах, тэр дундаа цэцэрлэгт хүрээлэн, үйлдвэрийн болон технологийн парк, бизнес-инкубатор байгуулах арга хэмжээг сайжруулахад дэмжлэг үзүүлэх; • орон сууцны салбар дахь төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагуудад орон сууцны хөтөлбөрүүд хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх; • орон сууцны салбарын хяналт үнэлгээ хийх. 	<ul style="list-style-type: none"> • ипотекийн зээлийн чиглэлээр - ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх; • түрээсийн байрны чиглэлээр - хамтын хөрөнгө оруулалтын механизмыг ашиглан түрээсийн орон сууцны зах зээлийг хөгжүүлэх; • газар ашиглалтын чиглэлээр - орон сууц барихын тулд холбооны мэдлийн огт ашиглагдаагүй болон үр ашиггүй ашиглагдаж байгаа газрыг эргэлтэнд оруулах; • банкны чиглэлээр - “Оросын капитал” банкны сууринд зорилготой ипотек, барилгын банк байгуулах.ы

ОХУ-ын холбогдох зарим хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт орсон, эсхүл хүчингүй болсон зэргээс шалтгаалж энэ Стратегид өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- 2016 оны 10 дугаар сард ОХУ-ын Ерөнхийлөгчийн дэргэдэх Стратегийн хөгжил, тэргүүлэх чиглэлийн төслүүдийн Зөвлөлийн тэргүүлэгчид “Ипотек ба түрээсийн орон сууц” тэргүүлэх төслийг⁹⁹ баталсан;
- ОХУ-ын Засгийн газрын 2017 оны 746 дугаар тогтоолоор батлагдсан “ОХУ-ын орон сууцны ипотекийн зээлийг 2020 он хүртэл хөгжүүлэх стратеги”-ийг хүчингүй болсон;
- Засгийн газрын шийдвэрээр “Оросын капитал” банкны нийт хувьцаа¹⁰⁰ ОХУ-ын Төрийн сангаас “Орон сууц” ХК-ийн дүрмийн санд шилжсэн. (ОХУ-ын Засгийн газрын 2017 оны 2465 дугаар тогтоол).

“Орон сууц” ХК-ийн дээр дурдсан нэгж, харьяа байгууллагуудын үйл ажиллагааг ТӨУХА-ын даргын тушаал, Бүгд хурал болон Хяналтын зөвлөлийн хуралдааны тэмдэглэл зэрэг баримт бичгүүдээр зохицуулдаг байна.¹⁰¹ (Хүснэгт 3.)

4.3.2. “Орон сууц” ХК-ийн удирдлагын бүтэц, зохион байгуулалт, эрх, үүрэг¹⁰²

“Төрийн өмчийн удирдлагын холбооны агентлагийн эрх зүйн байдлын тухай” ОХУ-ын Засгийн газрын 2008 оны 432 дугаар тогтоолын¹⁰³ дагуу ТӨУХА нь “Орон сууц” ХК-ийг удирдлагаар хангаж ажиллаж байна.

⁹⁹ Утверждение приоритетного проекта «Ипотека и арендное жилье» президиумом Совета при Президенте Российской Федерации по стратегическому развитию и приоритетным проектам (протокол от 19 октября 2016 года № 8).


¹⁰⁰ Үүнд: 5 069 530 899 241 258 888 ширхэг энгийн, 3 964 402 000 000 ширхэг давуу эрхийн хувьцаа багтсан. Эх сурвалж: Стратегией развития единого института развития в жилищной сфере на период 2016–2020 гг., утвержденной Наблюдательным советом 30.11.2017 года. 23 дахь тал.

¹⁰¹ “Орон сууц” ХК-ийн цахим хуудас: <https://дом.рф/about>


¹⁰² “Орон сууц” ХК-ийн цахим хуудас: <https://дом.рф/about>

¹⁰³ Постановление Правительство РФ от 05.06.2008 г. №432 “О Федеральном агентстве по управлению государственным имуществом”.

Зураг 2. Удирдлагын бүтэц



Эх сурвалж: <https://dom.pf/about/corp-management-more/#scheme-anchor06>



Хувьцаа эзэмшигчдийн бүгд хурал (“цаашид “Бүгд хурал”) нь “Орон сууц” ХК-ийн удирдах дээд байгууллага болно. Компанийн цорын ганц хувьцаа эзэмшигч нь ОХУ-ыг төлөөлж ТӨУХА байна.

Бүгд хурлын шийдвэрийг ТӨУХА-ын даргын тушаал хэлбэрээр гарна.

Бүгд хурал нь Хяналтын зөвлөл, Хяналтын хороо, “Орон сууц” ХК-ийн Аудиторыг сонгоно.

Хяналтын зөвлөл нь Бүгд хурлын бүрэн эрхэд хамаарахаас бусад “Орон сууц” ХК-ийн үйл ажиллагааны ерөнхий удирдлагыг хэрэгжүүлнэ.

Зөвлөл нь Бүгд хурлаас сонгогдох ба түүнд ажлаа тайлагнана. Одоогийн дарга, 5 гишүүнийг 2018 оны 7 дугаар сард сонгосон байна.

Хяналтын зөвлөлөөс Ерөнхий захирлыг томилох, Ерөнхий хороо, Дотоод аудитын алба, Компанийн ажлын албыг бүрдүүлэх эрхтэй.

Мөн Хяналтын зөвлөлөөс дараах нэгжүүдийг бүрдүүлэх ба тэд эргээд Хяналтын зөвлөлд ажлаа тайлагнана:

Хүснэгт 3. Хяналтын зөвлөлд ажлаа тайлагнадаг хороодын эрх, үүрэг, удирдлагын бүрэлдэхүүн

Стратеги төлөвлөлтийн хороо	Аудит, эрсдэлийн хороо	Хүний нөөц, шагналын асуудал хариуцсан хороо
Хяналтын зөвлөлийн бүрэн эрхэд хамаарах дараах асуудлыг урьдчилан хянаж үзээд дүн шинжилгээ, үнэлгээ хийж зөвлөмж гаргана:		
<ul style="list-style-type: none"> “Орон сууц” ХК-ийн урт болон дунд хугацааны хөгжлийн стратеги 	<ul style="list-style-type: none"> “Орон сууц” ХК-ийн санхүү, аж ахуйн үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, дотоод хяналтын тогтолцооны үйл ажиллагаа 	<ul style="list-style-type: none"> “Орон сууц” ХК-ийн хүний нөөцийн бодлоготой холбоотой компанийн удирдлагын үр ашгийг дээшлүүлэх асуудал
<ul style="list-style-type: none"> эдгээр асуудлаар Хяналтын зөвлөлөөс гаргасан шийдвэрийн хэрэгжилт 		
Удирдлагын бүрэлдэхүүн		
дарга, 6 гишүүн	дарга, 4 гишүүн	дарга, 4 гишүүн

Гүйцэтгэх байгууллагууд нь Бүгд хурлын бүрэн эрхэд хамаарахаас бусад “Орон сууц” ХК-ийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдлагаар хангана. Үүнд Ерөнхий захирал, Ерөнхий хороо хамаарна.

Хяналтын зөвлөлөөс Гүйцэтгэх байгууллагуудыг бүрдүүлэх ба тэд Хяналтын зөвлөлд ажлаа тайлагнана.

Ерөнхий захирал нь Ерөнхий хороог тэргүүлэх, өөрийн орлогч бөгөөд Хянагчийг томилох, Дотоод хяналтын албыг бүрдүүлэх эрхтэй.

Ерөнхий хорооны дарга, 6 гишүүнийг 2017 оны 5 дугаар сард сонгосон. Ерөнхий хорооноос Төсвийн болон Эрсдэлийн хороог бүрдүүлэх бөгөөд энэ 2 хороо нь түүнд ажлаа тайлагнана.

Хүснэгт 4. Төсвийн болон Эрсдэлийн хорооны эрх, үүрэг

Төсвийн хороо	Эрсдэлийн хороо
<ul style="list-style-type: none"> • “Орон сууц” ХК-ийн нөөцийн үр ашигтай ашиглалтыг хангах; • орон сууцны салбарын хөгжилд “Орон сууц” ХК-ийн стратеги, урт хугацааны хөгжлийн хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөг цаг тухай бүр бэлтгэх, өөрчлөлт оруулах; • тэдгээрийн хэрэгжилтийн тайланг тогтмол гаргах. 	<ul style="list-style-type: none"> • “Орон сууц” ХК, түүний харьяа байгууллагуудын эрсдэлийн хүлээн зөвшөөрөгдсөн түвшинд барих; • томоохон эрсдэлийг арилгах хангалттай хөрөнгийн сантай байх; • “Орон сууц” ХК, түүний харьяа байгууллагуудын эрсдэл болон орлогын оновчтой тэнцвэрийг хадгалахын тулд хөрөнгийн үр ашигтай хуваарилалтыг хангах; • эрсдэлийн талаар цаг тухай бүр, цогц байдлаар тайлагнах.

Бүгд хурлаас томилогдож, түүнд ажлаа тайлагнадаг нэгжүүд:

Хяналтын хороо нь “Орон сууц” ХК-ийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн тайлан, санхүү, аж ахуйн үйл ажиллагаа, эд хөрөнгийн мэдээлэлд хяналт тавина.

Одоо ажиллаж байгаа 3 гишүүнийг Бүгд хурлаас сонгож, ТӨУХА-ийн даргын 2018 оны 357 дугаар тушаалаар томилсон байна.

Аудитор нь ОХУ-ын холбогдох хууль тогтоомж болон өөртэй нь байгуулсан гэрээний дагуу “Орон сууц” ХК-ийн санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийнэ.

Аудиторын сонгон шалгаруулалтын дүн, Бүгд хурлаас гарсан шийдвэрт үндэслэн ТӨУХА-ийн даргын 2018 оны 357 дугаар тушаалаар “Орон сууц” ХК-ийн Аудитороор 2018 онд “Эрнест энд Янг” ХХК ажиллаж байна.

Хяналтын зөвлөл, Ерөнхий захиралд ажлаа тайлагнадаг нэгжүүд:

Дотоод аудитын алба нь “Орон сууц” ХК-ийн удирдлагын үр ашгийг дээшлүүлэхэд Хяналтын зөвлөл болон компанийн Гүйцэтгэх байгууллагуудын санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллана.

“Орон сууц” ХК-ийн үйл ажиллагаа нь ОХУ-ын үнэт цаас, санхүүгийн зах зээлийн хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхэд **Ерөнхий захирлын орлогч бөгөөд Хянагч** дотоод хяналт тавина.

Компанийн ажлын алба нь Бүгд хурал, Хяналтын зөвлөлийн үйл ажиллагаанаас гадна “Орон сууц” ХК-ийн хувьцаа эзэмшигчийн эрх, ашиг сонирхол холбооны хууль тогтоомжийн дагуу хэрэгжихэд нь дэмжлэг үзүүлж ажиллана.

Тус алба нь ажлаа Хяналтын зөвлөлийн даргад тайлагнана, харин зохион байгуулалтын хувьд Ерөнхий захиралд захирагдана.

“Орон сууц” ХК-ийн харьяа байгууллагууд¹⁰⁴:

“Орон сууц” ХК нь өөр бусад байгууллагыг байгуулах эрхийг Орон сууцны удирдлагыг хөгжүүлэх тухай хуулийн 3.1-т олгожээ.

“Оросын капитал” банк нь 1993 онд байгуулагдсан. Тус арилжааны банкны нийт хувьцааг 2017 оны 12 дугаар сараас өдрөөс “Орон сууц” ХК-нд шилжүүлжээ. Тус банк нь орон сууцны ипотекийн зээл олгох бөгөөд 2020 онд ипотекийн зээл олголтоороо шилдэг 3-т багтах олон талт ипотек, барилгын банк болох үүргийг хүлээсэн байна.

2017 оны 1 дүгээр сарын байдлаар “Оросын капитал” банк ОХУ-ын 30 субъектэд 88 салбар, Ипотекийн зээлийн 20 төвтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Түүний хяналтын байгууллага нь ОХУ-ын Төв банк байна.¹⁰⁵

“Хөрөнгийн удирдлага” ХХК нь түрээсийн орон сууцны хамтын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилготой “Кутузовский” үл хөдлөх хөрөнгийн хаалттай хамтын хөрөнгө оруулалтын санг удирдан зохион байгуулдаг.

Тус компанийн дүрмийн 3.1-д зааснаар түүний үйл ажиллагааны үндсэн зорилго бол ашиг олох гэж заасан байна.

“Фабрика” ипотекийн үнэт цаасны удирдах компани” ХХК нь ипотекээр баталгаажсан зээл, ипотекийн бонд гаргах эрхийг авах онцгой үйл ажиллагаа эрхэлдэг арилжааны мэргэжлийн байгууллагуудыг удирдана.

“Орон сууцны барилгыг санхүүжүүлэх агентлаг” ХК-ийн гол зорилго бол зээлдэгчдийг дэмжихийн тулд хямралын эсрэг арга хэмжээ боловсруулан хэрэгжүүлэх явдал юм.

Орон сууцны ипотекийн даатгалын чиглэлээр мэргэшсэн даатгалын болон давхар даатгалын **“Даатгал” ХК** нь анх 2010 онд байгуулагдаж байжээ.

4.3.3. “Орон сууц” ХК-ийн санхүүжилтийн эх үүсвэр

2003 оноос бонд гаргаж эхэлснээр “Орон сууц” ХК-ийн санхүүжилтийн гол эх үүсвэр болсон байна.¹⁰⁶ Одоогийн байдлаар тус компани нь 25 удаагийн 195,6 тэрбум рублийн бонд гаргаад байна.¹⁰⁷

“Орон сууц” ХК-ийн 2017 оны санхүүгийн нэгдсэн тайлангаас¹⁰⁸ үзэхэд, компанийн 2017 оны цэвэр ашиг 18.0 тэрбум рубль байсан нь өмнөх онтой харьцуулахад 4.3 тэрбум рубль буюу 31.2 хувиар өссөн байна. Уг тайланд санхүүгийн дараах гол үзүүлэлтүүдийг дурджээ:

- өөрийн хөрөнгийн өгөөж 12,1 хувьд хүрсэн нь 2016 оныхтой харьцуулахад 2,2 хувиар өссөн;
- ипотекийн хөрөнгийн багц 2017.12.31-ний байдлаар 394,5 тэрбум рубль болсон нь оны эхэн үеэс 122,5 тэрбум рублиэр өссөн;

¹⁰⁴ “Орон сууц” ХК-ийн цахим хуудас: <https://дом.рф/about>

¹⁰⁵ “Оросын капитал” банкны цахим хуудас: <https://rkbank.ru/about/>

¹⁰⁶ <http://www.banki.ru/banks/bank/ahml/>

¹⁰⁷ Орон сууц” ХК-ийн цахим хуудас: <https://дом.рф/investors>

¹⁰⁸ Годовой отчет АО “ДОМ.РФ” 2017.

- үл хөдлөх хөрөнгийн түрээсийн багц 2017.12.31-ний байдлаар 26,7 тэрбум рубль болсон нь оны эхэн үеэс 13,2 тэрбум рублиэр өссөн.

Орон сууцны удирдлагыг хөгжүүлэх тухай хууль болон 2016-2020 оны стратегийн дагуу 2017 онд “Орон сууц” ХК нь бүтэц, зохион байгуулалтын томоохон өөрчлөлт хийсэн. Үүний үр дүнд тус компанийн 2016 оны үйл ажиллагааны зардал 2014 оныхтой харьцуулахад 40 хувиар буурсан, харин өөрийн хөрөнгийн өсөлтийн 3,2 хувь нь 3 дахин буюу 10.4 хувь болж өссөн байна.

Хүснэгт 5. Стратегийг үндсэн үзүүлэлтийн 2016 оны хэрэгжилт

	Стратегид тусгасан төлөвлөгөө	2016 оны биелэлт	Биелэлтийн хувь
Ипотекийн зах зээлийг санхүүжүүлсэн, тэрбум рубль	70,0	71,3	102%
Түрээсийн орон сууцыг санхүүжүүлсэн, тэрбум рубль	10,0	13,5	135%
Ашиглагдаагүй болон үр ашиггүй ашиглагддаг газар дээр орон сууц барьж ашиглалтад оруулсан, сая м2	1,7	1,8	104%
Өөрийн хөрөнгийн өгөөж, %	6,2	9,9	150%
-хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлсэн, %	134,3	129,8	97%
-үйл ажиллагааны зардлыг бууруулсан, %	10,0	16,5	150%

5.ЯПОН УЛС

Япон улсын Засгийн газраас ард иргэдийг орон сууцаар хангах бодлогыг 1950-аад оноос эхлүүлсэн ба дараах 3 тулгуур арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- 1950 онд орон сууц барих, худалдан авахад зориулж урт хугацааны, бага хүүтэй санхүүжилтийг олгодог *Засгийн газрын орон сууцны зээлийн корпорацыг* (Government Housing Loan Corporation-GHLC; одоогийн “Японы орон сууц санхүүжилтийн агентлаг”) байгуулсан.
- 1951 онд “*Төрийн орон сууцжуулах үйл ажиллагааны тухай хууль*” (The Publicly-Operated Housing Act)-ийг баталсан бөгөөд энэ нь иргэдийг бага түрээс бүхий орон сууцаар хангах (улсын орон сууцжуулах ажлын) мөнгөн тэтгэмжийг төв засгийн газраас орон нутгийн засгийн газруудад олгох боломж нөхцөлийг бүрдүүлж өгсөн.
- 1955 онд *Японы Орон сууцны корпорац* (Japan Housing Corporation-JHC; одоогийн Urban Renaissance Agency-Хотын сэргээн босголтын агентлаг)-ийг тус тус байгуулжээ.

Эдгээр арга хэмжээ нь одоогийн “төрийн санхүүжилттэй орон сууцаар хангах систем”-ийн үндэс, суурь болжээ.

Төрийн удирдлагатай орон сууцжуулах систем нь дайны сүйтгэлээс үүдсэн орон сууцны гачигдлыг даван туулах нэгэн арга зам байсан бөгөөд Японы эдийн засгийн үсрэнгүй өсөлтийн үед ч их хэмжээний орон сууц барих хөтөлбөрүүд хэрэгжиж, томоохон хотод асар олноороо шилжин ирсэн ажилчид ба тэдний гэр бүлийнхнийг орон сууцжуулсан байна. Энэ үед төрийн удирдлагатай орон сууц барих ажил оргилдоо хүрч жилдээ 100 000 нэгжийг барьж байжээ.

Японы орон сууцны барилгажилтад дорвитой түлхэц өгөх зорилгоор 1966 онд

“Орон сууцны барилга төлөвлөлтийн хууль”-ийг баталж, энэ хуульд үндэслэн Засгийн газраас орон сууцны барилгажилтын хувийн сектор болон төв, орон нутгийн засгийн газруудын барилгын ажлыг бүрэн хамруулсан 5 жилийн хөтөлбөрийг эхлүүлсэн бөгөөд 1966-2000 оны хооронд нийт 8 удаагийн Орон сууц барих 5 жилийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, үр дүнд нь орон сууцны гачигдалтай байдлыг арилгаж, хэрэгцээт тоо хэмжээг бүрэн хангасан байна.

Улмаар нийгэм эдийн засгийн өөрчлөлт, хүн амын насжилт, төрөлт багассан, байгаль орчны асуудал ноцтой ихэссэн зэргээс орон сууцны бодлогыг үндсээр нь өөрчлөх шаардлага бий болж 2006 онд орон сууцны чанар, стандартыг сайжруулах зорилтыг хангахад чиглэсэн “Орон сууцны тухай ерөнхий хууль”(The Basic Act for Housing)-ийг баталсан. Мөн оны 9 дүгээр сард энэ хуулиар үндэслэсэн Засгийн газрын танхимын тогтоол гарч, үндсэн зарим арга хэмжээг биелүүлж, сурталчлах Орон сууцны ерөнхий төлөвлөгөөт хөтөлбөрийг баталсан байна.

Орон сууцны ерөнхий төлөвлөгөөт хөтөлбөрийг нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлын хэтийн төлөвтэй нийцүүлэн 5 жил тутам шинэчлэн боловсруулдаг ба одоогоор Засгийн газрын танхимаас 2016-2025 оны санхүүгийн жил хүртэлх 10 жилийн төлөвлөгөөг баталжээ. Уг хөтөлбөрийн дагуу бүх иргэдийн орон сууцны тав тух, амьдрах орчны стандартыг хангах зорилго бүхий арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

5.1.Зорилтот бүлгийн иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх, нөхцөлийг сайжруулахад төрийн болон орон нутгийн байгууллагуудын оролцоо, эрх үүрэг, санхүүжилтийн тогтолцоо

Япон улсад төрөөс орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх, нөхцөлийг сайжруулахад төрийн болон орон нутгийн байгууллагын оролцооны талаар 1951 онд батлагдсан “Төрийн орон сууцжуулах үйл ажиллагааны тухай хууль¹⁰⁹” (The Publicly-Operated Housing Act)-аар зохицуулж байна. Тус хууль нь 5 бүлэг 54 зүйлтэй. Хуулийн гол зорилго нь улсын болон орон нутгийн захиргаадын орон сууцны нэн шаардлагатай бага орлоготой иргэдийг түрээс багатай, эрүүл ахуй болон амьдрах бүх таатай нөхцөлийг хангасан орон сууцаар хангах үндэслэлийг бий болгож, хүмүүсийн тогтвортой амьдрах нөхцөлийг сайжруулахад дэмжлэг болоход оршино.

Хуульд зааснаар орон нутгийн засгийн газрууд нь өөрсдийн нутаг дэвсгэр дэх орон сууцны нөхцөл байдлыг судлан, орлого багатай иргэдийн орон сууцны гачигдлыг бууруулах шаардлагатай бол тэднийг нийтийн орон сууцаар хангах үүрэгтэй.

Төв засгийн газар нь орон нутгийн засгийн газруудаас хүргүүлсэн хэрэгцээ, шаардлагад үндэслэн “Ерөнхий орон сууцжуулах төлөвлөгөө”-г баталдаг. Хэдийгээр орон сууцны хангамжийн бодлого зэргийг Төв засгийн газар тодорхойлох боловч хэрэгжилтийг үндсэндээ *орон нутгийн засгийн газрууд* нь гүйцэтгэдэг байна.

Хуулийн 3-р зүйлд зааснаар Төв засгийн газраас шаардлагатай гэж үзвэл *орон нутгийн засгийн газруудад* нийтийн орон сууцны хангамжтай холбоотойгоор *санхүү болон техникийн тусламж өгч болно* гэжээ.

Төрийн орон сууцжуулалтын хүрээнд орон нутгийн засгийн газар нь сарын

¹⁰⁹ Төрийн орон сууцжуулах үйл ажиллагааны тухай хууль (The Publicly-Operated Housing Act)

түрээсийн тарифыг оршин суугчийн мэдүүлсэн орлого, сууцны байршил, хэмжээ, насжилт зэрэг олон шалгуур үзүүлэлтүүдийг харгалзан жил бүр тогтооно. Улсын мэдлийн орон сууцаар хангагдах орлогын шалгуурыг орон нутгийн засгийн газраас тогтоох ба өргөдөл гаргагч тэрхүү шалгуурын дагуу өөрийн нөхцөл байдлыг нотлох ёстой. Оршин суугчдыг нийтийн лоттери системээр сонгодог боловч орон сууцны гачигдалтай маш бага орлоготой иргэд, ялангуяа өндөр настан, өрх толгойлсон эцэг, эсхүл эх, тахир дутуу, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тухайн орон нутгийн нөхцөл байдалд тохируулан орон сууцаар хангагчдын зүгээс хүндэтгэн үзэж давуу байдал олгох тохиолдол байдаг.

Хүснэгт 1: Төрийн удирдлагатай орон сууцжуулалтын тойм

Зорилтот бүлэг	Орон сууцны гачигдалтай бага орлоготой иргэд
Насны шалгуур	Байхгүй
Орлогын шалгуур	<ul style="list-style-type: none"> ○ Орлогын төрөл <ul style="list-style-type: none"> • Үндсэндээ орлого 50% (сарын орлогын ¥259,000 нь) –аас бага бол Танхимын тогтоолоор заасан 25% (¥158,000) хэмээх шалгуурыг харгалзан үзэж орон нутгийн засгийн газар нь захирамж гаргана. • Тусгайлсан үндэслэл(өндөр настануудад г.м): Орон нутгийн засгийн газар нь захирамж гаргана. Орлого нь 50% (сарын орлогын ¥259,000 нь) –аас бага бол орон нутгийн засгийн газар нь тусгайлсан үндэслэлд хамаарах орлогын стандартын тухай захирамж гаргана. <p><Түрээсийн тусламжийн болзол></p> <ul style="list-style-type: none"> ○ Орлогын төрөл: 0-40%
Хангах арга	<ul style="list-style-type: none"> ○ Орон нутгийн засгийн газраас барих; ○ Хувийн секторынхан барьж, орон нутгийн засгийн газраас худалдаж авах, эсхүл түрээслэх.
Орон сууц сайжруулах өртөг	<ul style="list-style-type: none"> ○ Барилгын өртгийг оруулаад нийтийн орон сууцжуулах төслийн өртгийг тэр мэт төслийн өртөгийн тухай ерөнхий дүрмийн ½ дагуу (нийгмийн капиталыг сайжруулах ерөнхий тэтгэлэг, г.м-ийн тохиолдолд) тэтгэмж-тусламжийг бодох аргачлалаар тооцож орон нутгийн засгийн газарт олгоно.
Түрээс	Түрээсийн хэмжээ нь оршин суугчийн орлого, байршил, байрны хэмжээ зэргээс хамаарна. (Түрээсийн төлбөрийг бууруулах талаар төв засгийн газраас орон нутгийн засгийн газарт тэтгэлэг олгодог.)

Төрийн удирдлагатай орон сууцны барилгын ажлын эхний үед орон сууцны бирж байгуулагдсан ба энэ нь орон сууцжуулах нэгдсэн сүлжээг бий болгоход чухал ач холбогдолтой төсөл байсан. Орон сууцны биржийг бүс нутгийн онцлог шинжүүдэд тохирсон арга замаар ашигладаг.

Сүүлийн жилүүдэд гарч ирсэн бас нэгэн чухал зорилт бол өндөр настан болон тахир дутуу иргэдэд ээлтэй, таатай орчин нөхцөл бүхий тусгай орон сууцны төсөл юм. Үүнд: орон сууц барих болон түрээслэхдээ шатны бариул, хашлагыг суулгаж, явах замыг тэгш болгох зэрэг стандартыг тавих бөгөөд энэ нь бүс нутгийн орон сууцны төлөвлөгөөнд тусгалаа олсон байдаг. Эдгээр бодлогуудын дагуу орон сууцжуулах ажил системтэй сайжран шинэчлэгдсэн байна.

Хуулийн 13-р зүйлд зааснаар төрөөс орон сууц барих, худалдан авах, эсхүл газрын хамтарсан байгууламжийн барилгын ажил худалдан авах, нийтийн орон сууцны газрыг худалдан авах, эсхүл газар чөлөөлөх зэрэг орон нутгийн бонд шаардагдах зардлыг урт хугацаат сангаас дүрэм журмын хүрээнд хэлэлцэн тохиролцож болохоор зохицуулжээ.

2000 оноос орон сууцны зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, орон сууцны үнэт цаасанд урт хугацаат сангууд хөрөнгө оруулалт хийснээр богино хугацаат хадгаламж татдаг хадгаламжийн байгууллагуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэлийг бууруулах, орон сууцны зээл дэх төрийн оролцоог багасгах улмаар орон сууцны зах зээл нь өөрөө өөрийгөө санхүүжүүлэх нөхцөл бүрдсэн байна.

5.2. Төрийн болон орон нутгийн өмчийн түрээсийн орон сууцны сан бүрдүүлэх, сангийн үйл ажиллагаа, харилцааг зохицуулах.


Япон улсад төрийн болон орон нутгийн өмчийн түрээсийн орон сууцны хангамжийн асуудлыг 2007 оны 7 дугаар сард батлагдсан “Орон сууцны гачигдалтай иргэдийг түрээсийн байраар хангах явдлыг дэмжих тухай хууль” -аар зохицуулж байна. Тус хуулийн гол зорилго нь өндөр настан болон олон хүүхэдтэй бага орлоготой иргэдийг тогтвортой орон сууцаар хангах явдлыг баталгаажуулахад оршино. Хуульд “орон сууцны схем” (орон сууц нэн шаардлагатай иргэдийн хэрэгцээний)-ийг ашиглах, улсын мэдлийн орон сууцны ашиглалт, менежментийг идэвхжүүлэх болон бусад арга хэмжээг авч өнөөгийн орон сууцны нөөцийг үр дүнтэй ашиглах явдлыг дэмжих хууль, эрх зүйн үндэслэлүүдийг бий болгосон. Мөн орон сууцны уян хатан, баталгаат сүлжээ үүсгэн байгуулахыг дэмжих чухал ач холбогдолтой юм. Энэ сүлжээ нь бүс нутгийн нөхцөл байдалд нийцсэн, хувийн сектор нь нийтийн орон сууцаар хангахад туслах, өндөр настан болон олон хүүхэдтэй, бага орлоготой иргэдийг түрээсийн байраар хангах мэдээллийн системийг сайжруулахад чиглэсэн байна.

Орон сууцжуулах сүлжээ үйл ажиллагааг хувийн түрээсийн болон сул орон сууцыг ашиглах замаар өргөжүүлэх үүднээс 2017 оны 4 дүгээр сард “Орон сууц нэн шаардлагатай иргэдэд түрээсээр орон сууц олгох ажлыг дэмжих тухай хуулийг хэсэгчлэн шинэчилжээ. Үүний дагуу орон сууцны гачигдалтай тусгай нөхцөл шаардлагатай хүмүүсийг орон сууцжуулах зорилготой түрээсийн орон сууцны бүртгэлийн систем байгуулах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.

Шинэ орон сууцны баталгаат сүлжээ нь 3 гол хөтөлбөрөөс бүрдэнэ. Үүнд:

1. Орон сууцжуулахад онцгой анхаарах ёстой хүмүүст (тусгай нөхцөл шаардлагатай) зориулсан Түрээсийн орон сууцны бүртгэлийн систем;
2. Бүртгэгдсэн түрээсийн орон сууцанд засвар хийхэд оршин суугчдад санхүүгийн тусламж үзүүлэх;
3. Орон сууцжуулахад онцгой анхаарах ёстой хүмүүсийг орон сууцаар дэмжих.

Шинэ орон сууцны сүлжээний системийн зураглал



- 1) *Орон сууцжуулахад онцгой анхаарах (тусгай нөхцөл шаардлагатай) ёстой хүмүүст зориулсан Түрээсийн орон сууцны бүртгэлийн систем*

Энэ систем нь түрээслэх орон сууцаа орон нутгийн болон хотын захиргаадад бүртгүүлэхийг хүссэн түрээслэгчдэд зориулсан бөгөөд бүртгэлд хамрагдсан орон сууцнуудад зорилтот бүлгийн иргэдийг оруулахад эзэд нь татгалзах ёсгүй байдаг байна. Орон нутгийн засгийн газраас орон сууц түрээслэх хүсэлтэй иргэдэд бүртгэлтэй орон сууцны талаар мэдээлэл өгөх ба энэхүү мэдээлэлд үндэслэн тэдгээр иргэд түрээсийн байранд орох өргөдөл хүсэлтээ гаргадаг байна.

- 2) *Бүртгэгдсэн түрээсийн орон сууцанд засвар хийхэд оршин суугчдад санхүүгийн тусламж үзүүлэх*

Энэхүү шинэ хөтөлбөрт бүртгэгдсэн орон сууцны засвар болон оршин суугчийн төлбөрийн ачааг багасгахтай холбоотой зардлын тухайд санхүүгийн тусламж үзүүлэх үйл ажиллагаа багтана. Үүнд: байрны нийтийн эзэмшил хэсэгт засвар хийх, газар хөдлөлтийн улмаас үүссэн эвдрэл сүйтгэлийн засвар, байрны зорчих хэсгийг элдэв саадгүй болгох засвар зэрэг багтана. Эдгээр өөрчлөлт засваруудыг гагцхүү тусгай орон сууцны нөхцөл шаардлагатай (тахир дутуу, хөгжлийн бэрхшээлтэй, өндөр настан гэх мэт) иргэдэд зориулж хийдэг. Хэдийгээр Төв болон орон нутгийн засгийн газрууд хамтдаа дэмжих боловч эхэн үед нь Төв засгийн газраас операторуудад шууд тусалдаг. Үүнээс гадна Японы Орон сууцны санхүүжилтийн агентлаг нь гэрээ байгуулагч талуудын засварын зардалд санхүүжилт олгоно.

Бүртгэгдсэн түрээсийн орон сууцны оршин суугчдад санхүүгийн тусламж үзүүлэх хөтөлбөр нь байрны бага түрээстэй байлгах ба байрны түрээсийн даатгалын төлбөр төлөх зэрэг хэлбэрүүдээр тусална. Бага орлоготой хүмүүст дэмжлэг үзүүлэх тухайд төв болон орон нутгийн засгийн газрууд хамтран ажилладаг. Бүртгэлтэй түрээсийн орон сууцны түрээслэгчийн орон сууцны түрээсийг бага байлгах тусламжийн тухайд сард хамгийн ихдээ 40,000 йений тэтгэмж өгнө. Нөхцөл байдлаас шалтгаалан бага зэргийн ялгаатай байж болно. Энэхүү тэтгэмжийн хугацаа ихдээ 10 жил байх ба тэтгэлгийн хэрэгцээ шаардлагыг 3 жил тутамд үнэлэн дүгнэж үзнэ. Бага түрээсийн даатгалын тусламжийн тухайд бүртгэлтэй даатгагчаас, эсхүл орон сууцжуулалтыг дэмжих хуулийн этгээдээс ихдээ 60,000 йений тусламж өгнө. Энэ нь тухайлсан нөхцөл байдлаас шалтгаалан бага зэргийн ялгаатай байж

болдог. Мөнгөн тэтгэмж нь зөвхөн түрээслэгчийн байр түрээслэх хугацааны түрээсийн баталгаа бөгөөд үүнд оролцогч талууд оршин суугчаас хамтран гарын үсэг зурагч шаардахгүй байх нөхцөлтэй. Хоёр зүйл мөнгөн тэтгэмжийн аль алийг нь авах боломжтой ч нийт дүн хэмжээгээрээ нэг жилд 480,000 йенээс хэтрэхгүй байх ёстой.

3) *Орон сууцжуулахад онцгой анхаарах ёстой (тусгай нөхцөл шаардлагатай) хүмүүсийг орон сууцаар дэмжих.*

Шинэ системийн дагуу орон сууцжуулах ажилд туслах Ашгийн төлөө бус байгууллагуудыг томилох боломжийг бүрдүүлж өгсөн. Эдгээр байгууллагууд Орон сууцжуулах ажлыг дэмжих хуулийн этгээд болж ажиллах бөгөөд ингэхдээ тусгай нөхцөл шаардлагатай орон сууцны хэрэгцээтэй хүмүүсийг мэдээллээр хангах, зөвлөн туслах зэрэг ажлуудыг хийнэ. Орон сууцны түрээсийн баталгаа даатгалын бизнесийн тухайд шаардлага хангахуйц хуулийн этгээдүүдийг бүртгэх улсын бүртгэлийн систем байгуулагдсан ба, тухайн засгийн газар нь даатгалын бизнесийг зохистой зөв эрхлэн явуулж чадах хуулийн этгээдийг бүртгэн авдаг байна. Цаашилбал, энэ хөтөлбөр нь бүртгэлтэй баталгаа, даатгалаар хангагч болон орон сууцжуулалтыг дэмжигч хуулийн этгээдүүдэд өөрсдийн гаргасан түрээсийн даатгалыг Японы Орон сууцны санхүүжилтийн агентлагаар даатгуулан баталгаажуулах боломжийг олгосон байдаг.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Р., Сабирджанов Ф., (2011), Зарубежный опыт финансового обеспечения жилищной политики, *Вестник Саратовского государственного социально-экономического университета*, issue 4, p.127-131, <https://EconPapers.repec.org/RePEc:scn:009938:14843890>.
- Housing finance agencies in Asia, Appendix 5, US housing agencies: Historical background, p.19, Monetary and Economic Department December 2007, BIS Working Papers No 241 <https://www.bis.org/publ/work241.pdf>
- G.Thomas Kingsey, Trends in Housing Problems and Federal Housing Assistance, October 2017, Urban Institute, Metropolitan Housing and Community Policy Center <https://www.urban.org/sites/default/files/publication/94146/trends-in-housing-problems-and-federal-housing-assistance.pdf>
- <https://www.ncsha.org/about-us/>
- “Конституция РФ” (принята всенародным голосованием 12.12.1993).
- “Жилищный кодекс Российской Федерации” от 29.12.2004 N 188-ФЗ (ред. от 03.08.2018)
- Федеральный закон от 24 июля 2008 года N 161-ФЗ “О содействии развитию жилищного строительства”.
- Федеральный закон “О содействии развитию и повышению эффективности управления в жилищной сфере и о внесении изменений в отдельные законодательные акты Российской Федерации” от 13.07.2015 N 225-ФЗ.
- Распоряжение Правительства РФ от 17.11.2008 N 1662-р (ред. от 28.09.2018) “О Концепции долгосрочного социально-экономического развития Российской Федерации на период до 2020 года”.
- Постановление Правительства РФ от 26 августа 1996 г. N 1010 “Об Агентстве по ипотечному жилищному кредитованию”.
- Постановление Правительство РФ от 05.06.2008 г. №432 “О Федеральном агентстве по управлению государственным имуществом”.
- Постановление Правительства РФ от 17 декабря 2010 г. N 1050 “О реализации отдельных мероприятий государственной программы Российской Федерации. Федеральная целевая программа “Жилище” на 2011-2015 годы
- Постановление Правительства РФ от 25 августа 2015 г. N 889 “О внесении изменений в постановление Правительства РФ от 17 декабря 2010 г. N 1050”. Эх сурвалж:
- “Стратегия развития жилищной сферы Российской Федерации на период до 2025 года”. Минстрой России, Дом РФ.
- Стратегией развития единого института развития в жилищной сфере на период 2016–2020 гг., утвержденной Наблюдательным советом 26 февраля 2016 года.
- Годовой отчет АО «ДОМ.РФ» - 2017.
- “Орон сууц” ХК-ийн цахим хуудас: <https://дом.рф>
- “Оросын капитал” банкны цахим хуудас: <https://rkbank.ru/about/>

2 БҮЛЭГ

НИЙГЭМ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ХҮҮХДИЙН ЭРХ ХАМГААЛЛЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ТОГТОЛЦОО БА ХЭРЭГЖҮҮЛЭХ МЕХАНИЗМЫН ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

(Харьцуулсан судалгаа)

Г.Билгээ, О.Нарантуяа, Р.Нургүл

АГУУЛГА

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Хүүхдийн эрх хамгааллын эрх зүйн орчин, тогтолцоо ба хэрэгжүүлэх механизмын талаарх гадаадын зарим орны туршлага

Нэг. Бүгд Найрамдах Солонгос Улс

- 1.1. Эрх зүйн орчин
- 1.2. Хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын тогтолцоо
- 1.3. Хүүхдийн эрхийн өнөөгийн байдал, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ
- 1.4. НҮБ-ын Хүүхдийн хорооноос өгсөн зөвлөмж

Хоёр. Оросын Холбооны Улс

- 2.1. Эрх зүйн орчин
- 2.2. Хүүхдийн эрхийг хамгаалах байгууллагууд

Гурав. Австралийн Холбооны Улс

- 3.1. Хүүхэд хамгаалах тухай хууль тогтоомжууд
- 3.2. Хүүхдийн төлөө ажилладаг байгууллагуудын тогтолцоо

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

УИХ.МН
СУДАЛГААНЫ САН

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Энэхүү судалгаанд БНСУ, ОХУ болон Австрали улсуудын хүүхдийн эрх хамгааллын асуудлыг зохицуулж буй хууль тогтоомж, хүүхдийн эрхийг хамгаалах байгууллага болон хүүхдийн эрхийн өнөөгийн байдал, эдгээр улсын Засгийн газарт олон улсын байгууллагаас өгсөн санал, зөвлөмж зэргийг хамруулсан ба судалгаа, мэдээллийг тухайн орны холбогдох хууль тогтоомж, судалгааны мэдээлэл болон холбогдох байгууллагуудын тайлан, мэдээлэлд үндэслэн бэлтгэв.

Олон улсын туршлагаас үзэхэд, БНСУ нь Хүүхдийн эрхийн асуудлыг Үндсэн хууль, Иргэний хууль, Хөдөлмөрийн хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Залуучуудын халамжийн тухай хууль, Сураггүй алга болсон хүүхдийг хамгаалах, дэмжих тухай хууль, Ганц бие эцэг, эхийн гэр бүлийг дэмжих тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн халамжийн тухай хууль, Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль зэрэг гол гол хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан эрх зүйн бусад акт, хөтөлбөр, төлөвлөгөөгөөр зохицуулж байна.

Хүүхдийн эрх хамгаалах тогтолцооны хувьд БНСУ-д Хүүхдийн эрхийг хамгаалах хүрээнд Хүний эрхийн үндэсний комисс болон түүний дотор Хүүхдийн эрхийн хороо, Хүүхдийн бодлого зохицуулалтын хороо, Хүүхдийн эрхийг хамгаалах алба, Хүүхдийн эрхийг хамгаалах агентлаг гэсэн томоохон байгууллагууд хариуцан ажилладаг байна. Эдгээр байгууллагууд нь төв болон орон нутгийн захиргааны байгууллагууд, салбар нэгжүүдээр дамжуулан чиг үүргээ хэрэгжүүлдэг.

Хүүхдийн эрхийг хангах, хамгаалах асуудалд БНСУ-д төрөөс ихээхэн анхаарал хандуулан ажиллаж байгаа бөгөөд шаардлагатай хууль тогтоомжуудыг батлан гаргаж, зохицуулалтыг боловсронгуй болгох арга хэмжээ авч байна. Судалгаанд хүүхдийн эрхийг хангах, хамгаалах хүрээнд БНСУ-д хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаа, хэрэгжилтийн өнөөгийн байдлын талаарх мэдээлэл, лавлагааг Хүүхдийн эрхийн тухай конвенцын хүрээнд асуудал тус бүрээр тоймлон гаргасан. Үүнд: Иргэний эрх, эрх чөлөөний хүрээнд- үл ялгаварлах, эсэн мэнд амьдрах, хөгжих эрх, Хүүхдийн эрхийн хүчирхийлэлтэй тэмцэх хүрээнд - бие махбодын шийтгэл болон хүүхдийн хүчирхийлэл, Гэрийн бүлийн орчин, Хүүхдийн тусламж үйлчилгээний хүрээнд - хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон донтолтоос урьдчилан сэргийлэх, Боловсрол, соёл, чөлөөт цагийн арга хэмжээ, Тусгай хамгааллын арга хэмжээний талаар тусгасан.

БНСУ нь НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцын 5, 6 дугаар илтгэлээ 2018 оны 2 дугаар сард НҮБ-ын Хүүхдийн хороонд хүргүүлсэн байна. Тус улсын Засгийн газраас хүүхдийн эрхийн тухай конвенцын хэрэгжилтийг хангах хүрээнд хүчин чармайлт гаргаж буй улсын нэг юм.

ОХУ-ын туршлагаас үзэхэд, тус улс нь Хүүхдийн эрхийн тухай конвенцын оролцогч улсуудын хүлээсэн үүргийн дагуу шаардлагатай хууль тогтоомжийг батлан гаргах, захиргааны болон бусад бүх арга хэмжээг авах хүрээнд 1993 оноос хойш гэр бүл, хүүхэд хамгааллын чиглэлээр 200 гаруй холбооны хууль, ОХУ-ын Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол баталсан ба эдгээр нь гэр бүл, хүүхдийн нийгмийн хамгааллын арга хэмжээг бэхжүүлэхэд чиглэсэн байна. Мөн ОХУ-ын 25 субъектүүд бүрэн эрхийнхээ хүрээнд хүүхэд хамгааллыг дэмжих хууль, эрх зүйн актуудыг батлан гаргана.

Тус улсын нийгмийн бүхий л салбарт өөр өөрсдийн чиг үүргийнхээ хүрээнд хүүхдийн эрхийг хамгаалах механизмыг бүрдүүлэн ажиллаж байна. Тэдгээрээс нийтлэг эрхийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудыг дурдвал, тус улсын Прокурорын байгууллага нь хүүхдийн эрхийн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, Хүүхдийн эрхийг хамгаалах хороо нь хүүхдийн эрх ашгийг цогцоор хамгаалах ба Хүүхдийн эрхийн омбудсмен нь энэ чиглэлд хяналт тавих нэмэлт механизм болсон.

Австрали Улсад муж болон харьяа газар нутгийн засаг захиргаа нь хүүхэд хамгаалах үйлчилгээг зохион байгуулж хэрэгжүүлэх үүрэгтэй. Үүнийг муж болон харьяа газар нутгийн хууль тогтоомжуудаар зохицуулж, хэрэгжилтийг хангуулж байна. Муж болон харьяа газар нутгуудад мөрдөгдөж буй гол хуулиудыг нэрлэвэл:

- *Австралийн нийслэлийн бүс нутагт* - Хүүхэд, залуучуудын тухай хууль;
- *Шинэ Өмнөд Уэльст* - Хүүхэд, залуучуудын (Асрах болон хамгаалах) тухай хууль;
- *Хойд бүс нутагт* - Хүүхдийг асран хамгаалах тухай хууль;
- *Күйнсландад* - Хүүхэд хамгаалах тухай хууль;
- *Өмнөд Австралид* - Хүүхэд хамгаалах тухай хууль;
- *Тасманид* - Хүүхэд, залуучууд болон гэр бүлийн тухай хууль;
- *Виктори мужид* - Хүүхэд, залуучууд болон гэр бүлийн тухай хууль;
- *Баруун Австралид* - Хүүхдийн болон нийгмийн үйлчилгээний тухай хуулиудаар зохицуулж байна.

Хүүхэд хамгаалах тухай хууль тогтоомж нь муж болон харьяа газар нутаг бүрийн хувьд харилцан адилгүй байгаа нь тухайн газар нутгийн онцлог, хэрэгцээ шаардлагатай холбоотой юм.

Австрали Улс нь НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцын үндсэн зарчмуудыг хүүхэд хамгаалалтай холбоотой хууль тогтоомжид тусгаж өгсөнөөс гадна Хамтын нөхөрлөлийн (*Commonwealth*) Гэр бүлийн тухай хууль, Австралийн Хүний эрхийн Комиссын тухай хуулиудын үндсэн зарчмуудыг муж болон харьяа газар нутгийн хуулиудад тусгасан байдгаараа онцлогтой.

Эдгээр хууль тогтоомжийн хүрээнд гэрээс гадуур үзүүлэх асрамжийн үйлчилгээ (*out-of-home care*), асрах байгууллагад амьдарч байсан хүүхдэд насанд хүрснийх нь дараа үзүүлэх дэмжлэг, тусламжийн үйлчилгээг тасралтгүй төлөвлөх, тогтмол хүргэх, гэмт хэрэгт холбогдсон хүүхэд, залуучуудын хэргийг шүүх хянан хэлэлцэх, бэлгийн хүчирхийлэлд холбогдсон гэмт хэрэгтнийг бүртгэх болон мэдээллэх, хүүхэдтэй тулж ажиллах, гэр бүл болон хүүхэд асрамжийн үйлчилгээ, гэр бүл болон гэр бүлийн хүчирхийлэл, олон улсын орчинд хүүхэд хамгаалах, хүүхэд үрчлэх болон асран хамгаалах, хүүхдийн комиссар, асран хамгаалагч, өмгөөлөгчийн тухай, хүүхдийн хөдөлмөр эрхлэлттэй холбоотой харилцаануудыг зохицуулж байна.

Австрали улс нь хүүхдийн эрх хамгаалах тогтолцоо, төрийн болон төрийн бус байгууллагуудын зүгээс хүүхдэд үзүүлж буй дэмжлэг тусламжааны хувьд дэлхийд тэргүүлэх байр суурьтай байгаа бөгөөд хүүхдийн аюулгүй байдал, сайн сайхан байдлыг хангахад ихээхэн анхаардаг жишиг болохуйц сайн туршлагатай орнуудын нэг юм.

**ХҮҮХДИЙН ЭРХ ХАМГААЛЛЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН,
ТОГТОЛЦОО БА ХЭРЭГЖҮҮЛЭХ МЕХАНИЗМЫН ТАЛААРХ
ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА**

Нэг. БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС

БНСУ нь Үндсэн хуулиар тунхагласан хүний эрх, эрх чөлөө ялангуяа хүүхдийн эрх ашгийг дээд зэргээр хангах зорилтын хүрээнд хүүхдийн эрхийг хангах, хамгаалах хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хууль тогтоомжоор хамгаалагдсан хүүхдийн эрхийг эдлүүлэхэд онцгой анхаарахын зэрэгцээ НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцыг хэрэгжүүлэх чиглэлээр ихээхэн хүчин чармайлт гарган ажиллаж байна.

БНСУ нь 1991 онд Хүүхдийн эрхийн тухай конвенцод нэгдэн орсон бөгөөд 2018 оны 2 дугаар сард Хүүхдийн эрхийн конвенцын хэрэгжилтийн 5,6 дугаар тайланг НҮБ-ын Хүүхдийн хороонд хүргүүлээд байна. НҮБ-ын Хүүхдийн хорооны санал, зөвлөмж болон нийгмийн хөгжлийн явцад үүсч буй хүүхдийн эрхтэй холбоотой харилцааг зохицуулах, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хүүхдийн эрхийг зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтэд анхааран ажиллаж байна.

2003 онд хүүхдийн эрхийн түвшин, төлөв байдлыг тодорхойлох судалгааг хийж Солонгос улсын хүүхдийн талаарх мэдээллийн суурь баазыг бүрдүүлсэн. Энэхүү судалгааг түшиглэн хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, шаардлагатай хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулахад суурь судалгаа болгон ашиглаж байна. Одоогийн байдлаар:

- Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамнаас 2015 оны 9 сард “Хүүхдийн бодлогын үндсэн төлөвлөгөө-1”-ийг /2015-2019 он/ боловсруулсан бөгөөд үүнээс Хүүхдийн эрхийн конвенцыг хэрэгжүүлэхэд нэн тэргүүний ач холбогдолтой 158 бодлогын зорилтыг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

- Жендерийн тэгш байдал, гэр бүлийн яамнаас залуучуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг 5 жил тутам боловсруулж байгаа бөгөөд одоо 5 дахь Залуучуудын бодлогын төлөвлөгөө /2013-2017/-г хэрэгжүүлж байна.

- Хууль зүйн яам нь 3 дахь удаагийн Хүний эрхийн бодлогын үндсэн төлөвлөгөө /2017-2021/-г боловсруулаад байна.

Засгийн газраас бүх хүүхдэд зориулсан боловсрол, нийгмийн халамж, хамгаалал болон өсвөр үеийнхэнд зориулсан төсвийг өргөжүүлэх, мөн бэлгийн хүчирхийлэл, түүний хохирогчдод дэмжлэг тусалцаа үзүүлэх төсвийг нэмэгдүүлэх бодлого баримталж байна.

Сүүлийн 5 жилийн хугацаанд хууль тогтоомжийг боловсронгуй болгох хүрээнд хүчирхийлэлд өртсөн хүүхдэд зориулсан боловсролын асуудал, хохирогчдын хэргийг шийдвэрлэх, хүүхэд, залуучуудын соёл, урлаг, спортыг дэмжих асуудлаар хууль тогтоомжууд болон Иргэний хуульд өөрчлөлт оруулж Ази тивд анх удаа дүрвэгсдийн бие даасан байдал, хууль эрх зүйн тусалцаа үзүүлэх асуудлыг тусгайлан зохицуулалт хийсэн анхны улс болсон.

Түүнчлэн гэр бүл салалтын дараа хүүхдийн амьдралын тогтвортой байдлыг хамгаалах, дэмжлэг үзүүлэхтэй холбоотой асуудлыг боловсронгуй болгох асуудалд анхааран ажиллаж байна. Тухайлбал: 2011, 2014 онд ганц бие эцэг, эхчүүдийн суралцах эрхийг хамгаалах, бие даасан байдлыг нь дэмжих зорилгоор ганц бие эцэг, эхийн гэр бүлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж ганц бие эцэг, эхийн боловсролын зардлыг санхүүжүүлэх, итгэмжлэгдсэн боловсролын байгууллагуудад дадлагажиж ур чадвар эзэмших болон орон сууцтай болоход дэмжлэг туслалцаа, хөнгөлөлт үзүүлэх зэргээр бие даасан байдалд шаардлагатай санхүүгийн дэмжлэгийг үзүүлж эхэлсэн.

1.1.ЭРХ ЗҮЙН ОРЧИН

1) Үндсэн хууль

Үндсэн хуулийн Хоёрдугаар бүлгийн 31 дүгээр зүйлд иргэн бүр сурч боловсрох тэгш эрхтэй бөгөөд бага сургуулийн боловсролыг үнэ төлбөргүй олгоно гэж заасан. Мөн иргэн бүр хүүхэддээ бага боловсролыг заавал эзэмшүүлэх үүрэгтэй. Түүнчлэн насанд хүрээгүй хүүхдийн хөдөлмөрлөхтэй холбоотой харилцааг тусгайлсан хуулиар зохицуулахаар тус тус заасан байна.

2) Иргэний хууль

Иргэний хуулийн 4 дэх дэд хэсэгт Эцэг, эх ба хүүхэдтэй холбоотой харилцааг зохицуулж өгсөн. Тус хэсэгт Төрүүлсэн хүүхэд, үрчлэлт, өргөмөл хүүхдийн талаар, асран тэтгэх эрх үүрэг, асран хамгаалагч, төрөл садангийн талаар нарийвчлан зохицуулсан. Мөн дүрвэгсдийн асуудлыг тусгайлан зохицуулсан.

3) Хөдөлмөрийн хууль

Хөдөлмөрийн хуулийн 5 дугаар бүлэгт Эмэгтэй хүн ба хүүхдийн хөдөлмөрийн харилцааг зохицуулж өгсөн. Тус хуульд зааснаар 15 нас хүрээгүй хүүхдийг /дунд сургуульд суралцаж буй 18 нас хүртлэх этгээд/ ажилтнаар авч ажиллуулах, хүнд хортой нөхцөлд ажиллуулахыг хориглосон. Насанд хүрээгүй этгээдийг авч ажиллуулахдаа эцэг, эх, асран хамгаалагчийн зөвшөөрлийг авсан байна. 15-18 насны ажилтны ажиллах цаг нэг өдөрт 7 цаг, 1 долоо хоногт 40 цагаас хэтрэхгүй байна. Хэрэв талууд тохиролцсон бол өдөрт 1 цаг, 1 долоо хоногт 6 цагаар уртасган ажиллаж болно. 18 насанд хүрээгүй ажилтныг 22 цагаас 06 цаг хүртэл ажиллуулах, уурхай ба цооногт ажиллуулахыг хориглосон.

4) Хүүхэд хамгааллын тухай хууль

Тус хууль нь 1997 онд батлагдаж 1998 оны 1 дүгээр сарын 1-ээс эхлэн дагаж мөрдсөн. Тус хуулийн зорилго нь хүүхдийг эрүүл, аюулгүй орчинд өсч торних нөхцөлийг бүрдүүлэх, аз жаргалтай амьдрах боломжоор хангахад оршино гэж хуулийн 1 дүгээр зүйлд заасан.

Хүүхэд гэж 18 насанд хүрээгүй этгээд гэж тодорхойлсон байна. Тус хуулиар төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагын үүргийг тодорхой зааж өгсөн. Тухайлбал, хүүхдийн аюулгүй байдал, эрүүл мэнд, амьжиргааг дэмжих зорилгоор хүүхэд, тэдний гэр бүлийг дэмжих бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх, хүүхдийн сурч боловсрох эрхийг хамгаалах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрх ашгийг хамгаалах,

шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх, Хүүхдийн эрхийн тухай конвенцыг хэрэгжүүлэх үүргүүдийг нарийвчлан заасан байна.

Хүүхэд хамгааллын тухай хуульд хүүхдийн эрх, эрүүл мэнд, өсөлтийг дэмжсэн хүүхдийн хөгжлийн цогц бодлого боловсруулах, бодлогын хэрэгжилтийг хангах, хянах, үнэлэх үүрэг бүхий Ерөнхий сайдаар ахлуулсан Хүүхдийн бодлого зохицуулалтын хороотой байхаар заасан. Мөн хот, муж, дүүрэг бүрт хүүхдийн асуудал хариуцсан төрийн албан хаагчдаас бүрдсэн хүүхдийн хороо ажиллана. Хот, муж, дүүргийн Засаг дарга нь хүүхдийн халамжийн болон хамгаалалтын арга хэмжээ авч ажиллана.

Нийт иргэн, байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан нь хүүхдийн эсрэг дараах үйлдэл хийхийг хориглосон. Үүнд:

- хүүхэд худалдах, худалдан авах;
- хүүхдийн бэлгийн дарамт болон бэлгийн хүчирхийлэл;
- хүүхдийн биед гэмтэл учруулж, бие махбод, эрүүл мэнд, хөгжилд хохирол учруулах биеийн хүчирхийлэл;
- хүүхдийн оюун санааны эрүүл мэнд, хөгжилд сөргөөр нөлөөлж буй сэтгэл санааны дарамт;
- өөрийнхөө асрамж, хамгаалалтад байгаа хүүхдийг хамгаалах, асрах, эрүүл мэнд, боловсрол, хоол хүнсийг үл тоомсорлох;
- хүүхдээр гуйлга гуйлгах;
- хандив тусламжийн хөрөнгийг зориулалтын бусаар ашиглахыг тус тус хориглосон.

Хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, хүүхдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, түүнд анхаарал хандуулах зорилгоор жил бүрийн 11 дүгээр сарын 19-ний өдрийг хүүхдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх өдөр гэж тэмдэглэдэг.

Хүчирхийлэлд өртсөн хүүхэд гэртээ очсоны дараа хүүхэд дахин хүчирхийлэлд өртөж буй эсэхэд хяналт тавьж гэрт нь очих, утсаар зөвлөгөө өгөх зэргээр тусламж үйлчилгээ үзүүлдэг. Мөн хохирогчийн гэр бүл, асран хамгаалагч нь хүүхдийн хүчирхийлэл давтан үйлдэхээс урьдчилан сэргийлэх, шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хариуцуулсан.

Хүүхдийн эсрэг хүчирхийллийн мэдээллийн системийг Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд эрхлэн хариуцдаг. Энэхүү мэдээллийн системд хохирогч, түүний гэр бүл болон хүүхдийн эрхийг зөрчсөн этгээдийн талаарх мэдээллийг оруулах бөгөөд системээс мэдээлэл авах тохиолдолд Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдаас зөвшөөрөл авна.

Төрийн холбогдох байгууллагаас шаардлагатай гэж үзвэл дараах тохиолдолд хүүхэд асран хамгаалах үйл ажиллагаа явуулна:

- бие махбодын эрүүл мэндийг дэмжих;
- амиа хорлох, төрөл бүрийн донтохоос урьдчилан сэргийлэх зэрэг сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих;
- хоол тэжээлийн дэмжлэг, хоол тэжээлийн дутагдлыг сайжруулах;
- таргалалтаас урьдчилан сэргийлэх зорилгоор бие бялдрыг хөгжүүлэх, дэмжих.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 52 дугаар зүйлд заасны дагуу хамгаалах үйл ажиллагааг дараах байгууламжид хэрэгжүүлнэ:

- *Хүүхэд асрах байгууламж* - хүүхдийг хамгаалалтаар хангах замаар хамгаалалт, халамж, хөдөлмөр эрхлэлтийн сургалт, бие даах чадварыг дэмжих үйлчилгээ үзүүлэх;
- *Хүүхдийг түр хугацаагаар хамгаалах байгууламж* - хамгаалалтад авсан хүүхдийг түр хугацаагаар хамгаалах арга хэмжээ авах;
- *Хүүхэд хамгааллын тусламж үйлчилгээний байгууламж* - хүүхэд хамгаалах болон эмчилгээ үйлчилгээ үзүүлэх зорилготой. Эцэг, эх, асран хамгаалагчаас хүчирхийлэлд өртсөнөөс үүдэлтэй сэтгэл санааны болон зан үйлийн бэрхшээлтэй болсон хүүхдүүдэд тусламж үзүүлэх;
- *Нийгэмшүүлэх байр* - хамгаалагдсан хүүхдийг хамгаалах, хүмүүжүүлэх, бие даах чадварыг дэмжих үйлчилгээ үзүүлэх;
- *Өөртөө туслах байгууллага* - хүүхэд хамгаалах байрнаас гарсан тохиолдолд ажилд ороход бэлтгэх болон ажилд орсны дараа хөтөлбөрийн хугацаанд хамгаалж бие даахад нь дэмжлэг үзүүлэх;
- *Хүүхдэд зөвлөгөө өгөх төв* - Хүүхэд болон тэдний гэр бүлийхэнд зөвлөгөө өгөх, эмчлэх, урьдчилан сэргийлэх, судалгаа хийх;
- *Хүүхдэд зориулсан байгууламж* - Хүүхдийн цэцэрлэгт хүрээлэн, хүүхдийн тоглоомын талбай, хүүхдийн төв, спорт, театр, кино, шинжлэх ухааны туршилт, хүүхдийн амралтын газар, зуслангийн газар гэх мэт нийгмийн халамжийг дэмжихэд шаардлагатай үйлчилгээ үзүүлэх;
- *Орон нутгийн хүүхдийн төв* - Орон нутгийн хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсролыг дээшлүүлэх;
- Хүүхдийн эрхийг хамгаалах газар зэрэг хүүхэд хамгааллын газрууд ажиллахаар хуульчилсан байна.

5) Залуучуудын халамжийн хууль

Энэ хууль нь 2003 онд батлагдсан. Залуучуудыг эрүүл, зохистой амьдралаар амьдрах, хөгжих нөхцөлийг хангах зорилгоор нийгмийн болон эдийн засгийн дэмжлэг үзүүлэх зорилготой. Өсвөр насныхан энэ хууль тогтоомжийг хэрэгжүүлэхдээ арьс өнгө, шашин шүтлэг, нас хүйс, боловсрол, бие махбодын байдлаар ялгаварлан гадуурхахгүй бөгөөд нийгмийн харилцаанд тэгш оролцох эрхтэй.

Нийгэм, эдийн засгийн дэмжлэг шаардагдах өсвөр үеийнхний хувьд амьдралд зайлшгүй шаарлагатай үндсэн нөхцөлийг бүрдүүлэхэд залуучуудыг тусгайлан дэмжинэ. Мөн энэ хуулиар гэрээсээ явсан залуучуудыг түр зуур хамгаалах байраар хангах, тэднийг нийгэмшихэд дэмжлэг үзүүлэх зорилготой.

6) Залуучуудын үйл ажиллагааг дэмжих хууль

2004 онд батлагдсан тус хуулиар залуучуудын өсөлтийг хангахад чиглэсэн үйл ажиллагаа болон солилцоо, соёлын арга хэмжээнүүдийг дэмжих талаар тусгасан.

Төвийн болон орон нутгийн байгууллагууд нь залуучуудын үйл ажиллагааг дэмжих төвийг байгуулан ажиллуулна. Орон нутгийн Засаг дарга нь залуучуудын сургалтын төв, өсвөр үеийнхний соёлын төв байгуулан ажиллуулах үүрэгтэй. Тус төвүүд нь залуучуудын ур чадвар, зан байдлыг хөгжүүлэх төрөл бүрийн үйл ажиллагаа явуулах бөгөөд уламжлалт соёлыг сурталчлах соёлын арга хэмжээнүүдийг зохион байгуулах ёстой.

7) Биеэ үнэлэхээс урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах хууль

Тус хууль 2004 онд батлагдсан бөгөөд биеэ үнэлэхээс урьдчилан сэргийлэх, бэлгийн мөлжлөгт өртсөн хүмүүсийг хамгаалах, бие даасан байдлыг хангах асуудлыг зохицуулсан. Хохирогчийг хамгаалах, дэмжлэг үзүүлэх төрлүүд, хоол хүнсээр хангах, зөвлөгөө өгөх, эмчлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар мэдээллээр хангах асуудлыг энэ хуулийн хүрээнд хамруулсан.

8) Сураггүй алга болсон хүүхдийг хамгаалах, дэмжих тухай хууль

Сураггүй алга болсон хүүхдийг хамгаалах, дэмжих тухай хууль нь 2005 онд батлагдсан. Сураггүй алга болсон хүүхэд /хулгайлагдсан, уруу татагдсан, хаягдсан болон аваар осолд орсон, гэрээсээ зугатсан, төөрсөн зэрэг асран хамгаалагчаасаа салсан/-ийг хайх, эргэж ирсэн хүүхдийг гэр бүл, нийгмийн халамж үйлчилгээ үзүүлэх, нийгэмшүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой. Тус хуулиар байгууллага, хувь хүмүүсийн үүргийг дараах байдлаар тодорхойлсон:

- Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд нь хүүхдийг сураггүй алга болохоос урьдчилан сэргийлэх бодлогыг хэрэгжүүлэх, сураггүй алга болсон хүүхдийн нөхцөл байдлыг судлах, буцаж ирсний дараа нийгэмд дасан зохицоход дэмжлэг үзүүлэх, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

- Цагдаагийн ажилтан нь алга болсон хүүхдийг хайж олох, илрүүлэх зорилгоор сураггүй алга болсон хүүхдийн тухай мэдээллийн сан үүсгэх, удирдан зохион байгуулах, алга болсон хүүхдийг олж илрүүлэх зорилгоор эрэн сурвалжлах, мөрдөн байцаах, генетикийн шинжилгээ хийх зэрэг ажлуудыг хэрэгжүүлэх ёстой.

- Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд нь чиг үүргийнхээ хүрээнд зарим чиг үүргийг дагнан хариуцах мэргэжлийн байгууллагыг /сураггүй алга болсон хүүхэд/ байгуулж удирдан зохион байгуулах ажлыг нийгмийн халамжийн тухай хуулийн хүрээнд хэрэгжүүлж болно.

- Хамгаалах байрны дарга болон түүний ажилтан нь сураггүй алга болсон хүүхдийн талаар мэддэг бол энэ талаар цагдаагийн ажилтан эсвэл орон нутгийн засаг захиргааны даргад мэдэгдэх ёстой.

- Орон нутгийн захиргааны байгууллагын дарга нь хүүхэдтэй холбоотой хууль тогтоомжийн дагуу хамгаалалтын арга хэмжээ авахдаа шинэ карт бэлтгэж, түүний хуулбарыг мэргэжлийн байгууллагын дарга, хамгаалах байгууллагын даргад явуулах ёстой.

- Аливаа хүүхдийг олж илрүүлэхээс бусад зорилгоор хүүхдийн талаарх мэдээлэл, генетикийн шинжилгээг задруулахыг хориглоно.

9) Ганц бие эцэг, эхийн гэр бүлийг дэмжих тухай хууль

Тус хууль нь ганц бие эцэг, эхийн гэр бүлийг эрүүл, зохистой амьдралаар амьдрахад тусалж, ганц бие эцэг, эхийн аюулгүй байдал, нийгмийн халамжийг нэмэгдүүлэх зорилгоор 2007 онд батлагдсан. Энэ хуульд бэлэвсэрсэн, эхнэр/нөхрөөсөө салсан, сэтгэцийн болон бие махбодын хөгжлийн бэрхшээлээс болж хөдөлмөрийн чадвараа алдсан хүн, гэрлээгүй хүн, ганц бие эцэг, эх /18 хүртэлх насны хүүхэд, сургуульд сурч байгаа бол 22 нас хүрээгүй/ хамрагдана.

Ганц бие эцэг, эхийн тогтвортой, бие даасан байдлыг дэмжих зорилгоор өрхийн аж ахуй болон бизнес эрхлэх, хүүхдийн боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний зардал, орон сууц худалдан авах, бусад шаардлагатай санхүүжилтийг улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлдэг.

10) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн боловсролын тухай хууль

1994 онд батлагдсан Боловсролын тусгай хөтөлбөрөөр зохицуулагдаж байсан харилцааг 2007 онд өөрчилж Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн боловсролын тухай хуулийг баталсан. Энэ хуулиар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурах орчинг бүрдүүлэх, боловсролын тусгай хэрэгцээг хангах үүргийг төрийн болон орон нутгийн засаг захиргааны байгууллагад үүрэг болгосон.

Тусгай боловсролд харааны бэрхшээл, сонсголын бууралт, сэтгэцийн эмгэг, сэтгэл хөдлөл, зан үйлийн эмгэг, аутизм /үүнд хамааралтай эмгэгүүд/, харилцааны эмгэгүүд хамаарна. Үүнд нялхас, бага, дунд, дээд болон насан туршийн боловсрол хамаарна.

Боловсрол, хүний нөөцийн яам нь тусгай боловсролын удирдах зөвлөл, хороотой байх бөгөөд тусгай боловсрол нь үнэ төлбөргүй байна. Засгийн газар жил бүр Үндэсний Ассамблейн ээлжит чуулганы өмнө тусгай боловсрол болон цаашид авах арга хэмжээний талаарх тайланг хүргүүлсэн байх ёстой.

11) Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн халамжийн тухай хууль

Энэ хууль нь төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тусгай хэрэгцээг хангахад чиглэсэн цогц дэмжлэгийг бий болгох, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг эрүүл, аюулгүй орчинд амьдарч, нийгмийн амьдралд идэвхитэй оролцох, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй гэр бүлийн дарамтыг бууруулах зорилготойгоор 2011 онд батлагдсан.

Төвийн болон орон нутгийн захиргааны байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тохирох халамжийн үйлчилгээг хүргэх зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон түүний гэр бүлд зориулсан нийгмийн халамжийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээ, тэдэнд зориулсан халамжийн үйлчилгээний төслүүдийг судлах, хөгжүүлэх, хүргэх, шаардлагатай бусад халамжийн үйлчилгээтэй холбоотой асуудлыг зохицуулах, хянах үүргийг хүлээнэ.

Бодлого зохицуулалтын асуудлыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн халамжийн тухай хуульд заасны дагуу Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бодлого зохицуулалтын хороо хянана.

Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан нийгмийн халамжийн дэмжлэгийн судалгаа, бүс нутгийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг дэмжих төвүүдэд үнэлгээ хийх, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх, мэдээ материал бэлтгэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн

бэрхшээлийн төрлөөс нь хамаарч дэмжлэг үзүүлэх хөтөлбөр боловсруулах, гэр бүлд нь дэмжлэг үзүүлэх асуудлуудыг хариуцна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон гэр бүлд үзүүлэх халамжийн дэмжлэг, бусад шаардлагатай зүйлсийн талаар 3 жил тутам судалгааг шинэчлэн гаргаж байх ёстой.

12) Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль

Нийгмийн халамжийн үйлчилгээг өргөтгөх, асран хамгаалагчийн болон гэр бүлийн гишүүдийн амьдралын чанарыг сайжруулах, хүүхдэд ээлтэй нийгмийн орчинг бүрдүүлэх зорилгоор 12-оос доош насны хүүхдийг харах үйлчилгээний асуудлыг зохицуулсан хуулийг 2012 онд баталсан. Төрийн болон орон нутгийн засаг захиргааны байгууллагууд нь хүүхэд харах үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана. Мөн доогуур орлоготой өрхийн хүүхдүүдийн зардлыг хэсэгчлэн болон бүрэн хэмжээгээр төсвөөс санхүүжүүлэх асуудлыг шийдвэрлэх эрхтэй.

13) Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль

2017 оны 9 сард хамгийн сүүлд өөрчлөлт оруулсан. Энэ хуулиар бага орлоготой иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, нийгмийн халамжийг сайжруулахтай холбоотой харилцааг зохицуулна. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд эмнэлэгт хэвтэх, урьдчилан сэргийлэх үзлэг, жирэмслэлт, төрөлт, нөхөн сэргээх болон сувилахуйн үйлчилгээ, эм эмчилгээний үйлчилгээнүүд хамаарна.

14) Иргэний амьжиргааны баталгааны тухай хууль

Тус хууль нь 2000.01.01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн. Үндсэн хуулиар хамгаалагдсан иргэн бүр зүй зохистой нийгмийн орчинд амьдрах эрхийг хэрэгжүүлэх зорилготой. Тус хуулиар бага орлоготой иргэдийн амьжиргааг дэмжих, боловсрол, эрүүл мэнд, орон сууц зэрэг амьдралын наад захын хэрэгцээг хангах, уг асуудлыг хариуцан ажиллах байгууллагын асуудлыг зохицуулсан.

Хүүхдийн эрхийг хангах, хамгаалах зорилгоор салбар хуулиудад нарийвчилсан зохицуулалтыг оруулах, шаардлагатай хууль тогтоомжийг батлах ажлыг төрийн эрх бүхий байгууллагаас батлах ажлыг хийж байна.

15) Боловсролын багц хууль

Боловсролын багц хуулиудаар сургуулийн өмнөх, бага, дунд боловсролыг олгох асуудлыг нарийвчлан зохицуулсан. Боловсролын тогтолцоо нь бага боловсрол 4 жил, дунд болон ахлах анги тус бүр 4 жилээр 12 жилийн боловсролыг үнэ төлбөргүй эзэмшүүлдэг.

1.2.ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ БАЙГУУЛЛАГУУДЫН ТОГТОЛЦОО

1) Хүний эрхийн үндэсний комисс /국가인권위원회/


Солонгосын Хүний эрхийн Үндэсний Комисс нь Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийн дагуу 2001 онд байгуулагдсан.

Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуульд зааснаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Хүний эрхийн судалгаа хийх, бодлогын зөвлөмж гаргах замаар хүний эрхийн асуудлаар бодлого боловсруулах;
2. Ялгаварлан гадуурхах, хүний эрхийн зөрчлийн хэргийг мөрдөн байцаах, хохирлыг арилгах арга хэмжээ авах;
3. Хүний эрхийн боловсролын талаар олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх;
4. Олон улсын хүний эрхийн гэрээний хэрэгжилтийг дэмжих, хангах, хянах;
5. Засгийн газрын агентлагууд, иргэний нийгмийн байгууллагууд, хүний эрхийн байгууллагуудтай хамтран ажиллах (APF, ICC);
6. Хүний эрхийг хамгаалах, дэмжих шаардлагатай гэж үзсэн бусад асуудлууд.

Хүүхдийн эрхийн конвенцыг хэрэгжүүлэхтэй холбоотой зөвлөх байгууллага болохын хувьд Хүүхдийн эрхийн хороо /아동인권전문위원회/-г байгуулан ажиллуулж байна.

Зураг 1. БНСУ-ын Хүний эрхийн Үндэсний Комиссын бүтэц



2) Хүүхдийн бодлого зохицуулалтын хороо /아동정책조정위원회/

Хүүхэд хамгааллын тухай хуульд хүүхдийн эрх, эрүүл мэнд, өсөлтийг дэмжсэн хүүхдийн хөгжлийн цогц бодлого боловсруулах, бодлогын хэрэгжилтийг хангах, хянах, үнэлэх үүрэг бүхий Хүүхдийн бодлого зохицуулалтын хороо ажиллахаар заасан.

Тус хороо нь 25 хүний бүрэлдэхүүнтэй. Ерөнхий сайд тэргүүлж, 12 төрийн албан хаагч, 12 иргэний бүрэлдэхүүнтэй. Төрийн албан хаагчид Эрүүл мэндийн яам, Нийгмийн хамгаалал, гэр бүлийн асуудал хариуцсан яам, Хууль зүйн яам, Боловсрол, шинжлэх ухаан, техникийн яам болон хорооны даргын томилсон захиргааны төв байгууллагын гурван ахлагчаас бүрдэнэ. Иргэний зөвлөл нь хүүхдийн боловсролын чиглэлээр ажиллаж байсан туршлагатай 12 эрдэмтэн судлаачдаас бүрдэнэ. Тус хорооны гишүүнээр ажиллах хугацаа 2 жил бөгөөд нэг удаа улиран ажиллаж болно.

Хороо нь дараах асуудлыг хариуцан ажиллана:

- хүүхдийн талаарх суурь төлөвлөгөө боловсруулахтай холбоотой асуудал;
- хүүхдийн эрх ашиг болон нийгмийн хамгааллыг сайжруулах үндсэн чиглэлтэй холбоотой асуудал;
- хүүхдийн бодлого, төсвийн дэмжлэгийг сайжруулахтай холбоотой асуудал;
- хүүхдийн талаарх олон улсын гэрээг хэрэгжүүлэх, үнэлэх, зохицуулахтай холбоотой асуудал;
- хүүхдийн бодлогын талаар холбогдох яам хоорондын хамтын ажиллагаатай холбоотой асуудал;
- хорооны даргын хариуцах асуудал.

Хороо нь ажлын албатай байх бөгөөд шаардлагатай гэж үзвэл хүүхдийн эрх, аюулгүй байдал, ядуурлын асуудлаар дэд хороо байгуулан ажиллаж болно.

Хүүхдийн бодлого зохицуулалтын хорооны эрх зүйн байдлыг дээшлүүлэхэд Засгийн газраас анхаарч байгаа бөгөөд энэ талаар НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцын хэрэгжилтийн талаарх 5, 6 дугаар үндэсний тайланд Хүүхдийн бодлого зохицуулалтын хорооны чиг үүрэг, байгууллагын статусыг тодорхой болгон өргөжүүлэх шаардлагатай байна гэж тайландаа дурдсан байна.

3) Хүүхдийн эрхийг хамгаалах алба

Хүүхэд хамгааллын тухай хуульд заасны дагуу хүүхдийн эрхийг хамгаалах алба нь засаг захиргааны нэгжүүдэд үйл ажиллагаа явуулах бөгөөд дараах чиг үүрэгтэй:

- орон нутгийн хүүхэд хамгааллын агентлагуудад дэмжлэг үзүүлэх;
- хүүхдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэхтэй холбоотой судалгаа, мэдээлэл хийх;
- хүүхдийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх төсөл, хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх;
- хүүхдийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор сургалт зохион байгуулах;
- хүүхэд хамгааллын цахим тогтолцоог бүрдүүлэх, ажиллуулах;
- хүүхдийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх.

4) Хүүхдийн эрхийг хамгаалах агентлаг

Тус агентлаг нь Хүүхэд хамгааллын тухай хуульд заасны дагуу байгуулагдаж дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- хүүхэд хүчирхийлэлд өртөх боломжтой хэсгийн судалгаа, онцгой байдлын хамгаалалт;
- хохирогчид зөвлөгөө өгөх, мөрдөн байцаалтын өрөө гарган ажиллуулах;
- хохирогчид, хохирогчийн гэр бүлд зөвлөгөө өгөх, эрүүл мэнд болон боловсрол олгох ажлыг зохион байгуулах;
- хүүхдийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар боловсрол олгох, сурталчилгаа явуулах;
- хүчирхийлэлд өртсөн болон түүний улмаас гэмтсэн хүүхдэд хяналт тавих;
- хүүхдийн хүчирхийллийн хэрэг хариуцсан шинжээчдийн хороо байгуулах.

Агентлагийн үйл ажиллагаанд Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд 3 жил тутам гүйцэтгэлийн үнэлгээ хийдэг.

1.3.ХҮҮХДИЙН ЭРХИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭ

1) Иргэний эрх, эрх чөлөөний хүрээнд:

Үл ялгаварлах:

БНСУ-ын Үндсэн хуулиар ялгаварлан гадуурхахыг бүх хэлбэрээр хориглосон байдаг бөгөөд энэхүү заалт нь мөрдөн шалгах ажиллагаанд ч хамаардаг. Хүний эрхийн үндэсний комисс 2007 онд ялгаварлан гадуурхах явдлаас урьдчилан сэргийлэх тухай хуулийн төслийг Үндэсний Ассамблей хэлэлцэж жендер, хөгжлийн бэрхшээл, арьсны өнгө, үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхахыг хориглосон. ХЭҮК-оос ялгаварлан гадуурхахын эсрэг олон нийтийн арга хэмжээ болон хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг тогтмол зохион байгуулдаг.

Эмзэг бүлгийн болон цөөнхийн хүүхдийг ялгаварлан гадуурхахас урьдчилан сэргийлэх мөн Олон соёлт гэр бүлийн тоо 2005 оноос хойш 10 жилийн хугацаанд 80 хувь өсч 278.036 болсон байна. Засгийн газраас олон соёлт гэр бүлийг дэмжих хуулийн дагуу 5 жил тутамд олон соёлт гэр бүлийн бодлогын төлөвлөгөөг боловсруулж тэдний хүүхдүүдийн өсөлт, хөгжилд дэмжлэг үзүүлэх төрөл бүрийн хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

Мөн эмзэг бүлгийн гэр бүл, хүүхдүүдэд чиглэсэн ядуурлыг бууруулах зорилготой гэр бүлийн орчинд нь нэгдсэн үйлчилгээ үзүүлдэг DREAM START төслийг хэрэгжүүлж байна. Энэхүү төслийн үр дүнд эмзэг бүлгийн болон асран хамгаалагчгүй хүүхдүүдийн ядуурал, гутаан доромжлох, ялгаварлан гадуурхах явдлыг таслан зогсооход чиглэж байна.

Эсэн мэнд амьдрах, хөгжих эрх:

2015 оны Үндэсний статистикийн хорооны статистик мэдээллээр 10-19 насны хүүхдийн амиа хорлолт 100,000 хүнд 4.2 байгаа нь зам тээврийн ослын улмаас нас баралтаас өндөр байна. Энэ тоо 2011 онд 5.5 байсан бөгөөд буурч буй үзүүлэлттэй байна. 2012 онд амиа хорлохоос урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг боловсруулж

үндэсний хариуцлагын тогтолцоо, урьдчилан сэргийлэх бодлогыг тодорхойлсон. Бодлогын хэрэгжилтийг хангах хүрээнд амиа хорлохоос урьдчилан сэргийлэх төсөл, “залуучуудын хамтрагч” төсөл, залуучуудын утас 1388, залуучуудад кибер зөвлөгөө өгөх төв, бүс нутгийн залуучуудын нэгдлийг дэмжих төслүүдийг хэрэгжүүлж байна. Боловсролын яам нь сурагчдын амиа хорлолтоос урьдчилан сэргийлэх менежмент, сурагчийн сэтгэл хөдлөлийн зан үйлийн шалгалт, сэтгэцийн эрүүл мэндийн бодлогын судалгааны төвийг байгуулах, Wee хөтөлбөр зэрэг үйл ажиллагаануудыг хэрэгжүүлж байна.

2015 онд аюулгүй ажиллагааны ослоор 14 нас хүрээгүй 225 хүүхэд нас барсан байна. Үүнээс 103 хүүхэд зам тээврийн ослоор, 28 хүүхэд живж, 28 хүүхэд унаж осолдсон байна. Тиймээс Засгийн газраас хүүхдийн нас баралтаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж 2020 он гэхэд 100.000 хүүхэд тутамд 2-оос доош болгож нас баралтын тоог бууруулахаар ажиллаж байна.

2014 онд Хүүхдийн бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хуулийг баталсан бөгөөд 2016 оноос хүүхдийн аюулгүй байдлыг хангаагүй бүтээгдэхүүнийг сургуулийн ойр орчимд худалдан борлуулахыг хориглосон.

Боловсролын аюулгүй байдлыг хангах зорилгоор сургуулийн амьдралын чанарыг дээшлүүлэх, аюулгүй ажиллагааны мэдлэгийг дээшлүүлэх цогц арга хэмжээг боловсруулсан. Тус цогц арга хэмжээний хүрээнд хүүхдийн хөгжлийн үе шатанд /сургуулийн өмнөх, бага, дунд, ахлах ангийн/ тохирсон “Сургуулийн аюулгүй байдал, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх үндсэн төлөвлөгөө буюу 7 стандарт”¹¹⁰-ийг боловсруулсан. Тус 7 стандартад:

- амьдралын аюулгүй байдал;
- замын хөдөлгөөний аюулгүй байдал;
- хүчирхийллийн аюулгүй байдал;
- мансуурах бодис, интернетэд донтох;
- гамшгийн аюулгүй байдал;
- хөдөлмөрийн аюулгүй байдал;
- анхны тусламжаас бүрдэнэ.

Хүүхдийн үзэл бодлыг хүндэтгэх:

2014 оны 7 сард Хүний эрхийн үндэсний комиссоос хүүхэд, өсвөр үеийнхэнд зориулсан “Хүүхэд залуучуудын эрхийн баг” байгуулсан. Тус хороо нь хүүхдийн эрхийг зөрчсөн хэргүүдийг мөрдөн шалгах, хөндлөнгөөс оролцуулах, бодит нөхцөл байдалд судалгаа шинжилгээ хийх, хүүхэд, өсвөр үеийнхний шууд оролцооны “Хүүхдийн эрхийн ажиглагч”-ийг удирдан чиглүүлэх замаар бодлогын мониторинг хийж гүйцэтгэдэг. Засгийн газраас 2017 оноос хүүхдийн эрхийн хэрэгжилтэд хяналт тавих ажилд зарцуулах төсвийг нэмэгдүүлэх бодлого баримталж байна.

Жил бүр хүүхэд, өсвөр үеийнхний оролцсон Хүүхдийн ерөнхий ассамблей болон Залуучуудын тусгай хурлыг зохион байгуулж байгаа бөгөөд хурлуудаас санал болгож

¹¹⁰ БНСУ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцын хэрэгжилтийн талаар БНСУ-ын 5, 6 дугаар тайлан, дугаар 44.

The seven key areas are safety in life, safety in traffic, safety from violence and danger, safety from drug and Internet addiction, safety in disasters, safety at work, and first aid.

http://www.adongbokji.or.kr/adong/html/news_view.asp?num=60541569273693&page=1&keyword1=&keyword2=&cate=4&PB=%BA%B8%B0%C7%BA%B9%C1%F6%BA%CE%B9%DF%B0%A3%C0%DA%B7%E1&mode

буй бодлогын асуудлаар төсөв төсөвлөхийг эрмэлзэж байна. Орон нутгийн засаг захиргаанд хүүхэд залуучуудын зөвлөл, өсвөр үеийнхний оролцооны хороод ажиллах бөгөөд хүүхэд, өсвөр үеийнхний бодлогын асуудал, төсвийн талаар санал гаргахыг хүлээн зөвшөөрч дэмжин ажиллаж байна. Зарим хотын захиргаа төсөв хуваарилах үед хүүхэд, өсвөр үеийнхний санал болгож буй хөтөлбөрт төсөв хуваарилдаг “Хүүхэд, залуучуудын оролцооны төсөв” зарчмыг хэрэгжүүлж байна.

Мэдээлэл авах эрх:

Хүүхдийн хувийн эрх чөлөө нь БНСУ-ын Үндсэн хуулиар баталгаажсан эрх юм. Ихэнх өсвөр насныхан хөдөлгөөнт интернет болон ухаалаг утсыг чөлөөт цагаа өнгөрөөх, харилцаа холбооны зорилгоор ашигладаг. 10-аас дээш насны залуучууд долоо хоногт дунджаар 15.4 цаг буюу нэг өдрийн 93.9 хувийг интернет хэрэглэдэг гэсэн судалгаа гарсан байна. Тиймээс өсвөр үеийнхний сонирхолд тулгуурлан хэвлэл мэдээллийн боловсрол, интернетээр дамжуулан төрөл бүрийн залуучуудын оролцооны хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлж байна.

2013 оноос хойш хүүхдийн кибер хүчирхийллийн өнөөгийн байдлыг тогтоох судалгааг жил бүр явуулж байна. Кибер хүчирхийллийн тоо 2013 онд 3.4, 2014 онд 2.3, 2015 онд 1.7, 2016 онд 1.5 болж буурсан үзүүлэлттэй байна. 2015 оноос Боловсролын яам сурагчдын оролцоотой урьдчилан сэргийлэх боловсролыг олгох Кибер хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж байна. Сургууль дээр хүчирхийллийн яаралтай утас 117 ажиллах бөгөөд ирсэн дуудлагад Цагдаагийн байгууллага зөвлөгөө өгдөг.

2) Хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх хүрээнд

Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам, хүүхдийн эрхийг хамгаалах газраас хамтран Солонгос дахь хүүхдийн хүчирхийлэл, өнөөгийн байдал гэсэн судалгааг 2016 онд хийж гүйцэтгэсэн. Энэхүү судалгаагаар хүүхдийн эсрэг хүчирхийллийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, дүн шинжилгээнд тулгуурлан хүүхэд хамгааллын тогтолцоог сайжруулах арга хэмжээг эрэлхийлэх зорилготой.

Хүүхэд хамгааллын арга хэмжээг сайжруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор хүүхэд хамгаалах төв болон хууль, эрх зүйн орчинг сайжруулж байгаа хэдий ч хүүхдийн хүчирхийлэл жил тутам өсөн нэмэгдэж байна гэсэн судалгааг гаргасан байна. Нөгөө талаар хүүхдийн хүчирхийллийн талаар мэдээллэх байдал нэмэгдэж буйтай холбоотой гэж дүгнэсэн байна. 2016 онд хүүхдийн байгууллагаас гаргасан судалгаагаар сэтгэл санааны дарамт шахалт үзүүлэх хэлбэр илүү ихэссэн дүнтэй байна.

Бие махбодын шийтгэл:

2011 онд бага, дунд боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж хүүхдэд бие махбодын шийтгэл оногдуулахыг хориглосон. 2014 онд Хүүхдийн хүчирхийллийн гэмт хэрэг үйлдэгчдийг шийтгэх тухай тусгай хуулийг баталсан.

Засгийн газраас хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн харилцааг дэмжих зорилгоор эцэг, эх болон багш, сурган хүмүүжүүлэгчдийн хүчирхийллийн талаарх боловсролыг дээшлүүлэх, нэгдсэн нэг ойлголт өгөхөд анхаарч

сургалт зохион байгуулж байна. Хүүхдийн бие махбодын шийтгэлийг хориглож, хүчирхийллийн бус сахилгын арга хэлбэр боловсруулж байна. Бие махбодын шийтгэл хүлээсэн хохирогч Хүний эрхийн үндэсний комисс болон Нийслэлийн боловсролын албанд гомдол гаргах эрхтэй.

2016 онд улсын хэмжээнд хүүхэд хамгааллын 59 агентлагт 29674 хүүхэд хүчирхийлэлд өртсөн тухай бүртгэгдсэнээс хүчирхийлэлд өртөж болзошгүй сэжигтэй тохиолдол-25.878 буюу 87.2 хувь, давтан дуудлага 189 буюу 0.6 хувь, зөвлөгөө ярилцлага 3604 буюу 12.1 хувь байна. Хамгаалагдсан хүүхдийн тоо 14296. Хүчирхийллийн төрлөөр авч үзвэл сэтгэл санааны дарамт 45.8 хувь, бие махбодын хүчирхийлэл 39.4 хувь, үл хайхрах 10.6 хувь, бэлгийн хүчирхийлэл 4.2 хувийг эзэлж байна.¹¹¹ Хүчирхийлэлд өртөж буй хүүхдүүдийн 80.4 хувь нь гэр бүлийн хүчирхийлэлд өртдөг байна. Мөн сургууль дээрээ багш болон ажилчдаас хүчирхийлэлд өртөх тохиолдол элбэг байдаг. Нас баралтын хувьд хүүхдийн хүчирхийллийн 18700 тохиолдлоос нас баралт 50 буюу 0.3 хувийг эзэлж байна.

Хүүхдийн хүчирхийллийг багасгах, урьдчилан сэргийлэх зорилгоор хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох хүрээнд хүчирхийлэл үйлдэгчээс гадна хүүхдийн хүчирхийллийн талаар мэдээлээгүй хүнийг 3-5 сая хүртэл вонын торгууль ногдуулахаар хуульчилсан. Мөн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн нөхцөл байдлыг дордуулахгүй байх, хамгаалах зорилгоор гэмт хэрэгт өртсөн болон гэмт хэргийн нөлөөлөлд орсон хүүхдийн талаарх мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээллэхгүй байх, хүүхдийн хувийн мэдээллийг задруулахыг хориглосон.

Хүүхдийг хүчирхийллээс хамгаалах зорилтуудын хүрээнд дэд бүтцийг өргөжүүлэх ажлыг Засгийн газраас авч хэрэгжүүлж байна. Мөн хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх төслийн төсвийг нэмэгдүүлэх арга хэмжээ авч байна.

Хүүхдийн хүчирхийллийн талаарх мэдээллийг дараах утсуудаар 24 цагийн турш дуудлага хүлээн авч шаардлагатай тусламж үйлчилгээг үзүүлдэг:

- Цагдаагийн байгууллага - 112;
- Яаралтай тусламжийн үйлчилгээ - 119;
- Эрүүл мэнд, нийгмийн халамжийн дуудлагын төв - 129.

3) Гэр бүлийн орчин

Эцэг, эхчүүдийг бага насны хүүхдээ өөрсдөө өсгөн хүмүүжүүлэхэд нь туслах зорилтыг баримталж байна. Энэ нь хүүхэд асрах чөлөөг олгох тогтолцоог өргөжүүлэх, хүүхэд асрах чөлөөний тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх, ажилдаа эргэж орох боломжийг бүрдүүлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлж байна. Мөн аавын сар арга хэмжээг хэрэгжүүлж байгаа бөгөөд 2016 онд бага насны хүүхдээ асарч байгаа эрэгтэйчүүдийн тоо 56.3 хувиар нэмэгдсэн байна. Ганц бие эцэг, эхийн гэр бүлийн тухай хуулийн дагуу бага орлоготой эцэг, эхэд төрөөс дэмжлэг үзүүлдэг.

Мөн өсвөр насны сурагчдын сэтгэцийн эрүүл мэндэд онцгой анхаарч эрүүл мэндийн тухай хуулийн дагуу сурагчийн бие бялдар, оюун санааны эрүүл мэндийг дэмжих зорилгоор “сурагчийн эрүүл мэндийг дэмжих төлөвлөгөө”-г хэрэгжүүлж байна.

¹¹¹ Солонгос дахь хүүхдийн хүчирхийлэл, өнөөгийн байдал судалгааны тайлан-2016 он 32 дахь тал

2015 онд сурагчдын амиа хорлохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулсан. Сэтгэл санааны зан үйлийг гутаан доромжлохоос урьдчилан сэргийлэхийн тулд эцэг, эх, багш нарын сэтгэцийн эрүүл мэндийн сөрөг ойлголтыг арилгахын тулд сургалтын бодлогыг дэмжин ажиллаж байна. 2015 онд сэтгэл санааны болон зан үйлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан төвийг байгуулсан бөгөөд тус төв нь сэтгэл санааны хэвийн байдалдаа ороход нь хүүхэд, өсвөр насныханд зөвлөгөө өгөх, эмчлэх, хамгаалах, бие даах чадвар болон боловсрол олгох, тэдэнд өдөр тутмын амьдралаа сэргээхэд туслах зорилготой.

4) Хүүхдийн тусламж үйлчилгээ

Хүүхэд хамгааллын тухай хуульд заасны дагуу орон нутагт хүүхдийн эрх ашгийг хамгаалах хороо байгуулахаар заасан бөгөөд үүний дагуу орон нутагт Хүүхдийн халамжийн үнэлгээний хороог байгуулсан.

Хүүхдийг үрчлүүлэх асуудалд нэлээд анхаарч байгаа бөгөөд хүүхэд үрчилсэн хүмүүст тавих хяналтыг сайжруулахыг зорьж байгаа. Ганц бие эцэг, эхийн гэр бүлийг дэмжих тухай хууль батлагдсан нь хүүхдээ үрчлүүлэхийг хүссэн эцэг, эхийн тоо буурахад нөлөөлсөн. Тус хуулиар ганц бие эцэг, эхэд хүүхдээ өсгөхөд төрөөс дэмжлэг тусламж үзүүлэхийн зэрэгцээ ажил олох, өөрийн бизнесээ хийхэд дэмжих, орон сууцтай болоход төрөөс тусламж үзүүлэх зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байгаа нь хүүхэд гэр бүлдээ өсч хүмүүжих боломжийг бүрдүүлэхэд анхаарч байна.

Эрүүл мэндийн хуулийн дагуу сурагчдыг үнэ төлбөргүйгээр эрүүл мэндийн үзлэгт хамруулж байгаа бөгөөд 2016 оноос сургууль завсардсан хүүхэд, залуучуудад энэхүү арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

2009 оноос сургуулийн орчимд ногооны хоолны бүсийг байгуулж өөх тостой, өндөр илчлэгтэй, коффейнтэй хүнсний бүтээгдэхүүн худалдан борлуулахыг хориглохын зэрэгцээ хүүхдүүдийг телевиз үзэх цагаар сурталчилгаа явуулахыг хязгаарлаж байна. 2013 оноос эхлэн төрөөс нялхас, бага насны бүх хүүхдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон сэтгэл зүйн эрүүл мэнд:

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тусгай боловсролын тухай хуулийг 2008 онд баталсан бөгөөд тус хуулийн дагуу тусгай боловсролыг цэцэрлэгээс /3 наснаас/ ахлах сургууль хүртэл үнэ төлбөргүй олгоно. Засгийн газраас Боловсролыг хөгжүүлэх 4 дэх таван жилийн төлөвлөгөөг /2013-2017/ боловсруулж, төлөвлөгөөний дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор тусгай сургууль болон ангиудын тоог нэмэгдүүлж байна. Хөгжлийн бэрхшээлтэй сурагчдад зориулсан заавал эзэмшүүлэх боловсролыг олгох ажлыг сайжруулах зорилгоор төсвийг нэмэгдүүлж байна. Тусгай хэрэгцээт боловсролын багшийн эрхтэй 87.950 хүн байна.

2012 оноос эхлэн 4-71 сартай хүүхдүүдийн эрүүл мэндийн үзлэг буюу өсөлт хөгжил, хөгжлийн гажиг, таргалалт, осол гэмтэл, сонсголын болон харааны гажиг, шүдний цоорлыг үнэ төлбөргүй эмчлэхээр болгосон. 2013 оноос хөгжлийн бэрхшээлтэй хүний нарийн шинжилгээний төлбөрийн 30 хувийг эрүүл мэндийн даатгалаас олгож байна.

Засгийн газраас сурагчдын сэтгэл санааны зан үйлийн шалгалтыг арван жилийн бага, дунд, ахлах ангид нь хийж сэтгэл санааны хямралаас үүдэлтэй эрсдэлээс сэргийлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байна. Тус шалгалтын явцад хувийн нууцыг хамгаалах зорилгоор 2013 оноос цахимаар явуулж эхэлсэн. Мөн сэтгэл санааны зан үйлийг гутаан доромжлохоос урьдчилан сэргийлэх зорилгоор эцэг, эх, багш нарт нь сэтгэцийн эрүүл мэндийн талаарх боловсрол олгох арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Түүнчлэн хүүхдэд зориулсан мэргэжлийн сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих төвүүдийг өргөжүүлж байгаа бөгөөд тус төв нь хүүхэд, өсвөр үеийхэнд сэтгэцийн эрүүл мэндийн асуудлаас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, өндөр эрсдэлтэй бүлгүүдэд зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх, сэтгэл хөдлөлийн хэвийн байдалд ороход нь зөвлөгөө өгөх, эмчлэх, хамгаалах, бие даах чадвар, өдөр тутмын амьдралаа сэргээхэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр ажилладаг.

Донтолтоос урьдчилан сэргийлэх:

Засгийн газраас 2 жил тутамд мэдээллийн хэрэгслийн хэрэглээ болон орчны талаарх бодит байдлын судалгааг, жил тутам залуучуудын эрүүл зан үйлийн онлайн судалгааг явуулдаг бөгөөд архи, тамхинаас урьдчилан сэргийлэх зорилгоор эрүүл мэндийн боловсролыг олгох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүний дүнд залуучуудын тамхины хэрэглээ буурч буй судалгаа гарсан байна.

Залуучуудын интернет болон ухаалаг утасны донтолтын байдлыг тогтоох зорилгоор судалгаа явуулж донтолтоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийн түвшин бүрт тохирсон зөвлөгөө өгөх үйлчилгээг хэрэгжүүлж байна. Үүний хүрээнд донтолтыг хянах нэгдсэн төв 50 газар, сэтгэцийн эрүүл мэндийн төв 241 газар, залуучуудын зөвлөгөө өгөх халамжийн төв 208, залуучуудын интернет мөрөөдлийн хотхон 1 газар ажиллаж байна.

5) Боловсрол, соёл, чөлөөт цагийн арга хэмжээ

Цэцэрлэг, сургуульд хамрагдалтыг нэмэгдүүлэх, нэг багшид ногдох хүүхдийн тоог бууруулахад анхаарч байгаа бөгөөд боловсролын салбарт зарцуулах төсвийн хэмжээг нэмэгдүүлж байна. 2008 оноос боловсрол, соёлын салбарын цогц хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд сургууль завсардсан болон эмзэг бүлгийн хүүхдүүдийн боловсролын нөхцөлийг сайжруулах талаар арга хэмжээ авах шаардлагатай хэвээр байна. Үүний хүрээнд бага орлоготой хүүхдүүдийн боловсролын зардлын ачааллыг бууруулах зорилгоор гэр бүлд нь мөнгөн тусламж болон бусад хөнгөлөлт, чөлөөлөлтийг үзүүлж байна.

Мөн улсын болон хувийн сургуулийн ялгааг багасгахын тулд хувийн сургуулийн зардлыг бууруулахад анхаарч ажиллаж байна. 2017 оноос бага ангид орох хэлний боловсролын цагийг нэмэгдүүлж байна.

2012 онд ХЭҮК-оос Засгийн газарт хүний эрхийн ээлтэй сургуулийн бодлогыг хэрэгжүүлэхийг зөвлөсний дагуу Боловсролын яам 2015 онд боловсролын шинэчилсэн иж бүрэн хөтөлбөрт 10 сэдэвт хүний эрхийн боловсролыг багтаасан сургалтын хөтөлбөр боловсруулж, боловсролын үйл ажиллагааны бүх хүрээнд нэгдмэл байдлаар хүний эрхийн боловсрол олгохоор болсон. Үүний хүрээнд сурах бичиг дэх хүний эрхийн эсрэг элементүүдийг хянах, хүний эрхийн ээлтэй сурах бичиг боловсруулах,

хүний эрхийн боловсролыг дэмжих тухай хуулийг батлуулах зэрэг хүүхдийн эрхийн боловсролын институцийг боловсронгуй болгохоор ажиллаж байна.

Засгийн газраас зөвхөн өөрийн орноос гадна гадаад улс орон руу чиглэсэн арга хэмжээнд хөрөнгө оруулахад анхаарч байна. Тухайлбал 2015 оны 9-р сард НҮБ-ын Хөгжлийн чуулга уулзалт дээр "Better Life for Girls" санаачилгыг зарласан. Тус санаачилга нь хөгжиж буй орнуудын охид, эмэгтэйчүүдэд боловсрол, эрүүл мэнд, ирээдүйн чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн санаачилга нь ирэх таван жилд \$200 саяыг БНСУ-ын Олон Улсын Хамтын Ажиллагааны Агентлаг (KOICA)-аар дамжуулан хэрэгжүүлнэ.

6) Тусгай хамгааллын арга хэмжээ

БНСУ нь 1994-2016 оны хооронд 18.854 дүрвэгч хүлээн авсанаас 598 хүнийг дүрвэгсэдийн, 955 нь хүмүүнлэгийн зөвшөөрөл авсан байна. 2012 онд Иргэний хуульд өөрчлөлт орсноор зөвхөн дүрвэгсэд бус өргөдөл гаргагчдын амьжиргааны зардал, орон сууц, эмнэлгийн үйлчилгээ, бага болон дунд боловсролыг үнэ төлбөргүй эзэмшихэд нь дэмжлэг үзүүлж байна.

Бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, хамгаалах

Засгийн газар хүүхэд залуучуудыг бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх зорилгоор “Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийг устгах арга хэмжээ” /2012/ болон “Бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээ /2013-2017/”-г хэрэгжүүлж байна. Бэлгийн хүчирхийлэлтэй тэмцэх, үйлдэгдсэн гэмт хэрэгт шуурхай хариу арга хэмжээ авах, боловсролын үр дүнтэй байдлыг сайжруулах, бэлгийн боловсролын чиг баримжаа олгох зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байна.

Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчид, тэдний гэр бүлийнхэнд 365 хоног, 24 цагийн турш зөвлөгөө, эмчилгээ, цагдаагийн болон хууль зүйн туслалцаа үзүүлэх цогц үйлчилгээг үзүүлж байна.

Мөн 2013 онд бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчийг мөрдөн байцаах тусгай албыг байгуулсан бөгөөд томоохон хотуудын прокурорын газруудад мөн байгуулсан. Хүүхэд холбогдсон хэргийг дүүргийн болон гэр бүлийн шүүхийн насанд хүрээгүй иргэдийн шүүхээр шийдвэрлэдэг. Хохирогчдыг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд эрхээ эдлэхэд нь туслалцаа үзүүлэх өмгөөллийн, санал бодлоо илэрхийлэхэд туслалцаа үзүүлэх итгэмжлэгдсэн харилцааны системүүдийг хэрэгжүүлж байна. Хүчирхийллийн гэмт хэрэгт өртсөн хохирогчдод дэмжлэг үзүүлэх төвийг байгуулжээ.

1.4.НҮБ-ЫН ХҮҮХДИЙН ХОРООНООС ӨГСӨН ЗӨВЛӨМЖ

- Хүүхдийн эрхийн нөхцөл байдалд хяналт тавих байгууллага, түүний эрх зүйн статусыг тодорхойлж, бие даасан боловсон хүчин, ур чадвар, төсөв хөрөнгөөр бүрэн дэмжих. Хүний эрхийн үндэсний комисс хүүхдийн эрхийн асуудлаар мэргэших;
- Эдийн засгийн өндөр өсөлт, Эдийн засгийн хамтын ажиллагааны хөгжлийн байгууллага /OECD/-ын түвшинтэй уялдуулан Хүүхдийн эрхийн тухай конвенцыг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийг нэмэгдүүлэх;

- Хүүхдийн эрхийн тухай конвенцыг олон нийтэд сурталчлан таниулах ажлыг сайжруулах;
- Ядуу, олон үндэстэн, цагаач ажилтан, дүрвэгч, дүрвэгсэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эсрэг ялгаварлан гадуурхахаас урьдчилан сэргийлэх;
- Гэрлээгүй эхчүүдэд үзүүлэх дэмжлэг туслалцааг нэмэгдүүлэх;
- Хүүхэд амиа хорлох шалтгааныг судлах, амиа хорлохоос урьдчилан сэргийлэх тодорхой арга хэмжээ авах;
- Хүүхэд өөрт нь хамааралтай асуудлаар санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх, тэдэнд хүлээлгэх шийтгэл, шийдвэр гаргахдаа хүүхдийн санал бодлыг сонсох, хүндэтгэх. Хүүхдийн эрхэд хүндэтгэлтэй хандаж байгаа, тэдний амьдралд хэрхэн нөлөөлж байгаад байнгын хяналт тавих;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй холбоотой тусгай боловсролын хууль тогтоомжийг сахиулахад шаардлагатай төсөв болон боловсон хүчинд бүрэн дэмжлэг үзүүлэх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг энгийн хүүхдүүдтэй хамт суралцах боломжийг дэмжих;
- Хүүхдийн сэтгэл гутрал, амиа хорлох үндсэн шалтгааныг сайтар шалгаж, үр дүнг үндэслэн хүүхдийн сэтгэцийн эрүүл мэндийг үр дүнтэй удирдах, сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, урьдчилан сэргийлэх, бүх үйлчилгээг хамарсан эрүүл мэндийн цогц тогтолцоог бий болгох. Сэтгэцийн эрүүл мэндийн үнэлгээнээс гадна амиа хорлолтод нөлөөлж болзошгүй нийгмийн болон гэр бүлийн шалтгааныг судлах.

Хоёр. ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС

2.1.ЭРХ ЗҮЙН ОРЧИН

1) Олон Улсын эрх зүйн баримт бичгүүд

Хүүхдийн эрх хамгааллын чиглэлээрх олон улсын баримт бичгүүд нь оролцогч орнуудын бодлогын гол чиглэлийг тодорхойлсон байдаг бөгөөд ОХУ нь хүүхдийн эрх хамгаалалтай холбоотой дараах тунхаглал, конвенц, олон улсын пактыг соёрхон баталж хууль тогтоомжоороо баталгаажуулсан байна. Үүнд:

- Хүний эрхийн түгээмэл тунхаглал (1948.12.10)¹¹²;
- Хүний эрхийн тухай Европын конвенц (1950.11.04)¹¹³;
- Хүүхдийн эрхийн тунхаглал (1959.11.20)¹¹⁴;
- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (1966.12.16)¹¹⁵;
- Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт (1966.12.16)¹¹⁶;
- Насанд хүрээгүй хүмүүсийн талаар шүүн таслах ажиллагаа явуулахтай холбогдуулан НҮБ-аас гаргасан стандартын наад захын журам (Бээжингийн журам), (1985.11.29)¹¹⁷;
- Хүүхдийн эрхийн тухай конвенц (1989.11.20)¹¹⁸;
- Хүүхдийн эсэн мэнд амьдрах болон тэднийг хамгаалах, хөгжүүлэх олон улсын тунхаглал (1990.09.30)¹¹⁹;
- Иргэний, гэр бүлийн болон эрүүгийн эрх зүйн харилцаа, эрх зүйн туслалцааны тухай конвенц (1993.01.22)¹²⁰;
- Олон улсад хүүхэд хулгайлахтай тэмцэх иргэний эрх зүйн тухай конвенц (1980.10.25)¹²¹;
- Хүүхэд хамгаалах арга хэмжээ болон эцэг, эхийн хариуцлагатай холбоотой хэргээр хамтран ажиллах, мөрдөн шалгах, хууль хэрэглэх, шүүн таслах тухай конвенц (1996.10.19)¹²².

2) ОХУ-ын Үндсэн хууль¹²³

Тус улсын судлаачид хүүхдийн эрхийг хамгаалахтай холбоотой харилцааг зохицуулж буй ОХУ-ын Үндсэн хуулийн¹²⁴ хэм хэмжээг гурван бүлэгт авч үзэж байна.

Нэгдүгээр бүлгийн хэм хэмжээ нь хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалахтай шууд холбоотой бөгөөд Үндсэн хуулийн дараах хоёр зохицуулалтаас бүрдэнэ:

¹¹² Всеобщая декларация прав человека (от 10.12.1948 года).

¹¹³ Конвенция о защите прав человека и основных свобод (Европейская конвенция по правам человека), (от 04.11.1950 года).

¹¹⁴ Декларацию прав ребенка (от 20.11.1959 года).

¹¹⁵ Международный пакт о гражданских и политических правах (от 16.12.1966 года).

¹¹⁶ Международный пакт об экономических, социальных и культурных правах (от 16.12.1966 года).

¹¹⁷ Минимальные стандартные правила ООН, касающиеся отправления правосудия в отношении несовершеннолетних (Пекинские правила), (от 1985 года).

¹¹⁸ Конвенция ООН о правах ребенка (от 20.11.1989 года).

¹¹⁹ Всемирная декларация об обеспечении выживания, защиты и развития детей (от 30.09.1990 года).

¹²⁰ Конвенция о правовой помощи и правовых отношениях по гражданским, семейным и уголовным делам (Минск, от 22.01.1993).

¹²¹ Конвенция о гражданско-правовых аспектах международного похищения детей (Гаага, от 25.10.1980 года).

¹²² Конвенция о юрисдикции, применении права, признании, исполнении и сотрудничестве в отношении родительской ответственности и мер по защите детей (Гаага, от 19.10.1996 года).

¹²³ Теоретико-правовые основы защиты конституционных прав и свобод несовершеннолетних в России. Л.Н.Дегтярева (Центральный филиал Российского государственного университета правосудия). Тамбов, 2017. 10-11 дэх тал. Эх сурвалж: <http://ucom.ru/doc/mon.2017.04.01.pdf>

¹²⁴ "Конституция РФ" (принята всенародным голосованием 12.12.1993).

- Үндсэн хуулиар хүн (нас үл харгалзан), түүний эрх, эрх чөлөө нь хамгийн өндөр үнэ цэнэтэй болохыг тунхаглаж, түүнийг хүлээн зөвшөөрөх, сахин хамгаалах үүргийг төрд хариуцуулсан (2-р зүйл), төрийн бодлого нь хүний зохистой амьдрал, чөлөөтэй хөгжлийг хангахад чиглэнэ (7-р зүйл);
- төрөөс хүүхдийн эрх ашгийг эрхэмлэсэн нийгмийн бодлогыг гэр бүл, эцэг, эх, хүүхдэд дэмжлэг үзүүлэх замаар хэрэгжүүлэхийг Үндсэн хуульд заасан (7-р зүйл).

Хоёрдугаар бүлэг хэм хэмжээ нь хүүхдэд шууд хамааралтай Үндсэн хуулийн заалтууд багтана. Үүнд, хүүхэд нь гэр бүл, эцэг, эхийн нэгэн адил төрийн хамгаалалтад байх (38-р зүйл), хүүхдийг асран хамгаалах, хүмүүжүүлэх нь эцэг, эхийн тэгш эрх, үүрэг мөн (38-р зүйл) болохыг тогтоосон.

Гуравдугаар бүлэгт хүүхдийн эрх зүйн байдалтай шууд холбоотой хүн (иргэн)-ий эрх, эрх чөлөөг зохицуулсан Үндсэн хуулийн заалтууд хамаарна. Үүнээс үзэхэд, хүүхэд нь зөвхөн эцэг, эх, гэр бүлийн хамт байх боловч хүүхдийг үндсэн хуулийн эрх зүйн харилцааны бие даасан оролцогч гэдгийг тодорхойлсон бөгөөд мөн хүүхдийн эрх зүйн байдал нь ОХУ-ын иргэний эрх зүйн байдлын бүрдэл хэсэг болж, энэ нь наснаас нь үл хамааран хүний эрхийг адил тэгш хамгаалах баталгаа болно.

“Хүүхэд” гэсэн нэр томъёоны хувьд Үндсэн хуулийн “хүн ба иргэний эрх, эрх чөлөө” гэсэн 2 дугаар бүлэгт дөрвөн удаа хэрэглэжээ. Тодруулбал, 7 дугаар зүйлд гэр бүл, эцэг, эх, хүүхдийг төрөөс дэмжихийг тусгасан, 38 дугаар зүйлд төр болон эцэг, эхийн зүгээс хүүхдийг асран халамжлах үүргийг баталгаажуулсан, 39 дугаар зүйлд хүүхдийн нийгмийн хамгааллыг хөндсөн, 43 дугаар зүйлд боловсрол эзэмших эрхийг тогтоосон. Бусад тохиолдолд хүүхэд нь зөвхөн “иргэн”, “хүн бүр” гэсэн нэр томъёонд багтжээ.

3) Холбооны хууль тогтоомжууд

Хүүхдийн эрхийн тухай конвенцын 4 дүгээр зүйлд “Оролцогч улсууд энэхүү Конвенцод хүлээн зөвшөөрсөн эрхийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хууль тогтоох, захиргааны болон бусад бүх арга хэмжээг авна. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хэрэгжүүлэх арга хэмжээг нөөц бололцоондоо тулгуурлаж дээд зэргээр ашиглах, шаардлагатай бол олон улсын хамтын ажиллагааны хүрээнд авна” гэж заасан байдаг.

Үүний дагуу 1993 оноос хойш гэр бүл, хүүхэд хамгааллын чиглэлээр 200 гаруй холбооны хууль, ОХУ-ын Ерөнхийлөгчийн зарлиг, ОХУ-ын Засгийн газрын тогтоол батлагдсан ба эдгээр нь гэр бүл, хүүхдийн нийгмийн хамгааллын арга хэмжээг бэхжүүлэхэд чиглэгдсэн байна.¹²⁵

Эдгээрээс гадна ОХУ-ын 25 субъектүүд нь бүрэн эрхийнхээ хүрээнд хүүхдийн хамгааллыг дэмжин өөрийн хууль тогтоомжийг батлан гаргана.

Хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах талаарх холбооны хууль тогтоомжуудыг дараах 5 бүлэгт ангилан авч үзлээ:

- ✓ хүүхдийн эрх, эрх чөлөө;

¹²⁵ Теоретико-правовые основы защиты конституционных прав и свобод несовершеннолетних в России. Л.Н.Дегтярева (Центральный филиал Российского государственного университета правосудия). Тамбов, 2017. 32 дахь тал. Эх сурвалж: <http://ucom.ru/doc/mon.2017.04.01.pdf>

- ✓ гэр бүлийн орчин, асрамжийн хэлбэрүүд (эцэг, эхийг эрх, үүрэг; төрөөс гэр бүлийг дэмжих нь);
- ✓ эрүүл мэнд ба нийгмийн халамж (хүүхдийн эрүүл мэнд; хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд; нийгмийн халамж);
- ✓ боловсролын асуудал;
- ✓ тусгай хамгааллын арга хэмжээнүүд (хүүхдийн хөдөлмөр; өнчин болон хараа хяналтгүй хүүхэд; хүнд нөхцөлд амьдарч байгаа хүүхэд).

• **Хүүхдийн эрх, эрх чөлөө**

ОХУ-ын хүүхдийн эрх, үүрэг, хариуцлагатай холбоотой эрх зүйн гол баримт бичиг бол **Хүүхдийн эрхийн үндсэн баталгааны тухай хууль**¹²⁶ юм. Энэ хуулиар хүүхдийн эрхийн талаарх хууль тогтоомжоор зохицуулсан үндсэн баталгаануудыг цэгцэлсэн байна.¹²⁷ Энэ хуульд хүүхдийн ашиг сонирхлын үүднээс төрийн бодлогын зорилгыг тодорхойлсон:

- ✓ ОХУ-ын Үндсэн хуулийн дагуу хүүхдийн эрхийг хангах;
- ✓ хүүхдийн эрхийн баталгааны эрх зүйн үндсийг бүрдүүлэх;
- ✓ хүүхдийн зөрчигдсэн эрхийг сэргээх;
- ✓ хүүхдийг бие бялдар, оюун ухаан, сэтгэл зүй, ёс суртахууны хувьд хөгжүүлэх болон эх оронч үзэл, зөв иргэн болж хүмүүжихэд хөхиүлэн дэмжих.

Иргэний хуульд хүүхдийн эрхийг 6 хүртэлх насны, 6-14 (мөн бага насны гэж нэрлэдэг) болон 14-16 насны гэж гурван бүлэгт хуваасан байна.

Гэр бүлийн тухай хуулийн¹²⁸ 11 дүгээр бүлэгт хүүхдийн эрхийг хамгаалах, гэр бүлийн орчиндоо хамгаалуулах баталгааг тодорхойлохдоо тэднийг “эцэг, эхийн эрх мэдэл”-д хамаарах объект бус, харин бие даасан эрх зүйн субъект хэмээн үзэн дараах үндсэн эрхүүдийг тусгасан:

- ✓ гэр бүлд амьдарч, хүмүүжих эрх, ашиг сонирхлыг нь хангах, нэр төрийг нь хүндэтгэх бөгөөд бүх талаар нь хөгжүүлэх (54-р зүйл);
- ✓ гэр бүл салсан тохиолдолд эцэг, эх, бусад хамаатан садантайгаа харилцах эрх (55-р зүйл);
- ✓ хамгаалуулах эрх, үүнд, асран хамгаалуулах эрхийнхээ төлөө бие даан холбогдох байгууллага, шүүхэд хандах эрх (56-р зүйл);
- ✓ үзэл бодлоо илэрхийлэх эрх (57-р зүйл);
- ✓ овог, нэр авах (58-р зүйл) болон өөрчлөх эрх (59-р зүйл);
- ✓ эзэмших, өмчлөх эрх (60-р зүйл).

Эрүүгийн хуулийн¹²⁹ 17 дугаар бүлэгт хүн хулгайлах (126-р зүйл), хэн нэгнийг хууль бусаар хорих (127-р зүйл) зэрэг хүний эрх чөлөө, нэр төр, алдар хүндийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хариуцлага хүлээлгэхээр тусгасан.

¹²⁶ Федеральный закон “Об основных гарантиях прав ребенка в РФ” от 24.07.1998 года № 124-ФЗ.

¹²⁷ Права ребенка: необходимость внедрения новых механизмов защиты (Монография). С.В.Широ (кандидат педагогических наук, доцент, заведующий кафедрой права Волгоградского государственного педагогического университета.). Уполномоченный по правам ребенка в городе Москве, Российское представительство объединения “Спасем детей” (Норвегия). Москва - Мурманск. 2009. 40 дэх тал.

¹²⁸ “Семейный кодекс РФ” от 29.12.1995 года.

¹²⁹ “Уголовный кодекс РФ” от 13.06.1996 года № 63-ФЗ.

- **Гэр бүлийн орчин**

Эцэг, эхийн эрх, үүрэг:

Гэр бүлийн тухай хуулийн 12 дугаар бүлэгт хүүхдийг хүмүүжүүлэх, сургах, тэдний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах талаар эцэг, эхийн эрх, үүргийг (61-69-р зүйл), хүүхдийг гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах эрх зүйн үндсийг (65-р зүйл) тус тус тогтоосон байна.

Хүүхдээ тэжээх, хүмүүжүүлэх, сургах, түүний эрх, ашиг сонирхлыг хамгаалах үүргээ биелүүлээгүй, эсхүл хангалттай биелүүлээгүй эцэг, эхэд **ОХУ-ын захиргааны зөрчлийн тухай хуулиар**¹³⁰ 100-5000 рублээр торгох, эсхүл 5 хүртэл хоногоор баривчлах (5.35-р зүйл), **Эрүүгийн хуулиар** нэг жил хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл гурван сар хүртэл хугацаагаар баривчлах, нэг жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгэх (157-р зүйл)-ээр заасан. **Гэр бүлийн тухай хуулиар** эцэг, эхийн эрхийг хязгаарлах (73-76-р зүйл), хасах ба эрхийг нь 10 нас хүрсэн хүүхдийн зөвшөөрлөөр сэргээнэ (69-72-р зүйл).

Төрөөс гэр бүлийг дэмжих нь:

Хүүхэдтэй иргэдэд төрөөс тэтгэмж олгох тухай хуулиар¹³¹ эцэг, эхэд хүүхэд төрүүлэх, хүмүүжүүлэхэд нь чиглэсэн төрөөс олгох тэтгэмжийн нэгдсэн тогтолцоо бий болсноор эцэг, эх, хүүхдэд төрөөс баталгаажсан материаллаг дэмжлэг үзүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлсэн.

Татварын тухай хуулиар¹³² хүүхэдтэй этгээдэд сард 1400-3000 рублийн (хүүхэд тус бүрт) татварын хөнгөлөлт олгоно. Хэрэв 18 нас хүртэлх хүүхэд нь хөгжлийн бэрхшээлтэй бол, хүүхдийн эцэг, эх нь мэргэжлийн сургуулийн өдрийн ангийн, эсхүл аспирантурт сурдаг 24 хүртэлх насны оюутан, дадлагажигч бол 12000 рублийн (хүүхэд тус бүрт) татварын хөнгөлөлт олгоно (218-р зүйл).

Хүүхэдтэй гэр бүлд төрөөс дэмжлэг үзүүлэх нэмэлт арга хэмжээний тухай хуулийн¹³³ дагуу 2007 оноос гэр бүлүүдийг дэмжих шинэ хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн. Энэ нь хүүхэдтэй болсон, мөн хоёр дахь болон түүнээс олон хүүхэд өргөж авсан гэр бүлд “эх (гэр бүл)-ийн хөрөнгө оруулалтын сан”-ийн хэлбэрээр урт хугацаанд дэмжих арга хэмжээг хэрэгжүүлж байна. Хүүхэд нь 3 нас хүрэх үед эх (гэр бүл)-ийн хүсэлтээр уг хөрөнгө оруулалтын санг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн орон сууцны нөхцөлөө сайжруулах, хүүхдийн боловсролд зарцуулах, эхийн тэтгэврийн санд хуримтлуулах зэргээр ашиглаж болно.

Эдгээрээс гадна Хөдөлмөрийн тухай¹³⁴ болон Боловсролын тухай¹³⁵ хуулийн дагуу эцэг, эх, эсхүл хууль ёсны төлөөлөгчид эцэг, эхийн эрхээ хэрэгжүүлэхэд нь төрөөс дэмжлэг үзүүлэх харилцааг зохицуулна.

- **Эрүүл мэнд ба нийгмийн халамж**

¹³⁰ "Кодекс РФ об административных правонарушениях" от 30.12.2001 года № 195-ФЗ.

¹³¹ Федеральный закон "О государственных пособиях гражданам, имеющим детей" от 19.05.1995 №81-ФЗ.

¹³² Налоговый кодекс РФ (НК РФ).

¹³³ Федеральный закон "О дополнительных мерах государственной поддержки семей, имеющих детей" от 29.12.2006 года № 256-ФЗ.

¹³⁴ "Трудовой кодекс РФ" от 30.12.2001 года № 197-ФЗ.

¹³⁵ Федеральный закон "Об образовании в РФ" от 29.12.2012 года № 273-ФЗ.

Хүүхдийн эрүүл мэнд:

Иргэний эрүүл мэндийн хамгааллын тухай хуулиар¹³⁶ дараах асуудлыг зохицуулна:

- хүүхдэд зориулсан нийгмийн дэд бүтцийн тогтолцоонд хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;
- хүүхдийг эрүүл мэнд, ёс суртахуун, оюун санааны хөгжилд сөрөг нөлөөлөх мэдээлэл, зар сурталчилгаанаас хамгаалах;
- хүнд нөхцөлд амьдарч байгаа хүүхдийн эрхийг хамгаалах.

Эрүүл ахуй, халдвар судлалын хөгжлийн тухай хуульд¹³⁷ иргэдийн таатай орчинд амьдрах эрхийг баталгаажуулсан. Таатай орчинд гэдэгт хүрээлэн буй орчин, хөдөлмөрлөх, амьдрах, ахуйн болон амрах нөхцөл, сурч хүмүүжих орчин, хоол хүнс болон бусад бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал зэргийг оруулсан байна (8-р зүйл). Түүнчлэн боловсрол, эрүүл мэндийн болон бусад холбогдох байгууллагууд нь иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, сахих, өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл ахуйн дүрмийг сахих үүрэгтэй (28-р зүйл).

Төрийн нийгмийн тусламжийн тухай хуулийн¹³⁸ дагуу эмийн бүтээгдэхүүнийг нэгдсэн журмаар худалдан авах замаар үнэтэй эмчилгээ шаардлагатай хүүхэд, эмэгтэйчүүдийг эмийн бүтээгдэхүүнээр хангана.

Боловсролын тухай хуулиар сурагчдын эрүүл мэндийг хамгаалахад тавигдах шаардлагыг тогтоосон.

Боловсролын байгууллагуудын анги дүүргэлтийн нормыг ОХУ-ын Засгийн газрын 1996 оны 1063 дугаар тогтоолоор¹³⁹ баталсан ба анги дүүргэлт нь хүүхдийн наснаас хамааран өөр өөр байна:

- цэцэрлэгийн:
 - 1-3 настны ангид - 15 хүүхэд;
 - 3-7 настны ангид - 20 хүүхэд;
- ерөнхий боловсролын сургуулийн ангид – 25 сурагч.

ОХУ-ын Засгийн газрын тогтоолоор батлагдсан **“2025 он хүртэл анагаах ухааныг хөгжүүлэх стратеги”**¹⁴⁰-иар анагаах ухааны хөгжлийн тэргүүлэх салбаруудад "хүүхдийн эмгэг зүй", "нөхөн үржихүйн эрүүл мэнд" орсон байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд:

Тус улсын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаарх төрийн бодлого нь эдийн засаг, нийгэм, соёл, хувь хүний болон улс төрийн эрхийг хэрэгжүүлэхэд бусад иргэдтэй адил тэгш боломж олгох зорилготой.¹⁴¹

Хөдөлмөрийн тухай болон Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн

¹³⁶ Федеральный закон "Об основах охраны здоровья граждан в РФ" от 21.11.2011 года № 323-ФЗ.

¹³⁷ Федеральный закон "О санитарно-эпидемиологическом благополучии населения" от 30.03.1999 года № 52-ФЗ.

¹³⁸ Федеральный закон "О государственной социальной помощи" от 17.07.1999 года №178-ФЗ.

¹³⁹ Распоряжение Правительства РФ "Нормативы наполняемости классов и групп в образовательных учреждениях" от 03.07.1996 года № 1063-р.

¹⁴⁰ Распоряжение Правительства РФ "Стратегией развития медицинской науки в РФ на период до 2025 года" от 28 декабря 2012 года № 2580-р.

¹⁴¹ "Рассмотрение докладов, представляемых государствами-участниками в соответствии со статьей 44 Конвенции", "Четвертый и пятый периодические доклады государств-участников, подлежащие представлению в 2011 году - Российская Федерация". Организация Объединенных Наций. Комитет по правам ребенка. 03.06.2011 года. 32 дахь тал, 145 дугаар зүйл.

хамгааллын тухай хуулиар¹⁴² 2003 оноос хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн насны хязгаарыг 18 нас гэж заасан (1-р зүйл).

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын тухай (27.1-р зүйл) болон **Тэтгэврийн тухай**¹⁴³ (17, 21, 38, 113-115-р зүйл) хуулийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд төрөөс тэтгэвэр, тэтгэмж олгоно.

Мөн тэдний гэр бүлийн нийгмийн хамгааллыг бэхжүүлэх үүднээс мөнгөн тэтгэмж болон бусад хөнгөлөлтүүдийг эцэг, эх (асран хамгаалагч)-д нь олгож байна. Үүнд:

- 5500 рублийн мөнгөн тэтгэмж (*"18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, эсхүл бага наснаасаа тахир дутуугийн 1 дүгээр бүлэгт хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй насанд хүрсэн хүнийг асарч байгаа ажил эрхлээгүй хөдөлмөрийн чадвартай иргэнд сар бүр олгох мөнгөн тэтгэмжийн тухай"* ОХУ-ын Ерөнхийлөгчийн 2013 оны 175 дугаар тогтоол¹⁴⁴);
- 120 рублийн нөхөн олговор (*Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд асарч байгаа ажил эрхлээгүй хөдөлмөрийн чадвартай иргэнд сар бүр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 60 хувьтай тэнцэх нөхөн олговрын хэмжээг нэмэх тухай"* ОХУ-ын Ерөнхийлөгчийн 1994 оны 551 дугаар тогтоол¹⁴⁵);
- орон сууц, засвар үйлчилгээ болох орон сууцны их засварын зардлын 50 хувьтай тэнцэх нөхөн олговор олгох (*Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын тухай хуулийн 17-р зүйл*).

Хөдөлмөрийн тухай хуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эхийн хөдөлмөр эрхлэлтийн баталгааг тогтоосон байна. Тодруулбал, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эх хүсвэл ажлын хагас цагаар ажиллана (93-р зүйл), шөнийн цагаар (96-р зүйл), эсхүл илүү цагаар, амралтын болон баярын өдрөөр ажиллахгүй байх, албан томилолтоор явуулахгүй байх (259-р зүйл), цалинтай болон цалингүй нэмэлт амралтын өдөр (262, 263-р зүйл) олгох, хөдөлмөрийн гэрээг цуцлах, ажлаас халахыг хориглосон (261) байна.

Тэтгэврийн тухай хуулийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ 8 нас хүртэл өсгөсөн эхийн тэтгэврийг 50 наснаас тогтоох (15 жил ажилласан тохиолдолд) ба хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд асарсан хугацааг ажилласан жилд тооцно (11, 92(б)-р зүйл).

Сэтгэцийн болон биеийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн амьдралын асуудлуудыг Боловсролын тухай, Иргэний эрүүл мэндийн хамгааллын тухай, Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж болон түүнийг үзүүлэхэд иргэдийн эрхийн баталгааны тухай, Төрөөс үзүүлэх нийгмийн тусламжийн тухай¹⁴⁶ болон Хүүхдийн эрүүл мэнд, хөгжилд хор хөнөөл учруулах мэдээллээс тэднийг хамгаалах тухай¹⁴⁷ хуулиар зохицуулж байна.

Нийгмийн хангамж:

¹⁴² Федеральный закон "О социальной защите инвалидов в РФ" от 24.11.1995 года № 181-ФЗ.

¹⁴³ Федеральный закон "О трудовых пенсиях в РФ" от 17.12.2001 года № 173-ФЗ.

¹⁴⁴ Указ Президента РФ "О ежемесячных выплатах лицам, осуществляющим уход за детьми-инвалидами и инвалидами с детства I группы" от 26.02.2013 года № 175.

¹⁴⁵ Указ Президента РФ "О повышении размера компенсационных выплат неработающим трудоспособным лицам, осуществляющим уход за нетрудоспособными гражданами" от 17.03.1994 года № 551.

¹⁴⁶ Федеральный закон "О государственной социальной помощи" от 17.07.1999 года № 178-ФЗ.

¹⁴⁷ Федеральный закон "О защите детей от информации, причиняющей вред их здоровью и развитию" от 29.12.2010 года № 436-ФЗ.

Хүүхдүүдийн ашиг сонирхлыг хамгаалахад дараах холбооны хуулиар зохицуулж байна:

- Иргэдийн эрүүл мэндийн даатгалын тухай хууль¹⁴⁸;
- Иргэдэд үзүүлэх нийгмийн үйлчилгээний тухай хууль¹⁴⁹;
- Тэтгэврийн тухай хууль;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын тухай хууль;
- Хүүхэдтэй иргэдэд төрөөс тэтгэмж олгох тухай хууль.

Хүүхдийн орон сууцны асуудлыг *Орон сууцны тухай*¹⁵⁰ болон *Орон сууцны хувьчлалын тухай*¹⁵¹ хууль болон бусад холбогдох хууль тогтоомжоор баталгаажуулсан. **Орон сууцны тухай хуулийн** дагуу бага орлоготой иргэдэд орон сууц, засвар үйлчилгээний төлбөрийн тэтгэмж олгодог байна (159-р зүйл).

Орон сууцны хувьчлалын тухай хуулиар төрийн болон орон нутгийн орон сууцны хувьчлалын үндсэн зарчмуудыг тогтоосон. Улсын болон хотын орон сууцны сангаас түрээсийн зориулалттай орон сууцыг ашиглах эрхтэй ОХУ-ын иргэн нь зохих журмын дагуу тухайн орон сууцыг хувьчилж авч болно. Тус улсын 14-18 насныхан дараах журмын дагуу хамрагдана (2-р зүйл): 14 хүртэлх насны хүүхдүүдэд эцэг, эхийн нь хүсэлт, холбогдох байгууллагын зөвшөөрлийн дагуу, 14-18 насны залуучуудад өөрсдийнх нь хүсэлт, эцэг, эх болон холбогдох байгууллагын зөвшөөрлөөр тэдэнд орон сууцыг хувьчилна.

- **Боловсролын асуудал**

Боловсролын тухай хууль нь тус улсын боловсролын зорилго, үндсэн зорилтуудын зэрэгцээ боловсролын бүх байгууллагад суралцаж байгаа хүүхдүүдийн эрхийн баталгааг бий болгож, боловсролын салбарын эрх, үүрэг, эрх мэдлийг тодорхойлсон.

Хуулиар нийгмийн туслалцаа шаардлагатай хүүхдүүдэд боловсрол эзэмшихэд нь үзүүлэх дэмжлэгийг баталгаажуулж, төрөөс тэдний сургалтын зардлыг бүхэлд нь буюу хэсэгчлэн гаргахыг тогтоосон байна. (5-р зүйл)

ОХУ-д боловсрол, хүмүүжил, соёлд хамаарах хүүхдийн эрхийг Гадаадын иргэдийн эрх зүйн байдлын тухай¹⁵², Дүрвэгсдийн тухай¹⁵³, Иргэний харьяаллын тухай¹⁵⁴, Хүүхдийн эрхийн үндсэн баталгааны тухай¹⁵⁵ хуулиудаар баталгаажуулсан байна.

- **Тусгай хамгааллын арга хэмжээнүүд**

Хүүхдийн хөдөлмөр:

Хөдөлмөрийн тухай хуулиар¹⁵⁶ насанд хүрээгүй ажиллагсдын хөдөлмөрийн харилцааг зохицуулна. Хуулийн дагуу 16 нас хүрсэн этгээдийг ажилд авна. Онцгой

¹⁴⁸ Федеральный закон "Об обязательном медицинском страховании в РФ" от 29.11.2010 года № 326-ФЗ.

¹⁴⁹ Федеральный закон "Об основах социального обслуживания граждан в РФ" от 28.12.2013 года № 442-ФЗ.

¹⁵⁰ "Жилищный кодекс РФ" от 29.12.2004 года № 188-ФЗ.

¹⁵¹ Федеральный закон "О приватизации жилищного фонда в РФ" от 04.07.1991 года № 1541-1.

¹⁵² Федеральный закон "О правовом положении иностранных граждан в РФ" от 25.07.2002 N 115-ФЗ

¹⁵³ Федеральный закон "О беженцах" от 19.02.1993 года № 4528-1.

¹⁵⁴ Федеральный закон "О гражданстве РФ" от 31.05.2002 года № 62-ФЗ.

¹⁵⁵ Федеральный закон "Об основных гарантиях прав ребенка в РФ" от 24.07.1998 года № 124-ФЗ.

¹⁵⁶ "Трудовой кодекс РФ" от 30.12.2001 года № 197-ФЗ.

тохиолдолд 15 нас хүртсэн, бүрэн дунд боловсрол эзэмшсэн (эсхүл эзэмшиж байгаа) хүүхэдтэй өсвөр үеийнхний эрүүл мэндэд хохирол учруулахааргүй хөнгөн ажил хийлгэх гэрээ байгуулж болно. Харин 14 настай хүүхдээр түүний эрүүл мэндэд хохирол учруулахааргүй хөнгөн ажлыг түүний эцэг, эх болон холбогдох байгууллагын зөвшөөрөлтэйгээр, суралцахад нь саадгүй байхаар хийлгэж болно.

1. Насанд хүрээгүй ажиллагсдыг хүнд (ачаа ачих, буулгах гэх мэт), хортой болон аюултай ажил (гал түймэр, тэсрэх бодис үйлдвэрлэх гэх тэм), газар доорх ажил, тэдний ёс суртахууны хөгжилд сөргөөр нөлөөлөх ажил эрхлэх болон шөнийн цагаар ажиллахыг хориглоно.

2. Тэдний эрх, үүрэг нь насанд хүрэгчтэй адил байна. Өөрөөр хэлбэл, насанд хүрээгүй ажиллагсад нь үнэнч, шударга ажиллах, хөдөлмөрийн сахилга батыг сахих, хөдөлмөр хамгааллын шаардлагыг биелүүлэх, захиргааны удирдамжийг дагаж мөрдөх үүрэгтэй.

3. Гэхдээ тэд хөдөлмөр хамгаалал, ажлын цаг, цалин хөлс, амралтын өдрүүдэд тодорхой хөнгөлөлт эдэлнэ. Тухайлбал, 15-16 насныхан өдөрт 5 цаг, 16-18 насныхан өдөрт 7 цагаас хэтрүүлэхгүй ажиллах (94-р зүйл) боловч насанд хүрэгчдийн ажлын өдрийн үндсэн цалинтай тэнцүү цалин авна (271-р зүйл). Мөн 18 нас хүрээгүй ажиллагсад хуанлийн 31 хоног амарна (267-р зүйл).

4. Тухайн байгууллага, аж ахуйн нэгжийн захиргаа нь насанд хүрээгүй ажилтныг ажлаас халахдаа Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч, Насанд хүрээгүй хүмүүсийн хэргийг хянах, эрхийг хамгаалах хорооноос зөвшөөрөл авах ба хэрэв насанд хүрээгүй ажилтанг ажлаас халсан бол түүнд ажлын байр олж өгөх үүрэгтэй.

5. Хүүхдийг хүнд хөдөлмөрт оролцуулахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг дээрх хуулиас гадна Боловсролын тухай, Хүн амд үзүүлэх нийгмийн үйлчилгээний тухай, Насанд хүрээгүй хүүхэд хараа хяналтгүй болох, хууль зөрчихөөс урьдчилан сэргийлэх тогтолцооны тухай¹⁵⁷ болон Гэр бүлийн тухай хуулиар зохицуулдаг байна.

Өнчин болон хараа хяналтгүй хүүхэд:

Гэр бүлийн тухай хууль нь эцэг, эхийн асаргаагүй үлдсэн хүүхэд, тэдний эрх, хууль ёсны эрх ашгийг хамгаалах, үрчлэх, асран хамгаалах, хүмүүжүүлэх, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх тэднийг үрчлэн авах гэр бүлд шилжүүлэх болон бусад асуудлыг зохицуулсан.

Өнчин болон эцэг, эхийн асаргаагүй үлдсэн хүүхдийн нийгмийн халамжийн нэмэлт баталгааны тухай хуулиар¹⁵⁸ зорилгот бүлгийн хүүхдийн нийгмийн халамжийн ерөнхий зарчим, агуулга, арга хэмжээг тодорхойлсон ба зохицуулалтын хүрээнд 23 хүртэлх насныхан мөн хамрагдана. Хуульд хүүхдийн дараах эрхүүдийн нэмэлт баталгааг хөндсөн байна:

- боловсрол эзэмших эрх (6-р зүйл);
- эмнэлгийн тусламж авах эрх (7-р зүйл);
- эд хөрөнгө, байр эзэмших эрх (8-р зүйл);

¹⁵⁷ Федеральный закон "Об основах системы профилактики безнадзорности и правонарушений несовершеннолетних" от 24.06.1999 N 120-ФЗ.

¹⁵⁸ Федеральный закон "О дополнительных гарантиях по социальной поддержке детей-сирот и детей, оставшихся без попечения родителей" от 21.12.1996 года № 159-ФЗ.

- хөдөлмөрлөх эрх (9-р зүйл);
- өнчин хүүхэд болон эцэг, эхийн асаргаагүй үлдсэн хүүхдийн эрхийн шүүхийн хамгаалалт (10-р зүйл).

Эцэг, эхийн асаргаагүй үлдсэн хүүхдүүдийн талаарх төрийн мэдээллийн тухай хуулийн¹⁵⁹ дагуу зорилтот бүлгийн хүүхдүүдийн тоон мэдээллийн сангийн журам, ашиглалтыг зохицуулсан байна.

“Гэр бүл дэх хүүхдийн асрамжийн газрын тухай” Засгийн газрын 2001 оны 195 дугаар тогтоолоор гэр бүл дэх асрамжийн газрын үйл ажиллагааны журмыг тодорхойлсон. Гэр бүл дэх хүүхдийн асрамжийн газрыг байгуулахад эхнэр, нөхөр хоёр өөрийн хүсэлтээр 5-10 хүүхдийг гэр бүлд тулгуурлан асрах замаар хэрэгжүүлнэ.

14-16 насны хөвгүүд гэр бүлдээ тогтворгүй байх тохиолдолд тэднийг цэргийн ангиудад сургах, хүмүүжүүлэх арга хэмжээ авах ба үүнийг **“Цэргийн ангид сурч байгаа сурагчдын эрх зүйн байдлын тухай дүрэм батлах тухай”** Засгийн газрын 2000 оны 745 дугаар тогтоолоор зохицуулна. НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенц, олон улсын эрх зүйд заасан шаардлагын дагуу хүүхэд өөрөө зөвшөөрсөн тохиолдолд цэргийн ангид сурч, хүмүүжнэ. Тэнд сурч боловсрох хүүхдүүд нь төрийн хангамжид бүрэн хамрагдан ерөнхий боловсролын сургуульд суралцах бөгөөд төгссөний дараа мэргэжлээ бие даан сонгох эрхтэй.

Өнчин болон хараа хяналтгүй хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахтай холбоотой харилцааг Боловсролын тухай болон Насанд хүрээгүй хүүхэд хараа хяналтгүй болох, хууль зөрчихөөс урьдчилан сэргийлэх тогтолцооны тухай¹⁶⁰ хууль, “Нийгмийн нөхөн сэргээх шаардлагатай насанд хүрээгүй хүүхдийн тусгай мэргэжлийн байгууллагуудын жишиг дүрмийг батлах тухай” ОХУ-ын Засгийн газрын 2000 оны 896 дугаар тогтоолоор зохицуулж байна.

Хүнд нөхцөлд амьдарч байгаа хүүхэд:

Хүнд нөхцөлд амьдарч байгаа хүүхдийн эрхийг хамгаалах тухай тус улсын хууль тогтоомж нь амьдралын таатай болон хүнд нөхцөлд байгаа хүүхдийн эрхийг хамгаалах баталгаа болсон **ОХУ-ын Үндсэн хуулиас** гадна Өнчин болон эцэг, эхийн асаргаагүй үлдсэн хүүхдийн нийгмийн халамжийн нэмэлт баталгааны тухай, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын тухай, Боловсролын тухай, Гэр бүлийн тухай, Хөдөлмөрийн тухай болон Эрүүгийн хуулиар зохицуулна.

Хүүхдийн эрхийн үндсэн баталгааны тухай хуульд¹⁶¹ тодорхойлсноор хүнд нөхцөлд амьдарч байгаа хүүхэд гэдэгт (1-р зүйл):

- эцэг, эхийн асаргаагүй үлдсэн;
- хөгжлийн бэрхшээлтэй;
- сэтгэцийн болон биеийн согогтой;
- зэвсэгт болон олон үндэстний зөрчилдөөн, байгалийн болон технологийн гамшигт өртсөн;

¹⁵⁹ Федеральный закон “О государственном банке данных о детях, оставшихся без попечения родителей” от 16.04.2001 года № 44-ФЗ.

¹⁶⁰ Федеральный закон “Об основах системы профилактики безнадзорности и правонарушений несовершеннолетних” от 24.06.1999 года № 120-ФЗ.

¹⁶¹ Федеральный закон “Об основных гарантиях прав ребенка в РФ” от 24.07.1998 года № 124-ФЗ.

- дүрвэгсэд болон албадан нүүлгэн шилжүүлж байгаа гэр бүлийн;
- онцгой нөхцөлд байгаа;
- хүчирхийллийн хохирогч;
- засан хүмүүжүүлэх газарт хорих ял эдэлж байгаа;
- боловсрол, хүмүүжлийн тусгай байгууллагуудад байгаа;
- бага орлоготой өрхөд амьдарч байгаа;
- зан төлөвийн асуудалтай;
- амьдралын нөхцөлд хүндрэл учирч, үүнийг өөрийн, эсхүл гэр бүлийн тусламжтайгаар даван туулах боломжгүй байгаа зэрэг хүүхдүүд орно.

Насанд хүрээгүй хүүхэд хараа хяналтгүй болох, хууль зөрчихөөс урьдчилан сэргийлэх тогтолцооны тухай хуулийн¹⁶² 2 дугаар зүйлд 18 нас хүрээгүй этгээд буюу насанд хүрээгүй хүүхэд хараа хяналтгүй болох, хууль зөрчихөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үндсэн зорилгыг заасан байна. Үүнд:

- хүүхэд хараа хяналтгүй болох,
- хууль зөрчснийг тогтоох, арилгах, урьдчилан сэргийлэх;
- хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;
- нийгмийн аюултай нөхцөлд байгаа хүүхдийг нийгэмшүүлэх, сурган хүмүүжүүлэх чиглэлээр нөхөн сэргээх;
- хүүхдийг гэмт хэрэгт татан оруулсныг тогтоох, арилгах, урьдчилан сэргийлэх.

Эрүүгийн хуулиар бүх төрлийн хүчирхийллээс хүүхдийг хамгаалах ба хуулийн 16 дугаар бүлэгт хүүхдийн ам нас, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн этгээдэд, 18 дугаар бүлэгт насанд хүрээгүй хүүхдэд бэлгийн хүчирхийлэл үзүүлсэн этгээдэд, 20 дугаар бүлэгт гэр бүл болон хүүхдийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хариуцлага тооцох замаар тэднийг хамгаална.

2.2. ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГУУД

Насанд хүрээгүй хүүхэд хараа хяналтгүй болох, хууль зөрчихөөс урьдчилан сэргийлэх тогтолцооны тухай хуулийн дагуу хараа хяналтгүй болох болон тэднийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн байгууллагууд, мөн хүүхэд, тэдний эцэг, эх, хууль ёсны бусад төлөөлөгч нь хүүхдийн эрүүл мэнд, эд хөрөнгө, ёс суртахууны хохирол учруулсан талаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.

Харин энэ чиглэлийн асуудал эрхэлсэн байгууллагууд нь өөрсдийн бүрэн эрхийн хүрээнд дараах үүргийг хүлээнэ. (9-р зүйл) Үүнд:

- хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хангах;
- хүүхдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэр, бие махбодын болон сэтгэл санааны хүчирхийлэл, зүй бус харьцаа, бэлгийн болон бусад мөлжлөгөөс хамгаалах;
- нийгмийн хүнд нөхцөлд байгаа хүүхэд, тэдний гэр бүлийг тогтоох;
- энэ талаар эрх бүхий бусад байгууллагуудад хандах, мэдээллэх (Хүснэгт 1).

¹⁶² Федеральный закон “Об основах системы профилактики безнадзорности и правонарушений несовершеннолетних” от 24.06.1999 года № 120-ФЗ.

Хүснэгт 1. Хүүхэд хараа хяналтгүй болох, хууль зөрчихөөс урьдчилан сэргийлэх талаар эрх бүхий байгууллагуудад хандах, мэдээллэх чиглэл

№	Эрх бүхий байгууллагууд	Мэдээллийн чиглэл
1.	прокурорын байгууллагад	• хүүхдийн эрх, эрх чөлөөг зөрчсөн талаар;
2.	хүүхдийн эрхийг хамгаалах хороонд	• хүүхдийн боловсрол, хөдөлмөр, чөлөөт цаг, орон байр болон бусад эрхийн талаар; • хараа хяналтгүй болсон хүүхдийн тухай; • хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн байгууллагуудын үйл ажиллагааны талаар;
3.	асран хамгаалах байгууллагад	• эцэг, эхийн асаргаагүй үлдсэн хүүхдийн тухай; • амьдрал, эрүүл мэндэд нь хохирол учруулж болзошгүй, боловсрол эзэмшихэд нь саад учруулж буй орчинд байгаа хүүхдийн тухай;
4.	хүн амын нийгмийн хамгааллын байгууллагад	• орон гэргүй, хараа хяналтгүй, нийгмийн халамж шаардлагатай хүүхдийн тухай; • нийгмийн хүнд нөхцөлд байгаа гэр бүлийн талаар;
5.	дотоод хэргийн байгууллагад	• эцэг, эх нь хүүхэддээ харгис хандсан талаар; • хүүхдийг гэмт хэрэг, хууль бус үйлдэлд уруу татсан талаар; • хууль зөрчсөн хүүхдийн тухай;
6.	эрүүгийн мөрдөн байцаах газарт	• шийтгүүлж байсан, нийгмийн болон сэтгэл зүйн туслалцаа шаардлагатай хүүхдийн нийгэмд дасан зохицох болон ажил эрхлэх талаар; • хууль зөрчсөн, эсхүл нийгмийн эсрэг үйлдэл хийсэн хүүхдийн тухай; • шийтгүүлж байсан, мансуурах донтой хүүхэд эмчилгээнээс зайлсхийсэн талаар; • эмнэлгийн болон нийгмийн нөхөн сэргээх албадан эмчилгээнд явах тухай шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй хүүхдийн тухай;
7.	эрүүл мэндийн байгууллагад	• согтууруулах ундаа, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэсэн хүүхдийг эмчилгээнд хамруулах талаар;
8.	боловсролын байгууллагад	• эцэг, эхгүй үлдсэн хүүхэд асрамжийн байгууллагаас өөрийн хүсэлтээр явсан, төрийн дэмжлэг шаардлагатай хүүхдийн тухай; • хүндэтгэх шалтгаангүйгээр сургуулиас гарсан хүүхдийн тухай;
9.	залуучуудын асуудал эрхэлсэн байгууллагад	• нийгмийн аюултай нөхцөлд байгаа хүүхдийг тогтоох, тэдний амралт, чөлөөт цагаа өнгөрүүлэх болон ажил эрхлэхэд туслалцаа үзүүлэх талаар;
10.	хөдөлмөрийн асуудал эрхэлсэн байгууллагад	• хүүхдийг ажил эрхлэхэд туслалцаа үзүүлэх талаар.

Насанд хүрээгүй хүүхэд хараа хяналтгүй болох, хууль зөрчихөөс урьдчилан сэргийлэх тогтолцооны тухай хуульд гэр оронгүй, хараа хяналтгүй хүүхдүүдийн эрхийг өөрсдийн бүрэн эрхийн хүрээнд хамгаалах үүргийг дараах байгууллагад даалгасан байна. Үүнд:

- хүүхдийн эрхийг хамгаалах хороо (11-р зүйл);
- хүн амын нийгмийн хамгаалал, халамжийн байгууллагууд (12-р зүйл);
- хүүхдийн нийгмийн нөхөн сэргээх мэргэжлийн байгууллагууд (13-р зүйл);
- боловсролын байгууллагууд (14-р зүйл);
- боловсрол, хүмүүжлийн тусгай байгууллагууд (15-р зүйл);
- асрамжийн байгууллагууд (16-р зүйл);

- залуучуудын асуудал эрхэлсэн байгууллагууд (17-р зүйл);
- эрүүл мэндийн байгууллагууд (18-р зүйл).

Эдгээр байгууллагуудын үйл ажиллагаанд дээд шатны төрийн байгууллагууд нь эрх мэдлийнхээ хүрээнд хяналт тавина.

1) Прокурорын байгууллага

Прокурорын байгууллагын тухай хуулийн дагуу тус улсын прокурорын байгууллагууд нь хүүхдийн эрхийн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих хараат бус байгууллага юм.

Хүүхдийн эрхийг хамгаалах прокурорын байгууллага л ажиллагаанд эцэг, эхийн эрхийг хязгаарлах, хасах, тэтгэмжийн төлбөрийн асуудал, хүүхэд үрчлэхийг зогсоох зэрэг хүүхдийн эрхийг хамгаалахтай холбоотой шийдвэрийг гаргана.

2) Хүүхдийн эрхийг хамгаалах хороо

Хүүхдийн эрхийг хамгаалах хороо нь хүүхдийн эрхийг цогцоор хамгаалах үүргийг хүлээдэг. **Насанд хүрээгүй хүүхэд хараа хяналтгүй болох, хууль зөрчихөөс урьдчилан сэргийлэх тогтолцооны тухай хуульд** заасны дагуу ОХУ-ын субъектүүдийн Засгийн газар уг хороог өөрийн бүтцэд байгуулах ба хороо нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ (11-р зүйл). Үүнд:

- хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, сэргээх, хангах талаар арга хэмжээ авах;
- холбогдох байгууллагуудтай хамтран хүүхдийг хаалттай төрлийн сургалт, хүмүүжлийн тусгай байгууллагад хамруулах талаар шүүхэд хандах ажлыг зохин байгуулах;
- хүүхдийг бүрэн бус дунд боловсролоо эзэмшилгүйгээр боловсролын байгууллагаас гарсан асуудлыг хянах;
- шийтгүүлж байсан, эсхүл боловсрол, хүмүүжлийн тусгай байгууллагаас эргэж ирсэн хүүхдэд ажил эрхлэхт болон ахуйн туслалцаа үзүүлэх, нийгмийн нөхөн сэргээх талаар бусад арга хэмжээг авах;
- хууль тогтоомжид заасан журмын дагуу хүүхдүүд, тэдний эцэг, эхэд албадлагын зарим арга хэмжээ авах.

3) Хүүхдийн нийгмийн нөхөн сэргээх мэргэжлийн байгууллагууд

Насанд хүрээгүй хүүхэд хараа хяналтгүй болох, хууль зөрчихөөс урьдчилан сэргийлэх тогтолцооны тухай хуульд заасны дагуу хүүхдийн нийгмийн нөхөн сэргээх мэргэжлийн байгууллагуудад дор дурдсан байгууллагууд орно (13-р зүйл):

- хараа хяналтгүй болон амьдралын хүнд нөхцөлд амьдарч байгаа хүүхдийн нийгмийн нөхөн сэргээх төвүүд;
- хүнд нөхцөлд амьдарч байгаа, төрийн зүгээс яаралтай нийгмийн халамж шаардлагатай хүүхдийг түр хугацаагаар байрлуулан нийгмийн нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх нийгмийн асрамжийн газрууд;
- эцэг, эхийн асаргаагүй үлдсэн хүүхдүүдийг түр хугацаагаар байрлуулах, цаашид амьдралыг нь төвхнүүлэхэд туслалцаа үзүүлэх төвүүд.

Эдгээр мэргэжлийн байгууллагууд нь нийгмийн нөхөн сэргээх шаардлагатай дараах хүүхдүүдийг зохих журмын дагуу 24 цагийн турш хүлээн авна:

- эцэг, эх, эсхүл бусад хууль ёсны төлөөлөгчийн асаргаагүй үлдсэн;
- амьдралд аюултай нөхцөлд байгаа гэр бүлд амьдарч байгаа;
- төөрсөн, эсхүл орхигдсон;
- гэр бүлээ, эсхүл өнчин, эцэг, эхийн асаргаагүй үлдсэн хүүхдийн асрамжийн байгууллагыг сайн дураараа орхисон (үүнд, хаалттай хэлбэрийн боловсрол, хүмүүжлийн тусгай байгууллагыг сайн дураараа орхисон хүүхэд хамаарахгүй);
- оршин суух газар болон амьдрах эх үүсвэргүй;
- амьдралын хүнд нөхцөл байдалд орсон, нийгмийн халамж болон нөхөн сэргээх хөтөлбөрт хамрагдах шаардлагатай.

4) Боловсрол, хүмүүжлийн тусгай байгууллагууд

Боловсрол, хүмүүжлийн тусгай байгууллагуудыг хэлбэрийн хувьд хаалттай, нээлттэй гэж ангилна. (15-р зүйл)

Нээлттэй хэлбэрийн боловсрол, хүмүүжлийн тусгай байгууллагууд нь сурган хүмүүжүүлэх тусгай арга шаардлагатай 8-18 насны хүүхдийг Хүүхдийн эрхийг хамгаалах хорооны шийдвэр болон сурган хүмүүжүүлэх, сэтгэц, эрүүл мэндийн дүгнэлтийг үндэслэн асран хүмүүжүүлж сургана. Хүүхдийн эцэг, эхийн зөвшөөрлийг авна, харин 14 нас хүрсэн хүүхдээс өөрийнх нь зөвшөөрлөөр уг хөтөлбөрт хамруулна.

Хаалттай хэлбэрийн боловсрол, хүмүүжлийн тусгай байгууллагууд нь сурган хүмүүжүүлэх тусгай арга шаардлагатай 11-18 насны дараах хүүхдийг шүүхийн шийдвэрийг үндэслэн хүлээн авна:

- нийгэмд аюултай үйлдэл хийсэн боловч эрүүгийн хариуцлага хүлээлгэх насанд хүрээгүй учраас эрүүгийн хариуцлага хүлээгээгүй хүүхэд;
- эрүүгийн хариуцлага хүлээлгэх нас (14, 16 нас)-ндаа нийгэмд аюултай үйлдэл хийх үед сэтгэл гутралтай холбоогүй сэтгэцийн эмгэгээс болж нийгэмд аюултай үйлдэл хийж байгаагаа ухамсарлах чадваргүй байсан учраас эрүүгийн хариуцлага хүлээгээгүй хүүхэд;
- **хүндэвтэр болон хүнд** гэмт хэрэг үйлдэж шийтгүүлсэн, эсхүл Эрүүгийн хуулийн 92.2-т заасны дагуу шүүхийн шийдвэрээр суллагдсан хүүхэд.

5) Хүүхдийн эрхийн омбудсмен¹⁶³

ОХУ-д хүүхдийн эрхийг хамгаалах шинэ механизм бол Ерөнхийлөгчийн 2009 оны 986 дугаар зарлигаар¹⁶⁴ Хүүхдийн эрхийн омбудсмен байгуулагдсан явдал юм.

Энэхүү байгууллагыг НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцын хэрэгжилтийн талаарх ОХУ-ын хоёрдугаар тайланд НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооны өгсөн дүгнэлтэд тусгасан ОХУ-ын бие даасан хяналтыг нэвтрүүлэх гэсэн зөвлөмжийн дагуу байгуулсан.

Уг байгууллагын үйл ажиллагаа нь улс орон даяар төдийгүй олон улсын хэмжээнд хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалахад чиглэгдсэн. Үүний зэрэгцээ ОХУ-ын Хүүхдийн эрхийн омбудсмен нь дараах ажлыг гүйцэтгэнэ:

¹⁶³ Теоретико-правовые основы защиты конституционных прав и свобод несовершеннолетних в России. Л.Н.Дегтярева (Центральный филиал Российского государственного университета правосудия). Тамбов, 2017. 32 дахь тал. Эх сурвалж: <http://ucom.ru/doc/mon.2017.04.01.pdf>

¹⁶⁴ Указ Президента РФ от 01.09.2009 года № 986 "Об Уполномоченном при Президенте РФ по правам ребенка".

- 1) хүүхдийн эрхийг хамгаалах, зөрчсөн эрхийг сэргээх;
- 2) холбогдох чиглэлийн эрх зүйн боловсрол олгох;
- 3) холбооны болон ОХУ-ын субъектүүдийн төрийн байгууллагууд, орон нутгийн өөрөө удирдах байгууллага, бусад байгууллага, эрх бүхий албан тушаалтнаас шаардлагатай мэдээлэл, баримт бичгийг шаардаж авах, мөн:
 - тэдгээрийн үйл ажиллагаатай саадгүй танилцах;
 - бие даан, эсхүл эрх бүхий байгууллага, албан тушаалтнуудтай хамтран тэдгээрийн үйл ажиллагаанд шалгалт хийх, тэднээс тайлбар авах;
 - тэдгээрийн хүүхдийн эрх, ашиг сонирхлыг зөрчсөн гэж үзэж байгаа шийдвэр, үйл ажиллагаанд зөвлөмж гаргах;
- 4) хүүхдийн эрх, ашиг сонирхлын талаар шинжлэх ухааны болон бусад байгууллагын эрдэмтэд, мэргэжилтэн нарыг татан оролцуулах зэрэг болно.

Одоогийн байдлаар ОХУ-ын бүх субъектүүдэд Хүүхдийн эрхийн омбудсмен байгуулагдсан хэдий ч түүнийг байгуулах аргууд нь өөр өөр байна. Тухайлбал:

- парламентын дэргэд (Санкт-Петербург, Тамбовск муж гэх мэт);
- гүйцэтгэх засаглалын бүтцэд (Курск болон Воронеж бүс нутаг гэх мэт);
- Хүний эрхийн омбудсмены ажлын албаны бүтцэд (Смоленск муж, Красноярск хязгаар).

Тус улсад 2009 онд Хүүхдийн эрхийн 21 омбудсмен үйл ажиллагаагаа явуулж эхэлж байсан бол 2017 онд 85 болж өссөн байна. Гэтэл Хүүхдийн эрхийн омбудсменүүдийн үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн тогтолцоо одоогоор байхгүй байна. Судлаачдын үзэж байгаагаар, омбудсмены энэхүү тогтолцоо нь хүүхдийн эрхийн хамгааллын салбарт үр дүнтэй төрийн менежментийг хэрэгжүүлэхэд саатуулж байна.

Гурав. АВСТРАЛИЙН ХОЛБООНЫ УЛС

Австралид муж болон харьяа газар нутгийн засаг захиргаа нь хүүхэд хамгаалах үйлчилгээг зохион байгуулж хэрэгжүүлэх үүрэгтэй. Үүнийг муж болон харьяа газар нутгийн хууль тогтоомжуудаар зохицуулж, зохих үйлчилгээг үзүүлдэг.

3.1. Хүүхэд хамгаалах тухай хууль тогтоомжууд¹⁶⁵

Муж болон харьяа газар нутаг нь хүүхэд хамгаалалтай холбоотой тус тусын зохицуулалтуудыг хэрэглэж байна.

Австралийн нийслэлийн бүс нутагт гол хууль нь Хүүхэд, залуучуудын тухай хууль (Children and Young People Act 2008 ACT) юм. Түүнээс гадна дараах хуулиудаар зохицуулдаг. Үүнд:

- *Хүүхэд үрчлэх тухай хууль (Adoption Act 1993 ACT);*
- *Хүүхэд, залуучуудын (Австралийн нийслэлийн бүс нутагт Хүүхэд асран хамгаалах тухай стандартууд) тухай хууль (Children and Young People Act (ACT Childcare Services) Standards 2009 No. 1);*
- *Хүүхэд, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн тухай стандартууд (Children and Young People (Employment) Standards 2011 No. 1);*

¹⁶⁵ Australian child protection legislation
<https://aifs.gov.au/cfca/publications/australian-child-protection-legislation>

- *Гэмт хэргийн (Хүүхдийн бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэгтэн) тухай хууль (Crimes (Child Sex Offenders) Act 2005 ACT);*
- *Гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль (Family Violence Act 2016 ACT);*
- *Эмзэг бүлгийн хүмүүстэй ажиллах (Тодорхойлолт шалгах) тухай хууль 2011 (Working with Vulnerable People (Background Checking) Act 2011 ACT);*
- *Омбудсмeны тухай хууль (Ombudsman Act 1989 ACT) зэрэг хуулиуд орно.*

Шинэ Өмнөд Уэльс мужид хүүхэд хамгаалах талаар баримталдаг гол хууль нь **Хүүхэд, залуучуудын (Асрах болон хамгаалах) тухай хууль (Children and Young Persons (Care and Protection) Act 1998 (NSW)** юм. Мөн дараах хуулиудаар зохицуулж байна. Үүнд:

- *Хүүхэд үрчлэх тухай хууль (Adoption Act 2000 NSW);*
- *Хүүхэд, залуучуудыг өмгөөлөх тухай хууль (Advocate for Children and Young People Act 2014 NSW);*
- *Хүүхэд хамгаалах (Олон улсын арга хэмжээ) тухай хууль (Child Protection (International Measures) Act 2006 NSW);*
- *Хүүхэд хамгаалах (Гэмт хэрэгтнийг хориглох тухай журам) тухай хууль (Child Protection (Offenders Prohibition Orders) Act 2004 NSW);*
- *Хүүхэд хамгаалах (Гэмт хэрэгтний бүртгэл) тухай хууль (Child Protection (Offenders Registration) Act 2000 NSW);*
- *Хүүхэд хамгаалах (Хүүхэдтэй ажиллах) тухай хууль (Child Protection (Working with Children) Act 2012 NSW);*
- *Гэмт хэргийн (Гэр бүлийн болон хувь хүний хүчирхийлэл) тухай хууль (Crimes (Domestic and Personal Violence) Act 2007 NSW);*
- *Удирдлага болон ажилчид хоорондын харилцааны (Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт) тухай хууль (Industrial Relations (Child Employment) Act 2006 NSW);*
- *Омбудсмeнын тухай хууль (Ombudsman Act 1974 NSW);*
- *Өсвөр насны гэмт хэрэгтний тухай (Young Offenders Act 1997 NSW)*

Хойд бүс нутгийн хувьд гол хууль нь **Хүүхдийг асрах болон хамгаалах тухай хууль (Care and Protection of Children Act 2007 NT)** юм. Үүний зэрэгцээ дараах хуулиудыг хэрэглэж байна. Үүнд:

- *Хүүхэд үрчлэх тухай хууль (Adoption of Children Act 1994 NT);*
- *Хүүхэд хамгаалах (Гэмт хэрэгтний тухай мэдээллэх болон бүртгэх) тухай хууль (Child Protection (Offender Reporting and Registration) Act 2016 NT);*
- *Хүүхдийн Комиссарын тухай хууль (Children's Commissioner Act 2013 NT)*
- *Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан үйлчилгээний тухай хууль (Disability Services Act 2004 NT);*
- *Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (Domestic and Family Violence Act 2007 NT);*
- *Мэдээллийн тухай хууль (Information Act 2006 (NT));*
- *Өсвөр насны гэмт хэрэгтнийг шүүх тухай хууль (Youth Justice Act 2005 NT) зэрэг болно.*

Күйнсланд мужийн хүүхэд хамгаалахтай холбоотой гол хууль нь **Хүүхэд хамгаалах тухай хууль** (*Child Protection Act 1999 Qld*) юм. Түүнээс гадна дараах хуулиудыг мөрдөж байна. Үүнд:

- Хүүхэд үрчлэх тухай хууль (*Adoption Act 2009 Qld*);
- Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн тухай хууль (*Child Employment Act 2006 Qld*);
- Хүүхэд хамгаалах (Олон улсын арга хэмжээ) тухай хууль (*Child Protection (International Measures) Act 2003 Qld*);
- Хүүхэд, залуучуудын хороо болон хүүхэд асран хамгаалагчийн тухай хууль (*Commission for Children and Young People and Child Guardian Act 2000 Qld*);
- Хүүхэд хамгаалахтай холбоотой шүүхийн маргааныг удирдагчийн тухай хууль (*Director of Child Protection Litigation Act 2016 Qld*);
- Гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах тухай хууль (*Domestic and Family Violence Protection Act 2012 Qld*);
- Боловсрол болон халамж үйлчилгээний тухай хууль (*Education and Care Services Act 2013 Qld*);
- Боловсролын (Ерөнхий заалтууд) тухай хууль (*Education (General Provisions) Act 2006 Qld*);
- Гэр бүл болон хүүхдийн асуудал хариуцсан хорооны тухай хууль (*Family and Child Commission Act 2014 Qld*);
- Гэр бүлийн асуудал хариуцсан хорооны тухай хууль (*Family Responsibilities Commission Act 2008 Qld*);
- Асран хамгаалал болон захиргааны тухай хууль (*Guardianship and Administration Act 2000 Qld*);
- Омбудсманы тухай хууль (*Ombudsman Act 2001 Qld*);
- Цагдаагийн албаны эрх, үүргийн тухай хууль (*Police Powers and Responsibilities Act 2000 Qld*);
- Нийтийн асран хамгаалагчийн тухай хууль (*Public Guardian Act 2014 Qld*);
- Нийтийн эрүүл мэндийн тухай хууль (*Public Health Act 2005 Qld*);
- Хүүхэдтэй ажиллах (Эрсдэлийн удирдлага ба хяналт) тухай хууль (*Working with Children (Risk Management and Screening) Act 2000 Qld*);
- Өсвөр насны гэмт хэрэгтнийг шүүх тухай хууль (*Youth Justice Act 1992 Qld*) зэрэг хуулиудыг хэрэгжүүлдэг.

Өмнөд Австралийн хүүхэд хамгаалах талаарх гол хууль нь **Хүүхэд хамгаалах тухай хууль** (*Children's Protection Act 1993 SA*) юм. Түүнээс гадна дараах хуулиудыг хэрэглэнэ. Үүнд:

- Хүүхэд үрчлэх тухай хууль (*Adoption Act 1988 SA*);
- Хүүхэд хамгааллын хяналтын (Бүрэн эрх болон халдашгүй байдал) тухай хууль (*Child Protection Review (Powers and Immunities) Act 2002 SA*);
- Хүүхдийн аюулгүй байдлын тухай (Хориглосон хүмүүс) хууль (*Child Safety (Prohibited Persons) Act 2016 SA*);
- Хүүхдийн бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэгтнийг бүртгэх тухай хууль (*Child Sex Offenders Registration Act 2006 SA*);
- Хүүхэд, залуучуудын (хянах болон өмгөөлөн хамгаалах этгээд) тухай хууль (*Children and Young People (Oversight and Advocacy Bodies) Act 2016 (SA)*);

- Хүүхэд, залуучуудын (Аюулгүй байдал) тухай хууль (Children and Young People (Safety) Act 2017 SA);
- Гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль (Domestic Violence Act 1994 SA);
- Гэр бүлийн болон нийгмийн үйлчилгээний тухай хууль (Family and Community Services Act 1972 SA);
- Өсвөр насны гэмт хэрэгтний тухай хууль (Young Offenders Act 1994 SA)

Тасманид гол хууль нь **Хүүхэд, залуучууд болон тэдний гэр бүлийн тухай хууль** (Children, Young Persons and their Families Act 1997 Tas.) юм. Түүнээс гадна дараах хуулиудаар зохицуулдаг. Үүнд:

- Хүүхэд үрчлэх тухай хууль (Adoption Act 1988 Tas.);
- Хүүхдийн асрамжийн тухай хууль (Child Care Act 2001 Tas.);
- Хүүхэд хамгаалах (Олон улсын арга хэмжээ) тухай хууль (Child Protection (International Measures) Act 2003 Tas.);
- Хүүхэд, залуучуудын Комиссарын тухай хууль (Commissioner for Children and Young People Act 2016 Tas.);
- **Нийгмийн хамгааллын (Гэмт хэрэгтний тухай мэдээллэх) тухай хууль (Community Protection (Offender Reporting) Regulations 2016);**
- Боловсролын тухай хууль (Education Act 1994(Tas.));
- Гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль (Family Violence Act 2004 Tas.);
- Эмзэг бүлгийн хүмүүстэй ажиллахад шаардлагатай бүртгэлийн тухай хууль (Registration to Work with Vulnerable People Act 2013 Tas.);
- Өсвөр насны гэмт хэрэгтнийг шүүх тухай хууль (Youth Justice Act 1997 (Tas.)) зэрэг болно.

Виктори мужид гол хууль нь **Хүүхэд, залуучууд болон гэр бүлийн тухай хууль** (Children, Youth and Families Act 2005 Vic.) юм. Түүнээс гадна дараах хуулиудыг баримталдаг. Үүнд:

- Хүүхэд үрчлэх тухай хууль (Adoption Act 1984 Vic.);
- Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн тухай хууль (Child Employment Act 2003 Vic.);
- Хүүхдийн сайн сайхан болон аюулгүй байдлыг хангах тухай хууль (Child Wellbeing and Safety Act 2005 Vic.);
- Хүүхэд болон шүүхийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт (Хүүхдийг шүүх ажиллагаанд шинэчлэл хийх) оруулах тухай хууль (Children and Justice Legislation Amendment (Youth Justice Reform) Act 2017 Vic.);
- Хүүхэд, залуучуудын асуудал хариуцсан хорооны тухай хууль (Commission for Children and Young People Act 2012 Vic.);
- Гэр бүлийн хүчирхийлээс хамгаалах тухай хууль (Family Violence Protection Act 2008 Vic.);
- Бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэгтнүүдийг бүртгэх тухай хууль (Sex Offenders Registration Act 2004 Vic.);
- Хүүхэдтэй ажиллах тухай хууль (Working with Children Act 2005 Vic.) зэрэг болно.

Баруун Австралид Хүүхдийн болон нийгмийн үйлчилгээний тухай хууль (*Children and Community Services Act 2004 WA*) нь хүүхэд хамгааллын гол хууль юм. Түүнээс гадна уг асуудлыг зохицуулдаг дараах хуулиуд байна. Үүнд:

- Хүүхэд үрчлэх тухай хууль (*Adoption Act 1994 WA*);
- Хүүхдийн асрамж үйлчилгээний тухай хууль (*Child Care Services Act 2007 WA*);
- Хүүхдийн болон нийгмийн үйлчилгээний тухай хууль (*Children and Community Services Act 2004 WA*);
- Хүүхэд, залуучуудын Комиссарын тухай хууль (*Commissioner for Children and Young People Act 2006 WA*);
- Нийгмийн хамгааллын (Гэмт хэрэгтний тухай мэдээллэх болон бүртгэх) тухай хууль (*Community Protection (Offender Reporting and Registration) Act 2004 WA*);
- Гэр бүлийн шүүхийн тухай хууль (*Family Court Act 1997 WA*);
- Хязгаарлах журмын тухай хууль (*Restraining Orders Act 1997 WA*);
- Хүүхэдтэй ажиллах (Гэмт хэрэгт холбогдсон эсэхийг шалгах) тухай хууль (*Working with Children (Criminal Record Checking) Act 2004 WA*);
- Өсвөр насны гэмт хэрэгтний тухай хууль (*Young Offenders Act 1994 (WA)*) зэрэг хуулиуд багтана.

Эдгээр хууль тогтоомжийн хүрээнд хүүхэд хамгаалалтай холбоотой дараах асуудлуудыг зохицуулж байна. Үүнд:

- гэрээс гадуурх асрамжийн үйлчилгээ (*Out-of-home care*);
- Абориген болон Торрес Страйт арлын өвөрмөц соёлд хандах хандлага;
- асрамжийн дараах дэмжлэг (*after-care support*);
- тусламж үйлчилгээг тасралтгүй төлөвлөж, тогтмол хүргэх;
- гэмт хэрэгт холбогдсон хүүхэд, залуучуудыг шүүх;
- бэлгийн хүчирхийлэлд холбогдсон гэмт хэрэгтнийг бүртгэх болон мэдээллэх;
- хүүхэдтэй ажиллах;
- гэр бүлийн болон хүүхэд асрамжийн үйлчилгээ;
- гэр бүл болон гэр бүлийн хүчирхийлэл;
- олон улсын орчинд хүүхэд хамгаалах;
- хүүхэд үрчлэх болон асран хамгаалах;
- хүүхдийн Комиссар, асран хамгаалагч, өмгөөлөгчийн тухай;
- хүүхдийн хөдөлмөр эрхлэлт зэрэг болно

Out-of-home care буюу гэрээс гадуурх асрамжийн үйлчилгээ. Энэ нь гэр бүлийн хүчирхийлэл болон бусад шалтгааны улмаас гэр бүлдээ амьдрах боломжгүй хүүхдэд үзүүлэх үйлчилгээ бөгөөд хүүхэд хамгаалах хамгийн эцсийн шатны хууль ёсны арга хэмжээ юм. Эцэг, эх нь хүүхдээ уг үйлчилгээнд сайн дураар хамруулах зохицуулалт байдаг боловч ихэнх тохиолдолд холбогдох шүүхийн шийдвэрээр гүйцэтгэдэг.

Абориген болон Торрес Страйт арлын өвөрмөц соёлд хандах хандлага. Аль ч харьяа газар нутгийн хууль тогтоомжид уугуул, уугуул бус бүх хүүхдийн хувьд соёлын үнэт зүйл болон нийгмийн харилцаанд дасан зохицох чадварыг дэмжих зохицуулалтыг оруулсан байна. Ялангуяа Абориген үндэстэн, Торрес Страйт арлын хүүхэд, залуучууд болон тэдний гэр бүлд зориулсан тусгай заалтуудын хувьд

онцгойлон анхаардаг. (Тухайлбал, “Абориген хүүхдийг байршуулах зарчмууд”).

After-care support буюу асрамжийн дараах дэмжлэг нь гэрээс гадуурх асрамж үйлчилгээ дууссаны дараа бие даан амьдрах үед хэрэгжүүлэх арга хэмжээ бөгөөд энэхүү шилжилтийн үед ч тусламж хэрэгтэй гэсэн ойлголтод үндэслэсэн. Австралийн бүх газар нутгийн хууль тогтоомжууд нь асрамжийн дараах дэмжлэг үйлчилгээний талаар нарийвчлан тодорхойлсон заалттай бөгөөд тухайн үйлчилгээнд хамрагдах насны хувьд ялгаатай байна. Тухайлбал, Виктор болон Күйнсланд мужийн хуулиар 21 нас хүртэл гэж заасан бол Шинэ Өмнөд Уэльс, Өмнөд Австрали, Умард бүс нутаг, Баруун Австралид 25 нас хүртэл гэжээ. Харин Австралийн нийслэлийн бүс нутаг болон Тасманы хууль тогтоомжуудад насны хязгаар заагаагүй байна.

Тусламж үйлчилгээг тасралтгүй төлөвлөж, тогтмол хүргэх. Энэ нь Австралийн хүүхэд хамгааллын хүрээнд сүүлийн үед хөгжиж байгаа арга хэмжээ бөгөөд гэрээс гадуурх асрамж үйлчилгээнд хамардаг хүүхдийн ирээдүйн тогтвортой байдлыг хангахад гол анхаарлаа хандуулдаг. Өөрөөр хэлбэл, хүүхэд гэр бүлдээ аюулгүй амьдрах боломжгүй тохиолдолд урт хугацааны халамж үйлчилгээг хөгжүүлэх үйл ажиллагаа юм. Энэ нь сүүлийн үед нэвтэрч байгаа тул түүний талаар харьяа газар нутаг бүрийн хууль тогтоомжид хараахан тусгаж амжаагүй. Хууль тогтоомждоо тусгайлан оруулаагүй байгаа газар нутгийн хувьд түүнийг бодлогын хүрээнд зөвлөмж хэлбэрээр тусгажээ.

Гэмт хэрэгт холбогдсон хүүхэд, залуучуудыг шүүх. Австралийн ихэнх муж болон харьяа газар нутаг нь гэмт хэрэгт холбогдсон хүүхэд, залуучуудыг шүүх тухай тусгайлсан хуультай байна. Харин Австралийн нийслэлийн бүс нутагт уг асуудлыг Хүүхэд, залуучуудын тухай хуулиар зохицуулдаг. Шинэ Өмнөд Уэльст Өсвөр насны гэмт хэрэгтний тухай хууль (*Young Offenders Act 1997 NSW*), Хойд бүс нутагт Өсвөр насны гэмт хэрэгтнийг шүүх тухай хууль (*Youth Justice Act 2005 NT*), Күйнсландад Өсвөр насны гэмт хэрэгтнийг шүүх тухай хууль (*Youth Justice Act 1992 Qld*) гэх мэтчилэн муж болон харьяа газар нутаг болгон өөр өөрийн тусгайлсан хуулийг хэрэглэдэг.

Бэлгийн хүчирхийлэлд холбогдсон гэмт хэрэгтнийг бүртгэх болон мэдээллэх талаар зохицуулдаг хууль тогтоомжуудад зааснаар уг хэргийг хийсэн гэмт этгээд нь гэрийн хаяг, ажлын байр гэх мэт өөрийн хувийн мэдээллийг цагдаагийн газар заавал мэдэгдэх үүрэгтэй байна. Ингэснээр бүртгэлтэй гэмт хэрэгтнүүд дахин хүүхдэд хохирол учруулах эрсдэлээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой. Уг асуудалтай холбоотой муж болон харьяа газар нутгууд тус тусын хуулийг хэрэгжүүлдэг. Тухайлбал, Австралийн нийслэлийн бүс нутгийн хувьд Гэмт хэргийн (Хүүхдийн бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэгтэн) тухай хуулиар (*Crimes (Child Sex Offenders) Act 2005 ACT*), Өмнөд Австралид Хүүхдийн бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэгтнийг бүртгэх тухай хуулиар (*Child Sex Offenders Registration Act 2006 SA*), Хойд бүс нутагт Хүүхэд хамгаалах (Гэмт хэрэгтний талаар мэдээллэх болон бүртгэх) тухай хуулиар (*Child Protection (Offender Reporting and Registration) Act 2016 NT*) зохицуулах бөгөөд бусад муж болон харьяа газар нутгууд мөн адил тус тусын хуультай.

Хүүхэдтэй ажиллах талаар зохицуулдаг хууль тогтоомжид хүүхдийг бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах баталгааг хангахын тулд хүүхэдтэй ойр ажилладаг насанд хүрэгсэд, эсвэл асран

хамгаалагчийг шалгадаг зохицуулалтыг оруулсан. Жишээлбэл, Австралийн нийслэлийн бүс нутагт Эмзэг бүлгийн хүмүүстэй ажиллах (Тодорхойлолт шалгах) тухай хууль (*Working with Vulnerable People (Background Checking) Act 2011 ACT*), Өмнөд Австралид Хүүхэд хамгаалах тухай хуулиар (*Children's Protection Act 1993 SA*) тус тус зохицуулж байна. Бусад муж болон харьяа газар нутгуудийн хувьд тус тусын зохицуулалтыг хэрэглэдэг.

Гэр бүлийн болон хүүхдийн асрамж үйлчилгээний тухай хууль тогтоомжууд нь гэрээс гадуурх асрамж үйлчилгээний зөвшөөрөл олгох, хүүхдийг уг үйлчилгээнд хамруулах зэрэг асуудлыг зохицуулдаг. *Хойд бүс нутагт Хүүхдийг асрах болон хамгаалах тухай хууль (Care and Protection of Children Act 2007 NT)*, Тасманд Хүүхэд, залуучууд болон гэр бүлийн тухай хууль (*Children, Young Persons and their Families Act 1997 Tas.*), Хүүхэд асрамжлах тухай (*Child Care Act 2001 Tas.*) хууль зэрэг хуулиудаар зохицуулдаг бөгөөд бусад муж болон харьяа газар нутгууд өөр өөрийн холбогдох хуулийг хэрэглэнэ.

Гэр бүл болон гэр бүлийн хүчирхийлэл. Бүх муж, харьяа газар нутаг болгон гэр бүл болон гэр бүлийн хүчирхийллийн тухай хуультай байна. Эдгээр хуульд хүүхэд хамгаалах асуудлыг тусгасан.

Австралийн нийслэлийн бүс нутагт Гэр бүлийн хүчирхийллийн тухай (*Family Violence Act 2016 ACT*), Шинэ Өмнөд Уэльст Гэмт хэргийн (Гэр бүлийн болон хувь хүний хүчирхийлэл) тухай хууль (*Crimes (Domestic and Personal Violence) Act 2007 NSW*), Хойд бүс нутагт Гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль (*Domestic and Family Violence Act 2007 NT*), Күйнсландад Гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах тухай хууль (*Domestic and Family Violence Protection Act 2012 Qld*), Өмнөд Австралид Гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль (*Domestic Violence Act 1994 SA*), Тасманид Гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль (*Family Violence Act 2004 Tas.*), Викторид Гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах тухай хууль (*Family Violence Protection Act 2008 Vic.*), Баруун Австралид Хязгаарлах журмын тухай (*Restraining Orders Act 1997 WA*) хуулиар тус тус зохицуулна.

Олон улсын орчинд хүүхэд хамгаалах. Ихэнх муж болон харьяа газар нутагт олон улсын нөхцөлд хүүхэд хамгаалах, улс хооронд хүүхэд үрчлэх тохиолдолд Хамтын нөхөрлөлийн хууль эрх зүйн зохицуулалтыг баримталдаг. Шинэ Өмнөд Уэльс, Күйнсланд, Тасмани зэрэг муж нь уг асуудлыг тусгайлсан хуулиар зохицуулж байна. Эдгээр мужид Шинэ Өмнөд Уэльсийн Хүүхэд хамгаалах (Олон улсын арга хэмжээ) тухай хууль (*Child Protection (International Measures) Act 2006 NSW*), Күйнсландийн Хүүхэд хамгаалах (Олон улсын арга хэмжээ) тухай хууль (*Child Protection (International Measures) Act 2003 Qld*), Тасманий Хүүхэд хамгаалах (Олон улсын арга хэмжээ) тухай хууль (*Child Protection (International Measures) Act 2003 Tas.*) зэрэг хуулийг хэрэгжүүлдэг.

Хүүхэд үрчлэх болон асран хамгаалах. Австралийн бүх муж болон харьяа газар нутаг нь хүүхэд үрчлэх тухай өөр өөрийн тусгайлсан хуультай. Хойд бүс нутгаас бусад бүх муж болон Австралийн нийслэлийн бүс нутаг нь ижил хүйстэн хосуудад хүүхэд үрчлэхийг хуулиар зөвшөөрсөн байна. Тухайлбал, Австралийн нийслэлийн бүсийн Хүүхэд үрчлэх тухай хууль (*Adoption Act 1993 ACT*), Шинэ Өмнөд Уэльсийн Хүүхэд үрчлэх тухай хууль (*Adoption Act 2000 NSW*), Хойд бүс нутгийн Хүүхэд үрчлэх

тухай хууль (*Adoption of Children Act 1994 (NT)*) гэх мэт.

Хүүхдийн Комиссар, асран хамгаалагч, өмгөөлөгч нь эрх бүхий байгууллагаас томилогдох бөгөөд муж болон харьяа газар нутагт хүүхдийн эрхийг өмгөөлөн хамгаалах, тэдний ашиг сонирхлыг хамгаалах ба хүүхдийн сайн сайхны төлөө ажиллана. Комиссар нь хүүхдэд нөлөө үзүүлэх, хохирол учруулах, хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх хууль тогтоомж, бодлогыг хянаж үзэх үүрэгтэй. Австралийн нийслэлийн бүс нутагт Хүүхэд, залуучуудын тухай хуулиар (*Children and Young People Act 2008 ACT*), Шинэ Өмнөд Уэльст Хүүхэд, залуучуудыг өмгөөлөх тухай хууль (*Advocate for Children and Young People Act 2014 NSW*), Хойд бүс нутагт Хүүхдийн Комиссарын тухай хуулиар (*Children's Commissioner Act 2013 NT*) гэх мэтчилэн муж болон харьяа нутаг бүр өөр өөрийн хуулиар зохицуулж байна.

Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт. Муж болон харьяа газар нутгууд нь хүүхэд хийж болох ажил хөдөлмөрийн төрөл болон ажиллах нөхцөлийг хуулиар тогтоосон байдаг. Шинэ Өмнөд Уэльс, Күйнсланд, Виктори мужууд хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн тухай тусгайлсан хуультай. Харин бусад муж болон газар нутаг нь холбогдох хуулийн заалтаар зохицуулдаг байна. Өмнөд Австралид Боловсролын тухай хуулийн (*Education Act 1972 (SA)*) холбогдох зүйл заалт, Тасманид Хүүхэд, залуучууд болон гэр бүлийн тухай хуулийн (*Children, Young Persons and their Families Act 1997 Tas.*) холбогдох зүйл заалтыг тус тус хэрэглэдэг.

Австралийн муж болон харьяа газар нутаг нь хүүхэд хамгаалах талаар өөр өөрийн зохицуулалтыг хэрэгжүүлдэг боловч хууль, эрх зүйн зарим зохицуулалтыг нийтлэг хэрэглэж байна. Тухайлбал, Австралийн хүүхэд хамгаалах Үндэсний хөтөлбөр 2009-2020, Үндэсний стандарт (гэрээс гадуурх асрамж үйлчилгээний хэрэгжилтийг зохицуулдаг), *Working with children check* (хүүхдийн аюулгүй байдлыг хангах зорилготой хөтөлбөр) зэрэг хөтөлбөрүүдийг нэрлэж болно.

“Австралийн хүүхэд хамгаалах Үндэсний хөтөлбөр 2009-2020” (*National Framework for Protecting Australia's Children 2009–2020*)-ийг Австралийн Засгийн газрын Зөвлөлөөс боловсруулан гаргасан. Энэ нь бодлого болон хууль тогтоомж боловсруулахад хүүхдийн ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавихыг зорьдог бөгөөд нийгмийн эрүүл энх, сайн сайхны төлөө үйлчилдэг. Хөтөлбөр нь бүх муж болон харьяа газар нутгийн хэмжээнд хэрэглэгдэх нэгдсэн баримт бичиг бөгөөд хүүхэд хамгаалах асуудлын зохион байгуулалтыг өөрчлөн шинэчлэх зорилготой үндэсний хэмжээний зөвлөмж юм. Энэхүү хөтөлбөрөөр муж болон харьяа газар нутгийн хууль эрх зүйн ялгаа, үл зохицох байдлыг шийдвэрлэхийг зорьсон.

Муж болон харьяа газар нутгийн түвшинд нийтлэг хэрэглэгдэх хууль тогтоомж байхгүй боловч бодлогын болон практик түвшинд энэхүү ялгаа, үл зохицох байдлыг арилгахад анхаарал хандуулж байна. Тухайлбал, “*Working with Children Check*” буюу хүүхдийн аюулгүй байдлыг хангах зорилго бүхий баримт бичгийг нэгэн жигд хэрэгжүүлэх замаар ижил зохицуулалттай болгох нь Үндэсний хөтөлбөрийн нэн тэргүүний зорилтуудын нэг юм. Бодлогын түвшинд, гэрээс гадуурх асрамж үйлчилгээний хувьд нэгдмэл хууль тогтоомж байхгүй ч, түүний хэрэгжилтийн талаар зохицуулсан Үндэсний стандарт нийтлэг хэрэглэгддэг.

Хүүхэд хамгааллын бусад хууль тогтоомжууд

Австралийн зарим муж болон харьяа газар нутгийн цагдаагийн албаны эрх, үүрэгтэй холбоотой хууль тогтоомжуудад бэлгийн хүчирхийлэл, хүүхэд хулгайлах зэрэг хүүхэд хамгаалалтай холбоотой зарим зохицуулалтыг тусгасан байна. Ингэснээр хүүхэд хамгаалах тухай (ялангуяа хүүхдийн хүчирхийлэл болон хүүхдийг хайхрахгүй орхих) хуулиудад заасан цагдаагийн албаны эрх, үүргийг илүү нарийвчлан тодорхойлжээ.

Австралийн нийслэлийн бүс нутаг, Өмнөд Австрали, Виктори, Баруун Австралид цагдаагийн байгууллага нь хүүхдийн хүчирхийлэл болон хүүхдийг үл хайхрах талаарх асуудлыг хариуцдаг боловч цагдаагийн эрх, үүргийн тухай хуульд хүүхэд хамгаалах талаарх зохицуулалт оруулаагүй. Харин Шинэ Өмнөд Уэльсийн Хууль сахиулах (Эрх мэдэл болон үүрэг хариуцлага) тухай хууль (*Law Enforcement (Powers and Responsibilities) Act 2002 NSW*), Хойд бүс нутгийн Эрүүгийн хууль (*The Criminal Code Act 2006 NT*), Күйнсландын Цагдаагийн албаны эрх, үүргийн тухай хууль (*Police Powers and Responsibilities Act 2000 Qld*), Тасманий Цагдаагийн хэв журам зөрчих тухай (*Police Offences Act 1935 Tas.*) зэрэг хуулиудад хүүхэд хамгааллын талаарх зарим зохицуулалтыг тусгасан байна.

Австрали нь НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай Конвенцод нэгдэн орсон оролцогч улс бөгөөд конвенцын зарчмыг Австралийн хүүхэд хамгаалалтай холбоотой хууль тогтоомжид тусгажээ. Түүнчлэн Хамтын нөхөрлөлийн (*Commonwealth (Cth)*) хуулиуд, тухайлбал, Гэр бүлийн тухай хууль (*Cth*), Австралийн Хүний эрхийн Комиссын тухай хуулиудын (*Cth*) үндсэн санааг муж болон харьяа газар нутгийн хуулиудад тусгасан байна.

Мөн зарим муж болон харьяа газар нутгийн хүний эрхийн тухай хууль тогтоомжид хүүхэд хамгаалах талаар зохицуулжээ. Үүнд:

- Австралийн нийслэлийн бүс нутгийн Хүний эрхийн Комиссын тухай хууль (*Human Rights Commission Act 2005 ACT*);
- Шинэ Өмнөд Уэльсийн Хүний эрхийн тухай хууль (*Human Rights Act 2004 NSW*);
- Виктори мужийн Хүний эрх, үүргийн журмын тухай хууль (*The Charter of Human Rights and Responsibilities Act 2006 Vic.*) зэрэг хуулиуд нь хүүхэд хамгаалах тухай зохицуулалтыг агуулдаг.

Хүүхэд хамгаалах тухай хууль тогтоомж муж болон харьяа газар нутаг болгоны хувьд ялгаатай байгаа нь тухайн газар нутгийн хэрэгцээ шаардлагатай холбоотой юм. Хэдий тийм боловч дараах асуудлуудын хүрээнд ижил зарчим баримталдаг. Үүнд:

1. *Хүүхдийн нэн тэргүүний ашиг сонирхол (best interest of the child)*. Бүх муж болон харьяа газар нутгийн хууль тогтоомжид үүнийг анхдагч зарчим хэмээн үзэж шийдвэр гаргахад чухалчлан авч үздэг. Хууль тогтоомж бүрт үүнтэй холбоотой заалтыг оруулсан байна.
2. *Эрт оролцоо (early intervention)*. Муж болон харьяа газар нутаг нь эрт оролцоог дэмжин хэрэгжүүлдэг ба түүнийг хэрхэн хүргэх нь харилцан адилгүй байна. Энэ нь хүүхдийн хөгжлийн, эрүүл мэндийн, бусад хэрэгцээт дэмжлэгийг аль болох эрт хүргэхийг зорьдог бөгөөд төрсөн цагаас эхлэн сургуульд орох хүртэл нь

хүүхэд болон гэр бүлд үзүүлэх тусгай дэмжлэг юм¹⁶⁶. Эрт оролцоог дэмжихэд муж болон харьяа газар нутгууд ихээхэн анхаарал хандуулж, гэр бүл болон хүүхдийг дэмжих чиглэлээр шинэлэг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. Тухайлбал, Шинэ Өмнөд Уэльсийн “SafeCare”, Баруун Австралийн гэрт нь хүрч үйлчлэх “Best Beginning” зэрэг хөтөлбөрүүдийг онцолж болно¹⁶⁷.

3. *Шийдвэр гаргахад хүүхэд, залуучуудын оролцоог хангах (the participation of children and young people in decision-making processes)*. Австралийн бүхий л газар нутгийн хууль тогтоомж нь шийдвэр гаргах түвшинд хүүхэд, залуучуудын оролцоог дэмжихэд чиглэсэн байдаг (нас болон хөгжлийн түвшинд таарсан). Төрөөс хүүхэдтэй холбоотой асуудлаар аливаа шийдвэр гаргахад хүүхдүүдийн үзэл бодол, саналыг заавал харгалзан үзэх ёстой.

Түүнээс гадна гэрээс гадуурх асрамж үйлчилгээ болон Абориген, Торрес Страйт арлын хүүхдэд зориулсан тусгай заалтуудын хувьд эдгээр зарчмыг мөн адил баримтална.

3.2. ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ АЖИЛЛАДАГ БАЙГУУЛЛАГУУДЫН ТОГТОЛЦОО

Австралийн Нийгмийн үйлчилгээний газрын интернет хуудсанд мэдээлснээр Австрали даяар хүүхдийн төлөө ажилладаг дараах үндсэн байгууллагууд байна¹⁶⁸.

Families Australia нь Австралид хүүхдийн аюулгүй байдал, эрүүл мэндийг хамгаалах үндэсний кампанит ажилд идэвхтэй оролцож буй 200 гаруй төрийн бус байгууллага, судлаачдаас бүрдэнэ.

Австралийн нийслэлийн бүсийн Хүүхэд, залуучууд болон гэр бүлийг дэмжих алба (ACT Office for Children, Youth and Family Support). Хүүхэд, залуучууд болон гэр бүлийг дэмжих үйлчилгээг үзүүлдэг.

Австралийн нийслэлийн бүсийн Хүний Эрхийн Хороо (ACT Human Rights Commission) нь хүүхдийн төлөө идэвхтэй ажилладаг.

Шинэ Өмнөд Уэльсийн Хүүхэд асран хамгаалагчийн алба (Office of Children’s Guardian) нь тус мужийн Хүүхэд, залуучуудын (Асрах болон хамгалах) тухай хуулиар (Children and Young Persons (Care and Protection) Act 1998) байгуулагдсан бөгөөд “Гэрээс гадуурх асрамж” үйлчилгээнд хамрагддаг хүүхдийн эрх, ашиг сонирхлыг дэмжих үүрэгтэй.

Шинэ Өмнөд Уэльсийн Хүүхэд, залуучуудыг өмгөөлөх алба (Office of the Advocate for Children and Young People) нь Шинэ Өмнөд Уэльсийн Хүүхэд, залуучуудыг өмгөөлөх тухай хуулиар (Advocate for Children and Young People Act 2014) байгуулагдсан бөгөөд хүүхдийн эрх, ашиг сонирхлыг өмгөөлөн хамгаалах чиглэлээр ажиллана.

Шинэ Өмнөд Уэльсийн Гэр бүлийн болон нийгмийн үйлчилгээ (NSW Family and Community Services) нь хүүхэд, насанд хүрэгсэд, гэр бүл болон нийгмийн төлөө ажилладаг бөгөөд иргэдэд өөрт буй нөөц боломж, чадвар, чадамжаа таньж мэдэх, амьдралаа дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

¹⁶⁶ <https://raisingchildren.net.au/disability/services-support/services/early-intervention>

¹⁶⁷ Developments to strengthen systems for child protection across Australia. Child Family Community Australia. 2017. P8. https://aifs.gov.au/cfca/sites/default/files/publication-documents/44_child_protection_reforms.pdf

¹⁶⁸ <https://www.dss.gov.au/our-responsibilities/families-and-children/programs-services/protecting-australias-children>

Виктори мужийн Хүүхэд, залуучуудын асуудал хариуцсан хороо (*Commission for Children and Young People*) нь тус мужийн хүүхэд, залуучуудын аюулгүй байдал болон сайн сайхан байдлыг хангахын төлөө ажилладаг.

Виктори мужийн Хүний болон эрүүл мэндийн үйлчилгээний газар (*Vic Department of Health and Human Services*) нь тус мужийн иргэдийн эрүүл, сайн сайхан, аюулгүй байдлыг хангахын төлөө ажиллана.

Тасманий Хүний болон эрүүл мэндийн үйлчилгээний газар (*Tas Department of Health and Human Services - DHHS*) нь Тасманичуудын эрүүл мэнд, аюулгүй байдал, амьдралын баталгааг хангах, хамгаалах, сайжруулах үйл ажиллагааг төлөвлөх, удирдан чиглүүлэхээс гадна эрүүл мэндийн болон хүнд чиглэсэн чанартай үйлчилгээг үзүүлэх зорилготой.

Тасманий Хүүхэд, залуучуудын асуудал хариуцсан Комиссар (*Tas Commissioner for Children and Young People*) нь Тасманий хүүхэд, залуучуудын эрх, ашиг сонирхлыг хамгаалах, аюулгүй байдал болон сайн сайхан байдлыг хангах үүрэгтэй.

Хойд бүс нутгийн Гэр бүлийн газар (*NT Territory Families*) нь Хойд бүс нутгийн Засгийн газрын шийдвэрээр 2016 онд байгуулагдсан. Уг газар нь хүүхэд эрүүл, аз жаргалтай өсөх, ахмад настнуудыг халамжлан асрах бөгөөд гарал угсаа, зан заншил, хэл соёлоос үл хамааран ижил боломж олгодог орчин бүрдүүлэхийн төлөө ажилладаг.

Хойд бүс нутгийн Хүүхэд, залуучуудын асуудал хариуцсан Комиссар (*NT Children's Commissioner*) нь эмзэг бүлгийн хүүхдийн асуудлыг эрхэлсэн бие даасан албан тушаалтан юм.

Күйнсландын Хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан хороо (*Queensland Family and Child Commission*) нь хүүхэд хамгаалах тогтолцооны стратеги хяналтыг хэрэгжүүлдэг бөгөөд хүүхэд, залуучууд, гэр бүлийн сайн сайхан болон аюулгүй байдлыг хангаж, тэдний нэн тэргүүний ашиг сонирхлыг дэмжих чиглэлээр ажилладаг.

Күйнсландын Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон гэр бүлийн асуудал хариуцсан газар (*Department of Communities, Disability Services and Seniors*) нь Күйнсландыг хүүхэд, залуучууд болон гэр бүлд ээлтэй газар болгохын төлөө тэдэнтэй хамтран ажиллахыг зорьдог.

Өмнөд Австралийн Хүүхэд хамгааллын асуудал хариуцсан газар (*SA Department for Child Protection*) нь төрийн болон төрийн бус байгууллагууд, гэр бүл, асран хамгаалагч, хүүхэдтэй ойр байдаг бусад этгээдтэй хамтран хүүхэд, залуучуудыг аюулгүй орчин, тэгш боломжоор хангах зорилготой ажилладаг.

Өмнөд Австралийн Хүүхэд, залуучуудыг асран хамгаалах алба (*SA Office of the Guardian for Children and Young People*) нь хүүхэд залуучуудын эрх, нэн тэргүүний ашиг сонирхлыг өмгөөлөх болон дэмжих үүрэгтэй.

Баруун Австралийн Нийгэм, хүүхэд хамгаалал, гэр бүлийг дэмжих газар (*WA Department of Communities, Child Protection and Family Support*) нь Баруун Австралийн иргэд, хүүхэд болон гэр бүлд зориулж хүүхэд хамгаалах, гэр бүлийг дэмжих үйлчилгээ үзүүлдэг.

Баруун Австралийн Нийгмийн асуудал хариуцсан газар (WA Department for Communities) нь эрүүл чийрэг хүүхэд, тогтвортой гэр бүл, өөртөө итгэлтэй иргэд бүхий орчинг бий болгохын төлөө ажиллана.

Баруун Австралийн Хүүхэд, залуучуудын асуудал хариуцсан Комиссар (WA Commissioner for Children and Young People) нь хүүхэд, залуучууд болон тэдний гэр бүл, төрийн болон төрийн бус байгууллагуудтай нягт хамтран ажиллах бөгөөд Баруун Австралийг 0-18 насны хүүхдэд хамгийн ээлтэй газар болгохын төлөө ажилладаг.

The Line нь 12-20 насны өсвөр залуу үеийнхний зан байдлыг төлөвшүүлэхэд анхаарах бөгөөд түрэмгийлэл, хүчирхийллийг өдөөдөг зан араншинг өөрчлөх замаар эрүүл зөв харилцааг бий болгохын төлөө ажилладаг.

E-аюулгүй байдлын комиссарын алба (Office of the eSafety Commissioner) нь Австраличуудыг аюулгүй бөгөөд эерэг интернет хэрэглээгээр хангах үүрэгтэй.

Хүүхдийн туслах (Kids Helpline). Хүүхдэд туслах утас нь Австралийн 5-25 насны хүүхэд, залуучуудад зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлнэ. Хувийн нууцыг чандлан хадгалдаг бөгөөд 7 хоног, 24 цагаар үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлдэг.

Think you Know. Үүнийг анх Их Британид санаачилсан бөгөөд 2009 оноос Австрали улсад нэвтрүүлж, Австралийн Холбооны цагдаагийн газраас иргэддээ зориулан хөгжүүлсэн. Эцэг, эхчүүд хүүхдүүд нь онлайн орчинд юу үзэж, юу хийж байгаад үргэлж санаа зовохоос гадна яг юу үзэж, юу хийх ёстой талаар мэдэхийг хүсдэг. *Think you Know* нь үүнд үндэслэж, хүүхэд онлайн орчинд юу үзэж, юу ярьж, юу хийх ёстой талаар зөвлөгөө өгөх, хүүхдийг хөгжүүлэх зорилготой ажилладаг.

Австралийн гэр бүл судлалын хүрээлэн (Australian Institute of Family Studies). Засгийн газарт зориулсан гэр бүлийн судалгааны гол эх үүсвэрийг хангадаг мэргэжлийн байгууллага бөгөөд судалгаа, шинжилгээ хийж, бодлого боловсруулагчид, хэрэгжүүлэгч байгууллагууд, нийт иргэдэд гэр бүлийн амьжиргаанд нөлөөлж буй хүчин зүйлүүдийн талаарх ойлголт, зөвлөгөөг өгдөг.

Child Family Community Australia - external site нь гэр бүл, хүүхэд, иргэдийн төлөө ажиллаж буй бодлого боловсруулагчид, хэрэгжүүлэгч байгууллагууд болон судалгааны ажилтнуудад шаардлагатай мэдээллийг солилцох боломж олгодог.

Families and children-external site нь Нийгмийн үйлчилгээний газрын (Department of Social Services) интернет хуудас бөгөөд гэр бүл болон хүүхдийг дэмжих хөтөлбөр, үйлчилгээ, халамж, төлбөрийн талаарх мэдээллийг авах боломжтой.

Family life- external site. Гэр бүлийн эрүүл мэндийн талаарх өргөн хүрээний мэдээлэл бүхий линкүүдийг агуулдаг. Жишээ нь: Нярай хүүхэд, бага насны хүүхдийн тухай, өрхийн хоол хүнсний тухай, гэр бүл салалт, хүүхдийг хэрхэн асрах, хүүхдийн эрүүл мэндийн асуудлууд гэх мэт.

Learning Potential (Department of Education and Training)-external site. Хүүхдэд мэдлэг боловсрол олгоход эцэг, эхчүүдийг зөвлөгөө мэдээллээр хангана. Хүүхэдтэйгээ аль болох их цагийг өнгөрүүлэх тухай ашигтай санаа, зөвлөгөө өгдөг.

Австралид хүүхэд хамгаалах чиглэлээр ажилладаг байгууллага үүгээр хязгаарлагдахгүй бөгөөд төрийн болон төрийн бус олон тооны байгууллага хүүхдийн төлөө ажиллаж байна.

Австрали улс нь НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцын хэрэгжилтийн талаарх 5, 6 дугаар тайлан, илтгэлээ 2018 оны 1 дүгээр сард НҮБ-ын Хүүхдийн хороонд хүргүүлээд байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

БНСУ

- Солонгосын хүний эрхийн үндэсний комисс
<https://www.humanrights.go.kr/site/main/index001>
- 법령/아동복지-Солонгосын хүүхэд хамгааллын тухай хууль /солонгос хэлээр/
<http://www.law.go.kr/>
- Солонгосын хууль тогтоомжийн албан ёсны цахим хуудас <http://www.law.go.kr/>
- Хүний эрхийн үндэсний комиссийн тухай хууль /англи хэл дээр/
<http://www.refworld.org/pdfid/3ddd1a634.pdf>
- Солонгосын хүүхэд хамгаалах байгууллага, хүүхдийн эрхийн конвенцын 5, 6 дугаар тайлан
http://www.adongbokji.or.kr/adong/html/news_view.asp?num=60541569273693&page=1&keyword1=&keyword2=&cate=4&PB=%BA%B8%B0%C7%BA%B9%C1%F6%BA%CE%B9%DF%B0%A3%C0%DA%B7%E1&mode
- НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооноос 3, 4 дүгээр тайланд өгсөн зөвлөмж /солонгос хэл дээр/ <http://childvoice.kr/data/final.pdf>

ОХУ

- Права ребенка: необходимость внедрения новых механизмов защиты (Монография). С.В.Широ. Москва - Мурманск. 2009.
Эх сурвалж: www.crin.org/en/docs/Ombudsman_in_Russia%202009.pdf
- Теоретико-правовые основы защиты конституционных прав и свобод несовершеннолетних в России. Л.Н.Дегтярева (Центральный филиал Российского государственного университета правосудия). Тамбов, 2017. Эх сурвалж: <http://ucom.ru/doc/mon.2017.04.01.pdf>
- Конвенция ООН о правах ребенка (от 20.11.1989 года).
- “Рассмотрение докладов, представляемых государствами-участниками в соответствии со статьей 44 Конвенции”, “Четвертый и пятый периодические доклады государств-участников, подлежащие представлению в 2011 году - РФ”. Организация Объединенных Наций. Комитет по правам ребенка. 03.06.2011 года.
- “Конституция РФ” (принята всенародным голосованием 12.12.1993).
- “Жилищный кодекс РФ” от 29.12.2004 года № 188-ФЗ.
- “Налоговый кодекс” РФ (НК РФ).
- “Семейный кодекс РФ” от 29.12.1995 года.
- “Уголовный кодекс РФ” от 13.06.1996 года № 63-ФЗ.
- “Кодекс РФ об административных правонарушениях” от 30.12.2001 года № 195-ФЗ.
- “Трудовой кодекс РФ” от 30.12.2001 года № 197-ФЗ.
- Федеральный закон “О государственной социальной помощи” от 17.07.1999 года №178-ФЗ.

- Федеральный закон "О дополнительных мерах государственной поддержки семей, имеющих детей" от 29.12.2006 года № 256-ФЗ.
- Федеральный закон "О социальной защите инвалидов в РФ" от 24.11.1995 года № 181-ФЗ.
- Федеральный закон "О трудовых пенсиях в РФ" от 17.12.2001 года № 173-ФЗ.
- Федеральный закон "Об основах системы профилактики безнадзорности и правонарушений несовершеннолетних" от 24.06.1999 года № 120-ФЗ.
- Федеральный закон "Об основах социального обслуживания граждан в РФ" от 28.12.2013 года № 442-ФЗ.
- Федеральный закон "О государственном банке данных о детях, оставшихся без попечения родителей" от 16.04.2001 года № 44-ФЗ.
- Федеральный закон "О государственных пособиях гражданам, имеющим детей" от 19.05.1995 года № 81-ФЗ.
- Федеральный закон "О дополнительных гарантиях по социальной поддержке детей-сирот и детей, оставшихся без попечения родителей" от 21.12.1996 года № 159-ФЗ.
- Федеральный закон "О приватизации жилищного фонда в РФ" от 04.07.1991 года № 1541-1.
- Федеральный закон "О санитарно-эпидемиологическом благополучии населения" от 30.03.1999 года № 52-ФЗ.
- Федеральный закон "Об образовании в РФ" от 29.12.2012 года № 273-ФЗ.
- Федеральный закон "Об основах охраны здоровья граждан в РФ" от 21.11.2011 года № 323-ФЗ.
- Федеральный закон "Об основных гарантиях прав ребенка в РФ" от 24.07.1998 года № 124-ФЗ.
- Указ Президента РФ "Об Уполномоченном при Президенте РФ по правам ребенка" от 01.09.2009 года № 986.
- Указ Президента РФ "О ежемесячных выплатах лицам, осуществляющим уход за детьми-инвалидами и инвалидами с детства I группы" от 26.02.2013 года № 175.
- Указ Президента РФ "О повышении размера компенсационных выплат неработающим трудоспособным лицам, осуществляющим уход за нетрудоспособными гражданами" от 17.03.1994 года № 551.
- Распоряжение Правительства РФ "Нормативы наполняемости классов и групп в образовательных учреждениях" от 03.07.1996 года № 1063-р.
- Распоряжение Правительства РФ "Стратегией развития медицинской науки в РФ на период до 2025 года" от 28 декабря 2012 года № 2580-р.

АВСТРАЛИИ

- Australian child protection legislation <https://aifs.gov.au/cfca/publications/australian-child-protection-legislation>
- Developments to strengthen systems for child protection across Australia. Child Family Community Australia. https://aifs.gov.au/cfca/sites/default/files/publication-documents/44_child_protection_reforms.pdf
- Families Australia - <https://familiesaustralia.org.au/national-coalition/>
- ACT Office for Children, Youth and Family Support - <http://www.communityservices.act.gov.au/ocylfs>

- ACT Human Rights Commission. <http://www.hrc.act.gov.au/>
- Office of Children’s Guardian. <http://www.kidsguardian.nsw.gov.au/>
- Office of the Advocate for Children and Young People - <http://kids.nsw.gov.au/>
- NSW Family and Community Services
http://www.community.nsw.gov.au/welcome_to_docs_website.html
- Commission for Children and Young People. <https://ccyp.vic.gov.au/>
- Vic Department of Health and Human Services. <http://www.cyf.vic.gov.au/>
- Tas Department of Health and Human Services. <http://www.dhhs.tas.gov.au/>
- Tas Commissioner for Children and Young People <http://www.childcomm.tas.gov.au/>
- NT Territory Families. <https://territoryfamilies.nt.gov.au/>
- NT Children's Commissioner. <http://childrenscommissioner.nt.gov.au/>
- Child Safety, Youth and Women. <https://www.communities.qld.gov.au/>
- Queensland Family and Child. <https://www.qfcc.qld.gov.au/contact-us>
- SA Department for Child Protection. <https://www.childprotection.sa.gov.au/>
- SA Office of the Guardian for Children and Young People. <http://www.gcyp.sa.gov.au/>
- WA Department of Communities, Child Protection and Family Support.
<http://www.dcp.wa.gov.au/Pages/Home.aspx>
- WA Department for Communities. <http://www.communities.wa.gov.au/Pages/default.aspx>
- WA Commissioner for Children and Young People. <https://www.ccyp.wa.gov.au/>
- The Line - <http://www.theline.org.au/>
- Office of the eSafety Commissioner. <http://www.cybersmart.gov.au/>
- Kids Helpline - <http://www.kidshelp.com.au/>
- Think you Know. <http://thinkuknow.org.au/>
- <https://www.australia.gov.au/information-and-services/family-and-community>

**МОНГОЛ УЛС ДАХЬ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН
ЭРХИЙГ ХАМГААЛАХ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН,
БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АРГА ЗАМУУД**

(Харьцуулсан судалгаа)

*Ц.Норовдондог (Ph.D), О.Нарантуяа
Д.Жигваагүнсэл, Р.Нургүл, Ц.Элбэгзаяа*

АГУУЛГА

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Нэг. Нийгмийн хамгааллын үйлчилгээний хүрээнд

Хоёр. Боловсролын салбарын хүрээнд

Гурав. Эрүүл мэндийн салбарын хүрээнд

Дөрөв. Хөдөлмөр эрхлэлтийн хүрээнд

Тав. Ээлтэй хүртээмжтэй орчин бүрдүүлэх хүрээнд

ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

- БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС
- АВСТРАЛИ УЛС
- ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС

ДҮГНЭЛТ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Дэлхий дээр нэг тэрбум гаруй хүн ямар нэгэн хөгжлийн бэрхшээлтэй амьдарч байгаа бөгөөд 200 орчим сая хүн үйлдлийн бэрхшээлтэй амьдарч байна. Хүн амын өсөлт нэмэгдэх тусам хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо ч улам бүр өсөн нэмэгдэж байна гэж Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан байна.

НҮБ-аас 2006 онд “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц”-ыг баталсан бөгөөд тус конвенц нь “бүх хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хүний эрх, эрх чөлөөг бүрэн дүүрэн, тэгш эдлэхийг нь дэмжих, хамгаалах, баталгаажуулах, мөн тэдний эрхэм байдлыг хүндэтгэхийг дэмжих” зорилготой. Тус конвенцод Монгол Улс 2009 оны 5 дугаар сарын 13-нд нэгдэн орсон.

Манай улсад 2017 оны байдлаар хөгжлийн бэрхшээлтэй нийт **103.630** хүн, үүнээс төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй **44.384** хүн, олдмол хөгжлийн бэрхшээлтэй **59.246** хүн байна. Хөгжлийн бэрхшээлтэй нийт хүн амыг хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээр авч үзвэл хөдөлгөөний бэрхшээлтэй хүн ам хамгийн их буюу 19.9 хувь (20.6 мянга), ярианы бэрхшээлтэй хүн ам хамгийн бага буюу 4.0 хувь (4.2 мянга) байна.

Одоогийн байдлаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг зохицуулсан 70 гаруй хууль, эрх зүйн акт үйлчилж байна. Манай улс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг зохицуулсан анхны бие даасан хуулийг 2005 онд Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль нэртэйгээр баталсан бөгөөд 2016 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг шинэчлэн баталсан. Тус хууль нь Монгол Улс дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэний асуудлыг зохицуулж буй суурь хууль юм.

Тус хууль нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалахад тэднийг нийгмийн амьдралд эрх тэгш оролцоход аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахыг үл тэвчих, хөгжлийн бэрхшээлтэй хүний сонголт хийх эрх, хараат бус байдлыг хүндэтгэх, сурч боловсрох, хөдөлмөрлөх, нийгэмших зэрэг бүхий л харилцаанд тэгш оролцох боломжийг бүрдүүлэхээр хуульчилсан.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээг үзүүлэх хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль зэрэг 14 хууль тогтоомж үйлчилж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль болон Нийгмийн халамж, хамгааллын тухай хуульд заасны дагуу 15 төрлийн мөнгөн болон бусад дэмжлэг, хөнгөлөлт, чөлөөлөлтийг олгож байна. Дээрх хуулийн дагуу Нийгмийн даатгалын болон халамжийн тэтгэвэрийн хэмжээг үе шаттай нэмэгдүүлж байгаа бөгөөд 2019 оны 1 сард нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг 179.000 төгрөг, асаргааны тэтгэмжийн хэмжээг 76.000 төгрөг болгож нэмэгдүүлсэн. Дээрх тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг хүн амын амьжиргааны доод түвшинтэй уялдуулан нэмэгдүүлдэг.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох нийгмийн халамж тэтгэвэр, тэтгэмжийг ОХУ-д Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын тухай хууль, тэтгэврийн тухай хуулиар зохицуулдаг. Тус хуулиар 120-5500 рублийн мөнгөн тэтгэмж болон орон сууц, засвар үйлчилгээний нөхөн олговор олгодог байна. Тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг

тогтоохдоо хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулан тогтоодог.

БНСУ-ын хувьд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн халамжийн тухай хуулиар зохицуулдаг. Тус улс хөгжлийн бэрхшээлтэй иргэддээ хууль тогтоомжид заасан 41 нэр төрлийн мөнгөн болон бусад тэтгэвэр, тэтгэмж, дэмжлэг туслалцааг үзүүлдэг. Тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ нь бэрхшээлийн хэлбэр, ангилалаас хамаарч харилцан адилгүй байдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сурч, боловсрох эрхийг хангах хүрээнд 11 хууль, УИХ-ын болон Засгийн газрын 5 тогтоол, салбарын сайдын 2 тушаал, Олон улсын 3 конвенц үйлчилж байна. Монгол Улсын Үндсэн хуулийн 16.7 болон Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай хуулийн 4 дүгээр бүлэгт хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрхийг баталгаажуулж өгсөн. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тухайн хөгжлийн бэрхшээлээс нь үл хамаарч бүх шатны боловсролын байгууллагад бүрэн хамруулах зорилгоор тусгай хэрэгцээт боловсрол олгож буй сургалтын байгууллагад олгож буй санхүүжилтийг нэг сурагчийн хувьсах зардлын нормативийг 3 дахин нэмэгдүүлж олгож байна.

Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас 2018-2019 оны хичээлийн жилд цэцэрлэгийн насны 1088 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байна үүнээс тусгай 186 дугаар цэцэрлэгт 73 хүүхэд, 10 дугаар цэцэрлэгт 116 хүүхэд хамрагдаж байна.

2017-2018 оны хичээлийн жилийн статистик мэдээллээр хөгжлийн бэрхшээлтэй 7279 хүүхэд ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа бөгөөд үүнээс 1637 нь ерөнхий боловсролын тусгай сургуульд суралцаж байна.

2017-2018 оны хичээлийн жилд улсын хэмжээнд 85 мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад 35.800 суралцагч суралцсанаас 673 хөгжлийн бэрхшээлтэй суралцагч суралцсан байна. Улсын хэмжээнд 85 мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага байдгийн төрийн өмчийн 30, төрийн өмчийн бус 14 нийт 44 МСҮТ, политехник коллежид 673 хөгжлийн бэрхшээлтэй суралцагч суралцсанаас 556 суралцагч буюу 15-34 насны залуус 82.6 хувийг эзэлж байна.

Харин багшлах боловсон хүчин бэлтгэх ажлын хүрээнд зайлшгүй шаардлагатай байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажиллах багш, сувилахуй, физик эмчилгээ, хөдөлгөөн засал, хэл, сонсгол, хараа зүй, эм зүй зэрэг 9 мэргэжлийн чиглэлээр ОХУ-д 15 оюутан, Япон улсад 5 жилийн хугацаанд жил бүр 10 оюутныг 100 хувийн тэтгэлэгтэйгээр суралцуулах ажлыг зохион байгуулж байна.

ОХУ-ын хувьд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын тухай” хуулийн 19 дүгээр зүйлд “Төрөөс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг боловсрол эзэмших явдлыг бүхий л талаар дэмжин, үүний тулд шаардлагатай нөхцөлийг баталгаатай хангана”¹⁶⁹ гэж заасан байдаг бөгөөд гэрийн нөхцөлд нь сургахад дэмжих, түүнчлэн “Боловсролын тухай”¹⁷⁰ хуулийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэд мэргэжлийн боловсролыг нэг бус удаа үнэ төлбөргүй эзэмших эрхтэй бөгөөд тэдэнд оюутны цалинг 50 хувь нэмэгдүүлэн олгодог байна.

¹⁶⁹ ФЗ “О социальной защите инвалидов в российской федерации.” www.docs.cntd.ru

¹⁷⁰ ФЗ “Об образовании.” Consultant.ru

БНХАУ-ын хувьд Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамгаалах тухай хуулиар "Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн боловсрол эзэмших эрхийг төрөөс баталгаажуулна... Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудад албан ёсны боловсролыг олгоно... албан ёсны боловсрол эзэмшиж буй сурагчдад төрөөс сургалтын төлбөр ногдуулахгүй." Гэж заасан. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан тусгай сургуулиуд байхын зэрэгцээ ердийн буюу үндсэн сургуулиуд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг элсүүлэн авдаг байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх хүрээнд Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль болон бусад бодлого, хөтөлбөрүүд үйлчилж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай хуулийн 6 болон 7 дугаар бүлэгт хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаар зохицуулсан.

Мөн Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцын 25 дугаар зүйлд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэндийн асуудлыг тусгасан. Конвенцын оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хүн амд суурилсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үнэ төлбөргүй буюу худалдан авах чадавхид нийцсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, хөтөлбөрөөр хангах, эрт оношлох зэрэг эрүүл мэндийн үйлчилгээг ямар нэг алагчлалгүйгээр үзүүлэхээр заасан.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хүрээнд Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль зэрэг 6 хууль, бусад эрх зүйн акт, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын хөдөлмөрийн байгууллагын конвенцууд үйлчилж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай хуулийн 5 дугаар бүлэгт хөдөлмөр эрхлэлттэй холбоотой асуудлыг тусгасан.

Үндэсний статистикийн хорооны 2017 оны мэдээгээр хөгжлийн бэрхшээлтэй хөдөлмөрийн насны **19 974** хүн хөдөлмөр эрхэлж байна. Үүнээс хувиараа хөдөлмөр эрхлэгч-41.7 хувь, цалин хөлстэй ажиллагч-35.7 хувь, өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч-20.1 хувь, ажил олгогч-1.6 хувь, нөхөрлөл, хоршооны гишүүн-0.3 хувь байна. Хөдөлмөр эрхэлдэггүй хөгжлийн бэрхшээлтэй хүн **73 285** байна.

Хөдөлмөрийн хуулийн 111 дүгээр зүйлд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүний хөдөлмөрийн харилцааг зохицуулсан. Үүнд, 25 болон түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нь ажил, албан тушаалынхаа 4, түүнээс дээш хувийн орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулахаар заасан. 2017 оны байдлаар улсын хэмжээнд 25 ба түүнээс дээш ажилтантай 6479 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байгаагаас тэдгээрийн 43 хувь нь Хөдөлмөрийн хуулийн 111 дүгээр зүйлийг хэрэгжүүлж байна.

Үүнтэй ижил төстэй зохицуулалтыг БНХАУ-ын хувьд Засгийн газраас бүх улсын болон хувийн салбарын ажил олгогч нарт ажлын байрны 1,5%-аас багагүй, ОХУ-ын хувьд 100-аас дээш ажилтантай байгууллагад ажилтны дундаж тоонд хувь тэнцүүлэн (2 хувиас доошгүй, 4 хувиас дээшгүй), ХБНГУ-д 16-аас доошгүй тооны ажилтантай нийтийн болон хувийн хэвшлийн байгууллагууд нийт ажлын байрны 6 хувьтай тэнцэх ажлын байранд хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллуулах, БНСУ-д

шинээр бий болж буй төрийн албаны орон тооны 10%-д нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг авч ажиллуулахаар тус тус заасан байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд бие даан ажиллаж амьдрахад дэд бүтэц хамгийн чухал нөлөөтэй. Гэвч манай улсын ихэнх барилга байгууламж (олон нийтийн барилга байгууламж хамрагдаад), нийтийн тээврийн тогтолцоо болон мэдээ, мэдээллийн хүргэх хүртээмж хангалтгүй байна. Нийтийн тээврийн хэрэгслийн хүртээмж дутмаг байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүн ажил хайх, эсвэл эрүүл мэндийн тусламж дэмжлэг саадгүй авахад хүндрэл учруулдаг шалтгаан юм. Хараа болон сонсголын бэрхшээлтэй иргэд мэдээ, мэдээлэл авахад бага хэмжээний мэдээлэл тохирох форматаар байдаг нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээ хангагдаж чадахгүй байна.

Эдгээр асуудлыг зохицуулах эрх зүйн орчны хүрээнд Барилгын тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль, Автотээврийн тухай хууль, Автозамын тухай хууль, Харилцаа холбооны тухай хууль, Сонгуулийн тухай хууль, Олон нийтийн радио, телевизийн тухай хууль гэх мэт 17 хууль тогтоомж үйлчилж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 3 дугаар бүлэгт хүний ажиллаж амьдрах орчин нөхцөлийн талаар зохицуулсан. Хуулийн 6 дугаар зүйлд хөгжлийн бэрхшээлтэй хүний таатай, аюулгүй орчинд амьдрахад иргэн, хуулийн этгээд ялгаварлан гадуурхаж үл болно. Нийтийн тээврээр зорчих, дэд бүтэц, орон сууц, олон нийтийн барилга байгууламжид саадгүй хүрэх, нийтийн тээврийн хэрэгслээр чөлөөтэй зорчих нөхцөлийг бүрдүүлээгүй, хөгжлийн бэрхшээлтэй хүн мэдээлэл авах, бусадтай харилцахад шаардлагатай орчин нөхцөлийг бүрдүүлээгүй нь ялгаварлан гадуурхалт гэж заасан.

Мэдээллийн хүртээмжтэй байдлыг хангах хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд “Мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ шаардлагад нийцүүлэх хүрээнд мэдээллээр үйлчилдэг хуулийн этгээд нь өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэх явцад хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээлэл авах эрхийг хангах, техник, технологийн хэрэгсэл, бусадтай харьцах боломж, нөхцөлийг бүрдүүлнэ гэж заасан.

Барилга болон хот байгуулалтын тухай хуульд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтэц байгуулах талаар зохицуулсан. Автотээврийн тухай хуульд 20 ба түүнээс дээш нийтийн тээврийн хэрэгсэлтэй тээвэрлэгчийн тээврийн хэрэгслийн 10-аас доошгүй хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг тээвэрлэхэд зориулагдсан байх бөгөөд заасан хэмжээний тээврийн хэрэгсэлгүй бол Засгийн газраас тогтоосон хэмжээ, журмын дагуу жил бүр Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төлбөр төлөхөөр заасан. Гэсэн хэдий ч 2007 онд гарсан энэ заалт өнөөдрийг хүртэл ганц ч нийтийн тээврийн хэрэгсэл эдгээр иргэдийн зорчих боломжийг хангаагүй байна.

Судалгаанд БНСУ, Австрали болон Оросын Холбооны Улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг зохицуулж буй хууль тогтоомжийн талаар авч үзсэн болно.

БНСУ-д Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн халамжийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тусгай боловсролын тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангха туслалцаа үзүүлэх тухай хууль, хөдөлмөр

эрхлэлтийг дэмжих, мэргэжлийн чиг баримжаа олгох тухай хууль гэх мэт 16 хууль тогтоомж үйлчилж байна. Солонгос улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэний боловсрол, төрөөс үзүүлэх тусламж дэмжлэг, хөнгөлөлт болон бусад асуудлыг ерөнхийд нь *Хөгжлийн бэрхшээлтэй иргэний халамжийн тухай хуулиар* зохицуулж байна. Ерөнхий сайдын харьяанд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх олон талт бодлого боловсруулах, түүний хэрэгжилтийг үнэлэх, хяналт тавих чиг үүрэгтэй Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бодлого зохицуулах хороо ажилладаг байна.

Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сурч боловсрох, хөдөлмөрлөх эрхийг хангах хүрээнд ердийн болон тусгай сургууль, тусгай боловсролын төвд суралцах боломжтой бөгөөд боловсрол олгох 3 хэлбэр байдаг. Харин хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хүрээнд төр, орон нутгийн засаг захиргаа болон холбогдох бусад байгууллагууд дэмжлэг, туслалцаа үзүүлдэг. Тухайлбал мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэжлийн сургалтаар хангах, ажлын байранд дасан зохицох чадварыг хөгжүүлэх, ажилд зуучлах, хувиараа хөдөлмөр эрхлэхэд нь зээл олгох, хөнгөлөлт үзүүлж дэмжих гэх мэт олон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлдэг.

Австрали улсын хувьд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлчилгээний тухай хууль, Хамтын нөхөрлөлийн орнуудын Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ялгаварлан гадуурхалтын эсрэг хууль, Эрх тэгш боломжийн тухай хууль гэсэн том хуулиудаар зохицуулдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлчилгээний тухай хуулиар хөгжлийн бэрхшээлтэй иргэд үйлчилгээнд хүртээмжтэй хамрагдах, хамруулах төлөвлөгөөг албажуулж, улмаар тэдгээр төлөвлөгөөг хөгжүүлэх, хэрэгжүүлэх ба тайлагнах харилцааг хуульчилсан. Хамтын нөхөрлөлийн орнуудын Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ялгаварлан гадуурхалтын эсрэг хуулиар ажил эрхлэлт, боловсрол, байршлууд болон тээврийн хэрэгслийг хэрэглэх, орон байр, газар худалдан авах, эсхүл худалдах, клуб болон хамтарсан нийгэмлэгүүд, спорт, хамтын нөхөрлөлийн хууль, хөтөлбөрүүд, бараа, үйлчилгээ, тоног төхөөрөмж нийлүүлэх тохиолдолд ялгаварлан гадуурхахыг хориглосон.

ОХУ-ын хувьд ОХУ-д хөгжлийн бэрхшээлтэй иргэний асуудлыг Үндсэн хууль, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын тухай хууль, Боловсрол, Хөдөлмөр, Иргэний эрүүл мэндийг хамгаалах, Төрөөс үзүүлэх нийгмийн халамж үйлчилгээний тухай хууль гэх мэт томоохон хуулиудаар зохицуулдаг.

ОХУ-д хөгжлийн бэрхшээлтэй иргэний талаарх гол хууль нь 1995 онд батлагдсан Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын тухай хууль бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын салбарт төрөөс баримтлах бодлогыг тодорхойлж, Үндсэн хуулиар тогтоосон иргэний, эдийн засгийн, улс төрийн болон бусад эрх, эрх чөлөөг бусад иргэнтэй адил тэгш эдлэх боломжоор хангах, ОХУ-ын дагаж мөрддөг олон улсын хууль, гэрээ хэлэлцээрт заасан нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээ, зарчмуудыг хэрэгжүүлэхээр заасан.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын тухай хуулийн 19 дүгээр зүйлд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг боловсрол эзэмшихэд төрөөс бүх талаар дэмжих бөгөөд шаардлагатай нөхцөлийг баталгаатай хангана” гэж заасан бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бүх шатны боловсролыг үнэгүй эзэмших эрхийг

баталгаажуулсан. Тухайлбал ОХУ-ын Боловсролын тухай хуулийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэн мэргэжлийн боловсролыг нэг бус удаа үнэ төлбөргүй эзэмших эрхтэй ба 1-2 дугаар группын хөгжлийн бэрхшээлтэй иргэн техникийн дээд сургууль, техникийн дунд боловсролын сургуульд элсэлтийн шалгалтгүйгээр элсэн орох эрх эдэлдэг. Үүнээс гадна тэдэнд оюутны цалинг 50 хувь нэмэгдүүлэн олгодог байна.

Харин хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын тухай хуулийн 20-24 дүгээр зүйлд 100-аас дээш ажилтантай байгууллагад ажилтны дундаж тоонд хувь тэнцүүлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг авч ажиллуулах квот тогтоох (2 хувиас доошгүй, 4 хувиас дээшгүй), мөн мэргэжлээрээ хөдөлмөрлөх ажлын байрны нөөцийг бий болгох гэх мэт арга хэмжээг хэрэгжүүлж байна.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Дэлхий дээр нэг тэрбум гаруй хүн ямар нэгэн хөгжлийн бэрхшээлтэй амьдарч байгаа бөгөөд 200 орчим сая хүн үйлдлийн бэрхшээлтэй амьдарч байна. Хөгжлийн бэрхшээлийг нэг хэвийн ойлголтоор тэргэнцэртэй хүмүүс болон цөөн хэдэн сонгодог бүлгүүд буюу хараагүй, сонсголгүй хүмүүсээр ойлгодог. Гэтэл хөгжлийн бэрхшээл нь эрүүл мэндийн нөхцөл байдал, хувь хүний хүчин зүйл болон орчны хүчин зүйлсийн хоорондын харилцаанаас маш их шалтгаалдаг.

Хүн амын өсөлт нэмэгдэх тусам хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо ч улам бүр өсөн нэмэгдэж байна. Энэ нь хүн амын өндөр наслалт, чихрийн шижин, зүрх судасны өвчин, хавдар, сэтгэцийн эрүүл мэндийн өвчин зэрэг эрүүл мэндийн архаг нөхцөл байдлаас, нөгөө талаар ядуурал, байгалийн гамшиг, тогтворгүй байдал, осол гэмтэл, эмнэлгийн байгууллагын үйл ажиллагаанд гарсан алдаа дутагдлаас хүн хөгжлийн бэрхшээлтэй болох тохиолдол өссөөр байгааг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын мэдээ, тайланд дурдсан байна. Ялангуяа, ийм байдал хөгжлөөр буурай болон хөгжиж байгаа улс орнуудад харьцангуй өндөр хувьтай байдаг. Хэнд ч, хэдийд ч тохиолдож болох учраас хөгжлийн бэрхшээлийн асуудал хүн бүрийн асуудал юм.

Дэлхий дээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж, боловсролд хамрагдалт хангалтгүй, эдийн засгийн оролцоо бага байгаа зэрэг нь энгийн хүмүүсээс илүү ядууралд өртөх шалтгаан нь болж байна. Амьдралын хүнд хэцүү нөхцөл, хоол хүнсний дутагдал, эмнэлгийн үйлчилгээнд хамрагдаж чадахгүйгээс ядуу хүн хөгжлийн бэрхшээлтэй болох нь элбэг байхад сурч боловсрох, ажиллаж хөдөлмөрлөх боломж, орчин хязгаарлагдмал учраас хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн олонх нь ядуу амьдарч байна. Ядуурал хүний эдийн засаг, нийгэм, соёлын эрх зөрчигдөхөд хүргэдэг гол шалтгаан юм.

Өнгөрсөн түүхийн ихэнх хугацаанд, дэлхийн улс орнуудад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгмийн харилцаанд эрүүл иргэдийн нэгэн адил оролцох эрхтэй болохыг нь үл хүлээн зөвшөөрч, тэднийг гагцхүү төрийн тусламж, дэмжлэгийг хүртэгч”, “эмнэлэг, нийгмийн халамжийн үйлчилгээний объект” мэтээр хандаж ирсэн. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх ийнхүү ноцтой зөрчигдөж, алагчлагдаж тэднийг тохуурхах, нэр төрийг нь доромжлох, элдэв нэр хоч өгөх, цэрвэх, цээрлэх хандлага одоо ч нийгэмд байна.

2006 онд НҮБ-ын баталсан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай

конвенц нь “бүх хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хүний эрх, үндсэн эрх чөлөөг бүрэн дүүрэн, тэгш эдлэхийг нь дэмжих, хамгаалах, баталгаажуулах, мөн тэдний эрхэм байдлыг хүндэтгэхийг дэмжих” зорилготойгоор батлагдсан.


Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцыг НҮБ-ын Ерөнхий Ассамблей 2006 оны 12 дугаар сард баталсан бөгөөд Монгол Улс 2009 оны 5 дугаар сарын 13-нд нэгдэн орсон.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцын 1.2-т “хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэдэгт бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согогтой бөгөөд уг согог нь бусад төрлийн бэрхшээлтэй нэгдэн нийлсний улмаас бусдын нэгэн адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцоход нь саад учруулахуйц болсон этгээдийг хэлнэ гэж тодорхойлсон байна.

Харин манай улсын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4.1.1-д зааснаар “хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэдэгт бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг хэлнэ гэж тодорхойлсон.

Манай улсад 2017 оны байдлаар хөгжлийн бэрхшээлтэй нийт **103.630** хүн, үүнээс төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй **44.384** хүн, олдмол хөгжлийн бэрхшээлтэй **59.246** хүн байна¹⁷¹.

Зураг 1. Хөгжлийн бэрхшээлтэй хүн ам, төрлөөр, 2017 он



Олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүн ам өндөр байгаа нь манай улсын нийт хүн амын өвчлөл, нас баралтын голлох шалтгааны нэг нь осол гэмтэл болж байгаатай холбоотой байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн амыг хөгжлийн бэрхшээлийн төрлөөр, насаар авч үзэхэд бага, залуу насныхны дунд төрөлхийн хөгжлийн бэрхшээлийн тохиолдол өндөр байснаа нас ахихын хэрээр олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эзлэх хувь нэмэгдэх хандлагатай байна.

¹⁷¹ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: бодлого, үйл ажиллагаа, 10 дахь тал, 2017 он

Хүснэгт 1. Хөгжлийн бэрхшээлтэй хүн ам, насны бүлэг, төрлөөр, 2017 он

Насны бүлэг	Бүгд		Төрөлхийн ХБ		Олдмол ХБ	
	Хүний тоо	Эзлэх хувь	Хүний тоо	Эзлэх хувь	Хүний тоо	Эзлэх хувь
Бүгд	103 630	100.0	44384	42.8	59 246	57.1
0-14	8 835	100.0	6 656	75.3	2 179	24.0
15-17	2 618	100.0	1 759	67.1	859	32.8
18, түүнээс дээш	92 177	100.0	35 969	39.0	56 208	60.9
Улаанбаатар	34 246	100.0	14 106	41.1	20 140	58.8
0-14	3 617	100.0	2 875	79.4	742	20.5
15-17	830	100.0	620	74.6	210	25.3
18, түүнээс дээш	29 799	100.0	10 611	35.6	19 188	64.3

Хөгжлийн бэрхшээлтэй нийт хүн амыг хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээр авч үзвэл хөдөлгөөний бэрхшээлтэй хүн ам хамгийн их буюу 19.9 хувь (20.6 мянга), ярианы бэрхшээлтэй хүн ам хамгийн бага буюу 4.0 хувь (4.2 мянга) байна. Харин Улаанбаатар хотод сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүн ам хамгийн их буюу 17.7 хувь (6.0 мянга), ярианы бэрхшээлтэй хүн ам хамгийн бага буюу 4.6 хувь (1.5 мянга) байна.

Хүснэгт 2. Хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо, хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээр, 2017 он

Хөгжлийн бэрхшээлийн хэлбэр	Улсын хэмжээнд		Улаанбаатар хот	
	Хүний тоо	Эзлэх хувь	Хүний тоо	Эзлэх хувь
Бүгд	103 630	100.0	34 246	33.1
Харааны	11 071	10.6	3 068	8.9
Ярианы	4 228	4.0	1588	4.6
Сонсголын	8 554	8.2	2 810	8.2
Хөдөлгөөний	20 688	19.9	5 638	16.4
Сэтгэцийн	19 733	19.0	6 093	17.7
Хавсарсан	7 842	7.5	3 502	10.2
Бусад	31 514	30.4	11 547	33.7

Улаанбаатар хотод хөгжлийн бэрхшээлтэй 34.2 мянган хүн амьдарч байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй нийт хүн амын 33.0 хувийг эзэлж байгаа бөгөөд үлдсэн 69.3 мянга буюу 66.9 хувь нь аймаг, орон нутагт амьдарч байна.

Одоогийн байдлаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг зохицуулсан 70 гаруй хууль, эрх зүйн акт үйлчилж байна. Судалгаанд хамрагдсан хууль тогтоомжоос гадна тухайн асуудлыг хариуцсан байгууллага үйлчилгээ үзүүлэхдээ нарийвчилсан дүрэм, журам баталж үйл ажиллагаандаа мөрдөх тохиолдолууд байна. Манай улс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг зохицуулсан анхны бие даасан хуулийг 2005 онд **Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль** нэртэйгээр баталсан. 2006 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 61 дүгээр чуулганаар Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц, түүний нэмэлт протоколыг батлан гаргасан бөгөөд Монгол Улс 2008 онд тус конвенц болон нэмэлт протоколд нэгдэн орсоны дараа тус конвенцоор хүлээсэн үүрэг, мөн конвенцын зарчим, агуулгад нийцүүлэх зорилгоор Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийг шинэчлэн боловсруулж 2016 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай

хуулийг батлан гаргасан. Тус хууль нь Монгол Улс дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэний асуудлыг зохицуулж буй суурь хууль болж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудлыг зохицуулж буй хууль тогтоомжийн талаар дэлгэрүүлэн авч үзье. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудлыг зохицуулж буй суурь хуульд Монгол Улсын Үндсэн хууль, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай хууль болон НҮБ-ын конвенцуудыг юм.

1.Монгол Улсын Үндсэн хууль

Хүн төрөлхөөсөө эрх, эрх чөлөөтэй бөгөөд аливаа улсын Үндсэн хууль энэхүү эрх, эрх чөлөөг тунхаглаж, хамгаалах суурь зохицуулалтыг бий болгодог. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар Монгол Улсын Үндсэн хуульд тусгайлсан зохицуулалт байхгүй. Гэсэн хэдий ч Монгол Улсын иргэн бүр Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлд заасан “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш, хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна”, мөн 16 дугаар зүйлд заасан эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ хэмээн заасан. Харин дэлхийн улс орнуудад харилцан адилгүй зохицуулсан байдаг бөгөөд дэлхийн 198 улсын 39¹⁷² улс нь Үндсэн хуулиндаа хөгжлийн бэрхшээлээр нь ялгаварлан гадуурхахыг хориглосон заалтыг тусгасан байна.

2.Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай хууль

Монгол Улс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг зохицуулсан анхны бие даасан хуулийг 2005 онд *Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын тухай хууль* нэртэйгээр баталсан. Тус хууль нь 4 бүлэг, 13 зүйлтэй. Энэ хуулиар хөгжлийн бэрхшээлтэй хүнийг тодорхойлсон бөгөөд тэдэнд үзүүлэх нийгмийн хамгааллын болон халамжийн сангаас үзүүлэх тусламж, хөнгөлөлт, түүнчлэн тэдний сурч боловсрох, хөдөлмөрлөх эрхийг баталгаажуулж, соёл, урлаг, биеийн тамир, олон нийтийн арга хэмжээнд оролцоход төрөөс дэмжлэг үзүүлэхээр заасан. Мөн хөгжлийн бэрхшээлийг тогтоохтой холбоотой харилцаа болон хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын талаар байгууллага, албан тушаалтны гүйцэтгэх үүрэг, хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын арга хэмжээг тус тус зохицуулж байсан.

Манай улс 2009 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцод нэгдэн орсон бөгөөд тус конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын анхдугаар тайлан илтгэлийг 2015 онд Швейцарын Женев хотноо хуралдсан 13 дугаар хуралдаанаар хэлэлцээд, цаашид конвенцын хэрэгжилтийг хангаж ажиллах талаар Монгол Улсын Засгийн газарт зөвлөмж ирүүлсэн. Энэхүү зөвлөмжийн дагуу *Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай хуулийг* шинэчлэн боловсруулж 2016 оны 2 дугаар сарын 05-ны өдөр Улсын Их Хурал баталсан. Тус хууль нь хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд оролцох тэгш эрх, түүнийг хангах, хэрэгжүүлэх, хамгаалах талаар төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, оролцоо, баримтлах зарчмыг тодорхойлсон бөгөөд 45 зүйл, 149 хэсэг, 104

¹⁷² Ангол, Армен, Австри, АНУ, Боливи, Канад, Доминикан, Эквадор, Египет, Финланд, Фижи, Герман, Гуан, Унгар, Кени, Косова, Киргизтан, Мальдив, Мексик, Мозамбик, Нипал, ОХУ, Шинэ Зеланд, Никарагуа, Палестин, Панам, Руанда, Саудын Араб, Серби, Словань, Сомали, Өмнөд Африк, Швейцарь, Швед, Тажикстан, Тайланд, Туркменистан, Уганда, Украин

заалттай хууль болсон.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалахад тэднийг нийгмийн амьдралд эрх тэгш оролцоход аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахыг үл тэвчих, хөгжлийн бэрхшээлтэй хүний сонголт хийх эрх, хараат бус байдлыг хүндэтгэх, сурч боловсрох, хөдөлмөрлөх, нийгэмших зэрэг бүхий л харилцаанд оролцох хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг саадгүй, хүртээмжтэй хангах орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжих эрхийг хангах, тэдний онцлог байдлыг хүндэтгэх, хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүнд тэгш, хүртээмжтэй хүргэх явдал нь бүх нийтийн үүрэг байх, хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй холбоотой төрийн бодлого, шийдвэрийг боловсруулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд нь хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй хүн, тэдгээрийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн бус байгууллагын төлөөллийн оролцоог хангах зарчмуудыг тусгаж өгснөөрөө ач холбогдолтой болсон.

Энэ хууль батлагдсантай холбогдуулан 29 эрх зүйн акт батлан гаргана. Тухайлбал: Хөтөлбөр, төлөвлөгөө-3, Стандарт-5, дүрэм, журам-19, аргачлал -2.

Хүснэгт 3. Хууль дагаж батлагдах эрх зүйн актуудын талаарх лавлагаа

	Хуульд заасан баримт бичгийн нэр	Ангилал	Батлах субъект	Батлагдсан эсэх
1	Нийтийн тээвэр, харилцаа холбоо, нийтийн үйлчилгээ, барилга байгууламжийг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй болгох, хиймэл эрхтэн, туслах болон асаргаа сувилгаа, ариун цэвэр-эрүүл ахуйн материал, хэрэгсэл, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, үйлчилгээ үзүүлж байгаа иргэн, хуулийн этгээдийг дэмжих хөтөлбөр /§8.2/	Хөтөлбөр	Засгийн газар	Засгийн газрын 2017 оны 321 дүгээр тогтоол ¹⁷³
2	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургах, хөгжүүлэх, бүх шатны боловсрол олгох үндэсний хөтөлбөр, төлөвлөгөө /§14.5/	Хөтөлбөр, төлөвлөгөө	Засгийн газар	Засгийн газрын 2017 оны 321 тогтоолд орсон.
3	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол олгох сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр /§15.3/	Хөтөлбөр, төлөвлөгөө	Боловсролын асуудал эрхэлсэн ТЗТБ	Шинэчлэн батлаагүй
4	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагад нийцсэн авто болон явган хүний зам, замын байгууламжийн заавал дагаж мөрдөх үндэсний стандарт /§9.2/	Стандарт	Барилга, зам, тээвэр, хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн стандартчиллын байгууллага	Шинэчлэн батлаагүй
5	Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй буюу түүний хэрэгцээ, шаардлагад нийцсэн нийгмийн дэд бүтэц, орон сууц, олон нийтийн барилга	Стандарт	Барилгын болон хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн	Батлагдаагүй

¹⁷³ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр <https://www.legalinfo.mn/law/details/13031>

	байгууламжийн орчны болон дотоод зохион байгуулалтын заавал дагаж мөрдөх үндэсний стандарт /§9.3/		ТЗТБ-ын саналыг үндэслэн стандартчиллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага	
6	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээнд нийцсэн нийтийн тээврийн хэрэгсэл, зогсоол, үйлчилгээний заавал мөрдөх үндэсний стандарт /§10.2/	Стандарт	Тээвэр, хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн стандартчиллын байгууллага	Батлагдаагүй
7	Брайль үсгийн стандарт /§13.2/	Стандарт	Боловсролын асуудал эрхэлсэн ТЗТБ-ын саналыг үндэслэн стандартчиллын төв байгууллага	Батлагдаагүй
8	Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээний стандарт /§22.1/	Стандарт	тухайн асуудлыг эрхэлсэн ТЗТБ, Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн ТЗТБ-тай хамтран боловсруулж, стандартчиллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага	Батлагдсан.
9	Монгол дохионы хэлний хэлмэрч, орчуулгын үйл ажиллагаа эрхлэх, үйлчилгээ үзүүлэх журам /§12.2/	Журам	Боловсролын болон хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн ТЗТБ хамтран батална.	Төсөл гарсан. Батлагдаагүй байгаа.
10	Бүх шатны сургалтын байгууллагын хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлогт тохирох хэрэглэгдэхүүн, сургалтын орчныг бүрдүүлэх журам /§15.2/	Журам	Боловсролын асуудал эрхэлсэн ТЗТБ	Батлагдаагүй
11	Элсэлтийн шалгалтад тэнцэж, дотоод, гадаадын их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсролын байгууллагад суралцах эрхтэй болсон хөгжлийн бэрхшээлтэй хүний бакалавр, магистр, докторын зэрэг олгох сургалтын зардлын хэмжээ, олгох журам /§15.8/	Журам	Засгийн газар	Засгийн газрын 2014 оны 71 дүгээр тогтоолоор зохицуулж байна.
12	Ерөнхий боловсролын тусгай сургуулийн суралцагчийн үдийн хоолны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж, үдийн хоолоор үйлчлэх журам /§15.12/	Журам	Боловсролын асуудал эрхэлсэн ТЗТБ	Засгийн газрын 2017 оны 162 дугаар тогтоол
13	Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх	Журам	Тухайн асуудлыг эрхэлсэн Засгийн	Батлагдаагүй.

	үйлчилгээг эрхлэх байгууллагад тавигдах шаардлага /§23.4/		газрын гишүүн, хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран боловсруулж батална.	
14	Байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, бүрэн хараагүй, бүрэн хэлгүй, дүлий, одой иргэн болон байнгын асаргаа шаардлагатай хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хөгжлийн бэрхшээлтэй хүнд орон сууцны хөлс төлөхөд, хэрэв нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг бол түлш худалдан авахад нь жилд нэг удаа мөнгөн тусламж олгох /§26.1.1, §26.4/	Журам	Засгийн газар	Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоол ¹⁷⁴ Засгийн газрын 2012 оны 185 дугаар тогтоол ¹⁷⁵
15	18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн дотоодод хийлгэсэн протезын үнийг эдэлгээний хугацаа дууссан болон тухайн хүүхдийн өсөлтийн улмаас бие эрхтэнд нь таарахгүй болсон тохиолдолд тухай бүр 100 хувь нөхөн олгох /§26.1.2, §26.4/	Журам	Засгийн газар	
16	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас протез хийлгэх, сэргээн засалттай холбогдсон хөнгөлөлт авах эрх үүсээгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэний дотоодод хийлгэсэн протезын үнийг гурван жил тутам нэг удаа нөхөн олгох /§26.1.3, §26.4/		Засгийн газар	
17	18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, түүнчлэн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас протез хийлгэх, сэргээн засалттай холбогдсон хөнгөлөлт авах эрх үүсээгүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэний дотоодод хийлгэсэн болон худалдан авсан ортопед, тэргэнцэр зэрэг тусгай хэрэгслийн үнийг гурван жил тутам нэг удаа 100 хувь нөхөн олгох /§26.1.4, §26.4/	Журам	Засгийн газар	
18	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн цэцэрлэг, сургуульд ирж, очих унааны зардлыг хөнгөлөх, эсхүл автобусаар үйлчлэх /§26.1.5, §26.4/	Журам	Засгийн газар	
19	Насанд хүрсэн бүрэн хараагүй, сонсголгүй, хэл ярианы бэрхшээлтэй хүний харилцаа холбооны зардалд хөнгөлөлт үзүүлэх /§26.1.6, §26.4/	Журам	Засгийн газар	

¹⁷⁴ Хөгжлийн бэрхшээлтэй хүнд тусламж, хөнгөлөлт үзүүлэх журам <https://www.legalinfo.mn/annex/details/7964?lawid=12824>

¹⁷⁵ Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгох журам <https://www.legalinfo.mn/annex/details/5745?lawid=8950>

20	Хөгжлийн бэрхшээлтэй хүн бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээний журам, төрөл, хэлбэр, үйлчилгээ үзүүлэх байгууллагад тавигдах шаардлага /§32.3/	Журам	Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн	Батлагдсан. НХХЯ-ны сайдын 2017 оны А/184 тушаал
21	Хөтөч нохойг сургах, түүнийг хэрэглэх журам /§32.7/	Журам	Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална.	Батлагдсан.
22	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үнэмлэхийн загвар, түүнийг олгох журам /§38.4/	Журам	Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн	НХХЯ-ны сайдын 2017 оны А/109 тоот тушаал
23	Хуулийн 37.2.1-37.2.3-т заасан комиссын журам ¹⁷⁶	Журам	Засгийн газар	Засгийн газрын 2016 оны 200 дугаар тогтоол ¹⁷⁷
24	Хөгжлийн бэрхшээлтэй хүний үнэмлэхийн загвар, түүнийг олгох журам /§38.4/	Журам	Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн	Батлагдаагүй.
25	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар дундын үйл ажиллагааг улсын хэмжээнд уялдуулан зохицуулах, хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам	Журам	Засгийн газар	Засгийн газрын 2016 оны 136 дугаар тогтоол ¹⁷⁸
26	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах талаар үндэсний хөтөлбөр, төлөвлөгөө /§39.1.3/	Хөтөлбөр төлөвлөгөө	Засгийн газар	Батлагдсан.
27	37.2.1-д заасан хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тодорхойлох, хүүхдийн хөгжлийн цогц хөтөлбөрийг боловсруулах аргачлал /§37.6/	Аргачлал	Эрүүл мэнд, боловсрол, хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.	ЭМС, ХНХС-ын 2018 оны А/69, 48 дугаар хамтарсан тушаал ¹⁷⁹
28	37.2.2-т заасан хүний хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тодорхойлох аргачлал /§37.7/	Аргачлал	Эрүүл мэнд, хөдөлмөр, хөгжлийн бэрхшээлтэй хүний	Батлагдсан.

¹⁷⁶ 37.2.1. 0-16 насны хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс;

37.2.2. 16 ба түүнээс дээш насны хүний хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комисс;

37.2.3. хөгжлийн бэрхшээлтэй болсон шалтгаан, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комисс.

¹⁷⁷ Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрэм

<https://www.legalinfo.mn/annex/details/7537?lawid=12339>

¹⁷⁸ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн ажиллах журам

<https://www.legalinfo.mn/annex/details/7469?lawid=12265>

¹⁷⁹ Байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийг тодорхойлох заавар <https://www.legalinfo.mn/annex/details/8444?lawid=13364>

		асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.	
--	--	--	--

Тус хууль баталсантай холбогдуулан Засгийн газар болон бусад эрх бүхий байгууллагын батлах ёстой эрх зүйн актуудаас Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас батлан гаргах дүрэм, журам хугацаандаа батлагдаагүй, удаашралтай байна. Энэ нь хуулийн хэрэгжилтийг хангах ажил хангалтгүй байна гэж дүгнэж болохоор байна.

Хуулийн нэр томъёог жигдлэх шаардлагатай байна. Хуульд хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбоотойгоор батлагдах стандартуудыг стандарчлалын байгууллага батлахаар заасан. Гэтэл стандартчиллын байгууллагыг хуульд 5 өөрөөр нэрлэн заасан нь хуулийн мэргэжилгүй энгийн иргэн 5 өөр байгууллага гэж ойлгогдохоор байна. Улсын Их Хурлаас 2017 оны 12 дугаар сарын 21-ний өдөр баталсан Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийг шинэчлэн баталсан бөгөөд тус хуулиар үндэсний стандартыг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батлахаар хуульчилсан. Тиймээс хуулийн нэр томъёог салбар хуулийн нэр томъёотой нийцүүлж өөрчлөх шаардлагатай.

Харин хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын хувьд Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлагын ногдуулах 5 зүйл, заалт байна. Хуулийн 17.4 болон 17.5 дахь хэсэгт заасан хөдөлмөрлөх эрхтэй холбоотой зохицуулалтыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг орхигдуулсан байна.

3.Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенц

"Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай" конвенцыг НҮБ-ын Ерөнхий Ассамблей 2006 оны 12 дугаар сард баталсан. Конвенц хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хангах, хамгаалах улс орнуудын дотоодын механизм болосронгуй болж, олон улсын эрх зүйн хөгжилд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах шинэ хамгаалал, тогтолцоо бүрдэж эхэлсэн гэж үзэж болно. Тус конвенцод Монгол Улс 2009 оны 5 дугаар сарын 13-нд нэгдэн орсон бөгөөд конвенцын хэрэгжилтийн талаарх анхдугаар илтгэлээ 2011 онд хэлэлцүүлсэн бөгөөд хоёр дахь илтгэлээ 2020 онд НҮБ-ын Хүний эрхийн хороонд хүргүүлэхээр бэлтгэж байна.

Монгол Улсын нэгдэн орсон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах талаарх олон улсын гэрээ, конвенц, Үндсэн хуулийн үзэл санааг хэрэгжүүлэх зорилгоор хууль тогтоомж, үндэсний болон салбарын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн эрх, эрх чөлөөгөө эдлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох ажилд тодорхой ахиц гарч байна. Тухайлбал: 2018 онд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенц, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, салбар дундын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, оролцоог нэмэгдүүлэх зэрэг чиглэлээр үндэсний хэмжээнд ажиллах **хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал хариуцсан агентлагийг** байгуулсан явдал юм.

Хэдийгээр ололт амжилт байгаа ч хүний эрх, эрх чөлөөг хангаж, хамгаалахад чиглэгдсэн олон тооны хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрүүд байгаа боловч тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, санхүүгийн асуудлыг тодорхой шийдвэрлэхгүй орхигдуулсан, хэрэгжүүлэх байгууллага, механизмыг оновчтой тогтоож чадаагүйн улмаас хууль тогтоомж, хөтөлбөрүүд зөвхөн “цаасан дээр” үлдэж, зориулагдсан хүндээ хүрч үр дүнгээ өгөхгүй байгааг холбогдох байгууллагууд анхааралдаа авах шаардлагатай байна.

4. Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын конвенц

Монгол Улс нь хүүхдийн эрхийн асуудлыг анхааралдаа авсан улс орнуудын тоонд нэлээд дээгүүрт ордог бөгөөд 1989 онд гарсан НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцыг баталсан эхний 10 улсын тоонд ордог. НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенц нь дэлхийн бүх хүүхэд, тэр дотроо хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хамаатай. Конвенцод хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаар тусгайлан дурдсан нь үл гадуурхах, хөгжлийн бэрхшээл бол ялгаварлан гадуурхалтаас хамгаалагдах үндэс мөн гэж, эдгээр эрхийг хэрэгжүүлэхийн тулд оролцогч улсуудын зүгээс гаргах хүчин чармайлтыг онцолсон байдаг. Хүүхдийн эрхийн конвенцын хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий НҮБ-ын Хүүхдийн эрхийн хороо “Ерөнхий зөвлөмж 9” нэртэй баримт бичигтээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийг хэрэгжүүлэх чиглэлээр конвенцын бүх зүйл, заалтыг багтаасан зөвлөмжийг Конвенцод нэгдэн орсон улс орнуудын төр засагт хүргүүлсэн байна.

Конвенцын 23 дугаар зүйлийн 1-д “Оролцогч улсууд тахир дутуу буюу оюуны хомсдолтой хүүхдийн нэр төрийг хүндэтгэн өөртөө тулгуурлах, нийгмийн амьдралд идэвхтэй оролцох боломжтой орчинд бүрэн бүтэн, зохистой амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ”, 2-т “Оролцогч улсууд тахир дутуу буюу оюуны хомсдолтой хүүхэд онцгой халамж хүртэх эрхийг хүлээн зөвшөөрч, хүүхэд болон түүний эцэг эх, асран халамжлах бусад хүний нөхцөл байдлыг харгалзан, тэдний гаргасан хүсэлтийн дагуу нөөц боломжийнхоо хэрээр туслалцаа үзүүлэх, онцгой халамж анхаарал тавихыг дэмжинэ.” гэж мөн санхүүгийн нөөц бололцоог харгалзан тусламжийг аль болохоор үнэ төлбөргүй үзүүлэх, нийгмийн амьдралд оролцох бололцоог бүрдүүлэх, нөхөн сэргээх арга, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үйлчилгээг дээшлүүлэх талаар тус тус тунхагласан.

Манай улс Хүүхдийн эрхийн конвенцын хэрэгжилтийн 5 дугаар тайлангаа 2017 онд НҮБ-ын Хүүхдийн эрхийн хороогоор хэлэлцүүлсэн. Тус тайланг хэлэлцээд Монгол Улсын Засгийн газарт дүгнэлт, зөвлөмжийг хүргүүлсэн. Тус зөвлөмжид урт хугацааны бодлого шийдвэрийг гаргаж хэрэгжүүлэх нь бэрхшээлтэй хэдий ч Хүүхдийн эрхийн тухай конвенцын бүхий л чиглэлээр хүүхэдтэй холбоотой цогц бодлого баримтлахыг тэргүүлэх зорилтоо болгохыг зөвлөсөн.

Мөн тус улсад тэгш бус байдал өссөөр байгаад, ялангуяа орлого багатай өрхийн хүүхдүүд, шилжин суурьшсан болон бүртгэлгүй хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, ...гэх мэт эмзэг бүлэг, хүнд нөхцөлд орсон хүүхдүүдийг ялгаварлан гадуурхалтанд өртүүлж буйд, тухайлбал энэ тохиолдлуудад нь сургууль, дотуур байрны орчинд гараад байхад ямар ч хариуцлага тооцдоггүйд харамсаж буйгаа илэрхийлсэн.

Зөвлөмжид тус улсыг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оролцоог хангах цогц стратегийг хүний эрхэд суурилсан зарчимд тулгуурлан яаралтай баталж дараах арга хэмжээг хэрэгжүүлэхийг шаардсан. Үүнд:

(a) Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах Хорооноос 2015 оны 5 дугаар сард гаргасан зөвлөмжүүдийг бүрэн биелүүлэх;

(b) Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүү, арга зүй, хүний нөөцийг хангалттай хуваарилахад анхаарах;

(c) Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан бодлого хөтөлбөрүүдийг боловсруулж хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай хөгжлийн бэрхшээлийг оношлох үр дүнтэй тогтолцоог хөгжүүлэх, мэдээлэл цуглуулах ажлыг зохион байгуулах;

(d) Сурагч бүрийн онцлог хэрэгцээнд нийцсэн тэгш хамруулах боловсролыг хөгжүүлэх цогц арга хэмжээнүүдийг авах, улмаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тусгай сургууль, ангид сургахаас илүүтэйгээр тэгш хамруулах боловсролыг чухалчлах;

(e) Суралцах чадварын бэрхшээлтэй хүүхдүүдэд онцлон анхаарч тэд жирийн хүүхэдтэй хамт нэг ангид сурч байгаа үед тэдэнд ганцаарчилсан дэмжлэг үзүүлэх мэргэжлийн багш, ажилтныг сургаж томилж;

(f) Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хувьд хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, сэргээн засах хөтөлбөрт хамруулах зэрэг эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээг яаралтай авах;

(g) Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг жигшин гадуурхах, тэднээс ичиж зовох гэх мэт үйлдэлтэй тэмцэх, ийм хүүхдүүдийн эерэг дүр төрхийг нийгэмд бүрдүүлэхийн тулд төрийн албан хаагчид, олон нийт, гэр бүлд чиглэсэн ойлголт нэмэгдүүлэх кампанит ажлуудыг өрнүүлэх.

НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооноос өгсөн тус зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай.

НЭГ. НИЙГМИЙН ХАЛАМЖ, ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээг үзүүлэх хүрээнд дараах хууль тогтоомжууд үйлчилж байна.

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль
2. Нийгмийн халамжийн тухай хууль
3. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль
4. Эрүүл мэндийн даатгалын тухай хууль
5. Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030
6. Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого
7. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай УИХ-ын 2017 оны 46 дугаар тогтоол
8. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр

9. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд тусламж, хөнгөлөлт үзүүлэх журам

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 26 дугаар зүйлд нийгмийн халамжийн сангаас хөгжлийн бэрхшээлтэй хүнд тусламж, хөнгөлөлт үзүүлэх талаар зохицуулсан байна. Тус хуулийн 26.1.1 дэх хэсэгт “байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, бүрэн хараагүй, бүрэн хэлгүй, дүлий, одой иргэн болон байнгын асаргаа шаардлагатай хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хөгжлийн бэрхшээлтэй хүнд орон сууцны хөлс төлөхөд, хэрэв нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг бол түлш худалдан авахад нь жилд нэг удаа мөнгөн тусламж олгох”, 26.1.6-д “насанд хүрсэн бүрэн хараагүй, сонсголгүй, хэл ярианы бэрхшээлтэй хүний харилцаа холбооны зардалд хөнгөлөлт үзүүлэх”, 26.1.9-д “бүрэн хараагүй хүн эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр эмчлүүлэх, рашаан сувилалд сувилуулахаар аймгаас нийслэлд, нийслэлээс аймагт зорчсон тохиолдолд ирж, буцах унааны зардлын 75 хувийг жилд нэг удаа нөхөн олгох”, 26.1.14-д “хараагүй хүний брайлийн үсгээр бичсэн захидал, ил захидал, брайль хэвлэл, 10 кг хүртэлх илгээмжийг дотоодод үнэ төлбөргүй явуулж, хараагүй хүний зориулалттай техник, тоног төхөөрөмж, материал хэрэгслийг дотоодод үнэ төлбөргүй хүргүүлэх” гэж тус тус заасан.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 13-16 дугаар зүйлд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгохтой холбоотой харилцааг зохицуулсан. Нийгмийн халамжийн тухай хуулийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах, хангах талаар төрөөс төрөл бүрийн арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаагийн нэг хэлбэр нь дэмжлэг, туслалцаа шаардлагатай байгаа хүмүүст халамжийн үйлчилгээ үзүүлэх юм. Халамжийн үйлчилгээ нь мөнгөн болон бусад хэлбэртэй байдаг. Тэтгэмжийн талаар мэдээллийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 4. Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж

№	Хууль тогтоомжийн нэр, холбогдох зүйл, заалт	Тэтгэмж авах зорилтот бүлэг	Олгох хугацаа	Тэтгэмжийн хэмжээ
1	Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.2	16 хүртэлх насны байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд олгох амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж	Сар бүр	155.000 төг
2	Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.2 болон Гэр бүлийн тухай хуулийн 25.5, 74, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 13 дугаар зүйл.	Асаргааны тэтгэмж	Сар бүр	70.000 төг
3	Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.5	... гэр оронгүй тэнэмэл өрх, иргэн, 18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэнд гэр авахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж	Нэг удаа	1.200.000 төг
4	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай хуулийн 26.1	Орон сууцны хөлс болон түлшний үнийн хөнгөлөлтөд олгох мөнгөн тусламж	Жилд нэг удаа	140.000 төг

5	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай хуулийн 26.1.5	Нийслэл болон хот суурин газарт нийтийн тээврийн хэрэгслээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг бүх шатны сургалтын байгууллагад хүргэж өгч, авдаг асран хамгаалагч, харгалзан дэмжигч нэг хүнд олгох унааны зардлын хөнгөлөлт	Жилд нэг удаа	200.000 төг
6	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай хуулийн 26.1.6	Насанд хүрсэн бүрэн хараагүй, сонсголгүй, хэл ярианы бэрхшээлтэй хүний харилцаа холбооны зардалд хөнгөлөлт үзүүлэх	Сар бүр	20.000 төг
7	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай хуулийн 26.1.7	Дотоодын рашаан сувилалд сувилуулах шаардлагатай дараах хүнд ирж, очих унааны, ор хоногийн зардлыг эрүүл мэндийн даатгалтай иргэний энгийн өрөөний тарифаар тус тус тооцон хөнгөлөлт үзүүлнэ	Жилд нэг удаа	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд 100 хувь, асран хамгаалагч нэг иргэнд 50 хувь
8	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай хуулийн 26.1.9	Бүрэн хараагүй хүн эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр эмчлүүлэх, рашаан сувилалд сувилуулахаар аймгаас нийслэлд, нийслэлээс аймагт зорчсон тохиолдолд ирж, буцах унааны зардал	Жилд нэг удаа	Зардлын 75 хувь
9	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай хуулийн 26.1.12.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нь хүүхдийн зусланд амарвал эрхийн бичгийн хөнгөлөлт	Жилд нэг удаа	50 хувь
10	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай хуулийн 26.1.13	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд эмнэлгийн магадлагаагаар дотоодод усан эмчилгээ хийлгэсэн бол эмчилгээний төлбөрийн хөнгөлөлт	Жилд нэг удаа	70 хувь
11	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай хуулийн 26.1.14	Хараагүй хүний брайлийн үсгээр бичсэн захидал, ил захидал, брайль хэвлэл, 10 кг хүртлэх илгээмжийг дотоодод үнэ төлбөргүй явуулж, хараагүй хүний зориулалттай техник, тоног төхөөрөмж, материал хэрэгслийг дотоодод үнэ төлбөргүй хүргүүлэх;		Үнэ төлбөргүй
12	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай хуулийн 26.1.15.	Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасан оршуулгын тэтгэмж авах эрх үүсээгүй, хөгжлийн бэрхшээлтэй хүн болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нас барвал түүний оршуулгын	Нэг удаа	1 сая төгрөг

		зардлын мөнгөн тэтгэмж		
13	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай хуулийн 26.1	18 хүртлэх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн дотоодод хийлгэсэн протезын үнийг эдэлгээний хугацаа дууссан болон тухайн хүүхдийн өсөлтийн улмаас бие эрхтэнд нь таарахгүй болсон тохиолдолд олгох хөнгөлөлт	Тухай бүр	100 хувь
14	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай хуулийн 26.1	26.1.4. 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, ... дотоодод хийлгэсэн болон худалдан авсан ортопед, тэргэнцэр зэрэг тусгай хэрэгслийн үнийг нөхөн олгох хөнгөлөлт	Гурван жилд нэг удаа	100 хувь
15	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай хуулийн 32.7	Төрөөс хараагүй хүнийг тухайн орчинд зөв чиг баримжаатай, саадгүй, аюулгүй зорчиход нь туслах хөтөч нохойг тусгайлан сургаж бэлтгэх ба дотоодод сургаж бэлтгэсэн хөтөч нохойны үнэ	Есөн жилд нэг удаа	100 хувь

Дээр дурдсан нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээг хөдөлмөрийн чадвар алдсан болон өөртөө үйлчилж чаддаггүй хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй иргэд адилхан авдаг. Өөрөөр хэлбэл эрс ялгаатай хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ижил нийгмийн үйлчилгээг авдаг. Тиймээс ХБХ-ийн ангилалыг нарийвчлан тогтоож бэрхшээлийн онцлогт тохирсон халамжийн үйлчилгээг авах боломжийг бүрдүүлэх нь зүйтэй.

Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгож байгаа нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг Хөдөлмөрийн хөлсний доод түвшинтэй уялдуулах шаардлагатай. Одоо хүн амын амьжиргааны доод түвшинтэй уялдуулан нэмэгдүүлж байгаа. Хүн амын амьжиргааны доод түвшин гэдэг нь хэрэглээний доод хэмжээг мөнгөн хэлбэрээр илэрхийлснийг хэлнэ гэж хуулинд заасан байдаг.

Шигтгээ: Хөгжлийн бэрхшээлгүй хүмүүстэй харьцуулахад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ядууралд өртөх нь илүү байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй өрх гэр нь хоол хүнс, аюулгүй ус, орон байр, ариун цэвэр болон эрүүл мэндийн тусламжийн хүртээмж хангалтгүй зэрэг нь хөгжлийн бэрхшээлгүй хүн болон тэдний өрх гэрийнхнээс илүү доройтож байна.

Хэрэглээний доод хэмжээ нь хүний нэн тэргүүний, зайлшгүй хэрэгцээг хангах хүнсний болон хүнсний бус хэрэглээний сагсаар тодорхойлсон бараа, бүтээгдэхүүний тоо хэмжээ юм. Нийгмийн даатгалын сангийн тэтгэврийн доод хэмжээ 243.000 төгрөг байхад нийгмийн халамжийн сангийн тэтгэвэр 174 000 төгрөг байгаа нь нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр авагч хөгжлийн бэрхшээлтэй иргэд амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготойгоор амьдарч байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийг хангах, нийгмийн хамгааллын чиглэлээр

хийгдэж байгаа зарим ажлуудаас дурдвал:

- БНХАУ-ын буцалтгүй тусламжаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төв”-ийг барьж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, эцэг эхчүүдэд зориулсан сургалт, хөгжлийн арга хэмжээг зохион байгуулахаас гадна 250 хүүхэд хэвтэн эмчлүүлэх, 250 хүүхэд өдрөөр сэргээн засах үйлчилгээ үзүүлэх хүчин чадалтай, иж бүрэн, цогц үйлчилгээ үзүүлэх төвийг 2019 оны 1 дүгээр улиралд барилгыг ашиглалтад оруулаад байна.
- “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдэд зориулсан тусгай тоноглол бүхий спорт цогцолбор”-ыг техник хамтын ажиллагааны төслийг эхлүүлж байна. Тус цогцолбор нь спортын 10 төрлөөр хичээллэх орчин үеийн тоног төхөөрөмжөөр хангагдах ба жилийн 4 улиралд 200-400 тамирчин тогтмол хичээллэх боломжтой, 200 метрийн тойрог замтай, битүү дээвэртэй манеж бүхий гадна талдаа дэлхийн стандартад нийцсэн 400 метрийн тартан замтай, 200 тамирчин байрлах зочид буудалтай иж бүрэн цогц байдлаар байгуулах юм.
- Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах” 5 жилийн хугацаанд хэрэгжих техник туслалцааны төсөл 2018 оноос эхлэхээр төлөвлөсөн. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг эрт оношилж, эмчлэх, хөгжүүлэх үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай туслах хэрэгсэл, программ хангамж, дэд бүтцийг сайжруулна.
- Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх сэргээн засах үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор “Нялхсын клиник сувилал”-ын үйл ажиллагааг дэмжих, үйл ажиллагааг нь өргөжүүлэх зорилгоор шаардлагатай тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлж байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг нийгэмшүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй, байнгын асаргаа, сувилгаа шаардлагатай хүүхдийн эрхийг хангах зорилгоор “Хамтдаа инээмсэглэе” арга хэмжээний хүрээнд хүүхдийн зуслангийн тусгай ээлжийг Монголд анх удаа зохион байгуулсан. Тус арга хэмжээнд 8 аймаг, нийслэлээс 150 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, 150 асран хамгаалагчийн хамтаар оролцсон. Арга хэмжээний хүрээнд хүүхдийн чадамжийн үнэлгээ хийх, асран хамгаалагчид нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлж, хувь хүний хөгжлийн сургалтуудыг зохион байгуулсан.

“Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого”-ын зорилго нь “Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогын зорилго нь хүн амын тогтвортой өсөлтийг хангах, иргэдийн урт удаан, эрүүл энх, бүтээлчээр амьдрах, хөгжих таатай орчин бүрдүүлэх, хувь хүн болон гэр бүлийн амьдралын чанарыг дээшлүүлэхэд оршино.” гэж тодорхойлсон. Тус бодлогын 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “олон хүүхэдтэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй болон өрх толгойлсон эцэг, эх бүхий гэр бүл, ганц бие ахмад настанд дэмжлэг үзүүлж амьдралын түвшинг дээшлүүлэх” гэж тусгасан. Энэхүү зохицуулалт нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй гэр бүлийг дэмжихэд чиглэгдсэн.

“Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” УИХ-ын тогтоол. 2017 оны 46 дугаар тогтоолын 2 дугаар

зүйлд “хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд олгох тэтгэмжийг амьжиргааны доод түвшний хэмжээнд хүргэх, улсын төсвийн зарлагын ангилалд хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдийг дэмжих зардлын ангиллыг шинээр нэмж тусгах” гэж заасан. Тус ажлын хүрээнд Засгийн газраас 2019 оны 2 дугаар сарын 01-ний өдрөөс Нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг 174.000 төгрөг, асаргааны тэтгэмжийн хэмжээг 76.000 төгрөгөөр тогтоосон. Тус тэтгэвэр, тэтгэмжийг тогтоохдоо тухайн үед мөрдөж байгаа амьжиргааны доод түвшинг үндэслэхээр заасан. Гэсэн хэдий ч хэдэн хувиар тогтоох талаар зохицуулаагүй учир хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдэхэд багахан нэмээд өнгөрдөг. Энэ нь ажил хөдөлмөр эрхэлж чадахгүй байгаа тэтгэвэр, тэтгэмж авагчдын амьдралын наад захын хэрэгцээнд ч хүрдэггүй.

Хөгжлийн бэрхшээлийн талаарх Дэлхийн банкны судалгааны тайланд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 66.5 хувь нь архаг өвчтэй байна гэсэн судалгаа хийсэн байна. Мөн тус тайланд доогуур орлоготой орны хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эрүүл мэндийн зардалдаа хөгжлийн бэрхшээлгүй хүмүүсээс 50 хувиар илүү зардал гаргадаг гэж тайланд дурджээ.

“Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийн зорилт 4-т “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд ээлтэй нийгмийн хамгааллын үйлчилгээг хүргэнэ.” гэж заасан. Хөтөлбөрийн 4 дүгээр зорилтын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн хамгааллыг дэмжих чиглэлээр түрээсийн, халамжийн орон сууцад хамруулах, тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг амьжиргааны доод түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх, нэн хэрэгцээтэй хиймэл эрхтэн, туслах хэрэгслийн жагсаалт болон жишиг үнийг инфляцын түвшинтэй уялдуулан шинэчлэх, халамжийн үйлчилгээг оновчтой болгох, 6 аймагт хөгжлийн төв байгуулахаар тус тус заасан байна. Гэсэн хэдий ч хараа, сонсгол болон хэл ярианы бэрхшээлтэй хүний талаар тусгайлсан зохицуулалт байхгүй байна.

Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг¹⁸⁰ 2018 оны 05 дугаар сарын 21-ний өдөр ХНХ-ын сайд, БСШУС-ын сайд, Эрүүл мэндийн хамтарсан тушаалаар баталсан.

ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын тухай (27.1-р зүйл) болон ***Тэтгэврийн тухай***¹⁸¹ (17, 21, 38, 113-115-р зүйл) хуулийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд төрөөс тэтгэвэр, тэтгэмж олгодог.

Мөн тэдний гэр бүлийн нийгмийн хамгааллыг бэхжүүлэх үүднээс мөнгөн тэтгэмж болон бусад хөнгөлөлтүүдийг эцэг, эх (асран хамгаалагч)-д нь олгож байна. Үүнд:

- 5500 рублийн мөнгөн тэтгэмж (*“18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, эсхүл бага наснаасаа тахир дутуугийн 1 дүгээр бүлэгт хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй насанд хүрсэн хүнийг асарч байгаа ажил эрхлээгүй хөдөлмөрийн чадвартай иргэнд сар бүр олгох мөнгөн тэтгэмжийн тухай” ОХУ-ын Ерөнхийлөгчийн 2013 оны 175 дугаар тогтоол*¹⁸²);

¹⁸⁰ ХБХ-ний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө <http://www.misp.gov.mn/uploads/op/files/79d12c9c0ffed4b9c05a6068b870fae17a9944fd.pdf>

¹⁸¹ Федеральный закон "О трудовых пенсиях в РФ" от 17.12.2001 года № 173-ФЗ.

¹⁸² Указ Президента РФ "О ежемесячных выплатах лицам, осуществляющим уход за детьми-инвалидами и инвалидами с детства I группы" от 26.02.2013 года № 175.

- 120 рублийн нөхөн олговор (*Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд асарч байгаа ажил эрхлээгүй хөдөлмөрийн чадвартай иргэнд сар бүр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 60 хувьтай тэнцэх нөхөн олговрын хэмжээг нэмэх тухай*” ОХУ-ын Ерөнхийлөгчийн 1994 оны 551 дугаар тогтоол¹⁸³)
- орон сууц, засвар үйлчилгээ болох орон сууцны их засварын зардлын 50 хувьтай тэнцэх нөхөн олговор олгох (*Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын тухай хуулийн 17-р зүйл*)¹⁸⁴.

БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн халамжийн тухай хууль¹⁸⁵ нь төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тусгай хэрэгцээг хангахад чиглэсэн цогц дэмжлэгийг бий болгох, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг эрүүл, аюулгүй орчинд амьдарч, нийгмийн амьдралд идэвхтэй оролцох, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй гэр бүлийн дарамтыг бууруулах зорилготойгоор 2011 онд баталсан.

Төвийн болон орон нутгийн захиргааны байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тохирох халамжийн үйлчилгээг хүргэх зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон түүний гэр бүлд зориулсан нийгмийн халамжийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээ, тэдэнд зориулсан халамжийн үйлчилгээний төслүүдийг судлах, хөгжүүлэх, хүргэх, шаардлагатай бусад халамжийн үйлчилгээтэй холбоотой асуудлыг зохицуулах, хянах үүргийг хүлээнэ.

Бодлого зохицуулалтын асуудлыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн халамжийн тухай хуульд заасны дагуу Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бодлого зохицуулалтын хороо хянана. Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон гэр бүлд үзүүлэх халамжийн дэмжлэг, бусад шаардлагатай зүйлсийн талаар 3 жил тутам судалгааг шинэчлэн гаргаж байх ёстой.

Тус улс хөгжлийн бэрхшээлтэй иргэддээ 41¹⁸⁶ төрлийн мөнгөн болон бусад тэтгэвэр, тэтгэмж, дэмжлэг туслалцаа, үйлчилгээ үзүүлж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тэтгэвэр нь бэрхшээлийн хэлбэр, ангиллаас хамаарч 200-276 мянган вон, 18 хүртлэх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд 100-200 мянган вон мөн эрүүл мэндийн зардалд зарцуулсан төлбөрийг бэрхшээлийн хэлбэрээс хамаарч 5-50 хувийн хөнгөлөлт үзүүлдэг. Түүнчлэн нөхөн сэргээх эмчилгээ, үйлчилгээ үнэ төлбөргүй, унааны зардлын хөнгөлөлт, сонсголын бэрхшээлтэй хүүхдэд зориулсан чихний дунгийн суулгацын мэс заслын зардлын хөнгөлөлт, орон сууцны хөнгөлөлт, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг бууруулах, чөлөөлөх гэх мэт хөгжлийн бэрхшээлийн онцлогт нь тохирсон дэмжлэг тусламжийг үзүүлдэг.

ХОЁР. БОЛОВСРОЛЫН САЛБАР

Улсын Их Хурлаас 2016 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг

¹⁸³Указ Президента РФ “О повышении размера компенсационных выплат неработающим трудоспособным лицам, осуществляющим уход за нетрудоспособными гражданами” от 17.03.1994 года № 551.

¹⁸⁴ УИХТГ-ын Судалгаа, мэдээлэл, лавлагааны алба-Хүүхдийн эрх хамгааллын эрх зүйн орчин, тогтолцоо ба хэрэгжүүлэх механизмын талаарх гадаадын зарим орны туршлага, УБ, 2018 он

¹⁸⁵УИХТГ-ын Судалгаа, мэдээлэл, лавлагааны алба-Хүүхдийн эрх хамгааллын эрх зүйн орчин, тогтолцоо ба хэрэгжүүлэх механизмын талаарх гадаадын зарим орны туршлага, УБ, 2018 он

¹⁸⁶ <https://www.nyj.go.kr/main/977>

батлан гаргасан нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эрх ялангуяа сурч боловсрох эрхийг баталгаажуулж, тэдний амьдрах орчныг сайжруулах, нийгмийн халамж үйлчилгээний талаар нарийвчилсан зохицуулалттай болсон.

Хөгжлийн бэрхшээлтэй 2-5 насны хүүхдийн сурч хөгжих эрхийг хангах асуудал хүндрэлтэй асуудлын нэг байсаар байна. Монгол Улсад ганцхан байдаг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг хүлээн авдаг 10 дугаар цэцэрлэгийн барилгыг шинээр барих хөрөнгө, санхүүгийн асуудал 5 дах жилдээ шийдвэрлэгдээгүй байна. 2018 оны 6 дугаар сард Засгийн газраас цэцэрлэгийн барилгыг 5.3 тэрбум төгрөгөөр барихаар шийдвэрлэсэн боловч ахиц гараагүй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын энгийн ангид сургах асуудал хүндрэлтэй асуудал хэвээр байна. Ихэнх багш хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ангидаа авч сургахдаа амжилттай сургаж чадна гэдэгт эргэлздэг. Энэ нь энгийн сургуульд ажиллаж буй багш нарын хандлага, ойлголт, заах арга эзэмшсэн байдал, ур чадвартай нь холбоотой юм.

Манай улсад хөгжлийн бэрхшээлтэй хэдэн хүүхэд хаана, хэнтэй хэрхэн амьдарч буй талаар нэгдсэн тоо баримт өнөөг хүртэл байдаггүй. Төрийн байгууллагуудаас гаргасан статистик мэдээллүүд ч өөр хоорондоо зөрүүтэй байна.

Тухайлбал, улсын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд суралцдаг зургаан тусгай сургууль байдаг ч эдгээр сургуульд нийт 1700 орчим хүүхэд суралцдаг.

Улсын хэмжээнд 2017-2018 оны хичээлийн жилийн статистик мэдээллээр хөгжлийн бэрхшээлтэй 1599 хүүхэд цэцэрлэгт, 7279 хүүхэд ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа бөгөөд үүнээс 1637 нь ерөнхий боловсролын тусгай сургуульд суралцаж байна. Сургуульд хамрагдахгүй байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг дэмжих чиглэлээр 2017-2018 оны хичээлийн жилд улсын хэмжээнд 26 насан туршийн боловсролын төв, 326 нэгж үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд нийт 9291 хүүхэд суралцаж байгаагийн 18.5 хувь буюу 1716 нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагч байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсрол эзэмшихэд нь эцэг эх, багш, анги хамт олон чухал хэдий ч төрийн зохицуулалт, дэмжлэг туслалцаа хамгийн чухал нь юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол эзэмшүүлэх талаар дэлхий нийтийн чиг хандлага тэднийг энгийн сургуульд, энгийн хүүхдүүдтэй хамт сургах арга юм. Мөн бэрхшээлийн онцлогт нь тохирсон боловсролыг эзэмшүүлэх шаардлага нэн тэргүүний асуудал юм.

1960 онд ЮНЕСКО-гоос баталсан “Боловсролын салбарт ялгаварлан гадуурхахын эсрэг тэмцэх тухай конвенц” нь тэгш хамруулах боловсролын гол тулгуур бөгөөд боловсролын салбарт үл ялгаварлал, тэгш хандлага, тэгш боломж гэсэн зарчмуудыг эрхэмлэдэг. Монгол улс 1964 онд уг конвенцод нэгдэн орсон. 1948 оны НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон 1989 оны НҮБ-ийн Хүүхдийн эрхийн конвенцод ялгаварлан гадуурхалыг хориглож хүүхэд бүр боловсрол эзэмших эрхтэйг заасан байдаг. 1994 оны ЮНЕСКО-гийн Саламанкагийн мэдэгдэлд “Сургуулиуд хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгмийн гарал, сэтгэлийн хөдөлгөөн, хэл яриа болон бусад нөхцөл байдлыг үл харгалзан хүүхэд бүрийг авч сургах ёстой. Хөгжлийн бэрхшээлтэй ба авьяаслаг хүүхдүүд, хараа хяналтгүй ба ажил, хөдөлмөр эрхэлдэг

хүүхдүүд, алслагдсан ба нүүдэлчин өрхийн хүүхдүүд, хэл, соёл ба үндэсний цөөнхийн хүүхдүүд болон бусад ялгаварлан гадуурхагдсан бүлгийн хүүхдүүд бүгд сургуульд хамрагдах ёстой гэж тэмдэглэсэн байдаг. Тэгш хамруулах боловсрол нь бүх хүүхэд, залуучууд болон насанд хүрэгчдийн сурах хэрэгцээг хангахад чиглэгдсэн бөгөөд энэхүү үзэл баримтлал нь 1990 оны Бүх нийтийн боловсролын дэлхийн бага хурал болон Тусгай хэрэгцээт боловсролын асуудлаарх Саламанкагийн мэдэгдлийн суурь болж Дакарын боловсролын форумар дахин баталгаажсан байдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай хууль батлагдсаны дараа Засгийн газраас “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийг баталсан бөгөөд тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан байна. Тус хөтөлбөрийн зорилт 2-т Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бүх шатны боловсролд тэгш хамруулахаар заасан.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд боловсрол эзэмшихтэй холбогдсон харилцааг дараах хууль тогтоомжоор зохицуулж байна. Үүнд:

Нэг. Хууль

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай хууль
3. Боловсролын тухай хууль
4. Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль
5. Бага, дунд боловсролын тухай хууль
6. Дээд боловсролын тухай хууль
7. Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хууль
8. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль
9. Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030
10. Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого
11. Мэргэжлийн болон техникийн боловсролын хөгжүүлэх үндэсний хөтөлбөр

Хоёр. Монгол Улсын Их Хурал болон Засгийн газрын тогтоол

1. Монгол Улсын Их Хурлын 2013 оны 19 дүгээр тогтоол
2. Засгийн газрын 2012 оны 185 дугаар тогтоол
3. Засгийн газрын 2014 оны 71 дүгээр тогтоол
4. Засгийн газрын 2017 оны 162 дугаар тогтоол
5. Монгол Улсын Их Хурлын 2017 оны 46 дугаар тогтоол

Гурав. Сайдын тушаал

1. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын “Тусгай цэцэрлэг, сургуулийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 2017 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн А/195 дугаар тушаал
2. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 2017 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн А/196 дугаар тушаал

Дөрөв. Олон улсын конвенц

1. Боловсролын салбарт ялгаварлан гадуурхахын эсрэг тэмцэх тухай конвенц

2. Саламанкагийн тунхаглал 1994 он
3. Дакарын үйл ажиллагааны төлөвлөгөө “Бүх нийтийн боловсролын талаар гаргасан баримт бичиг” 2000 он.

Үндсэн хууль-ийн 16 дугаар зүйлийн 7-д “хүн бүр сурч боловсрох эрхтэй. Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгоно. ...” гэж заасан. Энэхүү эрхийг хангах хүрээнд боловсролын салбарын олон хууль тогтоомжууд батлан гаргасан.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай хуулийн 4 дүгээр бүлэгт хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрхийн талаар зохицуулсан. Тус хуулийн 14 дүгээр зүйлд хөгжлийн бэрхшээлтэй хүн бусад иргэний адил сурч боловсрох эрхтэй бөгөөд энэхүү эрхийг нь хангах чиглэлээр төрөөс хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсон. Хуулийн 14.1.2-т хувь хүний чадамж болон өөрийгөө үнэлэх үнэлэмжийг хөгжүүлэх, хүний эрх, үндсэн эрх чөлөөг хүндэтгэх явдлыг бэхжүүлэх гэж заасан.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тухайн хөгжлийн бэрхшээлээс нь үл хамаарч бүх шатны боловсролын байгууллагад бүрэн хамруулахаар заасны дагуу Монгол Улсын Засгийн газраас 2012 оны 185 дугаар тогтоолоор хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тусгай хэрэгцээт боловсрол олгох сургалтын байгууллагад санхүүжилт олгохдоо нэг сурагчийн хувьсах зардлын нормативыг 3 дахин нэмэгдүүлж тооцохоор болсон. Энэхүү заалт нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сургаж байгаа ердийн цэцэрлэг, сургуульд нэгэн адил хамаарахаар заасан. Энэ нь энгийн сургууль, цэцэрлэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцах боломжийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ тусгай сургуулиудын сургалтын орчин, нэг хүүхдэд үзүүлэх үйлчилгээний чанарыг сайжруулахад томоохон алхам болж чадсан.

Харин багшлах боловсон хүчнийг бэлтгэх, чадавхжуулах талаар хуулийн 16.4.-т “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол олгох багш, хэл засалч, хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалч, дохионы хэлний багш, сэтгэл зүйч, арга зүйчийг сургалтын төрийн сангийн зардлаар дотоод, гадаадад сургаж бэлтгэнэ.” гэж заасан нь хэл ярианы бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролд анхаарсан сайн зохицуулалт болсон. Тиймээс хуулийн хэрэгжилтийг сайжруулах шаардлагатай байна.

Мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.6-д элсэлтийн шалгалтад тэнцэж, дотоод, гадаадын их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсролын байгууллагад суралцах эрхтэй болсон хөгжлийн бэрхшээлтэй хүний бакалавр, магистр, докторын зэрэг олгох сургалтын төлбөрийг боловсролын зээлийн сан хариуцна гэж заасан. Харин Засгийн газрын 2014 оны 71 дүгээр тогтоолын 4.1.2-т хөгжлийн бэрхшээлтэй эсхүл эцэг, эх нь хоёулаа хөгжлийн бэрхшээлтэй бакалаврын хөтөлбөрт суралцагч¹⁸⁷-ид тэтгэлэг олгохоор заасан байна.

Боловсролын тухай хууль нь 2002 онд батлагдсан. Тус хуулийн 5 дугаар зүйлд “иргэнийг сурч боловсроход үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, **хөгжлийн онцлог**, эрүүл мэнд, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхахгүй байх, эх хэлээрээ сурч боловсрох тэгш боломж, нөхцөлөөр хангана” гэж заасан. Тус заалтад хөгжлийн

¹⁸⁷ Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын тэтгэлэг олгох журам

онцлогоор ялгаварлан гадуурхахыг хориглосон. Гэсэн хэдий ч өнөөгийн байдлаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол эзэмшилт анги дээшлэх тутам багасч буй холбогдох яамнаас гаргасан судалгаанаас харж болно.

2013 болон 2016 онд боловсролын багц хуулиудад томоохон хэмжээний нэмэлт, өөрчлөлт оруулсан. Тухайлбал, ерөнхий боловсролын тусгай сургууль нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сэргээн засах, чийрэгжүүлэх, бие даан хөгжүүлэх үйлчилгээ үзүүлэхээр болсон. Мөн хүүхдэд сэргээн засах, чийрэгжүүлэх, эрүүл мэндийн анхан шатны тусламж үзүүлэх чиглэлээр мэргэшсэн эмч, сувилагч, туслах багш, сэргээн засалч, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан хүүхдийн тооноос хамаарч ажиллах эрх зүйн орчинг бий болгосон.

Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль нь 2008 онд батлагдсан. Тус хуулийн 4 дүгээр зүйлд тусгай цэцэрлэг гэж хоёр наснаас сургуульд элсэх хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асрах, хамгаалах, хүмүүжүүлэх, сургах цогц үйл ажиллагаагаар хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийг дэмжих сургалтын байгууллагыг хэлнэ гэж заасан.

Түүнчлэн хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн бүлгийн хүүхдүүдтэй хамт сургаж болох бөгөөд хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хоёр хүртэл хүүхэд нэг бүлэгт байж болохоор заасан бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тооноос хамаарч багшид урамшуулал цалин олгохоор тус тус заасан. Манай улсын хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нэг л цэцэрлэг байдаг бөгөөд төсөв санхүүгийн асуудлаар болоод тус цэцэрлэгийн барилга баригдаж чадахгүй 5 жил болж байна. Энэ нь тусгай боловсрол шаардлагатай хүүхдүүдийн сурч боловсрох, нийгэмших эрх зөрчигдөж байгаа бодит жишээ юм.

Шигтгээ: Саажилттай хүүхэд, ХБ-тэй залуучуудыг сургах мэргэшсэн сургалтын байгууллагад хандахад “чамд туслах хүн манайд байхгүй, мөн чи гараад ажил олж хийхэд хэцүү учир авч сургаж чадахгүй” гэсэн хариу өгсөн байна. Энэ нь мэргэжлийн сургалтын байгууллагын багш нарт ХБ-тэй хүүхэдтэй ажиллах арга барил дутуу, сургуулийн барилга, сургалтын орчин хүртээмжгүй байна.

Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас 2018-2019 оны хичээлийн жилд цэцэрлэгийн насны 1088 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байна гэж мэдээлжээ. Улсын хэмжээнд байгаа 459 хүүхэд харах төвүүдэд 4200 гаруй хүүхэд хамрагдаж байгаагаас 149 нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хамрагдаж байна. Мөн тусгай 186 дугаар цэцэрлэгт нийт 73 хүүхэд, 10 дугаар цэцэрлэгт 116 хүүхэд хамрагдаж байна.

Хүүхдүүдийн цэцэрлэгт хамрагдалт, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн цэцэрлэгт хамрагдалт маш бага хувьтай. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг сургуулийн өмнөх боловсролд тэгш хамруулах зорилгоор цэцэрлэгийн цахим сонгон шалгаруулалтанд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг дараалал харгалзахгүй оруулж байгаа арга хэмжээ авч байна. Гэсэн ч орчны хүртээмжгүй байдал болон эцэг эхчүүдийн буруу ойлголт, хандлага, багш ажилчдын ур чадвар, ойлголт хандлага дутмаг байдгаас болоод хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд сургуулийн өмнөх боловсролд тэгш хамрагдаж

чадахгүй байна.

Бага, дунд боловсролын тухай хууль нь 2002 онд батлагдсан. Тус хуулийн 13 дугаар зүйлд ерөнхий боловсролын тусгай сургууль нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сэргээн засах, чийрэгжүүлэх, бие даалгах үйлчилгээ үзүүлж, бага, суурь, бүрэн дунд боловсрол, мэргэжил эзэмшүүлэх сургалтын байгууллагыг хэлнэ гэж тодорхойлсон. Тусгай сургууль нь боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяанд ажиллана. Тусгай сургууль нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сэргээн засах, чийрэгжүүлэх, эрүүл мэндийн анхан шатны тусламж үзүүлэх чиглэлээр мэргэшсэн эмч, сувилагч, туслах багш, сэргээн засалч, сэтгэл зүйч ажиллахаар хуульчилсан. Харин ерөнхий боловсролын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тооноос хамаарч тусгай мэргэжлийн багш, туслах багш, сэтгэл зүйч, сувилагч, сэргээн засалч, нийгмийн ажилтан ажиллуулж болохоор тус тус заасан.

Тусгай хэрэгцээт боловсролд хамрагдсан хүүхдүүд зөвхөн бичиг үсэг тайлагдахаас гадна хамт олон, хүмүүсийн дунд байж амьдрах ухааны аргад суралцах, сонирхлын дагуу өөрийгөө хөгжүүлэх хүсэл эрмэлзлийг нь төрүүлэх, түүнийг хөгжүүлэхэд анхаарах хэрэгтэй.

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль нь 2009 онд батлагдсан. 2017-2018 оны хичээлийн жилд мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй 673 суралцагч суралцаж байна. Үүнээс хэл ярианы бэрхшээлтэй 79, сонсголын бэрхшээлтэй 111 суралцагч байна. Тус хуулийн хүрээнд мэргэжлийн боловсрол эзэмших сонирхолтой хөгжлийн бэрхшээлтэй хүнийг дэмжих бодлогыг төрөөс баримталж байгаа нь сайшаалтай юм. Амьдралын хэв маяг, хөгжлийн бэрхшээлийн онцлогоос шалтгаалан бүх шатны боловсрол эзэмших боломжгүй болсон хүмүүс мэргэжлийн боловсрол эзэмшиж, ажил хөдөлмөр эрхлэх боломж бүрдүүлж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай хуульд заасны дагуу боловсролын байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй оюутныг ажил олгогчид танилцуулах, зуучлах үйл ажиллагааг зохион байгуулах үүрэгтэй бөгөөд энэхүү үүргийг биелүүлэхэд анхаарч бүх шатны боловсролын байгууллагад суралцаж төгсөж байгаа төгсөгчийг хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлэхэд анхаарах шаардлагатай байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд мэргэжлийн боловсрол, сургалт олгох, чадамж эзэмшүүлэх, тэднийг нийгмийн үйлчилгээнд хамруулах чиглэлээр дараах хууль зүйн үндэслэлийг тусгасан байна.

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын 24 дүгээр зүйлийн 5-д "... хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бусадтай адил тэгш, үл алагчлах үндэс дээр боловсрол эзэмших, мэргэжлийн сургалтад хамрагдах, насанд хүрэгсдийн болон насан туршийн сургалтад хамрагдах явдлыг хангана”;
- 2015 оны НҮБ-ын “Дэлхийн тогтвортой хөгжил-2030” хөтөлбөрийн “Чанартай боловсролыг дэмжих” гэсэн 4 дүгээр зорилгод мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагаатай холбоотой зорилтууд;
- Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ийн “нийгмийн тогтвортой хөгжил” гэсэн зорилтод иргэн бүрд хүртээмжтэй, чанартай боловсрол олгох, насан туршийн боловсролын үндэсний тогтолцоог бүрдүүлэх, зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, хөгжлийн

бэрхшээлтэй иргэдэд хөдөлмөр эрхлэх, нийгмийн үйлчилгээнд эрх тэгш оролцох боломжийг бүрдүүлэх;

- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийн 3.3.2 дахь заалт болон Мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүний мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх талаар тус тус тусгасан байна

2017-2018 оны хичээлийн жилд улсын хэмжээнд 85 мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад 35.800 суралцагч суралцсанаас 673 хөгжлийн бэрхшээлтэй суралцагч суралцсан байна. Улсын хэмжээнд 85 мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага байдгийн төрийн өмчийн 30, төрийн өмчийн бус 14 нийт 44 МСҮТ, политехник коллежид 673 хөгжлийн бэрхшээлтэй суралцагч суралцсанаас 556 суралцагч буюу 15-34 насны залуус 82.6 хувийг эзэлж байна.

Монгол Улсын Засгийн газраас 2019 оноос эхлэн МСҮТ-ийн оюутнуудад үндэсний тэтгэлэг 70.000 төгрөгийг олгохоор шийдвэрлэсэн.

Мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр нь Засгийн газрын 2016 оны 304 тоот тогтоолоор батлагдсан. Энэхүү хөтөлбөрөөр мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын шинэчлэлийг хөдөлмөрийн зах зээлийн эргэлтэд нийцүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодит механизм бүрдүүлж төлөвшүүлэх, мэргэжлийн боловсрол, сургалтын стандарт, хөтөлбөрийг шинэчлэх, багш нарыг заах арга зүй болон мэргэшсэн инженер, техникийн ажилтны түвшинд чадваржуулах, сургалтын нөхцөлийг орчин үеийн шаардлагад нийцүүлэх, иргэдийн хэрэгцээнд суурилсан үйлчилгээг нэвтрүүлэх, эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх асуудлыг тусгасан.

Хөтөлбөрийн 4.4.4 дүгээр заалтад хэрэгжүүлэх үйл ажиллагаанд “хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг мэргэжлийн боловсрол, сургалтад тэгш хамруулах боломжийг нэмэгдүүлэх” талаар тусгасан. Энэхүү хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан 5 мэргэжлийн ангийг шинээр нээж, үйл ажиллагааг хангасан байна гэсэн зорилт тавьсан. Тус хөтөлбөрийн дунд хугацааны зорилтот түвшинг 2019 онд, 2021 онд зорилтот түвшинд хүрсэн эсэхэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхээр төлөвлөсөн.

Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 нь 2016 оны 19 дүгээр Улсын Их Хурлын тогтоолоор батлагдсан. Тус үзэл баримтлалыг хэрэгжүүлснээр 2030 онд нэг хүнд ногдох үндэсний нийт орлого 17500 америк долларт хүрч, дунд орлоготой орнуудын эгнээнд хүрнэ, эдийн засгийн дундаж өсөлт 6.6 хувиас доошгүй байж, бүх төрлийн ядуурлыг эцэс болгохоор зорьсон.

Харин боловсролын асуудлаар суурь болон мэргэжлийн боловсролд хамрагдалтын түвшинг 100 хувьд хүргэж, насан туршийн боловсролын тогтолцоог бүрдүүлнэ гэж заасан. Энэхүү үзэл баримтлалд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн дараах зохицуулалтыг тусгасан.

Нийгмийн тогтвортой хөгжлийг хангах хүрээнд¹⁸⁸:

¹⁸⁸ Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030

- Нийгмийн хамгааллын үйлчилгээ нь баталгаатай, хүртээмжтэй, зорилтот бүлэгт чиглэсэн байх
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хөдөлмөр эрхлэх, нийгмийн үйлчилгээнд эрх тэгш оролцох боломжийг бүрдүүлэх
- Мэргэжлийн боловсрол, сургалтын эрэлтэд нийцсэн тогтолцоог төлөвшүүлж, суралцагчдын тоог нэмэгдүүлэхээр зорилт дэвшүүлсэн.

Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого нь 2015 оны Улсын Их Хурлын 12 дугаар тогтоолоор батлагдсан бөгөөд 2014-2024 оныг хүртэл 10 жилийн хугацаанд хэрэгжинэ. Боловсрол нь иргэн бүрийн насан туршийн амьдралын чанарыг дэмжин баталгаажуулах, улс орны нийгэм, эдийн засаг, шинжлэх ухаан, технологийн хөгжлийн түлхүүр хүчин зүйл, үндэсний тусгаар тогтнол, аюулгүй байдлын баталгаа хэмээн үзэж, Монгол Улсын төрөөс боловсролыг нийгмийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлэхээр заасан. Төрөөс иргэн бүрд үзүүлэх боловсролын үйлчилгээ нь олон улсад хүлээн зөвшөөрөгдөхүйц, чанартай, хүртээмжтэй байх зарчим баримтална. Боловсролын байгууллага нь ялгаварлан гадуурхалтаас ангид, иргэдийн эрх ашиг, эрүүл мэнд, ёс суртахуун, нийгмийн аюулгүй байдалд харшлахгүй байх зарчмыг баримталж ажиллахаар заасан. Ерөнхий боловсролын сургалтын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд 2018-2019 оны хичээлийн жилд хамрагдана. Мөн тэргүүлэх чиглэлийн дээд болон мэргэжлийн боловсролын 20-оос доошгүй хөтөлбөр олон улсад магадлан итгэмжлүүлэхээр зорилт тавьсан.

Мэргэжлийн болон техникийн боловсролын хөгжүүлэх үндэсний хөтөлбөр нь Монгол Улсын хөгжлийн бодлого, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, шаардлагад нийцсэн, иргэдийн хэрэгцээ, авьяас, сонирхолд тохирсон мэргэжлийн болон техникийн боловсролыг шинэчлэн хөгжүүлж, чанар, хүртээмж, үр өгөөжийг дээшлүүлэх зорилготой. Хөтөлбөр 2016-2021 он хүртэл хоёр үе шаттай хэрэгжинэ. Хөтөлбөрийн 4.4.4-т хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг мэргэжлийн боловсрол, сургалтад тэгш хамруулах боломжийг нэмэгдүүлэх, хөтөлбөрийн 5.1.13-т хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан 5 мэргэжлийн ангийг шинээр нээж, үйл ажиллагааг хангасан байна гэж заасан.

Засгийн газрын 2016 оны 216 дугаар тогтоолоор Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төвийн байгуулсан. Тус төв¹⁸⁹ нь Мэргэжлийн болон техникийн боловсролын хөтөлбөрийн шаардлага хангасан төгсөгчдийн мэргэжлийн ур чадварыг үнэлэх шалгах, баталгаажуулах, мэргэжлийн түвшинг тогтоох, зэрэг олгох, хөндлөнгийн үнэлгээ зохион байгуулах үндсэн чиг үүргийн хүрээнд үнэлгээ, гэрчилгээжүүлэлт, сургалт, судалгаа инновац, мэдээллийн сан бүрдүүлэх ажлуудыг хариуцан зохион байгуулж байна.

Монгол Улсын Их Хурлын 2013 оны 19 дүгээр тогтоол. Энэхүү тогтоолоор хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх боловсролын үйлчилгээг тусгай сургууль болон сэргээн засалтын бусад төрөлжсөн байгууллага эзэмшүүлэх ажлыг шинэчлэн зохион байгуулахаар заасан. Мөн дохионы хэлний багш, арга зүйч, согог зүйч зэргийг бэлтгэх зорилгоор нийт 20-иос доошгүй хүнийг жил бүр гэрээгээр, сургалтын төрийн сангийн зардлаар гадаадад сургахаар тус тус заасан. Энэхүү ажлын хүрээнд 2018 оны 10 сард Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд болон Японы анагаах ухаан,

¹⁸⁹ <http://www.asc.mn/intro/5> Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төв

нийгмийн халамжийн олон улсын сургуультай хамтран ажиллах санамж бичиг байгуулсан. Энэхүү санамж бичгийг байгуулснаар сувилахуй, физик эмчилгээ, хөдөлгөөн засал, хэл, сонсгол, хараа зүй, эм зүй зэрэг 9 мэргэжлийн чиглэлээр ирэх таван жилийн хугацаанд жил бүр 10 хүртэл оюутныг 100 хувийн тэтгэлгээр суралцуулахаар тохиролцсон.

ОХУ-ын Засгийн газрын тэтгэлгээр согог зүйч, хараа, сонсгол болон оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажиллах багш, хэл заслын мэргэжлээр жил бүр 15 оюутныг бакалаврын хөтөлбөрт хамруулахаар Монгол-Оросын Засгийн газар хоорондын комиссын боловсрол, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны комиссын XII хуралдаан (2018 оны 02 дугаар сарын 26)-аар талууд тохиролцсон ба эхний 10 оюутныг Эрхүү хотын Байгалийн их сургууль сургаж байна.

Засгийн газрын 2012 оны 185 дугаар тогтоол оор нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгох журам, тусгай хэрэгцээт боловсрол олгох сургалтын байгууллагын удирдах болон гүйцэтгэх албан тушаалд нэмэгдэл хөлс олгох, тусгай сургалтын байгууллагын зардал тооцох журмыг баталсан. Мөн энэ журмаар дотоодын их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсролын байгууллагад суралцах хөгжлийн бэрхшээлтэй иргэний сургалтын төлбөр болон амьжиргааны зардлын хэмжээг боловсрол болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран тогтоохоор заасан. Ийнхүү тогтоохдоо мөрдөж байгаа **сургалтын төлбөрийн хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс багагүй байх зарчим баримтлахаар** заасан байна. Тусгай хэрэгцээт боловсрол олгох сургалтын байгууллагын албан хаагчдад ажлын чиг үүргээс хамаарч албан тушаалын үндсэн цалингаас 10-30 хувиар тооцож нэмэгдэл хөлс олгохоор баталсан.

2018 оны 12 сарын байдлаар Ерөнхий боловсролын тусгай 6 сургуулийн бага ангид 72 туслах багш ажиллаж байгаа бөгөөд 2018 оны эхний хагас жилийн байдлаар 670.0 сая төгрөгийг сургууль багш, ажилчдын цалингийн төсөвт багтаан цалинжуулж байна. 2019 оны төсвийн төсөлд ерөнхий боловсролын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж буй багшийн нэмэгдэл олгох зардалд /7.8 тэрбум/ тусгасан боловч батлагдаагүй байна.

Засгийн газрын 2014 оны 71 дүгээр тогтоол нь дээд боловсролын байгууллагад суралцагчид сургалтын тэтгэлэг олгох журам юм. Энэхүү журмын 4 дүгээр зүйлд хөгжлийн бэрхшээлтэй эсхүл эцэг, эх нь хоёулаа хөгжлийн бэрхшээлтэй бакалаврын хөтөлбөрт суралцагчид сургалтын төлбөр олгохоор заасан. Харин Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6-д элсэлтийн шалгалтад тэнцэж, дотоод, гадаадын их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсролын байгууллагад суралцах эрхтэй болсон хөгжлийн бэрхшээлтэй хүний бакалавр, магистр, докторын зэрэг олгох сургалтын төлбөрийг боловсролын зээлийн сан хариуцна гэж заасан байдаг бол Засгийн газрын 2012 оны 185 дугаар тогтоолын 3.1-д дотоодын их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсролын байгууллагад зохих журмын дагуу элсэн суралцах хөгжлийн бэрхшээлтэй иргэнд сургалтын төрийн сангаас олгох сургалтын төлбөр болон амьжиргааны зардлын хэмжээг 2 дахин нэмэгдүүлж тооцно гэж заасан.

Засгийн газрын 2017 оны 162 дугаар тогтоол оор ерөнхий боловсролын тусгай сургуулийн суралцагчийн үдийн хоолны өдрийн зардлыг 2400 төгрөгөөр

ТОГТООСОН.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2013 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн “Сургалтын төлөвлөгөө, хичээлийн жилийн бүтцийг шинэчлэн батлах тухай” А/311 дүгээр тушаалын дөрөвдүгээр хавсралтаар “Оюуны бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн сургалтын төлөвлөгөө”, тавдугаар хавсралтаар “Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн сургалтын төлөвлөгөө”, зургаадугаар хавсралтаар “Харааны бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн сургалтын төлөвлөгөө”-г тус тус баталсан.

Оросын Холбооны Улс

ОХУ-ын “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын тухай” хуулийн 19 дүгээр зүйлд “Төрөөс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг боловсрол эзэмших явдлыг бүхий л талаар дэмжин, үүний тулд шаардлагатай нөхцөлийг баталгаатай хангана”¹⁹⁰ гэж заажээ. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бүх шатны боловсролыг үнэ төлбөргүй эзэмших эрхийг баталгаажуулсан бөгөөд энэ нь эдгээр иргэд бусад хүмүүсийн нэгэн адил хүний эрх, эрх чөлөөг эдлэх, тэдгээрийн бие хүний болон хувийн онцлог, боломжийг хөгжүүлэх, нийгмийн хөгжилд татан оролцуулахад чиглэгддэг байна.

Мөн дээрх байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсрол эзэмших үйл явцад сэтгэл зүй-сурган хүмүүжүүлэх дэмжлэг үзүүлэн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг гэрийн нөхцөлд нь сургахад дэмжлэг үзүүлнэ. Хүүхдээ гэрээр боловсрол олгоход гаргах зардлын хэмжээг ОХУ-ын субъектүүдийн эрх зүйн актын дагуу тодорхойлон эцэг, эхэд нь олгодог байна.

Түүнчлэн ОХУ-ын “Боловсролын тухай”¹⁹¹ хуулийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэд мэргэжлийн боловсролыг нэг бус удаа үнэ төлбөргүй эзэмших эрхтэй ба 1-2 дугаар группын хөгжлийн бэрхшээлтэй иргэд техникийн дээд сургууль, техникийн дунд боловсролын сургуульд элсэлтийн уралдаант шалгалтгүйгээр элсэн орох эрх эдэлдэг. Үүнээс гадна тэдэнд оюутны цалинг 50 хувь нэмэгдүүлэн олгодог.

Холбооны Бүгд Найрамдах Герман улс

ХБНГУ-ын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэд бусад хүмүүсийн нэгэн адил боловсрол эзэмших эрхтэй болохыг хуульчилж, төрөөс бүх иргэдэд заавал эзэмших үнэ төлбөргүй бүрэн дунд боловсролыг баталгаатай олгохыг заасан. Ихэнх хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд бусад хүүхдүүдийн нэгэн адил ердийн сургуульд суралцдаг ба ийм онцгой хэрэгцээтэй хүүхдүүд ердийн сургуульд суралцах боломжтой байдаг. Ердийн сургуулиуд эдгээр хүүхдүүдийн хэрэгцээнд тохируулан сурганы арга, арга зүйн үндсэн дээр зохих нөхцөлийг бүрдүүлсэн байдаг. Ийм маягийн инклюзив сургалттай ердийн сургууль нь нийгмийн харилцаанд эерэг уур амьсгалыг бий болгох, бүх нийтийг боловсролд тэгш хамруулах, ялгаварлан гадуурхах үзэлтэй хийх тэмцэлд ихээхэн үр нөлөө үзүүлдэг ажээ.

Ямар нэг шалтгааны улмаас ердийн ерөнхий боловсролын сургуульд суралцах боломжгүй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд тусгай сургалттай сургуульд суралцдаг. ХБНГУ-ын боловсролын хууль тогтоомжийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэд дээд,

¹⁹⁰ ФЗ “О социальной защите инвалидов в российской федерации.” www.docs.cntd.ru

¹⁹¹ ФЗ “Об образовании.” Consultant.ru

болон мэргэжлийн боловсрол эзэмших эрхээр бусад хүмүүсийн нэгэн адил хангагдсан ба ихэнх их, дээд сургуулиуд үнэ төлбөргүй байдаг. Үүний зэрэгцээ цөөн тооны оюутан элсүүлдэг зарим факультетад хөгжлийн бэрхшээлтэй элсэгчид зарим хөнгөлөлт эдэлдэг.

Хуулийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудын сурах үйл явцын үр өгөөжийг дээшлүүлэх зорилгоор тусгай тусламж авах эрхээр хангасан байдаг ба үүнд зарцуулагдах зардлыг холбооны муж улсын нийгмийн албад хариуцдаг. Харин хөгжлийн бэрхшээлтэй оюутны эцэг, эх нь дундаж цалингийн хэмжээнээс дээгүүр орлоготой бол тусгай тусламжийн зардлын тал хувийг өөрсдөө хариуцдаг байна.

Хөгжлийн бэрхшээлтэй оюутанд түүний суралцахад нь тусламж үзүүлэх хувийн туслагч тодорхой хугацаагаар үйлчилж, тусламж үзүүлэхийг тусгай тусламж гэх бөгөөд энэ нь дадлагын ажил бичих, ном, сурах бичиг олох, дадлага хийх, хараагүй оюутанд хичээлийн материалыг уншиж сонсох, сонсголтанд нь хичээлийг нь тэмдэглэж өгөх, өөрөө явах, хөдлөх боломжгүйд нь сургуульдаа явж, хөдлөхөд нь туслах гэх мэтээр тусладаг ажээ. Ийм маягийн туслагчаар тэр сургуулийнх нь оюутнууд ба тус сургуулийн дэргэдэх ийм тусламж үзүүлэх зорилго бүхий албаны ажилтнууд ажилладаг. Үүнээс гадна хөгжлийн бэрхшээлтэй оюутнууд сургалтандаа нэмэлт техникийн тусламж авдаг, тухайлбал, тусгай программ бүхий зөөврийн компьютер, хараагүй оюутнууд номын санд тусгай тоноглогдсон суудал, компьютертай байдаг. Мөн хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудад улирлын шалгалтын хугацааг сунгах, шалгалт өгөх хэлбэрийг сонгох, шалгалтыг тусгайлан өгөх зэрэг хөнгөлөлт үзүүлдэг.

Бүгд Найрамдах Хятад Ард Улс

“Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамгаалах тухай хууль” нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах тухайд чухал ач холбогдолтой гол хууль юм. Энэ хууль нь 1990 онд батлагдаж, 1991 оноос хүчин төгөлдөр болсон бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сувилаал, боловсрол, ажил эрхлэлт, нийгэм-соёлын амьдрал, халамж, үйлчилгээ, хууль зүйн үүрэг хариуцлага зэрэг асуудлыг хамарсан 9 бүлэг, 54 зүйлтэй.

Уг хуулийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай нийгмийн ухамсрыг дээшлүүлэх зорилгоор Хятад болон үндэсний цөөнхийн 7 хэл ба Брайл үсгээр 10 сая гаруй хувь хэвлэж, Засгийн газрын албад болон Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн олон нийтийн байгууллагуудын сүлжээгээр дамжуулан улс орон даяар түгээсэн байна.

Хятад улс нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сурч боловсрох асуудлыг ихээхэн анхаарч ирсэн. Тухайлбал, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамгаалах тухай хуулийн 18-р зүйлд: *"Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн боловсрол эзэмших эрхийг төрөөс баталгаажуулна... Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудад албан ёсны боловсролыг олгоно... албан ёсны боловсрол эзэмшиж буй сурагчдад төрөөс сургалтын төлбөр ногдуулахгүй."* гэж заажээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн боловсролын тухай журамд Сургуулийн өмнөх боловсрол, Албан ёсны боловсрол, Мэргэжлийн сургалт боловсрол, ба насанд хүрэгчдийн боловсрол, Багш нар болон материаллаг нөхцөлийн баталгаа зэргийг илүү

нарийн тусгасан байна. Журам¹⁹² нь 9 бүлэг, 52 зүйлтэй.

Журам ёсоор¹⁹³ бүх түвшний Ардын засгийн газрууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн боловсролын зардлыг төлөх санг бүрдүүлэх үүрэгтэй ба, тэдгээр сангууд нь баталгаатай байж, боловсролын үйл ажиллагааны зардал өсөхийн хэрээр эрэлт хэрэгцээнийх нь дагуу, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн боловсролын хөгжилд хэрэглэгдэх тусгай тэтгэлгийн сангуудыг байгуулж болно. Мөн бүх шатны орон нутгийн Ардын засгийн газруудаас албан ёсны боловсролд зориулан бүрдүүлсэн сангууд ба сургалтын төлбөрийн илүү төлөлтөөс үүссэн хуримтлалын тодорхой хувийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуучуудын албан ёсны боловсролд зарцуулах ёстой байдаг байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан тусгай сургуулиуд байхын зэрэгцээ маш олон ердийн буюу үндсэн сургуулиуд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг элсүүлэн авдаг. Учир нь зарим хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ердийн сургуульд суралцахыг сонгох нь элбэг байдаг байна.

ГУРАВ. ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАР

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах асуудал хамгийн хүндрэлтэй асуудлын нэг юм. Харааны болон сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүмүүсийн хувьд илүү хүндрэлтэй асуудал юм. Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх хүрээнд дараах хууль тогтоомжууд үйлчилж байна.

1. Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого
2. Эрүүл мэндийн тухай хууль
3. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль
4. Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль
5. Дүлийрэлт, сонсгол бууралтаас сэргийлэх, хянах үндэсний стратеги (2010-2019)
6. Сэргээн засах тусламж, үйлчилгээний журам
7. Сэтгэцийн эрүүл мэндийн хоёр дахь үндэсний хөтөлбөр (2010-2019)
8. Амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчнөөс сэргийлэх, хянах” үндэсний хөтөлбөр (2014-2021)

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай хуулийн 6 болон 7 дугаар бүлэгт хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаар зохицуулсан. Төрөөс хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, оношлох, үнэлэх, урьдчилан сэргийлэх, эмчлэх, сувилах, сэргээн засах цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр заасан. Эрүүл мэндийн байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ тэдний онцлог хэрэгцээ, шаардлагыг хангасан

Шигтгээ: Эмнэлгийн байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст үйлчлэхэд хангалтгүй байна. Бүх эмнэлгийн 52.2 хувь нь машины зогсоолоос эмнэлэг хүрэх зам нь хүртээмжгүй, 18,2 хувь нь налуу замгүй, 69.1 хувь нь лифтгүй, 94.7 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан бие засах газаргүй байна.

¹⁹² Regulations on the education of persons with disabilities, Beijing, China, 1997. <http://www.cdpe.org.cn/english/lawsdoc>

¹⁹³ Regulations on the education of persons with disabilities, Beijing, China, 1997. <http://www.cdpe.org.cn/english/lawsdoc>

хүртээмжтэй орчин, техник, тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байна гэж заасан.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай хуульд шинээр орж ирсэн зохицуулалтын нэг бол хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээ юм. Хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээ” гэж хөгжлийн бэрхшээлтэй хүнд нийгмийн амьдралд тэгш оролцох боломжийг бүрдүүлж, гэр бүл, хамт олны дунд эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгэм-сэтгэл зүйн үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэхийг хэлнэ. Энэхүү үйлчилгээг эрүүл мэнд, хөдөлмөр, нийгэм, дэд бүтэц, зам тээвэр, мэдээллийн технологийн чиглэлээр хэрэгжүүлэхээр заасан. Энэхүү үйлчилгээг өмчийн бүх хэлбэрийн байгууллага үзүүлж болох бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий тусгай зөвшөөрөлтэй төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх тохиолдолд зардлыг бүрэн болон хэсэгчлэн төрөөс санхүүжүүлнэ. Харин хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхдийг комиссын дүгнэлтийн дагуу хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээнд заавал хамруулах үүрэгтэй.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцын 25 дугаар зүйлд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэндийн асуудлыг тусгасан. Конвенцын оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хүн амд суурилсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үнэ төлбөргүй буюу худалдан авах чадавхад нийцсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, хөтөлбөрөөр хангах, эрт оношлох, зохих үед таслан зогсоох буюу багасгахад чиглэгдсэн болон хүүхэд, ахмадуудыг цаашид хөгжлийн бэрхшээлтэй болохоос урьдчилан сэргийлэх үйлчилгээнд хамруулах, эмнэлгийн үйлчилгээг бүх газарт тухайлбал, хөдөө орон нутагт ч аль болох гэрт нь ойр газар үзүүлэх, эрүүл мэндийн болон амь насны даатгалд ялгаварлахыг хориглох, хөгжлийн бэрхшээлийн улмаас эмнэлгийн тусламж, эрүүл мэндийн үйлчилгээ, эсхүл хоол хүнсний асуудалд алагчилж, үгүйсгэхээс урьдчилан сэргийлэхээр заасан.

Мөн сэргээлт, нөхөн сэргээлтийн асуудлыг тусгайлан зохицуулсан. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хараат бус байдлыг дээд зэргээр хангах, тэднийг бие махбод, оюун санаа, нийгмийн болон мэргэжлийн бүрэн чадавхитай болгох, нийгмийн бүхий л хүрээнд бүрэн хамрагдах, оролцох боломжийг олгох, эзэмшүүлэх зорилгоор шаардлагатай бүхий л зохистой арга хэмжээг хэрэгжүүлнэ. Сэргээх, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх салбарт ажилладаг мэргэжилтнүүд, ажилтнуудад зориулсан анхан болон үргэжилсэн сургалт зохион байгуулах, мөн сэргээлт, нөхөн сэргээлтэд шаардлагатай туслах тоног төхөөрөмж, технологиудыг хүртээмжтэй байлгах, тэдгээрийг хэрэглэх зааварчилгаа, мэдлэг олгох явдлыг хөхиүлэн дэмжих үүргийг хүлээлгэсэн.

Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого нь 2017 оны Засгийн газрын 24 дүгээр тогтоолоор батлагдсан. Тус бодлогын баримт бичгийн зорилго нь хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэдний эрэлт, хэрэгцээнд тулгуурлан аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх, нотолгоонд суурилсан оношилгоо, эмчилгээний шинэ технологийг нэвтрүүлэх, эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн зохистой тогтолцоог бүрдүүлэх замаар тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан монгол хүний дундаж наслалтыг уртасгахад оршино. Бодлогыг нийгмийн эрүүл мэнд, эмнэлгийн тусламж, үйлчилгээ, хүний нөөц, эрүүл мэндийн санхүүжилт, эрүүл мэндийн технологи, эм зүйн тусламж, үйлчилгээ, мэдээллийн технологи, мэдээллийн

удирдлага, эрүүл мэндийн салбарын удирдлага, зохион байгуулалт, ил тод байдал гэсэн 8 чиглэлээр хэрэгжүүлнэ. Тус бодлого нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, оношилгооны асуудал тусгагдаагүй байна. Бодлогын 2.4.2-т “сэргээн засах, ...тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан олон улсын жишигт хүргэх” гэж тусгасан байна.

Аливаа өвчин, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, түүнийг цаг алдалгүй оношлох, тохирсон эмчилгээ хийх нь бүх төрлийн өвчлөлийг багасгахад хамааралтай боловч энэ талаар ямарч заалт тусгагдаагүй байна. Эрүүл мэндийн технологийг сайжруулах талаар 6 заалт орсон ч хэт ерөнхий зохицуулалт болсон.

Баримт. НҮБ-ын Хүүхдийн сан, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв хамтран агаарын бохирдлын эсрэг хариу арга хэмжээ аваагүйгээс гарах үр дагаврын өртгийн тооцооны судалгаа хийжээ. Тус тайланд хэрвээ тодорхой арга хэмжээ авахгүй бол Улаанбаатар хотын хэмжээнд хүүхдэд үзүүлж буй эрүүл мэндийн үйлчилгээнд агаарын бохирдлын үзүүлж буй төсвийн ачаалал 2025 он хүртэл жил бүр 4.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэхээр байгаа аж. Ингэхдээ зөвхөн агаарын бохирдолтой өвчлөлд зарцуулж буй эмнэлгийн тусламж үйлчилгээний шууд зардал болон улсын төсвөөс нэг хүнд зарцуулж буй эрүүл мэндийн зардлыг тогтвортой түвшинд байхаар тооцсон

Эрүүл мэндийн тухай хууль нь 2011 онд батлагдсан. Хуулийн 16 дугаар зүйлд сувилахуйн төв нь байнгын асаргаа шаардагдах ахмад настан, архаг өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээг үзүүлэхээр заасан. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд харьяа өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлгийн байнгын хяналтад байж эрүүл мэндийн тусламж үйлчилгээг авахаар заасан. Энэхүү зохицуулалт нь хэт явцуу зохицуулалт болсон. Өрх, сум, тосгоны эмч нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаар мэдлэг, мэдээлэл дутмаг байдаг бөгөөд тухайн хүүхдэд шаардлагатай мэргэжлийн үйлчилгээг үзүүлж чадахгүй цаг алдах явдал гарах болсон. Тиймээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эхчүүд хувийн эмнэлэгт хандаж хяналтанд нь байх тохиолдол их байдаг боловч үүнийг нь асаргаа болон группыг нь сунгаж буй комисс хүлээн зөвшөөрдөггүй. Тиймээс заавал, хэлбэр төдий байдлаар улсын эмнэлгээр үйлчлүүлэх тохиолдол гарч байна. Тиймээс Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулж, хувийн эмнэлгийн статусыг тодорхой болгох шаардлагатай.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль 2016 онд батлагдсан. Энэ хуулиар хүн амд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулна. Өрхийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж буй эмнэлгийн байгууллагын чиг үүрэг, тусламж, үйлчилгээ үзүүлэх хүрээг тогтоож өгсөн. Мөн мэргэшсэн эмнэлгийн тусламж, үйлчилгээ болох эх барих, эмнэлгийн яаралтай тусламж, түргэн тусламж, сувилахуйн дагнасан үйлчилгээ, сэргээн засах тусламж, үйлчилгээний зохион байгуулалтыг зохицуулсан. Дээрх эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллага нь эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрөл авч үйл ажиллагаа явуулна. Эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой гарсан бүх зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль нь 2013 шинэчлэн батлагдсан. Энэ

хуулиар хүн амын сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, сэтгэцийн эмгэгээс урьдчилан сэргийлэх талаар төрөөс баримтлах бодлого, зарчмыг тодорхойлох, сэтгэцийн эмгэгтэй хүний эрхийг хамгаалах, нийгэм, эдийн засгийн харилцаанд оролцох, бие даасан байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх, сэтгэл зүйн тусламж авах нөхцөлийг хангахад иргэн, хуулийн этгээдийн хүлээх үүрэг, сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг байгууллага, эмнэлгийн мэргэжилтний үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулна. Энэхүү хууль нь хэт ерөнхий зохицуулалттай. Хэрэв сэтгэцийн эрүүл мэндийн улмаас өөрийгөө хянах боломжгүй, байнгын асаргаа шаардлагатай хүнийг хэрхэн эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх талаар нарийвчилсан зохицуулалт оруулах шаардлагатай.

Дүлийрэлт, сонсгол бууралтаас сэргийлэх, хянах үндэсний стратеги нь 2010-2019 он хүртэл хоёр үе шаттай хэрэгжүүлж байна. Стратегийн зорилго нь хүн амын дүлийрэлт, сонсгол бууралтын түвшинг тогтоон 2019 онд тогтоосон түвшингээс 5 хувиар бууруулах, тэдгээрт хүргэдэг хүчин зүйлсийн тархалтыг тогтоож, эрсдэлт хүчин зүйлсээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч сонсгол хамгаалах үйл ажиллагааг дэмжих юм. эрүүл мэндийн тусламжийн бүх шатлалд чих, сонсголын тусламж, үйлчилгээг найдвартай үзүүлэх сүлжээг бий болгож, дүлийрэлт сонсгол бууралтыг эрт оношлох, эмчлэх, нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулж байгаа бүх хэлбэрийн мэргэжлийн байгууллагуудын чадавхыг сайжруулна. Энэхүү стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн хугацаа дуусч байгаа боловч тайлан мэдээ нэг ч гараагүй. Хэн хариуцан ажиллаж байгаа нь ч тодорхой бус байна.

Сэргээн засах тусламж, үйлчилгээний журам нь Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 487 дугаар тушаалаар батлагдсан. Энэхүү журам нь сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлдэг төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад хамаарна.

Журамд зааснаар сэргээн засах тусламж, үйлчилгээ гэж өвчин эмгэг, бусад хүчин зүйлийн нөлөөгөөр бий болсон хүний биеийн бүтэц, үйл ажиллагааны алдагдлын улмаас үүссэн үр дагаврыг арилган амьдралын чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн урт хугацааны тусламж, үйлчилгээг хэлнэ. Сэргээн засах чиглэлийн мэргэжилтний үзлэг, үнэлгээ, зөвлөгөө нь дараах төрөлтэй.

- Бие бялдар засал (хөдөлгөөн засал эмчилгээ, физик эмчилгээ)
- Хөдөлмөр засал (үйл ажиллагааны, харилцах чадварын, танин мэдэхүйн сэргээн засах, сэтгэл засалын эмчилгээ)
- Хэл, яриа засал
- Протез, ортез, туслах хэрэгслийн засал

Эрүүл мэндийн салбар нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлдэг хамгийн чухал салбар боловч хамгийн зохицуулалт багатай, хүндрэл учруулдаг салбар юм. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоон статистикаас харахад жилд дунджаар 5-6 мянган хүн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эгнээнд нэгдсэн байх юм. Үүний тал хувь нь төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эзэлж байна. Эрүүл мэндийн салбарт энэ талаар нарийвчилсан судалгаа мэдээлэл одоог хүртэл байхгүй. Төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй төрж буй болон олдмол бэрхшээл дунд хараа болон сонсголын бэрхшээлийн шалтгаан нөхцөлийг судалгааны ажил орхигдож байна.

ДӨРӨВ. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэргэжлийн нөхөн сэргээлт, хөдөлмөр эрхлэлтийн тухай 159 дүгээр конвенцод хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ажил олох, ажлын байраа хадгалах, ахиж дэвших адил боломж олгох, тэгш хандах, тухайн ажил нь өөрийн сонголтод нийцэж, хувь хүний боломж чадварыг харгалзсан байх зэрэг нийтлэг хэм хэмжээг заасан байдаг. Түүнчлэн тус конвенцод мэргэжлийн нөхөн сэргээлтэд хамруулах, хөдөлмөрийн зах зээлд нээлттэй оролцуулах, хөдөлмөр эрхлэлт, нөхөн сэргээлтийн дэд бүтцийг бий болгох, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын цагийг богиносгох, тусгай зориулалтын тоног төхөөрөмжийг татвар, бусад төлбөрөөс чөлөөлөх, мэдээлэл хүргэх, тэднийг дэмжихэд чиглэсэн орон нутгийн оролцоог нэмэгдүүлэх, багш нарыг бэлтгэх, давтан сургах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг гишүүн орнуудад зөвлөсөн.

Конвенцын дагуу Монгол Улсын Засгийн газраас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрлөх эрхийг эдлүүлэхэд дэмжлэг, туслалцаа үзүүлэх талаар холбогдох хууль тогтоомжид тусгасан. Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой асуудлыг дараах хууль тогтоомжоор зохицуулж байна. Үүнд:

1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай хууль
2. Хөдөлмөрийн тухай хууль
3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль
4. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
5. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль
6. Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
7. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай Олон улсын Хөдөлмөрийн байгууллагын 155 дугаар конвенц
8. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай олон улсын Хөдөлмөрийн байгууллагын 155 дугаар конвенцын 164 дүгээр зөвлөмж
9. Тахир дутуу хүмүүсийн мэргэжлийн нөхөн сэргээлт, хөдөлмөр эрхлэлтийн тухай олон улсын Хөдөлмөрийн байгууллагын 159 дүгээр конвенц
10. Тахир дутуу хүмүүсийн мэргэжлийн нөхөн сэргээлт, хөдөлмөр эрхлэлтийн тухай олон улсын Хөдөлмөрийн байгууллагын 159 дүгээр конвенцын 168 дугаар зөвлөмж

Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилго 8 буюу “Тогтвортой, хүртээмжтэй эдийн засгийн өсөлт, бүрэн, бүтээмжтэй ажил эрхлэлт, зохистой хөдөлмөрийг хөхүүлэн дэмжих”-д 2030 он гэхэд эрэгтэй, эмэгтэй бүх хүн, түүний дотор залуу болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бүрэн, бүтээмжтэй ажил, зохистой хөдөлмөр эрхлүүлж, адил үнэ цэнэтэй ажилд адилхан цалин хөлс олгох зорилтыг дэвшүүлсэн. Энэхүү зорилтын хэрэгжилтэд хяналт тавьж байгаа субъект байхгүйгээс цаасан дээр буусан тунхаглал болж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хөдөлмөр эрхлэхэд тулгамдаж буй асуудалд

- Дэд бүтцийн хүртээмжгүй байдал
- Ажил олгогчдын хандлага сөрөг
- Ажлын байрны хүртээмж бага

- Ажлын байрны шалгуур өндөр байдаг тул хөдөлмөр эрхлэхэд хүндрэл учирч байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай хуулийн 5 дугаар бүлэгт хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн талаар зохицуулсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүн ажилд орох, албан тушаал ахих, цалин хөлс, нөхөн олговор авах, хөдөлмөр эрхлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд бусадтай адил тэгш хамрагдах эрхтэй. Энэхүү хуулийн нэг онцлог бөгөөд хөдөлмөр эрхэлж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг дэмжсэн зохицуулалт бол хуулийн 17.5 дахь хэсэгт заасан цалин хөлс олгож байгаа шалтгаанаар хөдөлмөр эрхэлж байгаа хүний нийгмийн халамжийн болон нийгмийн даатгалын аливаа тэтгэвэр, тэтгэмжийг зогсоохыг хориглосон зохицуулалт юм. Энэ хууль батлагдахаас өмнө ажил хөдөлмөр эрхэлж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэн, мөн байнгын асаргаа шаардлагатай хүүхдээ асардаг хүн хөдөлмөр эрхэлж байгаа бол нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж авдаггүй байсан. Энэ зохицуулалт бий болсноор хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон түүний гэр бүлийн санхүүд тодорхой хэмжээний дэмжлэг болж чадсан.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн хөдөлмөр эрхлэхэд төрөөс дараах дэмжлэгийг үзүүлж байна. Үүнд:

1. хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулж байгаа иргэн, хуулийн этгээдийг хууль тогтоомжийн дагуу татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамруулах, тохирох хэрэглэгдэхүүн бүхий ажлын байр бий болгохыг урамшуулах;
2. хөгжлийн бэрхшээлтэй хүний үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэхэд дэмжлэг үзүүлэх, төсвийн хөрөнгөөр хийх худалдан авалтад тэргүүн ээлжинд хамруулах;
3. хөгжлийн бэрхшээлтэй хүн мэргэжлээрээ ажиллахад шаардагдах ажлын багаж, тоног төхөөрөмж, материал болон бусад шаардлагатай хэрэгслийг худалдан авахад нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас нэг удаа санхүүгийн дэмжлэг үзүүлэх;
4. хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дунд мэргэжлийн ур чадварын тэмцээн зохион байгуулахыг дэмжих;
5. мэргэжлийн ур чадварын олон улсын тэмцээнд амжилттай оролцсон хөгжлийн бэрхшээлтэй хүнд урамшуулал олгох;
6. хөгжлийн бэрхшээлтэй хүнд мэргэжлийн чиг баримжаа, ур чадвар олгох чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа сургалтын байгууллагад төрөөс дэмжлэг үзүүлэх гэсэн хэлбэрүүдээр дэмжлэг үзүүлж байна.

2010 онд батлагдсан Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуульд аж ахуйн нэгж, байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажлаас халахыг хориглосон байсан. Энэ зохицуулалт шинэ хуулинд орж ирээгүй. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх зүйн байдлыг дордуулсан байна.

Хөдөлмөрийн тухай хууль нь 1999 онд батлагдсан. Хөдөлмөрийн гэрээгээр хөдөлмөр эрхэлж буй хүмүүсийн хөдөлмөрийн харилцааг зохицуулж буй гол хууль юм.

Энэхүү хуулиар хөгжлийн бэрхшээлтэй хүний ажлын цагийг долоо хоногийн 36 цаг хүртэл байхаар заасан бөгөөд ээлжийн амралтын хугацаа ажлын 20 өдөр байна.

Хөдөлмөрийн хуулийн 111 дүгээр зүйлд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүний хөдөлмөрийн харилцааг зохицуулсан. Үүнд 25 болон түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нь ажил, албан тушаалынхаа 4, түүнээс дээш хувийн орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулна. Хэрэв ажиллуулаагүй бол ажиллуулбал зохих орон тоо тутамд сар бүр төлбөр төлнө. Энэхүү төлбөрийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлж уг хөрөнгийг хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд зарцуулдаг. Хэрэв аж ахуйн нэгж, байгууллага тогтоосон төлбөрийг 24 сар тасралтгүй төлсөн тохиолдолд дараагийн 12 сард ногдох төлбөрийг чөлөөлөхөөр заасан.

Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлд заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй болон одой хүний хөдөлмөр эрхлэлтийн талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай тайлан, мэдээг аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллагад улирал тутам гаргана гэж заасан. 2017 оны байдлаар улсын хэмжээнд 25 ба түүнээс дээш ажилтантай 6479 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байгаагаас тэдгээрийн 43 хувь нь Хөдөлмөрийн хуулийн 111 дүгээр зүйлийг хэрэгжүүлж байна.

***Шуугтгээ:** ХБХ-ийг ажилд авч ажиллуулах квотын тогтолцоо үйлчилдэг. Үүнийг хэрэгжүүлэгч нь аймаг, дүүргийн Хөдөлмөрийн хэлтэс боловч хууль хэрэгжүүлээгүй аж ахуйн нэгжид хариуцлага тооцох үүрэг нь Мэргэжлийн хяналтын газар байдаг. Энэ нь хууль зөрчигчдөд хариуцлага тооцохгүй байгаа нэг шалтгаан болж байна.*

Үндэсний статистикийн хорооны 2017 оны мэдээгээр хөгжлийн бэрхшээлтэй хөдөлмөрийн насны **19974** хүн хөдөлмөр эрхэлж байна. Харин хөдөлмөр эрхэлж буй тэтгэврийн насны хүн **3018** байгаа юм. Хөдөлмөр эрхэлдэггүй хөгжлийн бэрхшээлтэй хүн **73285** байна. Хөдөлмөр эрхэлж буй иргэдийг хөдөлмөр эрхлэлтийн статусаар авч үзвэл:

- Хувиараа хөдөлмөр эрхлэгч-41.7 хувь
- Цалин хөлстэй ажиллагч-35.7 хувь
- Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч-20.1 хувь
- ажил олгогч-1.6 хувь
- Нөхөрлөл, хоршооны гишүүн-0.3 хувь байна.

2017 оны 10 дугаар сарын байдлаар Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газраас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн байдалд шалгалт хийжээ. Шалгалтанд 636 аж ахуйн нэгж, байгууллага хамрагдсан байна. Эдгээрээс 192 нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг зохих орон тоонд ажиллуулаагүй, ажлын байрны төлбөрийг төлөөгүй байна. Улсын байцаагчийн 116 акт үйлдэж 348 сая төгрөгийн нөхөн төлбөр тавьснаас 97 байгууллагад 277 сая төгрөгийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн санд төвлөрүүлсэн байна. Мөн 125 аж ахуйн нэгж, байгууллагад 25.4 сая төгрөгийн захиргааны хариуцлага ногдуулсан байна.

Оросын Холбооны улс

Хөдөлмөрийн тухай хуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эхийн хөдөлмөр

эрхлэлтийн баталгааг тогтоосон байна. Тодруулбал, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эх хүсвэл ажлын хагас цагаар ажиллана (93-р зүйл), шөнийн цагаар (96-р зүйл), эсхүл илүү цагаар, амралтын болон баярын өдрөөр ажиллахгүй байх, албан томилолтоор явуулахгүй байх (259-р зүйл), цалинтай болон цалингүй нэмэлт амралтын өдөр (262, 263-р зүйл) олгох, хөдөлмөрийн гэрээг цуцлах, ажлаас халахыг хориглосон (261) байна.

Тэтгэврийн тухай хуулийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ 8 нас хүртэл өсгөсөн эхийн тэтгэврийг 50 наснаас тогтоох (15 жил ажилласан тохиолдолд) ба хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд асарсан хугацааг ажилласан жилд тооцно (11, 92(б)-р зүйл)¹⁹⁴.

БНХАУ-д ажил хөдөлмөр эрхлэх эрхийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамгаалах хуулиар баталгаажуулдаг. Энэ хуульд¹⁹⁵: "Ажил эрхлэлт, сүй тавих, нийгмийн байдлыг тогтоох, дэмжих, техникийн эсвэл мэргэжлийн цолыг тодорхойлох, хөдөлмөрийн хөлсийг тогтоох, тэтгэмж ба нийгмийн даатгал эсвэл аливаа бусад талаар хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ялгаварлан үзэх ёсгүй" гэжээ.

Энэ ч үүднээс Засгийн газраас бүх улсын болон хувийн салбарын ажил олгогч нарт ажлын байрны 1,5%-аас багагүй орон тоог хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст гаргах ёстой гэсэн квотын системийг шаардах болжээ. Үүнийг орон нутгийн, мужийн захиргааны тусгай захирамж, журмын дагуу үндэслэсэн байдаг. Ингэснээр энэ квотын шаардлагыг биелүүлээгүй газрууд "Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ажил эрхлэлтийн хамгааллын сан-д төлбөр төлөх ёстой ба, үүгээрээ тэдгээр иргэдийн тусгай мэргэжлийн сургалт зэрэгт хандив тусламж үзүүлж байгаа хэрэг болдог байна. Энэ талын хяналт мониторингийн ажлыг татварын албад ба хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллагууд хийдэг.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль 2011 онд батлагдсан. Энэ хуулиар иргэнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, эрүүл мэндийн байдал, хөрөнгө чинээ, боловсрол, нийгмийн гарал, байдал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь үл ялгаварлаж, хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ адил тэгш, нээлттэй, ил тод байхаар заасан. Мөн ажил олоход хүндрэлтэй иргэдийн хөдөлмөрлөх тэгш эрх, адил боломжийг хангахаар заасан.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор төрөөс дараах арга хэмжээ хэрэгжүүлж байна. Үүнд:

- ажил олоход хүндрэлтэй иргэд хөдөлмөр эрхлэлтийн сургалтад хамрагдах хугацаанд нь хоол, унааны зардлын хөнгөлөлт үзүүлж, уг зардлыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлэх;
- хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 6 сараас дээш хугацаагаар ажилгүй байгаа иргэнийг ажилд авч, 12 сараас доошгүй хугацаагаар ажлын байраар хангасан ажил олгогчид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 12 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний урамшууллыг нэг удаа олгох;
- хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгэлтэй хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангаж, нийгмийн асуудлыг нь шийдвэрлэх талаар

¹⁹⁴ УИХТГ-ын Судалгаа, мэдээлэл, лавлагааны алба-Хүүхдийн эрх хамгааллын эрх зүйн орчин, тогтолцоо ба хэрэгжүүлэх механизмын талаарх гадаадын зарим орны туршлага, УБ, 2018 он

¹⁹⁵ [Law on the Protection of Persons with Disabilities -http://www.cdprf.org.cn/english/lawsdoc/content/2008-04/10/content_25056081.htm](http://www.cdprf.org.cn/english/lawsdoc/content/2008-04/10/content_25056081.htm)

тодорхой санаачилга гаргаж, үр дүнд хүрсэн ажил олгогчийг тусгай болзлын дагуу Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл шалгаруулж, урамшуулна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа нь хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа гэсэн 2 төрөлд хуваагддаг.

Шигтгээ: 15 ба түүнээс дээш насны ХБХ-ийн 19.9% нь хөдөлмөр эрхэлж байна. Хөдөлмөр эрхэлдэг иргэдийн 41.7% нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 35.7% нь цалинтай ажиллагч, 20.1% нь өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч байна. Дөнгөж 7032 хүн цалинтай ажиллагч байна.

Мөн энэ хуулиар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн асуудлыг зохицуулдаг.

ОХУ-ын “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын тухай”¹⁹⁶ хуулийн 20-24 дүгээр зүйлүүдэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн баталгааг хангах дараах арга хэмжээг хуульчилсан. Үүнд:

- 100-аас дээш ажилтантай байгууллагад ажилтны дундаж тоонд хувь тэнцүүлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг авч ажиллуулах квот тогтоох (2 хувиас доошгүй, 4 хувиас дээшгүй);
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд мэргэжлээрээ хөдөлмөрлөх боломжтой ажлын байрны нөөцийг бий болгох;
- Аж ахуйн нэгж, байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувийн онцлогт тохируулан зохион байгуулсан, нэмэлт тоног төхөөрөмж суурилуулсан тусгай ажлын байр бий болгох явдлыг дэмжих;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувийн нөхөн сэргээх хөтөлбөрийнх нь дагуу тэдний хөдөлмөрлөх нөхцөлийг бий болгох;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд аж ахуйн үйл ажиллагаа явуулах, эрхлэх нөхцөлийг бий болгох;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг шинэ мэргэжил эзэмших сургалтыг зохион байгуулах;
- Ажил олгогчид хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ажлын байртай холбоотой мэдээллийг зохих журмын дагуу өгөх зэрэг болно.

ХБНГУ-ын “Нийгэм, хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах тухай” хуулиар хөдөлмөр эрхэлдэг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалсан байна.

Тус хуулийн §5-12 SchwbG (Beschäftigungspflicht)¹⁹⁷ зүйлийн дагуу 16-аас доошгүй тооны ажилтантай нийтийн болон хувийн хэвшлийн байгууллагууд нийт ажлын байрны 6 хувьтай тэнцэх ажлын байранд хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллуулах үүрэгтэй болно. Хэрэв ажил олгогч хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хийх боломжтой ажлыг нь хийх боломж олгоогүй бол тэрээр тусгай сан болох Integrationsamt жилд 1200 евро төлөх ёстой.

Ажил олгогч нь 6 сараас дээш хугацаагаар ажилласан хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлаас халахдаа (§§ 15-22 SchwbG) Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нутгийн холбоо эсвэл Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ажил олгогчдын

¹⁹⁶ ФЗ “О социальной защите инвалидов в российской федерации.” www.docs.cntd.ru

¹⁹⁷ Schwerbehindertengesetz (SchwbG). <http://behinderung.org/gesetze/schwbg.htm>

зөвлөлдөх албаны зөвшөөрлийг заавал авсан байна. Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй иргэн нь ийм иргэдэд зориулсан тусгай газруудад ажил хөдөлмөр эрхлэх эрхтэйгээс гадна тусгай нөхөн сэргээх төвүүдэд (Berufförderungswerke) энгийн өөрт тохирсон мэргэжил эзэмших эрхтэй.

Түүнчлэн 50 хувиас доош түвшний хөгжлийн бэрхшээлтэй иргэн зохих газруудад хандан хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй нэгэн адил эрх эдлэн дээрх хуулийн заалтын дагуу хөдөлмөрлөх эрхээ хамгаалуулах боломжтой ажээ.

Мөн хувийн бизнесээ эрхэлж эхлэх (selbständiger Unternehmer) сонирхолтой хөгжлийн бэрхшээлтэй иргэн хөдөлмөрийн бирж ба интеграцийн товчоогоор дамжуулан санхүүгийн дэмжлэг хүртэх эрхтэй.

БНСУ-ын Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэх асуудлыг Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, мэргэжлийн чадварыг сэргээх тухай (Employment promotion and vocational rehabilitation)¹⁹⁸ хуулиар зохицуулдаг.

Хөдөлмөрийн яам ажилд зуучлах үйлчилгээг өргөжүүлэх, илүү хүртээмжтэй болгох үүднээс компьютерийн сүлжээ ажиллуулж байна. Ингэснээр хөгжлийн бэрхшээлтэй иргэний мэргэжлийн чадварыг сэргээх чиглэлээр ажилладаг байгууллагууд болон ажилд зуучлах байгууллагууд нь хоорондоо ажлын байрны талаарх, бусад төрлийн мэдээлэл солилцох боломжтой болжээ.

Бусад хүний нэгэн адил хөгжлийн бэрхшээлтэй иргэн ч өөрийн гэсэн тогтмол орлогогүйгээр, өөрөөр хэлбэл, ажиллаж хөдөлмөрлөхгүйгээр сайхан амьдрах боломжгүй юм. Иймд Хөдөлмөрийн яамнаас тэднийг тогтмол ажилтай байлгахад илүү анхаарлаа хандуулдаг. Энэ хүрээнд яамнаас зарим чухал арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна. Тухайлбал, 300-аас дээш ажилтантай компаний ажилчдын 2% нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн байх талаар шийдвэр гаргажээ¹⁹⁹. Компани үүнийг биелүүлэхгүй бол торгууль төлөх юм. Харин хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлаар хангасан компанид татварын хөнгөлөлт болон хөгжлийн бэрхшээлтэй иргэний цалин мөнгөнд тусламж үзүүлнэ.

Сөүл хотын засаг захиргаанаас хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор жил бүр шинээр бий болж буй төрийн албаны орон тооны 10%-д нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг авч ажиллуулахаар болсон байна²⁰⁰. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг тогтмол ажилтай болгож, тэдний тогтвортой амьжиргааг хангахад чухал хувь нэмэр оруулах юм.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль нь 2008 онд батлагдсан. Хуулийн 16 дугаар зүйлд хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлд тавигдах шаардлагыг зохицуулсан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрны нөхцөл нь хөдөлмөрлөх чадварт нь тохирсон байх бөгөөд түүнийг орж, гарахад нь саад болохооргүй байдлаар тоноглогдсон байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн төрийн захиргааны хяналтыг Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч хэрэгжүүлнэ. Улсын байцаагч нь хөгжлийн

¹⁹⁸ Employment promotion and vocational rehabilitation of disabled persons.

¹⁹⁹ http://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=17995&type=sogan&key=6

²⁰⁰ <http://mojseul.ru/obshhestvo/lyudi-s-ogranichennymi-vozmozhnostyami.html>

²⁰⁰ <http://mojseul.ru/obshhestvo/lyudi-s-ogranichennymi-vozmozhnostyami.html>

бэрхшээлтэй иргэнийг ажиллуулах ажлын байр нь стандартад нийцэж байгаа эсэхийг шалгах бүрэн эрхтэй.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль нь 2006 онд батлагдсан. Хуулийн 19 дүгээр зүйлд зааснаар хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажилладаг аж ахуйн нэгжид нийт ажиллагчдад хөгжлийн бэрхшээлтэй иргэний эзэлж байгаа хувь хэмжээгээр тооцон албан татварын хөнгөлөлт үзүүлнэ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс үүсгэн байгуулсан төрийн бус байгууллагыг дэмжих зорилгоор аж ахуйн нэгж, иргэнээс хандивласан нэг сая хүртэлх хэмжээний төгрөгийг ийнхүү хандивласан болох нь тогтоогдсон тохиолдолд тухайн татварын жилд уг аж ахуйн нэгжийн албан татвар ногдох орлогоос хасч тооцно.

Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль нь 2005 онд батлагдсан. Тус хуулиар захиалагч тендерийн үнэлгээ хийхдээ ажиллах хүчний 50 ба түүнээс дээш хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэн эзэлдэг, 25 ба түүнээс ажилтантай аж ахуйн нэгжид давуу эрх олгоно гэж хуулийн 10 дугаар зүйлд заасан.

ТАВ. ДЭД БҮТЭЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЛБАР

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд бие даан ажиллаж амьдрахад дэд бүтэц хамгийн чухал нөлөөтэй. Гэвч манай улсын ихэнх барилга байгууламж (олон нийтийн барилга байгууламж хамрагдаад), нийтийн тээврийн тогтолцоо болон мэдээ, мэдээллийн хүргэх хүртээмж хангалтгүй байна. Нийтийн тээврийн хэрэгслийн хүртээмж дутмаг байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүн ажил хайх, эсвэл эрүүл мэндийн тусламж дэмжлэг саадгүй авахад хүндрэл учруулж буй томоохон шалтгаан нь болдог.

Харааны болон хэл ярианы бэрхшээлтэй иргэдийн хувьд бага хэмжээний мэдээлэл тохирох форматаар байдаг тул тэдний мэдээ, мэдээлэл авах боломж хангалтгүй байна. Сонсголгүй хүмүүс дохионы хэлний орчуулга авахад үргэлж бэрхшээлтэй байдаг: 93 оронд хийсэн судалгаанаас харахад 31 оронд дохионы хэлний орчуулгын үйлчилгээ ерөөсөө байдаггүй, 30 оронд 20 ба түүнээс бага дохионы хэлний мэргэшсэн орчуулагчтай байдаг байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан дэд бүтэц бий болгох, мэдээлэл авах эрхийг хангах хүрээнд дараах хууль тогтоомжууд үйлчилж байна. Тухайлбал:

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль
2. Барилгын тухай хууль
3. Хот байгуулалтын тухай хууль
4. Автотээврийн тухай хууль
5. Автозамын тухай хууль
6. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль
7. Олон нийтийн радио, телевизийн тухай хууль
8. Харилцаа холбооны тухай хууль
9. Номын сангийн тухай хууль
10. Сонгуулийн тухай хууль
11. Түрээсийн орон сууцны хөтөлбөр

12. “Нийтийн тээвэр Замналын зогсоол. Ангилал. Техникийн шаардлага” MNS 5879-2012
13. “Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам. Техникийн шаардлага” MNS 5682:2006
14. “Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар” MNS 6056:2009
15. Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин. Үндсэн шаардлага” MNS 6055:2009
16. “Нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолын төлөвлөлт” БД 32-101-17
17. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих журам (ЗГ-ын 2017 оны 197 дугаар тогтоол)

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 3 дугаар бүлэгт хөгжлийн бэрхшээлтэй хүний ажиллаж амьдрах орчин нөхцөлийн талаар зохицуулсан. Хуулийн 6 дугаар зүйлд хөгжлийн бэрхшээлтэй хүний таатай, аюулгүй орчинд амьдрахад иргэн, хуулийн этгээд ялгаварлан гадуурхаж үл болно. Нийтийн тээврээр зорчих, дэд бүтэц, орон сууц, олон нийтийн барилга байгууламжид саадгүй хүрэх, нийтийн тээврийн хэрэгслээр чөлөөтэй зорчих нөхцөлийг бүрдүүлээгүй, хөгжлийн бэрхшээлтэй хүн мэдээлэл авах, бусадтай харилцахад шаардлагатай орчин нөхцөлийг бүрдүүлээгүй нь ялгаварлан гадуурхалт гэж заасан.

Орон сууц, олон нийтийн барилга байгууламж, зам талбай, нийтийн тээвэр, мэдээлэл, харилцаа холбооны технологи нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байлгах, тэдний хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох, шаардлагатай стандарт, удирдамжийн бичиг баримтыг боловсруулах зэрэг шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх ажлыг төрийн байгууллага хэрэгжүүлэх бөгөөд холбогдох зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ. Төрөөс хөгжлийн бэрхшээлтэй хүн дэд бүтэц, орон сууц, олон нийтийн барилга байгууламжид саадгүй хүрэх, тэдгээрийг чөлөөтэй ашиглах нөхцөлийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу иргэн, хуулийн этгээдтэй хамтран зохион байгуулахаар хуульчилсан.

Энэ хуульд орсон онцлог зохицуулалтын нэг бол Орон сууц, нийгмийн дэд бүтцийн байгууламжийг ашиглалтад оруулах барилгын комиссын бүрэлдэхүүний дөрөвний нэгд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулах болсон юм. Хэрэв энэхүү эрхийг хангаагүй барилга байгууламжийг улсын комисс хүлээж авахыг хориглосноор хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зорчих эрхийг хангах баталгаа болсон.

Харин хуулийн 10 дугаар зүйлд заасан нийтийн тээврийн байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй хүн нийтийн тээврийн хэрэгслээр чөлөөтэй зорчих нөхцөлийг бүрдүүлэх, тэдний хэрэгцээнд нийцсэн тээврийн хэрэгсэл, зогсоол, үйлчилгээний мөрдөх стандартыг батлуулахаар заасан. Гэвч бодит байдал дээр ямарч хэрэгжилт байхгүй байсаар байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийтийн тээврийн хэрэгслээр зорчих, буух, суух гэх мэт наад захын хэрэгцээ хангасан нэг ч автобус Улаанбаатар хотод байхгүй байна. Хуульд хориглосон хэм хэмжээ, гүйцэтгэх үүргээ биелүүлээгүй бол ямар хариуцлага хүлээлгэх талаар зохицуулалт байхгүй байна. Тиймээс хариуцлагын арга хэмжээ, хариуцлага тооцох эрх бүхий албан тушаалтныг нарийвчлан зохицуулж өгөх шаардлагатай.

Мэдээллийн хүртээмжтэй байдлыг хангах хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд “Мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ шаардлагад нийцүүлэх хүрээнд мэдээллээр үйлчилдэг хуулийн этгээд нь өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэх явцад хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээлэл авах эрхийг хангах, техник, технологийн хэрэгсэл, бусадтай харьцах боломж, нөхцөлийг бүрдүүлнэ гэж заасан. Энэхүү чиг үүргээ хэрэгжүүлэх чиглэлээр төрийн болон нийтийн үйлчилгээний байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүнд дохионы хэлний хэлмэрчтэй, текст унших боломжтой байдлаар нэвтрүүлэх арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэхээр заасан.

Сонсголын бэрхшээлтэй хүн цагдаа, эрүүл мэндийн байгууллага, онцгой байдлын албаны тусгай дугаарт текст мессеж, дохионы хэлний хэлмэрчийн зайн дүрс, ярианы тусламжтайгаар хандаж, үйлчилгээ авах боломжийг төрөөс бүрдүүлэхээр ажиллаж байгаагийн нэг нь тусгай дугаарт мессеж хүлээж авч эхэлсэн явдал юм.

Барилгын тухай хууль нь 2016 онд шинэчлэн батлагдсан. Энэ хуулиар барилгын үйл ажиллагаа эрхлэх, барилгын материал үйлдвэрлэх, барилгын ажил гүйцэтгэх, түүнд хяналт тавих, ашиглалтад оруулахтай холбогдсон харилцааг зохицуулж байна. Энэ хуулиар барилга байгууламж нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг зорчих, хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангасан байхаар төлөвлөгдөн баригдсан байх шаардлагыг тавих бөгөөд барилга байгууламжийн зураг төсөлд энэ талаар тусгаж барилгыг батлагдсан зураг төслийн дагуу барих ёстой. Энэ талаар нарийвчилсан норм, дүрэм, стандартыг батлан мөрдүүлнэ.

Баримт: Улаанбаатар хотын төвийн нэг дүүргийн зам дагуух хамгийн тохижилттой хэсгийн 26 байгууллага ХБХ-т хүрээмжтэй эсэхэд үнэлгээ хийхэд 50 хувь нь огт хүртээмжгүй, 27 хувь нь стандарт бус налуу замтай. 15 хувь нь налуу замтай ч дотроо олон шаттай. 8 хувь нь боломжийн налуу замтай боловч бие засах газаргүй байсан.

БНХАУ-Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хамгааллын хууль ба бусад холбогдох бодлогуудын шаардлагаар 2001 оны 6-р сард Барилгын яамнаас Хотын зам ба барилга байгууламжийн хэрэглээний тухай загварын дүрмийг (JGJ 50-2001) 1988 оны бичиг баримтад үндэслэн шинэчлэн баталжээ. Эдгээр дүрмийг бүх хотын зам, барьж байгуулсан орчин, нийтийн хэрэглээтэй холбогдох хэрэгслүүд, байр, албан өрөө, бизнес, үйлчилгээ, соёл, боловсрол, спортын арга хэмжээ, ажлын газрууд, шинээр баригдах болон засварлагдаж буй бүх барилгуудад баримтлах бөгөөд энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн таатай орчинг бүрдүүлж буй хэрэг юм. Энэ нь албан ёсны шаардлага болсон учир бүрэн хэрэгждэг.

Хот байгуулалтын тухай хууль нь 2008 онд шинэчлэн батлагдсан. Хуулийн 20 дугаар зүйлд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтэц байгуулах талаар зохицуулсан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн дэд бүтцийн байгууламжид саадгүй хүрэх нөхцөлийг хангах төлөвлөлтийг гүйцэтгэхдээ төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан норм ба дүрэм, журамд заасныг баримтлах бөгөөд энэхүү нөхцөлийг хангаагүй хот төлөвлөлт болон барилгажилтын шийдэл, зураг төсөл, инженерийн болон нийгмийн дэд бүтцийг барьж байгуулах аливаа төсөлд зөвшөөрөл олгохыг хориглоно.

Хэрэв хот байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хориглох журам зөрчсөн бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. Хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан норм, дүрэм, журам мөрдөөгүй хүнийг найман зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг найман мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгохоор Зөрчлийн тухай хуулийн 12.5-д заасан.

Автотээврийн тухай хууль нь 1999 онд батлагдсан. Энэ хуулиар аймаг, нийслэл Засаг дарга нь Нийтийн тээврийн хэрэгслээр зорчиж байгаа хараагүй хүнд зориулж буудлыг зарлах, сонсголын бэрхшээлтэй иргэнд зориулж буудал бүрд нэр, хаяг, чиглэлийг бичмэл болон зургийн хэлбэрээр байрлуулах, өөрчлөх шийдвэрийг гаргахаар заасан. Харин 20 ба түүнээс дээш нийтийн тээврийн хэрэгсэлтэй тээвэрлэгчийн тээврийн хэрэгслийн 10-аас доошгүй хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг тээвэрлэхэд зориулагдсан байх бөгөөд заасан хэмжээний тээврийн хэрэгсэлгүй бол Засгийн газраас тогтоосон хэмжээ, журмын дагуу жил бүр төлбөр төлнө. Төлбөрийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлэн, уг хөрөнгийг хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулах нийгмийн хамгааллын арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулахаар зохицуулсан.

Нийтийн тээврийн үйлчлэх тухай хуулийн заалт 2007 онд гарсан ч өнөөдрийг хүртэл ганц ч нийтийн тээврийн хэрэгсэл эдгээр иргэдийн зорчих боломжийг хангаагүй байна. Нийтийн тээврийн хэрэгслийн хүртээмжгүй байгаагаас сурах, хөдөлмөрлөх зэрэг хүний үндсэн эрхүүд зөрчигдөж байна.

Автозамын тухай хууль нь 2017 онд шинэчлэн батлагдсан. Энэ хуулиар хөгжлийн бэрхшээлтэй хүн зорчиход зориулсан зам нь замын байгууламжийн нэг хэсэг гэж заасан. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан тээврийн хэрэгслийг авто зам, замын байгууламж ашигласны төлбөрөөс чөлөөлөхөөр заасан.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль нь 2015 онд шинэчлэн батлагдсан. Замаар явган яваа хөгжлийн бэрхшээлтэй хүний тэргэнцэртэй, түүнчлэн тэрэг түрж яваа хүнийг явган зорчигчид оруулан заасан. Хөгжлийн бэрхшээлтэй ч замын хөдөлгөөнд оролцож байгаа явган хүн, тэргэнцэртэй хүн болон авто тээврийн хэрэгсэл жолоодож байгаа бүх хүн энэ хуулийн дагуу замын хөдөлгөөнд оролцох ёстой.

Олон нийтийн радио, телевизийн тухай хууль нь 2005 онд батлагдсан. Олон нийтийн радио, телевиз нь хөтөлбөртөө үндэстний цөөнх, эмэгтэйчүүд, хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн бүлэг, давхаргын болон олон нийтийн эрэлт хэрэгцээг тэнцвэртэй хангах бодлогыг баримталж ажиллах ёстой. Олон нийтийн радио, телевизийн хөтөлбөрийн талаар зөвлөх үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөл байгуулж болох бөгөөд уг зөвлөлийн бүрэлдэхүүнд сэтгүүл зүй, улс төр, эрх зүй, хэрэглэгчдийн эрх ашиг, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, боловсрол, соёл, шинжлэх ухаан, эрүүл мэнд, урлаг, шашин, байгаль орчин, спорт зэрэг чиглэлээр мэргэшсэн хүмүүсийг оруулна гэж хуулийн 8.5 дугаар зүйлд заасан.

Монголын Үндэсний Олон Нийтийн ТВ"-ийн “Цагийн хүрд” мэдээг эс тооцвол сонсголын бэрхшээлтэй хүмүүс мэдээлэл хүлээн авах боломж хаалттай хэвээр байна. Хараагүй болон хэвлэмэл материал ашиглах бэрхшээлтэй хүмүүсийн хувьд ч мэдээлэл авах боломж хязгаарлагдмал. Хараагүйчүүдийн Үндэсний Холбооны дэргэдэх ярьдаг номын цехийг эс тооцвол мэдээллийн орчинг ХБХ-т хүртээмжтэй болгох тухай ойлголт Монгол Улсад эхлээгүй байна.

НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооноос өгсөн зөвлөмж: Бүх хүүхдүүд, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, өөр хэлтэй үндэсний цөөнхийн хүүхдүүдийн хэрэгцээг анхаарсан хүүхдийн нийгэм, оюун санаа, ёс суртахуун, биеийн болон сэтгэцийн эрүүл мэндийг дэмжсэн контентийг хүүхдэд зориулсан телевизийн нэвтрүүлэг, ном зэрэг олон нийтийн мэдээллийн хэрэгслийн олон хэлбэрийг ашиглан хүргэх замаар хүүхдэд тохиромжтой хэрэгтэй мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авахыг мөн зөвлөж байна.

БНХАУ-Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамгаалах хуулиар²⁰¹ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн мэдээлэл ба харилцаа холбоог хэрэглэх боломжийг баталгаажуулсан байдаг. Үндэстний хэмжээний стандарт дохионы хэлийг хэдийнээ боловсруулсан бөгөөд Хятадын Брайл Хэвлэлийн газар ба бусад хэвлэн нийтлүүлэгчид Брайл үсэгтэй болон сонсдог ном, сэтгүүл хэвлүүлэх ажлыг хийж байна. Үүнд үндсэн хууль ба бусад хуулиудыг ийм хэлбэрээр хэвлүүлэх ажил ч орж байна.

Эдийн засгийн өндөр хөгжилтэй бүс нутгуудад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дунд тэдэнд зориулсан хэд хэдэн сониныг хэвлэн гаргаж түгээсэн. Тухайлбал, Бээжинд "Chinese Times" сониныг, Хятадын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гэдэг сар тутмын сэтгүүл зэрэг болно. Хууль ёсоор²⁰² хараагүй иргэдэд зориулсан унших материалыг улсын шуудангаар үнэ төлбөргүй хүргэх ёстой байдаг байна.

Номын сангийн тухай хууль нь 2014 онд батлагдсан. Энэ хууль нь номын сангийн төрөл, зохион байгуулалт, чиг үүргийг тодорхойлж, уншигчийн эрхийг хангах, номын сангийн үйл ажиллагааны эрх зүйн үндэсийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулна. Тус хуулийн 3 дугаар зүйлд “тусгай бүлгийн уншигч” гэж хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон номын санд биеэр ирж үйлчлүүлэх боломжгүй иргэнийг хэлнэ гэж заасан. Хэрэв тусгай бүлгийн уншигч нь номын санд биеэр ирж үйлчлүүлэх боломжгүй өндөр настай, өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэн гэрээр ном олгох үйлчилгээг авах боломжийг бүрдүүлж өгсөн байна.

Сонгуулийн тухай хууль нь 2015 онд батлагдсан. Сонгуулийн санал өгөх насны харааны бэрхшээлтэй сонгогч саналаа өгөхөд зориулсан саналын хуудсыг унших, саналаа тэмдэглэх тусгай зориулалтын брайль үсэг бүхий хавтас санал авах байр бүрд нэг байхаар хуулийн 87 дугаар зүйлд заасан. Санал авах байранд сонгогчдоос саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэх боломжийг хангасан, хэсэг дэх сонгогчдын тооноос хамааран хоёроос доошгүй тооны санал бэлтгэх бүхээг байх бөгөөд санал авах байр бүрд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан нэгээс доошгүй санал бэлтгэх бүхээгийг тусгайлан тоноглож бэлтгэсэн байна гэж тус тус заасан. Ээлжит сонгуулийн санал хураалтын дараах статистик мэдээнд хөгжлийн

²⁰¹ Article 37,38; [Law on the Protection of Persons with Disabilities](http://www.cdpc.org.cn/english/lawsdoc/content/2008-04/10/content_25056081.htm) http://www.cdpc.org.cn/english/lawsdoc/content/2008-04/10/content_25056081.htm

²⁰² Мөн тэнд

бэрхшээлтэй, түүний дотор харааны болон бусад төрлийн бэрхшээлтэй хэдэн иргэн санал өгсөн талаар мэдээлэл гаргадаггүй. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд сонгох, сонгогдох эрхээ эдэлж байгаад ямар ч хяналт байхгүй байна.

Түрээсийн орон сууцны хөтөлбөрийг 2015 онд Засгийн газрын тогтоолоор баталсан. Хөтөлбөрийг 2015-2021 онд хэрэгжүүлэх бөгөөд хөтөлбөрийн хүрээнд хотод 16.0, аймгуудын төвд 4000 айлын түрээсийн орон сууцны сан бүрдүүлэхээр зорилт тавин ажиллаж байна. Хөтөлбөрт зааснаар төрийн болон орон нутгийн өмчийн нэг айлын түрээсийн сууц нь барилгын норм, дүрмийн шаардлагыг хангасан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй орчинг бүрдүүлсэн, инженерийн иж бүрэн хангамжтай, зочны, унтлагын, гал тогоо, ариун цэврийн өрөө бүхий 70м² хүртэлх талбайтай сууц байна. Хувийн хэвшлийн нэг айлын түрээсийн орон сууцны хувьд талбайн дээд хязгаарыг тогтоохгүй бөгөөд талбайн доод хэмжээ 30 м²-аас багагүй байхаар заасан.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтэц, хүртээмжийг сайжруулах хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэж байна.

Нийслэлд шинээр барих болон өргөтгөл шинэчлэлт хийх авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулах ажлын даалгаварт “Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормал ”БД”31-10104-ийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам, замын байгууламжийг тусгаж, шинээр болон шинэчлэгдэн баригдаж байгаа авто зам, замын байгууламжийг тэргэнцэртэй хүнд зориулсан рампан зам, хараагүй хүмүүст зориулсан явган хүний замын хөтөч хавтантай хийгдэж эхэлсэн.

“Барилгын тухай” хуулийн 9.1.3-д барилга байгууламж нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний хэрэгцээг хангасан байх, 10.1.3-д барилгын зураг төсөл нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээг хангах арга хэмжээг тусгасан байхаар тус тус заасныг зураг төслийн экспертизээр дамжуулан хэрэгжүүлж байна.

“Амаржих газрын бүтэц, үйл ажиллагаа” MNS 6188:2010 стандартыг боловсруулж, Стандартчилал, хэмжил зүйн Үндэсний зөвлөлийн 2010 оны 46 тоот тогтоолоор баталж, улсын бүртгэлд бүртгэсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Уг стандартад хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд зориулж налуу зам, босгогүй өрөө, төрөхийн өмнөх өрөө, хонгил, ариун цэврийн өрөөний хана, цахилгаан шатанд зориулалтын бариул ханын дагуу байрлуулах гэх мэт дэд бүтцийг онцгойлон зааж өгсөн.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн их багтаамжийн 400 автобусны 300-д нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон ахмад настанд зориулсан тусгай суудал гаргаж, суудлын бүрээсийг өөр өнгөөр ялган, суудлын хажууд тэмдэглэл байрлуулсан. Мөн хараагүй хүмүүст зориулж буудлыг зарлах төхөөрөмжийг суурилуулан ашиглаж байна. Сонсголын бэрхшээлтэй иргэдэд зориулж буудал бүрт нэр, хаяг чиглэлийг бичмэл болон зургийн хэлбэрээр байрлуулах ажлыг хийж байна.

Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн ерөнхий тогтолцоонд “Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль / БД 31-101-04/ барилгын дүрэм, “Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин /MNS 6055:2009/ Монгол Улсын стандарт

хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС

*БНСУ-д Хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбоотой харилцааг дараах хууль болон журмын дагуу зохицуулж байна*²⁰³. Үүнд:

1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зөрчигдсэн эрхийг нөхөн сэргээх, ялгаварлан гадуурхалтыг хориглох тухай хууль (Act on the prohibition of discrimination against persons with disabilities, remedy against infringement of their rights, etc. (Act no. 8341, apr. 10, 2007)
2. Өндөр настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг орон сууцны дутагдалтай иргэдэд тусламж үзүүлэх тухай хууль (Act on the support for housing disadvantaged persons including persons with disabilities and the aged (Act no. 11370, feb. 22, 2012)
3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тусгай боловсролын тухай хууль (Act on special education for persons with disabilities, etc. (Act no. 8852, feb. 29, 2008))
4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тусгай боловсролын тухай хуулийг хэрэгжүүлэх журам Enforcement decree of the act on special education for persons with disabilities, etc. (Presidential decree no. 20790, may 26, 2008.)
5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл байх, эмнэлгийн туслалцаа авах эрхийг хангах тухай хууль (Act on guarantee of right to health and access to medical services for persons with disabilities)
6. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн халамжийн тухай хууль (Act on welfare of persons with disabilities act no. 8367, apr. 11, 2007.)
7. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн халамжийн тухай хуулийг хэрэгжүүлэх журам (Enforcement rule of the act on welfare of persons with disabilities Presidential Decree No. 20323, Oct. 15, 2007)
8. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах туслалцаа үзүүлэх тухай хууль (Act on guarantee of rights and support for persons with developmental disabilities (Act no. 12618, may 20, 2014.)
9. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд туслах үйлчилгээний тухай хууль (Act on activity assistant services for persons with disabilities (Act no. 10426, jan. 4, 2011.)
10. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн аж ахуйн үйл ажиллагааны тухай хууль (Act on the facilitation of entrepreneurial activities of persons with disabilities (Act no. 7632, jul. 29, 2005.)
11. Дээрх хуулийн Хэрэгжүүлэх журам (Enforcement decree of the act on the facilitation of entrepreneurial activities of persons with disabilities Presidential decree no. 19099, oct. 26, 2005.)

²⁰³ https://elaw.klri.re.kr/kor_service/lawTotalSearch.do

12. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, мэргэжлийн чиг баримжаа олгох тухай хууль (Act on the employment promotion and vocational rehabilitation of persons with disabilities Act no. 8491, may 25, 2007.)
13. Жирэмсэн болон өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд холбогдох хөнгөлөлт, давуу тал олгох тухай хууль (Act on guarantee of promotion of convenience of persons with disabilities, the aged, pregnant women, etc Act no. 5332, apr. 10, 1997.)
14. Өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд туслах хэрэгсэл, төхөөрөмжийн тухай хууль (Act on the support for assistive devices for persons with disabilities, older persons, etc. And promotion of use thereof act no. (13662, dec. 29, 2015)
15. Тус хуулийг хэрэгжүүлэх журам Enforcement decree of the act on the support for assistive devices for persons with disabilities, older persons, etc. And promotion of use thereof (Presidential decree no. 27665, dec. 5, 2016.)
16. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн халамжийн тухай хууль (Act on welfare support for children with disabilities Act No. 11009, Aug. 4, 2011)

Солонгос улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэний боловсрол, төрөөс үзүүлэх тусламж дэмжлэг, хөнгөлөлт болон бусад асуудлыг ерөнхийд нь *Хөгжлийн бэрхшээлтэй иргэний халамжийн тухай хуулиар (Act on Welfare of persons with disabilities)*²⁰⁴ зохицуулж байна.

Энэ хуулийн зорилт нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд халамж үйлчилгээ үзүүлэх, тэдний нийгмийн оролцоог урамшуулан дэмжих замаар нийгэмд бусдын адил амьдрах нөхцөл бололцоогоор хангах, хөгжлийн бэрхшээлтэй иргэний ая тухтай амьдрах нөхцөл болон түүний эрхийг хангах талаар төр, орон нутгийн засаг захиргааны үүрэг хариуцлагыг тодорхой болгох, зөвхөн мөнгө өгөх биш, эмнэлгийн үйчилгээ, нөхөн сэргээх эмчилгээ, боловсрол, ажил эрхлэх, амьдралын нөхцөлөө дээшлүүлэх зэрэг тэдний хэрэгцээ шаардлагыг тодорхойлж бие даан амьдрах бололцоо болон амьжиргааны тогтвортой байдлыг дэмжихэд оршино.

Хуульд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгмийн халамжийн үндсэн зарчмыг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгмийн бүрэн оролцоо тэгш байдлыг хангах замаар нийгмийн нэгтгэлийг бий болгох явдал гэж тодорхойлсон байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд нь нэр төр, хувь хүний хувьд адил хүндлэгдэж харьцаж, улс төр нийгмийн бүхий л эрхийг эдэлж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбогдох бодлого боловсруулах асуудлаар тэргүүн зэргийн эрхтэй байна гэж заасан байна. Хуулийн 5-р зүйлд тус бодлого тодорхойлох, боловсруулахад хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдний эцэг эх асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн санал бодлыг заавал цуглуулахыг Засгийн газар орон нутгийн удирдлагад даалгасан байна. Мөн Засгийн газар, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдгээрийн харгалзан дэмжигч нарыг дэмжих, олон нийтэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ойлгож танихад чиглэсэн бодлого боловсруулах үүрэгтэйг заажээ.

Иргэд олон нийтийн зүгээс хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүндэтгэлтэй хандах,

²⁰⁴ Act on Welfare of persons with disabilities. http://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=21516&type=sogan&key=10

тэдний нийгмийн халамжийг сайжруулахад хамтран ажиллах тэднийг эрт илрүүлэх, хөгжлийн бэрхшээлээс урьдчилан сэргийлэх талаар чармайх шаардлагатай гэж заажээ. 11-р зүйлд Эрүүл мэнд нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн яам нь холбогдох төрийн захиргааны байгууллагуудтай хамтран хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан бодлогын хөтөлбөрийн 5 жил тутамд гаргаж байх, тус хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн халамж, боловсрол соёл, эдийн засгийн үйл ажиллагаа, нийгмийн үйл ажиллагаанд оролцох оролцоо болон тус иргэдийн эрх, ашиг сонирхол, нийгмийн халамжийг дээшлүүлэхтэй холбогдсон асуудлуудыг тусгахаар зааж өгсөн байна.

Холбогдох төрийн захиргааны байгууллагууд нь жил тутам үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж, төлөвлөгөө болон төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар жил бүр яаманд тайлагнаж байх үүрэгтэй. Эрүүл мэнд нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн яам нь хөтөлбөр төлөвлөгөө түүний хэрэгжилтийн талаар жил бүр Парламентын холбогдох байнгын хороонд тайлагнах үүрэгтэй байна.

Ерөнхий сайдын харьяанд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх олон талт бодлого боловсруулах, түүний хэрэгжилтийг үнэлэх, хяналт тавих чиг үүрэгтэй Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бодлого зохицуулах хороо ажилладаг байна.

Хороо нь дараах асуудлыг хариуцан ажиллана.

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн халамжийн үндсэн чиглэлийг тодорхойлох
- Холбогдох байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулах, нийгмийн халамжид чиглэсэн төсвийн тусламж дэмжлэгтэй холбогдох асуудлууд
- Тусгай боловсролын бодлогыг зохицуулах асуудал
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжихтэй холбогдох асуудал
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бодлого хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө босгох
- Холбогдох яам аентлагийн хамтын ажиллагаатай холбогдох асуудал
- Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоосон бусад асуудал

Орон нутгийн засаг захиргаанд хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй асуудал төлөвлөх, хэрэгжүүлэх, шалгах үйл ажиллагааг эрхлэх орон нутгийн хороо ажиллана. Түүний үйл ажиллагаа зохион байгуулалттай холбогдох асуудлыг Ерөнхийлөгчөөс баталсан журамд нийцүүлэн орон нутгийн захиргаанаас тогтооно.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх ойлголтыг олон нийтэд ойлгуулах, тэдэнд туслах хүсэл зоригийг бий болгох зорилгоор жил бүрийн 4 сарын 20-ны өдрийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өдөр гэж нэрлэн, тус өдрөөс эхлэх 7 хоногийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 7 хоног гэж төрийн холбогдох байгууллагууд холбогдох олон нийтийн үйл ажиллагааг зохион байгуулна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн халамжийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд Засгийн газар болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өдөр тутмын амьдралд тохиромжтой орон сууцны болон холбогдох хэрэгслээр хангах талаар бодлого боловсруулж, түүнийг хөгжүүлэх үүрэгтэй гэж заасан байна. Тус хуулийн 16 дугаар зүйлд мөн засгийн газар нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эдийн засгийн бие

даасан байдлыг дэмжих, эдийн засгийн дарамтыг багасгах үүднээс холбогдох татварын хөнгөлөлт, олон нийтийн үйлчилгээний газруудад хөнгөлөлт үзүүлэх зэрэг бодлогын арга хэмжээг хэрэгжүүлнэ. Мөн 17 дугаар зүйлд дээрх байгууллагууд нь тус хуулийн зорилтыг хангах үүднээс хууль зүйн болон санхүүгийн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Тус байгууллагууд нь Ерөнхийлөгчөөс баталсан тусгай нөхцөлийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсрол, ажил эрхлэлт, бизнес эрхлэх, сургалтанд хамрагдах зэрэг үйл ажиллагааг дэмжих чиглэлээр зээлийн сан байгуулж болохоор заасан байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний сурах, бүх шатны боловсрол эзэмшихэд төрөөс үзүүлэх дэмжлэг, хөнгөлөлт

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний боловсролын асуудлыг *Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусгай боловсролын тухай хууль (Act on Special education for disabled person)*²⁰⁵ болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулдаг.

Хуулийн зорилт төр, орон нутгийн засаг захиргаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөгжлийн бэрхшээлийн төрөл, зэрэгт нь тохирсон тусгай боловсролоор хангах, сурч боловсрох орчин бүрдүүлэх зэргээр тэдний нийгмийн оролцоог хангах, авьяас чадвар, чадавхийг хөгжүүлэн дэмжихэд оршино.

Төр, орон нутгийн засаг захиргаа дараах үүрэгтэй. Үүнд:

- Төр, орон нутгийн засаг захиргаа нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний нас, боломж бололцоо, хөгжлийн бэрхшээлийн төрөл, зэрэгт нь тохирсон үр ашигтай боловсрол олгох ба түүний агуулга, арга хэлбэрийг хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн оролцоонд тохируулан сайжруулахад шаардлагатай арга хэмжээг авна.
- Төр, орон нутгийн засаг захиргаа нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний боловсролын талаарх судалгаа шинжилгээний ажлыг урамшуулан дэмжинэ.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нөхцөл байдал, онцлогт тохирсон мэргэжил олгох сургалтын системийг боловсруулна.

Боловсролын байгууллагын үүрэг:

- Аль ч шатны сургуулийн удирдлага хөгжлийн бэрхшээлтэй иргэний суралцах хүсэл, хэрэгцээг хүндэтгэн үзэх ба зүй зохисгүй хандаж болохгүй. Тухайлбал, сургуульд суралцах хүсэлт гаргах, эсвэл элсэлтийн шалгалтыг амжилттай өгч элсэх хүсэлт гаргахад хөгжлийн бэрхшээлтэй гэх шалтгаанаар татгалзаж болохгүй.
- Бүх боловсролын байгууллага хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг сургуульд элсэн орох болон суралцахад хөгжлийн бэрхшээлийн төрөл, зэрэгт нь тохирсон тав тухтай, тусгай нөхцөлөөр хангах ба бусад шаардлагатай арга хэмжээг авна.

Хуулинд тодорхойлсноор тусгай боловсрол гэдэг нь тусгай боловсрол авах эрх бүхий хүмүүст зориулсан ба тэдний онцлогт тохирсон боловсролоор хангах “*тусгай боловсролд хамаарах үйлчилгээ*” (*special education-related services*) юм.

“*Тусгай боловсролд хамаарах үйлчилгээ*” гэж хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг сурч боловсроход чухал шаардлагатай, хүний оролцоотой дэмжлэг туслалцаа болон

²⁰⁵ Act on special education for the disabled persons. http://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=24893&type=sogan&key=2

материаллаг тусламжийг хэлнэ. Үүнд:

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, түүний гэр бүлд боловсролтой холбоотой болон бусад зөвлөгөө өгөх;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эмчилгээнд (физик) дэмжлэг тусалцаа үзүүлэх;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд боловсрол эзэмшихэд нь туслах тусгай бэлтгэгдсэн хүнээр хангах;
- Бүх шатны сургууль нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг сурч боловсроход тохиромжтой сургалтын орчин, тусгай хэрэгсэл, зориулалтын техник, төхөөрөмжөөр хангах;
- Бүх шатны сургууль хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг автобус унаагаар хангах, сургуулийн төлбөр зардлыг хариуцах, суралцахад тав тухтай орчин бүрдүүлэх гэх мэт суралцахад шаардлагатай нөхцөлөөр хангах;
- Сургуулийн дэргэд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан дотуур байртай байх;
- Интернет болон бусад хэлбэрээр мэдээлэл авах боломжоор хангах зэрэг үйлчилгээнүүд багтана.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэн:

- Ердийн сургуульд ердийн боловсрол эзэмших;
- Ердийн сургуульд тусгай боловсрол эзэмших;
- Тусгай сургуульд, эсвэл тусгай боловсролын төвд боловсрол эзэмших боломжтой.

Түүнээс гадна боловсрол олгох дараах 3 хэлбэр байдаг. Үүнд:

1. Integrated education: Хөгжлийн бэрхшээлийн төрөл, зэргээс үл хамааран нас чацуу хүмүүсийг нэгтгэн ердийн сургуулийн зарчмаар боловсрол олгоно.

Сургуулийн удирдлага нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг сурч боловсрох нөхцөлөөр хангах цогц төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ. Үүнд тусгай сургалтын хөтөлбөр зохиох, хүний тусалцаагаар хангах, тусгай хэрэгсэл, зориулалтын техник төхөөрөмжөөр хангах, тусгай багш бэлтгэх зэрэг асуудлыг хамруулна. Түүнчлэн, тусгай анги нээж хуулинд заасан стандартын дагуу тоноглож тохижуулна.

2. Individualized education: Тухайн хүний нөхцөл байдал, онцлогт нь тохирсон зорилго, хөтөлбөр, арга барил, тусгай боловсролд хамаарах үйлчилгээ бүхий тусгай хөтөлбөрийг боловсролын бүх шатанд боловсруулж хэрэгжүүлнэ.

Бүх шатны сургууль нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнд боловсрол олгохын тулд тусгай баг зохион байгуулах ба үүнд хөгжлийн бэрхшээлтэй иргэний асран хамгаалагч, багш, тусгай боловсролын багш, ирээдүйн ажил мэргэжил буюу ажил хөдөлмөр эрхлэхэд бэлтгэх багш, “тусгай боловсролд хамаарах үйлчилгээ”-ний хүрээнд бэлтгэгдсэн хүн хамрагдана. Тусгай баг нь семестер тутамд шинэ хичээлийн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлдэг. Суралцагч өөр сургууль руу шилжих, эсвэл анги дэвших, дээд шатны сургуульд ороход хичээлийн хөтөлбөрийг дамжуулж өгнө.

3. Itinerant education: “Тусгай боловсролд хамаарах үйлчилгээ”-ний хүрээнд бэлтгэгдсэн хүн, эсвэл тусгай боловсролын багш бүх шатны сургуульд, эрүүл мэндийн байгууллагад, гэрт нь очиж боловсролын үйлчилгээ үзүүлнэ.

Энэ тохиолдолд тусгай боловсролын төвүүд болон сургуулиудад тусгай багш, эсвэл “тусгай боловсролд хамаарах үйлчилгээ”-ний хүрээнд бэлтгэгдсэн хүнийг ажиллуулна. Хэрэв хөгжлийн бэрхшээлээс шалтгаалан тодорхой хугацаанд сургуульд явах боломжгүй бол энэхүү хэлбэрээр боловсрол эзэмших боломжтой. Мөн хөгжлийн бэрхшээлийн улмаас хөдлөх боломжгүй, эмнэлэг, асрамжийн газар болон гэртээ байдаг бол тусгай боловсролын багш, эсвэл тусгай бэлтгэгдсэн хүн очиж боловсролын үйлчилгээ үзүүлэх юм.

Ажил хөдөлмөр эрхлэх бэлтгэл сургалт (Education for future career and vocation). Холбогдох агентлагууд хамтран ажиллах замаар хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг боловсрол эзэмшсэний дараа нийгэмд ажил хөдөлмөр эрхлэхэд бэлтгэлтэй болгох, биеэ даан амьдрахад сургах юм.

Ахлах-дунд сургууль болон дээд шатны сургуулиуд хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ирээдүйд ажил хөдөлмөр эрхлэх бэлтгэл сургалтыг зохион байгуулдаг. Сургуулийн зүгээс стандартын дагуу сургалтын орчин бүрдүүлж, бусад шаардлагатай зүйлсээр хангах үүрэгтэй. Энэ сургалтын хүрээнд мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн боловсрол олгох болон ажлаар хангана. Түүнээс гадна, өдөр тутмын амьдрал болон нийгэмд дасан зохицож бие даан амьдрах чадварыг эзэмшүүлэх юм.

Тусгай боловсролын байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажил хөдөлмөр эрхлэхэд бэлтгэх зорилготой мэргэших тэнхим байгуулж, 1 ба түүнээс дээш жилийн сургалт явуулна. Тусгай сургалтын төвүүд хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг энэхүү сургалтаар хангахын тулд холбогдох агентлагуудтай хамтарч ажилладаг.

Тусгай боловсролын сургууль болон бусад бүх шатны сургууль нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний боловсролд зориулж тусгай ангиудыг нээж ажиллуулна. Үүнд:

- **Цэцэрлэгийн анги.** Хэрэв тусгай боловсрол эзэмших суралцагчийн тоо 1-4 байвал 1 анги, 4-өөс их бол 2 болон түүнээс олон ангитай байна.
- **Бага анги болон бага дунд анги.** Суралцагчийн тоо 1-6 бол 1 анги, 6-аас их бол 2 болон түүнээс их анги байгуулна.
- **Ахлах дунд анги.** Суралцагчийн тоо 1-7 бол 1 анги, 7-оос их бол 2 болон түүнээс олон ангитай байна.

Цэцэрлэг, бага сургууль, бага дунд сургууль, ахлах дунд сургуулийн боловсрол нь заавал эзэмших боловсролд тооцогддог бөгөөд үүнийг 3-17 настай хөгжлийн бэрхшээлтэй иргэд ч эзэмших боломжтой. Аль ч шатны сургууль, түүний удирдлага хөгжлийн бэрхшээлтэй иргэний суралцах хүсэлтийг хүлээн авахаас, элсэлтийн шалгалтад оруулахаас, шалтгалтаа амжилттай өгсөн иргэнийг суралцуулахаас татгалзах зэргээр ялгаварлан гадуурхаж, түүний суралцах боломжийг хааж болохгүй.

Өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд туслах хэрэгсэл, төхөөрөмжийн тухай хуулийг 2015 онд баталсан.

Туслах хэрэгсэл, төхөөрөмж гэдэгт Эрүүл мэнд нийгмийн халамжийн сайдын тушаалаар батлагдсан өдөр тутмын хөдөлгөөн үйлдэл хийхэд туслах, сэтгэцийн болон биеийн үйл ажиллагааг хангах, сайжруулахад чиглэгдсэн бүх төрлийн багаж хэрэглэл тоног төхөөрөмж, машиныг хамруулахаар хуульд заасан. Төр болон орон нутгийн захиргаа нь өөрийн төсвийн хэмжээнд дараах чиглэлийн төслүүд хэрэгжүүлж

болохоор заасан байна.

- Төнөг төхөөрөмж түрээслүүлэх, тараах хуваарилах зэрэг Кэйс менежментийн үйлчилгээ;
- Туслах хэрэгсэл төхөөрөмжийн талаарх мэдээллээр хангах;
- Туслах хэрэгсэл төхөөрөмжийг сайжруулах, судалгаа шинжилгээ хийх, чанарын хяналт шалгалт гүйцэтгэх зэрэгт туслах.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнээс туслах хэрэгсэл, төхөөрөмж олгох талаар хүсэлт гаргавал төр, орон нутгийн байгууллага нь өөрийн төсвийн хүрээнд шаардлагатай хэрэгсэл, төхөөрөмжөөр хангах, эсхүл туслах хэрэгсэл, төхөөрөмж хэрэгцээгүй ашиглах боломжгүй болсон бол гарсан зардлыг нөхөн төлнө. Төрөөс туслах хэрэгсэл төхөөрөмжийн чанарыг шалгах, түүнийг сайжруулах, аюулгүй байдлын баталгаа гаргах зэрэг үйл ажиллагааг явуулж болно.

Хуулиар туслах хэрэгсэл үйлдвэрлэгч компанид үйлдвэрлэж буй бүтээгдэхүүн нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн аюулгүй байдлыг нэн тэргүүнд хангах, бүтээгдэхүүнийг ашиглах, засвар үйлчилгээ баталгааны мэдээллээр заавал хангаж байх үүргийг хүлээлгэсэн. Мөн хуулиар Эрүүл мэнд нийгмийн халамжийн яам нь туслах хэрэгсэл, төхөөрөмжийн төвийг байгуулан, үйл ажиллагааг явуулахаар заасан. Тус төв нь туслах хэрэгсэл, төхөөрөмжийн судалгаа хийх, хөгжүүлэх төсөл хэрэгжүүлэх, мэдээлэл цуглуулах, мэдээллээр хангах, бүсийн туслах хэрэгсэл төхөөрөмжийн төвүүдийн үйл ажиллагаа удирдлагын үйл ажиллагаанд туслах, хэрэглэгч болон бодит хэрэглээний байдалд дүн шинжилгээ хийх, олон улсын хамтын ажиллагааны чиглэлээрх төслийг гүйцэтгэнэ.

Эрүүл мэнд нийгмийн халамжийн яамнаас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн туслах хэрэгсэл, төхөөрөмж үйлдвэрлэх, засвар үйлчилгээ явуулах, зөвлөх, сургалт явуулах, мэдээллээр хангах чиглэлийн зөвшөөрлийг олгоно.

Төрөөс туслах хэрэгсэл төхөөрөмж үйлдвэрлэгчдийг бодлогын хүрээнд холбогдох шагнал, үйлдвэрлэлийн урамшуулал олгох, техник технологийн туслалцаа үзүүлэх зэрэг арга хэмжээг авч болно гэж заасан.

Хөдөлмөр эрхлэлт

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэх асуудлыг *Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, мэргэжлийн чадварыг сэргээх тухай (Employment promotion and vocational rehabilitation)*²⁰⁶ хуулиар зохицуулдаг.

Төр, орон нутгийн засаг захиргаа нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний боловсрол эзэмших, хөдөлмөр эрхлэх, энэ талаар олон нийтэд сурталчлан таниулах болон түүнтэй холбоотой үйл ажиллагааг байнга дэмжиж ажилладаг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор бизнес эрхлэгчид болон олон нийтэд илүү сайн ойлголт өгөх талаар түлхүү анхаардаг байна. Ялангуяа, хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй хүнийг илүү анхаарч үздэг.

Төр, орон нутгийн захиргаа нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр

²⁰⁶ Employment promotion and vocational rehabilitation of disabled persons.
http://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=17995&type=sogan&key=6

эрхлэлтийг дэмжих зорилгоор бизнес эрхлэгчид, хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон тэдний хөдөлмөр эрхлэлтэд санаа тавьж буй байгууллага, хүний үйл ажиллагааг урамшуулан дэмждэг.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд зарцуулагдах зардлын зарим хэсгийг төрөөс санхүүжүүлдэг.

Төр, орон нутгийн засаг захиргааны үүрэг:

- Төр, орон нутгийн засаг захиргаа нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажилд зуучилж хөдөлмөр эрхлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- Төр, орон нутгийн засаг захиргаа нь мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэжлийн чадварыг хөгжүүлэх, ажил мэргэжилд дасан зохицох сургалт зохион байгуулах, ажилд сургаж авах зэргээр хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг авьяас чадвар, чадавхид тохирсон ажилтай болгоход шаардлагатай арга хэмжээг авна.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тохиромжтой мэргэжлийн төрөл болон бусад хөдөлмөр эрхлэлттэй холбоотой судалгаа шинжилгээний ажлыг урамшуулан дэмжинэ.

Бизнес эрхлэгчдийн үүрэг:

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд хамтарч ажиллах бөгөөд тэдний авьяас чадвар, чадавхид тохирсон ажлаар хангах болон ажил эрхлэх талаар зохих бодлогыг хэрэгжүүлнэ.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажил хөдөлмөр эрхлэхэд ялгаварлан гадуурхаж болохгүй.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг мэдлэг, мэргэжлээ дээшлүүлэх боломжоор хангах, ажлын байрандаа тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, өргөжүүлэхэд анхаарч ажиллах үүрэгтэй. Үүнд хөдөлмөрийн яамнаас бизнес эрхлэгчид дэмжлэг туслалцаа үзүүлдэг.
- Хөдөлмөрийн яам нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийн талаарх үндсэн төлөвлөгөөг боловсруулах бөгөөд үүнд дараах асуудлыг тусгана:
- хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, мэргэжлийн чадварыг сэргээх;
- хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн талаар;
- хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бусад үйл ажиллагааг оруулна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжихийн тулд төр, орон нутгийн засаг захиргаа болон холбогдох яамдууд дараах дэмжлэг туслалцаа, хөнгөлөлтүүдийг үзүүлдэг.

Мэргэжлийн чиг баримжаа олгох (Vocational Guidance)

Хөдөлмөрийн яам болон Эрүүл мэнд, нийгэм хамгааллын яамнаас хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлог, хэрэгцээ, чадавхид тохирсон ажлаар хангахын тулд мэргэжлийн талаар зөвлөгөө өгөх, мөн тэдний мэргэжлийн чадварыг тодорхойлох, ажлын байранд дасан зохицох чадварыг (workplace skill) үнэлэх, хөдөлмөр эрхлэлтийн талаарх мэдээллээр хангах зэргээр мэргэжлийн чиг баримжаа олгодог. Шаардлагатай тохиолдолд энэхүү үйлчилгээг үзүүлдэг мэргэжлийн байгууллагад хандах бөгөөд

холбогдох зардлыг яамнаас гаргана. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэн эрхлэхэд тохиромжтой ажлын байр болон ажлын төрлийг хөгжүүлэхэд анхаарч ажилладаг. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэнд мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагаа эрхлэх гэж буй, эрхлэж буй байгууллага болон хүнд зээл, мөнгөн тусламж олгох замаар дэмжлэг үзүүлнэ.

Мэргэжлийн сургалтаар хангах (Vocational Adjustment Training)

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих асуудлаар Хөдөлмөрийн яам нь Эрүүл мэнд, нийгэм хамгааллын яамтай хамтран ажилладаг ба хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүсэл эрмэлзэл, авьяас чадвар, чадавхид тохирсон мэргэжлийн сургалтаар хангах хөтөлбөр хэрэгжүүлдэг.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа явуулж буй этгээдэд түүний энэхүү үйл ажиллагаанд зориулж зээл, мөнгөн тэтгэмж олгох зэргээр урамшуулан дэмждэг байна. Түүнчлэн, хөтөлбөр болон сургалтанд хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэнд мөн зээл, сургалтын тэтгэмж олгох замаар дэмжлэг тусламжаа үзүүлдэг.

Ажлын байранд дасан зохицох чадварыг хөгжүүлэх (Workplace Skill Development Training)

Хөдөлмөрийн яам хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүсэл эрмэлзэл, авьяас чадвар, чадавхид тохирсон ажлын байранд дасан зохицох чадварыг хөгжүүлэх хөтөлбөр гаргана. Энэ хөтөлбөрийг хэрэгжүүлж буй байгууллага, хүнд мөн үүнд хамрагдан суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зээл, мөнгөн тэтгэмж, сургалтын тэтгэмж олгох зэргээр дэмжлэг үзүүлнэ.

Ажил үүргээ биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх (Supportive Employment)

Хөдөлмөрийн яам болон Эрүүл мэнд, нийгэм хамгааллын яамнаас хөгжлийн бэрхшээл нь илүү хүнд бөгөөд үүний улмаас ажил үүргээ биелүүлэхэд бэрхшээл үүсч буй хүмүүст зориулан тусгай хөтөлбөр хэрэгжүүлдэг. Өөрөөр хэлбэл, ажил үүргээ хүндрэлгүй, амар хялбар гүйцэтгэхэд шаардлагатай тусламжаар хангах юм.

Protective employment

Төр, орон нутгийн захиргаа нь ердийн ажлын орчинд ажиллах боломжгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг тусгай ажлын орчноор хангах хөтөлбөр хэрэгжүүлнэ.

Ажилд зуучлах үйлчилгээ (Job Placement Services, etc.)

Хөдөлмөрийн яам нь ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл болон хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүсэл эрмэлзэл, авьяас чадвар, чадавхийг харгалзан тохиромжтой ажлаар хангах бодлого баримталдаг. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг өөрөө бие даан ажил хөдөлмөр эрхлэхэд тусалж дэмжих бөгөөд шаардлагатай арга хэмжээнүүдийг авдаг. Шаардлагатай үед энэ төрлийн арга хэмжээг зохион байгуулдаг мэргэжлийн байгууллагуудад хандах ба зардлыг яам хариуцна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажилд зуучлах үйл ажиллагаа явуулж буй байгууллага, хүнд зээл болон мөнгөн тусламж олгох зэргээр урамшуулан дэмждэг.

Хөдөлмөрийн яам ажилд зуучлах үйлчилгээг өргөжүүлэх, илүү хүртээмжтэй болгох үүднээс компьютерийн сүлжээ ажиллуулж байна. Ингэснээр хөгжлийн бэрхшээлтэй иргэний мэргэжлийн чадварыг сэргээх чиглэлээр ажилладаг

байгууллагууд болон ажилд зуучлах байгууллагууд нь хоорондоо ажлын байрны талаарх, бусад төрлийн мэдээлэл солилцох боломжтой болжээ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хувиараа хөдөлмөр эрхлэхэд дэмжиж туслах (Support for Self-Employed Disabled Persons)

Хөдөлмөрийн яам нь бизнес эрхлэхээр төлөвлөж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг дэмжиж зээл олгох, бизнес явуулах байрыг хөнгөлөлттэй нөхцөлөөр түрээслэх зэргээр дэмжлэг үзүүлдэг.

Хөгжлийн бэрхшээлтэй ажилтанд олгох дэмжлэг тусламж (support for disabled workers)

Хөдөлмөрийн яам хөгжлийн бэрхшээлтэй ажилтанд тогтвортой ажиллахад нь шаардлагатай тохиолдолд зээл олгодог.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын удирдамжаар хангах (Adjustment guidance after employment)

Хөдөлмөрийн яам болон Эрүүл мэнд, нийгэм хамгааллын яамнаас хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах үүднээс хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын орчинд хэрхэн ажиллах удирдамжаар хангана.

Бизнес эрхлэгчид зориулсан удирдамж (Employment Guidance for Business Proprietors)

Хөдөлмөрийн яам хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулдаг болон ажиллуулахаар төлөвлөж буй бизнес эрхлэгчийг шаардлагатай удирдамжаар хангана. Үүнд хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажил эрхлэлт, түүнд үзүүлэх тусламж дэмжлэг, түүний ажиллах орчин, тоног төхөөрөмж болон бусад асуудлыг оруулна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг түүний онцлогт тохирсон ажиллах орчноор хангах (Support for Standard Workplaces for Disabled Persons)

Хөдөлмөрийн яам нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний стандартад тохирсон ажлын орчин бүрдүүлсэн болон уг орчныг бүрдүүлэхэд хувь нэмэр оруулсан бизнес эрхлэгчид зээл болон мөнгөн тусламж олгох зэргээр дэмжлэг үзүүлнэ. Ялангуяа, энэхүү орчныг хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй хүнд зориулсан бол зээл, мөнгөн тусламж үзүүлэхэд илүү давуу эрх олгоно.

Солонгосын Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих агентлаг

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилготой *Солонгосын Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих агентлаг (Korea employment agency for the disabled)* ажилладаг. Агентлаг нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлттэй холбоотой мэдээлэл цуглуулж судалгаа, дүн шинжилгээ хийх, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд мэргэжлийн чиг баримжаа олгох, ажил болон ажлын орчинд дасан зохицох бэлтгэл сургалт явуулах, ажилд зуучлах гэх мэт олон төрлийн үйл ажиллагаа явуулдаг.

Бусад хүний нэгэн адил хөгжлийн бэрхшээлтэй иргэн ч өөрийн гэсэн тогтмол орлогогүйгээр, өөрөөр хэлбэл, ажиллаж хөдөлмөрлөхгүйгээр сайхан амьдрах

боломжгүй юм. Иймд Хөдөлмөрийн яамнаас тэднийг тогтмол ажилтай байлгахад илүү анхаарлаа хандуулдаг. Энэ хүрээнд яамнаас зарим чухал арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна. Тухайлбал, 300-аас дээш ажилтантай компаний ажилчдын 2% нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн байх талаар шийдвэр гаргажээ²⁰⁷. Компани үүнийг биелүүлэхгүй бол торгууль төлөх юм. Харин хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлаар хангасан компанид татварын хөнгөлөлт болон хөгжлийн бэрхшээлтэй иргэний цалин мөнгөнд тусламж үзүүлнэ.

Сөүл хотын засаг захиргаанаас хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор жил бүр шинээр бий болж буй төрийн албаны орон тооны 10%-д нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг авч ажиллуулахаар болсон байна²⁰⁸. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг тогтмол ажилтай болгож, тэдний тогтвортой амьжиргааг хангахад чухал хувь нэмэр оруулах юм.

АВСТРАЛИ УЛС²⁰⁹

Сүүлийн жилүүдэд Австралид Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх үйлчилгээг сайжруулахад чиглэсэн хууль эрх зүйн томоохон өөрчлөлтүүд хийгдсэн. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан мэдээллийн хүртээмж, үйлчилгээ ба бусад заалтууд бүхий 3 түлхүүр хууль гарсан. Үүнд:

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлчилгээний тухай хууль 1993 (Баруун Австрали, 2004 онд нэмэлт өөрчлөлт орсон);
- Хамтын нөхөрлөлийн орнуудын Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ялгаварлан гадуурхалтын эсрэг хууль (1992);
- Эрх тэгш боломжийн тухай хууль (Баруун Австрали, 1988 онд нэмэлт өөрчлөлт орсон).

Эдгээр хуулиуд нь Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын дараах үндсэн 8 зарчмыг бүхэлд нь хангах зорилгын хүрээнд батлагдсан байна:

- a) сонголт хийх эрх чөлөө болон хүний бие даасан байдлыг оролцуулан хүний нэр төр, нандин чанар, хувийн хараат бус байдлыг хүндэтгэх;
- b) алагчлахгүй байх;
- c) нийгэмд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох болон хамрагдах;
- d) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн онцлог байдлыг хүндэтгэх, тэднийг хүний ялгаатай байдал, хүн төрөлхтний нэг хэсэг гэж хүлээн авах;
- e) тэгш боломж олгох;
- f) хүртээмжтэй байх;
- g) эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш эрхтэй байх;
- h) хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хувьсаж өөрчлөгдөх чадамжийг хүндэтгэх болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өөрийн онцлог байдлаа хадгалах эрхийг хүндэтгэн хандах.

²⁰⁷ <http://mojseul.ru/obshhestvo/lyudi-s-ogranichennymi-vozmozhnostyami.html>

²⁰⁸ <http://mojseul.ru/obshhestvo/lyudi-s-ogranichennymi-vozmozhnostyami.html>

²⁰⁹ Legislation and Disability in Australia (for State Government) – Part 4

https://www.planning.wa.gov.au/dop_pub_pdf/Legislation_and_Disability_in_Australia_for_State_Government.pdf

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлчилгээний тухай хууль 1993²¹⁰

Энэхүү хуулиар хөгжлийн бэрхшээлтэй иргэд үйлчилгээнд хүртээмжтэй хамрагдах, хамруулах төлөвлөгөөг (Disability Access and Inclusion Plans - DAIP) албажуулж, улмаар тэдгээр төлөвлөгөөг хөгжүүлэх, хэрэгжүүлэх ба тайлагнах харилцааг хуульчилсан.

Тус хуульд хөгжлийн бэрхшээлтэй хүний гэмтэл согог нь хэр зэрэг, ямар түвшний гэдгээс үл хамааран нийгмийн бусад гишүүдийн нэгэн адил хүний эрхийг эдэлж, хүний үнэ цэнэ, нэр төр нь хүндлэгдэх ёстой гэж заажээ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлчилгээний тухай хууль нь Баруун Австралийн муж ба Орон нутгийн Засгийн газрыг Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчилгээ хүртээмжтэй байх, үйлчилгээнд хамрагдаж байх (Disability Access and Inclusion Plans - DAIP - Урьд өмнө нь Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх төлөвлөгөө гэж нэрлэдэг байсан) төлөвлөгөөг заавал боловсруулж хэрэгжүүлэхийг шаардсан бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэд аливаа үйлчилгээнд бүрэн хамрагдах эрхийг баталгаажуулсан байна.

Хуулийн 5-р бүлэгт олон нийтийн аливаа үйлчилгээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хүртээмжтэй, бүрэн хамруулсан байх төлөвлөлтийг хийхэд нийтийн захиргаанд тавигдах шаардлагуудын хүрээг тогтоосон байдаг. Тухайлбал;

- 1) Нийтийн захиргаа бүр нь олон нийтийн үйл ажиллагаа, үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй, тэднийг бүрэн хамруулах төлөвлөгөөтэй байна. Улмаар тэдгээр үүрэг, үйл ажиллагааны гүйцэтгэлүүд нь Хөтөлбөр 1-ийн зарчмуудыг гүнзгийрүүлж, Хөтөлбөр 2-ын зорилтуудыг хангасан байна.
- 2) Төлөвлөгөө нь тодорхой тогтоосон стандартыг хангасан байна.
- 3) Нийтийн захиргаа нь өөрийн төлөвлөгөөг Комисст хүргүүлж танилцуулна:
 - а) хэрвээ энэхүү захиргаа нь Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлчилгээний тухай хуулийн 2004 оны нэмэлт өөрчлөлтүүд мөрдөгдөхөөс өмнө байгуулагдсан бол тэр даруйдаа;
 - б) хэрвээ энэхүү захиргаа нь тус хуулийн нэмэлт өөрчлөлтүүд мөрдөгдсөний дараа байгуулагдсан бол байгуулагдсан өдрөөсөө хойш 12 сарын дотор.
- 4) Нийтийн захиргаа өөрийн төлөвлөгөө (DAIP)-нд хэдийд ч нэмэлт өөрчлөлт оруулж болно.
- 5) Нийтийн захиргаа өөрийн төлөвлөгөө (DAIP)-г хэдийд ч эргэн харж, хянан үзэж болно.
- 6) Төлөвлөгөө (DAIP)- гөө эргэн харж, хянан үзсэний дараагаар тухайн нийтийн захиргаа ийнхүү нягталсан тухай тайлангаа (7) дахь дэд хэсэгт заасанчлан Комисст хүргүүлнэ.
- 8) Төлөвлөгөө (DAIP)- г хянан шалгаж үзсэнийхээ дараа нийтийн захиргаанаас түүнийг шинэчлэн өөрчилнө, эсхүл дахин шинээр боловсруулна.
- 9) Нийтийн захиргаа нь төлөвлөгөө (DAIP)-гөө шинэчлэн өөрчилсөн, эсхүл дахин

²¹⁰ Disability service act 1993 <https://www.legislation.gov.au/Details/C2018C00146>

шинээр боловсруулсан аль ч тохиолдолд нягтлан үзсэнийхээ дараа, эсхүл өмнө нь төлөвлөөгөөгөө Коммист хүргүүлнэ.

10) Нийтийн захиргаа нь төлөвлөгөө (DAIP) боловсруулах, эргэн шалгах, эсхүл өөрчлөлт оруулах үедээ хууль журамд заасанчлан олон нийтээр хэлэлцүүлэн зөвлөлдөнө.

Төлөвлөгөө нь дараах үндсэн 3 хөтөлбөрийн хүрээнд боловсруулагдана. Үүнд:

Хөтөлбөр 1: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тухайд баримтлах зарчмууд

- 1) Хөгжлийн бэрхшээлтэй иргэд бол хүний үнэ цэнэ, нэр төрөө хүндэтгүүлэх төрөлх эрхтэй.
- 2) Ямар ч угсаа гарвал, төрөлх байдал, гэмтэл согогийн төрөл болон түвшингээс үл хамааран хөгжлийн бэрхшээлтэй иргэд нь нийгмийн бусад гишүүдийн адил тэгш эрхтэй тул тэдгээр хүний үндсэн эрхийг эдлэх боломжтой байх ёстой.
- 3) Хөгжлийн бэрхшээлтэй иргэд нь хувь хүний бие, нийгэм, сэтгэл хөдлөл, оюун ухаан болон оюун санааны чадвар боломжоо ашиглах, хөгжүүлэх нийгмийн бусад гишүүдтэй адил тэгш эрхтэй.
- 4) Хөгжлийн бэрхшээлтэй иргэд нь нийгмийн бусад гишүүдийн нэгэн адилаар гэр бүл болон асран хамгаалагчдынхаа үүрэг, хэрэгцээг хүлээн зөвшөөрүүлэх, боломжийн сайн амьдрахад нь дэмжлэг болохуйц аливаа үйлчилгээнд хамрагдах эрхтэй.
- 5) Хөгжлийн бэрхшээлтэй иргэд нь нийгмийн бусад гишүүдийн адилаар өөрсдийн амьдралд нөлөөлөхүйц шийдвэрүүдийг гаргахад шууд оролцож, хэрэгжүүлэх эрхтэй.
- 6) Хөгжлийн бэрхшээлтэй иргэд нь нийгмийн бусад гишүүдийн нэгэн адилаар өөрсдийн эрх, боломж бололцоог хангах үр дүн бүхий үйлчилгээг хүртэх эрхтэй.
- 7) Хөгжлийн бэрхшээлтэй иргэд нь нийгмийн бусад гишүүдийн нэгэн адилаар үйлчилгээтэй холбоотой аливаа санал гомдлоо илэрхийлж шийдвэрлүүлэх эрхтэй.
- 8) Хөгжлийн бэрхшээлтэй иргэд нь өөрсдийн хэрэгцээнд хамгийн тохиромжтой гэж үзсэн үйлчилгээний төрөл хэлбэрүүдэд хамрагдаж, тэдгээрийг дэмжих эрхтэй.
- 9) Хөдөө орон нутаг болон зах хязгаар нутагт оршин суудаг хөгжлийн бэрхшээлтэй иргэд нь том хотуудад оршин суугч хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй адил нөхцөл бүхий үйлчилгээнд хамрагдах эрхтэй.
- 10) Хөгжлийн бэрхшээлтэй иргэд нь аливаа үл ойшоосон, гутаан доромжилсон, ялгаварлан гадуурхалтгүй орчинд амьдрах эрхтэй.

Хөтөлбөр 2: DAIP - ийн стандарт

- 1) Аливаа DAIP төлөвлөлт нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг олон нийтийн захиргаанаас үзүүлдэг үйлчилгээ, зохион байгуулдаг арга хэмжээ зэрэгт бусад хүмүүсийн адилаар хамрагдах, оролцох боломжтой байх явдлыг хангасан байх;

- 2) Аливаа DAIP төлөвлөлт нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг олон нийтийн холбогдох захиргааны байшин барилга ба тавилга хэрэгслүүдийг бусад хүмүүстэй адил тэгш хэрэглэх боломжоор хангасан байх;
- 3) Аливаа DAIP төлөвлөлт нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг олон нийтийн ямарваа захиргаанаас мэдээллийг бусад хүмүүс чөлөөтэй хүлээн авч хэрэглэдэгтэй адил түвшинд хүлээн авах арга хэлбэрээр хангасан байх;
- 4) Аливаа DAIP төлөвлөлт нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олон нийтийн захиргааны ажилтнаас бусад иргэд ямар түвшин, ямар чанартай үйлчилгээг авч буйтай яг адил үйлчилгээг авах арга замыг хангасан байх;
- 5) Аливаа DAIP төлөвлөлт нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд олон нийтийн захиргаадад өргөдөл гомдол өгөх талаар бусад иргэдтэй адил боломж нөхцөлийг бүрдүүлсэн байх;
- 6) Аливаа DAIP төлөвлөлт нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг олон нийтийн захиргаанаас өгч буй ямарваа нийтийн зөвлөн туслах үйлчилгээнд бусад хүмүүсийн адил хамрагдан оролцох боломж бололцоогоор хангасан байх;
- 7) Аливаа DAIP төлөвлөлт нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ажил олгох, тогтвортой ажил хөдөлмөр эрхлэх саад тотгоруудыг багасган бууруулахад чиглэсэн байх. (Хөтөлбөр 2 - ийн 6-аас хойших зүйлс 2013 оны 6 дугаар сард өөрчлөгдсөн)

Хөтөлбөр 3: DAIP төлөвлөлтийн хүрэх үр дүн

- 1) Хөгжлийн бэрхшээлтэй иргэд олон нийтийн захиргаанаас үзүүлдэг үйлчилгээ, зохион байгуулдаг арга хэмжээ зэрэгт бусад хүмүүсийн адилаар хамрагдах, оролцох боломжтой байх;
- 2) Хөгжлийн бэрхшээлтэй иргэд олон нийтийн холбогдох захиргааны байшин барилга ба тавилга хэрэгслүүдийг бусад хүмүүстэй адил тэгш хэрэглэх боломж хангагдсан байх;
- 3) Хөгжлийн бэрхшээлтэй иргэд олон нийтийн захиргаанаас мэдээллийг нийгмийн бусад гишүүдийн нэгэн адилаар чөлөөтэй хүлээн авах арга хэлбэрээр хангагдсан байх;
- 4) Хөгжлийн бэрхшээлтэй иргэд олон нийтийн захиргааны ажилтнаас бусад иргэдийн адил түвшний, чанартай үйлчилгээг авах арга зам хангагдсан байх;
- 5) Хөгжлийн бэрхшээлтэй иргэд олон нийтийн захиргаадад өргөдөл гомдол өгөх талаар бусад иргэдтэй адил боломж нөхцөлөөр хангагдсан байх.
- 6) Хөгжлийн бэрхшээлтэй иргэд олон нийтийн захиргаанаас өгч буй ямарваа нийтийн зөвлөн туслах үйлчилгээнд бусад хүмүүсийн адил хамрагдан оролцох боломж бололцоогоор хангагдсан байх.
- 7) Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажилд орох, тогтвортой ажил хөдөлмөр эрхлэх саад тотгорууд багасаж буурсан байх. (Хөтөлбөр 2 –ийн 6-аас хойших зүйлс 2013 оны 6 дугаар сард өөрчлөгдсөн.)

Хамтын нөхөрлөлийн орнуудын Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ялгаварлан гадуурхалтын тухай хууль²¹¹

Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ялгаварлан гадуурхалтын тухай хууль (1992) нь хөгжлийн бэрхшээлтэй хүн, эсхүл хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй хамаарал бүхий этгээдийг (жишээлбэл, эхнэр/нөхөр, асран хамгаалагч, бизнесийн хамтрагч) дараах тохиолдолд ялгаварлан гадуурхах явдлыг хууль бус гэж тодорхойлсон байна.

- ажил эрхлэлт;
- боловсрол;
- байршлууд болон тээврийн хэрэгслийг хэрэглэх;
- орон байр;
- газар худалдан авах, эсхүл худалдах;
- клуб болон хамтарсан нийгэмлэгүүд;
- спорт;
- хамтын нөхөрлөлийн хууль, хөтөлбөрүүд;
- бараа, үйлчилгээ, тоног төхөөрөмж нийлүүлэх.

Үүнээс гадна Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ялгаварлан гадуурхалтын тухай хуулийн 31 (1) хэсэг нь нийтийн тээвэр, боловсрол, орон байр, хөдөлмөр эрхлэлт болон Хамтын Нөхөрлөлийн Хөтөлбөрүүдтэй холбоотой "хөгжлийн бэрхшээлийн стандарт" (disability standards) -ыг боловсруулах боломжийг олгодог. Хөгжлийн бэрхшээлийн стандарт нь эдгээр тодорхой бүс нутгийн хууль тогтоомжийн шаардлагын талаар илүү тодорхой түвшний онцлог байдлыг хангах арга зам юм.

Хуулийн 2-р хэсэгт Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэх болон боловсрол эзэмших харилцаанд ялгаварлан гадуурхахыг хориглох тухай зохицуулсан. Тухайлбал,

Бүлэг 1 – Хөдөлмөрийн ялгаварлан гадуурхалт

15. Хөдөлмөр эрхлэлтээр ялгаварлан гадуурхах

(1) Ажил олгогч, эсхүл ажил олгогчийн нэрийн өмнөөс үүрэг гүйцэтгэж буй этгээдийн зүгээс хүнийг хөгжлийн бэрхшээлтэй нь хувьд доор дурдсан хэлбэрээр ялгаварлан гадуурхах нь хууль бус:

- (a) ажлын байранд тавигдах шаардлагыг тодорхойлох зорилгоор тавигдах зохицуулалтаар;
- (b) ажлын байрыг хэнд өгөхийг тодорхойлохдоо;
- (c) ажлын байр санал болгох нөхцөлөөр.

(2) Ажил олгогч, эсхүл ажил олгогчийн нэрийн өмнөөс үүрэг гүйцэтгэж буй этгээдийн зүгээс ажилтныг хөгжлийн бэрхшээлтэйн хувьд нь доор дурдсан хэлбэрээр ялгаварлан гадуурхах нь хууль бус:

- (a) ажил олгогчийн зүгээс ажилтны хөдөлмөр эрхлэх нөхцөл, хугацаагаар;
- (b) хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан тоноглол хийхгүй байх, тоноглолыг хязгаарлах, ажилтны албан тушаал ахих, өөр ажилд шилжих, сургалтанд

²¹¹ Disability Discrimination Act 1992, <http://www.comlaw.gov.au>

хамрагдах болон ажлын байртай нь холбоотой бусад ололт, дэвшилд хүрэх нөхцөлийг нь хаах, хязгаарлах;

(c) ажилтныг халах;

(d) ажилтанд бусад хэлбэрээр хохирол учруулах.

Мөн энэ бүлгийн 16, 17, 18 дугаар заалтуудад худалдааны агент (*commission agents*), гэрээт ажилтан, хоршооллогчдын хувьд дээр дурдсан 15 дугаар заалттай адилаар хүнийг хөгжлийн бэрхшээлтэйн хувьд нь ялгаварлан гадуурхах нь хууль бус гэж тодорхойлжээ.

Энэ бүлгийн 19 дүгээр зүйлээр тодорхой мэргэжилийн дадлага олгох, мэргэшүүлэх, зөвшөөрөл олгох болон эгүүлэн хураах эрх, үүрэг бүхий тусгай байгууллагуудын зүгээс; 20 дугаар зүйлд аливаа бүртгэгдсэн байгууллага, түүний удирдлагын хорооны зүгээс хүнийг хөгжлийн бэрхшээлтэйн хувьд нь ялгаварлан гадуурхах нь хууль бус болохыг тус тус тодорхойлсон байна.

21. Хөдөлмөр эрхлэлтийн агентлагууд

(1) Хөдөлмөр эрхлэлтийн агентлагууд хүнийг хөгжлийн бэрхшээлтэйн хувьд нь дараах хэлбэрээр ялгаварлан гадуурхахыг хуулиар хориглоно:

(a) өөрийн үзүүлдэг аливаа үйлчилгээг үзүүлэхээс татгалзах;

(b) өөрийн үзүүлдэг аливаа үйлчилгээг үзүүлэхдээ тавигдах нөхцөл, хугацаагаар;

(c) өөрийн үзүүлдэг аливаа үйлчилгээг үзүүлэх арга хэлбэрээр.

Бүлэг 2 – Бусад хэлбэрийн ялгаварлан гадуурхалт

22. Боловсрол

(1) Боловсролын байгууллага хүнийг хөгжлийн бэрхшээлтэйн хувьд нь дараах хэлбэрээр ялгаварлан гадуурхахыг хуулиар хориглоно:

(a) хөгжлийн бэрхшээлтэй хүний суралцах хүсэлтийг хүлээн авахгүй байх, татгалзах;

(b) суралцуулахаар авах нөхцөлөөр ялгавар тогтоох.

(2) Боловсролын байгууллага суралцагчийг хөгжлийн бэрхшээлтэйн хувьд нь дараах хэлбэрээр ялгаварлан гадуурхахыг хуулиар хориглоно:

(a) хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид зориулсан тоноглол хийхгүй байх, тоноглолыг хязгаарлах, боловсролын байгууллагын зүгээс олгох аливаа хөнгөлөлтийг хязгаарлах;

(b) суралцагчийг хасах;

(c) суралцагчид бусад хэлбэрийн хүндрэл учруулах.

(2A) Боловсролын байгууллага хүнийг хөгжлийн бэрхшээлтэйн хувьд нь дараах хэлбэрээр ялгаварлан гадуурхах нь хууль бус:

(a) сургалтын хөтөлбөр болон дадлагын курсын агуулгыг боловсруулахдаа суралцагчын оролцох боломжийг хаасан, эсхүл хүндрэл учруулсан;

(b) дээрх заалтанд тусгагдсан агуулга бүхий сургалтын хөтөлбөр болон дадлагын курсыг батлах.

Өндөр насны болон тахир дутуугийн тэтгэврийн хууль

1908 онд Өндөр насны болон тахир дутуугийн тэтгэврийн хууль (*Invalid and Old-Aged Pensions Act 1908*) батлагдаж, 1910 оноос хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тэтгэвэр олгож эхэлжээ. Энэ тэтгэврийг цалин хөлстэй хөдөлмөр эрхлэн бие даан амьдрах бололцоогүй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулан бий болгосон. Дээрх хуулиар 16 нас хүрсэн, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг гэр бүл, төрөл төрөгсдийн зүгээс дэмжлэг авахгүй гэж үзэж, тэтгэвэр тогтоодог.

Одоо 1991 онд батлагдсан Нийгмийн хамгааллын хуулиар (*Social Security Act 1991*²¹²) хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн халамж, тэтгэвэр, бусад хөнгөлөлтүүдийг зохицуулдаг. Энэ хуулийн 2 дугаар хэсгийн (*Chapter 2—Pensions, benefits and allowances*) Бүлэг 2.3. –т (*Part 2.3—Disability support pension*) хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэврийн талаар заасан байдаг.

Энэ хуулиар:

- 16 наснаас тэтгэврийн нас хүртэл;
- Хараагүй болон бие, оюун, сэтгэцийн хувьд хөгжлийн бэрхшээлтэйд тооцогдох;
- Хөдөлмөрлөх чадваргүй, эсхүл хөгжлийн бэрхшээлээсээ шалтгаалан ойрын 2 жилд долоо хоногт 15 ба түүнээс дээш цагаар ажиллаж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинжихын тулд дахин бэлтгэгдэх шаардлагатай хүмүүс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэр авна.

Австралид өндөр насны тэтгэвэр тогтоолгох нас нь:

1949 оны 1 дүгээр сарын 1-нээс өмнө төрсөн эмэгтэй 64,5 насандаа, 1949 оны 1 дүгээр сарын 1-нээс 1952 оны 6 дугаар сарын 30-ны хооронд төрсөн эмэгтэй 65 насандаа, 1952 оны 7 дугаар сарын 1-нээс өмнө төрсөн эрэгтэй 65 насандаа тус тус тэтгэвэрт гарах эрхтэй болно. Харин 2017 оны 6 дугаар сарын 1-нээс эхлэн тэтгэвэр тогтоох насыг 65-аас 65 нас 6 сар болгон нэмэгдүүлнэ. Ингээд цаашид тэтгэвэр тогтоох насыг 2 жил тутамд 6 сараар нэмэгдүүлж, 2023 оны 7 сарын 1 гэхэд 67 нас хүргэнэ.

1991 оны Нийгмийн хамгааллын хуулийн 55 дугаар зүйлд зааснаар өндөр насны ба хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэврийн хэмжээг хараагүй хүний хувьд энэ хуулийн 1065 дугаар зүйлээр, бусад хүний хувьд 1064 дүгээр зүйлээр тогтооно.

Баруун Австралийн Эрх тэгш боломжийн тухай хууль²¹³ 1988

Баруун Австралийн Эрх тэгш боломжийн тухай хууль нь 1984 онд батлагдсан бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нийгмийн бусад гишүүдийн нэгэн адил түвшний үйлчилгээг авах шаардлагатай бөгөөд хамрагдах эрхтэй гэдгийг хүлээн зөвшөөрөх үүднээс 1988 онд нэмэлт өөрчлөлтийг оруулсан байна.

Энэ хуулийн зорилго нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг түүний ямар нэгэн тахир

²¹² Social Security Act 1991, <http://www.comlaw.gov.au>

²¹³ The Equal Opportunity Act (Western Australia, amended 1988) www.slp.wa.gov.au

дутуу байдлаас нь шалтгаалан адилхан нөхцөл байдалд бусдаас ялган үзэхийг зохицуулахад оршино. Хуулийн нэмэлт өөрчлөлтөөр бусдыг тахир дутуу хэмээх үндэслэлээр ялгаварлах нь хууль бус үйлдэл гэж үзсэн.

Хэрвээ дараах шаардлага, эсхүл нөхцөлийг тавьсан тохиолдолд ялгаварлах хэрэг гарна:

- хөгжлийн бэрхшээлгүй хүмүүс л шаардлага хангахуйц байх магадлал өндөр хувьтай;
- өгөгдсөн нөхцөл байдалд нийцэхгүй;
- хөгжлийн бэрхшээлтэй хүн биелүүлэхийн аргагүй гэх мэт.

Ялгаварлан үзэх явдал дор дурдсан салбаруудад ажиглагддаг:

- ажил эрхлэлт
- боловсрол
- байршлууд болон тээврийн хэрэгслийг хэрэглэх
- эд бараа, үйлчилгээ, тавилга хэрэгслүүд
- орон байр
- спорт
- клуб болон хамтарсан нийгэмлэгүүд
- мэргэжлийн / эрдмийн зөвлөлүүд - *qualifying bodies*
- хамтын ажиллагаа
- мэргэжлийн болон худалдааны байгууллагууд.

Хэрвээ хөгжлийн бэрхшээлтэй хүн тахир дутуугийн улмаас ялгаварлагдсан гэж үзвэл Баруун Австралийн Адил тэгш боломжийн комиссарт өргөдөл гомдлоо гаргаж болно.

ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС

ОХУ-д хөгжлийн бэрхшээлтэй иргэний асуудлыг Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын тухай хууль (*Федеральный закон О социальной защите инвалидов в Российской Федерации*) болон бусад холбогдох хуулиудын хүрээнд зохицуулж байна. Үүнд:

- Үндсэн хууль (*Конституция Российской Федерации*)
- Боловсролын тухай хууль (*ФЗ Об образовании в Российской Федерации*)
- Хөдөлмөрийн тухай хууль (*Трудовой кодекс Российской Федерации*);
- Иргэний эрүүл мэндийг хамгаалах тухай хууль (*Федеральный закон Об основах охраны здоровья граждан в Российской Федерации*);
- Сэтгэцийн эмгэгтэй иргэнд үзүүлэх тусламж, түүний эрхийн баталгааг хангах тухай хууль (*Федеральный закон “О психиатрической помощи и гарантиях прав граждан при ее оказании”*);
- Төрөөс үзүүлэх нийгмийн халамж үйлчилгээний тухай хууль (*Федеральный закон “О государственной социальной помощи”*);
- Өндөр насны тэтгэвэрийн тухай хууль (*Федеральный закон “О трудовых пенсиях в Российской Федерации”*);
- Бусад хууль тогтоомжууд орно.

ОХУ-д хөгжлийн бэрхшээлтэй иргэний талаарх гол хууль нь 1995 онд батлагдсан Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын тухай хууль (*Федеральный закон О социальной защите инвалидов в Российской Федерации*) юм.

Хуулийн зорилго нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын салбарт төрөөс баримтлах бодлогыг тодорхойлж, Үндсэн хуулиар тогтоосон иргэний, эдийн засгийн, улс төрийн болон бусад эрх, эрх чөлөөг бусад иргэнтэй адил тэгш эдлэх боломжоор хангах, ОХУ-ын дагаж мөрддөг олон улсын хууль, гэрээ хэлэлцээрт заасан нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээ, зарчмуудыг хэрэгжүүлэхэд оршино.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэн сурах, бүх шатны боловсрол эзэмших

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын тухай хуулийн 19 дүгээр зүйлд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг боловсрол эзэмшихэд төрөөс бүх талаар дэмжих бөгөөд шаардлагатай нөхцөлийг баталгаатай хангана” гэж заасан байна.

Хуулиар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бүх шатны боловсролыг үнэгүй эзэмших эрхийг баталгаажуулсан бөгөөд энэ нь тэдэнд бусад хүмүүсийн нэгэн адил хүний эрх, эрх чөлөөг эдлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэний бие хүний болон хувийн онцлог, боломжийг хөгжүүлэх, нийгмийн хөгжилд татан оролцуулахад чиглэгдсэн.

Боловсролын удирдах болон боловсролын үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучууд, тэдгээрийн эцэг, эх, хууль ёсны төлөөлөгчийг хөгжлийн бэрхшээлтэй иргэний боловсрол эзэмшихэд шаардлагатай мэдээллээр хангах үүрэгтэй. Мөн эдгээр байгууллагууд нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний боловсрол эзэмших үйл явцад сэтгэл зүй-сурган хүмүүжүүлэх дэмжлэг үзүүлэх ба хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг гэрийн нөхцөлд сургахад дэмжлэг үзүүлнэ. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг гэрээр боловсрол эзэмшүүлэхэд гарах зардлыг ОХУ-ын субъектуудын эрх зүйн актын дагуу тодорхойлон эцэг, эхэд нь олгоно.

Түүнчлэн ОХУ-ын Боловсролын тухай хуулийн (*ФЗ Об образовании в Российской Федерации*) дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэн мэргэжлийн боловсролыг нэг бус удаа үнэ төлбөргүй эзэмших эрхтэй ба 1-2 дугаар группын хөгжлийн бэрхшээлтэй иргэн техникийн дээд сургууль, техникийн дунд боловсролын сургуульд элсэлтийн шалгалтгүйгээр элсэн орох эрх эдэлдэг. Үүнээс гадна тэдэнд оюутны цалинг 50 хувь нэмэгдүүлэн олгодог байна.²¹⁴

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлт

ОХУ-ын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын тухай хуулийн 20-24 дүгээр зүйлүүдэд хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дараах зохицуулалтуудыг тусгасан байна²¹⁵. Үүнд:

- 100-аас дээш ажилтантай байгууллагад ажилтны дундаж тоонд хувь тэнцүүлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг авч ажиллуулах квот тогтоох (2 хувиас доошгүй, 4 хувиас дээшгүй);
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэн мэргэжлээрээ хөдөлмөрлөх ажлын байрны нөөцийг бий болгох;

²¹⁴ Федеральный закон Об образовании в Российской Федерации, <http://pravo.gov.ru/proxy/ips/?docbody=&nd=102162745>

²¹⁵ Федеральный закон О социальной защите инвалидов в РФ, Статья 20-24, <http://pravo.gov.ru/proxy/ips/?docbody=&nd=102038362&rdk=>

- Аж ахуйн нэгж, байгууллагууд нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувийн онцлогт тохирсон нэмэлт тоног төхөөрөмж бүхий тусгай ажлын байр бий болгох явдлыг дэмжих;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувийн нөхөн сэргээх хөтөлбөрийнх нь дагуу тэдний хөдөлмөрлөх нөхцөлийг бий болгох;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх нөхцөлийг бий болгох;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг шинэ мэргэжил эзэмших сургалтыг зохион байгуулах;
- Ажил олгогчид нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ажлын байртай холбоотой мэдээллийг зохих журмын дагуу өгөх зэрэг болно.

ОХУ-ын Хөдөлмөрийн тухай хуулийн (*Трудовой кодекс РФ*) дагуу хөдөлмөр эрхэлдэг хөгжлийн бэрхшээлтэй иргэн дараах хөнгөлөлтийг эдэлдэг²¹⁶. Үүнд:

- 1-2 дугаар группын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын цаг 7 хоногт 35 цагаас илүүгүй байна.
- Мөн жил бүр ээлжийн амралтыг календарийн 30 хоногоос доошгүй, харин цалингүй амралтыг 60 хүртэл хоног олгоно.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр амралтын өдөр болон шөнийн цагаар ажиллуулахыг хориглоно.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний өндөр насны тэтгэвэр

Энэхүү асуудлыг Төрийн тэтгэвэрийн хангамжийн тухай хуулиар (*ФЗ О государственном пенсионном обеспечении*) зохицуулсан. Энэ хуулийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэн нь тахир дутуугийн тэтгэвэр, эсхүл өндөр насны тэтгэвэр хоёрын аль нэгийг сонгох эрхтэй. Өөрөөр хэлбэл, хөдөлмөр эрхэлж байгаад өндөр насны тэтгэвэр тогтоолгоход хөгжлийн бэрхшээлтэй иргэн энэ хоёр тэтгэврийн аль өндөр хэмжээтэйг сонгох боломжтой юм.

Түүнээс гадна зарим хөгжлийн бэрхшээлтэй иргэн дээрх хоёр тэтгэврийг зэрэг авах эрхтэй байна. Үүнд:

- Байлдааны ажиллагааны улмаас тахир дутуу болсон;
- Эх орны Агуу их дайнд оролцогч;
- “Ленинградад бүслэгдэгч тэмдгээр шагнагдсан иргэн хамрагдана.

Хөдөлмөрийн хууль, тэтгэврийн тухай хуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийг хамгаалах талаар дараах нэн чухал зохицуулалтуудыг тусгаж, амьдралын баталгааг хангахад онцгойлон анхаарсан. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эх ажлын хагас цагаар ажиллана (93 дугаар зүйл).
- Мөн хуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эх болон ажилтны хөдөлмөр эрхлэлтийн баталгааг тогтоосон ба үүнд, шөнийн цагаар (96 дугаар зүйл), эсхүл илүү цагаар, амралтын болон баярын өдрөөр ажиллахгүй байх, албан томилолтоор явуулахгүй байх (259 дугаар зүйл), цалинтай болон цалингүй нэмэлт амралтын өдөр (262, 263 дугаар зүйл) олгох, хөдөлмөрийн гэрээг цуцлах, ажлаас халахыг хориглосон (261 дүгээр зүйл) байна.

²¹⁶ Трудовой кодекс РФ, Статья 92., <http://www.trudkod.ru/>

- Тэтгэврийн тухай хуульд зааснаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ 8 нас хүртэл өсгөсөн эхийн тэтгэврийг 50 наснаас тогтоох (15 жил ажилласан тохиолдолд) ба хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд асарсан хугацааг ажилласан жилд тооцно (11, 92(б) дүгээр зүйл).

ДҮГНЭЛТ

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг зохицуулж байгаа 70 гаруй хууль тогтоомж үйлчилж байгаа хэдий ч Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэд ялгаварлан гадуурхалтад байнга өртөж, энгийн хүнтэй адил амьдрах нөхцөл боломжоор хангагдаж чадахгүй байгааг судалгаанаас харж болохоор байна. Хууль тогтоомжийн зохицуулалт дутагдалтай байгаагаас бус хууль тогтоомжийн хэрэгжилт сул, санхүү, төсвийн дутагдалтай байдал нь хууль тогтоомжийн хэрэгжилтэд сөрөг нөлөө үзүүлж байна гэж үзэж байна. Мөн хууль тогтоомжуудын уялдаа холбоо, зохих зохицуулалтыг салбар хуулинд тусгаагүй зэрэг олон шалтгаан урган гарч байна. Тиймээс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг зохицуулж байгаа хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар дараах саналуудыг боловсрууллаа. Үүнд:

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна. Хууль батлагдсантай холбоотойгоор 29 дүрэм, журмыг батлахаар заасан байна. Гэтэл 2019 оны байдлаар батлагдаагүй эрх зүйн баримт бичгүүд байна. Зарим нь тус хуулийг батлагдахаас өмнө баталсан дүрэм, журмаар зохицуулагдаж байна. Тиймээс батлагдаагүй байгаа эрх зүйн актуудыг батлан гаргах шаардлагатай.
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг батлахдаа холбогдох хууль тогтоомжуудад хийх нэмэлт, өөрчлөлтийг дутуу хийсэн. Энэ нь хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаагийн нэг шалтгаан болж байна. Зарим дүрэм, журам нь энэхүү хуулийн зарим зүйл, заалтыг дордуулсан байдлаар зохицуулсан хэвээр байна. Тухайлбал, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Боловсролын багц хууль гэх мэт.
3. Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага дутуу, байгаа нь хэт сул байна. Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулахдаа дутуу оруулсан тул зохицуулалтыг нөхөж оруулах шаардлагатай байна. Мөн хуульд заасан хориглосон хэм хэмжээг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын арга хэмжээг тусгаагүй байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангахад учирч буй бэрхшээлтэй асуудлын суурь гэж үзэж байна. Хуульд байгаа нэр томъёог жигдлэх шаардлагатай. Тухайлбал стандартчилалын байгууллагыг хууль 5 өөрөөр нэрлэн заасан байна.
4. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай болон Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын конвенцын хэрэгжилтийн тайланд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажилд анхаарах. Мөн Хүүхдийн эрхийн конвенцын орчуулгыг эргэн харах. Тус конвенцын орчуулгад байгаа тахир дутуу буюу оюуны хомсдолтой гэсэн нэр томъёог өөрчлөх нь зүйтэй.
5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлж буй тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай. Хүн амын амьжиргааны доод түвшинтэй уялдуулан нийгмийн халамжийн тэтгэвэрийг нэмэгдүүлж байгааг өөрчилж хөдөлмөрийн хөлсний доод түвшинтэй уялдуулан тогтоох шаардлагатай. Мөн нийгмийн халамж шаардлагатай хүмүүсийн судалгаа, мэдээллийн нэгдсэн сантай болж тусламж,

- дэмжлэг шаардалагатай байгаа хүмүүст бэрхшээлийн хэлбэрээс нь хамаарч тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг тогттоох нь зүйтэй.
6. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай хууль болон НҮБ-ын конвенцод заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулан сургах талаар Боловсролын тухай хуульд нэмэлт оруулах шаардлагатай. ЕБС-д хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулан сургах талаар нарийвчилсан зохицуулалт байхгүй байна.
 7. Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль нь хэт ерөнхий зохицуулалттай байна. Хэрэв сэтгэцийн эрүүл мэндийн улмаас өөрийгөө хянах боломжгүй, байнгын асаргаа шаардлагатай хүнийг хэрхэн эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх талаар нарийвчилсан зохицуулалт оруулах шаардлагатай.
 8. Хөдөлмөрийн тухай хуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийг хүндэтгэх шалтгаангүйгээр ажлаас халахыг хориглосон зохицуулалтыг нэмж оруулах. Өнөөгийн манай нийгмийн хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй гэр бүлд бүх ачааллыг үүрүүлж байгаа нь гэр бүлээрээ ядууралд өртөх нөхцөлийг бүрдүүлж байна. Тиймээс зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжихээс гадна гэр бүлийг нь дэмжих нь хамгийн чухал. Энэ зохицуулалтыг ОХУ амжилттай хэрэгжүүлж байгаа сайн туршлагатай орон юм.
 9. Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулж хөгжлийн бэрхшээлтэй хүн авч ажиллуулаагүй аж ахуйн нэгжид ногдуулах татварын хэмжээг нэмэгдүүлэх. Ингэснээр аж ахуйн нэгжүүдийг хариуцлагажуулна.
 10. Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулж компаниудад тавьж буй шалгуурыг багасгах. Ингэснээр өрсөлдөх чадвар болон давуу тал нэмэгдвэл хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг авч ажиллуулах сонирхол аж ахуйн нэгжүүдэд нэмэгдэж хөдөлмөр эрхлэлт нэмэгдэх ач холбогдолтой.
 11. Дэд бүтэц болон Барилга байгууламжийн тухай хууль тогтоомжуудын нэр томъёог жигдлэх шаардлагатай байна. Энэ салбарт мөрдөгдөж байгаа хууль тогтоомжуудад тахир дутуу иргэд гэсэн нэр томъёог хэрэглэсэн. Тиймээс холбогдох хууль тогтоомжуудад өөрчлөлт оруулах.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Нэг. Хууль тогтоомж:

- Монгол Улсын Үндсэн хууль
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай хууль
- Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030
- Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого
- Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль
- Нийгмийн халамжийн тухай хууль
- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль
- Бага, дунд боловсролын тухай хууль
- Дээд боловсролын тухай хууль
- Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хууль
- Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль
- Эрүүл мэндийн тухай хууль
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль
- Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль
- Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Барилгын тухай хууль
- Хот байгуулалтын тухай хууль
- Автотээврийн тухай хууль
- Автозамын тухай хууль
- Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль
- Олон нийтийн радио, телевизийн тухай хууль
- Харилцаа холбооны тухай хууль
- Номын сангийн тухай хууль
- Сонгуулийн тухай хууль

Хоёр. Эрх зүйн баримт бичиг:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай (УИХ-ын 2017 оны 46 дугаар тогтоол)
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр (ЗГ-ын газрын 2017 оны 321 дүгээр тогтоолын хавсралт)

- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө (ХНХС, БСШУСС, ЭМС-ын хамтарсан тушаал-2018.05.21, А/116)
- Хөгжлийн бэрхшээлтэй хүнд тусламж, хөнгөлөлт үзүүлэх журам (ЗГ-ын 2017 оны 197 дугаар тогтоол)
- Мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр (ЗГ-ын 2016 оны 304 тоот тогтоол)
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай (Монгол Улсын Их Хурлын 2013 оны 19 дүгээр тогтоол)
- Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгох журам (ЗГ-ын 2012 оны 185 дугаар тогтоол)
- Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид суралцагчийн тэтгэлэг олгох журам (Засгийн газрын 2014 оны 71 дүгээр тогтоол)
- Тогтоолд нэмэлт оруулах тухай (Засгийн газрын 2017 оны 162 дугаар тогтоол)
- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын “Тусгай цэцэрлэг, сургуулийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 2017 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн А/195 дугаар тушаал
- Тусгай сургалтын байгууллагын зардал тооцох, албан тушаалтанд нэмэгдэл хөлс олгох журам /ЗГ-ын 2012 оны 185 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт)
- Дүлийрэлт, сонсгол бууралтаас сэргийлэх, хянах үндэсний стратеги (2010-2019)
- Хөтөч нохойг сургах, түүнийг хэрэглэх журам
- Сэргээн засах тусламж, үйлчилгээний журам (ЭМС-ын сайдын 2015 оны 487 дугаар тушаал)
- Сэтгэцийн эрүүл мэндийн хоёр дахь үндэсний хөтөлбөр (2010-2019)
- Амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчнөөс сэргийлэх, хянах” үндэсний хөтөлбөр (2014-2021)
- Жагсаалт, шалгуур үзүүлэлт, заавар, маягт батлах тухай (ЭМС, ХНХС-ын 2018 оны А/69, 48 дугаар хамтарсан тушаал)
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрэм (ЗГ-ын 2016 оны 200 дугаар тогтоол)
- Түрээсийн орон сууцны хөтөлбөр (Засгийн газрын 2015 оны 248 тогтоол)
- “Нийтийн тээвэр Замналын зогсоол. Ангилал. Техникийн шаардлага” MNS 5879-2012
- “Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам.Техникийн шаардлага” MNS 5682:2006
- “Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар” MNS 6056:2009
- Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин. Үндсэн шаардлага” MNS 6055:2009
- “Нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолын төлөвлөлт” БД 32-101-17
- Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих журам (ЗГ-ын 2017 оны 197 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт)

- Хөгжлийн бэрхшээлтэй хүн бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээний журам, төрөл, хэлбэр, үйлчилгээ үзүүлэх байгууллагад тавигдах шаардлага (НХХЯ-ны сайдын 2017 оны А/184 тушаал)
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үнэмлэхийн загвар, түүнийг олгох журам (НХХЯ-ны сайдын 2017 оны А/109 тоот тушаал)

Гурав. Олон улсын гэрээ:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенц
- Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын конвенц
- Боловсролын салбарт ялгаварлан гадуурхахын эсрэг тэмцэх тухай конвенц
- Саламанкагийн тунхаглал 1994 он
- Дакарын үйл ажиллагааны төлөвлөгөө “Бүх нийтийн боловсролын талаар гаргасан баримт бичиг” 2000 он.
- Биеийн үйлдэл, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангилал, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага 2001 он
- Хамт олонд түшиглэсэн сэргээн засах хандлагын Удирдамж” ДЭМБ, НҮБ-ын БШУСБ, ОУХБ, Хөгжил, хөгжлийн бэрхшээлийн олон улсын консерциум 2010
- Хамт олонд түшиглэн сэргээн засах хандлагын дэлхийн анхдугаар чуулганаас гаргасан “АГРА Тунхаглал” 2012 он
- Ази, Номхон далайн бүсийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан “Эрхийг бодит болгоё” Инчоно стратеги 2012 он
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай Олон улсын Хөдөлмөрийн байгууллагын 155 дугаар конвенц
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай олон улсын Хөдөлмөрийн байгууллагын 155 дугаар конвенцын 164 дүгээр зөвлөмж
- Тахир дутуу хүмүүсийн мэргэжлийн нөхөн сэргээлт, хөдөлмөр эрхлэлтийн тухай олон улсын Хөдөлмөрийн байгууллагын 159 дүгээр конвенц
- Тахир дутуу хүмүүсийн мэргэжлийн нөхөн сэргээлт, хөдөлмөр эрхлэлтийн тухай олон улсын Хөдөлмөрийн байгууллагын 159 дүгээр конвенцын 168 дугаар зөвлөмж

Дөрөв. Ном, гарын авлага:

- Б.Чимид. Үндсэн хуулийн үзэл баримтлал. УБ., 2 дахь хэвлэл
- Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Дэлхийн банк. Хөгжлийн бэрхшээлийн талаарх дэлхийн тайлан.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын анхдугаар илтгэл. УБ., 2011 он
- Монгол Улсын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хэрэгжилт. 2014 он
- Хүүхдийн эрхийн конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын 5 дугаар тайланд өгсөн дүгнэлт, зөвлөмж, 2017 он
- ХНХЯ, JICA. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа. УБ., 2017 он

- Ц.Товуусүрэн, П.Амаржаргал, Б.Мөнхцэцэг, А.Пагма, Б.Хатантуул. Хөдөлмөр эрхлэлтийн тухай хуулинд энгийн иргэд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар тусгасан байдал. УБ., 2011 он
- Р.Хатанбаатар, А.Пагма, Д.Жигваагүнсэл, Р.Нургүл. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зарим эрхийг хэрэгжүүлэхэд төрөөс үзүүлэх дэмжлэг, хөнгөлөлтийн эрх зүйн зохицуулалтын талаарх гадаад орнуудын туршлага. УБ., 2014 он
- Ц.Норовдондог, И.Жаргалзаяабямба, О.Нарантуяа. Монгол Улс дахь хүүхэд хөгжил, хүүхдийн эрх хамгааллын эрх зүйн орчин, бодлогын хэрэгжилтийн өнөөгийн байдал. УБ., 2018 он
- Ц.Норовдондог, Г.Билгээ, О.Нарантуяа, Р.Нургүл. Хүүхдийн эрх хамгааллын эрх зүйн орчин, тогтолцоо ба хэрэгжүүлэх механизмын талаарх гадаадын зарим орны туршлага. УБ., 2018 он
- НҮБ-ын Хүүхдийн сан. Хүүхдийн эрүүл мэндэд агаарын бохирдлын үзүүлэх нөлөө, шийдвэрлэх арга зам. УБ., 2016 он
- ХНХЯ, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар Хөгжлийн бэрхшээл судлал нь салбар дундын шинжлэх ухаан болох нь-2018 сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ., 2018 он

МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮҮХЭД ХӨГЖИЛ, ХҮҮХДИЙН ЭРХ ХАМГААЛЛЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН, БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

(Мэдээлэл, лавлагаа)

И.Жаргалзаяабямба, О.Нарантуяа

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Нэг. Монгол Улсын хүүхэд хөгжил, хамгааллын эрх зүйн орчин

1.1.Хуулиуд

1.2.Бодлогын баримт бичиг, Засгийн газрын хөтөлбөрүүд

Хоёр. Хүүхдийн эрхийн өнөөгийн байдал, хэрэгжүүлж буй арга хэмжээ, олон улсын байгууллагын зөвлөмж

2.1.Хүүхдийн эрхийн үндсэн зарчмын хүрээнд

2.2.Иргэний эрх, эрх чөлөө

2.3.Хүүхдийн эсрэг хүчирхийлэл

2.4.Гэр бүлийн орчин ба хүүхдийн асрамж, халамжийн үйлчилгээ

2.5.Эрүүл мэнд ба нийгмийн халамж

2.6.Тусгай хамгааллын арга хэмжээ

Гурав. Цаашид авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээ

Дөрөв. Нийгмийн халамжийн сангаас хүүхдэд олгох зарим тэтгэмж тусламж, хөнгөлөлтийн хэмжээ

Тав. Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас хүүхэд хамгаалал, аюулгүй байдлын чиглэлээр хийсэн ажлын талаар

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

ОИН.МН
СУДАЛГААНЫ САН

Товчилсон үгийн жагсаалт:

АШУУИС	Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их сургууль
БСШУСЯ	Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын яам
ГБХЗХГ	Гэр бүл, Хүүхэд Залуучуудын Хөгжлийн газар
ГХЯ	Гадаад хэргийн яам
МХЕГ	Мэргэжлийн Хяналтын Ерөнхий газар
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ОУБ	Олон Улсын Байгууллага
ОУХБ	Олон Улсын Худалдааны Байгууллага
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
СЭМҮТ	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв
ХНХЯ	Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам
ХЭҮК	Хүний Эрхийн Үндэсний Комисс
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ЭМЯ	Эрүүл мэндийн яам

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Энэхүү мэдээлэл лавлагааг НҮБ-ийн Хүүхдийн эрхийн тухай конвенц, түүний хэрэгжилтийн талаарх тайлан болон НҮБ-ын Хүүхдийн хорооноос Монгол Улсын Засгийн газарт өгсөн дүгнэлт, зөвлөмж болон хүүхэд хөгжил, хүүхдийн эрх хамгааллын чиглэлээр ажилладаг төрийн болон төрийн бус байгууллагууд, олон улсын байгууллагуудаас гаргасан тайлан мэдээлэл, холбогдох судалгаанд үндэслэн тоймлон гаргав.

Монгол Улсад хүүхэд хөгжил, хамгааллын асуудлыг Монгол Улсын Үндсэн хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Боловсролын багц хуулиуд, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хууль, Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль болон холбогдох бусад эрх зүйн актуудын хүрээнд зохицуулж байна.

Нийгэм хурдацтайгаар хувьсан өөрчлөгдөж буй цаг үед хүүхэд тэвчишгүй хөдөлмөр эрхлэх, цахим орчинд донтох, гэр бүлийн орчинд болон цэцэрлэг, сургууль, асран хүмүүжүүлэх газар, сургуулийн дотуур байр, ажлын байр, гудамж талбайд бие махбод, сэтгэл санааны, бэлгийн болон үл хайхрах хүчирхийлэлд өртөх тохиолдол гарсаар байна. Хүүхдийн эрхийн эдгээр зөрчлийг арилгах, таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэхэд дан ганц хууль эрх зүйн орчныг сайжруулах нь хангалтгүй бөгөөд хүүхэд болон насанд хүрэгчид, үүрэг хүлээгчдийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, нийгмийн тогтсон хандлагыг өөрчлөх, зөв дадал, зан үйлийг хэвшүүлэх шаардлага тулгарсан хэвээр байна.

Мөн амьдралын ялгаатай хэв маяг үүсч байгаагаас улбаалан хүүхэд, өсвөр үеийнхний дунд амьдралын түвшин, гарал үүсэл, боловсрол, гадаад байдал, хөгжлийн бэрхшээл зэргээс шалтгаалсан тэгш бус байх, ялгаварлан гадуурхагдах тохиолдол байсаар байна.

Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль зэрэг гол гол хуулиуд санхүү, арга зүй, хүний нөөцийн дутагдалтай байдлаас шалтгаалан үр ашигтай хэрэгжиж чадахгүй байна гэсэн дүгнэлтийг олон улсын байгууллагаас Монгол Улсад өгсөн байна. Тухайлбал:

Хүүхэд амьд явахын эрхийн хүрээнд Засгийн Газар хүүхэд бүрийг эсэн мэнд амьдрах, хөгжих бололцоогоор дээд зэргээр хангах үүрэгтэй ч төрөөс хүүхдийн хөгжил, хамгааллын талаар хууль, эрхзүйн орчныг бүрдүүлэн, тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа хэдий ч аюулгүй ажиллагааны дүрэм журам, стандарт мөрдөөгүй, үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, иргэд болон эцэг эхчүүдийн үүрэг хариуцлага сул, тэдний хайхрамж болгоомжгүй байдлаас шалтгаалан хүүхдүүд осол, гэмтэлд өртөх зэргээр эрүүл мэнд, амь насаараа хохирсоор байна.

Тухайлбал: 2018 оны эхний 7 сарын байдлаар гэмт хэргийн халдлагад 1028 хүүхэд өртөж хохирсон нь өмнөх оны мөн үеэс 144 нэгжээр буюу 16.3 хувиар өссөн²¹⁷.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас 13 хүүхэд хохирч, 355 хүүхэд бэртэж, гэмтсэн бол 55 хүүхэд нас барсан байна. Зам тээврийн осол, гэмтэл 0-5 хүртэлх насны хүүхдийн 3 дахь шалтгаан, 6-18 насны хүүхдийн 2 дахь гол шалтгаан болж байна. 2018 он гарсаар зам тээврийн ослын улмаас 304 хүүхэд гэмтэж, 4 хүүхэд нас барсан байна.

Хүүхэд амьд явах эрхийн хүрээнд хүүхэд хамгааллын үйлчилгээг боловсронгуй болгох зорилгоор хүүхдийн эрх ба бизнесийн зарчимд суурилсан **“Хүүхэд хамгааллын даатгалын үйлчилгээ”**-г нэвтрүүлсэн байна. Энэхүү даатгалын үйлчилгээг нэвтрүүлснээр даатгалын тохиолдол үүсэх буюу хүүхэд ор сураггүй алга болох, бүх төрлийн хүчирхийлэлд өртсөн тохиолдолд эрэн хайх, эрүүл мэндийг нөхөн сэргээх, тээвэрлэх, аюулгүй байдлыг хангах, хууль шүүхийн шатанд эрх зүйн туслалцаа үзүүлэх өмгөөлөгчийн зардал зэргийг даатгалын компаниар нөхөн төлүүлэх боломжтой болох юм.

Хүүхэд мэдээлэл олж авах эрхийн хүрээнд Сүүлийн жилүүдэд зөвхөн манай улс төдийгүй дэлхийн бүх улс оронд хүүхдүүдийн интернетийн хэрэглээ өсч байгаагаас үүдэн сөрөг нөлөө нь нэмэгдэж байгаад бүх нийтээрээ анхаарал хандуулах нөхцөл байдал бий болоод байна.

Манай улсын хувьд хүүхэд, өсвөр үеийнхнийг дэлгэцийн донтолт болон цахим орчны гэмт хэрэг, хүчирхийлэл, дарамтаас урьдчилан сэргийлэх, мэдээллийн технологийн зохистой хэрэглээг дэмжих чиглэлээр “Мэдээллийн технологийн зохистой хэрэглээг бий болгох, цахим орчин дахь хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх” чиглэлээр авах арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж байна. Төлөвлөгөөний 3 зорилтын хүрээнд нийт 28 арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Их Хурлаас 2018 оны 5 дугаар сард Цахим бодлогын түр хороо байгуулсан бөгөөд энэ хороо нь нийгмийн сүлжээнд хүний эрх, ялангуяа хүүхдийн эрх хэрхэн зөрчигдөж байгаад судалгаа, дүгнэлт хийж, хүүхдийн аюулгүй байдлыг хангах, хүүхдийн эрүүл мэнд, бие махбод, оюун санаа, ёс суртахууны хөгжил, төлөвшилд сөрөг нөлөө бүхий мэдээллээс тэднийг хамгаалахад олон нийтийн

²¹⁷ ЦЕГ-ын Мэдээллийн сан

оролцоог идэвхжүүлэх чиглэлээр ажиллаж байна.

Хүүхдүүд цахим тоглоомонд донтох, гэмт хэрэг зөрчилд холбогдох зэрэг эрсдэлд өртөх нь эцэг эхчүүдийн хариуцлагатай холбоотой боловч хүүхэд, гэр бүлийн хөгжлийг дэмжих, хүүхэд чөлөөт цагаа өнгөрүүлэхэд зориулсан биеийн тамирын талбай, тоглоомын төв, усан бассейн, спортын цогцолбор, хүүхдийн ордон зэрэг газрууд хомс байгаатай бас холбоотой байна.

Хүүхдийн эсрэг хүчирхийллийн хүрээнд Хүүхдийн эсрэг хүчирхийлэл нь нийгэм, сэтгэл зүйн хохирол амсах, хүчирхийллийг хүлээн зөвшөөрөх, эрт бэлгийн харилцаанд орох, сэтгэл зүйн дарамтад орох, ой тогтоолт нь буурах, эмх цэгцээ алдах, хий юм үзэх, түрэмгий зан авиртай болох, уушиг, зүрх, элэгний өвчлөл, бэлгийн замаар дамждаг өвчнүүд, үр зулбах гэх мэт сөрөг үр дагавруудтай.

Бие махбодийн буюу биеийн шийтгэл нь олон хэлбэртэй байдаг бөгөөд биеийг тавгуйтүүлэх зорилгоор үйлдэгдэх биеийн хүчээр үзүүлж буй аливаа шийтгэлийг хэлнэ. Үндэсний статистикийн хорооноос 2010-2014 оны хооронд хийсэн судалгаанаас үзэхэд, 2-14 насны хүүхдийн 45-47% нь гэр бүлийн аль нэг гишүүний зүгээс үзүүлэх биемахбодийн шийтгэл амсдаг гэсэн дүн гарчээ.

Бие махбодийн шийтгэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Хүүхдийг эерэг аргаар хүмүүжүүлэе үндэсний аян”-ыг 21 аймаг, 9 дүүрэгт өрнүүлж 1628 сургагч багш бэлтгэж, 8240 боловсролын байгууллагын ажилтан, 53,650 эцэг эхчүүдэд сургалт зохион байгуулж, зөвлөгөө мэдээлэл, нөлөөллийн ажил хийгдэж байна

Сургууль, цэцэрлэг, асрамж, халамжийн байгууллагын орчинд хүүхэд хүчирхийлэлд өртөх явдал буурахгүй байна. Сургууль, цэцэрлэгийн орчинд хүүхэд хүчирхийлэлд өртөх шалтгаан нөхцөл маш олон талтай хэвээр байна.

Манай улсын хувьд сүүлийн жилүүдэд хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн тоо өсч, үүний дотор ураг төрлийн хүчирхийлэл нэмэгдсэн байна. Цагдаагийн байгууллагын тоо мэдээгээр 2015-2017 онд хүчиндэх гэмт хэргийн улмаас 950 хүн хохирсоны 936 эмэгтэй, 14 эрэгтэй хүн байна. Энэ хугацаанд 6 хүний амь нас хохирч, 262 хүн гэмтсэн ба нийт хохирсон хүмүүсийн 469 буюу 49,4% нь 18 хүртэлх насны хүүхэд байна²¹⁸.

“Хүчиндэх” гэмт хэрэгт сэжиглэгдэн шалгагдсан хүмүүсийн 97 буюу 10.1% нь “Ураг төрлийн хамааралтай” хүмүүс бөгөөд тэдний 44.3% нь хойд эцэг, 18.5% нь төрөл садангийн хүн, 12.3% нь төрсөн эцэг, 10.3% нь хүргэн нь байна.

Эрүүл мэндийн байгууллагын мэдээллээр 2017 онд хүчирхийллийн шалтгаанаар эмнэлгийн тусламж, үйчилгээ авсан нийт 17.309 тохиолдлын 1835 тохиолдол буюу 10.6 хувь нь хүүхэд байжээ. Харин гэмтэл согог судлалын үндэсний төвд 2017 онд гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн нийт 910 үйлчлүүлэгч үйлчлүүлснээс 299 нь 0-16 насны хүүхэд байжээ.²¹⁹

Гэр бүлийн орчны хүрээнд Монгол Улсын хүн ам 2017 оны урьдчилсан дүнгээр 3,2 сая болж, нийт өрхийн тоо 885,639 мянган гэр бүл бүртгэлтэйгээс 2017 онд шинээр 20470 хос гэрлэлтээ бүртгүүлж, 3945 гэр бүл цуцалсан байна. Өмнөх онтой

²¹⁸ ЦЕГ-ын мэдээллийн сан

²¹⁹ Асуулгын хариу, ХЗДХСайд, 2018.05.18

харьцуулахад гэрлэлт 22 хувиар өсөж, цуцлалт 3,4 хувиар буурсан байна.² Улсын хэмжээнд гэр бүлд зөвлөгөө өгөх 14 төв, танхим ажиллаж зөвлөгөө мэдээлэл өгч байна.

Гэр бүлийн хөгжлийг дэмжих үйлчилгээний хүрээнд “Гэр бүлийг дэмжих туршилтын хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж байна.

Гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийллийг эрт үед илрүүлэх, таслан зогсоох, нөхөн сэргээх үйлчилгээнд хохирогч бүрийг хамруулах, тохиолдол бүрт үзүүлэх илрүүлэлт, нөхцөл байдлын үнэлгээ, тусгай хамгаалалт, сэтгэл зүйн болон хууль зүйн зөвлөгөө, үйлчилгээг үнэ төлбөргүй болгоход хөрөнгө санхүүгийн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.

Асрамжийн үйлчилгээний хүрээнд: 2018 оны 6 дугаар сарын байдлаар Монгол Улсад 31 асрамж, халамжийн төвд 1013 хүүхэд амьдарч байна.

Нийслэлийн Цагдаагийн газар болон Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас эцэг эхийн хараа хяналт сул хүүхдийг илрүүлэх арга хэмжээг тогтмол зохион байгуулж, хүүхдүүдийг эцэг эх, асран хамгаалагчид нь хүлээлгэн өгөх, шаардлагатай тохиолдолд хамгаалах байр, халамж, асрамжийн төвүүдэд байршуулж, удаан хугацаагаар тэнэсэн гэр бүлдээ очих боломжгүй хүүхдүүдийг “Хараа хяналтгүй хүүхдийг нийгэмшүүлэх төв”-д байрлуулан нийгэм, сэтгэлзүйн нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлж байна.

Цаашид хүүхдийн хөгжил, хамгааллыг гэр бүлд түшиглэн хэрэгжүүлэх бодлогын хүрээнд төрийн зайлшгүй асрамж, халамж шаардлагатай хүүхдийг төвлөрсөн асрамжийн газарт биш гэр бүл, түүнтэй дүйцэх орчинд төрөл садны болон асралт гэр бүлд өсгөн хүмүүжүүлэх бодлого баримталж, тус үйлчилгээнд шаардагдах хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийн асуудлаар дэлхий нийтийн хэмжээнд үл хүндлэл, ялгаварлан гадуурхалтад хамгийн ихээр өртөн, нийгмийн амьдралаас тусгаарлагдсан хүмүүсийн тоонд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд багтдаг байна. Монгол Улсын нийт хүн амын 36.2 хувийг 0-18 хүртэлх насны хүүхэд эзэлж байгаа бөгөөд үүнээс 11.435 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байна.

Улсын Их Хурлаас 2016 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг батлан гаргасан нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эрх ялангуяа сурч боловсрох эрхийг баталгаажуулж, тэдний амьдрах орчныг сайжруулах, нийгмийн халамж үйлчилгээний талаар нарийвчлан зохицуулж өгсөн.

Хөгжлийн бэрхшээлтэй 2-5 насны хүүхдийн сурч хөгжих эрхийг хангах асуудал хүндрэлтэй асуудлын нэг байсаар байна. Монгол Улсад ганцхан байдаг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг хүлээн авдаг 10 дугаар цэцэрлэгийн барилгыг шинээр барих асуудал 5 дах жилдээ шийдэгдэж чадаагүй л байна. 2018 оны 6 дугаар сард Засгийн газраас цэцэрлэгийн барилгыг 5.3 тэрбум төгрөгөөр барихаар шийдвэрлэсэн боловч ахиц гарсан зүйл байхгүй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын энгийн ангид сургах асуудлыг хүндрэлтэй асуудал хэвээр байна. Ихэнх багш хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ангидаа авч сургахдаа амжилттай сургаж чадна гэдэгт эргэлздэг. Энэ нь энгийн сургуульд ажиллаж буй багш нарын хандлага, ойлголт, заах арга эзэмшсэн

байдал, ур чадвартай нь холбоотой юм.

Манай улсад хөгжлийн бэрхшээлтэй хэдэн хүүхэд хаана, хэнтэй хэрхэн амьдарч буй талаар нэгдсэн тоо баримт өнөөг хүртэл байдаггүй. Төрийн байгууллагуудаас гаргасан статистик мэдээллүүд ч өөр хоорондоо зөрүүтэй байна.

Тухайлбал, улсын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд суралцдаг зургаан тусгай сургууль байдаг ч эдгээр сургуульд нийт 1700 орчим хүүхэд суралцдаг.

Хүүхдийн боловсролын хүрээнд Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд 2018 онд боловсролын салбар дахь хүүхэд хамгааллын асуудалд анхаарал хандуулж, хүүхдийн эрхийн зөрчил, хүүхдийн эсрэг хүчирхийллийг бууруулах, хүүхдийн хөгжил, оролцоог дэмжих, багш, эцэг эхийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, хүүхдэд ээлтэй сургалтын орчин нөхцөлийг сайжруулахад чиглэсэн **“Хүүхэд хамгааллын жишиг сургууль”** загварыг улсын хэмжээнд ерөнхий боловсролын 31 сургууль дээр 2018-2019 оны хичээлийн жилд хэрэгжүүлж байна.

2017-2018 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 729 сургуульд 572,8 мянган хүүхэд суралцаж байна. ЕБС-ын дотуур байранд 35,2 мянган хүүхэд суралцаж байгаагийн 73% нь малчдын хүүхэд байна.

Улаанбаатар хотын хувьд цэцэрлэггүй 21 хороо байна. Улсын хэмжээнд цэцэрлэгт хамрагдалт 74.6 хувь, нийслэлд 76 хувьтай байна. Цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байгаа 73500 хүүхэд байна.

Хүүхдийн хөдөлмөрлөх эрхийн хүрээнд Хүүхдийн хөдөлмөр нь сурч боловсрох, эрүүл байх боломжийг үгүйсгэж, ядуурлыг гүнзгийрүүлж байдаг тул хүний үндсэн эрхийн зөрчил гэж үздэг.

Хүүхдийг хэт эрт хөдөлмөр эрхлэхээс сэргийлэхийн тулд ОУ-ын Хөдөлмөрийн байгууллагын 138-р конвенцод хөдөлмөрийн насны доод хязгаарыг заавал эзэмших боловсролыг бүрэн эзэмших наснаас багагүй буюу ямар ч тохиолдолд 15 наснаас багагүй байхаар тодорхойлсон байна.

Монгол Улс 2001 онд нэгдсэн орсон 1999 оны Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн тухай конвенцын 3 дугаар зүйлд Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг тодорхойлжээ. Засгийн газраас 2011 онд Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хүнд хэлбэрийг устгах үндэсний хөтөлбөрийг баталсан.

Өнөөгийн байдлаар уул уурхай, хөдөө аж ахуй, барилга, тээвэр, зочид буудал, боловсруулах үйлдвэр зэрэг 11 салбарын 79 ажлын байрыг хүүхэд эрхэлж болохгүй, хүнд ажлын байранд тооцдог.

Ажил эрхэлж байгаа арван хүүхдийн найм нь хөдөө аж ахуйн салбарт, нэг нь бөөний болон жижиглэн худалдаа, засвар үйлчилгээний газарт ажиллаж байна. Мөн 15-17 насныхан уул уурхай, олборлолт, боловсруулах үйлдвэрт ажиллаж байна. Судалгааны тархалтын тооцоогоор 5-17 насны 1857 хүүхэд өрхөөс гадуур эдийн засгийн ажиллагаа эрхэлж байх бөгөөд тэдний 65,4 хувь нь сургуульд сурдаг байв. Ажил эрхэлдэг нийт хүүхдийн 2,0 хувь цалин хөлстэй ажил эрхэлж байна. Эдгээр хүүхдийн 11.1 хувь хүнд хортой болон аюултай ажил хийж байна.

Уралдаанч хүүхэд: Хурдны морь унаж уралдах нь хүүхдийн хөдөлмөр төдийгүй

хөдөлмөрийн мөлжлөгийн хэлбэр гэж НҮБ-ийн Хүүхдийн хороо үзсэн байна.

Унаач хүүхдийн дийлэнх нь амьжиргааны түвшин доогуур айлын хүүхэд байдаг. Эхчүүдийн боловсролын түвшин, өрхийн амьжиргааны түвшин дээшлэх тусам хүүхэд хурдан морь унах нь буурах хандлагатай байна. Хурдан морь унаач хүүхдийн нийгмийн хамгааллын асуудлын нэг хэсэг нь ослын даатгал болон морины эзэнтэй хийх гэрээ, урамшуулал юм.

Тиймээс хурдан морины уралдаанч хүүхдийн гэнэтийн ослын даатгалын нөхцөлийг сайжруулж, даатгалын хураамжийг 100,000 төгрөг болгож, 20,0 хүртэл сая төгрөгийн нөхөн олговрыг олгуулах асуудлаар Санхүүгийн зохицуулах хороо, даатгалын компаниудтай хамтран ажиллаж байна.

2018 онд хурдан морины уралдаанч хүүхдийг био сканаар бүртгэж, мэдээллийг цахим бүртгэлд оруулах ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулсан.

Бэлгийн мөлжлөг болон хүчирхийлэл: 2010–2014 онд бэлгийн мөлжлөг, хүүхдийг хил дамнуулах худалдаалах асуудлаар 8 төрлийн судалгаа хийж, үр дүнг нь холбогдох байгууллага олон нийтэд мэдээлсэн байна.

Хүний наймааны төрөл, хэлбэрийн хувьд бэлгийн мөлжлөг болон хуурамч гэрлэлтийг хамгийн түгээмэл хэлбэр гэж үзсэн байна. “Өсвөр насны хүүхдийн садар самуун, бэлгийн мөлжлөгт өртөж буй талаарх судалгаа”-аар оролцогчдын 41,6 хувь нь 20-24 насны, 34,7 хувь нь 15-19 насныхан буюу залуу, өсвөр насны хүүхэд ихэвчлэн хүний наймааны гэмт хэрэгт өртөж байна гэж үзсэн байна.

Мөн уран нугаралтын үзүүлбэрээр хилийн чанадад гэрээгээр ажиллах явцдаа хөдөлмөрийн мөлжлөг, хүний наймаанд өртөх эрсдэлтэй байдалд орсон үед гадаад дахь Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газрууд, Эрүүгийн цагдаагийн газар хамтран ажиллаж, хүүхдийг эх оронд нь буцаасан тохиолдол ч гарсаар байна.

2009 оноос Хил хамгаалах ерөнхий газар “Хүүхэд, эрх зүйн чадамжгүй хүнийг улсын хилээр нэвтрүүлэх журам”-ыг нарийвчлан боловсруулж 7-оос доош насны хүүхдийг зөвхөн эцэг эх буюу хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хамт улсын хилээр нэвтрүүлэхээр болсон. Энэ нь бага насны хүүхдийг хүний наймаанд өртөхөөс урьдчилан сэргийлэх нэг хэлбэр юм.

2012 онд шинэчлэн найруулсан Нийгмийн халамжийн тухай хуулийн дагуу хүчирхийлэлд өртсөн иргэнд халамжийн үйлчилгээ үзүүлж байна.

Хууль зөрчсөн болон гэрч, хохирогч хүүхэд: Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйл, Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны журмын дагуу хууль зөрчсөн, гэмт хэргийн гэрч, хохирогч болсон хүүхдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх чиг үүрэгтэй салбар дундын “Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо” байгуулагдан ажиллаж байна.

Хүүхдийн эрхийн хэрэгжилтэд хяналт тавих, Зөрчлийн тухай хуульд заасан хүүхдийн эсрэг 16 төрлийн зөрчлийг шалган шийдвэрлэх чиг үүрэгтэй ажиллах хүүхдийн эрхийн байцаагчийг хуульд заасны дагуу сонгон шалгаруулж, сургалтад хамруулан, 32 албан хаагчид Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн эрх олгосон.

Хууль зүйн туслалцааны төв нь ажлын алба, 32 салбартайгаар улсын хэмжээнд хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааг явуулж байна.

Насанд хүрээгүйчүүдийн хорих ангийн дэргэд 2000 оноос хойш ажиллаж байсан хөдөлмөрийн төрөлжсөн сургалттай суурь боловсрол олгох тусгай сургуулийг 2013 оноос бүрэн дунд сургууль болгон өөрчилж, ял эдэлж байгаа хүүхэд боловсролоо үргэлжлүүлэн эзэмших эрх бүрэн хангагдах нөхцөлийг бүрдүүлж суурь болон бүрэн дунд гэрчилгээ олгодог боллоо. Мөн ял эдэлж байгаа хүүхдийг мэргэжлийн сургалтад хамруулж, сүүлийн арваад жилд 539 хүүхэд суралцаад байна.

Хүүхдийн тусламжийн утас-108: Засгийн газрын 2016 оны 55 дугаар тогтоолоор Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дэргэд “Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв”-ийг байгуулж, сард дунджаар 10 мянга гаруй дуудлага хүлээн авч, хүүхэд өсвөр үеийнхэнд зөвлөгөө, мэдээлэл өгч, хүүхэд хамгааллын шуурхай тусламж үзүүлэн ажиллаж байна. Уг төв нь 2017 онд хүүхдийн эрх, хамгаалалтай холбоотой 4490 тохиолдлыг, 2018 оны 2 дугаар улирлын байдлаар 1320 тохиолдлыг аймаг орон нутгийн гэр бүл, хүүхэд залуучуудын газар /хэлтэс/, хамтарсан багт шилжүүлсэн байна. Мөн “Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ түр хамгаалах байр”-ыг Засгийн газрын 2017 оны 231 дүгээр тогтоолоор байгуулж, байгуулагдсанаас хойш 0-18 хүртэлх насны 561 хүүхдийг хүлээн авч, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлсэн байна.

Нийгмийн халамжийн сангаас хүүхдийн эрхийг хангах, хамгаалах, гэр бүлд дэмжлэг, туслалцаа үзүүлэх асуудлыг Нийгмийн халамжийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хууль, Засгийн газрын 2017 оны 18 дугаар тогтоолоор батлагдсан “Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох журам”-аар тус тус зохицуулж байна. Дээр хууль тогтоомжийн хүрээнд хүүхэд, гэр бүлд 17 төрлийн тэтгэмж, хөнгөлөлт, чөлөөлөлтийг олгож байна.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газар нь хүүхдийн эрхийг хамгаалах асуудлаар хяналт тавих эрх бүхий төрийн байгууллагуудын нэг бөгөөд тус бүрэн эрхийнхээ хүрээнд өөрийн харьяалах асуудлуудаар хяналт шалгалтын ажлыг шат дараатай хэрэгжүүлж байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, тусгай хяналтын газар болон Эрүүл мэнд, боловсрол, соёлын хяналтын газраас хүүхэд хамгаалал, аюулгүй байдлын чиглэлээр дараах хяналт шалгалт, тандан судалгааг хийж гүйцэтгэсэн байна.

- Унаач хүүхдийн асуудлаар Улсын хэмжээнд зохион байгуулагдсан үндэсний баяр наадмын хурдан морины уралдааны унаач хүүхдийн аюулгүй байдлыг хангуулах урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг зохион байгуулсан.
- Хүүхдийг тэвчишгүй хөдөлмөрийн асуудлаар Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2018 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу албан бус секторт ажиллаж байгаа хүүхдийн талаарх тандалт судалгаа хийсэн. Судалгаагаар 495 хүүхэд хөдөлмөр эрхэлж байгаагаас бичил уурхайд 20 хүүхэд, худалдаа үйлчилгээ буюу захуудад 82 хүүхэд, барилга угсралтын үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагад 8 хүүхэд, ХАА, газар тариаланд 367 хүүхэд, зам тээврийн салбарт 6 хүүхэд, 12 хүүхэд нь хог хаягдлын цэг болон гудамжинд худалдаа эрхэлж байсан.
- Боловсролын байгууллагын орчны асуудлаар Нийслэлийн засаг даргын 2018 оны 02 тоот албан даалгавраар дүүргүүдийн боловсролын байгууллагатай

хамтран ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, нийтийн эзэмшлийн биеийн тамирын болон хүүхдийн тоглоомын талбайн орчны аюулгүй байдал тэнд ашиглагдаж байгаа хөдөлгөөнт болон хийлдэг тоглоом, тоног төхөөрөмжүүдэд хяналт шалгалтын ажлын хийжээ. Үүнд 44 сургууль, 60 цэцэрлэг, нийтийн эзэмшлийн биеийн тамирын болон хүүхдийн тоглоом талбай 45, тоглоом тоглуулж буй 2 аж ахуйн нэгж байгууллага, 13 иргэний 34 тоглоомын талбайг хамруулсан.

- Хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажлыг шалгахад сургууль, цэцэрлэгийн сургалт, хүмүүжлийн бэлтгэл ажил бүрэн хангагдаагүй. Хөрөнгө санхүү болон шинээр баригдаж буй барилгын чанараас шалтгаалж, сургалтын орчин нөхцөлтэй холбоотой зөрчил өмнөх онтой харьцуулахад 5 хувиар буурсан.
- Хүүхэд өсвөр үеийн эрүүл ахуй, халдвар хамгаалалын чиглэлээр Нэг ангид суралцдаг хүүхдийн дундаж тоо сургуульд 31, цэцэрлэгт 47, хичээлийн танхимын дундаж талбайн хэмжээ сургуульд 47 м.кв, цэцэрлэгт 43 м.кв, сургалтын танхимын дундаж эзлэхүүн сургуульд 142 м.куб, цэцэрлэгт 120 м.куб, 1 хүүхдэд ноогдох талбайн хэмжээ 16 /62%/ сургуулийн 16 ангид бага, 13 цэцэрлэгийн 39 цэцэрлэгт бага байна.
- Сургууль, цэцэрлэгийн ундны усны чанар, аюулгүй байдлын чиглэлээр: Тус шинжилгээнд аймаг, нийслэлийн 379 сургууль, цэцэрлэг хамрагдсан. Ундны уснаас 483 дээж авч хими, нян судлалын шинжилгээнд хамруулахад 18.6%-д нь нянгийн тоо стандартад заасан хэмжээнээс их, 7.2%-д гэдэсний бүлгийн эмгэг төрөгч E.Coli илэрсэн байна. Нийслэлийн сургууль, цэцэрлэгийн усны шаардлага хангаагүй дээжийн 60% нь хэсгийн, 40% нь зөөврийн ус хангамжтай байна.
- Импортын хүүхдийн тоглоомийн талаар: Импортын хүүхдийн тоглоомын хяналт шинжилгээг Замын-Үүд, Алтанбулаг, Буянт-Ухаа хилийн боомт, Улаанбаатар хотын гүний терминалиудаар нэвтрэх үед болон нийслэлд үйл ажиллагаа явуулж буй томоохон зах, худалдааны төв, төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус хяналт шалгалтад хамрагдсан хүүхдийн цэцэрлэгүүдэд хэрэглэгдэж байсан хүүхдийн тоглоомуудыг хамруулсан.
- Өдөр өнжүүлэх, хүүхэд харах үйлчилгээ эрхлэгч байгууллагуудын эрүүл ахуй чиглэлээр: Тандалт судалгаанд аймаг, нийслэлд үйл ажиллагаа явуулж буй 94 өдөр өнжүүлэх бүлэг, 259 хүүхэд харах үйлчилгээ эрхлэгчдийг хамруулсан. Хүүхэд харах үйлчилгээ эрхэлж буй газруудын 82.2 хувь их, дунд эрсдэлтэй, гадна орчин, барилга байгууламжид тавигдах шаардлагын хэрэгжилт 25.9 хувь, усан хангамж, ариун цэврийн байгууламжид тавигдах шаардлагын хэрэгжилт 37.8 хувь, байрны эрүүл ахуйн шаардлагын хэрэгжилт 38.4 хувь, хоол үйлдвэрлэлд тавигдах шаардлагын хэрэгжилт 37.2 хувьтай, дотоод хяналт шалгалтын хэрэгжилт 5.2 хувьтай байгаа нь хамрагдаж буй хүүхдүүдийн дунд халдварт өвчин гарах, дамжин тархах эрсдэл үүсч болзошгүй байна.

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

УДИРТГАЛ

Хүүхэд гэж хэн бэ? Хүүхдийн эрхийн тухай конвенцод тунхагласнаар “тухайн хүүхдэд хэрэглэх хуулийн дагуу тэрээр 18 наснаас өмнө насанд хүрсэнд тооцоогүй бол 18 нас хүрээгүй хүн бүрийг хүүхэд гэнэ²²⁰” гэж тодорхойлсон.

Хүүхэд нь бие даан өөрийгөө хамгаалах, өөрийн хэрэгцээгээ бүрэн хангах чадваргүй бөгөөд тэдэнд эцэг эх, асран хамгаалагчдын анхаарал халамж, хамгаалалт цаг үргэлж хэрэгтэй байдаг. Тиймээс эцэг эх, асран хамгаалагч нь хүүхдийг бүрэн дүүрэн амьдрах, сурч боловсрох, сайн иргэн болоход шаардлагатай дэмжлэг туслалцааг үзүүлэх үүргийг хуулиар баталгаажуулсан байдаг.

Монгол Улсын нийт хүн амын 36.2 хувийг 0-18 хүртэлх насны хүүхэд эзэлж байна. Насны бүлгээр авч үзвэл 0-4 насны 394.514, 5-9 насны 322.575, 10-14 насны 220.429, 15-18 насны 189.661 хүүхэд байна²²¹.

Нийт хүүхдүүдийн дунд бүтэн өнчин 3.400 хүүхэд, хагас өнчин 33.300 хүүхэд, хүүхдийн асрамж халамжийн төвд асран хамгаалуулж байгаа 1.013 хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй 11.435 хүүхэд байна.

Хүүхдийн эрхийн тухай конвенц²²² буюу хүүхдийн эрхийг хамгаалах олон улсын гэрээ нь 1990 онд батлагдсан бөгөөд үүнийг оролцогч бүх улс орнууд хэрэгжүүлэх үүрэгтэй. Конвенц нь хүүхэд бүрийг ЭРХ ЭДЛЭГЧ, харин насанд хүрсэн хүн бүрийг ҮҮРЭГ ХҮЛЭЭГЧ хэмээн тодотгож, хүүхдийн эрхийг хамгаалах үүрэгтэй. 2016 онд батлагдсан Хүүхдийн эрхийн тухай хуульд зааснаар хүүхэд дараах 4 бүлэг эрхийг эдлэх ёстой. Үүнд: эсэн мэнд амьдрах, хөгжих, хамгаалуулах, оролцох гэсэн бүлгүүдэд хүүхдийн эрхийг тусгайлан зааж өгсөн бөгөөд эдгээр эрхүүд нь өөр

Хүүхдийн эрхийг хангах, хамгаалах гэдэг нь тэдний хуульд заасан эрхийг эдлүүлж, түүнийг зөрчихгүй байх, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсэн тохиолдолд тусламж үйлчилгээ үзүүлэх, нөхөн сэргээх, хэвийн орчинд ороход туслах нь асран хамгаалагч, гэр бүл, төрийн байгууллагын үүрэг юм. Хүүхдийн эрхийн тухай хуульд хүүхэд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, бие махбодийн шийтгэл, сэтгэл санааны дарамт, үл хайхрах байдал болон мөлжлөгийн аливаа хэлбэрээс нийгмийн бүх орчинд хамгаалагдах эрхтэй гэж заажээ.

НЭГ. МОНГОЛ УЛСЫН ХҮҮХЭД ХӨГЖИЛ, ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Монгол Улс нь хүүхдийн эрхийн асуудлыг анхааралдаа авсан улс орнуудын тоонд нэлээд дээгүүрт ордог бөгөөд 1989 онд гарсан НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцыг баталсан эхний 10 улсын тоонд ордог. Олон улсын гэрээ, конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлэхийн тулд дотоодын хууль тогтоомжоороо хүүхдийн эрхийг хангах, хамгаалах бүхий л үүргийг Засгийн газар хүлээдэг. Энэхүү үүргийн хүрээнд хүүхэд хөгжил, хүүхдийн эрхийг хангах, хамгаалах чиглэлээр дараах хууль тогтоомжуудыг батлан хэрэгжүүлж байна. Үүнд:

²²⁰ Хүүхдийн эрхийн тухай конвенцын 1 дүгээр зүйл.

²²¹ www.nso.mn

²²² МУ-ын ОУ-ын гэрээ, Хүүхдийн эрхийн тухай конвенц <http://www.legalinfo.mn/law/details/1276?lawid=1276>

1.1.Хуулиуд:

- **Монгол Улсын Үндсэн хууль**²²³ Монгол Улсын Үндсэн хуульд иргэдийн эдлэх эрх, эрх чөлөөг бие даан бүлэг болгон тодорхойлсны дотор амьд явах эрх (16); ажил мэргэжлээ чөлөөтэй сонгож, хөдөлмөрийн аятай нөхцөл, цалин хөлсөөр хангагдах, амрах эрх (16-4); өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, хүүхэд төрүүлэх, асрах, тодорхой нөхцөлд эд, мөнгөн тусламж авах эрх (16-5); эрүүл мэндээ хамгаалах, эмнэлгийн тусламж авах эрх (16-6); сурч боловсрох, ерөнхий боловсролд төлбөргүй суралцах эрх (16-7)-ийг тодорхой заасан байна.
- **Хүүхдийн эрхийн тухай хууль**²²⁴ нь 2016 оны 02-р сарын 05-ны өдөр батлагдсан, 4 бүлэг 22 зүйлтэй. Энэ хуулиар хүүхдийн амьдрах, хөгжих, хамгаалуулах, оролцох 4 бүлэг эрх болон хүүхдийн эрхийг хамгаалах эцэг эхийн үүргийг тодорхойлжээ. Уг хуульд хүүхдийн хувийн орон зайн тухай, хүүхэд хүмүүжүүлэх зарчим, хүүхдийн эрхийг хамгаалах механизм болон өргөдөл гомдол гаргах, хүүхдийн эрхийг хянах, тайлагнах чиг үүргийг нарийвчлан тусгажээ.
- **Хүүхэд хамгааллын тухай хууль**²²⁵ нь 2016 оны 2 дугаар сарын 05-ны өдөр батлагдсан, 6 бүлэг 25 зүйлтэй. Энэ хуулиар нийгмийн бүх орчинд хүүхэд бүрийг хүчирхийлэл, дарамт, мөлжлөг, үл хайхрах байдал, эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хариу үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан. Мөн хүүхэд хамгааллын тогтолцоо, оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлон заажээ. Хүүхэд хамгаалах байгууллагуудыг хуулийн 3 дугаар бүлгийн 11-16 дугаар зүйлд Улсын Их Хурал, Засгийн газар, нутгийн өөрөө удирдах байгууллага, Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллага, Хүүхдийн төлөө үндэсний болон орон нутгийн зөвлөл, 4-р бүлгийн 17-р зүйлд бүх шатны Засаг дарга, иргэн, хуулийн этгээд хэмээн тодорхойлсон.
- **Гэр бүлийн тухай хууль**²²⁶ нь 1999 онд батлагдсан 9 бүлэг, 76 зүйлтэй. Тус хуулиар эцэг, эх, хүүхдийн хоорондын харилцаа, хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах, хүүхдээ хүмүүжүүлэх эцэг, эхийн эрх, үүрэг, эцэг, эх байх эрхийг хязгаарлахтай холбоотой харилцаа, тэжээн тэтгэх болон тэтгүүлэх эрх, үүрэг, хариуцлага, хүүхэд үрчлэх, үрчлүүлэх, хүүхдийг гэр бүлдээ авч асран хүмүүжүүлэхтэй холбоотой харилцааг нарийвчлан зохицуулсан.
- **Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль**²²⁷ нь 2017 оны 12-р сарын 26-ны өдөр батлагдсан, 6 бүлэг, 47 зүйлтэй. Энэ хуулиар гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, түүнийг таслан зогсоох, хохирогч болон түүний гэр бүлийн бусад гишүүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоосон. Мөн гэр бүлийн хүчирхийллийн хэлбэр, түүнийг хориглох, хохирогчийг хамгаалах, гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох, мэдээллэх, хүүхдийг хүчирхийллээс хамгаалах, тусгай хамгаалтад хамруулах

²²³ Монгол Улсын Үндсэн хууль <http://www.legalinfo.mn/law/details/367>

²²⁴ Хүүхдийн эрхийн тухай хууль, Хуулийн вэб сайт, 2016 <http://legalinfo.mn/law/details/12393>

²²⁵ Хүүхэд хамгааллын тухай хууль, Хуулийн вэб сайт, 2016 <http://legalinfo.mn/law/details/12393>

²²⁶ Гэр бүлийн тухай хууль <http://www.legalinfo.mn/law/details/226>

²²⁷ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль <http://legalinfo.mn/law/details/12393>

зэрэг нөхцөл байдлын үнэлгээ, хохирогчдод үзүүлэх үйлчилгээний төрөл хэлбэрийг тодорхойлжээ.

- **Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль**²²⁸ нь 2015 оны 7 дугаар сарын 2-ны өдөр батлагдсан, 8 бүлэг 17 зүйлтэй. Энэ хуулиар эрүүл аюулгүй орчинд хүүхэд харах үйлчилгээг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулна. Уг хуулинд баримтлах зарчим, тавигдах шаардлага, зохион байгуулалт, санхүүжилт, хүүхэд харагчийн эрх, үүрэг, эрхлэх зөвшөөрөл, түтгэлзүүлэх, хяналт тавьж хариуцлага тооцох механизм зэргийг тусгажээ.
- **Нийгмийн халамжийн тухай хууль**²²⁹ нь 2012 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр шинэчлэн батлагдсан. Тус хуулиар нийгмийн халамж шаардлагатай хүүхдүүд болон тэдэнд олгох нийгмийн халамжийн үйлчилгээний төрөл, түүний дотор олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний талаар болон хамрагдах субъектийг хуульчилж өгсөн. Нийгмийн халамжийн үйлчилгээ шаардлагатай хүүхдүүдэд энэ хуульд заасан тэтгэвэр, тэтгэмжийг Нийгмийн халамжийн байгууллагаар дамжуулан төрөөс олгож байна.
- **Боловсролын тухай хууль**²³⁰ нь 2002 оны 5 дугаар сарын 03-ны өдөр батлагдсан. 7 бүлэг, 48 зүйлтэй. Боловсролын зорилго, иргэний сурч боловсрох үндсэн эрх, үүрэг, боловсролын хөтөлбөр, агуулга, боловсролын байгууллага түүний тогтолцоо, боловсролын сургалтын байгууллага байгуулах, тусгай зөвшөөрөл олгох тухай, боловсролын удирдлагын тогтолцоо, бүрэн эрх, санхүүжилт, боловсролын харилцаанд оролцогч багш, суралцагч, эцэг эх, асран хамгаалагч, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг, хүлээх хариуцлагын талаар нарийвчлан зохицуулсан.
- **Бага, дунд боловсролын тухай хууль**²³¹ нь 2002 оны 5 дугаар сарын 03-ны өдөр батлагдсан. Тус хуулиар бага, суурь, бүрэн дунд боловсролын зорилго, агуулга, бага, дунд боловсролын байгууллага, түүний төрөл, удирдлага, зохион байгуулалт, сургуулийн захирал, багшийн эрх, үүрэг, хүлээх хариуцлагыг тусгасан.
- **Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль**²³² Сургуулийн өмнөх боловсрол нь бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагааны агуулга, цэцэрлэг түүний удирдлага, зохион байгуулалт, багш, эцэг, эх, асран хамгаалагчийн эрх, үүрэг, хүлээх хариуцлагыг нарийвчлан зохицуулсан.
- **Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль**²³³ нь 2016 онд батлагдсан 12 бүлэг, 45 зүйлтэй. Тус хуулиар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрх болон сурч боловсрох эрх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн амьдрах орчин нөхцөлийг сайжруулах асуудал болон хариуцах байгууллага, тэдэнд үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээний талаар нарийвчлан зохицуулсан.

²²⁸ Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль <http://www.legalinfo.mn/law/details/11223>

²²⁹ Нийгмийн халамжийн тухай хууль <http://www.legalinfo.mn/law/details/393>

²³⁰ Боловсролын тухай хууль <http://www.legalinfo.mn/law/details/9020>

²³¹ Бага, дунд боловсролын тухай хууль <http://www.legalinfo.mn/law/details/72?lawid=72>

²³² Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль <http://www.legalinfo.mn/law/details/462>

²³³ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль <http://www.legalinfo.mn/law/details/11711>

- **Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хууль**²³⁴ нь 2017 онд батлагдсан 3 бүлэг, 9 зүйлтэй. Тус хуулиар жирэмсэн эх, 0-3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эх, дөрөв хүртэлх насны ихэр хүүхэдтэй эх, эцэг, гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгохтой холбогдсон харилцааг зохицуулсан.
- **Эрүүгийн хууль**²³⁵-ийн шинэчилсэн найруулга нь 2015 оны 12-р сарын 03-ны өдөр батлагдсан, 30 бүлэг 30 зүйлтэй. Энэ хуулиар хүүхдийн эсрэг гэмт үйлдэл, эс үйлдэхүйн дараах үйлдлүүдэд хариуцлага тооцохоор заасан. Үүнд: хүүхдийг гэмт хэрэг үйлдэхэд татан оролцуулах, хүүхдийг согтуурах, мансуурах, донтох байдалд татан оролцуулах, хүүхдийг хаях, төөрүүлэх, тэнүүчлэлд хүргэх, хүүхдээр гуйлга гуйлгах, хүүхэд солих, хүүхэд худалдах, хүүхэд шийтгэх, хүүхдэд садар самууныг сурталчилах, уруу татах, хүүхэд оролцуулж садар самууныг сурталчилах, хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх, хүүхдийг асран хамгаалах үүргээ үл биелүүлэх зэргийг хуульчилсан.
- **Зөрчлийн тухай хууль**²³⁶-ийн шинэчилсэн найруулга нь 2017 оны 5-р сарын 11-ний өдөр батлагдсан, 17 бүлэг 17 зүйлтэй. Энэ хуулиар хүүхдийн эрхийн 5 зөрчилд хариуцлага оногдуулахаар заажээ. Үүнд: хүүхдийг хувцас, хоол хүнс, орон байраар хангах, сурч боловсрох, хөгжих, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хязгаарласан, хүүхдийг урьдчилан сэргийлэх тарилгад хамруулаагүй, хүүхдийг зөвшөөрөлгүйгээр мэдээлэл, сурталчилгаанд ашигласан, аюул учруулах тоглоом, наадамд оролцуулсан, хүүхдийг шашны үйл ажиллагаанд татан оролцуулсан, сургууль, сургуулийн дотуур байр, тэдгээрийн гаднах орчинд сурагч, бусад сурагчийг дарамталж, зүй бус харьцаж сургуульд суралцах боломжгүй байдлыг бий болгосон зэрэг зөрчилд хариуцлага оногдуулна гэж заасан.

1.2.Бодлогын баримт бичиг, Засгийн газрын хөтөлбөрүүд

- Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого (2016-2025) /2016 онд батлагдсан/
- Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр²³⁷ (2017-2021)
- Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр (2017 оны Засгийн газрын 148 дугаар тогтоолоор баталсан)
- Засгийн газрын 5 дугаар тайлан илтгэлтэй холбогдуулан НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооноос өгсөн зөвлөмж²³⁸
- Өвөл, хаврын улирлын хурдан морины уралдааны тухай Засгийн газрын тогтоол /2018 онд батлагдсан/
- Засгийн газрын албан даалгавар зэрэг бодлогын баримт бичиг, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна.

Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд нөхцөл байдлын үнэлгээ хийх, хүүхдийн асуудлаарх мэдээллийн сан бий болгох, хүүхдийн эрхийн улсын байцаагч, нийгмийн ажилтны ёс зүй, хүүхэд

²³⁴ Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хууль <http://www.legalinfo.mn/law/details/12756>

²³⁵ Эрүүгийн хууль (шинэчилсэн найруулга) <http://www.legalinfo.mn/law/details/11634>

²³⁶ Зөрчлийн хууль (шинэчилсэн найруулга) <http://www.legalinfo.mn/law/details/12695>

²³⁷ Хавсралт номноос дэлгэрэнгүй үзнэ үү

²³⁸ Засгийн газрын 5 дугаар тайланд өгсөн дүгнэлт, зөвлөмж

хамгааллын үйлчилгээ үзүүлэгчдийг магадлан итгэмжлэхтэй холбоотой 10 дүрэм, журам, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд 34 дүрэм, журмыг баталж, хэрэгжүүлж байна.

ХОЁР. ХҮҮХДИЙН ЭРХИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА АРГА ХЭМЖЭЭ, ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГЫН ЗӨВЛӨМЖ

Монгол Улс дахь хүүхдийн эрхийн өнөөгийн байдал, хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар Хүүхдийн эрхийн тухай конвенцын хэрэгжилтийн талаарх 5 дугаар илтгэл, тайлан болон хүүхдийн эрхийг хангах, хамгаалах эрх, үүрэг бүхий бүх шатны байгууллагаас хэрэгжүүлж байгаа ажлуудын тайлан мэдээ, судалгаанаас авсан болно. Мөн НҮБ-ын Хүүхдийн хорооноос өгсөн дүгнэлт, зөвлөмжийг²³⁹ хураангуйлан танилцуулав.

Нийгэм хурдацтайгаар хувьсан өөрчлөгдөж буй цаг үед хүүхэд тэвчишгүй хөдөлмөр эрхлэх, цахим орчинд донтох, гэр бүлийн орчинд болон цэцэрлэг, сургууль, асран хүмүүжүүлэх газар, сургуулийн дотуур байр, ажлын байр, гудамж талбайд бие махбод, сэтгэл санааны, бэлгийн болон үл хайхрах хүчирхийлэлд өртөх тохиолдол гарсаар байна. Хүүхдийн эрхийн эдгээр зөрчлийг арилгах, таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэхэд дан ганц хууль эрх зүйн орчныг сайжруулах нь хангалтгүй бөгөөд хүүхэд, насанд хүрэгчид, үүрэг хүлээгчдийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, нийгмийн тогтсон хандлагыг өөрчлөх, зөв дадал, зан үйлийг хэвшүүлэх шаардлага тулгарсан хэвээр байна.

Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд санхүү, арга зүй, хүний нөөцийн дутагдалтай байдлаас шалтгаалан хэрэгжилт хангалтгүй байна гэсэн дүгнэлтийг олон улсын байгууллагаас өгсөн байна.

Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль болон Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр /2017-2021/, түүнийг 2018-2019 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө нь зарим салбар яам, агентлаг, анхан шатанд хэрэгжилт хангалтгүй байна. Тиймээс Засгийн газраас хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, хүүхдийг аливаа осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх, аюулгүй ажиллагааны стандарт, шаардлагыг мөрдүүлэх чиглэлээр шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг холбогдох байгууллага, албан тушаалтанд албан даалгавраар үүрэг, чиглэл хүргүүлж, хэрэгжилтийг улирал бүрээр дүгнэж, тайлангаа ирүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосон байна.

Хүүхдийн эрх, хамгааллын асуудал хариуцсан байгууллагуудын хууль тогтоомжийн хэрэгжүүлэх талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ хангалтгүй, сул байсаар байна. Тиймээс Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас салбар бүрт мөрдөх **“Хүүхэд хамгааллын жишиг бодлого”**-ын төслийг боловсруулж байна. Төслийг яам, агентлаг, хүүхдийн эрхийн чиглэлээр ажиллаж буй төрийн бус байгууллагуудаар хэлэлцүүлж саналуудыг нэгтгэн боловсруулж байгаа.

Хүүхдийн эрхийг хангах, хамгаалах асуудалд хамгийн чухал асуудал бол

²³⁹ Хүүхдийн эрхийн конвенцын хэрэгжилтийн талаарх Засгийн газрын 5 дугаар тайланд өгсөн дүгнэлт, зөвлөмжийг тайланд хавсаргав.

төсвийн асуудал байдаг. Монгол Улс анх удаа 2018 оны төсөвт хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн хөгжил, хамгаалал, үйлчилгээнд зарцуулах төвсийг нэмэгдүүлж 5.0 тэрбум төгрөг болгосон. Батлагдсан төсвийн хуваарилалтыг бүс нутгийн онцлог, хүүхэд, гэр бүл, залуучуудын тоотой уялдуулан хийсэн бөгөөд орон нутагт олгож буй санхүүгийн дэмжлэг 11.9 дахин нэмэгдсэн. Үүнд:

- ✓ Хүүхэд, гэр бүлийн бодлого төлөвлөлт, зохицуулалтад салбар дундын хамтын ажиллагааг сайжруулахад-9.9%,
- ✓ Хүүхэд, гэр бүлийн чиглэлээрх хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, зохион байгуулахад-12.6%,
- ✓ Хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээний төвүүдийг бэхжүүлэх, хамгааллын үйлчилгээнд /Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолбор, Өнөр бүл, хүүхдийн төв, Хүүхдийн төлөө утас-108, Хариу үйлчилгээний түр хамгаалах байр, Сургалт, судалгааны мэдээллийн төв, Нарт хангай хараа хяналтгүй хүүхдийн хөгжлийн төв/-13.7%,
- ✓ Олон нийтийн ойлголт, хандлагыг дээшлүүлэх нөлөөлөл, сурталчилгаанд- 3.3%,
- ✓ Хөгжил, хамгааллын үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр гэрээний үндсэн дээр Төрийн бус байгууллагуудаар ажил гүйцэтгүүлэх зардалд- 23.9%,
- ✓ Орон нутаг, нийслэл, дүүргийн хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээнд- 36.5%,

Нийт санхүүжилтийн 61%-ийг урьдчилан сэргийлэх, чадваржуулах, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд 39%-ийг хамгааллын үйлчилгээнд зарцуулж байна.

2018 оны эхний хагас жилийн байдлаар 3.2 тэрбум төгрөг төлөвлөсөн бөгөөд 68 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 2.9 тэрбум төгрөг зарцуулсан байна.

Засгийн газраас 2010 онд “Нийгмийн үйлчилгээний жишиг норматив”-ын дагуу суманд 1000-3000 хүн амд 1 нийгмийн ажилтан, 3000-аас дээш хүн ам тутамд 1 нийгмийн ажилтан, хороонд 5000-аас дээш хүн ам тутамд 1 нийгмийн ажилтан байхаар тогтоосон. Өнөөгийн байдлаар 1500 гаруй нийгмийн ажилтан нийгмийн халамж, үйлчилгээг үзүүлж байна. Энэ нь нийслэлийн 1 хороонд 15-20 мянган хүн амд 1 нийгмийн ажилтан ногдож байна.

Нийгмийн анхан шатанд хүүхэд, гэр бүлд хамгааллын үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий сум, хорооны нийгмийн ажилтаны ажлын ачаалал их болж, хуулиар хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байдал байсаар байна. Нийгмийн халамжийн ажилтны хүрэлцээгүй байдлыг шийдэх зорилгоор хороодын хэсгийн ахлагч нарын ажил үүргийн хуваарьт хүүхдийн эсрэг хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллийг мэдээллэх, урьдчилан сэргийлэх чиг үүргийг оруулж, сургалт зохион байгуулж байна.

Эцэг эх, асран хамгаалагчдын болон иргэд, байгууллагын хүүхдийн өмнө хүлээх үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх, хүүхдийн аюулгүй байдлыг хангах, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх ажлыг бүх нийтийн үйл хэрэг болгож, төрийн болон хувийн хэвшлийн бүх байгууллагууд аюулгүй ажиллагааны дүрэм журам, стандартыг чанд мөрдүүлэх, буруутай этгээдэд хариуцлага тооцох ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.

2.1.Хүүхдийн эрхийн үндсэн зарчмын хүрээнд:

Үл ялгаварлах

Хүүхдийн Эрхийн тухай Конвенцын 2 дугаар зүйлд хүүхэд, түүний эцэг, эх буюу

хууль ёсны асран хамгаалагчийг яс үндэс, гарал угсаа, арьс өнгө, хүйс, хэл, шашин, улс төрийн болон бусад үзэл бодол, нийгмийн гарал, эд хөрөнгө, эрүүл мэнд, биеийн төрсөн, олдмол байдал болон бусад байдлаас шалтгаалан аливаа хэлбэрээр алагчлахгүй байх, Конвенцын бүх эрхийг хүүхэд бүрийн хувьд хүндэтгэн хүргэхээр заасан бөгөөд энэ үзэл санааг Монгол Улсын Үндсэн хуульд баталгаажуулсан байдаг. Гэсэн хэдий ч нийгэмд амьдралын ялгаатай хэв маяг үүсч байгаагаас улбаалан хүүхэд, өсвөр үеийнхний дунд амьдралын түвшин, гарал үүсэл, боловсрол, гадаад байдал, хөгжлийн бэрхшээл зэргээс шалтгаалсан тэгш бус байх, ялгаварлагдах тохиолдол байсаар байна.

Тухайлбал: бага орлоготой өрхийн хүүхдүүд сургууль дээрх хүүхдүүдийн хандлагын улмаас сургууль завсардах, хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд 6 нас хүрээд цэцэрлэгт хамрагдах боломжгүй болдог, сургуульд хамрагдах боломжгүй байдлын улмаас цоожтой хаалганы цаана амьдарч байна. Энэхүү асуудлыг зохицуулсан бодлого, арга хэмжээ байхгүй байсаар байна.

Зөвлөмж:

- Ялгаварлан гадуурхалтын талаар мэдээллэх явдлыг дэмжих
- Ийм зөрчил гаргасан хүмүүст тохирох арга хэмжээг нь шуурхай ногдуулахад анхаарах
- Энэ талаарх ойлголтыг дээшлүүлэх, боловсрол олгох арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх

/Тайлбар: НҮБ-ын Хүүхдийн хорооноос Хүүхдийн эрхийн тухай конвенцын хэрэгжилтийн 5 дугаар тайланд өгсөн дүгнэлт, зөвлөмжийг Зөвлөмж гэсэн хэсэгт оруулсан болно/

Хүүхдийн дээд ашиг сонирхлыг дээдлэх

Хүүхдийн дээд ашиг сонирхол гэдэг нь хүүхэд хэнтэйгээ амьдрах, хэнээс дэмжлэг туслалцаа авах, эцэг эхтэйгээ харилцах зэргийг үл хязгаарлахтай холбоотой эрх зүйн ойлголт юм. Сүүлийн долоон жилд 52 иргэн эцэг, эх байх эрхээ шүүхээр хасуулсан байна.

Гэр бүлийн тухай хуульд зааснаар ихэнх нөхцөлд хүүхэдтэйгээ ёс бус харьцсан тохиолдолд ийм шийдвэр гаргадаг байна. Гэхдээ эцэг байх эрхийг нь хасаж, хүүхдийг асрамжид авах нь хүүхдийг хамгаалах, төлөвшүүлэх шилдэг арга биш, хүүхдээ харж хандаж чадахгүй байгаа ухамсаргүй эцэг эхийн эрхийг хасах, хязгаарлахаас илүү нийгэмшүүлэх ёстой гэдгийг мэргэжилтнүүд зөвлөж байгаа юм. Мөн гэр бүл цуцлалтын шүүхийн практикт 7 нас хүрсэн хүүхдээс эцэг, эхийнхээ хэнтэй амьдрах талаар саналыг нь асуух ажиллагааг нэвтрүүлэн ажиллаж байна. Эрүүгийн хуульд зааснаар хууль зөрчин, эрүүгийн хариуцлага хүлээж байгаа насанд хүрээгүй этгээдэд оногдуулах ялын бодлого, шийтгэлийг хүүхдэд ээлтэй байх зарчмыг баримтлан хэрэгжүүлж байна.

Зөвлөмж: (а) Гэр бүлийн хууль, хүүхдийн асран хамгаалагчийг тогтоох, эцэг эхэд ял шийтгэл ноогдуулах зэрэгтэй холбоотой шүүх, прокурор, захиргааны шийдвэр гаргах, тайлбар өгөх зэрэгтэй хүүхдийн эрх ашгийг нэн тэргүүнд тавихыг бүхий л үйл явцын туршид мөрддөг байхад анхаарах

(б) Хүүхэдтэй хамаатай бүхий л асуудлаар хүүхдийн эрх ашгийг нэн тэргүүнд тогтоох үүрэг хүлээсэн бүх хүмүүст өгөх энэ чиглэлийн заавар зөвлөгөө, шалгуур журмыг боловсруулах;

Амьд явах эрхийг хамгаалах

Хүүхэд амьд явах жам ёсны эрхтэй бөгөөд Засгийн Газар хүүхэд бүрийг эсэн мэнд амьдрах, хөгжих бололцоогоор дээд зэргээр хангах үүрэгтэй.

Төрөөс хүүхдийн хөгжил, хамгааллын талаар хууль, эрхзүйн орчныг бүрдүүлэн, тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа хэдий ч аюулгүй ажиллагааны дүрэм журам, стандарт мөрдөөгүй үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, иргэд болон эцэг эхчүүдийн үүрэг хариуцлага сул, хайхрамж, болгоомжгүй байдлаас шалтгаалж хүүхдүүд осол, гэмтэлд өртөж эрүүл мэнд, амь насаараа хохирсоор байна.

Тухайлбал: 2017 онд гэмт хэргийн халдлагад 1758 хүүхэд өртөж, 127 хүүхэд амь насаа алдсан. 2018 оны эхний 7 сарын байдлаар гэмт хэргийн халдлагад 1028 хүүхэд өртөж хохирсон нь өмнөх оны мөн үеэс 144 нэгжээр буюу 16.3 хувиар өссөн²⁴⁰. Хүүхэд хохирсон гэмт хэргийн тоог авч үзвэл, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт өртсөн 292, дээрэмдүүлсэн 142, эд зүйлээ хулгайд алдсан 169, бэлгийн хүчирхийлэлд өртсөн 135, залилуулсан 79, зам тээврийн осолд өртсөн 105, бэлгийн мөлжлөгт өртсөн 1, олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулсантай холбоотойгоор хүүхэд хохирсон 2, бусад төрлийн гэмт хэрэгт өртөж хохирсон 103 хүүхэд бүртгэгдсэн байна.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас 13 хүүхэд хохирч, 355 хүүхэд бэртэж, гэмтсэн бол 55 хүүхэд нас барсан байна. Зам тээврийн осол, гэмтэл 0-5 хүртэлх насны хүүхдийн 3 дахь шалтгаан, 6-18 насны хүүхдийн 2 дахь гол шалтгаан болж байна. Зам тээврийн осол гэмтэлд өртөж буй хүүхдийн тоог бууруулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд хүүхдэд зориулсан автомашины суудлыг гаалийн татвараас чөлөөлөх, зах зээлд худалдаалагдаж буй үнийг бууруулах, нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, суудлын зориулалттай автомашин хэрэглэгчдийн (392,0 мянга) 30 хүртэлх хувьд хэрэглүүлж хэвшүүлэхээр мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

2018 он гарсаар зам тээврийн ослын улмаас 304 хүүхэд гэмтэж, 4 хүүхэд нас барсан байна. 2000-2017 он хүртэлх хугацаанд замын хөдөлгөөний аюулгүй байдал зөрчигдсөний улмаас 851 хүүхэд амь насаа алдаж, 3,446 хүүхэд хүнд болон хүндэвтэр гэмтсэн байна.²⁴¹

Мөн 2018 оны хоёрдугаар улиралд 5 хүүхэд золгүй тохиолдлоор нас барсан /1 хүүхэд хөл бөмбөгийн талбайд тоглож байгаад, 2 хүүхэд өндөр хүчдэлийн цахилгаанд цохиулж, 3 хүүхэд голд живж/, хүүхдийн паркийн тоглоомын аюулгүй ажиллагааны ослоор 4 хүүхэд гэмтсэн хэргүүд гарлаа.²⁴² Онцгой байдлын ерөнхий газрын мэдээллээс харахад 2017 онд гал түймэр, усны болон үерийн, төөрсөн, золгүй тохиолдлоор 44 хүүхэд, 2018 онд эхний хагас жилийн байдлаар 27 хүүхэд амь насаа алдсан байна.

Дээрх тоо баримтаас харахад хүүхдийн амьд явах эрх зөрчигдөх явдал буурахгүй байна. Энэ нь гэр бүл, эцэг эх, асран хамгаалагч гээд хүүхдийн эрхийг хангах үүрэгтэй хүмүүсийн анхаарал халамж сул байгааг харуулж байна. Мөн нийгмийн хөгжлийн үйл явцтай уялдуулж нийгмийн халамж, үйлчилгээ, хууль эрх зүйн орчныг боловсронгуй

²⁴⁰ ЦЕГ-ын Мэдээллийн сан

²⁴¹ Авто зам дахь хүүхдийн аюулгүй байдал, осол гэмтлийн нөхцөл байдлын үнэлгээ, НҮБ-ын хүүхдийн сан, 2018 он

²⁴² Цагдаагийн ерөнхий газар, 2018 оны 5 дугаар сар

болгох, хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах шаардлагатай байгаа юм.

Хүүхэд хамгааллын үйлчилгээг боловсронгуй болгох хүрээнд хүүхдийн эрх ба бизнесийн зарчимд суурилсан “**Хүүхэд хамгааллын даатгалын үйлчилгээ**”-г нэвтрүүллээ. Эхний ээлжинд хамгийн их эрсдэлтэй 7000-9000 гэр бүл, хүүхдийн хамруулахаар төлөвлөсөн байна. Одоогийн байдлаар халамж, асрамжийн төвд амьдарч байгаа 0-18 хүртэлх насны 1013 хүүхдийг хамрууллаа.

Энэхүү даатгалын үйлчилгээг нэвтрүүлснээр хүүхэд даатгалын тохиолдол буюу ор сураггүй алга болох, бүхий л төрлийн хүчирхийлэлд өртсөн тохиолдолд эрэн хайх, эрүүл мэндийг нөхөн сэргээх, тээвэрлэх, аюулгүй байдлыг хангах, хууль шүүхийн шатанд эрх зүйн туслалцаа үзүүлэх өмгөөлөгчийн зардал зэргийг даатгалын компаниар нөхөн төлүүлэх боломжтой болох юм.

Зөвлөмж: Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх талаар эцэг эх олон нийтэд сургалт сурталчилгаа хийх, буруутай этгээдэд хариуцлага тооцох гэх мэтээр осол гэмтлээс урьдчилан сэргийлэх хүчин чармайлтаа бэхжүүлэхийг зөвлөж байна.

2.2.Иргэний эрх, эрх чөлөө

Мэдээлэл олж авах эрх, эрх чөлөө

Хүүхэд чөлөөтэй бодож сэтгэх, мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Монгол Улсад үндэсний аюулгүй байдлын эсрэг үйл ажиллагаа явуулах, терроризм болон бусад гэмт хэрэг, садар самуун, хүчирхийллийг сурталчилах, түүнчлэн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон хүүхэд өөрөө хүсээгүй бол хүүхдийг сурталчилгаанд ашиглахыг Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулиар хориглосон.

Сүүлийн жилүүдэд зөвхөн манай улс төдийгүй дэлхийн улс орнуудын хүүхдүүдийн интернетийн хэрэглээ өсч байгааг дагаж, сөрөг нөлөө нь нэмэгдэж байгаад бүх нийтээрээ анхаарлаа хандуулах нөхцөл байдал тулгараад байна.

Манай улсын хувьд хүүхэд, өсвөр үеийнхнийг дэлгэцийн донтолт, цахим орчны гэмт хэрэг, хүчирхийлэл, дарамтаас урьдчилан сэргийлэх, мэдээллийн технологийн зохистой хэрэглээг дэмжих чиглэлээр “Мэдээллийн технологийн зохистой хэрэглээг бий болгох, цахим орчин дахь хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх” чиглэлээр авах арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж байна. Төлөвлөгөөний 3 зорилтын хүрээнд нийт 28 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Нэг. Цахим орчин дахь хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөг, гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг судлах, арилгах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилтын хүрээнд 6 арга хэмжээг Хууль зүй, дотоод хэргийн яам хариуцан зохион байгуулж байна.

Хоёр. Цахим орчин дахь хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх хүрээнд мэдээллийн технологийн зохистой хэрэглээг бий болгох, эцэг эхийн оролцоог нэмэгдүүлж, хяналтыг сайжруулах зорилтын хүрээнд нийт 5 арга хэмжээг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, Харилцаа холбооны

зохицуулах хороо зохион байгуулж байна.

Уг арга хэмжээний хүрээнд үүрэн холбооны 4 оперотор компанитай уулзалт хийж, бүртгэлгүй гар утасны дугаарыг бүртгэлжүүлэх, хүүхдийн эзэмшиж ашиглаж байгаа гар утасны дугаарыг бүртгэлжүүлэх ажлыг хамтран зохион байгуулахаар ажиллаж байна.

Гурав. Цахим орчин дахь хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх сурталчилгаа, нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулах зорилтын хүрээнд нийт 8 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж биелэлт 70 хувьтай хэрэгжиж байна.

Аймаг орон нутаг дахь төр захиргааны 163 байгууллага, 46 аж ахуйн нэгж байгууллагыг үйл ажиллагаандаа татан оролцуулж хамтран ажиллаж Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсийн сайт, цахим хуудас, фэйсбүүк группээр “Бүтээе, нэгдье, харилцан хүндэлье-Эерэг интернет танаас эхэлнэ”, “Цахим гэмт хэргээс ирээдүй үеэ хамгаалья”, “Хүүхдийн оролцоо-Хөгжлийн ирээдүй” зэрэг 14 төрлийн уриалгуудыг санаачлан түгээж, “Цахим орчин дахь зөв зохистой хэрэглээ”- иргэд олон нийт, өсвөр үеийн хүүхэд залуучуудад ойлгуулах уриалга бүхий постер бэлтгэж, байршуулан олон нийтэд түгээн ажиллаж байна.

Хүүхэд, өсвөр үеийнхнийг осол гэмтэл, болзошгүй эрсдэл, цахим орчны сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх чадавхийг бэхжүүлэх, хор хохирол, үр дагаврыг нийгэмд таниулах зорилготой цахим орчноос хүүхэд өсвөр үеийг урьдчилан сэргийлэх “Цахим орчинд хүүхэд хамгаалал” аяныг Ерөнхий боловсролын сургуулийн 5-7 дугаар ангийн 2300 сурагчийг хамруулан зохион байгууллаа. Аянд Багахангай, Багануур, Налайх дүүргийн хүүхдүүдэд цахим орчин дахь хүүхэд хамгаалал, ухаалаг утасны хор нөлөө, интернетийн зүй зохистой хэрэглээ, цахим гэмт хэрэг түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан.

Нийслэл хотын хэмжээнд хүүхэд, өсвөр үеийнхнийг цахим орчны гэмт хэрэг, хүчирхийлэл дарамтаас урьдчилан сэргийлэх, цахим орчин, хэвлэл мэдээллийн зохистой хэрэглээг дэмжих, цахим орчны эерэг боломжуудын талаар сурталчилан таниулах ажлыг зохион байгуулж байна.

Монгол Улсын Их Хурлаас 2018 оны 5 дугаар сард Цахим бодлогын түр хороо байгуулсан нь цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх ажил урагш ахихад томоохон алхам болсон. Тус түр хорооноос хэрэгжүүлж буй үйл ажиллагаа 3 чиглэлээр өрнөж буйн нэг нь нийгмийн сүлжээнд хүний эрх, ялангуяа хүүхдийн эрх хэрхэн зөрчигдөж байгаад судалгаа, дүгнэлт хийж, хүүхдийн аюулгүй байдлыг хангах, хүүхдийн эрүүл мэнд, бие махбод, оюун санаа, ёс суртахууны хөгжил, төлөвшилд сөрөг нөлөө бүхий мэдээллээс тэднийг хамгаалах үйлсэд олон нийтийн оролцоог идэвхжүүлэхэд чиглэж байна.

Түр хорооноос 2018 оны 9 дүгээр сард “Таны хүүхдийг танихгүй хүн хүмүүжүүлж байна” нээлттэй хэлэлцүүлгийг санаачлан зохион байгуулж “Unfriend” хөдөлгөөнийг эхлүүлсэн бөгөөд тус хэлэлцүүлгээс 3 чиглэлээр 17 зөвлөмж²⁴³-ийг гаргасан. Тухайлбал, Цахим орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хангах үр дүнтэй эрх зүйн орчныг

²⁴³ Зөвлөмжийг бүрэн эхээр нь хавсаргав.

бүрдүүлэх, боловсронгуй болгох чиглэлээр-4, Цахим орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор авч хэрэгжүүлэх зохион байгуулалтын болон соён гэгээрүүлэх арга хэмжээний талаар 11, Хэвлэл, мэдээллийн байгууллага, харилцаа, холбооны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдэд 4 зөвлөмжийг гаргасан.

Зөвлөмж: Бүх хүүхдийн, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, өөр хэлтэй үндэсний цөөнхийн хүүхдүүдийн хэрэгцээг анхаарсан хүүхдийн нийгэм, оюун санаа, ёс суртахуун, биеийн болон сэтгэцийн эрүүл мэндийг дэмжсэн контентийг хүүхдэд зориулсан телевизийн нэвтрүүлэг, ном зэрэг олон нийтийн мэдээллийн хэрэгслийн олон хэлбэрийг ашиглан хүргэх замаар хүүхдэд тохиромжтой хэрэгтэй мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авахыг зөвлөж байна.

Хүүхдүүд цахим тоглоомонд донтох, гэмт хэрэг зөрчилд холбогдох зэрэг эрсдэлд өртөх нь эцэг эхчүүдийн хариуцлагатай холбоотой боловч хүүхэд, гэр бүлийн хөгжлийг дэмжих, чөлөөт цагийг өнгөрүүлэх хүүхдэд зориулсан биеийн тамирын талбай, тоглоомын төв, усан бассейн, спортын цогцолбор, хүүхдийн ордон зэрэг газар хомс байгаатай бас холбоотой байна.

2.3.Хүүхдийн эсрэг хүчирхийлэл

Хүүхдийн эсрэг хүчирхийллийг Хүүхдийн эрхийн конвенцын 19-р зүйлд “гэмтэл бэртэл учруулах, зүй бусаар харьцах, анхаарч халамжлахгүй байх, үл хайхрах, бэлгийн хүчирхийлэл үйлдэх, мөлжих зэрэг бие махбод, сэтгэл санааны хүчирхийлэлийн бүх хэлбэр” хэмээн тодорхойлсон. Харин Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4 дүгээр зүйлд хүүхдийн эсрэг хүчирхийлэл гэж санаатай эсхүл санамсаргүйгээр хүүхдийн амь нас, эрүүл мэнд, хөгжил, бие махбод, сэтгэл санаанд хохирол учруулах үл хайхрах байдал, бэлгийн зүй бус үйлдэл болон бие махбодийн шийтгэл, сэтгэл санааны дарамтыг хэлнэ гэж тодорхойлсон.

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл нь нийгэм, сэтгэл зүйн хохирол амсах, хүчирхийллийг хүлээн зөвшөөрөх, эрт бэлгийн харилцаанд орох, сэтгэл зүйн дарамтад орох, ой тогтоолт нь буурах, эмх цэгцээ алдах, хий юм үзэх, түрэмгий зан авиртай болох, уушиг, зүрх, элэгний өвчлөл, бэлгийн замаар дамждаг өвчнүүд, үр зулбах гэх мэт сөрөг үр дагавруудтай.

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл нь ямагт санаатай үйлдэгддэг бөгөөд дараах хэлбэртэй байна.

- ✓ Хүүхдийн эсрэг бие махбодын хүчирхийлэл
- ✓ Хүүхдийн эсрэг сэтгэл санааны дарамт, хүчирхийлэл
- ✓ Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл
- ✓ Хүүхдийг үл хайхрах.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 2.2-т “Хүүхэд хамгаалал нийгмийн бүх орчинд хүүхэд бүрийг үл хайхрах байдал, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэрээс, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хариу үйлчилгээ үзүүлэх зорилготой олон талт, цогц, мэргэшсэн үйл ажиллагаанаас бүрдэнэ.”, 2.6 дахь хэсэгт “Хүүхэд, өсвөр насны хүнийг халамжлах, эмчлэх, удирдан чиглүүлэх, тэдэнд боловсрол олгох үүрэг хүлээсэн эцэг, эх, асран хамгаалагч, бусад хүн тэднийг хүмүүжүүлэх, алдаатай зан авирыг нь засахдаа бие махбодийн болон доромжлон гутаасан бүх төрлийн

шийтгэлийн арга хэрэглэхийг хориглоно” гэж тусгасан. Мөн хүүхдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийг, бүх орчинд Боловсролын тухай хуулиар хориглосон.

Хүчирхийллийн улмаас хохирсон хүүхдийг хамгаалах зорилгоор шаардлагатай хугацаанд түр хамгаалах байранд байршуулж байна. Түр хамгаалах байрны хувьд улсын хэмжээнд 12 аймаг, нийслэлийн Хан-уул, Баянгол дүүрэгт түр хамгаалах байр ажиллаж, түр хамгаалах байранд 629 хүүхдийг түр байршуулсан байна.

Үүнээс Засгийн газрын 2017 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 231 дүгээр тогтоолоор байгуулагдсан “Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, түр хамгаалах байр 0-18 хүртэлх насны **423** хүүхэд “хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ”-г үзүүлээд байна.

Дорноговь аймгийн Замын үүд, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Мандал сумдад “Эрсдэлт нөхцөлд байгаа эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдал, хөгжих хэвийн орчин алдагдсан насанд хүрээгүй хүүхдийг эрсдэлээс хамгаалах” зорилгоор 3 түр хамгаалах байр байгуулж, ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын А/13 тоот тушаалаар 64 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэн, байрны тохижилт үйлчилгээ болон 6 ажилтныг орон тоогоор ажиллуулах зардлыг шийдвэрлэсэн.

Дархан-Уул, Архангай, Баян-Өлгий, Дорноговь, Говь-Алтай, Өмнөговь, Ховд, Хөвсгөл аймгуудад түр хамгаалах байр байгуулах асуудлыг ойрын хугацаанд шийдвэрлэж, гэр бүлийн хүчирхийллийн хохирогч, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд аюулгүй байдлын хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлэх шаардлагатай байна.

Мэдээлэлд анализ хийхэд тэдний эцэг, эх, асран хамгаалагч, хамаарал бүхий этгээдийн зүгээс хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлддэг ба 50.6 хувь архины хамааралтай, 31.7 хувь нь эцэг эх, асран хамгаалагчийн зүгээс хараа хяналт сул, 10% нь хүүхдээр хөдөлмөр эрхлүүлж эрхийг нь зөрчиж байна.

Бие махбодын хүчирхийлэл

“Хүүхэд ч гэсэн хүний эрх эдлэгч бөгөөд бие махбодийн шийтгэл бол тэдний хүний нэр төр, биеийн болон сэтгэл санааны халдашгүй байдлыг хүндэтгэх хүүхдийн эрхийн үндсэн зөрчил гэдгийг олон нийт сайтар мэддэг болжээ. Хүүхдийн эрхийн тухай конвенцын 19 дүгээр зүйлд эцэг эх болон бусдын халамжид байгаа хүүхдийг “биеийн болон сэтгэл санааны хүчирхийллийн бүх хэлбэрээс хамгаалахыг” конвенцын гишүүн улсуудаас шаарддаг.

Бие махбодийн буюу биеийн шийтгэл бол хүүхдийг гараар цохих, эсвэл саваадах, ороолгох, өөр зүйлээр цохих, өшиглөх, сэгсрэх, шидэх, самардах, маажих, чимхэх, хазах, үсийг зулгаах, ая тухгүй байдалд байлгахаар хүчлэх, түгжих, хүлэх, түлэх, шалзлах, хүчээр залгиулах (жишээлбэл амыг савангаар угаах) зэрэг өвчин шаналал, биеийг тавгүйтүүлэх зорилгоор үйлдэгдэх биеийн хүчээр үзүүлж буй аливаа шийтгэлийг хэлнэ²⁴⁴.

Үндэсний статистикийн хорооноос 2010-2014 оны хооронд хийсэн “Хүүхэд хөгжил” 3 ба 4 дүгээр судалгаа болон Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаанаас

²⁴⁴ Хүүхдийн бие махбодийн шийтгэл устгах даян дэлхийн санаачилга- www.endcorporalpunishment.org

харахад 2-14 насны хүүхдийн 45-47% нь гэр бүлийн хэн нэг гишүүний зүгээс үзүүлэх биемахбодийн шийтгэл амсдаг дүн гарчээ. Хүчирхийлэлд өртсөн хүүхэд дан ганц бие махбодийн хувьд хохироод зогсохгүй, сэтгэл зүйн хувьд шарх авч, улмаар тэдний хөгжил, бие махбод, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хүрээнд эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх чиг үүрэгтэй 609 хамтарсан баг ажиллаж байна. Хамтарсан баг 2017 онд 1298, 2018 эхний хагас жилийн байдлаар 1548 гэр бүлийн хүчирхийлэлтэй гэр бүлтэй ажиллаж, 2336 хүүхдэд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлж, давхардсан тоогоор 6318 хүүхэд, иргэнд аюулгүй байдлын хамгаалалт, сэтгэл зүйн зөвлөгөө, эмнэлгийн тусламж, холбон зуучлах үйлчилгээг үзүүлсэн байна.

“Хүүхдийг эерэг аргаар хүмүүжүүлэе үндэсний аян”-ыг 21 аймаг, 9 дүүрэгт өрнүүлж 1628 сургагч багш бэлтгэж, 8240 боловсролын байгууллагын ажилтан, 53,650 эцэг эхчүүдэд хүүхэд хүмүүжлийн эерэг аргын сургалтыг зохион байгуулж, зөвлөгөө мэдээлэл, нөлөөлөл сурталчилгааны ажил хийгдэж байн

Сургууль, цэцэрлэг, асрамж, халамжийн байгууллагын орчинд хүүхэд хүчирхийлэлд өртөх явдал буурахгүй байна. Сургууль, цэцэрлэгийн орчинд хүүхэд хүчирхийлэлд өртөх шалтгаан нөхцөл маш олон талтай хэвээр байна.

Сургууль, цэцэрлэгийн орчинд гарч байгаа ихэнх хүчирхийлэлд багш нь хүүхдийг ямар нэг хэлбэрээр хүчирхийлсэн байдлаар илэрч, багш шийтгэл авсаар байна. Иймд багш нарыг хүчирхийлэлгүй заах арга зүйд сургах, урьдчилан сэргийлэх, зайлшгүй нөхцөлд хамгаалах тогтолцоог хөгжүүлэх, багшийн ажиллах орчинг сайжруулах шаардлагатайг нотолж байна.

Зөвлөмж: Бие махбодын шийтгэлийг гэр бүл, сургууль зэрэгт өргөнөөр хэрэглэсээр байгаад Хорооны зүгээс сэтгэл ихээр зовинож буйгаа илэрхийлье. Хүүхэд өсгөх, хүмүүжүүлэхдээ хүчирхийллийн биш, эерэг, оролцооны аргыг хэрэглэхийг эцэг эх, багш нарт сургах, үндэсний хэмжээний кампанит ажил өрнүүлэх гэх мэт олон нийтийн боловсролд чиглэсэн арга хэмжээ өрнүүлэх замаар хуулийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд анхаарахыг зөвлөж байна.

Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл

Хэн нэгэн хүүхдийг дургуй байхад нь бэлгийн сонирхлоор илж таалах, үнсэх зэргээр хүчиндэх хүртэлх үйлдлийг бэлгийн хүчирхийлэл гэнэ.

Манай улсын хувьд сүүлийн жилүүдэд хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн тоо өсч, үүний дотор ураг төрлийн хүчирхийлэл нэмэгдсэн байна. 2019 онд бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд үйлчилгээ үзүүлэх чиг үүрэгтэй “Нөхөн сэргээх төв”-ийг байгуулахаар төлөвлөж, холбогдох судалгаа, шинжилгээ хийж, бусад улс орны сайн туршлагыг судалж байна.

Цагдаагийн байгууллагын тоо мэдээгээр 2015-2017 онд хүчиндэх гэмт хэргийн улмаас 950 хүн хохирсоны 936 эмэгтэй, 14 эрэгтэй хүн байна. Энэ хугацаанд 6 хүний амь нас хохирч, 262 хүн гэмтсэн ба нийт хохирсон хүмүүсийн 469 буюу 49,4% нь 18

хүртэлх насны хүүхэд байна²⁴⁵.

Он	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Улсын хэмжээнд	342	367	305	344	300	279	290	376
Нийслэлд	157	180	155	182	152	133	132	194
Орон нутагт	185	187	150	162	148	146	158	182

(2010-2017 онд үйлдэгдсэн хүчиндэх гэмт хэрэг)²⁴⁶

2010 онд хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч хүүхдийн тоо 152 байсан бол 2017 онд 189, 2018 оны 5 сарын байдлаар 98, бэлгийн мөлжлөгийн хохирогч хүүхэд 1 бүртгэгдсэн байна²⁴⁷.

“Хүчиндэх” гэмт хэрэгт сэжиглэгдэн шалгагдсан хүмүүсийн 97 буюу 10.1% нь “Ураг төрлийн хамааралтай” хүмүүс бөгөөд тэдний 44.3% нь хойд эцэг, 18.5% нь төрөл садангийн хүн, 12.3% нь төрсөн эцэг, 10.3% нь хүргэн нь байна. Хохирогчдын 26.3 хувь нь бэлгийн хүчирхийлэлд давтан өртсөн судалгаа гарсан байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс Монгол Улс дахь гэмт хэргийн байдал, шалтгаан нөхцөл, хэтийн төлөв хандлагыг нийгэм, цаг үеийн нөхцөл байдалтай харьцуулан, шинжлэх ухааны үндэслэлтэй судлах, түүнтэй тэмцэх арга замыг тодорхойлон төр засаг, хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагад санал, зөвлөмж болгох зорилгоор Монгол Улсад анх удаа “гэмт хэргийн цагаан ном 2016” товхимлыг гаргасан. Уг товхимлын 5 дугаар бүлэгт Гэр бүлийн хүчирхийлэл ба гэмт явдал, 6 дугаар бүлэгт Хүүхэд холбогдсон болон хохирсон гэмт явдал, 18 дугаар бүлэгт бэлгийн мөлжлөг ба хүчиндэх гэмт явдлыг тус тус судалсан байна.

Уг судалгаагаар хүүхдийн эсрэг хүчирхийллийн шалтгаан нөхцөлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Гэр бүлийн орчин, сургуулийн өмнөх боловсрол, дунд болон их сургуульд хүчирхийлэл, гэмт хэрэг, харилцааны талаар үндсэн болон нэмэлт мэдлэг, хандлага өөрчлөх чиглэлээр хичээл орохгүй явж ирснээс шалтгаалж нийгэм тэр чигтээ хүчирхийлэлд дасан зохицох хандлага;
- Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн Гэр бүлийн хүчирхийллийн гомдол мэдээллийн 70 гаруй хувьд хамаарах тохиодол нь архи дан согтуурсан үедээ үйлдсэн;
- Гэр бүлийн таагүй уур амьсгал, сургуулийн орчин дахь эрх зүй, зан суртахууны ба хүйсийн харилцааны алдаа, хувь хүний сэтгэц, физиологийн онцлог, хохирогчийн буруутай үйлдэл, хэвлэл мэдээллийн хэрэгслийн сөрөг сурталчилгааны нөлөө;
- Хүчирхийлэгчийн нийтлэг байдлыг авч үзэхэд хохирогчийн танил, 16-35 насны, ажилгүй, бүрэн дундаас доош боловсролтой, эрэгтэй хүмүүс.

Эрүүл мэндийн байгууллагын мэдээллээр 2017 онд хүчирхийллийн шалтгаанаар эмнэлгийн тусламж, үйчилгээ авсан нийт 17.309 тохиолдлын 1835 тохиолдол буюу 10.6 хувь нь хүүхэд байжээ. Тухайлбал: Эх, хүүхдийн эрүүл мэндийн төвийн Өсвөр

²⁴⁵ ЦЕГ-ын мэдээллийн сан

²⁴⁶ ЦЕГ-ын мэдээллийн сан

²⁴⁷ ЦЕГ-ын мэдээллийн сан., 2017-2018 оны хагас жил

үеийн клиник 2017 онд 3661 хүүхдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлснээс хүчирхийлэлд өртсөн 58 хүүхэд байсан ба тэдний 89.7 хувь нь бэлгийн хүчирхийлэл, 10.3 хувь нь бие махбодын, үл хайхрах, сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн байжээ.

Харин гэмтэл согог судлалын үндэсний төвд 2017 онд гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн нийт 910 үйлчлүүлэгч үйлчлүүлснээс 299 нь 0-16 насны хүүхэд байжээ.²⁴⁸

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас улсын хэмжээнд хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн шийдвэрлэлтийг сайжруулах, бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үзүүлэх нөхөн сэргээх, нийгэмшүүлэх үйлчилгээний загвар, аргачлалыг бий болгох чиглэлээр мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Мөн “Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч хүүхдүүдэд үзүүлэх стратегийн өмгөөлөл” хийх ажлыг ТББ-аар гэрээлэн гүйцэтгүүлж байна.

Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч хүүхдэд үзүүлэх хүүхэд хамгааллын үйлчилгээний дундаж зардал **128.304 төгрөг**, аюулгүй байдлын хамгаалалтын үйлчилгээ **19.100 төгрөгөөр** тооцож, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх магадлан итгэмжлэл авсан төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлэхээр төлөвлөжээ.

НҮБ-ийн хүн амын сан болон Үндэсний статистикийн хорооноос 2017 онд улс орон даяар жендерт суурилсан хүчирхийллийн судалгааг хийж 2018 оны 6 сард нийтэд танилцуулсан. Энэхүү судалгаа нь Монгол Улсад жендерт суурилсан хүчирхийллийн талаар хийсэн анхны томоохон хэмжээний тоон болон чанарын судалгаа болсон. Судалгааны хүрээнд эмэгтэйчүүдийн эсрэг бие махбодын, бэлгийн, эдийн засгийн, сэтгэл санааны, хянах зан үйлийн хүчирхийллийн хэлбэрүүдийг бүрэн хамарч хот хөдөөгийн 7300 гаруй эмэгтэйчүүдийг хамруулж, ойр дотны болон бусдын зүгээс эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэж буй хүчирхийллийн түвшинг хэт өндөр байна гэж тогтоосон байна.

БНХАУ-ын Эрээн хот, Хайлаар, Манжуур, Дүрэмт хошуунд амьдарч байгаа иргэд, гэр бүл, хүүхдийн нөхцөл байдалд үнэлгээ хийх ажлыг 2018 оны 9-10 дугаар сард зохион байгуулахаар ГХЯ, БСШУСЯ, ЦЕГ, Хил хамгаалах ерөнхий газар, Гадаадын иргэн харьяатын газар зэрэг байгууллагууд хамтран ажиллаж байна.

2.4.Гэр бүлийн орчин ба хүүхдийн асрамж халамжийн үйлчилгээ

Гэр бүлийн орчин

Монгол Улсын хүн ам 2017 оны урьдчилсан дүнгээр 3,2 сая болж, нийт өрхийн тоо 885,639 мянган гэр бүл бүртгэгдэж, 65 хувь нь хот суурин газар, 35 хувь нь хөдөөд, нэг өрхөд дунджаар 3,5 гишүүн амьдарч байна. Нийт өрхийн тоо 885,639-д хүрч өрх толгойлсон эхчүүд²⁴⁹ 76.9 мянга болж өмнөх онтой харьцуулахад буурч, өрх толгойлсон эцэг 20.6 мянга болж өмнөх оноос 0.3%-аар өслөө.

2017 онд 20470 хос гэрлэлтээ бүртгүүлж, 3945 гэр бүл цуцалсан байна. Өмнөх

²⁴⁸ Асуулгын хариу, ХЗДХСайд, 2018.05.18

²⁴⁹ Мэдээллийн эх сурвалж www.1212.mn

²⁵⁰ www.1212.mn

онтой харьцуулахад гэрлэлт 22 хувиар өсөж, цуцлалт 3,4 хувиар буурсан байна.²⁵⁰

Улсын хэмжээнд гэр бүлд зөвлөгөө өгөх 14 төв, танхим ажиллаж, 2017 онд 34,000 иргэн, гэр бүлд гэр бүлийн үнэ цэнэ, харилцаа, хандлагын талаар зөвлөгөө мэдээлэл авсан байна.

Гэр бүлийн боловсрол олгох чиглэлээр 2018 оны эхний хагас жилийн байдлаар 21 аймаг, 9 дүүргийн салбар нэгжүүд “Багшийн ёс зүй, гэр бүлийн харилцаа хандлага”, “Боловсролын орчин дахь хүүхэд хамгаалал”, “Гэр бүлийн үнэ цэнэ” сэдвээр багш сурган хүмүүжүүлэгч, эцэг эхчүүдэд 170 удаагийн сургалт лекц зохион байгуулж, 23,750 хүн хамрагдаад байна.

Гэр бүлийн хөгжлийг дэмжих үйлчилгээний хүрээнд “Гэр бүлийг дэмжих туршилтын хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж байна. Уг хөтөлбөрийн хүрээнд 40,000 өрхөөс судалгаа авч, 8100 өрхийг сонгон, гэр бүлийн зөвлөгч нараар дамжуулан тухайн гэр бүлийн нөхцөл байдал, тулгамдсан асуудлыг судлан, тодорхойлж, гэр бүлийн хэрэгцээ, онцлогт тохирсон хөгжлийн төлөвлөгөө боловсруулах, шаардлагатай үйлчилгээнд холбон зуучлах, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, гэр бүлд чиглэсэн үйлчилгээний арга зүйг боловсруулан ажиллаж байна. 21 аймаг 9 дүүрэгт нийт 3464 гэр бүлийн зөвлөгч нарыг бэлтгээд байна.

Жич: (Ойролцоогоор нэг хүүхдийн хүүхэд хамгааллын зардалд 118,304 төгрөгийн санхүүжилт шаардлага гэж тооцвол 8,7 тэрбум төгрөг шаардлагатай. 2017 онд үйлчилгээнд хүүхэд хамгааллын үйлчилгээ авсан 69.0 мянган хүүхдийг 7%-аар өсгөхөд 73,830 хүүхэд буюу нийт хүүхдийн 6,1%-д үйлчилгээ үзүүлнэ гэж тооцов)

2017 онд гэр бүлийн хүчирхийллийн улмаас 63 хүүхэд, 2018 оны эхний 5 сарын байдлаар 28 хүүхэд, бэлгийн хүчирхийллийн улмаас 2017 онд 189 хүүхэд хохирсон бол 2018 оны эхний 5 сарын байдлаар 98 хүүхэд хохирсон байна.

Гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийллийг эрт үед илрүүлэх, таслан зогсоох, нөхөн сэргээх үйлчилгээнд хохирогч бүрийг хамруулах, тохиолдол бүрт үзүүлэх илрүүлэлт, нөхцөл байдлын үнэлгээ, тусгай хамгаалалт, сэтгэл зүйн болон хууль зүйн зөвлөгөө, үйлчилгээг үнэ төлбөргүй болгоход хөрөнгө санхүүгийн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.

Нийгмийн суурь орчин болох гэр бүлийг дэмжихэд хууль тогтоомжийг боловсронгуй болгох шаардлагатай байна. Тиймээс Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-д өргөн барьж, батлуулахаар ажиллаж байна. Хуулийн төсөлд гэр бүлийн тогтвортой амьдралыг дэмжих, гэр бүлийн үнэ цэнийг дээшлүүлэх, гэр бүлийн боловсролыг бага наснаас нь олгох, гэр бүлийн хөгжлийг дэмжих шинэ төрлийн үйлчилгээнүүдийг хөгжүүлэх, гэр бүлийн харилцаанд хүүхдийн дээд ашиг сонирхлыг тэргүүн ээлжинд хамгаалж, хүүхдийн тэтгэлэг бүрэн төлөгдөх механизмыг бүрдүүлэх, хүүхдийн өмчлөлийн эрхийг хуульчлах, эцэг, эхийн үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх, үрчлэлт болон асралт гэр бүлийн асуудлыг нарийвчлан зохицуулахаар төсөлд тусгаад байна.

Асрамжийн үйлчилгээ

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан “Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний стандарт”-ыг 2017 онд Стандартчиллын үндэсний зөвлөлөөр

шинэчлэн баталсан бөгөөд тус стандартыг халамж, асрамжийн төвүүдэд мөрдөж ажиллаж байна.

Нийслэлийн Цагдаагийн газар болон Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас эцэг эхийн хараа хяналт сул хүүхдийг илрүүлэх арга хэмжээг тогтмол зохион байгуулж, хүүхдүүдийг эцэг эх, асран хамгаалагчид нь хүлээлгэн өгөх, шаардлагатай тохиолдолд хамгаалах байр, халамж, асрамжийн төвүүдэд байршуулж, удаан хугацаагаар тэнэсэн гэр бүлдээ очих боломжгүй хүүхдүүдийг “Хараа хяналтгүй хүүхдийг нийгэмшүүлэх төв”-д байрлуулан нийгэм, сэтгэлзүйн нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлж байна.

Асрамж, халамжийн төвд амьдарч буй хүүхдийн нөхцөл байдлыг сайжруулах, мэдээллийн санг бүрдүүлэх, хагас өнчин, эцэг эх нь асран хамгаалагчийн үүргээсээ татгалзсан, асрамж халамжийн төвд амьдрах хугацаанд эцэг эх нь сураггүй болсон хүүхэд, залуусыг бүтэн өнчинд тооцож нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж олгох асуудлыг Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчлэлийн хүрээнд шийдэхээр ажиллаж байна.

2018 оны 6 дугаар сарын байдлаар Монгол Улсад 31 асрамж, халамжийн төв ажиллаж байгаагаас 3 төв нь буюу Өнөр бүл хүүхдийн төв, Хүүхэд, залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолбор, Нялхсын клиник сувилал улсын төсвөөс, бусад 28 төв нь олон улсын болон гадаадын иргэний санхүүжилтээр ажиллаж байна.

2018 оны 6 дугаар сарын байдлаар дээрх төвүүдэд 1013 (529 эрэгтэй, 484 эмэгтэй хүүхэд) байна. Улсын төсвөөс санхүүждэг ГБХЗХГ-ын харьяа Өнөр бүл хүүхдийн төвд-189, нийслэлийн Засаг даргын дэргэдэх Хүүхэд, залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолборт-129, ЭМЯ-ны харьяа Нялхасын клиник сувилалд-33 хүүхэд, хувийн халамж, асрамжийн 28 төвд 662 хүүхэд амьдарч байна. 2018 онд халамж, асрамжийн төвөөс 18 нас хүрч, нийгэмд бие даан амьдрах 55 хүүхэд байна. Мөн 18-аас дээш насны 21 залуус амьдарч байна.

Халамж, асрамжийн төвд амьдарч буй хүүхдийн нөхцөл байдал

№	Үзүүлэлт	Тоо	Хувь
1.	Нийт хүүхдийн тоо	1013	(100%)
	Үүнээс:		
1.1	0-5 нас	152	(15%)
1.2	6-11 нас	334	(32.9%)
1.3	12-18 нас	506	(50 %)
1.4	18-аас дээш насны	21	(2.07%)
1.5	хагас өнчин	444	(43,8%)
1.6	бүтэн өнчин	171	(16,8%)
1.7	гэр бүлтэй	335	(33%)
1.8	Эцэг эх байх эрхийг түтгэлзүүлсэн	13	(1,28)
1.9	бүртгэл тодорхойгүй	50	(4,9%)
1.10	үрчлэгдэх боломжтой	29	
1.11	холбогдох тэтгэмжээ авч чадахгүй	19	

Асрамж, халамжийн төвөөс гарч байгаа хүүхэд, залуусын 40-50 хувь нь мэргэжил эзэмшиж, ажлын байртай болж чаддаггүй, өөрийн гэсэн өмч хөрөнгөгүй, орон гэргүй, хамаатан садны дэмжлэг байдаггүй, төрийн үйлчилгээ авч чаддаггүйгээс гэмт хэрэг зөрчилд холбогдох, тэнэмэл байдлаар амьдрах тохиолдол цөөнгүй байна. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас асрамж, халамжийн төвд амьдарч байгаа 18 нас хүрсэн залуусыг “Нийгэмд бие даан амьдрах хөтөлбөр”-т хамруулж, амьдрах ухааны ур чадвар олгох, гадаад улсад ажиллах чиглэлээр анхаарлаа хандуулж, дэмжлэг туслалцаа үзүүлж байна.

“Өнөр бүл” хүүхдийн төв болон бусад халамж, асрамжийн төвд 76 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, СЭМҮТ-д байнгын асаргаа сувилгаа шаардлагатай, сэтгэцийн өвчтэй асран хамгаалагчгүй 4 хүүхэд амьдарч байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харъяа Сургалт, хүмүүжлийн тусгай байгууллага, 407 дугаар нээлттэй, хаалттай хорих ангид хүмүүжиж байгаа хүүхэд, эмэгтэйчүүдтэй уулзалт хийж, нөхцөл байдлын үнэлгээний дагуу нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулсан байна.

Цаашид хүүхдийн хөгжил, хамгааллыг гэр бүлд түшиглэн хэрэгжүүлэх бодлогын хүрээнд төрийн зайлшгүй асрамж, халамж шаардлагатай хүүхдийг төвлөрсөн асрамжийн газарт биш гэр бүл, түүнтэй дүйцэх орчинд төрөл садны болон асралт гэр бүлд өсгөн хүмүүжүүлэх бодлого баримталж, тус үйлчилгээнд шаардагдах хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай.

2.5.Эрүүл мэнд ба нийгмийн халамж

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрх

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухайн конвенцод “Хөгжлийн бэрхшээлтэй хүн гэдэгт бие махбод, сэтгэл мэдрэл, оюун санаа, мэдрэхүйн байнгын согогтой бөгөөд уг согог нь янз бүрийн саад тотгортой нийлсний улмаас бусдын нэгэн адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцоход нь саад учруулахуйц болсон хүнийг багтааж ойлгоно”²⁵⁰ гэжээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хувьд зарим хүүхэд төрөлхийн эрүүл мэндийн байдал, согогийн улмаас хөгжлийн бэрхшээлтэй байдаг бол зарим нь гэмтэл бэртэл, өвчин, хоол тэжээлийн дутагдал зэргээс хөгжлийн бэрхшээлтэй болдог. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоонд тархины саажилт, нугасны ивэрхий, булчингийн сулрал, нуруу нугасны гэмтэл, Дауны синдром, мөн хараа, сонсгол, бие махбод, харилцааны болон оюун ухааны согог зэрэг эрүүл мэндийн нөхцөл байдалтай хүүхэд багтана²⁵¹.

Дэлхий нийтийн хэмжээнд үл хүндлэл, ялгаварлан гадуурхалтад хамгийн ихээр өртөн, нийгмийн амьдралаас тусгаарлагдсан хүмүүсийн тоонд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд багтдаг байна.

Монгол Улсын нийт хүн амын 36.2 хувийг 0-18 хүртэлх насны хүүхэд эзэлж байгаа бөгөөд үүнээс 11.435 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байна.

²⁵⁰ Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенц http://www.forum.mn/res_mat/2012/UNDP%20konwenzi_book.pdf

²⁵¹ Бага насны хүүхдийн хөгжил, хөгжлийн бэрхшээл-Асуудал дэвшүүлсэн тайлан. ННФ http://apps.who.int/iris/bitstream/handle/10665/75355/9789997332028_mon.pdf?sequence=9&isAllowed=y

НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенц нь дэлхийн бүх хүүхэд, тэр дотроо хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хамаатай. Конвенцод хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаар тусгайлан дурдсан нь үл гадуурхах, хөгжлийн бэрхшээл бол ялгаварлан гадуурхалтаас хамгаалагдах үндэс мөн гэж, эдгээр эрхийг хэрэгжүүлэхийн тулд оролцогч улсуудын зүгээс гаргах хүчин чармайлтыг онцолсон байдаг. Хүүхдийн эрхийн конвенцын хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий НҮБ-ын Хүүхдийн эрхийн хороо “Ерөнхий зөвлөмж 9” нэртэй баримт бичигтээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийг хэрэгжүүлэх чиглэлээр конвенцын бүх зүйл, заалтыг багтаасан зөвлөмжийг Конвенцод нэгдэн орсон улс орнуудын төр засагт хүргүүлсэн байна.

Улсын Их Хурлаас 2016 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг батлан гаргасан нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эрх ялангуяа сурч боловсрох эрхийг баталгаажуулж, тэдний амьдрах орчныг сайжруулах, нийгмийн халамж үйлчилгээний талаар нарийвчлан зохицуулж өгсөн.

Хөгжлийн бэрхшээлтэй 2-5 насны хүүхдийн сурч хөгжих эрхийг хангах асуудал хүндрэлтэй асуудлын нэг байсаар байна. Монгол Улсад ганцхан байдаг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг хүлээн авдаг 10 дугаар цэцэрлэгийн барилгыг шинээр барих асуудал 5 дах жилдээ шийдэгдэж чадаагүй л байна. 2018 оны 6 дугаар сард Засгийн газраас цэцэрлэгийн барилгыг 5.3 тэрбум төгрөгөөр барихаар шийдвэрлэсэн боловч ахиц гарсан зүйл байхгүй байна. Тус цэцэрлэгийн барилга ашиглалтад орвол хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй, сургуульд суралцах боломжгүй хүүхдүүд 18 нас хүртлээ цэцэрлэгт хамрагдаж нийгэмших боломжтой болох юм.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцын 24 дүгээр зүйлд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хөгжлийн бэрхшээлийн улмаас ерөнхий боловсролын үйлчилгээний гадна үлдэх ёсгүй бөгөөд бусад хүүхдийн адил амьдарч байгаа орон нутагтаа чанартай бага болон дунд боловсролд үнэ төлбөргүй тэгш хамрагдах эрхтэй гэж заажээ.

Манай улсад хөгжлийн бэрхшээлтэй хэдэн хүүхэд хаана, хэнтэй хэрхэн амьдарч буй талаар нэгдсэн тоо баримт өнөөг хүртэл байдаггүй. Төрийн байгууллагуудаас гаргасан статистик мэдээллүүд ч өөр хоорондоо зөрүүтэй байна.

Тухайлбал, улсын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд суралцдаг зургаан тусгай сургууль байдаг ч эдгээр сургуульд нийт 1700 орчим хүүхэд суралцдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын энгийн ангид сургах асуудлыг хүндрэлтэй асуудал хэвээр байна. Ихэнх багш хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ангидаа авч сургахдаа амжилттай сургаж чадна гэдэгт эргэлздэг. Энэ нь энгийн сургуульд ажиллаж буй багш нарын хандлага, ойлголт, заах арга эзэмшсэн байдал, ур чадвартай нь холбоотой юм.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийг хангах, нийгмийн хамгааллын чиглэлээр хийгдэж байгаа зарим ажлуудаас дурдвал:

- БНХАУ-ын буцалтгүй тусламжаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төв”-ийг барьж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, эцэг эхчүүдэд зориулсан сургалт, хөгжлийн арга хэмжээг зохион байгуулахаас гадна 250 хүүхэд хэвтэн эмчлүүлэх, 250 хүүхдэд өдрөөр сэргээн засах үйлчилгээ үзүүлэх хүчин

чадалтай, иж бүрэн, цогц үйлчилгээ үзүүлэх төвийг 2019 онд ашиглалтад оруулах төлөвлөгөөтэй.

- “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдэд зориулсан тусгай тоноглол бүхий спорт цогцолбор”-ыг техник хамтын ажиллагааны төслийг эхлүүлж байна. Тус цогцолбор нь спортын 10 төрлөөр хичээллэх орчин үеийн тоног төхөөрөмжөөр хангагдах ба жилийн 4 улиралд 200-400 тамирчин тогтмол хичээллэх боломжтой, 200 метрийн тойрог замтай, битүү дээвэртэй манеж бүхий гадна талдаа дэлхийн стандартад нийцсэн 400 метрийн тартан замтай, 200 тамирчин байрлах зочид буудалтай иж бүрэн цогц байдлаар байгуулах юм.
- Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах” 5 жилийн хугацаанд хэрэгжих техник туслалцааны төсөл энэ оноос эхэлнэ. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг эрт оношилж, эмчлэх, хөгжүүлэх үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай туслах хэрэгсэл, программ хангамж, дэд бүтцийг сайжруулна.
- Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх сэргээн засах үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор “Нялхсын клиник сувилал”-ын үйл ажиллагааг дэмжих, үйл ажиллагааг нь өргөжүүлэх зорилгоор шаардлагатай тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлж байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг нийгэмшүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй, байнгын асаргаа, сувилгаа шаардлагатай хүүхдийн эрхийг хангах зорилгоор “Хамтдаа инээмсэглэе” арга хэмжээний хүрээнд хүүхдийн зуслангийн тусгай ээлжийг Монголд анх удаа зохион байгуулсан. Тус арга хэмжээнд 8 аймаг, нийслэлээс 150 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, 150 асран хамгаалагчийн хамтаар оролцсон. Арга хэмжээний хүрээнд хүүхдийн чадамжийн үнэлгээ хийх, асран хамгаалагчид нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлж, хувь хүний хөгжлийн сургалтуудыг зохион байгуулсан.

Зөвлөмж: Тус улсыг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оролцоог хангах цогц стратегийг хүний эрхэд суурилсан зарчимд тулгуурлан яаралтай баталж дараах арга хэмжээг хэрэгжүүлэхийг шаардаж байна. Үүнд:

- (a) Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүү, арга зүй, хүний нөөцийг хангалттай хувиарлахад анхаарах;
- (b) хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тусгай сургууль, ангид сургахаас илүүтэйгээр тэгш хамруулах боловсролыг чухалчлах;
- (c) Хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, сэргээн засах хөтөлбөрт хамруулах зэрэг эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээг яаралтай авах;
- (d) Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эерэг дүр төрхийг нийгэмд бүрдүүлэхийн тулд төрийн албан хаагчид, олон нийт, гэр бүлд чиглэсэн ойлголт нэмэгдүүлэх кампанит ажлуудыг өрнүүлэх.

Хүүхдийн эрүүл мэнд

УИХ-аас 2011 онд баталсан Эрүүл мэндийн тухай хуульд 18 хүртэл насны хүүхдэд төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлыг төр хариуцахаар тусгасан. Энэхүү хуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд харьяа анхан, дунд шатны эрүүл мэндийн төвийн байнгын

хяналтад байж тусламж, үйлчилгээ авах, 16 хүртэл насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эмийн зардлыг төр хариуцах, өрх, сумын эрүүл мэндийн төвд хүүхдийн мэргэшсэн эмч ажиллаж байна.

Эх хүүхдийн тусламжийг анхан шатны эрүүл мэндийн байгууллага болох өрх, сумын эрүүл мэндийн төв, аймаг, дүүргийн Нэгдсэн эмнэлэг, Эх хүүхдийн эрүүл мэндийн төв зэрэг 3 шатлалаар үйлчлэх болсон нь эмнэлгийн ачааллыг бууруулахад эерэг нөлөөлөл үзүүлж байна.

“ХДХВ/ДОХ-оос сэргийлэх тухай”, “Сэтгэцийн эрүүл мэндийн тухай” болон “Тамхины хяналтын тухай” хуулийн хүрээнд өсвөрийн үеийнхний эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үйлчилгээг сайжруулах, болзошгүй эрсдэлийг бууруулахад чиглэж байна.

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар тамхины хэрэглээ, дам тамхидалтаас хүн амыг хамгаалах эрх зүйн орчинг сайжруулж, сургуулийн орчинд 500 м –ийн дотор тамхи зарах, 18 нас хүрээгүй хүнд тамхи худалдах, түүгээр тамхи худалдуулахыг хориглосон. Монгол Улсад эрэгтэйчүүдийн дунд архи, согтууруулах ундааны хэрэглээ эмэгтэйчүүдтэй харьцуулахад илүү байна. Эмэгтэйчүүдийн 20.9 хувь нь архи огт ууж үзээгүй байхад 0.8 хувь нь 15 нас хүрэхээсээ өмнө архи, согтууруулах ундаа ууж үздэг байна.

Боловсрол

Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд 2018 онд боловсролын салбар дахь хүүхэд хамгааллын асуудалд анхаарал хандуулж, хүүхдийн эрхийн зөрчил, хүүхдийн эсрэг хүчирхийллийг бууруулах, хүүхдийн хөгжил, оролцоог дэмжих, багш, эцэг эхийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, хүүхдэд ээлтэй сургалтын орчин нөхцөлийг сайжруулахад чиглэсэн **“Хүүхэд хамгааллын жишиг сургууль”** загварыг улсын хэмжээнд ерөнхий боловсролын 31 сургууль дээр 2018-2019 оны хичээлийн жилд хэрэгжүүлж байна.

2017-2018 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 729 сургуульд 572,8 мянган хүүхэд суралцаж байна. ЕБС-ын дотуур байранд 35,2 мянган хүүхэд суралцаж байгаагийн 73% нь малчдын хүүхэд байна.

2017 онд улсын төсвөөс 9 цэцэрлэг, нийслэлийн төсвөөс 2 цэцэрлэг ашиглалтад орж, төрийн бус өмчийн 47 цэцэрлэг шинээр нэмэгдэж, үйлчилгээний хүчин чадал 4307-аар нэмэгдсэн байна.

ЕБСургууль шинээр 16-аар нэмэгдэж, суралцах хүүхдийн тоо 24,4 мянгаар нэмэгдэж байна. 1 дүгээр ангид 76,4 мянган хүүхэд элсэн орж байна.

2018-2019 оны энэ хичээлийн жилд 1435 цэцэрлэг үйл ажиллагаа явуулна. Төрийн өмчийн 889, /үүнээс 27 нь төмөр замын харъяа/ хувийн хэвшлийн 546 цэцэрлэг байна. Урьдчилсан мэдээгээр 260000 хүүхэд сургуулийн өмнөх боловсролд хамрагдах тооцоо байна.

Улаанбаатар хотын хувьд цэцэрлэггүй 21 хороо байна. Улсын хэмжээнд цэцэрлэгт хамрагдалт 74.6 хувь, нийслэлд 76 хувьтай байна. Цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байгаа 73500 хүүхэд байна.

Нийслэлийн хэмжээнд сурагчдын замын хөдөлгөөнд оролцоход аюулгүй байдлыг хангах зорилгоор нийт 5 дүүргийн 34 сургууль 104 автобусаар өөрийн сургуулийн 3424 суралцагчдад зохион байгуулалттай тээврийн үйлчилгээ үзүүлж, Сонгинохайрхан дүүргийн нийт 12 сургуулийн сурагчдад тусгай маршрутын автобусаар үйлчилж байна.

2013 оноос эхлэн Нийслэлийн ИТХ-ын шийдвэрийн дагуу бүх дүүргийн 154 сургуульд “School Policy” эргүүлийн хөдөлгөөн өрнөж, 48217 эцэг эх сургуулийн орчинд үйлдэгдсэн 1500 хэрэг зөрчлийг илрүүлж, 460 гаруй удаа урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулсан нь хүүхдийг сургуулийн орчимд зам тээврийн ослоос урьдчилан сэргийлсэн үр дүнтэй арга хэмжээний нэг гэж үзэж байна.

Бага ангийн сурагчдыг “Үдийн цай” хөтөлбөрийг Үдийн хоол болгох, эмзэг бүлгийн өрхийн хүүхдийг хичээлийн хэрэгслээр хангах ажлыг үргэлжлүүлэн, төрөөс сурагчдыг сурах бичгээр хангах, дотуур байрны хамрагдалтыг нэмэгдүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлж байна.

2.6.Тусгай хамгааллын арга хэмжээ

Хүүхдийн хөдөлмөр

Хүүхдийн хөдөлмөр нь сурч боловсрох, эрүүл байх боломжийг үгүйсгэж, ядуурлыг гүнзгийрүүлж байдаг тул хүний үндсэн эрхийн зөрчил гэж үздэг.

Монгол Улсад 5-17 насны хүүхдийн 10 хувь буюу 56.000 гаруй хүүхэд хөдөлмөр эрхэлж байгаагийн дийлэнх нь ХАА /хурдны морь унаж уралдах зэрэг/, уул уурхай, барилгын салбарт ажиллаж байна.²⁵² Хот, суурин газартай харьцуулахад хөдөө орон нутагт ядуу өрх олон байхын хэрээр хүүхдүүд хөдөлмөр эрхлэх нь элбэг байна. Боловсрол дахь жендерийн тэгш бус байдлын улмаас охидтой харьцуулахад хөвгүүд хөдөлмөр эрхлэх илүү эрсдэлтэй, харин охидын хувьд гэрийн ажил хийх нь их байдаг.

Хүүхдийн хөдөлмөрийг тодорхойлох нь маш түвэгтэй. Энэ нь тэдний хүүхэд нас, хөгжих боломж, хүний эрхэм чанарыг үгүйсгэж, тэдний бие бялдар, оюун ухааны хөгжилд сөргөөр нөлөөлдөг.

Шигтгээ: Хөдөлмөрийн тухай хуульд 15 хүртлэх насны хүүхэд ажил эрхлэхийг зөвшөөрөхгүй, 15 настай хүүхдүүд эцэг эх, асран хамгаалагч болон төрийн байгууллагын зөвшөөрлийн үндсэн дээр мэргэжлийн чиг баримжаа эзэмших, тодорхой чадвартай болгох ба 16 нас хүрсэн хүүхдүүд ямарваа нэгэн зөвшөөрөл шаардахгүйгээр хөдөлмөрийн гэрээ байгуулж болохоор заажээ. Хөдөлмөрийн хууль нь хүүхдийн насны байдалд харгалзуулан ажлын цагийг хязгаарлаж илүү цагаар болон олон нийтийн баяр, амралтын өдрүүдэд ажиллахыг хоригложээ.

Хүүхдийг хэт эрт хөдөлмөр эрхлэхээс сэргийлэхийн тулд ОУ-ын Хөдөлмөрийн байгууллагын 138-р конвенцод хөдөлмөрийн насны доод хязгаарыг заавал эзэмших боловсролыг бүрэн эзэмших наснаас багагүй буюу ямар ч тохиолдолд 15 наснаас багагүй байхаар тодорхойлсон байна.

Монгол Улс 2001 онд нэгдсэн орсон 1999 оны Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн тухай конвенцын 3 дугаар зүйлд Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг тодорхойлжээ.

²⁵² Хүүхдийн хөдөлмөр-Монгол Улсын бодлогын хураангуй, 2016 https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---asia/---ro-bangkok/---ilo-beijing/documents/publication/wcms_508366.pdf

- ✚ Хүүхдийг худалдах, өрийн барьцаанд өгөх, боолчлох, албадан хөдөлмөр эрхлүүлэх, зэвсэгт мөргөлдөөнд дайчлах, хүчээр элсүүлэх зэрэг боолчлолын бүх хэлбэрүүд, түүнтэй төстэй практикууд;
- ✚ Хүүхдийн биеийг үнэлүүлэх, садар самуун агуулга бүхий материал үйлдвэрлэх, садар самууны үзвэр, үйлчилгээнд ашиглах, татан оролцуулах, уг ажлыг санал болгох;
- ✚ Холбогдох олон улсын гэрээнд заасанчлан мансууруулах бодис үйлдвэрлэх, хил дамнуулан худалдах зэрэг хууль бус үйл ажиллагаанд ашиглах, зуучлах, эсвэл санал болгох;
- ✚ Үйл ажилагааны мөн чанар үр дагаврын хувьд хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, зан суртахуунд хохирол учруулахуйц ажлууд орно.

Засгийн газраас 2011 онд Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хүнд хэлбэрийг устгах үндэсний хөтөлбөрийг баталсан нь зохих үүрэг гүйцэтгэж байна. Хөтөлбөрийн үндсэн зорилгыг 2016 он гэхэд хүүхдийн хөдөлмөрийг тэвчишгүй хэлбэрийг бүрэн устгах гэж тодорхойлоод хүүхдийн хөдөлмөрийг зохицуулах хууль тогтоомжийг нэгдэн орсон олон улсын гэрээ конвенцын зарчимд нийцүүлэх, энэ чиглэлээр хууль сахиулах чадамжийг сайжруулах, хөдөлмөр эрхэлж байгаа, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрт өртсөн хүүхдүүдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилтуудыг дэвшүүлжээ.

2016 онд барилгын салбарын бүх төрлийн ажлыг хүүхдийн тэвчишгүй хөдөлмөрт оруулаад байгаа. Мөн морь унаач хүүхдүүдийг өвөл, хаврын улиралд болон шөнийн цагаар уралдаанд оролцохыг хориглосон. Энэ мэтээр хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийг бууруулах, тэвчишгүй хэлбэрийг устгах зорилт аажим аажмаар урагшилж буй.

Өнөөгийн байдлаар уул уурхай, хөдөө аж ахуй, барилга, тээвэр, зочид буудал, боловсруулах үйлдвэр зэрэг 11 салбарын 79 ажлын байрыг хүүхэд эрхэлж болохгүй, хүнд ажлын байранд тооцдог.

Ажил эрхэлж байгаа арван хүүхдийн найм нь хөдөө аж ахуйн салбарт, нэг нь бөөний болон жижиглэн худалдаа, засвар үйлчилгээний газарт ажиллаж байна. Мөн 15-17 насныхан уул уурхай, олборлолт, боловсруулах үйлдвэрт ажиллаж байна. Судалгааны тархалтын тооцоогоор 5-17 насны 1857 хүүхэд өрхөөс гадуур эдийн засгийн ажиллагаа эрхэлж байх бөгөөд тэдний 65,4 хувь нь сургуульд сурдаг байв. Ажил эрхэлдэг нийт хүүхдийн 2,0 хувь цалин хөлстэй ажил эрхэлж байна. Эдгээр хүүхдийн 11.1 хувь хүнд хортой болон аюултай ажил хийж байна.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Швейцарын хөгжлийн агентлаг, олон улсын хөдөлмөрийн байгууллагатай хамтран бичил уурхай болон албажаагүй ил уурхайд хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн тоог гаргасан байна. 11 аймагт хийсэн тус судалгаагаар 8-18 насны 1498 хүүхэд уурхайд хөдөлмөр эрхэлж байсан бөгөөд хүүхдүүдийн дийлэнх нь гэр бүлээ даган уурхайд ажиллаж байжээ.²⁵³

²⁵³ Хууль зүй, дотоод хэргийн сайдын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай асуулгын хариу. 2018.05.11

Зөвлөмж: а/ 2012-2016 онд хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах үндэсний хөтөлбөрийн санхүү төсөв, менежмент хангалтгүй байсны улмаас уг хөтөлбөр сайн хэрэгжээгүйд дүгнэлт хийж, Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах үйл ажиллагааны цогц төлөвлөгөө, бодлогыг хангалттай төсөв, санхүү, арга зүй, хүний нөөцтэйгээр батлах;

б/15-аас доош насны хүүхэд хөдөлмөр эрхлэхгүй байхад анхаарах.

Уралдаанч хүүхэд

Хурдан морь унаж уралдах нь Монголын уламжлалт соёлын нэг хэсэг. Наадам арга хэмжээг 2010 онд ЮНЕСКО-гийн Хүн төрөлхтний биет бус соёлын өвийн жагсаалтад бүртгүүлсэн байна.

Хурдны морь унаж уралдах нь хүүхдийн хөдөлмөр төдийгүй хөдөлмөрийн мөлжлөгийн хэлбэр гэж НҮБ-ийн Хүүхдийн хороо үзсэн байна.

Уралдаанч хүүхдийн аюулгүй байдлыг хангах талаар нөлөөллийн олон талын арга хэмжээ авч байна. Уралдаанч хүүхдийн бүртгэлийн систем бий болж, уралдаан бүрийг түүнд оролцох хүүхэд бүрийн аюулгүй байдлыг хянах мэдээллийн нэгдсэн сан²⁵⁴ бий болгосон.

Засгийн газар, Стандарт, хэмжил зүйн газар хамтран “Үндэсний морин уралдааны морь унаач хүүхдийн хамгаалалтын хувцас, морины хэрэгсэлд тавих шаардлага” MNS 6264:2011 стандартыг 2018 оны 5 дугаар сард шинэчлэн батлуулсан.

Уралдаанч хүүхдийн амьдрах нөхцөл, сурах боломжийг сайжруулах, эдгээр хүүхдийг хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрт өртөх, эдийн засгийн мөлжлөгт орохоос нь сэргийлэх, хүүхдийн дээд эрх ашгийг хамгаалах асуудлаар хамтран ажиллахаар 30 шахам тал Санамж бичигт гарын үсэг зурж төв, орон нутгийн түвшинд шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Тухайлбал, уралдаанч хүүхдэд хамгаалалтын хувцас, хэрэглэл хэрэглэдэг болсон, өвөл, хаврын уралдаанд 16 хүртэл насны хүүхэд оролцуулахыг хориглох байр суурийг хүүхдийн эрхийг хамгаалах байгууллагууд барьж байна.

Унаач хүүхдийн дийлэнх нь амьжиргааны түвшин доогуур айлын хүүхэд байдаг. Эхчүүдийн боловсролын түвшин, өрхийн амьжиргааны түвшин дээшлэх тусам хүүхэд хурдан морь унах нь буурах хандлагатай байна. Хурдан морь унаач хүүхдийн нийгмийн хамгааллын асуудлын нэг хэсэг нь ослын даатгал болон морины эзэнтэй хийх гэрээ, урамшуулал юм.

Тиймээс хурдан морины уралдаанч хүүхдийн гэнэтийн ослын даатгалын нөхцөлийг сайжруулж, даатгалын хураамжийг 100,000 төгрөг болгож, 20,0 хүртэл сая төгрөгийн нөхөн олговрыг олгуулах асуудлаар Санхүүгийн зохицуулах хороо, даатгалын компаниудтай хамтран ажиллаж байна.

²⁵⁴ www.unaach.nac.gov.mn

2018 онд хурдан морины уралдаанч хүүхдийг био сканаар бүртгэж, мэдээллийг цахим бүртгэлд оруулах ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулсан.

Зөвлөмж: Морины эзэд, уяачдын зүгээс учруулсан бие махбод, сэтгэл санааны хүчирхийлэлд өртөх, сургууль завсардах, гэмтэж бэртэх, амь насаа алдах эрсдэлд унаач хүүхдүүд өртсөөр байгаад Хороо маш их харамсаж байна.

а/ Жил бүрийн 11 дүгээр сарын 1-нээс тавдугаар сарын 1-нийг хүртэлх хугацаанд 16-аас доош насны хүүхдээр хурдан морь унуулахыг хориглосон шийдвэрийг 18 наснаас доош хүүхдээр хурдан морь унуулахыг хориглох үйл явцын эхний алхам гэж үзэн хэрэгжилтийг нь сахиулахад хатуу анхаарах

б) Хурдан морины уралдаанд оролцож байгаад хүндээр гэмтсэн амь насаа алдсан хүүхдүүдийн хэргийг мөрдөн шалгаж буруутай этгээдэд хариуцлага ноогдуулах;

в) Хурдан морины уралдаан гэх мэт аюултай, хортой хүүхдийн хөдөлмөрт хүүхдийг оролцуулдаг бизнес эрхлэж буй төрийн албан хаагчдын хувийн болон албаны ашиг сонирхлын зөрчил гаргаж буй үйлдэлд арга хэмжээ авах, ийм үйлдэл гаргуулахгүй байхад чиглэсэн хээл хахуулийн эсрэг арга хэмжээнүүдийг авах.

Бэлгийн мөлжлөг болон хүчирхийлэл

Монголд эмэгтэйчүүдийг БНХАУ, Макао, Гонконг, БНСУ, Сингапур, Тайван, Турк, Израил, Япон, Малайз болон Европын Холбооны Улсуудад худалдсан хэрэг бүртгэгдэх болсноор хүний наймааны илгээгч улс орон болж байна гэж ЦЕГ мэдээлсэн. 2009-2013 онд 113 хохирогчтой хүний наймаатай холбоотой 94 хэрэг бүртгэсэн. Үүнээс 54 хэргийн хохирогч БНХАУ-ын Эрээн, Хөх хот, Макао, Хайнан зэрэг газарт, Солонгос, Сингапур, Энэтхэг, Египет, Африк зэрэг улсад худалдагдсан, тэдгээрийн 41 нь 16-17 насны хүүхэд байсан юм. Харин үлдсэн 40 хэргийн хохирогч нь дотооддоо буюу эх орондоо хүний наймааны хохирогч болсон байна²⁵⁵.

2010–2014 онд бэлгийн мөлжлөг, хүүхдийг хил дамнуулах худалдаалах асуудлаар 8 төрлийн судалгаа хийж, үр дүнг нь холбогдох байгууллага олон нийтэд мэдээлсэн байна. Хүний аюулгүй байдлын судалгааны төв, Хүүхдийн эрхийн үндэсний төв, ТББ-ууд хамтран хийсэн “Өсвөр насны хүүхдийн садар самуун, бэлгийн мөлжлөгт өртөж буй талаарх судалгаа”-аар асуулгад оролцогчдын 89 хувь нь хүний наймааг “Ноцтой асуудал” хэмээн тодорхойлсон байна. Хүний наймааны төрөл, хэлбэрийн хувьд бэлгийн мөлжлөг болон хуурамч гэрлэлтийг хамгийн түгээмэл хэлбэр гэж үзсэн байна. Асуулгад оролцогчдын 41,6 хувь нь 20-24 насны, 34,7 хувь нь 15-19 насныхан буюу залуу, өсвөр насны хүүхэд ихэвчлэн хүний наймааны гэмт хэрэгт өртөж байна гэж үзсэн байна.

Мөн уран нугаралтын үзүүлбэрээр хилийн чанадад гэрээгээр ажиллах явцдаа хөдөлмөрийн мөлжлөг, хүний наймаанд өртөх эрсдэлтэй байдалд орсон үед гадаад дахь Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газрууд, Эрүүгийн цагдаагийн газар хамтран ажиллаж, хүүхдийг эх оронд нь буцаасан тохиолдол ч гарсаар байна.

2009 оноос Хил хамгаалах ерөнхий газар “Хүүхэд, эрх зүйн чадамжгүй хүнийг улсын хилээр нэвтрүүлэх журам”-ыг нарийвчлан боловсруулж 7-оос доош насны хүүхдийг зөвхөн эцэг эх буюу хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хамт улсын хилээр нэвтрүүлэхээр болсон. Энэ нь бага насны хүүхдийг хүний наймаанд

²⁵⁵ Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ийн конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Засгийн газрын тавдугаар тайлан илтгэл, 2014 он, 86 дахь тал

өртөхөөс урьдчилан сэргийлэх нэг хэлбэр юм.

2012 онд шинэчлэн найруулсан Нийгмийн халамжийн тухай хуулийн дагуу хүчирхийлэлд өртсөн иргэнд халамжийн үйлчилгээ үзүүлж байна. Мөн Гэр бүлийн тухай хууль болон хүчирхийллийн улмаас сэтгэл санааны болон бие махбодын хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэдэд халамжийн тэтгэмж олгож дэмжлэг туслалцаа үзүүлж байна.

Хууль зөрчсөн болон гэрч, хохирогч хүүхэд

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйл, Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны журмын дагуу хууль зөрчсөн, гэмт хэргийн гэрч, хохирогч болсон хүүхдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх чиг үүрэгтэй салбар дундын “Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо” байгуулагдан ажиллаж байна.

Шадар сайдын 2012 оны 28 тоот тушаалаар “Хүүхдийн хууль зүйн хорооны нийтлэг журам”-ыг баталжээ. Нийслэлийн бүх дүүрэг болон аймгуудад Засаг даргаар ахлуулсан Хүүхдийн хууль зүйн хороо байгуулагдаад байна. Орон нутаг дахь “Хүүхдийн хууль хороо” нь гэмт хэрэгт холбогдсон хүүхдийг аль болохоор хорих ялаас чөлөөлөх, ял эдлэх хугацааг хойшлуулах нөхцөлийг судалж, холбогдох байгууллагад санал дүгнэлт гаргаж байна. Улсын хэмжээнд 2018 оны эхний 7 сарын байдлаар насанд хүрээгүй хүүхдийн үйлдсэн нийт 473 гэмт хэрэгт 477 хүүхэд холбогдсон нь өнгөрсөн оны мөн үеэс 60 хэргээр буюу 11.3 хувь, гэмт хэрэгт холбогдсон хүүхэд 129 буюу 21.3 хувиар тус тус буурсан.

Улсын хэмжээнд 2017 онд гэмт хэрэг зөрчилд холбогдсон, гэмт хэргийн улмаас хохирсон 618 хүүхдэд, **2018 оны хагас жилд 897** хүүхдэд үйлчилгээ үзүүлсэн.

Хууль зүйн хороогоор үйлчлүүлсэн хүүхдийн мэдээллийн сан үүсгэх, Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны гишүүдийг чадавхжуулах, хамтарсан баг, хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагааг уялдуулах, Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны ажил үйлчилгээг үнэлэх аргачлалыг боловсруулж байна.

Хүүхдийн эрхийн хэрэгжилтэд хяналт тавих, Зөрчлийн тухай хуульд заасан хүүхдийн эсрэг 16 төрлийн зөрчлийг шалган шийдвэрлэх чиг үүрэгтэй ажиллах хүүхдийн эрхийн байцаагчийг хуульд заасны дагуу сонгон шалгаруулж, сургалтад хамруулан, 32 албан хаагчид Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн эрх олгосон. 2017 онд 26 зөрчлийг, 2018 оны эхний хагас жилийн байдлаар 83 зөрчлийг шалган шийдвэрлэсэн байна.

Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны журмын дагуу аймаг, дүүрэгт хууль зөрчсөн, гэмт хэргийн гэрч, хохирогч болсон хүүхдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх чиг үүрэгтэй салбар дундын “Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо” байгуулагдан ажиллаж, 2017 онд 618 хүүхдэд, 2018 оны 2 дугаар улирлын байдлаар 897 хүүхдэд эрх зүйн туслалцаа, зөвлөгөө, үйлчилгээ үзүүлсэн байна.

УИХ 2013 онд баталсан Төлбөрийн чадваргүй яллагдагчид эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай хуулийн үйлчлэлд гэмт хэрэгт холбогдсон хүүхэд эрх зүйн туслалцааг үнэ төлбөргүй авах зохицуулалтыг оруулж өгсөн. Хууль зүйн сайд, Сангийн сайд нарын хамтарсан 2014 оны тушаалаар Хууль зүйн туслалцааны төвийн салбаруудын орон тоо, байршлыг баталсан. Хууль зүйн туслалцааны төв нь ажлын алба, 32

салбартайгаар улсын хэмжээнд хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааг явуулж байна.

Насанд хүрээгүйчүүдийн хорих ангийн дэргэд 2000 оноос хойш ажиллаж байсан хөдөлмөрийн төрөлжсөн сургалттай суурь боловсрол олгох тусгай сургуулийг 2013 оноос бүрэн дунд сургууль болгон өөрчилж, ял эдэлж байгаа хүүхэд боловсролоо үргэлжлүүлэн эзэмших эрх бүрэн хангагдах нөхцөлийг бүрдүүлж суурь болон бүрэн дунд гэрчилгээ олгодог боллоо. Хүүхдийн боловсролын гэрчилгээ дээрээ хорих ял эдэлж байсан гэсэн тэмдэглэгээ хийхгүй байгаа нь ирээдүйд учирч болзошгүй ялгаварлан гадуурхалтаас хамгаалахад чухал үүрэгтэй.

Ял эдэлж байгаа хүүхдийг мэргэжлийн сургалтад хамруулж, сүүлийн арваад жилд 539 хүүхэд талх, нарийн боов, жижиг урлал, гар хивс, ноосон эдлэл, мужаан, барилгын засал чимэглэл, тогооч, өрөгч угсрагчийн мэргэжилд суралцан мэргэжлийн үнэмлэх сертификат авсан байна. Мэргэжлийн сургалтыг олон улсын болон бусад төрийн бус байгууллагуудын дэмжлэг туслалцаатай зохион байгуулдаг юм.

Хүүхдийн эрхийн зөрчлийг шалган шийдвэрлэх замаар хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, Зөрчлийн тухай хуульд заасан хүүхдийн эсрэг 16 төрлийн зөрчлийг шалган шийдвэрлэх, хууль сурталчилах чиг үүрэгтэй 32 хүүхдийн эрхийн улсын байцаагч ажиллаж байна. 2017 онд 26 зөрчил, 2018 онд 181 зөрчлийг шалган шийдвэрлэлээ. Хүүхдийн эрхийн улсын байцаагч нар “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”-ын дагуу хяналт шалгалт хийх, дотуур байр, сүм хийд, интернет тоглоомийн газруудад төлөвлөгөөт хяналт, шалгалт хийж, зөвлөн туслах, зөрчлийг илрүүлэх, шалгах, хууль сурталчилах үйл ажиллагаа зохион байгуулж ажиллаж байна. Зөрчлийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 5,6,7,8,9 дүгээр зүйлтэй уялдуулж, тухайн орчинууд дахь хүүхдийн эрхийн зөрчлийг шалган шийдвэрлэх зохицуулалтыг тодорхой болгох саналыг нэмэж орууллаа.

Хүүхдийн тусламжийн утас-108

Засгийн газрын 2016 оны 55 дугаар тогтоолоор Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дэргэд “Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв”-ийг байгуулж, сард дунджаар 10 мянга гаруй дуудлага хүлээн авч, хүүхэд өсвөр үеийнхэнд зөвлөгөө, мэдээлэл өгч, хүүхэд хамгааллын шуурхай тусламж үзүүлэн ажиллаж байна. Уг төв нь 2017 онд хүүхдийн эрх, хамгаалалтай холбоотой 4490 тохиолдлыг, 2018 оны 2 дугаар улирлын байдлаар 1320 тохиолдлыг аймаг орон нутгийн гэр бүл, хүүхэд залуучуудын газар /хэлтэс/, хамтарсан багт шилжүүлсэн байна. Мөн “Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ түр хамгаалах байр”-ыг Засгийн газрын 2017 оны 231 дүгээр тогтоолоор байгуулж, байгуулагдсанаас хойш 0-18 хүртэлх насны 561 хүүхдийг хүлээн авч, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлсэн байна.

Хүүхдийн тусламжийн 108 утас 2017 онд **144.869** дуудлага хүлээн авсны 3173 дуудлагыг аймаг, орон нутгийн ГБХЗХГ, хэлтэс, хамтарсан багт шилжүүлснээс 63%-ийг шийдвэрлэсэн байна.

Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвд 2018 оны хагас жилийн байдлаар нийт **84.819** дуудлага хүлээн авч утсаар анхан шатны нийгэм-сэтгэл зүйн тусламж үйлчилгээг үзүүлсэн. Үүнээс:

- зорилтот 38.581 дуудлага;
- хүүхэд хамгааллын үйлчилгээ шаардлагатай 14.035 дуудлага;
- хүүхдийн эрхийн зөрчлийн тухай 1099 дуудлага;
- зөвлөлгөө хүссэн 3585 дуудлага;
- мэдээлэл хүссэн 16.616 дуудлага;
- чимээгүй 10.896 дуудлага;
- санал гомдол 133 дуудлага;
- 27 дуудлагыг хяналтанд буюу хариу үйлчилгээнд холбон зуучилсан.

Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвд ирсэн сургуулийн орчин дахь үе тэнгийнхний дарамт, хүчирхийлэл, орчны аюулгүй байдал хангалтгүй, багш, сурган хүмүүжүүлэгчдийн зүгээс хүүхэдтэй зүй бус харилцсан зэрэг дуудлагад анализ хийж, туршилтын төслийг шалгуур үзүүлэлтийн дагуу сонгож, 21 аймаг, 9 дүүргийн 31 сургууль дээр хэрэгжүүлж байна. Төслийн хэрэгжилтийн хүрээнд хүүхэд бүрт хүрсэн хөгжлийн хөтөлбөртэй, хүүхэд бүрийн оролцоог хангасан дугуйлан секцтэй, сургуулийн дотоод, гадаад орчны эрүүл, аюулгүй байдал сайжирч, сургууль бүр “Хүүхэд хамгааллын бодлого”-той болох юм. Тус төслийн сайн туршлагыг 2019 онд үндэсний хэмжээний Ерөнхий боловсролын сургуульд (798 сургууль)-д түгээн дэлгэрүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна.

“Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв”-д Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн А/292 тоот тушаалаар батлагдсан журмын дагуу тус төвийн тээврийн хэрэгсэлд тусгай болон гэрлэн дохио хэрэглэж байна.

ГУРАВ.ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭ

Хүүхдийн хөгжил, хамгааллын асуудлыг гэр бүлд түшиглэн шийдвэрлэх бодлого баримталж, дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-д өргөн барьж, батлуулах.

- Эцэг эхийн хариуцлагыг дээшлүүлж, хүүхдээ асрах, хүмүүжүүлэх зөв мэдлэг хандлагад сургах, “Хүмүүжлийн эерэг арга” сургалтыг үндэсний хэмжээнд төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, ажилтнуудад зохион байгуулж, төрийн бүх шатны байгууллага, хувийн хэвшлийн байгууллагад “Эцэг эхийн зөвлөл” байгуулан ажиллуулах.

- Гэр бүлийн нөхцөл байдал, гэр бүлийн хүчирхийлэл болон хүүхдийн эсрэг хүчирхийллийн нөхцөл байдал, аж байдлын талаар судалгаа, шинжилгээ хийх, баримт нотолгоо бий болгох. Ялангуяа эцэг эхийн хараа хяналтаас гадуурх хүүхдүүд болон сургуульд суух зорилгоор гэрээсээ тусдаа өрх толгойлон амьдарч буй, дотуур байр болон айлд байдаг, малчны хүүхдүүд, уул уурхайтай холбоотой шилжин суурьшигчдын хүүхдүүдийн нөхцөл байдалд судалгаа хийж, хяналт тавьж, эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлнэ.

- Гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийллийг эрт үед илрүүлэх, таслан зогсоох, нөхөн сэргээх үйлчилгээнд хохирогч бүрийг хамруулах, тохиолдол бүрт үзүүлэх илрүүлэлт, нөхцөл байдлын үнэлгээ, тусгай хамгаалалт, сэтгэл зүйн болон хууль зүйн зөвлөгөө, үйлчилгээг санхүүжүүлнэ.

- Хүүхдийн зусланд хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төслийг санхүүжүүлэх, хүүхдийн бие бялдар, оюун санаа, нийгэмшихүй, амьдрах ухаан, бие даах чадварыг хөгжүүлнэ.

- Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд хүүхдэд ээлтэй сургалтын орчин нөхцөлийг сайжруулахад чиглэсэн “Жишиг сургууль”-ийн загварыг улсын хэмжээнд ерөнхий боловсролын 31 сургууль дээр хэрэгжүүлж эхэлнэ.

- Төрийн зайлшгүй асрамж, халамж шаардлагатай хүүхдийг төвлөрсөн асрамжийн газарт биш гэр бүл, түүнтэй дүйцэх орчинд төрөл садны болон асралт гэр бүлд өсгөн хүмүүжүүлэх бодлого баримталж, тус үйлчилгээнд шаардагдах хөрөнгийн асуудлыг шийдвэрлэнэ.

- Байнгын асаргаа, сувилгаа шаардлагатай, хагас, бүтэн өнчин, асран хамгаалагчгүй 0-18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй 80 хүүхэд, залуус Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, асрамж, халамжийн төвүүдэд амьдарч байна. Цаашид эдгээр хүүхэд, залууст байнгын асрамж, халамж, дэмжлэгийн үйлчилгээ үзүүлэх нөөц боломжийг судалж, шийдвэрлэх зэрэг асуудалд анхаарч ажиллана.

ДӨРӨВ. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГААС ХҮҮХДЭД ОЛГОХ ЗАРИМ ТЭТГЭМЖ ТУСЛАМЖ, ХӨНГӨЛӨЛТИЙН ХЭМЖЭЭ

Хүүхдийн эрхийг хамгаалах, хангах талаар төрөөс төрөл бүрийн арга хэмжээ авч хэрэгжүүлдэгийн нэг хэлбэр нь дэмжлэг, туслалцаа шаардлагатай байгаа хүүхдүүдэд халамжийн үйлчилгээ үзүүлэх юм. Халамжийн үйлчилгээ нь мөнгөн болон бусад хэлбэртэй байдаг. Энэхүү лавлагаанд хүүхэд болон түүний гэр бүлийг дэмжих дэмжлэгийг хамааруулав.

№	Хууль тогтоомжийн нэр, холбогдох зүйл, заалт	Тэтгэмж авах зорилтот бүлэг	Олгох хугацаа	Тэтгэмжийн хэмжээ
1	Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.2	16 хүртлэх насны байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд олгох амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж	Сар бүр	155.000 төг
2	Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.2 болон Гэр бүлийн тухай хуулийн 25.5, 74, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 13 дугаар зүйл.	Асаргааны тэтгэмж	Сар бүр	70.000 төг
3	Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.5	... гэр оронгүй тэнэмэл өрх, иргэн, 18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэнд гэр авахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж	Нэг удаа	1.200.000 төг
4	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай хуулийн 26.1	Орон сууцны хөлс болон түлшний үнийн хөнгөлөлтөд олгох мөнгөн тусламж	Жилд нэг удаа	140.000 төг
5	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай хуулийн 26.1.5	Нийслэл болон хот суурин газарт нийтийн тээврийн хэрэгслээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг бүх шатны сургалтын байгууллагад	Жилд нэг удаа	200.000 төг

		хүргэж өгч, авдаг асран хамгаалагч, харгалзан дэмжигч нэг хүнд олгох унааны зардлын хөнгөлөлт		
6	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай хуулийн 26.1.7	Дотоодын рашаан сувилалд сувилуулах шаардлагатай дараах хүнд ирж, очих унааны, ор хоногийн зардлыг эрүүл мэндийн даатгалтай иргэний энгийн өрөөний тарифаар тус тус тооцон хөнгөлөлт үзүүлнэ	Жилд нэг удаа	хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд 100 хувь; асран хамгаалагч нэг иргэнд 50 хувь;
7	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай хуулийн 26.1.12.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нь хүүхдийн зусланд амарвал эрхийн бичгийн хөнгөлөлт	Жилд нэг удаа	50 хувь
8	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай хуулийн 26.1.13	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд эмнэлгийн магадлагаагаар дотоодод усан эмчилгээ хийлгэсэн бол эмчилгээний төлбөрийн хөнгөлөлт	Жилд нэг удаа	70 хувь
9	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай хуулийн 26.1.15.	Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасан оршуулгын тэтгэмж авах эрх үүсээгүй, хөгжлийн бэрхшээлтэй хүн болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нас барвал түүний оршуулгын зардлын мөнгөн тэтгэмж	Нэг удаа	1 сая төгрөг
10	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай хуулийн 26.1	18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн дотоодод хийлгэсэн протезын үнийг эдэлгээний хугацаа дууссан болон тухайн хүүхдийн өсөлтийн улмаас бие эрхтэнд нь таарахгүй болсон тохиолдолд олгох хөнгөлөлт	Тухай бүр	100 хувь
11	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай хуулийн 26.1	26.1.4. 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, ... дотоодод хийлгэсэн болон худалдан авсан ортопед, тэргэнцэр зэрэг тусгай хэрэгслийн үнийг нөхөн олгох хөнгөлөлт	Гурван жилд нэг удаа	100 хувь
12	Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуулийн 6.1	Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмжийг эхэд жирэмсний 5 сартайгаас эхлэн 12 сарын хугацаанд	Сар бүр	40.000 төг
13	Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуулийн 6.2	Төрүүлсэн 0-3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эхийн хүүхэд асарсны тэтгэмж	Сар бүр	50.000 төг
14	Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуулийн 6.3	2 ихэр хүүхэд төрүүлж эсэн мэнд өсгөж байгаа өрх, иргэнд олгох амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж	Нэг удаа (хүүхэд тус бүрт)	1 сая төгрөг
15	Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуулийн 6.3	3 болон түүнээс дээш ихэр хүүхэд төрүүлж эсэн мэнд өсгөж байгаа өрх, иргэнд олгох амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж	Нэг удаа (хүүхэд тус бүрт)	3 сая төгрөг
16	Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт	3 болон түүнээс дээш тооны 18 хүртлэх насны хүүхэдтэй өрх	Улиралд	240.000 төг

	тэтгэмж олгох тухай хуулийн 6.4	толгойлсон эх (эцэг)-д олгох амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж		
17	Засгийн газрын 2017.01.18-ны өдрийн 18 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох журам”	Хүүхдийн мөнгөн тэтгэмж-Монгол Улсын 0-18 насны босго шугамаас доогуур эрэмблэгдсэн өрхийн хүүхэд бүрд бэлэн мөнгөөр олгоно.	Сар бүр	20.000 төг

ТАВ. МХЕГ-ААС ХҮҮХЭД ХАМГААЛАЛ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЧИГЛЭЛЭЭР ХИЙСЭН АЖЛЫН ТАЛААР²⁵⁶ (2018-09-11-ний байдлаар)

Мэргэжлийн хяналтын ерөнхий газар нь хүүхдийн эрхийг хамгаалах асуудлаар хяналт тавих эрх бүхий төрийн байгууллагуудын нэг бөгөөд тус бүрэн эрхийнхээ хүрээнд өөрийн харьяалах асуудлуудаар хяналт шалгалтын ажлыг шат дараатай хэрэгжүүлж байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, тусгай хяналтын газар болон Эрүүл мэнд, боловсрол, соёлын хяналтын газраас хүүхэд хамгаалал, аюулгүй байдлын чиглэлээр дараах хяналт шалгалт, тандан судалгааг хийж гүйцэтгэсэн байна.

✓ **Унаач хүүхдийн асуудлаар:**

Улсын хэмжээнд зохион байгуулагдсан үндэсний баяр наадмын хурдан морины уралдааны унаач хүүхдийн аюулгүй байдлыг хангуулах урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг зохион байгуулсан. Тус шалгалтаар баяр наадмаар нийт 51917 мориныг 28238 хүүхэд унаж уралдсанаас

- морьноос унасан-330 /125 хүүхэд хөнгөн гэмтэл, 11 хүүхэд хүнд гэмтсэн/
- 7 нас хүрээгүй уралдааны морь унасан-20
- дуулга өмсөөгүй-336
- хамгаалах хэрэгсэлгүй-183
- морины хэрэгсэлгүй-330
- гурвалсан гэрээ байгуулаагүй-4771
- даатгуулаагүй-1174 хүүхэд уралдаанд оролцуулсан зөрчил илэрсэн байна.

2018 оны тайлангийн дүн мэдээг 2017 онтой харьцуулахад мориноос унаж нас барсан хүүхэд байхгүй, мориноос унасан хүүхдийн тоо 282, хөнгөн гэмтэл авсан хүүхдийн тоо 39-өөр тус тус буурсан байна.

Хамгаалах хувцас хэрэгслийн хувьд дуулга өмссөн хүүхдийн тоо 98.8 хувь, хамгаалах хэрэгсэл өмссөн хүүхдийн тоо 99.3 хувь, морины хэрэгслийн бүрэн бүтэн шаардлага хангасан морьдын тоо 99.1 хувьд хүрсэн нь осол, гэмтэл буурах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

✓ **Хүүхдийг тэвчишгүй хөдөлмөрийн асуудлаар**

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2018 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу албан бус секторт ажиллаж байгаа хүүхдийн талаарх тандалт судалгаа хийсэн. Судалгаагаар 495 хүүхэд хөдөлмөр эрхэлж байгаагаас бичил уурхайд 20 хүүхэд, худалдаа үйлчилгээ буюу захуудад 82 хүүхэд, барилга угсралтын үйл ажиллагаа

²⁵⁶ Мэргэжлийн Хяналтын Ерөнхий газрын товч мэдээлэл

явуулж байгаа байгууллагад 8 хүүхэд, ХАА, газар тариаланд 367 хүүхэд, зам тээврийн салбарт 6 хүүхэд, 12 хүүхэд нь хог хаягдлын цэг болон гудамжинд худалдаа эрхэлж байсан.

Дээрх хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдүүдийг насаар нь авч үзвэл 5-9 настай 9 хүүхэд, 10-14 настай 81 хүүхэд, 15-17 настай 405 хүүхэд байгаагаас эмэгтэй 83, эрэгтэй 412 хүүхэд тус тус ажиллаж байна. Үүнээс 236 хүүхэд нь сургууль завсардсан байна.

Хөдөлмөрийн сайдын 2016 оны А/36 тоот тушаалаар батлагдсан “Насанд хүрээгүй хүн ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт” болон ОУХБ-ын “Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн тухай” 182 дугаар Конвенцод заасан хүүхдийн тэвчишгүй хөдөлмөр эрхэлж байгаа 27 хүүхэд байна.

Хөдөлмөр эрхэлж байгаа насанд хүрээгүй хүүхдүүд нь ажлын цагийг богиносгож ажиллуулах, ээлжийн амралт олгох тухай “Хөдөлмөрийн тухай” хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1 дэх “Долоо хоногийн ажлын цаг нь 14-15 насны ажилтанд 30 цаг хүртэл, 16-17 насны болон хөгжлийн бэрхшээлтэй ажилтанд 36 цаг хүртэл байна”, мөн хуулийн 79 дүгээр зүйлийн 79.3-д “18 насанд хүрээгүй, хөгжлийн бэрхшээлтэй ажилтны ээлжийн үндсэн амралтын хугацаа ажлын 20 өдөр байна” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

✓ **Боловсролын байгууллагын орчны асуудлаар**

Нийслэлийн засаг даргын 2018 оны 02 тоот албан даалгавраар дүүргүүдийн боловсролын байгууллагатай хамтран ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, нийтийн эзэмшлийн биеийн тамирын болон хүүхдийн тоглоомын талбайн орчны аюулгүй байдал тэнд ашиглагдаж байгаа хөдөлгөөнт болон хийлдэг тоглоом, тоног төхөөрөмжүүдэд хяналт шалгалтын ажлын хийжээ. Үүнд 44 сургууль, 60 цэцэрлэг, нийтийн эзэмшлийн биеийн тамирын болон хүүхдийн тоглоом талбай 45, тоглоом тоглуулж буй 2 аж ахуйн нэгж байгууллага, 13 иргэний 34 тоглоомын талбайг хамруулсан. Шалгалтаар дараах зөрчлийг илрүүлсэн байна.

Сүхбаатар дүүргийн 28 цэцэрлэгээс камергүй-14, авто замын аюулгүй байдал хангагдаагүй-36, гэрэлтүүлэггүй-20, сүүдрэвч хөдөлгөөнтэй-15, тоглоомын хашааны бүрэн бүтэн байдал алдагдсан суурь нь хөдөлгөөнтэй-17, тоглоомын талбайгүй-22, тоглоомын талбайн аюулгүй байдлын шаардлага хангаагүй-6 сургууль цэцэрлэг байна.

Шалгалтаар хүүхдийн тоглоомын талбайн боолт эрэг суларсан, гулсуурын шат нь эвдэрсэн, цахилгааны шитний хайрцаг таггүй, цоожгүй, зарим айл өрхийн цахилгаан шит ил, бороо усны хамгаалалтгүй утаснууд нь ил задгай аюул, осол гарах, эрсдэл үүссэн зөрчлүүд илэрсэн байна. Мөн цэцэрлэгүүдийн гаднах камер шаардлага хангахгүй, ашиглалтын үед засвар үйлчилгээ хийж аюулгүй байдлыг хангуулаагүй, аюулгүй ажиллагааны зааварчилгааг боловсруулж мөрдүүлээгүй, анхааруулга санамж байршуулаагүй, хаалт хамгаалалтгүй зөрчлүүдийг илрүүлсэн байна.

Тус хяналт шалгалтаар нийт 398 зөрчил илрүүлж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар 151 байгууллагад мэдэгдэл хүргүүлж, хүүхдийн тоглоомын аюулгүй байдал, гал, цахилгааны аюулгүй байдлыг хангаагүй 6 иргэнд нийт 1.800.0 сая төгрөгийн торгууль ногдуулан бүрэн барагдуулсан байна.

✓ **Боловсролын хяналтын асуудлаар**

Хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажлыг шалгахад сургууль, цэцэрлэгийн сургалт, хүмүүжлийн бэлтгэл ажил бүрэн хангагдаагүй. Хөрөнгө санхүү болон шинээр баригдаж буй барилгын чанараас шалтгаалж, сургалтын орчин нөхцөлтэй холбоотой зөрчил өмнөх онтой харьцуулахад 5 хувиар буурсан. Тухайлбал:

Өнгөрсөн хичээлийн жилд сургууль, цэцэрлэгийн засварын ажлын дуусаагүй шалтгаанаар 9 дүгээр сарын 1-ний өдөр хичээл эхлүүлэх боломжгүй 9 сургууль цэцэрлэг байсан бол энэ хичээлийн жилд 14 сургууль, цэцэрлэг байна. Энэ нь тендер хугацаа алдаж зарлагддаг, зуны турш засварын байдалд тавигдах хяналт дутмаг байдагтай холбоотой байна. **Шалгалтаар:**

- Шалгалтанд хамрагдсан цэцэрлэгүүдийн 154 буюу 55.9% нь нэг багшид ногдох хүүхдийн тоо, нэг ангид байх хүүхдийн тоо, нэг хүүхдэд ногдох талбай болон ариун цэврийн нэг тоноглолд ногдох хүүхдийн тоо эрүүл ахуйн нормоос 1-2 дахин их байгаа нь Сургалт хүмүүжлийн байгууллагын барилга байгууламжийн норм ба дүрэм БНБД II-66-88-ийн 5.1 дэх заалт, “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны ус, ариун цэвэр, эрүүл ахуйд тавигдах норм, шаардлагын 2.1.11, 3.1.8, “Хүүхдийн цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрэм”-ийн 2.3 дахь заалтыг;

- Цэцэрлэгийн гадна талбайн тоглоом, тоног төхөөрөмж нь хүүхдийн нас, биеийн онцлогт тохирсон, аюулгүй байдлыг хангасан, хүүхдийн хөгжлийн гол хэрэгсэл болсон тоглоом, наадгай дутагдалтай, сургалтад шаардлагатай техник хэрэгслэл, тоног төхөөрөмж, хөгжмийн зэмсэгийн хангамж 96 цэцэрлэг буюу 34.9%-д хангагдаагүй байгаа нь “Боловсролын тухай” хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.4, “Хүүхдийн тоглоомын аюулгүй байдал ISO8124:2011” стандарт, “Хүүхдийн цэцэрлэгийн аюулгүй байдлын дүрэм”-ийг; СӨБ-ын тухай хуулийн 15.1 дэх заалтыг;

- Нийслэлд 51, орон нутагт 83 нийт 134 цэцэрлэгт мэргэжлийн бус багш ажиллаж байгаа нь Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 заалтыг;

- Шалгалтад хамрагдсан цэцэрлэгүүдийн 75% нь хөгжмийн заал, кабинетгүй, биеийн тамирын хичээлийн зориулалтын заалгүй, шаардлага хангасан биеийн тамирын гадаа талбайг сургалтад ашигладаггүй нь биеийн тамир, хөгжмийн боловсролын стандарт хангагдахгүй, хүүхдийн авъяас чадварыг нээх, хөгжүүлэх нөхцөл боломж бүрдэхгүй байна.

- Төрийн өмчийн цэцэрлэгийн 80 гаруй хувь нь нэг ангид байх хүүхдийн тоо их, нэг багшид ноогдох хүүхдийн тоог 65-78 болгож, багшийн ачааллыг 3 дахин нэмэгдүүлсэн нь сургалтыг хэвийн явуулах боломжгүй, хүүхдийн эрүүл, мэндэд болзошгүй эрсдэл үүсгэх нөхцөлийг бүрдүүлсэн, хууль бус төлбөр хураамж авах, хүүхэд эрүүл ахуйн зөв дадлыг олгодоггүй гэх мэт хууль зөрчсөн асуудлууд гарахад нөлөөлж байна.

- Цэцэрлэгийн барилгын хүчин чадлаас хүүхдийн тоо 1.6-2 дахин ихэссэн, төрийн бус өмчийн цэцэрлэгүүд мэргэжлийн багшаар хангагдаагүй, анги, танхимд физик хэмжилтээр 1.5-2 хүүхдэд ногдох талбай, эдэлбэр газрын хэмжээ эрүүл ахуйн нормоос 0.6-0.7 дахин багассан, ангийн чийглэг, эрүүл ахуйн зөвшөөрөгдөх хэмжээнээс бага, төрийн бус өмчийн цэцэрлэгүүд нь түрээсийн байранд байрладаг тул байрыг өөрчлөн засварлах боломжгүй, хөрөнгө санхүүгээс хамаарч шаардлагатай

ерөө тасалгааг гаргах, тоног төхөөрөмж шинэчлэх, хүчин чадлыг нэмэгдүүлэхэд хүндрэлтэй, урсгал засвар хийгддэг ч шаардлагын хэмжээнд хүрдэггүй зэрэг нь дээрх зөрчлүүд гарах шалтгаан нөхцөл болж байна.

- Ерөнхий боловсролын сургуулийн анги дүүргэлт дунджаар баруун аймгуудын төвд 54, төвийн бүсэд 42, зүүн аймгуудад 40, Нийслэлд 59 хүүхэдтэй байна. Энэ нь БСШУ-ны сайд, НХХ-ийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2007 оны 307/91/237 дугаар “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын норм тогтоох, багш, зарим албан тушаалтны цалин хөлсийг тооцож олгох журам батлах тухай” тушаалын 1.4 дэх заалтыг зөрчиж байна.

- 2016-2017 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуульд мэргэжлийн бус 1139 багш ажиллаж байгаагийн 62.1 хувь нь орон нутагт, 37.9 хувь нь Нийслэлд байна. Хяналт шалгалтын үр дүнд мэргэжлийн бус багшийн тоо 348-аар буурсан боловч энэ хичээлийн жилд 791 мэргэжлийн бус багш байна. Мэргэжлийн бус багшийн 36 хувь нь бага ангийн, 30 хувь нь байгалийн ухааны, 24 хувь нь дуу хөгжим, 10 хувь гадаад хэлний багш нар байна.

Зөрчил буурахгүй байгаа шалтгаан нь нэг талаас багш мэргэжлээр сургууль төгсөгчид багшаар ажиллах эрхийн шалгалтад тэнцэхгүй, нөгөө талаас сургууль, цэцэрлэгийн удирдлагууд аймгийн боловсрол, соёл урлагийн газарт дутагдалтай байгаа багшийн захиалга ирүүлдэггүй, багш дутагдалтай байгаа сумдын сургуулийн ажлын байрны сонгон шалгаруулалтад оролцох хүнгүй байх тохиолдолтой холбоотой.

- Сургалтын чанарт хяналт тавих зорилгоор 2017-2018 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийн 5, 9, 12 дугаар ангийн Монгол хэл, Математикийн хичээлийн стандартын хэрэгжилтэд хяналт хийхэд суралцагчдын мэдлэг, чадварын гүйцэтгэл 74 хувьтай, сургалтын чанар 59 хувьтай үнэлэгдлээ.

Хяналт шалгалтаар илэрсэн нийт зөрчлийн 49.3% нь боловсролын байгууллагуудад сургалтын орчинтой холбоотой зөрчил эзэлж байгаа нь сургалтын байгууллагуудын сургалтын орчин хэвийн үйл ажиллагаа явуулах шаардлага хангахгүй байгааг харуулж байна. Боловсролын салбарт мэргэжлийн багшгүй, нэг ангид байх хүүхдийн тоо хүчин чадлаас хэтэрсэн, сургалтын орчин нөхцөлд багш суралцагчийн эрүүл аюулгүй байх нөхцөл бүрэн бүрдэхгүй, сурах бичгийн агуулга алдаатай байх зэрэг нь боловсролын чанар, хяналт шалгалтаар илэрч байгаа зөрчил, дутагдал гарахад нөлөөлж байна.

✓ **Хүүхэд өсвөр үеийн эрүүл ахуй, халдвар хамгаалалын чиглэлээр**

Сургууль, цэцэрлэгийн дотоод орчны агаарын чанарт үнэлгээ өгөх хяналт шинжилгээ хийсэн талаар:

Хяналт шинжилгээнд нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа нийт 31 сургууль, цэцэрлэгийг хамруулж, үнэлгээ дүгнэлт өгсөн. Хяналт шинжилгээний дүнгээр:

1. Нэг ангид суралцдаг хүүхдийн дундаж тоо сургуульд 31, цэцэрлэгт 47, хичээлийн танхимын дундаж талбайн хэмжээ сургуульд 47 м.кв, цэцэрлэгт 43 м.кв, сургалтын танхимын дундаж эзлэхүүн сургуульд 142 м.куб, цэцэрлэгт 120 м.куб, 1 хүүхдэд ноогдох талбайн хэмжээ 16 /62%/ сургуулийн 16 ангид бага, 13 цэцэрлэгийн 39 цэцэрлэгт бага байна.

- Ангийн агаарын температур сургуульд 5-7, цэцэрлэгт 1-8 градусаар их,
- Агаарын чийглэг сургуульд 17-35%, цэцэрлэгт 13.5-23%-иар бага,
- Ангийн агаарт нүүрсхүчлийн хийн хэмжээ сургуульд 2%-55.2%, цэцэрлэгт 8.2%-52.6% их,
- Нарийн ширхэглэгт тоосонцорын /PM2.5/ хэмжээ стандартад заасан ЗДХ-ээс 5 сургуулийн 5 ангид 0.4- 27%, цэцэрлэгийн 4 ангид 0.16-2 дахин их, дотоод орчны агаарын бохирдолт ихтэй байгаа нь амьсгалын замын халдварт өвчин тархах, хүүхдийн суралцах орчин эрүүл ахуйн шаардлага хангахгүй байх нөхцөлийг бүрдүүлж байгааг тогтоосон.

Хяналт шинжилгээний дүнгээр цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Шадар сайд, ЭМЯ, БСШУСЯ-нд орчны эрүүл мэндийн чиглэлээр хяналт, судалгаа, шинжилгээ хийх лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, агаар дахь хүнд металл болон тоосонцорын бүрэлдэхүүнийг тодорхойлох багаж төхөөрөмжөөр хангах асуудлыг шийдвэрлэж бодлого зохицуулалтын арга хэмжээ авах, гадаад дотоод орчны агаарт химийн хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээг тогтоосон стандарт боловсруулж батлуулах, шинээр баригдаж буй сургууль, цэцэрлэгийн барилгыг анх барихад барилга байгууламжийн норм, дүрмийн дагуу бариулахад анхаарах талаар албан бичиг хүргүүлсэн байна.

✓ **Сургууль, цэцэрлэгийн ундны усны чанар, аюулгүй байдлын чиглэлээр:**

Тус шинжилгээнд аймаг, нийслэлийн 379 сургууль, цэцэрлэг хамрагдсан. Ундны уснаас 483 дээж авч хими, нян судлалын шинжилгээнд хамруулахад 18.6%-д нь нянгийн тоо стандартад заасан хэмжээнээс их, 7.2%-д гэдэсний бүлгийн эмгэг төрөгч E.Coli илэрсэн байна. Нийслэлийн сургууль, цэцэрлэгийн усны шаардлага хангаагүй дээжийн 60% нь хэсгийн, 40% нь зөөврийн ус хангамжтай байна.

Химийн шинжилгээгээр хатуулаг, магни, кальци, төмөр, сульфат, хлорид, аммиак, нитрат, нитрит гэсэн үзүүлэлтээр шинжлэхэд 27 худгийн ус магни, 38 худгийн ус нитрит, 2 худгийн ус аммиак, 14 худгийн ус хатуулаг, 8 худгийн ус кальци, 11 худгийн ус нитрат, 1 худгийн ус хлорид, 5 худгийн ус төмөр нийт 106 /21.9%/ худгийн ус стандартын шаардлага хангахгүй гарсан байна.

Ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн сурах бичиг эрүүл ахуйн шаардлага, монгол хэлний сурах бичгийн агуулга, стандартын шаардлага хангаж буй эсэх талаар:

Тандалт судалгаанд 133 сургуулийн сурах бичгээс түүвэрлэн 1956 сурах бичгийг хамруулан тандалт судалгаа хийж, үнэлгээ дүгнэлт өгсөн.

Мөн сурах бичиг тус бүрийн жин, нэг өдөрт авч явж буй номны нийт хэмжээ, сурагчийн цүнхний хэмжээ зэргийг хэмжиж үзэхэд сурагчийн цүнхний нийт жин:

- 1-р ангид 3.28±0.6 кг,
- 2-р ангид 3.85±0.9 кг,
- 3-р ангид 3.74±0.9 кг,
- 4-р ангид 5.42±0.8 кг,
- 5-р ангид 4.83±0.8 кг байна.

Сурагчийн цүнхний жинг сурагчдын биеийн жинтэй харьцуулахад биеийн

жингийн 12.4- 20.5%-ийг эзэлж байгаа нь ДЭМБ-ын зөвлөмж хэмжээнээс 1.24-2.05 дахин их байна. Сурагчийн цүнхний нийт жингийн 30 хувийг цүнхний жин, 42.8 хувийг номны жин, 27 хувийг дэвтэр, үзэг, бал, харандаа, үдийн цайнд хэрэглэдэг аяга, таваг бусад эд зүйлс эзэлж байгааг тогтоосон.

Сурах бичгийг огт цэвэрлэж халдваргүйжүүлдэггүй, дамжуулан хэрэглэдэг, багш нараас авсан асуумж судалгааны дүнгээр сурах бичигт тавигдах эрүүл ахуйн шаардлага, тэдгээрт цэвэрлэгээ, халдваргүйтгэл хийх, хүүхдийн бие махбодид үзүүлэх хор уршгийн талаарх мэдлэг хангалтгүй байна.

Тандалт судалгааны дүнг цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар БСШУСЯ-нд 7, Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллагад 1, МХГ-ын түвшинд 4, сурах бичгийн хэвлэлийн үйлдвэрүүдэд 2, ЕБС-иудын удирдлагуудад 6 заалт бүхий санал боловсруулж хүргүүлсэн.

✓ **Импортын хүүхдийн тоглоомийн талаар:**

Импортын хүүхдийн тоглоомын хяналт шинжилгээг Замын-Үүд, Алтанбулаг, Буянт-Ухаа хилийн боомт, Улаанбаатар хотын гүний терминалиудаар нэвтрэх үед болон нийслэлд үйл ажиллагаа явуулж буй томоохон зах, худалдааны төв, төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус хяналт шалгалтад хамрагдсан хүүхдийн цэцэрлэгүүдэд хэрэглэгдэж байсан хүүхдийн тоглоомуудыг хамруулсан.

Хяналт шинжилгээний дүнгээр:

Буянт-Ухаа, Замын-Үүд, Алтанбулаг, Хавирга боомт, нийслэлийн АБТЭМА, Ти Ай ложистик, Интердесижн, Материал импекс, Прогресс транс, Монгол транс гүний гаалийн хяналтын бүсээр нэвтэрсэн болон 39 аж ахуйн нэгж, 27 иргэний 10 улсаас импортолсон 182,7 тн, 18951 ширхэг хүүхдийн тоглоом, нийслэлд хүүхдийн тоглоом худалдаалдаг худалдааны газар, 155 цэцэрлэгт хэрэглэж буй тоглоомоос дээж авч шинжилгээнд хамруулахад стандартын шаардлага хангасан дүнтэй гарсан байна. Гэвч БНХАУ-аас хувь хүн гарал үүсэл нь тодорхойгүй, эрүүл ахуйн баталгаажилтгүй тоглоомыг хяналт шалгалтад хамруулахгүйгээр импортлон зах зээлд худалдаалж байгаа нь хүүхдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх эрсдэлийг үүсгэж болзошгүй байна.

Хяналт шалгалтын явцад сургууль, цэцэрлэг, дотуур байр, их дээд сургуульд эрүүл ахуй, халдвар хамгааллын нөхцөлийг шалгах хяналтын хуудсаар тус тус эрсдэлийн үнэлгээ хийхэд 314 буюу 47,4% нь “бага эрсдэлтэй”, 285 буюу 30,5% нь “дунд эрсдэлтэй”, 63 буюу 9.5% нь “их эрсдэлтэй” үнэлэгдсэн байна. Хяналт шалгалтын явцад нийт 167 объектийн эрсдэлийн түвшин буурсан байна.

Цэцэрлэг болон сургуулийн дотуур байрны хүүхдийн хоолны илчлэг, тэжээллэг байдалд хяналт шинжилгээ хийсэн дүнгээс:

Хяналт шинжилгээнд 2018 оны төлөвлөгөөт хяналт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээнд хамрагдахаар зарлагдсан объектийн 59.9 хувь буюу 40 сургуулийн дотуур байр, 96 цэцэрлэгийг хамруулсан. Хяналт шинжилгээний дүнгээр:

1.Цэцэрлэг, дотуур байрны хүүхдэд өдөрт өгч буй сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээ ЭМС-ын 2014 оны 113 дугаар тушаалаар батлагдсан зөвлөмж хэмжээнээс 1.1-2.2 дахин, гурилан бүтээгдэхүүний хэрэглээ 1-1.6 дахин, хүнсний ногооны хэрэглээ

1.4-1.7 дахин, жимс, жимсгэний хэрэглээ 3.3-4.1 дахин тус тус бага, мах, махан бүтээгдэхүүний хэрэглээ 1.08-1.2 дахин, төрөл бүрийн будааны хэрэглээ 1.5-1.6 дахин, чихэрлэг зүйлсийн хэрэглээ 1.4-1.5 дахин тус тус их байна.

2.Цэцэрлэг, дотуур байрны хүүхдийн хоолны уургийн хэмжээ 1.2, өөх тосны хэмжээ 1.1, нүүрс усны хэмжээ 1.2-1.3 дахин тус тус бага, өдөрт дунджаар 1038.6-1972.4 ккал илчлэгтэй хоол хүнсийг өгч байгаа нь ЭМС-ын 2014 оны 113 дугаар тушаалаар батлагдсан зөвлөмж хэмжээнээс 310.6-357 ккал-иар бага байна.

✓ **Өдөр өнжүүлэх, хүүхэд харах үйлчилгээ эрхлэгч байгууллагуудын эрүүл ахуй чиглэлээр:**

Тандалт судалгаанд аймаг, нийслэлд үйл ажиллагаа явуулж буй 94 өдөр өнжүүлэх бүлэг, 259 хүүхэд харах үйлчилгээ эрхлэгчдийг хамрууллаа. Тандалт судалгааны дүнгээр:

1. Хүүхэд харах үйлчилгээ эрхэлж буй газруудын 82.2 хувь их, дунд эрсдэлтэй, гадна орчин, барилга байгууламжид тавигдах шаардлагын хэрэгжилт 25.9 хувь, усан хангамж, ариун цэврийн байгууламжид тавигдах шаардлагын хэрэгжилт 37.8 хувь, байрны эрүүл ахуйн шаардлагын хэрэгжилт 38.4 хувь, хоол үйлдвэрлэлд тавигдах шаардлагын хэрэгжилт 37.2 хувьтай, дотоод хяналт шалгалтын хэрэгжилт 5.2 хувьтай байгаа нь хамрагдаж буй хүүхдүүдийн дунд халдварт өвчин гарах, дамжин тархах эрсдэл үүсч болзошгүй байна.


2. Өдөр өнжүүлэх бүлгийн 80.9 хувь нь их, дунд эрсдэлтэй, 73.6 хувь зориулалтын бус шаардлага хангахгүй байранд үйл ажиллагаа явуулж байгаа ба 52.6% нь ариун цэврийн тоног төхөөрөмж хүрэлцээгүй, өдөр тутмын цэвэрлэгээ, халдваргүйтгэл хангалтгүй, дотооддоо хяналт тавьж ажилладаггүй, эрх зүйн зохицуулалт дутмаг, мөрдөж ажиллах стандарт, дүрэм, журам байхгүй нөхцөлд үйл ажиллагаа явуулж байгаа нь хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна.

3. Боловсролын тухай хуулийн 18.5-д “өдөр өнжүүлэх үйлчилгээ эрхлэхэд тавих нийтлэг шаардлагыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална” гэж заасан боловч өнөөг хүртэл тодорхой эрх зүйн зохицуулалт байхгүй, өдөр өнжүүлэх бүлэгт тавигдах нийтлэг шаардлага батлагдаагүй, хаанаас зөвшөөрөл олгогдох нь тодорхойгүй байгаад анхаарал хандуулж шийдвэрлэх шаардлагатай байна.

Тандалт судалгааны явцад нийт 136 зөрчил илэрснээс 45 хувийг газар дээр нь мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч арилгуулах арга хэмжээ авч, 6 албан шаардлага хүргүүлсэн.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Монгол Улсын ОУ-ын гэрээ, Хүүхдийн эрхийн тухай конвенц, <http://www.legalinfo.mn/law/details/1276?lawid=1276>
- “Хүүхдийг хүмүүжүүлэх эсрэг арга” ном Дэлхийн Зөн Монгол ОУБ, 2017 он
- Хүүхдийн эрхийн тухай хууль, Хуулийн вэб сайт, 2016 <http://legalinfo.mn/law/details/12393>
- Хүүхэд хамгааллын тухай хууль, Хуулийн вэб сайт, 2016 <http://legalinfo.mn/law/details/12393>
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хуулийн вэб сайт, 2017 <http://legalinfo.mn/law/details/12393>
- Эрүүгийн хууль (шинэчилсэн найруулга), Хуулийн вэб сайт, 2015 <http://www.legalinfo.mn/law/details/11634>
- Зөрчлийн хууль (шинэчилсэн найруулга), Хуулийн вэб сайт, 2017 <http://www.legalinfo.mn/law/details/12695>
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенц http://www.forum.mn/res_mat/2012/UNDP%20konwenzi_book.pdf
- Хүүхдийн бие махбодийн шийтгэл устгах даян дэлхийн санаачилга <https://www.google.com/url?sa=t&rct=j&q=&esrc=s&source=web&cd=21&cad=rja&uact=8&ved=2ahUKEwjqr6am64zeAhXuxlkKHZZLCX4QFjAUegQIAhAC&url=http%3A%2F%2Fwww.mn-nhrc.org%2Ffiles%2FDon't%2520hit%2520anyone.doc&usg=AOvVaw1geYjGK9Jnc8WhsGDMw6YP>
- Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын үндэсний тавдугаар тайлан илтгэл, Засгийн газар, 2014 он
- Нэгдсэн Үндэсний байгууллагын хүүхдийн эрхийн тухай конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Засгийн газрын 5 дугаар тайланд өгсөн дүгнэлт, зөвлөмж, ХНХЯ, 2017 он
- “Хүүхдийн эсрэг хүчирхийллийн өнөөгийн байдал” илтгэл, ХЭҮК-ын гишүүн П.Оюунчимэг
- Засгийн Газрын Хэрэг Эрхлэх газрын танилцуулга
- Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яамны тайлан
- Мэргэжлийн хяналтын Ерөнхий газрын товч мэдээлэл
- Гэр бүл хөгжлийн газрын тайлан
- Авто зам дахь хүүхдийн аюулгүй байдал, осол гэмтлийн нөхцөл байдлын үнэлгээ,
- НҮБ-ын Хүүхдийн сан, 2018 он
- Дэлхийн Зөн Монгол, ОУБ
- Цагдаагийн ерөнхий газар, 2018 оны 5 дугаар сар
- ЦЕГ-ын мэдээллийн сан, 2017-2018 оны хагас жил
- Үндэсний статистикийн хороо www.nso.mn
- Статистикийн мэдээ www.1212.mn



БҮГД НАЙРАМДАХ УЛС ТУНХАГЛАСНЫ БАЯРЫН ӨДРИЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ ЛАВЛАГАА МЭДЭЭЛЭЛ

(Лавлагаа мэдээлэл)

Р.Нургүл, Ц.Элбэгзаяа

1924 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр Монгол улс анхдугаар Үндсэн хуулиа баталж, Хаант засгаас Бүгд найрамдах засаглалд шилжиж, хамжлагат ёсыг халан, үндэсний ардчилсан өөрчлөлт, эрх зүйн чухал зарчмууд, улс төрийн цоо шинэ тогтолцоог хуульчлан баталгаажуулсан.

Улс тунхагласны баярыг 1924 оноос тэмдэглэж ирсэн гэж үздэг бөгөөд ардын хувьсгалын ойн баяртай хамтатган 7 дугаар сарын 11-нд тэмдэглэдэг байсан. 1934 онд буюу 10 жилийн ойн арга хэмжээг Ерөнхий сайд П.Гэндэнгийн санаачилгаар комисс гаргаж өргөн хэмжээнд тэмдэглэж байжээ.

1990 оны Үнэн сонины 11 дүгээр сарын 25-ны №277-д МАХН-ын төв хорооны дэргэдэх эрдэм шинжилгээний ажилтан Г.Дашням болон түүхийн ухааны дэд эрдэмтэн Б.Ганболдын “Тусгаар тогтнолоо тэмдэглэхүй” хэмээх тэмдэглэлд “Тусгаар тогтнолынхоо өдрийг олон жил ердийнхөөс ялгахгүй явж иржээ, огт мартсан гэвэл алдас болно, 50, 60 жилийн ойг сүр дуулиантай тэмдэглэсэн удаа бий” гэжээ. 1940 онд шинэ үндсэн хууль баталсан болон ардын хувьсгалын 19 жилийн ойгоор Уран сайхны хүрээлэнгээс карнавал наадам зохион байгуулсан талаар тэмдэглэл байна.²⁵⁷

1994 онд Монгол Улс анхдугаар Үндсэн хуулиа баталж, Бүгд Найрамдах Улс тунхагласны 70 жилийн ой тохиосон бөгөөд Улс тунхагласны 70 жилийн ойг 1994 оны 11 дүгээр сарын 26-нд орон даяар тэмдэглэхээр УИХ 1994 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн 45 дугаар тогтоол гаргаж байсан²⁵⁸.

Мөн 1990 онд Улс тунхагласны 66 жилийн ойн өдрөөр БНМАУ-ын анхны Ерөнхийлөгч П.Очирбат ард түмэндээ хандаж радио телевизээр үг хэлж, улс тунхагласны баярт зориулсан уулзалт, үдэшлэг нийслэл хотноо болж байсан талаарх тэмдэглэл Үнэн сонины 1990.11.28 ны №278 дугаарт нийтлэгдсэн байна.

Улс тунхагласны баярыг 1990-2012 онуудад тэмдэглэж байгаад, 2012 оны 11-р сарын 08-ны өдрийн Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар хүчингүй болгосон бөгөөд эргээд 2016 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар сэргээн тэмдэглэж эхлээд байна.

2012 онд УИХ-ын гишүүн С.Баярцогт нарын өргөн мэдүүлсэн Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалд энэхүү баярыг хүчингүй болгосон шалтгааныг дараах байдлаар тайлбарлажээ. Үүнд: МУ-ын Ерөнхийлөгч нь 2012 оны 9 дүгээр сарын 4-ний өдөр УИХ-д “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” УИХ-ын тогтоолын төслийг өргөн мэдүүлсэн. Уг төсөлд УИХ-ын 2002 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 21

²⁵⁷ Архивын Ерөнхий газар,

²⁵⁸ Анхдугаар Үндсэн хуулиа баталж, Бүгд Найрамдах Улс тунхагласны 70 жилийн ойг тэмдэглэх тухай УИХ-ын тогтоолын хувийн хэргээс,

дүгээр тогтоолын дагуу бий болсон “Чингис хаан” одонг уг тогтоолд нэмэлт оруулж “Монгол бахархлын өдөр” буюу жил бүрийн 11 дүгээр сарын 14-ний өдөр олгож байхаар тусгажээ. Үүний дагуу Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд 11 дүгээр сарын 14-ний өдрийг “Монгол бахархлын өдөр” буюу нийтээр тэмдэглэх баярын өдөр болгож, бүх нийтээр амардаг байхаар, харин Бүгд Найрамдах Улс тунхагласны баярын өдөр буюу 11 дүгээр сарын 26-ны өдрийг нийтээр тэмдэглэх баярын өдөр байсныг нийтээр тэмдэглэх тэмдэглэлт өдөр болгон зохицуулсан байна²⁵⁹.

2016 онд УИХ-ын гишүүн Я. Содбаатар нарын 9 гишүүний санаачилсан Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг өргөн барьсан байна. Хуулийн төслийн танилцуулга, үзэл баримтлалд дурдсанаар Бүгд найрамдах улс тунхагласны баярын өдрийг нийтээр тэмдэглэх баярын өдөр болгон ёслол төгөлдөр тэмдэглэж ирсэн уламжлалтай бөгөөд 2012 оноос уг өдрийг тэмдэглэлт өдрийн түвшинд өнгөрөөх болсон нь түүхийн чухал үйл явдлын ач холбогдлыг багасгаж, түүх уламжлалыг бүдгэрүүлэх алдаатай шийдвэр болсныг ард иргэд шүүмжлэн, эрдэмтэн судлаачид байр сууриа илэрхийлсэн. Тусгаар тогтнол, түүх уламжлал, үндэсний бахархал бол өнөөгийн бидний дээдлэн авч явах ёстой үзэл санаа юм. Тийм учраас хүн төрөлхтний нийтлэг чиг хандлагыг даган Үндсэн хуульт Бүгд Найрамдах Улсаа тунхагласан түүхэн өдрийг цаашид нийтээр тэмдэглэх баярын өдөр болгох нь зүйтэй гэж хууль санаачлагчид үзсэний дагуу 11 дүгээр сарын 26-ны өдрийг нийтээр тэмдэглэх тэмдэглэлт өдрөөс хасч, нийтээр тэмдэглэх баярын өдөрт оруулах нэмэлт, өөрчлөлт батлагдсан байна.

Энэхүү бүх нийтээр тэмдэглэх баярын өдрөөр Ерөнхийлөгч, УИХ-ын дарга баярын мэндчилгээ дэвшүүлэх, төрийн далбаа мандуулах, УИХ-ын дарга, Ерөнхий сайд, УИХ-ын болон Засгийн газрын гишүүд Эзэн Чингис, жанжин Сүхбаатарын хөшөөнд цэцэг өргөх, хүндэтгэл үзүүлэх, мөн Үндэсний бөхийн барилдаан, МУ-ын 16 нас хүрсэн иргэд иргэний андгай өргөх зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулсаар ирсэн уламжлалтай. Улс тунхагласан баярын өдөрт зориулж, 1990-2017 онуудад үндэсний бөхийн барилдааныг тасралтгүй зохион байгуулсаар иржээ.

2002 оноос хойш Монголын Залуучуудын Холбооны санаачилгаар Иргэний андгай өргөх ёслолын арга хэмжээг Ерөнхий сайдын ивээл дор Улс тунхагласны ойн өдрөөр зохион байгуулж ирсэн байна. Энэ арга хэмжээний үеэр 16 нас хүрсэн иргэд тангараг өргөж, иргэний үнэмлэхээ гардан авдаг.

Бүгд Найрамдах Улс тунхагласан өдрийг тохиолдуулан өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуулийн 2010 оны 11 дүгээр сарын 25-ны Пүрэв гарагийн 1, 2 дугаар ээлжийн нэгдүгээр цагийн хичээлийг “Бүгд Найрамдах Улс тунхагласан нь” сэдвээр зохион байгуулахаар аймаг, нийслэлийн Боловсрол, соёлын газруудад чиглэл өгч, хичээлийн агуулгыг хүргүүлсэн нь онцлог арга хэмжээ байв. Энэхүү хичээлийг зохион байгуулсан зорилго нь суралцагчид анхны Үндсэн хууль батлагдсан түүхэн нөхцөл, ач холбогдол, түүхэн сургамжийн талаар мэдэж, эх орноороо бахархах, үзэл хандлага төлөвшүүлэхэд оршиж байв²⁶⁰.

²⁵⁹ Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хувийн хэргээс,
²⁶⁰ <https://mecss.gov.mn/news/380/>

Улс тунхагласны ойн баяраар зохион байгуулагдсан арга хэмжээнүүдээс дурдвал/цахим эх сурвалжийн хүрээнд/:

- 1990-2017 онуудад жил бүр Улс тунхагласны ойн баярыг тохиолдуулан Үндэсний бөхийн барилдаан зохион байгуулж байсан байна.
- 2002 оноос хойш Монголын Залуучуудын Холбооны санаачилгаар Иргэний андгай өргөх ёслолын арга хэмжээг Ерөнхий сайдын ивээл дор Улс тунхагласны ойн өдрөөр зохион байгуулж ирсэн.
- 2006.11.26 нд Монгол Улсын анхны Үндсэн хуулийг баталж, Бүгд Найрамдах Улсаа тунхагласны 82 жилийн ойг тохиолдуулан МУ-ын Ерөнхийлөгч Н.Энхбаяр радио, телевизээр үг хэлж, мэндчилгээ дэвшүүлсэн.
- 2007 онд Улс тунхагласны 83 жилийн ой, хөшөөнд цэцэг өргөх арга хэмжээ
- 2008 онд Улс тунхагласны 84 жилийн ой, цэцэг өргөх, Ерөнхий сайдын ивээл дор андгай өргөх ёслол, Үндэсний бөхийн барилдаан зэрэг арга хэмжээг зохион байгуулсан.
- 2009 онд цэцэг өргөх арга хэмжээ (H1N1 хүрээний ханиадны вирус тархсантай холбоотой улс даяар өндөржүүлсэн бэлэн байдал зарласан учир нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулахгүй байх чиглэл өгсөн)
- 2009.11.25 Бүгд Найрамдах Улс тунхагласны 85 жилийн ойг тохиолдуулан УИХ-ын дарга Д.Дэмбэрэлийн радио, телевизээр үг хэлсэн.
- 2010.11.25 Бүгд Найрамдах Улс тунхагласны ойг тохиолдуулан УИХ-ын дарга Д.Дэмбэрэл УИХ-ын Чуулган дээр монголын нийт ард иргэдэд хандаж үг хэлсэн, мөн Их эзэн Чингис хааны хөшөөнд хүндэтгэл үзүүлсэн.
- 2011.11.26 Бүгд Найрамдах Улс тунхагласны 87 жилийн ойг тохиолдуулан УИХ-ын дарга Д.Дэмбэрэл ард иргэдэд хандаж үг хэлсэн, жанжин Д.Сүхбаатарын хөшөөнд цэцэг өргөж, Их эзэн Чингис хааны хөшөөнд хүндэтгэл үзүүлсэн. Мөн Ерөнхий боловсролын бүх сургуулиудад “Бүгд Найрамдах Улс тунхагласан нь” сэдвээр хичээл орсон.
- 2012.11.26 УИХ-ын дарга З.Энхболд МҮОНРТ-ээр ард түмэндээ хандаж Бүгд Найрамдах Улс тунхагласны 88 жилийн ойн мэндчилгээ дэвшүүлсэн.
- 2012, 2013 онд МАХН-аас монголчуудын тусгаар тогтнолоо тэмцэн олсон өдрийг заавал тэмдэглэх ёстой гэж үзэн Бөхийн барилдаан зохион байгуулж, Чингисийн хөшөөнд хүндэтгэл үзүүлж, Сүхбаатарын хөшөөнд цэцэг өргөсөн. Мөн МАН-ын гишүүд төлөөлөгчид Д.Сүхбаатарын хөшөөнд цэцэг өргөж, Их эзэн Чингис хааны хөшөөнд хүндэтгэл үзүүлсэн.
- 2014.11.27 нд УИХ-ын дарга З.Энхболд Бүгд Найрамдах Улс тунхагласан 90 жилийн ойн өдрөөр ард түмэндээ мэндчилгээ илгээсэн. Мөн УИХ-ын дарга болон дэд дарга, шадар сайд гишүүд Д.Сүхбаатарын хөшөөнд цэцэг өргөж, Их эзэн Чингис хааны хөшөөнд хүндэтгэл үзүүлсэн.
- 2014.11.27-нд УИХ-ын дэд дарга М.Энхболдын Үндэсний шуудан сонинд өгсөн ярилцлага “Үндсэн хуулийн өөрчлөлтийг зоригтой, дорвитой хийх цаг болсон” УИХ-ын дэд дарга М.Энхболд.
- 2015.11.26 УИХ-ын дэд дарга М.Энхболд Бүгд Найрамдах Улс тунхагласны 91 жилийн ойн мэндчилгээ дэвшүүлсэн.
- 2016.11.26 УИХ-ын дарга М.Энхболд ард түмэндээ мэндчилгээ дэвшүүлсэн.

- 2017 онд УИХ-ын дэд дарга Л.Энх-Амгалан, Ерөнхий сайд болон УИХ болон ЗГ-ын гишүүд жанжин Сүхбаатарын хөшөөнд цэцэг өргөж, Эзэн Чингисийн хөшөөнд хүндэтгэл үзүүлэв. Ерөнхий сайд У.Хүрэлсүх Улс тунхагласны баярын мэндчилгээ дэвшүүлсэн. Мөн Монгол улсын төрийн далбаа мандуулах ёслол болон Монгол улсын Ерөнхий сайдын ивээл дор шатрын тэмцээн зохион байгуулсан.

УИХ-ын дарга, Ерөнхий сайдын Улс тунхагласны баярын өдөр дэвшүүлсэн мэндчилгээ, хэлсэн үг, зохион байгуулсан арга хэмжээний талаарх материалыг өдрийн сонин болон холбогдох ном, цахим хуудаснаас түүвэрлэн авч хавсаргав.

ХАВСРАЛТ МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

УИХ-ын дарга, дэд дарга, Ерөнхий сайдын Улс тунхагласны баярын өдөр дэвшүүлсэн мэндчилгээ, хэлсэн үг, зохион байгуулсан арга хэмжээний талаарх товъёг:

- Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал (Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хувийн хэргээс Д-9 ХН-50, Д-8 ХН-27);
- 1990.11.26 БНМАУ-ыг тунхагласны ойг тохиолдуулан БНМАУ-ын ерөнхийлөгч П.Очирбатын ард түмэндээ хандаж радио телевизээр хэлсэн үг; Үнэн сонин 1990.11.28 ны №278 хуудас 2;
- Монгол Улсын анхны Үндсэн хуулийг баталж Бүгд Найрамдах Улсаа тунхагласны 82 жилийн ойг тохиолдуулан МУ-ын Ерөнхийлөгч Н.Энхбаярын радио, телевизээр хэлсэн үг, 2006.11.26, 3 хуудас;
- Бүгд Найрамдах Улс тунхагласны 85 жилийн ойг тохиолдуулан УИХ-ын дарга Д.Дэмбэрэлийн радио, телевизээр хэлсэн үг, 2009.11.25, 2 хуудас;
- Бүгд Найрамдах Улс тунхагласны ойг тохиолдуулан УИХ-ын Чуулган дээр монголын нийт ард иргэдэд хандаж хэлсэн үг, УИХ-ын дарга Д.Дэмбэрэл, 2010.11.25, 2 хуудас;
- Бүгд Найрамдах Улс тунхагласны ойг тохиолдуулан УИХ-ын дарга З.Энхболдын монголын нийт ард иргэдэд хандаж хэлсэн үг, 2012.11.26; 2 хуудас;
- УИХ-ын дэд дарга М.Энхболдын 2014.11.27-нд Үндэсний шуудан сонинд өгсөн ярилцлага “М.Энхболд: Үндсэн хуулийн өөрчлөлтийг зоригтой, дорвитой хийх цаг болсон”, 9 хуудас;
- Бүгд Найрамдах Улс тунхагласны 91 жилийн ойн мэндчилгээ, УИХ-ын дэд дарга М.Энхболд, 2015.11.26, 2 хуудас;
- УИХ-ын дарга М.Энхболд ард түмэндээ мэндчилгээ дэвшүүлэв, 2016.11.26, 3 хуудас;
- Ерөнхий сайд Улс тунхагласны баярын мэндчилгээ дэвшүүллээ, 2017.11.26, 2 хуудас;
- Сургуулиуд улс тунхагласны өдрийг дурсаж байна, 1 хуудас;
- Улс тунхагласны ойн барилдаан, 1 хуудас;
- Төрийн Ёслолын албаны тэмдэглэл 2010, 2011, 2012, 2014, 2017;

3 БҮЛЭГ

ЭРХ ЗҮЙ, ТӨРИЙН БАЙГУУЛАЛ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ПАРЛАМЕНТЫН ХҮНИЙ ЭРХИЙН ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

(Харьцуулсан судалгаа)

*Г.Алтан-Оч (Ph.D), Д.Жигваагүнсэл
Р.Оргилмаа, Ц.Элбэгзаяа*

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Нэг. Парламент дахь Хүний эрхийн хороодын эрх зүйн орчин, үйл ажиллагааны чиг хандлага

1.1 Парламентын Хүний эрхийн хороодын үйл ажиллагаа

1.2.Европын орнуудын Хүний эрхийн хороодын загварууд

Хоёр. Гадаадын зарим орны Парламентын Хүний эрхийн хороодын бүтэц, үйл ажиллагааны талаарх зохицуулалт

2.1.Австрали

2.2.ИБУИНВУ

2.3.БНХУ

2.4.ХБНГУ

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Товчилсон үгийн жагсаалт

БНХУ	Бүгд Найрамдах Хорват Улс
ГХЭИ	Германы Хүний эрхийн институт
ИБУИНВУ	Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс
ЕХ	Европын Холбоо
ЕЗПА	Европын Зөвлөлийн Парламентын Ассамблей
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НҮБХХ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр
ОУПХ	Олон Улсын Парламентын Холбоо
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

УДИРТГАЛ

Судалгааны хамрах хүрээ: Судалгааны Нэгдүгээр хэсэгт, Парламентын засаглалтай орнууд дахь хүний эрхийн институц, тэдгээрийн үндсэн чиг үүрэг, Европын холбооны орнуудад түгээмэл ашиглагдаж байгаа Хүний эрхийн хороодын загварууд болон тэдгээр загварыг ашиглаж байгаа орнуудын талаарх мэдээлэл, Хоёрдугаар хэсэгт, Австрали, ХБНГУ, БНХУ, ИБУИНВУ зэрэг орнуудын Парламентын хүний эрхийн хороодын эрх зүйн орчин, бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, үйл ажиллагаа зэргийг холбогдох хууль тогтоомж болон Олон улсын Парламентын холбооны судалгаа, тайлан, мэдээллийн хүрээнд судалсан болно.

Судалгааны үр дүнгийн тойм: Судалгаанаас үзэхэд дэлхийн ихэнх улс орнуудад НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглалын зарчмыг үндэслэн хүний эрхийн чиг үүрэг бүхий парламентын институцийг ажиллуулж ирсэн байна. Тухайлбал, Европын холбооны орнуудын Парламентын хүний эрхийн институцийн тогтолцоог судалж үзэхэд Хүний эрхийн (тусгай) байнгын хороотой, Хүний эрхийн асуудлаар дагнасан дэд хороотой, хүний эрхийн асуудлыг авч хэлэлцдэг парламентын нэг бус хэд хэдэн хороод, дэд хороодтой, эсхүл холимог (Hybrid) загвар бүхий хүний эрхийн хороодтой гэсэн 4 загвар зонхилж байна.

Эдгээр парламентын хүний эрхийн хороодын чиг үүрэг харилцан адилгүй байх боловч ерөнхийдөө хүний эрхийн чиглэлээр олон улсын гэрээ конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлж байгаа байдлыг үнэлж дүгнэх, хууль тогтоомжид холбогдох өөрчлөлт оруулах төсөл боловсруулах, хүний эрхийг хангах талаар явуулж буй гүйцэтгэх засаглалын байгууллагуудын үйл ажиллагаа, чиг үүргийн талаар болон хууль тогтоомж олон улсын хүний эрхийн зарчимтай нийцэж байгаа эсэх асуудлаар хяналт шалгалт явуулах, парламентын гишүүдийг холбогдох мэдээллээр хангах, хүний эрхийн бусад байгууллагуудтай харилцах, парламентын нэгдсэн хуралдаанд санал, зөвлөмж оруулах зэрэг чиг үүргийг нийтлэг гүйцэтгэдэг байна.

Хүний эрхийн хороодын бүтэц, бүрэлдэхүүнийг²⁶¹ авч үзвэл ихэнхдээ хорооны дарга болон гишүүдээс бүрдэж байгаа бөгөөд ерөнхийдөө улс төрийн намууд парламентын хороодод нэр дэвшүүлэх гишүүдээ танилцуулсны үндсэн дээр

²⁶¹ Parliamentary human rights Committees. NDI. page18-19.

тэдгээрийн парламентад авсан суудлын тоотой харьцуулах буюу пропорциональ зарчмаар бүрдүүлдэг байна.

Гэхдээ хэд хэдэн хувилбар ашигладаг байна. Англи-саксоны эрх зүйн тогтолцоотой орнуудад гишүүдийг сонгох үүрэг бүхий тусгай хороо гишүүдийг сонгож, парламентаас томилдог бол зарим тохиолдолд ерөнхийлөгчийн зүгээс зохих тооны гишүүдийг томилдог тохиолдол байна. Зарим парламентад (Гана улс) хүний эрхийн хороодын гишүүдийг боловсрол, мэргэжил, туршлагыг харгалзан томилдог зохицуулалттай байна. Филиппиний хүний эрхийн хороо 9 хүний бүрэлдэхүүнтэй ба парламент дахь олонх, цөөнх болсон намуудын даргыг тус хорооны гишүүнээр томилдог. Хорооны бүрэн эрх, үйл ажиллагааны журмаас хамааран парламентын гишүүдээс гадуур нийгмийн бүлэг, олон нийтээс томилдог журам Хорват улсад үйлчилдэг байна. Хорват улсын Хүний эрх болон үндэсний цөөнхийн эрхийг хамгаалах хороо нь дарга, дэд дарга болон үндсэн 13 гишүүн, томилогдсон 4 гишүүний бүрэлдэхүүнтэй байна. Парламентын хүний эрхийн хорооны 7 гишүүнийг тус улс дахь үндэсний цөөнхөөс, 6 гишүүнийг өөр өөр шашны урсгалын тэргүүн, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах болон хүүхэд, залуусын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг сонирхлын бүлэг, төрийн бус байгууллагаас сонгодог байна. Харин хорооны даргыг ихэнхдээ хороодын гишүүд дундаас анхны хуралдаанаар сонгон томилдог ба мөн парламент дахь намуудын хоорондын тохиролцоогоор томилох тохиолдол байна.

Судлагдсан орнуудын парламентын хүний эрхийн хороод нь үйл ажиллагаа, арга хэлбэрийн хувьд ихэнхдээ адил зарчмаар ажилладаг. Харин хорооны хэлэлцэх асуудал түүний бүрэн эрхээс хамааралтай байдаг байна. Эрх хэмжээ нь хязгаарлагдмал хороодын хувьд парламентаас тухайлан өгсөн чиглэл, асуудлаар ажилладаг бол өргөн хүрээний бүрэн эрхтэй хороод парламентын гишүүд, олон нийт, хүний эрхийн байгууллагуудаас хандсан санал, хүсэлт болон бусад асуудлын хүрээнд ажилладаг байна. Тухайлбал, Австралийн хүний эрхийн хорооны бүрэн эрх зөвхөн дотоодын хууль тогтоомжоор хязгаарлагдахгүй НҮБ-ын хүний эрхийн хэрэгжилтийн талаарх чиг хандлага, зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах, мөрдүүлэх эрхтэй байдаг байна. Ажлын төлөвлөгөө, хөтөлбөрийг хороодын гишүүдийн олонхоор тогтоодог бол зарим улсад хорооны дарга бие даан шийдвэрлэдэг.

Парламентын хүний эрхийн хорооны эрх зүйн байдал, үйл ажиллагааны чиглэлийг Парламентын хороодын дүрэм (ИБУИНВУ), Омбудсманы тухай хууль (Хорват), бие даасан Хүний эрхийн тухай хууль (Human Rights (Parliamentary Scrutiny) Act 2011 (Австрали))-аар зохицуулсан байдаг бол хүний эрхийн асуудлаар сонсгол, мэдээлэл хийх, хяналт тавих журмыг Дэгийн тухай хууль, дүрэм болон Хуулийн тухай хуулиар тус тус зохицуулсан байна.

Дэлхий нийтэд парламентаас хүний эрхийн асуудалд хяналт тавих зайлшгүй хэрэгцээ шаардлага байгаа нь нийтлэг асуудал бөгөөд энэ асуудал нь гүйцэтгэх, хууль тогтоох, шүүх аль ч засаглалын хамтарсан эрх үүрэг байх ба тухайлсан ганц байгууллагад хамаарах асуудал бус бүхий л төрийн байгууллагын хамтын ажиллагаа гэсэн агуулга зонхилж байна.

Европын холбооны парламентын холбооноос Европын холбооны хүний эрхийн шүүхийн шийдвэр, хэм хэмжээг хэрэгжүүлэхэд парламентын чиг үүрэг чухал болохыг онцгойлон дурдаж, 2011 онд 1823 дугаар тогтоолоор олон улсын хүний эрхийн

стандарт, шаардлагыг парламентын зүгээс хянан шалгах үндсэн зарчим, бусад байгууллага, иргэний нийгэмтэй хамтран ажиллах хүрээ зэргийг батлан гаргасны дагуу Их Британи, Герман, Финланд, Румын, Нидерланд зэрэг улсууд шүүхийн шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий парламентын бүтцийг бий болгож эхэлсэн байна.

Дэлгэрэнгүйг судалгааны хэсгээс үзнэ үү.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Нэг. ПАРЛАМЕНТЫН ЗАСАГЛАЛ ДАХЬ ХҮНИЙ ЭРХИЙН ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГ ХАНДЛАГА

Аливаа улс гүрэн хүний эрх, эрх чөлөөг хэр зэрэг хангаж, хамгаалж байгаагаар нь түүний олон улсын тавцанд эзлэх байр суурь нь тодорхойлогддог. Түүгээр ч барахгүй тухайн улсын хүний эрхийн салбарт явуулж буй үйл ажиллагаа, түүний механизм нь өөрийнх нь нийгмийн хөгжлийн түвшинг тодорхойлох шалгуур болдог.

Тиймээс ч ардчиллын үндсэн шалгуур болох хүний эрх, эрх чөлөөг дээдлэн хангах явдлыг ардчилсан гэгдэж буй улс гүрнүүд бүхэлдээ төрийн үйл ажиллагааны үндсэн зорилго, зарчмаа болгон үүнийг хангахын төлөө зохих чармайлт гарган ажиллахыг зорьдог.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн бүтцийн байгууллага болох НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс /НҮБХХ/ Парламентын хууль тогтоомжийг батлан гаргах, гүйцэтгэх засаглалын үйл ажиллагааг хянах, бодлого боловсруулах, үйл ажиллагаанд ард түмний хүсэл зоригийг төлөөлөх үндсэн чиг үүргийн онцлогийг харгалзан парламентын чиг үүргийг дээшлүүлэх, парламентыг хөгжүүлэх явдал нь хүний эрхийг дээдлэх, хангах үйл ажиллагааны чухал хөшүүрэг хэмээн үзэж сүүлийн жилүүдэд Үндсэн хуулийн шинэчлэл, институцуудын чадавхыг хөгжүүлэх чиглэлээр туслалцаа үзүүлэх, дэмжих үйл ажиллагаа түлхүү явуулж байна. Парламентын институцууд хүчтэй байх нь хүний эрх, хууль тогтоомжийн хэрэгжилт ардчиллыг баталгаажуулахад чухал хүчин зүйл болдог бөгөөд парламентыг хөгжүүлэх нэг үндсэн арга нь парламентын институцуудыг хөгжүүлэх буюу парламент хороодын чиг үүрэг, оролцоог нэмэгдүүлэх явдал юм.

Энэ ч үүднээс парламент өөртөө хүний эрхийн хороотой байх нь хууль тогтоогч нарыг хүний эрхийн талаарх өргөн хүрээний мэдээллээр хангах, ойлголт өгөх, үндэсний хүний эрхийн комиссын үйл ажиллагаанд хяналт тавих шууд механизмыг бүрдүүлэх, хүний эрхийн чиглэлээр олон тооны асуудлуудыг гаргаж ирэх, иргэний нийгэм-парламент хоорондын харилцааг хялбарчлах зэрэг онцгой чухал ач холбогдолтой гэж үзжээ.

1.1 Парламентын хүний эрхийн хороод

Парламентын ихэнх үйл ажиллагаа түүний хороодоор дамжин явагддаг. Засаглал хуваах зарчмын үүднээс үзвэл парламентын хороод хүний эрхийн чиглэлээр онцгой бүрэн эрхтэй байх шаардлагатай.

2018 оны 5 дугаар сарын 1-ний өдөр НҮБ-ын Дээд Комиссарын газраас тайлан гаргаж, НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс Олон Улсын Парламентын Холбоо /ОУПХ/ болон тус байгууллагын уялдаа холбоог сайжруулах үүднээс холбогдох судалгаа хийлгэх хүсэлт гаргасны дагуу Парламентын хүний эрхийн хороодын талаарх мэдээлэл цуглуулах зорилгоор асуулга боловсруулж, гишүүн орнууддаа хүргүүлснээс гадна Олон Улсын Парламентын Холбоо мөн адил өөрийн гишүүн орнууддаа хүргүүлсэн байна. Асуулгын нэгдсэн тайланд²⁶² дурдсанаар тус асуулгад давхацсан

²⁶² Contribution of parliaments to the work of the Human Rights Council and its universal periodic review, Annual report of the United Nations High Commissioner for Human Rights and reports of the Office of the High Commissioner and the Secretary-General, General Assembly, 17 May 2018. page 7

тоогоор 65 буюу нийт 56 улс хариу ирүүлсэн бөгөөд үүнээс одоогийн байдлаар 35 улс Парламентын хүний эрхийн хороотой байна. Үүнээс Европын улс 17, Латин Америкийн улс орнууд 5, Ази, Номхон далайн орнууд 7, Африкийн 6 улс байна.²⁶³

Мөн 25 улсын парламентын хүний эрхийн хороо нь холбогдох Парламентын хууль, дүрэм журмын дагуу үүсгэн байгуулагдсан гэж хариу ирүүлсэн бол 15 улсын Үндсэн хуульд парламентын Хүний эрхийн хорооны талаар холбогдох суурь зохицуулалт хийж өгсөн, 4 улс үндэсний хууль тогтоомжоор зохицуулсан хэмээн тус тайланд дурджээ.

Асуулгын хариунаас үзэхэд парламентын хүний эрхийн хороодын чиг үүрэг харилцан адилгүй байх боловч ерөнхийдөө хүний эрхийн чиглэлээр олон улсын гэрээ конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлж байгаа байдлыг үнэлж дүгнэх, холбогдох өөрчлөлт оруулах төсөл боловсруулах, гүйцэтгэх засаглалын хүний эрхийг хангах талаар явуулж буй үйл ажиллагаа, чиг үүргийн талаар хяналт шалгалт явуулах, парламентын хэлэлцүүлэг, сонсгол, хүний эрхийн бусад байгууллагуудтай харилцах, парламентын нэгдсэн хуралдаанд санал зөвлөмж оруулах зэрэг чиг үүргийг нийтлэг гүйцэтгэдэг байна.

Европын парламентын хүний эрхийн хороод харьцангуй өндөр үүрэг рольтой буюу хууль тогтоомж, олон улсын хүний эрхийн зарчимтай нийцэж байгаа эсэх болон бусад хүний эрхтэй холбогдох асуудлаар хяналт, шалгалт явуулах үүргийг гүйцэтгэдэг байна. Тухайлбал,

Австралийн Хүний эрхийн хороо нь хууль тогтоох болон бодлогын хүрээнд хүний эрхийн асуудлуудыг зохих ёсоор хүлээн зөвшөөрөх явдлыг хангана гэж заасан байна. Тус хорооны бүрэн эрх зөвхөн дотоодын хууль тогтоомжоор хязгаарлагдахгүй НҮБ-ын хүний эрхийн хэрэгжилтийн талаарх чиг хандлага, зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах, мөрдүүлэх эрхтэй байдаг байна.

Кипрт парламентын хүний эрхийн хороо нь хүний эрхийн талаарх хууль тогтоомжийг гүйцэтгэх засаглалаас хэрэгжүүлж буй байдалд хяналт тавих болон хууль тогтоомжийн төслийг урьдчилан хянах эрхтэй.

Гэвч олон улсын хүний эрхийн механизмуудтай шууд харилцаа холбоо байдаггүй байна. Жишээ нь: Канадын Парламентын хүний эрхийн хороо нь хүний эрхтэй холбогдох асуудлаар шалгалт явуулах хүсэлт гаргах, Парламентаас тус улсын Засгийн газрын үйл ажиллагаа нь тухайн нэгдэн орсон хүний эрхийн олон улсын гэрээ конвенцод нийцэж байгаа эсэх болон бусад асуудлаар хяналт, шалгалт явуулахыг хороонд даалгадаг байна.

Хороо нь Засгийн газарт хүний эрхийг хангах чиглэлээр холбогдох зөвлөмж өгдөг, Засгийн газраас зөвлөмжийн дагуу хариу өгдөг боловч энэ нь зайлшгүй мөрдөгдөж байх зохицуулалт байдаггүй байна. Тухайлбал,

Германд Бундестагийн хүний эрхийн хороо олон улсын хүний эрхийн механизмуудтай холбогдох асуудлаар өөрийн байр суурийг Засгийн газартаа мэдэгдэж, тухайн асуудлыг хэлэлцэх үед тус байр суурийг анхаарч авч үзэхийг зөвлөдөг. Мөн Холбооны засгийн газар болон бусад байгууллагаас хүний эрхийн

²⁶³ Мөн тэнд

нөхцөл байдлын талаар байнга илтгэл, тайланг авч байдаг байна. Гүржид хүний эрхийн хороо Засгийн газраас НҮБ болон түүний харьяа байгууллагуудад тайлагнасан ажлын тайланг хянаж, Засгийн газраас өгсөн зөвлөмжийн дагуу хэрэгжилтийн байдлыг эргэн тайлагнадаг байна.

Латин Америк, Карибын орнуудад парламентын хүний эрхийн хороод нь ерөнхийдөө хүний эрхийн болон бусад хууль тогтоомжийн төсөлд санал, зөвлөмж өгөх замаар ажилладаг байна. Мексик, Колумби зэрэг улсад хүний эрхийн хороод нь хүний эрхийн үндэсний хөтөлбөрийн үнэлгээ, хяналтыг хийж гүйцэтгэдэг байна.

Ази, Номхон далайн орнуудаас Индонез, Непал зэрэг улс нь Засгийн газраас хүний эрхийн олон улсын гэрээ конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлж буй эсэхэд хяналт тавьдаг байна. Пакистанд мөн нэгдэн орсон олон улсын гэрээний хэрэгжилт, тайлагналд хяналт тавьж ажиллана. Тус орнууд мөн дотоодын хүний эрхийн хөтөлбөрийн хэрэгжилтэд оролцож үйл ажиллагааг нь хянадаг байна.

Африкийн орнуудад хороо нь үндэсний хүний эрхийн хөтөлбөрт оролцож ажилладаг ба Того улсад хүний эрхийн нөхцөл байдалд хяналт, шинжилгээ хийдэг бол Кенид үндэсний хүний эрхийн комиссын тайланг хүлээн авч хяналт, шинжилгээ явуулдаг байна.

Молдав улсын парламент дахь Хүний эрх болон үндэсний цөөнхийн асуудал хариуцсан хороо нь парламентаас батлан гаргасан хуулиуд нь олон улсын хүний эрхийн стандарт, шаардлагад нийцэж буй эсэхийг хянах, батлагдсан хуулиуд хүчин төгөлдөр болсноос хойших 6 сарын хугацааны хэрэгжилтийн байдлыг парламентад тайлагнах, зорилтот бүлгийн иргэдийн эрх ашгийн асуудлаар парламентын холбогдох хороодтой хамтран ажиллаж байхаар зохицуулсан байна.

Мөн парламентын хүний эрхийн хороог байгуулж, үйл ажиллагаа жигдэрсний дараа тухайн хорооноос Хүний эрхийн үндэсний комисс зэрэг хүний эрхийн чиглэлээр ажиллах бусад байгууллагуудтай харилцах нэмэлт бүтцийг тогтоож өгвөл ач холбогдолтой гэж үзэж байна. Жишээ нь: Шри Ланка улс.

Дэлхий нийтэд парламентаас хүний эрхийн асуудалд хяналт шалгалт хийх зайлшгүй хэрэгцээ шаардлага байгаа нь нийтлэг асуудал бөгөөд энэ асуудал нь гүйцэтгэх, хууль тогтоох, шүүх аль ч засаглалын хамтарсан эрх үүрэг бөгөөд тухайлсан ганц байгууллагад хамаарах асуудал бус бүхий л төрийн байгууллагын хамтын ажиллагаа гэсэн агуулга зонхилж байна.

Европын холбооны парламентын холбооноос Европын холбооны хүний эрхийн шүүхийн шийдвэр хэм хэмжээг хэрэгжүүлэхэд парламентын чиг үүрэг чухал болохыг онцгойлон дурдаж, 2011 онд 1823 дугаар тогтоолоор олон улсын хүний эрхийн стандарт, шаардлагыг парламентын зүгээс хянан шалгах үндсэн зарчим, бусад байгууллага, иргэний нийгэмтэй хамтран ажиллах хүрээ зэргийг батлан гаргасны дагуу Их Британи, Герман, Финланд, Румын, Нидерланд зэрэг улсууд шүүхийн шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий парламентын бүтцийг бий болгож эхэлсэн байна.²⁶⁴

Хүний эрхийн талаар Парламентын гишүүдэд зориулсан гарын авлагыг анх 2005

²⁶⁴ Models of Human Rights Committee practice, 20 January 2017, SPICe Research center.

оноос НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын алба болон Олон улсын парламентын холбоо хамтран гаргасан байна. Тус гарын авлага нь парламент болон түүний гишүүд хүний эрхийг хамгаалах асуудалд үнэтэй хувь нэмэр оруулж болохуйц арга замуудыг багтаасан байна.

Хууль санаачлах, батлах, улсын төсвийг хэлэлцэн батлах, гүйцэтгэх салбарыг хянах зэрэг улс төр, иргэн, нийгэм, эдийн засаг, соёлын зэрэг иргэний эдлэх бүхий л эрхэд хяналт тавьдагаараа Хүний эрхийг хамгаалах, бэхжүүлэх асуудалд парламент болоод парламентын гишүүд нь онцгой үүрэгтэй юм.

2016 онд гаргасан гарын авлага №26-д Хүний эрхийг хамгаалахад парламент дахь төлөөллийг сайжруулах, парламентын гишүүдийг үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээр хангах, тэдгээрийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, ялангуяа шинээр сонгогдсон парламентын гишүүдэд өөрийн орны хууль эрх зүй, хүний эрхийн асуудлаар хүлээсэн үүрэг болон олон улсад мөрдөгдөж буй дүрэм, журмыг танилцуулах, хүний эрх, түүн дотроо эдийн засаг, нийгэм, соёлын эрх, хөгжих эрх гэж юу болох, хүний эдгээр эрхийг бүрэн дүүрэн эдлүүлэхэд парламентын гишүүний хувиар хийж, гүйцэтгэж, сайжруулж болох ажлуудын талаар зааварчилгаа өгсөн 15 бүлэг бүхий гарын авлага гаргасан байна.

Дэлгэрэнгүй гарын авлагыг дараах холбоосын дагуу үзэх боломжтой.

Эх сурвалж: IPU-Human rights, Handbook for Parliamentarians N° 26
<https://www.ohchr.org/Documents/Publications/HandbookParliamentarians.pdf>

1.2. Европын холбооны орнуудын хүний эрхийн хороодын загварууд

Европын холбооны орнуудад хүний эрхийн хороодын 4 төрлийн загвар зонхилж байна. Хүний эрхийн хороодын загварууд болон тухайн загварт харьяалагдах орнуудын мэдээллийг товч байдлаар дор хүснэгтээр авч үзвэл²⁶⁵:

1.2.1. Парламентын бүтэцдээ Хүний эрхийн (тусгай) байнгын хороотой улс орнууд:

Энэ нь тусгай хороод (The specialised model) нь холбогдох хууль тогтоомж дотоодын болон олон улсын хүний эрхийн хэм хэмжээ, гэрээ, конвенцод нийцэж байгаа эсэхийг шалгах, хянах чиг үүрэгтэй. Европын хүний эрхийн шүүхээс гаргасан шийдвэрийн биелэлтэд хяналт тавина. Жишээ нь: Их британийн парламентын хүний эрхийн хамтын хороо, Албани, Финланд, Грек, Унгар, Латви, Монтенегро, Туркийн хүний эрхийн хороо.

Албани

Албани улсын парламентын Хууль зүй, төрийн захиргаа, хүний эрхийн асуудал хариуцсан хороо нь (Хүний эрхийн дэд хороотой) хүний эрхийн талаар хууль эрх зүйн асуудлыг хариуцан ажиллана. Гэвч тус хороо нь Европын хүний эрхийн шүүхээс гаргасан шийдвэрийн биелэлтэд хяналт тавих үүрэг хүлээдэггүй.

Финланд

Финланд улсын парламентын Үндсэн хуулийн хороо нь парламентаар хэлэлцэгдэх хуулийн төсөл нь Үндсэн хуульд нийцэж буй эсэх, олон улсын болон

²⁶⁵ The role of parliaments in implementing ECHR standards: overview of existing structures and mechanisms, Council of Europe and Parliamentary Assembly, 2 November 2016.

Европын холбооны хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэхэд дүгнэлт гаргах үндсэн чиг үүрэгтэй. Хуулийн төслийн албан ёсны хэлэлцүүлгийн шатанд төрийн албан хаагчид болон гадны шинжээчдийн санал бодлыг сонсон, төсөлд тусгана. Зөрүүтэй санал гарсан тохиолдолд нэмэлт, өөрчлөлт хийдэг байна.

Тус хорооны санал дүгнэлтийг парламентаар хэлэлцэх үүрэгтэй. Хороо нь Европын хүний эрхийн шүүхийн шийдвэрийг зайлшгүй авч үзнэ. Гадаад хэргийн сайд нь Европын хүний эрхийн шүүхээс Финланд улстай холбоотой гаргасан бүх шийдвэрийг парламентын Мэдээллийн хорооны тамгын газарт танилцуулна. Парламентын Омбудсман Страсбургт хэлэлцсэн Финланд улстай холбоотой шийдвэрлэсэн бүх хэргүүдийн талаар жил бүрийн тайланг парламентад танилцуулна. Үндсэн хуулийн хороо нь уг тайлантай нарийвчлан танилцах хэдий ч шүүхийн шийдвэр дээр байр сууриа илэрхийлдэггүй байна.

Грек

2013 оны сүүлээр Грек улсын парламент нь Европын хүний эрхийн шүүхийн шийдвэрт хяналт тавих Тусгай байнгын хороог байгуулсан байна. Тус хороо нь батлагдсан хууль, тогтоомж олон улсын гэрээ, конвенцтой нийцэж буй эсэх болон Европын хүний эрхийн шүүхийн шийдвэрийн биелэлтэд хяналт тавих үндсэн чиг үүрэгтэй байна.

Унгар

Унгар улсын Үндэсний Ассамблейн Хуулийн хороо нь хүний эрхийн асуудлыг хариуцдаг байна. 2014 онд Үндсэн хууль болон шүүхийн байнгын хороог Хүний эрх, үндэсний цөөнх, иргэн болон шашны асуудал хариуцсан байнгын хороотой нэгтгэснээр тус хороог 12 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулжээ.

Засгийн газрын агентлаг нь Европын хүний эрхийн шүүхээс Унгар улстай холбоотой гаргасан шийдвэр хийгээд шүүхээс гаргасан цаазын ялын тухай жил бүрийн тайланг Хуулийн хороонд танилцуулдаг байна.

Латви

Латви улсын парламентын Хүний эрх болон олон нийтийн асуудал эрхэлсэн хороо нь олон улсын хүний эрхийн хэм хэмжээний гүйцэтгэлд хяналт тавих үүрэгтэй. Европын хүний эрхийн шүүхийн шийдвэрийн биелэлтэд хяналт тавих үүрэг хүлээгээгүй хэдий ч Засгийн газрын агентлагаас жилдээ нэг удаа тус хороонд цаазын ялын тухай мэдээлдэг байна.

Монтенегро

Монтенегро улсын парламентын Хүний эрх, эрх чөлөөний хороо нь хүний эрхийн асуудлуудыг авч хэлэлцдэг. Тус хороо нь Европын хүний эрхийн шүүхээс гаргасан шийдвэрийн биелэлтэнд хяналт тавих үе шаттай зохицуулалт байхгүй хэдий ч Парламентын Ерөнхийлөгчид шүүхийн шийдвэрийн талаар болон цаашид энэ тал дээр зохион байгуулах үйл ажиллагааныхаа талаар мэдээлэл бэлтгэн танилцуулдаг байна.

1.2.2. Хүний эрхийн асуудлаар дагнасан дэд хороотой улс орнууд:

(Хүний эрхийн байнгын хорооны дотроо хүний эрхийн асуудлаар илүү нарийн чиг

үүрэг бүхий дэд хороодтой байна. (sub-committee). Жишээ нь: Чех, Ирланд, Польш, Румын.

Чех

Чех улсын парламентын Депутатуудын танхим (Доод танхим)-ын Үндсэн хууль болон хууль, эрх зүйн хороо нь Омбудсман болон Европын хүний эрхийн шүүхийн талаар хууль санаачлах дэд хороог байгуулсан байна. Омбудсман буюу олон нийтийн эрхийг хамгаалагч нь гомдол гаргагч болон төрийн албан тушаалтнуудын хооронд зуучаар ажиллана. Тус хороо нь Засгийн газрын агентлагаас бэлтгэн танилцуулдаг Чех улсын тухайн онд шийдвэрлэсэн ялын дээд хэмжээ болон Европын хүний эрхийн шүүхээс гаргасан шийдвэрийг жил бүр хэлэлцдэг байна. Үүнээс гадна өргөдөл, гомдлын хороо нь Хүний эрхийн дэд хороотой байна. Дээрх дэд хороод нь төрийн болон төрийн бус байгууллагаас санаачилсан хууль, тогтоомжийн төслүүдийг Европын холбооны хүний эрхийн стандарт болон олон улсын хүний эрхийн гэрээтэй нийцүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг байна.

Ирланд

2014 оны 12 дугаар сард Ирландын парламентын 2 танхимын хамтарсан Хууль зүй, тэгш эрхийн хороо нь Хүний эрхийн дэд хороог байгуулсан байна. Тус дэд хороо нь хэлэлцэгдэж буй хуулийн төсөл нь хууль ёсны буюу улсын дотор мөрдөгдөж буй хүний эрхийн хууль, дүрэм, журамтай нийцэж буй эсэх талаар хяналт тавьдаг байна. Харин хүний эрхийн талаар гаргасан шүүхийн шийдвэрийн биелэлтэд хяналт тавих үүрэг хүлээгээгүй байна.

Румын

2009 онд Депутатуудын танхим (Доод танхим)-ын Хууль зүйн хороо нь Европын хүний эрхийн шүүхээс гаргасан шийдвэрийн биелэлтэд хяналт тавих Дэд хороог байгуулсан байна. Дэд хороо нь парламентын бүлгүүдийн төлөөлөл 7 гишүүн болон мэргэшсэн хуулийн зөвлөхүүдээс бүрдэнэ. Дэд хороо нь тусгайлан үзсэн асуудлууд дээр Засгийн газраас томилогдсон ажилтнуудтай хамтран ажиллаж, олон нийтийн сонсгол зохион байгуулдаг, мөн Засгийн газрын агентлагаас тогтмол тайлан хүлээн авч хэлэлцдэг байна.

Европын хүний эрхийн шүүхээс ирүүлсэн хүний эрх зөрчсөн талаарх олон тооны шийдвэрүүдийг үндэслэн Дэд хороо нь Депутатуудын танхим болон Сенаттай хамтран Европын хүний эрхийн шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэхэд, түүнчлэн Хүний эрхийн конвенцын стандартад нийцүүлж ажиллахад Засгийн газарт онцгой хяналт тавьж ажиллах чиг үүрэг бүхий парламентын хамтарсан хороог байгуулахаар санал гаргасан байна.

1.2.3. Парламентын нэг бус хэд хэдэн хороод, дэд хороод хүний эрхийн асуудлыг авч хэлэлцдэг улс орнууд:

(Mainstreamed model) буюу өөрийн эрхлэх асуудлын хүрээн дэх хүний эрхийн асуудлаар ажилладаг. ОХУ, Дани, Нидерланд, Швед зэрэг улс байна.

Дани

Дани улсын парламентад хороо бүр хүний эрхийн тодорхой асуудлыг хариуцдаг

байна. Хууль зүйн асуудал эрхэлсэн хороо нь Данийн Хүний эрхийн байгууллага болон Омбудсмантай тогтмол холбоо харилцаатай ажиллаж, жил бүр эдгээр байгууллагын тайланг хэлэлцэнэ. Парламентын хороодын чиг үүрэгт Европын хүний эрхийн шүүхийн шийдвэрийн биелэлтэд хяналт тавих үүрэг байхгүйн дээр Засгийн газар нь парламентад тайлагнах үүрэг хүлээдэггүй байна.

Нидерланд

Нидерланд улсад парламентын аль ч хороо тусгайлан хууль, тогтоомжоо Европын хүний эрхийн конвенцод нийцүүлэх, Европын хүний эрхийн шүүхийн шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг хүлээгээгүй. Хүний эрхийн асуудлыг хариуцсан тусгайлсан нэгж байхгүй хэдий ч парламентын аль ч танхим (Төлөөлөгчдийн танхим болон Сенат) нь Европын хүний эрхийн конвенцтой нийцүүлж хууль, тогтоомжоо батлах тал дээр анхаардаг Хууль эрх зүйн хороодтой байна.

Засгийн газраас өргөн баригдаж буй төслүүдэд Европын хүний эрхийн конвенц болон олон улсын хүний эрхийн стандартад нийцэж буй эсэхийг тайлбарласан тайлбар дагалддаг байна.

Хуулийн төсөл бүр нь хүний эрхийн аливаа дүрэм, журамтай нийцэж байгаа эсэхийг хянах Төрийн зөвлөлийн шалгуурыг давах ёстой байна. Үүний дараагаар асуудлыг хамаарч буй байнгын хороогоор дахин хянуулах ёстой.

Парламентын гишүүд нь Төрийн зөвлөл болон хүний эрхийн талаар сургалт явуулдаг Хууль зүйн яамны төрийн албан хаагчдаас зөвлөгөө авах боломжтой байна. Засгийн газар нь жил бүр парламентад шүүхийн шийдвэрийн гүйцэтгэлийг танилцуулдаг байна.

Орос

Төрийн Дум нь 30 хороотой бөгөөд эдгээрийн аль нь ч тусгайлан хүний эрхийн асуудлыг хариуцдаггүй. Европын хүний эрхийн шүүхийн шийдвэртэй холбоотой болон Европын хүний эрхийн конвенцтой нийцэх эсэх зэрэг асуудал нь ерөнхийдөө иргэн, гэмт хэрэг, арбитр, хууль тогтоомжийн хороо, Үндсэн хууль, Төрийн байгуулалтын хороо болон Гадаад хэргийн асуудал хариуцсан хороо зэрэг гурван хороонд харьяалагддаг. Парламентад шүүхийн шийдвэрийн биелэлтэд хяналт тавих механизм байхгүй байна. 2011 оноос Ерөнхийлөгчийн зарлигаар Хууль зүйн яамнаас Европын хүний эрхийн шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх үүднээс парламентаар хэлэлцэн батлах болон хүчингүй болгох хуулиудын жагсаалтыг багтаасан жил бүрийн тайланг Ерөнхийлөгчид танилцуулдаг болсон байна.

1.2.4.Холимог загвар бүхий улс орнууд:

Холимог загвар (hybrid model) буюу Хүний эрхийн асуудлаар нэг болон хэд хэдэн хороо, дэд хороотой байх загвар. Жишээ нь: Армени, Кипр, Гүрж, Итали, Литва зэрэг улс байна.

Армен

Армен улсын Үндэсний Ассамблейн Хүний эрх болон олон нийттэй харилцах хороо, Төрийн болон хууль зүйн асуудал хариуцсан хороо нь тус тус хүний эрхийн асуудлыг хариуцдаг байна. Гэвч Европын хүний эрхийн шүүхийн шийдвэрийн

гүйцэтгэлд хяналт тавих механизм байхгүй байна. Түүнчлэн Засгийн газраас парламентад тогтмол тайлан тавих зохицуулалт байхгүй байна.

Гүрж

Гүрж улсын парламентын Хүний эрхийн хороо нь улс орны хэмжээн дэх хүний эрхийн нөхцөл байдлыг хянах, үнэлэх, Засгийн газраас хэрэгжүүлж буй үйл ажиллагаа нь үндэсний бөгөөд олон улсын хууль, дүрэм, журмыг баримталж, тэдгээрийг хэрэгжүүлж байгаа эсэхэд мөн хяналт тавих зэрэг өргөн хүрээний эрх мэдэлтэй ажилладаг байна. Хууль зүйн асуудал эрхэлсэн хороо нь эрүүгийн эрх зүйтэй холбоотой хуулийн төсөл боловсруулах зэрэг тохиолдолд Хүний эрхийн хороотой хамтарч ажилладаг байна. Тус хороо нь Европын холбооны шүүхийн шийдвэрийн биелэлтэд хяналт тавих үүрэг хүлээгээгүй болно. Засгийн газар нь мөн парламентад хүний эрхийн асуудлаар тогтмол тайлан тавьдаггүй байна.

Итали

Итали улсын парламентын Депутатуудын танхим болон Сенат аль аль нь Үндсэн хуулийн асуудал хариуцсан хороодтой. Мөн Сенат нь Хүний эрхийг хамгаалах онцгой эрх бүхий комисстой байна. Эдгээр гурван хороо нь Европын хүний эрхийн шүүхийн шийдвэрийг хянан үзэж, өөрийн улсын хууль тогтоомжид өөрчлөлт оруулах шаардлага бий эсэх талаар хэлэлцэн шийдвэрлэдэг байна. Түүнчлэн Ерөнхий сайдын ажлын албанаас эдгээр хороодод жил бүр шүүхийн шийдвэрийн тайланг хүргүүлдэг байна.

ХОЁР. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ПАРЛАМЕНТЫН ХҮНИЙ ЭРХИЙН ХОРООДЫН БҮТЭЦ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ ЗОХИЦУУЛАЛТ

2.1.АВСТРАЛИ УЛС²⁶⁶

Холбооны түвшинд Австралийн Засгийн газар хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, биелүүлэхийн тулд олон улсын эрх зүйн дагуу үүрэг хүлээдэг. Энэ нь хүмүүс хүний эрхээ эдлэх боломжийг хангахын тулд Засгийн газар тодорхой үйл ажиллагаа явуулах үүрэгтэй бөгөөд 1980 оноос НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглалын хүрээнд дараах хүний эрхийн 7 гэрээ, конвенцод нэгдэн оржээ. Үүнд:

- Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт (International Covenant on Civil and Political Rights) (ICCPR);
- Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн олон улсын пакт (International Covenant on Economic, Social and Cultural Rights) (ICESCR);
- Арьс өнгөөр ялгаварлах үзлийн бүх хэлбэрийг арилгах тухай олон улсын конвенц (International Convention on the Elimination of All Forms of Racial Discrimination) (ICERD);
- Эмэгтэйчүүдийг ялгаварлах үзлийг арилгах конвенц (Convention on the Elimination of Discrimination against Women) (CEDAW);
- Эрүүдэн тамлах болон бусад хэрцгий, хүмүүн бус буюу гутаан доромжилсон шүүлт, шийтгэлийн эсрэг конвенц (Convention against Torture and Other Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment) (CAT);

²⁶⁶ Australia's human rights framework
<https://www.humanrightscommission.vic.gov.au/human-rights/the-charter/australian-human-rights-framework>

- Хүүхдийн эрхийн конвенц (Convention on the Rights of the Child) (CRC);
- Тахир дутуу хүний эрхийн тухай конвенц (Convention on the Rights of Persons with Disabilities) (CRPD).

Улмаар 1986 онд Холбооны парламентын шийдвэрээр **Хүний эрхийн комиссыг** байгуулснаас гадна хүний эрхийг аливаа төрлийн ялгаварлан гадуурхалтаас хамгаалах, хүний эрхийн зөрчлөөс байгууллага, хувь хүмүүсийг хамгаалахын тулд олон тооны хуулийг баталсан байна. Үүнд:

- ✓ Австралийн Хүний эрхийн комиссын тухай хууль 1986 (Australian Human Rights Commission Act 1986)
- ✓ Насаар ялгаварлан гадуурхалтын тухай хууль 2004 (Age Discrimination Act 2004)
- ✓ Тахир дутуугийн ялгаварлан гадуурхалтын тухай хууль 1992 (Disability Discrimination Act 1992)
- ✓ Арьс өнгөөр ялгаварлан гадуурхах тухай хууль 1975 (Racial Discrimination Act 1975)
- ✓ Жендерийн ялгаварлан гадуурхалтын тухай хууль 1984 (Sex Discrimination Act 1984)

Мөн 2012 онд хууль тогтоох үйл явцад хүний эрхийг хамгаалах, хүндэтгэх, хүний эрхийн талаарх ойлголтыг сайжруулах зорилгоор Парламентын бүтцэд **Хүний эрхийн хамтарсан байнгын хороог** ажиллуулах болсон байна.

Энэхүү судалгаанд Парламентын хүний эрхийн хорооны үйл ажиллагаа, бүтэц, чиг үүрэг зэргийг нарийвчлан авч үзлээ.

1. Хүний эрхийн комиссын тухай²⁶⁷:

Австралийн Хүний эрхийн комисс нь 1986 онд байгуулагдсан бөгөөд дээрх хуулиудын дагуу үүрэг хүлээдэг бие даасан хууль ёсны байгууллага юм. Хүний эрхийн комиссын тухай хуульд²⁶⁸ зааснаар тус комисс нь Хууль зүйн сайдаар дамжуулан Холбооны парламентад үйл ажиллагаагаа тайлагнах ба хууль тогтоомжид заасан ялгаварлан гадуурхах, хүний эрхийн зөрчилтэй холбогдсон аливаа гомдол, саналыг шийдвэрлэх үндсэн чиг үүрэгтэй. Тухайлбал,

- Холбооны ялгаварлан гадуурхалтын тухай хууль тогтоомжийн хүрээнд хууль бус ялгаварлан гадуурхалттай холбоотой гомдлуудыг шийдвэрлэх;
- хүний эрх, хөдөлмөр эрхлэх тэгш боломжоор хангагдсан эсэхийг асууж тодруулах;
- Австралид хүний эрх, эрх чөлөөг хүлээн зөвшөөрөх, хүлээн зөвшөөрөх явдлыг хөхиүлэн дэмжих;
- хүний эрхийн болон холбооны ялгаварлан гадуурхалтын хуулиудын зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд судалгаа шинжилгээний болон боловсролын хөтөлбөр, бусад хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

²⁶⁷ Commission Guidelines <https://www.humanrights.gov.au/guidelines-distinct-role-president-and-commissioners-australian-human-rights-commission-relation>

²⁶⁸ Australian Human Rights Commission Act 1986 No. 125 <https://www.legislation.gov.au/Details/C2017C00143>

- хүний эрхийн зөрчил, хууль бус ялгаварлалтаас зайлсхийх зорилгоор удирдамж бэлтгэх, нийтлэх;
- хүний эрхийн буюу хууль бус ялгаварлан гадуурхалтын асуудлаар шүүх хуралдаанд оролцох;
- хууль тогтоомжийг хянан шалгах (хэрэв сайд хүсэлт гаргасан бол хууль тогтоомжийг эрэмбэлэн) ба шалгалтын тайланг сайд нарт мэдээллэх;
- Парламентаас хууль тогтоомжийн шалгалтын тайланг, эсхүл Хамтын нөхөрлөлийн зүгээс хүний эрхийг хангах, хууль бус ялгаварлан гадуурхахтай холбоотой асуудлаар сайд нарт тайлагнах.

Комисс нь эдгээр үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хамтран ажиллах, ерөнхий прокурор, сайд нар болон бусад парламентын гишүүдтэй холбоо тогтоох, хүний эрхийн боловсролыг дээшлүүлэх, тэднийг хүний эрх ашгийг хамгаалах, хөхиүлэн дэмжих хүчин чармайлт гаргахад нь дэмжлэг үзүүлэхэд байгууллага, удирдагчид, бизнесийн салбартай хамтран ажиллах, тайлан хэлэлцүүлэг зохион байгуулах зэргээр өргөн арга хэлбэрийг ашигладаг байна.

2. Парламентын хүний эрхийн хамтарсан хороо²⁶⁹

Парламентын бүтцэд хүний эрхийн хороог *Хүний эрхийн (парламентын хяналт) хууль 2011 (Human Rights (Parliamentary Scrutiny) Act 2011)*²⁷⁰-д үндэслэн 2012 оны 3 дугаар сард үүсгэн байгуулжээ. Хорооны зорилго нь Австрали дахь хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх ба ойлгох ойлголтыг улам бүр гүнзгийрүүлэн батжуулах, хууль тогтоомж ба бодлогын хөгжил дэх хүний эрхийн асуудлуудыг зохистойгоор хүлээн зөвшөөрөх явдлыг баталгаажуулахад оршино. Парламентын хүний эрхийн хамтарсан хорооны үйл ажиллагаа, бүтэц, чиг үүрэг зэргийг дээрх хуулиар²⁷¹ зохицуулсан байна.

Хорооны чиг үүрэг:

Хүний эрхийн (парламентын хяналт) хуулийн 2 дугаар бүлгийн 4-р зүйлд зааснаар Парламент бүрийн анхдугаар чуулган эхэлсний дараа аль болох богино хугацаанд Парламентын гишүүдийн хамтарсан хороог байгуулж, Парламентын хүний эрхийн хамтарсан хороо гэж нэрлэн үйл ажиллагааг нь Парламентын үйл ажиллагаанд нийцүүлэн журамлана.

Хороо нь хуулиар тогтоосон дараах үйл ажиллагааг эрхэлнэ:

- Парламентын хоёр танхимын аль алианаар хэлэлцэгдэх хуулийн төсөл ба хууль тогтоох арга хэлбэрийг хүний эрхтэй нийцэж буй эсэхийг урьдчилан хянан үзэж, парламентын хоёр танхимд энэ тухай асуудлаар тайлагнах;
- Бүх хуулийг хүний эрхтэй нийцэж буй эсэхийг нягтлан үзэж, энэ тухай асуудлаар хоёр танхимд мэдээлэл хийж, тайлагнах;
- Хууль зүйн сайдаас чиглэл өгсөн хүний эрхтэй хамаарах аливаа асуудлыг нягтлан үзэж, тухайн асуудлаар хоёр танхимд илтгэн тайлагнах зэрэг болно.

Хороо нь хууль тогтоомжийг хүний эрхийн олон улсын дээрх 7 гэрээгээр баталгаажуулсан стандартуудтай харшилсан эсэхийг шинжилнэ. “Иргэний болон улс

²⁶⁹ Parliamentary Joint Committee on Human Rights https://www.aph.gov.au/joint_humanrights/

²⁷⁰ Human Rights (Parliamentary Scrutiny) Act 2011 No. 186 <https://www.legislation.gov.au/Details/C2011A00186>

²⁷¹ Мөн тэнд

төрийн эрхийн олон улсын пакт” ба “Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн олон улсын пакт” нь иргэний, улс төрийн, эдийн засгийн, нийгмийн, соёлын бүх үндсэн түлхүүр эрхүүдийг хамарна. Бусад 5 гэрээ нь эдгээр эрхүүдийг илүү дэлгэрэнгүйгээр тайлбарласан шинжтэй юм. Энэ ойлголт нь Хууль зүйн асуудал эрхэлсэн Холбооны Засгийн газраас гүйцэтгэх газар, агентлагуудад хэрэгжүүлдэг арга замтай нийцэж байдаг байна.

Хорооны бүтэц, бүрэлдэхүүн:

Хуулийн 5-р зүйлд зааснаар хороо нь 10 гишүүнтэй байна. Үүнээс:

а) Сенатаас томилогдсон сенатын 5 гишүүн:

- ✓ Төлөөлөгчдийн танхимаас Засгийн газрыг бүрдүүлэгч намын 3 гишүүн;
- ✓ Төлөөлөгчийн танхимаас сөрөг намын, эсхүл бие даагч 2 гишүүн.

б) Тухайн танхимаар томилогдсон Төлөөлөгчдийн танхимын 5 гишүүн:

- ✓ Засгийн газар бүрдүүлэгч намын 2 сенатор;
- ✓ Сөрөг хүчний 2 сенатор;
- ✓ Цөөнхийн намын, эсхүл бие даагч 1 сенатор.

Дараах Парламентын гишүүд хорооны гишүүнээр томилогдох эрхгүй:

- Сайд;
- Сенатын ерөнхийлөгч;
- Төлөөлөгчдийн танхимын дарга;
- Сенатын дэд ерөнхийлөгч ба хороодын дарга нар;
- Төлөөлөгчдийн танхимын дэд дарга.

Мөн хуульд зааснаар хорооны гишүүн нь дээрх албан тушаалуудыг хашиж байгаа болон Парламентын гишүүнээс больсон тохиолдолд, эсхүл өөрийн хүсэлтээр гишүүний албан үүргийг зогсооно. Тухайн гишүүний орон гарсан танхимаас гишүүдийг нөхөн томилж болдог байна.

Хороо нь Төлөөлөгчийн, эсхүл Сенаторын танхимаас хэн нэгэн засгийн газрын гишүүнийг хорооны даргаар сонгох ба дэд даргад хорооны хэн нэгэн Засгийн газрын гишүүн бус гишүүнийг сонгодог.

Харин хорооны эрх мэдэл, хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой бүх асуудлыг Парламентын хоёр танхимын тогтоолоор шийдвэрлэнэ.

Хорооны үйл ажиллагаа:

Австрали нь НҮБ-ын хүний эрхийн тухай 7 гол гэрээг хүлээн зөвшөөрч нэгдэн орсон байдаг. Олон улсын хүний эрхийн тухай хуулийн²⁷² ерөнхий зарчим бол хүний эрхийн гэрээгээр хамгаалагдсан эрхүүдийг өргөн тайлбарлаж, хүний эрхийг хязгаарласан бүхнийг нягт нарийн хянах явдал юм.

Тэгэхээр хорооны тайлан илтгэлийн гол цөм нь аливаа хүний эрхийг хязгаарласан зүйл байгаа эсэхийг, тэр нь хууль ёсны эсэхийг тодорхойлох байдаг.

²⁷² The International Bill of Human Rights
<https://www.ohchr.org/Documents/Publications/FactSheet2Rev.1en.pdf>

Олон улсын хүний эрхийн тухай хуулиар ихэнх эрх, эрх чөлөөнд учир үндэслэл бүхий хязгаарлалт тавихыг зөвшөөрдөг. Гэхдээ ямар ч нөхцөлд хязгаарлаж үл болох цөөн хэдэн үнэмлэхүй эрх бий.²⁷³ Түүнээс бусад бүх эрхийг тодорхой стандарт шаардлагад нийцүүлэн хязгаарлаж болно гэж үздэг.

Ерөнхийдөө хүний эрхийг хязгаарлаж буй ямарваа арга хэмжээ нь дараах шалгуурыг хангаж байх ёстой байдаг байна:

- Хуулиар тогтоосончлон;
- Хууль ёсны зорилгоор мөрдөн шалгахад;
- Тодорхойлсон зорилго, үндэслэлтэйгээр холбогдож байх;
- Тэрхүү зорилгод хүрэх арга замын нэг хэсэг болж байх.

Хүний эрхийг хязгаарласан аливаа хуулийн төсөл, эсхүл арга хэрэгслээс хороо нь дээрх хязгаарлах шалгууруудыг хангасан эсэх талаар дэлгэрэнгүй бөгөөд баримттай үнэлэн дүгнэсэн мэдэгдэл шаардана. Энэхүү мэдэгдэл нь хорооны нягтлан шинжлэх ажлын эхлэлийн цэг болох ба хүний эрхтэй холбогдох үнэлгээний хүрээ болдог.

Хуулийн 3 дугаар бүлэгт зааснаар хороо нь парламентын хэлэлцүүлэгт өргөн баригдсан бүх төсөл, хууль тогтоомжийн арга хэрэгслүүдийг хүний эрхтэй нийцэж буй эсэхийг нягтлан үзэж тайлагнана.

Хороо нь Сенатын хяналтын хороодын баримталдаг конвенцын дагуу нам бус, хууль тогтоомжийн хяналтдаа мэргэжлийн үүднээс хандах ёстой.

Хороо нь ерөнхийдөө Төлөөлөгчдийн танхим болон Сенатын аль аль нь байлцах үед хуралдах ба эдгээр хуралдааны талаар тогтмол тайлагнана. Хорооны тайлан илтгэлийг хуралдаан бүрийн дараа хэлэлцэх бөгөөд хуулийн төсөл ба хууль тогтоох арга хэрэгслийн тухайд өргөн баригдахаас нь өмнө нягтлан үзнэ.

Аливаа хуулийн төслийг хэлэлцэгдэхээс нь өмнө судлан шинжилж, дүгнэлтээ гарган улмаар судалгаа, шинжилгээ хийж, үр дүнг парламентад илтгэнэ. Ингэснээр тэрхүү шинжилгээ, дүгнэлт нь парламентын хууль тогтоох шийдвэрт мэдээлэл болно.

Гэхдээ хорооны энэ ажлын чадамж нь тухайн үеийн Засгийн газрын хууль тогтоох хөтөлбөр, хорооны хүсэлтэд хариу ирүүлэх сайд нарын хариу цагтаа ирэх зэргээс хамаардаг байна.

Хороо нь Хууль тогтоох тухай хууль 2003 (*Legislation Act 2003*)²⁷⁴-д заасан хориглох үйл явцаас ангид хууль тогтоох арга хэрэгслүүдийн хүрээнд парламентаар хэлэлцэх бүх хууль тогтоох арга хэрэгслүүдийг шалган нягтална.²⁷⁵ Ингэхдээ хуульд заасан хугацаанд (хурлын 15 өдөрт) багтаан хууль тогтоох арга хэрэгслүүдийн шинжилгээгээ дуусгаж илтгэнэ. Гэвч нягтлан үзэж буй асуудал заагдсан хугацаанд багтаж шийдэгдэхээргүй бол хорооноос тухайн арга хэрэгслийг хориглох санал мэдэгдлийг өгч болно.

²⁷³ Absolute rights are: the right not to be subjected to torture, cruel, inhuman or degrading treatment; the right not to be subjected to slavery; the right not to be imprisoned for inability to fulfil a contract; the right not to be subject to retrospective criminal laws; the right to recognition as a person before the law; and the right to non-refoulement.

²⁷⁴ Legislation Act 2003 <https://www.legislation.gov.au/Details/C2017C00300>

²⁷⁵ Prior to March 2016, the LA was called the *Legislative Instruments Act 2003*. LA (section 9) or (section 42). <https://www.legislation.gov.au/Details/C2015C00271>

Хорооны үндсэн үйл ажиллагаа бол хууль тогтоомжийн санал оруулагчидтай (ихэвчлэн сайд нар) хэлэлцүүлэг мэтгэлцээн явуулах арга замаар хууль тогтоомжийг хянан шалгах явдал юм. Тиймээс хууль тогтоох явцад хүний эрхийн талаар холбогдох мэдэгдэлд хууль ёсоор зөв нийцүүлээгүй асуудал гарвал хороо нь өөрийн байр суурийг илэрхийлсэн урьдчилсан тайлан илтгэлийг хэвлэн нийтлүүлж, санал оруулагчдаас тодруулга мэдээллийг хүснэ. Санал оруулсан талын аливаа хариултыг тэр даруйд нь нягтлан үзэж, улмаар тухайн асуудлын талаарх хорооны дүгнэлт тайлангийн хамтаар хэвлэн нийтэлнэ. Тэрчлэн хороо нь холбогдох хууль тогтоомжуудаас хүний эрхтэй нийцүүлсэн үндэслэл заалтуудыг олж, Австралийн хүний эрхийн талаар хүлээсэн үүрэгтэй нийцүүлсэн тодорхой санал зөвлөмжийг гаргаж болно.

Зарим тохиолдолд, хуулийн санал оруулагчид хожим нь хорооны байр суурьд нийцүүлэн арга хэмжээ авч болно (жишээлбэл, хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах, эсхүл эргэн нягталж үзэх зэрэг).

Хороо нь хууль тогтоомжийн хяналт, шинжилгээний ажилтай холбоотойгоор олон нийтийн саналыг төдийлөн авдаггүй. Гэхдээ энэ хуулийн дагуу хорооны үйл ажиллагаатай холбогдох асуудлыг дэвшүүлэх хүсэл сонирхол бүхий парламентын гишүүд, бүлэг, оролцогчдын саналд нээлттэй ханддаг. Хороо нь тэдгээр саналыг тухайлсан хууль тогтоомжийн зүйлийг хянан шалгахад холбогдож байвал анхааран үзнэ.

2.2.ИХ БРИТАНИ УМАРД ИРЛАНДЫН НЭГДСЭН ВАНТ УЛС²⁷⁶

ИБУИНВУ-ын Парламентын хүний эрхийн хамтарсан хороо/The Joint Committee on Human Rights/ нь парламентын дээд, доод танхимаас томилогдсон 12 гишүүний бүрэлдэхүүнтэй бөгөөд хувь хүнд хамаарах маргаанаас бусад тус улсын дотоод дахь хүний эрхтэй холбогдох асуудлуудыг шалган судлах үндсэн чиг үүрэг бүхий хороо юм.

Парламентын хүний эрхийн хамтарсан хороо нь Засгийн газраас гарч буй аливаа шийдвэр хүний үндсэн эрх, эрх чөлөөтэй нийцэж байгаа эсэх, ИБУИНВУ-ын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцоор хамгаалагдсан хүний эрх, дотоодын болон 1998 оны хүний эрхийн тухай хууль болон Хүний эрхийн тухай Европын конвенц дахь хүний эрх, эрх чөлөөний заалтуудтай нийцэж буй эсэхийг хянан шалгана.

Мөн Засгийн газрын шийдвэр нь дээрх хууль тогтоомжид заасан хүний эрхийг хэрхэн хангаж байгаа буюу одоогийн нөхцөл байдлаас сайжруулж буй эсэх талаар хянан үздэг. Түүнчлэн тус улсын нэгдэн орсон олон улсын гэрээ конвенцоор хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаа болон хүний эрхтэй холбогдох асуудлаар гаргасан шүүхийн шийдвэрт Засгийн газраас хариу өгөх, биелүүлж байгаа эсэх асуудлаар шалгалт явуулдаг. Өөрийн эрхлэх асуудлын хүрээн дэх дурын асуудлаар шалгалт явуулах, холбогдох баримт материалыг цуглуулах зэрэг үйл ажиллагаа явуулдаг байна.

²⁷⁶ Role-Joint committee on human rights, <https://www.parliament.uk/business/committees/committees-a-z/joint-select/human-rights-committee/role/>

Хороо нь дараах зарчмын дагуу ажилладаг байна.

- Хороо шаардлагатай буюу парламентаас даалгасан асуудлыг гүйцэтгэх талаар шийдвэр гаргаж, энэ талаараа олон нийтэд мэдээлнэ;
- Холбогдох баримт бичиг, мэдээ сэлтийг олж цуглуулах;
- Шаардлагатай баримт бичгийг цуглуулах үүднээс холбогдох иргэд, албан тушаалтанг дуудан уулзах, тайлбар авах;
- Холбогдох газруудад нэвтрэх;
- Шаардлагатай асуудлаар парламентаас зөвшөөрөл авах;
- Холбогдох ажлын хэсэг, дэд хороог байгуулах;
- Холбогдох хууль тогтоомж хүний эрхэд нийцэх, нийцэж буй эсэх талаар дүгнэлт гаргах, холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах талаар санал оруулах;
- Судалгаа хийх, туршлага судлах;
- Парламентын тэргүүний холбогдох тайланг хэлэлцэх, засвар өөрчлөлт оруулах;
- Засгийн газарт хандсан тохиолдолд Засгийн газраас 60 хоногийн хугацаанд хариу өгөх;
- Тайлан гаргах, Хорооны тайланг парламентын нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх.

Мөн 1998 оны Хүний эрхийн тухай хуульд заасан аливаа засан сайжруулах шийдвэртэй холбогдох асуудлаар парламентад тайлагнах үүрэгтэй.

2002 онд батлагдсан хороодын дүрмээр²⁷⁷ хороодод томилогдох хүсэлтэй гишүүд нь тус саналаа бичгээр гаргаж өгнө. Парламентаас өөрөөр заагаагүй бол Хорооны даргыг парламентын 2 бүрэн эрхийн хугацаанд хорооны даргаар ажиллаж байсан, эсхүл 8-аас доошгүй жилийн хугацаанд гишүүнээр ажиллаж байсан этгээдийг хорооны гишүүд өөрсдөө сонгох эрхтэй байхаар заасан байна.

Дүрэмд зааснаар Хүний эрхийн хороо (ХЭХ) нь дээр дурдсан асуудлаас гадна парламентаас шаардлагатай гэж үзэж шилжүүлсэн аливаа асуудлыг авч хэлэлцэнэ. Хороо нь асуудлыг авч хэлэлцээд шаардлагатай, шаардлагагүй болон хэрхэн өөрчилбөл зохих гэсэн агуулгаар парламентад зөвлөмж гаргаж хүргүүлэх үүрэгтэй.

Хороо асуудлыг авч хэлэлцсэнтэй холбогдолтой ямар ч асуудлаар парламентад тайлан гаргаж өгч болно. Хорооны хурлын ирц 3-аас доошгүй гишүүн оролцсоноор хүчинтэйд тооцогддог байна.

Парламентаас өөрөөр тогтоогоогүй бол хорооны гишүүдийн бүрэн эрх парламентын бүрэн эрхийн хугацаатай адил байна. Хороо үйл ажиллагаагаа явуулахдаа холбогдох албан тушаалтан, албан бичиг явуулах, хурал уулзалтад байлцах, шууд олдох боломжгүй мэдээ мэдээлэл, баримт цуглуулах асуудлаар холбогдох мэргэжилтэн томилон гүйцэтгүүлэх эрхтэй байна.

2002 онд батлагдсан журмын²⁷⁸ /Standing Orders/ 152Б-д Хүний эрхийн хамтарсан хорооны талаарх зохицуулалтыг дараах байдлаар тусгасан байна.

²⁷⁷ Standing Orders №152B

²⁷⁸ Standing Orders of the House of Commons, <https://publications.parliament.uk/pa/cm200102/cmstords/27519.htm#152B>

1. 6 гишүүний бүрэлдэхүүнтэй хороо нь Лордын танхимаас томилогдсон хороотой хамтран Хүний эрхийн хамтарсан хороо нэртэйгээр ажиллана.
2. Хороо дараах асуудлыг авч хэлэлцэнэ.
 - А. ИБУИНВУ-ын доторх хүний эрхтэй холбогдох асуудлууд;
/хувь хүнтэй холбоотой хэрэг маргаанаас бусад/
 - В. Хүний эрхийн тухай хуулийн 10 дугаар зүйл болон 2-р хавсралтад заасны дагуу хэрэгжих Хүний эрхийн тухай Европын конвенцод ИБУИНВУ-ын дотоодын эрх зүйг нийцүүлэх, засан сайжруулах хууль тогтоомжийн төслийг боловсруулах;
 - С. Дээрх заалттай холбоотойгоор энэ журмын 151 дүгээр зүйлд зааснаар Парламентаас шилжүүлэн өгсөн асуудлууд.
3. Хороо дараах асуудлаар Парламентад тайлагнана.
 - А. Хүний эрхийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын 3-т заасантай холбоотойгоор Парламентад хэлэлцэгдэх төслийн талаарх зөвлөмж;
 - В. Дээр дурдсан төслийг Парламентаас батлах шаардлагатай эсэх талаарх дүгнэлт.Хороо нь дээр дурдсан асуудлыг хянан хэлэлцэх явцад үүссэн аливаа нөхцөл байдлын талаар Парламентад тайлан гаргаж болно.
4. Хороо нь Хүний эрхийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын 4-т заасантай холбоотойгоор дараах хэлбэр, агуулгаар Парламентад зөвлөмж гаргаж өгнө.
 - А. Тухайн төсөл Парламентад танилцуулагдсан хэлбэрээр батлагдах шаардлагатай эсэх;
 - Б. Холбогдох өөрчлөлт шаардлагатай эсэх;
 - В. Батлах шаардлагагүй.
5. Хорооны хурлын ирц 3 гишүүн оролцсоноор хүчин төгөлдөр байх ба шалгаж буй асуудалтай холбоотойгоор нотлох баримт цуглуулах зорилгоор хийгдэж хуралдаанд 2 гишүүн оролцсоноор хүчинтэй байна.
6. Парламентаас өөрөөр зохицуулаагүй бол хорооны хурлын гишүүний бүрэн эрх тухайн Парламентын бүрэн эрхийн хугацаанд хадгалагдана.
7. Хороо дор дурдсан бүрэн эрхтэй байна:
 - А. Холбогдох албан бичиг, албан тушаалтныг илгээх, томилж явуулах, хуралд байлцах, илтгэл тайлан явуулах;
 - В. Хорооны чиг үүрэгтэй холбогдох асуудлаар шууд унших замаар олж авах боломжгүй аливаа мэдээлэл цуглуулах, олж авах зорилгоор холбогдох мэргэжилтэн зөвлөх томилон ажиллуулах.

2.3. БҮГД НАЙРАМДАХ ХОРВАТ УЛС

Бүгд Найрамдах Хорват Улс /БНХУ/-д хүний эрхтэй холбогдон гарах харилцааг Үндсэн хууль /Constitution of Republic of Croatia/²⁷⁹, Омбудсманы тухай хууль /Ombudsman act/²⁸⁰, Эрүүдэн шүүх, хэрцгий, хүнлэг бусаар хүнтэй харьцах, шийтгэхийн

²⁷⁹ https://www.constituteproject.org/constitution/Croatia_2013?lang=en

²⁸⁰ http://rai-see.org/wp-content/uploads/2015/08/ombudsman_act-en.pdf

эсрэг үндэсний урьдчилан сэргийлэх механизмын тухай хууль /Act on the National Preventive Mechanism against Torture and other Cruel, Inhumane or Degrading Treatment or Punishment/²⁸¹ Хүнийг ялгаварлан гадуурхахын эсрэг хууль /Anti-discrimination act/²⁸², Үндэсний цөөнхийн эрхийн тухай хууль /The Constitutional National Minority Rights Act/²⁸³ болон холбогдох бусад хууль тогтоомж, олон улсын гэрээ, хэлэлцээрүүдээр тус тус зохицуулж байна.

Хорват улсын Үндсэн хуулийн III бүлгийн 14-69 дүгээр зүйлд хүний эрхийг хуульчилсан байна.

Хорват улсын парламент (Sabor) нь хүний эрхийн асуудлаар бие даасан хороотойгоос гадна асуудал тус бүрээр дэд хороотой байна. Мөн хүний эрхийн тодорхой асуудлыг хариуцсан хороодтой байна. Тухайлбал:

- Хүний эрх болон Үндэсний цөөнхийн эрхийг хамгаалах хороо /Committee on Human and National Minority Rights/
 - Хүний эрхийн дэд хороо /Human rights sub-committee/;
 - Үндэсний цөөнхийн эрхийг хамгаалах дэд хороо /National Minority Rights sub-committee/.
- Хүйсийн тэгш байдлын хороо /Gender Equality Committee/;
- Иргэний эрх чөлөө, шударга ёс, дотоод хэргийн хороо /Civil Liberties, Justice and Home Affairs Committee/;
- Үндсэн хууль, парламентын дэг, улс төрийн системийн хороо /Constitution, Standing orders and Political system committee/;
- Өргөдөл, гомдлын хороо /Petitions and Appeals Committee/;
- Ахмад дайчдын хороо /War Veterans Committee/;
- Шүүх эрх зүйн хороо /Legislation committee/;
- Үндэсний аюулгүй байдал, дотоод бодлогын хороо /Internal Policy and National Security committee/;
- Эрүүл мэнд, нийгмийн бодлогын хороо /Health and Social policy committee/;
- Гэр бүл, залуучууд, спортын хороо /Family, Youth and Sport committee/.

Эдгээрээс Хүний эрх болон Үндэсний цөөнхийн эрхийг хамгаалах хорооны талаар энд дэлгэрүүлэн авч үзлээ. Тус хороо нь дарга, дэд дарга, үндсэн 13 гишүүн, томилогдсон 4 гишүүдээс бүрдэнэ.²⁸⁴

Хорооны 7 гишүүнийг үндэсний цөөнхийн төлөөллөөс сонгоно. Үлдсэн гишүүдийг улс төрийн намын төлөөллүүд болон бие даасан гишүүдээс бүрдүүлдэг байна.²⁸⁵

Тус хороо нь Хорват улсын парламентын төлөвлөсөн үйл ажиллагааны дагуу хүний эрхийн асуудлаарх бодлого боловсруулах, бодлогын хэрэгжилтэд хяналт тавих зэрэг чиг үүрэгтэйгээр дараах хүрээнд үйл ажиллагаагаа явуулна:

- Хүний эрхийг хамгаалах олон улсын гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг хянах;
- БНХУ-ын Үндсэн хуульд заасан хүний үндсэн эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхтэй холбоотой санал, дүгнэлтэнд хяналт тавих;

²⁸¹ http://www.ilo.org/dyn/natlex/natlex4.detail?p_lang=en&p_isn=89264

²⁸² <http://www.prs.hr/index.php/english/anti-discrimination-act>

²⁸³ <http://www.sabor.hr/the-constitutional-act-on-the-rights-of-national-m>

²⁸⁴ <http://www.sabor.hr/committee-on-human-and-national-minority-right-9>

²⁸⁵ http://archive.ipu.org/parline-e/reports/instance/2_53.htm

- Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах болон хэрэгжүүлэх;
- БНХУ-ын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид заасан үндэсний цөөнхийн эрхийг хамгаалах заалтыг хэрэгжүүлэх;
- Хорват улсын доторх болон Европын бусад улс орнуудад амьдарч буй үндэсний цөөнхөд хамааралтай олон улсын гэрээ хэлэлцээр, олон улсын соёл, боловсролын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх;
- Үндэсний цөөнхөд шаардлагатай, тулгамдсан хэрэглээг нь санхүүжүүлэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Хүний эрх болон Үндэсний цөөнхийн эрхийг хамгаалах хороо нь хүний эрх болон үндэсний цөөнхийн эрхийг хамгаалах асуудлаар дагнасан эрдэм шинжилгээний болон мэргэжлийн, төрийн болон төрийн бус, бусад орны парламентын тухайн асуудлыг хариуцсан байгууллагууд, гадаадын болон олон улсын байгууллагуудтай хамтран ажиллана. Үүн дотроо Засгийн газрын тухайн асуудлыг хариуцсан яамдтай нягт хамтарч ажилладаг байна.

Хүний эрх болон Үндэсний цөөнхийн эрхийг хамгаалах хороо нь дангаараа болон шаардлагатай тохиолдолд парламентын бусад хороодтой хамтарсан хуралдаануудыг зохион байгуулна. Ингэснээр асуудлыг илүү нухацтай авч үзэн, хэлэлцүүлэг үр дүнтэй болдог байна.

Хорооны үйл ажиллагаанд Засгийн газрын болон Хүний эрхийн байгууллага, Үндэсний цөөнхийн эрхийг хамгаалах байгууллагын төлөөллүүд, Омбудсман байнга оролцоно.

Хорват улсын парламентын дэгийн тухай хуулиар, парламентын хорооны үндсэн бус гишүүд буюу иргэний нийгмийн байгууллагын төлөөллүүд парламентын бараг бүх хороодын ажлын албаны бүтцэд орж ажиллахаар заасан байдаг байна.

Хүний эрхийг хамгаалагч Иргэний нийгмийн байгууллагууд нь хууль тогтоомжийн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах саналаа олон нийтийн хэлэлцүүлэг болон тухайн асуудлыг хамаардаг парламентын байнгын хороодоор дамжуулан уламжилдаг байна.²⁸⁶

2008 оноос Хорват улсын Омбудсман нь Хүний эрхийн үндэсний хорооны үүргийг гүйцэтгэх болсон байна. БНХУ-д хуулиар олгосон хүний эрхийг хамгаалах эрх бүхий Омбудсперсоны (хүйсийн хувьд эрэгтэй, эмэгтэй аль нь ч байж болно) эрх, үүргийг Үндсэн хууль, Омбудсманы тухай хууль болон Хүнийг ялгаварлан гадуурхахын эсрэг хуулиар тус тус зохицуулсан байна.

БНХУ-ын Үндсэн хууль

93 дугаар зүйл:

Омбудсперсон нь БНХУ-ын Үндсэн хууль болон бусад хууль, тогтоомж, олон улсын хүний эрхийг хамгаалах хууль эрх зүйн баримт бичгүүдэд заасан хүний эрхийг хамгаалах, баталгаажуулах эрх бүхий БНХУ-ын Парламентаас сонгосон бүрэн эрхт төлөөлөгч мөн.

²⁸⁶ http://www.europarl.europa.eu/cmsdata/122089/Answers_Croatian%20Parliament_LIBE_22-6-2017.pdf

Хүн бүр засгийн газар болон орон нутаг, бүс нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн захиргааны албан тушаалтнуудын гаргасан буруу шийдвэрийн улмаас Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжоор хамгаалагдсан эрхээ зөрчигдсэн гэж үзвэл Омбудсперсонд хандан гомдол гаргах эрхтэй.

Хорват улсын парламентаас омбудсперсоныг 8 жилийн хугацаагаар сонгоно. Омбудсперсон нь парламентаас хараат бус, бие даан үйл ажиллагаагаа явуулна. Омбудсперсонд нэр дэвшигч, түүнийг сонгох, чөлөөлөх, түүний бүрэн эрх, хэрэгжүүлэх үйл ажиллагаа зэргийг хуулиар нарийвчлан зохицуулна. Хуулиар, омбудсперсонд Үндсэн хуулиар олгосон хүний үндсэн эрхийг хамгаалах үүрэг бүхий этгээдийн хувьд тодорхой эрх мэдлийг олгоно.

Омбудсперсон болон Хорват улсын парламентаас хүний үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалахаар сонгогдсон бусад төлөөлөгчид нь Хорват улсын парламентын гишүүний адил халдашгүй эрх эдэлнэ.

Омбудсманы тухай хууль нь 2012 онд шинэчлэгдэн батлагдсан байна. Тус хуулиар Хүний эрхийг хамгаалах байгууллага буюу Омбудсманы эрх, үүрэг, гүйцэтгэх үйл ажиллагаа, хамрах хүрээг нарийвчлан заасан байна.

Омбудсман нь хүний эрхийг хамгаалах, баталгаажуулах доорх 4 чиглэлийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна:

- Хүний эрхийг хамгаалах омбудсман
- Хүйсийн тэгш эрхийг хангах омбудсман
- Хүүхдийн эрхийг хамгаалах омбудсман
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах омбудсман.

2013 оноос жил бүр Омбудсман нь Хорватын парламентад үйл ажиллагааны тайлангаа (салбар тус бүрээр) тавих болсон бөгөөд шаардлагатай тохиолдолд парламентын ажлын албанд орж ажиллан, хариуцсан асуудал нь парламентаар хэлэлцэгдэх үед парламентын хуралдаанд оролцдог байна. Хүний эрх ноцтойгоор зөрчигдсэн тохиолдолд ээлжит тайлангийн хугацааг хүлээлгүй уг асуудлыг хариуцсан байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлж, цаашлаад парламентын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэн, шийдвэрлүүлэх эрхтэй байна.

Омбудсманы тухай хууль

Хорват улсын парламентад тайлан тавих

16 дугаар зүйл:

1. Омбудсман нь жил бүр, тогтмол Хорватын парламентад ажлаа тайлагнах үүрэгтэй. Тус тайланд БНХУ дахь хүний эрх, эрх чөлөөний ерөнхий байдлын үнэлгээ, нийгмийн тодорхой бүлэг болон хувь хүний эрхийг зөрчсөн зөрчлийн талаарх үнэлгээ, Омбудсманы тавьсан шаардлага, санамж, анхааруулгын дагуу, энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасан төрийн удирдах байгууллагуудын хийсэн ажил, үйлчилгээ хийгээд иргэдийн үндсэн хууль болон бусад хууль ёсны эрх зөрчигдөхөд хүргэж буй системийн алдаа, дутагдлыг арилгах Омбудсманы зөвлөмжийг багтаадаг байна.

3. Омбудсман нь өмнөх жилийн тайланг шинэ оны эхний улиралд багтаан парламентад танилцуулах ёстой байна.
4. Омбудсман нь жилийн болон тусгай (хэрэв шаардлагатай бол) тайланг өөрийн вэбсайт болон тохиромжтой бусад хэлбэрээр олон нийтэд мэдээлэн, танилцуулах үүрэгтэй.

Хорват улсын парламенттай хамтарч ажиллах

17 дугаар зүйл:

1. Омбудсман өөрийн эрх мэдлийн хүрээнд хүний эрх, эрх чөлөөний ерөнхий байдалд үнэлгээ хийсний дагуу, шаардлагатай тохиолдолд, хууль, дүрэм журмыг нэмж батлах, нэмэлт өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлагын тухай Хорватын парламентад мэдэгдэнэ. Мөрдөгдөж буй хууль, тогтоомж нь БНХУ-ын Үндсэн хууль болон олон улсын стандартад нийцэж буй эсэхийг мөн мэдээлнэ.
2. Омбудсман нь өөрийн хариуцаж буй асуудлаар парламентын ажлын албанд орж ажиллах болон парламентын хуралдаанд оролцох эрхтэй.

Хорват улсын парламентад хүний эрхтэй холбоотой асуудал, хуулийн төсөл, Омбудсманы тайланг хэлэлцэх тусгайлсан процедур байхгүй бөгөөд бусад асуудлын адил Парламентын дэгийн тухай хуулийн дагуу хэлэлцдэг байна.²⁸⁷

2.4.ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛС

Тус улсад Хүний эрхийн зөрчилтэй тэмцдэг байгууллагыг хүний эрхийн байгууллага гэнэ²⁸⁸. Хүний эрхийн тухай ерөнхий тайлбар хийх нь тэдний ажлын онцлог байдаг. Хүний эрхийн байгууллага нь улс төрийн хоригдлыг баривчлан хорих, цаазаар авах ял оноох, эсхүл үндэстний цөөнхийг мөрдөн байцаахад байгууллагын зүгээс мэдэгдэл хийх, эсэргүүцэл илэрхийлэх буюу хэвлэлийн мэдээ гаргах замаар улс төрийн үйл явцад нөлөөлөх буюу улс төрийн тэмцэл эхлүүлэх үйл ажиллагаа явуулдаг.

Хүний эрхийн байгууллага нь Иргэний эрхийн хөдөлгөөн (1950-60-аад онд АНУ-д бий болсон арьс өнгөөр ялгаварлан гадуурхахын эсрэг нийгмийн хөдөлгөөн)-ий нэгэн адил ихэвчлэн төрийн бус байгууллага байдаг.

Ерөнхийдөө хандив, орон тооны бус гишүүнчлэл болон нэр төртэй хүмүүсийн хэлсэн үгээр дэмжлэг туслалцаа авч үйл ажиллагаа явуулдаг байна.

“Германы Хүний эрхийн институт” (ГХЭИ)

“Deutsches Institut für Menschenrechte” (DIMR)²⁸⁹

Тус институт нь 2001.03.08-ны өдөр байгуулагдсан, Берлинд орших ТББ юм. ГХЭИ нь үндэсний хүний эрхийн институтийн статустай, НҮБ-ын “Парижийн зарчим”-д үндэслэн үйл ажиллагаа явуулдаг. Орон тооны 62 ажилтантай.

2015 оноос хойш шинээр батлагдсан “ГХЭИ-ийн эрх зүйн байдал, чиг үүргийн тухай” хууль мөрдөгдөж байна. Уг хууль болон үндсэн дүрмийн дагуу тус институт нь

²⁸⁷ http://www.europarl.europa.eu/cmsdata/122089/Answers_Croatian%20Parliament_LIBE_22-6-2017.pdf

²⁸⁸ Хүний эрхийн байгууллага-Menschenrechtsorganisationen-германаар <https://de.wikipedia.org/wiki/Menschenrechtsorganisation>

²⁸⁹ Германы Хүний эрхийн институт-Deutsche Institut für Menschenrechte-германаар https://de.wikipedia.org/wiki/Deutsches_Institut_f%C3%BCr_Menschenrechte

улс төрийн хувьд хараат бус орших боловч, санхүүжилт нь даалгавар өгөгч болох парламент (Бундестаг) буюу улсын нэгдсэн төсвөөс хамааралтай юм.

Тус байгууллага нь мөн НҮБ-ын Тахир дутуу хүний эрхийн конвенц болон НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенцыг тус тус удирдамжаар хангаж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажилладаг байна. Санхүүжилт нь эхний ээлжинд Бундестагаас гарах боловч, зарим төслүүд нь гуравдагч этгээдээс санхүүждэг байна.

Ажлын агуулга, үндсэн чиглэлийг Кураториум буюу Удирдах зөвлөл тогтоодог.

Ажлын даалгаврыг хууль болон үндсэн дүрмээр тодорхойлсон байдаг. Институт нь хүний эрхийн холбогдох асуудлыг салбар хоорондын түвшинд хэрэглээнд чиглүүлсэн байдлаар судалдаг бөгөөд ХБНГУ-ын хүний эрхийн байдлыг ажигладаг байна. Германы Бундестагт жил тутам тайлагнадаг бөгөөд дотоодын болон олон улсын шүүх, цаашилбал хүний эрхийн олон улсын дээд байгууллагуудад саналаа хэлдэг байна.

Иймээс НҮБ, Европын зөвлөл болон Европын холбооны Хүний эрхийн дээд байгууллагуудтай нягт хамтран ажилладаг. Тус институт нь түүнээс гадна Үндэсний Хүний эрхийн байгууллагуудын Дэлхийн холбоо (Global Alliance of National Human Rights Institutions) болон Үндэсний Хүний эрхийн байгууллагуудын Европын сүлжээ (European Network of National Human Rights Institutions)-ний гишүүн юм. Мөн олон нийт чөлөөтэй хандах эрх бүхий хүний эрхийн сэдвээр дагнасан тусгай номын сантай бөгөөд хүний эрхийг дэмжих олон нийтийн ажил эрхэлдэг байна.

Чиг үүрэгт нь хамаарах бас нэгэн асуудал бол дотоод болон гадаадын хүний эрхийн байдалд улс төрийн зөвлөмж өгөх болон энэ талаар олон нийтийг мэдээллээр хангах явдал юм.

“Парламентчид парламентчаа хамгаалж байна”

Гадаад улсад парламентын гишүүн болон хүний эрх хамгаалагчийг мөрдөн байцаахын эсрэг чиглэсэн ийм нэртэй нэгэн хөтөлбөрийг Германы Бундестаг хэрэгжүүлдэг байна²⁹⁰.

Энэхүү ажиллагааг Бундестагийн Хүний эрх болон хүмүүнлэгийн тусламжийн хорооны ажлын алба (нарийн бичгийн даргын газар) зохицуулдаг байна.

Түүнд дэмжлэг үзүүлдэг байгууллагууд гэвэл:

- Бүлгүүдийн хүний эрх, хүмүүнлэгийн тусламжийн ажлын хэсэг
- Олон улсын парламентын холбооны дэргэдэх Германы төлөөлөгч
- Европын зөвлөлийн Парламентын хурлын дэргэдэх Германы төлөөлөгч
- OSZE-ийн Парламентын хурлын дэргэдэх Германы төлөөлөгч
- Хүний эрхийн олон улсын байгууллагууд, тухайлбал [amnesty international www.amnesty.de](http://www.amnesty.org), [Human Rights Watch www.hrw.org](http://www.hrw.org)

Уг хорооны ажил үүргийг тоймлон дурдвал:

- Дотоод болон гадаадад улс төрийн шийдвэр гаргагчтай ярилцах, заналхийлэлд өртсөн болон хоригдсон хүний эрхийг хамгаалагчийн өмнөөс

²⁹⁰ “Парламентчид парламентчаа хамгаалж байна” брошюр-„Parlamentarier schützen Parlamentarier“ flyer https://www.bundestag.de/blob/549506/98bda5de1f7a307a6171db6890a126ad/psp_flyer-deutsch-data.pdf

өргөдөл гомдол гаргах, хамгаалалтдаа авсныг илэрхийлэх буюу суллахыг шаардах;

- Гадаадад хүний эрхийг хамгаалагчтай биечлэн уулзаж, хүндэтгэл үзүүлэх, шоронд очиж уулзах, шударга шүүх хуралдаанд оролцох буюу шүүх хуралдааны процессыг ажиглах;
- Гадаад дахь заналд өртсөн парламентын гишүүнийг батлан даалтанд авах боломжийг судалдаг байна.

ХБНГУ-д үйл ажиллагаа явуулдаг хүний эрхийн байгууллагуудын жагсаалтыг дор үзүүлэв. Үүнд:

- Aktionsgruppe Indianer & Menschenrechte “Индианчууд ба хүний эрхийн бүлгэм”–Хойд америкийн индиан ард түмэнд улс төрийн болон соёлын дэмжлэг үзүүлэх
- Arbeitskreis deutscher Bildungsstätten “Германы боловсролын байгууллагуудын ажлын хэсэг”–Европ дахь ардчилал болон хүний эрхийн боловсрол олгох DARE төслийн байгууллага
- Brot für die Welt “Дэлхий дахинд талх”-Германы Эвангел сүмийн тусламжийн нэгж
- Deutsche Liga für Menschenrechte “Хүний эрхийн төлөө германы лиг”–Хүний эрхийг хамгаалахад оролцдог, ихэвчлэн ХБНГУ-д
- Deutsches Institut für Menschenrechte “Германы Хүний эрхийн институт”
- Dokumentationszentrum Menschenrechte in Lateinamerika “Латин Америкийн хүний эрхийн баримтын төв”
- Forum Menschenrechte “Хүний эрхийн чуулган”–Хүний эрхийг хамгаалах чиглэлийн германы 40 төрийн бус байгууллагын бүлэг
- Freunde der Naturvölker “Нүүдэлчин ард түмний андууд”–Дэлхийн хамгийн сүүлчийн индиан “нүүдэлчин ард түмэн”-д дэмжлэг үзүүлэх
- Gesellschaft für bedrohte Völker (GfbV) “Устаж буй ард түмний төлөө нийгэмлэг”–Тус байгууллага нь үндэсний болон шашны бүлийг хоморголон алах, хөөн зайлуулах, мөрдөн байцаах болон ялгаварлан гадуурхахын эсрэг 40 жилийн турш хүний эрхийн тэмцлийн ажил явуулж байна.
- Infoe–“Экологи болон Этнологийн институт” ТББ–Индиан ард түмэнд хүний эрхийг хамгаалах үйлсэд нь дэмжлэг туслалцаа үзүүлдэг
- Informations- und Dokumentationszentrum für Antirassismusbearbeitung “Арьс өнгөөр ялгаварлан гадуурхахын эсрэг ажлын мэдээлэл, баримтын төв”
- Internationale Liga für Menschenrechte (Berlin) “Берлиний Хүний эрхийн Олон улсын лиг”
- medico international “Медико интернациональ”–Франкфуртын тусламж ба хүний эрхийн байгууллага”
- Medinetz Dresden “Дрездений медисүлжээ”–Оршин суух зөвшөөрөлгүй дүрвэгсэд болон цагаачдад бүртгэлгүй, үнэгүй эмнэлгийн тусламж үзүүлдэг.
- Bischöfliches Hilfswerk Misereor “Мисереорын санваартны туслах нэгж”-тэд нөгөөтэйгүүр НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн дэргэдэх “Эдийн засаг ба хүний эрх” сэдвээр ажилладаг.
- Pro Asyl “–дэлхий даяар орогнох газар хайгч болон дүрвэгсдэд тусламж үзүүлдэг.

- TARGET (Menschenrechtsorganisation) “Таргет (Хүний эрхийн байгууллага)”
- Tourism Watch “Туризм воч”-Аялал жуулчлалын бүс нутаг дахь хүүхдийн бэлгийн мөлжлөгийн эсрэг

Дотоод болон гадаадын хүний эрхийн байгууллагуудыг санхүүжүүлж, дэмжлэг үзүүлдэг германы сангуудын жагсаалтыг дор үзүүлэв. Үүнд:

- Friedrich-Ebert-Stiftung, SPD-“Фридрих Эбертийн сан”, Социаль демократ нам
- Friedrich-Naumann-Stiftung, FDP-“Фридрих Науманы сан”, Чөлөөт ардчилсан нам
- Heinrich-Böll-Stiftung, Bündnis 90/Die Grünen-“Хайнрих Бөлийн сан”, 90-ийн холбоо/Ногоон нам
- Konrad-Adenauer-Stiftung, CDU-“Конрад Аденаурын сан”, Христийн ардчилсан нэгдэл нам
- Rosa-Luxemburg-Stiftung, Die Linke-“Роза Люксембургийн сан”, Зүүнтний нам

АШИГЛАСАН МАТЕРИАЛ:

- The role of parliaments in implementing ECHR standards: overview of existing structures and mechanisms, Parliamentary Assembly Council of Europe, 2016.
- <https://publications.parliament.uk/pa/cm200102/cmstords/27519.htm>
- http://archive.ipu.org/parline-e/reports/instance/2_120.htm
- Parliamentary human rights Committees, 2004, The National Democratic Institute, https://www.ndi.org/sites/default/files/parlhrccommittees_080105.pdf
- http://archive.ipu.org/parline-e/reports/instance/2_120.htm
- United Nations General Assembly, Human Rights Council, Contribution of parliaments to the work of the Human Rights Council and its universal periodic review, 2018/05/17.
- https://www.ipu.org/sites/default/files/documents/report_a_hrc_38_25_-_english.pdf
- <http://website-pace.net/documents/10643/695436/20142110-PPSDNotefondstandardsCEDH-EN.pdf/113ad45b-7ffd-4ee7-b176-7fb79ad32f93>
- http://www.europarl.europa.eu/cmsdata/122089/Answers_Croatian%20Parliament_LIBE_22-6-2017.pdf
- <http://www.sabor.hr/committee-on-human-and-national-minority-right-9>
- http://archive.ipu.org/parline-e/reports/instance/2_53.htm
- <http://www.sabor.hr/the-constitutional-act-on-the-rights-of-national-m>
- <http://www.sabor.hr/standing-orders-of-the-croatian-parliament-sabor>
- <http://ennhri.org/Ombudsman-Republic-of-Croatia>
- http://www.europarl.europa.eu/cmsdata/122089/Answers_Croatian%20Parliament_LIBE_22-6-2017.pdf
- Deutsche Institut für Menschenrechte
https://de.wikipedia.org/wiki/Deutsches_Institut_f%C3%BCr_Menschenrechte
- Parlamentarier schützen Parlamentarier
https://www.bundestag.de/blob/549506/98bda5de1f7a307a6171db6890a126ad/psp_flyer-deutsch-data.pdf
- Parlamentarier schützen Parlamentarier“ flyer
https://www.bundestag.de/blob/549506/98bda5de1f7a307a6171db6890a126ad/psp_flyer-deutsch-data.pdf
- Ipu.org
- Human right act
- Standing orders of the House of Commons - 2002(2),
<https://publications.parliament.uk/pa/cm200102/cmstords/27501.htm>



ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ПАРЛАМЕНТЫН СУДАЛГААНЫ АЛБАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

(Харьцуулсан судалгаа)

*Ц.Норовдондог (Ph.D), Г.Алтан-Оч (Ph.D),
Д.Жигваагүнсэл, И.Жаргалзаяабямба,
Р.Нургүл*

АГУУЛГА

УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Гадаадын зарим орны Парламентын Судалгааны албаны үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт

- АНУ-ын Конгрессийн Судалгааны алба
- Австралийн Парламентын Номын сан
- БНСУ-ын Үндэсний Ассамблейн Судалгааны алба
- ЯПОН улсын Парламентын Номын сан
- Македон улсын Парламентын институт
- ХБНГУ-ын Бундестагийн Судалгааны алба

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ПАРЛАМЕНТЫН СУДАЛГААНЫ АЛБАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ²⁹¹

Судалгаа, шинжилгээний ажлын хүрээнд парламентын судалгаа гэсэн бие даасан ангилал буй болсноос хойш багагүй хугацаа өнгөрсөн бөгөөд парламентын судалгааны албад нь хууль тогтоогчдыг шаардлагатай мэдээлэл, судалгаагаар шуурхай ханган, оновчтой шийдвэр гаргахад чухал нөлөө үзүүлдэг болохыг тэдгээрийн үйл ажиллагааны олон жилийн түүхэн туршлага харуулдаг.

Парламентын судалгааны алба нь номын сан, архивын хөмрөг зэрэг мэдээллийн олон талт эх үүсвэрт түшиглэн хууль тогтоох, төрийн бодлого тодорхойлох парламентын үйл ажиллагаанд мэргэжлийн үйлчилгээ үзүүлдэг нь Парламентат ёсыг хэрэгжүүлж буй улс орнуудад мөрддөг нийтлэг жишиг юм.

Парламентын судалгааны албадын чанартай судалгаа, шинжилгээ нь хууль тогтоох үйл ажиллагаанд маш чухал ач холбогдолтой:

- Юуны түрүүнд хууль тогтоох байгууллагын өмнө тулгарсан улс төрийн тодорхой асуудлаар гаргах шийдвэрийг оновчтой болгоход нөлөөлнө.
- Дараагийн түвшинд хууль тогтоох үйл явцыг хурдасгах, эрчимжүүлэхэд нөлөөлнө.
- Хууль тогтоох байгууллага улс төрийн түвшинд чанартай мэдээллийг ашигласнаар шинжлэх ухаан технологи, мэдээлэл хөгжсөн эринд амьдрах чадвартай хууль тогтооход томоохон хувь нэмэр оруулна.
- Хууль тогтоох үйл ажиллагааны судалгаа улс төрийн олон ургалч үзлийг хөгжүүлэхэд нөлөөлнө.
- Хууль тогтоох үйл ажиллагааны явцад гүйцэтгэсэн чанартай судалгаа нь хууль тогтоох байгууллагыг хүлээн зөвшөөрөх хүрээг (*легитим чанар*) өргөтгөхөд хувь нэмэр оруулдаг.
- Иргэдэд төрийн удирдлагын талаар шийдвэр гаргахад үр нөлөө бүхий санал дэвшүүлэх боломжийг олгосноор ардчиллыг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулна.
- Улс төрийн ардчиллыг гүнзгийрүүлэх, харилцан ойлголцлын соёлыг дээшлүүлэхэд нөлөөлнө.

Судалгааны албад нь дараах ерөнхий чиг үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

- Парламентаар хэлэлцэх хуулийн төслийн талаар харьцуулсан судалгаа, товч мэдээлэл, бодлогын дүн шинжилгээ, судалгаа болон эрх зүй, эдийн засаг, төсөв, хүрээлэн буй байгаль орчны шинжилгээ судалгаа, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, нийгэм, эдийн засгийн төлөв байдал эдийн засаг, мөнгөний бодлого, хуулийн төслийн нийгэмд үзүүлэх нөлөөллийн талаар мониторинг хийх;
- Парламентын гишүүд болон судалгаа захиалах эрх бүхий хэрэглэгчийн хүсэлтээр эрх зүйн акттай холбоотой мэдээлэл бэлтгэх, санал боловсруулах;
- Танхим, байнгын хороодоор хэлэлцэгдэж буй хуулийн төслийн талаарх мэргэжлийн байгууллага болон олон нийтийн санаа бодлыг тандан судлах;
- **Парламент болон Байнгын хороод, хэлтэс, албадын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхүйц судалгаа, шинжилгээний ажил гүйцэтгэх;**
- Шинээр сонгогдсон гишүүдэд зориулан лавлагаа, мэдээлэл бэлтгэх;

²⁹¹ СТ-14/210 Парламентын судалгааны албадын эрх зүйн зохицуулалт 2014 он

- **Дотоодын болон олон улсын судалгааны институт, номын сангууд, их, дээд сургуулиудтай нягт уялдаа холбоотой ажиллах;**
- Хуулийн төслийн шинжилгээ хийх;
- Олон улсын харилцааны тодорхой асуудлаар дагнасан судалгаа, мэдээллээр захиалагчийг хангах зэрэг болно.

Парламентын судалгааны албад нь үйл ажиллагаандаа бие даасан, хараат бус, тэнцвэртэй, улс төрийн үзэл бодлоос ангид, шуурхай, парламентын гишүүдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн байх гэсэн үндсэн зарчмуудыг баримтлан ажилладаг ба шуурхай гүйцэтгэл, цаг үеэ олсон байх, бичмэл материал ойлгомжтой, товчхон байх шаардлагыг хангасан байдаг шинж чанараараа академик болон их, дээд сургууль, төрийн болон бусад хэвшлийн судалгааны байгууллагаас ялгарах онцлогтой.

Австралийн парламентын Судалгаа, мэдээллийн албаны тэргүүн Юн Феррье парламентын судалгааг “Алаг эрээн орон зайд алагчлалгүй судалгаа гүйцэтгэх”²⁹² гэж тодорхойлсон нь улс төрийн олон ургалч үзэл бодол уралдсан орон зайд улс төрөөс ангид, хараат бус судалгаа гүйцэтгэхийг хэлсэн ажээ.

Хууль тогтоох үйл ажиллагааны судалгааны нэгжийг бэхжүүлэхийн тулд судлаачдад өндөр шаардлага тавигддаг. *Тухайлбал*, судлаачийн орон тоонд хамгийн сайн хүмүүсийг шилж сонгох, хууль тогтоогчийн захиалгад төвлөрөн ажиллах, үнэн зөв, тэнцвэртэй судалгаа гүйцэтгэх, улс төрийн мэдрэмж сайтай байх, улс төрийн философи сайн эзэмшсэн байх, хууль тогтоох байгууллагын төвийг сахисан арбитрын хэрэгцээг ханган ажиллах зэрэг болно.

Эндээс үзвэл парламентын судалгааны албаны үйл ажиллагааны эрх зүйн хэм хэмжээг хуульчлан тогтоох нь маш чухал байдаг.

Улс орнуудын парламентын дэргэдэх ажлын албаны бүтэц, зохион байгуулалтаас үзэхэд судалгааны нэгж нь парламентын ажлын албаны үндсэн бүтцэд, эсхүл парламентынхаа харьяанд харьцангуй бие даасан (*ажлын албатайгаа ижил статустай*) хэлбэрээр ажилладаг байна. (*Хавсралт1-ээс үзнэ үү.*)

Парламентын судалгааны нэгж нь парламентын ажлын албатай ижил статустай ба бие даасан эрх зүйн актаар үйл ажиллагаа нь зохицуулагддаг АНУ-ын Конгрессийн Судалгааны алба /KCA/, Австралийн Парламентын номын сан, Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндэсний Хурлын Судалгааны алба, Японы Парламентын номын сан, Македон улсын Парламентын институт, ХБНГУ-ын Бундестагийн судалгааны албаны эрх зүйн зохицуулалтыг дэлгэрэнгүй авч үзэв.

2.1.АНУ-ын Конгрессийн Судалгааны алба²⁹³ /KCA/:

Конгрессийн хууль тогтоох үйл ажиллагааг сайжруулах зорилгоор 1914 онд Конгрессийн номын сангийн бүтцэд Хууль зүйн лавлагааны албыг байгуулжээ. “Хууль тогтоох байгууллагын бүтэц, зохион байгуулалтын тухай хууль”-аар (*Legislative Reorganization Act of 1970*) 1970 онд Хууль зүйн лавлагааны албаны нэрийг өөрчилж Конгрессийн судалгааны алба болгосон байдаг.

²⁹² Юн Феррье. Успешное предоставление профессиональных беспристрастных услуг в пристрастной среде. Совет Федерации РФ. Аналитический вестник. №8 (228). М., 2004г.

²⁹³ Дэлхийн улс орнуудын парламентын Ажлын алба. Уб., 2012 он, 53 дахь тал.

Конгрессийн судалгааны алба нь хууль тогтоох үйл ажиллагаанд туслах дэлхийн хамгийн том судалгааны төв бөгөөд Конгрессийн гишүүд солигдож шинэчлэгдсэн ч энэ алба нь “Конгрессийн тархи” болж үе үеийн Конгрессийн гишүүд, Байнгын хороодод мэдээлэл, мэдлэг, судалгаагаар хангах үйлчилгээг үзүүлдэг байнгын цэнэглэгч хүч нь байсаар иржээ. Шинжээчид нь хуулийн төслийг Байнгын хороодоор хэлэлцүүлэхээс эхлээд хууль батлагдах хүртэлх бүх шатанд мэдээлэл, судалгааг бэлтгэхдээ цаг үедээ нийцсэн, бодитой, аль нэг улс төрийн хүчнээс хараат бус, төвийг сахисан, нууцлалыг чандлан хадгалах зарчмуудыг барьж ажиллах ёстой.

Гүйцэтгэх засаглал ба хууль тогтоох байгууллагын судалгааны чадавхыг тэнцвэржүүлэх зорилгоор тус албыг 1970-аад оны үед өргөтгөн бэхжүүлсэн байна. Эрх зүйн зохицуулалтын хувьд тус албаны үйл ажиллагааг АНУ-ын Конгрессийн хууль тогтоох үйл явцтай нягт уялдуулж өгсөн ба Конгресст бодлогын олон талт хувилбарууд ба тэдгээрээс гарах үр дагаврыг тооцсон санал боловсруулан танилцуулах үүрэг хүлээдэг.


Судалгааны албанаас тайлан, мэдээлэл, илтгэл бэлтгэх, семинар, хэлэлцүүлэг зохион байгуулах, биечлэн болон утсаар зөвлөгөө өгөх зэрэг төрөл бүрийн үйлчилгээг гишүүд, Байнгын хороод, Конгрессийн дээд, доод танхимд хууль тогтоох үйл ажиллагааны бүх шатанд үзүүлдэг.

Судалгааны албаны бүтэц:

Захирлын ажлын алба:

- Захиргааны үйл ажиллагааны алба - *Office of Administrative Operations*
- Олон нийттэй харилцах алба - *Communications Office*
- Нягтлан шалгах газар - *Review Office*

Судалгааны алба нь 5 салбар, 1 хэсэгтэй.



1) Нэгдсэн Улсын хуулийн салбар

Энэ салбар нь хуулийн чиглэлийн бүхий л асуултуудад хариулт өгдөг. Ингэхдээ тухайн асуудал Үндсэн хуулийн зарчим, холбогдох хууль тогтоомж, холбооны улсын зарчим, худалдаа, иргэний эрхтэй нийцсэн эсэх талаас голчлон авч үзнэ. Түүнчлэн бизнес, гэмт хэрэг, байгаль орчин, иргэний эрх, олон улсын эрх зүйн зарчим, хэм хэмжээ зэрэг салбарын хууль, холбогдох асуудлуудад дүн шинжилгээ хийдэг. Энэ салбар нь дотроо 5 хэсэгтэй.

2) Нийгмийн бодлого

Энэ салбар нь дотоодын нийгмийн бодлогын хөтөлбөрийн асуудлуудад дүн шинжилгээ хийж үнэлэлт, дүгнэлт өгөх зорилготой. Энэ салбарын хамрах асуудлын хүрээнд боловсрол, хөдөлмөрийн нөөц, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн даатгал ба санхүүжилт, эрүүл мэндийн үйлчилгээ, насжилт, нийгмийн даатгал, тэтгэвэр, иргэдийн шилжилт хөдөлгөөн, эрүүгийн хэргийн шүүх, нийгмийн хангамж, хүнс ба орон сууцны хөтөлбөрүүд зэрэг багтана. Энэ салбар нь дотроо 6 хэсэгтэй.

3) Гадаад хэрэг, батлан хамгаалах, худалдаа

Энэ салбарын шинжээчид нь дэлхийн улс төр, эдийн засгийн хөгжлийн асуудал, АНУ ба бусад улс хоорондын улс төр, эдийн засгийн харилцаа, улс хоорондын асуудал болох терроризм, цагаачлалын асуудлыг хариуцан ажилладаг. Үндэсний аюулгүй байдлын судалгаанд зэвсэгт хүчний стратеги, АНУ-ын батлан хамгаалахын төсөв, зэвсгийн систем, зэвсэгт хүчний баазын нөхөн төлбөр зэрэг асуудлууд хамаарна. Худалдааны шинжээчид нь эдийн засгийн асуудлуудад дүгнэлт өгөх ба худалдааны тариф, экспорт, импортын талаарх судалгаа шинжилгээний асуудлыг хариуцна.

4) Засгийн газар ба Санхүү

Энэ салбарын шинжээчид нь Конгресс ба шүүх засаглал, гүйцэтгэх засаглалын салбарын үйл ажиллагаа (*Ерөнхийлөгчийн алба ба эрх мэдэл, ерөнхийлөгчид нэр дэвшигчид, холбооны ажиллах хүч, Нэгдсэн улсын шуудан, дүрэм журмын удирдлага, спорт*), Холбооны улсын зарчим, сонгууль ба онцгой байдлын удирдлага, банк, даатгал, үнэт цаас ба макро эдийн засгийн бодлого, хууль тогтоох ба төсөв батлах үе шат, Засгийн газрын санхүү ба татварын асуудлыг хариуцан ажилладаг.

Санхүүгийн асуудлын хүрээнд банк, санхүүгийн байгууллага, даатгал, үнэт цаас, татвар, төрийн санхүү, төсвийн болон мөнгөний бодлого, улсын зээлэлт, эдийн засгийн зээлийн үзүүлэлтүүдийг судалдаг. Тус салбар нь зургаан хэсэгтэй бөгөөд хэсэг тус бүр удирдагчтай байна.

5) Шинжлэх ухаан, үйлдвэрлэл, нөөц

Тус салбар нь байгалийн нөөц, шинжлэх ухааны дэвшил, технологийн хөгжил, бизнесийн гол салбаруудын зохицуулалтын судалгаа хийдэг. Нөөцийн асуудлын хүрээнд байгалийн баялаг, байгаль орчин, хөдөө аж ахуй, хүнс ба загас агнуур, эрчим хүч ба ашигт малтмал зэрэг хамаарна. Шинжлэх ухааны салбарын асуудалд иргэний болон зэвсэгт хүчний судалгаа хөгжлийн асуудлууд, мэдээллийн технологи, сансар судлал, бусад шинжлэх ухааны салбарууд хамаарна. Үйлдвэрлэлийн асуудалд тээврийн хяналт, тээврийн дэд бүтцийн асуудал, үйлдвэрлэлийн зах зээл ба зохицуулалтын талаарх шинжилгээ, судалгааны ажлууд багтдаг. Энэ салбар нь 6 хэсэгтэй.

Мэдлэгийн мэдээллийн хэсэг

Энэ хэсэг нь дээр дурдагдсан судалгааны салбаруудын бодлогын судлаачдын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, туслах хэлбэрээр хамтран ажилладаг.

КСА- ны Эрхэм зорилго: “Хууль тогтоох үйл ажиллагаанд Конгрессийг иж бүрэн, үнэн зөв мэдээлэл, дүн шинжилгээ, судалгаагаар хангаж ажиллах, үйлчилгээ нь төвийг сахисан, цагаа олсон, нууцыг чандлан хадгалсан байх”

КСА-ны Үнэт зүйлс: “Нууцыг хадгалах, төвийг сахих, бодитой хандах” хэмээн тодорхойлжээ.

Энэхүү эрхэм зорилго, үнэт зүйлсийн дагуу КСА-ны ажилтан бүр судалгааны бүх үе шатанд нууцыг чандлан хадгалах, төвийг сахиж нөлөөнд үл автсан, бие даасан байдлаар гишүүдэд дэмжлэг үзүүлэх, тэнцвэртэй, бодитой дүн шинжилгээ хийх, мэдлэг, мэдээллийг хадгалах, уламжлан дамжуулж ажилладаг.

КСА-ны чиг үүрэг: Конгресст Нэгдсэн улсын иргэдийн эрх ашигт нийцсэн, мэдээлэлд суурилсан шийдвэр гаргахад шаардлагатай төвийг сахисан судалгаа, дүн шинжилгээ хийх, бодлогын альтернатив хувилбарууд боловсруулах, түүнээс гарч болох үр дагаврыг тооцоолсон мэдээллээр хангах үүрэгтэй.

Конгрессийн судалгааны албанаас үзүүлэх үйлчилгээ болон бүтээгдэхүүнүүд:

- Бодлого, эрх зүй болон процедурын иж бүрэн дүн шинжилгээ хийх;
- Бодлогын олон талт хувилбаруудыг нээн илрүүлэх, үнэлэх, тэдгээр хувилбаруудын үр дүн, үр дагаврыг тооцох;
- Хуулийн төсөл боловсруулахад анхан шатны дэмжлэг үзүүлэх;
- Сүүлийн үеийн судалгааны арга зүй, аргачлалыг ашиглан тодорхой асуудлаар тоон мэдээллийн сан буй болгох, дүн шинжилгээ хийх;
- Судалгааны шинэ үр дүн, мэдээ ба мэдээллийн эх сурвалжийг олж авах, тодорхойлолт гаргах;
- Конгрессийн байнгын хороодод шинжээчийн дүгнэлтийг сонсгох;
- Хууль тогтоох байгууллагын анхаарлын төвд байгаа асуудлаар сургалт семинар хийх.

КСА нь зөвхөн Конгрессийн байнгын хороод болон Конгрессийн гишүүдийн мэдээлэл, судалгааны хэрэгцээг хангах зорилгоор ажилладаг. КСА-ны үйлчилгээний хэлбэр:

- Зөвлөгөө өгөх, мэдээлэл хийх;
- Нууц танилцуулга бэлтгэх;
- Шинжээчдийн мэдүүлэг хийх;
- Цахим хуудасны үйлчилгээ;
- Конгрессоор дамжуулж олон нийтэд хүргэх мэдээлэл;
- Сургалт семинар зохион байгуулах;
- Ерөнхий мэдээллээр хангах;
- Уншлагын танхим ба судалгааны төвүүдээр дамжуулж үйлчлэх.

Конгресст хэлэлцэх хуулийн төслийн жагсаалттай уялдуулан Судалгааны албанаас бэлтгэн гаргаж буй судалгаа шинжилгээний бүтээлүүд нь зохиогчийн эрхээр хамгаалагдахгүй бөгөөд Конгрессийн зөвшөөрлөөр нийтэд чөлөөтэй ашиглагдахаар КСА-ны цахим хуудсанд байрлуулдаг. Мөн Конгрессийн гишүүд болон бүх Байнгын хороодын хүсэлтээр мэдээлэл бэлтгэх бөгөөд энэ мэдээлэл нь бүх гишүүдэд нээлттэйгээр эсвэл зөвхөн нэг гишүүнд зориулагдсан нууц хэлбэрээр бэлтгэгдэнэ.

Хуулиар хориглосон үйлчилгээ

- Туйлширсан, төвийг үл сахисан, нэг талын өрөөсгөл мэдээллийн үйлчилгээ үзүүлэх;
- Конгрессийн нэг гишүүний мэдээллийг нөгөө гишүүнд дамжуулан өгөх;

- Хуулийн төслийг бичих болон хуультай холбоотой албан ёсны төсөв тооцоо гаргах.

2 дугаар хэсгийн бичлэгийн хэлбэрийг хадгалсан албан бус орчуулга

Хэсэг 2 – Конгрессийн судалгааны алба

Конгрессийн судалгааны чадавхыг сайжруулах

Зүйл 321. (a) Нэмэлт оруулсан 1946 оны Хууль тогтоох байгууллагыг өөрчлөн байгуулах хуулийн (2 U.S.C. 166) 203 дугаар зүйлийг дараах байдлаар өөрчлөв:

Конгрессийн судалгааны алба

“Зүйл 203. (a) Конгрессийн номын сангийн Хуулийн лавлагааны албыг цаашид Конгрессийн номын сан дахь бие даасан департамент хэлбэрээр ажиллуулах ба Конгрессийн судалгааны алба гэж өөрчлөн нэрлэнэ.

“(b) Конгрессийн бодлого нь-

“(1) Конгрессийн Номын санч нь Конгрессийн судалгааны албанд доорх чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь бүх арга замаар дэмжиж, туслаж, хамтран ажиллана-

- (A) Конгресст хамгийн үр дүнтэй, бодитой тусалцаа үзүүлэх
- (B) Конгрессийн онцлог хэрэгцээнд хамгийн шуурхай, үр дүнтэй, бодитой хариулт өгөх ба
- (C) Конгресст өөрийн үүргээ биелүүлэх;

ба

(2) Конгрессийн Номын санч нь Конгрессийн судалгааны алба хараат бусаар судалгаа хийх болон судалгаа хийхдээ захиргаанаас максимум хэмжээгээр хамааралгүй байх нөхцөл бүрдүүлэх баталгаа, энэ нөхцөлийг бүрдүүлэгч байна.

“(c) (1) Конгрессийн судалгааны албаны захирлыг Конгрессийн Номын санч Конгрессийн Номын сангийн хамтарсан хороотой зөвшилцсөний дараа томилно. Захирлын суурь цалин нь United States Code, Title5-ийн 5310 дугаар зүйл дэхь Гүйцэтгэх ажилтны цалингийн сүлжээний V түвшний жилийн суурь цалинтай тэнцүү байна.

(2) Захирлын санал болгосноор Конгрессийн Номын санч Конгрессийн судалгааны албаны орлогч захирал болон бусад ажилтнуудыг томилно. Орлогч захирлын суурь цалинг United States Code, Title5-ийн 51 дүгээр бүлэг (ангилалтай холбоотой) болон 53 дугаар бүлгийн III дэд бүлэг (Цалингийн нэгдсэн сүлжээтэй холбогдох)-т үндэслэн тогтооно, гэхдээ уг Title-ийн 5108(a) заалтыг харгалзахгүй. Конгрессийн судалгааны албаны бусад ажилтнуудын суурь цалинг United States Code, Title5-ийн 51 дүгээр бүлэг (ангилалтай холбоотой) болон 53 дугаар бүлгийн III дэд бүлэг (Цалингийн нэгдсэн сүлжээтэй холбогдох)-т үндэслэн тогтооно. Энэ заалтанд хамаарахгүй ажилтнууд нь—

(A) Энэ зүйлийн (e) дэд зүйлд заагдсан судалгааны секторуудын Ахлах мэргэжилтний албан тушаалын ангилал нь Засгийн газрын гүйцэтгэх ажилтны хамгийн дээд ангилалаас багагүй байна, энд мөн тухайн үед томилогдон ажиллаж байгаа судалгааны аналитикууд болон хяналтын чиг үүрэггүй зөвлөхүүд орно.

(B) Конгрессийн судалгааны албаны мэргэжилтэн болон ахлах мэргэжилтэн нь United States Code, Title5-ийн 5332 дугаар зүйлд заагдсан албан тушаалын Ерөнхий ангиллын GS-16, 17, 18–тай адил ангилалд багтааж болно, гэхдээ уг Title-ийн 5108(a) заалтыг харгалзахгүй. Эдгээр албан тушаалтны албан тушаалын ангилалыг тогтоохын тулд Конгрессийн Номын сангийн нэгдсэн хороотой урьдчилан зөвшилцсөн байна.

(3) энэ дэд зүйлийн (1), (2) заалтууд болон энэ зүйлийн (e) дэд зүйлийн дагуу ажилтныг томилохдоо Нийтийн албаны тухай хууль болон улс төрийн намын харьяаллыг харгалзахгүй, зөвхөн тухайн албан тушаалын чиг үүргийг хэрэгжүүлж чадах чадварыг нь харгалзана.

“(d) Конгрессийн судалгааны алба нь доорх чиг үүргийг алагчлалгүйгээр²⁹⁴ гүйцэтгэнэ:

(1) Сенат юмуу Төлөөлөгчдийн танхимын хороод, Конгрессийн хамтарсан хороодын хүсэлтээр тухайн хорооны эрхлэх асуудлын хүрээнд хууль тогтоох үйл ажиллагааны санал болон Конгресст Ерөнхийлөгчөөс, эсвэл Засгийн газраас өргөн барьсан асуудлаар шинжилгээ, үнэлгээ, дүгнэлт гаргахад нь туслах, зөвлөлгөө өгөх, Хороонд туслахын тулд-

- (A) Тухайн саналыг хүлээн авах эсэхийг шийдвэрлэх;
- (B) Тухайн санал болон альтернатив саналаас үүдэн гарч болох үр дүнг үнэлэх; ба
- (C) Тухайн үр дүнд хүрч болох өөр арга хэрэгслийн талаар дүгнэлт гаргахад нь туслах болон Хороо зайлшгүй шаардлагатай гэж үзсэн асуудлаар судалгаа, анализийн үйлчилгээ үзүүлэх, өөрөөр хэлбэл, бүхэлдээ хууль тогтоох санал, санаачлагыг зөв зохистойгоор тодорхойлох, үнэлэхэд туслах; Судалгааны алба энэхүү үүргээ

²⁹⁴ without partisan bias – нэг талыг бариагүй, алагчлаагүй, тал тохой татаагүй, төвийг сахисан

гүйцэтгэхийн тулд АНУ-ын Засгийн газрын аль ч яам, агентлагаас шаардлагатай гэж үзсэн баримт, бичиг, меморандум, захидал харилцаа, ном, бичлэгийг гаргуулан авах эрхтэй, энэ эрхийг нь Хорооноос баталгаажуулна; АНУ-ын яам, агентлагууд нь гаргасан хүсэлтийг нь биелүүлэх үүрэгтэйгээс гадна холбогдох бусад хүсэлтийг нь биелүүлэх ёстой; Судалгааны алба бүх Хороодтой байнга, тогтмол харилцаж байх ёстой.

- (2) Шинээр сонгогдсон Конгрессийн нээлтэн дээр Сенатын болон Төлөөлөгчдийн танхимын хороод, хоёр Танхимын Хамтарсан хороодод тухайн Хорооны хамрах хүрээнд Конгрессийн эрхийн хугацаанд хэрэгжүүлэх, дуусгах хөтөлбөр, ажлуудын жагсаалтыг хүргэх;
- (3) Шинээр сонгогдсон Конгрессийн нээлт дээр Сенатын болон Төлөөлөгчдийн танхимын хороод, хоёр Танхимын Хамтарсан хороодод тухайн хорооноос Судалгааны албаар анализ хийлгэж болох асуудал, бодлогын хүрээг мэдээллэх;
- (4) Захиалгын дагуу юмуу захиалга ирүүлээгүй ч өөрийн санаачлагаар хууль тогтоох үйл ажиллагаанд хэрэглэгдэх судалгаа, тайлан, хэвлэлийн тойм, бюллетень, орчуулга зэрэг аливаа материалыг цуглуулж, ангилж, анализ хийж судлан Сенат, Төлөөлөгчдийн танхимын гишүүд, Хороод болон хоёр Танхимын Хамтарсан хороодын хэрэгцээнд ашиглаж болохуйц сан бүрдүүлэх;
- (5) Захиалгын дагуу юмуу захиалга ирүүлээгүй ч өөрийн санаачлагаар Сенат, Төлөөлөгчдийн танхимын гишүүд, Хороод болон хоёр Танхимын Хамтарсан хороодын хууль тогтоох болон төлөөлөх чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь зориулан мэдээлэл, судалгаа, лавлагаа бэлтгэх, хүргүүлэх;
- (6) Сенат болон Төлөөлөгчдийн танхимд өргөн баригдсан хуулийн төслүүд бусад нийтлэг тогтоомжуудын талаар товчлол, лавлагаа бэлтгэх;
- (7) Конгрессийн гишүүн болон хороодын захиалгаар Конгресс, Хороодын сонсголоор хэлэлцэхээр тогтсон хууль тогтоох үйл ажиллагаатай холбоотой аливаа асуудлаар товч илтгэх хуудас бэлтгэн хүргүүлэх. Уг товч илтгэл нь тухайн асуудлын зорилго, гарч болох үр дүнгийн талаар болон өмнө нь Конгресст өргөн баригдаж байсан төсөөтэй асуудал, арга хэмжээ, гарсан үр дүнгийн талаарх тойм, Конгрессоос адил төсөөтэй асуудлаар авсан арга хэмжээнүүдийг тусгасан байна;
- (8) Энэ дэд хэсэгт заагдсан чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээлэл, судалгааны чадавх, үүний дотор Ахлах мэргэжилтнүүд, мэргэжилтнүүд, албан хаагчид, зөвлөхүүдийн хүчийг бүрдүүлэх, хөгжүүлэх.

“(e) Конгрессийн судалгааны албаны ажилтнуудыг Захирал, мэргэжилтэн, ахлах мэргэжилтний санал болгосноор Конгрессийн Номын санч дараах судалгааны салбаруудад томилно:

- (1) Хөдөө аж ахуй;
- (2) Америкийн Засгийн газар, нийтийн алба;
- (3) Америкийн нийтийн эрх зүй;
- (4) Байгал хамгаалах;
- (5) Боловсрол;
- (6) Нийтийн үйлчилгээний ажил, инженерийн ажил;
- (7) Орон сууцжуулалт;
- (8) Аж үйлдвэрийн зохион байгуулалт, корпорацын санхүү;
- (9) Олон улсын харилцаа;
- (10) Гадаад худалдаа, эдийн засгийн харилцаа;
- (11) Ажлын байр, хөдөлмөр эрхлэлт;
- (12) Ашигт малтмалын эдийн засаг;
- (13) Мөнгө, банк;
- (14) Үндэсний батлан хамгаалах;
- (15) Үнийн эдийн засаг;
- (16) Шинжлэх ухаан;
- (17) Нийгмийн хамгаалал;
- (18) Татвар, төсвийн бодлого;
- (19) Технологи;
- (20) Тээвэр, харилцаа холбоо;
- (21) Хотжилтын асуудал;
- (22) Ахмад дайчдын асуудал;
- (23) Захирлын шаардлагатай гэж үзсэн судалгааны бусад чиглэл.

Мөн Сенат болон Төлөөлөгчдийн танхимын Хороод, гишүүд, Конгрессийн хамтарсан хороодын тусгай ажлын шаардлагын дагуу энэ зүйлийн (d) дэд хэсэгт заагдсан чиг үүргийг хэрэгжүүлэх мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн болон бусад ажилтнууд байна.

“(f) Захирал доор дурдсан эрхтэй:

- (1) Сенат болон Төлөөлөгчдийн танхимын Хороод, гишүүд, Конгрессийн хамтарсан хороодоос

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

Конгрессийн судалгааны албанд хандан гаргасан зөвлөлгөө, тусламж, бусад үйлчилгээ хүссэн захиалгыг өөрийн шаардлагатай гэж үзсэн хэлбэрээр ангилах, системчлэх, эрэмбэлэх, бүлэглэх, хуваах зэргээр зохион байгуулах-

- (A) Сенат болон Төлөөлөгчдийн танхимын гишүүдийн захиалгыг гүйцэтгэх ажлыг хурдавчлах, дөхөм хэлбэрт оруулах,
- (B) Сенат болон Төлөөлөгчдийн танхимын Хороод, Конгрессийн хамтарсан хороодод үзүүлэх үйлчилгээний үр дүнг дээшлүүлэх,
- (C) Конгрессийн судалгааны албанаас хууль тогтоох ажлын судалгаа болон бусад үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх болон

(2) Энэ зүйлд заагдсан зорилтыг биелүүлэхэд илүү тохиромжтой гэж үзвэл тодорхой хугацаанд Конгрессийн судалгааны албаны судалгааны болон лавлагааны хэсгүүд, бусад зохион байгуулалтын нэгжүүдийг өөрчлөн зохион байгуулах.

“(g) Санхүүгийн жил бүрийн Конгрессийн судалгааны албаны төсвийн хэрэгцээг Конгрессоос судлах, хэлэлцэх, үнэлэх, тогтоох процессийг хялбарчлахын тулд Конгрессийн номын сангийн тухайн санхүүгийн жилийн төсвийн төсөлд тусдаа бие даасан хэсэг болж орох Конгрессийн Судалгааны албаны төсвийн төслийг Захирал тусдаа бие даан нарийвчлан бэлтгэх ба Конгрессийн Номын санч уг төслийг хүлээн авч АНУ-ын Засгийн газрын төсөвт тусгуулахаар өргөн барина.

“(h) (1) Конгрессийн Судалгааны албаны захирал нь түр хугацаагаар болон үе үе хувь экспертүүд, зөвлөхүүд (стенографч мөн орно) болон мэдлэгийн тодорхой салбараар мэргэжсэн хүмүүсийг татан ажиллуулж болно:

- (A) Хувь экспертүүд, зөвлөхүүд болон чөлөөт судлаач бусад этгээдтэй Конгрессийн судалгааны албанд зориулан судалгаа, трактат, тодорхой сэдэв, ярилцлага, диссертаци, резюме, зөвлөхийн дүгнэлт болон бусад холбогдох үйлчилгээ үзүүлэх гэрээ (*Nonpersonal services contract*²⁹⁵) байгуулах, буюу
- (B) Хувь экспертүүд, зөвлөхүүд болон чөлөөт судлаач бусад этгээдийг Конгрессийн судалгааны албанд ажиллуулах (нэг жил хүртэл хугацаагаар) хувийн гэрээг (*Personal services contract*²⁹⁶) нийтийн албаны ангилалд хамруулахгүйгээр байгуулах. Энэ гэрээгээр хөдөлмөрийн хөлсний хэмжээ нь US Code-ийн Title 5-ын 3332 дугаар зүйлийн Ерөнхий ангилалд заасан суурь цалингийн дээд ангилалаас хэтрэхгүй байх ба албан томилолтоор явж ажиллах бол томилолтын мөнгө олгоно.

(2) Конгрессийн судалгааны албаны захирал нь түр хугацаагаар болон үе үе боловсрол, судалгааны болон бусад экспертүүд, зөвлөхүүдийн байгууллага (стенографч мөн орно) болон мэдлэгийн тодорхой салбараар мэргэжсэн боловсрол, судалгаа, болон бусад чиглэлийн байгууллагатай гэрээ байгуулан ажиллаж болно.

“(i) Конгрессийн судалгааны албаны захирал нь Конгрессийн ээлжит чуулган бүрийн өмнө ирэх санхүүгийн жилд Конгрессийн судалгааны албаны хийх ажлын талаар тусд нь дэлгэрэнгүй, нарийвчилсан илтгэл бэлтгэж Номын сангийн хамтарсан хороонд хүргүүлнэ.

“(j) Хамтарсан хороо нь Конгрессийн судалгааны албанаас санхүүгийн жилд чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэмжээ болон санхүүжилтийн хуваарийг тогтооно.”

(b) 1946 оны “*Legislative Reorganization Act of 1946*” хуулийн Title II –ийн гарчигийн хэсгийн “Sec. 203. Legislative Reference Service.” гэснийг зураасаар даран “Sec. 203. Congressional Research Service ” гэж оруулна.

Зүйл 322. Хууль тогтоох байгууллагын санхүүжилтийн тухай хуулийн²⁹⁷ 105 дугаар зүйл (61 Stat, 377; Public Law 197, Eightieth Congress) болсон Төлөөлөгчдийн танхимын “Мэдээллийн зохицуулагчийн офисийн тухай” наядахь Конгрессийн Төлөөлөгчдийн танхимын 183 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцов.

2.2.Австралийн Парламентын номын сан²⁹⁸

Парламентын Номын сан анх 1901 онд Мэлбурн хотноо Австралийн парламенттай нэгэн зэрэг байгуулагдсан түүхтэй. Тус улсын Парламентын номын сан

²⁹⁵ Nonpersonal services contract means a contract under which the personnel rendering the services are not subject, either by the contract's terms or by the manner of its administration, to the supervision and control usually prevailing in relationships between the Government and its employees.

²⁹⁶ Personal services contract means a contract that, by its express terms or as administered, makes the contractor personnel appear, in effect, Government employees

²⁹⁷ Legislative Branch Appropriation Act, 1948

²⁹⁸ Дэлхийн улс орнуудын парламентын ажлын алба. УБ., 2012 он, 46 дахь тал.

нь 1960 он хүртэл Тамгын газартайгаа нэг удирдлага, зохион байгуулалттайгаар үйл ажиллагаагаа явуулж байсан ба харин 1962 оноос Австралийн Үндэсний номын сантай хамтарч үйл ажиллагаа явуулжээ. Гэвч тун удалгүй бие даасан Парламентын номын сан болжээ. Ингээд 1999 онд парламентын номын сангийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоосон *"Парламентын үйлчилгээний тухай"* хууль батлагдсан.

Австралийн парламентын судалгааны алба нь номын сантайгаа нэгдмэл бүтэцтэй байна. Парламентын номын сан нь үндсэн хоёр хэсэгтэй. Үүнд:

- Судалгаа, шинжилгээ;
- Мэдээлэл, сурталчилгаа.

Хуулийн дагуу парламентын номын сан нь:

- Цаг хугацаанд нь, нууцлалын өндөр зэрэглэлтэйгээр баримт материалын лавлагаа, мэдээллийн үйлчилгээ үзүүлэх;
- Парламентын гишүүд, сенаторуудын хүсэлтийн дагуу мэдээлэл судалгааны үйлчилгээ үзүүлэх;
- Өндөр хэмжээний стандарт мөрдөж ажиллах;
- Үйлчлүүлэгчдэд тэгш эрхийн зарчмаар үйлчлэх;
- Сенатын гишүүдийн оролцох асуулт, хариултын арга хэмжээний /Question time/ хүрээнд хөтөлбөр боловсруулж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх;
- Гишүүдийн сонгогчидтойгоо уулзах уулзалтанд зориулсан мэдээллийг тэдний хүсэлтээр бэлтгэх үүрэгтэй.

Номын сан болон судалгааны албанаас үзүүлэх бүтээгдэхүүн үйлчилгээ:

- Шинжээчийн дүгнэлт;
- Бичгэн болон аман зөвлөмж;
- Баримт, тоон болон статистик мэдээлэл;
- Судалгааны зөвлөмж болон хэвлэл мэдээллийн анализ;
- Хуулийн төслийн тайлбар, үндэслэл;
- Сургалт, семинар, хэлэлцүүлэг, лекц, яриа;
- Сэтгүүлийн нийтлэл, өгүүлэл, ном, мэдээллийн сан;
- Хэвлэл мэдээллийн (сонин, радио, телевизийн нэвтрүүлгийн бичлэг, CD гэх мэт) бүтээгдэхүүн зэрэг байдаг. Австралийн парламентын Судалгааны албаны судалгаа шинжилгээний ажлын чухал хэсэг нь *Хуулийн төслийн дүн шинжилгээ (bill digest)* байдаг.

Хуулийн төслийн шинжилгээ

Хуулийн төслийн шинжилгээг зөвхөн Судалгааны албаны шинжээчид гүйцэтгэнэ. Учир нь Байнгын хороодын судлаачид улс төрийн өнгө аястай тайлан бичдэг гэж үздэг тул хараат бус бие даасан, бодит судалгаа гаргах үүднээс хуулийн төслийн дүн шинжилгээг судалгааны албаны үндсэн чиг үүрэгт хамааруулдаг байна.

Судалгааны алба

Австралийн Номын сангийн Судалгааны алба жилд ойролцоогоор 2000 гаруй шинжээчийн дүгнэлт болон судалгааны ажил бэлтгэж гаргадаг. Судалгааны ажил гүйцэтгэх хугацаа маш шахуу, ачаалал өндөртэй ажилладаг байна. Судалгааны салбарын бүтэц зохион байгуулалтанд дөрвөн жилийн өмнө өөрчлөлт орсон.

Судалгааны алба нь 80 гаруй судлаачид, ажилтантай. Судалгааг дараах зохион байгуулалтаар хуваарилан гүйцэтгэдэг. Үүнд:

- Эдийн засгийн судалгааны хэсэг;
- Гадаад хэрэг, аюулгүй байдлын судалгааны хэсэг;
- Эрх зүй болон хуулийн төслийн шинжилгээний хэсэг;
- Улс төр болон нийтийн удирдлагын судалгааны хэсэг;
- Шинжлэх ухаан, технологи, хүрээлэн буй орчин, байгалийн баялагийн судалгааны хэсэг;
- Нийгмийн бодлогын судалгааны хэсэг;
- Статистик, график дүрслэлийн судалгааны хэсэг.

Судалгааны хэсгүүд нь судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэхдээ "Судалгааны захиалга хүлээн авах журам", "Судалгааны ажил гүйцэтгэх заавар", "Хуулийн төслийн дүн шинжилгээ хийх журам" болон холбогдох бусад заавар, журмыг мөрдөнө.

Австралийн парламентын үйлчилгээний тухай хууль 1999²⁹⁹

Бүлэг 1

3. Хуулийн зорилт

Энэхүү хуулийн зорилт нь:

- а. Парламентад нам, улс төрийн нөлөөллөөс ангид, бүтээмжтэй, үр дүнтэй үйлчилгээ үзүүлэх.
- б. Парламентын үйлчилгээний ажилтнуудад үр дүнтэй, эрх тэгш, алагчлалгүй ажлын байр, удирдлагаар хангах эрх зүйн орчинг бүрдүүлэх.
- в. Нарийн бичгийн дарга нар, Парламентын номын санч, Парламентын үйлчилгээний Комиссар болон Парламентын үйлчилгээний Мерит зарчмыг хамгаалах Комиссар /Parliamentary Service Merit Protection Commissioner/ нарын бүрэн эрх, үүргийг тогтоох.
- г. Парламентын үйлчилгээний ажилтнуудын эрх, үүргийг тодорхойлно.

6. Департаментын үйл ажиллагаан дахь ажилтнуудын оролцох оролцоо

1. Хамтын нөхөрлөлийн өмнөөс Департаментад ажил, үүрэг гүйцэтгэж буй бүхий л албан хаагчид нь энэхүү хууль, эсхүл өөр хуульд захирагдана.
2. Дэд хэсэг 1 нь өргөмжит албан тушаалд /honorary basis/ хамаарахгүй.
3. Энэ хэсэг нь Нарийн бичгийн хувь хүмүүсийг гэрээт ажилчнаар ажиллуулах бүрэн эрхэд нь хамаарахгүй.

Бүлэг 2

7. Нэр томъёоны тодорхойлолт

Энэ хуульд заасан нэр томъёог, өөрөөр заагаагүй бол дор дурдсан утгаар ойлгоно:

Ахлах гүйцэтгэх үйлчилгээний ажилтны орлогч нь АГҮ-ний ажилтны албан тушаалд АГҮ-ний бус ажилтан орлохыг хэлнэ.

АГҮ-ий ажилтан Нийтийн албаны тухай хууль 1999-д заасныг.

Австралийн тэгш шан хөлс болон хөдөлмөрийн нөхцөлийн стандарт нь Хөдөлмөрийн тухай хуульд заасныг /Fair Work Act 2009/.

Эрх бүхий гишүүн, Парламентын намын:

- а. Парламентын намын дарга; эсхүл
- б. Парламентын намын даргаас хуульд заасан үйл ажиллагааг явуулах зөвшөөрлийг бичгээр авсан намын гишүүнийг хэлнэ.

Төсөв нь Хамтын Нөхөрлөлийн жилийн төсөв.

Бүх нийтийн сонгуулийн үеэр засгийн газрын **түр ажиллах хугацаа** нь Австралийн төсвийн шударга байдлын тухай хууль 1998-д заасныг

Парламентын үйлчилгээний ажилтны ангилал нь дараах ангиллыг хэлнэ:

- а. Парламентын үйлчилгээний ажилтнууд;
- б. Тодорхой хугацаа, эсхүл тодорхой ажил үүрэг явагдах хугацаанд Парламентын

²⁹⁹ Албан бус орчуулга

үйлчилгээнд ажиллах ажилтнууд;

в.Тогтмол бус, эсхүл давтамжтайгаар Парламентын үйлчилгээнд ажиллах ажилтнууд;

Ангиллын дүрэм нь Парламентын тухай хуулийн 23 дугаар хэсэг, 2 бүлэг заасан дүрмийг хэлнэ.

Ёс зүйн дүрэм гэдэг нь:

а. 13 дугаар хэсэгт заасан дүрэм; болон

б.Үндсэн хуулийн 50 дугаар хэсэгт зааснаар Парламентын үйлчилгээний ажилтнуудад хамаарал бүхий Төлөөлөгчдийн танхимын сенатын гаргасан аливаа журам болон тушаалууд.

Комиссар энэхүү хуульд заасны дагуу томилогдсон Парламентын үйлчилгээний Комиссарыг хэлнэ.

Хамтын нөхөрлөлийн байгууллага нь:

а.Санхүүгийн удирдлага болон хариуцан тайлагнах тухай хууль 1997-д тодорхойлсон Агентлаг; эсхүл

б.Австралийн Дээд шүүх; эсхүл

в.Хамтын нөхөрлөлийн агентлагийг Хамтын нөхөрлөлийн агентлаг болон компанийн тухай хууль 1997-д заасанчлан.

г.Хамтын нөхөрлөлийн компанийг Хамтын нөхөрлөлийн агентлаг болон компанийн тухай хууль 1997-д тус тус заасанчлан ойлгоно.

Департамент нь энэхүү хуулиар байгуулагдах Парламентын Департаментыг хэлнэ.

Бүх нийтийн сонгууль нь Төлөөлөгчдийн танхимын гишүүдийн бүх нийтийн сонгуулийг хэлнэ.

Бие даагч гишүүн, бүх нийтийн сонгуулийн үеийн түр засгийн газрын үед дараах этгээдийг хэлнэ. Үүнд:

а.Парламентын намын гишүүн бус; болон

б.бүх нийтийн сонгууль, эсхүл бүх нийтийн сонгуулийн өдөр зэрэг явагдах Сенатын сонгуульд улс төрийн намын дэмжлэггүй нэр дэвшихээр төлөвлөж буй этгээд; болон

в.түр Засгийн газар байгуулагдахын өмнөх Сенатор, эсхүл Төлөөлөгчдийн танхимын гишүүн нь:

i.Сенат, эсхүл Төлөөлөгчдийн танхимд улс төрийн намын дэмжлэггүйгээр сонгогдсон; эсхүл

ii.Сенатад улс төрийн намын дэмжлэг, нөлөөлөлгүй сул албан тушаалд сонгогдсон, эсхүл томилогдсон.

Хамтарсан Департамент нь:

а.Парламентын үйлчилгээний Департамент; эсхүл

б.Даргалагч нар нь өөр Департаментыг хамтарсан Департамент гэж тогтоовол, тухайн Департамент.

Номын сангийн хороо нь Парламентын танхимуудын Парламентын номын санчийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар Даргалагч нарт зөвлөгөө үзүүлэх зорилго бүхий хороо, эсхүл хороод.

Өндөр насны тэтгэвэрт гарах доод насны хязгаар нь:

а.доорх заалт хамаарахгүй тохиолдолд, 55 нас; эсхүл

б.тогтоолоор 55 наснаас дээш, эсхүл түүнээс доош нас заасан тохиолдолд, тухайн нас.

АГҮ-ний бус ажилтан нь АГҮ-ний ажилтнаас бусад Парламентын үйлчилгээний ажилтнуудыг хэлнэ.

Даргалагч, эсхүл **Даргалагч нар** нь:

а.Сенатын Департамент, эсхүл Сенатын Клерктэй холбоотой асуудал тухай хэлэлцэгдэж байгаа тохиолдолд, Сенатын Ерөнхийлөгчийг хэлнэ; эсхүл

б.Төлөөлөгчдийн танхимын Департамент, эсхүл тухайн танхимын Клерктэй холбоотой асуудал хэлэлцэгдэж байгаа тохиолдолд, Төлөөлөгчдийн танхимын Спикерыг хэлнэ; эсхүл

в.Сенатын ерөнхийлөгч болон Төлөөлөгчдийн танхимын Спикер нарыг хамтад нь хэлнэ.

Холбогдох Департамент нь Нарийн бичгийн даргын хувьд, түүний тэргүүлж буй Департаментыг хэлнэ.

Нарийн бичгийн дарга нь Департаментын нарийн бичгийн даргыг хэлэх ба үүнд Сенатын Клерк, Төлөөлөгчдийн танхимын Клерк болон Парламентын төсвийн ажилтан нарыг хэлнэ.

Департаментын **Нарийн бичгийн** дарга нь:

а. Департамент нь Сенатын Департамент бол Сенатын Клерк; эсхүл

- б. Департамент нь Төлөөлөгчдийн танхим бол тухайн танхимын Клерк; эсхүл
- ба. Департамент нь Парламентын төсвийн Алба бол Парламентын төсвийн ажилтан; эсхүл
- в. Департамент нь дээрхээс өөр Департамент бол тухайн парламентын Нарийн бичгийн дарга.

Сенатын сонгууль нь муж улс, нийслэлийн нутаг дэвсгэр болон Хойд нутаг дэвсгэрийн Сенатын сонгуулийг хэлнэ.

Бүлэг 3. Австралийн Парламентын үйлчилгээ

9. Австралийн Парламентын үйлчилгээний үндсэн дүрэм

1. Австралийн Парламентын үйлчилгээ Нарийн бичгийн дарга нар, Парламентын Номын санч болон Парламентын үйлчилгээний ажилтнуудаас бүрдэнэ.
2. Парламентын үйлчилгээ нь Парламентын танхим, хороо, Сенаторууд болон Төлөөлөгчдийн танхимын гишүүдэд Хамтын Нөхөрлөлийн Засгийн газраас хараат бус, мэргэжлийн дэмжлэг, зөвлөгөө өгөх болон материаллаг баазаар хангах замаар Парламентад үйлчилгээ үзүүлнэ.

10. Парламентын үйлчилгээний эрхэмлэх зүйлс

1. Парламентын үйлчилгээ нь дараах зүйлсийг эрхэмлэнэ. Үүнд:
 - а. Парламентын үйлчилгээ нь Парламентад мэргэжлийн зөвлөгөө болон дэмжлэг үзүүлэхдээ Хамтын нөхөрлөлийн гүйцэтгэх засаглалаас хараат бус байна.
 - б. Парламентын үйлчилгээ нь Парламентын танхим тус бүр, Танхим тус бүрийн хороо, хоёр танхимын хамтарсан хороо болон Төлөөлөгчдийн танхимын гишүүд болон Сенторуудад төвийг сахисан, ямарваа нэгэн алагчлалгүй зөвлөгөө болон үйлчилгээ үзүүлнэ.
 - в. Парламентын үйлчилгээ нь ёс зүйн өндөр стандартыг баримтлах.
 - г. Парламентын үйлчилгээ нь ажил үүргээ шударгаар гүйцэтгэх ба Парламентын өмнө ажлаа тайлагнана.
 - д. Парламентын үйлчилгээ нь дээд зэргийн чанартай удирдлагатай байна.
 - е. Парламентын үйлчилгээнд ажиллахыг сонгон шалгаруулалтын замаар шийдвэрлэнэ.
 - ё. Парламентын үйлчилгээ нь ажлын байранд алагчлахгүй, Австралид хүлээн зөвшөөрөгдсөн нийгмийн төрөл бүрийн бүлгүүдийг хүлээн зөвшөөрнө.
 - ж. Парламентын үйлчилгээ нь ажилтнуудтайгаа ажлын байртай холбоотой асуудлаар харилцан мэдээллэх, зөвшилцөх, хамтрах ажиллахыг эрхэмлэнэ.
 - з. Парламентын үйлчилгээ нь шударга, уян хатан, аюулгүй болон урамшуулал бүхий ажлын байраар хангана.
 - и. Парламентын үйлчилгээ ажлын үр дүн
Парламентын үйлчилгээ нь Хамтын нөхөрлөлийн нөөц, хөрөнгийг үр ашигтай, зохистой зарцуулна.
Парламентын үйлчилгээ нь ажлын байранд алагчлах, гадуурхахгүй байна.
Парламентын үйлчилгээ нь Парламентын үйлчилгээнд ажилд орох иргэдэд биелэгдэхүйц, боломжит шаардлага тавина.
 - й. Парламентын үйлчилгээ нь Австралийн засгийн газрын ардчилсан системийн уялдаа холбоо үр ашгийг дээшлүүлэх албан тушаал ахих */career based service/* тогтолцоонд суурилна.

11. Комиссар нь Даргалагч нарт Парламентын үйлчилгээний эрхэмлэх зүйлсийн талаар зөвлөгөө өгнө.

1. Комиссар нь Даргалагч нарт зөвлөгөө өгнө.
 - а. Парламентын үйлчилгээ нь Парламентын үйлчилгээний эрхэмлэх зүйлсийг даган мөрдөж, дээдэлж байгааг дүгнэхэд туслах зорилгоор
 - б. шаардлагатай үед Парламентын үйлчилгээний эрхэмлэх зүйл тус бүрийн хэрэглэх хүрээг тогтооход дэмжлэг үзүүлэхэд
2. Даргалагч энэ зүйлийн 1-т заасан Комиссараас авсан зөвлөгөөг үндэслэн, Парламентын үйлчилгээний эрхэмлэх зүйл тус бүрийн тухайд энэ хэсгийн 71-т зааснаар бичгээр тодорхойлолт гаргана.
3. Даргалагч нь энэ заалтын 1-т заасан Комиссарын зөвлөгөөнийг хувийг Парламентын танхим бүрд хүргүүлнэ.

12. Нарийн бичгийн дарга нар Парламентын үйлчилгээний эрхэмлэх зүйлсийг эрхэмлэнэ.

Нарийн бичиг нь Парламентын үйлчилгээний эрхэмлэх зүйлсийн дээдлэн эрхэмлэнэ

13. Парламентын үйлчилгээний ёс зүйн дүрэм

1. Парламентын үйлчилгээний ажилтан нь Парламентын үйлчилгээнд ажил эрхлэх хугацаандаа ажил үүргээ үнэнч шударгаар биелүүлнэ
2. Парламентын үйлчилгээний ажилтан нь Парламентын үйлчилгээнд ажил эрхлэх хугацаандаа анхааралтай болон хичээнгүй ажиллана
3. Парламентын үйлчилгээний ажилтан нь Парламентын үйлчилгээнд ажил эрхлэх хугацаандаа эргэн тойрны хүмүүст хүндлэлтэй хандах ба бусдыг доромжлохгүй байна.
4. Парламентын үйлчилгээний ажилтан нь Парламентын үйлчилгээний ажил үүрэгтэй холбоотой үйл ажиллагаа явуулахдаа холбогдох бүх Австралийн хуулийг дагаж мөрдөнө. Иймд Австралийн хуулийг дараах байдлаар ойлгоно:
 - а. Энэхүү хуулийг оролцуулан бүх хууль, эсхүл Хуулийн дагуу үйлчлэх бүх хэрэгслүүд.
 - б. Муж улс эсхүл газар нутгийн хууль тогтоомж болон тус хуулийн дагуу үйлчлэх бүх хэрэгслүүд.
5. Парламентын үйлчилгээний ажилтан нь удирдамж өгөх эрх бүхий Парламентын үйлчилгээний албаны ажилтны өгсөн хууль ёсны, үндэслэлтэй удирдамжийг дагах үүрэгтэй.
6. Парламентын үйлчилгээний ажилтан нь Парламентын танхимууд, танхимуудын аль ч хороод, хоёр танхимуудын хамтарсан хороо, Сенатор болон Төлөөлөгчдийн танхимын гишүүд, болон тэдгээрийн албан хаагчидтай харьцахдаа тодорхой хэмжээний нууцлалыг сахина.
7. Парламентын үйлчилгээний ажилтан нь өөрийн ажлын байр, үйл ажиллагаатай холбоотойгоор ашиг сонирхлын зөрчил үүсэхээс сэргийлэх арга хэмжээ авах ба тодорхой мэдээллийг ил болгоно.
8. Парламентын үйлчилгээний ажилтан нь Хамтын нөхөрлөлийн нөөцийг зүй зохистой байдлаар ашиглана. /A Parliamentary Service employee must use the resources of the Commonwealth in a proper manner. /
9. Парламентын үйлчилгээний ажилтан нь өөрийнх нь ажил, үүрэгтэй холбоотой асуудлаар албан ёсоор мэдээ, мэдээлэл авахыг хүссэн хүсэлтэд худал эсхүл төөрөгдүүлсэн мэдээ, мэдээлэл олгох ёсгүй.
10. Парламентын үйлчилгээний ажилтан нь дараах заасныг зүй бусаар ашиглахыг хориглоно:
 - а. Дотоод мэдээ, мэдээлэл; эсхүл
 - б. Ажилтны ажил үүрэг, байр суурь, болон эрх мэдэл зэргийг ашиглан ашиг орлого олох, олохыг завдах, ажилтан эсхүл өөр хэн нэгэнд давуу байдал олгох эсхүл ашиглах.
11. Парламентын үйлчилгээний ажилтан нь цаг ямагт:
 - а. Парламентын үйлчилгээний эрхэмлэх зүйл, Парламентын үйлчилгээний ажлын байрны зарчмын дээдлэн сахих болон
 - б. Өөрийн ажиллаж буй Департамент болон Парламентын үйлчилгээний нэр хүнд, бүрэн бүтэн байдлыг эрхэмлэх.
12. Парламентын үйлчилгээний ажилтан нь гадаадад ажиллаж байх хугацаандаа Австралийн нэр хүндийг дээдлэн, биеэ зохих байдлаар авч явна.
13. Парламентын үйлчилгээний ажилтан нь тогтоол, шийдвэр, Парламентын танхимуудын гаргасан ажил, үүрэг, бусад үйл ажиллагаатай холбоотой шаардлагыг биелүүлнэ.

Бүлэг 4. Парламентын үйлчилгээний ажилтнууд болон Парламентын номын санч

Хэсэг 1 - Парламентын үйлчилгээний ажилтнууд

20. Нарийн бичиг нарын үндсэн чиг үүрэг

1. Парламентын үйлчилгээний ажилтнуудын удирдлага, зохион байгуулалттай холбоотойгоор Нарийн бичиг нарын ерөнхий чиг үүргийг энэхүү заалтад зааснаар бичгээр тогтооно:
2. Энэхүү чиг үүргийг
 - а. Сенатын Клеркд – Сенатын ерөнхийлөгч, эсхүл
 - б. Төлөөлөгчдийн танхимын Клеркд – Төлөөлөгчдийн танхимын дарга, эсхүл
 - в. Бусад нарийн бичиг нарт – Сенатын Ерөнхийлөгч болон Төлөөлөгчдийн танхимын Дарга нар хамтран.
3. Санал болгосон чиг үүрэгтэй холбоотойгоор зөвхөн Парламентын үйлчилгээний Комиссар нь Сенатын ерөнхийлөгч, Төлөөлөгчдийн танхимын дарга, эсхүл Сенатын ерөнхийлөгч, Төлөөлөгчдийн танхимын дарга нартай зөвшилцсөн нөхцөлд чиг үүргийн тодорхойлно.
4. энэхүү заалт нь Нарийн бичгийн тодорхой хувь хүмүүст холбоотойгоор Нарийн бичигт өөрийн бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд чиг үүрэг олгохгүй.
5. энэ хэсэгт заасан чиг үүрэг нь:

а.14 өдрийн дотор *Gazette* төрийн мэдээлэлд хэвлэгдсэн байна.

б.Чиг үүрэг тодорхойлогдсон дараа, боломж гарангуут Холбогдох Танхимд танилцуулагдсан байна.

6. энэ заалтад холбогдох танхим нь:

а.Чиг үүргийг Сенатын Клеркд өгсөн тохиолдолд – Сенат, эсхүл

б.Чиг үүргийг Төлөөлөгчдийн танхимын Клеркд өгсөн тохиолдолд – Төлөөлөгчдийн танхим

Хэсэг 3 – Парламентын номын санч

38А. Парламентын номын санч

1.Энэхүү заалтаар Парламентын Номын санчийн албыг байгуулна */An Office of Parliamentary Librarian/*

2.Парламентын номын санч болон Парламентын номын санчид туслах хамтарсан Департаментыг Парламентын номын сан гэж болно.

38Б. Парламентын номын санчийн ажил, үүрэг:

1.Парламентын номын санч нь дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

а.Сенатч болон Төлөөлөгчдийн танхимын гишүүдэд парламент болон тэдгээрийн төлөөлдөг ажил үүргийг гүйцэтгэхэд нь чанартай мэдээ, мэдээллээр хангах, дүн шинжилгээ болон зөвлөгөөгөөр хангана.

б.Парламентын номын санч нь Хамтарсан Департаментын хүрээнд а.Заалтад заасан үүрэгтэй холбогдох бусад үүргийг гүйцэтгэхэд Даргалагч /тэргүүлэгч/-ийн зөвшөөрснөөр хамтарсан департаментын нарийн бичгээс бичгээр гаргана.

2.Парламентын номын санч нь 1а-д заасан үүргээ гүйцэтгэхдээ:

а.Цаг тухайд, шударга болон найдвартай хийж гүйцэтгэнэ

б.эрдэм мэдлэг, бүрэн бүтэн байдлыг хадгална.

в.Сенатор, Төлөөлөгчдийн танхимын гишүүд, парламентын хороод болон Сенатор, парламентын хороодын гишүүдийг төлөөлж буй бүхэнд эрх тэгш үйлчлэх зарчмыг баримтална.

г.Парламентын Хамтын нөхөрлөлийн гүйцэтгэх засаглалаас хараат бус байдлыг тооцно.

38В. Парламентын номын санчийн томилгоо

1.Парламентын номын санчийг Даргалагч 5 жилийн хугацаагаар томилно.

2.Даргалагч нь Хамтарсан Департаментын Нарийн бичгээс орон тооны асуудлаар тайлан аваагүй нөхцөлд томилгоо хийх эрхгүй.

3.Даргалагч дараах шаардлага хангаагүй этгээдийн Парламентын номын санчаар томилох эрх эдлэхгүй:

а. Дараах шаардлагын нэг эсхүл хоёуланг хангаж буй этгээд:

i.номын сан эсхүл мэдээллийн удирдлагын мэргэжлийн ур чадвар эзэмшсэн.

ii.номын сан эсхүл мэдээллийн удирдлагын хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн холбооны гишүүн.

б. Даргалагч нь этгээдийн мэргэжил нь өөр холбогдох салбарын, ажлын дадлага, туршлага, болон бусад ур чадвар нь Парламентын номын санчийн албан үүргийг гүйцэтгэхэд хангалттай гэж үзсэн нөхцөлд.

4. Томилгоо нь томилгоотой холбоотой алдаа дутагдалтай холбоогүй байна.

38 Г. Парламентын номын санчийн томилгоог хүчингүй болгох

1.Даргалагч нь бичгээр мэдсэнээр Парламентын номын санчийн томилгоог аль ч үед хүчингүй болгох эрхтэй.

2.Даргалагч нь Комиссараас томилгоог хүчингүйд тооцох тухай бичгээр хүлээн аваагүй нөхцөлд томилгоог хүчингүй болгох эрхгүй.

38 Д. Цалин хөлс болон томилгооны бусад нөхцөлүүд

1.Парламентын номын санчийг ажиллуулах цалин хөлс болон бусад нөхцөлүүд нь Даргалагчийн тогтоосноор байна.

2.1-д заасныг тогтоохдоо Цалин хөлсний шүүн таслах комиссоос зөвлөмж авч харгалзан үзнэ.

3. Тогтоол тус бүр:

а. 14 өдрийн дотор *Gazette* төрийн мэдээлэлд хэвлэгдсэн байна.

б. Боломж гарангуут Сенат болон Төлөөлөгчдийн танхимд танилцуулна.

38 Е. Парламентын номын санчийн үүрэг гүйцэтгэгч

1. Даргалагч Парламентын номын санчийн албанд үүрэг гүйцэтгэх этгээдийг томилох эрхтэй.
 - а. Албанд орон тоо байгаа нөхцөлд, албанд өмнө нь томилгоо хийгдсэн эсэхээс үл хамааран
 - б. Парламентын номын санчийг үүрэгт ажлаасаа чөлөөтэй, Австралиас гадна эсхүл өөр ямарваа нэгэн шалтгаанаар үүрэг ажлаа гүйцэтгэх боломжгүй аль нэг үед, эсхүл бүхий л хугацаанд
2. Гэвч, Даргалагч нь 38В-д заасан шаардлагыг хангаагүй нөхцөлд томилох эрхгүй байна:
3. Энэхүү заалтаар үүрэг гүйцэтгэх этгээдийн үйлдэл эсхүл тус этгээдэд хамаарах үйлдэл нь дараах шалтгаанаар хүчин төгөлдөр бус байна:
 - а. Томилох нөхцөл бүрдээгүй, эсхүл
 - б. Томилгоотой холбогдолтой алдаа дутагдал илэрсэн
 - в. Томилгоо хүчингүй болсон,
 - г. Үүрэг гүйцэтгэх нөхцөл бүрдээгүй эсхүл цуцлагдсан.

38 Ё. Парламентын номын санчийн нөөц

1. Хамтарсан Департаментын Нарийн бичиг нь дэд хэсгийн 2-т заасан нөхцөлүүдийг хангасан жилийн гэрээнд заасны дагуу Парламентын номын санчийг нөөцөөр хангана.
2. Тус гэрээ нь:
 - а. Хамтарсан Департаментын Нарийн бичиг болон Парламентын номын санчийн хооронд байгуулсан байх, ба
 - б. Гэрээний агуулга дээр Номын сангийн хорооноос зөвлөмж авсны дараагаар Даргалагчийн зөвшөөрсөн бичгээр авсан байх
 - в. Даргалагч нь 2 дахь дэд хэсэгт заасан зорилгоор гэрээг Нарийн бичиг болон Парламентын номын санч хоёрыг гэрээ байгуулсны өмнө эсхүл хойно зөвшөөрч болно.

38 Ж. Номын сангийн хороонд тайлагнах

1. Парламентын номын санч нь Номын сангийн Хорооны хүсэлтийн дагуу Парламентын номын сангийн үйл ажиллагааны тайланг гаргаж өгнө.
2. Тэгэхдээ, Парламентын номын санч тус тайланг Хороонд санхүүгийн жилд нэгээс доошгүй удаа өгнө.

38 З. Зохиогчийн эрх

- Зохиогчийн эрхийн тухай хуулийн 1968, 48 А болон 104 А заалтын зорилгоор:
- а. Хамтарсан Департаментын Парламентын Номын санчаар удирдуулсан болон номын сангийн үйлчилгээ үзүүлдэг хэсэг нь Парламентын гишүүдэд номын сангийн үйлчилгээ үзүүлэх үндсэн зорилго бүхий номын сан байна.
 - б. Парламентын номын санч нь номын санг хариуцах албан тушаал байна.
 - в. Парламентын номын санчийн нэрийн өмнөөс номын сангийн үйлчилгээ үзүүлэх, үүрэг гүйцэтгэх бүрэн эрхийг Парламентын номын санчаас итгэмжлэн авсан этгээд нь тухайн номын сангийн итгэмжлэгдсэн ажилтнууд байна.

39. Парламентын үйлчилгээний Комиссар

Парламентын үйлчилгээ Комиссартай байна.

40. Комиссарын ажил, үүрэг

1. Комиссарын ажил, үүрэгт дараах үүрэг багтана:
 - а. Парламентын үйлчилгээний удирдлагын бодлого болон ажлын суудлаар Даргалагчид зөвлөмж өгөх.
 - б. Даргалагчийн хүсэлтийн дагуу хүсэлтэд заасан Парламентын үйлчилгээгээр тайлан гаргах болон гүнзгийрүүлэн лавлах.
2. 1б-д заасан Комиссарын тайлан нь зөвлөмж агуулсан байж болно.
3. Комиссар нь өөрийн ажил үүргээ гүйцэтгэхдээ Хамтын Нөхөрлөлийн гүйцэтгэх засаглалын удирдлага дор орохгүй юм.

42. Жилийн тайлан

1. Санхүүгийн жилийн төгсгөл бүрд, Комиссар нь өмнөх жилийн үйл ажиллагааны тайлангаа Даргалагч нарт тайлагнаж Парламентад танилцуулна.
2. Тайланг Парламентын нэрийн өмнөөс Санхүү болон Аудитын Хамтарсан хорооноос баталсан удирдамжийн дагуу бэлтгэнэ.

Хэсэг 2—Комиссарын томилгоо, нөхцөл г.м.

43. Комиссарын томилгоо

- 1.Комиссарыг Даргалагч нар нь томилгооны журмын дагуу 5 жилийн хугацаагаар томилно.
- 2.Этгээд нь Комиссарын алба болон Австралийн нийтийн албаны Комиссарын албан тушаалыг нэгэн зэрэг хашиж болно.

44.Комиссарыг томилох ерөнхий нөхцөл

1.4 дэд хэсэгт заасныг харгалзан, Комиссарыг томилох ерөнхий нөхцөлийг Даргалагч нарыг бичгээр тодорхойлсны дагуу тогтооно.

2.Тогтоол түс бүрд Даргалагч нар нь Цалин хөлсний шүүн таслах комиссоос зөвлөмж авч, харгалзан үзнэ.

3.Тогтоол тус бүр нь:

а.14 өдрийн дотор *Gazette* төрийн мэдээлэлд хэвлэгдсэн байна.

б.Тогтоолыг эцэслэсэн даруй Парламентын танхимуудад танилцуулна.

4.Этгээд нь Комиссарын алба болон Австралийн нийтийн албаны Комиссарын албан тушаалыг нэгэн зэрэг хашиж байгаа тохиолдолд Комиссарын албанаас цалин урамшуулал авахгүй.

Хэсэг 2—Парламентын төсвийн ажилтан

Дэд хэсэг А—Байгуулалт, чиг үүрэг гм.

64А. Парламентын төсвийн албаны Департамент

1.Энэхүү дэд хэсэгт заасны дагуу Парламентын Департамент болох Парламентын төсвийн албаны Департаментыг байгуулна.

Тайлбар: Энэхүү хуульд Парламентын төсвийн албаны Департаментыг Парламентын төсвийн алба гэнэ.

2.Парламентын төсвийн алба нь Парламентын төсвийн ажилтан болон Парламентын төсвийн ажилтанд тусалж буй Парламентын үйлчилгээний ажилтнуудаас бүрдэнэ.

64В. Парламентын төсвийн албаны зорилт

Парламентын төсвийн албаны гол зорилго нь энэхүү хэсэгт заасны дагуу санхүүгийн үйл ажиллагааны үе шат, санхүүгийн бодлого болон хуулийн төслийн эдийн засгийн тооцоонд хараат бус, улс төрийн нөлөөллөөс ангид дүн шинжилгээ хийж Парламентад мэдээллэх үүрэгтэй.

64С. Парламентын төсвийн ажилтан

Парламентын төсвийн ажилтны албыг энэхүү заалтаар байгуулна.

Тайлбар: Парламентын төслийн ажилтан нь Парламентын төсвийн албаны Нарийн бичгийн дарга байна.

64Д. Нэгдсэн төсвийн орлогын сангийн зарцуулалт

Нэгдсэн төсвийн орлогын санг нь Парламентын төсвийн ажилтан болон Парламентын төсвийн албаны хэрэгцээнд 2011 оны 7 дугаар сарын 1-нээс төсөвлөх бөгөөд, мөнгөн дүн нь 6 сая доллароос хэтрэхгүй байна.

64Е. Парламентын төсвийн ажилтны үүрэг

1. Парламентын төсвийн ажилтан нь дараах үүрэгтэй байна:

а. нийтийн сонгуулийн үеийн түр засгийн газрын хугацаанаас бусад тохиолдолд, 64Н-д заасны дагуу Сенатор эсхүл Төлөөлөгчдийн танхимын гишүүдийн хүсэлтээр бодлогын тооцоо судалгааг бэлтгэнэ.

б. нийтийн сонгуулийн үеийн түр засгийн газрын хугацааны үед 64J-д заасны дагуу Парламентын намын эрх бүхий гишүүд эсхүл бие даагч гишүүдийн хүсэлтээр бодлогын тооцоо судалгааг бэлтгэнэ;

в. бодлогын тооцоо судалгаанаас бусад Сенатор болон Төлөөлөгчдийн танхимын гишүүдийн төсөвтэй холбоотой асуудлаар хариулт бэлтгэх.

г. Парламентын хороодын хүсэлтээр тус Парламентын асуулгад материал бэлтгэх;

д.нийтийн сонгуулийн дараа, 64 МА-д заасны дагуу тодорхой Парламентын намын сонгуулийн амлалтын талаар мэдээллэх;

е. өөрийн санаачилгаар, энэхүү заалтын а, г хэсэгт заасан хүсэлтийг урьтаж, төсөв болон санхүүгийн бодлогын асуудлаар судалгаа, дүн шинжилгээ явуулах.

2. Парламентын төсвийн ажилтны үүрэгт нь дараах заалтууд хамаарахгүй. Үүнд:

а.эдийн засгийн урьдчилсан тооцоо бэлтгэх; эсхүл

б.төсвийн тооцоо бэлтгэх; (засгийн газар, агентлаг эсхүл хөтөлбөрийн хүрээнд)

3.1-д заасан үүргээ гүйцэтгэхдээ, Парламентын төсвийн ажилтан нь 5, 6, 7 болон Төсвийн шударга байдлын тухай хууль 1998-д заасан хамгийн сүүлийн хамаарал бүхий тайлан дахь эдийн засгийн

урьдчилсан тооцоо, үзүүлэлтүүдийг ашиглана.

4. Парламентын төсвийн ажилтан нь 1 дэд хэсэгт заасан ажил үүргээ зөвхөн 64Б-д дурдсан Парламентын Төсвийн албаны зорилгоор гүйцэтгэнэ.

64F. Хамтын нөхөрлөлийн байгууллагуудаас мэдээлэл авах зарчим

1. Парламентын төсвийн ажилтан нь Хамтын нөхөрлөлийн байгууллагын Дарга, эсхүл Даргаас эрх олгогдсон этгээд болон Парламентын төсвийн албаны дарга нар тухайн албанаас Парламентын төсвийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээлэл авах асуудлаар бичгээр тохиролцож болно.

2.1 дэд хэсгийг хязгаарлалгүйгээр, тус зүйлд заасан тохиролцоо нь ил болгосон мэдээлэл, тохиролцсоны дагуу олгосон материалыг нууцалж болно.

3. Парламентын төсвийн ажилтан нь энэ зүйлийн 1 дэд хэсэгт заасан тохиролцоо нь олон нийтэд хүртээмжтэй болгохыг хариуцна.

4. Энэ зүйлийн 1 дэд хэсэгт заасан тохиролцоо нь хууль эрх зүйн хэрэгсэл биш байна.

2.3. Бүгд Найрамдах Солонгос Улс Үндэсний Ассамблейн судалгааны алба³⁰⁰

Тус албыг 2006 оны 12 дугаар сарын 26-нд Үндэсний ассамблейн судалгааны тухай хууль батлагдаж, 2007 онд Судалгааны алба байгуулагджээ. 2010 онд тус албыг судалгааны 3 офис, удирдлагын 1 офис, 12 хэлтэс, 101 орон тоотойгоор өөрчлөн байгуулсан байна.

Парламентын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд туслах зорилгоор хууль тогтоох болон бодлогын үйл ажиллагааны талаар судалгаа, шинжилгээ хийх, холбогдох мэдээлэл хайх, боловсруулах үүрэгтэй.

Судалгааны алба нь гишүүд, хороодоос ирүүлсэн хүсэлтийн дагуу судалгаа, шинжилгээ хийнэ.

Үндэсний Ассамблейн Судалгааны албаны үйл ажиллагааны журмыг Үндэсний Ассамблейн Судалгааны Албаны тухай хууль болон Үндэсний Хурлын хуулийн 22-3 дугаар хэсэгт зааснаар зохицуулдаг.

Үндэсний Ассамблейн Судалгааны албаны гол үйлчилгээ:


- Хороод болон парламентын гишүүдийн захиалгаар судалгаа, шинжилгээний ажил гүйцэтгэх;
- Хууль тогтоох болон бодлогын асуудлаар судалгаа, шинжилгээ хийж, холбогдох мэдээллээр хангах;
- Хууль тогтоох болон бодлогын асуудлаар мэдээлэл цуглуулах, боловсруулах, хүргэх;
- Гишүүдийн судалгааны хэсгүүдийг мэдээллээр хангах;
- Бусад улсуудын хууль тогтоох үйл ажиллагааны чиг хандлагад шинжилгээ хийж, холбогдох мэдээллээр хангана.

Үндэсний Ассамблейн Судалгааны алба нь гишүүдийн болон хороодын захиалгаар судалгаа, шинжилгээний ажлыг гүйцэтгэхдээ:

- ✓ Гишүүд болон хороодын хэрэгцээнд суурилан цаг хугацаанд нь, захиалагчийн шаардлагыг хангахуйц мэдээллийг бэлтгэж, хамгийн тохиромжтой хэлбэрээр захилагчид хүргэх;

³⁰⁰ БНСУ-ын Үндэсний Ассамблейн Ажлын албадын тухай. УИХ-ын Тамгын Судалгааны эмхэтгэл XIV боть. Уб., 2013 он

- ✓ Чанар сайтай мэдээллээр хангахын тулд үйл ажиллагааны процессийг стандартчилах, бусад экспертүүдтэй хамтран ажиллах, шинжлэх ухааны аргачлалыг ашиглах;
- ✓ Бүтээгдэхүүний үнэн зөв, бодит байдлыг хангахын тулд хяналтын хэвтээ болон босоо тогтолцоог ашиглах;
- ✓ Судалгааны нууцлалыг хангана.



Төлөвлөлт, удирдлагын офис

1. *Ерөнхий хэрэг эрхлэх баг* Боловсон хүчин, санхүү, ерөнхий асуудал, удирдлага, нийгмийн үйлчилгээний асуудлыг хариуцан ажиллана.
2. *Төлөвлөлт, хамтын ажиллагааны баг* Төлөвлөлт, төсөв, олон нийттэй харилцах, сургалт, мэдээллийн удирдлага, судалгааны захиалгын бүртгэлийн асуудлыг хариуцан ажиллана.

Улс төр, захиргааны судалгааны офис

1. *Улс төр, парламентын судалгааны баг* Үндсэн хууль, парламент, улс төрийн нам, сонгууль, улс төрийн сангуудын судалгааг хариуцан ажиллана.
2. *Шүүх, хууль тогтоомжийн судалгааны баг* Шүүх эрх мэдлийн асуудал, авилгатай тэмцэх, хүний эрх, шүүхүүд, эрх зүй, Үндсэн хуулийн шүүх, аудит, хяналт шалгалт, шударга өрсөлдөөний асуудлаарх судалгааг хариуцан ажиллана.

3. *Гадаад хэрэг, үндэсний аюулгүй байдлын баг* Гадаад хэрэг, гадаад худалдаа, үндэстний дахин нэгдэх, үндэсний батлан хамгаалах, ахмадын асуудал болон хүний аюулгүй байдлын асуудлаарх судалгааг хариуцан ажиллана.
4. *Төрийн захиргаа, аюулгүй байдлын баг* Төрийн захиргаа, орон нутгийн өөрийн удирдлага, орон нутгийн санхүү/татвар/, цагдаа, гал түймэртэй тэмцэх, гамшгийн удирдлага, сонирхлын бүлгийн асуудлаарх судалгааг хариуцан ажиллана.

Эдийн засаг, аж үйлдвэрийн судалгааны офис

1. *Төрийн санхүү, эдийн засгийн баг* Төрийн санхүү, төсөв, үндэсний татвар, эдийн засгийн бодлого, төрийн худалдан авалт, статистикийн асуудлаарх судалгааг хариуцан ажиллана.
2. *Санхүү, валютын харилцааны баг* Банк, даатгал, санхүүгийн хөрөнгө оруулалт, санхүүгийн хоршилт, гадаад санхүү, гадаад валютын харилцааны асуудлаарх судалгааг хариуцан ажиллана.
3. *Аж үйлдвэр, байгалийн нөөцийн баг* Аж үйлдвэр, үйлдвэржүүлэх бодлого, жижиг дунд бизнес, хөдөө аж ахуй, ой мод, загас агнуур, хүнс, худалдаа, оюуны өмч, эрчим хүч, байгалийн баялгийн асуудлаарх судалгааг хариуцан ажиллана.
4. *Газар, тээвэр, далайн асуудлын баг* Үндэсний газрын хөгжил, хот төлөвлөлт, газар нутаг, орон сууцжуулалт, барилгажуулалт, усны нөөц, тээвэр, төмөр зам, агаарын тээвэр, далай тэнгисийн асуудлаарх судалгааг хариуцан ажиллана.

Нийгэм, соёлын судалгааны офис

1. *Боловсрол, шинжлэх ухааны баг* Боловсрол, хүний нөөцийн хөгжил, шинжлэх ухаан, технологийн асуудлаарх судалгааг хариуцан ажиллана.
2. *Соёл, мэдээлэл, харилцаа холбооны баг* Соёл, спорт, аялал жуулчлал, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, харилцаа холбооны сүлжээ, мэдээллийн хэрэгсэл, интернет, мэдээллийн аюулгүй байдлын талаарх судалгааг хариуцан ажиллана.
3. *Эрүүл мэнд, гэр бүл, нийгмийн халамж, жендерийн баг* Эрүүл мэндийн үйлчилгээ, эмнэлгийн тусламж, нийгмийн халамж, нийгмийн даатгал, гэр бүл, хүйсийн тэгш байдлын асуудлаарх судалгааг хариуцан ажиллана.
4. *Хүрээлэн байгаа орчин, хөдөлмөрийн асуудлын баг.* Хүрээлэн байгаа орчин, цаг уурын өөрчлөлт, хөдөлмөрийн зах зээл, хөдөлмөр эрхлэлтийн асуудлаарх судалгааг хариуцан ажиллана.

Төлөвлөлт, удирдлагын офис

1. *Ерөнхий хэрэг эрхлэх баг.* Боловсон хүчин, санхүү, ерөнхий асуудал, удирдлага, нийгмийн үйлчилгээний асуудлыг хариуцан ажиллана.
2. *Төлөвлөлт, хамтын ажиллагааны баг.* Төлөвлөлт, төсөв, олон нийттэй харилцах, сургалт, мэдээллийн удирдлага, судалгааны захиалгын бүртгэлийн асуудлыг хариуцан ажиллана.

Улс төр, захиргааны судалгааны офис

1. *Улс төр, парламентын судалгааны баг* Үндсэн хууль, парламент, улс төрийн нам, сонгууль, улс төрийн сангуудын судалгааг хариуцан ажиллана.
2. *Шүүх, хууль тогтоомжийн судалгааны баг* Шүүх эрх мэдлийн асуудал, авилгатай тэмцэх, хүний эрх, шүүхүүд, эрх зүй, Үндсэн хуулийн шүүх, аудит,

хяналт шалгалт, шударга өрсөлдөөний асуудлаарх судалгааг хариуцан ажиллана.

3. *Гадаад хэрэг, үндэсний аюулгүй байдлын баг* Гадаад хэрэг, гадаад худалдаа, үндэстний дахин нэгдэх, үндэсний батлан хамгаалах, ахмадын асуудал болон хүний аюулгүй байдлын асуудлаарх судалгааг хариуцан ажиллана.
4. *Төрийн захиргаа, аюулгүй байдлын баг* Төрийн захиргаа, орон нутгийн өөрийн удирдлага, орон нутгийн санхүү/татвар/, цагдаа, гал түймэртэй тэмцэх, гамшгийн удирдлага, сонирхлын бүлгийн асуудлаарх судалгааг хариуцан ажиллана.

Эдийн засаг, аж үйлдвэрийн судалгааны офис

1. *Төрийн санхүү, эдийн засгийн баг*. Төрийн санхүү, төсөв, үндэсний татвар, эдийн засгийн бодлого, төрийн худалдан авалт, статистикийн асуудлаарх судалгааг хариуцан ажиллана.
2. *Санхүү, валютын харилцааны баг* Банк, даатгал, санхүүгийн хөрөнгө оруулалт, санхүүгийн хоршилт, гадаад санхүү, гадаад валютын харилцааны асуудлаарх судалгааг хариуцан ажиллана.
3. *Аж үйлдвэр, байгалийн нөөцийн баг* Аж үйлдвэр, үйлдвэржүүлэх бодлого, жижиг дунд бизнес, хөдөө аж ахуй, ой мод, загас агнуур, хүнс, худалдаа, оюуны өмч, эрчим хүч, байгалийн баялгийн асуудлаарх судалгааг хариуцан ажиллана.
4. *Газар, тээвэр, далайн асуудлын баг* Үндэсний газрын хөгжил, хот төлөвлөлт, газар нутаг, орон сууцжуулалт, барилгажуулалт, усны нөөц, тээвэр, төмөр зам, агаарын тээвэр, далай тэнгисийн асуудлаарх судалгааг хариуцан ажиллана.

Нийгэм, соёлын судалгааны офис

1. *Боловсрол, шинжлэх ухааны баг* Боловсрол, хүний нөөцийн хөгжил, шинжлэх ухаан, технологийн асуудлаарх судалгааг хариуцан ажиллана.
2. *Соёл, мэдээлэл, харилцаа холбооны баг*. Соёл, спорт, аялал жуулчлал, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, харилцаа холбооны сүлжээ, мэдээллийн хэрэгсэл, интернет, мэдээллийн аюулгүй байдлын талаарх судалгааг хариуцан ажиллана.
3. *Эрүүл мэнд, гэр бүл, нийгмийн халамж, жендерийн баг* Эрүүл мэндийн үйлчилгээ, эмнэлгийн тусламж, нийгмийн халамж, нийгмийн даатгал, гэр бүл, хүйсийн тэгш байдлын асуудлаарх судалгааг хариуцан ажиллана.
4. *Хүрээлэн байгаа орчин, хөдөлмөрийн асуудлын баг* Хүрээлэн байгаа орчин, цаг уурын өөрчлөлт, хөдөлмөрийн зах зээл, хөдөлмөр эрхлэлтийн асуудлаарх судалгааг хариуцан ажиллана.

БНСУ-ын Үндэсний Ассамблейн Судалгааны албаны дарга нь Төрийн албаны тухай хууль /*National Service Act*-иар төрийн жинхэнэ албан хаагч /“*Career*” civil servants/ бөгөөд статусын хувьд дэд сайдтай эн тэнцэхүйц 2 дугаар зэрэг, бусад албан тушаалтнууд 3-4 зэргийн ангилалд хамаарна. Тус хуулиар төрийн албаны нийт 9 зэрэгтэй байна.

Үндэсний Ассамблейн Судалгааны албаны тухай хууль³⁰¹

/National Assembly Research Service Act/

2007.01.24,

№8263

2009.02.03, № 9404 нэмэлт, өөрчлөлт орсон.

1 дүгээр зүйл /Зорилго/

Энэ хуулиар Үндэсний Ассамблейн Судалгааны албаны зохион байгуулалт, чиг үүрэг, шаардлагатай бусад асуудлыг зохицуулна.

2 дугаар зүйл (Статус)

(1) Үндэсний Ассамблейн Судалгааны алба (цаашид "Судалгааны алба" гэх) нь Үндэсний Ассамблейн Спикерийн (цаашид "Судалгааны алба" гэх) хяналтанд байна.

(2) Судалгааны алба нь чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хараат бус байна.

3 дугаар зүйл (Чиг үүрэг)

Судалгааны алба нь хууль тогтоох болон бодлогын асуудлаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

1. Үндэсний Ассамблейн Байнгын хороо (цаашид "Хороо" гэх), Үндэсний Ассамблейн гишүүний хүсэлтээр тэднийг судалгаа, дүн шинжилгээ хийж, мэдээлэл бэлтгэнэ;

2. Хууль тогтоох болон бодлогын асуудалтай холбоотой судалгаа, мэдээллээр хангах;

3. Хууль тогтоох болон бодлогын асуудлаар мэдээлэл цуглуулах, боловсруулах, хүргэх;

4. Гишүүдийн ажлын хэсгүүдийг мэдээллээр хангах;

5. Бусад улсуудын хууль тогтоох үйл ажиллагааны чиг хандлагын талаарх мэдээллээр хангах. шинжилгээ хийх.

4 дүгээр зүйл (Дарга)

(1) Үндэсний Ассамблейн Судалгааны албаны дарга (цаашид "дарга" гэх) нь улс төрийн албаны төрийн албан тушаалтан байх бөгөөд түүний цалин нь дэд сайдынхтай адил байна.

(2) Дарга нь чиг үүргээ хэрэгжүүлэхдээ мэргэшсэн, төвийг сахисан байр суурь баримтлана.

(3) Дарга нь Үндэсний Ассамблейн Спикерийн нэрийн өмнөөс Судалгааны албаны үйл ажиллагаанд ерөнхий хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх бөгөөд албаны ажилтнуудын үйл ажиллагааг удирдаж, хяналт тавина: Үүнд, Үндэсний Ассамблейн Нарийн бичгийн даргын газрын тухай хууль, Төрийн нийтийн албан хаагчийн тухай хууль, Үндэсний төсвийн хууль, Төрийн өмчийн хууль, болон хүний нөөцийн удирдлага, төсөв, нягтлан бодох бүртгэл, төрийн өмчийг захиран зарцуулахтай бусад хууль тогтоомжуудаар зохицуулагдах асуудал хамаарахгүй. Мөн Үндэсний Ассамблейн нарийн бичгийн даргын газар болон Ерөнхий нарийн бичгийн даргын эрх мэдлийн асуудал хамаарахгүй.

4-2 дүгээр зүйл (Рекомендацийн хорооноос Үндэсний Ассамблейн Судалгааны албаны даргад нэр дэвшүүлэх)

(1) Үндэсний Ассамблейн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 3-т заасны дагуу Үндэсний Ассамблейн Спикер нь Үндэсний Ассамблейн Судалгааны албаны даргыг томилохын тулд Рекомендацийн хороотой зөвшилцөн, томилно.

(2) Рекомендацийн хороо нь Үндэсний Ассамблейг Судалгааны албаны даргад Судалгааны албаны чиг үүргийг хэрэгжүүлэх мэргэшсэн, улс төрийн хувьд төвийг сахисан байр суурь бүхий этгээдийг нэр дэвшүүлнэ. Нэр дэвшигч нь Үндэсний Ассамблейн гишүүн байж болохгүй.

(3) Рекомендацийн хорооноос нэр дэвшүүлэх үйл ажиллагааг журмаар зохицуулна.

(Энэ зүйл 2009 оны 02 сарын 03-нд нэмэлт, өөрчлөлт оруулсан)

5 дугаар зүйл /Төрийн албан хаагчийг томилох/

Төрийн албаны 5 дугаар зэрэг болон түүнээс дээш зэрэглэлтэй Судалгааны албаны албан тушаалтныг Спикер томилох буюу ажлаас чөлөөлнө. Бусад төрийн албан хаагчдыг Судалгааны албаны дарга томилж, чөлөөлнө. Спикер томилох, чөлөөлөхтэй холбоотой зарим эрхээ Судалгааны албаны даргад шилжүүлж болно.

6 дугаар зүйл /Зохион байгуулалт/

/1/ Судалгааны албаны удирдах бүрэлдэхүүнд даргын орлогч, ерөнхий захирал болон захирлууд орно. Удирдах бүрэлдэхүүн үүнээс ялгаатай байх бол дүрмээр зохицуулна.

/2/ Судалгааны албаны дарга, ерөнхий захирал нарт туслах үүрэгтэй, даргын шууд удирдлаганд ажиллах орлогч дарга, ерөнхий захирлын орлогч нар байна. Эдгээр хүмүүсийг оролцуулсан удирдлагын хэлтсийг даргын шууд харьяанд байгуулж болох бөгөөд энэ хэлтэс нь Судалгааны албаны бүтцэд орохгүй.

/3/ Судалгааны албаны даргын орлогч, ерөнхий захирал болон захиралууд нь төрийн албаны 1 буюу 2, 2 буюу 3, 3 буюу 4 дүгээр зэрэглэлийн төрийн албан хаагч байх буюу гэрээгээр ажилладаг

³⁰¹ БНСУ-ын Үндэсний Ассамблейн Судалгааны албанаас ирүүлсэн Судалгааны албаны тухай хууль, 2014 он.

төрийн албан хаагч байж болно. Ерөнхий захирлын орлогч нь 2-оос 4 дүгээр зэрэглэлийн төрийн албан хаагч байх буюу гэрээгээр ажилладаг төрийн албан хаагч байж болно. /Хавсралт/-аас БНСУ-ын төрийн албаны ангилал, зэрэглэл/ үзнэ үү.

/4/ Судалгааны албаны даргад зөвлөлгөө өгөх Зөвлөгчдийн алба байгуулж болно.

/5/ Судалгааны албаны ажилтнуудын орон тоо, офис, товчоо, хэлтсүүдийг байгуулах, чиг үүргийг нь тодорхойлох, ерөнхий захирлын орлогч нарын ажлын чиг үүргийг тодорхойлох болон бусад шаардлагатай асуудлыг дүрмээр зохицуулна. Бүтэц, чиг үүргийг журмаар зохицуулна. Судалгааны албаны хэлтсүүдийг байгуулах болон хэлтсүүд, ерөнхий захирлын орлогч нарын ажлын чиг үүргийг тодорхойлох эрхийг Судалгааны албаны даргад шилжүүлж болно.

7 дугаар зүйл /Үндэсний Ассамблейн хороод, гишүүдэд материал хүргүүлэх/

Судалгааны албаны дарга нь чиг үүргийнхээ хүрээнд Үндэсний ассамблейн хороод, гишүүдэд шаардлагатай гэж үзсэн мэдээ материалыг хүргүүлнэ.

8 дугаар зүйл /Байнгын хороонд мэдээ, материал өгөх/

/1/ Судалгааны албаны дарга болон бусад албан тушаалтан Байнгын хороонд тайлангаа танилцуулах ба хорооноос шаардлагатай гэж үзсэн бол холбогдох тайлбарыг хийнэ.

/2/ Судалгааны албаны дарга нь өөрийн чиг үүргийг гүйцэтгэх явцдаа холбогдох захиргааны байгууллагатай холбоотой хууль бус асуудал, эсвэл тэдгээр байгууллагын үйл ажиллагааг сайжруулах арга зам, эсвэл Судалгааны албаны дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулахад шаардлагатай зүйлсийг олж тогтоовол тэдгээр асуудлуудыг Үндэсний Ассамблейн Байнгын хороонд хуулийн дагуу шийдвэрлүүлэхээр илтгэнэ.

9 дүгээр зүйл /Мэдээлэл хүсэх тухай/

Судалгааны албаны дарга нь Спикерээс зөвшөөрөл авч ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай материалуудыг төрийн болон бусад байгууллагуудаас гаргуулан авах тухай хүсэлт гаргаж болно.

10 дугаар зүйл /Бусад зүйл/

Энэ хуульд тусгагдаж, хуулийг хэрэгжүүлэх шаардлагын дагуу дүрмээр нарийвчлан тогтоогдсон асуудлуудыг өөрчлөх шаардлага гарвал Спикер Танхимын Ерөнхий хороотой зөвшилцөн шийдвэрлэнэ.

2.4. Япон Улсын Парламентын номын сан

Парламентын номын сан /National Diet Library/ нь 1948 онд Парламентын дэргэд *Парламентын тухай хуулийн 130 дугаар заалтыг* үндэслэж, Парламентын номын сангийн тухай хуулиар байгуулагдсан, Номын сангийн захирлыг *Парламентын номын сангийн тухай хуулийн 4 дүгээр зүйд заасны дагуу* Парламентын дээд танхимын Ерөнхийлөгч, доод танхимын Спикер нарын хамтын шийдвэрээр томилно. Тус номын сангийн үндсэн үүрэг нь Парламентын гишүүдэд ажил, үүргээ гүйцэтгэхэд нь дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ гүйцэтгэх болон шүүх эрх мэдлийн байгууллага, олон нийтэд үйлчилнэ. Парламентын номын сан нь сан хөмрөг бүрдүүлэх цорын ганц номын сан бөгөөд Японд хэвлэгдэн гарсан бүхий л ном, сонин, сэтгүүлийн зайлшгүй хадгалах хувийг бүрдүүлж, үндэсний соёлын өв болгож хадгална. 2013 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаар Парламентын номын сан нь 890 албан хаагчтай, Судалгаа, хуулийн лавлагааны товчоо нь 190 албан хаагчтай үйл ажиллагаа явуулж байна.

Японы Парламентын судалгааны нэгж нь Парламентын номын сангийн Судалгаа, хуулийн лавлагааны товчоо /*Research, Legislative Reference Bureau*/ байна.

Парламентын номын сангийн тухай хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу Номын сангийн захирал нь өөрийн бүрэн эрхийн хүрээнд Судалгаа, хуулийн лавлагааны товчооны даргыг томилно.

Парламентын номын сангийн судалгааны нэгжээс гадна Парламентын танхимуудын бүтцэд судалгааны нэгж /Зөвлөхүүдийн танхимын Судалгааны Хороо, Төлөөлөгчдийн танхимын Судалгааны Товчоо/-үүд байна. Төлөөлөгчдийн танхим нь

байнгын ба тусгай хороодтой байх ба Зөвлөхүүдийн танхим нь дээрхээс гадна *Парламентын тухай хуулийн 54-2 дугаар зүйлд* заасны дагуу Судалгааны хороодтой байна. *Парламентын тухай хуулийн 43 дугаар зүйлд заасны дагуу* Байнгын хороодын бүтцэд тус бүрийн бүрэн эрхэд хамаарал бүхий асуудлыг боловсруулахад дэмжлэг үзүүлэх мэргэжлийн зөвлөх болон судлаач, шинжээчид ажиллана. Зөвлөхүүдийн танхимын судалгааны хороод нь *Зөвлөхүүдийн танхимын журмын 80-2 дугаар зүйлд* зааснаар тус танхимын сонгуулийн дараа хуралдах эхний чуулганаар байгуулагдана. Тэдгээр нь төрийн удирдлагын асуудлаар иж бүрэн судалгаа, дүн шинжилгээ хийх бөгөөд үүнээс гурван тусгай хороо нь хуулийн төсөл хэлэлцэх эрхгүй байна.

Парламентын номын сангийн Судалгаа, хуулийн лавлагааны товчоо

Судалгаа, хуулийн лавлагааны товчоо /СХЛТ/ гол чиг үүрэг нь парламентын үйл ажиллагааг хэвийн явуулахад парламентын гишүүдэд шаардагдах судалгаа, дүн шинжилгээ болон хэрэгцээт мэдээллээр хангахад оршино.

2010 оны байдлаар Товчоо нь 190 гаруй ажилтантай, үүнээс 110 нь бодлогын шинжээч, 80 гаруй нь мэдээллийн, захиргааны болон туслах ажилтнууд байна.

Бүтэц, зохион байгуулалт

Судалгаа, хуулийн лавлагааны товчоо нь 12 судалгааны алба /research office/ болон 14 хэлтэс /division/-ээс бүрдэнэ. Судалгааны алба болон хэлтсүүдийг ерөнхийд нь судалгаа, төлөвлөлт ба нийтлэг үйлчилгээ, материал хангамж гэсэн хоёр хэсэгт хувааж болно.

Судалгааны алба тус бүр ахлах мэргэжилтэн болон туслах ажилтнуудтай байна. Хэлтэс бүр хэлтсийн дарга болон судлаачидтай байна. Тусгай, нарийн мэргэжлийн салбарт судалгаа хийх шаардлага гарсан тохиолдолд тодорхой мэргэжлийн эрдэмтэн, мэргэжилтнүүдийг түр хугацаагаар ажиллуулж болдог байна.

Салбар хоорондын судалгааны алба:

- Судалгаа төлөвлөлтийн хэлтэс – Ерөнхий асуудал, төлөвлөлт, хэвлэлийн төлөвлөгөө болон хэвлэлийн эхэд засвар хийх;
- Хуулийн лавлагаа болон Мэдээллийн сангийн хэлтэс – Гишүүдээс судалгааны захиалга авах, энгийн судалгаа хийх, судалгааны материал бэлтгэх, Парламентын гишүүдийн уншлагын танхим болон судалгааны өрөөг хариуцах;
- Салбар хоорондын судалгааны ажлын алба, хамтын ажиллагаа;
- Цахим мэдээллийн үйлчилгээний хэлтэс – Парламентын хуралдааны тэмдэглэл, Эзэн хааны парламентын (1889-1947) хуралдааны тэмдэглэлийн өгөгдлийн санг удирдах, СХЛТ-ны веб хуудсыг ажиллуулах.

Парламентын баримт бичиг, хэвлэлийн судалгааны алба:

- Парламентын баримт бичиг, хэвлэлийн мэдээлэлд судалгаа хийх хэлтэс – Япон болон гадаад улс орнууд, олон улсын байгууллагуудын Парламентын үндсэн баримт бичиг, журам болон албан ёсны хэвлэлийг бэлтгэх, ашиглах.

Улс төр болон парламентын судалгааны алба:

- Улс төр болон Парламентын судалгааны хэлтэс - Парламент, засгийн газар, улс төрийн ёс зүй, нам, сонгууль, улс төрийн хандив, улс төрийн тогтолцоо, улс төрийн процесс;
- Үндсэн хуулийн судалгааны хэлтэс - үндсэн хууль.

Төрийн захиргаа, шүүхийн судалгааны алба:

- Төрийн захиргаа, шүүхийн судалгааны хэлтэс – Захиргаа, нийтийн албаны албан хаагч, орон нутгийн захиргаа, гал унтраах, цагдаа, иргэний эрх зүй, эрүүгийн эрх зүй, хүний эрх, шүүх;

Гадаад харилцаа болон дотоодыг хамгаалах судалгааны алба:

- Гадаад харилцаа болон дотоодыг хамгаалах судалгааны хэлтэс – Дипломат ёс, олон улсын улс төр, олон улсын эрх зүй, батлан хамгаалах, аюулгүй байдал, НҮБ, олон улсын байгууллагууд;

Санхүүгийн судалгааны алба:

- Санхүүгийн хэлтэс – Санхүү, татвар, олон улсын санхүү, эдийн засгийн үзүүлэлтүүд, богино хугацааны эдийн засгийн удирдлага, үнэ, тооцооны систем;

Эдийн засаг болон худалдаа, үйлдвэрлэлийн судалгааны алба:

- Эдийн засаг болон худалдаа, үйлдвэрлэлийн хэлтэс – Эдийн засгийн удирдлага, үйлдвэрлэл, худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа, байгалийн баялаг болон эрчим хүч, шударга худалдаа, хэрэглэгчдийн асуудал;

Хөдөө аж ахуй, ойн аж ахуй болон байгаль орчны судалгааны алба:

- Хөдөө аж ахуй, ойн аж ахуй болон байгаль орчны хэлтэс - Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, далайн гаралтай бүтээгдэхүүн, хөдөө орон нутаг, хүнс, дэлхийн байгаль орчны хамгаалал, бохирдол, байгаль хамгаалал, байгаль орчны асуудал;

Газар ашиглалт /Land development/ болон харилцаа холбооны судалгааны алба:

- Газар ашиглалт болон харилцаа холбооны хэлтэс - Нийгмийн харилцааны баялаг /нийгмийн капитал/, барилга угсралт, байгалийн гамшиг, тээвэр, аялал жуулчлал, цаг агаарын мэдээ, эргийн хилийн хамгаалалт, мэдээлэл харилцаа, шуудангийн удирдлага;

Боловсрол, соёл, шинжлэх ухаан болон технологийн судалгааны алба:

1. Боловсрол, соёл, шинжлэх ухаан болон технологийн хэлтэс – Боловсрол, спорт, урлаг болон соёл, зохиогчийн эрх, шашин;
2. Шинжлэх ухаан болон технологийн судалгааны төв – шинжлэх ухаан болон технологи;

Нийгмийн хамгаалал болон хөдөлмөрийн судалгааны алба:

- Нийгмийн хамгаалал болон судалгааны хэлтэс – Нийгмийн аюулгүй байдал, нийгмийн хамгаалал, нийгмийн эрүүл мэнд, эрүүл мэндийн үйлчилгээ, хөдөлмөрийн нөхцөл, ажил эрхлэлт, хүн амын асуудал;

Гадаад орны хууль, эрх зүйн мэдээллийн судалгааны алба:

- Гадаад орны хууль, эрх зүйн мэдээллийн хэлтэс – Гадаад орны хууль эрх зүйн болон бодлогын чиг хандлага, Гадаад хууль, эрх зүйн эмхэтгэлийг хэвлэн гаргах;

- Номын сан - ном, сэтгүүл, сонин болон парламентын баримт бичгээр үйлчлэх номын сан.

Судалгаа, хуулийн лавлагааны товчооны судалгааны ажил

Судалгааны товчооны судлаачид нь Парламентын гишүүд, Парламентын хоёр танхимын хороод болон улс төрийн намуудын захиалгат судалгаа болон судалгааны товчооны өөрийн санаачилгаар явуулах гэсэн хоёр төрлийн судалгаа болон шинжилгээний үйлчилгээ үзүүлдэг байна. Судалгааны товчооны өөрийн санаачилгаар явуулах судалгааг “Урьдчилсан судалгаа” /*Anticipatory Research*/ гэнэ.

2011 онд Товчоо нь нийт 40485 захиалгат лавлагаа, судалгаа хийж гүйцэтгэснээс 811 нь лекц болон уулзалт, 6509 нь судалгааны тайлан болон 32189 лавлагаа байсан байна.

Урьдчилсан судалгаа нь судалгааны ажлын нэгэн томоохон хэсгийг бүрдүүлэх ба уг судалгааны гол зорилго нь захиалгат судалгаанд ашиглагдахуйц судалгааны санг бий болгох, ажилтнуудын чадварыг дээшлүүлэх, судалгааны чадавхыг сайжруулахад оршино. Парламентын гишүүдэд урьдчилсан судалгааны хэвлэгдэн гарсан хувь бүрийг түгээж, Парламентын гишүүд болон олон нийтэд цахим хэлбэрээр веб хуудсанд байрлуулдаг байна.



Парламентын тухай хууль

Бүлэг 5. Хороод ба гишүүнчлэл

43 зүйл. Байнгын хороо тус бүр мэргэжлийн зөвлөх болон судлаачидтай байж болно.

5-2 Бүлэг. Зөвлөхүүдийн танхимын Судалгааны хороод

54-2. Зөвлөхүүдийн танхимын Судалгааны хороод /Research Committee/

Зөвлөхүүдийн танхим нь засгийн газрын эрхлэх асуудлын хүрээн дэх чухал асуудлаар урт хугацааны дэлгэрэнгүй судалгаа явуулах Судалгааны хороотой байж болно. Судалгааны хороо нь Зөвлөхүүдийн танхимын гишүүдийн тал хувийн бүрэн эрх дуусгавар болох хүртэл ажиллана. Судалгааны хорооны судалгааны зүйл болон судалгааны сэдвийг Зөвлөхүүдийн танхим тогтооно.

54-3. Судалгааны хорооны гишүүдийг Танхим томилох бөгөөд Судалгааны хороо хүчин төгөлдөр нөхцөлд хүчинтэй байна. Судалгааны хороодын гишүүнчлэлийг Танхим дахь улс төрийн бүлгүүдийн тоон харьцаанд үндэслэн хуваарилсны дараа Хорооны гишүүд тус хуваарийн дагуу томилогдоно. Судалгааны хорооны даргыг зөвлөхүүдийн танхимын гишүүд өөрийн гишүүд дундаас сонгоно.

17 Бүлэг. Парламентын номын сан, Хууль зүйн товчоо, Гишүүдийн нарийн бичиг болон гишүүдийн ажлын байрны барилга

130 зүйл. Парламентын гишүүдэд судалгаа болон шинжилгээнд туслалцаа үзүүлэх зорилгоор Парламентад бие даасан хуулиар Парламентын номын санг байгуулна.

131 зүйл. Танхим бүр Гишүүдэд хуулийн төсөл боловсруулахад нь дэмжлэг үзүүлэх Хууль зүйн товчоотой байна. /Legislative Bureau/

Хууль зүйн товчоо тус бүр нэг Ерөнхий Төлөөлөгчтэй байх, ажлын алба болон шаардлагатай бусад ажилтнуудтай байна.

Хууль зүйн товчооны Ерөнхий Төлөөлөгчийг Танхимын санал, дүгнэлтийг үндэслэн танхимын дарга томилж, чөлөөлнө. Парламентын чөлөөт цагаар танхимын дарга Ерөнхийлөн төлөөлөгчийн ажлаас халагдах өргөдлийг хүлээн авч болно.

Хууль зүйн товчооны Ерөнхий Комиссар Хууль зүйн товчооны үйл ажиллагааг танхимын даргын удирдлага дор гүйцэтгэн явуулна.

Хууль зүйн товчооны нарийн бичиг болон бусад ажилтнуудыг Ерөнхий Комиссар танхимын дарга болон Дэг, захиргааны хорооны саналыг үндэслэн томилж, чөлөөлнө.

Хууль зүйн товчооны нарийн бичгүүд Ерөнхий Комиссарын удирдлага дор ажиллана.

Парламентын номын сангийн тухай хууль

Бүлэг 1. Хуулийн зорилт

1 дүгээр зүйл. Энэхүү хуулиар Парламентын номын санг байгуулах ба уг хуулийг Парламентын номын сангийн тухай хууль гэнэ.

2 дугаар зүйл. Парламентын номын сан нь Парламентын гишүүдэд өдөр тутмын үйл ажиллагаа явуулахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор ном болон бусад холбогдох хэвлэлийг цуглуулах болон төрийн гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллага ба нийт Японы ард иргэдэд номын сангийн үйлчилгээнд үзүүлэх зорилготой юм.

3 дугаар зүйл. Парламентын номын сан нь төв номын сан болон энэхүү хуульд заасан номын сангийн салбарууд болон цаашид байгуулагдах номын сангуудаас бүрдэнэ.

Бүлэг 2. Номын сангийн захирал

4 дүгээр зүйл. Нэгэн зэрэг Парламентын номын санд зөвхөн нэг Номын сангийн захирал /Chief Librarian/ байна. Номын сангийн захирлыг Танхимуудын санал, дүгнэлт болон танхимуудын Дэг, захиргааны хороотой /Rule and Administration committee/ зөвшилцсөний үндсэн дээр Төлөөлөгчдийн танхимын Спикер болон Зөвлөхүүдийн танхимын Ерөнхийлөгч томилно.

1. Номын сангийн захирал нь ажил үүргээ хангалттай биелүүлж байгаа нөхцөлд ажлаа үргэлжлүүлнэ. Тэрээр улс төрийн үйл ажиллагаанаас ангид байх ба түүнийг улс төрийн шалтгаанаар чөлөөлөхийг хориглоно. Номын сангийн захирлыг Төлөөлөгчдийн танхимын Спикер болон Зөвлөхүүдийн танхимын Ерөнхийлөгчийн хамтын шийдвэрээр чөлөөлнө.

5 дугаар зүйл. Номын сангийн захирал Номын сангийн захиргааг удирдах, албан хаагчдыг ажил үүргээ гүйцэтгэхэд нь чиг, удирдлагаар хангана.

2. Номын сангийн захирал нь номын сангийн үйл ажиллагааг удирдан, зохион байгуулах дүрэм журмыг урьдчилан, эсхүл хоёр танхимын Дэг, захиргааны хороодын зөвшөөрсний дараа гаргана.

6 дугаар зүйл. Номын сангийн захирал нь санхүүгийн жил бүрийн эхэнд Төлөөлөгчдийн танхимын Спикер болон Зөвлөхүүдийн танхимын Ерөнхийлөгчид Номын сангийн өмнөх жилийн үйл ажиллагаа болон санхүүгийн асуудлаар тайлагнана.

7 дугаар зүйл. Номын сангийн захирал нь Японд өмнөх жил, эсхүл заасан хугацаанд хэвлэгдэн гарсан хэвлэлийг жилд нэгээс доошгүй удаа иргэдэд ашиглахад тохиромжтой хэлбэрээр каталог, эсхүл индексжүүлэх ажлыг зохион байгуулна.

8 дугаар зүйл. Номын сангийн захирал нь Японы хууль тогтоомжийн индексийг хэвлэхэд тохиромжтой хэлбэрээр бэлтгэх ажлыг зохион байгуулах эрхтэй.

Бүлэг 3. Номын сангийн захирлын туслах болон бусад албан хаагчид болон ажилчид

9 дүгээр зүйл. Нэгэн зэрэг Парламентын номын санд зөвхөн нэг Номын сангийн захирлын туслах /Assistant Chief Librarian/ байна. Номын сангийн захирлын туслахыг Зөвлөхүүдийн танхимын Ерөнхийлөгч болон Төлөөлөгчдийн танхимын Спикерийн зөвшөөрснөөр Номын сангийн захирал томилно. Номын сангийн захирлын туслах нь Номын сангийн захиралд Номын санг удирдахад дэмжлэг үзүүлнэ. Номын сангийн захирлыг түр эзгүйд Номын сангийн захирлын туслах ажил үүргийг нь орон гүйцэтгэнэ.

10 дугаар зүйл. Парламентын номын сангийн бусад бүх албан хаагч болон ажилтнуудыг Номын сангийн захирал гагцхүү өөрсдийн ажлын байрны зохих шаардлагыг хангаж байгаа эсэх үндэслэлээр Парламентын тамгын газрын албан хаагчдын тухай хуульд заасны дагуу томилно. Эдгээр албан хаагчдын ажил үүргийн хуваарийг Номын сангийн захирал тогтооно.

2. Номын сангийн албан хаагч нь төрийн гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагын салбар номын сангаас бусад тохиолдолд нэг зэрэг Парламентын гишүүн, засгийн газар дахь гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагуудад өөр албан тушаал эрхлэхийг хориглоно.

Бүлэг 4. Парламентын номын сангийн Дэг, захиргааны хороо болон зохицуулах хороо

11 дүгээр зүйл. Хоёр танхимын Дэг, захиргааны хороод нь зургаан сард нэг удаагаас доошгүй уулзаж, Номын сангийн үйл ажиллагааны талаарх Номын сангийн захирлын тайлан, Номын сангийн үйл ажиллагаатай холбогдон гарсан дүрэм журам, Номын сангийн төсөв болон холбогдох бусад асуудлыг хэлэлцэнэ.

2. Танхимуудын Дэг, захиргааны хороодын дарга нар нь хэлэлцсэн асуудлын үр дүнг холбогдох танхимуудад мэдээлнэ.

12 дугаар зүйл. Энэхүү заалтаар Парламентын номын сангийн зохицуулах хороог байгуулна. Зохицуулах хороо дараах дөрвөн гишүүдээс бүрдэнэ:

Хоёр танхимын Дэг, захиргааны хороодын дарга, Ерөнхий шүүгчийн томилсон Дээд шүүхийн шүүгч, Ерөнхий сайдын томилсон төрийн сайд тус тус байна. Гишүүд өөрсдийн дундаас Даргыг сонгоно.

2. Хорооны дарга болон гишүүд нэмэлт цалин хөлс авахгүй.
3. Хорооны хуралд Номын сангийн захирал оролцож болох ба санал өгөх эрх эдлэхгүй.

13 дугаар зүйл. Зохицуулах хороо нь танхим тус бүрийн Дэг, захиргааны хороонд Номын сангийн Парламент болон гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагад үйлчлэх үйл ажиллагааг сайжруулах талаар зөвлөмж гаргана.

Бүлэг 5. Номын сангийн хэлтсүүд

14 дүгээр зүйл. Номын сангийн захирал нь номын санг зохих хэлтэс, алба болон бусад шаардлагатай нэгжээр зохион байгуулна.

Бүлэг 6. Судалгаа, хуулийн лавлагааны товчоо

15 дугаар зүйл. Номын сангийн захирал Парламентын номын сан дотор Судалгаа, хуулийн лавлагааны товчоо нэртэй хэлтэс /department/ байгуулна. Хэлтэс дараах үйл ажиллагаа явуулна:

1. Захиалгын дагуу, хэлэлцэхээр хүлээгдэж буй хууль, Засгийн газраас өргөн барьсан хуулийн төсөл, шинжлэх, үнэлэх болон дүгнэхэд Парламентын бүхий л хороодод туслалцаа болон зөвлөмж гаргах, эсхүл хороодод арга хэмжээ авах үндэслэл гаргахад дэмжлэг үзүүлнэ.
2. Захиалгын дагуу, эсхүл өөрийн санаачилгаар захиалгыг урьдаж холбогдох хуулиудтай хамааралтай, холбогдолтой материал, мэдээллийг цуглуулж, ангилж, шинжлэн орчуулга, индекс, эмхэтгэл, бюллетень хэлбэрээр, мэдээллийг шилж сонгох болон танилцуулахдаа нам, улс төрийн нөлөөллөөс ангид байна.
3. Парламент, түүний хороод болон гишүүдэд хуулийн төсөл бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх, ингэхдээ зөвхөн хороо, эсхүл парламентын гишүүний захиалгаар хийх бөгөөд Судалгаа, хуулийн лавлагааны товчооны албан хаагчид хууль санаачлах болон батлуулах асуудалд оролцох эрхгүй.
4. Парламент болон хороодын үйл ажиллагаанд саад учруулахгүй нөхцөлд гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагуудад мэдээлэл бэлтгэх.

16 дугаар зүйл. Номын сангийн захирал Товчооны дарга болон дэд дарга, шаардлагатай бусад албан хаагчдыг намын харьяаллыг харгалзахгүйгээр зөвхөн ажлын байрны шаардлага болон Парламентын тамгын газрын боловсон хүчний тухай хуульд заасны дагуу, нийцүүлэн, томилно.

2. Номын сангийн захирал нь Товчооны ахлах мэргэжилтнүүдийг Парламентын хэд хэдэн байнгын хороодын эрхлэх асуудалд холбоотой чиглэлээр мэргэшсэн этгээдийг томилох эрхтэй байна.

Бүлэг 7. Гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагуудад үзүүлэх үйлчилгээ

17 дугаар зүйл. Номын сангийн захирал гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагуудад номын сангийн дараах үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулна. Үүнд:

1. Холбогдох байгууллагуудын төлөөлж буй Зохицуулах хорооны гишүүдийн саналыг үндэслэн гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагуудын номын санчийг томилох. Харин, нийтийн албаны тухай хуульд хамаарал бүхий иргэдийг нийтийн албаны тухай хуульд зааснаар болон холбогдох байгууллагын даргын зөвшөөрлөөр томилно.
2. Номын санд ашиглагдах, үйл ажиллагаатай холбоотой систем болон аргачлалыг тогтоох.
3. Төрийн гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагуудын номын санчдаас жил тутмын болон тусгай тайлан гаргуулж авах.

18 дугаар зүйл. Төрийн гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагуудын номын сангийн төсөв нь тухайн байгууллагын төсөвт “номын сан” гэсэн тодорхой зүйлд багтаж, тус зүйлийг Номын сангийн захирал болон тухайн байгууллагыг төлөөлж буй Зохицуулах хорооны гишүүний зөвшөөрөлгүй тухайн байгууллагын төсвийн зүйл хооронд шилжүүлэх, багасгах зэргээр захиран зарцуулахыг хориглоно.

19 дүгээр зүйл. Төрийн гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагуудын номын санч нь тухайн байгууллагад номын сангийн хэвийн үйл ажиллагааг хангах хариуцлага хүлээнэ. Өөрийн эрх мэдлийн хүрээнд холбогдох албан хаагчдыг Парламентын Тамгын газрын албан хаагчийн тухай хууль, эсхүл Нийтийн албаны тухай хууль, эсхүл Шүүхийн тухай хуульд заасны дагуу томилж, чөлөөлнө. Номын сангийн захирлын батлах журмын дагуу номын санд авах ном, материалыг худалдан авах, эсхүл бусад хэлбэрээр авахыг холбогдох байгууллагын удирдлага болон Номын сангийн захиралд зөвлөмж өгөх, эсхүл дээрх худалдан авалт болон бусад худалдан авалтыг шууд гүйцэтгэх эрх эдэлнэ.

20 дугаар зүйл. Энэ бүлэгт заасны дагуу Номын сангийн захирлыг анх томилсноос зургаан сараас доошгүй хугацаанд төрийн гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагуудын номын сангууд нь Парламентын номын сангийн салбар болно. Өөрийн номын сангүй төрийн байгууллага нь нэгээс доошгүй жилийн хугацаанд салбар номын сан байгуулна.

Бүлэг 12. Мөнгө бэлгэнд хүлээн авах, зарцуулалт, төсөв

Номын сангийн захирал нь Парламентын номын сан, номын сангийн үйлчилгээ болон цуглуулгатай холбоотойгоор шууд захиран зарцуулахаар мөнгө бэлгэнд хүлээн авч болно. Дээрх бүх тохиолдлуудад Дэг, захиргааны хорооноос урьдчилан зөвшөөрөл авна.

27 дугаар зүйл. Парламентын номын сангийн төсвийг Номын сангийн захирлын удирдлага дор, түүний томилсон төсвийг шууд зарцуулах эрх бүхий албан хаагч захиран зарцуулна.

28 дугаар зүйл. Парламентын номын сангийн жилийн төсвийг Номын сангийн захирал хоёр танхимын Дэг, захиргааны хороонд өргөн мэдүүлнэ. Хороод төсвийг хянан зөвлөмжтэй, эсхүл зөвлөмжгүй Зөвлөхүүдийн танхимын Ерөнхийлөгч болон Төлөөлөгчдийн танхимын Спикер өргөн барина.

2.5.Бүгд Найрамдах Македон улсын Парламентын институт

Парламентын Институт (Parliamentary Institute) нь Македоны Ассамблейн үйл ажиллагааг судалгаа, шинжилгээгээр хангадаг парламентын судалгааны нэгж юм. Энэхүү нэгж нь Ассамблейн Ерөнхий нарийн бичгийн дарга болон Удирдлагын Зөвлөлийн удирдлага дор үйл ажиллагаа явуулна. Уг нэгж нь дараах бүтэцтэй байна³⁰².

³⁰² Development of Parliamentary Research Services in Central Europe and the Western Balkans, NDI, Page 39-40.
<https://www.ndi.org/sites/default/files/development-of-parliamentary-research-services-CEE.pdf>

Зураг 1. Парламентын Институтийн бүтэц



1. Парламентын институтийн тэргүүн нь ерөнхий удирдлагаар хангана. Бүтэц зохион байгуулалт, ерөнхий үйл ажиллагааг хариуцах ба стратеги чиглэл, судалгааны үйл ажиллагааг төлөвлөх, хөгжүүлэхтэй холбоотой удирдлагыг хэрэгжүүлнэ.
2. Ерөнхий шинжилгээ, судалгаа болон Европын интеграцын асуудал хариуцсан алба (*Department on General analyses, research and european integration*) нь Үндсэн хууль болон парламентаас гаргаж буй хуультай холбоотой судалгаа, мөн Европтой харилцах асуудлууд болон түүнтэй холбоотой хуулийг байнгын хороогоор хэлэлцүүлэхэд судалгаагаар хангана. Энэ алба нь нь дотроо 2 нэгжтэй байна. Үүнд:
 - **Хуулийн судалгаа, шинжилгээний нэгж** (**unit on Legal analysis and research**) нь парламентын үйл ажиллагааны тухай журмыг тайлбарлах, Үндсэн хуульд тайлбар хийх болон парламентаас гаргасан хуультай холбоотой судалгаа, хууль зүйн дүн шинжилгээ хийнэ.
 - **Ерөнхий судалгаа, шинжилгээний нэгж** (**unit on General analyses and research**) нь эдийн засаг, нийгмийн бодлого, бүс нутгийн бодлого зэрэг салбар дагнасан судалгаануудыг хийнэ.
3. Сургалт, харилцаа болон хуулийн сан, судалгааны номын сан хариуцсан алба (**Department on Education and communication/ research library and legislative archive**) нь ажилтнуудын чадавхыг бэхжүүлэх, парламентад шинээр сонгогдсон гишүүдэд зориулж парламентын үйл ажиллагааны тухай журам, парламентын үйл ажиллагааг таниулах талаар сургалт явуулах, хууль зүйн санг ашиглах орчин үеийн аргыг нэвтрүүлэх, хэрэглэхэд хялбар номын сангаар үйлчлэх зэрэг үйл ажиллагааг хариуцна. Уг алба нь дараах 2 нэгжтэй байна. Үүнд:
 - **Сургалт, харилцаа хариуцсан нэгж**
 - **Хуулийн сан болон Судалгааны номын сан хариуцсан нэгж** зэрэг болно.

Парламентын Институт нь дараах үйлчилгээг үзүүлнэ. Үүнд:

Судалгаа, шинжилгээний чиглэлээр: Хуулийн төсөлд тайлан, хураангуй бэлтгэх, дүн шинжилгээ, нөлөөллийн үнэлгээ хийх, мөн Парламентын судалгаа болон бичиг баримт хариуцах Европын төв сүлжээ (*European Center for Parliamentary Research and Documentation - ECPRD*), Олон улсын хууль эрх зүйн мэдээллийн сүлжээ (*Global Legal*

Information Network - GLIN), Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагатай (*Organization for Security and Co-operation in Europe - OSCE*) хууль эрх зүйн талаарх мэдээллийг солилцох, хамтран ажиллах;

Харилцаа болон сургалтын чиглэлээр: сургалт, семинар, бага хурал, мэдээлэл зааварчилгаа өгөх зорилго бүхий танилцуулга семинар хийх, тойм мэдээ, брошур, зурагт хуудас бүхий танилцуулга гаргах, Ассамблейн үйл ажиллагаатай танилцах хөтөлбөр, дадлагажуулалтын хөтөлбөр, олон нийттэй харилцах тусгайлсан хөтөлбөр зэргийг зохион байгуулах;

Хуулийн сан: Хуулийн сангийн хадгалалтын системийг боловсронгуй болгох, түүнийг ашиглах үйл ажиллагааг хурдан шуурхай явуулах;

Номын сангийн үйлчилгээ: Номын сангийн фондыг ашиглах, баяжуулан сайжруулах үйл ажиллагаа явуулах, ном болон бусад материал, судалгааны материалаар үйлчлэх үүрэгтэй байна.

Парламентын Институтийн зохицуулалт

Энэхүү нэгжийн үйл ажиллагааг Бүгд Найрамдах Македон Улсын Ассамблейн тухай хуулиар (*LAW ON THE ASSEMBLY OF THE REPUBLIC OF MACEDONIA*) зохицуулдаг. Энэ хуульд судалгааны нэгжийн талаар дараах зохицуулалтыг тусгасан байна³⁰³.

Бүгд Найрамдах Македон Улсын Ассамблейн тухай хуулиар

42 дугаар зүйл.

1. Хууль тогтоох үйл ажиллагааг сайжруулах, хяналт тавих, шинжилгээ ба судалгаагаар хангах чадавхыг бэхжүүлэх зорилгоор Ассамблей тусгай зохион байгуулалтын нэгжийг байгуулна (Парламентын институт).
2. Энэ хууль хвчин төгөлдөр болсноос хойш гурван сарын дотор уг тусгай зохион байгуулалтын нэгжийн үйл ажиллагааг Ассамблейн дарга, дэд дарга болон УИХ дахь намын бүлгийн Зохицуулагч нарын харилцан тохиролцсон байр суурь дээр үндэслэн Ерөнхий нарийн бичгийн даргын баталсан тусгай зохицуулалтаар зохицуулна.
3. Парламентын институт нь судалгааны төв байх бөгөөд парламентын үйл ажиллагааг явуулахад гишүүдийг цаг хугацаанд нь бодитой, хараат бус эксперт судалгаа, шинжилгээгээр хангана.
4. Парламентын институтийн ажилтан нь үнэнч шударга, эрх тэгш байдлыг эрхэмлэн ажиллах бөгөөд мэргэжлийн болон мэргэшлийн шалгуур үзүүлэлтийг хангасан байна.
5. Македон хэлээс өөр хэлээр ярьдаг гишүүнд (уг хэлээр Македоны хүн амын ядаж 20% нь ярьдаг байх) Парламентын институт нь мэдээллээ түүний эх хэл болон бичиг рүү хөрвүүлж үйлчилнэ. Мөн Парламентын гишүүний хүсэлтээр бусад улсын хэл рүү орчуулна.
6. Парламентын институт нь төрийн болон бусад байгууллагуудтай нууцын зэрэглэлтэйгээс бусад мэдээлэл, материалыг цаг тухайд нь харилцан солилцох замаар хамтарч ажиллана.

³⁰³ БҮГД НАЙРАМДАХ МАКЕДОН УЛСЫН АССАМБЛЕЙН ТУХАЙ ХУУЛЬ (LAW ON THE ASSEMBLY OF THE REPUBLIC OF MACEDONIA), <https://www.sobranie.mk/law-on-the-assembly-of-rm.nspx>

7. Парламентын институтийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах болон хянах ажлыг Удирдлагын зөвлөл удирдан явуулна. Удирдлагын зөвлөл нь Парламент дахь намын бүлгийн Зохицуулагч, Ассамблейн Ерөнхий нарийн бичгийн дарга, бусад төлөөллөөс бүрдэнэ. Бусад төлөөллийг Ассамблейн дарга, дэд дарга болон Парламент дахь намын Зохицуулагч нар зөвшилцсөний үндсэн дээр томилно.
8. Парламентын институт нь жилийн ажлын тайлангаа Удирдлагын зөвлөл болон Ассамблейн даргад хүргүүлнэ.
9. Ассамблей нь үйл ажиллагаандаа е-Парламентыг хэрэглэх нөхцөлийг бүрдүүлнэ.
10. Ассамблей нь парламентын номын сангийн үйл ажиллагааг явуулах нөхцөлийг хангана.

2.6. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Бундестагийн судалгааны алба

Германы Бундестаг (парламент)-ийн судалгаа алба (СА)³⁰⁴ нь Бундестагийн тамгын газрын бүтцэд “W” буюу Судалгаа ба Гадаад харилцааны Ерөнхий захиргааны харьяанд “Судалгааны газар” нэртэйгээр зохион байгуулагдсан байна. 2011 оноос хойш тус газрыг сэтгүүлч, номлолын ухааны доктор Гуйдо Хайнэн 100 гаруй судлаачдын хамтаар удирдаж байна.

СА нь Холбооны яамдын мэргэжлийн бүрэн эрхээс (мэдлэгээс) үл хамааран Бундестагийн депутатуудыг тодорхой асуудлын хүрээнд мэдээллээр хангах үндсэн зорилготой байгууллага юм. Гүйцэтгэх засаглал нь хууль тогтоох засаглалтай харьцуулахад мэдлэгийн хувьд давуу байдалтай байдаг тул СА үүнийг саармагжуулах зорилготой юм.

СА-нд захиалгыг депутат буюу Бундестагийн удирдлагаас ирүүлнэ. Уг алба нь жилд 4 300 шахам захиалгыг “халуун шугам”-аар³⁰⁵ хүлээн авдаг. СА нь ерөнхийдөө өөрөө эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийдэггүй, харин судалгаа шинжилгээний өнөөгийн түвшин, мөн хууль тогтоомжийг ойлгомжтой, гаргацтай байдлаар гаргаж тавьдаг.

СА-ны гаргаж байгаа ажлууд нь улстөрөөс ангид байх ёстой. Депутатууд нь СА-ыг үндсэндээ зөвхөн мандаттайгаа холбоотой ажил төрөлд л ашиглах үүрэгтэй.

Захиалгаар хийгдсэн ажил нь ерөнхийдөө захиалагчийн эрх мэдэлд 4 долоо хоногийн туршид байдаг. 2016 оноос хойш, энэ хугацаа өнгөрсний дараа хэрэв “нарийн зохицуулагдсан хасах нөхцөл эсрэгцэн бүрдээгүй бол”³⁰⁶ (Мэдээллийн эрх чөлөөний тухай 2016 оны 2 дугаар сарын шинэ хуулийн дагуу) уг судалгааны ажлыг Бундестагийн вэб хуудсанд байршуулдаг болсон³⁰⁷.

СА-нд парламентын номын сангуудын дотор дэлхийд 3 дугаарт жагсах, ойролцоогоор 1.4 сая уншлагын нэгж бүхий Германы Бундестагийн Номын сан харьяалагдана.

³⁰⁴ Германы Бундестагийн Судалгааны алба-Wissenschaftliche Dienste des Deutschen Bundestages https://de.wikipedia.org/wiki/Wissenschaftliche_Dienste_des_Deutschen_Bundestages

³⁰⁵ Hotline W

³⁰⁶ “so dem nicht eng gefasste Ausschlussgründe entgegenstehen”-германаар

³⁰⁷ Мэдээллийн эрх чөлөө: Бундестаг өөрийн дүгнэлтүүдээ сүлжээнд тавьж байна-Informationsfreiheit: Bundestag stellt seine Gutachten ins Netz <http://www.zeit.de/digital/internet/2016-02/informationfreiheit-bundestag-stellt-wissenschaftliche-gutachten-online>

Түүнээс гадна Германы Бундестагийн Архив мөн СА-нд хамрагдана.

Мөн СА нь өөрийн санаачлагаар “Тулгамдсан асуудлууд” нэртэй, 2 хуудаст багтсан судалгааны ажил хийдэг. Үүнийгээ бүх депутатад түгээдэг. Харин вэб хуудсанд илүү дэлгэрэнгүй боловсруулсан хувилбарыг байршуулж өргөн олны хүртээл болгодог.

СА болон Европын тасаг нь депутатуудыг дүн шинжилгээ болон мэргэжлийн салбарын мэдээлэл, үнэлэлт өгч дүгнэсэн байр суурь илэрхийлсэн баримт бичгээр хангаж, тэдэнд дэмжлэг үзүүлдэг³⁰⁸. СА нь зөвхөн дан ганц парламентын төлөө ажилладаг. Түүнчлэн, “Тулгамдсан асуудлууд” болон “Мэдээллийн хуудас”³⁰⁹, “Европын тулгамдсан асуудлууд” нэртэй товхимолууд гаргадаг. Судалгаа шинжилгээний ажлуудын агуулгад “Хариуцлагаас чөлөөлөх”³¹⁰ болон “Зохиогчийн эрхийн хамгаалалт”³¹¹-ын эрх зүйн орчин үйлчилнэ.



³⁰⁸ Бундестаг: Мэргэжлийн мэдээлэл болон дүн шинжилгээ-Bundestag: Fachinformationen und Analysen
<http://www.bundestag.de/analysen>

³⁰⁹ германаар Infobrief

³¹⁰ германаар Haftungsausschluss

³¹¹ германаар Urheberrechtsschutz

**ПАРЛАМЕНТЫН СУДАЛГААНЫ АЛБАДЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН, БҮТЭЦ, ЗОХИОН
БАЙГУУЛАЛТ**

**Парламентын Судалгааны нэгж парламентын
Ажлын албатай ижил статустай байх хэлбэр³¹²**

Хүснэгт №1

№	Улс орон	Бүтэц, зохион байгуулалт	Орон тоо	Эрх зүйн орчин
1	АНУ <i>Конгрессийн судалгааны алба</i> <i>/CRS/</i>	<ul style="list-style-type: none"> • Захирлын ажлын алба • Судалгааны 5 салбар, 1 хэсэгтэй. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Нэгдсэн улсын хуулийн салбар - Нийгмийн бодлогын салбар - Гадаад хэрэг, батлан хамгаалах, худалдааны салбар - Засгийн газар ба Санхүүгийн салбар - Шинжлэх ухаан, үйлдвэрлэл, нөөцийн салбар - Мэдлэгийн үйлчилгээний хэсэг 	CRS: 700 гаруй ажилтантай: - бодлогын шинжээч – 450, - мэргэшсэн судлаач – 250 Төсвийн алба – 300	Бүтэц зохион байгуулалтын тухай хууль /1970/
2	Австрали <i>Парламентын Номын сан</i> <i>/Parliamentary Library/</i>	<p>Парламентын номын сан хоёр үндсэн хэсгээс бүрдэнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Судалгаа, шинжилгээ - Мэдээлэл <p>Судалгааны салбар 7 хэсэгтэй. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Эдийн засгийн судалгааны хэсэг - Гадаад хэрэг, аюулгүй байдалын судалгааны хэсэг - Эрх зүй болон хуулийн төслийн шинжилгээний хэсэг - Улс төр болон нийтийн удирдлагын судалгааны хэсэг - Шинжлэх ухаан, технологи, Хүрээлэн буй орчин байгалийн баялагын судалгааны хэсэг - Нийгмийн бодлогийн судалгааны хэсэг - Статистик дүрслэлийн судалгааны хэсэг 	<ul style="list-style-type: none"> - Судалгааны салбар нь 80 гаруй судлаач, - Мэдээллийн салбар нь 60 гаруй албан хаагчтай 	"Парламентын үйлчилгээний тухай"
3	БНСУ <i>-Үндэсний судалгааны газар</i> <i>/NRD/</i> <i>-Үндэсний Хурлын Төсвийн Оффис</i>	<ul style="list-style-type: none"> - Төлөвлөлт, удирдлагын алба - Улс төр, захиргааны судалгааны алба - Эдийн засаг аж үйлдвэрийн алба - Нийгэм, соёлын судалгааны алба 		Үндэсний Ассамблейн тухай хууль
4	Вьетнам <i>Хууль зүйн судалгааны институт</i> <i>/LRI/</i>	<ul style="list-style-type: none"> • Шинжлэх ухааны судалгааны төв: <ul style="list-style-type: none"> - Мэргэшсэн хэлтсүүд - Судалгааны менежментийн хэлтэс • Шинжлэх ухааны мэдээллийн төв: <ul style="list-style-type: none"> - Мэргэшсэн хэлтсүүд • Ерөнхий үйл ажиллагааны газар: <ul style="list-style-type: none"> - Захиргаа, нөөцийн хэлтэс - Гадаад харилцаа, хамтын 	ХЗСИ нь: -250 гаруй мэргэжилтэн, эксперт, судлаач, -50 гаруй албан хаагчтай	Үндэсний Ассамблейн Байнгын хорооны 2008 оны 614-р тогтоол

³¹² Зарим орны парламентын Судалгааны нэгжийн талаарх мэдээлэл. УИХ-ын ТГ-ын Судалгааны эмхэтгэл XIII боть. УБ., 2012 он.

		ажиллагааны хэлтэс - Санхүүгийн хэлтэс		
5	Канад <i>Парламентын номын сан /Parliamentary Library/</i>	Парламентын Номын сантайгаа хамт	300 орчим албан хаагчтай	Канадын парламентын актын 73-79-р зүйл
6	Саудын Араб <i>Судалгаа, мэдээллийн ерөнхий хэлтэс</i>			- Зөвлөх зөвлөлийн тухай хууль - Зөвлөх зөвлөлийн дэг тухай хууль
7	Япон <i>Номын Сангийн судалгаа, хуулийн лавлагааны товчоо</i>	Парламентын номын сантай хамт нэгдсэн удирдлагатай бөгөөд парламентын ажлын албатай ижил статустай. - Номын сан - Номын сангийн судалгаа, хуулийн лавлагааны товчоо	<i>Номын сан нийт 900 албан хаагчтай.</i> -190 орчим нь судалгааны албан хаагчид байна	<ul style="list-style-type: none"> Парламентын тухай хуулийн XVII дугаар бүлгийн 130-133 зүйл Танхимуудын тухай хууль /1948/

Парламентын Судалгааны нэгж парламентын Ажлын албаны дотоод бүтцэд байх хэлбэр

Хүснэгт №2

№	Улс орон	Ерөнхий мэдээлэл	Эрх зүйн орчин
1	Австри <i>Мэдээллийн хэлтэс</i>	Мэдээллийн хэлтэсийн чиг үүрэг: - Үндэсний болон Холбооны Зөвлөл /ҮЗ, ХЗ/-ийн Ерөнхийлөгчид мэдээллийн үйлчилгээ үзүүлэх; - Парламентын бүлгүүд болон парламентын Тамгын газарт мэдээллийн үйлчилгээ үзүүлэх; - Тухайн цаг үеийн мэдээллийн хэрэгслүүдийн мэдээлэл, судалгаа шинжилгээнд анализ хийх;	
2	Аргентин <i>Парламентын мэдээллийн захиргаа</i>	Парламентын мэдээллийн захиргаа нь Депутатуудын танхимын ЕНБД-ын удирдлаганд Парламентын мэдээллийн захиргаанд хамаарна. Хууль тогтоох үйл ажиллагаатай холбоотой чиг үүргийг хэрэгжүүлнэ. Мөн Сенатын танхимын ЕНБД-ын удирдлаганд <i>Холбооны парламент судлалын институт</i>	
3	Армян <i>Судалгаа, шинжилгээний газар</i>	Судалгаа, шинжилгээний газар дараах бүтэцтэй: - Нийгмийн судалгааны хэлтэс - Эдийн засгийн судалгааны хэлтэс	<i>Үндэсний хурлын дэгийн тухай хууль болон бие даасан бусад хууль, журам</i>
4	Босни-Герцеговин <i>Судалгааны газар</i>	Судалгааны газар нь Нарийн бичгийн дарга нарын Коллегиор удируулсан Нэгдсэн албаны харьяанд хамаарна.	
5	Бразил <i>Баримтжуулалт ба мэдээллийн төв</i>	Парламентын доод танхимын Тамгын газрын Хуулийн хэлтэсийн харьяанд Баримтжуулалт ба мэдээллийн төв нь дараах үндсэн чиг үүргийн дагуу ажиллана: - Хуулийн шинжлэл - Мэдээлэл, судалгаа - Баримтжуулалт, архивын бүрдүүлэлт - Хэвлэн нийтлэх үйл ажиллагаа	

		<ul style="list-style-type: none"> - Олон нийттэй харилцах - Номын сангийн үйлчилгээ 	
6	Габон <i>Баримтжуулалт, сургалт, шинжлэх ухааны судалгааны газар</i>	Баримтжуулалт, сургалт, шинжлэх ухааны судалгааны газар нь ЕНБД-ын удирдлаганд Эрх зүй, хууль тогтоомжийн ерөнхий газарт үйл ажиллагаагаа явуулдаг.	
7	ХБНГУ <i>Судалгаа, гадаад харилцааны ерөнхий газар</i>	<p>Бундестагийн ЕНБД-ын удирдлаганд байдаг <i>Судалгаа, гадаад харилцааны ерөнхий газар</i> нь 3 газартай:</p> <ul style="list-style-type: none"> • Судалгааны газар • Гадаад харилцааны газар • Өргөдөл, хүсэлт хариуцсан газар <p><i>Судалгааны газрын</i> ерөнхий чиг үүрэг нь парламентын гишүүдийг мэргэжлийн өндөр түвшинд боловсруулсан мэдээллээр хангах, анализ шинжилгээ хийх, зөвлөмж гаргах юм.</p> <p>Дараах секторуудтай:</p> <ul style="list-style-type: none"> - Түүх, орчин үеийн түүх, улс төрийн судалгааны хэсэг - Гадаад харилцаа, ОУ-ын хууль, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжил, Батлан хамгаалах, Хүний эрх, Хүмүүнлэгийн тусламжийн судалгааны хэсэг, - Үндсэн хуулийн эрх зүй, Төрийн захиргааны судалгааны хэсэг, - Төсөв, санхүүгийн судалгааны хэсэг, - Эдийн засаг, технологи, Хэрэглэг-чийн эрхийг хамгаалах, Хүнс, ХАА, Аялал, жуулчлалын судалгааны хэсэг, - Хөдөлмөр, нийгмийн асуудлын судалгааны хэсэг, - Эрүү, иргэн болон иргэн, эрүүгийн байцаан шийтгэх хууль, Байгаль орчныг хамгаалах хууль, Тээвэр, барилга, хот байгуулалтын хуулийн судалгааны төв, - Байгаль орчны хамгаалалт, цөмийн аюулгүй байдал, Боловсрол, шинж-лэх ухааны судалгааны хэсэг, - Эрүүл мэнд, гэр бүл, өндөр настан, эмэгтэйчүүд, залуучуудын судал-гааны хэсэг, - Соёл, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, спортын судалгааны баг, - Европын асуудлын судалгааны хэсэг тус тус байна. 	
8	Гүрж <i>Судалгааны газар</i>	Судалгааны газрын бүтэц: Архив, Хууль тогтоох үйл ажиллагааны мэдээлэл, хангамжийн хэлтэс, Номын сан	<i>Парламентын дэгийн тухай хуулийн 44-р бүлэг /2004/</i>
9	Жибути <i>Шинжээчдийн алба</i>	Шинжээчдийн алба нь Баримт бичиг, мэдээллийн газарт хамаарах ба эрх зүй, нийгэм, эдийн засаг, соёл, дипломат болон цэргийн ерөнхий асуудлуудаар техникийн экспертиз хийнэ.	
10	Исланд Улс <i>Мэдээлэл, олон нийтийн хэлтэс</i>	<p>Мэдээлэл, олон нийтийн хэлтэс дараах зохион байгуулалттай:</p> <ul style="list-style-type: none"> - Албан ёсны танилцуулгын алба - Судалгаа шинжилгээ ба номын сангийн алба - Олон нийттэй харилцах алба 	
11	Их Британи <i>Парламентын шинжлэх ухаан, технологийн офис</i>	Хоёр танхимын дундын Парламентын шинжлэх ухаан, технологийн офис нь шинжлэх ухаан, технологийн бодлогын асуудлаар бие даасан, бусдаас хамааралгүй, хүртээмжтэй анализ хийх үүрэгтэй парламентын дотоод эх сурвалж болох байгууллага юм.	

12	Кабо-Верде <i>Баримт бичиг, парламентын мэдээллийн хэлтэс</i>	Баримт бичиг, парламентын мэдээллийн хэлтэс нь Парламентын мэдээлэл, баримт бичгийн үйлчилгээний газарт хамаарах ба мэдээлэл, баримт бичгүүдийг шуурхай тараах, хураан авах, хадгалах, системчлэнэ зэрэг үүрэгтэй.	
13	Камбож <i>Судалгааны ерөнхий департамент</i>	Ерөнхий нарийн бичгийн даргын удирдлаганд ажиллана.	
14	Литв <i>Парламентын судалгааны газар</i>	Парламентын судалгааны газар нь ерөнхий мэдээллийн хэлтэс, ном зүйн мэдээллийн хэлтэс, эдийн засгийн болон нийгмийн мэдээллийн хэлтэс, эрх зүй ба улс төрийн мэдээллийн хэлтэс гэсэн зохион байгуулалттай.	
15	Марокко <i>Судалгаа, баримт бичгийн хэлтэс</i>	<i>Судалгаа, баримт бичгийн хэлтэс</i> нь Архив, бичиг хэрэг, номын сангийн үйлчилгээний алба болон Судалгаа, орчуулгын албатай.	
16	Мексик <i>Судалгаа, шинжилгээ, анализийн төв</i>	Судалгаа, шинжилгээ, анализийн төв нь Депутатуудын танхимын Парламентын асуудал хариуцсан нарийн бичгийн даргын удирдлаганд Баримт бичиг, мэдээлэл хариуцсан ерөнхий газарт үйл ажиллагаагаа явуулдаг Депутатуудын үйл ажиллагаанд шаардлагатай мэдээлэл, лавлагаа, бодлогын болон харьцуулсан судалгаа зэргийг мэргэжлийн өндөр түвшинд үнэн бодит мэдээлэлд тулгуурлан бэлтгэж үйлчилнэ. Эдийн засгийн, Үндэсний аюулгүй байдал, улс төрийн болон тусгай сэдэв гэсэн 3 дэд хэсгүүдтэй.	<i>Депутатуудын танхимын дотоод журмын 32-р зүйл</i>
17	Молдов <i>Мэдээлэл- судалгааны алба</i>	Мэдээлэл-судалгааны алба нь Парламент судлал, шинжилгээний ба Мэдээллийн нөөцийн хэлтэстэй	<i>Парламентын дэгийн тухай хуулийн 12-р бүлэг /1996/</i>
18	Монтенегро <i>Судалгаа, шинжилгээ, номын сан, баримт бичиг, архивын алба</i>	Судалгаа, шинжилгээ, номын сан, баримт бичиг, архивын алба нь Судалгаа, баримт бичиг, мэдээллийн технологийн секторт хамаарах ба 4 салбар нэгжтэй: - Судалгаа шинжилгээ, бичиг баримт, номын сан, архивын салбар - Мэдээллийн технологийн салбар - Парламентын чуулганы телевиз-радио нэвтрүүлэг, бичлэгийн салбар - Аудио болон бичмэл протоколын салбар.	- <i>Парламентын тухай хууль</i> - <i>Парламентын үйл ажиллагааны журам</i> - <i>Парламентын мэргэшсэн албаны зохион байгуулалт, системчлэлийн дүрэм</i>
19	Намиби <i>Судалгаа, мэдээлэл, нийтлэл, редакцийн хэлтэс</i>	Судалгаа, мэдээлэл, нийтлэл, редакцийн хэлтэс нь Үндэсний Ассамблейг шинжлэх ухааны арга зүйн үндэслэлтэй судалгаа, мэдээллээр хангана. Хэлтэс нь хэд хэдэн албадтай ба тэдгээрийн нэг нь <i>Судалгааны алба</i> ба гишүүдэд хууль тогтоох эрх мэдлээ хэрэгжүүлэхэд нь шаардлагатай судалгаа, мэдээллээр үйлчилнэ.	
20	Норвеги <i>Судалгааны хэсэг (Research Section)</i>	Судалгааны хэсэг нь Стортингийн ЕНБД-ын удирлаганд Мэдээлэл, баримт бичгийн газарт хамаарах ба гишүүд, БХ-д, намын ажлын албадад экспертийн туслалцаа үзүүлнэ.	- <i>Үндсэн хууль</i> - <i>Парламентын дэгийн тухай хууль</i>
21	ОХУ	Судалгааны газар нь хуулийн зохицуулалт шаардагдаж буй нийгэм, эдийн засгийн тодорхой асуудлаар болон	<i>Төрийн Думын даргын захирамж</i>

	<i>Судалгааны газар</i>	хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар мэдээлэл, судалгааны материал бэлтгэж депутатуудад хүргэх үүрэгтэй	
22	Румын <i>Парламент, хуулийн судалгааны газар</i>	<i>Парламент, хуулийн судалгааны газар</i> нь Тамгын газарт харьялах ба дараах хэлтэстэй: - Эрх зүйн судалгаа, баримт бичгийн хэлтэс / <i>Парламентын шинжилгээ, судалгааны хэсэг, Баримт бичиг, хуулийн мэдээллийн хэсэг, Номын сан гэсэн бүтэцтэй/</i> - Нийтийн эрх зүйн хэлтэстэй байна.	<i>Депутатын танхимын ажлын албаны үйл ажиллагаа, зохион байгуулалтын журам /2009/</i>
23	Серби <i>Мэдээлэл, судалгаа, номын сангийн хэлтэс</i>	Мэдээлэл, судалгаа, номын сангийн хэлтэс нь Зохион байгуулалт, Клеркийн секторт хамаарах ба Мэдээлэл судалгааны алба, Номын сан гэсэн 2 албатай. Дараах чиг үүрэгтэй: - ҮА-н хууль тогтоох үйл ажиллагаатай холбогдуулан мэргэжлийн болон шинжээчийн судалгаа, мэдээллээр хангах; - ҮА-н хуралдаанаар хэлэлцэгдэж буй асуудлаар парламентын гишүүд болон БХ-дод мэргэжлийн харьцуулсан судалгааны үйлчилгээ үзүүлнэ.	- <i>Үндэсний Ассамблейн тухай хуулийн 292-р зүйл</i> - <i>Үндэсний Ассамблейн үйл ажиллагааны журмын 35-р зүйл</i> - <i>Үндэсний Ассамблей /ҮА/- н дэмжлэг үйлчилгээний байгууллагын тухай шийдвэр</i>
24	Сингапур <i>Номын сан, судалгааны газар</i>	<i>Судалгааны газар</i> нь сүүлийн үеийн мэдээлэл, хэвлэлийн чиг хандлага, судалгаанд үндэслэсэн үнэн зөв мэдээллийг бий болгох зорилго бүхий гол байгууллага <i>Номын сангийн</i> гол үйлчилгээ нь парламентын гишүүд, хуулийн төслийн туслахууд, Тамгын газрын ажилтнуудыг мэдээллээр хангах, лавлагааны материал боловсруулахад чиглэгдэнэ.	
25	Словени <i>Судалгаа, баримт бичгийн хэлтэс</i>	Судалгаа, баримт бичгийн хэлтэс нь Судалгааны алба, Номын сан, баримт бичгийн зэрэг албатай.	<i>Үндэсний Ассамблейн дэгийн тухай хуулийн 25-27-р зүйлүүд</i>
26	Турк <i>Судалгааны төв</i>	Судалгааны төв болон Номын сан, баримт бичиг, орчуулгын хэлтэс нь Хууль тогтоомжийн газарт харьяалагдана. Тус төвд эдийн засаг, ОУ-ын харилцаа, улс төрийн шинжлэх ухаан, төрийн захиргаа зэрэг мэргэжлийн судлаач, мэргэжилтнүүд ажиллах ба гишүүдээс ирүүлсэн захиалгын дагуу судалгаа хийж хариуг амаар болон бичгээр өгч болно. Судалгааны ажил, тайлангаар улирал тутам “Bilgi” сэтгүүл, ном хэвлэнэ.	- <i>Үндэсний Их Хурлын даргын 2006 оны 107 тоот шийдвэр</i> - <i>Үндэсний Их Хурлын Судалгааны төвийн журам</i>
27	Украин <i>Эрдэм шинжилгээ- судалгааны газар</i>	Эрдэм шинжилгээ-судалгааны газар нь Төрийн байгуулалтын, Үндсэн хуулийн, ОУ, хүний эрх, ЕХ-ны, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн, Иргэний болон аж ахуйн харилцаа, жижиг үйлдвэрийн, ХАА, байгаль, экологийн, Төсөв, татварын, Макро эдийн засаг, аж үйлдвэрийн хөгжлийн зэрэг хэлтсүүдтэй.	<i>Парламентын дэгийн тухай хууль</i>
28	Финланд <i>Судалгааны алба</i>	<i>Судалгааны алба</i> нь ЕНБД-ын удирлаганд Мэдээлэл холбооны газарт хамаарах ба парламентаар хэлэлцэгдэж буй асуудал болон гишүүдийн үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд нь шаардлагатай мэдээлэл, судалгаагаар хангах болон хэвлэлийн материал зэргийг бэлтгэх үүрэгтэй. Мөн ЕХ-ны тухай мэдээлэл, телевизэд	<i>Парламентын дэгийн тухай хууль</i>

		зориулсан видео үйлчилгээ, онлайн үйлчилгээгээр хангах зэрэг чиг үүрэгтэй.	
29	БНХАУ <i>Номын сан, судалгаа болон зөвлөгөө өгөх байгууллага</i>	Номын сан, судалгаа болон зөвлөгөө өгөх байгууллага нь ЕНБД-ын удирдлаганд байна. Мөн Эрх зүйн болон Төсвийн комиссууд тус бүр <i>Судалгааны офистой.</i>	
30	Чех <i>Судалгааны төв</i>	Судалгааны төвийн зохион байгуулалт: - дарга - орлогч дарга - судлаачид - захиргааны ажилтнууд Нийт 16 ажилтантай. Үүнд: хуульч 7, эдийн засагч 2, түүхч 1, улстөр судлаач 2, техникийн ажилтан 1, туслах ажилтан 3.	
31	Чили <i>Мэдээллийн хэлтэс</i>	Мэдээллийн хэлтэс нь дараах 3 албатай: - Хууль, эрх зүйн судалгаа, статистик мэдээний алба, - Иргэний мэдээллийн алба, - Гадаад зөвлөх системийн хэлтэс	
32	Швед <i>Судалгааны алба</i>	<i>Судалгааны алба</i> нь парламентын гишүүд, намын бүлгүүдийн нарийн бичгийн даргын газар, хороод болон парламентын бусад албадад зориулан судалгаа, мэдээллийн ажил гүйцэтгэнэ.	
33	Шинэ Зеланд <i>Парламентын судалгаа, боловсролын бүлэг</i>	Клеркийн газрын орлогч нь бага хэмжээний процедурын судалгаа ба бодлогын хөгжлийн бүлгийг толгойлох бөгөөд уг бүлэг нь процедурын мэдээллийн нэгдсэн төв санг бүлдүүлэх, хадгалах ажил болон парламентын боловсролын асуудлыг хариуцна.	
34	Эстони <i>Эрх зүй, судалгааны хэлтэс</i>	Эрх зүй, судалгааны хэлтэс нь Рийгикогу, Тамгын газрын хэлтэс, албадад эрх зүй, парламентын хяналт, нийгэм, эдийн засгийн салбарууд болон ЕХ-ны асуудлаар зөвлөлгөө өгөх, харьцуул-сан судалгаа, шинжилгээ хийх, лавлагаа мэдээлэл өгөх, хууль, тогтоолын төсөлд дүн шинжилгээ хийж зөвлөмж, дүгнэлт гаргах, шинжилгээ судалгааны ажил захиалах, гадаад орнуудын парламентын судалгаа, шинжилгээний байгууллагуудтай хамтран ажиллана.	<i>Рийгикогу /парламент/-ын тогтоолоор 1992.10.05-нд байгуулсан</i>
35	Энэтхэг <i>Парламентын номын сан, судалгаа, лавлагаа, мэдээлэл, баримтжуулах болон мэдээллэх үйлчилгээ</i>	Парламентын номын сан, судалгаа, лавлагаа, мэдээлэл, баримтжуулах болон мэдээллэх үйлчилгээ нь Парламентын доод танхим буюу Ардын танхим, дээд танхим буюу Муж Муж улсуудын зөвлөлийн тус бүрийн Тамгын гарзын харъяанд байна. 5 хэлтэст хуваагдана. Үүнд: номын сан, судалгаа, лавлагаа, хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах, парламентийн музей. 90 ажилтантай	<i>Үндсэн хууль болон бие даасан бусад хууль</i>

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Дэлхийн улс орнуудын парламентын Ажлын алба. УБ., 2012 он.
- СТ-14/210 Парламентын судалгааны албадын эрх зүйн зохицуулалт 2014 он
- Болормаа Ц., Билгээ Г. Зарим орны парламентын Судалгааны нэгжийн талаарх мэдээлэл., Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгааны эмхэтгэл XIII боть., УБ., 2012 он,
- Хатанбаатар Р., Товуусүрэн Ц., Пагма А. БНСУ-ын Үндэсний Ассамблейн Ажлын албадын тухай., Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгааны эмхэтгэл XIV боть. УБ., 2013 он.
- Legislative Reorganization Act of 1970, 91st Congress (1969-1970), <https://bulk.resource.org/gao.gov/91-510/000062AF.pdf>
- Judy Schneider, Christopher M. Davis, Betsy Palmer. Reorganization of the House of Representatives: Modern Reform Efforts, CRS Report for Congress, Order Code RL31835, 2003.
- Parliamentary Service Act 1999. <http://www.comlaw.gov.au/Details/C2014C00045>
- Association of Parliamentary Libraries of Australia, Research Services in Australian Parliaments
- Responses from all State, Territory and Federal Parliaments. <http://www.apla.org.au/information/bm.doc/research-services-in-australian-parliaments-2011-va470837.pdf>
- Department of Parliamentary Services Annual Report 2012-2013, Part 4 ParliamentaryLibrary.http://www.aph.gov.au/About_Parliament/Parliamentary_Departments
- The Diet Law 1947. <http://www.sangiin.go.jp/eng/law/diet/>
- National Diet Library Law 1948. <http://www.ndl.go.jp/en/aboutus/laws.html>
- Anticipatory Research of the National Diet (Parliamentary) Library Japan: A Major Research Resource for the Diet, <http://www.ndl.go.jp/en/publication/>
- *International Federation of Library Associations, The Japanese Diet (Parliament) of the future and the progress of the services to the Diet*, <http://conference.ifla.org/past-wlic/2010/141-hirose-en.pdf>
- The House of Representatives, Diet Functions, http://www.shugiin.go.jp/internet/itdb_english.nsf/html/statics/guide/secretar.htm
- Юн Феррье. Успешное предоставление профессиональных беспристрастных услуг в пристрастной среде. Совет Федерации РФ. Аналитический вестник. №8 (228). М., 2004г.

**ПАРЛАМЕНТЫН СПИКЕР НАМЫН ГИШҮҮНЧЛЭЛЭЭС ТҮДГЭЛЗДЭГ ЭСЭХ,
СПИКЕРИЙН БҮРЭН ЭРХИЙН ХУГАЦАА БА БҮРЭН ЭРХТЭЙ ХОЛБООТОЙ ЗАРИМ
ЗОХИЦУУЛАЛТ**

(Харьцуулсан судалгаа)

*Г.Алтан-Оч (Ph.D), Г.Билгээ, И.Жаргалзаяабямба,
Д.Жигваагүнсэл, О.Нарантуяа, Р.Нургүл
Р.Оргилмаа, Ц.Элбэгзаяа*

АГУУЛГА

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Нэг. Парламентын спикер намын гишүүнчлэлээс түдгэлздэг тухай

- 1.1. Их Британи, Умард Ирландын Вант Улс
- 1.2. Канад Улс
- 1.3. Бүгд Найрамдах Солонгос Улс
- 1.4. Бүгд Найрамдах Турк Улс
- 1.5. Парламентын гишүүн намаас гарсантай холбогдох асуудал

Хоёр. Дэлхийн бусад орнуудын парламентын спикерийн бүрэн эрхийн хугацаа

Гурав. Парламентын спикерийн бүрэн эрхтэй холбоотой зарим зохицуулалт

- 3.1. Парламентын үйл ажиллагааг зохион байгуулах бүрэн эрх
- 3.2. Онцгой бүрэн эрх
- 3.3. Хууль санаачлах, үг хэлэх, санал өгөх болон бусад бүрэн эрх

ХАВСРАЛТ. Дэлхийн улс орнуудын парламентын спикерийн бүрэн эрхийн хугацаа

ОИХ МН
СУДАЛГААНЫ САН

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Судалгаанд захиалагчийн хүсэлтийн дагуу дэлхийн бусад орнуудын парламентын спикерийн бүрэн эрх, үйл ажиллагаатай холбоотой дараах асуудлуудыг харьцуулан судлав. Үүнд:

1. спикер намын гишүүнчлэлээс түдгэлздэг тухай;
2. спикерийн бүрэн эрхийн хугацаа;
3. спикерийн бүрэн эрхтэй холбоотой зарим зохицуулалт

Судалгааны явцад бусад орнуудын Үндсэн хууль, Парламентын тухай хууль зэрэг холбогдох эрх зүйн актуудын хүрээнд хайлт хийж үзэхэд, ихэнх улс орнуудад **парламентын спикер нь намын гишүүнчлэлээс түдгэлздэг тухай** зохицуулалт байхгүй байна. Гэвч захиалагчаас спикер нь намын гишүүнчлэлээс түдгэлздэг туршлага бүхий орнуудын талаарх мэдээлэл хүссэн учраас ийм туршлага бүхий Их Британи, БНСУ, Канад зэрэг орнуудыг энэхүү судалгаанд хамруулав. Эдгээр орнуудад спикер нь улс төрийн бүх үйл ажиллагаанаас ангид, намын гишүүнчлэлээс түдгэлздэг зохицуулалттай байна. Энэхүү уламжлал нь Канад, Энэтхэг, Шри Ланк, Шинэ Зеланд, Турк зэрэг орнуудын парламентад байдаг боловч спикер нь намын гишүүнчлэлээс түдгэлзэхгүйгээр парламентын үйл ажиллагааг удирдан явуулна, ингэхдээ намын эрх ашгийн үүднээс асуудалд хандахгүй, шийдвэр гаргахад алагчлахгүй хандах, улс төрийн болон намын үйл ажиллагаанд оролцохгүй зэрэг тодорхой зарчмуудыг баримтлан ажилладаг байна.

Парламентын спикерийн бүрэн эрхийн хугацааны талаар дэлхийн 144 орны парламентын 184 танхимыг судлахад, спикерийн сонгогдон ажиллах хамгийн бага хугацаа нь 6 сар, хамгийн их нь 6 жил байна. Эдгээр танхимуудаас спикер нь 5 жилээр сонгогддог - 82 танхим (45%), 4 жилээр сонгогддог - 43 танхим (23%), 1 жилээр сонгогддог – 31 танхим (17%), 3 жилээр сонгогддог - 9 танхим (5%), 2 жилээр сонгогддог - 8 танхим (4%), 6 жилээр сонгогддог - 5 танхим (3%), хагас жилээр сонгогддог - 2 танхим (1%) байна.

Хүснэгт 1. Улс орнуудын парламентын танхим ба спикерийн бүрэн эрхийн хугацаа

Спикерийн сонгогдон ажиллах хугацаа	Улсын тоо	Танхимын тоо	Танхимын бүрэн эрхийн хугацаа (жил)							
			2	3	4	5	6	7	8	Хугацааг заагаагүй болон өөрөөр зохицуулсан
6 сарын хугацаанд	2	2				2*				
1 жилийн хугацаанд	26	31			15	11	2	1		2
2 жилийн хугацаанд	6	8	1		5	2			1	
2.5 жилийн хугацаанд	4	4				4				
3 жилийн хугацаанд	7	9		4			4			1
4 жилийн хугацаанд	37	43			36		1			
5 жилийн хугацаанд	69	82				81		1		
6 жилийн хугацаанд	5	5					4			1

Тайлбар: * Австри Улсын Холбооны Зөвлөлийн бүрэн эрхийн хугацаа 4-6 жил байх бөгөөд энд дундаж хугацаагаар авав.

Парламентын танхимын бүрэн эрхийн хугацааг спикерийн сонгогдох хугацаатай харьцуулж авч үзвэл, судалгаанд хамрагдсан парламентын 184 танхимын 125 (68%) танхимд спикерийн бүрэн эрхийн хугацаа нь танхимын бүрэн эрхийн хугацаатай ижил байна. Спикер нь танхимынхаа бүрэн эрхийн тал хугацаанд сонгогддог 9 (5%) танхим байна. (Хүснэгт 1.)

Парламентын спикерийн бүрэн эрхтэй холбоотой зарим зохицуулалтын талаар дэлхийн 19 орны парламентын 27 танхимын спикерийн бүрэн эрхийг Олон улсын парламентын холбоо (Inter Parliamentary Union, IPU)-ны ангилалын дагуу парламентын үйл ажиллагааг зохион байгуулах бүрэн эрх, онцгой бүрэн эрх, хууль санаачлах, үг хэлэх, санал өгөх болон бусад бүрэн эрхийн хүрээнд авч үзлээ. Судалгааны ажлыг гүйцэтгэхдээ захиалгад дурдсаны дагуу парламентын спикер нь 1-2.5 жилийн хугацаатай сонгогддог парламентын танхимын спикерүүдийн хувьд авч үзсэн бөгөөд эдгээр танхимын спикерүүдийн бүрэн эрхүүдээс зарим онцлох эрхийг авч үзье.

Хуулийн төсөл санаачлах бүрэн эрхийн хүрээнд Дани Улсын парламентын спикер нь парламентын онцгой нөхцөл байдлаас бусад тохиолдолд хуулийн төсөл санаачлахгүй.

Үг хэлэх бүрэн эрхийн хүрээнд Норвегийн парламент, Швейцарын хоёр танхимын спикерүүд үг хэлэх үед түүний орлогч буюу Дэд Ерөнхийлөгч хуралдаан даргалдаг бол Доминиканы БНУ-ын Депутатуудын 2 танхимын спикерүүд хууль тогтоомжийн хэлэлцүүлгийн үед суудлаа орхихгүй байх үүрэгтэй.

Санал хураалтад оролцох бүрэн эрхийн хүрээнд Бразил Улсын парламентын 2 танхимын спикер нь зөвхөн нууц санал хураалтад оролцох эрхтэй, Швейцарын парламентын 2 танхимын спикер нь зөвхөн санал тэнцсэн тохиолдолд санал хураалтанд оролцоно.

Үндсэн хуулийн хэрэгжилтийн баталгааг хангах бүрэн эрхийн хүрээнд Колумби, Чили, Аргентиний парламентын спикерүүд нь хууль, хуулийн төсөл Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх талаар саналаа илэрхийлэх, энэ талаар зарлах эрхтэй.

(Энэхүү судалгаанд Олон улсын парламентын Холбоо (Inter Parliamentary Union, IPU)-ны цахим хуудасны “Дэлхийн улс орнуудын парламентын мэдээлэл” (2018 оны 9 дүгээр сарын байдлаар) болон УИХ-ын Тамгын газрын Судалгааны төвөөс 2010 онд эмхэтгэн гаргасан “Дэлхийн улс орнуудын парламент” номыг эх сурвалж болгон ашигласан.)

Нэг. ПАРЛАМЕНТЫН СПИКЕР НАМЫН ГИШҮҮНЧЛЭЛЭЭС ТҮДГЭЛЗДЭГ ТУХАЙ

1.1. Их Британи Умард Ирландын Вант Улс

Анхны томилогдсон спикер нь 1377 онд Sir Thomas Hungerford байжээ. Түүний өмнөх нь Sir Peter de la Mare байсан бөгөөд 1376 онд Танхимын гишүүдээс сонгогдсон Иргэдийн төлөөлөгчдийн спикер юм. Анхнаасаа, спикерийн зарчмын (үндсэн) үүрэг бол Лордын Танхим болон эзэн хаантай харьцахад танхимаа төлөөлөн ярилцах явдал байв. Тэр үед хааны эрх мэдэл болон нөлөөлөх чадвар үлэмж их байсан бөгөөд танхим нь итгэл төгс биш, хавсарга байдалтай, спикер нь эзэн хааны ашиг сонирхлыг хамгаалах бие төлөөлөгч (иймээс ч “хааны хүн” хэмээдэг) байдалтай байжээ. Эзэн хаанаас спикерт нөлөөлөх явдал 1642 онд Charles I хаан спикерийг огцруулснаар төгсгөл болсон байдаг. Үүнээс хойш спикерийн сэнтийд Засгийн газрын эрх мэдэлтэн залрах болсон. Спикерийг засгийн эрх авсан намын гишүүдийн саналаар томилдог бөгөөд тэдний бодлогыг хэрэгжүүлдэг болсон. Гэвч Arthur Onslow спикер (1728-61) энэхүү засгийн газартай холбогдсон хүлээсийг сулруулж, спикерийн албаны хараат бус³¹³, үнэнч шударга байдлын³¹⁴ стандартыг тогтоосон байдаг. Тэрээр засгийн газарт өргөн дэлгэрсэн авлигал, хээл хахууль нь парламентын сүр хүч, нэр хүндийг гутааж байна гэж үзсэн учраас дэг журмыг хатуу баримтлагч, танхимын үйл ажиллагааны шударга арбитрчин болж түүхэнд тэмдэглэгдэн үлджээ. 1800-аад оны дундуур Shaw-Lefevre (1839-57) спикерийн албан тушаалд байх үедээ спикер нь улс төрийн бүх үйл ажиллагаанаас ангид байх зарчмыг үндэслэсэн байдаг. XIX-XX зуунд спикерийг үнэлэмж өндөртэй чухал эрх мэдэл, нэр хүндтэй албан тушаал болгох чиглэлд дүрэм журмаа боловсронгуй болгосоор нам бус³¹⁵ спикер байх уламжлалыг эргэлт буцалтгүй тогтоожээ.

Shaw-Lefevre спикерийн тогтоосон зарчмын дагуу спикер нь намын бүх гишүүнчлэлээс татгалзах³¹⁶ бөгөөд хэрэв танхимын дахин сонгуульд орох бол спикерийн хувиар нэр дэвшинэ. Гэхдээ энэ зарчим Нэгдсэн Вант Улсад хэрэгждэг бол Канадад нэвтрээгүй. Өнөөдрийг хүртэл Британийн Иргэдийн Төлөөлөгчдийн Танхимын спикер дахин сонгуульд өрсөлдөөд ялагдсан тохиолдол байхгүй байна. Харин идэвхтэй үзэл сурталжсан³¹⁷ (партизанлаг) улс төрийн амьдралаа золиосолсны нөхөн олговор болгож спикерийг албан тушаалаасаа буумагц нь тэтгэвэртэй байхаар Лордын Танхимд томилдог.

Хэрэв спикерээр сонгогдсон бол улс төрийн намаас татгалзах бөгөөд уг албан тушаалаас буусны дараа ч гэсэн улс төрөөс ангид байна. Спикер нь ерөнхий сонгуульд нэр дэвших ба улс төрийн гол намууд нэр дэвшүүлж түүнтэй өрсөлдөхгүй байх заншилтай. Үүнд түүний анхлан парламентын гишүүнээр сонгогдсон нам ч бас хамаарна. Сонгуулийн үеэр спикер нь аливаа улс төрийн асуудлаар сурталчилгаа хийхгүй. Харин спикер нь парламентын гишүүний хувьд сонгогчийн өмнө бусад гишүүний нэгэн адил үүрэг хариуцлага хүлээнэ.³¹⁸

³¹³ independence - *англиар*

³¹⁴ impartiality - *англиар*

³¹⁵ non-partisan - *англиар*

³¹⁶ renounces - *англиар*

³¹⁷ partisan - *англиар*

³¹⁸ Нэгдсэн Вант Улсын Нийтийн Танхим - House of Commons

<https://www.parliament.uk/documents/commons-information-office/Speaker.pdf>

1.2. Канад Улс

Британи болон Канадын спикерийн түүхэн нөхцөл болон зан байдал³¹⁹ эрс ялгаатай юм. Канадад эзэн хаан болон Сенат, Төлөөлөгчдийн Танхимын харилцааны асуудлыг Холбооны Улс байгуулагдаж байх үед тодорхойлсон байдаг. Иймээс Канадын спикер нь Британид хэдэн зуун жил үргэлжилсэн шиг эрх мэдлийн төлөөх үндсэн хуулийн маргаанд холбогдож байгаагүй. 1867 онд баталсан Үндсэн хуулинд спикерийн томилгоо болон үүргийг тодорхой зааж өгсөн байдаг. Түүнээс гадна улс төрийн намууд болон Засгийн эрх барьж буй нам нь Канадын парламентын салшгүй хэсэг байдаг.

Британиас ялгаатай нь, Канадын спикерийн алба хаших хугацааг нэг буюу хоёр парламентаар хязгаарласан байдаг. Гэвч үргэлжлүүлэн хашуулах асуудал парламентад байнга босож ирдэг. Нийт 30 гаруй спикерийн 3 нь л хоёроос олон удаа спикерээр ажилласан байдаг (спикер Lemieux (1922-30) болон спикер Lamoueix (1966-74), спикер Milliken 2001 онд анх сонгогдсон).

Спикер нь үргэлж Засгийн эрх барьж буй намын гишүүдийн дундаас сонгогдох бөгөөд үзэл сурталжсан улс төрийн үйл ажиллагаанаас түтгэлздэг³²⁰, намаас бүрмөсөн гардаггүй. Дахин сонгуульд өрсөлдөж буй спикер нь үзэл сурталжсан мэдэгдэл хийхээс аль болох зайлсхийх шаардлагатай байдаг. Учир нь ирээдүйд түүний хүлээн зөвшөөрөгдөх, үнэнч шударга байдалд эргэлзээ төрж болзошгүй гэж үздэг.

1.3. Бүгд Найрамдах Солонгос Улс

Тус улсын Үндэсний Ассамблейн хуулийн³²¹ “Үндэсний Ассамблейн бүрэлдэхүүн болон зардал” гэсэн 3 дугаар бүлэгт Үндэсний Ассамблейн дарга нь уг албан тушаалд сонгогдон ажиллах хугацаандаа намын гишүүнчлэлээсээ татгалзахаар хуульчилсан байна.

БНСУ-ын Үндэсний Ассамблейн хуулиас

20-2 дугаар зүйл. (Үндэсний Ассамблейн дарга намын гишүүн байхыг хориглох)

1/ Үндэсний Ассамблейн гишүүн нь Үндэсний Ассамблейн даргаар сонгогдон ажиллах хугацаандаа намын гишүүнчлэлээсээ татгалзах шаардлагатай.

2/ 1 дүгээр хэсэгт заасны дагуу намын гишүүнчлэлээсээ татгалзсан Үндэсний Ассамблейн дарга нь бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болоход буцаад намын гишүүнчлэлээ сэргээх эрхтэй.

1.4. Бүгд Найрамдах Турк Улс³²²

Турк Улсын Үндсэн хууль 94 дүгээр зүйлд зааснаар “Турк Улсын Үндэсний Ассамблейн дарга, дэд дарга нар нь Үндэсний Ассамблейн дотор болон гадна явагдаж буй өөрийн харьяалагддаг улс төрийн нам болон намын бүлгийн аливаа үйл ажиллагаа хийгээд албан тушаалын чиг үүрэгт өөрөөр заагаагүй тохиолдолд парламентын хэлэлцүүлэгт оролцохгүй. Түүнчлэн дарга болон дэд дарга нь өөрийн даргалж буй чуулганы хуралдаанд санал өгөх эрхгүй” байдаг байна.

³¹⁹ character - *англиар*

³²⁰ eschews - *англиар*

³²¹ National Assembly Act https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=44198&lang=ENG

³²² https://www.constituteproject.org/constitution/Turkey_2017?lang=en

1.5. Парламентын гишүүн намаас гарсантай холбогдох асуудал³²³

Сонгуулийн мэдлэгийн сүлжээ (ACE Topic Areas) төслийн судалгаанаас үзэхэд парламентын гишүүн нь нэр дэвшүүлсэн намаасаа гарсан бол бие даасан (хараат бус) парламентын гишүүн болж парламентдаа үлдэхийг хориглодог 18 улс орон байна. Үүнд: Бутан, Гайана, Гана, Замби, Зимбабве, Кабо-Верде, Казахстан, Камбож, Камерун, Кени, Киргиз, Малави, Намиби, Нигер, Сейшелийн Арлууд, Сьерра Леон, Тайланд болон Энэтхэг. Энэ тохиолдолд нөхөн сонгууль явуулах шаардлагатай болдог.

Канадын Парламентад энэ тухай асуудлаар хуулийн төсөл хэлэлцэгдэж байгаа тухай мэдээлэл байна.

Энэтхэгт халдашгүй байдлын тухай хуулийг нэлээн “цоорхойтой” гэж үздэг. Учир нь парламентын гишүүнийг эргүүлэн татах талаарх шийдвэрийг спикер гаргадаг бөгөөд тэр нь улс төрийн нөлөөнд автаж болзошгүй юм.

Шведэд олон нийтийн дунд явуулсан судалгаанаас үзэхэд, намаас гарсан гишүүн бие даагч болон парламентдаа үлдэх асуудлыг олон нийт хүлээн зөвшөөрөхгүй, үл нийцэх гэж үзсэн байна.

Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага (Organization for Security and Cooperation in Europe, OSCE)-ын тогтоосон стандартын дагуу парламентын суудлын мандат эзэмшигч нь хувь хүн байдаг. Хэрэв намаас гарсантай холбогдуулан суудлыг нь авах бол заавал “албан ёсны шүүх буюу хуулинд тусгасан бусад хянан шүүх процессын замаар” хийх ёстой байдаг.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

³²³ ACE (Сонгуулийн мэдлэгийн сүлжээ)-Төсөл: Сонгогдсон парламентын гишүүн намаас гарсан бол бие даагч болон үлдэж эс болох-ACE Electoral Knowledge Network: Elected Member of Parliament not allowed to stay on as independent MP after leaving party http://aceproject.org/electoral-advice/archive/questions/replies/576224281/mobile_conversation_view

Хоёр. ДЭЛХИЙН ПАРЛАМЕНТУУДЫН СПИКЕРИЙН БҮРЭН ЭРХИЙН ХУГАЦАА

Парламентын спикерийн бүрэн эрхийн хугацааг дэлхийн 144 улсын парламентын нийт 184 танхимуудыг судлан үзлээ. Парламентын спикерүүдын сонгогдон ажиллах хамгийн бага хугацаа нь 6 сар, хамгийн их нь 6 жил байна. (Хүснэгт 2.)

Хүснэгт 2. Улс орнуудын парламентын спикерийн бүрэн эрхийн хугацаа

Спикерийн бүрэн эрхийн хугацаа	Улсын тоо	Танхимын тоо	Улсын нэр
6 сарын хугацаанд	2	2	Австри, Сан Марино
1 жилийн хугацаанд	26	31	Аргентин, Бельги, Боливи, Гаити, Гватемал, Герман, Дани, Иран, Исланд, Йордан, Камерун, Колумби, Коста-Рика, Люксембург, Мексик, Монако, Норвег, Панама, Парагвай, Перу, Сири, Уругвай, Финланд, Чили, Швейцар, Эстони
2 жилийн хугацаанд	6	8	АНУ, Бразил, Доминиканы БНУ, Никарагуа, Солонгос (БНСУ), Эквадор
2.5 жилийн хугацаанд	4	4	Марокко, Парагвай, Словени, Турк
3 жилийн хугацаанд	7	9	Австрали, Малайз, Науру, Пакистан, Филиппин, Франц, Шинэ Зеланд
4 жилийн хугацаанд	37	43	Андорра, Арабын Нэгдсэн Эмират Улс, Аргентин, Бахрейн, Бенин, Болгар, Вануату, Гана, Герман, Грек, Израил, Кибати, Кувейт, Ливан, Македон, Литва, Лихтенштейн, Маршаллын Арлууд, Монгол, Монтенегро, Унгар, Хорват, Чад, Чех, Нидерланд, Нигер, Палау, Польш, Португал, Румын, Словак, Словени, Соломоны Арлууд, Испани, Тувалу, Швед, Япон
5 жилийн хугацаанд	69	82	Австри, Азербайжан, Алжир, Антигуа ба Барбуда, Армени, Бангладеш, Барбадос, Бахам, Белиз, БНХАУ, Ботсван, Буркино Фасо, Бурунди, Бутан, Вьетнам, Габон, Гайана, Гамби, Гвиней, Гренада, Доминик, Жибути, Замби, Зимбабве, Индонез, Ирланд, Итали, Их Британи, Кабо-Верде, Камбож, Кени, Кипр, Коморос, Конго, Конго (БНАКУ), Куба, Лаос, Лесото, Мавритани, Малави, Малайз, Мали, Мальта, Молдав, Намиби, Нигер, Өмнөд Африк, Папуа Шинэ Гвиней, Руанда, Самоа, Свазиланд, Сейшелийн Арлууд, Сенегал, Сент Люсиа, Сент-Киттс ба Невис, Сингапур, Солонгос (БНАСАУ), Тажикистан, Того, Тринидад ба Тобаго, Туркменистан, Уганда, Украин, Уругвай, Франц, Экваторын Гвиней, Энэтхэг, Этиоп, Ямайка
6 жилийн хугацаанд	5	5	Габон, Намиби, ОХУ, Шри Ланка, Япон


Эдгээр танхимуудаас спикер нь 5 жилээр сонгогддог - 82 танхим (45%), 4 жилээр сонгогддог - 43 танхим (23%), 1 жилээр сонгогддог – 31 танхим (17%), 3 жилээр сонгогддог - 9 танхим (5%), 2 жилээр сонгогддог - 8 танхим (4%), 6 жилээр сонгогддог -

5 танхим (3%), хагас жилээр сонгогддог - 2 танхим (1%) байна. (Зураг 1.)



Австри, Сан Марино зэрэг улсын парламентын спикерийн бүрэн эрхийн хугацаа нь **хагас жил** байна. Сан Марино Улсын Ерөнхий Зөвлөлийн бүрэн эрхийн хугацаа 5 жил байна. Харин Австри Улсын Холбооны Зөвлөлийн 64 гишүүдийг муж улсуудын Парламент (Landtag)-аас 4-6 жилийн хугацаатай сонгоно. Холбооны Зөвлөлийн спикерийг мөн муж улсуудын Парламентаас сонгох ба муж улсуудын төлөөлөл тус бүр 6 сарын хугацаагаар ээлжлэн энэ албан тушаалд сонгогдоно.³²⁴


Спикер нь **1 жилийн хугацаанд** сонгогдон ажилладаг 26 улсын парламентын нийт 31 танхим байна. Эдгээр танхимуудаас 15 (48%) танхимын бүрэн эрхийн хугацаа 4 жил, 11 (35%) танхимынх - 5 жил, 2 (6%) танхимынх - 6 жил, 1 (3%) танхимынх - 8 жил тус тус байна. Герман, Швейцар зэрэг холбооны улсын 2 танхимын гишүүд нь муж улсуудаас сонгогдох учир гишүүдийн бүрэн эрхийн хугацаа муж улсуудаас хамаарч өөр өөр байна. (Зураг 2.)



Спикерийг **2 жилийн хугацаанд** сонгодог 6 улсын парламентын 8 танхим байна. Эдгээрээс 5 (63%) танхимын бүрэн эрхийн хугацаа 4 жил, 2 (13%) танхимынх - 5 жил байна. АНУ-ын Төлөөлөгчдийн танхимын бүрэн эрхийн хугацаа нь 2 жил бол Бразилийн Холбооны Сенатынх 8 жил байна. (Зураг 3.)

³²⁴ Дэлхийн улс орнуудын парламент (Хураангуй лавлах). УИХ-ын Тамгын газрын Судалгааны төв. УБ., 2010. 550 дахь тал.

**Зураг 3. Спикерийн бүрэн эрхийн хугацаа 2 жил байдаг улсуудын
Парламентын танхимын бүрэн эрхийн хугацаа**



Спикер нь **2.5 жилийн хугацаанд** сонгогддог 4 улсын парламентын 4 танхим байх бөгөөд тэдгээрийн бүрэн эрхийн хугацаа бүгд 5 жил байна.

7 улсын парламентын 9 танхимын спикерийг **3 жилийн хугацаанд** сонгодог байна. Австрали, Пакистан, Филиппин, Франц зэрэг улсын Сенатуудын бүрэн эрхийн хугацаа бүгд 6 жил, харин Малайзын Сенатын бүрэн эрхийн тодорхой хугацаа байхгүй. Австрали, Филиппины парламентын доод танхим, мөн Науру, Шинэ Зеландын парламентын 2 танхим (нийт 4 танхим)-ын бүрэн эрхийн хугацаа тус бүр 3 жил байна.

Монгол Улстай ижил парламентынхаа бүрэн эрхийн **4 жилийн хугацаанд** спикер нь сонгогдон ажилладаг 36 улсын парламентын 42 танхим байна. Энд Аргентины Сенат хамрагдах бөгөөд энэхүү танхимын бүрэн эрхийн хугацаа 6 жил бөгөөд Дэд ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаатай давхцдаг байна.

Спикер нь парламентынхаа бүрэн эрхийн **5 жилийн хугацаанд** сонгогддог 68 улсын парламентын 81 танхим байна. Үүнээс гадна Угандагийн парламентын спикер нь энэ хугацаанд сонгогддог боловч парламентынх нь бүрэн эрхийн хугацаа 7 жил байна. Их Британийн Лордуудын Танхимын бүрэн эрхийн тодорхой хугацаа байхгүй.

Мөн спикерийг парламентынхаа бүрэн эрхийн **6 жилийн хугацаанд** сонгогддог 4 улсын парламентын 4 танхим байна. Энд ОХУ-ын Холбооны Зөвлөл хамаарах бөгөөд түүний бүрэн эрхийн тодорхой хугацаа байхгүй.

Гурав. ПАРЛАМЕНТЫН СПИКЕРИЙН БҮРЭН ЭРХТЭЙ ХОЛБООТОЙ ЗАРИМ ЗОХИЦУУЛАЛТ

Судалгааны энэ хэсэгт парламентын спикерийн бүрэн эрхийн хугацаа 1-2.5 жилийн хугацаатай 19 улсын парламентын 27 танхимын спикерийн дараах бүрэн эрхийг авч үзсэн. Үүнд:

1. парламентын үйл ажиллагааг зохион байгуулах бүрэн эрх;
2. онцгой бүрэн эрх;
3. хууль санаачилах, үг хэлэх, санал өгөх болон бусад бүрэн эрх зэрэг болно.

Судалгаанд хамрагдсан орнуудын парламентын спикерүүдын дээр дурдсан бүрэн эрхүүд ерөнхийдөө нийтлэг (Хүснэгт 3, 4, 5) байх тул энд зарим онцлох эрх, үүргийг нь орууллаа.

Судалгаанд Олон улсын парламентын Холбоо (Inter Parliamentary Union, IPU)-ны цахим хуудасны Дэлхийн улс орнуудын парламентын мэдээллийг (2018 оны 9 дүгээр сарын байдлаар) эх сурвалж болгон ашиглав.

3.1. Парламентын үйл ажиллагааг зохион байгуулах бүрэн эрх

Энд спикерийн ерөнхий эрх, үүрэг хамаарна. (Хүснэгт 3.) Үүнд:

- 1) чуулган зарлан хуралдуулах эрхийн хүрээнд:
 - Парагвайн (Депутатуудын Танхим), Доминиканы БНУ (Сенат, Депутатуудын Танхим)-ын спикерийн хувьд онцгой чуулган зарлан хуралдуулах;
- 2) хэлэлцэх асуудлыг тогтоох;
- 3) хуулийн төслийн бүрдүүлбэрийг хянах;
- 4) хуралдаан удирдан зохион байгуулах, үг хэлэх хугацааг тогтоох;
- 5) баримт бичгүүдийг судлуулахаар холбогдох хороонд шилжүүлэх эрхийн хүрээнд:
 - Данийн парламентад спикерээс хороонд шилжүүлсэн асуудал нь тухайн хорооны харьяалах асуудал биш бол тухайн баримт бичгийг өөр хороонд шилжүүлж болно;
- 6) мөрдөн шалгах болон бусад хороог байгуулах тухай саналыг хянах, энэ талаар шийдвэр гаргах;
- 7) хорооны даргыг томилох.

3.2. Онцгой бүрэн эрх

Олон улсын парламентын холбооны үзэж байгаагаар спикерийн онцгой бүрэн эрхэд дараах бүрэн эрхүүд хамаарна. (Хүснэгт 4) Үүнд:

- 1) нэгдсэн төсвийн хэлэлцүүлэгт оролцох /санал өгөх эрхийн хүрээнд:
 - Эстонийн парламентын дарга нь улсын төсөв батлахад бусад гишүүдийн адил эрхтэй;
 - Чилийн парламентын 2 танхимын дарга нь нэгдсэн улсын Ерөнхийлөгчид төсвийн талаар санал өгөх эрхтэй;
- 2) танхимын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;
- 3) танхимын төсөвт санал өгөх / хянах / батлах;
- 4) гадаад хэрэг / батлан хамгаалах бодлогод хяналт тавих эрхийн хүрээнд:

- Чилийн Сенатын дарга нь Үндэсний аюулгүй байдлын гишүүний хувьд батлан хамгаалах болон гадаад хэргийн асуудлыг хариуцах онцгой үүрэгтэй;
- 5) гадаад орны парламенттай харилцах;
 - 6) парламентын танхимд эмх замбараагүй байдал үүсвэл цагдаа дуудах;
 - 7) парламентын ажлын албаны дарга (Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга)-ыг санал болгох / томилох, чөлөөлөх;
 - 8) төрийн албан хаагч болон ажлын алба (Тамгын газар)-ын бусад ажилтныг албан тушаалд томилох, чөлөөлөх.

3.3.Хууль санаачлах, үг хэлэх, санал өгөх болон бусад бүрэн эрх

Парламентын спикерүүд нь хууль тогтоох үйл ажиллагааны дараах нийтлэг эрхүүдийг (Хүснэгт 5) хэрэгжүүлэх боловч зарим талаараа бусад гишүүдээс ялгаатай байна. Үүнд:

- 1) хуулийн төсөл санаачилах / өргөн барих эрхийн хүрээнд:
 - Данийн парламентын спикер нь парламентын онцгой нөхцөл байдлаас бусад тохиолдолд хуулийн төсөл санаачлахгүй;
- 2) үг хэлэх эрхийн хүрээнд:
 - Норвегийн парламент, Швейцарын парламентын 2 танхимын спикерүүд үг хэлэх үед түүний орлогч буюу Дэд Ерөнхийлөгч нь хуралдаан даргална;
 - Доминиканы парламентын 2 танхимын спикерүүд хууль тогтоомжийн хэлэлцүүлгийн үед суудлаа орхихгүй байх үүрэгтэй;
- 3) хэлэлцэж буй асуудлын талаар тайлбар хийх (эсхүл хэлэлцүүлгийг зогсоох) эрхийн хүрээнд:
 - Данийн парламентын спикер нь хуулийн төслийн хэлэлцүүлэг удаан хугацаагаар үргэлжлэх бол түүнийг зогсоох эрхтэй;
- 4) санал хураалтад оролцох эрхийн хүрээнд:
 - Бразилийн парламентын 2 танхимын спикер нь зөвхөн нууц санал хураалтанд оролцох эрхтэй;
 - Швейцарийн парламентын 2 танхимын спикер нь зөвхөн санал тэнцсэн тохиолдолд санал хураалтад оролцоно;
- 5) парламентын хяналтын үйл ажиллагаанд оролцох;
- 6) Үндсэн хуулийн хэрэгжилтийн баталгааг хангах эрхийн хүрээнд:
 - Колумбийн парламентын 2 танхимын спикер нь хууль тогтоомж нь Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх талаар саналаа илэрхийлнэ;
 - Чилийн парламентын 2 танхимын спикер нь хуулийн төсөл Үндсэн хуульд нийцэхгүй байгааг зарласнаар Үндсэн хуулийн баталгааг хангах;
 - Аргентиний парламентын 2 танхимын спикер нь хуулийн хэрэгжилтийг хянан шалгах замаар Үндсэн хуулийн баталгааг хангах;
- 7) хууль ёсчлох /батламжлуулахаар Улсын Ерөнхийлөгчид илгээх.

Эдгээрээс гадна Финланд, Никарагуа зэрэг улсын Парламентын спикер нь онцгой нөхцөл байдал буюу парламентыг тараах тохиолдолд заавал зөвлөлдөх үүрэгтэй аж.

Хүснэгт 3. Спикерийн парламентын үйл ажиллагааг зохион байгуулах бүрэн эрх

	Улсын нэр (Танхимын нэр)	Чуулган зарлан хуралдуулах	Хэлэлцэх асуудлыг ТОГТООХ	Хуулийн төслийн бүрдүүлбэрийг хянах	Хуралдаан удирдан зохион байгуулах, үг хэлэх хугацааг ТОГТООХ	Баримт бичгүүдийг судлуулахаар холбогдох хороонд шилжүүлэх	Мөрдөн шалгах болон бусад хороог байгуулах тухай саналыг хянах, энэ талаар шийдвэр гаргах	Хорооны даргыг томилгох
1.	Аргентин (Сенат)							
2.	Аргентин (Депутатуудын Танхим)							
3.	Бельги (Сенат)							
4.	Бельги (Төлөөлөгчийн Танхим)							
5.	Бразил (Холбооны Сенат)							
6.	Бразил (Депутатуудын Танхим)							
7.	Дани (Парламент)							
8.	Доминиканы БНУ (Сенат)							
9.	Доминиканы БНУ (Депутатуудын Танхим)							
10.	Исланд (Парламент)							
11.	Колумби (Сенат)							
12.	Колумби (Төлөөлөгчдийн Танхим)							
13.	Марокко (Төлөөлөгчдийн Танхим)							
14.	Мексик (Сенат)							
15.	Никарагуа (Үндэсний Ассамблей)							
16.	Норвег (Парламент)							
17.	Парагвай (Сенат)							
18.	Парагвай (Депутатуудын Танхим)							
19.	Солонгос (БНСУ) (Үндэсний Ассамблей)							
20.	Турк (Үндэсний Ассамблей)							
21.	Финланд (Парламент)							
22.	Чили (Сенат)							
23.	Чили (Депутатуудын Танхим)							
24.	Швейцар (Муж улсуудын Зөвлөл)							
25.	Швейцар (Үндэсний Зөвлөл)							
26.	Эквадор (Үндэсний Ассамблей)							
27.	Эстони (Парламент)							

Хүснэгт 4. Спикерийн онцгой бүрэн эрх

	Улсын нэр (Танхимын нэр)	Улсын төсвийн хэлэлцүүлэгт оролцох / санал өгөх	Танхимын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах	Танхимын төсөвт санал өгөх / хянах / батлах	Гадаад хэрэг / батлан хамгаалах бодлогод хяналт тавих	Гадаад орны парламенттай харилцах	Парламентын танхимд эмх замбараагүй байдал үүсвэл цагдаа дуудах	Парламентын ажлын албаны даргыг санал болгох / томилох, чөлөөлөх	Төрийн албан хаагч болон ажлын албаны бусад ажилтныг албан тушаалд томилох, чөлөөлөх
1.	Аргентин (Сенат)								
2.	(Депутатуудын Танхим)								
3.	Бельги (Сенат)								
4.	(Төлөөлөгчийн Танхим)								
5.	Бразил (Холбооны Сенат)								
6.	(Депутатуудын Танхим)								
7.	Дани (Парламент)								
8.	Доминиканы БНУ (Сенат)								
9.	(Депутатуудын Танхим)								
10.	Исланд (Парламент)								
11.	Колумби (Сенат)								
12.	(Төлөөлөгчдийн Танхим)								
13.	Марокко (Төлөөлөгчдийн Танхим)								
14.	Мексик (Сенат)								
15.	Никарагуа (Үндэсний Ассамблей)								
16.	Норвег (Парламент)								
17.	Парагвай (Сенат)								
18.	(Депутатуудын Танхим)								
19.	Солонгос (БНСУ) (Үндэсний Ассамблей)								
20.	Турк (Үндэсний Ассамблей)								
21.	Финланд (Парламент)								
22.	Чили (Сенат)								
23.	(Депутатуудын Танхим)								
24.	Швейцар (Муж улсуудын Зөвлөл)								
25.	(Үндэсний Зөвлөл)								
26.	Эквадор (Үндэсний Ассамблей)								
27.	Эстони (Парламент)								

Хүснэгт 5. Спикерийн хууль санаачлах, үг хэлэх, санал өгөх болон бусад эрх

	Улсын нэр (Танхимын нэр)	Хуулийн төсөл санаачлах / өргөн барих	Үг хэлэх	Хэлэлцэж буй асуудлын талаар тайлбар хийх	Санал хураалтад оролцох	Парламентын хяналтын үйл ажиллагаанд оролцох	Үндсэн хуулийн хэрэгжилтийн баталгааг хангах	Хууль ёсчлох / батламжуула- хаар Улсын Ерөнхийлөгчид илгээх
1.	Аргентин (Сенат)							
2.	(Депутатуудын Танхим)							
3.	Бельги (Сенат)							
4.	(Төлөөлөгчийн Танхим)							
5.	Бразил (Холбооны Сенат)							
6.	(Депутатуудын Танхим)							
7.	Дани (Парламент)							
8.	Доминиканы БНУ (Сенат)							
9.	(Депутатуудын Танхим)							
10.	Исланд (Парламент)							
11.	Колумби (Сенат)							
12.	(Төлөөлөгчдийн Танхим)							
13.	Марокко (Төлөөлөгчдийн Танхим)							
14.	Мексик (Сенат)							
15.	Никарагуа (Үндэсний Ассамблей)							
16.	Норвег (Парламент)							
17.	Парагвай (Сенат)							
18.	(Депутатуудын Танхим)							
19.	Солонгос (БНСУ) (Үндэсний Ассамблей)							
20.	Турк (Үндэсний Ассамблей)							
21.	Финланд (Парламент)							
22.	Чили (Сенат)							
23.	(Депутатуудын Танхим)							
24.	Швейцар (Муж улсуудын Зөвлөл)							
25.	(Үндэсний Зөвлөл)							
26.	Эквадор (Үндэсний Ассамблей)							
27.	Эстони (Парламент)							

Улс орнуудын парламентын спикерийн бүрэн эрхийн хугацаа³²⁵

Д/д	Улс орны нэр	Танхимын тоо	Танхимын нэр (дээд/доод)	Танхимын бүрэн эрхийн хугацаа (жил)	Тайлбар
6 сарын хугацаанд					
1.	Австри	2	Холбооны Зөвлөл (доод)	4-6	Гишүүдийг мужийн парламентаас 4-6 жилийн хугацаатай сонгоно.
2.	Сан Марино	1	Ерөнхий Зөвлөл	5	
1 жилийн хугацаанд					
3.	Аргентин	2	Депутатуудын Танхим (доод)	4	
4.	Бельги	2	Сенат (дээд)	5	Нэг чуулганы хугацаанд "-"
			Төлөөлөгчдийн Танхим (доод)	5	
5.	Боливи	2	Сенаторуудын Танхим (дээд)	5	
			Депутатуудын Танхим (доод)	5	
6.	Гаити	2	Сенат (дээд)	6	
7.	Гватемал	1	БНУ-ын Конгресс	4	Нэг чуулганы хугацаанд
8.	Герман	2	Бундесрат (дээд)	-	Гишүүдийг муж (Land)-ийн Засгийн газруудаас сонгоно. Спикерийг нэг чуулганы хугацаанд томилно.
9.	Дани	1	Парламент	4	Нэг чуулганы хугацаанд
10.	Иран	1	Ираны Исламын Парламент	4	
11.	Исланд	1	Парламент	4	Нэг чуулганы хугацаанд
12.	Йордан	2	Төлөөлөгчдийн Танхим (доод)	4	
13.	Камерун	2	Үндэсний Ассамблей (доод)	5	
14.	Колумби	2	Сенат (дээд)	4	Нэг чуулганы хугацаанд "-"
			Төлөөлөгчдийн Танхим (доод)	4	
15.	Коста-Рика	1	Хууль тогтоох Ассамблей	4	4-р сарын 30-ны өдөр дуусна.
16.	Люксембург	1	Депутатуудын Танхим	5	10-р сарын 2-ны өдөр эхлэнэ.
17.	Мексик	2	Сенат (дээд)	6	
18.	Монако	1	Үндэсний Зөвлөл	5	
19.	Норвег	1	Парламент	4	
20.	Панама	1	Үндэсний Ассамблей	5	
21.	Парагвай	2	Сенат (дээд)	5	6-р сарын 30-ны өдөр дуусна.
22.	Перу	1	БНУ-ын Конгресс	5	7-р сарын 26-ны өдөр дуусна.
23.	Сири	1	Ардын Хурал	4	
24.	Уругвай	2	Төлөөлөгчдийн Танхим (доод)	5	
25.	Финланд	1	Парламент	4	Шинэ Парламентын анхны хуралдаанаар Парламентын даргыг нэг жилийн хугацаатайгаар сонгох ба жил бүрийн 2-р сард Парламентын ээлжит чуулган эхлэхээс 1 өдрийн өмнө Парламентын даргыг шинээр сонгоно.
26.	Чили	2	Сенат (дээд)	8	Гишүүдийн тэн хагас нь 4 жил тутамд шинэчлэгдэнэ.
			Депутатуудын Танхим (доод)	4	
27.	Швейцар	2	Үндэсний Зөвлөл (дээд)	4	Гишүүдийн бүрэн эрхийн хугацааг мужууд (Canton)-ын хуулиар
			Холбооны Ассамблей (доод)	-	

³²⁵ Дэлхийн улс орнуудын парламент (Хураануй лавлах). УИХ-ын Тамгын газрын Судалгааны төв. УБ., 2010.
Inter-Parliamentary Union - <http://archive.ipu.org/parline-e/parlinesearch.asp>

					ТОГТООНО.
28.	Эстони	1	Парламент	4	
2 жилийн хугацаанд					
29.	АНУ	2	Төлөөлөгчдийн Танхим (доод)	2	Бүрэн эрхийн хугацаанд
30.	Бразил	2	Холбооны Сенат (дээд) Депутатуудын Танхим (доод)	8 4	
31.	Доминиканы БНУ	2	Сенат (дээд) Депутатуудын Танхим (доод)	4 4	
32.	Никарагуа	1	Үндэсний Ассамблей	5	
33.	Солонгос (БНСУ)	1	Үндэсний Ассамблей	4	Бүрэн эрхийн хугацааны хагаст
34.	Эквадор	1	Үндэсний Ассамблей	4	
2.5 жилийн хугацаанд					
35.	Марокко	2	Төлөөлөгчдийн Танхим (доод)	5	
36.	Парагвай	2	Депутатуудын Танхим (доод)	5	
37.	Словени	2	Үндэсний Зөвлөл (дээд)	5	Бүрэн эрхийн хугацааны хагаст
38.	Турк	1	Үндэсний Ассамблей	5	
3 жилийн хугацаанд					
39.	Австрали	2	Сенат (дээд) Төлөөлөгчдийн Танхим (доод)	6 3	Бүрэн эрхийн хугацаанд
40.	Малайз	2	Сенат (дээд)	-	Тодорхой хугацаа байхгүй
41.	Науру	1	Парламент	3	Бүрэн эрхийн хугацаанд
42.	Пакистан	2	Сенат (дээд)	6	
43.	Филиппин	2	Сенат (дээд) Төлөөлөгчдийн Танхим (доод)	6 3	Бүрэн эрхийн хугацаанд
44.	Франц	2	Сенат (дээд)	6	
45.	Шинэ Зеланд	1	Төлөөлөгчдийн Танхим	3	Бүрэн эрхийн хугацаанд
4 жилийн хугацаанд					
46.	Андорра	1	Ерөнхий Зөвлөл	4	Бүрэн эрхийн хугацаанд
47.	Арабын Нэгдсэн Эмират Улс	1	Холбооны Үндэсний Зөвлөл	4	-
48.	Аргентин	2	Сенат (дээд)	6	Дэд ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаатай давхцдаг.
49.	Бахрейн	2	Зөвлөх Зөвлөл (дээд)	4	Бүрэн эрхийн хугацаанд
50.	Бенин	1	Үндэсний Ассамблей	4	-
51.	Болгар	1	Үндэсний Ассамблей	4	-
52.	Вануату	1	Парламент	4	-
53.	Гана	1	Парламент	4	-
54.	Герман	2	Бундестаг (доод)	4	-
55.	Грек	1	Парламент	4	-
56.	Израил	1	Парламент	4	-
57.	Испани	2	Сенат (дээд) Төлөөлөгчдийн Конгресс (доод)	4 4	-
58.	Кибати	1	Ассамблей	4	-
59.	Кувейт	1	Үндэсний Ассамблей	4	-
60.	Ливан	1	Үндэсний Ассамблей	4	-
61.	Литва	1	Парламент	4	-
62.	Лихтенштейн	1	Диет	4	-
63.	Македон	1	БНУ-ын Ассамблей	4	-
64.	Маршаллын Арлууд	1	Парламент	4	-
65.	Монгол	1	Улсын Их Хурал	4	-
66.	Монтенегро	1	Парламент	4	-
67.	Нигер	2	Сенат (дээд) Төлөөлөгчдийн Танхим (доод)	4 4	-
68.	Нидерланд	2	Сенат (дээд) Төлөөлөгчдийн Танхим (доод)	4 4	-
69.	Палау	2	Сенат (дээд) Төлөөлөгчдийн Танхим (доод)	4 4	-

70.	Польш	2	Сенат (дээд)	4	--
			Сежм (доод)	4	--
71.	Португал	1	БНУ-ын Ассамблей	4	--
72.	Румын	2	Депутатуудын Танхим	4	--
			Сенат	4	--
73.	Словак	1	Үндэсний Зөвлөл	4	--
74.	Словени	2	Үндэсний Ассамблей (доод)	4	--
75.	Соломоны Арлууд	1	Үндэсний Парламент	4	--
76.	Тувалу	1	Парламент	4	--
77.	Унгар	1	Үндэсний Ассамблей	4	--
78.	Хорват	1	Парламент	4	--
79.	Чад	1	Үндэсний Ассамблей	4	--
80.	Чех	2	Депутатуудын Танхим (доод)	4	--
81.	Швед	1	Парламент	4	--
82.	Япон	2	Төлөөлөгчдийн Танхим (дээд)	4	--
5 жилийн хугацаанд					
83.	Австри	2	Үндэсний Зөвлөл (дээд)	5	Бүрэн эрхийн хугацаанд
84.	Азербайжан	1	Үндэсний Ассамблей	5	--
85.	Алжир	2	Үндэсний Ардын Хурал (доод)	5	--
86.	Антигуа ба Барбуда	2	Сенат (дээд)	5	--
			Төлөөлөгчдийн Танхим (доод)	5	--
87.	Армени	1	Үндэсний Ассамблей	5	--
88.	Бангладеш	1	Парламент	5	--
89.	Барбадос	2	Сенат (дээд)	5	--
			Ассамблей (доод)	5	--
90.	Бахам	2	Ассамблей (доод)	5	--
91.	Белиз	2	Сенат (дээд)	5	--
			Төлөөлөгчдийн Танхим (доод)	5	--
92.	БНХАУ	1	Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Хурал	5	--
93.	Ботсван	1	Үндэсний Ассамблей	5	--
94.	Буркино Фасо	1	Үндэсний Ассамблей	5	--
95.	Бурунди	2	Сенат (дээд)	5	--
96.	Бутан	2	Үндэсний Зөвлөл (дээд)	5	--
97.	Вьетнам	1	Үндэсний Ассамблей	5	--
98.	Габон	2	Үндэсний Ассамблей (доод)	5	--
99.	Гайана	1	Үндэсний Ассамблей	5	--
100.	Гамби	1	Үндэсний Ассамблей	5	--
101.	Гвиней	1	Үндэсний Ассамблей	5	--
102.	Гренада	2	Сенат (дээд)	5	--
			Төлөөлөгчдийн Танхим (доод)	5	--
103.	Доминик	1	Ассамблей	5	--
104.	Жибути	1	Үндэсний Ассамблей	5	--
105.	Замби	1	Үндэсний Ассамблей	5	--
106.	Зимбабве	2	Үндэсний Ассамблей (доод)	5	--
107.	Индонез	1	Төлөөлөгчдийн Танхим	5	--
108.	Ирланд	2	Сенат (дээд)	5	--
			Төлөөлөгчдийн Танхим (доод)	5	--
109.	Итали	2	Сенат (дээд)	5	--
			Төлөөлөгчдийн Танхим (доод)	5	--
110.	Их Британи	2	Лордуудын Танхим (дээд)	-	Тодорхой хугацаа байхгүй
			Нийтийн Танхим (доод)	5	Бүрэн эрхийн хугацаанд
111.	Кабо-Верде	1	Үндэсний Ассамблей	5	--
112.	Камбож	2	Үндэсний Ассамблей (доод)	5	--
113.	Кени	2	Үндэсний Ассамблей (доод)	5	--
114.	Кипр	1	Төлөөлөгчдийн Танхим	5	--
115.	Коморос	1	Холбооны Ассамблей	5	--
116.	Конго	2	Үндэсний Ассамблей (доод)	5	--

117.	Конго (БНАКУ)	2	Сенат (дээд)	5	--
118.	Куба	1	Ардын Засгийн Үндэсний Ассамблей	5	--
119.	Лаос	1	Үндэсний Ассамблей	5	--
120.	Лесото	2	Сенат (дээд)	5	--
121.	Мавритани	1	Үндэсний Ассамблей	5	--
122.	Малави	1	Үндэсний Ассамблей	5	--
123.	Малайз	2	Төлөөлөгчдийн Танхим (доод)	5	--
124.	Мали	1	Үндэсний Ассамблей	5	--
125.	Мальта	1	Төлөөлөгчдийн Танхим	5	--
126.	Молдав	1	Парламент	5	--
127.	Намиби	2	Үндэсний Ассамблей (доод)	5	--
128.	Нигер	1	Үндэсний Ассамблей	5	--
129.	Өмнөд Африк	2	Мужуудын Үндэсний Зөвлөл (дээд)	5	--
			Үндэсний Ассамблей (доод)	5	--
130.	Папуа Шинэ Гвиней	1	Үндэсний Парламент	5	--
131.	Руанда	2	Депутатуудын Танхим (доод)	5	--
132.	Самоа	1	Хуль тогтоох Ассамблей	5	--
133.	Свазиланд	2	Ассамблей (доод)	5	--
134.	Сейшелийн Арлууд	1	Үндэсний Ассамблей	5	--
135.	Сенегал	1	Үндэсний Ассамблей	5	--
136.	Сент-Киттс ба Невис	1	Үндэсний Ассамблей	5	--
137.	Сент Люсиа	2	Сенат (дээд)	5	--
			Ассамблей (доод)	5	--
138.	Сингапур	1	Парламент	5	--
139.	Солонгос (БНАСАУ)	1	Ардын Их Хурал	5	--
140.	Тажикистан	2	Төлөөлөгчдийн Танхим (доод)	5	--
141.	Того	1	Үндэсний Ассамблей	5	--
142.	Тринидад ба Тобаго	2	Сенат (дээд)	5	--
			Төлөөлөгчдийн Танхим (доод)	5	--
143.	Туркменистан	1	Ассамблей	5	--
144.	Уганда	1	Парламент	7	--
145.	Украин	1	Парламент	5	--
146.	Уругвай	2	Сенат (дээд)	5	--
147.	Франц	2	Үндэсний Ассамблей	5	--
148.	Экваторын Гвиней	2	Депутатуудын Танхим (доод)	5	--
149.	Энэтхэг	2	Ардын Танхим (дээд)	5	--
			Муж улсуудын Зөвлөл (доод)	5	--
150.	Этиоп	2	Холбооны Танхим (дээд)	5	--
			Ардын Төлөөлөгчдийн Танхим (доод)	5	--
151.	Ямайка	2	Сенат (дээд)	5	--
			Төлөөлөгчдийн Танхим (доод)	5	--
6 жилийн хугацаанд					
152.	Габон	2	Сенат (дээд)	6	Бүрэн эрхийн хугацаанд
153.	Намиби	2	Үндэсний Зөвлөл (дээд)	6	--
154.	ОХУ	2	Холбооны Зөвлөл (дээд)	-	Тодорхой хугацаа байхгүй
155.	Шри Ланка	1	Парламент	6	Бүрэн эрхийн хугацаанд
156.	Япон	2	Зөвлөхүүдийн танхим (доод)	6	--

ПАРЛАМЕНТЫН ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАНЫГ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ҮНДСЭН ХУУЛЬ БОЛОН ХОЛБОГДОХ БУСАД ХУУЛЬ, ДҮРМЭЭР ЗОХИЦУУЛСАН БАЙДАЛ

(Лавлагаа, мэдээлэл)

Д.Халиун

АГУУЛГА

ПАРЛАМЕНТЫН ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАНЫ ТУХАЙ

Нэг. Парламентын ээлжит бус чуулганыг гадаадын зарим орны Үндсэн хуулиар зохицуулсан байдал

Хоёр. Парламентын ээлжит бус чуулганыг гадаадын зарим оронд холбогдох хууль, дүрмээр зохицуулсан байдал

1. ХБНГУ
2. БНСУ
3. ЯПОН
4. ЛАТВИ
5. БОЛГАР
6. СЕРБИ
7. УНГАР

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

ХАВСРАЛТ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ПАРЛАМЕНТЫН ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАНЫ ТУХАЙ

Чуулган нь парламентын үйл ажиллагааны зохион байгуулалтын хэлбэр болж тогтохын хувьд Үндсэн хуульт хаан засаг төлөвшиж эхэлсэн үеэс үүдэлтэй. Абсолют эрх мэдэл нь парламент буюу хууль тогтоох эрх мэдлийн өөрт нь тавих хяналт, нөлөөг хязгаарлах зорилгоор цаг хугацааны хүрээ тогтоож өгсөн байдаг бол парламентууд нь эсрэгээр абсолют эрх мэдлийн эрхийг хязгаарлахыг зорьсон байдаг. Ийнхүү дэлхийд парламентын үйл ажиллагааны зохион байгуулалтын хоёр хэлбэр дэлгэрсэн байдаг.

Нэгдүгээрт, парламент тодорхой, эсхүл хуульд заасан хугацаанд (Үндсэн хуулиар тогтоосон) хуралдах буюу ердийн буюу ээлжит чуулган, эсхүл шаардлага гарсан тохиолдолд ээлжит буюу тусгай чуулган хуралдах хэлбэрээр зохион байгуулагдана. Тухайлбал, Францын Үндсэн хуулийн 28 дугаар зүйлд Парламент нь хавар, намар тогтоосон хугацаанд жилд хоёр удаа хуралдана. Ерөнхий сайд, эсхүл Үндэсний Ассамблейн гишүүдийн олонхын хүсэлтээр тодорхой асуудал хэлэлцүүлэхээр ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулах ба тус чуулганыг Ерөнхийлөгчийн тусгай зарлиг, шийдвэрээр нээж, хаана. Австри, Их Британи, Итали, Япон зэрэг улсад парламент нь чуулган хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг.

Хоёрдугаарт, тогтмол үйл ажиллагаатай буюу Парламент нь завсарлага, чөлөөтэй байх хугацаагаа өөрөө тогтоох эрхтэй байна. Тухайлбал, Словакийн Үндсэн хуулийн 82 дугаар зүйлд “Үндэсний Зөвлөлийн чуулган тасралтгүй байна.”³²⁶ 82.3-т Үндэсний Зөвлөл чуулганыг завсарлуулахыг тогтоолоор шийдвэрлэх ба завсарлагааны хугацаа 4 сараас хэтрэхгүй байна. Завсарлагааны хугацаанд Үндэсний Зөвлөлийн дарга, дэд дарга болон хороодын үйл ажиллагаа хэвийн явагдана. Түүнчлэн, хоёр танхимтай парламентын хувьд танхимуудын үйл ажиллагааны зохион байгуулалтын хэлбэр нь ялгаатай байж болно. Тухайлбал, Австрийн Парламентын доод танхим Үндэсний Зөвлөл нь чуулган хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулдаг бол, дээд танхим Холбооны Зөвлөл нь тогтмол үйл ажиллагаатай байна.

Парламентын ээлжит бус чуулган³²⁷ - **extraordinary session** (мөн тусгай чуулган - **special session**) нь ээлжит чуулган (**ordinary session**)- аас гадуур хуралдах гол төлөв ээлжит чуулганаар, эсхүл тухайн жилд хэлэлцэхээр төлөвлөсөн боловч хэлэлцэж амжаагүй асуудал, үүнд төсвийн төсөл, төсөөлөл зэргийг хэлэлцэх зорилгоор зарлан хуралдуулна. Мөн ээлжит бус чуулганыг эдийн засгийн хямралын үед төсвийн зарлагуудыг бууруулах, холбогдох арга хэмжээ авах зорилгоор зарлан хуралдуулдаг. Зарим тохиолдолд ээлжит бус чуулганаар тодорхой асуудлыг хэлэлцэх, эсхүл (зарим улсад онцгой чуулган – **emergency session**) дайны буюу онц байдалд зарлахад хуралдуулна.³²⁸

³²⁶ The National Council of the Slovak Republic shall be continually in session.

<https://www.prezident.sk/upload-files/46422.pdf>

³²⁷ Парламент өөрийгөө зохион байгуулах арга зам, түүний дотор цагийн хуваариа хянах, шаардлагатай бол ээлжит чуулганаас гадуур хуралдаан зарлан дуудах боломжтой байх зэрэг нь парламентын бие даасан байдал буюу автономии байх эрхэд хамаарах асуудал юм. Парламентын Ерөнхий нарийн бичгийн дарга нарын холбоо (ПЕНХ)-ны 1998 оны илтгэлд бие даасан байдлыг “нэг талаас, гүйцэтгэх засаглалтай харилцах харилцаанд Ассамблей хараат бус бөгөөд захирагддаггүй байх, нөгөө талаас, ердийн хуулийн үйлчлэлээс өөрийгөө ядахдаа хэсэгчлэн чөлөөлж, оронд нь өөрийнхөө дүрэм журмыг мөрдөх” гэж тодорхойлжээ. Түүнд “бариагүй оронд парламентын бие даасан байдлын зарчмыг үндсэн хуульдэрх мэдлийн хуваарилалттай холбоотой хэсэгт албан ёсоор хүлээн зөвшөөрсөн байдаг” гэж тэмдэглэжээ. (Michel Couderc, ‘The principle of parliamentary autonomy’, Constitutional and Parliamentary Information, No. 176, 1998) Ардчилал ба парламент. Олон улсын парламентын холбоо. 2006 он.125 дахь тал.

³²⁸ https://www.senate.gov/artandhistory/history/common/generic/Feature_Homepage_Extraordinarysession.htm

Улс орнуудад ээлжит чуулганаас гадуур зарлан хуралдуулах чуулганыг “тусгай чуулган” (special session) болон “ээлжит бус чуулган” (extraordinary session) зэрэг нэр томъёогоор илэрхийлэн, харилцан орлуулж хэрэглэх нь түгээмэл байна.

Харин АНУ, Япон зэрэг зарим улсад special session, extraordinary session гэх нэр томъёог ялгаатай авч үзэж байна. Тухайлбал, АНУ-ын Үндсэн хуулийн 2 дугаар зүйлийн 3 дугаар хэсэгт заасны дагуу АНУ-ын Ерөнхийлөгч онцгой тохиолдолд хоёр Танхимын нэгдсэн буюу аль нэгнийх нь чуулганыг хуралдуулж болно гэж заасан. Дээрх байдлаар зарлан хуралдуулсан чуулганыг "extraordinary" буюу ээлжит бус чуулган гэж нэрлэнэ.

Харин АНУ-ын Сенат буюу Парламентын дээд танхимд “ээлжит бус чуулган”-ыг хоёр ялгаж үзэх ба special session буюу тусгай чуулган нь ээлжит чуулганаас гадуур буюу ердийн бус цаг хугацаанд зарлагдах чуулганыг хэлэх бол extraordinary session буюу ээлжит бус чуулган нь Ерөнхийлөгч үндсэн хуулиар олгосон эрхийн хүрээнд ээлжит бус чуулган зарлан хуралдуулахыг ойлгож байна.

<p>special session, extraordinary session нь ээлжит чуулган</p>	<p>special session, extraordinary session-ыг ялгамжтай байдлаар хэрэглэж буй</p>
<p><u>БНСУ-ын Үндэсний Ассамблейд</u> special session - Үндэсний Ассамблейн ээлжит чуулганыг хуульд заасны дагуу жилд нэг удаа, ээлжит бус буюу тусгай чуулганыг Ерөнхийлөгч, эсхүл нийт гишүүдийн 1/4-ийн саналаар зарлан хуралдуулна. Тусгай чуулганыг гурван хоногийн өмнө зарлах бол гадаад, эсхүл дотоод аюул, гамшиг, эсхүл санхүүгийн буюу эдийн засгийн хямралын үед, үндэсний аюулгүй байдалд харшлах нөхцөл байдал, эсхүл дайны байдал, гамшиг, эсхүл түүнтэй адилтгах онц нөхцөл байдалд чуулганыг нэг хоногийн өмнө зарлана.</p> <p><u>Канадын Парламентад</u> special session³²⁹ буюу тусгай чуулган нь Танхимын ердийн бус цаг хугацаанд тодорхой асуудлаар богино хугацаанд хуралдахыг хэлнэ. Процедурын хувьд ээлжит чуулгантай ижил байдлаар явагдана.</p> <p><u>Францын Үндэсний Ассамблейд</u> extraordinary session³³⁰ буюу ээлжит бус чуулганыг Ерөнхий сайд, эсхүл Үндэсний Ассамблейн гишүүдийн олонхын хүсэлтээр тодорхой асуудал хэлэлцүүлэхээр зарлан хуралдуулна.</p> <p><u>Казахстаны Парламентад</u> extraordinary session буюу ээлжит бус чуулганыг Парламентын чуулгануудын хороон дахь хугацаанд Ерөнхийлөгч өөрийн санаачилгаар, эсхүл Танхимуудын дарга</p>	<p><u>АНУ-ын Сенатад</u>³³¹ special session буюу тусгай чуулган нь <i>sine die adjournment</i> (дараагийн хурлын товыг зарлалгүй завсарлах) буюу ээлжит чуулган хаагдсаны дараагаар хуралдах чуулганыг хэлнэ.</p> <p>extraordinary session буюу ээлжит бус чуулган нь Ерөнхийлөгч үндсэн хуулиар олгосон эрхийн хүрээнд <i>sine die adjournment</i>, эсхүл чуулганы чөлөөт цагт Конгрессыг зарлан хуралдуулахыг хэлнэ.</p> <p><u>Японы Парламентад</u> extraordinary session³³² буюу ээлжит бус чуулганыг Засгийн газар, Танхимын нийт гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй саналаар, эсхүл Төлөөлөгчдийн танхимын бүрэн эрхийн хугацаа дуусан, ээлжит сонгууль зарласны дараа, Зөвлөхүүдийн танхимын ээлжит сонгуулийн дараа хуралдуулна.</p> <p>special session буюу тусгай чуулганыг Төлөөлөгчдийн танхимын бүрэн эрх хугацаанаасаа өмнө дуусгавар болж, сонгуулийг хугацаанаас нь өмнө зарласан тохиолдолд хуралдуулна.</p> <p>emergency session буюу онцгой чуулганыг Төлөөлөгчдийн танхим тарсан үед Кабинет нь Зөвлөхүүдийн танхимын онцгой чуулганыг зарлан хуралдуулна.</p>

³²⁹ (*session spéciale*) Brief session held for a specific purpose at a time of the year when the House does not usually sit. From a procedural standpoint, a special session is like any other session. Glossary of Parliamentary procedure, House of Commons of Canada. http://publications.gc.ca/collection_2009/parl/X9-18-2008E.pdf

³³⁰ https://www.senate.gov/artandhistory/history/common/generic/Feature_Homepage_Extraordinarysession.htm

³³¹ Special Session: When the Senate convenes an extra session, following sine die adjournment, it is known as a special session. Extraordinary Session: An extraordinary session occurs when the president exercises his constitutional authority to call Congress back into session during a recess or after a sine die adjournment.

³³² http://www.shugiin.go.jp/internet/itdb_english.nsf/html/statics/guide/convocation.htm

нарын саналаар, эсхүл Парламентын нийт гишүүдийн 1/3-ээс доошгүйн саналаар хуралдуулна.	
---	--

Парламентын ээлжит чуулганы үргэлжлэх хугацаа нь улс орнуудын хувьд харилцан адилгүй байх ба ээлжит бус буюу чуулганаас гадуур хуралдах чуулганы ач холбогдол мөн адил ээлжит чуулганы үргэлжлэх хугацаанаас хамааран улс орнуудын хувьд харилцан адилгүй байна.

Олон улсын парламентын холбооноос гаргасан судалгаанд хамрагдсан нийт 163 парламентын танхимын хувьд жилд нэгээс хоёр удаа чуулган хуралдах нь түгээмэл байх бол хугацааны хувьд 20-иос доош болон 151 өдрөөс дээш хуралдаг парламентын тоо 15 хувь хүрэхгүй бол, 21-150 өдөр хуралддаг парламентууд дийлэнх хувийг эзэлж байна.³³³

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

³³³ p.105, Global parliamentary report. UNDP and IPU. 2012

Парламентын чуулганы тоо

Чуулганы тоо	Нэг танхим бүхий парламент болон доод танхимын хувьд	Дээд танхим
Нэг	24.59%	29.27%
Хоёр	32.79%	31.71%
Гурав	12.30%	9.76%
Тогтмол	11.48%	12.20%
Бусад	18.85%	17.07%

Парламентын хуралдааны тоо, жилд (2010)

Хуралдааны тоо, өдрөөр	Нэг танхим бүхий парламент болон доод танхимын хувьд	Дээд танхим
20 -иос доош	7.38%	24.39%
21 - 40	22.95%	21.95%
41 - 60	13.93%	19.51%
61 - 80	14.75%	9.76%
81 - 100	14.75%	7.32%
101 - 150	20.49%	12.20%
151-ээс дээш	5.74%	4.88%

НЭГ. ПАРЛАМЕНТЫН ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАНЫГ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ҮНДСЭН ХУУЛИАР ЗОХИЦУУЛСАН БАЙДАЛ

Ихэнх улс орнууд ээлжит бус чуулгантай холбоотой асуудлыг Үндсэн хуулиар тодорхойлсон байх ба үүнээс гадна Парламентын ба үйл ажиллагааны тухай хууль, дүрэм зэргээр тодорхойлсон байдаг. Ихэнх парламентуудын хувьд парламент өөрөө өөрийнхөө үйл ажиллагаатай холбоотой эрх мэдлийг хэрэгжүүлэх бол завасарлагааны буюу парламент хуралдаагүй үед тогтсон хугацаанаас өмнө хойшлуулшгүй, эсхүл урьдчилан тооцоогүй нөхцөл байдалд шийдвэр гаргах шаардлага гарсан тохиолдолд Парламентыг хуралдуулах байнгын ажиллагаа бүхий эрх бүхий институц байх шаардлага байдаг. Энэхүү эрхийг гол төлөв Спикер буюу парламентын даргалагч нар, эсхүл тодорхой тооны гишүүд (ихэнхдээ гишүүдийн гуравны нэгийн санал/шаардлага), зарим тохиолдолд Парламентаас сонгогдсон (томилогдсон) Байнгын хороо (*Permanent deputation*) дээрх эрхийг эдлэх бол ерөнхийлөгч болон хагас ерөнхийлөгчийн засагтай улс орны ихэнхэд Ерөнхийлөгч дангаараа, эсхүл дээр дурдсан эрх бүхий институцуудтай хамтран/зөвшилцөн парламентын ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулах эрхтэй байна. Тухайлбал, АНУ-ын Үндсэн хуулийн 2 дугаар зүйлийн 3 дугаар хэсэгт “Ерөнхийлөгч онцгой тохиолдолд хоёр Танхимын нэгдсэн буюу аль нэгнийх нь Чуулганыг хуралдуулж болох бөгөөд тийм чуулганы хугацааг өөрчлөх асуудлаар хоёр танхим санал зөрсөн тохиолдолд ерөнхийлөгч зүйтэй гэж үзсэн хугацаагаараа хойшлуулан товлож болно” гэж заасан. Харин дээрх байдлаар хуралдсан Парламент (танхим) хэлэлцэх асуудлын ач холбогдол болон дарааллыг өөрөө тогтоох ба үүнд Ерөнхийлөгч улс төрийн нөлөө үзүүлэх бол хэлэлцэх асуудлын хувьд процедурын ямарваа нэгэн эрхийг эдлэхгүй.³³⁴

Ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулах эрх буй субъектын хувьд дээрхээс гадна Засгийн газар, Ерөнхий сайд, холбооны зарим улсын хувьд холбооны субъект (муж, коммун гм.)-ын саналаар /шаардсанаар/ ээлжит бус чуулганыг хуралдуулж болно.

Парламентын тодорхой тооны гишүүдийн саналаар /шаардсанаар/ ээлжит бус чуулганыг хуралдуулж буй улс орнуудын хувьд Австри, Герман, Куба, Итали, Латви, Литва, Люксембург, Серби зэрэгт гишүүдийн 1/3-ны саналаар хуралдуулах бол зарим парламентад дээрх тоо нь харьцангуй өндөр байх ба Беларусь, Мексик, Монако зэрэгт гишүүдийн 2/3-ны саналаар, Иранд гишүүдийн 3/4-ны саналаар парламентыг тус тус хуралдуулна. Цөөнгүй улсад парламентын талаас доошгийн саналаар хуралдуулж болох ба зарим тохиолдолд цөөнхийн төлөөллийн оролцоог шаардаж болдог. Армэн, БНСУ, Япон, Словени, Швейцар зэрэгт гишүүдийн 1/4-ний саналаар, Албани, БНХАУ, Чех, Болгар, Словак, Эстонид гишүүдийн 1/5-ны саналаар парламентыг тус тус хуралдуулна.

Дээрхээс гадна иргэд буюу сонгогчид хууль тогтоох дээд байгууллагыг хуралдуулах эрхийг эдэлдэг байна. Тухайлбал, Лихтенштейний Вант Улсын Үндсэн хуулийн 48 дугаар зүйлийн 48.2 дахь заалтад зааснаар Үндэслэл бүхий хүсэлт гаргасан санал өгөх эрхтэй 1000-аас доошгүй иргэдийн саналаар, эсхүл Парламентыг

³³⁴ Elliot Bulmer, Presidential Legislative Powers, International Institute for Democracy and Electoral Assistance (International IDEA), 2017 p.11

зарлан хуралдуулах тогтоолыг 3 доошгүй коммуны Ассамблей баталснаар Парламентын чуулганыг хуралдуулна.³³⁵

Ээлжит бус чуулганыг зарлах тохиолдлын ихэнхэд хэлэлцэх асуудлыг тодорхойлж өгөх ба хэлэлцэхээр товлосон асуудлыг хэлэлцэж дууссанаар чуулган хаагдана. Зарим улсад гүйцэтгэх эрх мэдлийн институц нь Парламентын ээлжит бус чуулганы хэлэлцэх асуудлыг тогтоох, тодорхойлох эрхтэй байна. Тухайлбал, Колумбын Үндсэн хуулийн 158 дугаар зүйлд зааснаар Конгрессын тусгай чуулганыг Засгийн газар товлон хуралдуулах ба хугацааг Засгийн газар тогтооно. Тусгай чуулганаар Конгресс нь зөвхөн Засгийн газраас өргөн мэдүүлсэн асуудлыг хэлэлцэнэ.

Улс орнуудын Үндсэн хуулийг шүүн үзэхэд 192 орноос 158 улсын Үндсэн хуульд парламентын ээлжит бус (тусгай) чуулгантай холбоотой асуудлыг тусгасан байна. Ээлжит бус чуулганаар хэлэлцэх асуудал, хуралдуулал үндэслэлийг хэрхэн тусгасныг багцлан тоймолбол дараах байдалтай байна.³³⁶

	Үндсэн хуульд ээлжит бус чуулганыг хуралдуулах үндэслэлийг хэрхэн тусгасан	Улсын тоо	Улсын нэр
1.	Тодорхой асуудлыг хэлэлцэхээр тусгасан (specific agenda) Хэлэлцэхээр товлосон асуудлыг хэлэлцэнэ (товлосноос бусад асуудлыг хэлэлцэхгүй) гэж заасан	48 улс	Алжир, Бенин, Буркина Фасо, Бурунди, Кабо Верде, Чад, Чили, Коморын Арлууд, Конго (БНАУ), Джибути, Франц, Габон, БНСУ, Мали, Марокко, Мексик, Науру, Португал, Сенегал, Өмнөд Африк, Испани, Өмнөд Судан, Зүүн Тимор, Того, Тунис, Зимбабве - Бахрейн, Боливи, Кот Д'Ивуар, Эквадор, Гвиней, Гондурас, Ирак, Йордан, Казахстан, Кувейт, Мадагаскар, Мексик, Нигер, Парагвай, Катар, Серб, Украин, АНЭУ, Уругвай
2.	Хойшлуулшгүй, яаралтай шийдвэрлэх асуудал гарсныг үндэслэхээр тусгасан (urgent matter)	6 улс	Ангол, Беларусь, Бразил, Египет, Никарагуа, Уругвай
3.	Нийтийн эрх ашигтай холбоотой асуудлыг үндэслэхээр тусгасан (public interest reasons so justify)	7 улс	Бразил, Фижи, Гватемала, Гвиней Биссау, Сан Томе ба Принсип, Тайланд, Эль Сальвадор
4.	Төсвийг хэлэлцэн батлахтай холбоотой асуудлыг тусгасан	4 улс	Габон - (Парламент тэнцвэртэй төсөв батлалгүй завсарласан бол), Экваторын Гвиней, Ливан, Конго
5.	Эрх бүхий институцээс өргөн мэдүүлсэн асуудлыг хэлэлцэхээр зохицуулсан (Ерөнхийлөгч, Засгийн газар, Хаан гм.)	8 улс	Армен (Парламент, Засгийн газар); Грек, Исланд, Киргиз - (Ерөнхийлөгч); Колумби, Панама (Засгийн газар); Мексик - (Байнгын хороо); Оман - (Султан)
6.	Бусад	5 улс	Хаан ширээг залгамжлахад – Лихтенштейн; Давагдашгүй хүчин зүйл – Гондурас; Асуудлын ач холбогдол – Венесуэль, нөхцөл байдал шаардсан бол – Бутан; Ээлжит бус чуулганы хэлэлцэх асуудал болон товгыг ард нийтэд түгээнэ – Камбож.
7.	Дайны болон онц байдал зарлах асуудлыг хэлэлцүүлэхийг тусгасан (Тарсан парламентыг зарлан хуралдуулах)	26 улс	Бангладеш, Ботсвана, Бразил, Кабо Верде, Конго, Доминика, Гамби, Гана, Гиана, Гайти, Иран, Лесото, Кени, Либери, Литва, Мальта, Маршаллын Арлууд, Сент Лучиа, Сейшеллын Арлууд, Сьерра Леоне, Тайланд, Өмнөд Африк, Шри Ланк, Свазиленд ³³⁷ , Танзани, Уганда

³³⁵ Pursuant to a substantiated written request by at least 1,000 Liechtenstein citizens eligible to vote or pursuant to a resolution adopted by the municipal assemblies of at least three municipalities, Parliament shall be convened.

³³⁶ Энэхүү лавлагаанд Үндсэн хуулийн нэгдсэн сан буюу www.constituteproject.org (Техасын Их Сургууль, Чикагогийн Их Сургууль, Лондонгийн Их Сургууль, АНУ-ын Энх тайвны институтээс хамтран хэрэгжүүлсэн төсөл) цахим хуудас дахь эх сурвалжийг ашигласан болно.

³³⁷ "Свазилендын Үндсэн хуулийн 134 дугаар зүйлд зааснаар Парламент тарсан үед, ерөнхий сонгууль явагдахаас өмнө онц байдал бүхий нөхцөл байдал үүссэн бол Хаан, Ерөнхийлөгч болон тарсан Парламентын даргатай зөвшилцөн Парламентын хоёр танхимыг албан ёсны сонинд хэвлэн, зарлан хуралдуулна. Энэхүү заалтад заасан "онц" (emergency) нөхцөл байдал гэсэнд хууль батлах шаардлагыг оруулна." гэж заасан байна.

8.	Үндсэн хуульд Парламентын ээлжит бус чуулгантай холбоотой асуудлыг тусгасан боловч ээлжит бус чуулганыг хуралдуулах үндэслэлийг нарийвчлан тусгаагүй	68 улс	АНУ, Афганистан, Албани, Австри, Азербайжан, Багамын Арлууд, Бельги, Болгар, Камерун, Төв Африкийн БНУ, Хорват, Куба, Чех, Доминиканы БНУ, Эстони, Этиоп, Финланд, Гүрж, Герман, Гренада, Энэтхэг, Ирланд, Итали, Япон, Кирибати, Косово, Латви, Люксембург, Ливан, Лаос, Мавритани, Малави, Микронез, Молдов, Монгол, Монако, Черна Гора, Мозамбик, Мьянмар, Намиби, Непал, Шинэ Зеланд, Норвег, Пакистан, Палау, Перу, Филиппин, Румын, ОХУ, Руанда, Сент Китс ба Невис, Сингапур, Словени, Сомали, Өмнөд Судан, Судан, Швед, Швейцар, Сири, (Тайвань), Тонга, Турк, Туркменистан, Вануату, Вьетнам, Иемен, Замби
----	--	--------	---

ХОЁР. ПАРЛАМЕНТЫН ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАНЫГ ГАДААДЫН ЗАРИМ УЛСАД ХОЛБОГДОХ ХУУЛЬ, ДҮРМЭЭР ЗОХИЦУУЛСАН БАЙДАЛ

1. ХБНГУ

1.1. ХБНГУ-ын Суурь хууль

39 дүгээр зүйл.

3. Бундестаг нь чуулганаа завсарлуулах, нээх хугацааг өөрөө тогтооно. Бундестагийн Ерөнхийлөгч (Доод танхимын дарга) нь чуулганыг хугацаанаас өмнө Бундестагийн гишүүдийн гуравны нэг (1/3), Холбооны Ерөнхийлөгч, эсхүл Холбооны Канцлерын шаардсанаар хуралдуулж болно.

52 дугаар зүйл.

1. Бундесрат нь Ерөнхийлөгч (Дээд танхимын дарга)-ийг нэг жилийн хугацаагаар сонгоно.
2. Ерөнхийлөгч (Дээд танхимын дарга) нь хоёроос доошгүй Ландер (муж улс)-ын төлөөлөгч, эсхүл Холбооны Засгийн газрын шаардсанаар Бундестагийн чуулганыг хуралдуулна.

1.2. ХБНГУ-ын Бундестаг болон Зуучлах хорооны үйл ажиллагааны дүрэм

VI. Хэлэлцэх асуудлын дараалал, Бундестагийн чуулганыг хуралдуулах, хуралдааныг удирдах, дэг журам сахиулах арга хэмжээ

20 дугаар дүрэм. Хэлэлцэх асуудлын дараалал

1. Бундестагийн чуулганы хуралдааны тов, хэлэлцэх асуудал болон дарааллыг Бундестаг дээрх асуудлаар өмнө нь шийдвэр гаргасан, эсхүл Дүрмийн 21.1-д заасны дагуу Ерөнхийлөгч өөрийн эрх мэдлийн хүрээнд тогтоосноос бусад тохиолдолд Ахмад гишүүдийн зөвлөл тогтооно.

21 дүгээр дүрэм. Ерөнхийлөгч Бундестагийн чуулганыг хуралдуулах нь

1. Бундестаг Ерөнхийлөгчид холбогдох эрхийг олгосон, эсхүл гишүүдийн ирц бүрдээгүйгээс бусад шалтгаанаар шийдвэр гаргах боломжгүй бол Ерөнхийлөгч нь өөрийн эрх мэдлийн хүрээнд чуулганы хуралдаанаар хэлэлцэх асуудал, хуралдааны товыг тогтооно.
2. Ерөнхийлөгч нь Бундестагийн гишүүдийн гуравны нэг (1/3), Холбооны Ерөнхийлөгч, эсхүл Холбооны Канцлерын шаардсанаар Бундестагийг хуралдуулж болно.
3. Бусад шалтгаанаар (21.2) Ерөнхийлөгч өөрийн эрх мэдлийн хүрээнд чуулганы хуралдааны товыг тогтоосон, эсхүл хэлэлцэх асуудал нэмсэн тохиолдолд, хуралдаан эхлэхэд Бундестагаас зөвшөөрөл авна.

2. БНСУ

2.1. БНСУ-ын Үндсэн хууль

47 дугаар зүйл. Чуулган

1. Үндэсний Ассамблейн ээлжит чуулган хуульд заасны дагуу жил бүр нэг удаа, ээлжит бус (extraordinary) чуулган нь Ерөнхийлөгч, эсхүл нийт гишүүдийн дөрөвний нэг (1/4)-ийн саналаар чуулна.
2. Ээлжит чуулганы хугацаа 100 хоног, ээлжит бус чуулгааны хугацаа 30 хоногоос хэтрэхгүй байна.
3. Ерөнхийлөгч ээлжит бус чуулганыг хуралдуулахыг хүссэн тохиолдолд, ээлжит бус чуулганы хугацаа болон хуралдуулах шалтгааныг тодорхой мэдэгдэнэ.

2.2. Үндэсний Ассамблейн тухай хууль

5 дугаар зүйл. Тусгай чуулган (Special sessions)

1. Тусгай чуулганыг зарлан хуралдуулах хүсэлт гаргасан тохиолдолд Спикер нь чуулганыг хуралдуулахаас гурав хоногийн өмнө олон нийтэд зарлана. Тусгай чуулган хуралдуулах хоёр ба түүнээс дээш хүсэлт гаргасан ба чуулган хуралдуулах хугацаа нь давхцаж буй тохиолдолд эхэлж гаргасан хүсэлтийг олон нийтэд зарлана.
2. Спикер нь 1 дэх хэсэгт заасныг үл харгалзан доорх дэд хэсэгт заасанд хамаарах бол чуулганыг хуралдуулахаас нэг хоногийн өмнө олон нийтэд зарлана.
 - 1) гадаад, эсхүл дотоод аюул, гамшиг, эсхүл санхүүгийн буюу эдийн засгийн хямралын үед;
 - 2) үндэсний аюулгүй байдалд харшлах нөхцөл байдал, эсхүл дайны байдал, гай гамшиг, эсхүл түүнтэй адилтгах онц байдлын үед.

5-2 дугаар зүйл. (Үндсэн хуваарь, Үндэсний Ассамблейн жилийн ерөнхий үйл ажиллагаа)

1. Спикер нь Үндэсний Ассамблейн дараа жилийн ерөнхий үйл ажиллагааны үндсэн хуваарийг парламент дахь намын бүлгийг төлөөлж буй Үндэсний Ассамблейн гишүүдтэй зөвшилцөн жил бүрийн 12 дугаар сарын 31-ний дотор тогтооно.
2. Үндэсний Ассамблейн ерөнхий үйл ажиллагааны үндсэн хуваарийг доорх дэд хэсэгт заасан шалгуурт үндэслэн бэлтгэнэ.
 - 1) Тусгай чуулганыг 2 дугаар сарын 1, 4 дүгээр сарын 1, 6 дугаар сарын 1 болон 8 дугаар сарын 16-нд тус тус зарлан хуралдуулна. Үндэсний Ассамблейн ерөнхий сонгууль явагдсан сард дээрх нь хамаарахгүй ба тусгай чуулганыг хуралдуулахаар товлосон өдөр бүх нийтээр амрах өдөр давхацсан бол тусгай чуулганыг дараагийн өдөрт шилжүүлнэ.

8 дугаар зүйл. Чуулганы завсарлага

1. Үндэсний Ассамблейн чуулганыг санал хураалтаар тодорхой хугацаагаар сунгаж болно.
2. Ерөнхийлөгч хүсэлт тавьсан, Спикер хойшлуулшгүй шаардлагатай гэж үзсэн, эсхүл Үндэсний Ассамблейн нийт гишүүдийн дөрөвний нэгийн саналаар Үндэсний Ассамблейн чуулган (чуулганы нэгдсэн хуралдаан)-ы завсарлагааны хугацаанд хуралдуулж болно.

3. ЯПОН

3.1. Японы Үндсэн хууль

IV. Парламент

52 дугаар зүйл. Парламентын ээлжит чуулган жил нэг удаа чуулна.

53 дугаар зүйл.

Кабинет (Засгийн газар) нь Парламентын ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулж болно. Кабинет нь Парламентын аль нэг танхимын нийт гишүүдийн дөрөвний нэг ба түүнээс дээшхийн шаардсанаар ээлжит бус чуулганыг хуралдуулна.

54 дүгээр зүйл.

Төлөөлөгчдийн танхим тарсан бол Төлөөлөгчдийн танхимын ерөнхий сонгуулийг тарсан өдрөөс 40 хоногийн дотор явуулах ба сонгуулийг явуулснаас 30 хоногийн дотор Парламентыг хуралдуулна.

Төлөөлөгчдийн танхим тарсан тохиолдолд мөн хугацаанд Зөвлөхүүдийн танхим хаагдана. Харин үндэсний онц байдлын үед Кабинет нь Зөвлөхүүдийн танхимын онцгой чуулганыг хуралдуулна.

Дээрх тохиолдолд авсан арга хэмжээ нь түр зуурын шинжтэй байх ба Парламентын дараагийн чуулган нээгдсэнээс 10 хоногийн дотор Төлөөлөгчдийн танхим дэмжээгүй бол хүчингүй болно.

3.2. Парламентын тухай хууль

1 Бүлэг. Парламентын чуулганы зарлан хуралдуулах, нээлтийн ёслол

1 дүгээр зүйл.

a.i. Парламентын чуулганыг Эзэн хаан зарлигаар товлон зарлаж хуралдуулна.

a.ii. Ээлжит чуулганыг зарлан хуралдуулах Эзэн хааны зарлигийг 10-аас доошгүй хоногийн өмнө гаргана.

Ээлжит бус (extraordinary) болон тусгай (special) чуулганыг (Үндсэн хуулийн 54 зүйлд заасан онцгой чуулган/emergency session) зарлан хуралдуулах тохиолдолд дээрх дэд хэсэгт заасныг хэрэглэхгүй.

2 дугаар зүйл. Ээлжит чуулганыг жил бүрийн 2 дугаар зард зарлан хуралдуулна.

2-2 дугаар зүйл. Тусгай чуулганыг ээлжит чуулгантай хамтруулан явуулж болно.

3 дугаар зүйл.

Ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулах шаардлагыг Танхимын нийт гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй гишүүд бичгээр гарган холбогдох танхимын Даргаар дамжуулан Кабинетад өргөн мэдүүлнэ.

2 бүлэг. Парламентын чуулганы үргэлжлэх хугацаа ба завсарлагаа

11 дүгээр зүйл.

Парламентын ээлжит бус болон тусгай чуулганы хугацааг хоёр танхимын хамтарсан шийдвэрээр тогтооно.

12 дугаар зүйл.

Парламентын чуулганы хугацааг хоёр танхимын хамтарсан шийдвэрээр сунгаж болно. Ээлжит чуулганы хугацааг нэг, тусгай, эсхүл ээлжит бус чуулганыг хоёроос

дээшгүй удаа сунгаж болно.

13 дугаар зүйл.

Дээрх хоёр зүйлд заасан тохиолдолд, хоёр танхим нэгдсэн шийдэл хүрээгүй, эсхүл Зөвлөхүүдийн танхим нь шийдвэр гаргаагүй бол чуулганы хугацааг Төлөөлөгчдийн танхим тогтооно.

15 дугаар зүйл.

Парламентыг хоёр танхимын хамтарсан шийдвэрээр завсарлуулна. Парламентын завсарлагааны хугацаанд танхимын даргалагч хойшлуулшгүй шийдвэрлэх асуудал гэж үзсэн, эсхүл Танхимын нийт гишүүдийн дөрөвний нэгээс доошгүйн шаардсанаар нэг танхимын нэгдсэн хуралдааныг нөгөө танхимын даргалагчтай зөвшилцөн хуралдуулна.

Дээрх хэсэгт заасны дагуу хуралдуулсан нэгдсэн хуралдааныг Үндсэн хууль болон энэ хуульд заасны дагуу завсарлагааны хугацаанд тооцно.

Танхим нь 10 дээшгүй хоногоор завсарлах шийдвэр гаргаж болно.

3.3. Зөвлөхүүдийн танхимын дүрэм

4 бүлэг. Чуулганы хугацааг сунгах болон Парламентын завсарлагаа

22 дугаар зүйл.

Ээлжит бус болон тусгай чуулганы хугацааг Ерөнхийлөгч (Зөвлөхүүдийн танхимын дарга) Төлөөлөгчдийн танхимын Спикертэй хэлэлцсэний дараа Парламент тогтооно. Энэ тохиолдолд Ерөнхийлөгч (Зөвлөхүүдийн танхимын дарга) нь Байнгын хороодын дарга нартай чуулганаар хэлэлцэх хууль тогтоомж (legislative program)-ийн талаар зөвшилцөн, саналыг нь урьдчилан авсан байна. Дээрх хэсэгт заасан шийдвэрийг Төлөөлөгчдийн танхим болон Кабинетад мэдэгдэнэ.

23 дугаар зүйл.

Дээрх зүйлд заасан зохицуулалтыг Парламентын чуулганы хугацааг сунгахад *mutatis mutandis* зарчмаар (зохих өөрчлөлттэйгээр) хэрэглэнэ.

4. 23-II дугаар зүйл.

22 дугаар зүйлд заасан зохицуулалтыг Парламентыг завсарлуулахад *mutatis mutandis* зарчмаар (зохих өөрчлөлттэйгээр) хэрэглэнэ. Танхимыг завсарлуулах асуудлыг Ерөнхийлөгч (Зөвлөхүүдийн танхимын дарга)-ийн саналаар танхим шийдвэрлэнэ. Энэ тохиолдолд Ерөнхийлөгч (Зөвлөхүүдийн танхимын дарга) нь Байнгын хороодын дарга нартай зөвшилцөн, саналыг нь урьдчилан авсан байна.

- Танхимын чуулган завсарлагааны хугацаанд Ерөнхийлөгч (Зөвлөхүүдийн танхимын дарга) хойшлуулшгүй шаардлагатай гэж үзсэн, эсхүл нийт гишүүдийн дөрөвний нэгээс доошгүйн саналаар Танхимыг хуралдуулж болно.
- Дээрх хэсэгт заасны даруу нэгдсэн хуралдааныг явуулсан тохиолдолд Танхимын чуулганы завсарлага өндөрлөнө.

4. ЛАТВИ

4.1. Латви Улсын Үндсэн хууль

16 дугаар зүйл.

Сейм нь Сеймийн бүрэн эрхийн хугацаанд тасралтгүй ажиллах Дарга, хоёр дэд дарга, хоёр нарийн бичгийн даргаас бүрдсэн Президиум (Хурлын тэргүүлэгчид)³³⁸-ыг сонгоно.

19 дүгээр зүйл.

Президиум (Хурлын тэргүүлэгчид) нь Сеймийн чуулганыг зарлан хуралдуулах ба ээлжит болон ээлжит бус хуралдааны товыг тогтооно.

20 дугаар зүйл.

Президиум (Хурлын тэргүүлэгчид) нь Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, эсхүл Сеймийн гишүүдийн гуравны нэгээс доошгүйн саналаар Сеймыг хуралдуулна.

4.2. Сеймийн үйл ажиллагааны дүрэм

4 бүлэг. Сеймийн чуулган ба хуралдаан

36 дугаар зүйл.

1. Сейм нь ээлжит болон ээлжит бус чуулганыг хуралдуулна. Нэг жилд намар, өвөл, хаварын гурван ээлжит чуулгантай байна.
2. Ээлжит чуулганы завсарлаагааны аль ч үед ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулж болно.

37 дугаар зүйл.

Сеймийн ээлжит чуулганыг Президиум (Хурлын тэргүүлэгчид) зарлан хуралдуулна. Ээлжит чуулганы нээх, хаах асуудлыг Сейм шийдвэрлэнэ.

38 дугаар зүйл.

1. Ээлжит бус чуулган, эсхүл хуралдааныг Президиум (Хурлын тэргүүлэгчид) өөрсдийн үзэмжээр, мөн Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, эсхүл Сеймийн гишүүдийн гуравны нэгээс доошгүйн саналаар зарлан хуралдуулна. Хүсэлтэд хэлэлцэх асуудлыг тусгасан байна.
2. Хүсэлтийг хүлээж авсны дараагаар Президиум (Хурлын тэргүүлэгчид) хүсэлтэд дурдсан хугацаанд ээлжит бус чуулган, эсхүл хуралдааныг товлон зарлана. Хүсэлтэд тодорхой хугацаа заагаагүй бол ээлжит бус чуулганыг 48 цаг, ээлжит бус хуралдааныг хүсэлт хүлээж авснаас 24 цагийг дотор тус тус хуралдуулна.
3. Ээлжит бус чуулган, эсхүл ээлжит бус хуралдааныг радио болон телевизээр зарлах ба, боломжтой бол Сеймийн гишүүн бүрт мэдэгдэнэ.
4. Ээлжит бус чуулган, эсхүл хуралдааны хэлэлцэх асуудалд гагцхүү ээлжит бус чуулган, эсхүл хуралдааныг зарлан хуралдуулах санал, эсхүл хүсэлтэд дурдсан асуудлыг оруулах ба тэдгээр асуудлыг хэлэлцэж дууссанаар чуулган, эсхүл хуралдаан хаагдана.

40 дүгээр зүйл.

³³⁸ The Presidium consists of five MPs: the Speaker, two Deputy Speakers, the Secretary and the Deputy Secretary. The Presidium determines the internal rules and work procedures of the Saeima, gives its opinions regarding documents submitted to it and forwards them as prescribed by the Rules of Procedure of the Saeima, prepares the agenda of plenary sittings and confirms planned business trips. The Presidium also appoints and dismisses heads of the Saeima organisational units and performs other routine tasks.

Хуралдааныг товыг 54-р зүйлд заасны дагуу³³⁹ Сейм өөрөө тогтоосон, эсхүл ээлжит бус хуралдааныг хуралдуулах хүсэлтэд хугацааг зааснаас бусад тохиолдолд Президиум (Хурлын тэргүүлэгчид) хуралдааны товыг тогтооно.

42 дугаар зүйл.

1. Ээлжит хуралдаанаар хэлэлцэх асуудлыг хуралдааныг нээхээс 48 цагийн өмнө зарлана. Дээрх зарыг бичгээр Сеймийн барилга дотор байрлуулах ба боломжтой бол хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарыг түгээнэ. Ээлжит бус хуралдаанаар хэлэлцэх асуудлыг Президиум (Хурлын тэргүүлэгчид) хуралдааныг нээхэд зарлана.
2. 27.3-р заалтад зааснаас бусад тохиолдолд³⁴⁰ хэлэлцэх асуудлыг дарааллыг Президиум (Хурлын тэргүүлэгчид) тогтооно.

5. БОЛГАР

5.1. Болгар Улсын Үндсэн хууль

78 дугаар зүйл.

Үндэсний Ассамблейн чуулганыг түүний Даргалагч нь:

1. Өөрийн санаачилгаар;
2. Гишүүдийн тавны нэгийн саналаар;
3. Ерөнхийлөгчийн саналаар;
4. Сайд нарын зөвлөлийн саналаар зарлан хуралдуулна.

5.2. Үндэсний Ассамблейн үйл ажиллагааны дүрэм

45 дугаар зүйл.

1. Жилд Үндэсний Ассамблей 3 чуулган чуулна.
2. Үндэсний Ассамблей нь жил бүрийн 12 дугаар сарын 22-ноос 1 дүгээр сарын 10, Улаан өндөгний баяраар Ариун баасан гаригаас 10 хоног, 8 дугаар сарын 1-нээс 31-ний хооронд тус тус завсарлана.
3. Үндэсний Ассамблей нь онцгой тохиолдолд завсарлагааны хугацааг өөрчилж болно.

46 дугаар зүйл.

1. Үндэсний Ассамблейн чуулганыг Үндэсний Ассамблейн Ерөнхийлөгч (дарга) зарлан хуралдуулна.
2. Үндсэн хуулийн 78.2-4-р заалтад заасны дагуу, Ерөнхийлөгч (Үндэсний Ассамблейн дарга) Үндэсний Ассамблейн чуулган завсарласан эсэхээс үл хамааран, хүсэлт хүлээж авснаас 7 хоногийн дотор хуралдааныг хуралдуулахаар товлон.

³³⁹ 54. (1) In the cases prescribed in Article 8 and paragraph 2 of Article 31; Articles 40, 41, 49, 51, 52, 65, 77, 82, 84, 90, 92, 93, 98, 104, 117, 127, 133, 135, 136, 140 and 142, only two Members shall be given the floor before a vote – one Member in support of the proposal and the other against it – for not longer than five minutes for each speaker.

(2) If the submitter of the proposal defends his/her proposal, he/she shall be deemed as the speaker in support of the proposal.

³⁴⁰ Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг хэлэлцэх асуудлыг дараагийн ээлжит хуралдааны хэлэлцэх асуудлын эхэнд оруулна.

27.(1) When the Cabinet of Ministers has been formed, the candidate to the office of Prime Minister invited by the President shall notify the Speaker thereof and shall submit a statement about the planned work of the Cabinet and the draft resolution to be adopted by the Saeima.

(2) Copies of the above documents shall be distributed to Members without delay.

(3) If no proposal has been made to call an extraordinary session or an extraordinary sitting of the Saeima, the Presidium shall put the said notification and the draft resolution as the first item on the agenda of the next regular sitting of the Saeima.

3. Үндсэн хуулийн 78-р зүйлд заасан хүсэлт гаргагчид нь хэлэлцэх асуудлыг тусгах үүрэгтэй байна.

48 дугаар зүйл.

1. Үндэсний Ассамблейн ээлжит чуулганы нэгдсэн хуралдааныг Лхагва, Пүрэв, Баасан гаригийн 9-14 цагийн хооронд явуулна. Үндэсний Ассамблейн шийдвэрээр хуралдааны хугацааг сунгаж болно.
2. Үндэсний Ассамблей нь чуулганаар урьдчилан мэдэгдсэн хэлэлцэх асуудлын хүрээнд ээлжит бус хуралдааныг 1-р заалтад зааснаас бусад өдөр хуралдуулж болно. Ээлжит бус хуралдааныг онцгой нөхцөл байдал үүсэн аль ч үед хуралдуулж болно.

6. СЕРБИ

6.1. Серб Улсын Үндсэн хууль

106 дугаар зүйл.

Жилд Үндэсний Ассамблейн хоёр ээлжит чуулган чуулна. Нэгдүгээр ээлжит чуулган 3 дугаар сарын эхний ажлын өдөр, хоёрдугаар ээлжит чуулган 10 дугаар сарын эхний ажлын өдөр эхэлнэ. Ээлжит чуулган нь 90 хоногоос хэтрэхгүй байна. Үндэсний Ассамблейн ээлжит бус чуулганыг гишүүдийн гуравны нэгээс доошгүйн саналаар, эсхүл Засгийн газрын саналаар урьдчилан тогтоосон хэлэлцэх асуудлаар зарлан хуралдуулна.

Дайны, эсхүл онц байдал зарлавал Үндэсний Ассамблейг зарлахгүйгээр хуралдуулна.

6.2. Үндэсний Ассамблейн тухай хууль

48 дугаар зүйл.

Жилд Үндэсний Ассамблейн хоёр ээлжит чуулган чуулна. Нэгдүгээр ээлжит чуулган 3 дугаар сарын эхний ажлын өдөр, хоёрдугаар ээлжит чуулган 10 дугаар сарын эхний ажлын өдөр эхэлнэ. Ээлжит чуулган нь 90 хоногоос хэтрэхгүй байна. Үндэсний Ассамблейн ээлжит бус чуулганыг гишүүдийн гуравны нэгээс доошгүйн саналаар, эсхүл Засгийн газрын саналаар урьдчилан тогтоосон хэлэлцэх асуудлаар зарлан хуралдуулна.

Дайны, эсхүл онц байдал зарлавал Үндэсний Ассамблейг зарлахгүйгээр хуралдуулна.

6.3. Үндэсний Ассамблейн үйл ажиллагааны дүрэм

11 бүлэг. Үндэсний Ассамблейн ээлжит бус чуулган

249 дугаар зүйл.³⁴¹

Үндэсний Ассамблейн Спикер нь ээлжит бус чуулган хуралдуулах хүсэлтийг гишүүд болон Засгийн газарт хүргүүлэх ба Үндэсний Ассамблейг хуралдуулах товыг тогтооно.

³⁴¹ Article 249 The Speaker of the National Assembly shall communicate requests for extraordinary sessions to MPs and the Government and shall determine a date for convening the National Assembly.

Article 250 At extraordinary sessions, the National Assembly shall work according to an agenda decided in advance and put forward by the submitter of the request for an extraordinary session.

The sequence of discussions on the items on the agenda may not be changed without the consent of a representative of the proposer upon whose request the extraordinary session is convened.

Article 251 Extraordinary sessions shall be subject to the application of provisions of these Rules of Procedure on regular sessions, unless otherwise specified by the provisions of this Chapter.

250 дугаар зүйл.

Ээлжит бус чуулганаар Үндэсний Ассамблей нь ээлжит бус чуулган хуралдуулах хүсэлтэд заасан, урьдчилан шийдвэрлэсэн хэлэлцэх асуудлаар хэлэлцүүлэг явуулна. Хэлэлцэх асуудлын дарааллыг ээлжит бус чуулганыг хуралдуулах хүсэлт гаргагчийн төлөөлөгчийн зөвшөөрөлгүй солихгүй.

251 дүгээр зүйл.

Энэ бүлэгт зааснаас бусад тохиолдолд ээлжит бус чуулганд энэхүү дүрэмд заасан ээлжит чуулгантай холбоотой зохицуулалтыг хэрэглэнэ.

7. УНГАР

7.1. Үндэсний Ассамблейн тухай хууль

35 дугаар зүйл.

2. БНУ-ын Ерөнхийлөгч, Засгийн газар, эсхүл Үндэсний Ассамблейн гишүүдийн тавны нэгийн бичгээр гаргасан хүсэлтээр ээлжит бус чуулган, эсхүл ээлжит бус хуралдааныг зарлан хуралдуулна. Хүсэлтэд хэлэлцэх асуудал, хуралдааны тов болон дарааллыг тусгана. Спикер нь Үндэсний Ассамблейг боломжтой бол товлон хугацаанд, эсхүл хүсэлтэд дурдсан өдрөөс 8 хоногоос хэтрэхгүй хугацаанд хуралдуулна.
3. Спикер нь ээлжит бус чуулган, эсхүл ээлжит бус хуралдааныг энэ хууль болон Үндэсний Ассамблейн үйл ажиллагааны дүрэмд заасны дагуу зарлан хуралдуулна.

7.2. Үндэсний Ассамблейн үйл ажиллагааны дүрэм

7. Ээлжит бус чуулганаар хэлэлцэх асуудал, дараалал тогтоох тусгай дүрэм

16 дугаар зүйл.

1. Ээлжит бус чуулган, эсхүл ээлжит бус хуралдааныг “үндсэн хүсэлт” (*substantive motion*)³⁴²-ыг хэлэлцэх зорилгоор хүсэлт гаргасан бол хэлэлцэх асуудалд оруулах *substantive motion*-г, ээлжит бус чуулганыг хуралдуулах хүсэлтийн хамтаар хүргүүлнэ.
2. Гишүүний 1 дэх заалтад заасны дагуу гаргасан *substantive motion*-г тусгай шийдвэр гаргалгүй Үндэсний Ассамблейн хэлэлцэх асуудлын бүртгэл (*Order Book of the National Assembly*)-д оруулна. Ээлжит бус чуулган, эсхүл ээлжит бус хуралдааны явцад бүртгэлд оруулсан гишүүний *substantive motion*-г тухайн өдрийн хэлэлцэх асуудлын товд оруулаагүй бол, гишүүний *substantive motion* бүртгэлээс хасагдана.
3. Зөвхөн ээлжит бус чуулган хуралдуулах хүсэлт гаргах эрх бүхий этгээдээс *substantive motion*-г хэлэлцэх асуудалд оруулах хүсэлт гаргасан тохиолдолд хэлэлцэх асуудалд оруулна.

³⁴² Тухайлбал, итгэл үзүүлэх, Спикерийг сонгох, огцруулах, Ерөнхийлөгчийн импичмент зэрэг.

Substantive motion is a self contained independent proposal submitted for the approval of the House and drafted in such a way as to be capable of expressing a decision of the House.

85. Ерөнхийлөгчийн сонгууль, Ерөнхийлөгчийг огцруулах, солихтой холбоотой процедур

128 дугаар зүйл.

1. Ерөнхийлөгч чөлөөлөгдөх өргөдлөө Үндэсний Ассамблейд гаргасан тохиолдолд энэхүү тогтоолд заасан зохицуулалтыг дор заасан өөрчлөлттэйгээр хэрэглэнэ:

а) өргөдөл хүлээж авснаас 15 хоногийн дотор чөлөөлөгдөх өргөдлийг хэлэлцэж, санал хураалтыг явуулна. Тухайн хугацаанд Үндэсний Ассамблей чуулаагүй бол ээлжит бус чуулган, эсхүл ээлжит бус хуралдааныг хуралдуулна.

86. Итгэл үзүүлэх, итгэл үл үзүүлэх санал хураалт

129 дүгээр зүйл.

1. Ерөнхий сайдад итгэл хүлээлгэж байгаа эсэхээр санал оруулсан бол энэхүү тогтоолд заасан зохицуулалтыг дор заасан өөрчлөлттэйгээр хэрэглэнэ:

а) итгэл хүлээлгэж байгаа эсэхийг Суурь хуульд заасан хугацаанд Үндэсний Ассамблейн чуулаагүй гэх үндэслэлээр явуулах боломжгүй бол ээлжит бус чуулган, эсхүл ээлжит бус хуралдааныг хуралдуулна.

13 бүлэг. Халдашгүй байдалтай холбоотой асуудал

146 дугаар зүйл.

1. Гишүүн болон гишүүнээр ажиллаж байсан этгээдийн халдашгүй байдалтай холбоотой асуудлыг шийдвэрлэхэд энэхүү тогтоолд заасан зохицуулалтыг энэхүү бүлэгт заасан өөрчлөлттэйгээр хэрэглэнэ.

2. Үндэсний Ассамблейн чуулаагүй үед гишүүний халдашгүй байдалтай холбоотой асуудлаар ээлжит бус чуулган, эсхүл ээлжит бус хуралдааныг хуралдуулах эсэхийг Спикер шийдвэрлэнэ.

15 бүлэг. Албан тушаалд харшлах нөхцөлүүд болон ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой асуудал

149 дүгээр зүйл.

1. Гишүүний албан тушаал, үүрэгт харшлах ажил, үйл ажиллагаа болон ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой асуудлыг шийдвэрлэхэд энэхүү тогтоолын 149-152 дугаар зүйлд заасан өөрчлөлттэйгээр хэрэглэнэ.

2. Спикер нь Халдашгүй байдлын хороонд дараахийг цаг алдалгүй хянуулахаар шилжүүлнэ:³⁴³

а) Гишүүний албан тушаал, үүрэгт харшлах ажил, үйл ажиллагааны талаар, эсхүл гишүүний ашиг сонирхлын зөрчлийн асуудлаар гаргасан өргөдөл;

б) эрүүгийн хариуцлага хүлээлгэх тухай шүүхийн шийдвэр, эсхүл эцсийн шийдвэр, эсхүл улсад төлөх төлбөрийн талаарх мэдэгдэл;

³⁴³ (2) The Speaker shall transmit without delay to the committee on immunity for examination a) the Member's motion for declaring the incompatibility or the conflict of interest of a Member, b) the notification of a final conviction for a criminal offence or of a final judgement or final decision on a public due payable to the State (hereinafter: "notification of disqualification due to unworthiness"), c) the Member's initiative for launching a procedure for incompatibility or conflict of interest of a Member, and d) the notification of incompatibility or conflict of interest of a Member, and shall inform the National Assembly and the affected Member thereof, with due account to the provisions of paragraph (3). If the National Assembly holds no sitting, the Speaker shall decide whether it is necessary to convene an extraordinary session or an extraordinary sitting for considering the incompatibility or conflict of interest case.


в) гишүүний санаачилгаар албан тушаал, үүрэгт харшлах ажил, үйл ажиллагааны талаар мэдүүлэг, эсхүл гишүүний ашиг сонирхлын зөрчилтэй эсэхийг шалгуулах хүсэлт;

г) Гишүүний албан тушаалд харшлах ажил, үйл ажиллагаа, эсхүл ашиг сонирхлын зөрчилтэй талаарх мэдэгдэх ба Үндэсний Ассамблей болон холбогдох гишүүнд мэдэгдэнэ;

Үндэсний Ассамблейн чуулаагүй үед албан тушаал, үүрэгт харшлах ажил, үйл ажиллагаа, эсхүл ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой асуудлаар ээлжит бус чуулган, эсхүл ээлжит бус хуралдааныг хуралдуулах эсэхийг Спикер шийдвэрлэнэ.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- <https://www.constituteproject.org>
- <https://www.ipu.org>
- Elliot Bulmer, Presidential Legislative Powers, International Institute for Democracy and Electoral Assistance (International IDEA), 2017
- В.В.Маклаков, Конституционное право зарубежных стран. Общая часть, Wolters Kluwer, 2006
- ХБНГУ-ын Суурь хууль <https://www.btg-bestellservice.de/pdf/80201000.pdf>
- ХБНГУ-ын Бундестаг болон Зуучлах хорооны үйл ажиллагааны дүрэм <https://www.btg-bestellservice.de/pdf/80060000.pdf>
- БНСУ-ын Үндсэн хууль <http://korea.assembly.go.kr/res/low01read.jsp>
- Үндэсний Ассамблейн тухай хууль (БНСУ) <http://korea.assembly.go.kr/res/low06read.jsp>
- Японы Японы Үндсэн хууль <http://www.shugiin.go.jp/internet/itdbenglish.nsf/html/statics/english/constitutione.htm>
- Парламентын тухай хууль (Япон) <http://www.sangiin.go.jp/eng/law/diet/index.htm#ChapterVI>
- Зөвлөхүүдийн танхимын дүрэм <http://www.sangiin.go.jp/eng/law/rothoc/index.htm>
- Латвийн Үндсэн хууль <http://www.saeima.lv/en/legislation/constitution>
- Сеймийн үйл ажиллагааны дүрэм (Латви) <http://www.saeima.lv/en/legislation/rules-of-procedure>
- Болгарын Үндсэн хууль <http://www.parliament.bg/en/const>
- Үндэсний Ассамблейн үйл ажиллагааны дүрэм (Болгар) <http://www.parliament.bg/en/rulesoftheorganisations>
- Сербийн Үндсэн хууль <http://www.parlament.gov.rs/upload/documents/Constitution%20ofSerbiapdf.pdf>
- Үндэсний Ассамблейн тухай хууль (Серби) <http://www.parlament.gov.rs/upload/documents/The%20Law%20on%20the%20National%20Assembly.pdf>
- Үндэсний Ассамблейн үйл ажиллагааны дүрэм (Серби) <http://www.parlament.gov.rs/upload/documents/06.06.2014.%20ENG%20Rules%20of%20Procedure%20edit%202014.pdf>
- Унгарын Үндэсний Ассамблейн тухай хууль <http://www.parlament.hu/documents/125505/138409/Act+XXXVI+of+2012+on+the+National+Assembly/b53726b7-12a8-4d93-acef-140feef44395>
- Унгар Үндэсний Ассамблейн үйл ажиллагааны дүрэм <http://www.parlament.hu/documents/125505/138409/Resolution+on+certain+provisions+of+the+Rules+of+Procedure/968f2e08-f740-4241-a87b-28e6dc390407>



**Хүснэгт 1. ГАДААДЫН ЗАРИМ УЛСАД ПАРЛАМЕНТЫН ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАНААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫГ ХОЛБОГДОХ ХУУЛЬ,
ДҮРМЭЭР ЗОХИЦУУЛСАН БАЙДАЛ**

	Үндсэн хууль	Парламентын тухай хууль	Парламентын үйл ажиллагааны дүрэм
ХБНГУ	<p>39 дүгээр зүйл.</p> <p>3. Бундестаг нь чуулганаа завсарлуулах, нээх хугацааг өөрөө тогтооно. Бундестагийн Ерөнхийлөгч (Доод танхимын дарга) нь чуулганыг хугацаанаас өмнө Бундестагийн гишүүдийн гуравны нэг (1/3), Холбооны Ерөнхийлөгч, эсхүл Холбооны Канцлерын шаардсанаар хуралдуулж болно.</p> <p>52 дугаар зүйл.</p> <p>1. Бундесрат нь Ерөнхийлөгч (Дээд танхимын дарга)-ийг нэг жилийн хугацаагаар сонгоно.</p> <p>2. Ерөнхийлөгч (Дээд танхимын дарга) нь хоёроос доошгүй Ландер (муж улс)-ын төлөөлөгч, эсхүл Холбооны Засгийн газрын шаардсанаар Бундестагийн чуулганыг хуралдуулна.</p>	-	<p>20 дугаар дүрэм. Хэлэлцэх асуудлын дараалал</p> <p>1. Бундестагийн чуулганы хуралдааны тов, хэлэлцэх асуудал болон дарааллыг Бундестаг дээрх асуудлаар өмнө нь шийдвэр гаргасан, эсхүл Дүрмийн 21.1-д заасны дагуу Ерөнхийлөгч өөрийн эрх мэдлийн хүрээнд тогтоосноос бусад тохиолдолд Ахмад гишүүдийн зөвлөл тогтооно.</p> <p>21 дүгээр дүрэм. Ерөнхийлөгч Бундестагийн чуулганыг хуралдуулах нь</p> <p>1. Бундестаг Ерөнхийлөгчид холбогдох эрхийг олгосон, эсхүл гишүүдийн ирц бүрдээгүйгээс бусад шалтгаанаар шийдвэр гаргах боломжгүй бол Ерөнхийлөгч нь өөрийн эрх мэдлийн хүрээнд чуулганы хуралдаанаар хэлэлцэх асуудал, хуралдааны товыг тогтооно.</p> <p>2. Ерөнхийлөгч нь Бундестагийн гишүүдийн гуравны нэг (1/3), Холбооны Ерөнхийлөгч, эсхүл Холбооны Канцлерын шаардсанаар Бундестагийг хуралдуулж болно</p> <p>3. Бусад шалтгаанаар (21.2) Ерөнхийлөгч өөрийн эрх мэдлийн хүрээнд чуулганы хуралдааны товыг тогтоосон, эсхүл хэлэлцэх асуудал нэмсэн тохиолдолд, хуралдаан эхлэхэд Бундестагаас зөвшөөрөл авна.</p>
БНСУ	<p>47 дугаар зүйл. Чуулган</p> <p>1. Үндэсний Ассамблейн ээлжит чуулган хуульд заасны дагуу жил бүр нэг удаа, ээлжит бус (extraordinary) чуулган нь Ерөнхийлөгч, эсхүл нийт гишүүдийн дөрөвний нэг (1/4)-ийн саналаар чуулна.</p> <p>2. Ээлжит чуулганы хугацаа 100 хоног, ээлжит бус чуулганы хугацаа 30 хоногоос хэтрэхгүй байна.</p> <p>3. Ерөнхийлөгч ээлжит бус чуулганыг хуралдуулахыг хүссэн тохиолдолд, ээлжит бус чуулганы хугацаа болон хуралдуулах</p>	<p>5 дугаар зүйл. Тусгай чуулган (Special sessions)</p> <p>1. Тусгай чуулганыг зарлан хуралдуулах хүсэлт гаргасан тохиолдолд Спикер нь чуулганыг хуралдуулахаас гурав хоногийн өмнө олон нийтэд зарлана. Тусгай чуулган хуралдуулах хоёр ба түүнээс дээш хүсэлт гаргасан ба чуулган хуралдуулах хугацаа нь давхцаж буй тохиолдолд эхэлж гаргасан хүсэлтийг олон нийтэд зарлана.</p> <p>2. Спикер нь 1 дэх хэсэгт заасныг үл харгалзан доорх дэд хэсэгт заасанд</p>	-

	шалтгааныг тодорхой мэдэгдэнэ.	<p>хамаарах бол чуулганыг хуралдуулахаас нэг хоногийн өмнө олон нийтэд зарлана.</p> <p>1) гадаад, эсхүл дотоод аюул, гамшиг, эсхүл санхүүгийн буюу эдийн засгийн хямралын үед;</p> <p>2) үндэсний аюулгүй байдалд харшлах нөхцөл байдал, эсхүл дайны байдал, гай гамшиг, эсхүл түүнтэй адилтгах онц байдлын үед.</p> <p>8 дугаар зүйл. Чуулганы завсарлага</p> <p>2) Ерөнхийлөгч хүсэлт тавьсан, Спикер хойшлуулшгүй шаардлагатай гэж үзсэн, эсхүл Үндэсний Ассамблейн нийт гишүүдийн дөрөвний нэгийн саналаар Үндэсний Ассамблейн чуулганы завсарлагааны хугацаанд хуралдуулж болно.</p>	
Япон	<p>5. IV. Парламент</p> <p>6. 52 дугаар зүйл.</p> <p>7. Парламентын ээлжит чуулган жил нэг удаа чуулна.</p> <p>8. 53 дугаар зүйл.</p> <p>9. Кабинет (Засгийн газар) нь Парламентын ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулж болно. Кабинет нь Парламентын аль нэг танхимын нийт гишүүдийн дөрөвний нэг ба түүнээс дээшхийн шаардсанаар ээлжит бус чуулганыг хуралдуулна.</p>	<p>15 дугаар зүйл.</p> <p>Парламентын завсарлагааны хугацаанд танхимын даргалагч хойшлуулшгүй шийдвэрлэх асуудал гэж үзсэн, эсхүл Танхимын нийт гишүүдийн дөрөвний нэгээс доошгүйн шаардсанаар нэг танхимын нэгдсэн хуралдааныг нөгөө танхимын даргалагчтай зөвшилцөн хуралдуулна.</p>	<p>10. 22 дугаар зүйл.</p> <p>11. Ээлжит бус болон тусгай чуулганы хугацааг Ерөнхийлөгч (Зөвлөхүүдийн танхимын дарга) Төлөөлөгчдийн танхимын Спикертэй хэлэлцсэний дараа Парламент тогтооно. Энэ тохиолдолд Ерөнхийлөгч (Зөвлөхүүдийн танхимын дарга) нь Байнгын хороодын дарга нартай чуулганаар хэлэлцэх хууль тогтоомж (legislative program)-ийн талаар зөвшилцөн, саналыг нь урьдчилан авсан байна.</p> <p>Дээрх хэсэгт заасан шийдвэрийг Төлөөлөгчдийн танхим болон Кабинетад мэдэгдэнэ.</p> <p>12. 23-II дугаар зүйл.</p> <p>• Танхимын чуулганы завсарлагааны хугацаанд Ерөнхийлөгч (Зөвлөхүүдийн танхимын дарга) хойшлуулшгүй шаардлагатай гэж үзсэн, эсхүл нийт гишүүдийн дөрөвний нэгээс доошгүйн саналаар Танхимыг хуралдуулж болно.</p>
Латви	<p>16 дугаар зүйл.</p> <p>Сейм нь Сеймийн бүрэн эрхийн хугацаанд тасралтгүй ажиллах Дарга, хоёр дэд дарга, хоёр нарийн бичгийн даргаас бүрдсэн Президиум (Хурлын тэргүүлэгчид)³⁴⁴-ыг сонгоно.</p>	-	<p>36 дугаар зүйл.</p> <p>2. Ээлжит чуулганы завсарлаагааны аль ч үед ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулж болно.</p> <p>38 дугаар зүйл.</p> <p>1. Ээлжит бус чуулган, эсхүл хуралдааныг</p>

³⁴⁴ The Presidium consists of five MPs: the Speaker, two Deputy Speakers, the Secretary and the Deputy Secretary.

	<p>19 дүгээр зүйл. Президиум (Хурлын тэргүүлэгчид) нь Сеймийн чуулганыг зарлан хуралдуулах ба ээлжит болон ээлжит бус хуралдааны товыг тогтооно. 20 дугаар зүйл. Президиум (Хурлын тэргүүлэгчид) нь Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, эсхүл Сеймийн гишүүдийн гуравны нэгээс доошгүйн саналаар Сеймыг хуралдуулна.</p>		<p>Президиум (Хурлын тэргүүлэгчид) өөрсдийн үзэмжээр, мөн Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, эсхүл Сеймийн гишүүдийн гуравны нэгээс доошгүйн саналаар зарлан хуралдуулна. Хүсэлтэд хэлэлцэх асуудлыг тусгасан байна. 2. Хүсэлтийг хүлээж авсны дараагаар Президиум (Хурлын тэргүүлэгчид) хүсэлтэд дурдсан хугацаанд ээлжит бус чуулган, эсхүл хуралдааныг товлон зарлана. Хүсэлтэд тодорхой хугацаа заагаагүй бол ээлжит бус чуулганыг 48 цаг, ээлжит бус хуралдааныг хүсэлт хүлээж авснаас 24 цагийг дотор тус тус хуралдуулна. 4. Ээлжит бус чуулган, эсхүл хуралдааны хэлэлцэх асуудалд гагцхүү ээлжит бус чуулган, эсхүл хуралдааныг зарлан хуралдуулах санал, эсхүл хүсэлтэд дурдсан асуудлыг оруулах ба тэдгээр асуудлыг хэлэлцэж дууссанаар чуулган, эсхүл хуралдаан хаагдана. 42 дугаар зүйл. 1. Ээлжит хуралдаанаар хэлэлцэх асуудлыг хуралдааныг нээхээс 48 цагийн өмнө зарлана. Дээрх зарыг бичгээр Сеймийн барилга дотор байрлуулах ба боломжтой бол хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарыг түгээнэ. Ээлжит бус хуралдаанаар хэлэлцэх асуудлыг Президиум (Хурлын тэргүүлэгчид) хуралдааныг нээхэд зарлана.</p>
<p>Болгар</p>	<p>78 дугаар зүйл. Үндэсний Ассамблейн чуулганыг түүний Даргалагч нь: 1. Өөрийн санаачилгаар; 2. Гишүүдийн тавны нэгийн саналаар; 3. Ерөнхийлөгчийн саналаар; 4. Сайд нарын зөвлөлийн саналаар зарлан хуралдуулна.</p>	<p>-</p>	<p>46 дугаар зүйл. 1. Үндэсний Ассамблейн чуулганыг Үндэсний Ассамблейн Ерөнхийлөгч (дарга) зарлан хуралдуулна. 2. Үндсэн хуулийн 78.2-4-р заалтад заасны дагуу, Ерөнхийлөгч (Үндэсний Ассамблейн дарга) Үндэсний Ассамблейн чуулган завсарласан эсэхээс үл хамааран, хүсэлт хүлээж авснаас 7 хоногийн дотор хуралдааныг хуралдуулахаар товлоно. 3. Үндсэн хуулийн 78-р зүйлд заасан хүсэлт гаргагчид нь хэлэлцэх асуудлыг тусгах үүрэгтэй байна.</p>

The Presidium determines the internal rules and work procedures of the Saeima, gives its opinions regarding documents submitted to it and forwards them as prescribed by the Rules of Procedure of the Saeima, prepares the agenda of plenary sittings and confirms planned business trips. The Presidium also appoints and dismisses heads of the Saeima organisational units and performs other routine tasks.

			48 дугаар зүйл. 3. Үндэсний Ассамблей нь чуулганаар урьдчилан мэдэгдсэн хэлэлцэх асуудлын хүрээнд ээлжит бус хуралдааныг 1-р заалтад зааснаас бусад өдөр хуралдуулж болно. Ээлжит бус хуралдааныг онцгой нөхцөл байдал үүсэн аль ч үед хуралдуулж болно.
Серби	106 дугаар зүйл. Жилд Үндэсний Ассамблейн хоёр ээлжит чуулган чуулна. Нэгдүгээр ээлжит чуулган 3 дугаар сарын эхний ажлын өдөр, хоёрдугаар ээлжит чуулган 10 дугаар сарын эхний ажлын өдөр эхэлнэ. Ээлжит чуулган нь 90 хоногоос хэтрэхгүй байна. Үндэсний Ассамблейн ээлжит бус чуулганыг гишүүдийн гуравны нэгээс доошгүйн саналаар, эсхүл Засгийн газрын саналаар урьдчилан тогтоосон хэлэлцэх асуудлаар зарлан хуралдуулна. Дайны, эсхүл онц байдал зарлавал Үндэсний Ассамблейг зарлахгүйгээр хуралдуулна.	48 дугаар зүйл. Жилд Үндэсний Ассамблейн хоёр ээлжит чуулган чуулна. Нэгдүгээр ээлжит чуулган 3 дугаар сарын эхний ажлын өдөр, хоёрдугаар ээлжит чуулган 10 дугаар сарын эхний ажлын өдөр эхэлнэ. Ээлжит чуулган нь 90 хоногоос хэтрэхгүй байна. Үндэсний Ассамблейн ээлжит бус чуулганыг гишүүдийн гуравны нэгээс доошгүйн саналаар, эсхүл Засгийн газрын саналаар урьдчилан тогтоосон хэлэлцэх асуудлаар зарлан хуралдуулна. Дайны, эсхүл онц байдал зарлавал Үндэсний Ассамблейг зарлахгүйгээр хуралдуулна.	249 дугаар зүйл. Үндэсний Ассамблейн Спикер нь ээлжит бус чуулган хуралдуулах хүсэлтийг гишүүд болон Засгийн газарт хүргүүлэх ба Үндэсний Ассамблейг хуралдуулах товыг тогтооно. 250 дугаар зүйл. Ээлжит бус чуулганаар Үндэсний Ассамблей нь ээлжит бус чуулган хуралдуулах хүсэлтэд заасан, урьдчилан шийдвэрлэсэн хэлэлцэх асуудлаар хэлэлцүүлэг явуулна. Хэлэлцэх асуудлын дарааллыг ээлжит бус чуулганыг хуралдуулах хүсэлт гаргагчийн төлөөлөгчийн зөвшөөрөлгүй солихгүй.
Унгар	-	35 дугаар зүйл. 1. БНУ-ын Ерөнхийлөгч, Засгийн газар, эсхүл Үндэсний Ассамблейн гишүүдийн тавны нэгийн бичгээр гаргасан хүсэлтээр ээлжит бус чуулган, эсхүл ээлжит бус хуралдааныг зарлан хуралдуулна. Хүсэлтэд хэлэлцэх асуудал, хуралдааны тов болон дарааллыг тусгана. Спикер нь Үндэсний Ассамблейг боломжтой бол товлосон хугацаанд, эсхүл хүсэлтэд дурдсан өдрөөс 8 хоногоос хэтрэхгүй хугацаанд хуралдуулна. 2. Спикер нь ээлжит бус чуулган, эсхүл ээлжит бус хуралдааныг энэ хууль болон Үндэсний Ассамблейн үйл ажиллагааны дүрэмд заасны дагуу зарлан хуралдуулна.	16 дугаар зүйл. 4. Ээлжит бус чуулган, эсхүл ээлжит бус хуралдааныг “үндсэн хүсэлт” (substantive motion)-ыг хэлэлцэх зорилгоор хүсэлт гаргасан бол хэлэлцэх асуудалд оруулах <i>substantive motion</i> -г, ээлжит бус чуулганыг хуралдуулах хүсэлтийн хамтаар хүргүүлнэ. 5. Гишүүний 1 дэх заалтад заасны дагуу гаргасан <i>substantive motion</i> -г тусгай шийдвэр гаргалгүй Үндэсний Ассамблейн хэлэлцэх асуудлын бүртгэл (<i>Order Book of the National Assembly</i>)-д оруулна. Ээлжит бус чуулган, эсхүл ээлжит бус хуралдааны явцад бүртгэлд оруулсан гишүүний <i>substantive motion</i> -г тухайн өдрийн хэлэлцэх асуудлын товд оруулаагүй бол, гишүүний <i>substantive motion</i> бүртгэлээс хасагдана. 6. Зөвхөн ээлжит бус чуулган хуралдуулах хүсэлт

		<p>гаргах эрх бүхий этгээдээс <i>substantive motion</i>-г хэлэлцэх асуудалд оруулах хүсэлт гаргасан тохиолдолд хэлэлцэх асуудалд оруулна.</p> <p>Дараахь тохиолдод Үндэсний Ассамблей чуулаагүй бол ээлжит бус чуулган, эсхүл ээлжит бус хуралдааныг хуралдуулна:</p> <ul style="list-style-type: none"> - Ерөнхийлөгч чөлөөлөгдөх өргөдөл гаргасан бол; - Ерөнхий сайдад итгэл хүлээлгэж байгаа эсэхээр санал оруулсан бол. <p>Дараахь тохиолдод Үндэсний Ассамблейн чуулаагүй үед ээлжит бус чуулган, эсхүл ээлжит бус хуралдааныг хуралдуулах эсэхийг Спикер шийдвэрлэнэ:</p> <ul style="list-style-type: none"> - Гишүүн болон гишүүнээр ажиллаж байсан этгээдийн халдашгүй байдалтай холбоотой асуудлаар; - Гишүүний албан тушаал, үүрэгт харшлах ажил, үйл ажиллагаа болон ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой асуудлаар.
--	--	--

Хүснэгт 2. Парламентын ээлжит бус чуулгантай холбоотой үндсэн хуулийн зохицуулалт

	Улс	Үндсэн хууль		Хүсэлтийг хүлээж авснаас хэдэн хоногийн дотор хуралдах	Хэлэлцэх асуудлыг нарийвчлан заасан эсэх
		Үндсэн хуулийн зохицуулалт	Санаачлах, зарлан хуралдуулах эрх бүхий субъект		
5.	Afghanistan 2004	CHAPTER V ARTICLE 107 Extraordinary sessions of the Assembly during recess shall be convened by Presidential order.	Ерөнхийлөгчийн зарлигаар Үндэсний Ассамблейн ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулна.	-	-
6.	Albania 1998 (rev. 2016)	PART THREE CHAPTER III ARTICLE 74 2. The Assembly meets in extraordinary session when it is requested by the President of the Republic, the Prime Minister or by one-fifth of all the deputies.	Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, эсхүл Парламентын нийт гишүүдийн 1/5-ны хүсэлтээр Ассамблейн ээлжит бус чуулганыг хуралдуулна.	-	-
7.	Algeria 1989 (reinst. 1996, rev. 2016)	TITLE II CHAPTER II ARTICLE 135 The Prime Minister may request the extension of the ordinary session in order to finish the study of a specific issue on the agenda. The Parliament may meet in extraordinary session on the initiative of the President of the Republic. It may also be summoned by the President of the Republic on the request of the Prime Minister or the request of two-thirds (2/3) of the members of the People's National Assembly.	- Парламентын ээлжит бус чуулганыг БНУ-ын Ерөнхийлөгчийн санаачилгаар хуралдуулж болно. - Парламентын ээлжит бус чуулганыг мөн Ерөнхий сайд, эсхүл Ардын Үндэсний Ассамблейн гишүүдийн 2/3-ны хүсэлтээр хуралдуулж болно. Ерөнхий сайд нь хэлэлцэх асуудлын товд багтсан тодорхой асуудлыг хэлэлцэж дуусгахаар ээлжит чуулганы хугацааг сунгах хүсэлтийг гаргаж болно.	-	-
8.	Angola 2010	TITLE IV CHAPTER III SECTION III ARTICLE 156 (3) 3. The Standing Committee shall be responsible for: c. Convening special sessions of the National Assembly when specific and urgent matters need to be analysed;	Байнгын хороо нь дараахь үүргийг хэрэгжүүлнэ: Нарийвчлан авч үзэх шаардлага бүхий тодорхой, яаралтай асуудлаар Үндэсний Ассамблейн ээлжит бус чуулганыг хуралдуулна.	-	Нарийвчлан авч үзэх шаардлага бүхий тодорхой, яаралтай асуудлыг хэлэлцэх
9.	Argentina 1853 (reinst. 1983, rev. 1994)	PART 2 TITLE I SECTION I CHAPTER III ARTICLE 63 Both Chambers shall assemble by themselves in regular sessions every year from March 1 to November 30. They may also be convened in special sessions by the President of the Nation or have their sessions extended.	Ерөнхийлөгч Танхимуудын тусгай чуулганыг хуралдуулах, эсхүл чуулганы хугацааг сунгаж болно.	-	-
10.	Armenia 1995 (rev. 2015)	CHAPTER 4 ARTICLE 100 EXTRAORDINARY SESSIONS AND SITTINGS OF THE NATIONAL ASSEMBLY 1. An extraordinary session or sitting of the National Assembly shall be convened by the National Assembly Chairman by the initiative of at least one quarter of the total number of parliamentarians or of the Government. 2. The extraordinary session or sitting shall be conducted with the agenda and in the time period set by the initiator.	Үндэсний Ассамблейн дарга Парламентын нийт гишүүдийн 1/4-с доошгүйн, эсхүл Засгийн газрын саналаар Үндэсний Ассамблейн чуулган, чуулганы хуралдааныг зарлан хуралдуулна.	Ээлжит бус чуулган, хурлыг санаачлагчийн тавьсан болон хугацаанд явуулна.	Ээлжит бус чуулган, хурлыг санаачлагчийн тавьсан асуудал болон хугацаанд явуулна. (Гишүүдийн ¼-ээс доошгүйн эсхүл Засгийн газрын саналаар)
11.	Austria 1920 (reinst. 1945, rev. 2013) https://www.parlament.gv.at Federal Constitutional Law	CHAPTER IIA ART 28 2. The Federal President can also convoke the National Council for extraordinary sessions. If the Federal Government or at least one third of the members of the National- or the Federal Council so demands, the Federal President is bound to convoke the National Council for an extraordinary session to meet moreover within two weeks of the demand reaching him; the convocation needs no countersignature. A request by members of the National Council or by the Federal Council does not require a recommendation by the Federal Government.	- Холбооны Ерөнхийлөгч Үндэсний Зөвлөлийн ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулж болно. - Холбооны Засгийн газар, эсхүл Үндэсний зөвлөл (доод), Холбооны зөвлөлийн (дээд) гишүүдийн 1/3-ээс доошгүйн шаардлагаар Холбооны Ерөнхийлөгч Үндэсний Зөвлөлийн ээлжит бус чуулганыг шаардлагыг хүлээж авсан өдрөөс 2 долоо хоногийн дотор зарлан хуралдуулна. Үндэсний Зөвлөл, эсхүл Холбооны Зөвлөлийн гишүүдийн хүсэлтэд Холбооны Засгийн газрын зөвлөмж (батламж) шаардлагагүй байна.	2 долоо хоногийн дотор	-

12.	Azerbaijan 1995 (rev. 2016)	THIRD PART CHAPTER V ARTICLE 88 II. Special sessions of the Milli Majlis of the Republic of Azerbaijan shall be summoned by the Speaker of the Milli Majlis of the Republic of Azerbaijan at the request of the President of the Republic of Azerbaijan, or 42 Members of the Milli Majlis.	Парламентын тусгай чуулганыг Ерөнхийлөгч, эсхүл парламентын 42 гишүүний (1/3) хүсэлтээр Парламентын дарга зарлан хуралдуулна.	-	-
13.	Bahamas (The) 1973	CHAPTER V PART 566 The Governor-General, acting in accordance with the advice of the Prime Minister, may at any time by proclamation prorogue Parliament.	Ерөнхий сайдын зөвлөмжийн дагуу Амбан захирагчийн зарлигаар аль ч үед Парламентыг зарлан завсарлуулж болно	-	-
14.	Bahrain 2002 (rev. 2017)	CHAPTER IV SECTION 3 PART 3 ARTICLE 75 Both the Consultative Council and the Chamber of Deputies shall be called, by Royal Decree, to meet in extraordinary session if the King deems it necessary, or if so requested by a majority of members of either chamber. When in extraordinary session the two chambers may not consider matters other than those for which it has been called to convene.	Хаан шаардлагатай гэж үзсэн, эсхүл аль нэг танхимын гишүүдийн олонхын саналаар Зөвлөлдөх зөвлөл болон Депутатуудын танхимын ээлжит бус чуулганыг Хааны зарлигаар зарлан хуралдуулна.	-	Ээлжит бус чуулганаар хоёр Танхим нь хэлэлцэхээр товлон зарласнаас бусад асуудлыг хэлэлцэхгүй.
15.	Bangladesh 1972 (reinst. 1986, rev. 2014)	PART V CHAPTER 172 SESSIONS OF PARLIAMENT 4.If after a dissolution and before the holding of the next general election of members of Parliament the President is satisfied that owing to the existence of a state of war in which the Republic is engaged it is necessary to recall Parliament, the President shall summon the Parliament that has been dissolved to meet.	Парламент тарсны дараа, ерөнхий сонгууль явагдахаас өмнө Ерөнхийлөгч дайны байдал зарлах нөхцөл байдал үүсэж, Парламентыг хуралдуулах шаардлагатай гэж үзсэн бол, Ерөнхийлөгч тарсан Парламентыг зарлан хуралдуулна.	-	Парламент тарсны дараа, ерөнхий сонгууль явагдахаас өмнө Ерөнхийлөгч дайны байдал зарлах нөхцөл байдал үүсэж, Парламентыг хуралдуулах шаардлагатай гэж үзсэн бол, Ерөнхийлөгч тарсан Парламентыг зарлан хуралдуулна.
16.	Belarus 1994 (rev. 2004)	SECTION 4 CHAPTER 4 ARTICLE 95 The House of Representatives and the Council of the Republic may in instances of urgent necessity be convened for an extraordinary session to the request of the President, or initiative of no less than a two-thirds majority of the full composition of every chamber for a special agenda . The extraordinary sessions shall be called by the decrees of the President.	Яаралтай шаардлага гарсан тохиолдолд Төлөөлөгчдийн танхим болон Төрийн Зөвлөлийн ээлжит бус чуулганыг Ерөнхийлөгч, эсхүл танхим тус бүрийн нийт гишүүдийн 2/3-аас дээшхийн санаачилгаар тусгай асуудал хэлэлцүүлэхээр хуралдуулж болно.	-	Яаралтай шаардлага гарсан тохиолдолд ээлжит бус чуулган чуулж болно.
17.	Belgium 1831 (rev. 2014)	TITLE III CHAPTER I ARTICLE 44 The King has the right to convene the Houses to an extraordinary meeting.	Хаан Танхимыг ээлжит бусаар хуралдуулж болно.	-	-
18.	Benin 1990	TITLE IV I ARTICLE 88 The National Assembly shall be convened in special session by its President with a specific agenda at the request of the President of the Republic or by the absolute majority of the Deputies. The duration of an special session may not exceed fifteen days. The National Assembly may break up as soon as the agenda has been exhausted.	Ерөнхийлөгч, эсхүл нийт гишүүдийн олонхын саналаар Үндэсний Ассамблейн тусгай чуулганыг тодорхой асуудлаар хуралдуулна. Ээлжит бус чуулган 15 өдрөөс хэтрэхгүй байна. Хэлэлцэхээр товлосон асуудлыг хэлэлцэж дууссаны дараа хаагдана.	-	- тодорхой асуудлаар;
19.	Bhutan 2008	ARTICLE 10 12. The Speaker and the Chairperson shall convene an extraordinary sitting of Parliament on the command of the Druk Gyalpo if the exigencies of the situation so demand.	Нөхцөл байдал шаардсан үед Хааны зарлигаар Спикер болон Дарга нь Парламентыг ээлжит бусаар хуралдуулна.	-	-
20.	Bolivia (Plurinational State of) 2009	PART II TITLE I CHAPTER I ARTICLE 154 In extraordinary cases, for matters of urgency , the Assembly can be convoked by its President or by the President of the State. It shall only take up the matters set forth in the convocation.	Онц тохиолдолд хойшлуулшгүй асуудлаар Парламентын дарга, Ерөнхийлөгч Ассамблейг зарлан хуралдуулна.	-	- зөвхөн хэлэлцэхээр товлосон асуудлыг хэлэлцэнэ




21.	Botswana 1966 (rev. 2005)	<p>CHAPTER V PART V 91 5. If, after a dissolution of Parliament and before the holding of the general election of the Elected Members of the National Assembly, the President considers that, owing to the existence of a state of war or of a state of emergency in Botswana or any part thereof, it is necessary to recall Parliament, the President may summon the Parliament that has been dissolved to meet and that Parliament shall be deemed to be the Parliament for the time being, but the general election of the Elected Members of the National Assembly shall proceed and the Parliament that has been recalled shall, if not sooner dissolved, again stand dissolved on the day before the day on which the election is held.</p> <p>CHAPTER V PART V93 SITTINGS OF NATIONAL ASSEMBLY The President may at any time summon a meeting of the National Assembly. Subject to the provisions of this Constitution, the sittings of the National Assembly in any session of Parliament after the commencement of that session shall be commenced at such times and on such days as the Assembly shall appoint.</p>	<p>Парламент тарсны дараа, ерөнхий сонгууль явагдахаас өмнө Ерөнхийлөгч дайны байдал, эсхүл Ботсвана, эсхүл түүний аль нэг хэсэгт онц байдал зарлах нөхцөл байдал үүсэж, Парламентыг хуралдуулах шаардлагатай гэж үзсэн бол, Ерөнхийлөгч тарсан Парламентыг зарлан хуралдуулна. Тарсан Парламент үүнээс өмнө тараагүй бол Үндэсний Ассамблейн сонгуулийн өмнөх өдөр дахин тарна. Ерөнхийлөгч аль ч үед Үндэсний Ассамблейг хуралдуулж болно. Үндсэн хуульд заасны дагуу дээрх байдлаар зарлан хуралдуулсны дараагийн аливаа чуулганыг Ассамблейн товлосон хугацаа болон өдөр нээнэ.</p>	-	<p>Парламент тарсны дараа, ерөнхий сонгууль явагдахаас өмнө Ерөнхийлөгч дайны байдал, эсхүл Ботсвана, эсхүл түүний аль нэг хэсэгт онц байдал зарлах нөхцөл байдал үүсэж, Парламентыг хуралдуулах шаардлагатай гэж үзсэн бол, Ерөнхийлөгч тарсан Парламентыг зарлан хуралдуулна.</p>
22.	Brazil 1988 (rev. 2017)	<p>TITLE IV CHAPTER I SECTION VI ART 57 §6°. Extraordinary sessions of the National Congress shall be called: I. by the President of the Senate, in the event a state of defense or federal intervention is decreed, of a request for authorization to decree a state of siege and for the President and the Vice-President of the Republic to take their oaths and offices; II. by the President of the Republic, the Presidents of the Chamber of Deputies and Federal Senate or at the request of a majority of the members of both Chambers in the event of urgency or relevant public interest, in all cases in this subparagraph with approval by an absolute majority of each House of the National Congress.</p> <p>TITLE V CHAPTER I SECTION II ART 138 §2°. If authorization to decree a state of siege is requested during a legislative recess, the President of the Federal Senate shall immediately convoke the National Congress to meet within five days in extraordinary session in order to consider the act.</p>	<p>Үндэсний Конгрессын ээлжит бус чуулганыг: - Сенатын ерөнхийлөгч дайны, эсхүл онц байдал зарласан, эсхүл зарласан дайны (онц) байдлыг батламжлах, эсхүл Ерөнхийлөгч болон Дэд Ерөнхийлөгчийг тангараг өргүүлэхээр; - Ерөнхийлөгч, 2 танхимын дарга, 2 танхимын гишүүдийн олонхын саналаар, хойшлуулшгүй, эсхүл холбогдох нийтийн эрх ашгийн асуудлаар, болон дэд хэсэгт заасан бүх асуудлыг Танхим бүрийн нийт гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ. Дайны, эсхүл онц байдал зарласан, эсхүл зарласан дайны (онц) байдлыг батламжлах хүсэлтийн парламентын завсарлагааны хугацаанд хүлээж авсан бол Сенатын ерөнхийлөгч тухайн асуудлыг хэлэлцэхээр Парламентыг нэн даруй 5 хоногийн дотор хуралдуулна.</p>	<p>Парламентыг нэн даруй 5 хоногийн дотор хуралдуулна.</p>	<p>- дайны, эсхүл онц байдал зарлах, Ерөнхийлөгч болон Дэд Ерөнхийлөгчийг тангараг өргүүлэх; - Хойшлуулшгүй, эсхүл нийтийн эрх ашгийн асуудлаар.</p>
23.	Bulgaria 1991 (rev. 2015)	<p>CHAPTER III ARTICLE 78 The National Assembly shall be convened for its sessions by its Chairperson: 1. On his own initiative; 2. At the request of one-fifth of its members; 3. At the request of the President; 4. At the request of the Council of Ministers.</p>	<p>Үндэсний Ассамблейн дарга дараах тохиолдолд чуулганыг зарлан хуралдуулна. - парламентын даргын санаачилгаар; - гишүүдийн 1/5-ны хүсэлтээр; - Ерөнхийлөгчийн хүсэлтээр; - Сайд нарын зөвлөлийн хүсэлтээр.</p>	-	-
24.	Burkina Faso 1991 (rev. 2012)	<p>TITLE V ARTICLE 88 Each Chamber of the Parliament meets in extraordinary session on convocation of its President[,] at the demand of the Prime Minister or of that of an absolute majority of the Deputies or of the Senators on a specific agenda. The extraordinary session is closed on completion of the agenda.</p>	<p>- Ерөнхий сайд, эсхүл - нийт депутат, эсхүл сенаторуудын олонхын шаардсанаар Парламентын танхимын Ерөнхийлөгч зарлан хуралдуулна.</p>		- тодорхой асуудлаар
25.	Burundi 2005	<p>TITLE V 1 ARTICLE 104</p>	<p>Ерөнхийлөгч, эсхүл нийт гишүүдийн олонхын</p>		- тодорхой асуудлаар




		<p>In the case of necessity, the Parliament is convoked in extraordinary session. TITLE VI 2 ARTICLE 174 Extraordinary sessions may not last longer than fifteen days. They may be convened at the demand of the President of the Republic or at the demand of an absolute majority of the members composed of the National Assembly, for a specific agenda. Extraordinary sessions are opened and closed by decree of the President of the Republic. TITLE VI 3 ARTICLE 185 Extraordinary sessions may not last longer than fifteen days, may be convened at the demand of the President of the Republic or at the demand of an absolute majority of members composing the Senate, for a specific agenda. Extraordinary sessions are open and closed by decree of the President of the Republic.</p>	шаардсанаар		
26.	Cambodia 1993 (rev. 2008)	<p>CHAPTER VII ARTICLE 83 The agenda and the date of the extraordinary session shall be disseminated to the population. CHAPTER VIII ARTICLE 107 The Senate holds ordinary sessions twice a year. Each session shall last at least three months. If requested by the King, or the Prime Minister, or at least one-third of all Senators, the Senate shall convene in an extraordinary session.</p>	<p>- Хаан; - Ерөнхий сайд; - Сенаторуудын 1/3-с доошгүйн саналаар.</p>		- ээлжит бус чуулганаар хэлэлцэх асуудал болон хурлын товыг ард нийтэд түгээнэ.
27.	Cameroon 1972 (rev. 2008)	<p>PART III ARTICLE 143 3. Both Houses of Parliament shall meet on the same dates: b.in extraordinary session, at the request of the President of the Republic or of one-third of the members of both Houses.</p>	<p>- Ерөнхийлөгч; - 2 танхимын гишүүдийн 1/3-ийн хүсэлтээр.</p>		-
28.	Cape Verde 1980 (rev. 1992)	<p>PART V TITLE II CHAPTER III ARTICLE 147 3. The President of the Republic, when requesting an extraordinary session of the National Assembly, shall indicate clearly the specific matters to be considered and the period within which the session shall be called; the President of the National Assembly shall have the responsibility of convening the Assembly within the period indicated. 4. In the cases referred to in (2)(h), if the National Assembly is not in session and it is not possible to convene it immediately, the authorization may be given by its Permanent Commission, but this must be ratified by the Plenary Session at the first meeting after the date of authorization. PART V TITLE III CHAPTER III ARTICLE 166 SPECIAL SESSIONS Outside the normal period of functioning, the National Assembly may meet in extraordinary session in case of war, martial law or a state of emergency, to review the program of the Government, or to take care of a specific emergency matter of relevant national interest. The National Assembly may also be convened in extraordinary session at the request of the President of the Republic to deal with specific matters as provided in Article 147, 1(p)[o] and (3). In the extraordinary sessions the National Assembly may only deal with the specific matters which are the object of the session.</p>	<p>- Ерөнхийлөгч;</p>		-

29.	Central African Republic 2016	TITLE IV ARTICLE 64 The Chambers of the Parliament meet on the same dates: •in extraordinary sessions, at the demand of the President of the Republic or of the third of the members composing one or the other Chamber.	- Ерөнхийлөгч, эсхүл аль нэг танхимын гишүүдийн 1/3-ны шаардсанаар.	-
30.	Chad 1996 (rev. 2015)	TITLE III CHAPTER I ARTICLE 90 The President of the Republic communicates with the National Assembly by messages that he has read and which do not give rise to any debate. Out of session, the National Assembly is convened specially to this effect. TITLE IV ARTICLE 119 The National Assembly meets in extraordinary Session at the demand of the Prime Minister or of the majority of its members, on a specific agenda . When the extraordinary Session is held at the demand of the members of the National Assembly, the decree of cloture intervenes once it has exhausted the agenda for which it had been convoked and at the latest fifteen (15) days counting from the date of opening of the Session. The Prime Minister may only demand one new Session before the expiration of the month which follows the Decree of cloture.	- Ерөнхий сайд, эсхүл гишүүдийн олонхын шаардсанаар.	- тодорхой асуудлаар
31.	Chile 1980 (rev. 2015)	CHAPTER IV PRESIDENT OF THE REPUBLIC ARTICLE 32 The special powers of the President of the Republic are: 2.Request, indicating the reasons, that any of the branches of the National Congress be called to session. In this case, the session must be held as soon as possible;	- Ерөнхийлөгч.	-
32.	China (People's Republic of) 1982 (rev. 2004)	CHAPTER III SECTION 1 ARTICLE 61 The National People's Congress meets in session once a year and is convened by its Standing Committee. A session of the National People's Congress may be convened at any time the Standing Committee deems this necessary, or when more than one-fifth of the deputies to the National People's Congress so propose. When the National People's Congress meets, it elects a presidium to conduct its session.	- Байнгын хороо, эсхүл БХАТИХ-ын гишүүдийн 1/5-аас доошгүйн саналаар.	-
33.	Colombia 1991 (rev. 2015)	TITLE VI CHAPTER II ARTICLE 138 The Congress shall also meet in special sessions by convocation of and for the period of time stipulated by the government. During these special sessions, Congress shall only be entitled to discuss the issues submitted for its consideration by the government, without prejudice to the function of political control that it enjoys and which it may exercise at all times.	Конгрессын ээлжит бус чуулганыг Засгийн газар товлон зарлана.	- - Онцгой чуулганаар Конгресс нь зөвхөн Засгийн газраас хэлэлцүүлэхээр мэдүүлсэн асуудлыг хэлэлцэнэ.
34.	Comoros 2001 (rev. 2009)	TITLE III CHAPTER II ARTICLE 23 The Assembly of the Union shall meet in extraordinary session at the request of the President of the Union or of the absolute majority of the Deputies to debate a specific agenda. The extraordinary session shall be closed not later than fifteen days after the Assembly's first sitting.	Ерөнхийлөгч, эсхүл нийт гишүүдийн олонхын саналаар тодорхой асуудлаар хэлэлцэхээр ээлжит бус чуулганыг хуралдуулна.	- - тодорхой асуудлаар
35.	Congo (Democratic Republic of the) 2005 (rev. 2011)	TITLE III CHAPTER 1 SECTION 2 PARAGRAPH 6 ARTICLE 116 Each Chamber of Parliament can be convoked in extraordinary session by its President on a specific agenda , either at the demand of its Bureau, or of half of its members, or of the	Парламентын танхимын дарга нар Товчоо, эсхүл гишүүдийн тал, Ерөнхийлөгч, Засгийн газрын шаардсанаар ээлжит бус чуулганыг хуралдуулна.	- - тодорхой асуудлаар


		President of the Republic, or of the Government. Cloture intervenes after the Chamber has exhausted the agenda for which it had been convoked and, at the latest, thirty days counting from the beginning of the session.			
36.	Congo 2015	<p>TITLE IV SUB-TITLE I ARTICLE 93 When the institutions of the Republic, the independence of the Nation, the integrity of the national territory or the execution of the international engagements are menaced in a grave and imminent manner[,] and that the regular functioning of the public powers is interrupted, the President of the Republic takes the measures required by the circumstances, after consultation of the Prime Minister and of the Presidents of the two Chambers of the Parliament. He informs the Nation by a message. The Parliament meets of plain right in extraordinary session. The Parliament establishes the time period at the term of which the President of the Republic can no longer take the exceptional measures.</p> <p>TITLE V SUB-TITLE I ARTICLE 119 Each Chamber of the Parliament is convoked in extraordinary session by its President on a determined agenda, at the demand of the President of the Republic or of the absolute majority of its members. The closure intervenes when the Chamber has exhausted the agenda for which it was convoked and, at the latest, fifteen days counting from the date of the beginning of its meeting.</p> <p>TITLE VI ARTICLE 153 If the Parliament has not voted the budget at the end of the session of October, the Prime Minister demands an extraordinary session of which the duration cannot exceed fifteen (15) days. Passing this time, the budget is established, definitively, by ordinance after the opinion of the Constitutional Court. If the Parliament has not been referred to [the matter] of the bill of the law of finance within the time periods specified in Article 152 and the budget has not been voted in the course [issu] of this first extraordinary session, a second extraordinary session is convoked at the demand of the Prime Minister.</p>	<p>- БНУ-ын институцүүд, улсын тусгаар тогтнол, улсын газар нутгийн халдашгүй байдал, эсхүл олон улсын гэрээ хэлэлцээрийг хэрэгжүүлэх</p> <p>- Ерөнхийлөгч, эсхүл нийт гишүүдийн олонхи шаардсанаар.</p> <p>- 10 дугаар сарын чуулган дуусахад Парламент төсвийг батлаагүй бол Ерөнхий сайд ээлжит бус чуулган зарлахыг шаардах ба үргэлжлэх хугацаа нь 15 хоногоос дээшгүй байна. [...] Ээлжит бус чуулганаар төсвийг батлаагүй бол Ерөнхий сайд хоёр дахь ээлжит бус чуулганыг зарлахыг шаардана.</p>	-	- 10 дугаар сарын чуулган дуусахад Парламент төсвийг батлаагүй бол Ерөнхий сайд ээлжит бус чуулган зарлахыг шаардах ба үргэлжлэх хугацаа нь 15 хоногоос дээшгүй байна. [...] Ээлжит бус чуулганаар төсвийг батлаагүй бол Ерөнхий сайд хоёр дахь ээлжит бус чуулганыг зарлахыг шаардана.
37.	Côte d'Ivoire 2016	<p>TITLE IV CHAPTER IV ARTICLE 95 Parliament is convened in extraordinary session by the President of each house on a set agenda, by the request of the President of the Republic or an absolute majority of its members. Extraordinary sessions are adjourned as soon as the agenda is exhausted.</p>	<p>- Ерөнхийлөгч, эсхүл нийт гишүүдийн олонхын саналаар танхим тус бүрийн Ерөнхийлөгч (дарга) хуралдуулна.</p>	-	- тогтсон асуудлаар
38.	Croatia 1991 (rev. 2013)	<p>IV 1 ARTICLE 78 The Croatian Parliament shall convene emergency sessions at the request of the President of the Republic, the Government or the majority of its members. The President of the Croatian Parliament may, upon prior consultation with the parliamentary clubs of members of the parliamentary parties, call it into an emergency session.</p>	<p>- Ерөнхийлөгч, Засгийн газар, эсхүл нийт гишүүдийн олонхын саналаар онцгой чуулганыг зарлана. - Парламентын ерөнхийлөгч (дарга) парламентад суудал бүхий намын бүлгийн гишүүдтэй зөвшилцөн онцгой чуулганыг зарлана.</p>	-	-
39.	Cuba 1976 (rev. 2002)	<p>CHAPTER X ARTICLE 78 The National Assembly of People's Power holds two regular</p>	<p>- гишүүдийн 1/3-ны саналаар, эсхүл Төрийн зөвлөл (ЗГ) -ийн саналаар;</p>	-	-



		sessions a year and a special session when requested by one-third of the membership or when called by the Council of State.			
40.	Czech Republic 1993 (rev. 2013)	CHAPTER II ARTICLE 34 While a session is adjourned, the Chairperson of the Assembly of Deputies or the Senate may summon their respective chambers to a meeting before the date designated therefor. They shall always do so should the President of the Republic, the government, or at least one-fifth of that chamber's members so request.	- Ерөнхийлөгч, Засгийн газар, эсхүл танхимын гишүүдийн 1/5-аас доошгүйн саналаар;	-	-
41.	Djibouti 1992 (rev. 2010)	TITLE IV ARTICLE 52 The National Assembly can be reunited in extraordinary session on a specific agenda at the demand of the President of the Republic, of the President of the National Assembly or at the demand of the absolute majority of the Deputies. The duration of an extraordinary session may not exceed fifteen days. The National Assembly recesses once the agenda is exhausted.	- Ерөнхийлөгч, Үндэсний Ассамблейн Ерөнхийлөгч (дарга), эсхүл нийт гишүүдийн олонхын шаардсанаар хэлэлцэхээр товлосон асуудлаар ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулна. Ээлжит бус чуулганы үргэлжлэх хугацаа 15 өдрөөс хэтрэхгүй ба Үндэсний Ассамблей нь хэлэлцээр товлосон асуудлаа хэлэлцэж дууссаны дараа хаагдана.	-	- тодорхой асуудлаар
42.	Dominica 1978 (rev. 2014)	CHAPTER III PART III 54 If, after a dissolution of Parliament and before the holding of the general election of Representatives, the Prime Minister advises the President that, owing to the existence of a state of war or of a state of emergency in Dominica, it is necessary to recall Parliament , the President shall summon the Parliament that has been dissolved to meet, but, unless the life of Parliament is extended under the provisions of subsection (3) of this section, the general election of Representatives shall proceed and the Parliament that has been recalled shall, if not sooner dissolved, again stand dissolved on the date appointed for the nomination of candidates in that general election.	- Парламент тарсны дараа, ерөнхий сонгууль явагдахаас өмнө Ерөнхийлөгч дайны байдал, эсхүл Доминикад онц байдал зарлах нөхцөл байдал үүсэж, Парламентыг хуралдуулах шаардлагатай гэж үзсэн бол, Ерөнхийлөгч тарсан Парламентыг зарлан хуралдуулна. Тарсан Парламент үүнээс өмнө тараагүй бол Парламентын сонгуульд нэр дэвшигчдийг тодруулах өдөр тарна.	-	- парламент тарсан үед, мөн парламентын сонгууль явуулахаас өмнө онц болон дайны байдал зарлах нөхцөл байдал үүссэн бол Ерөнхий сайд Ерөнхийлөгчид тарсан Парламентыг хуралдуулахыг зөвлөнө.
43.	Dominican Republic 2015	TITLE III CHAPTER II ARTICLE 89 DURATION OF THE LEGISLATURES The Executive Power shall be able to convoke them in an extraordinary manner.	- Гүйцэтгэх эрх барьж буй этгээд (Ерөнхийлөгч)	-	-
44.	Ecuador 2008 (rev. 2015)	TITLE IV CHAPTER 2 SECTION 1 ARTICLE 123 During recess, the President of the National Assembly, as such, at the request of the majority of the members of the Assembly or of the President of the Republic, shall convene special sessions to deal exclusively with the specific matters indicated in the call to meeting.	- Үндэсний Ассамблейн ерөнхийлөгч (дарга), эсхүл Ассамблейн нийт гишүүдийн олонх, эсхүл Ерөнхийлөгчийн саналаар тусгай хурал хуралдуулах ба гагцхүү хэлэлцэхээр товлосон асуудлаар тусгай чуулганыг хуралдуулна.	-	- гагцхүү тусгай хурал хуралдуулах болсон асуудлаар тусгай чуулганыг хуралдуулна.
45.	Egypt 2014	CHAPTER FIVE SECTION ONE ARTICLE 116 EXTRAORDINARY SESSION It is possible for the House of Representatives to be called to an extraordinary meeting to look into an urgent matter based on a request by the President of the Republic, or upon a request signed by at least 10 members from the House. CHAPTER FIVE SECTION TWO SUBSECTION ONE ARTICLE 156 DECREES THAT HAVE THE FORCE OF LAW In the event that the House of Representatives is not in session, and where there is a requirement for urgent measures that cannot be delayed , the President of the Republic convenes the House for an emergency session to present the matter to it. In absence of the House of Representatives, the President of the Republic may issue decrees that have the force of law, provided	- Ерөнхийлөгч, эсхүл 10-аас доошгүй гишүүний гарын үсэг зурсан хүсэлтийг үндэслэн ээлжит бус хурлыг хуралдуулна. - Чуулганы бус хугацаанд Ерөнхийлөгч онц чуулганыг хуралдуулж асуудлыг танилцуулна. Төлөөлөгчдийн танхим нь бүрэлдээгүй нөхцөлд Ерөнхийлөгч хуулийн хүчинтэй зарлиг гаргах ба тус зарлигийг шинэ Танхим хуралдсанаас 15 хоногийн дотор хэлэлцэн, батална. Дээрх	-	- яаралтай асуудлаар - хойшлуулшгүй, яаралтай арга хэмжээ шаардсан асуудлаар



		that these decrees are then presented to the House of Representatives, discussed and approved within 15 days from the date the new House convenes. If such decrees are not presented to the House and discussed, or if they are presented but not approved, their legality is revoked retroactively, without the need to issue a decision to that effect, unless the House affirms their validity for the previous period, or chooses to settle the consequent effects.	зарлигийг Танхимд өргөн бариагүй, эсхүл өргөн мэдүүлсэн боловч батлаагүй, парламентаас өөр ямарваа нэгэн шийдвэр гаргаагүй бол Ерөнхийлөгчийн зарлиг ямарваа нэгэн нэмэлт шийдвэр гаргалгүй хүчингүй болно.		
46.	El Salvador 1983 (rev. 2014)	TITLE VICHAPTER IIARTICLE 167 It corresponds to the Council of Ministers: 7th.To convoke extraordinarily the Legislative Assembly when the interests of the Republic demand it;	- Сайд нарын зөвлөл БНУ-ын ашиг сонирхлын үүднээс Парламентын ээлжит бус чуулган зарлан хуралдуулна.	-	- БНУ-ын ашиг сонирхлын үүднээс ээлжит бус чуулган зарлах шаардлагатай бол
47.	Equatorial Guinea 1991 (rev. 2012)	SECOND TITLE CHAPTER IV COMMON PROVISIONS OF THE CHAMBERS ARTICLE 70 2.On petition of the Government, the Chamber of Deputies and Senate are convoked ten days to meet in extraordinary session for a new deliberation. SECOND TITLE CHAPTER IV COMMON PROVISIONS OF THE CHAMBERS ARTICLE 71 If the Budgets are not presented by the Government in the course of the second ordinary session of the Chamber of Deputies and Senate, the President of the Republic will convoke an extraordinary session to this end.	- Засгийн газраас өргөдөл гаргасан бол Төлөөлөгчдийн танхим болон Сенатыг шинэ хэлэлцүүлэг явуулах ээлжит бус чуулганыг 10 хоног хуралдуулна. - Засгийн газраас хоёр дахь ээлжит чуулганаар Төлөөлөгчдийн танхим болон Сенатад төсвийг өргөн бариагүй бол Ерөнхийлөгч ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулна.	-	- хоёр дахь ээлжит чуулганаар төсвийг өргөн бариагүй бол
48.	Eritrea 1997	CHAPTER IV ARTICLE 36 2. At the request of the President, its Chairperson or one-third of all its members, the National Assembly shall convene emergency meetings.	- Ерөнхийлөгч, Дарга болон нийт гишүүдийн 1/3-ний саналаар	-	- онц хурлыг хуралдуулна
49.	Estonia 1992 (rev. 2015)	CHAPTER IV ARTICLE 68 Extraordinary sessions of the Riigikogu shall be convened by the Chairman of the Riigikogu, on the proposal of the President of the Republic, the Government of the Republic, or not less than one-fifth of the membership of the Riigikogu.	- Ерөнхийлөгч, Засгийн газар, эсхүл Парламентын нийт гишүүдийн 1/5-аас доошгүйн саналаар Парламентын дарга ээлжит бус чуулганыг зарлана.	-	-
50.	Ethiopia 1994	CHAPTER SIX PART ONE ARTICLE 58 4. The Speaker of the House may call a meeting of the House when it is in recess. The Speaker of the House is also obliged to call a meeting of the House at the request of more than one-half of the members.	Парламентын чуулганы завсарлагааны хугацаанд Парламентын дарга, танхимын нийт гишүүдийн талаас дээшихийн хүсэлтээр Парламентын дарга ээлжит бус хурлыг зарлана.	-	-
51.	Fiji 2013	CHAPTER 3 PART B67 4. If- a.Parliament is not in session; and b.the President receives a request in writing from not less than one-third of the members of Parliament requesting that Parliament be summoned to meet to consider without delay a matter of public importance, If- a.Parliament is in session but more than 2 months have elapsed between the sitting of Parliament; and b.the Speaker receives a request in writing from the Prime Minister or from not less than one-third of the members of Parliament requesting that a sitting be held to consider without delay a matter of public importance, CHAPTER 3 PART B67 4 the President shall summon Parliament to meet.	- Парламент хуралдаагүй үед, Ерөнхийлөгчид Парламентын 1/3-ээс доошгүй гишүүд олон нийтэд ач холбогдол бүхий асуудлаар, хойшлуулшгүй хэлэлцэх хүсэлтийг бичгээр гаргасан; - парламентын чуулган завсарлаагүй боловч хуралдааны хооронд 2 сар гаруй хугацаа өнгөрсөн, - Спикерт Ерөнхий сайд, эсхүл Парламентын гишүүдийн 1/3-ээс доошгүй гишүүд бичгээр олон нийтэд ач холбогдол асуудлаар, хойшлуулшгүй хуралдах хүсэлт гаргасан; - Спикер хүсэлт гаргасан өдрөөс хойш нэг долоо хоногийн дотор чуулганыг зарлан хуралдуулна.	- хүсэлт гаргаснаас нэг долоо хоногийн дотор	- олон нийтэд ач холбогдол бүхий асуудлаар; - олон нийтэд ач холбогдол бүхий асуудлаар.



		the Speaker must call a sitting of Parliament within one week of the date on which the request was made.			
52.	Finland 1999 (rev. 2011)	CHAPTER 4 SECTION 33 The parliamentary session continues until the time when the Parliament convenes for the following parliamentary session. However, the last parliamentary session of an electoral term shall continue until the Parliament decides to conclude its work. Thereafter, the President shall declare the work of the Parliament finished for that electoral term. However, the Speaker of the Parliament has the right to reconvene the Parliament, when necessary, before new elections have been held.	- парламентын чуулганы хуралдаан дараагийн парламентын чуулган хуралдах хүртэл үргэлжилнэ. Хэдий тийм ч, парламентын бүрэн эрхийн хугацааны сүүлийн чуулган Парламент үйл ажиллагаагаа дуусгах шийдвэр гаргах хүртэл үргэлжилнэ. Үүний дараа Ерөнхийлөгч Парламент бүрэн эрхийн хугацааны үйл ажиллагааг дуусгавар болгосныг зарлана. Спикер нь шинэ сонгууль явуулахаас өмнө Парламентын зарлан хуралдуулах эрхтэй байна.	-	
53.	France 1958 (rev. 2008)	TITLE IV ARTICLE 29 Parliament shall meet in extraordinary session, at the request of the Prime Minister or of the majority of the Members of the National Assembly, to debate a specific agenda. Where an extraordinary session is held at the request of Members of the National Assembly, this session shall be closed by decree once all the items on the agenda for which Parliament was convened have been dealt with, or not later than twelve days after its first sitting, whichever shall be the earlier. The Prime Minister alone may request a new session before the end of the month following the decree closing an extraordinary session.	- Ерөнхий сайд, эсхүл Үндэсний Ассамблейн гишүүдийн олонхын хүсэлтээр; - Үндэсний Ассамблейн гишүүдийн хүсэлтээр ээлжит бус чуулганыг зарласан тохиолд, тус чуулган нь тус чуулганаар хэлэлцэхээр товловсон асуудлыг хэлэлцэж дуусах хүртэл, эсхүл анх хуралдсан өдрөөс хойш 12 өдрөөс дээшгүй хугацаанд чуулна.	-	- тодорхой асуудлыг хэлэлцэх;
54.	Gabon 1991 (rev. 2011)	TITLE III ARTICLE 43 The Chambers of Parliament will reunite in an exceptional session, summoned by their presidents, for a specific agenda at the demand of either the President of the Republic proposed by the Prime Minister, or the absolute majority of their members. These exceptional sessions are opened and terminated by decree of the President of the Republic. They may not exceed a duration of fifteen (15) days. TITLE IV ARTICLE 48 If, during the budgetary session, Parliament adjourns without voting in a balanced budget, the Government is authorized to reuse, by Ordinance, the preceding budget. This Ordinance may nevertheless provision, in cases of necessity, any reduction of expenditures or augmentation of revenue. At the demand of the Prime Minister, Parliament will convene within fifteen (15) days in an exceptional session for a new deliberation. If Parliament does not vote in a balanced budget by the end of their exceptional session, the budget will be definitively established by Ordinance taken by the Council of Ministers, and signed by the President of the Republic.	- Парламентын танхим бүрийг тэдгээр танхимын дарга Ерөнхий сайдын санал гарган Ерөнхийлөгчийн шаардсанаар, эсхүл нийт гишүүдийн олонхын саналаар ээлжит бус чуулганыг зарлан чуулна. - Төсөв хэлэлцэж буй чуулганаар, Парламент нь тэнцвэртэй төсөв (balanced budget) батлалгүй завсарласан бол Засгийн газар тогтоол гарган өмнө баталсан төсвөө дахин мөрдөх эрхтэй байна. Шаардлагатай бол тус тогтоолоор аль ч төсвийн зардлыг бууруулах, эсхүл төсвийн орлогыг нэмэгдүүлж болно. Ерөнхий сайдын шаардсанаар Парламентын 15 хоногийн дотор шинээр хэлэлцүүлэгтэй холбоотойгоор ээлжит бус чуулганыг хуралдуулна. Ээлжит бус чуулганаар тэнцвэртэй төсвийг батлаагүй бол төсвийг Сайд нарын зөвлөл тогтоол гарган Ерөнхийлөгч гарын үсэг зурна.	-	- тодорхой асуудлаар; - Төсөв хэлэлцэж буй чуулганаар, Парламент нь тэнцвэртэй төсөв (balanced budget) батлалгүй завсарласан бол Засгийн газар тогтоол гарган өмнө баталсан төсвөө дахин хэрэглэх эрхтэй байна. Шаардлагатай бол тус тогтоолоор аль ч төсвийн зардлыг бууруулах, эсхүл төсвийн орлогыг нэмэгдүүлж болно. Ерөнхий сайдын шаардсанаар Парламентын 15 хоногийн дотор шинээр хэлэлцүүлэгтэй холбоотойгоор ээлжит бус чуулганыг хуралдуулна.
55.	Gambia (The) 1996 (rev. 2004)	CHAPTER VII PART 297 2. The President may request the Speaker summon a session of the National Assembly in the event of a declaration of a public emergency under section 34. 2. At any time when The Gambia is at war or a state of emergency is declared, the National assembly may, by resolution supported by the votes of not less than two-thirds of all the members, extend the life of the National Assembly for not more than three months at a time, but the life of the National Assembly shall not be extended under this subsection for more	- Онц байдал зарлах нөхцөлд Ерөнхийлөгч Спикерт Үндэсний ассамблейг хуралдуулах хүсэлт тавьж болно. - Дайны, эсхүл онц байдал зарласан тохиолдолд Үндэсний Ассамблейг нийт гишүүдийн дийлэнх олонхын саналаар (2/3) дэмжсэн тогтоолоор нэг удаад 3 сараас дээшгүй хугацаагаар чуулахгүй ба энэ хэсэгт заасан үндэслэлээр чуулахад нийтдээ 1 жилээс дээшгүй байна.	-	- онц байдал зарлах

		than a total period of one year.			
56.	Georgia 1995 (rev. 2013)	CHAPTER THREE ARTICLE 61 2. The President of Georgia shall convene a special session of Parliament at the request of the Chairperson of Parliament, or that of not less than one fourth of MPs, or on the recommendation of the Government during the period between regular sessions. In the course of a regular session, the President shall convene a special meeting under the same procedure. Unless an act of summoning Parliament is issued within 48 hours after a written request, Parliament shall assemble within the following 48 hours according to Parliamentary Rules.	Парламентын дарга, эсхүл гишүүдийн ¼-ээс доошгүйн саналаар, эсхүл ээлжит чуулганы хооронд Загсийн газрын зөвлөмжийг үндэслэн Ерөнхийлөгч Парламентын тусгай чуулганыг хуралдуулна.	48 цагийн дотор	-
57.	Germany 1949 (rev. 2014)	III ARTICLE 39 3. The Bundestag shall determine when its sessions shall be adjourned and resumed. The President of the Bundestag may convene it at an earlier date. He shall be obliged to do so if one third of the Members, the Federal President or the Federal Chancellor so demand. IV ARTICLE 52 2. The President shall convene the Bundesrat. He shall be obliged to do so if the delegates of at least two Länder or the Federal Government so demand.	Бундестаг нь чуулганаа нээх, хаах тухай шийдвэр гаргана. Бундестагийн Ерөнхийлөгч нь хугацаанаас өмнө зарлан хуралдуулж болно. Ингэхдээ гишүүдийн 1/3-ийн шаардсанаар, Холбооны Ерөнхийлөгч, эсхүл Холбооны Канцлерийн шаардсанаар зарлан хуралдуулна. Ерөнхийлөгч Бундесратыг зарлан хуралдуулна. Ингэхдээ хоёроос доошгүй Ландерын төлөөлөгч, эсхүл Холбооны Засгийн газарын шаардсанаар зарлан хуралдуулна.	-	-
58.	Ghana 1992 (rev. 1996)	CHAPTER 10 PART III 112 3. Notwithstanding any other provision of this article, fifteen percent of members of Parliament may request a meeting of Parliament; and the Speaker shall, within seven days after the receipt of the request, summon Parliament. 3. Where, after a dissolution of Parliament but before the holding of a general election, the President is satisfied that owing to the existence of a state of war or of a state of public emergency in Ghana or any part of Ghana, it is necessary to recall Parliament, the President shall cause to be summoned the Parliament that has been dissolved to meet.	- Парламентын гишүүдийн 15 хувь; - Парламент тарсны дараа, ерөнхий сонгууль явагдахаас өмнө Ерөнхийлөгч дайны, эсхүл Гана, түүний аль нэг хэсэгт онц байдал зарлах нөхцөл гэж үзэн Парламентын зарлан хуралдуулах шаардлагатай бол, Ерөнхийлөгч тарсан Парламентыг зарлан хуралдуулж болно.	- хүсэлт хүлээж авснаас хойш 7 хоногийн дотор Парламентыг зарлан хуралдуулна.	- Парламент тарсны дараа, ерөнхий сонгууль явагдахаас өмнө Ерөнхийлөгч дайны, эсхүл Гана, түүний аль нэг хэсэгт онц байдал зарлах нөхцөл гэж үзэн Парламентын зарлан хуралдуулах шаардлагатай бол, Ерөнхийлөгч тарсан Парламентыг зарлан хуралдуулж болно.
59.	Greece 1975 (rev. 2008)	PART 3 SECTION II CHAPTER 2 ARTICLE 40 The President of the Republic shall convoke Parliament to a regular session once a year as specified in article 64 paragraph 1 and to an extraordinary session whenever he shall judge this to be reasonable , and he shall proclaim the commencement and termination of each parliamentary term in person or through the Prime Minister	- Ерөнхийлөгч үндэслэлтэй гэж үзсэн бүрд ээлжит бус чуулганыг зарлах хуралдуулах бөгөөд чуулганы нээлт, хаалт бүрийг биечлэн, эсхүл Ерөнхий сайдаар дамжуулан зарлана.	-	- Ерөнхийлөгч үндэслэлтэй гэж үзсэн
60.	Grenada 1973 (reinst. 1991, rev. 1992)	CHAPTER III PART III 52 The Governor-General may at any time prorogue or dissolve Parliament.	- Амбан захирагч аль ч үед Парламентыг чуулганыг завсарлуулж, тараах эрхтэй байна.	-	-
61.	Guatemala 1985 (rev. 1993)	TITLE IV CHAPTER II FIRST SECTION ARTICLE 158 SESSIONS OF THE CONGRESS The annual period of sessions of the Congress is initiated the fourteenth of January of each year without [the] necessity of convocation. The Congress will meet in ordinary sessions from the fourteenth of January to the fifteenth of May and from the first of August to the thirtieth of November of each year. It will meet in extraordinary sessions when it is convoked by the Permanent Commission or by the Executive Organ to take cognizance of the matters that motivated the convocation. It can take cognizance of other matters with the favorable vote of the	- ээлжит бус чуулганыг Байнгын комисс, эсхүл Гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага зарлан хуралдуулах болсон асуудлаар хуралдана. Бусад асуудлаар нийт гишүүдийн дийлэнх олонхын (2/3) саналаар хэлэлцэнэ. Гишүүдийн 25-аас дээш хувь Байнгын комисст хүсэлт гаргаснаар хангалттай үндэслэл бүхий, эсхүл нийтийн эрх ашигтай холбоотой асуудлаар Конгрессыг зарлан хуралдуулж болно. Гишүүдийн талаас дээш хувь нь санал гарсан тохиолдолд Байнгын комисс нэн даруй зарлан хуралдуулна.	- Гишүүдийн талаас дээш хувь нь санал гарсан Конгрессыг зарлан хуралдуулж болно.	- Гишүүдийн 25-аас дээш хувь Байнгын комисст хүсэлт гаргаснаар хангалттай үндэслэл бүхий, эсхүл нийтийн эрх ашигтай холбоотой асуудлаар Конгрессыг зарлан хуралдуулж болно.

		absolute majority of the total of the Deputies that integrate it. Twenty-five percent of the Deputies or more have the right to request of the Permanent Commission the convocation of the Congress for sufficient reasons of necessity or [of] public convenience . If it is requested by at least half plus one of the total [number] of Deputies, the Permanent Commission shall proceed immediately to the convocation.			
62.	Guinea 2010	TITLE IV ARTICLE 69 The National Assembly meets in extraordinary session either at the initiative of the President of the Republic, or at the demand of the majority of the members who compose it, on a determined agenda . The extraordinary session is closed as soon as the National Assembly has exhausted the agenda. The Deputies may not demand a new extraordinary session before the expiration of the month following the closure of a session. Except in the cases where the National Assembly meets as of plain right, the extraordinary sessions are opened or closed by decree.	- Ерөнхийлөгчийн санаачилгаар, эсхүл нийт гишүүдийн олонхын шаардсанаар хэлэлцэхээр товлосон асуудлаар Үндэсний Ассамблейн ээлжит бусаар чуулна.	- Гишүүд чуулган хаагдсан сарыг дуустал шинэ ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулахыг шаардах эрхгүй байна.	- хэлэлцэхээр товлосон асуудлаар
63.	Guinea-Bissau 1984 (rev. 1996)	PART III SECTION II ARTICLE 68 Are exclusive roles of the President of the Republic: d.Summon an extraordinary meeting of the National Popular Assembly every time imperious public interest reasons so justify ; PART III SECTION IV ARTICLE 89 The National Popular Assembly will gather in extraordinary sessions when so requested by the President of the Republic, Congressmen, the Government or its Standing Committee. PART III SECTION IV ARTICLE 953 The Standing Committee is competent to: c.Convoked the National Popular Assembly whenever necessary ;	- Ерөнхийлөгчийн онцгой бүрэн эрх: Үндэсний нийтийн ассамблейн ээлжит бус чуулганыг нийтийн эрх ашгийн асуудлаар зарлан хуралдуулна. - Ерөнхийлөгч, гишүүд, Засгийн газар, эсхүл Байнгын хороодын саналаар Үндэсний нийтийн ассамблейн ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулна.	- Байнгын хороо ҮНА-г шаардлагатай үед зарлан хуралдуулна.	- Ерөнхийлөгчийн Үндэсний нийтийн ассамблейн ээлжит бус чуулганыг нийтийн эрх ашгийн асуудлаар зарлан хуралдуулна. - Байнгын хороо ҮНА-г шаардлагатай үед зарлан хуралдуулна.
64.	Guyana 1980 (rev. 2016)	PART 1 CHAPTER VI SUMMONING PROROGATION AND DISSOLUTION 70 If, after a dissolution and before the holding of an election of members of the Assembly, pursuant to the provisions of article 61, the President considers that owing to the existence of a state of war or of a state of emergency in Guyana or any part thereof, it is necessary to recall Parliament , the President shall summon the Parliament that has been dissolved to meet, but the election of members of the Assembly shall proceed and the Parliament that has been recalled shall, if not sooner dissolved, again stand dissolved on the day before the day on which the election is held.	- Ассамблей тарсан үед, сонгууль явагдахаас өмнө Ерөнхийлөгч дайны, эсхүл Гиана, түүний аль нэг хэсэгт онц байдал зарлах нөхцөл байдал үүссэн гэж үзэн Парламентыг хуралдуулах шаардлагатай бол, Ерөнхийлөгч тарсан Парламентыг зарлан хуралдуулна.	-	- дайны, эсхүл Гиана, түүний аль нэг хэсэгт онц байдал зарлах нөхцөл байдал үүссэн гэж үзэн
65.	Haiti 1987 (rev. 2012)	TITLE V CHAPTER II SECTION B ARTICLE 95-2 The Senate may however adjourn, but not during the Legislative Section. When it adjourns, it leaves a permanent, committee charged with handling current business. The committee may not make any decisions, except to convene the Senate. In emergencies , the Executive may also convene the Senate before the end of the adjournment period. TITLE V CHAPTER II SECTION C ARTICLE 101 In emergencies , when the Legislature is not in session, the Executive Power may call a special session of the National	- Сенат завсарласан үед байнгын, хороод өдөр тутмын үйл ажиллагааг хариуцах ба хороо нь Сенатыг зарлан хуралдуулахаас өөр шийдвэр гаргахгүй. - Онц байдалд Гүйцэтгэх эрх мэдэлтэн Сенатын чуулганы завсарлагаа дуусахаас өмнө тусгай чуулганыг зарлан хуралдуулж болно. - Ерөнхийлөгч нь ээлжит чуулганы завсарлагаанаар, онц байдалд тусгай чуулганыг хуралдуулна.	-	- онц байдал

		Assembly. TITLE V CHAPTER II SECTION D ARTICLE 105 In the interval between regular sessions and in emergencies , the President of the Republic may call a special session of the Legislature.			
66.	Honduras 1982 (rev. 2013)	TITLE V CHAPTER I ARTICLE 190 The National Congress shall also hold special sessions: 1.At the request of the Executive Branch; 2.When convoked by its Permanent Committee; and 3.Whenever half plus one of its members so agree. In such cases it shall deal only with matters that caused the respective decree of convocation. TITLE V CHAPTER I ARTICLE 191 Five or more Representatives may convoke the National Congress into special sessions anywhere in the Republic whenever the Executive, another authority, force majeure or an act of God prevent the installation of Congress or the holding of its meetings. TITLE V CHAPTER I ARTICLE 208 The powers of the Permanent Committee are the following: 8.To convoke the National Congress for special sessions, at the request of the executive branch or whenever the exigent circumstances so require ; TITLE V CHAPTER VI ARTICLE 245 The President of the Republic shall be responsible for the general administration of the state; his powers and duties are as follows: 6.To convene the National Congress in special sessions through the Permanent Committee or to propose the continuance of regular sessions;	Үндэсний Конгресс нь тусгай чуулганыг дараах тохиолдолд зарлан хуралдуулна: - гүйцэтгэх эрх мэдлийн саналаар; - Байнгын хороо зарласан бол; - гишүүдийн талаас дээш хувь нь шийдсэн бол. Эдгээр тохиолдолд гагцхүү хэлэлцэхээр товловсон асуудлыг хэлэлцэнэ. - Засгийн газар, өөр аливаа эрх мэдэлтэн, эсхүл давагдашгүй хүчин зүйл Конгрессын чуулганыг хуралдуулахад саад учруулсан бол тав ба түүнээс дээш тооны гишүүд тусгай чуулганыг БНУ-ын аль ч хэсэгт зарлан хуралдуулж болно. - Байнгын хороо нь дараахь эрхийг эдэлнэ: Гүйцэтгэх эрх мэдлийн саналаар, эсхүл хойшлуулшгүй хүчин зүйлийн улмаас Үндэсний Конгрессын тусгай чуулганыг зарлан хуралдуулна. Ерөнхийлөгчийн бүрэн эрх: - Байнгын хороогоор дамжуулан Үндэсний Конгрессын тусгай чуулганыг зарлан хуралдуулах, эсхүл	-	Засгийн газар, өөр аливаа эрх мэдэлтэн, эсхүл давагдашгүй хүчин зүйл Конгрессын чуулганыг хуралдуулахад саад учруулсан бол;
67.	Iceland 1944 (rev. 2013)	II ARTICLE 23 If sessions of Althingi have been adjourned, the President of the Republic may nevertheless convene Althingi as deemed necessary . Moreover, the President is obliged to do so upon the request of a majority of the Members of Althingi.	Ерөнхийлөгч шаардлага гэж үзсэн бол Парламентын чуулганыг завсарлагааны хугацаанд Парламентын чуулганыг хуралдуулж болно. Мөн Ерөнхийлөгч Парламентын гишүүдийн олонхын саналаар Парламентын чуулганыг зарлан хуралдуулах үүрэгтэй байна.	-	Ерөнхийлөгч шаардлага гэж үзсэн бол
68.	India 1949 (rev. 2016)	PART V CHAPTER II GENERAL 85 The President shall from time to time summon each House of Parliament to meet at such time and place as he thinks fit, but six months shall not intervene between its last sitting in one session and the date appointed for its first sitting in the next session.	Парламентын танхимуудыг Ерөнхийлөгч зохимжтой гэж үзсэн хугацаа болон газар зарлан хуралдуулах бөгөөд нэг чуулганы сүүлийн хурал болон товловсон дараагийн чуулганы эхний хурлын хоёрын хооронд 6 сараас доош хугацаагаар товлоно.	-	-
69.	Iran (Islamic Republic of) 1979 (rev. 1989)	CHAPTER VI SECTION 1 ARTICLE 68 In time of war and the military occupation of the country, elections due to be held in occupied areas or countrywide may be delayed for a specified period if proposed by the President of the Republic, and approved by three-fourths of the total members of the Islamic Consultative Assembly, with the endorsement of the Guardian Council. If a new Assembly is not formed, the previous one will continue to function.	Дайн болон улсын нутаг дэвсгэрт цэргийн хүчээр халдан довтолсон үед халдлагад өртсөн бүс нутаг, эсхүл улс орон даяар явагдах сонгуулийг тодорхой хугацаагаар хойшлуулах саналыг Ерөнхийлөгч гарган, Парламентын нийт гишүүдийн 3/4-ны саналаар баталж, Харгалзагчдын зөвлөл батламжилна. Шинэ Парламент бүрдээгүй бол өмнөх Парламент үйл ажиллагааг үргэлжлүүлнэ. (P-L-Guardian council)	-	- дайн болон улсын нутаг дэвсгэрт цэргийн хүчээр халдан довтолсон үед [...] шинэ Парламент бүрдээгүй бол өмнөх Парламент үйл ажиллагааг үргэлжлүүлнэ.
70.	Iraq 2005	SECTION THREE CHAPTER ONE ONE ARTICLE 58 SECTION THREE CHAPTER ONE ONE ARTICLE 58 FIRST	Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Төлөөлөгчдийн Зөвлөлийн Спикер, эсхүл Төлөөлөгчдийн	-	- ээлжит бус чуулганаар чуулганыг зарлан хуралдуулсан, сэдвээс

		The President of the Republic, the Prime Minister, the Speaker of the Council of Representatives, or fifty members of the Council of Representatives may call the Council to an extraordinary session. The session shall be restricted to the topics that necessitated the call for the session.	Зөвлөлийн 50 гишүүн Зөвлөлийг ээлжит бус чуулганыг хуралдуулж болно.		бусад асуудлыг хэлэлцэхгүй.
71.	Ireland 1937 (rev. 2015)	THE PRESIDENT ARTICLE 132 3°.The President may at any time, after consultation with the Council of State, convene a meeting of either or both of the Houses of the Oireachtas.	Ерөнхийлөгч Төрийн Зөвлөлтэй зөвшилцсөний дараа, Парламентын аль нэг танхим, эсхүл хоёуланг нь аль ч үед зарлан хуралдуулж болно.	-	-
72.	Italy 1947 (rev. 2012)	PART II TITLE I SECTION I ART 62 Each House may be convened in special session on the initiative of its President, the President of the Republic or a third of its members.	Парламентын танхимын дарга нар, Ерөнхийлөгч, эсхүл Парламентын гишүүдийн 1/3-ний саналаар тусган Парламентын танхимуудын тусгай чуулганыг хуралдуулна.	-	-
73.	Japan 1946	CHAPTER IV ARTICLE 53 The Cabinet may determine to convoke extraordinary sessions of the Diet. When a quarter or more of the total members of either House makes the demand, the Cabinet must determine on such convocation.	Кабинет нь Парламентын ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулж болно. Аль нэг танхимын 1/4-ээс дээшихийн шаардсанаар Кабинет дээрх шийдвэрийг гаргана.	-	-
74.	Jordan 1952 (rev. 2016)	CHAPTER 6 PART 3 ARTICLE 82 The King may whenever necessary summon the Parliament to meet in extraordinary sessions for an unspecified period for every session for the purpose of deciding certain matters to be specified in the Royal Decree when the summons are issued. The extraordinary session shall be prorogued by a Decree The King shall summon the Parliament to meet in extraordinary sessions as well when requested by the absolute majority of the House of Representatives by a petition signed thereby indicating the matters desired to be discussed. The Parliament may not discuss in any extraordinary session except the matters specified in the Royal Decree by virtue of which the session is convened.	Эзэн хаан шаардлагатай гэж үзсэн үедээ Парламентын ээлжит бус чуулганыг тодорхой бус хугацаагаар, Эзэн хааны зарлигт тодорхой тусгасан асуудлыг хэлэлцүүлэхээр завсарлуулж болно. Эзэн хаан Төлөөлөгчдийн танхимын нийт гишүүдийн хэлэлцэх асуудлаа тусгасан өргөдлөө гарын үсэг зурж баталгаажуулсныг үндэслэн Парламентын ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулна.	-	Парламент нь ээлжит бус чуулганаар хэлэлцэхээр товлосон Эзэн хааны зарлигт зааснаас бусад асуудлыг хэлэлцэхгүй.
75.	Kazakhstan 1995 (rev. 2017)	SECTION III ARTICLE 441 The President of the Republic of Kazakhstan shall: 2. call extraordinary session of the Parliament; SECTION IV ARTICLE 59 In the period between Parliament's sessions, the President of the Republic of Kazakhstan may call an extraordinary session of the Parliament on his own initiative, at the suggestion of the chairpersons of the Chambers or no less than one-thirds from the total number of the deputies of the Parliament. Only the issues that were the reason for convocation shall be reviewed at this session.	Ерөнхийлөгч нь: Парламентын ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулна. Парламентын чуулганы завсарлагааны хугацаанд Ерөнхийлөгч өөрийн санаачилгаар, эсхүл Танхимуудын дарга нарын саналаар, эсхүл Парламентын нийт гишүүдийн 1/3-ээс доошгүйн саналаар Парламентын ээлжит бус чуулганыг хуралдуулна.	-	- ээлжит бус чуулганаар чуулганыг зарлан хуралдуулсан сэдвээс бусад асуудлыг хэлэлцэхгүй.
76.	Kenya 2010	CHAPTER 8 PART 2102 When Kenya is at war, Parliament may, by resolution supported in each House by at least two-thirds of all the members of the House, from time to time extend the term of Parliament by not more than six months at a time.	Дайны байдалд Парламент хоёр танхимын нийт гишүүдийн дийлэнх олонхын (2/3) дэмжсэнээр Парламентын бүрэн эрхийн хугацааг сунгаж болох ба нэг удаад 6 сараас хэтрэхгүй байна.	-	-
77.	Kiribati 1979 (rev. 2013)	CHAPTER V PART III 77 The Beretitenti or one-third of the members of the Maneaba may, subject to the provisions of this Constitution and of the rules of procedure of the Maneaba, advise the Speaker to summon the Maneaba at any time.	Беретиенти, эсхүл Парламентын гишүүдийн 1/3-ны саналаар Үндсэн хууль болон дэгд заасны дагуу Спикерт Парламентыг аль ч үед зарлан хуралдуулж болно.	-	-



78.	Korea (Republic of) 1948 (rev. 1987)	<p>CHAPTER III ARTICLE 47 A regular session of the National Assembly shall be convened once every year as prescribed by law, and extraordinary sessions of the National Assembly shall be convened upon the request of the President or one fourth or more of the total members. The period of regular sessions shall not exceed a hundred days and of extraordinary sessions thirty days. If the President requests the convening of an extraordinary session, the period of the session and the reasons for the request shall be clearly specified. CHAPTER IV PART 2 SECTION 2 ARTICLE 89 The following matters shall be referred to the State Council for deliberation: 7.Requests for convening an extraordinary session of the National Assembly;</p>	Ерөнхийлөгч, эсхүл нийт гишүүдийн 1/4 ба түүнээс дээшхийн саналаар Парламентын ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулна.	-	Ерөнхийлөгч ээлжит бус чуулганыг хуралдуулах хүсэлт гаргасан тохиолдолд, ээлжит бус чуулганы үргэлжлэх хугацаа болон хүсэлт гаргах болсон шалтгааныг нарийвчлан заана.
79.	Kosovo 2008 (rev. 2016)	<p>CHAPTER IV ARTICLE 69 The Assembly of Kosovo convenes an extraordinary meeting upon the request of the President of the Republic of Kosovo, the Prime Minister or one third (1/3) of the deputies.</p>	Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, эсхүл гишүүдийн 1/3-ний саналаар Парламентын ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулна.	-	-
80.	Kuwait 1962 (reinst. 1992)	<p>PART IV CHAPTER III ARTICLE 88 By Decree should the Amir find it necessary, or upon the request of a majority of its members, the National Assembly may be summoned to an extraordinary convention. At the extraordinary convention, the Assembly shall not, save with the Cabinet's approval, debate matters other than those for which it was convoked.</p>	Эмир шаардлагатай гэж үзсэн Зарлиг гаргасан, эсхүл нийт гишүүдийн олонхын саналаар Үндэсний Ассамблейн ээлжит бус чуулганыг хуралдуулна.	-	Ээлжит бус чуулганаар, Кабинетын зөвшөөрснөөс бусад мөн ээлжит бус чуулганаар хэлэлцэхээс товлосноос бусад асуудлыг хэлэлцэхгүй.
81.	Kyrgyzstan 2010 (rev. 2016)	<p>SECTION III ARTICLE 64 (2) 2. The President: 2. shall have the right to convene an extraordinary sitting of the Jogorku Kenesh and define the issues for consideration thereof; SECTION IV CHAPTER II ARTICLE 77 The Toraga of the Jogorku Kenesh shall convene extraordinary sessions of the Jogorku Kenesh at the proposal of the President, the Government or not less than one third of the deputies of the Jogorku Kenesh.</p>	Ерөнхийлөгч нь Парламентын ээлжит бус чуулганы хуралдааныг зарлан хуралдуулж, хэлэлцэх асуудлыг тодорхойлох эрхтэй байна.	-	Ерөнхийлөгч нь Парламентын ээлжит бус чуулганы хуралдааныг зарлан хуралдуулж, хэлэлцэх асуудлыг тодорхойлох эрхтэй байна.
82.	Lao People's Democratic Republic 1991 (rev. 2003)	<p>CHAPTER V ARTICLE 57 The National Assembly convenes its ordinary session twice a year at the summons of the National Assembly Standing Committee. The National Assembly Standing Committee may convene an extraordinary session of the National Assembly if it deems it necessary.</p>	Үндэсний Ассамблейн Байнгын Хороо нь шаардлагатай гэж үзвэл Үндэсний Ассамблейн ээлжит бус чуулганыг хуралдуулж болно.	-	-
83.	Latvia 1922 (reinst. 1991, rev. 2016)	<p>CHAPTER II ARTICLE 19 The Presidium shall convene sessions of the Saeima and schedule regular and extraordinary sittings. CHAPTER II ARTICLE 20 The Presidium shall convene sittings of the Saeima if requested by the President, the Prime Minister, or not less than one third of the members of the Saeima.</p>	Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, эсхүл Парламентын гишүүдийн 1/3-ээс доошгүйн саналаар Президиум (Парламентын даргалагч нар) Парламентын ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулна.	-	-
84.	Lebanon 1926 (rev. 2004)	<p>PART II CHAPTER THREE ARTICLE 33 Ordinary sessions begin and end, de jure, as scheduled by Article 32. The President of the Republic, in agreement with</p>	- Ерөнхийлөгч, Засгийн газрын тэргүүнтэй зөвшилцөн Төлөөлөгчдийн Танхимын ээлжит бус чуулганыг Зарлигаар нээлт, хаалт болон хэлэлцэх	Төлөөлөгчийн танхим төсвийн төслийг	- Ерөнхийлөгч, Засгийн газрын тэргүүнтэй зөвшилцөн Төлөөлөгчдийн Танхимын ээлжит



		<p>the Head of Government may convene the Chamber of Deputies to extraordinary sessions by a decree setting their opening, end, and agenda. The President of the Republic is required to convene the Chamber to extraordinary sessions in response to the request made by the absolute majority of all its members.</p> <p>PART II CHAPTER FOUR SECOND ARTICLE 64</p> <p>The Prime Minister is the Head of Government. He represents it, speaks in its name, and is responsible for executing the public policy made by the Council of Ministers. He assumes the following powers:</p> <p>5.He signs the decree to open an extraordinary session and the decrees promulgating the laws and the request to reconsider them.</p> <p>PART IV B ARTICLE 86</p> <p>If the Chamber of Deputies does not decide definitely in the matter of the budget proposal before the expiration of the session devoted for its examination, then the President of the Republic, with the agreement of the Head of Government, convenes the Chamber immediately to an extraordinary session lasting to the end of January to continue the budget examination.</p>	<p>асуудлын товыг тусган зарлан хуралдуулна.</p> <p>- Төлөөлөгчийн танхим төсвийн төслийг хэлэлцэх чуулганы хугацаанд тодорхой шийдвэр гаргаагүй бол Ерөнхийлөгч нь Засгийн газрын тэргүүнтэй зөвшилцөн Танхим танхимыг нэн даруй ээлжит бус чуулган зарлан хуралдуулна. Ээлжит бус чуулганаар төсвийн төслийн хэлэлцүүлгийг үргэлжлүүлэх ба 1-р сарын сүүл хүртэл үргэлжилнэ.</p>	<p>хэлэлцэх чуулганы хугацаанд тодорхой шийдвэр гаргаагүй бол Ерөнхийлөгч нь Засгийн газрын тэргүүнтэй зөвшилцөн Танхим танхимыг нэн даруй ээлжит бус чуулган зарлан хуралдуулна.</p>	<p>бус чуулганыг Зарлигаар нээлт, хаалт болон хэлэлцэх асуудлын товыг тусган зарлан хуралдуулна.</p> <p>- Төлөөлөгчийн танхим төсвийн төслийг хэлэлцэх чуулганы хугацаанд тодорхой шийдвэр гаргаагүй бол Ерөнхийлөгч нь Засгийн газрын тэргүүнтэй зөвшилцөн Танхим танхимыг нэн даруй ээлжит бус чуулган зарлан хуралдуулна. Ээлжит бус чуулганаар төсвийн төслийн хэлэлцүүлгийг үргэлжлүүлэх ба 1-р сарын сүүл хүртэл үргэлжилнэ.</p>
85.	Lesotho 1993 (rev. 2011)	<p>CHAPTER VI PART 384</p> <p>2. If, after a dissolution of Parliament and before the holding of a general election of members of the National Assembly, the King is advised by the Council of State that, owing to a state of war or of a state of emergency in Lesotho, it is necessary to recall Parliament, the King shall recall the Parliament that has been dissolved and that Parliament shall be deemed to be the Parliament for the time being (and the members of the dissolved Parliament shall be deemed to be the members of the recalled Parliament), but the general election of members of the National Assembly shall proceed and the recalled Parliament shall, if not sooner dissolved, stand dissolved on the day immediately preceding the day fixed for such general election or, if more than one such day, the first of such days.</p>	<p>Парламент тарсны дараа, ерөнхий сонгууль явагдахаас өмнө Төрийн Зөвлөлийн саналыг үндэслэн Хаан дайны, эсхүл Лесото, түүний аль нэг хэсэгт онц байдал зарлах нөхцөл гэж үзсэн бол, Хаан тарсан Парламентыг зарлан хуралдуулж болно.</p>	-	<p>Парламент тарсны дараа, ерөнхий сонгууль явагдахаас өмнө Төрийн Зөвлөлийн саналыг үндэслэн Хаан дайны, эсхүл Лесото, түүний аль нэг хэсэгт онц байдал зарлах нөхцөл гэж үзсэн бол, Хаан тарсан Парламентыг зарлан хуралдуулж болно.</p>
86.	Liberia 1986	<p>CHAPTER V ARTICLE 32</p> <p>b. The President shall, on his own initiative or upon receipt of a certificate signed by at least one-fourth of the total membership of each House, and by proclamation, extend a regular session of the Legislature beyond the date for adjournment or call a special extraordinary session of that body to discuss or act upon matters of national emergency and concern. When the extension or call is at the request of the Legislature, the proclamation shall be issued not later than forty-eight hours after receipt of the certificate by the President.</p>	<p>Ерөнхийлөгч өөрийн санаачилгаар, эсхүл Танхим тус бүрийн нийт гишүүдийн 1/4-ээс доошгүйн гарын үсэг зурсан баримтыг үндэслэн үндэсний онцгой байдал болон холбогдох асуудлаар ээлжит чуулганы хугацааг сунгах буюу ээлжит бус чуулганыг тунхаглан зарлана.</p>	<p>Парламентаас ээлжит бус чуулган зарлах, эсхүл сунгах хүсэлт гаргасан бол Ерөнхийлөгчөөс гэрчилгээ гаргаснаас 48 цагийн дотор зарлан хуралдуулна.</p>	<p>Үндэсний онцгой байдал болон холбогдох асуудлаар ээлжит бус чуулган хуралдана.</p>
87.	Liechtenstein 1921 (rev. 2011)	<p>CHAPTER V ART 48</p> <p>2. In pursuance of a substantiated written request submitted by not less than 1,000 citizens entitled to vote or of a resolution adopted by the communal assemblies of not less than three communes, Parliament must be convened.</p>	<p>Үндэслэл бүхий хүсэлт гаргасан санал өгөх эрхтэй 1000-аас доошгүй иргэдийн саналаар, эсхүл 3 доошгүй коммуны ассамблей тогтоолоор Парламентын чуулганыг хуралдуулна.</p>	<p>Эзэн хааны суудлыг залгамжлах тунхаг бичиг болон хаан төрдөө тохиолдолд 30 хоногийн дотор</p>	<p>Эзэн хааны суудлыг залгамжлах тунхаг бичиг болон хаан төрдөө үнэнч зүтгэх тангарах өргүүлэхээр 30 хоногийн дотор Парламентын</p>

		CHAPTER V ART 51 In the case of an accession to the Throne, Parliament shall be convened to an extraordinary session within 30 days for the purpose of receiving the declaration of the Prince Regnant as provided for in Art. 13 and of taking the oath of allegiance.		Парламентын ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулна.	ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулна.
88.	Lithuania 1992 (rev. 2006)	CHAPTER V ARTICLE 64 Extraordinary sessions shall be convened by the Speaker of the Seimas on the proposal of not less than [1/3] one-third of all the Members of the Seimas, and, in cases provided for in the Constitution, by the President of the Republic. CHAPTER VI ARTICLE 84 The President of the Republic: 19.shall convene, in cases provided for in the Constitution, an extraordinary session of the Seimas; CHAPTER XIII ARTICLE 144 When a threat arises for the constitutional system or social peace of the State, the Seimas may impose a state of emergency throughout the territory of the State, or in any part of it. The period of the state of emergency shall not exceed six months. In cases of urgency , between sessions of the Seimas, the President of the Republic shall have the right to adopt such a decision and convene, at the same time, an extraordinary session of the Seimas for the consideration of this issue. The Seimas shall approve or overrule the decision of the President of the Republic.	Парламентын нийт гишүүдийн 1/3-аас доошгүйн саналаар, эсхүл үндсэн хуульд зааснаар Ерөнхийлөгч санал гаргаснаар Спикер ээлжит бус чуулганыг зарлана.	Яаралтай тохиолдолд Сеймийн хуралдаагүй үед БНУ-ын Ерөнхийлөгч дээрх шийдвэрийг гаргах ба нэгэн зэрэг Сеймийн ээлжит бус хуралдааныг зарлан тухайн асуудлыг хэлэлцүүлнэ.	Улс орны Үндсэн хуулийн институцийн тогтолцоо, эсхүл нийгмийн амар амгалан байдалд аюул занал үүссэн тохиолдолд Сейм нь тухайн улсын нутаг дэвсгэрт буюу түүний аль ч хэсэгт онц байдал тогтоож болно. Онц байдлын хугацаа 6 сараас хэтрэхгүй байна. Яаралтай тохиолдолд Сеймийн хуралдаагүй үед БНУ-ын Ерөнхийлөгч дээрх шийдвэрийг гаргах ба нэгэн зэрэг Сеймийн ээлжит бус хуралдааныг зарлан тухайн асуудлыг хэлэлцүүлнэ.
89.	Luxembourg 1868 (rev. 2009)	CHAPTER IV ARTICLE 72 The Grand Duke may convoke the Chamber extraordinarily; he must do so on the demand of one-third of the Deputies.	Гишүүдийн 1/3-ийн шаардсанаар Их Герцог Танхимыг ээлжит бусаар хуралдуулна.	-	-
90.	Madagascar 2010	TITLE III SUB-TITLE II CHAPTER I ARTICLE 76 The National Assembly meets in extraordinary session, on a determined agenda , by decree of the President of the Republic taken in the Council of Ministers, either by the initiative of the Prime Minister or at the demand of the absolute majority of the members composing the National Assembly. The duration of the session may not exceed twelve days. Nevertheless, a decree of closure intervenes when the National Assembly has exhausted the agenda for which it was convoked. TITLE II ISUB-TITLE II CHAPTER II ARTICLE 84 The Senate meets of plain right in two ordinary sessions per year. The duration of each session is established at sixty days. The first session begins on the first Tuesday of May and the second, consecrated principally to the adoption of the law of finance, the third Tuesday of October. It may equally meet in special session by convocation of the Government. Its agenda is then limitatively established by the decree of convocation taken in the Council of Ministers. When the National Assembly is not sitting, the Senate may only discuss issues referred to it by the Government for its opinion, excluding all legislative bills.	- Ерөнхий сайдын санаачилгаар, эсхүл Үндэсний Ассамблейн нийт гишүүдийн олонхын шаардсанаар; - Сенатын тусгай чуулганыг Засгийн газар зарлан хуралдуулна. Хэлэлцэх асуудлын товыг Сайд нарын зөвлөл ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулах тогтоолоор хязгаарлагдмал хүрээнд тогтооно.	-	- Үндэсний Ассамблей хэлэлцэхээр товловсон асуудлаар ээлжит бусаар хуралдана. - Сенатын тусгай чуулганыг Засгийн газар зарлан хуралдуулна. Хэлэлцэх асуудлын товыг Сайд нарын зөвлөл ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулах тогтоолоор хязгаарлагдмал хүрээнд тогтооно. - Үндэсний Ассамблейн чуулган хуралдаагүй үед (завсарлагааны хугацаанд) Сенат хууль тогтоомжийн төслүүдийг хэлэлцэхгүй ба гагцхүү Засгийн газраас санал авахаар тусгасан асуудлыг хэлэлцэнэ.
91.	Malawi 1994 (rev. 2017)	CHAPTER VI 591 Provided that— a.the President, in consultation with the Speaker of the National	Ерөнхийлөгч, Спикертэй зөвшилцөн Үндэсний Ассамблейн ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулна.	-	-

		Assembly, may summon, on extraordinary occasions, a meeting of the National Assembly; and			
92.	Mali 1992	<p>TITLE V ARTICLE 66</p> <p>The National Assembly shall convene in extraordinary session upon the demand of the Prime Minister or of the majority of its members to consider a specific agenda.</p> <p>When the extraordinary session is held at the request of the members of the National Assembly, the closure decree shall take effect as soon as the National Assembly has exhausted the agenda for which it was called and at the latest fifteen days from the date of its convening.</p> <p>The Prime minister may demand a new session before the expiration of the month following the closure decree and upon a specific agenda.</p> <p>TITLE V ARTICLE 67</p> <p>Apart from the cases in which the National Assembly meets by right, extraordinary sessions shall be opened and closed by decree of the President of the Republic.</p>	Үндэсний Ассамблей Ерөнхий сайд, эсхүл гишүүдийн олонхын шаардсанаар тодорхой асуудлыг хэлэлцэхээр ээлжит бус чуулганыг хуралдуулна.	-	Үндэсний Ассамблей Ерөнхий сайд, эсхүл гишүүдийн олонхын шаардсанаар тодорхой асуудлыг хэлэлцэхээр ээлжит бус чуулганыг хуралдуулна.
93.	Malta 1964 (rev. 2016)	<p>CHAPTER VI PART 376</p> <p>If between a dissolution of Parliament and the next ensuing general election of members of the House of Representatives an emergency arises of such a nature that, in the opinion of the Prime Minister it is necessary to recall Parliament, the President may by proclamation summon the Parliament that has been dissolved to meet, and that Parliament shall thereupon be deemed (except for the purpose of article 77 and, in relation to the next ensuing general election, article 61(3) and 66(6) of this Constitution) not to have been dissolved but shall be deemed (except as aforesaid) to be dissolved on the date on which the polls are concluded in the next ensuing general election.</p>	Парламент тарсан үед дараагийн ерөнхий сонгууль явуулах хооронд онцгой шинж бүхий нөхцөл байдал үүссэн гэж Ерөнхий сайд үзсэн бол Ерөнхийлөгч тарсан парламентыг зарлан хуралдуулна.	-	Парламент тарсан үед дараагийн ерөнхий сонгууль явуулах хооронд онцгой шинж бүхий нөхцөл байдал үүссэн гэж Ерөнхий сайд үзсэн бол Ерөнхийлөгч тарсан парламентыг зарлан хуралдуулна.
94.	Marshall Islands 1979 (rev. 1995)	<p>ARTICLE IV SECTION 10</p> <p>If there has been a general election or if, at any time when the Nitijela is not in session, an election of the President is for any other reason required, and more than 60 days will elapse before the date of the next regular session of the Nitijela, the President shall, within 14 days after the date of the general election or the date of the occurrence of any other event requiring an election of the President, call the Nitijela to meet in special session on a date not more than 30 days after the date of the call; and, in any case where the President has not called the Nitijela to meet in special session in accordance with this paragraph, the Speaker shall call the Nitijela to meet in special session as soon as practicable.</p> <p>If more than 120 days have elapsed after the date on which the preceding session of the Nitijela terminated, any 10 members of the Nitijela, not being members of the Cabinet, representing not less than 4 electoral districts, may, by written petition signed by each of them, request the President to call the Nitijela to meet in special session in order to consider the matter or matters of urgent public business set forth in the petition. Unless the President has, within 7 days of the receipt of the petition, called the Nitijela to meet in special session on a date not more than 30 days after the date of the call, the Speaker shall call the Nitijela to meet in special session as soon as practicable. Any</p>	Ерөнхий сонгууль явагдсан, эсхүл парламентын чуулган хуралдаагүй үед Ерөнхийлөгчийн сонгуулийг өөр бусад шалтгаанаар явуулна.	Ээлжит чуулган эхэлтэл 60 хоногоос дээш хугацаа үлдсэн бол Ерөнхийлөгч сонгууль явагдсанаар хойш 14 хоногийн дотор, эсхүл Ерөнхийлөгчийн сонгууль явуулахыг шаардсан өөр нөхцөлд үүсэн бол Ерөнхийлөгч тусгай чуулганыг зарласан өдрөөс хойш 30-аас дээшгүй хоногийн дотор	Ерөнхий сонгууль явагдсан, эсхүл парламентын чуулган хуралдаагүй үед Ерөнхийлөгчийн сонгуулийг өөр бусад шалтгаанаар явуулах ба ээлжит чуулган эхэлтэл 60 хоногоос дээш хугацаа үлдсэн бол Ерөнхийлөгч сонгууль явагдсанаар хойш 14 хоногийн дотор, эсхүл Ерөнхийлөгчийн сонгууль явуулахыг шаардсан өөр нөхцөлд үүсэн бол Ерөнхийлөгч тусгай чуулганыг зарласан өдрөөс хойш 30-аас дээшгүй хоногийн дотор зарлан хуралдуулна.

		<p>special session called pursuant to this paragraph may consider any matter; but no such special session shall be terminated before the expiration of 30 sitting days unless the Speaker has certified that the Nitijela has sooner disposed of the matter or matters of urgent public business which it was called to consider.</p> <p>At any time when the Nitijela is not already meeting in regular session or in special session, the President may, by writing signed by him, call it to meet in special session.</p> <p>Subject to paragraph (3) of this Section and to Section 11 of this Article, the President shall, by writing signed by him, appoint the date for the termination of any special session of the Nitijela.</p>		зарлан хуралдуулна.	
95.	Mauritania 1991 (rev. 2012)	<p>TITLE III ARTICLE 53</p> <p>The Parliament can meet in an extraordinary session at the demand of the President of the Republic or of the majority of the members of the National Assembly for a determined agenda [ordre du jour]. The length of an extraordinary session may not exceed one month.</p> <p>The extraordinary sessions are opened and closed by a decree of the President of the Republic.</p>	Ерөнхийлөгч, эсхүл Парламентын нийт гишүүдийн олонхын шаардсанаар урьдчилан товлосон асуудлаар Парламентын ээлжит бус чуулганыг хуралдуулна.	-	Урьдчилан товлосон асуудлаар Парламентын ээлжит бус чуулганыг хуралдуулна.
96.	Mexico 1917 (rev. 2015)	<p>TITLE THREE CHAPTER II SECTION I ARTICLE 67</p> <p>The Congress or just one of the Houses, when dealing with an issue under its exclusive jurisdiction, shall assemble in extraordinary period of sessions at the Permanent Committee's request. In such case, the Congress shall only resolve the issue or issues submitted by the Permanent Committee and indicated in the notification.</p> <p>TITLE THREE CHAPTER II SECTION IV ARTICLE 78</p> <p>Besides the powers conferred by this Constitution, the Permanent Committee shall have the following powers:</p> <p>IV. Agree by its own means or by proposal of the Executive the call for an extraordinary period of sessions in one or both Houses of the Congress. The call shall be approved the vote for two-thirds of the present congressmen/congresswomen. The call shall clearly state the reasons and objectives for the extraordinary sessions. When the reason for the extraordinary call is because the General Congress needs to become an Electoral College to appoint the interim or alternate president, the approval for the call shall only require the votes of the majority of the present members.</p> <p>TITLE THREE CHAPTER III ARTICLE 89</p> <p>The powers and rights of the President of the Republic are the following:</p> <p>XI. To call the Congress to an extraordinary period of sessions at Permanent Committee's agreement.</p>	<p>- Конгресс, эсхүл түүний аль нэг танхим нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд ээлжит бус чуулганыг Байнгын хорооны саналаар хуралдуулна. Энэ тохиолдолд Конгресс нь гагцхүү Байнгын хорооноос өргөн мэдүүлсэн, мэдэгдэлд тусгасан асуудал(ууд)-ыг хэлэлцэн шийдвэрлэнэ.</p> <p>- Байнгын хороо нь Үндсэн хуульд зааснаас гадна дараах эрхийг эдэлнэ: Байнгын хороо өөрөө, эсхүл Ерөнхийлөгчийн саналаар Конгрессын нэг, эсхүл хоёр танхимын ээлжит бус чуулганыг шаардана. Ээлжит бус чуулганыг зарлахдаа зарлах болсон шалтгаан, зорилгыг тодорхой тусгах ба гишүүдийн 2/3-ны саналаар батална.</p> <p>- Ерөнхийлөгч нь дараахь онцгой эрхийг эдэлнэ: Байнгын хороотой зөвшилцөн Конгрессын ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулах.</p>	-	Конгресс, эсхүл түүний аль нэг танхим нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд ээлжит бус чуулганыг Байнгын хорооны саналаар хуралдуулна. Энэ тохиолдолд Конгресс нь гагцхүү Байнгын хорооноос өргөн мэдүүлсэн, мэдэгдэлд тусгасан асуудал(ууд)-ыг хэлэлцэн шийдвэрлэнэ. Ээлжит бус чуулганыг зарлахдаа зарлах болсон шалтгаан, зорилгыг тодорхой тусгана.
97.	Micronesia (Federated States of) 1978 (rev. 1990)	<p>ARTICLE IX SECTION 16</p> <p>The Congress shall meet in regular, public session as prescribed by statute. A special session may be convened at the call of the President of the Federated States of Micronesia, or by the presiding officer on the written request of 2/3 of the members.</p>	Ерөнхийлөгч, гишүүдийн 2/3-ны бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн даргалагч тусгай чуулганыг зарлан хуралдуулна.	-	-
98.	Moldova (Republic of) 1994 (rev. 2016)	<p>TITLE III CHAPTER IV SECTION I ARTICLE 67</p> <p>2. Parliament may also meet in extraordinary or special sessions, upon the request of the President of the Republic of</p>	Ерөнхийлөгч, Спикер, эсхүл гишүүдийн 1/3-ний саналаар ээлжит бус, эсхүл тусгай чуулганыг зарлан хуралдуулна.	-	-



		Moldova, the Speaker of Parliament or a third of its members.			
99.	Monaco 1962 (rev. 2002)	CHAPTER VII ART 59 The National Council meets in extraordinary session, convened either by the Prince or on the request of at least two thirds of the members, by the President.	Ерөнхийлөгч Үндэсний Зөвлөлийн ээлжит бус чуулганыг Ханхүү, эсхүл гишүүдийн 2/3-ны саналаар зарлан хуралдуулна.	-	-
100.	Montenegro 2007 (rev. 2013)	PART 31 ARTICLE 90 Extraordinary session shall be called for at the request of the President of Montenegro, the Government or minimum one third of the total number of Members of the Parliament.	Ерөнхийлөгч, Засгийн газар, эсхүл Парламентын нийт гишүүдийн 1/3-ны саналаар ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулна.	-	-
101.	Morocco 2011	TITLE IV OF THE ORGANIZATION OF THE PARLIAMENT ARTICLE 66 The Parliament can meet in extraordinary session, either by decree, or at the demand of one-third of the members of the Chamber of Representatives or of the majority of those of the Chamber of Councilors. The extraordinary sessions of the Parliament are held on the basis of a specific agenda . When this latter is exhausted, the session is closed by decree.	Парламентын ээлжит бус чуулганы хуралдааныг Зарлигаар, Төлөөлөгчдийн Танхимын гишүүдийн 1/3-ны саналаар, эсхүл Зөвлөхүүдийн Танхимын гишүүдийн олонхын шаардсанаар тодорхой асуудлаар зарлан хуралдуулна.	-	Парламентын ээлжит бус чуулганы хуралдааныг тодорхой асуудлаар зарлан хуралдуулна.
102.	Mozambique 2004 (rev. 2007)	TITLE VII CHAPTER III ARTICLE 186 PARLIAMENTARY SESSIONS The Assembly of the Republic shall meet in ordinary session twice each year, and in extraordinary session whenever requested by the President of the Republic, by the Standing Commission or by at least one third of the deputies.	Ерөнхийлөгч, Байнгын хороо, эсхүл гишүүдийн 1/3-аас доошгүйн санал гаргах бүрд ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулна.	-	-
103.	Myanmar 2008	CHAPTER IV APART 5 82. The Speaker of the Pyidaungsu Hluttaw may convene a special session or an emergency session, if necessary. 83. The Speaker of the Pyidaungsu Hluttaw shall convene a special session or an emergency session as soon as possible when the President informs him to do so. 84. The Speaker of the Pyidaungsu Hluttaw shall convene a special session as soon as possible, if at least one-fourth of the total number of the representatives so require.	Шаардлагатай бол Спикер Парламентын ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулна. Парламентын ээлжит бус, эсхүл онц чуулганыг Ерөнхийлөгчийн мэдэгдсэнээр Спикер аль болох түргэн зарлан хуралдуулна. Парламентын ээлжит бус чуулганыг Парламентын нийт гишүүдийн 1/4-ний шаардсанаар Спикер аль болох түргэн зарлан хуралдуулна.	Парламентын ээлжит бус, эсхүл онц чуулганыг Ерөнхийлөгчийн мэдэгдсэнээр Спикер аль болох түргэн зарлан хуралдуулна	-
104.	Namibia 1990 (rev. 2014)	CHAPTER 5 ARTICLE 323 Without derogating from the generality of the functions and powers contemplated by Sub-Article (1) hereof, the President shall preside over meetings of the Cabinet and shall have the power, subject to this Constitution to: b.determine the times for the holding of special sessions of the National Assembly, and to prorogue such sessions; CHAPTER 7 ARTICLE 621 The National Assembly shall sit: c.for such special sessions as directed by Proclamation by the President from time to time.	Үндсэн хуульд заасны дагуу Ерөнхийлөгч Үндэсний Ассамблейн тусгай чуулганыг товлон зарлан, тухайн чуулганыг хаана.	-	-
105.	Nauru 1968 (rev. 2015)	PART IV 42 SESSIONS OF PARLIAMENT AT REQUEST OF ONE-THIRD OF MEMBERS. Where- a.Parliament is not in session; and b.there is delivered to the Speaker a request that complies with clause (2.) of this Article for the holding of a session, the Speaker shall appoint a time for the holding of a session of Parliament, being a time before the expiration of fourteen days	Парламентын чуулган хуралдаагүй үед (завсарлагааны хугацаанд) Спикерт ээлжит бус чуулган зарлан хуралдуулах хүсэлт гаргасан бол Спикер ээлжит бус чуулганыг хуралдуулах товлон зарлана. Хүсэлт нь: - хүсэлтийг бичгээр гаргасан байна; - багадаа гурваас доошгүй тойрог бүрээс	-	Парламентын чуулган хуралдаагүй үед (завсарлагааны хугацаанд) Спикерт ээлжит бус чуулган зарлан хуралдуулах хүсэлт гаргасан бол Спикер ээлжит бус чуулганыг хуралдуулах товлон зарлана. Хүсэлтэд Парламентын

		<p>after the request is delivered A request referred to in clause (1.) of this Article- a. shall be in writing; b. shall be signed by a member of Parliament for each of at least three constituencies and by a number of members of Parliament which is at least one-third of the total number of members of Parliament; and c. shall set out particulars of the business proposed to be dealt with at the session of Parliament.</p>	<p>сонгогдсон гишүүн болон нийт гишүүдийн 1/3-аас доошгүйн гарын үсэг зурсан байна; - Хүсэлтэд Парламентын чуулганаар хэлэлцэх асуудлыг тодорхой тусгасан байна.</p>		<p>чуулганаар хэлэлцэх асуудлыг тодорхой тусгасан байна.</p>
106.	Nepal 2015 (rev. 2016)	<p>PART 893 SUMMONING AND PROROGATION OF SESSIONS President shall summon a session of parliament within one month after the elections to the House of Representatives are held. Thereafter, President shall summon other sessions from time to time in accordance with this Constitution: Provided that the interval between two consecutive sessions shall not be more than six months. President may prorogue the session of both or either of the Houses of Parliament. If, during the prorogation or recess of the House of Representatives, one-fourth of its members submit a request stating that it is desirable that a session or meeting of House of Representatives be called, the President shall call the session or meeting of the Parliament by setting date and time for this within a fortnight, and House of Representatives shall convene or commence its session on the specified date and the time thus fixed.</p>	<p>Төлөөлөгчдийн Танхимын сонгууль явагдсанаас 1 сарын дотор Ерөнхийлөгч Парламентын ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулна. Бусад чуулганыг Ерөнхийлөгч Үндсэн хуульд заасны дагуу зарлан хуралдуулна. Чуулганы завсарлагаа, эсхүл чөлөөт цагт гишүүдийн 1/4 Төлөөлөгчдийн танхимын чуулган, эсхүл хуралдааныг зарлан хуралдуулах зохимжтой гэж үзсэн бол Ерөнхийлөгч хоёр долоо хоногийн дотор товлон зарлана.</p>	<p>Чуулганы завсарлагаа, эсхүл чөлөөт цагт гишүүдийн 1/4 Төлөөлөгчдийн танхимын чуулган, эсхүл хуралдааныг зарлан хуралдуулах зохимжтой гэж үзсэн бол Ерөнхийлөгч хоёр долоо хоногийн дотор товлон зарлана.</p>	-
107.	New Zealand 1852 (rev. 2014)	<p>CONSTITUTION ACT 1986 PART 3B18 The Governor-General may by Proclamation summon Parliament to meet at such place and time as may be appointed therein, notwithstanding that when the Proclamation is signed or when it takes effect Parliament stands prorogued to a particular date.</p>	<p>Амбан захирагч Тогтоолоор парламентыг товлон зарлан хуралдуулах ба тогтоолд гарын үсэг зурсан, тогтоол хүчин төгөлдөр үйлчлэх хугацаа нь Парламентын чуулган хуралдаагүй, завсарлагаан таарсныг үл харгалзан тогтоолд заасан хуралдаах газар болон хугацаанд хуралдана.</p>	-	-
108.	Nicaragua 1987 (rev. 2014)	<p>TITLE VIII CHAPTER II ARTICLE 138 The National Assembly has the following functions: 31. To hold ordinary and extraordinary sessions. TITLE VIII CHAPTER III ARTICLE 150 The President of the Republic has the following functions: 7. To request the President of the National Assembly to call special sessions during the recess period of the National Assembly in order to legislate on urgent matters of the Nation.</p>	<p>Үндэсний ассамблейн завсарлагааны хугацаанд Ерөнхийлөгч Үндэсний ассамблейн даргад улс үндэсний яаралтай асуудлаар хууль тогтоомж гарахаар Үндэсний ассамблейн ээлжит бус чуулган зарлан хуралдуулах саналыг гаргана.</p>	-	<p>Үндэсний ассамблейн завсарлагааны хугацаанд Ерөнхийлөгч Үндэсний ассамблейн даргад улс үндэсний яаралтай асуудлаар хууль тогтоомж гарахаар Үндэсний ассамблейн ээлжит бус чуулган зарлан хуралдуулах саналыг гаргана.</p>
109.	Niger 2010 (rev. 2017)	<p>TITLE IV ARTICLE 92 The National Assembly is convoked in extraordinary session by its President on a determined agenda, at the demand of the Prime Minister or by two-fifths (2/5) of the Deputies. The extraordinary sessions, except in the cases where they take place of plain right, are opened and closed by decree of the President of the Republic. The closure comes as soon as the agenda is exhausted. Their duration may not exceed fifteen (15) days.</p>	<p>Үндэсний Ассамблейн ээлжит бус чуулганыг Ерөнхий сайд, эсхүл гишүүдийн 2/5-ны шаардсанаар Ерөнхийлөгч хэлэлцэхээр товлосон асуудлаар зарлан хуралдуулна.</p>	-	<p>Хэлэлцэхээр товлосон асуудлаар ээлжит бус чуулган хуралдана.</p>
110.	Norway 1814 (rev. 2016)	<p>C ARTICLE 69 When the Storting is not assembled, it may be summoned by the</p>	<p>Хаан шаардлагатай гэж үзсэн бол Парламентын хуралдаагүй үед зарлан хуралдуулж болно.</p>	-	-

		King if he finds it necessary.			
111.	Oman 1996 (rev. 2011)	CHAPTER FIVE ARTICLE 58BIS 28 His Majesty the Sultan may summon Majlis Oman, outside the regular session, to convene in circumstances which His Majesty determines.	Султан нь Оманы Парламентын ээлжит чуулганаас бусад үед өөрийн товлосон асуудлаар зарлан хуралдуулж болно.	-	Султан нь Оманы Парламентын ээлжит чуулганаас бусад үед өөрийн товлосон асуудлаар зарлан хуралдуулж болно.
112.	Pakistan 1973 (reinst. 2002, rev. 2017)	PART III CHAPTER 2 SECTION 154 SUMMONING AND PROROGATION OF MAJLIS-E-SHOORA (PARLIAMENT) 1.The President may, from time to time, summon either House or both Houses or Majlis-e-Shoora (Parliament) in joint sitting to meet at such time and place as he thinks fit and may also prorogue the same. 3.On a requisition signed by not less than one-fourth of the total membership of the National Assembly, the Speaker shall summon the National Assembly to meet, at such time and place as he thinks fit, within fourteen days of the receipt of the requisition; and when the Speaker has summoned the Assembly only he may prorogue it.	Ерөнхийлөгч Парламентын аль нэг танхим, эсхүл хоёуланг өөрийн зохимжтой гэж үзсэн хугацаа болон газар хуралдуулж, мөн хааж болно. Парламентын нийт гишүүдийн 1/4-ээш доошгүйн гарын үсгээр зурснаар Спикер өөрийн зохимжтой гэж үзсэн хугацаа болон газар хуралдуулна. Спикер Ассамблейг зарлан хуралдуулсан тохиолдолд гагцхүү Спикер чуулганыг хаана.	Спикер хүсэлт хүлээж авснаас 14 хоногийн дотор ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулна.	-
113.	Palau 1981 (rev. 1992)	ARTICLE IX SECTION 11 Each house of the Olbiil Era Kelulau shall convene its meeting on the second Tuesday in January following the regular general election and may meet regularly for four (4) years. Either house may be convened at any time by the presiding officer, or at the written request of the majority of the members, or by the President.	Парламентын аль ч танхимыг Даргалагч, эсхүл гишүүдийн олонхын бичгээр гаргасан хүсэлт, эсхүл Ерөнхийлөгч зарлан хуралдуулна.	-	-
114.	Panama 1972 (rev. 2004)	TITLE V CHAPTER 1 ARTICLE 149 The National Assembly shall convene, in its own right, without need for previous convocation, in the capital city for sessions that last eight months in a one year period, divided into two ordinary legislative sessions of four month's duration. Such sessions shall extend from September 1 through December 31, and March 1 through June 30. The National Assembly shall meet in extraordinary session when convoked by the Executive Branch and during the time it designates, to hear exclusively, matters that the Branch submits for the members' consideration.	Гүйцэтгэх засаглал гагцхүү гүйцэтгэх засаглалаас өргөн мэдүүлсэн асуудлаар Үндэсний Ассамблейг ээлжит бус чуулганыг товлон зарлаж, хуралдуулна.	-	Гүйцэтгэх засаглал гагцхүү гүйцэтгэх засаглалаас өргөн мэдүүлсэн асуудлаар Үндэсний Ассамблейг ээлжит бус чуулганыг товлон зарлаж, хуралдуулна.
115.	Paraguay 1992 (rev. 2011)	PART II TITLE II CHAPTER I SECTION I ARTICLE 184 OF THE SESSIONS Both Chambers of the Congress will meet annually in ordinary sessions, from the first of July of each year to the next 30 of June with a time period of recess from the twenty-first of December to the first of March, [the] date at which they will render their report to the President of the Republic. Both Chambers will be convoked to extraordinary sessions or will extend their sessions by the decision of one-fourth of the members of either of them; by resolution of two-thirds of the members [integrantes] of the Permanent Commission of the Congress, or by decree of the Executive Power. The President of the Congress or that of the Permanent Commission must convoke them in the peremptory time [término] of forty-eight hours. The extension of the sessions will be effected in the same way. The extraordinary [sessions] will be convoked to discuss a determined agenda, and will be closed once this [agenda] has been exhausted.	Парламентын аль нэг танхимын 1/4-ээс доошгүйн саналаар, эсхүл Конгрессын Байнгын комиссын 2/3-ны санлаар, эсхүл Ерөнхийлөгчийн зарлигаар Парламентын ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулна. Ээлжит бус чуулганаар хэлэлцэхээр товлосон асуудлыг хэлэлцэх ба хэлэлцүүлэг дууссанаар ээлжит бус чуулган өндөрлөнө. Ерөнхийлөгч нь Конгрессын танхим (2 танхимыг нэгэн зэрэг)-ын ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулах ба гагцхүү хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн асуудлыг хэлэлцэнэ.	Конгрессын, эсхүл Байнгын комиссын дарга ээлжит бус чуулганыг 48 цагийн дотор зарлан хуралдуулна.	Ээлжит бус чуулганаар хэлэлцэхээр товлосон асуудлыг хэлэлцэх ба хэлэлцүүлэг дууссанаар ээлжит бус чуулган өндөрлөнө. Ерөнхийлөгч нь Конгрессын танхим (2 танхимыг нэгэн зэрэг)-ын ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулах ба гагцхүү хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн асуудлыг хэлэлцэнэ.

		PART II TITLE II CHAPTER II SECTION I ARTICLE 23 8 [The following] are duties and attributions of whoever exercises the presidency of the Republic: 11.to convoke the Congress to extraordinary sessions, either of the Chambers or both at the same time, [where] these must only treat those issues submitted to their respective consideration;			
116.	Peru 1993 (rev. 2009)	TITLE IV CHAPTER VI ARTICLE 130 Within thirty days of having assumed his functions, the President of the Cabinet and the other ministers shall attend Congress to present and discuss the general policy of the government and the main measures required for its implementation, asking for a vote of confidence. If Congress is not convened, the President of the Republic calls a special session.	Кабинетын Ерөнхийлөгч болон бусад сайд нар үүргээ хүлээж авснаас 30 хоногийн дотор Засгийн газрын мөрийн хөтөлбөр болон түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээг танилцуулж, хэлэлцэх ба итгэл хүлээлгэх асуудлаар санал хураана. Конгресс хуралдаагүй үед Ерөнхийлөгч тусгай чуулганыг зарлан хуралдуулна.	-	-
117.	Philippines 1987	ARTICLE VI SEC 15 The Congress shall convene once every year on the fourth Monday of July for its regular session, unless a different date is fixed by law, and shall continue to be in session for such number of days as it may determine until thirty days before the opening of its next regular session, exclusive of Saturdays, Sundays, and legal holidays. The President may call a special session at any time.	Ерөнхийлөгч аль үед Парламентыг зарлан хуралдуулж болно.	-	-
118.	Portugal 1976 (rev. 2005)	PART III TITLE III CHAPTER III ARTICLE 174 Following a Plenary decision to extend the normal parliamentary term, or on the initiative of the Standing Committee, or, in the event that the said Committee is unable to function and there is a dire emergency , on the initiative of more than half of all the Members, the Assembly may conduct proceedings outside the term set out in the previous paragraph. The President of the Republic may also call the Assembly on an extraordinary basis in order to address specific matters.	Байнгын хорооны санаачилгаар, эсхүл тухайн хороо үйл явуулах боломжгүй үед, яаралтай шаардлага гарсан нөхцөлд нийт гишүүдийн талаас дээшхийн санаачилгаар ээлжит бусаар хуралдана. Ерөнхийлөгч тодорхой асуудлуудыг хэлэлцэхээр Ассамблейн ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулж болно.	-	Ерөнхийлөгч тодорхой асуудлуудыг хэлэлцэхээр Ассамблейн ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулж болно.
119.	Qatar 2003	CHAPTER IV SECTION III ARTICLE 88 The Prince invites the Advisory Council to an extraordinary meeting by a decree in case of necessity or based upon the request of the majority of the Council's members. In an extraordinary session, the Council may not view except the matters for which it was invited.	Ханхүү Зөвлөх Зөвлөлийг шаардлага гарсан, эсхүл Зөвлөлийн гишүүдийн олонхын саналаар ээлжит бус хуралдааныг зарлан хуралдуулах ба Зөвлөл хэлэлцэхээр товлосноос бусад асуудлыг хэлэлцэхгүй.	-	Ханхүү Зөвлөх Зөвлөлийг шаардлага гарсан, эсхүл Зөвлөлийн гишүүдийн олонхын саналаар ээлжит бус хуралдааныг зарлан хуралдуулах ба Зөвлөл хэлэлцэхээр товлосноос бусад асуудлыг хэлэлцэхгүй.
120.	Romania 1991 (rev. 2003)	TITLE III CHAPTER I SECTION 1 ARTICLE 66 2. The Chamber of Deputies and the Senate also meet in extraordinary sessions, at the request of the President of Romania, of the permanent bureau of each Chamber, or at least one-third of the deputies or senators.	Ерөнхийлөгч, эсхүл Танхим тус бүрийн байнгын хорооны, эсхүл депутат/сенаторуудын 1/3-ээсш доошгүйн саналаар Төлөөлөгчдийн Танхим, эсхүл Сенатыг ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулна.	-	-
121.	Russian Federation 1993 (rev. 2014)	SECTION ONE CHAPTER 5 ARTICLE 99 2. The State Duma shall convene its first session on the thirtieth day after election. The President of the Russian Federation may convene a session of the State Duma earlier than this date.	Сонгууль явагдсанаас хойших 13 дахь өдөр Төрийн Думын анхны чуулган хуралдана. Ерөнхийлөгч дээрх хугацаанаас өмнө Төрийн Думын чуулганыг зарлан хуралдуулж болно.	-	-
122.	Rwanda 2003 (rev. 2015)	CHAPTER VII SECTION 2 SUBSECTION ONE ARTICLE 72 Each Chamber of Parliament meets in an extraordinary session on invitation by its leader after consultation with the other members of the concerned Bureau or at the request of the	Парламентын танхимын дарга холбогдох Хорооны гишүүдтэй зөвлөлдөж, эсхүл Кабинетын санал болгосноор Ерөнхийлөгчийн саналаар, эсхүл холбогдох танхимын гишүүдийн 1/4-ийн	-	-

		President of the Republic following a proposal by Cabinet or at the request of one quarter (1/4) of the members of the Chamber of Parliament concerned. An extraordinary joint session of Parliament may be convened by mutual agreement of the President of the Senate and the Speaker of the Chamber of Deputies, at the request of the President of the Republic, or one quarter (1/4) of the members of each Chamber of Parliament.	саналаар тус тус Парламентын танхимын ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулна. Ерөнхийлөгч, эсхүл Танхим тус бүрийн 1/4-ний саналаар Парламентын ээлжит бус нэгдсэн чуулганыг Сенатын дарга болон Депутатуудын Танхимын Даргын нарын зөвшилцөн зарлан хуралдуулна.		
123.	Saint Kitts and Nevis 1983	CHAPTER IV PART 347 The Governor-General may at any time prorogue or dissolve Parliament.	Амбан захирагч аль ч үед чуулганы хугацааг завсарлуулах, эсхүл Парламентыг тараана.	-	-
124.	Saint Lucia 1978	CHAPTER III PART 355 If, after a dissolution of Parliament and before the holding of a general election of members of the House, the Prime Minister advises the Governor-General that, owing to the existence of a state of war or of a state of emergency in Saint Lucia, it is necessary to recall Parliament, the Governor-General shall summon the Parliament that has been dissolved to meet, but unless the life of parliament is extended under the provisions of subsection (3) of his section, the general election shall proceed and the Parliament that has been recalled shall, if not sooner dissolved, again stand dissolved on the date appointed for the nomination of candidate in the general election.	Парламент тарсны дараа, ерөнхий сонгууль явагдахаас өмнө дайны, эсхүл онц байдал зарлах нөхцөл гэж үзэн Ерөнхий Сайд Амбан захирагчид Парламентын зарлан хуралдуулах шаардлагатай гэж зөвлөсний үндсэн дээр Амбан захирагч тарсан Парламентыг зарлан хуралдуулж болно.	-	Парламент тарсны дараа, ерөнхий сонгууль явагдахаас өмнө дайны, эсхүл онц байдал зарлах нөхцөл гэж үзэн Ерөнхий Сайд Амбан захирагчид Парламентын зарлан хуралдуулах шаардлагатай гэж зөвлөсний үндсэн дээр Амбан захирагч тарсан Парламентыг зарлан хуралдуулж болно.
125.	Sao Tome and Principe 1975 (rev. 2003)	PART III TITLE II ARTICLE 81 As regards other bodies the President of the Republic has the following: d.To convene extraordinary meetings of the National Assembly whenever compelling reasons of public interest justify this; PART III TITLE IV ARTICLE 105 The National Assembly may meet extraordinarily in the instances prescribed in its By-laws or at the convocation of the President of the Republic.	Ерөнхийлөгч нийтийн эрх ашгийн үндэслэл бүхий асуудал бүрийг хэлэлцүүлэхээр Үндэсний Ассамблейн ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулна. Үндэсний Ассамблейн ээлжит бус чуулганыг дүрэмд заасан үндэслэлээр, эсхүл Ерөнхийлөгчийн зарласнаар хуралдана.	-	Ерөнхийлөгч нийтийн эрх ашгийн үндэслэл бүхий асуудал бүрийг хэлэлцүүлэхээр Үндэсний Ассамблейн ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулна.
126.	Senegal 2001 (rev. 2016)	TITLE VI ARTICLE 63 In [the] case where the ordinary session or the extraordinary session is closed without the National Assembly having established the date of opening of the next ordinary session, this is established in a timely fashion by the Bureau of the National Assembly. The National Assembly, also, meets in extraordinary session, on a specific agenda , either: •on the written demand of more than half of the Deputies, addressed to the President of the National Assembly; •on the decision of the President of the Republic, alone or on proposal of the Prime Minister. However, the duration of each extraordinary session may not exceed fifteen days. The extraordinary sessions are closed once the agenda is exhausted.	Ээлжит бус чуулган дараахь үед хуралдуулна: - гишүүдийн талаас дээших нь Үндэсний Ассамблейн даргад бичгээр өргөдөл гаргасан; - Ерөнхийлөгч дангаараа, эсхүл Ерөнхий сайдын санал болгосноор.	-	Тодорхой асуудлаар ээлжит бус чуулганыг хуралдуулна.
127.	Serbia 2006	PART 51 ARTICLE 106 The National Assembly shall be convoked for extraordinary session upon the request of at least one third of deputies or upon the request of the Government, with previously determined agenda .	Гишүүдийн 1/3-ээс доошгүйн саналаар, эсхүл Засгийн газрын саналаар хэлэлцэхээр урьдчилан товлосон асуудлаар Үндэсний Ассамблейн ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулна.	-	Гишүүдийн 1/3-ээс доошгүйн саналаар, эсхүл Засгийн газрын саналаар хэлэлцэхээр урьдчилан товлосон асуудлаар Үндэсний Ассамблейн ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулна.

128.	Seychelles 1993 (rev. 2017)	CHAPTER VI PART V106 3.Where a period of public emergency subsists at the time when the National Assembly would stand dissolved under clause (2)(a) National Assembly may, by resolution approved by a majority of the members of the Assembly, extend the sessions of the 109. The President may, at any time by Proclamation published in the Gazette, summon a meeting of the National Assembly.	Үндэсний Ассамблей хуралдаагүй үед олон нийтийн онц байдал үүссэн бол гишүүдийн дийлэнх нь батлагдсан тогтоолоор Ассамблейн хуралдааныг сунгаж болно. 109. Ерөнхийлөгч Үндэсний Ассамблейн хуралдааныг албан ёсны сонинд нийтлүүлснээр аль ч үед зарлаж болно.	-	-
129.	Sierra Leone 1991 (reinst. 1996, rev. 2013)	CHAPTER III 29 PUBLIC EMERGENCY CHAPTER VI PART II 86 SITTINGS OF PARLIAMENT 1.The President may at any time summon a meeting of Parliament. 2.Notwithstanding the provision of subsection (1), at least twenty per centum of all the Members of Parliament may request a meeting of Parliament and the Speaker shall, within fourteen days after the receipt of that request, summon a meeting of Parliament.	Ерөнхийлөгч аль ч үед Парламентын ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулна. Парламентын нийт гишүүдийн 20-иос дээшхийн саналаар Спикер хүсэлт хүлээж авсан өдрөөс 14 хоногийн дотор Парламентыг зарлан хуралдуулна.	Спикер хүсэлт хүлээж авсан өдрөөс 14 хоногийн дотор Парламентыг зарлан хуралдуулна.	Тарсан парламентыг онц байдалд зарлан хуралдуулна.
130.	Singapore 1963 (rev. 2016)	PART XII 150 PROCLAMATION OF EMERGENCY 2.If a Proclamation of Emergency is issued when Parliament is not sitting, the President shall summon Parliament as soon as practicable, and may, until Parliament is sitting, promulgate ordinances having the force of law, if satisfied that immediate action is required.	Парламент хуралдаагүй үед онц байдал зарласан бол Ерөнхийлөгч аль боломжтой үед Парламентыг хуралдуулах ба Парламентыг хуралдах хүртэл нэн яаралтай арга хэмжээ авах шаардлагатай үед хуулийн хүчинтэй зарлиг гаргана.	-	-
131.	Slovakia 1992 (rev. 2017)	CHAPTER FIVE PART ONE ARTICLE 82 While the session is interrupted, the Speaker of the National Council of the Slovak Republic may convene a meeting of the National Council of the Slovak Republic even prior to the set date. He will do so whenever requested by the Government of the Slovak Republic or at least one-fifth of the Members of Parliament. CHAPTER FIVE PART ONE ARTICLE 83 2. The Speaker of the National Council of the Slovak Republic shall convene a meeting of the National Council of the Slovak Republic also when requested to do so by at least one-fifth of its Members of Parliament. In that case he will convene a meeting within seven days.	Парламентын чуулганы завсарлагааны хугацаанд Засгийн газар, эсхүл Парламентын гишүүдийн 1/5-ний саналаар Спикер Парламентыг товлосон хугацаанаас өмнө хуралдуулж болно. Парламентын нийт гишүүдийн 1/5-аас доошгүйн саналаар Спикер Парламентыг хуралдуулж болно. Дээрх тохиолдолд Парламентыг долоон хоногийн дотор хуралдуулна.	Парламентын нийт гишүүдийн 1/5-аас доошгүйн саналаар Спикер Парламентыг хуралдуулж болно. Энэ тохиолдолд Парламентыг 7 хоногийн дотор хуралдуулна.	-
132.	Slovenia 1991 (rev. 2016)	IVA ARTICLE 85 SESSIONS OF THE NATIONAL ASSEMBLY The National Assembly meets in regular and extraordinary sessions. Regular and extraordinary sessions are called by the President of the National Assembly; an extraordinary session must be called if so required by at least a quarter of the deputies of the National Assembly or by the President of the Republic.	Ээлжит бус чуулганыг Үндэсний Ассамблейн гишүүдийн 1/4-ийн саналаар, эсхүл Ерөнхийлөгчийн шаардсанаар зарлан хуралдуулна.	-	-
133.	Somalia 2012	CHAPTER 6 TITLE TWO ARTICLE 66 The House of the People of the Federal Parliament shall be convened for a special session whenever: a.Called by the President of the Federal Republic acting on the request of the Council of Ministers; b.Called by its Speaker; c.Requested in writing by at least 20% of the members of the House of the People of the Federal Parliament. CHAPTER 6 TITLE THREE ARTICLE 74 The Upper House of the Federal Parliament shall be convened for a special session whenever: a.Called by the Prime Minister;	Холбооны Парламентын Ардын Танхимын ээлжит бус чуулганыг дараахь тохиолдолд зарлан хуралдуулна: - Сайд нарын зөвлөлийн саналаар Ерөнхийлөгч зарласан бол; - Спикер зарласан бол; - Холбооны Парламентын Ардын Танхимын гишүүдийн 20 хувиас дээшихийн бичгээр гаргасан хүсэлтээр. Холбооны Парламентын Дээд Танхимын ээлжит бус чуулганыг дараахь тохиолдолд зарлан хуралдуулна:	-	-

		b.Called by its Speaker; c.Requested in writing by at least two (2) Federal Member States.	- Ерөнхий сайд зарласан бол; - Спикер зарласан бол; - Холбооны мужийн 2-оос дээшихийн бичгээр гаргасан хүсэлтээр.		
134.	South Africa 1996 (rev. 2012)	CHAPTER 442 The President may summon Parliament to an extraordinary sitting at any time conduct special business . CHAPTER 4 PART A51 2. The President may summon the National Assembly to an extraordinary sitting at any time to conduct special business. CHAPTER 4 PART B63 2. The President may summon the National Council of Provinces to an extraordinary sitting at any time to conduct special business. CHAPTER 5842 2. The President is responsible for- d.summoning the National Assembly, the National Council of Provinces or Parliament to an extraordinary sitting to conduct special business; CHAPTER 11 PART A 203 2. If Parliament is not sitting when a state of national defence is declared, the President must summon Parliament to an extraordinary sitting within seven days of the declaration.	Ерөнхийлөгч тусгай асуудлаар Үндэсний Ассамблей, Үндэсний Зөвлөлийн ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулж болно. Парламентын чуулган хуралдаагүй үед онц байдал зарласан бол Ерөнхийлөгч Парламентын ээлжит бус чуулганы хуралдааныг зарласан өдрөөс 7 хоногийн дотор зарлан хуралдуулна.	Парламентын чуулган хуралдаагүй үед онц байдал зарласан бол Ерөнхийлөгч Парламентын ээлжит бус чуулганы хуралдааныг зарласан өдрөөс 7 хоногийн дотор зарлан хуралдуулна.	Ерөнхийлөгч тусгай асуудлаар Үндэсний Ассамблей, Үндэсний Зөвлөлийн ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулж болно. Парламентын чуулган хуралдаагүй үед онц байдал зарласан бол Ерөнхийлөгч Парламентын ээлжит бус чуулганы хуралдааныг зарласан өдрөөс 7 хоногийн дотор зарлан хуралдуулна.
135.	South Sudan 2011 (rev. 2013)	PART FIVECHAPTER I68 SESSIONS OF THE NATIONAL LEGISLATURE 4.The National Legislature or each House may convene an emergency or extraordinary session on the request of half of its members or upon a call from the President.	Парламент, эсхүл аль нэг Танхимын ээлжит бус, эсхүл онц чуулганыг тэдгээрийн гишүүдийн талаас дээшихийн, эсхүл Ерөнхийлөгчийн саналаар зарлана хуралдуулна.	-	-
136.	Spain 1978 (rev. 2011)	PART III CHAPTER ISECTION 73 2. The Houses may meet in extraordinary sessions at the request of the Government, of the Permanent Deputation or of the overall majority of members of either of the two Houses. Extraordinary sessions must be convened with a specific agenda and shall be adjourned once this has been dealt with.	Засгийн газар, Байнгын Хороо, эсхүл Танхимын гишүүний талаас дээшихийн саналаар зарлан хуралдуулна.	-	Тодорхой асуудлаар
137.	Sri Lanka 1978 (rev. 2015)	CHAPTER XI703 3. Provided that, at any time while Parliament stands prorogued, the President may by Proclamation- i.summon Parliament for an earlier date, not being less than three days from the date of such Proclamation, or CHAPTER XI70 If at any time after the dissolution of Parliament the President is satisfied that an emergency has arisen of such a nature that an earlier meeting of Parliament is necessary, he may by Proclamation summon the Parliament which has been dissolved to meet on a date not less than three days from the date of such Proclamation and such Parliament shall stand dissolved upon the termination of the emergency or the conclusion of the General Election, whichever is earlier.	Парламентын чуулганы завсарлагааны үед Ерөнхийлөгч Тунхагаар зарлан хуралдуулна. Ерөнхийлөгч онц байдал үүссэн гэж үзвэл тарсан Парламентыг зарлан хуралдуулж болно.	summon Parliament for an earlier date, not being less than three days from the date of such Proclamation	Ерөнхийлөгч онц байдал үүссэн гэж үзвэл тарсан Парламентыг зарлан хуралдуулж болно.
138.	Sudan 2005	PART FOURCHAPTER I93 3. Either Chamber may convene an emergency or extraordinary session on the request of half of its members or representatives or upon call from the President of the Republic.	Гишүүдийн тал хувийн саналаар, эсхүл Ерөнхийлөгч Танхим(ууд)-ын ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулж болно.	-	-

139.	Swaziland 2005	<p>CHAPTER VII PART 4 135 RECALLING PARLIAMENT IN CASE OF EMERGENCY</p> <p>Where, between a dissolution of Parliament and the next ensuing general election of the elected members of the House, an emergency arises of such a nature that in the opinion of the King, after consultation with the President and Speaker of the dissolved Parliament, it is necessary for the two chambers of Parliament to be summoned before that general election can be held, the King may, by proclamation published in the Gazette, summon the preceding chambers of Parliament as constituted immediately before that dissolution.</p> <p>Where the King has recalled Parliament in terms of subsection (1), the two chambers of Parliament shall be deemed (except for purposes of section 136) not to have been dissolved but shall be deemed (except for the purposes of section 137) to be dissolved as soon as the emergency has been disposed of or on the date on which the next ensuing general election of elected members of the House is held.</p> <p>For the purposes of this section “emergency” includes the necessity to enact a law.</p>	<p>Парламент тарсан үед, ерөнхий сонгууль явагдахаас өмнө онц байдал бүхий нөхцөл байдал үүссэн бол Хаан, Ерөнхийлөгч болон тарсан Парламентын даргатай зөвшилцөн Парламентын 2 танхимыг албан ёсны сонинд хэвлэн зарлан хуралдуулна.</p> <p>Энэхүү заалтад заасан “онц” нөхцөл байдал гэсэнд хууль батлах шаардлагыг оруулна.</p>	-	<p>Парламент тарсан үед, ерөнхий сонгууль явагдахаас өмнө онц байдал бүхий нөхцөл байдал үүссэн бол Хаан, Ерөнхийлөгч болон тарсан Парламентын даргатай зөвшилцөн Парламентын 2 танхимыг албан ёсны сонинд хэвлэн зарлан хуралдуулна.</p> <p>Энэхүү заалтад заасан “онц” нөхцөл байдал гэсэнд хууль батлах шаардлагыг оруулна.</p>
140.	Sweden 1974 (rev. 2012)	<p>THE INSTRUMENT OF GOVERNMENT CHAPTER 15 PART 1 ART 1</p> <p>If the Realm finds itself at war or is exposed to the danger of war, the Government or the Speaker shall convene a meeting of the Riksdag. Whoever issues the notice convening the meeting may decide that the Riksdag shall convene at some place other than Stockholm.</p>	<p>Дайны үед, эсхүл дайны аюул нүүрлэсэн бол Парламентын хуралдааныг Засгийн газар, эсхүл Спикер зарлана. Зарласан этгээд нь Парламентын хуралдааныг Стокгольмоос өөр газар хуралдуулж болно.</p>	-	-
141.	Switzerland 1999 (rev. 2014)	<p>TITLE FIVE CHAPTER 2 SECTION 1 ART 151</p> <p>2. The Federal Council or one quarter of the members of either Council may request that the Councils be convened for an extraordinary session.</p>	<p>Холбооны зөвлөл, эсхүл аль ч Зөвлөл (дээд/доод)-ийн 1/4-ийн саналаар ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулна.</p>	-	-
142.	Syrian Arab Republic 2012	<p>TITLE III CHAPTER I ARTICLE 65</p> <p>2. The Assembly may be invited to extraordinary sessions upon the request of the Speaker, one third of the members of the Assembly or the Assembly’s office;</p>	<p>Спикер, гишүүдийн 1/3-ны саналаар, эсхүл Ассамблейн албаны саналаар Ассамблейн ээлжит бус чуулганыг хуралдуулна.</p>	-	-
143.	Taiwan (Republic of China) 1947 (rev. 2005)	<p>CHAPTER VI ARTICLE 69</p> <p>An extraordinary session of the Legislative Yuan may be held in either of the following circumstances:</p> <p>1.At the request of the President of the Republic.</p> <p>2.At the request of at least one-fourth of its Members.</p>	<p>- Ерөнхийлөгчийн саналаар; - гишүүдийн ¼-ээс доошгүйн саналаар Парламентын ээлжит бус чуулганыг хуралдуулна.</p>	-	-
144.	Tanzania (United Republic of) 1977 (rev. 2005)	<p>CHAPTER 1 PART III SECTION 732</p> <p>In the event a state of emergency is proclaimed in relation to the whole of the United Republic, or to the whole of Mainland Tanzania or the whole of Tanzania Zanzibar, the President shall forthwith transmit a copy of the proclamation to the Speaker of the National Assembly who, after consultation with the Leader of Government Business in the National Assembly shall convene a meeting of the National Assembly within not more than fourteen days, to consider the situation and decide, whether to pass or not to pass a resolution, which has to be supported by the votes of not less than two thirds of all members, in support of the proclamation of a state of emergency issued by the President.</p> <p>CHAPTER 3 PART III SECTION 392</p> <p>3. The President may at any time summon a meeting of the</p>	<p>Онц байдал зарласан бол Ерөнхийлөгч Парламент дахь Засгийн газрын асуудал хариуцсан тэргүүнтэй зөвшилцсөний үндсэн дээр Парламентын ээлжит бус чуулганыг 14 хоногийн дотор зарлан хуралдуулж, Ерөнхийлөгчийн зарласан онц байдлыг дэмжих эсэх тогтоолыг холбогдох нөхцөл байдлын хүрээнд хэлэлцэж гишүүдийн дийлэнх олонхын саналаар батална. Ерөнхийлөгч аль ч үед Үндэсний Ассамблейг хуралдуулж болно.</p>	-	<p>Онц байдал зарласан бол Ерөнхийлөгч Парламент дахь Засгийн газрын асуудал хариуцсан тэргүүнтэй зөвшилцсөний үндсэн дээр Парламентын ээлжит бус чуулганыг 14 хоногийн дотор зарлан хуралдуулж, Ерөнхийлөгчийн зарласан онц байдлыг дэмжих эсэх тогтоолыг холбогдох нөхцөл байдлын хүрээнд хэлэлцэж гишүүдийн дийлэнх олонхын саналаар батална.</p>

		National Assembly.			
145.	Thailand 2017	<p>CHAPTER VII PART 4 SECTION 122 When it is necessary for the interests of the State, the King may convoke an extraordinary session of the National Assembly.</p> <p>CHAPTER VII PART 4 SECTION 123 Members of both Houses or Members of the House of Representatives comprising not less than one-third of the total number of existing members of both Houses have the right to lodge with the President of the National Assembly their petition to report to the King for the issuance of a Royal Command convoking an extraordinary session of the National Assembly. The President of the National Assembly shall report to the King and countersign the Royal Command.</p> <p>CHAPTER VII PART 4 SECTION 126 In the absence of the House of Representatives whether due to the expiration of its term, its dissolution, or on any other grounds, the Senate shall not hold its sitting except in the following cases: 1.where the National Assembly shall act under section 17, section 19, section 20, section 21, or section 177; 2.where the Senate shall hold a sitting to consider the appointment of a person to hold any office under the provisions of this Constitution.</p> <p>Where a case under paragraph one occurs, the Senate is permitted to hold a sitting. The President of the Senate shall report to the King for the issuance of a Royal Command convoking an extraordinary session of the National Assembly, and the President of the Senate shall countersign the Royal Command.</p> <p>In the case of (1), the Senate shall act as the National Assembly, provided that the votes for the approval under section 177 shall be of not less than two-thirds of the total number of existing Senators.</p>	Улс орны эрх ашигт шаардлагатай үед Хаан Үндэсний Ассамблейн ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулна.		Улс орны эрх ашигт шаардлагатай үед Хаан Үндэсний Ассамблейн ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулна.
146.	Timor-Leste 2002	<p>PART III TITLE III CHAPTER THREE ARTICLE 99 The National Parliament convenes on an extraordinary basis whenever so decided by the Standing Committee, at the request of one-third of Members or following notice of the President of the Republic with a view to addressing specific issues.</p>	Гишүүдийн 1/3-ны саналаар, эсхүл Ерөнхийлөгчөөс тодорхой асуудлыг хэлэлцүүлэх хүсэлт ирүүлснийг үндэслэн Байнгын хороо Үндэсний Ассамблейн ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулах шийдвэр гаргана.	-	Гишүүдийн 1/3-ны саналаар, эсхүл Ерөнхийлөгчөөс тодорхой асуудлыг хэлэлцүүлэх хүсэлт ирүүлснийг үндэслэн Байнгын хороо Үндэсний Ассамблейн ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулах шийдвэр гаргана.
147.	Togo 1992 (rev. 2007)	<p>TITLE III ARTICLE 55 The National Assembly and the Senate are convoked in extraordinary session by their respective president on a specific agenda, at the demand of the President of the Republic or of the absolute majority of the deputies or of the senators.</p>	Ерөнхийлөгч, эсхүл нийт гишүүд, эсхүл сенаторуудын олонхын шаардсанаар тодорхой асуудлаар Үндэсний Ассамблейн болон Сенатын дарга нар ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулна.	-	Ерөнхийлөгч, эсхүл нийт гишүүд, эсхүл сенаторуудын олонхын шаардсанаар тодорхой асуудлаар Үндэсний Ассамблейн болон Сенатын дарга нар ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулна.
148.	Tonga 1875 (rev. 2013)	<p>PART I 19 EXPENDITURE TO BE VOTED No money shall be paid out of the Treasury nor borrowed nor debts contracted by the Government but by the prior vote of the Legislative Assembly, except in the following cases: ii.In cases of war or rebellion or dangerous epidemic or a similar emergency, then it may be done by the Minister for Finance with the consent of Cabinet, and the King shall at once convoke the Legislative Assembly and the Minister for Finance shall state the</p>	Доор дурдсан үндэслэлээс буусад тохиолдод Засгийн газар нь Үндэсний Ассамблейн урьдчилан санал хурааснаас бусад зардал гарахгүй, зээл авахгүй. - дайн, эсхүл бослого, эсхүл аюултай халдварт өвчин буюу адил төстэй онц байдалд Кабинетын зөвшөөрснөөр Сайнгийн сайд зардал гаргах, зээл авах ба Хаан Ассамблейг зарлан хуралдуулсны	-	Доор дурдсан үндэслэлээс буусад тохиолдод Засгийн газар нь Үндэсний Ассамблейн урьдчилан санал хурааснаас бусад зардал гарахгүй, зээл авахгүй. - дайн, эсхүл бослого, эсхүл аюултай халдварт өвчин буюу адил төстэй онц байдалд

		grounds for the expenditure and the amount. PART II 38 KING'S RELATIONS WITH PARLIAMENT The King may convoke the Legislative Assembly at any time and may dissolve it at his pleasure and command that new representatives of the nobles and people be elected to enter the Assembly. But it shall not be lawful for the Kingdom to remain without a meeting of the Assembly for a longer period than one year. The Assembly shall always meet at Nuku'alofa and at no other place except in time of war.	дараа Сангийн сайд зардлын дүн, үндэслэлийг танилцуулна.		Кабинетын зөвшөөрснөөр Сайнгийн сайд зардал гаргах, зээл авах ба Хаан Ассамблейг зарлан хуралдуулсны дараа Сангийн сайд зардлын дүн, үндэслэлийг танилцуулна.
149.	Tunisia 2014	TITLE THREE ARTICLE 57 During its recess, the Assembly of the Representatives of the People shall convene in an extraordinary session upon the request of the President of the Republic, the Head of Government, or one-third of its members, to examine a specific agenda.	Ардын төлөөлөгчдийн хурал хуралдаагүй үед, Ерөнхийлөгч, Засгийн газрын тэргүүн, эсхүл гишүүдийн 1/3-ний саналаар Ардын төлөөлөгчдийн хурлыг тодорхой асуудлыг хэлэлцүүлэхээр ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулна.	-	Ардын төлөөлөгчдийн хурал хуралдаагүй үед, Ерөнхийлөгч, Засгийн газрын тэргүүн, эсхүл гишүүдийн 1/3-ний саналаар Ардын төлөөлөгчдийн хурлыг тодорхой асуудлыг хэлэлцүүлэхээр ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулна.
150.	Turkey 1982 (rev. 2017)	PART THREE CHAPTER ONE IIIA ARTICLE 93 The Assembly may be in recess for a maximum of three months in a legislative year; during adjournment or recess it may be summoned by the President of the Republic. The Speaker of the Assembly may also summon the Assembly either on his own initiative or at the written request of one fifth of the members.	Парламентын завсарлагааны хугацаанд Ерөнхийлөгч Парламентын хуралдуулж болно. Ассамблейн Спикер нь өөрийн санаачилгаар, эсхүл гишүүдийн 1/5-ны бичгээр гаргасан хүсэлтээр хуралдуулж болно.	-	-
151.	Turkmenistan 2008 (rev. 2016)	SECTION III CHAPTER II ARTICLE 71 The President of Turkmenistan shall: 13.designate the date of referenda, shall have the right to convene an early session of the Mejlis;	Ерөнхийлөгч;	-	-
152.	Uganda 1995 (rev. 2017)	CHAPTER 6 PROCEDURE OF PARLIAMENT 95 Notwithstanding any other provision of this article, at least one-third of all members of Parliament may, in writing signed by them, request a meeting of Parliament; and the Speaker shall summon Parliament to meet within twenty-one days after receipt of the request. CHAPTER 7 DECLARATION OF A STATE OF WAR 124 3. Where the President makes the declaration of a state of war under clause (2) when Parliament is in recess, the Speaker shall, immediately summon Parliament to an emergency session to sit within seventy-two hours after the declaration of a state of war.	Парламент хуралдаагүй үед Ерөнхийлөгч дайны байдал зарласан тохиолдолд Спикер Парламентын ээлжит бус чуулганыг нэн даруй зарлах ба онц байдал зарласнаас 72 цагийн дотор хуралдуулна.		Парламент хуралдаагүй үед Ерөнхийлөгч дайны байдал зарласан тохиолдолд Спикер Парламентын ээлжит бус чуулганыг нэн даруй зарлах ба онц байдал зарласнаас 72 цагийн дотор хуралдуулна.
153.	Ukraine 1996 (rev. 2016)	CHAPTER IV ARTICLE 83 Special sessions of the Verkhovna Rada of Ukraine, with the stipulation of their agenda , are convoked by the Chairman of the Verkhovna Rada of Ukraine, on the demand of no fewer National Deputies of Ukraine than one-third of the constitutional composition of the Verkhovna Rada of Ukraine, or on the demand of the President of Ukraine.	Ерөнхийлөгч, эсхүл Дээд Радын нийт гишүүдийн 1/3-ээс доошгүй шаардлагаар Дээд Радын дарга хэлэлцэхээр товлосон асуудлаар ээлжит бус чуулганы хуралдааныг зарлан хуралдуулна.		Ерөнхийлөгч, эсхүл Дээд Радын нийт гишүүдийн 1/3-ээс доошгүй шаардлагаар Дээд Радын дарга хэлэлцэхээр товлосон асуудлаар ээлжит бус чуулганы хуралдааныг зарлан хуралдуулна.
154.	United Arab Emirates 1971 (rev. 2009)	PART IV CHAPTER 4 SECTION 2 ARTICLE 78 The FNC meets in an annual regular session for a minimum of seven months, commencing on the third week of October every year. The FNC may be called into a special session, if necessary. The FNC may not hear at a special session any matter other than those for which it has been called into session.	Парламентын ээлжит бус чуулганаар хэлэлцэхээр товлосноос бусад асуудлыг хэлэлцэхгүй.		Парламентын ээлжит бус чуулганаар хэлэлцэхээр товлосноос бусад асуудлыг хэлэлцэхгүй.

		<u>PART IV CHAPTER 4 SECTION 2 ARTICLE 79</u> The FNC is called into session and is dismissed by decree issued by the President of the UAE subject to the approval of the Federal Council of Ministers. A meeting of the FNC convened without a formal call or in a place other than that specified for its meetings in the Constitution is deemed invalid and has no effect. However, if the FNC is not convened for its annual regular session before the third week of November, the FNC is convened ipso facto on the twenty first of that month.			
155.	United States of America 1789 (rev. 1992)	<u>ARTICLE II SECTION 3</u> He shall from time to time give to the Congress Information on the State of the Union, and recommend to their Consideration such Measures as he shall judge necessary and expedient; he may, on extraordinary Occasions, convene both Houses, or either of them, and in Case of Disagreement between them, with Respect to the Time of Adjournment, he may adjourn them to such Time as he shall think proper; he shall receive Ambassadors and other public Ministers; he shall take Care that the Laws be faithfully executed, and shall Commission all the Officers of the United States.	Ерөнхийлөгч Нэгдсэн Улсын байдлын талаар Конгресст үе үе мэдээлж, зайлшгүй шаардлагатай бөгөөд зохистой гэж үзсэн арга хэмжээний талаарх зөвлөмжөө Конгрессын анхааралд толилуулна. Ерөнхийлөгч онцгой тохиолдолд хоёр Танхимын нэгдсэн буюу аль нэгнийх нь Чуулганыг хуралдуулж болох бөгөөд тийм чуулганы хугацааг өөрчлөх асуудлаар хоёр танхим санал зөрсөн тохиолдолд ерөнхийлөгч зүйтэй гэж үзсэн хугацаагаараа хойшлуулан товлож болно.	Чуулганы хугацааг өөрчлөх асуудлаар хоёр танхим санал зөрсөн тохиолдолд ерөнхийлөгч зүйтэй гэж үзсэн хугацаагаараа хойшлуулан товлож болно.	Ерөнхийлөгч онцгой тохиолдолд хоёр Танхимын нэгдсэн буюу аль нэгнийх нь Чуулганыг хуралдуулж болох бөгөөд тийм чуулганы хугацааг өөрчлөх асуудлаар хоёр танхим санал зөрсөн тохиолдолд ерөнхийлөгч зүйтэй гэж үзсэн хугацаагаараа хойшлуулан товлож болно.
156.	Uruguay 1966 (reinst. 1985, rev. 2004)	<u>SECTION VI CHAPTER I ARTICLE 104</u> Only for grave and urgent reasons may the General Assembly or either of its Chambers, or the Executive Power, convoke extraordinary sessions to terminate a recess, and then exclusively for the purpose of dealing with the questions which have given rise to the convocation or with a proposed law declared to be of urgent consideration and that is under study although it was not included in the call. Likewise, a recess is automatically suspended for the Chamber which has before it or which receives for consideration, during the recess, a proposal declared to be of urgent consideration. A simple convocation to extraordinary sessions does not suffice to terminate the recess of the General Assembly or of either of its Chambers. For the recess to be interrupted sessions must actually be held, and the interruption shall last as long as the sessions are being held.	Ерөнхий Ассамблейн нэгдсэн, эсхүл танхим, Гүйцэтгэх эрх мэдлийн институт нь Ерөнхий Ассамблейг хурладуулна.	-	Хэлэлцэхээр товлосон, эсхүл хэлэлцэх асуудлыг товд ороогүй боловч яаралтай хэлэлцэх шаардлагатай ба хэлэлцүүлэхээр судалсан асуудлыг хэлэлцэнэ.
157.	Vanuatu 1980 (rev. 2013)	<u>CHAPTER 421</u> 2. Parliament may meet in extraordinary session at the request of the majority of its members, the Speaker or the Prime Minister.	Гишүүдийн олонхын саналаар, Спикер, эсхүл Ерөнхий сайдын саналаар.	-	-
158.	Venezuela (Bolivarian Republic of) 1999 (rev. 2009)	<u>TITLE V CHAPTER I SECTION TWO ARTICLE 196</u> The following are powers of the Delegated Committee: 1. To call the National Assembly into extraordinary session, when the importance of any matter so demands. <u>TITLE V CHAPTER II SECTION TWO ARTICLE 236</u> The following are attributions and duties of the President of the Republic: 9. To call special sessions of the National Assembly.	Эрх бүхий хороо нь аливаа асуудлын ач холбогдол үүнийг шаардах бол Үндэсний Ассамблейн ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулна.	-	Эрх бүхий хороо нь аливаа асуудлын ач холбогдол үүнийг шаардах бол Үндэсний Ассамблейн ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулна.
159.	Viet Nam 1992 (rev. 2013)	<u>CHAPTER V ARTICLE 83</u> 2. The National Assembly shall hold two sessions each year. When so required by the State President, the Prime Minister, or at least one-third of the total membership of the National	Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, нийт гишүүдийн 1/3-ээс доошгүйн саналаар.	-	-

		Assembly, National Assembly shall hold extraordinary session. The Standing Committee convenes the session of the National Assembly.			
160.	Yemen 1991 (rev. 2015)	PART THREE CHAPTER I ARTICLE 74 The House shall annually hold two ordinary sessions. It may be called to hold extraordinary session. The internal regulations of the House shall specify the dates of the ordinary sessions and their duration. In times of necessity, the House may call for extraordinary sessions by Presidential decree, a decision by the Presiding Board of the House, or a written request from one third of the members. The House session shall not be adjourned during the last quarter of the year before the endorsement of the General Budget of the state.	Танхимын удирдах зөвлөл, эсхүл гишүүдийн 1/3-ны бичгээр гаргасан хүсэлтээр.	-	-
161.	Zambia 1991 (rev. 2016)	PART VI PROCEEDINGS OF NATIONAL ASSEMBLY ARTICLE 75 3. Notwithstanding clause (2), the President, or two-thirds of the Members of Parliament, may, in writing, request the Speaker to summon a sitting of the National Assembly, as prescribed.	Ерөнхийлөгч, эсхүл Парламентын гишүүдийн 2/3 Спикерт Үндэсний ассамблейг хуралдуулах хүсэлтийг бичгээр гаргана.	-	-
162.	Zimbabwe 2013 (rev. 2017)	CHAPTER 5 PART 41102 2. Subject to this Constitution, the President is responsible for-- c.summoning the National Assembly, the Senate or Parliament to an extraordinary sitting to conduct special business; CHAPTER 6 PART 8146 146. Each House of Parliament determines the time and duration of its sittings, other than its first sitting, and its periods of recess, but-- a.the President may summon Parliament at any time to conduct special business;	Ерөнхийлөгч Үндэсний Ассамблей, Сенат, эсхүл Парламентаар тусгай асуудлыг хэлэлцэхээр ээлжит бус чуулганы хуралдааныг хуралдуулна.		Ерөнхийлөгч Үндэсний Ассамблей, Сенат, эсхүл Парламентаар тусгай асуудлыг хэлэлцэхээр ээлжит бус чуулганы хуралдааныг хуралдуулна.

ЗӨРЧИЛ ШАЛГАН ТОГТООХ, ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛЖ БУЙ ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН

(Лавлагаа мэдээлэл)

*Д.Халиун, Г.Алтан-Оч (Ph.D), Г.Билгээ
И.Жаргалзаяабямба, Д.Жигваагунсэл
О.Нарантуяа, Р.Нургүл, Ц.Элбэгзаяа*

АГУУЛГА

УДИРТГАЛ

1. АЗЕРБАЙЖАН

- Захиргааны зөрчлийн тухай хууль
- Захиргааны шийдвэр гаргах ажиллагааны тухай хууль
- Захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль

2. МОЛДАВ

- Зөрчлийн төрөлжсөн хууль
- Захиргааны хууль

3. ЛАТВИ

- Захиргааны зөрчлийн тухай хууль
- Захиргааны процессын тухай хууль

4. ХБНГУ

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

УДИРТГАЛ

Судалгааны хамрах хүрээ: Энэхүү лавлагааг гүйцэтгэхдээ зөрчил шалган шийдвэрлэх тухай бие даасан хуультай, эрх зүйн бүлийн хувьд Монгол улстай ижил төстэй улс орнууд болох Азербайжан, Молдав, Латви, болон ХБНГУ-ын хуулийн зохицуулалтыг судалсан болно.

Уг судалгаанд авагдсан орнуудад зөрчилд юуг хамруулдаг, зөрчилд оногдуулах хариуцлагыг хэн хүлээлгэдэг, зөрчил хянан шийдвэрлэх ажиллагаа ямар зарчмын дагуу, хэрхэн явагддаг, зөрчил шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаа болон зөрчилд шийтгэл оногдуулсан шийдвэрийг давж заалдах процессийн талаар Зөрчлийн тухай хууль болон Захиргааны процессийн хуулийн хүрээнд судалсан. Дээрх улс орнуудын холбогдох хууль тогтоомжийн нийцлийг үнэлээгүй болно.

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

АЗЕРБАЙЖАН УЛС

1. Захиргааны зөрчлийн тухай хууль, 2000 он
2. Захиргааны шийдвэр гаргах ажиллагааны тухай хууль, 2005 он
3. Захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх (процедур) тухай хууль, 2009 он

1. ЗАХИРГААНЫ ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ

Захиргааны зөрчлийн тухай хууль (The Code of the Azerbaijan Republic On administrative violations) нь 6 хэсэг, 458 зүйлтэй, 2000 оны 7 сард батлагдсан. Энэхүү хуулиар захиргааны зөрчил болон захиргааны зөрчлийг хянан шийдвэрлэх харилцааг зохицуулсан.

Захиргааны зөрчил-Захиргааны зөрчил гэж энэ хуулиар хамгаалагдсан нийгмийн харилцааг зөрчсөн, захиргааны хариуцлага хүлээлгэх буруутай (зориудаар буюу санаатай хандах) үйлдэл (үйлдэл, эс үйлдэхүй)-ийг хэлнэ. (§12)

Захиргааны зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан (§357)³⁴⁵

1. Дүүрэг (хот)-ийн шүүх; (§360.1)³⁴⁶
2. Сонгуулийн хороод болон насанд хүрээгүй хүмүүсийн эрхийг хамгаалах комисс; (§358)
3. Гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагууд болон Төв банкны холбогдох эрх бүхий албан тушаалтан (§359).

Захиргааны зөрчил (Тусгай ангийн 2 дугаар хэсэг)

6 дугаар бүлэг. Улс төр, нийгмийн харилцаа болон хөдөлмөрлөх эрх зөрчсөн захиргааны зөрчил

7 дугаар бүлэг. Хүн амын эрүүл мэнд, ариун цэвэр, эрүүл ахуй-халдвар судлалын журам зөрчсөн захиргааны зөрчил

8 дугаар бүлэг. Өмч хөрөнгийн эсрэг захиргааны зөрчил

9 дүгээр бүлэг. Байгаль орчны аюулгүй байдал, менежмент болон байгаль орчныг хамгаалах журам зөрчсөн захиргааны зөрчил

10 дугаар бүлэг. Цахилгаан болон түлш эрчим хүчний үйлдвэрлэлийн журам зөрчсөн захиргааны зөрчил

11 дүгээр бүлэг. Мал эмнэлгийн эрүүл ахуйн журам зөрчсөн захиргааны зөрчил

12 дугаар бүлэг. Төмөр зам болон гол, далай, агаарын тээврийн журам зөрчсөн захиргааны зөрчил

³⁴⁵ 360.2. If in events, stipulated in article 360.1 of this Code the case on administrative violations is subordinated not only to the authorised body (official), but also a court and sent by the authorised authority (official) for consideration to the court, such case shall be resolved in court.

³⁴⁶ Энэ хуулийн 360.1-д заасан захиргааны зөрчилд цэргийн албан хаагч, цэргийн алба хааж байгаа хүмүүс холбогдсон бол хэргийг цэргийн шүүхээр шийдвэрлэнэ. (§360.3)

- 13 дугаар бүлэг. Гудамжны хөдөлгөөний журам зөрчсөн захиргааны зөрчил
- 14 дүгээр бүлэг. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах журам зөрчсөн захиргааны зөрчил
- 15 дугаар бүлэг. Харилцаа холбооны журам зөрчсөн захиргааны зөрчил
- 16 дугаар бүлэг. Мэдээллийн хэрэглээ, түгээлт, хамгаалалтын журам зөрчсөн захиргааны зөрчил
- 17 дугаар бүлэг. Орон сууцны барилга байгууламжийн журам зөрчсөн захиргааны зөрчил
- 18 дугаар бүлэг. Эдийн засгийн үйл ажиллагааны журам зөрчсөн захиргааны зөрчил
- 19 дүгээр бүлэг. Захиргааны журам зөрчсөн захиргааны зөрчил
- 20 дугаар бүлэг. Санхүү, даатгал, татвар болон татвар төлөлтийн журам зөрчсөн захиргааны зөрчил
- 21 дүгээр бүлэг. Гаалийн журам зөрчсөн захиргааны зөрчил
- 22 дугаар бүлэг. Олон нийтийн дэг журам, нийгмийн аюулгүй байдал болон олон нийтийн ёс зүйн дүрэм зөрчсөн захиргааны зөрчил
- 23 дугаар бүлэг. Хяналтын журам зөрчсөн захиргааны зөрчил
- 24 дүгээр бүлэг. Цэргийн бүртгэлийн журам зөрчсөн захиргааны зөрчил

Захиргааны зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэх журам (§423)

1. Захиргааны зөрчлийн хэргийг шийдвэрлэхдээ:

- хэргийг шийдвэрлэж буй этгээд хэргийн талаарх товч мэдээлэл болон хэргийг шийдвэрлэсэн этгээдийн талаар мэдээлнэ.
- хэргийн оролцогч иргэн, хуулийн этгээд болон тэдний хууль ёсны төлөөлөгч болон бусад хүмүүсийн талаар мэдээлнэ.
- Иргэн, хуулийн этгээдийн албан ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийг тогтооно.
- Хэргийн оролцогчид хүрэлцэн ирээгүй шалтгааныг тодруулж, хэргийг хэрэгсэхгүй болгох, эсхүл хойшлуулах тухай шийдвэр гаргана.
- Хэргийн оролцогчдын эрх, үүрэг, хариуцлагыг танилцуулна.

2. Дараах тохиолдолд хэргийг хойшлуулах тухай шийдвэр гаргана.

- хэргийг шийдвэрлэж буй шүүгч, албан тушаалтан болон бүрэлдэхүүний гишүүн өөрөө татгалзах, эсхүл татгалзсан тухай хүсэлт ирсэн нь хэргийг шийдвэрлэхэд нөлөөлөхөөр байвал;
- хэрэв мэргэжилтэн, шинжээч, орчуулагчаас татгалзсан бол;
- оролцогчоос нэмэлт нотлох баримт болон шинжээч томилохыг шаардсан.

Шүүх харьяалан шийдвэрлэсэн хэргийн талаар Захиргааны зөрчлийн тухай хуулийн 421 дүгээр зүйлд заасны дагуу шийдвэр гаргана.

Захиргааны зөрчлийн хэргийн талаарх шийдвэрийг давж заалдах (§430)

Хохирогч, түүний өмгөөлөгч болон төлөөлөгч, хувь хүн, насанд хүрээгүй хүн, хуулийн этгээдийн хууль ёсны төлөөлөгч шийдвэрийг эсэргүүцэх, хэргийн талаарх шийдвэрийг давж заалдах гомдол гаргах эрхтэй бөгөөд мөн прокурор эсэргүүцэх эрхтэй.

Гомдол болон эсэргүүцлийг дараах журмаар гаргана.

1. шүүгчийн шийдвэрийг-Давж заалдах шүүхэд;
2. хамтарсан байгууллагын шийдвэрийг-хамтарсан байгууллагын орших шүүхэд;
3. эрх бүхий байгууллага (албан тушаалтан)-ын шийдвэрийг- Дээд шатны эрх бүхий байгууллага (албан тушаалтан), эсхүл шүүхэд.

Захиргааны зөрчлийн хэргийн шийдвэрт гаргасан гомдлыг давж заалдах журам (§431)

1. Захиргааны зөрчлийн хэргийн шийдвэрт гаргасан гомдол, эсэргүүцлийн талаар шийдвэр гаргасан шүүгч, эрх бүхий байгууллага (албан тушаалтан)-д мэдэгдэнэ.
2. Шийдвэр гарснаас хойш 3 хоногийн дотор шүүгч, эрх бүхий байгууллага (албан тушаалтан) гомдол, эсэргүүцлийг холбогдох материалын хамт харьяалах шүүх, эрх бүхий байгууллага (албан тушаалтан), хамтарсан байгууллагын оршин байгаа газрын шүүхэд шилжүүлнэ.
3. Захиргааны баривчлах шийтгэлд гаргасан гомдол, эсэргүүцлийн талаар давж заалдах шатны шүүхэд гомдол, эсэргүүцэл хүлээн авсан өдөр илгээнэ.
4. Хэрэв гомдол, эсэргүүцэл нь шүүгч, байгууллага (албан тушаалтан)-ын эрх хэмжээнд хамаарахгүй бол 3 хоногийн дотор харьяаллыг дахин тогтооно.
5. Захиргааны зөрчлийн хэргийн шийдвэрт гаргасан гомдолд тэмдэгтийн хураамж төлөхгүй.

2. ЗАХИРГААНЫ ШИЙДВЭР ГАРГАХ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ХУУЛЬ

Захиргааны шийдвэр гаргах ажиллагааны тухай хууль нь захиргааны байгууллагаас захиргааны акт гаргах, гүйцэтгэх, хүчингүй болгох ажиллагааны хууль эрх зүйн үндэслэл, зарчим, дүрэм журамтай холбоотой харилцааг зохицуулна³⁴⁷.

Хуулийн хамрах хүрээ: Энэ хууль нь хууль тогтоомжоор тодорхойлогдсон захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хамааралтай. Харин тус хууль нь эрүүгийн хэргийг байцаан шийтгэхтэй холбоотой үйл ажиллагаа болон захиргааны байгууллагын захиргааны зөрчилтэй холбоотой үйл ажиллагаанд хамааралгүй болно³⁴⁸.

Захиргааны акт гэж зохицуулалт хийх зорилгоор захиргааны байгууллагаас гаргасан шийдвэр, захирамж, бусад захиргааны хэм хэмжээ, эсхүл нийтийн эрх зүйн хүрээнд тодорхой асуудалтай холбоотой хувь хүн, хуулийн этгээдэд эрх зүйн тодорхой үр дагаврыг бий болгох шийдвэрийг хэлнэ³⁴⁹.

Захиргааны шийдвэр гаргах ажиллагаа (административное производство) гэдэг нь хувь хүн, хуулийн этгээдээс хандсаны дагуу, эсхүл захиргааны байгууллагын өөрийн санаачилгаар захиргааны актыг боловсруулан гаргах, гүйцэтгэх, өөрчлөх, хүчингүй болгох, түүнчлэн энэ хуулиар тогтоосон журмын хүрээнд холбогдох захиргааны байгууллагаас хэрэгжүүлсэн үйл ажиллагаанд гаргасан захиргааны гомдлыг хянан үзэх үйл ажиллагаа юм.

³⁴⁷ Захиргааны шийдвэр гаргах ажиллагааны тухай хууль, 1 дүгээр зүйл
<https://www.legislationline.org/ru/documents/id/17124>

Закон Азербайджанской Республики Об административном производстве
³⁴⁸ Захиргааны шийдвэр гаргах ажиллагааны тухай хууль, 3 дугаар зүйл
<https://www.legislationline.org/ru/documents/id/17124>

³⁴⁹ Захиргааны шийдвэр гаргах ажиллагааны тухай хууль, 2 дугаар зүйл
<https://www.legislationline.org/ru/documents/id/17124>

Захиргааны гомдол гэж холбогдох этгээд өөрийн хууль ёсны эрх болон ашиг сонирхлоо хамгаалах зорилгоор захиргааны байгууллагаас гаргасан захиргааны актыг, эсхүл захиргааны байгууллагын үйлдэл, эс үйлдэхүйг хүлээн зөвшөөрөхөөс татгалзаж, тэр талаар холбогдох дээд байгууллагад бичгээр хандахыг хэлнэ.

Холбогдох этгээд³⁵⁰ гэж

- захиргааны байгууллагын гаргасан захиргааны акт, эсхүл үйл ажиллагааны талаар захиргааны байгууллагад хандсан этгээд;
- эсхүл захиргааны байгууллагын гаргасан захиргааны акт болон үйлдэл, эс үйлдэхүйн үйлчлэлд хамаарах этгээд;
- эсхүл захиргааны байгууллагын гаргаж буй, гаргасан захиргааны акт болон үйл ажиллагааны улмаас хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хөндөх, хөндөж болзошгүй хувь хүн болон хуулийн этгээд;
- тухайн этгээдийн гаргасан өргөдлийг үндэслэж, эсхүл захиргааны байгууллагын санаачилгаар захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд татан оролцуулсан этгээдийг хэлнэ.

Захиргааны шийдвэр гаргах ажиллагааг эхлэх³⁵¹

Энэхүү ажиллагааг эхлүүлэхэд:

1. Хувь хүн, эсхүл хуулийн этгээдийн гаргасан өргөдөл;
2. Захиргааны байгууллага өөрийн санаачилгаар, эсхүл хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх;
3. Захиргааны гомдол буюу захиргааны актад гаргасан гомдлыг үндэслэл болгоно.

1 болон 3-т заасан тохиолдолд өргөдөл, гомдлыг бүртгэж авснаар захиргааны шийдвэр гаргах ажиллагааг эхлүүлнэ. 2-т заасан тохиолдолд холбогдох этгээдэд мэдэгдэж, эсхүл тухайн хэргийн хамгийн анхны процессоос эхэлнэ.

Өргөдөл, гомдол гаргах³⁵²

Холбогдох этгээд нь хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол холбогдох захиргааны байгууллагад өргөдөл, гомдлыг бичгэн хэлбэрээр гаргаж, шуудан, эсхүл цахим шуудангаар илгээнэ.

Захиргааны актын хэлбэр³⁵³

Хуульд өөрөөр заагаагүй бол захиргааны актыг бичгэн хэлбэрээр гаргана. Захиргааны актыг захиргааны байгууллагын холбогдох албан тушаалтан гаргах бөгөөд гарын үсэг зурж баталгаажуулна. Хууль тогтоомжид заасан, эсхүл төрийн болон олон нийтийн ашиг сонирхолд хохирол учруулах аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах

³⁵⁰ 2.0.3. заинтересованное лицо — лицо, обратившееся в административный орган в связи с принятием административного акта либо совершением соответствующего действия, либо в отношении которого принят административный акт либо совершено соответствующее действие (бездействие), либо любое физическое или юридическое лицо, на права либо охраняемые законом интересы которого непосредственно повлиял или может повлиять административный акт, предусмотренный к принятию либо принятый административным органом, либо действие административного органа, и которое привлечено к административному производству на основании своего ходатайства либо по инициативе административного органа в случаях, вытекающих из его служебного положения.

³⁵¹ Захиргааны шийдвэр гаргах ажиллагааны тухай хууль, 28 дугаар зүйл <https://www.legislationline.org/ru/documents/id/17124>

³⁵² Захиргааны шийдвэр гаргах ажиллагааны тухай хууль, 29 дүгээр зүйл <https://www.legislationline.org/ru/documents/id/17124>

³⁵³ Захиргааны шийдвэр гаргах ажиллагааны тухай хууль, 57 дугаар зүйл <https://www.legislationline.org/ru/documents/id/17124>

зэрэг яаралтай тохиолдолд захиргааны актыг аман буюу бусад хялбаршуулсан хэлбэрээр (ойлгомжтой хэлбэрээр) гаргаж болно.

Захиргааны актын алдааг засч залруулах³⁵⁴

Захиргааны байгууллага нь алдаатай шийдвэр гаргасан бол өөрийн санаачилгаар, эсхүл холбогдох этгээдийн гаргасан өргөдлийг үндэслэн алдаатай шийдвэр бүхий актыг засч залруулж болно.

Захиргааны байгууллага нь алдаатай шийдвэрээ засч залруулахад шаардлагатай баримт бичгийг нэхэж болно.

Захиргааны актад хийсэн залруулга нь захиргааны байгууллагын холбогдох албан тушаалтны гарын үсэг, эсхүл захиргааны гишүүдийн гарын үсгээр баталгаажсан байна.

Захиргааны байгууллага нь энэ хуулийн холбогдох заалтад (62 дугаар зүйлд) заасан журмын дагуу захиргааны актад хийсэн залруулгын талаар холбогдох этгээдэд албан ёсны мэдээлэл өгөх үүрэгтэй.

Захиргааны гомдлыг шийдвэрлэх тухай³⁵⁵

Захиргааны актыг давж заалдах эрх³⁵⁶. Холбогдох этгээд нь өөрийн эрх болон хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах зорилгоор захиргааны актыг давж заалдах, эсхүл хүлээн зөвшөөрөхөөс татгалзах эрхтэй байна.

Тухайн этгээдийн давж заалдах өргөдөл нь захиргааны актыг батлахтай холбогдолгүй бол энэ хуульд заасан журмын дагуу захиргааны байгууллагын үйлдэл, эс үйлдлийн талаар гомдол гаргаж болно.

Завсрын захиргааны акт (промежуточный административный акт)-ын эсрэг гаргасан гомдлыг холбогдох дээд шатны захиргааны байгууллагад, эсхүл зөвхөн дараах тохиолдолд гомдлыг авч үзэх эрх бүхий бусад байгууллагад гаргана. Үүнд:

- эрх мэдэлтэй холбоотой;
- эсэргүүцэх тохиолдол;
- холбогдох этгээдэд шийдвэр гаргах ажиллагааны материалтай танилцахыг зөвшөөрөөгүй, эсхүл мэдээлэл өгөхөөс татгалзсан;
- хуульд заасан бусад тохиолдол орно.

Захиргааны гомдлыг шийдвэрлэх³⁵⁷

Захиргааны гомдлыг авч үзсэний дараа эрх бүхий байгууллага:

- захиргааны актыг өөрчлөхгүй хэвээр үлдээх;
- захиргааны актыг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хүчингүй болгох, эсхүл захиргааны шинэ акт гаргах;
- захиргааны актыг өөрчлөх шийдвэр гаргана.

³⁵⁴ Захиргааны шийдвэр гаргах ажиллагааны тухай хууль, 63 дугаар зүйл
<https://www.legislationline.org/ru/documents/id/17124>

³⁵⁵ Захиргааны шийдвэр гаргах ажиллагааны тухай хууль, 7 дугаар бүлэг
<https://www.legislationline.org/ru/documents/id/17124>

³⁵⁶ Захиргааны шийдвэр гаргах ажиллагааны тухай хууль, 71 дүгээр бүлэг
<https://www.legislationline.org/ru/documents/id/17124>

³⁵⁷ Захиргааны шийдвэр гаргах ажиллагааны тухай хууль, 80 дугаар зүйл
<https://www.legislationline.org/ru/documents/id/17124>

3. ЗАХИРГААНЫ ХЭРГИЙГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ (ПРОЦЕДУР) ТУХАЙ ХУУЛЬ³⁵⁸

Энэ хууль нь 2009 оны 6 дугаар сарын 30-ны өдөр батлагдсан (№846-IIIQ), 2010 оны 9 дүгээр сарын 1-ны өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн ба (№934-IIIQD), 18 бүлэг, 132 зүйл ангитай байна.

Тус хууль нь дараах бүтэцтэй байна. Үүнд:

- нийтлэг үндэслэл;
- захиргааны хэргийг шүүхэд шийдвэрлэхэд баримтлах зарчмууд;
- шүүгчийн татгалзан гарах үндэслэл шалтгаанууд;
- шүүхэд нэхэмжлэл гаргах, хүлээн авах, нотлох баримт;
хэргийн оролцогчийн эрх зүйн байдал;
- шүүхийн зардал, улсын тэмдэгтийн хураамж;
- хялбаршуулсан журмаар хэрэг шийдвэрлэх;
- шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг;
- шүүх хурлыг зарлах, шүүх бүрэлдэхүүн, хуралдааны журам;
- анхан шатны шүүх хуралдаан, түүний шийдвэр;
- давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа;
- хяналтын журмаар хэрэг шийдвэрлэх ажиллагаа;
- шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шийдвэрийг дахин хянах ажиллагаа
- шүүхийн шийдвэр гүйцэтгэл ... гэсэн нийт 18 бүлэгтэй.

Бүгд Найрамдах Азербайжан Улсын “Захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх хууль”-ийн агуулгад зарим онцлог асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар дараах бүлгүүдтэй байна. Үүнд:

- Хэм хэмжээ, норм тогтоосон хуульд нийцэж байгаа эсэхийг хянан шийдвэрлэх;
- Улс төрийн намуудын үйл ажиллагаанд холбогдох маргааныг хянан шийдвэрлэх;
- Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагаанд холбогдож гарсан маргааны хянан шийдвэрлэх;
- Сонгогчийн эрхийг хамгаалах, сонгууль, олон нийтийн санал асуулгатай холбогдож гарсан хэрэг маргааныг хянан шийдвэрлэх;
- Санхүүгийн зах зээлийн үйл ажиллагаанд эрх бүхий байгууллагуудаас хяналт тавихтай холбогдож гарсан маргааныг шийдвэрлэх асуудлуудыг хамруулжээ.

Хуулийн VI бүлэг: Захиргааны процессийн оролцогч талуудын болон нэхэмжлэлийн төрлүүдийн тусгасан ба үүнд:

- 25 дугаар зүйлд, хүн, хуулийн этгээд, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд, төрийн захиргааны ба орон нутгийн захиргааны байгууллагуудыг оролцогч байхаар заажээ.
- 27 дугаар зүйлд, хэргийн оролцогчоор нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдийг тухайлан дурдаж заасан. (тухайн хэргийн оролцогч нарын

³⁵⁸ The Administrative Procedural Code of the Republic of Azerbaijan
<https://www.legislationline.org/documents/id/17124>

төлөөлөгч, өмгөөлөгч нь хэргийн бие даасан оролцогч бус зөвхөн төлөөлүүлж, өмгөөлүүлж байгаа этгээдийнхээ эрх, хууль ёсны ашиг сонирхлыг илэрхийлэн хамгаалагч байна) гэж заасан нь "Захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль" болон бусад улсын холбогдох хууль тогтоомжтой, нийтлэг агуулгатай байна.

Захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиас:

1 дүгээр зүйл

1.1 Бүгд Найрамдах Азербайжан Улсын "Захиргааны процедурын тухай" хуулийн хүрээ нь захиргааны эрх зүйн харилцаанд хамаарах маргаан (шүүхийн захиргааны маргаан) шүүхийн маргааныг хянан шийдвэрлэх процессын зарчим, журмуудыг шүүхийн харьяаллын дагуу тогтооно.

1.2. Захиргааны маргаантай холбоотой асуудлыг (цаашид - захиргааны хэргийг шийдвэрлэхэд) захиргааны хуулиар Бүгд Найрамдах Азербайжан Улсын "Иргэний тухай хууль"-ийн заалтууд энэ хуульд үйлчлэхгүй бөгөөд зарчмыг хувьд зөрчигдөөгүй тохиолдолд хэрэгжүүлнэ.

2 дугаар зүйл. Захиргааны маргааныг хянан шийдвэрлэх шүүхийн эрх мэдэл

2.1. Хууль тогтоомжид эрх мэдлийн талаарх бусад хуульд өөрөөр заагаагүй бол, захиргааны маргааныг захиргааны-эдийн засгийн шүүх, захиргааны болон эдийн засгийн бүрэлдэхүүн гэж ангилна.

2.2. Захиргааны процессыг энэ хуулийн дагуу дараах асуудлаар шийдвэрлэнэ
Үүнд:

2.2.1. хүний эрх, үүрэг хариуцлагын талаарх захиргааны байгууллагаас баталсан захиргааны хуулийн маргаантай асуудал (цуцлалт буюу өөрчлөлт);

2.2.2. захиргааны хуулийг албан ёсоор зарлахтай холбоотой үүрэг хариуцлагын талаарх захиргааны эрх мэдэлд хуваарилах, захиргааны байгууллагын үйл ажиллагаа (албадлага, нэхэмжлэл гаргах) -аас хамгаалуулах нэхэмжлэл;

2.2.3. захиргааны хуулийг зарлахтай холбогдоогүй тодорхой үйл ажиллагааны захиргааны эрх мэдэл (гүйцэтгэлийн нэхэмжлэл);

2.2.4. захиргааны хуулийг захиргааны байгууллагаас албан ёсоор зарлаагүй, хууль ёсны хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн хууль бус үйл ажиллагааны эсрэг нэхэмжлэл гаргах (тодорхой үйлдлээс татгалзах нэхэмжлэл);

2.2.5. Захиргааны эрх зүйн харилцааны хүртээмжтэй байдал, эсхүл дутагдал, захиргааны хуулийг хүчингүйд тооцох тухай мэдэгдэл (үүсгэн байгуулах, хүлээн зөвшөөрөх тухай нэхэмжлэл);

2.2.6. Бүгд Найрамдах Азербайжан Улсын Үндсэн хуулийн цэцийн эрх мэдэлд хамаарах асуудлаас бусад (хуульд нийцүүлэн гаргасан нэхэмжлэлийн шаардлагыг эс тооцвол) норматив зарчмын хууль тогтоомжид нийцэж буй эсэхийг шалгах тухай мэдүүлэг;

2.2.7. захиргааны маргаан, шийдвэртэй холбоотой эд хөрөнгийн талаарх

нэхэмжлэл, түүнчлэн захиргааны эрх бүхий байгууллагын албан тушаалтны хууль бус шийдвэр (захиргааны хууль), үйлдэл (үйлдэл хийхгүй байх) учирсан хохирлыг нөхөн төлөх талаарх шаардлагыг;

2.2.8. Хотын захиргаа болон захиргааны хяналтын байгууллага, захиргааны хяналтын байгууллагуудын үйл ажиллагаа;

2.2.9. Банкийг албадан татан буулгах, татан буулгах тухай томилгоо, банкны төлбөрийн чадваргүй болсон Бүгд Найрамдах Азербайжан Улсын “Банкны тухай хууль”-ийн дагуу банкуудын шийдвэрийг сайжруулах, нийслэлд хувь эзэмшдэг хувь хүн, банкны болон бусад хяналт шалгалтын арга хэмжээ авах эрхийг хасах зэрэг асуудлууд болно.

3 дугаар зүйл. Захиргааны болон эдийн засгийн шүүхийн харьяалал

3.1. Энэ хуулийн 3.2-т зааснаас бусад тохиолдолд маргааныг захиргааны хэргийн эдийн засгийн шүүхээр анхан шатны шүүхээр шийдвэрлэнэ,

3.2. Энэхүү хуулийн XV, XVI, XVIII, XIX бүлэгт дурдсан маргаантай холбоотой асуудлыг Бүгд Найрамдах Азербайжан Улсын шүүхийн захиргааны болон эдийн засгийн зөвлөлийг анхан шатны шүүх шийдвэрлэнэ. Энэ хуульд заасан журмын дагуу холбогдох хэрэг хянан шийдвэрлэх журмыг анхан шатны шүүх шийдвэрлэнэ. Давж заалдах шатанд шүүхийн захиргааны маргааныг XV, XVI, XVII, XVIII бүлгүүд нь заасан дүрэм журмаас бусад тохиолдолд хянан шийдвэрлэнэ.

3.3. Давж заалдах журмын захиргааны маргааныг Бүгд Найрамдах Азербайжан Улсын Давж заалдах шатны шүүхийн захиргааны болон эдийн засгийн зөвлөл хянан шийдвэрлэнэ.

3.4. Захиргааны маргааныг Дээд шүүхийн журмаар хянан шийдвэрлэнэ.

25 дугаар зүйл. Хуулийн процедурын чадамж

25. Захиргааны шүүхийн үйл ажиллагаанд дараах этгээдийг оролцуулах эрхтэй.

Үүнд: 25.1. хувь хүн болон хуулийн этгээд;

25.2. төрийн болон орон нутгийн засаг захиргаа.

27 дугаар зүйл. Захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх үйл ажиллагаа

27.0. Дараах этгээдүүд захиргааны шүүхийн оролцоно. Үүнд:

27.0.1. нэхэмжлэгч;

27.0.2. хариуцагч;

27.0.3. захиргааны шүүх ажиллагаанд оролцож буй гуравдагч этгээд зэрэг болно.

45 дугаар зүйл. Анхан шатны шүүх

45.1 Өргөдөл гаргасан хүсэлтийг холбогдох шүүхэд бичгээр хүргүүлнэ.

47 дугаар зүйл. Шүүгчийн тэргүүлэгч /цаашид даргалагч/ баримт бичгийг хавсарган өргөдлийг хүлээн авсны дараа захирамж гаргана.

48 дугаар зүйл. Шүүхийн шийдвэрт оролцогч талуудын үүрэг

48.1 Хуралдаан даргалагч нь албан ёсны буруутай үйлдлийг арилгах, тодорхой бус мэдэгдэлд тодруулга хийх, хэргийг мөн чанарт анхаарал хандуулах, бүрэн бус дутуу баримтыг бүрдүүлэх, бичгээр мэдэгдлийг гаргах, хэргийг бүрэн үнэлэх, үйл явцын дараагийн шатанд дүгнэлт гаргана.

48.2. Захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчид нь шүүх хуралдаан эхлэх хүртэл шүүхийн баримт бичиг эсэргүүцэл, холбогдох баримт бичиг шүүхэд хүргүүлэх үүрэгтэй. Хуралдааныг даргалагч нь цаг хугацааг тогтоож, үйл ажиллагааны дагуу үүрэг хариуцлага, шүүхийн баримт бичгийн хуулбарыг бусад оролцогсад хүргүүлнэ.

48.3. Бичгээр үйлдсэн уриалга, эсэргүүцэл, мэдэгдлийг бүрэн болон хавсаргасан баримт бичгийн эх хувь, хуулбарыг хавсаргасан байна. Эсрэг тал нь эдгээр баримт бичгийг мэдэж байх буюу баримт бичиг нь хэтэрхий том байгаа тохиолдолд тэдгээрийн өвөрмөц онцлогийг тодорхойлсноор эсрэг талын намтарт танилцуулах боломжийн талаар мэдэгдэнэ.

49- 80 дугаар зүйлүүдэд дараах асуудлуудыг хамруулжээ. Үүнд:

- урьдчилан бэлтгэл;
- шүүхийн тогтоол;
- шүүхээр хугацааг тогтоох;
- эсрэг заргыг мэдүүлэх;
- нэхэмжлэлийг өөрчлөх;
- шүүхийн өмнө хүлээх хариуцлага, нотлох баримтыг шалгах;
- захиргааны байгууллагуудын хүлээх хариуцлага;
- шүүх хуралдааныг зарлан хуралдуулах;
- нэхэмжлэгчийн нэхэмжлэгчийг шийдвэрлэх;
- бичгээр үйлдсэн үйлдлийг хянах;
- захиргааны актыг хүчингүй болгох шүүхийн тогтоол;
- албадан саатуулах шийдвэр;
- захиргааны актыг хараат бусаар хянан шийдвэрлэх;
- шийдвэр гарган хүргүүлэх;
- шүүхийн шийдвэрийн хариуцлага;
- шүүгчийн гүйцэтгэл;
- шүүхийн шийдвэр зэрэг асуудлуудыг хуульд заажээ.

81 дүгээр зүйл Давж заалдах эрх

81.1. “Захиргааны -эдийн засгийн шүүх”-ийн шийдвэрээс бусад тохиолдолд энэ хуульд зааснаар давж заалдаж болно. Шүүхийн “захиргаа-эдийн засгийн зөвлөл” давж заалдах шатны журмын дагуу (цаашид давж заалдах шатны шүүх) гомдлыг давж заалдаж болно.

81.2. Захиргааны шүүхийн үйл ажиллагаанд оролцогчид (оролцогч талууд болон гуравдагч этгээд) шүүх ажиллагааны явцад давж заалдаж, гомдол гаргах эрхтэй.

81.3. Энэ бүлэгт өөрөөр заагаагүй бол Бүгд Найрамдах Азербайжан Улсын захиргааны *процедурын тухай хууль, давж заалдах хэлбэр, агуулгын хувьд тавигдах*

шаардлага, “Иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай” хууль, давж заалдах шатны шүүхийн байцаан шийтгэх үйл ажиллагааны зохих заалтуудад шаардлага хангасан байна.

82 дугаар зүйл. Маргааныг давж заалдах шатны шүүхэд хянан шийдвэрлэнэ.

Давж заалдах шатны шүүх эрх зүйн хэм хэмжээгээр хууль зүйн асуудлыг баримт нотолгоонд тулгуурлан хэлэлцэнэ. Давж заалдах шатны шүүхэд хүргүүлсэн нотолгоо (нотлох баримт), бодит баримтууд нь энэ хуулийн 12 дугаар зүйлийн шаардлагад нийцсэн байна.

86 дугаар зүйл. Анхан шатны шүүхийн мэдэгдэл хүлээн авснаас хойш давж заалдах

Энэ зүйлд давж заалдах тухай мэдэгдлийг хүлээн авмагц захиргааны болон эдийн засгийн шүүх албан ёсны шаардлагад нийцүүлэн давж заалдах өргөдлийг гаргана. Шүүх нь давж заалдах өргөдөл гаргагчид албан ёсны алдааг засах үйлчилгээ үзүүлнэ. Захиргааны- эдийн засгийн шүүх давж заалдах гомдлын тухай мэдэгдэнэ. Мэдэгдлийг хүлээн авснаас хойш 5 хоногийн дотор холбогдох материалыг шүүх хуралдаанд оролцуулна.

87 дугаар зүйл. Давж заалдах шатны шүүхэд

87.1. Давж заалдах шатны шүүх давж заалдах гомдлыг хүлээн авч, үзэл бодлоо илэрхийлэх боломжийг олгох, давж заалдах гомдол барагдуулах шийдвэр гаргана.

87.2. Давж заалдах шатны шүүх хэргийг давж заалдах боломжтой эсэхийг шалгана.

87.3. Хэрэв хэргийг давж заалдаагүй тохиолдолд давж заалдах шатны шүүх татгалзсан тухай мэдэгдэнэ.

87.4. Шүүх нь давж заалдах гомдол гаргах эрхтэй байна. Ийм шийдвэр гаргахын өмнө оролцогч этгээдийг оролцоог сонсох эрхтэй.

87.5. Давж заалдах шатны шүүх нь шийдвэр гаргахын тулд амаар хянан шийдвэрлэх болон давж заалдах боломжтой байна.

87.6. Давж заалдах шатны шүүх өмнөх тогтоолыг өөрчлөхгүй байж, шүүхийн шийдвэрийг хэсэгчлэн буюу шинэчилсэн байдлаар давж заалдах шүүхийн шийдвэр гаргана.

98 дугаар зүйл. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай Улсын дээд шүүхийн шийдвэр

98.1. Захиргааны маргаантай асуудлаар Улсын дээд шүүхийн шийдвэр эцсийнх байна.

98.2. Шүүхийн маргааныг гарсан тохиолдолд Дээд шүүхийн захиргааны эдийн засгийн зөвлөлөөс илүү шийдвэр гаргана.

98.3. Шүүхийн хуралдаанаар хэргийг хянан шийдвэрлэхдээ дүгнэлт хийж, бичгээр үйлдэнэ.

124 дүгээр зүйл. Хэргийг Үндсэн хуулийн цэцэд танилцуулах

Бүгд Найрамдах Азербайжан Улс нь давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг зөрчсөн гэж үзвэл Үндсэн хуулийн цэцэд хандаж, маргааныг энэ хуулийн 130 дугаар зүйлд заасны дагуу хэрэгсэхгүй болгоно.

Бүгд Найрамдах Азербайжан Улсын Үндсэн хуульд нийцүүлэн энэхүү хуулийг дагаж мөрдөх, лавлагаа илгээх, Улсын Дээд шүүхээр дамжуулан Үндсэн хуулийн цэцэд хандаж болно.

МОЛДАВ УЛС

1. Зөрчлийн төрөлжсөн хууль, 2008 он
2. Захиргааны хууль, 2018 он (2019 оны 4 дүгээр сарын 1-ээс хүчин төгөлдөр үйлчилнэ)

1. МОЛДАВ УЛСЫН ЗӨРЧЛИЙН ТӨРӨЛЖСӨН ХУУЛЬ, 2008 ОН

Бүгд Найрамдах Молдав Улсад зөрчил шалган тогтоох, шийдвэрлэх ажиллагааг 2008 оны 10 дугаар сарын 28-ны өдөр батлагдаж, 2009 оны 5 дугаар сарын 31-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн Зөрчлийн төрөлжсөн хуулиар зохицуулдаг. Шинэ хууль батлагдан, дагаж мөрдөж эхэлсэнтэй холбоотойгоор 1985 оны 3 дугаар сарын 19-ний өдөр батлагдсан Захиргааны зөрчлийн тухай хуулийг хүчингүй болгосон. Өмнө үйлчилж байсан тус хуульд 200 гаруй нэмэлт, өөрчлөлт оруулсан ч улс орны нийгэм, эдийн засгийн хөгжил, нөхцөл байдалтай уялдахгүй, захиргааны зөрчлөөс урьдчилан сэргийлж чадахгүй байна гэж үзсэний үндсэн дээр шинэ Зөрчлийн тухай хууль боловсруулах ажлыг 1999 онд эхлүүлсэн.

Захиргааны төрөлжсөн хууль нь нийт 484 зүйлтэй, бүтцийн хувьд хоёр дэвтрээс бүрдэх ба нэгдүгээр дэвтэр нь материаллаг хэм хэмжээний ерөнхий, тусгай ангитай, 20 бүлэгтэй, хоёр дугаар дэвтэр нь процессийн хэм хэмжээний ерөнхий, тусгай ангитай, 10 бүлэгтэй. Хуулийн нэгдүгээр дэвтрийн 1-5 бүлэгт зөрчлийн тухай ерөнхий зохицуулалт, 6-20 бүлэгт зөрчлийн тусгай ангийн зохицуулалт, хоёрдугаар дэвтрийн 1-5 бүлэгт зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаатай холбоотой зохицуулалтууд, 6-10 бүлэгт зөрчил шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагааг тус тус зохицуулсан байна.

Тус хуулийн зорилго нь зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд хувь хүний эрх, хууль ёсны ашиг сонирхол, өмчийн эрх, нийгмийн хэв журам болон хуулиар хамгаалагдсан бусад үнэт зүйлсийг хамгаалах, зөрчил үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэхэд оршино.

Зөрчлийн төрөлжсөн хуулиар зөрчилтэй холбоотой ерөнхий болон тусгай зарчим, эрх зүйн хэм хэмжээг тогтоох, зөрчилд тооцох үндэслэл, зарчмыг тогтоох, ямар үйлдлийг зөрчилд тооцох, зөрчил гаргасан этгээдэд ямар төрийн байгууллага, албан байгууллага, ямар шийтгэлийг, ямар журмаар оногдуулах асуудлыг зохицуулсан байна.

Энэхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд тус хуулийн зохицуулалтаар Молдав Улсын албан ёсны хэвлэлд нийтлэгдсэн хэм хэмжээ тогтоосон актыг хэрэглэж болно. Энэ тохиолдолд урьдчилан таамаглагдах (predicatability) зэрэг Зөрчлийн

төрөлжсөн хуульд хамаарах шаардлагууд холбогдох хуулиудад мөн адил үйлчилнэ.

Аливаа хэм хэмжээ тогтоосон актыг хэрэглэх явцад тухайн хуулийн зохицуулалт нь Захиргааны төрөлжсөн хуулиар тогтоосон зарчимтай зөрчилдөх тохиолдолд Захиргааны төрөлжсөн хуулийн зохицуулалтуудыг хэрэглэнэ.

Зөрчил:

Молдав Улсын Зөрчлийн төрөлжсөн хуулийн 10 дугаар зүйлд “зөрчлийг энэ хуулийн дагуу хариуцлага хүлээлгэхээр заасан нийгмийн хор аюулаараа гэмт хэргээс бага, хуулиар хамгаалагдсан үнэт зүйлсэд халдаж буй гэм буруутай хэрэг (үйлдэл, эс үйлдэхүй)-г ойлгоно.” гэж тодорхойлсон байна.

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаан дахь хөөн хэлэлцэх хугацаа 1 жил байна.

Зөрчилд оногдуулах шийтгэл:

1. Зөрчил үйлдсэн хүнд дараах төрлийн шийтгэл оногдуулдаг. Үүнд:

- сануулах;
- торгууль ногдуулах /хувь хүнд 1-500 тооцооны нэгж хүртэл, албан тушаалтанд 10-1500 тооцооны нэгж хүртэл, хуулийн этгэдэд 10-1500 тооцооны нэгж хүртэл/³⁵⁹;
- тодорхой үйл ажиллагаа явуулах эрх хасах /3 сараас 1 жил хүртэл хугацаагаар/;
- тодорхой албан тушаал хаших эрхийг хасах /3 сараас 1 жил хүртэл хугацаагаар/;
- торгуулийн оноо тооцох / зөрчил гаргасан тээврийн хэрэгслийн жолооч/;
- тусгай эрх хасах (тээврийн хэрэгсэл жолоодох эрх, галт зэвсэг эзэмших эрх) /нөхцөлөөсөө хамааран: тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг – 6 сараас 1 жил хүртэл, эсхүл 6 сараас 3 жил хүртэл хугацаагаар, галт зэвсэг эзэмших эрхийг 3 сараас 1 жил хүртэл хугацаагаар тус тус хасна/;
- нийтэд тустай хөдөлмөр хийлгэх /10-60 цаг/;
- баривчлах /3-15 хоног, эсхүл 30 хүртэл хоног/.

2. Тодорхой үйл ажиллагаа явуулах, албан тушаал хаших эрхийг хасах, торгуулийн оноо тооцохыг нэмэлт шийтгэл хэлбэрээр хэрэглэж болно.

Зөрчил үйлдсэн хуулийн этгээдэд дараах төрлийн шийтгэл оногдуулна. Үүнд:

- торгууль ногдуулах;
- тодорхой үйл ажиллагаа явуулах эрх хасах /3 сараас 1 жил хүртэл/.

Тодорхой үйл ажиллагаа явуулах эрх хасах шийтгэлийг нэмэлт шийтгэл хэлбэрээр хэрэглэж болно.

Хуулийн нэгдүгээр дэвтрийн тусгай ангийн 6-20 дугаар бүлэгт захиргааны зөрчилд тооцох үйлдэл, эс үйлдэхүйг дараах байдлаар төрөлжүүлж зохицуулсан. Үүнд:

- Хувь хүний улс төр, хөдөлмөр болон Үндсэн хуулийн бусад эрхийн эсрэг зөрчил;
- Хүн ам, хүнийн эрүүл мэнд, эрүүл ахуйн журмын эсрэг зөрчил;

³⁵⁹ Тооцооны нэгж нь 50 лейтай тэнцүү байна. (34-р зүйл)

- Өмчлөх эрхийн эсрэг зөрчил;
- Байгаль орчныг хамгаалах журмын эсрэг зөрчил;
- Үйлдвэрлэл, барилга, эрчим хүч, орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээний журмын эсрэг зөрчил;
- Хөдөө аж ахуй, малын эрүүл ахуйн талаар тогтоосон журмын эсрэг зөрчил;
- Тээврийн журмын эсрэг зөрчил;
- Хөдөлгөөний аюулгүй байдлын журмын эсрэг зөрчил;
- Мэдээлэл, харилцаа холбоо, шуудан, мэдээллийн технологийн үйл ажиллагааны эсрэг зөрчил;
- Аж ахуйн үйл ажиллагаа, татвар, гааль, үнэт цаасны журмын эсрэг зөрчил;
- Төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааны эсрэг зөрчил;
- Улсын хил, Молдав Улсад зөрчих журмын эсрэг зөрчил;
- Зах зээлийн хяналт, стандартчилал, хэмжил зүй, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах журмын эсрэг зөрчил;
- Нийтийн хэв журам, аюулгүй байдлын эсрэг зөрчил;
- Цэргийн бүртгэлийн журмын эсрэг зөрчил.

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэгч:

- Шүүх;
- Прокурор;
- Захиргааны комисс /Орон нутгийн иргэдийн төлөөлөгчид байгуулна, бүрэлдэхүүнд дарга, дэд дарга, нарийн бичиг болон 4-7 гишүүн байна/;
- Хуулийн 400-423 дуугаар зүйлд заасан албан ёсны хянан шалгагч³⁶⁰

холбогдох зөрчлүүдийг тус тус шалган шийдвэрлэнэ.

Зөрчилд оролцогчийн эрх:

384 дүгээр зүйлд заасны дагуу Зөрчилд холбогдогч нь хуульд заасан журмын дагуу зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий байгууллага, албан шийдвэр, авсан арга хэмжээ, үүнд шүүхийн шийдвэрийн эсрэг давж заалдах эрхтэй.

Түүнчлэн зөрчилд холбогдогч нь зөрчил шалган тогтоох, эсхүл зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий байгууллага, албан тушаалтны хууль бус үйлдэл, эсхүл эс үйлдэхгүйгээс өөрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй байна.

Мөн хуульд зөрчлийн үр дагаврыг арилгах, учирч болзошгүй хохирол, хор уршгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ буюу аюулгүй байдлыг хангахтай холбоотой зохицуулалтыг тусгасан. Ингэхдээ хариуцлага тооцох үндэслэл байхгүй ч аюулгүй байдлыг хангахад чиглэсэн дараах арга хэмжээ авч болохыг заасан байна. Үүнд: албадан гаргах, зөвшөөрөлгүй баригдсан барилга, байгууламжийг буулгах, мод, бутыг огтлох, тусгай эд хөрөнгө хураах.³⁶¹

³⁶⁰ **385 Статъя.** Констатирующий субъект

(1) Констатирующим субъектом является представитель органа публичной власти, разрешающий в пределах своей компетенции дело о правонарушении в установленном настоящим кодексом порядке.

(2) Констатирующим субъектом назначается наделенный полномочиями по констатации правонарушения и/или назначению наказания служащий органов, указанных в статьях 400–423¹⁰.

³⁶¹ V¹ бүлэг, 439 дүгээр зүйл

Зөрчил шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаа:

Хуулийн хоёр дугаар дэвтрийн 7 дугаар бүлэгт зөрчил Зөрчил шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагааг зохицуулсан. Зөрчил хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд прокурорын бүрдүүлсэн нотлох баримтыг түрүүлж танилцуулна. Талууд, эсхүл бусад оролцогчдын хүсэлтээр нотлох баримтыг хэлэлцэх дараалал өөрчлөлт оруулж болно. Шүүх нь хэрэгт хамаарах бүхий л нотлох баримт, шүүх хуралдаанд хэлэлцсэн нотлох баримт, өргөдөл, гомдлыг хянаж, шаардлагатай бол нэмэлт ажиллагаа явуулахаар шийдвэрлэж болно.

Зөрчил шүүхээр хянан шийдвэрлэхэд дараах нөхцөл байдлыг тогтооно.³⁶² Үүнд:

- зөрчил гарсан эсэх;
- хэргийн зөрчлийн шинжийг арилгах нөхцөл байдал байгаа эсэх;
- зөрчил үйлдсэн гэж буруутгагдаж байгаа хүн буруутай эсэх;
- шийтгэлийг хөнгөрүүлэх/хүндрүүлэх нөхцөл байгаа эсэх;
- шийтгэл оногдуулах шаардлагатай эсэх, оногдуулах хэмжээ;
- хэргийг зохих ёсоор шийдвэрлэхэд ач холбогдол бүхий бусад асуудлууд.

Зөрчилд шийтгэл оногдуулсан шийдвэрийг давж заалдах ажиллагаа:

Хуулийн хоёр дугаар дэвтрийн 8 дугаар бүлэгт зөрчилд оногдуулсан шийдвэрийг давж заалдах асуудлыг зохицуулсан. Зөрчилд оногдуулсан шүүхийн шийдвэрийг кассацийн шүүхэд давж заалдаж болох ба кассацийн шүүхийн шийдвэр эцсийнх байна.

Кассацийн журмаар давж заалдах үндэслэл:

Зөрчилд оногдуулсан шүүхийн шийдвэрийн хууль зүйн алдааг засч залруулахад дараах үндэслэлээр давж заалдаж болно:

- а) тухайн хүний статус, эсхүл чадамжийг тогтоосон заалтуудыг мөрдөөгүй;
- б) шүүх хурал нээлттэй явагдаагүй;
- в) хэргийг хэлэлцэхдээ хуульд заасан журмын дагуу аль нэг талыг оролцуулаагүй, эсхүл хуульд заасан журмын дагуу дуудагдсан этгээд хүрэлцэн ирж, оролцох боломжгүй талаар шүүхэд мэдэгдээгүй;
- г) шийдвэрт давж заалдах гомдол гаргасан нь шийтгэл оногдуулсан шийдвэр нь үндэслэлгүй, эсхүл шийдвэр нь аль тогтоолын аль нэг хэсэгтэй зөрчилдсөн, эсхүл шийдвэрийн хэсгийг тодорхой заагаагүй, эсхүл бичгээр гаргасан шийдвэрийн хэсэг шүүхийн хурлын дараа зарласан шийдвэрийн хэсэгтэй зөрчилдсөн;
- е) зөрчлийн бүрэлдэхүүнд ямар нэгэн шинж тэмдэг байхгүй, эсхүл зөрчилд буруутгагдсанаас өөр хэрэгт шийтгэл оногдуулсан, үүнд хууль тогтоомж өөрчлөгдөн хөнгөрүүлэх зохицуулалтад хамаарахгүй;
- е) зөрчил үйлдсэн этгээдэд энэ хуульд заагаагүй үйлдэлд шийтгэл оногдуулсан;
- г) шийтгэлийг хууль тогтоомжид зааснаас өөрөөр хэрэглэсэн, эсхүл гаргасан

³⁶² VII бүлэг, 457 дугаар зүйл

- (1) Рассмотрев дело о правонарушении, судебная инстанция обязана установить:
 - а) имело ли место вменяемое в вину правонарушение;
 - б) имеются ли причины, устраняющие правонарушительный характер деяния;
 - в) виновно ли лицо, в отношении которого возбуждено производство о правонарушении;
 - г) имеются ли смягчающие и/или отягчающие ответственность обстоятельства;
 - д) есть ли необходимость наказания и какая мера наказания должна быть назначена;
 - е) другие аспекты, важные для правильного разрешения дела.
- (2) Вопросы, возникающие в ходе рассмотрения дела, разрешаются судебным определением, вносимым в протокол судебного заседания и подлежащим обжалованию одновременно с решением по делу о правонарушении.

зөрчилд тохироогүй шийтгэлийг оногдуулсан, эсхүл зөрчил гаргагчид тохироогүй шийтгэлийг оногдуулсан;

h) зөрчил үйлдсэн этгээдэд тухайн зөрчилд урьд нь хариуцлага хүлээлгэсэн, эсхүл шийтгэлийг хүлээлгэхгүй байх үндэслэлтэй бол, эсхүл шинэ хуулиар хасагдах буюу өршөөлд хамрагдсан бол, эсхүл зөрчил үйлдсэн этгээдийн нас барсан, эсхүл хуульд заасан тохиолдолд талууд эвлэрсэн;

i) гарсан зөрчлийн зүйлчлэлд алдаа гаргасан;

j) зөрчил гаргасан этгээдэд илүү тааламжтай хууль батлагдсан;

к) Үндсэн хуулийн шүүх хэрэглэсэн хуулийн заалтыг Үндсэн хууль зөрчсөн гэж тогтоосон;

1) Олон улсын шүүхээр өөр хэргийг шийдвэрлэхэд үндэсний хэмжээнд хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн гэж тогтоож, тухайн шийдвэрийг холбогдох зөрчилд хэрэглэж болох бол.

2. ЗАХИРГААНЫ ХУУЛЬ ТОГТООМЖ

Бүгд Найрамдах Молдав Улс (БНМУ)-ын шинэ Захиргааны хууль³⁶³ нь 2018 оны 7 дугаар сарын 19-ны өдөр Парламентаас батлагдсан бөгөөд 2019 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

Захиргааны хууль (ЗХ) тогтоомжийн зорилго нь нийтийн ашиг сонирхол, эрх зүйг харгалзан хувь хүн, хуулийн этгээдийн эрх, эрх чөлөөг хангахад чиглэсэн захиргааны үйл ажиллагааг болон үүнийг хянах шүүхийн ажиллагааг зохицуулахад оршино. (ЗХ-ийн 3-р зүйл)

Захиргааны хууль тогтоомж нь захиргааны үйл ажиллагааг болон энэхүү үйл ажиллагааг хянах шүүхийн ажиллагааг хэрэгжүүлэхэд захиргааны харилцааны зохицуулалтыг хангах эрх зүйн үндэс болно. Эрх зүйн актыг зөвхөн хуульд үндэслэж, тэдгээрт нийцүүлэн гаргасан бол захиргааны харилцааг зохицуулахад хэрэглэж болно. (ЗХ-ийн 1-р зүйл)

Энэ хуулийн хэм хэмжээ нь захиргааны харилцаанд оролцогчдын эрх зүйн байдал, нийтийн захиргааны болон шүүхийн байгууллагуудын бүрэн эрх, захиргааны шийдвэр гаргах болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын маргаан, эрх, үүргийг хянах эрх бүхий этгээдийн бүрэн эрхийг зохицуулна. (ЗХ-ийн 2.1)

Энэ хуулийн хэм хэмжээ нь дараах харилцаанд үйлчлэхгүй. (ЗХ-ийн 2.3) Үүнд:

- нэг талд нь нийтийн захиргааны байгууллага оролцсон хувийн эрх зүйн харилцаанд;
- Зөрчлийн тухай болон Эрүүгийн хуульд үндэслэн үйл ажиллагаа явуулж буй нийтийн захиргааны байгууллагын эрх зүйн харилцаанд;
- Үндсэн хуулийн хяналтын эрх зүйн харилцаанд;
- захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд.

Нийтийн захиргааны байгууллага нь хууль тогтоомжийн хүрээнд байгуулагдсан, нийтийн ашиг сонирхлыг хэрэгжүүлэх зорилгоор нийтийн захиргааны журмын дагуу үйл ажиллагаа явуулж байгаа зохион байгуулалтын бүтэц буюу байгууллага байна.

³⁶³ Административный Кодекс Республики Молдав от 19.07.2018 (№. 116). Опубликовано : 17.08.2018 в Monitorul Oficial Nr. 309-320 статья № : 466 Дата вступления в силу: 01.04.2019. Эх сурвалж: <http://lex.justice.md/viewdoc.php?action=view&view=doc&id=376815&lang=2>

(ЗХ-ийн 7-р зүйл)

Захиргааны шийдвэр гаргах ажиллагаа нь эхлээд нөхцөл байдлыг судлах, дараа нь түүний бэлтгэл ажлыг хангах, эцэст нь захиргааны акт батлах, захиргааны гэрээ байгуулах, захиргааны арга хэмжээ авах зэрэг захиргааны байгууллагын үйл ажиллагааны (гадаад) үр дагавар хэмээн Захиргааны хуульд тодорхойлжээ. (ЗХ-ийн 6.1)

Захиргааны шийдвэр ба түүний төрөл

Захиргааны акт нь нийтийн эрх зүйн харилцааг үүсгэх, өөрчлөх, эсхүл зогсоох замаар шууд хууль зүйн үр дагавар бий болгох зорилгоор нийтийн эрх зүй салбарын нэг удаагийн тохиолдлыг зохицуулахын тулд нийтийн захиргааны байгууллагаас гаргасан аливаа тушаал, шийдвэр болон албан ёсны бусад арга хэмжээ юм. Мөн захиргааны хууль бус үйл ажиллагаанаас учирсан хохирлыг нөхөн төлөх тухай нийтийн захиргааны шийдвэр нь нийтийн захиргааны акт болно. (ЗХ-ийн 10-р зүйл)

Захиргааны актыг дараах байдлаар ангилна. (ЗХ-ийн 11.1):

- сөрөг нөлөөлөл бүхий захиргааны акт-хаягласан этгээдэд хариуцлага хүлээлгэсэн, шийтгэсэн, үүрэг болгосон, эсхүл эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн, хүссэн үр өгөөжийг хангахын тулд бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн татгалзсан захиргааны акт;
- эерэг нөлөөлөл бүхий захиргааны акт-хаягласан этгээдэд аливаа тэтгэмж, урамшуул олгосон захиргааны акт.

Мөн захиргааны зохицуулах акт гэж байх ба энэ нь үндсэн хуулийн болон бусад хуулийн хууль тогтоомжийн хэм хэмжээнд үндэслэсэн, үндсэн хуулийн хяналтад хамаарахгүй, тодорхойгүй адил нөхцөл байдалд заавал биелүүлэх журмыг тогтоосон нийтийн захиргааны байгууллагаас баталсан эрх зүйн акт болно. (ЗХ-ийн 12-р зүйл)

Захиргааны гэрээ бол нийтийн эрх зүйн харилцааг тогтоох, өөрчлөх, эсхүл дуусгавар болгох гэрээ байна. (ЗХ-ийн 13-р зүйл)

Бодит акт (реальный акт) нь бодит үр дүнд хүрэх зорилготой нийтийн эрх зүйн захиргааны үйл ажиллагаа бөгөөд энэ нь нийтийн захиргааны байгууллагын лавлагаа мэдээлэл, сэрэмжлүүлэг, эсхүл зөвлөмж, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ зэрэг хэлбэрээр гарна. Өөрөөр хэлбэл, бодит акт нь императив хэм хэмжээ биш юм. (ЗХ-ийн 14-р зүйл)

Захиргааны нэхэмжлэл гаргах

Захиргааны хуулийн зорилгын хүрээнд иргэн, хуулийн этгээдээс нийтийн захиргааны байгууллагад хандаж хүсэлт гаргаж болно. Хүсэлтийг дараах байдлаар ангилна (ЗХ-ийн 9-р зүйл):

- өргөдөл/гомдол - захиргааны акт, эсхүл захиргааны арга хэмжээ авахыг шаардана;
- хандсан үг - хувийн болон нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлын талаар нийтийн захиргааны байгууллагад мэдээлнэ;
- санал - нийтийн захиргааны байгууллагаас нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой үйл ажиллагааны санал гаргана.

Нийтийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны улмаас эрх нь зөрчсөн гэж үзсэн байгаа хэн ч захиргааны нэхэмжлэл гаргаж болно. (ЗХ-ийн 20, 186.1)

Дараах төрлийн нэхэмжлэл байна (ЗХ-ийн 206.1):

- хүчингүй болгох тухай нэхэмжлэл - захиргааны актыг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хүчингүй болгох;
- үүргийн тухай нэхэмжлэл - нийтийн захиргааны байгууллагад захиргааны акт гаргахыг үүрэг болгох;
- үүргийн гүйцэтгэлийн тухай нэхэмжлэл - үйлдэл хийх, үйлдэл хийхийг зөвшөөрөх, үйлдлээс татгалзахыг үүрэг болгох;
- тогтоох тухай нэхэмжлэл - захиргааны акт, эсхүл захиргааны гэрээний эрх зүйн зөрчил, эсхүл хүчин төгөлдөр бус болохыг тогтоох;
- зохицуулалтын хяналтын тухай нэхэмжлэл - захиргааны зохицуулах актыг бүрэн буюу хэсэгчлэн хүчингүй болгох.


Захиргааны нэхэмжлэлийг хянан шийдвэрлэх шүүхийн харьяалал

Захиргааны дараах маргаанаас бусад бүх захиргааны нэхэмжлэлийг шүүхийн анхан шатны журмаар хянан шийдвэрлэнэ (ЗХ-ийн 191-р зүйл):

- давж заалдах шатны танхим (Апелляционная палата) нь захиргааны зохицуулах акттай холбоотой захиргааны нэхэмжлэхийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэнэ;
- Кишинёв хотын³⁶⁴ давж заалдах шатны шүүх (Апелляционный суд Кишинёва) нь Магистратурын дээд зөвлөл, Прокурорын дээд зөвлөлийн тогтоол болон Сонгуулийн тухай хуульд заасан түүний бүрэн эрхтэй холбоотой захиргааны нэхэмжлэлийг шүүхийн анхан шатны журмаар хянан шийдвэрлэнэ.

Давж заалдах шатны танхимд шүүхийн тодорхойлолтод давж заалдах гомдол гаргах бол Дээд шүүхийн танхим (Высшая судебная палата)-д Давж заалдах шатны танхимын шийдвэр болон тодорхойлолтод гомдол гарган давж заалдаж болно. (ЗХ-ийн 191.4, 5)

Давж заалдах шатны танхим болон Дээд шүүхийн танхимд шүүгчдийн тусгай зөвлөл, эсхүл коллеги байгуулагдаж захиргааны нэхэмжлэлийг хянан шийдвэрлэнэ. (ЗХ-ийн 192-р зүйл)




Анхан шатны шүүх захиргааны нэхэмжлэл хянан шийдвэрлэх ажиллагаа

Урьдчилсан мэдэгдэл гаргах замаар шүүхээс өмнөх шатанд маргааныг


³⁶⁴ Кишинэу - Бүгд Найрамдах Молдов Улсын нийлэл хот.

шийдвэрлэх боломжийг Захиргааны хуулийн 19, 162-р зүйлээр зохицуулсан байна.



Давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах, түүнийг хянан шийдвэрлэх ажиллагаа (апелляционная инстанция)

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг давж заалдаж болно. (ЗХ-ийн 231-р зүйл)



↓
Давж заалдах гомдлыг хянан үзэх

- Давж заалдах шүүх нь гомдлыг хүлээн авах нөхцөлийг хангаж байгаа эсэхийг хянан үзнэ. (ЗХ-ийн 236-р зүйл)
- Хэрэв Давж заалдах шүүх нь гомдлыг хүлээн авахыг хүлээн зөвшөөрөөгүй бол тухайн гомдлыг кассацийн журмаар давж заалдана. (ЗХ-ийн 236.1)

↓
Давж заалдах шүүх

- Давж заалдах шүүх дараах шийдвэрийг гаргана: (ЗХ-ийн 240-р зүйл)
- давж заалдах гомдлыг хэрэгсэхгүй болгох;
 - анхан шатны шүүхийн шийдвэрийг хэсэгчлэн хүчингүй болгож өөр тодорхойлолт гаргах;
 - анхан шатны шүүхийн шийдвэрийг бүхэлд нь хүчингүй болгож шинэ тодорхойлолт гаргах.

Дээд шүүхэд давж заалдах гомдол гаргах, түүнийг хянан шийдвэрлэх ажиллагаа (в кассационном порядке)

Анхан шатны шүүхийн болон Давж заалдах шүүхийн тодорхойлолтыг кассацийн журмаар давж заалдаж болно. (ЗХ-ийн 241-р зүйл)

Дээд шүүхэд гомдол гаргах

Давж заалдах шүүхийн тодорхойлолтыг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор Дээд шүүхэд гомдол гаргаж болно. (ЗХ-ийн 245.1)

↓
Дээд шүүх гомдлыг хянан үзэх

Дээд шүүх нь гомдлыг хүлээн авах нөхцөлийг хангаж байгаа эсэхийг хянан үзнэ. (ЗХ-ийн 246-р зүйл)

↓
Дээд шүүх

Дээд шүүх нь шүүхийн тодорхойлолтыг кассацийн журмаар давж заалдсан гомдлыг шүүх хурал хийхгүйгээр шийдвэрлэх ба шаардлагатай гэж үзвэл оролцогчдыг дуудаж болно. (ЗХ-ийн 247)

↓
Дээд шүүхийн шийдвэр

- Дээд шүүх гомдлыг хянан үзээд дараах шийдвэрүүдийн нэгийг гаргана. (ЗХ-ийн 248.1) Үүнд:
- давж заалдах гомдлыг хэрэгсэхгүй болгох;
 - давж заалдах шатны шүүхийн тодорхойлолтыг хэсэгчлэн хүчингүй болгож хүчингүй болгосон хэсэгт шинэ тодорхойлолт гаргах;
 - давж заалдах шатны шүүхийн тодорхойлолтыг бүхэлд нь хүчингүй болгож шинэ тодорхойлолт гаргах;
 - давж заалдах шатны шүүхийн тодорхойлолтыг бүхэлд нь

хүчингүй болгож хэргийг давж заалдах шүүхийн шатанд буцаах. Дээд шүүхийн тодорхойлолт нь батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох ба тодорхойлолтыг баталсан өдрийг тус шүүхийн албан ёсны цахим хуудсанд байршуулсан хугацааг тооцно. Тодорхойлолт батлагдсан өдрөөс хойш 5 хоногийн дотор оролцогчдод гардуулна. (ЗХ-ийн 248.2, 3)

ЛАТВИ УЛС

1. Захиргааны зөрчлийн тухай хууль, 1984 он
2. Захиргааны процессын тухай хууль, 2001 он

Тус улсад зөрчил шалган шийдвэрлэх асуудлыг Захиргааны зөрчлийн тухай хууль, Захиргааны процессын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжоор зохицуулдаг байна.

1. ЗАХИРГААНЫ ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ³⁶⁵

Латви улсын **Захиргааны зөрчлийн тухай хууль** (Latvian Administrative Violations Code) нь 1984 онд батлагдсан 2 хэсэг 32 бүлэг 321 зүйл бүхий хууль юм.

Энэ хуулийн зорилго нь нийтийн хэв журам, эд хөрөнгө, нийгэм-эдийн засаг, улс төр болоод хүний эрх, эрх чөлөө, хувь хүн, байгууллагын хууль ёсны ашиг сонирхол, үйл ажиллагааг хамгаалах, хууль ёсыг бэхжүүлэх, эрх, үүргийг зөрчихөөс сэргийлэх, төр, олон нийтийн эрх ашгийг хамгаалах, иргэдэд хууль ёсоо даган мөрдөх, бусдын эрх, эрх чөлөөнд хүндэтгэлтэй хандах хандлагыг төлөвшүүлэх, нийгэм, олон нийтийн өмнө хүлээх үүрэг, хариуцлагыг дээшлүүлэхэд оршино гэжээ.

Хуулийн зорилтод иргэдийн нийгэм эдийн засаг, улс төрийн эрх, эрх чөлөө, өмч, нийгмийн хэв журам, түүнчлэн байгууллагуудын хууль ёсны ашиг сонирхол, үйл ажиллагаа, төр олон нийтийн хэм хэмжээг хамгаалах, хууль ёсыг бэхжүүлэх, эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэдэд хууль тогтоомж, бусдын болон нийгмийн эрх ашгийг дээдлэн хүндэтгэх, өөрийгөө хүндэтгэх, үүрэг хариуцлагаа ухамсарлах дадалд сургах, боловсрол олгох явдал гээд тус зорилтыг хэрэгжүүлэх үүднээс ямар үйлдэл, эс үйлдлийг захиргааны зөрчилд тооцох, захиргааны зөрчил үйлдсэн этгээдэд ямар байгууллага, албан тушаалтнаас ямар шийтгэлийг ямар журмаар оногдуулахыг тодорхойлжээ.

Хуулийн 9 дүгээр зүйлд **захиргааны зөрчлийг** иргэдийн эрх, эрх чөлөө болон төр, нийгмийн хэв журам, эд хөрөнгө, захиргааны журамд аюул учруулсан санаатай, эсхүл болгоомжгүй байдлаар үйлдэгддэг энэ хуульд тодорхойлон заасан хууль бус, буруутай үйлдэл, эс үйлдэхүй гэж заасан байна. Мөн захиргааны хариуцлага нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжоор тухайн асуудалд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол үүсэн гарч ирнэ гэж заасан. Хуулийн 14 дүгээр зүйлд захиргааны

³⁶⁵ Latvian Administrative Violations Code <https://likumi.lv/ta/en/id/89648-latvian-administrative-violations-code>

Энэхүү судалгаанд ашигласан Бүгд Найрамдах Латви Улсын Захиргааны зөрчлийн тухай хуулийг Латвийн эрх зүйн мэдээллийн албан ёсны веб хуудаснаас авсан бөгөөд уг хуулийн англи хэл дээрх орчуулгад 2010 оны 6 дугаар сарн 17-ны өдрөөс хойш орсон нэмэлт, өөрчлөлтүүд тусгагдаагүй. Мэдээллийн хайлтын явцад тус хуулийн дэлхийн нийтлэг хэрэглэгддэг хоёрдогч хэлээр орчуулсан өөр орчуулга олдоогүй болно.

хариуцлага хүлээх насны хязгаарыг 14 ба түүнээс дээш гэж тогтоосон байна.

Хуулийн 22 дугаар зүйлд захиргааны шийтгэл нь захиргааны зөрчил үйлдсэн этгээдийг бусдын болон нийгмийн амьдрал, хууль ёсыг хүндэтгэх талаар сургах, дахин зөрчил үйлдэх, бусдын эрх ашгийг зөрчихөөс урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн хариуцлагын арга хэмжээ гэж заагаад дараах төрлийн захиргааны шийтгэлийг хуульчилсан байна. Үүнд:

- Анхааруулах;
- Торгох;
- Захиргааны зөрчлийн объектыг хураах, эсхүл хэрэгслийг хураах;
- Тухайн этгээдэд олгосон тусгай эрхийг хураах;
- Тодорхой хугацаагаар тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг хасах;
- Тодорхой албан тушаал эрхлэх эрх хасах буюу тодорхой буюу бүх төрлийн худалдаа арилжааны явуулах эрх хасах;
- Баривчлах.

Хуулийн тусгай анги буюу 41 дүгээр зүйлээс эхлэн иргэдийн эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой, өмчийн эсрэг, байгаль орчин түүх соёлын зүйлсийг хамгаалахтай холбоотой, цахилгаан, дулааны эрчим хүч, хэмжил зүйн хэрэглээнд үйлдэгдсэн, хөдөө аж ахуйн үйл ажиллагааны эсрэг, зам тээвэр харилцаа холбооны салбарын, замын хөдөлгөөний эсрэг, барилга орон сууцны салбар, түүний ашиглалт, хэрэглээний, худалдаа үйлчилгээ санхүүгийн салбарын, аж ахуйн үйл ажиллагааны, хэрэглэгчийн эрхийг хамгаалахтай холбоотой, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаатай холбоотой, нийгмийн хэв журмын эсрэг, захиргааны тусгай журмын эсрэг, хэвлэл мэдээллийн эсрэг, гаалийн салбартай холбоотой, төрийн албан ёсны хэлтэй холбоотой, шүүн таслах үйл ажиллагааны эсрэг, төрийн бэлгэ тэмдгийн хэрэглээтэй холбогдох, төрийн байгууллагад өргөдөл, гомдол хүлээн авах, хянан шалгахтай холбогдох, спорт, боловсролын салбар дахь захиргааны зөрчлүүд, бусад захиргааны зөрчил гэсэн байдлаар захиргааны зөрчлүүдийг бүлэглэн хуульчилсан байна.

Мөн хуулийн 16 дугаар бүлэгт захиргааны зөрчлийн асуудлыг шалган шийдвэрлэх эрх бүхий байгууллага, албан тушаалтныг дараах байдлаар заажээ. Үүнд:

- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын байгууллагын хороо;
- Хотын болон хотын зөвлөлийн захирагч нар;
- Орон нутгийн удирдлагын байгууллагаас баталсан журмаар эрх олгосон, түүний хэрэгжилтэд хяналт, тавьж захиргааны шийтгэл оногдуулах орон нутгийн гүйцэтгэх засаглалын байгууллагын албан хаагчид;
- Хот, дүүргийн шүүхийн шүүгч нар;
- Энэ хуулиар эрх олгосон цагдаагийн болон төрийн бусад байгууллага;
- Тээврийн хэрэгслийн зогсоолын журам зөрчсөн этгээдэд торгууль оногдуулах эрх бүхий нутгийн захиргааны байгууллагаас эрх олгосон төрийн байгууллага, албан хаагч нар.

Мөн дээрх эрх бүхий этгээдүүдээс харьяалан шийдвэрлэх зөрчлийг зааж, эрх бүхий байгууллага, улсын байцаагч нарыг тодорхойлон зааж өгсөн байна. Прокурорын байгууллагаас захиргааны зөрчил оногдуулах эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавихаар зохицуулсан. Захиргааны зөрчил гэмт

хэргийн шинжтэй гэж үзвэл прокурорт шилжүүлэхээр зохицуулсан.

Захиргааны шийтгэл оногдуулах субъектын хувьд харилцан адилгүй буюу тусгайлсан журам хуулиар тогтоогоогүй байх ба зөрчлийг шалган шийдвэрлэх нийтлэг журмыг тогтоосон байна.

Захиргааны шийтгэл оногдуулсан шийдвэрт захиргааны хариуцлага хүлээсэн этгээд болон хохирогч давж заалдах гомдол гаргах эрхтэй.

Дүүрэг болон хотын шүүхийн шийдвэрт бүсийн шүүхэд давж заалдах гомдол гаргахаар, шүүхээс бусад этгээдээс оногдуулсан шийтгэлд дүүрэг болон хотын шүүхэд давж заалдах гомдол гаргахаар хуульчилсан. Захиргааны шийтгэл оногдуулсан шийдвэрт прокурор эсэргүүцэл бичиж болох ба тус тохиолдолд дээр дурдсан журмаар хэлэлцдэг байна.

Захиргааны шийтгэл оногдуулах шийдвэрт тавигдах шаардлага, шийдвэр хэрэгжүүлэх журам зэргийг хуулийн бусад бүлэгт зохицуулсан байна.

2. ЗАХИРГААНЫ ПРОЦЕССЫН ТУХАЙ ХУУЛЬ³⁶⁶

Латви улсын **Захиргааны процессын тухай хууль** (Administrative Procedure Law) нь 2001 онд батлагдсан бөгөөд 8 хэсэг, 44 бүлэг, 385 зүйлтэй. Энэхүү хуулийг бусад хуульд өөрөөр заагаагүй бол байгууллагын захиргааны процесст хэрэглэх ба, шүүхэд захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг энэ хуульд заасны дагуу хэрэгжүүлнэ.

Захиргааны процессын тухай хуульд зааснаар **“Захиргааны акт”** гэж нийтийн эрх зүйн хүрээнд бие даасан хүн болон хуулийн этгээдэд хамааралтай үүссэн нөхцөл байдлыг зохицуулахаар захиргааны байгууллага, албан тушаалтнаас гаргасан гадагш чиглэсэн захирамжилсан шийдвэрийг хэлнэ. Мөн захиргааны актууд нь эрх зүйн статусыг тогтоох, өөрчлөх, дуусгавар болгох, эсхүл тухайн байгууллагын ажилтнуудад болон харьяалагдах доод шатны ажилтанд шийтгэл ногдуулах, мөн ажилтнууд болон доод шатны ажилтны хүний эрхийг ноцтойгоор хязгаарласан бусад шийдвэртэй хамааралтай шийдвэрийг хэлнэ. Хувийн эрх зүйн хүрээнд байгууллагын бусад төрлийн үйлдэл, шийдвэр, доод шатны ажилтан, эсхүл доод шатны байгууллагуудын болон байгууллагын өөрт хамаарах дотоод шийдвэрүүд захиргааны актад хамаарахгүй. Хууль тогтоох байгууллага, Ерөнхийлөгч, Засгийн газар, эсхүл орон нутгийн засаг захиргаа, хотын консул (дүүргийн болон сүмийн зөвлөл)-ын улс төрийн шийдвэр (улс төрийн тунхаглал, уриалга, зарлал, албан ёсны сонгууль болон бусад төстэй), мөн түүнчлэн эрүүгийн эрх зүйн процесс болон шүүхийн шийдвэртэй холбоотой шийдвэрүүд захиргааны актад хамаарахгүй.

Хуульд зааснаар “Гадаад хууль тогтоомж” гэж Үндсэн хууль, бусад хуулиуд, Засгийн газрын дүрэм журам, орон нутгийн засаг захиргаатай хамааралтай дүрэм журам болон олон улсын гэрээнээс бүрдэнэ. “Дотоод хууль тогтоомж” гэдэг нь хуулийн этгээдийн өөрийнхөө үйл ажиллагааны хүрээнд гадаад хууль тогтоомжийн хэрэглэх процедурыг тодруулах, эсхүл доод шатны байгууллага болон өөрийн дотоод ажлын

³⁶⁶ Administrative Procedure Law
<http://unpan1.un.org/intradoc/groups/public/documents/UNTC/UNPAN018406.pdf>

процедурыг тодорхойлох зорилготой нийтийн эрх зүйн хүрээнд хуулийн этгээдээс олгосон захирамжилсан шийдвэрийг хэлдэг байна.

Энэ хуулийн 51 дүгээр зүйлд, тухайн шийдвэр гаргасан байгууллагад гомдлоо гаргахыг заасан байх бөгөөд хуулийн 6 дугаар бүлэгт Захиргааны байгууллагаас захиргааны актын гомдлыг шийдвэрлэх процессыг тус тус заасан байна.

Мөн түүнчлэн 10 дугаар бүлэгт, шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх захиргааны процессын асуудлыг зохицуулсан ч захиргааны тусгай шүүхийн талаар зохицуулалт байхгүй байна.

Энэ хуулийн 32 дугаар бүлэгт, Давж заалдах шатны шүүхийн процессын талаар заасан бол 36 дугаар бүлэгт, Хяналтын шатны шүүхийн процессыг тус тус зохицуулсан байна. Гурван шатны шүүхийн талаарх зохицуулалтад захиргааны тусгайлсан шүүхийн талаар зохицуулалт байхгүй байна.

Хуулийн 8 дугаар бүлэгт, байгууллага, албан тушаалтны шийдвэр, захиргааны актаас шалтгаалан хохирсон хохирогчийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх тухай зохицуулсан байна. Тухайлбал,

91-р зүйл. Нөхөн олговрын эрх

Байгууллагын бодит үйлдэл, эсхүл захиргааны актаас шалтгаалан ёс зүйн хохирлыг оруулан хувийн хохирол болон санхүүгийн алдагдалд нөхөн олговор нэхэмжлэх эрхтэй.

Мөн хуулийн 41 дүгээр бүлэгт мөнгөн төлбөртэй холбоотой Захиргааны актын албан ёсны гүйцэтгэлийн талаар дараах байдлаар зохицуулсан.

366-р зүйл.1. Захиргааны актаар тухайлсан мөнгөн төлбөрийг төлөх үүрэг хүлээсэн этгээд мөнгөн төлбөрийн төлөлтийг Иргэний процессын хуулийн заалтад үндэслэн гүйцэтгэх хуудасны дагуу төлнө.

ХБНГУ

1. Зөрчлийн болон Захиргааны хууль, түүний процессийн хуулиуд байдаг эсэх талаар

Германд хэв журмын зөрчил гэж мөнгөн торгууль оногдуулахуйц хэв журмын эрх зүйг зөрчихийг хэлнэ. Хэв журмын зөрчлийн тухай хууль³⁶⁷ бий. Уг хууль нь мөнгөн торгуулийн процессийн зохицуулалтаа дотроо агуулдаг. Замын хөдөлгөөний журмын зарим зөрчилд мөнгөн торгуулиас гадна 3 сар хүртэлх хугацаагаар жолоодох эрхийг хасах шийтгэл оногдуулдаг байна.³⁶⁸

Зөрчлийн эрх зүй нь өргөн утгаараа эрүүгийн эрх зүйд хамаардаг. Учир нь эрүүгийн эрх зүйн аргуудыг хэрэглэдэг бөгөөд процесс нь адилхан байдаг. Зөрчил гаргасан этгээдийг гэмт хэрэг үйлдсэн гэж арай үзэхгүй. Зөрчил гаргасан этгээдэд ихэвчлэн мөнгөн торгууль оногдуулдаг.³⁶⁹

Захиргааны эрх зүй нь гүйцэтгэх засаглал буюу төрийн захиргааны эрх зүй бөгөөд нийтийн эрх зүйн бүрэлдэхүүн хэсэг юм. Захиргааны эрх зүйгээр төр, иргэний хоорондын харилцаа болон захиргааны байгууллагуудын үйл ажиллагаа, тэдгээрийн хоорондын харилцааг зохицуулдаг байна. Захиргааны ерөнхий эрх зүй нь төрийн захиргаа болон түүний үйл ажиллагааны үндсэн зарчмын үндэс суурийг тодорхойлдог бол захиргааны тусгай эрх зүй нь тухайн төрийн захиргааны салбарын тусгай үйл ажиллагааг мэргэжлийн онцлогтойгоор тусгайлан зохицуулдаг. Жишээлбэл, барилгын эрх зүй, орон нутгийн эрх зүй, замын хөдөлгөөний эрх зүй г.м.³⁷⁰

Захиргааны эрх зүйн үндсэн зарчмууд:

- Хуулийг урьтал болгох зарчим: хуулийн эсрэг эс үйлдэх.
- Хууль дээдлэх зарчим: хуульгүйгээр эс үйлдэх.
- Харьцангуй харьцааны зарчим: захиргаа нь арга хэмжээний зорилгын шаардлагаас хэтрүүлэн хүний эрхэнд халдахгүй байх.

Захиргааны эрх зүйн эх үүсвэрүүд:

- Ард түмнүүдийн эрх зүй, Европын эрх зүй
- Үндсэн хуулийн эрх зүй
- Ердийн хуулиуд
- Эрх зүйн тогтоомжууд (Засгийн газар буюу захиргааны байгууллагын тогтоол, захирамж)
- Нийтийн эрх зүйн дүрмүүд
- Захиргааны заавар журмууд

Захиргааны процессийн тухай хууль³⁷¹, Захиргааны шийдвэр гүйцэтгэлийн тухай хууль³⁷² тус тус бий.

³⁶⁷ Хэв журмын зөрчлийн тухай хууль-Gesetz über Ordnungswidrigkeiten https://de.wikipedia.org/wiki/Gesetz_%C3%BCber_Ordnungswidrigkeiten

³⁶⁸ Хэв журмын зөрчил-Ordnungswidrigkeit <https://de.wikipedia.org/wiki/Ordnungswidrigkeit>

³⁶⁹ Эрүүгийн эрх зүй (Герман)-Strafrecht (Deutschland) [https://de.wikipedia.org/wiki/Strafrecht_\(Deutschland\)](https://de.wikipedia.org/wiki/Strafrecht_(Deutschland))

³⁷⁰ Захиргааны эрх зүй (Герман)-Verwaltungsrecht (Deutschland) [https://de.wikipedia.org/wiki/Verwaltungsrecht_\(Deutschland\)](https://de.wikipedia.org/wiki/Verwaltungsrecht_(Deutschland))

³⁷¹ Захиргааны процессийн хууль-Verwaltungsverfahrensgesetz <https://de.wikipedia.org/wiki/Verwaltungsverfahrensgesetz>

³⁷² Захиргааны шийдвэр гүйцэтгэлийн хууль-Verwaltungs-Vollstreckungsgesetz <https://de.wikipedia.org/wiki/Verwaltungs-Vollstreckungsgesetz>

2. Зөрчилд оногдуулсан шийдвэр болон захиргааны актын ялгааны талаар

Захиргааны үйлдлийн хэлбэрүүд:

- Захиргааны акт (шийдвэр)
- Захиргааны реал-акт
- Нийтийн эрх зүйн гэрээ хэлцэл (нийтийн барилгын эрх зүй, хүрээлэн буй орчны эрх зүй, татаасын эрх зүй, үндсэн хуулийн эрх зүй, ард түмнүүдийн эрх зүй г.м.)
- Захиргааны эрх зүйн өрийн харилцаа
 - Захиргааны эрх зүйн хадгаламжийн харилцаа
 - Тохоон томилогдохгүйгээр нийтийн эрх зүйн байгууллагыг удирдах

3. Захиргааны зөрчилд юу юу хамааруулдаг талаар

Дээр өгүүлсэнчлэн, захиргааны ерөнхий эрх зүйгээс гадна захиргааны тодорхой, бодит чиг үүрэг, хэрэгцээ шаардлагад нийцсэн захиргааны тусгай эрх зүй байдаг. Тусгай эрх зүй нь ерөнхий эрх зүйгээ тодотгох буюу сайжруулдаг байна. Эсрэгээрээ, ерөнхий эрх зүй нь тусгай эрх зүйгээ бие даасан зохицуулалт хийгдээгүй хэсэгт нь нөхөж, түүнийг бүрэн бүтэн болгодог байна. Тусгай эрх зүйг системчлэн жагсаавал:

- Хэв журмын эрх зүй буюу аюулаас хамгаалах эрх зүй
 - Цагдаа буюу хэв журмын ерөнхий эрх зүй
 - Барилгын журмын эрх зүй
 - Хурал, цуглааны эрх зүй
 - Гадаадын иргэний эрх зүй
- Орон нутгийн (сумын) эрх зүй
 - Орон нутгийн үндсэн дүрэм (хууль) эрх зүй
 - Орон нутгийн татварын эрх зүй
- Орон зайн журам, барилга болон мэргэжлийн төлөвлөлтийн эрх зүй
 - Орон зайн журам болон газар төлөвлөлтийн эрх зүй
 - Хотын барилгажилтын эрх зүй
- Эдийн засгийн захиргааны болон эдийн засгийн зохицуулалтын эрх зүй
 - Аж ахуйн нэгжийн эрх зүй, дотроо хамруулсан байдлаар:
 - Хоол зоогийн газрын эрх зүй
 - Гар урлал (үйлдвэрлэл)-ын эрх зүй
 - Тээврийн эрх зүй (хүн тээвэр, ачаа бараа тээвэр, төмөр замын тээвэр, усан замын тээвэр)
 - Эрчим хүчний эрх зүй
 - Картелийн эрх зүй (Өрсөлдөөнийг хязгаарлахын эсрэг хууль)
 - Харилцаа холбооны эрх зүй
- Хүрээлэн буй орчны эрх зүй
 - Утаанаас (нүүрс төрөгчийн хийнээс) хамгаалалтын эрх зүй
 - Хог хаягдлын эрх зүй
 - Усны эрх зүй
 - Хөрс хамгаалалтын эрх зүй
- Эмийн эрх зүй
 - Хүн болон амьтны эмийн эрх зүй

- Сайн (клиник) эмнэлгийн практикийн журам
 - Эм болон бодис үйлдвэрлэх журам
- Мэдээ алдуулах бодисын эрх зүй
- Апотекийн (эмийн сангийн) эрх зүй
- Эмийн сурталчилгааны эрх зүй (Чанга бус өрсөлдөөний эсрэг хууль мөн багтана)
- Дээрх хуулиудын нэмэлт байдалтай бусад бүх журам болон захиргааны заавар
- Анагаах бүтээгдэхүүний эрх зүй
- Боловсролын эрх зүй, ялангуяа
 - Дунд боловсролын эрх зүй
 - Дээд боловсролын эрх зүй
- Төрийн албаны эрх зүй
 - Төрийн албан хаагчийн эрх зүй
 - Цэрэг болон иргэний албан хаагчийн эрх зүй
- Нийгмийн эрх зүй
- Татварын болон бусад шимтгэлийн эрх зүй
- Нийт замын хөдөлгөөний эрх зүй (хөдөлгөөний иргэний эрх зүй болон хөдөлгөөний эрүүгийн эрх зүй багтахгүй)
 - Авто замын хөдөлгөөний эрх зүй
 - Авто зам болон явган хүний замын эрх зүй

4. Хэн оногдуулдаг талаар

Эрүүгийн эрх зүйн үндэс маш хүчтэй харагддаг хэдий ч хэв журмын зөрчлийн эрх зүйг системчлэн үзвэл тэрээр захиргааны эрх зүйд багтана.³⁷³

Хэв журмын зөрчлийн эрх зүй (ХЖЗЭЗ)-г ихэвчлэн эрүүгийн эрх зүйн дүү гэж үздэг. ХЖЗЭЗ нь хэдийгээр эрүүгийн эрх зүйг дуурайлган хийсэн ч зарим зүйл дээр мэдэгдэхүйц ялгаатай. Хэв журмын зөрчил илрүүлж (мөрдөж), шийтгэвэр оногдуулж буй төрийн захиргааны байгууллага нь яллах шийтгэл оногдуулах (энэ эрх зөвхөн шүүхэд хадгалагдана) эрхгүй учир мөнгөн торгууль нь ял шийтгэл биш юм. Түүнээс гадна ХЖЗЭЗ-д эрүүгийн эрх зүйгээс ялгаатай нэг зүйл бол хамтрагч (бүлэглэн үйлдэгч, туслагч) гэдэг ойлголт байхгүй, харин бүх гэмт үйлдэлд оролцогчийг үйлдэгч (ганц тоон дээр) гэж үздэг.

Мөн замын хөдөлгөөний хэв журмын зөрчлийн эрх зүйн үр дагавар нь замын хөдөлгөөний эрүүгийн хэргийн эрх зүйн үр дагавраас эрс ялгаатай. Замын хөдөлгөөний гэмт хэрэгт ялын шийтгэл оногдуулдаг. Харин ХЖЗЭЗ-д ёс зүйн үнэ цэн, ёс суртахууны үнэлэмж дутагдалтай байдаг. ХЖЗЭЗ-д тухайн холбогдогчид буруу зуршлаа засах боломж олгож мөнгөн торгууль оногдуулах буюу жолоо барихыг тодорхой хугацаагаар хориглох шийтгэл оногдуулдаг байна.

5. Шүүхийн аль харьяаллаар, ямар процессоор шийдвэрлэдэг талаар

Захиргааны шүүхийн журам³⁷⁴ нь Холбооны улсын хууль бөгөөд захиргааны шүүх

³⁷³ Хэв журмын зөрчил-Ordnungswidrigkeit <https://de.wikipedia.org/wiki/Ordnungswidrigkeit>

³⁷⁴ Захиргааны шүүхийн журам-Verwaltungsgerichtsordnung <https://de.wikipedia.org/wiki/Verwaltungsgerichtsordnung>

дэх шүүхийн процессийг зохицуулдаг.

Захиргааны хэргийн шүүх³⁷⁵ нь үндсэн хуулийн эрх зүйн төрлөөс бусад нийтийн эрх зүйн маргаантай хэргийг хариуцдаг. Иргэний шүүх болон нийгмийн шүүхээс ялгахад зарим тохиолдолд маш их хүндрэлтэй, маргаантай байдаг. Түүнээс гадна татварын эрх зүйн маргааныг Санхүүгийн шүүх хариуцдаг.

Захиргааны хэргийн шүүх нь 3 шатлал бүхий бүтэцтэй. Ихэнх захиргааны шүүхийн процессийг анхан шатаар Захиргааны шүүх хамаардаг.

Давж заалдах болон гомдол барагдуулах³⁷⁶ (төрийн байгууллага буюу шүүхийн гаргасан шийдвэр, тогтоомж болон арга хэмжээг эсэргүүцэн давж заалдах) шатны шүүхийн үүргийг муж улсуудын Захиргааны дээд шүүх гүйцэтгэдэг. Захиргааны дээд шүүх нь мөн дүрмүүдийн хэм хэмжээнд хяналт тавих, муж улсын эрх зүйн хүрээнд холбоодод хориг тавих, болон техникийн буюу зам тээврийн том төслүүдэд зөвшөөрөл олгох үед анхан шатны шүүхийн үүрэг гүйцэтгэдэг байна.

Хяналтын болон эрх зүйн гомдол барагдуулах шатны шүүх нь Лайпциг хотод байрлах Холбооны захиргааны хэргийн шүүх юм. Холбооны захиргааны шүүх нь мөн даатгалын зохицуулалтын болон Холбооны улс болон муж улсуудын хоорондох үндсэн хуулийн бус маргааныг шийдвэрлэхэд анхан шатны шүүхийн үүрэг гүйцэтгэнэ.

Германы захиргааны шүүхийн процесст албан байгууллага эрэн сурвалжлах үндсэн дүрэм (шүүх буюу төрийн захиргааны байгууллага нь шийдвэр гаргахад шаардагдах нотлох баримтыг холбогдогчийн өргөдлөөс бус буюу түүнээс хамааралгүйгээр албан байгууллагаас гаргуулж судалж, шинжлэх)-ийг баримталдаг. Энэхүү үндсэн дүрмийг өөрөөр бас мөрдөн шинжилгээний үндсэн дүрэм, албан байгууллага эрэн сурвалжлах үүрэг, албан байгууллага нотлох үүрэг, “шүүх цаазын максим” ч гэж нэрлэдэг.

Захиргааны шүүхийн процесс нь ерөнхийдөө төлбөртэй байдаг. Гэхдээ насанд хүрээгүйчүүдийн тусламж, дайнд амь үрэгсдийн халамж, хүнд тахир дутуу болон бусад халамжийн хэргийн процесст төлбөр болон хураамж авдаггүй байна.



³⁷⁵ Захиргааны шүүх-Verwaltungsgerichtsbarkeit
[https://de.wikipedia.org/wiki/Verwaltungsgerichtsbarkeit_\(Deutschland\)](https://de.wikipedia.org/wiki/Verwaltungsgerichtsbarkeit_(Deutschland))

³⁷⁶ Beschwerdeinstanz-германаар

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Азербайжан

- http://www.ombudsman.gov.az/upload/editor/files/Azerbaijan_Code%20on%20Administrative%20offences_2000_eng.pdf
- Захиргааны шийдвэр гаргах ажиллагааны тухай хууль, 80 дугаар зүйл <https://www.legislationline.org/ru/documents/id/17124>
- ¹*The Administrative Procedural Code of the Republic of Azerbaijan* <https://www.legislationline.org/documents/id/17124>

Молдав

- КОДЕКС Nr.218 от 24.10.2008 О Правонарушениях Опубликовано: 16.01.2009 в Monitorul Oficial Nr.3-6 статья №:15 Дата вступления в силу: 31.05.2009
- <http://lex.justice.md/ru/330333/>
- Contraventions Code of the Republic of Moldova
- <https://www.ilo.org/dyn/natlex/docs/ELECTRONIC/86500/97673/F144678591/MDA86500.pdf>
- КОДЕКС Nr. 116 от 19.07.2018 Административный Кодекс Республики Молдав
- Опубликовано: 17.08.2018 в Monitorul Oficial Nr. 309-320 статья №:466 Дата вступления в силу: 01.04.2019
- <http://lex.justice.md/viewdoc.php?action=view&view=doc&id=376815&lang=2>
- <http://www.legeasiviata.in.ua/archive/2018/10-1/9.pdf>
- ЗАКОН Nr.793 от 10.02.2000 об административном суде* Опубликовано: 03.10.2006 в Monitorul Oficial Nr. ed.speciala <http://lex.justice.md/viewdoc.php?action=view&view=doc&id=350170&lang=2>

Латви

- Latvian Administrative Violations Code
- <https://likumi.lv/ta/en/id/89648-latvian-administrative-violations-code>
- Administrative Procedure Law
- <http://unpan1.un.org/intradoc/groups/public/documents/UNTC/UNPAN018406.pdf>

ХБНГУ

- Хэв журмын зөрчлийн тухай хууль-Gesetz über Ordnungswidrigkeiten https://www.gesetze-im-internet.de/owig_1968/
- Захиргааны процессийн хууль-Verwaltungsverfahrensgesetz
- <https://www.gesetze-im-internet.de/vwvfg/>
- Захиргааны шийдвэр гүйцэтгэлийн хууль-Verwaltungs-Vollstreckungsgesetz <https://www.gesetze-im-internet.de/vwvg/>
- Холбооны хууль: Захиргааны шүүхийн журам-Verwaltungsgerichtsordnung <https://www.gesetze-im-internet.de/vwgo/>